

АЛБАН ТУШААЛЫН ГЭМТ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ЭМХТГЭЛ

(2014 он)

II боть

Хянасан: Д.Дуламсүрэн

Эмхтгэсэн: Д.Цэнд-Аюуш
У.Номин-Эрдэнэ

Энэхүү эмхтгэлийг хэвлүүлэхэд дэмжлэг үзүүлсэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн “Монгол Улсад иргэн төвтэй төрийн албыг төгөлдөржүүлэх нь” төслийн нэгжийн удирдлага, хамт олонд талархал илэрхийлье.

Энэхүү эмхтгэлд орсон шүүхийн шийдвэрүүдийг “Монгол Улсын Шүүхийн шийдвэрийн цахим сан” (www.shuukh.mn)-аас түүвэрлэн авав.

Цаасны хэмжээ: А4
Хэвлэлийн хуудас: 48
Хэвлэсэн тоо: 1000

“УРАНГАР ПРЕСС” ХХК-д хэвлэв

УНШИГЧ ТАНАА

Авлигатай тэмцэх үйл ажиллагаанд авлига, албан тушаалтын гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоохоос гадна авлигын шалтгаан нөхцөлийг арилгах, эрсдэлээс сэргийлэх, авлигын нийгмийн хор аюулыг олон нийтэд ойлгуулах, таниулах, соён гэгээрүүлэх ажил чухал байр суурийг эзэлдэг.

Монгол Улсын Авлигатай тэмцэх газар 2007 оны 9 дүгээр сарын 07-ны өдрөөс Эрүүгийн байцаан шийтгэх хуульд зааснаар 10 төрлийн гэмт хэрэгт хэрэг бүртгэл, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байв. Харин 2017 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгаар авлигын 11 төрлийн гэмт хэргийг харъяалан шалгаж байна.

Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт авлига, албан тушаалын гэмт хэрэг болон түүний шийдвэрлэлтийн талаар хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийтэд тогтмол мэдээлэх, шийдвэрлэлтийн мэдээлэлд дүн шинжилгээ хийх тогтолцоо бүрдүүлэх зорилтыг тусгасан. Авлигын гэмт хэргийн шийдвэрлэлтийг ил тод болгосноор олон нийтийн хяналтыг тогтоох, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд мөн ач холбогдолтой юм.

Авлигатай тэмцэх газраас мөрдөн шалгаж, шүүхээр шийдвэрлэгдсэн гэмт хэргийн шийдвэрийг цувралаар олон нийтэд хүргэхээр энэ удаад 2014 онд

шийдвэрлэгдсэн албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрүүдийг эмхтгэн толилуулж байна.

Энэхүү эмхтгэлд Авлигатай тэмцэх газраас мөрдөн шалгасан авлигын гэмт хэргийн 40 шийдвэр багтсан бөгөөд хууль хэрэглээний болон практик ач холбогдлыг харгалзан анхан шатны шүүхийн тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлал, хяналтын шатны шүүхийн тогтоолыг багтааснаараа онцлог юм.

Авлига, албан тушаалын гэмт хэргийн шүүхийн шийдвэрийг ийнхүү эмхтгэн гаргаснаар Эрүүгийн хуулийг нэг мөр хэлбэрэлтгүй хэрэгжүүлэхэд хууль хэрэглээний практикийг жигдрүүлэх, шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч нарт практик ач холбогдолтой бөгөөд багш, судлаач, оюутнуудын эрдэм шинжилгээ, сургалт судалгааны эргэлтэд оруулж, улмаар авлигын эсрэг эрх зүйн орчин, ялын бодлогыг сайжруулахад хувь нэмэр оруулна гэдэгт итгэж байна.

Эмхэтгэлтэй холбоотой санал хүсэлтээ Авлигатай тэмцэх газрын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст (hututulbur@iaac.mn цахим шуудан, утас 70112467) хандаж ирүүлэх боломжтой бөгөөд бид Таны саналыг таатай хүлээн авч хамтран ажиллах болно.

Авлигатай тэмцэх газар

ГАРЧИГ

1.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шийтгэх тогтоол 261	5
2.	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн магадлал 436	51
3.	Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол 385	101
4.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 1025	129
5.	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн магадлал 958	172
6.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 1360	207
7.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 751	249
8.	Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн магадлал 787	291
9.	Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол 425	349
10.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн цагаатгах тогтоол 1299	362
11.	Сум дундын 26 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 13/А	372
12.	Сум дундын 28 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 132	376
13.	Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шийтгэх тогтоол 1214	381
14.	Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдааны тогтоол 472	383

ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 261

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч Г.Буяннэмэх даргалж, шүүгч З.Болдбаатар, И.Ганбат нарын бүрэлдэхүүнтэй Цагдан хорих 0461 дүгээр анги дахь шүүх хуралдааны танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар

Иргэдийн төлөөлөгч Д.Алтангэрэл, Б.Оюунбилэг, Я.Гантөмөр, Нарийн бичгийн дарга М.Бэхбат, Н.НАмсрайжав, Улсын яллагч О.Гэрэл, Ш.Баярбилэг, Шүүгдэгч Ч.Га, түүний өмгөөлөгч Г.Оюунцэцэг, А.Ундрах, Шүүгдэгч Д.Эн, түүний өмгөөлөгч Х.Баасанжаргал, Э.Энэбиш, Д.Батбаяр, С.Жанцан, Шүүгдэгч Б.Бу, түүний өмгөөлөгч Б.Мөнхбат, Л.Данзанноров, Шүүгдэгч Б.Жа, түүний өмгөөлөгч Н.Цогт, Ш.Энхмаа, Шүүгдэгч П.Га, түүний өмгөөлөгч Ч.Мөнхцэцэг, Шүүгдэгч Н.Ра, түүний өмгөөлөгч Ж.Батзоригт, Шүүгдэгч Б.Өс, түүний өмгөөлөгч Б.Цэнгүүн, Шүүгдэгч Н.Чи, түүний өмгөөлөгч Х.Цогтсайхан, Шүүгдэгч Б.Жр, түүний өмгөөлөгч К.Бауиржан, Шүүгдэгч О.Бя, түүний өмгөөлөгч Г.Мөнхбат, Шүүгдэгч Ч.Да, түүний өмгөөлөгч С.Оюунцэцэг, Ц.Гансүх, Шүүгдэгч Х.Ха, түүний өмгөөлөгч Г.Тунгалаг, Б.Хишигбаатар, Шүүгдэгч Б.Жал, түүний өмгөөлөгч Б.Энхтуяа, Хохирогч, иргэний нэхэмжлэгч Татварын ерөнхий газрын төлөөлөгч З.Ми, Хохирогч «ЭҮ» ХХК-ийн төлөөлөгч А.Ба, Иргэний хариуцагч «ПВР» ХХК-ийн төлөөлөгч М.Ня, Д.Бо, тэдгээрийн өмгөөлөгч С.Цэрэнжээ, Иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-ийн төлөөлөгч Н.Зо, Л.Зу, Шинжээч Л.А, Д.Б, Н.Г, Б.Б, С.Ба, Б.Э, Ч.У, С.О, Ц.Б, Гэрч Пла, Ж.На, Д.Га, Орчуулагч С.Ба нарыг оролцуулан,

Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн,

1. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}, 272 дугаар зүйлийн 272.2, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдэд холбогдсон Ч.Га,

2. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}, 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдэд холбогдсон Д.Эн,

3. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт заасан гэмт

хэрэгт холбогдсон Б.Бу,

4. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}, 254 дүгээр зүйлийн 254.2 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдэд холбогдсон Б.Жа,

5. 6. 7. 8. 9. 10. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдсон П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя,

11. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдэд холбогдсон Ч.Да,

12. 13. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасныг журамлан, мөн хуулийн тусгай

ангийн 265 дугаар зүйлийн 265.2, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдэд холбогдсон Х.Ха, Б.Жал нарт холбогдох №20130100003. дугаартай эрүүгийн хэргийг 2013 оны 12 дугаар сарын 26-ны өдөр хүлээн авч, 2014 оны 02 дугаар сарын 17-ноос 21-ний өдрүүдэд цагдан хорих 0461 дүгээр анги дахь шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт:

1.Монгол Улсын иргэн ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, гэмт хэрэгт холбогдох үедээ Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн дарга ажилтай байсан, ам бүл ..., эхнэр, охин, хүү, зээ нарын хамт амьдардаг, Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, Баянзүрх дүүргийн ...дугаар хороо...тоотод оршин суух бүртгэлтэй, урьд ял шийтгүүлж байгаагүй, Алтангадас одонтой, хэрэг хариуцах чадвартай, Ө овогт Ч.Га (РД:ЧМ.....),

2.Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Ховд аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч, бизнесийн удирдлага мэргэжилтэй, гэмт хэрэгт холбогдох үедээ Татварын ерөнхий газрын харьяа улсын төсвийн орлого хяналтын газрын эрсдэлийн удирдлага судалгаа үнэлгээний хэлтсийн дарга ажилтай байсан, ам бүл ..., эхнэр хүүхдүүдийн хамт амьдардаг, Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, Алтангадас одонтой, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, Д овогт Д.Эн (РД:ШЖ.....),

3. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Сүхбаатар аймгийн ...хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, гэмт хэрэгт холбогдох үедээ Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст татварын улсын ахлах байцаагч ажилтай байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг, Баянзүрх дүүрэг ...дугаар хороо ...тоотод оршин суух, Алтан гадас одонтой, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, Х овогт Б.Бу (РД: УХ.....),

4. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Өмнөговь аймгийн ...суманд төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй,

гэмт хэрэгт холбогдох үедээ Шүүх шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний хэлтсийн дарга ажилтай байсан, ам бүл..., эцэг, нөхөр, охин, зээ нарын хамт амьдардаг, Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, Хөдөлмөрийн хүндэт медальтай, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, С овогт Б.Жа (РД:КЮ.....),

5. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Булган аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, гэмт хэрэгт холбогдох үедээ Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, одоо Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн тасгийн дарга ажилтай, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг, Баянгол дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, төрөөс авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, Б овогт П.Га (РД:ГЮ.....)

6. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Булган аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, халх, дээд боловсролтой, нягтлан бодогч эдийн засагч мэргэжилтэй, 2009 оны 04 дүгээр сарын 01-нээс Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагч, 2011 оны 2 дугаар сараас 2013 оны 04 дүгээр сарын 15 хүртэл Нийслэлийн татварын албанд татварын улсын байцаагч, одоо Баянзүрх дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байгаа, ам бүл..., эхнэр хүүхдийн хамт амьдардаг, Баянзүрх дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, Хөдөлмөрийн хүндэт медальтай, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, У овогт Н.Ра (РД:УС.....)

7. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр Төв аймгийн ...суманд төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, барилгын инженер-эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, 2009 оны 09 дүгээр сарын 01-нээс 2011 оны 6 дугаар сарын 22 хүртэл Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагч, 2011 оны 6 дугаар сарын 22-оос 2013 оны 10 дугаар сарын 18 хүртэл сургалтын төвд багш, одоо тус газрын хууль, эрх зүйн хэлтэст магадлагч ажилтай, ам бүл..., хүүхдийн хамт амьдардаг, Баянгол

дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, Хөдөлмөрийн хүндэт медальтай, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, Г овогт Б.Өс (РД:НЭ.....),

8. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч-нягтлан бодогч мэргэжилтэй, 2007 оны 5 дугаар сарын 01-нээс 2013 оны 04 дүгээр сарын 01 хүртэл Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байгаад, одоо тус газрын хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт татварын улсын байцаагч ажилтай, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт амьдардаг, Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, төрөөс авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, С... овогт Н.Чи (РД:ХО.....),

9. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, санхүүч-эдийн засагч мэргэжилтэй, 2008 оны 10 дугаар сарын 06-наас 2012 оны 02 дугаар сарын 01 хүртэл Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагч, 2012 оны 02 дугаар сарын 01-нээс одоо хүртэл тус газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газарт татварын улсын байцаагч ажилтай, ам бүл ..., нөхөр, хүүхдүүдийн хамт амьдардаг, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, О...овогт Б.Жр (РД:ШЗ.....),

10. Монгол Улсын иргэн,... оны ...дугаар сарын ...-ны өдөр Өвөрхангай аймгийн ...суманд төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч-эдийн засагч мэргэжилтэй, 2004 оны 4 дүгээр сарын 01-нээс 2013 оны 03 дугаар сарын 27-ны өдөр хүртэл Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагч ажилтай байсан (2013 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн мөрдөн байцаагчийн тогтоолоор албан тушаал эрхлэх эрхийг түдгэлзүүлсэн), ам бүл ..., хүүхдийн хамт амьдардаг, Баянгол дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, төрөөс авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, Ү... овогт О.Бя (РД: ЮЮ.....)

11. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн,

...настай, эрэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, 2001 оны 01 дүгээр сараас 2010 оны 12 дугаар сарын 05-ныг хүртэл "НА" ХХК-ийн дэд захирал, аудитор, 2011 оны 01 дүгээр сарын 01-нээс "СА" ХХК-ийн ерөнхий захирал ажилтай, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, төрөөс авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, Ө овогт Ч.Да (РД:ЦГ.....),

12. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч-эдийн засагч мэргэжилтэй, "ЭҮ" ХХК-д нягтлан бодогч, ерөнхий нягтлан бодогчийн орлогчоор нийт 35 жил ажилласан, 2013 оны 07 дугаар сарын 19-нөөс өндөр насны тэтгэвэрт гарсан, ам бүл ..., нөхрийн хамт амьдардаг, Орхон аймгийн ...багийн ...дүгээр байранд оршин суух, Алтан гадас одонтой, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, Т овогт Х.Ха (РД:ФМ.....)

13. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч, бизнесийн удирдлагын магистр, 2010 оны 04 дүгээр сарын 15-наас 2013 оны 01 дүгээр сарын 31 хүртэл "ЭҮ" ХХК-ийн Ерөнхий захирлын эдийн засаг эрхэлсэн орлогчоор ажиллаж байсан, одоо эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эхнэр, хүүхдүүдийн хамт амьдардаг, Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...байр ...тоотод оршин суух, төрөөс авсан гавьяа шагналгүй, урьд ял шийтгүүлж байгаагүй, хэрэг хариуцах чадвартай, И... овогт Б.Жал (РД:УЖ.....)

Яллах дүгнэлтэд тэмдэглэсэнээр шүүгдэгч нарын холбогдсон хэргийн талаар:

1.Шүүгдэгч Ч.Га нь

1.1. Татварын ерөнхий газарт ирсэн мэдээллийн дагуу 2006 оны 5 дугаар сард «ВАТТ» ХХК-д татварын хяналт шалгалт хийлгэж байх хугацаандаа албан тушаалынхаа байдлыг ашиглан өөрийн танил Ц.Со-оор дамжуулан «ВАТТ» ХХК-аас татварын улсын байцаагчийн актаар тавигдах нөхөн татвар, хүү торгуулийг багасгаж, хийх ёстой үйлдлээ хийхгүй байхаар амлан, хясан боогдуулах замаар ам долларын буюу 295.500.000 төгрөгийг нэхэж, онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан гэмт хэрэгт,

1.2. 2002 оны 02 сарын 15-ны өдрөөс

2013 оны 01 сар хүртэлх хугацаанд Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж тухайн албан тушаалын цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа хууль ёсны орлогоосоо гадна эцэг У.Чи-ийн нэр дээр өөрийн хамтран эзэмшдэг 110302XXXX тоот америк долларын данс нээж, 2008 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд 1.362.655.48 америк долларын буюу 1.771.358.017 төгрөгийн орлого, 1.207.415.2 америк долларын буюу 1.581.063.830 төгрөгийн зарлагын гүйлгээ, мөн У.Чи-ийн нэрээр 110503xxxx тоот төгрөгийн данс нээж 2010 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2013 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр хүртэлх хугацаанд 1.073.951.176,93 төгрөгийн орлого, 1.073.850.400,00 төгрөгийн зарлагын гүйлгээг тус тус хийж, уг мөнгөн дүнгээс АНУ-д амьдрах хүү Г.Газ-д их хэмжээний мөнгө шилжүүлж 2007 оны 12 сараас 2012 оны 07 сар хүртэлх хугацаанд Лексус 570 маркийн 3, Лексус 470 маркийн 2 автомашиныг Монгол Улсад оруулж ирсэн, Монгол Улсад явж байсан Ланд круйзер 200 маркийн 1, нийт 635 сая төгрөгийн үнэ бүхий 6 автомашиныг эзэмших болсон, 2012 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоот 257,8 м2 талбай бүхий амины орон сууцыг автомашины грашийн хамт 825.375.400 төгрөгөөр худалдан авсан, 2011, 2012 онуудад иргэн О-аас 2 ширхэг шүрэн толгойтой, манан хөөргийг нийт 58 сая төгрөгөөр худалдан авах зэргээр нийт 1.518.375.400 төгрөгийн эд хөрөнгийг олж, хууль бусаар хөрөнгөжсөн гэмт хэрэгт,

1.3. ТЕГ-ын Татварын хяналт шалгалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын ахлах байцаагч Б.Бу-ийн Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст шилжүүлэх байсан «АФ» ХХК-д татварын ногдуулалт, төлөлттэй холбоотой 3.747.357.3 мянган төгрөгийн төлбөр ногдуулсан актыг шилжүүлээгүй дарагдуулсан байхад Ч.Га нь татварын улсын байцаагчийн акт, дүгнэлтийг холбогдох байгууллагад шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулж хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Монгол Улсын төсөвт төвлөрөх байсан 3.747.357.3 мянган төгрөгийн онц их хэмжээний татварыг төлүүлээгүй албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэгт,

1.4. Татварын Ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргын албан

тушаалын байдлаа урвуулан, өөрийн төрсөн дүү Ч.Да-тэй үгсэн тохирч түүгээр 2010 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр татварын шалгалт хийлгэх тухай мэдээллийг Татварын Ерөнхий газарт гаргуулан улмаар өөрийн удирдлагад ажиллаж байсан татварын улсын байцаагч О.Бя, Б.Жа, Н.Чи, Б.Өс, Н.Ра, П.Га нараар «ХБЭ» ХХК, «ЭрЭ» ХХК, «БАЭ» ХХК, «ХЭ» ХХК, «КЖЭМ» ХХК, «ШЭ» ХХК-иудын татварын ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийлгүүлэн 13.398.688.100 төгрөгийн татварыг ногдуулалгүйгээр татварын байцаагчийн илтгэх хуудас, акт гаргуулан төсөвт төвлөрөх ёстой дээрх хэмжээний буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

1.5. Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-д 2010 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 26/123 тоот албан бичгээр «НТГ», «УМ» ХХК, «З.У» ХХК-иудын албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд яаралтай шалгалт хийлгэх албан бичгийг Баянгол дүүргийн татварын хэлтэст хүргүүлж, татварын улсын байцаагч томилуулан шалгалтыг хийлгэсэн,

1.6. Шалгалтаар татварын улсын байцаагч нар нэр бүхий аж ахуйн нэгжүүд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдсан буюу эрх шилжүүлсэн орлогыг нуусан гэж үзэж 2010 оны 02 дугаар сарын 25-ны өдөр «НТГ» ХХК-нд 6.974.495.000 төгрөгийн зөрчилд нь 260006 тоот дүгнэлтийг, «УМ» ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан нар 2.876.273.500 төгрөгийн ногдох орлогыг нуусан үйлдэлд нь 260007 тоот дүгнэлтийг, «З.У» ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан нар 975.852.500 төгрөгийн татвар ногдох орлогыг нуусан үйлдэлд нь 2010 оны 3 дугаар сарын 19-ний өдөр 260009 тоот дүгнэлтийг бичиж Эрүүгийн цагдаагийн газарт эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар хүргүүлсний дараа Ч.Га нь Үндэсний татварын албаны хяналт шалгалтын ажлын дүрмийн 2.3, 2.2.6-д заасан заалтуудын зөрчиж, татварын хяналт шалгалтын ажилд томилох томилолт бичих эрхгүй атлаа татварын улсын байцаагч Н.Ра, П.Га нарыг нэг нэгээр нь томилж “НТГ”, “УМ» ХХК-ийн татвар төлөлтийн байдлыг шалгуулж, татварын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзсэн илтгэх хуудас бичүүлж, Баянгол дүүргийн Татварын хэлтсийн даргаар ажиллаж байсан Д.Эн-д хүргүүлсний дагуу Д.Эн нь 2010 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 73 тоот тушаалаар 260006, 260007 тоот дүгнэлтүүдийг хүчингүй

болгож «ПС» ХХК буюу одоогийн «ПВР» ХХК-ийн татварт төлөх ёстой 1.021.587.453 төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлэлгүй онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

1. Шүүгдэгч Б.Бу нь

ТЕГ-ын Татварын хяналт шалгалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа Татварын ерөнхий газраас “АФ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж 2011 оны 7 дугаар сарын 08-ны өдөр татварын улсын байцаагчийн 9802034 тоот актаар нийт 3.747.357.3 мянган төгрөгийн төлбөр ногдуулж, Татварын Ерөнхий газрын маргаан таслах зөвлөлийн 2011 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45 тоот тогтоолоор уг актыг үндэслэлтэй гэж үзэн Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст шилжүүлэхээр шийдвэрлэсэн байхад дарагдуулж, хууль тогтоомж, журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлэлгүйгээр тус компанийн татвар төлөгч нарт татвар төлөхөөс зайлсхийх боломж олгож, Монгол Улсын төсөвт төвлөрөх байсан 3.747.357.3 мянган төгрөгийн онц их хэмжээний татварыг төлүүлээгүй, албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэгт,

2. Шүүгдэгч Д.Эн нь

3.1. Баянгол дүүргийн Татварын хэлтсийн даргаар ажиллаж байхдаа албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ээс ирүүлсэн “НТГ” ХХК, “УМ” ХХК, “З.У” ХХК-иудын албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд яаралтай шалгалт хийх тухай 2010 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 26/123 дугаартай албан бичгийг үндэслэн, тус дүүргийн татварын улсын байцаагч нараар дээрх компаниудад татварын хяналт шалгалт хийлгэж, шалгалтаар нэр бүхий аж ахуйн нэгжүүд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдсан буюу эрх шилжүүлсэн орлогыг нуусан гэж үзэж 2010 оны 02 дугаар сарын 25-ны өдөр “НТГ” ХХК-нд 6.974.495.000 төгрөгийн зөрчилд нь 260006 тоот дүгнэлтийг, “УМ” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан нар 2.786.273.500 төгрөгийн ногдох орлогыг нуусан үйлдэлд нь 260007 тоот дүгнэлтийг, “З.У” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан нар 975.852.500 төгрөгийн татвар ногдох орлогыг нуусан үйлдэлд нь 2010 оны 3 дугаар сарын 19-ний

өдөр 260009 тоот дүгнэлтийг бичиж Эрүүгийн цагдаагийн газарт хүргүүлсэн байхад Ч.Га нь өөрийн удирдлагад ажилладаг Н.Ра, П.Га нарыг нэг нэгээр нь томилж “НТГ”, “УМ” ХХК-ийн татвар төлөлтийн байдлыг шалгуулж, татварын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзсэн илтгэх хуудас бичүүлж хүргүүлснийг үндэслэж, Татварын Ерөнхий хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1-д заасны дагуу шийдвэрлэлгүй 2010 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 73 тоот тушаалаар татварын улсын байцаагчийн 260006, 260007 тоот дүгнэлтүүдийг хүчингүй болгож, 1.021.587.900 төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан, “З.У” ХХК-д холбогдох 260009 тоот дүгнэлтийг 2010 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 93 тоот тушаалаар тус хүчингүй болгож 197.780.800 төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулан давтан үйлдлээр нийт төсөвт төвлөрүүлэх 1.219.368.700 төгрөгийг төвлөрүүлээгүй буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

3.2. Голомт банкны 170501xxxx тоот төгрөгийн хувийн харилцах дансаар 2012 оны 05 дугаар сарын 01-нээс хойш он дуустал хугацаанд 53.900.000 төгрөгийн эх үүсвэр нь тодорхойгүй орлого олсон. Үүнд: 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 2.500.000 төгрөг, 2012 оны 05 дугаар сарын 21-ний өдөр 1.400.000 төгрөг, 2012 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 5.000.000 төгрөг, 2012 оны 06 дугаар сарын 20-ны өдөр 7.000.000 төгрөг, 2012 оны 07 дугаар сарын 09-ний өдөр 12.000.000 төгрөг, 2012 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр 22.000.000 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 4.000.000 төгрөгийг тус тус,

Голомт банкны 180129xxxx тоот ам долларын хувийн харилцах дансаар 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хойш 2012 он дуусах хүртэл хугацаанд 32.430 ам долларын эх үүсвэр нь тодорхойгүй орлого, үүнд: 2012 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 330 ам доллар, 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 17.100 ам доллар, 2012 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр 8.000 ам доллар, 2012 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 7.000 ам доллар буюу 45.113.500 төгрөг тус тус,

“НК” ХХК-тай 2012 оны 05 дугаар сарын 23-ны өдөр “Орон сууцны захиалга, хөрөнгө оруулалт”-ын КС127313... тоот гэрээний дагуу 493.822.000 төгрөгийн орон сууц худалдан авсан байх ба орлогын эх үүсвэр нь тодорхойгүй 592.835.500 төгрөгийн орлогыг

хууль ёсны орлогоосоо гадна олж хууль бусаар хөрөнгөжсөн гэмт хэрэгт,

3.3. Мөн 2008 онд 19.000.000, 2009 онд 241.750.000, 2010 онд 9.851.000, 2011 онд 139.322.500, 2012 онд 90.489.600 төгрөг буюу нийт 500.413.100 төгрөгийн орлого олсон атлаа хувь хүний орлогын татвар ногдуулах орлогоо татварт бүрэн тайлагнаагүй, татварт тайлагнах тоо хэмжээгээ зориуд бууруулан тайлагнан 50.041.300 төгрөгийн буюу онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэрэгт,

4. Шүүгдэгч Б.Жа нь

4.1. Цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хх-ххУНТ улсын дугаартай Лексус-470 маркийн автомашиныг 47.500.000 төгрөгөөр, 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...зусланд байрлалтай зуслангийн зориулалттай байшин, газрын хамт 39.000.000 төгрөгөөр тус тус худалдан авч, хууль ёсны орлогоосоо гадна нийт 86.500.000 төгрөгийн орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн гэмт хэрэгт,

4.2. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч комиссар Д.З-ын 2013 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн шинжээч томилох тогтоолын дагуу Д.Эн нарт холбогдох хэрэгт Д.Эн нь татвар ногдуулах орлого нуусан, татвар төлөхөөс зайлсхийсэн эсэх талаар шинжээчийн дүгнэлт гаргахдаа санаатайгаар 34.638.200 төгрөгийг бууруулан 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдөр 164 дугаартай шинжээчийн дүгнэлтэд 15.403.100 төгрөг төлөх талаар санаатай худал дүгнэлт гаргасан гэмт хэрэгт,

5. Шүүгдэгч П.Га нь Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт, Арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Ч.Га-ээс өгсөн томилолтын дагуу Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм”-ийн 2.2.6 “...Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш Татварын улсын /ахлах/ байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх...” гэсэн заалтыг зөрчиж ганцаараа “УМ” ХХК-ны татвар ногдуулалт төлөлтийг хянан шалгаж Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагч Г.Бая, Ж.На нар “УМ” ХХК-д татвар

ногдуулалт төлөлтийг шалган 2010 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эрх борлуулсан орлогын 2.786.273.500 төгрөгийн зөрчилд нь 260007 тоот дүгнэлт бичсэн дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзэж илтгэх хуудас бичиж, илтгэх хуудсыг Ч.Га нь баталгаажуулан Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-д хүргүүлж Д.Эн 2010 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 73 тоот тушаалаар Татварын улсын байцаагчийн дүгнэлт 260007 тоот дүгнэлтийг хүчингүй болгож “ПС” ХХК буюу “ПВР” ХХК-ийн төлөх ёстой 472.648.400 төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлээгүйн улмаас 472.648.400 төгрөг буюу онц их хэмжээний хохирол учруулсан,

“КЖЭМ” ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд татварын улсын байцаагч Б.Жа, Б.Өс нарын хамтаар шалгалт хийж тус компани нь 11.431.656.900 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад нь 2010 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр №10 дугаартай “Илтгэх хуудас” бичсэн нь Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу “...татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих...” гэсэн заалтыг зөрчиж, дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлээгүйн улмаас улсад 11.431.656.900 төгрөгийн буюу давтан үйлдлээр нийт 11.904.305.300 төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

6. Шүүгдэгч Н.Ра нь Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт, Арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Ч.Га-ээс өгсөн томилолтын дагуу Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм”-ийн 2.2.6 “...Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш Татварын улсын /ахлах/ байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх ...” гэсэн заалтыг зөрчиж ганцаараа “НТГ” ХХК-ны татвар ногдуулалт төлөлтөд шалгалт хийж Баянгол дүүргийн Татварын улсын байцаагч нараас шалгаад 2010 оны 02 дугаар сарын 25-ны өдөр “НТГ” ХХК-ийн 6.974.495.000 төгрөгийн зөрчилд нь 260006 дугаартай бичсэн дүгнэлтийг үндэслэлгүй гэж

илтгэх хуудас бичиж, илтгэх хуудсыг Ч.Га нь баталгаажуулан Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-д хүргүүлж Д.Эн 2010 оны 5 дугаар сарын 07-ны өдрийн 73 тоот тушаалаар Татварын улсын байцаагчийн дүгнэлт 260006 тоот дүгнэлтийг хүчингүй болгож «ПС» ХХК буюу «ПВР» ХХК-ийн төлөх ёстой 548.939.500 төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлээгүйн улмаас 548.939.500 төгрөг буюу онц их хэмжээний хохирол учруулсан,

-ганцаараа “БАЭ” ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж тус компани нь 217.700.600 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад нь 2010 оны 10 дугаар сарын 26-ны өдөр № 09 дугаартай “Илтгэх хуудас” бичсэн бөгөөд Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу “... татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих...” гэсэн заалтыг зөрчиж, дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлээгүйн улмаас улсад 217.700.600 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулж нийт 766.640.100 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэрэгт,

7. Шүүгдэгч Б.Өс нь Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм”-ийн 2.2.6 “...Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш Татварын улсын (ахлах) байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хий...” гэсэн заалтыг зөрчиж ганцаараа “ХБЭ” ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 489.998.900 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад нь 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдөр № 07 дугаартай “Илтгэх хуудас” бичсэн,

-Татварын улсын байцаагч П.Га, Б.Жа нарын хамтаар “КЖЭМ” ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 11.431.656.900 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад нь 2010 оны 11 дүгээр сарын 08-ны

өдөр №10 дугаартай “Илтгэх хуудас” бичсэн бөгөөд Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу “...татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих...” гэсэн заалтыг зөрчиж, дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлэлгүй, давтан үйлдлээр төсөвт 11.921.655.800 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

Шүүгдэгч Н.Чи нь Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан «Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм»-ийн 2.2.6 «...Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш Татварын улсын (ахлах) байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх...» гэсэн заалтыг зөрчиж ганцаараа «ХЭ» ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 896.964.100 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийснийг илрүүлсэн атлаа 2010 оны 11 дүгээр сарын 01-ийн өдөр № 980020 дугаартай «Татварын улсын байцаагчийн акт» бичсэн бөгөөд Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу «...татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих...» гэсэн заалтыг зөрчиж, дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлээгүйн улмаас төсөвт 896.964.100 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

9. Шүүгдэгч Б.Жр нь Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үндэсний Татварын албаны

татварын хяналт шалгалтын ажлын дүрэм"-ийн 2.2.6 "...Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш Татварын улсын /ахлах/ байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх..." гэсэн заалтыг зөрчиж ганцаараа "ШЭ" ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 46.900.800 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад нь 2010 оны 10 дугаар сарын 26-ны өдөр №06 дугаартай "Илтгэх хуудас" бичиж,

Татварын улсын байцаагч П.Га, Б.Өс нарын хамтаар «КЖЭМ» ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 11.431.656.900 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад нь 2010 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр №10 дугаартай "Илтгэх хуудас" бичсэн бөгөөд Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу «...татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих...» гэсэн заалтыг зөрчиж, дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлэлгүй, давтан үйлдлээр төсөвт нийт 11.478.557.700 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан,

10. Шүүгдэгч О.Бя нь Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт Арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм"-ийн 2.2.6 "...Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш Татварын улсын (ахлах) байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх ..." гэсэн заалтыг зөрчиж ганцаараа "ЭрЭ" ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, 315.476.800 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад нь 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдөр №08 дугаартай "Илтгэх хуудас" бичиж Монгол Улсын Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу "... татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн

хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих..." гэсэн заалтыг зөрчиж, дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлээгүйн улмаас төсөвт 315.476.800 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

11. Шүүгдэгч Ч.Да нь

11.1. "ЭҮ" ХХК-ийн Ерөнхий захирлын эдийн засаг эрхэлсэн орлогчоор ажиллаж байсан Б.Жал, Ерөнхий нягтлан бодогчийн орлогч Х.Ха нартай бүлэглэн, "СА" ХХК-ийн нэрээр ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр "ЭҮ" ХХК-ийн Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээний №5/426-11 дугаартай гэрээг байгуулан, зөвлөх үйлчилгээний тайлан гаргаж уг үйлчилгээний хөлсөнд 78.623.341 төгрөгийг авахаар байхад 626.120.000 төгрөгийг шилжүүлэн авч, 547.496.659 төгрөгийг илүү завшсан,

-мөн Санхүүгийн сургалт явуулах боловсон хүчний боломжгүй хэрнээ 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 5/336-12 дугаартай 48,0 сая төгрөгийн үнэ бүхий, "ЭҮ" ХХК-ийн нягтлан бодогчдод нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлан бэлтгэлтийн талаар сургалт явуулах тухай гэрээг байгуулан, 38.400.000 төгрөгийг шилжүүлэн авсан боловч гэрээний үүргийг өөр аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж, "ЭҮ" ХХК-тай байгуулсан гэрээний үнийн дүнгээс 20.400.000 төгрөгийг завшиж онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

11.2. Мөн төрсөн ах Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байсан Ч.Га-тэй үгсэн тохиролцож, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсээс төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу "КЖЭМ" ХХК болон хамаарал бүхий "ХБЭ" ХХК, "ЭрЭ" ХХК, "БАЭ" ХХК, "ХЭ" ХХК, "ШЭ" ХХК-иудад татварын шалгалт хийгдэж эхлэх үед буюу 2010 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Татварын ерөнхий газарт иргэн Р.Ба-ын нэрээр дээрх компаниудын татвар ногдуулалт төлөлтийн байдалд хяналт шалгалт хийлгүүлэх талаар хуурамч гомдол хүргүүлж, улмаар төрсөн ах Ч.Га нь албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн байцаагч нарын хийж байсан шалгалтыг зогсоож, өөрийн удирдлагад ажилладаг татварын улсын байцаагч нараар дээрх нэр бүхий аж ахуйн нэгжүүдийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт

шалгалт хийлгэж, 13.398.688.100 төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй улмаас төсөвт онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

12. Шүүгдэгч Х.Ха нь “ЭҮ” ХХК-ийн Ерөнхий захирлын эдийн засаг эрхэлсэн орлогчоор ажиллаж байсан Б.Жал-тай бүлэглэн “СА” ХХК-ийн захирал Ч.Да-д давуу байдал олгон, албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 36,37,38 дугаар зүйлүүдийг зөрчиж, «СА» ХХК-тай 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр «ЭҮ» ХХК-ийн Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээний №5\426-11 дугаартай гэрээг байгуулж, гэрээний заалтын дагуу ажлын хөлсийг тооцон олгохдоо үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн 547.496.659 төгрөгийг илүү олгосон гэмт хэрэгт,

-мөн Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлан бэлтгэлтийн талаар сургалт явуулах боловсон хүчний боломжгүй “СА” Ххк-аар дээрх сургалтыг явуулахаар 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн №5/33.-12 дугаартай гэрээг 48.000.000 төгрөгийн төсөвт өртөгтэйгээр, ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр шууд байгуулан, гэрээний урьдчилгаанд 38.400.000 төгрөгийг шилжүүлэн 20.400.000 төгрөгийг завших боломжийг олгон, байгууллагын хөрөнгийг онц их хэмжээгээр үрэгдүүлсэн гэмт хэрэгт,

13. Шүүгдэгч Б.Жал нь “ЭҮ” ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогчийн орлогч Х.Хат-тэй бүлэглэн “СА” ХХК-ийн захирал Ч.Да-д давуу байдал олгон, албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 36,37,38 дугаар зүйлүүдийг зөрчиж, “СА” ХХК-тай 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр “ЭҮ” ХХК-ийн Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээний №5/42.-11 дугаартай гэрээг байгуулж, гэрээний заалтын дагуу ажлын хөлсийг тооцон олгохдоо үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн 547.496.659 төгрөгийг илүү олгосон,

мөн Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлан бэлтгэлтийн талаар сургалт явуулах боловсон хүчний боломжгүй «СА» Ххк-аар дээрх сургалтыг явуулахаар 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн №5/336-12 дугаартай гэрээг 48.000.000 төгрөгийн

төсөвт өртөгтэйгээр, ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр шууд байгуулан, гэрээний урьдчилгаанд 38.400.000 төгрөгийг шилжүүлэн 20.400.000 төгрөгийг завших боломжийг олгон, байгууллагын хөрөнгийг онц их хэмжээгээр үрэгдүүлсэн гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Шүүх хуралдаан дээр шүүгдэгч нараас мэдүүлэхдээ:

1. Ч.Га-ээс: Намайг “ВА” компаниас мөнгө завшхыг завдсан гэсэн зүйл ангиар ял сонсож байгаа. “ВА” компанитай холбоотой асуудал дээр 8 гэрчийн мэдүүлэг бичигдсэн байсан. С.Ба, Ц.Со гэдэг 2 гэрч намайг мөнгө авахаар завдсан гэсэн. Энэ 2 гэрч намайг их олон жил гүтгэж ирсэн. Ц.Со-той би их олон жилийн өмнөөс харьцаа муудсан байсан. С.Ба-тай мөн харьцаа муудсан байсан. Надад өс хонзон санасан 2 гэрчийн мэдүүлгээр намайг яллаж байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна. Р.Ар анх мэдүүлэг өгөхдөө Ч.Га хээл хахууль аваагүй гэж мэдүүлэг өгч байснаа 2013 онд Авлигатай тэмцэх газар мэдүүлэг өгөхдөө Ч.Га авсан мэтээр мэдүүлэг өгсөн байсан. “ВА” компаниас хээл хахууль авахыг завдсан гэсэн хэргээр Татварын ерөнхий газар хүсэлт гаргасан. Тэгсэн энэ хэрэг тогтоогдохгүй байна гэж байснаа сүүлдээ Ч.Га болж хувирсан. Тэгсэн сүүлдээ Р.Ар болж хувирсан. Тэгээд дараа нь Н.Бт, дараа нь н.Зо болж таарсан. Р.Ар гэж хүн 2 удаа мэдүүлэг өгсөн байдаг. Анх 2006 онд мэдүүлэг өгсөн. Дараа нь 2013 оны 06 сард мэдүүлэг өгсөн. Энэ мэдүүлэгтээ Ч.Га хээл хахууль нэхсэн талаар нэг ч яригдаагүй. Харин Ц.Со гэж хүн хээл хахууль нэхсэн гэж мэдүүлэг өгсөн байдаг. Тэгээд Ц.Со-г сэжигтнээр татаж эхлээд 2013 оны 06 дугаар сарын 14-нд хөөн хэлэлцэх хугацаа дууссан гэж хэргийг хэрэгсэхгүй болгосон байсан. “ВА” компани дээр маш их хэмжээний зөрчил илрүүлсэн. Үүнийг Сангийн сайдад хэлж байсан. Мөн Ж.М гэж хүн миний эсрэг мэдүүлэг өгсөн. Энэ хүн Татварын ерөнхий газар байцаагч хийдэг байсан. 2006 онд ажлаасаа гарсан санагдаж байна. Даргын тушаал гараад ажлаас халагдсан гэдгээ намайг эрх ашгийг нь хөндсөн мэт хэлсэн байсан. Төрийн аль ч байгууллага иргэдийн мэдээллийг илээр мэдээлдэг. Хяналт шалгалтын хэлтсээр ордог. Орлогын хэмжээг нуусан, нуун дарагдуулсан гэсэн. Нууцлагдаагүй мэдээллийг ердийн журмаар шалгаж шийдвэрлэнэ гэж заасан. Мөн гэрч Ч.Эн гэх хүн өөрөө 85 хоног ажиллаж,

намайг ажлаасаа өөрчлөгдөхөд миний дараа томилогдсон байсан. Энэ хүн мөн миний эсрэг мэдүүлэг өгөөд явж байсан. Мөн намайг Н.Бт гэж хүнтэй найз гэсэн байсан. Би энэ хүнийг огт танихгүй, хэн хэнийгээ ямар учиртай шалгуулсан гэдгийг мэдэхгүй байна. Би анх 2005 оны 5 дугаар сард ажлаасаа өөрчлөгдсөн. Тэгээд шүүхэд хандаж 10 дугаар сард миний ажлаас өөрчлөгдсөн нь үндэслэлгүй байна гэсэн шийдвэр гарсан. 2006 онд намайг ажилд эргүүлэн томилсон. Байцаагч нар 85 мянган долларын зөрчил илэрсэн гэж хэлсэн байдаг. Тэгэхэд Ч.Эн дарга уурлаад шалгалтаа одоо дуусга гээд дэд дарга Н.Бт дээр орсон. 2006 оны 7 дугаар сарын 5-ны өдөр танилцуулга дээрээ энэ тухай дурдсан байгаа. Ингээд 2006 оны 12 сар гэхэд их хэмжээний акт гарсан. Ч.Эн даргад эх хувиар, Н.Бт даргад хуулбар хувиар өгч байсан. Ингээд үүнийг Ч.Эн дарга, Н.Бт дарга, мөн шалгалт хийсэн 2 байцаагч мэдсэн байхад би аргалах боломж байхгүй. Надад тийм бөх зүрх ч байхгүй. 7 дугаар сарын 20-ны өдөр дүгнэлт гарсан, 7 дугаар сарын 4-ний өдөр дэд дарга Ариунсан гэж хүн дээр С.Ба бид хэд ороод гарах гэхэд С.Ба намайг мөнгө нэхсэн гэж хэлсэн. Би үүний дагуу 7 дугаар сарын 10-нд гомдол гаргаж байсан. Р.Ар гэж "ВА" компанийн менежер хүн С.Ба-д аргалаад өгье гэж хэлсэн үнэн үү гэхэд үгүй ээ тийм зүйл байхгүй гэж хэлсэн. Мөн намайг гүтгэж байна би ажлаасаа гаръя гэдэг хүсэлт хүртэл гаргаж байсан. С.Ба-тай таардаггүй гэсэн мэдүүлэг байгаа. 2007 оны 05 сард Р.Ар гэрчээр мэдүүлэг өгөхдөө мөн хэлсэн байгаа. 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдөр гэрчээр мэдүүлэг өгөхдөө Ц.Со тухайн үед надад үнийн дүн хэлж байгаагүй гэж хэлсэн. 2013 оны 06 дугаар сарын 05-ны өдөр мөн мэдүүлэг өгөхдөө Ч.Ж байцаагч тулгасан, шахсан асуулт тавьсан байгаа. Үүнийг сайн анхаарч үзнэ үү. Хүнийг хэрэгт хийхгүй гээд хамаагүй зүйл яриагүй гэж хэлсэн байдаг. Ц.Со гэж хүн 2006 онд мөрдөн байцаах газар мэдүүлэг өгөхдөө Р.Ар манай компани дээр шалгалт ирсэн байгаа аргалж өгөөч гэж байсан би тоглоом шоглоом болгоод аргалж өгвөл 10-30% шагнал авдаг гэсэн шүү гэсэн мэдүүлэг байгаа. 2013 оны 06 дугаар сарын 05-ны өдөр мэдүүлэг өгөхдөө Ч.Га гэж хүнтэй танилууд байсан гэж хэлсэн байдаг. Хүмүүсийн яриаг дамжуулсан гэсэн байгаа. 2013 оны 06 дугаар сарын 11-ний өдөр сэжигтнээр татсан боловч хэрэгсэхгүй болсон. Энэ үед Р.Ар-ыг жийсэн

байгаа. Татварын ерөнхий газраас шалгалт орж байгаа юм уу гэхэд Ч.Га Р.Ар-ын утасны дугаарыг өгсөн гэсэн. Ц.Со гэж хүн Р.Ар-д хэлээд Р.Ар нь С.Ба-д хэлсэн гээд, С.Ба Ч.Га юм болов уу гэж таамагласан гэж хэлсэн байгаа. С.Ба хэлэхдээ Ч.Га үндэслэлтэй гэж тайлбарласан гэсэн. Намайг энэ хүмүүс гүтгээд байна. Хавтаст хэрэгт дандаа яллах талын нотлох баримтууд байгаа. Цагаатгах талын баримтуудыг цуглуулаагүй. Цагаатгах талын нотлох баримтуудыг өмгөөлөгч нар цуглуулах гэхэд Татварын газраас цагаатгах баримтуудыг гаргаж өгөхгүй байсан. Дээд шүүхийн тогтоол болон бусад нотлох баримтууд зөндөө байсаар байхад үүнийг хавтаст хэрэгт хавсаргаагүй.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹.2 гэсэн зүйл анги дээр Дээд шүүхийн тогтоол байгаа. Үүнийг зөрчсөн. Энэ зүйл ангид онц их хэмжээгээр орлого олсон, орлогын эс үүсвэргүй гэсэн байгаа. Энэ хууль Монгол улсад анх удаа хэрэгжиж байгаа хууль. Ч.Да бид 2 аавд хэлдэг байсан. Энэ хүнээс өөр татварын тайлан гаргадаг хүн байдаггүй байсан. Ч.Да өөрөө гарын үсэг зурсан гэж буруутах байх. Дансанд байгаа мөнгийг нь аав, ээж, Ч.Да ч мэдэж байгаа. Өөр хүн мэдэхгүй. Бид нар аавтай ярилцаад хөрөнгийн данс нээсэн. Энэ данс У.Чи гэж нэр дээр байсан. Дараа нь төгрөгийн данс нээсэн. Үүн дээр миний гарын үсэг байхгүй. Манайх социализмын нийгмийн үед хөрөнгөтэй байсан. Манай аав н.З Москвич машинтай, 3 гэртэй байсан. Би социализмын нийгмийн юм ярьж байна. Байрыг худалдан авсан гэрээн дээр миний нэр байхгүй. Миний аавын нүд нь 2012 онд муудаад бүх малаа зарсан. Гэрийхэнтэй зөндөө ярьсны эцэст хотод шилжүүлж ирье гэж ярьсан. Тэгээд хотод байр авсан. Миний том хүү АНУ-д 8 жил болсон, англи хэлтэй, байр авах асуудал дээр миний хүү л очиж уулзсан. Би нэг удаа л хамт очиж, хуучин тавилгуудаа зараад үнээ буулга гэж хэлж байсан. Өөр зүйлд би оролцоогүй. Манай гэрт засвар хийж байсан, тэгээд л ээж аавындаа байсан. Манай хүү сургуулиа төгсөөд ирэх гэж байхад мөнгө шилжүүлсэн. 2007 оноос мөнгө шилжүүлсэн, 5 машин оруулж ирсэн нь үнэн. Би өмнө нь пааз автобустай бурхан болсон дүүгээрээ бариулаад тээвэр хийдэг байсан. Германаас машин оруулж ирж байсан. Ланд 105 машиныг би худалдаж авч байсан. Үүнийг зараад өөр машин авч байсан. Миний эхнэр Япон улсад цалинтай

ажил хийдэг байсан. Би төрд 30 жил 6 сар ажилласан. Би энэ хугацаанд 2 хөөрөг авах мөнгөтэй болж чадахгүй байх уу. Манай аав 80 гарсан настай хөгшнийг 6 дугаар сарын 22-нд хагас сайн өдөр ганцааранг нь суулгаж байгаад байцаалт аваад гарын үсэг зуруулсан, манай аавын нүд нь юм харахгүй байсан хүн. Цагаатгах талын баримтыг цуглуулаагүй, 1,5 тэрбум төгрөг хаачсан бэ гэдгийг тогтоолгомоор байна. Аавын олсон энэ мөнгийг тогтоогооч.

Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйл анги дээр Р.Ба ийм акт үйлдээгүй, санхүүгийн тайлан эд хөрөнгө битүүмжилсэн талаар бүх нотлох баримт дээр Р.Ба нэг ч баримт бичиг байхгүй. 2011 оны 7 сард энэ актыг үйлдэхдээ Монгол улсад бүртгэлтэй гэсэн байгаа. 2011 оны 09 сард ерөнхий захирал нь Монгол Улсаас гараад явсан. Захирал нь 40 хоногийн дараа гараад явсан. 10 дугаар сарын 14-нд батлагдсан тогтоол маань 20 хоногийн дараа ерөнхий газар очсон байгаа. Ерөнхий захирлыг хилээр гарснаас хойш 51 хоногийн дараа манай хэлтэс дээр ирсэн. Би дарагдуулсан биш маргаан таслах комисс дарагдуулсан. Байхгүй заалтыг байгаа мэт хэлсэн, ямар хууль тогтоомж дүрэм журмаар тодорхойлсон бэ гэдэг сонин байна. Энэ тушаалаар батлагдсан 6.1-д Татварын ерөнхий газар хууль тогтоомж маргаан таслах комисс, маргаан гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх зохион байгуулах гэж заасан. Хүнийг яллах гээд цагаатгах баримтыг өгөхгүй байна. Татварын хуулийн 11.2-т татвар алданги тооцно гэж заасан байгаа. 45 тоот тогтоол 7 сарын дараа хууль эрх зүйн газар хүргүүлсэн байдаг. Үүнийг хүргэх ёсгүй. 6 сар болоод ийм шийдвэр болсон гэдэг манай хэлтэст буруу байхгүй. Татварын ерөнхий газрын үр дүн хууль тогтоомжийн дагуу хийх ажлыг нь заасан байгаа. Тэгсэн мөртлөө хугацаа заасан байгаа. Нэг жилд гэж заасан байгаа.

Өөрийн төрсөн дүү Ч.Да-тай үгсэн тохирч онц их хэмжээний хохирол учруулсан гэсэн байгаа. Үүнийг тогтоогдохгүй байна гэж үзэж байна. Ганцаараа шалгалт хийсэн гэж үзэж байгаа бол би ганцаараа 100% хариуцлага хүлээх ёстой. Ганцаараа шалгалт хийсэн бол миний тушаалаар хийсэн байгаа. Ч.Да-тэй үгсэн тохирч гэсэн зүйл хэсэг бүлэг хүмүүсийн зориудын үйлдэл гэж үзэж байна. Хэзээ, хаана, юу гэж үгсэн тохирсон, хэн гэрчилж байна гэдгийг тогтоосон зүйл байхгүй. Хяналт шалгалт хийсэн 6

байцаагчийг сайн шалгаарай гэж үүрэг даалгавар өгсөн гэж хэлсэн. Шинжээчийн дүгнэлт ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж байгаа. Шинжээч нар шүүхийн шинжилгээний тухай хуулийн бүх заалтыг зөрчсөн байгаа. Тогтоол дээр 19 хүний нэр байгаа. Тогтоол гарснаас хойш сүүлд нь гарын үсэг зуруулсан байгаа. Шинжээчийн дүгнэлтээр тогтоолд нэрийг нь заагаагүй байгаа. Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс үүнийг шалгаагүй. Бүх хүмүүст нь танилцуулж байхыг үүрэг болгодог байгаа. Хууль эрх зүйн үндэсгүй гэж үзэх юм бол ахин шалгадаг. 2 сар шахам шалгаагүй, ажлын нэг өрөөг цоожлоод явж байсан гэж гомдол гаргаж байсан. Тэгсэн өнөөдөр өөр юм яриад явж байна. Шинжилгээ хийх хугацааг тогтооно гэж заасан байгаа. 24 хүнийг ажиллуулахаар заасан, ажиллуулах хугацааг сунгаагүй. Хүчин төгөлдөр бус тогтоолоор дүгнэлт хийсэн. Мөн хуулийн 14.1 шинжилгээг тал бүрээс нухацтай хийх ёстой гэснийг зөрчсөн. Татварын хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байна гэснийг бас зөрчсөн байгаа. Харилцан хамааралтай гэж дүгнэлт гаргасан. Өөрийнх нь хөрөнгөөс гаргуулах ёстой байдаг. Шинжээчид хориглох зүйл гэж байгаа. Ч.У, З.Э нар нэмэлт өөрчлөлтөөр биш гээд байгааг мөн болгоод шалгаад байгаа. Мөн шинжилгээ хийлгэж байгаа этгээдэд нэн даруй мэдэгдэнэ гэж заасан байгаа. Мөн шинжээчийн дүгнэлтэд бодит үр дүнг тусгасан байх ёстой. Энэ бүгдийг шинжээч нар зөрчсөн. Баянгол дүүргийн шинжээчийн дүгнэлт аль зэрэг үндэслэлтэй вэ гэсэн асуудал байгаа. Шилжүүлэн худалдсан хувьцааны Баянгол дүүргийн татварын хэлтсийн дүгнэлтийг шинжээч нараас тулгаж асуусан байсан. Татварын хуулийн дагуу илтгэх хуудас бичүүлсэн байдаг. 2011 оны 11 дүгээр сарын 22-нд мэдээлэл солилцох журам батлагдсан байгаа. Үүнийг шинжээч нар дүгнэлтдээ дурдсан байсан. 2005 оны зүйлийг 2010 онд тооцоод байгааг ойлгохгүй байна гэв.

Шүүгдэгч Д.Эн-аас: -Намайг Эрүүгийн хуулийн 263.2, 166.2 гэсэн зүйл анги дээр гэм буруутайд тооцоод байгаа. Энд цугларсан хүмүүсийн 35% нь татварын хүмүүс байна. Улсын төсвийн орлогыг бүрдүүлэх эрхэм үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсээс хүлцэл өчье. 2009 оны 04 дүгээр сарын 06-нд Баянгол дүүргийн татварын даргаар томилогдсон. Ажил авахад үйл ажиллагаа алдагдсан байсан. Ажил хүлээж аваад татвар төлөгч, хяналт шалгалтыг жигд явуулахад

анхаарч ажилласан байгаа. 13.500 орчим татвар төлөгчтэй байсан боловч 67% хувь нь татвар төлдөггүй байсан. Үйл ажиллагаа явуулдаггүй, оршин суугаа хаягтаа байдаггүй байсан. Идэвхтэй хэсэг нь 33% байсан. Төлөвлөгөөгөө биелүүлэх үүднээс татвар төлдөг хэсгээсээ ахин мөнгө авсан байсан. Үүсгэн байгуулагч нарыг олж тогтоон улсын бүртгэлийн албанд өгсөн. Татвар төлөгч нар маань өөрсдийнхөө хүсэлтээр татан буугдах хүсэлт ирүүлдэг байсан. Асар том ашигт малтмалын ордтой газар ч энэ дотор байсан. Манай байцаагч нар “БЦ” компанид татвар ногдуулсан. Үүнийг хүлээн зөвшөөрөхгүй захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргасныг шүүхээс “БЦ” компани татвар төлөх үндэсгүй байна гэж шийдвэр гарсан. Яг үүний адил их олон компани хүсэлт гаргасан. Үүн дотор “НТГ”, “УМ”, “Үа” гэх мэт компани байсан. “ПР” компани мөн байсан. Татварын байцаагчтайгаа ярилцаад “ПС” компанид хяналт шалгалт хийхээр өгсөн байгаа. Үүний талаарх баримтуудыг өмгөөлөгч нар шинээр гаргаж өгсөн баримтдаа өгсөн байх. Зөрчил дутагдал илэрсэн байна. Үүнийг лицензийн ногдох албан татварыг зөрчин олгосон байж магадгүй. Улсын төсвийн дагуу хяналт шалгалт хийж өгнө үү гэж 2009 оны 12 дугаар сарын 04-ний өдөр хандсан. Ч.Га-д мөн утга агуулга нэг хандсан байгаа. Татварын ерөнхий газрын даргад хандсан тоот Т гэж даргад очсон байсан. Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх газрын даргад 5 компанийн асуудлаар хандсан. Дэд хурандаа Д явуулсан материалыг Эрүүгийн цагдаагийн газар шилжүүлсэн байдаг. 2010 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Баянгол дүүргийн татварын хэлтэст яаралтай шалгалт хийж хувийг эрүүгийн цагдаагийн газарт гэсэн байгаа. Би 2010 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр ажилбарт гэж хийгээд өгсөн. 2010 оны 3 дугаар сарын 21-нд өгсөн байгаа. Манай байцаагч нарт буруу үндэслэлээ гаргасан байна гэсэн байсан. Ш.На ашигт малтмалын хувьцаагаа юм уу татвараа ногдуулсан байсан. 2010 оны 3 дугаар сарын 23-ны өдөр “УМ”, “Н” компани дээр хяналт шалгалт хийхээр шилжүүлсэн. Баянгол дүүргийн татварын тасгийн дарга Д.Бр н.Ч-д хүргүүлсэн байдаг. 2010 оны 3 дугаар сарын 19-ний өдөр бичигдсэн дүгнэлтийг сарын дараа н.Ч-д хүргүүлсэн байдаг. Үүнийг би уншсан. Манай байцаагч үндэслэлгүй акт тавьсан зүйл харагдаж байсан. Төлөх ёстой гэж үзсэн бол “ПР”

компани байх ёстой байсан. Уг асуудлаар татварын хяналт шалгалтын арга зүйн дарга надтай утсаар яриад татварын улсын байцаагч нартай хариуцлага тооц гэж хэлсэн. Нийслэлийн прокурорын газраас 2010 оны 5 дугаар сарын 06-ны өдөр С.Х прокурор эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байсан. Татварын ерөнхий газрын 73 тоот тушаал гаргаж “УМ” компанид хамаарагдах хэсгийг хүчингүй болгосон. Татварын ерөнхий хуульд доод шатны албан тушаалтан дээд шатны албан тушаалтанд шууд захирагдана гэж заасан. Татварын улсын байцаагчийн актыг хүчингүй болгох 3 субъект байдаг. Татварын ерөнхий газрын дарга хамааралтай. Арга зүйгээр хангаж өгөөч гэсэн байсан. Уг асуудлыг хуулийн байгууллагаар шалгуулахаар өөрөө санаачлаад хуулийн байгууллага руу явуулсан. Яагаад “ПС” компани дээр шалгалт хийгээгүй юм бэ. Татварын улсын байцаагчаас 3 акт гардаг байгаа. Би шийдвэр биелүүлсэн гэж ойлгож байгаа. Хуулийн байгууллагын шийдвэр дээд удирдлагын гаргасан шийдвэрийг биелүүлсэн. Д.Бр гэж хүн хяналт шалгалтын газрын дарга байсан. “ПС” компани томоохон татвар төлөгч байсан. Д.Бр тоотыг хянаагүй эс үйлдэл гаргасан байгаа. Өөрийнх нь шалгаж байсан компани болохоор ийм зүйл хийсэн. Мөрдөн байцаалтад Д.Бр зөрүүтэй мэдүүлэг өгсөн байсан. Хэлэлцүүлгийн явцад өөрийнх нь гэм буруутай холбоотой үйлдэл ч гарч ирж болзошгүй байгаа. Эрүүгийн цагдаагийн газар дүгнэлт гарснаас хойш 3 сарын дараа гарсан. Би хууль хяналтын газраар шалгуулахаар хүргүүлсэн байгаа. Би 5 компанийн асуудал яриад байгаа. Д.Бр өөрийнхөө нэрээр Эрүүгийн цагдаагийн газар тоот явуулах эрхгүй. Энэ асуудлыг Д.Бр сайн мэдэж байгаа. Төсвийн үүргийн биелэлт биелэх нь л гол асуудал байсан.

Эрүүгийн хуулийн 270¹.2 гэсэн зүйл анги дээр манай гэр бүл сэхээтний гэр бүл. Манай аав насаараа цагдаа хийсэн. Ээж маань багш байсан. Сонгинохайрхан дүүрэгт манай аав 4 өрөө байр авч байсан. Манайд ийм л хөрөнгө байсан. Миний орлогын эх үүсвэр 1990 оноос эхтэй. Манай 2 эгч Орост сургуульд явсан. Дундуур нь наймаа хийдэг байсан. Үүнийг нь би монголд зардаг байсан. 1992 онд би их дээд сургуульд орсон. Сургуулиасаа жилийн чөлөө аваад хадам ахтайгаа наймаанд явдаг байсан. Би хар зах дээр наймаа хийдэг байсан. Миний наймааны эх сурвалж үүнээс хамааралтай. Манай ээж 4 өрөө байраа

зараад 2 өрөө байр авч, наймаа хийж олсон мөнгөн дээрээ нэмээд би 2 өрөө байр авч байсан. Сургуулиа төгсөөд эдийн засгийн албанд төлөөлөгч хийж байгаад үндэслэлгүй цагдаагаас халагдаж, би шүүхэд хандан нэр төрөө сэргээлгэсэн. Тэгээд би хөрөнгө оруулалт хийж “АБ” гэдэг компани байгуулж, тухайн үеийн бизнесийн үр ашгаар би амьдарч байгаа. Баянгол дүүргийн 4 дүгээр хороонд байрлах оффис, гараж худалдаж авч байсан. 2004 онд Яргайтад зуны сууц, 2007 онд Сонгинохайрхан дүүрэгт 125 м2 газар авсан. Мөн өөрийнхөө хүүгийн нэр дээр 250 сая төгрөгийн хугацаатай хадгаламж нээлгэж байсан. 2005 онд манайх шинэ хүнтэй болсон. Тэгээд компани зарсан байгаа. Татварын хэлтсээс шалгалт зарлаад би шалгалт өгч тэнцээд, ажилд орж байсан. Авлигатай тэмцэх газраас шалгалт ороод намайг газар, байр нуусан байна гэсэн. Хөрөнгө орлогын мэдүүлэг дээр би бүх хөрөнгөө бичсэн. Хөрөнгө орлогын мэдүүлгийг тухайн үед сайн ойлгодоггүй байсан. Би өөрөө LEXUS-470 маркийн машин унадаг байсан. Би анх “ЖМ” компанид хөрөнгө оруулалт хийсэн. Үүний дагуу ашгаа надад өгсөн. 2012 онд манайх шинэ хүнтэй болох гээд шинэ байранд орох болж, тавилганы мөнгөө гаргаж авъя гээд Америк улс руу 4 ширхэг LEXUS-570 маркийн машин захиалж, машинаа Саруул зах дээр байрлуулж зарсан. Манай найз 2 машиныг нь зарсан, би нийт 5 машин борлуулсан, нэг машинаа авга ахынхаа хүүд зарсан. Тохирсноос хойш манай байрыг зарсан байсан. Нэг машин 125 мянган доллараар зарсан байгаа. БЭ гэж хүнтэй энэ бизнесийн талаар ярьсан. Би Герман стандартаас 210 ам.доллар авсан байгаа. Нийт 5 машин маань 774 сая төгрөг болсон. Би мөнгөө 2012 оны 06 дугаар сараас цувуулж авсан. Би эхнэрийнхээ хуучин машиныг өгөөд дээр нь 80 сая төгрөг нэмж өгөөд шинэ LEXUS-570 маркийн машин авсныг хууль бус үндэслэлээр олсон гэсэн байгаа. 2012 оны 05 дугаар сарын 01-нээс 53.9 сая төгрөг, долларын дансаар мөн мөнгө олсон гэж Б.Ал мэдүүлсэн байгаа. 2012 оны 05 дугаар сарын 01-нээс хойш Голомт, Хаан банкнаас 217 сая төгрөг гаргасан байна. Би хүүтэй, хүүгүй мөнгө зээлдэг байсан. 2012 оны 05 дугаар сарын 01-нээс хойш 738 сая төгрөг аваад буцаагаад тушаасан байна. Анх би 500 сая төгрөгтэй байсан. Үүн дээр “ЖМ” компаниас 300 сая төгрөг авсан. 2012 оны 06 дугаар сарын 20-нд 7 сая төгрөг гэсэн байгаа. 2012 оны 05

дугаар сарын 24-ний өдөр илүү дутуу мөнгө авч яваагүй. Надад нуусан мөнгө байхгүй. Татварын албанд ороход намайг хувийн бизнес хийдэг байсан гэдгийг мэдэж байсан. 18 мянган доллар авснаа би тушаасан. 2012 оны 12 дугаар сарын 25-нд Голомт банкнаас мөнгө гаргасан байгаа. Би томоохон бизнес хийдэг, найз нартаа ч мөнгө зээлдэг байсан. Америк улс руу машин захиалсан. Д.Г-ын захиалсан машиныг би өөрөөсөө мөнгө шилжүүлээд өгсөн, дараа нь Д.Г мөнгөө над руу шилжүүлсэн. Үүнийг шинжээч нар миний хөрөнгө гэж дүгнэлт гаргасан. Энэ талаар нэг ч тайлбар надаас аваагүй. Д.З байцаагч өөрийнхөө утга санаагаар найруулж бичдэг байсан. Сүхбаатар дүүргийн татварын улсын байцаагчийн акт үндэслэлтэй байсан уу гэдгийг шинжээч нар нэг нь ч хариулаагүй байсан. 2008 онд татвар ногдуулах байсан. Би зардлаа хасаад тэр 10 сая төгрөгийг шууд оруулсан байсан. Би энэ ажил үүргээ бүрэн тайлагнасан байгаа. 2009 онд хөрөнгө орлогын мэдүүлэг дээр надаас тайлбар авах ёстой байсан. 2008 оны хөрөнгө орлогын мэдүүлэг дээр бичсэн зүйлийг хэлсэн байсан. Буцаагаад авсан мөнгөө л хөрөнгө орлогын мэдүүлэгт өгсөн. 43.500.000 төгрөгийн асуудал байна. Би Сүхбаатар аймгаас найзаасаа адуу авсан байсан. Би зээлээ авсан мөнгөө бичсэн байсан. Миний данснаас түүж аваад давхардуулсан байсан. 2010 онд 149 сая төгрөг зардлаа хасаад 9 сая төгрөг тайлагнаагүй гэсэн байсан. 400 мянган долларыг 608 сая төгрөг болсон байсан. Данснаас орж ирсэн мөнгийг орлого гэж түүж авсан байсан. 2012 онд татварын тайландаа хөрөнгө орлогын мэдүүлэгтээ н.Бая-т зээлсэн мөнгөө бичсэн байсан. Гаалийн жишиг үнээр маш өндөр бодсон байсан. Өртөг дээр ч гэсэн нэмж бодсон байсан. Өмнөх оных нь өртгөөр бодоходоо 110 сая гэж бодчихоод тэрний өмнөх оныхыг нь 115 сая гээд илүү бодсон байсан. 2011 оны шинэ LEXUS-570 захисан байсан. Нийт машин захисан мөнгө 448.500 ам.доллар болж байна. Надад татвар төлөхөөс зайлсхийсэн асуудал нэг ч байхгүй. Би хөрөнгө орлогын мэдүүлэгтээ дандаа үнэн зөв мэдүүлдэг байсан. Мөн шинжээчийн дүгнэлтээр бид нарыг яллах гээд байна. Энэ шинжээчийн дүгнэлт өөрөө хууль зүйн үндэслэлгүй гарсан байгаа. Энэ зүйл ангиудыг хүлээн зөвшөөрөхгүй байна гэв.

3. Б.Бу-ээс: -Надад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272.2-т зааснаар яллах

дүгнэлт үйлдэж ирүүлсэн. Татварын улсын байцаагчийн 2011 оны 7 дугаар сарын 27-ны өдрийн акт гарсан. Би 2011 оны 7 дугаар сарын 7-ны өдрөөс 8 дугаар сарын 12-ны өдөр хүртэл ээлжийн амралттай байсан. Энэ хугацаанд акт гарсан байсан. Энэ актыг зөвшөөрөхгүй гэж маргаан таслах зөвлөлд гомдол гаргасан гэсэн. Тэгээд маргаан таслах зөвлөл дээрээс 2011 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр 45 тоот тогтоолыг маргаан таслах зөвлөлөөс ирүүлсэн байсан. Би 2011 оны 11 дүгээр сарын 05-наас 11 дүгээр сарын 10-ны өдрүүдэд Канад улс руу томилолтоор явсан байсан. Эзгүй хойгуур тус газрын хяналт шалгалтын хэлтсийн дарга Ч.Га хүлээж аваад татварын улсын байцаагчид цохолт хийж өгсөн. Үүний дагуу татварын улсын байцаагч П.Га 45 тоот тогтоолыг 11 дүгээр сарын 08-ны өдөр хүлээж авсан. Энэ нотлох баримтаар нотлогдож байгаа. Мөн намайг татвар төлөгч нарыг татвар төлөхөөс зайлсхийхэд боломж олгосон гэж байгаа. 2011 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 980034 тоот акт татварын ерөнхий газрын маргаан таслах комисс хянан хэлэлцэхээс өмнө 2011 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Орос улсын иргэн В гэж хүн Монгол Улсын хилээр гараад явсан байдаг. Маргаан таслах зөвлөлийн тогтоол маань 2011 оны 10 дугаар сарын 14-ний өдөр хэлэлцсэн. Тэгэхэд нөгөө хүн маань хилээр гараад явсан байсан. Тус компанитай холбоотой 3.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй гэсэн байгаа. Би үүнийг мэдсэн даруйдаа Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст хүлээлгэж өгсөн. Хяналт шалгалт хийсэн байцаагч хамаарах ёстой. Манайхтай огт хамааралгүй зүйл байгаа гэв.

3. Б.Жа-аас:- Би төрд 28 жил ажилласан. Үүнээс шинжээчээр 10 жил ажилласан байдаг, өнөөдөр шүүх хуралдаанд шүүгдэгчээр орж байна. Намайг 2 зүйл ангиар ял сонгосон байгаа. Миний гаргасан шинжээчийн дүгнэлтийг санаатайгаар худал буруу гаргасан гэж эрүүгийн хуулийн тусгай ангийн 254.2 дахь зүйл анги дээр ярьж. Бүрэлдэхүүнтэй гаргасан шинжээч нарын дүгнэлтийг, өөрийнхөө гаргасан дүгнэлттэй харьцуулж хэлье гэж бодож байна. Шинжээч бол Шүүхийн шинжилгээний тухай хуулийн дагуу дүгнэлт гаргадаг. Эрүүгийн болон иргэний, захиргааны хэрэг маргааныг хянан шийдвэрлэхэд шүүхийн шинжилгээний тухай хуулийг хэрэглэнэ гэж заасан. Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч, комиссар

Д.З 2013 оны 06 дугаар сарын 16-ны өдөр шинжээчийн дүгнэлт гаргуулахаар тогтоол үйлдсэн байдаг. Уг тогтоолд Сүхбаатар дүүргийн татварын улсын байцаагч Ч.Эн, Д.А нарын дүгнэлт үндэслэлтэй эсэх гэсэн байсан. Манай шинжилгээний хүрээлэнгийн гаднаас ирсэн шинжилгээг хүлээж авдаг хэлтэс дээр Ч.Га-ийн тогтоол танилцуулагдаад над дээр ирсэн. Би уг тогтоолтой танилцахад шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх боломжгүй тогтоол байсан. Татварт ногдох зөрчлийг тавьсан байсан. 2 дугаар асуултад нь татвар ногдуулах орлогын хэмжээг нь хасаагүй байсан, тэгээд аваад яв, очоод тогтоолоо засаад ир гээд явуулсан. Дараа нь эргээд ирэхдээ бичиг хэргээр дамжаагүй над дээр шууд ирсэн. Бичиг хэргээр дамжсан нь болохоор Д.З-ын утасны дугаартай хүлээж авсан байдаг. Тэгээд би дүгнэлт гаргасан. 2013.11.20-29 өдрийн хооронд шинжилгээ хийх тогтоол ирүүлсэн байдаг, тогтоол нь надад ирээгүй. Шинжээчийн дүгнэлтийг надад Ч.У 2013 оны 10 дугаар сарын 12-ны өдөр хэрэг прокурорт шилжүүлж байна гээд миний дүгнэлтийг бусад шинжээч нарын дүгнэлтийн хамт өгсөн. Энэ дүгнэлт дээр надтай холбоотой 2 асуудал байгаа 6, 7 дугаар асуулт байгаа. 6 дугаар асуулт нь Сүхбаатар дүүргийн татварын улсын байцаагч Д.А, Ч.Эн нарын иргэн Д.Эн-т холбогдох 2013 оны 06 дугаар сарын 3-ны өдрийн тоот татварын улсын байцаагчийн дүгнэлт, шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн эдийн засгийн хэлтсийн дарга Б.Жа-ын 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 164 тоот дүгнэлтийн аль нь үндэслэлтэй вэ гэж асуусан байгаа. Мөн иргэн Д.Эн татварын тайлангаа тайлагнаагүй, татвар ногдох орлого, улсад төлөх ёстой татварын өр хэд вэ гэж асуусан байдаг. Ингээд хөл толгой 2-ыг асуусан байдаг. Татвар төлөгчийн үндсэн үйл ажиллагаа их биеэсээ хаясан байгаа нь харагддаг. Эндээс харахад шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй зөв биш гарсан байна. Яагаад гэхээр шинжээч хүн асуултаа харж байж ямар тооцоолол хийх хүснэгт, төлөвлөгөө, толгойгоо гаргадаг. Гэтэл энэ асуулт учир дутагдалтай байсан нь харагдаж байна. 7 асуулт нь дахин шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн эдийн засгийн хэлтсийн дарга Б.Жа-ын Д.Эн-д холбогдуулан бичсэн 2013 оны 08 сарын 21-ний өдрийн 164 тоот дүгнэлт, нэгжлэгээр хураагдсан дүгнэлт 2-ын аль үндэслэлтэй вэ гэсэн байгаа. Гэтэл нэгжлэгээр дүгнэлт хураагдаагүй байгаа,

2013 оны 08 сарын 04-ний өдрийн орон тооны бус комиссын хурлаар гарсан ноорог хураагдсан байдаг. Мөн энэ өдөр иргэн Д.Эн-д холбогдох дүгнэлт гараагүй байсан, комиссын хурлаар ороод буцсан юм. Дараа нь баталгаажсан дүгнэлт нь гарсан байдаг. Гэтэл Д.3 байцаагч нь нэгжлэгээр хураагдсан дүгнэлт гээд бас нэг дүгнэлт байгаа юм шиг асуусан байдаг. Тийм дүгнэлт байхгүй. Миний дүгнэлтийн нийтлэг үндэслэл нь бланкан дээр гаргадаггүй, он сар нь үнэн гэсэн тамга тэмдэгтэй, дугаартай байгаа, дугаар нь 24 эсвэл 26 гэж байгаа. Дүгнэлтийн хувьд иргэн Д.Эн-д холбогдох тоот хэрэгт шинжилгээ хийсэн тухай. Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаах газрын комиссар Д.3-ын 2013 оны 06 сарын 17-ны өдрийн шинжилгээ хийх тогтоолыг манай байгууллагад 2013 оны 06 сарын 19-ний өдөр ирүүлсний дагуу 2013 оны 07 сарын 2-оос 08 дугаар сарын 20-ны дотор шинжилгээ явуулсан. Хугацаа алдах юм бол торгуультай байдаг. Шүүхийн шинжилгээний тухай хуулиар шинжилгээний санхүүгийн объект хэзээ ирсэн тэр өдрөөс шинжээчийн дүгнэлт гаргах хугацааг тооцдог. Уг материалыг мөрдөн байцаагч мөрдөн байцаалтын нууц гээд канондсан хувь 196 хуудас баримтыг 7 дугаар сарын 2-нд өгсөн байгаа. Шинжилгээг Авлигатай тэмцэх газраас хамтарсан эдийн засгийн шинжилгээ хийх журам байгаа. Энэ журмыг үндэслээд шүүхийн шинжилгээний тухай хуулийн 8.4-т зааснаар мэргэжлийн журмуудыг Засгийн газрын гишүүдтэй хамтран батална гэсний дагуу баталсан байгаа. Дараа нь шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн захирлын 2010 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 320 тоот тушаалаар батлагдсан эдийн засагт тавигдах стандарт, шаардлага гэж байгаа. Эдийн засгийн шинжилгээний стандартыг стандарт хэмжил зүйн төв байгууллагын захирал баталдаг. Захирал нь дангаараа баталдаггүй, стандарт хэмжил зүйн төвөөс дугаар авч байж баталдаг. Энэ 3 эрх зүйн актын хүрээнд эдийн засгийн шинжилгээ хийгддэг. Үүнийг хэлэх зайлшгүй шаардлагатай. Бүрэлдэхүүнтэй шинжээч нарын нийтлэг үндэслэл дээр ямар хуулийг барьсан талаар ямар ч заалт алга байна. Шүүхийн шинжилгээний тухай хуульд бүх процессыг эхнээсээ эхлээд архивт орох хүртэлх зүйл заалттай байдаг. Гэтэл шинжээч нарын дүгнэлт дээр байхгүй.

Яллах дүгнэлтийн 40 дугаар хуудсанд байгаа. Миний дүгнэлт энэ 3 шинжээч нарын дүгнэлттэй зөрөөд байгаа гол зүйл

нь 250041 тоот дүгнэлт дээр энэ хүмүүс шинжилгээ хийсэн байгаа. Энэ хүмүүс анхан шатны баримтын хүрээнд шинжилгээ хийсэн, шүүхийн шинжилгээний хуулийг сөхөж хараагүй нь харагддаг. Шүүхийн шинжилгээний гол зүйл бол объект дээр хийдэг. Гэтэл энэ 3 шинжээчийн дүгнэлт объектоо ойлгоогүй, 27 дугаар зүйл заалтыг бүхэлд нь зөрчсөн объект дээр үндэслээгүй. Шинжээч нөгөө шинжээчийн дүгнэлт үндэслэлтэй эсэхийг тогтоодоггүй. Б.Жа-ын дүгнэлт буруу юм уу гэдгийг энэ шинжээч нар тогтоохгүй. Объект дээр шүүхийн шинжилгээний тухай хуулийн 18 дугаар зүйлийг анхаарах хэрэгтэй. Шинжээчийн дүгнэлтийн гол нь объект дээр тулгуурласан байх ёстой байдаг. Гэхдээ энэ хүмүүс ажил хийгээгүй биш хийсэн. Эдийн засгийн шинжилгээний объектоо Д.Эн-ын болсон болоогүй дансны хуулга зэргийг боловсруулаад 1 тэрбум 748 сая 42000 мянган төгрөг гарсан. Минийх 1 тэрбум 400 сая гарсан. 340 сая төгрөгийн зөрүү гардаг. Энэ шинжээч нар татвар ногдох орлогыг тэр болгон задалж хийгээгүй байдаг. Мөн хуулийн 14.1-ийг зөрчсөн. Хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдал олж тогтоовол энэ талаар дүгнэлтдээ тусгана гэж байдаг. Энэ хүмүүс Б.Жа-ын дүгнэлтээс 340 сая төгрөгийн зөрүү гарлаа, энэ нь шинэ нөхцөл байдал гэж үзээд байгаа. Энэ бол шинэ нөхцөл байдал биш юм, объект нь буруу байдаг. Шинэ нөхцөл байдал ямар тохиолдолд үүсэх вэ гэхээр 3 тэрбум 781 сая төгрөг дээр л үүсэх ёстой. 27.2 дахь хэсэгт эдийн засгийн шинжилгээ хийж байгаа шинжээч нь баримтын шалгалт дахин хийх буюу тооллого явуулах эрхгүй гэсэн байдаг. Энэ хүмүүсийн хийсэн шинжилгээ нь миний хийсэн шинжилгээтэй их зөрүүтэй байдаг. Баримтын шалгалт нь анхан шатанд очоод байгаа юм, тэгэхээр энэ шинэ нөхцөл байдалд бас биш юм. Би Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 14.3-т заасны дагуу ажлаа хийсэн. Шинжээчийн дүгнэлтийн асуултад хариулсан байдаг. Сүхбаатар дүүргийн татварын байцаагч Ч.Эн, Г.А нарын 2013 оны 06 сарын 03-ны өдрийн 2500.1 тоот дүгнэлт үндэслэлтэй эсэх гэсэн байгаа. Үүн дээр дээр би бүрэн үндэслэлгүй гэж үзсэн талаараа сая ярилаа. Энэ татварын улсын байцаагч нарын 3 тэрбум 784 сая 661 мянган төгрөгийн зөрчил нь тайлагнасан дүнг оруулж тооцдог гэсэн. 1 тэрбум 400 сая 619 мянган төгрөг болж буурсан бөгөөд

тайлагнасан дүнг хасаж тооцоход татвар ногдох орлого нь 762.998.000 төгрөг болж байна гэсэн. Татварын улсын байцаагч нар нь тооцсон татварын зөрчлийн дүнгээр Д.Эн-ын 2008-2012 оны хүү татварын орлогоос хасаагүй явуулсан байсан. Хавсралт дээр би их тодорхой хэлсэн байгаа. Татварын 2 байцаагч мөрдөн байцаагч нар нь зөрчилтэй байсан. Юун дээр зөрчилтэй байсан гэхээр 665 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсан дээр татвар төлөөгүй гэдэг. Мөрдөн байцаагч Д.3-аас баримтыг нэхэхээр нөгөө 2 байцаагчид байгаа, утасдаад авна гэж хэлж байсан, нөгөө 2 байцаагчаас асуухад Д.3-ыг хэлэхээр бичсэн гэж хэлсэн. Ийм зөрчилтэй байхад эрүүгийн хэрэг үүсгэнэ гээд байх юм бол уу гэж бодсон. 665 сая төгрөгийн асуудал дээр дахин шинжээч томилох ёстой байх гэж бодсон. Дүгнэлт гаргасан улсын байцаагч, хариуцагч, нэхэмжлэгч нараас баримтаа гаргаж өг гэж шаардах ёстой байсан. Тэгээд би Д.Эн-тай уулзая гэсэн чинь эхнэр Б.Он-той нь уулз, олон өмгөөлөгч нартай нь уулз гэж байсан. 6 машиныг борлуулсан асуудал дээр тэр Б.Он-г дуудаж асуусан. Ерөнхийдөө хүлээн зөвшөөрч байсан болохоор борлуулалтыг нь нэр дээр нь авсан. Тэгээд 665 сая төгрөгийн маргаан энэ манайд ирээд маш их удсан байсан, хугацаа алдвал хариуцлага хүлээдэг болохоор 2013 оны 08 дугаар сарын 3-нд комиссын хурлаар Д.Эн-ын хэргийг хэлэлцүүлсэн. Манай М дарга ээлжийн амралттай байсан учраас би хурал даргалж байсан. Тус хурлаар дүн нь маш их буурсан байсан мөн дэд дарга Э-г ирэхээр асуудлыг шийдэх хэрэгтэй байсан. 665 сая төгрөг дээр татварын байцаагчийн дүгнэлт гаргадаг учраас Авлигатай тэмцэх газраас албан тоот явуулж баталгаажуулж байж дараагийн хуралд оруулна гэж хэлсэн. Мөн намайг тооцоолол дээрээ ахин сайн шалгаж үз гэж хэлсэн. Ингээд 08 дугаар сарын 21-ний өдрийн дүгнэлтээр татвар ногдуулах орлогын хэмжээ 36 сая төгрөг болж буурсан. 3.600.000 төгрөгөөр зөрсөн байгаа. Энэ юунаас зөрсөн гэхээр 2009 оны «ЖМ» компанид оруулсан хөрөнгө оруулалт 72.123.000 төгрөг 50 мянган доллар олгосон зээлийн эх үүсвэрээс 2008 онд 35.615.000 төгрөг хасаад үлдэгдэл 36 сая төгрөг дээр нь татвар ногдуулаад бичсэн байсан. Тэгээд би Авлигатай тэмцэх газар тоот явуулсан байгаа. Дараа нь ахиж тооцоолол дээр хянасан. 7 дугаар сарын 5-ны өдөр 50 сая

төгрөг ногдуулсан байгаа. Үндсэн баримтаар хангалттай 72 сая төгрөг байсан. Комиссын хурал болоод 665 сая төгрөг чинь үл хөдлөх хөрөнгө борлуулсан мөнгө биш байна гэж хэлсэн. Тэгээд би үүнийг Д.3-д аваачиж өгсөн. Нэмэлт шинжээч томилох хэрэгтэй гэж хэлэхэд маргааш нь Д.3 орж ирээд тэр баримтыг аваад явсан. Би хоригдож байхдаа миний дүгнэлтийг зөв дүгнэх байх гэж их найдаж байсан. Намайг шинжээчээр байцаалт аваагүй шууд хорьсон. Шинжээч хүн маш хариуцлагатай байх ёстой. Шинжээч хүн шүүхийн 3 шатанд хэрэгтнээсээ илүү өндөр хариуцлагатай байдаг. 9 дүгээр сарын 25-нд намайг байцаахад би шинжээчээр байцаалт өгье. Миний дүгнэлтийг аваад ир гэж хэлсэн. Тэгтэл надаас байцаалт авах гэж байсан байцаагч би энэ талаар байцаахгүй Д.3 байцаагч байцаана гэж хэлсэн. Тэгээд дараа нь Д.3 байцаасан. Тэгсэн надаас зөвхөн хөрөнгийн тал дээр мэдүүлэг авсан. Шинжээчийн үндсэн үйл ажиллагааг асуугаагүй байгаа. Өнөөдрийг хүртэл асуугаагүй байна. Д.Эн нь 154 сая төгрөг тайлагнаагүй нуусан гэж бичсэн байгаа. 2008 оны 296.257.000 төгрөгийн хадгаламжаасаа ногдуулсан нь тодорхой байгаа. «ЖМ» компанийн 100.000 доллараас 9 сая төгрөгийн татвар ногдуулсан. 2011 оны LEXUS-570 маркийн машины тооцоог бичээгүй гэсэн байгаа. 2011 оны 8 дугаар сарын 01-ний өдөр Д.Га-ад өгсөн машин, 649.370.000 төгрөг нэрээрээ орж ирсэн байсан. Эдийн засгийн шинжээчийн дүгнэлт дээр дотоод итгэл үнэмшил гэж байдаггүй. Анхны нотлох баримт дээр үндэслэж дүгнэлт гаргадаг байгаа. Д.3-д мэдүүлэг өгөхдөө би хэлж байсан. 2011 оны 8 дугаар сарын 03-нд машины шилжүүлгийн гадаад төлбөр тооцооны баримтыг нь олоогүй байгаа.

Энэ машин LEXUS-570 маркийн машин солилцсон байгаа. Нотлох баримтын хүрээнд л би дүгнэлтээ гаргасан. Нөгөө дүгнэлтийн асуултад тодорхой хариулаагүй. Шүүхийн шинжилгээний тухай хуулийг зөрчсөн. Үүгээрээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг мөн давхар зөрчөөд байна. Намайг хоригдож байхад байцаагч танай 3 байцаагчид эрүү үүсгэхээр боллоо гэж хэлсэн. Асуултад хариулаагүй гэж хэлсэн. 2 асуултын нэгэнд нь хариулаагүй байсан. Дүгнэлтийн баталгаажуулалт гэж байгаа. Миний 163 тоот дүгнэлт үндэслэлтэй. Шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийлгэсэн тохиолдолд шинжээчийн гарын үсгээр

баталгаажсан байх ёстой. Шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур шинжээч томилуулахад асуултад хариулна, эрх зүйн актыг баталгаажуулсан байх ёстой. 14.1 дээр шинжээчийн үүрэг гэж байгаа, үүн дээр бусдаас хараат байж зөвхөн хуульд захирагдана гэж заасан. Энэ хүмүүс бол хараат дүгнэлт гаргасан гэж ойлгож байна. Авлигатай тэмцэх газар эдгээр шинжээч нарыг их хэцүү дүгнэлт гаргуулсан. 500 сая төгрөгөөс татвар ногдуулна гэж яриад байна. Миний гаргасан дүгнэлтийг эдгээр хүмүүс ойлгоогүй. Б.А миний дүгнэлтийг үндэслэлгүй гэсэн. Үүнийг тодорхой заасан байгаа. Энэ шинжээч нар яагаад ийм дүгнэлт гаргасан гэдгийг надаас асуучих ёстой байсан. Тэгэхэд юу ч асуугаагүй. Шүүхийн шинжилгээний тухай хууль тухайн үед гараагүй байсан. Шүүхийн шинжилгээний зарчим гэж байдаг. Н.Г шинжээч энэ зарчмыг бүхэлд нь зөрчсөн гэж үзэж байна. Миний дүгнэлт 3 тэрбум 18 сая төгрөгийн зөрүүтэй гарсан. Шүүх үндэслэлгүй гаргасан гэж үзсэн. Н.Г ашиг сонирхлын зөрчилтэй гэж үзэж байгаа. 16.1.3 гэсэн зүйлийг зөрчөөд байна. Хохирогч татварын газар ажиллаж байсан. Татварын ерөнхий газрын дотоод будлиан хийж байна. Ийм дүгнэлт хийж байгаа хүмүүс энгийн ард иргэд дээр яаж дүгнэлт хийж байгаа нь ойлгомжтой. Б.А, Ц.С мөн ашиг сонирхолын зөрчилтэй гэж үзэж байна. Шинжээчээс татгалзах үндэслэлүүд байсан. Тэгэхэд дүгнэлт гаргаж байсан. Миний дүгнэлтийг эдгээр 3 шинжээчийн дүгнэлттэй харьцуулж үзэх боломжгүй юм. Намайг асуугаагүй байж хорьсон. Одоо ч гүйцэт асуугаагүй байгаа. Миний гаргасан дүгнэлт дээр ингээд буруу гаргасан байна гээд баримт дээр маргах, эсвэл тооцооллын асуудал дээр маргавал дахин шинжилгээ хийлгэх ёстой байсан. Шинжээчийн дүгнэлтийг эргэлзэж маргавал ахин шинжээч томилох ёстой. Би үүнийг үгүйсгэдэг. Яллах цагаатгах баримтыг адил цуглуулах ёстой байсан. Тэгэхэд зөвхөн яллах талын баримтыг цуглуулсан байгаа.

Эрүүгийн хуулийн 270^{1.2} гэсэн зүйл анги дээр энэ миний хууль ёсны орлого байгаа. Энэ машиныг авсан мөнгө хууль ёсных. Энэ манай гэр бүлийн 8 дахь машин, өмнөх машинаа зараад энэ машиныг авсан. Манай нөхөр өмнө нь Старекс гэдэг машинтай, тээвэрт явдаг, Дулааны цахилгаан станцтай гэрээгээр нүүрс зөөдөг байсан. Мөн найз нөхөдтэйгээ нийлээд хувийн машинаар тээвэр хийдэг байсан. Дулааны цахилгаан

станц Хас банктэй гэрээтэй болохоор Хас банкны данстай байсан. Мөн хажуугаар нь цахилгаан станцын шон зөөгөөд Хаан банкны дансаар мөнгө нь орж ирдэг байсан. Тэр мөнгөөр энэ машиныг авсан байгаа. Гэрчээр мэдүүлэг авахдаа ээжтэйгээ явсан гэж бичсэн байсан. Тэгсэн манай хүүхэд ээж яваагүй шүү дээ гэж хэлэхэд за гээд н.Ж гэж нэрийг дараад ахин хэвлээд гарын үсэг зуруулсан байсан. Хуваарьт өмчөөрөө олсон хөрөнгийг заасан байгаа. БХ-ын нэр дээр тэр Хово машин байсан бол би бичих байсан. Тухайн үед нөхөртэйгээ таарамжгүй харьцаатай байсан болохоор өөр хүний нэр дээр авсан байх гэж бодож байгаа. 2003 онд манайх Өмнөговь аймагт 3 өрөө байртай, Ланд круйзер маркийн машинтай, зөөдөг зөөдөггүй 2 гражтай, 1 дүгээр хороололд 1 өрөө байртай байсан. Анх Сангийн яаманд ажилд ороход би байртай байсан. Манай охин нэг өрөө байранд орсон. Тэгээд түүнийгээ 2 өрөө болгоод зассан байсан. Тэгээд Өмнөговь дахь байраа зараад нэг өрөө байр болгосон. 2013 оны 04 дүгээр сард манай охин 3 дахь хүүхдээ гаргах гээд жирэмсний амралтаа авсан байсан. Тэгээд манай нөхөр хүүхдүүд олон болж байна, энэ байрыг томсгох хэрэгтэй юм байна гэж хэлсэн. Манай бүх эд хөрөнгө зээлийн барьцаанд байдаг. 1 дүгээр хороололд байсан байр ганцхан зээлийн барьцаагүй байсан. Тэгээд тэр байраа 64 сая төгрөгөөр зарсан. Үүнээс 45 сая төгрөгийг урьдчилгаанд өгөөд хүргэнийхээ нэр дээр зээлээр байр авсан. Манай охин миний хадгаламжид 12 сая төгрөг хийсэн. Үүнээс манай ажлын хүн яаралтай мөнгө хэрэгтэй болоод байна гээд 2 сая төгрөг зээлсэн байсан. Тэгээд үлдсэн 10 сая төгрөг дээрээ цалингийн 8 сая төгрөгийн зээл аваад орон сууц зарсан мөнгөн дээрээ нэмээд 39 сая төгрөгөөр энэ зуслангийн байрыг худалдаж авч байсан. Би энэ зүйл ангиудыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Би хуулийн дагуу дүгнэлтээ гаргасан байгаа гэв.

4. П.Га-аас:- Би энэ яллах дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Би “КЖЭМ», «УМ» гэж компаниуд дээр шалгалт хийсэн. Уг шалгалт нь Баянгол дүүргийн байцаагч нарын тус компаниуд дээр хийсэн дүгнэлт хууль эрх зүйн дагуу хийгдсэн эсэхэд үнэлэлт дүгнэлт өгөх шалгалт байсан. Байцаагч нарын дүгнэлт дээр 2008 онд “УМ» ХХК нь хувьцаагаа “ПС» ХХК-д шилжүүлж, «УМ» компанийг «ПС» ХХК нь худалдан авч тус компанийг худалдан борлуулж Ашигт

малтмалын тусгай хайгуулын зөвшөөрлийн үнэ 2.4 сая доллар борлуулсныг татварын орлогод тусгаагүй, татвар ногдуулаагүй байна гэсэн дүгнэлтийг хийсэн байдаг. Би тус компанийг худалдан борлуулсан нь хууль эрх зүйн үндэслэлгүй гэсэн шийдвэрийг дараах үндэслэлээр гаргасан юм. Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд хувьцаа эзэмшигчийн үүргийг компани хариуцахгүй гээд заасан. Компани, компанийн хувьцаа эзэмшигчид тус тусдаа хуулийн этгээд байдаг. Тэгэхээр эдгээр байцаагч нар хэнтэй холбоотой ямар ажил юм бэ гэдгийг шалгаагүй нь харагддаг. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нь өөрөө тус хуулиараа зохицуулагддаг. Ашигт малтмалын тухай хуулийн 49.2-т заасан Өөрөөр хэлбэл, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг зарах гэсэн ойлголт байхгүй, харин мэдээлэл зарах гэсний дагуу тусгай зөвшөөрөл шилжигдэх юм байна. Эндээс үзэхэд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу эрх борлуулсан орлого гэдэг ойлголт ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлд орохгүй байна. Эндээс харахад энэ 2 байцаагч ашигт малтмалын лицензийг хайгуулын болон ашиглалтын гэдгийг нь шалгаагүй нь буруу дүгнэлт гаргасан байдаг. Миний гаргасан дүгнэлтийг шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн байцаагч шалгаад Баянгол дүүргийн байцаагчийн дүгнэлт үндэслэлтэй биш байна гэж гаргасан байдаг. Дараа нь Н.Г, Б.А, Ц.С гэсэн бүрэлдэхүүнтэй шинжээч нарын дүгнэлт гарсан. Миний шалгаагүй “ПС» ХХК-ийн 2007-2013 оны нягтлан бодох бүртгэлд шалгалт хийгээд “УМ» компани татвар ногдуулах үүрэггүй байна гээд шийдвэр гаргасан. Ийм байхад би яагаад гэм буруутай болоод шүүгдэгч болж байна. Дараа нь ганцаараа шалгасан асуудал дээр хяналт шалгалт хариуцсан мэргэжлийн байцаагч яахаараа хяналт шалгалт хийх эрхгүй болдог байна. Монгол Улсын татварын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлд татварын байцаагчийн бүрэн эрхийг заагаад өгсөн байгаа, уг заалтад ганцаараа хоёулаа гэсэн заалт байхгүй. Хуулийн дагуу хуульдаа нийцсэн дүрэм журам байх ёстой. Би “УМ» ХХК-ийг шалгасны дараа улсын байцаагчийн асуудал дээр яагаад хуулийн дагуу явахгүй байна, хуулийг нэг мөр хэрэглэхгүй байна гэж Татварын ерөнхий газрын ёс зүйн хороонд танилцуулга гаргасан. “КЖЭМ» ХХК-д учруулсан 11,4 тэрбум төгрөгийн хохирлын талаар “УМ» ХХК-ийн хүсэлтийн дагуу 2008-

2009 оны татварын тайланд шалгалт хийсэн. Ингэхдээ 2005 оны тайланг байцаагч ӨБ, 2006 оны тайланг байцаагч Ж, 2008-2009 оны тайланг би шалгасан. Тус шалгалтаар зөрчил илрээгүй мэт дүгнэлт бичсэн. 2007 оны шалгалтаар 995.7 сая төгрөгийн зөрчил илэрсэн. НӨАТ-ыг тайландаа тусгаагүй зөрчилд 45, 46, 47 дугаартай актуудыг тус тус тогтоосон. Үүний дараа Чингэлтэй дүүргийн байцаагч Б.Ба, С.О нар илт хууль бус шинжээчийн дүгнэлт гаргасан. Уг дүгнэлтээр 2008 оны 3 сарын 24-ний өдөр хувьцаа худалдах, худалдан авах гэрээний дагуу хувьцаагаа «КЖЭМ» ХХК-д шилжүүлсэн байдаг. Эрх шилжүүлсний орлого нийт 9,8 тэрбум төгрөг, эрх шилжүүлсний орлогоос НӨАТ ногдуулаагүй, улсад 2,1 тэрбум төгрөгийн хохирол учруулсан гэж дүгнэлт гаргасан байдаг. «КЖЭМ» ХХК ямар хувьцаа зарсан юм бэ, ямар ч хувьцаа зараагүй. Мөн ямарч ашигт малтмалын хайгуулын лиценз зараагүй, зарсан мэтээр дүгнэлт гаргасан байдаг. Гэтэл 2006 онд «КЖЭМ» ХХК нь НӨАТ төлөгчөөр бүртгэгдээгүй, татвар төлөгчийн гэрчилгээ олгогдоогүй байхад улсад их хэмжээний хохирол учруулсан гэж төлбөр ногдуулсан байгаа. Дараагийн төлбөр нь компани 1 тэрбум 88 сая төгрөгөөр ашигт малтмалын хайгуулийн лицензийг бусдад худалдан борлуулсан байна. Үүнээс НӨАТ-т татвар төлөөгүйгээс улсад 1,7 сая төгрөгийн хохирол учруулсан гэсэн учир нь үл ойлгогдох дүгнэлтийг шинжээчид гаргасан. Мөн зургаан компани шалгагдсан байдаг. Энэ зургаан компанийн зургуулангийх нь хувьцааг Их Британийн “Ви» компани эзэмшдэг. Зөвхөн «КЖЭМ» ХХК-ийн хувьцааг энэ компани зараагүй, зургуулангийх нь хувьцааг зарсан. Зургуулаа ашигт малтмалын хайгуулын лицензтэй. Гэтэл яагаад зөвхөн “КЖЭМ» ХХК-ийн ашигт малтмалын лицензийг зарсан гээд байгаа юм бэ гэв.

5. Н.Ра-гээс:-Татварын ерөнхий газрын арга зүйн хяналтын хэлтэст татварын улсын байцаагчийн албан тушаалыг хашиж байхдаа албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2008 оны 9 сарын 31-ний өдрийн 192-р тогтоолын дагуу Үндэсний татварын газрын хяналт шалгалтын журмыг зөрчин ганцаараа хяналт шалгалтыг «НТГ» ХХК-д хийж 548 сая 900 төгрөгийн, «КЖЭМ» ХХК-д шалгалт хийж 217 сая 700 мянган төгрөг, нийт 765 сая төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан үйлдэлдээ Эрүүгийн хуулийн

ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.4-т заасныг журамлан, тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан эрүүгийн хэрэг үүсгэснийг ойлгохгүй байна. Би Татварын ерөнхий хууль болон Үндэсний татварын албаны хяналт шалгалтын дүрмийн хүрээнд заасан ажлыг хийж гүйцэтгэсэн. Хяналт шалгалтыг хийж гүйцэтгэхдээ хууль дүрмийг зөрчөөгүй. Ямар нэгэн нөлөөнд автаагүй, эрх мэдлээ урвуулан ашиглаагүй тул хүлээн зөвшөөрөхгүй байна. Намайг ганцаараа хяналт шалгалтыг хийсэн гэж буруутгасан, Татварын ерөнхий газрын хяналт шалгалтын хэлтсийн газрын дарга надад үүрэг өгсөн, би ажлын байрны тодорхойлолтод заасны дагуу ажил үүрэг гүйцэтгэсэн.

Татварын улсын байцаагч Ш.На, А.Д нар «НТГ» ХХК-ийн 2007-2009 оны татварын тайланд шалгалт хийж 2010 оны 2 сарын 25-ны өдөр 260006 тоот дүгнэлтийг гаргасан. Уг дүгнэлтийг хууль эрх зүйн үндэслэлтэй эсэхийг тогтоох талаар татварын ерөнхий газрын хяналт шалгалтын хэлтсийн даргын 2013 оны 4 сарын 14-ний өдрийн 0003 тоот тогтоолоор «НТГ» ХХК-ийн 2007-2009 оны татварын тайланд хэсэгчилсэн шалгалт хийсэн. Зөвхөн «НТГ» ХХК-ийн тайлангийн дүгнэлтийн эрх зүйн үндэслэлийг шалгахын тулд энэ шалгалт хийгдсэн. Энэ шалгалтыг хийхийн тулд Баянгол дүүргийн татварын улсын байцаагч Ш.На, А.Д нартай хоёр ч удаа уулзаж ярилцсан. Гомдол гаргасан компанитай уулзаж ярилцсан. Дүгнэлтэд нийтдээ 6 тэрбум 974 мянга 495 төгрөгийн зөрчил гарсан байдаг. Зөрчил дотор энгийн хувьцаа худалдсан 2 сая 794 мянган төгрөг, хайгуулын лиценз худалдах, худалдан авах гэрээний зөрчил байсан. Дүгнэлт дээр хайгуулын лиценз худалдсан тухай ямар ч баримт байгаагүй, тийм учраас хоёр байцаагчийг дуудаж яагаад ийм өндөр дүн тогтоосон талаар асуусан. Гэтэл энэ дүгнэлтийг гаргахдаа зөрчил болгоныг салгаад бичсэн юм, таны хэлснийг ойлгож байна, бид нар буруу гаргасан байна гэсэн. «ППС» ХХК нь «НТГ» ХХК-ийн хувьцаа худалдан авах талаар хувьцаа худалдах худалдан авах гэрээ байгуулаад, хувьцаа шилжүүлэх болон төлбөрийн нөхцөлийг татвар оролцуулалгүй 2,4 сая доллар байна гэж гэрээнд тусгасан байдаг. Энэ нь хавтаст хэрэгт байдаггүй, шинжээчид үүнийг үзээгүй байх. Энэ 2.4 сая долларын үнэлгээ орж ирээд, «Голомт» банкны 160139xxxx гэсэн дансаар орж ирсэн байдаг. Үүний 10% болох

321757 төгрөгийг Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст 2008 оны 6 сарын 25-ны өдөр төлөгдсөн бөгөөд Сүхбаатар дүүргийн татварын хяналт шалгалтын тасгийн дарга н.Са нь Баянгол дүүргийн татварын хэлтэст «ППС» ХХК нь «НТГ» ХХК, «УМ» ХХК-ийн хувьцааг худалдан авсны төлбөрийн 10%-ийн албан татварыг суутгасан байна гэсэн албан бичиг хүргүүлсэн байдаг. Шинжээчид хувьцааг худалдсан гэж үзэж байгаа, ашигт малтмалын хайгуулын лиценз худалдсан тухай ямар ч баримт дүгнэлтэд байхгүй. Хувьцааг худалдах, худалдан авсан талаар өөрчлөлтийг Улсын бүртгэлийн газар хийдэг, Монгол Улсын Компанийн тухай хуульд хувьцаа худалдах талаар санал тавьж байгаа эзэмшигчид нь эхний ээлжинд худалдах эрхтэй байдаг. Тэгэхээр «ППС» ХХК нь «НТГ» ХХК-ийн хувьцааг худалдан авах эрхтэй. Баянгол дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагч нар нь шалган тогтоосон «НТГ» ХХК-ийн 2010 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дүгнэлтэд Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч н.Тү шинжилгээ хийсэн. Уг хоёр байцаагчийн дүгнэлтийг үндэслэлтэй гэж үзэхээргүй гэсэн дүгнэлт гаргасан. Эдийн засгийн шинжилгээгээр хувьцаа худалдсан гэвэл хувьцаа худалдсан уу, ашигт малтмалын лиценз худалдсан уу гэдгийг тогтоох боломжгүй. Хэрвээ хувьцаа худалдсан бол 10%-ийн төлбөрийг төлсөн байна, ашигт малтмалын лиценз худалдсан бол «ППС» ХХК нь 548939.5 төгрөгийн төлбөрийг төлөх ёстой юм байна гэсэн дүгнэлтийг гаргасан. Шинжээчид миний дүгнэлтийг үзээгүй, мөн хувьцаа худалдах худалдан авах гэрээг үзээгүй. Хоёр компанийн өөрчлөлт хийгдсэн гэрчилгээг үзээгүй. Улсын бүртгэлийн албанаас лавлагаа авалгүй ийм дүгнэлтийг гаргасан. Дахин шинжээчийн багт Үндэсний аудитын газрын санхүүгийн аудитын газрын аудит Ц.С, Татварын ерөнхий газрын улсын байцаагч Н.Г, Мэргэжлийн хяналтын газрын байцаагч Б.А нар 2013 оны 10 сарын 20-ны өдөр томилогдоод 2013 оны 11 сарын 20-ны өдөр дүгнэлт гаргасан. Дүгнэлтэд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн эрх борлуулсны орлогыг тодорхойлж, түүнд татвар ногдуулах арга зүйн дагуу төлөх, тайлагнах, сэргээх дарааллыг хуульчилж өгсөн байна. Үүнд татварын улсын байцаагчийн дүгнэлтийн дүнг гаргахдаа буруу тооцоолж гаргасан байна. «НТГ» ХХК эрх борлуулсан орлогоо аж ахуйн нэгжийн

орлогын албан татварын тайланд тусгах ёстой байсан. Тухайн үед шинжээчид «НТГ» ХХК-ийг шалгасан боловч хувьцаа худалдах, худалдан авах гэрээг үзээгүй, Улсын бүртгэлийн албанаас лавлагаа аваагүй, дүгнэлтийг зөвхөн «ППС» ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн баримт дээр тулгуурлан гаргасан нь хууль бус гэж үзэж байна. Хэдийгээр дүгнэлтийг хууль бус гэж үзэж байгаа боловч «Н» ХХК-д Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар ногдуулах эрхтэй гэж холбогдох албан тушаалтнуудыг үзэж байгаа юм. Шинжээчид дүгнэлтийг гаргахдаа нотлох баримтад үндэслэж гаргах ёстой. Тэгэхээр яагаад хувьцаа худалсныг ашигт малтмалын лиценз худалдсан гэж буруу дүгнэлт гаргасныг ойлгохгүй байна. Нотлох баримт нь хувьцаа худалдах, худалдан авах гэрээ л байгаа. Ашигт малтмалын лиценз худалдсан гэсэн ямар нэгэн үг өгүүлбэр миний шалгасан баримтад байхгүй, худалдах худалдан авах гэрээнд ч байхгүй, хавтаст хэрэгт ч байхгүй. Шинжээчид Татварын ерөнхий газрын баримтуудыг авч үзэх бүрэн боломжтой. Энэ бүгдийг үзээгүйгээр нэг талыг барьж дүгнэлт гаргасан. «БАЭ» ХХК-д шалгалт хийсэн. Тус компанийн 2005-2009 оны татварын тайланд шалгалт хийсэн. Шалгалтаар НӨАТ-ын 220851,8 төгрөгийн илүү төлөлтийг баталгаажуулан 2009 оны 12 сарын 31-ний өдөр 41 тоот баталгаажуулалтын акт үйлдсэн, 2006 оны 3 сая 288,9 төгрөг, 2007 оны 38 сая 118 мянган төгрөг, 2008 оны 5 сая 241,5 мянган төгрөг, 2009 оны 8 сая 422,5 мянган төгрөг нийт 50 сая 70,9 мянган төгрөгийн алдагдлыг бууруулахад баталгаажуулах эрх олгогдсон. Ингэхдээ баримтгүй зардлуудыг хасаж жагсаалт гарган, баримт үйлдсэн. 2013 оны 11 сарын 10-ны өдөр шинжээчийн дүгнэлт гарсан байсныг 2013 оны 12 сарын 9-ний өдөр Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчаас танилцсан. Дүгнэлтээс асуулт байгаагүй. Монгол Улсад байдаггүй татвар төлөгч Монгол Улсад олсон орлогын 20%-иар, тус хуулийн 17.2.9-ийн в-д зааснаар Удирдлагын төлсөн зардлыг төлөх, 17.2.9-ийн г-д зааснаар Монгол улсад гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлого, 17.2.9-ийн д-д зааснаар Монгол улсаас эх үүсвэртэйгээр шууд болон цахим хэлбэрээр гүйцэтгэсэн ажил үйлчилгээний орлого гэж заасан байна. Татварын ерөнхий газрын татварын удирдлага хамтын ажиллагааны 2013 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн

572016 тоот албан бичиг 2012 оны 01 сарын 01-нээс өмнөх гардан шилжүүлсэн орлого тус хуулийн 17.2.7-н д-д хамааруулан аж ахуйн нэгжийн орлогын албан татвараас суутгагдах ёстой гэсэн тайлбарыг ирүүлсэн. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган тооцоогүй гарт шилжүүлсэн 157 сая 629 мянган төгрөгийн орлогоос суутган тооцох ёстой татварын өр нь 37 сая 525 мянган төгрөг гэж гарсан. «БАЭ» ХХК-ийн 2007-2008 оны татвар ногдох орлогод хуулийг буцааж хэрэглэсэн. Монгол улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт орохоос өмнө 2007-2009 онд Монгол Улсад байрладаггүй, Монгол Улсад үйл ажиллагаа явуулаагүй, Монгол Улсаас эх үүсвэртэй орлого олсон тохиолдолд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын дагуу татвар ногдуулах заалт байгаагүй. Татварын газрын дэргэдэх маргаан таслах комисс, Нийслэлийн захиргааны хэргийн шүүх, Захиргааны хэргийн давж заалдах шүүх, Улсын дээд шүүх, 2012 оны 12 сарын 1-нээс өмнөх гадаад эх үүсвэртэй аж ахуйн нэгжид албан татвар ногдуулсан татварын улсын байцаагчийн актыг хүчингүй болгосон шийдвэр тогтоол практикт байдаг. Газрын төлбөр төлөх талаар лавлагаа аваагүй, аймаг бүрт байдаг газрын төлбөр төлөх итгэлцүүр үзүүлэлт гэж байдаг. Энэ үзүүлэлтийг байцаагч нар судалж үзээгүй. Энэ итгэлцүүр үзүүлэлтээр төлбөрийг тогтоох ёстой. Газрын албатай гэрээ байгуулахдаа ямар хэмжээний газар, ямар төлбөр төлөх вэ, ашиглалт нь хаана явагдах, эдэлбэр газар нь хаана байх гэдгээ тооцоолж итгэлцүүр үзүүлэлтээр гэрээ байгуулаад, Засаг даргаар батлуулах ёстой. Засаг даргаар батлуулан гэрээ байгуулснаар газрын төлбөр төлөх эрх нь үүсч байгаа юм. Гэтэл ингэж газрын төлбөр төлөх эрх нь үүсээгүй байхад газрын төлбөр төлөөгүй гэсэн дүгнэлт гаргасныг үндэслэлгүй байна гэж үзэж байна. Би «НТГ» ХХК, «БАЭ» ХХК-иудад хяналт шалгалтыг явуулахдаа хууль дүрмээ баримталсан, хэн нэгэнтэй үгсэн хуйвалдаагүй. Мөн хэн нэгний нөлөөнд автаагүй, албан тушаал эрх мэдлээ урвуулан ашиглаагүй, Татварын ерөнхий хууль болон Үндэсний татварын ажлын дүрэм, ажлын байрны тодорхойлолтод заасан үүргээ гүйцэтгэсэн. Ийм учраас би шүүх хуралдаан болж байгаа энэ эрүүгийн хэргийг зөвшөөрөхгүй байна гэв.

7. Б.Өс-аас: - Намайг Авлигатай тэмцэх

газрын байцаагч н.Уу 2013 оны 05 сарын 31-ний өдөр анх гэрчээр байцаасан. Ямар шалтгаанаар «КЖЭМ» ХХК-д Чингэлтэй дүүргийн татварын албаны хяналт шалгалт орж байхад давхар шалгалтыг явуулсан талаар асуусан. Мэдүүлэгтээ бид нар бол хяналтын байгууллага, үүрэгт ажлаа гүйцэтгэсэн, удирдлагаас өгсөн хяналтын байгууллагын үүргээ гүйцэтгэсэн гэж мэдүүлсэн. Ингэж гэрчийн мэдүүлэг өгч байх хугацаанд үндэслэлгүйгээр илтгэх хуудас зохиож бичсэн гэдэг асуудал яригдаж байсан. «КЖЭМ» ХХК-ийн хувьд ганцхан илтгэх хуудас бичигдээгүй, энэ компанийн НӨАТ-ын актаар илтгэх хуудаст дурдагдсан зөрчлийн хэмжээгээр баталгаажуулалтын акт 2007 онд бичигдсэн байгаа гэсэн гэрчийн мэдүүлэг өгсөн. Намайг байцааж байх үед мөрдөн байцаагч н.Уу нь «КЖЭМ» ХХК-ийн НӨАТ-ын баталгаажуулалтын актын талаар ямар ч ойлголтгүй байсан. Үүний дараа 2013 оны 12 сарын 2-нд намайг сэжигтнээр байцаасан. Тухайн үед мөн ялгаа байхгүй албан тушаалаа урвуулан ашигласан, «ХБЭ» ХХК-д ганцаараа хяналт шалгалтыг явуулсан, «КЖЭМ» ХХК-д П.Га, Б.Жа-ын хамтаар илтгэх хуудас бичсэн байна гэсэн үндэслэлээр байцаасан. Ганцаараа шалгалт явуулсан нь хууль эрх зүйн хувьд Үндэсний татварын албаны дүрмийн Улсын төсөв орлого бүрдүүлэлтийн нэгж, хяналт шалгалтын ажлын нэгжийн байцаагч нар томилолтыг олгохдоо гээд заасан байдаг, энд Ерөнхий газар гэсэн нэг ч үг үсэг байхгүй. Яг энэ дагуу хяналтын хэлтсийн даргыг томилолтоо олгосон гэж үзэж байгаа. Ийм учраас би удирдлагаас өгсөн томилолтын дагуу үүрэгт ажлаа гүйцэтгэсэн учраас энэ бол надад хамааралгүй гэж мэдүүлэг өгсөн. «КЖЭМ» ХХК-ийн хувьд би зөвхөн 2005 оны татварын тайланг шалгасан. Энд зөрчил гаргаагүй учраас үүнтэй холбоотой бусад асуудлыг би мэдэхгүй гэсэн хариулт өгсөн. 2013 оны 12 сарын 2-ны өдөр сэжигтнээр байцааснаас хоёр хоногийн дараа 2013 оны 12 сарын 4-ний өдөр намайг яллагдагчаар татаж байцаасан. Би яллагдагчаар татсан дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй. Өнөөдөр ч би хууль зүйн дагуу үйл ажиллагаа явуулсан, ямар нэгэн хууль дүрэм зөрчөөгүй гэдэгтээ итгэлтэй байна. Би өмгөөлөгч аваагүй, өмгөөлөгч авах боломж ч олдоогүй. Өмгөөлөгч авах уу гэхэд нь надад өмгөөлөгч авах шаардлага байхгүй гэсэн. Шүүхийн шатанд өмгөөлөгч авсан. Шинжээчийн

дүгнэлт үндэслэлгүй байна, хуулийн зүйл заалтыг нь нягталж харна уу гэж байцаагч н.У-т хүсэлт тавьсан. Үүнийг шийдвэрлэж өгөлгүй шууд прокурорт шилжүүлсэн. Гэтэл нэг өдөр прокурор дээр дуудаад, тэр өдрөө шууд шүүхэд шилжүүлсэн байгаа. Ямар нэгэн тайлбар, нотлох баримт өгөх боломж олдоогүй. Өөрийн байдлын болон хууль бус шинжээчийн дүгнэлтийн талаар би прокурорт хүсэлт гаргасан. Үүнийг бас шийдээгүй. Мөн шүүхийн байгууллагад би тайлбар бичиж өгсөн боловч аль ч шатанд хэргийн байдлыг тогтоохын тулд эрүүгийн хуулийн 16.1-т заасан цагаатгах яллах талын баримтыг бүрдүүлээгүй, хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн байдлаар тогтоох үүргээ биелүүлээгүй гэж үзэж байгаа. Хурлын эхэнд би прокуророос асуусан, 35.1-д хамтран оролцогч гэсэн заалт байна, би хэнтэй хамтран оролцсон талаар асуухад Ч.Га-тэй хамтран оролцсон гэсэн. Тэгэхээр нэгдүгээрт хамтран оролцсон, хоёрдугаарт «ХБЭ» компани дээр ганцаараа шалгалт хийсэн, гуравдугаарт «КЖЭМ» ХХК-д илтгэх хуудас бичсэн гэж буруутган яллах дүгнэлт үйлдсэнд нь тайлбар өгөх хэрэгтэй гэж бодож байна. Гэрчийн мэдүүлгээр Чингэлтэй дүүргийн байцаагч С.Ба, Д.Бр, татварын хяналт шалгалтын тасгийн дарга н.Ба нарын мэдүүлгээр 8 сарын 2-ны өдөр томилгоогүйгээр «КЖЭМ» ХХК-д шалгалт хийсэн байсан. Би Чингэлтэй дүүргийн 2010 оны хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой байцаагч нарын акт илтгэх хуудсуудыг харж байсан. Үүнээс харахад зөвхөн «ШЭ» ХХК-д 2010 оны 9 сарын 24-нд шалгалт хийгдсэн, бусад нь 2010 оны 9 сарын 27-ны өдрөөр бичигдсэн байсан. Хяналт шалгалт, арга зүйн хэлтсээс 9 сарын 30-нд томилгоо өгөгдсөн байдаг. Надад 2010 оны 9 сарын 18-ны өдөр «ХБЭ» ХХК-д хяналт шалгалт явуулах томилгоо ирсэн. Шалгалтыг би 2010 оны 10 сарын 18-нд хийсэн. Чингэлтэй дүүргийн татварын хяналт шалгалтын хэлтсийн дарга Н-д Татварын ерөнхий газраас хяналт шалгалтыг хийлгэе гэсэн албан бичиг явуулан энэ бүх процесс явагдсан байхад намайг хэнтэй хамтарсан гээд байгаа нь ойлгомжгүй байна. Мөн би 9 сарын 1-ний өдрөөс 10 сарын 5-ны өдрийг дуустал ээлжийн амралттай байсан. Энэ бүх процессыг явагдсан байхад би амарч байсан гэдгээ цагаатгах баримтад оруулсан байгаа. Иймээс хамтран гүйцэтгэсэн гэж буруутгагдаж байгаа нь нотлогдохгүй гэж үзэж байна.

Төрийн албан тушаалтан албан тушаалаа урвуулан ашигласан гэсэн зүйл заалтын талаар ярья. Шинжээчийн хэлсэнчлэн хяналт шалгалтын албаны байцаагчид бид ч мөн хууль эрх зүйн хүрээнд нотлох баримт дээр тулгуурлан акт баримтаа гаргадаг. Бид анхан шатны баримт, хөндлөнгийн мэдээлэл, нотлох баримтуудын хүрээнд хяналт шалгалтыг хийдэг. Хууль дүрмийн дагуу үндсэн үүргээ гүйцэтгэж байхад ямар албан тушаал эрх мэдлээ ашигласан тухай хэргийн материалд байхгүй байгаа. «ХБЭ» ХХК дээр Чингэлтэй дүүргийн байцаагч Л.А, Г.Б нар шинжээчийн дүгнэлт гаргасан. Дүгнэлт дээр гэрээний асуудал яригддаг. Ашигт малтмалын хайгуулын мэдээлэл худалдах, худалдан авах буюу лиценз шилжүүлэх гэрээ, тусдаа бас дахиад лиценз шилжүүлэх гэрээ гэсэн хоёр гэрээний асуудал яригддаг. Мэдээлэл худалдах, худалдан авах гэрээ нь ашигт малтмалын хайгуулын хөрөнгөтэй холбоотой хуримтлагдсан зардлын дүнгээр нөгөө талдаа эрх шилжүүлсэн гэрээ байдаг. Шинжээчийн дүгнэлтэд лиценз шилжүүлэх гэрээг орхигдуулсан байсан. Мэдээлэл худалдах худалдан авах гэрээний 1 тэрбум 88 сая төгрөгөө үндэслээд шууд 32 тоот акт бичсэн байдаг. Яагаад ингэж бичсэнийг нь би одоо болтол ойлгохгүй байгаа. Хайгуулын тусгай зөвшөөрөл авснаас хойшхи хугацааны зардлыг хайгуулын үнэлгээ хүртэл оруулсан байдаг, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад биет бус хөрөнгө гэдгийг заагаад хүлээн зөвшөөрчихсөн байхад яагаад үүнийг эрх борлуулсан орлого гэж үзээд байгаа нь ойлгомжгүй юм. «КЖЭМ» ХХК-аас 12 ширхэг хайгуулын лиценз авснаа Кадастрын албанд бүгдийг буцаан өгсөн байдаг. Энэ юуг харуулж байна вэ гэхээр хайгуулын үйл ажиллагаа эрсдэлтэй, тодорхойгүй, хэрвээ нөөц хангалтгүй бол компани үйл ажиллагааны зарлага гэж хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн байгууллагын Олон улсын стандартад хайгуулын зардлыг бүртгэхдээ 2 янзаар бүртгэдэг. Нэг нь Үйл ажиллагааны зардал, нөгөө нь хуримтлуулах гэсэн зардлаар бүртгэдэг. «ХБЭ» ХХК, «КЖЭМ» ХХК нь үйл ажиллагааныхаа зардлыг хуримтлуулах буюу капиталжуулах аргаар хийсэн байсан. 2004 онд Монголд Улсад Олон Улсын стандартын дагуу батлагдаад 2006 оноос хэрэгжиж эхэлсэн. 2011 оны 1 сард 12 тоот Сангийн сайдын тушаалаар ашиглалтын болон хайгуулын холбоотой зардлыг хэрхэн бүртгэх журмыг гаргасан

байгаа. Үүнээс өмнө аж ахуйн нэгжүүд үйл ажиллагааны зардалд эсвэл урьдчилж төлсөн гэсэн дээр бүртгээд явж байсан. Хавтаст хэргийн материалаас харж болно, урьдчилж төлсөн хэсэгт хайгуулын зардлуудыг бичээд явсан байгаа, санхүүжилт гэсэн хэсэгт хөрөнгө оруулалтаа бичсэн байдаг. «ХБЭ» ХХК-ийн 2007 оны санхүүгийн тайлан дээр 1 тэрбум төгрөгийн орлогыг урт хугацааны санхүүжилт гээд тусгасан байдаг. Нийт 1 тэрбум 200 сая төгрөгөөс урт хугацааны хөрөнгө оруулалтын бусад дансанд 631 сая төгрөгийн үлдэгдэл бүртгэгдсэн байдаг. Яагаад ингэв гэхээр 9 лицензийг буцааж, 685 сая төгрөгийг санхүүгийн тайлангаар үйл ажиллагааны зардал хэмээн хүлээн зөвшөөрч бүртгэсэн байдаг. Ингээд бүртгэсэн байхад яагаад үүнийг эрх гэж төлөөд байсан юм бэ? Лицензийг үнэ төлбөргүй шилжүүлсэн байхад ямар үндэслэлээр 30%-ийн татвар авах юм бэ? Гэрээндээ мэдээллийг 1 тэрбум 88 сая төгрөгөөр борлууллаа гээд мэдүүлсэн, нөгөө тал нь лицензээ үнэ төлбөргүй шилжүүлсэн гэсэн байхад шинжээч ийм дүгнэлт гаргасан нь үндэслэлгүй байна. Би өөрөө мэргэшсэн нягтлан бодогч, нөгөө талаар би татвар төлөгчдөд олон улсын стандарт, Сангийн сайдын тушаалын дагуу хичээл заадаг учраас миний өөрийн дүгнэлт хууль зүйн үндэслэлтэй. «ХБЭ» ХХК-тай холбоотойгоор «КЖЭМ» ХХК-ийн 2007 оны илтгэх хуудас, илтгэх хуудасны хавсралтад «ХБЭ» ХХК-ийн худалдаж авсан лицензтэй холбоотой орлогыг НӨАТ-ын тайланд тусгаагүй гэсэн 962 сая төгрөгийн зөрчил бичсэн байгаа. Үүний борлуулалтын орлогын НӨАТ-ыг 45 гэсэн актаар НӨАТ-ын баталгаажуулалтын алба ногдуулсан байгаа. Орлогын ногдлыг санхүүгийн тайланд тусгасан, НӨАТ-ыг ногдуулсан, ийм баталгаатай баримтуудыг хооронд нь шинжлээд оногдуулсан. «ХБЭ» ХХК-ийн хувьд 1 тэрбум 88 сая төгрөгөөр мэдээлэл борлуулсан гэсэн өртгийн дүнгээр эрхээ борлуулсан байна гээд үйлдсэн нь үндэслэлгүй юм. «КЖЭМ» ХХК-ийн хувьд би зөвхөн 2005 оны татварын тайланг шалгасан. П.Га байцаагч хэллээ, бид нарыг 2005-2009 оны тайланг шалга гэсэн томилгоог 2010 оны 9 сарын 30-нд өгсөн. Ж бид хоёр «ХБЭ» ХХК-д 2010 оны 10 сарын 25-ны өдөр шалгалтаа хийж дуусган дүгнэлтээ гаргасан. Мөн 2010 оны 10 сарын 25-ны өдөр Ж бид хоёрыг «КЖЭМ» ХХК-д шинээр шалгалт хийхээр оруулсан байгаа. Ингэхдээ Ж бид хоёрт он

зааж өгөөгүй. Үүнийг юугаар нотлох вэ гэхээр 2005 оны аж ахуйн нэгжийн орлогын албан татвар төлөлтийн тооцоолол дээр миний гарын үсэг байгаа, 2006 оных дээр Ж байцаагчийн гарын үсэг байгаа. 2007-2009 оны илтгэх хуудас дээр П.Га байцаагчийн гарын үсэг байдаг. Татварын ерөнхий хуулийн 47.7-д заасанчлан Хяналт шалгалтын байцаагч нь шалгалтад оролцоогүй бол шалгалтын акт, дүгнэлт, хавсралт тооцоонууд дээр гарын үсэг зурж болохгүй гэсэн байдаг. Хяналт шалгалт хийсэн байцаагч нар нэг дүгнэлт нэг акт тухайн аж ахуйн нэгж дээр бичнэ гэж заасан байдаг. Нэгдсэн акт дээр гурвуулаа гарын үсэг зурна. Хавсралт тооцоонуудын хувьд нэг нэгээрээ гарын үсэг зурдаг. Ийм учраас «КЖЭМ» ХХК дээр 2005 онд зөрчил илрээгүй тул надтай холбоотой асуудал яригдахгүй байх гэж үзэж байна. «ХБЭ» ХХК дээр хоёр гэрээ байхад нэг гэрээгээр тооцсон, иймээс энэ яллах дүгнэлтийг үндэслэлгүй байна гэсэн тайлбарыг гаргасан гэв.

8. Н.Чи-аас:- Намайг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан зүйл ангиар яллаж байна. Би албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж, энэ хэргийг хийгээгүй, гэмт хэрэгт хамтран оролцсон оролцогч биш. Би “ХЭ” ХХК-д Татварын хяналт шалгалтын хэлтсийн албаны даргын томилолтоор ажил үүргийн дагуу 2005-2009 оны татвар ногдуулалтад шалгалт хийж 332 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 50 сая төгрөгийн акт үйлдэж, татвар ногдуулсан. Уг 50 сая төгрөгийн актаар 16 сая төгрөгөөр бууруулаад 33 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэхээр 2010 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр 980020 тоот акт үйлдсэн. Тус шалгалтыг би хууль дүрмийн дагуу хийж гүйцэтгэсэн. Уг нотлох баримтууд хавтаст хэрэгт авагдсан байгаа. Үндэсний татварын албаны 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан үндэсний татварын хяналт шалгалтын дүрмийн 2.2.6 дахь хэсэгт заасан заалтыг зөрчсөн гэж дүгнэлт гаргасан байгаа. Тус дүрмийн 2.2.2-т Улсын татварын хяналт шалгалтын нэгж, Нийслэл, аймаг, дүүргүүдийн татварын газар, хэлтэс болон Хяналт шалгалтын нэгжийн дарга нь татварын ахлах байцаагчдыг хяналт шалгалт хийлгэхээр томилохдоо дараах бодлого чиглэлийг баримтална. 2.2.6-д хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэй

багаар хийх гэж заасан нь татварын ахлах байцаагчийн хэрэгжүүлэх заалт биш, Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн татварын улсын ахлах байцаагчдыг татвар ногдуулалт төлөлтийн байдалд хяналт шалгалт хийлгэхээр томилолт олгоход хамаарахгүй. Уг заалтаар Татварын ерөнхий газрын улсын байцаагчийг тус дүрмийн заалтыг зөрчсөн гэдэг нь үндэслэлгүй байна. Мөн Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтэс татварын ерөнхий газраас хяналт шалгалтын дүрмийг хэрхэн ойлгож хэрэгжүүлдэг талаар лавлагаа авсан байдаг. Үүний дагуу татварын ерөнхий газрын даргын орлон гүйцэтгэгч Д.Б 2013 оны 07 дугаар сарын 14-ний өдөр 1224 тоот Татварын ерөнхий газрын хяналт шалгалт эрхэлсэн арга зүйн хэлтсээс бусад хяналт шалгалт эрхэлсэн дарга нарт татварын улсын байцаагч нар хяналт шалгалт хийхдээ 2 ба түүнээс дээш бүрэлдэхүүнтэйгээр багаар хийх бодлого чиглэлийг баримталж байна гэж бичиг явуулсан байдаг. Энэ хууль дүрмийг зөрчсөн гээд байгаа зүйл заалтыг татварын албанд ингэж ойлгож хэрэгжүүлж байгаа юм. Авлигатай тэмцэх газраас татварын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн 2008-2012 оны бүх хяналт шалгалтад хамрагдсан татвар төлөгчдийн судалгааг гаргасан байгаа. Үүгээр 2007-2012 онд нийт татвар төлөгчдийн 60-аас дээш хувьд нь байцаагч нар дангаараа шалгалт хийсэн байна гэж гарсан. “ХЭ” ХХК-д 2005-2009 оны татвар төлөлтийн байдалд шалгалт хийж 896 сая төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийснийг илрүүлсэн байтал татварын улсын байцаагчийн акт бичсэн гэж байгаа. Татварын хяналт шалгалтаар ийм зөрчил илрээгүй, би түрүүн хэлсэн 332 сая төгрөгийн зөрчил илрээд акт тогтоосон гэж. Ийм учраас Татварын ерөнхий хуулийн 33.2.6-т заасан эрүүгийн хэрэгт дүгнэлт хийх эрх зүйн үндэс байхгүй юм. Гэтэл энэ хэрэг дээр шинжээчээр ажилласан Чингэлтэй дүүргийн татварын байцаагч Ц.Б, С.Ба нар 2013 оны 11 дүгээр сарын 11-нд илт буруу дүгнэлт гаргасан. Нэгдүгээрт Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутгаагүй гадагш нь шилжүүлсэн төлбөр 1 тэрбум 980 сая төгрөгийн орлогоос 397 сая төгрөгийн татвар суутгаж төлөөгүй гэсэн байна. Аж ахуйн нэгжийн орлогын татварын тухай хуулиар Монгол Улсад байрладаг, Монгол Улсад байдаггүй татвар төлөгч гэж 2 хуваадаг. Монгол Улсад байдаг татвар төлөгч нь мэдээж Монгол Улсын

хуулийн дагуу үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд байна. Эдгээр нь Монгол Улсад олсон орлогоосоо татвар төлдөг. Харин Монгол Улсад байдаггүй татвар төлөгч буюу гадаадын аж ахуйн нэгж Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Монгол Улсын дагуу үйл ажиллагаа явуулах бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүрэгтэй байдаг. Би татварын хяналт шалгалтаар гадагшаа шилжүүлсэн төлбөр болох “ХЭ” ХХК дээр хайгуулын лицензийг шалгаж байх явцдаа гадаадын компаниудаар хайгуулын тодорхой үйл ажиллагаа гүйцэтгүүлсэн ажил нь татварын хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа гүйцэтгэгдсэн байсан. Үйл ажиллагааных нь зарим нэг хэсэг дээр нь акт ногдуулаад, ногдуулаагүй хэсэг дээр нь зөрчил тооцоод акт тооцсон. Харин шинжээч нар гадаадын компаниудын Монгол Улсын нутаг дэвсгэрт гүйцэтгээгүй орлогод нь татвар ногдуулсан байдаг. Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 1.2-т Монгол улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж олсон орлогод албан татвар ногдуулна гэж заасан байдаг. Шинжээч нар энэ хуулийн заалтыг зөрчсөн. Мөн шинжээчийн дүгнэлтэд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 11.2.9-г-д заасныг зөрчсөн байдаг. Нүүрсний дээжийг тус компани Австрали улсад шинжилгээ хийлгэсэн байдаг. Энэ нь хавтаст хэрэгт авагдсан байгаа. Мөн шинжээчийн дүгнэлтийн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 11.2.9-ийн В заалт нь удирдлагын зардал төсөвт албан татвар ногдуулах. Энэ удирдлагын зардал гэдгийг Улсын дээд шүүхийн тайлбарт байгаа. Мэргэжилтэн гэрээгээр буюу харилцан тохиролцож ажлуулсны үндсэн дээр ногдсон орлогыг хэлнэ гэж байгаа. Гэтэл танай компани гадаадын хуулийн этгээдээр ажил гүйцэтгүүлснийг удирдлагын зардал гэж үзэх үндэслэл байхгүй. Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр тус хуулийн 11.2.9-ийн г-д нэмэлт өөрчлөлт орсон. Гэтэл шинжээч нар тус заалтыг үндэслээд хуулийг буцаан хэрэглэсэн байдаг. «ХЭ» ХХК-ийн 2001-2009 оны үйл ажиллагаанд албан татвар ногдуулахдаа 2012 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдсөн тус хуулийн заалтаар хуулийг буцаан хэрэглэсэн. Мөн Сангийн сайдын 2001 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн 18

тоот, 2009 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 281 тоот тушаалаар батлагдсан Нэмэгдсэн өртгийн албан татварын хасалт хийх, буцаан олгох, тэдгээрийн нягтлан бодох бүртгэлтэй холбоотой харилцааг зохицуулсан журам байдаг. Тус журмын 6.3, 1.4.9-т заасан заалт. «ХЭ» ХХК нь 2009 онд 14493 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн газрын төлбөрт 8 сая 155 мянган төгрөгийг төл гэсэн дүгнэлт гарсан. Газрын тухай хуулиар бол би түрүүн дурдсан 100% гадаадын хөрөнгө оруулалттай компани. Хуульд гадаадын хөрөнгө оруулалттай компани нь газрыг ашиглаж болно гэж заасан байдаг. Аж ахуйн нэгж газрыг ашиглуулах талаар гэрээ байгуулж, хуулийн дагуу газрын төлбөр ногдуулах үүрэгтэй байдаг. Энэ талаар Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Засаг даргын Тамгын газрын дарга албан тоотод «ХЭ» ХХК нь 2009 онд газар ашиглаагүй гэсэн байдаг. 2010 оноос тус сумын Засаг даргатай гэрээ байгуулаад газрын төлбөрийг төлөөд явсан байдаг. Лицензтэй талбайн мэдээлэл худалдсан талаар: Ашигт малтмалын тухай хуулийн 49.2-т заасны дагуу гэрээгээр шийдсэн байдаг. «КЖЭМ» ХХК нь «ХЭ» ХХК-д хайгуулын лицензид талбайн мэдээлэл борлуулсан байдаг. «ХЭ» ХХК нь худалдаж авсан үүргээ хүлээхгүй. Учир нь Монгол улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.5-д биет бус хөрөнгийг заасан байгаа, үүнд ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл хамаарна гэж. Өөрөөр хэлбэл, биет бус хөрөнгө буюу ашигт малтмалын хайгуулын мэдээллийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 11.1-д заасны дагуу 10% буюу шаталсан хувиар албан татвар ногдуулна. Шинжээчийн дүгнэлтээр «ХЭ» ХХК нь «КЖЭМ» ХХК-иуд харилцан хамааралтай гэж дурдсан байдаг. Харилцан хамааралтай компанийг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 6.1-д заасны дагуу энэ 2 компани харилцан хамааралтай биш юм. Харилцан хамааралтай нь тогтоогдоогүй байдаг. Мөн 2008 оны Татварын ерөнхий хуулийн 14.1-д заасны дагуу торгууль алданги ногдуулсан байдаг. Татварын орлогоо нуун дарагдуулсан бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол татварын улсын байцаагч нь 30% хүртэл хэмжээний торгууль алданги тооцно гэж заасан байдаг. Эцэст нь шинжээч нар илт хууль бус, хуулийг буруу хэрэглэсэн байдаг. Үүнд шүүх

бүрэлдэхүүн анхаарлаа хандуулаарай гэв.

9. Б.Жр-аас:-Намайг яллах дүгнэлтэд албан тушаалаа урвуулан ашиглаж ганцаараа шалгалт хийсэн гэж яллаж байна. Энэ хүмүүс ганцаараа шалгасан гэдэг дээр хангалттай тайлбар хэлсэн байна. Авлигатай тэмцэх газраас энэ талаар 2013 оны 05 дугаар сард Хяналт шалгалтын газрын дарга ганцаараа шалгах боломжтой юм уу гэсэн лавлагаа авсан байдаг. Тус лавлагааны хариуг 2013 оны 05 дугаар сарын 14-нд Авлигатай тэмцэх газраас манайд ирүүлсэн байдаг. Энэ нь ганцаараа шалгах заалт Татварын ерөнхий газрын улсын байцаагчид хамаарахгүй байна гэсэн хариултыг Авлигатай тэмцэх газар авсан боловч мөрдөн байцаагч хавтаст хэрэгт хийгээгүй байна. Буруутгах талын бүх баримтыг цуглуулсан, харин цагаатгах талын баримтыг аваагүй байна. Ганцаараа шалгасан талаар “ШЭ” ХХК-д би өөрөө дур мэдэж шалгалт хийгээгүй. Татварын ерөнхий газрын хяналт шалгалтын хэлтсийн даргын томилолтын дагуу 2010 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр шалгалт хийсэн. Тус компани 2005-2008 оны хооронд үйл ажиллагаа явуулаагүй компани байсан. Шалгалтаар татварын зөрчил илрээгүй. Энэ компани Өмнөговь аймгийн Манлай суманд Шүтээн нэртэй газар ашигт малтмалын хайгуулын лиценз эзэмшиж байсан. Гэхдээ газрын харилцааны эрх үүрэг үүсээгүй байсан. Тус газраа огт ашиглаагүй, ашигт малтмалын тусгай зөвшөөрлөө ашигт малтмалын хэрэг эрхлэх газарт буцаагаад өгсөн гэсэн. Энэ талаар газрын харилцааны эрх үүсээгүй гэж Өмнөговь аймгийн Манлай сумын газрын харилцааны асуудал эрхэлсэн байцаагч нь бичиг ирүүлсэн. Газар ашиглах ашиглалтын лиценз гэдэг өөр асуудал байгаа. Ямар ашиглалт хийж байна гэдгийг тооцож ногдуулдаг байгаа. “ШЭ” ХХК нь 2012 онд татан буугдсан, 2005-2008 онд ашиглалтын лиценз эзэмшиж байсан гэхдээ ашиглалт олборлолт огт явуулаагүй гээд лицензээ буцаагаад олгосон байдаг. Тийм учраас 46 сая 900 мянган төгрөгийг төлөх үндэслэлгүй юм. Татвараас зайлсхийсэн гэх үндэслэл байхгүй. Татварын улсын байцаагч П.Га, Ө нарын “КЖЭМ” ХХК-ийн татварын ногдолд хяналт шалгалт хийгээд илрүүлээгүй байдаг. “КЖЭМ” ХХК дээр П.Га байцаагч 2007-2009 оны санхүүгийн баримтыг, Ө байцаагч 2005 оны санхүүгийн баримтыг шалгасан. Би 2006 оны санхүүгийн баримтыг 2013 оны 10 дугаар сарын 25-нд шалгах томилолт аваад

шалгалт хийсэн байгаа. “КЖЭ” ХХК дээр 2006 онд шалгалтаар гарсан зөрчлийн талаар ярьж: 2006 оны 1 дүгээр сарын 14-нд “ХЭ” ХХК-тай “КЖЭМ” ХХК нь гэрээ байгуулаад 2006 оны 01 дүгээр сарын 14-нд лицензийг шилжүүлсэн байгаа. НӨАТ-ын хуучин хууль үйлчилж байсан. Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2006 оны 7 дугаар сарын 8-нд батлагдсан. 2006 оны 7 дугаар сарын 3-нд “ХЭ” ХХК-д эрх шилжүүлсэн, тусгай зөвшөөрлийг худалдан борлуулж орлого олоогүй, 2006 онд “КЖЭМ” ХХК компани НӨАТ төлөгч байгаагүй. Шинжээч нар үүнийг сайн авч хэлэлцээгүй, хохирлын хэмжээг тогтоохдоо байцаагч нар 15% бодоод, буруу бодсон байсан. Шинжээч нар бид нарын хийсэн дүгнэлт дээр шалгалт хийгээгүй. Дүгнэлт бичээгүй гэдэг дээр тийм хэмжээний зөрчил илрээгүй, зөрчил илэрсэн, гэхдээ дүгнэлт бичих хэмжээний зөрчил илрээгүй юм гэв.

10.О.Бя-гээс:- 2013 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхэлж намайг хорьсон, 2 сарын дараа ажлаас түдгэлзүүлсэн байдаг. Өнөөдрийг хүртэл би ажилгүй байгаа. Өнөөдөр миний өөрийн амнаас үнэнийг сонсох хэрэгтэй. Намайг шинжээчийн дүгнэлтийг үндэслээд шүүхийн шатанд ирүүлсэн байна. Би ямар нэгэн хэрэг хийгээгүй гэдгээ төрийн сүлдний өмнө хэлье. Шинжээч нарын дүгнэлт үндэслэлгүй гэдгийг хуулийн заалтын дагуу тайлбарлаж хэлэхэд: Үндэсний татварын ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Үндэсний татварын албаны татвар хяналт шалгалтын ажлын дүрэм”-ийн 2.2.6 дахь заалтыг зөрчин “ЭрЭ” ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийсэн гэж яллаж байна. Гэтэл тус дүрмийн 2.2.6 заалт нь Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын ахлах байцаагчдыг татвар төлөгчийн татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийлгэхээр томилолт олгоход хамаарахгүй. Энэ заалтыг татварын улсын ахлах байцаагчийн хэрэгжүүлэх заалт биш. Татварын ерөнхий газраас бусад татварын албадын хяналт шалгалтын хэлтэс, тасгийн даргын мөрдөх заалт юм. Иймд ТЕГ-ын хэлтсийн газрын даргын олгосон 37 дугаартай Татварын хяналт шалгалт хийх томилолтын дагуу “ЭрЭ” ХХК-д ганцаараа татварын хяналт шалгалт хийсэн нь хууль

зүйн үндэслэлтэй байсан. Би хяналт шалгалт арга зүйн хэлтэст 2004 оноос ажиллаж эхэлсэн байгаа. Томилолтын дагуу хяналт шалгалт хийсэн нь хуулийн дагуу байсан. Би татварын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн Татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа буюу тус дүрэм мөрдөгдөж эхэлснээс хойш, 2008 онд “АНЭ” ХХК, “Ано” ХХК, 2009 онд “ТӨЭЭ” ХХК, “ТОА” ХХК “МУИАО”, “ЭЭЯМА” ХХК, “РФ” ХХК, “ЭАА” ХХК, “АУМ” ХХК, 2010 онд “ШГ” ХХК, “Билгүүн хүслэн” ХХК, “ЭрЭ” ХХК, 2011 онд “КШ” ХХК, 2008-2011 онд нийт 12 ХХК, 3 иргэний татвар ногдуулалт, төлөлтийн байдалд Татварын хяналт шалгалт хийх томилолтын дагуу ганцаараа хяналт шалгалт хийсэн нь Монгол Улсын хууль тогтоомж болон Үндэсний татварын албаны хяналт шалгалтын ажлын дүрэм зүйл заалтыг зөрчөөгүй байдаг. Уг шалгалтаар “ЭрЭ” ХХК-ийн 2005-2009 оны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу хийсэн хяналт шалгалтаар 313.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн 2006 оны 7.994.7 мянган төгрөгийн алдагдлыг бууруулж 7.681.6 мянган төгрөг болгон 2010 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн хууль эрх зүйн үндэслэлтэй 08 дугаартай Илтгэх хуудас бичсэн. Гэтэл шинжээчээр томилогдсон Чингэлтэй дүүргийн татварын улсын байцаагч Ц.Б, С.Ба нар “ЭрЭ” ХХК-ийн 2005-2009 оны татварын ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, тус ХХК-ийг 2 төрлийн зөрчил гаргасан гэж үзэж захиргааны хариуцлага хүлээлгэн, 2013 оны 11 сарын 05-ны өдөр илт гүтгэсэн хууль эрх зүйн үндэслэлгүй 01 дугаартай шинжээчийн дүгнэлт гаргасан. Тухайн илтгэх хуудаст ийм хэмжээний татвар төлөх дүн огт байгаагүй. Шинжээчийн дүгнэлтээр тусгаагүй, мөн газрын төлбөр төлөөгүй гэж үзсэн нь үндэслэлгүй, би үүнийг зөрчил гэж үзэхгүй байна. Шинжээчийн дүгнэлтээр “ЭрЭ” ХХК нь эрх борлуулсны орлого 700.783.296.44 төгрөгийг “КЖЭМ” ХХК-д олгохдоо санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэл, тайлан болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тайланд тусгаагүй татвар ногдуулан төсөвт төлөөгүй нь хууль зөрчсөн байна гэж үзсэн байгаа. Гэтэл шинжээч нар лицензит талбайн мэдээлэл худалдсаны орлогыг эрх борлуулсны орлого гэж үзсэн нь хууль эрх зүйн үндэслэлгүй байна. Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлийн

8.2-т эрх борлуулсны орлогод эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад төлбөртэй шилжүүлснээс олсон орлогыг хамруулна гэж заасныг буруу хэрэглэн, лицензит талбайн мэдээлэл борлуулсныг эрх борлуулсан орлого гэж үзсэн нь хууль эрх зүйн үндэслэлгүй шинжээчийн дүгнэлт гарсан гэж үзэж байна. Монгол Улсын Татварын хууль тогтоомжид ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл борлуулсны орлогыг эрх борлуулсны орлогод хамруулна гэсэн зүйл заалт байхгүй. Харин Монгол Улсын аж ахуйн нэгжийн орлогыг албан татварын тухай хуульд ашигт малтмалыг хайгуулын тусгай зөвшөөрлийг биет бус хөрөнгөд хамруулж, уг тусгай зөвшөөрлийг худалдсаны орлогыг биет бус хөрөнгө борлуулсны орлогод хамруулахаар зохицуулсан. Мөн нягтлан бодох бүртгэлийн тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад лицензид талбайн мэдээлэл болон ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг эрх гэж үзэхгүй, биет бус хөрөнгө гэж үзэж нягтлан бодох бүртгэл хөтөлж, тайлан тэнцэл гаргахыг шаардсан байдаг. Өнөөдөр ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч бүх компаниуд Монгол Улсын сангийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 12 дугаар тушаалаар Санхүүгийн олон улсын стандарт хэрэгжүүлэх зорилгоор баталсан “Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх журам”-ыг мөрдөж байна. Мөн Монгол Улсын Сангийн яамны тусгай зөвшөөрөл бүхий “ОА” ХХК, “ТОА” ХХК, “ДЭБЖА” ХХК-иуд “ЭрЭ” ХХК-ийн 2006-2009 оны санхүүгийн тайланг шалгаж, нягтлан бодох бүртгэлээ хөтөлсөн, хөрөнгө, үйл ажиллагаагаа бүгдийг нь зохих журмын дагуу зөв бүртгэсэн байна гэж шалгалтаар баталсан байдаг. Иймд “ЭрЭ” ХХК, “КЖЭМ” ХХК-иуд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу тайлан тэнцэл гарган, татварын тооцоо хийсэн байхад их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн гэж үзэх нь хууль эрх зүйн үндэслэлгүй байна. Хавтаст хэрэгт байгаа шинжээч Ц.Б-гийн мэдүүлэгтэй танилцсан. Ямар ч баримт журнал үзэхгүйгээр дүгнэлт гаргаад байгааг гайхаж байна. Санхүүгийн анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн тайлан болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тооцоог хийсэн байхад,

гаргаж өгөөгүй хийгээгүй, татвар төлөхөөс зайлсхийсэн мэтээр татварын байцаагчийг үндэслэлгүйгээр буруутгасан, гүтгэсэн болох нь байцаалтад өгсөн мэдүүлэгт нь байдаг. Тэгээд шинжээч нарт буруу дүгнэлт гаргасан байна гэж үзэж захиргааны хариуцлага тооцсон байгаа. Авлигатай тэмцэх газраас шинжээчээр томилогдсон Чингэлтэй дүүргийн татварын улсын байцаагч Б.Ба, С.О нар мөн энэ 2 компанийн татвар төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01 дугаартай шинжээчийн дүгнэлт гаргахдаа зөрчил гэж үзээгүй Ц.Б, С.Ба нарын дүгнэлтийг үгүйсгэсэн байдаг. Мөн шинжээч Ц.Б, С.Ба нарын дүгнэлтээр “ЭрЭ” ХХК нь ашигт малтмалын хайгуулын болон ашиглалт явуулж буй талбайнууддаа газрын төлбөр төлөх үүрэгтэй байна. Тус компани нь 2005-2009 оны хооронд газрын төлбөр төлөөгүй, тус компанид шилжиж ирснээс хойш нийтдээ 74.4 төгрөг төлөхөөр байна гэж гарсан байдаг. Шинжээч нар Монгол Улсын Газрын тухай хууль, Газрын төлбөрийн тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль холбогдох хууль тогтоомжуудыг зөрчиж газрын төлбөр ногдуулсан, төлбөрийн хэмжээг тооцохдоо буруу аргачлал хэрэглэсэн байдаг. Тухайлбал: “ЭрЭ” ХХК нь 13262А тоот ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч болсноор газар ашиглах эрхтэй боловч 2008, 2009 онд 245 гектар газрыг ашиглаагүй, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын захирамж гараагүй, тус ХХК-д газар ашиглуулах гэрээ байгуулж, гэрчилгээ аваагүй байхад газрын төлбөр төлөгч биш, газрын төлбөр төлөх үүрэггүй юм. Мөн Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын тамгын газрын дарга Л.Б-гийн 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 23 тоот бичигт «ЭрЭ» ХХК нь зөвшөөрлөөр олгогдсон газрыг 2008, 2009 онд ашиглаагүй ба Сумын Засаг даргын захирамж гарган уг компанийг газрын төлбөр төлөгч биш гэж тодорхойлсон. «ЭрЭ» ХХК-ийг хэн гэдэг хүн, ямар шалтгаанаар шалгаж байгааг мэдээгүй, мэдэх шаардлага, үүрэг байдаггүй бөгөөд 0037 дугаартай Татварын хяналт шалгалт хийх томилолтыг үндэслэн 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 08 дугаартай илтгэх хуудас бичихдээ гагцхүү хууль, түүнд нийцүүлэн гаргасан эрх зүйн актыг удирдлага болгон, хууль дээдэлж, бусдын нөлөөнд үл автан татвар төлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн ажилласан нь гэмт

үйлдэл гэж үзээд байгаад гомдолтой байна. Эцэст нь хэлэхэд өнөөдөр энэ шүүх хуралдаанд шинжээч нарын үндэслэлгүй гаргасан дүгнэлтээр гүтгүүлээд зогсож байна. Шүүх бүрэлдэхүүн хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтыг үндэслээд хуулийн дагуу үнэн зөвөөр шийдэж өгөхийг хүсэж байна гэв.

11. Ч.Да-гээс:-Би энэ 263.2 дугаар зүйлийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Учир нь төрийн албан хаагч албаны эрх мэдлээ урвуулан ашигласан гэсэн зүйл заалт байгаа. Би өөрөө төрийн албан хаагч биш гэхээр намайг 35.4 зүйлд заасныг журамласан юм гээд Авлигатай тэмцэх газрын байцаагчийн дүгнэлтэд байгаа. Энэ нь бусдыг гэмт хэрэг үйлдэхэд ятгах, заналхийлэх, зоригжуулах, өдөөн турхирсан гэсэн байгаа юм. 6 компанийг шалгасан шалгах талаар мэдээллийг би өгсөн нь үнэн, гэхдээ Татварын ерөнхий газрын дарга Ц.Га-тэй уулзсан ярьсан үгсэн хуйвалдсан зүйл байхгүй. Энэ 6 компанийг шалгасан байцаагч нарыг ятгасан заналхийлсэн тийм зүйл байхгүй, энэ хүмүүсийг би танихгүй, хэрэг шүүхэд шилжсэний дараа бие биенээ мэддэг болсон. Дараагийн яллаж байгаа зүйл анги нь 150.3 гэсэн зүйл ангийн хувьд ЭҮ-тэй байгуулсан 2 гэрээн дээр эрүүгийн хэрэг үүсгэсэн байгаа. Нэг нь татварыг үр ашигтай байлгах гэрээ, татварын хууль тогтоомжийн мөрдөлтийн талаар татварыг оновчтой үр ашигтай болгох гэсэн 2 үндсэн зөвлөх үйлчилгээний чиглэл байдаг. Энэ удаа 2 дахь зөвлөх үйлчилгээг сонгосон юм. Анх ЭҮ-тэй гэрээ байгуулахад гэрээ нь үнэгүй байсан. Бид нар санал өгөхдөө үр ашгийг бий болгох үр ашгийн үйлчилгээний хөлс 20% гэсэн санал өгсөн боловч ЭҮ 10% гэрээ байгуулъя гэсэн. Ингээд ЭҮ-тэй 10% гэрээ байгуулсан. ЭҮ-ийн татварын төлөлт ногдуулалтын талаар зөвлөх үйлчилгээ үзүүлэхдээ гэрээний дагуу зөвлөх үйлчилгээний тайлангаа өгсөн. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 12-т заасны дагуу ЭҮ-ийн татвар ногдох орлогоос хасагдахгүй гэж заасныг хэлсэн байгаа. Монгол Улсын Засгийн газар нь 30 гаруй оронтой татвар ногдуулах олон улсын гэрээ байгуулсан байгаа. Энэ гэрээний дагуу Аж ахуйн нэгжийн хувь хүний орлогын албан татварын дагуу төлөх ёстой татварыг Олон улсын гэрээтэй байгууллагад хөнгөлөлт үзүүлдэг, үүний дагуу олон улсын гэрээг дагаж мөрдөнө гэсэн заалтыг барьсан

байдаг. Монгол Улсаас гадаадад ногдуулсан татвар дээр Монгол Улсад ногдуулсан татвар төлдөг байсан. Энэ талаар манай зөвлөмжийн дагуу 5.3 тэрбум төгрөг татварын үр ашиг болно гээд тайлбарлаад өгсөн. Үүнийг ЭҮ-ийн татварын товчооны дарга Ч.Га гэж хүн шалгаад зарим хэсгийг нь хүлээн зөвшөөрөхгүй гээд 4.7 тэрбум төгрөгийг боломжтой гээд ажил хүлээж авсан акт гарсан байдаг. Энэ актын дагуу гэрээний зөвлөх үйлчилгээг өгөөд явж байсан. ЭҮ улсын төсвийн 10% орчим бүрдүүлдэг томоохон аж ахуйн нэгж байгаа. Манай зөвлөмжүүдийг ЭҮ хэрэгжүүлсэн, хэрэгжүүлэхдээ 2011 онд зарим зөвлөмжүүдийг 2012 онд мөн адил хэрэгжүүлсэн. Зөвлөмжүүдийн тайлбар өгсөн хугацаа ЭҮ-ийн зөвлөмж хэрэгжүүлсэн хугацаа зөрүүтэй байдаг. Энэ нь юу гэсэн үг вэ гэхээр би зөвлөх үйлчилгээний тайлбарыг 2012 оны 01 дүгээр сарын 03-нд өгсөн байдаг. Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиар аливаа аж ахуйн нэгж санхүүгийн тайлангаа 2 дугаар сарын 10-ны дотор өгөх ёстой байдаг. Өөрөөр хэлбэл, ЭҮ манай зөвлөмжийг авсан учраас 38 хоногийн дотор шийдвэрлэсэн байдаг. Дараа нь Татварын ерөнхий газраас лавлагаа авсан байгаа, лавлагаан дээр 596 сая төгрөгийн үр ашиг буюу залруулга хийсэн гэсэн байдаг. ЭҮ үнэхээр энэ зөвлөмжийг хэрэгжүүлээгүй юм уу гэхэд хэрэгжүүлсэн байдаг. ЭҮ 8.1 тэрбум төгрөгийн ашиг олсон гэж заасан байдаг. 3 бүрэлдэхүүнтэй шинжээчийн дүгнэлт гаргахдаа шинжээч нар сайн ойлгоогүй юм уу гэсэн бодолтой байна. Дараагийн асуудал нь ЭҮт сургалт явуулж МУИС-ийн багш нараар нягтлан бодогч нартаа үнэлгээ гаргасан байсан. Тэгээд нягтлан бодогч нар нь онол сайн байгаа боловч практик муу байсан гэсэн дүгнэлттэй байсан. Тэгээд ЭҮ нягтлан бодогч нарынхаа мэдлэгийг дээшлүүлье гэсэн үүднээс сургалт явуулах боломжтой юу гэсэн саналыг манайд тавьсан. Үүний үндсэн дээр ЭҮ-тэй 48 сая төгрөгөөр сургалтын гэрээг байгуулсан. Энэ гэрээний дагуу 80% болох 38.4 сая төгрөг эхлээд авсан. Бид нар Нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнтэй туслан гүйцэтгэх гэрээ байгуулж, үүний дагуу 18 сая төгрөгийг сургалтаар гэрээнд өгсөн байдаг. ЭҮ-ээс авсан мөнгө сургалтаар нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнд төлсөн мөнгөний зөрүүгээр намайг 20.4 сая төгрөгийг шамшигдуулсан гэж үзээд байдаг. Би яагаад энэ мөнгийг хүлээн зөвшөөрөхгүй байна вэ гэвэл би нягтлан бодогч нараас

эхлээд 2 удаа тест авч байсан. Энэ тестийг боловсруулаад ЭҮ-ийн удирдлагад өгч байсан. Практик талын мэдлэгтэй болох хэрэгтэй байна гэсэн үүднээс 8 удаагийн сургалт явуулсан байгаа, үүнээс манайх гэрээний дагуу 6 удаа сургалт явуулсан. Сүүлийн 2 удаагийн сургалт нь санхүүгийн тайлангийн шинжилгээ, аудит, цогц бодлого, шалгалт гэсэн сургалтыг ЭҮ-ийн захирал Б.Жал гэж хүн зөвшөөрч гарын үсэг зурсан. Тэгэхээр 20.4 сая төгрөгийг би завшсан гэж үзэхгүй байгаа. 20.4 сая төгрөг цэвэр ашиг биш юм. Яагаад гэвэл 3 сараас 7 сар хүртэл би цагдан хоригдсон байгаа. Тэгээд би ЭҮ-ийн ерөнхий захиралд сургалтаа үргэлжлүүлэх саналтай байна гэдгээ хэлсэн. Тэгтэл үргэлжлүүлэхгүй гээд үлдсэн 2 удаагийн сургалтаа мөнгөндөө бодоод авъя гэж хэлсэн. Би 6 удаагийн сургалт зохион байгуулсан байсан. Нэг удаагийн сургалт нь 6 сая төгрөг байдаг. Тэгээд татвараа нэмээд 39.6 сая төгрөг болсон. Харин ЭҮ надад 38.4 сая төгрөг өгсөн, үндсэндээ би ЭҮ-ээс 1.2 сая төгрөгийн авлагатай байгаа. Үнийн дүнгийн хувьд 20.4 сая төгрөг нь цэвэр ашиг биш. 34.9 сая төгрөгөөс Нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн туслан гүйцэтгэх гэрээнд 18 сая төгрөг өгснийг хасаад 15.6 сая төгрөг, үүнээс ЭҮт 2-3 удаа томилолтоор явсан зардал хасах ёстой. Би сургалтын үйлчилгээний үйл ажиллагаанд байнга хяналт тавьж байсан, тодорхой зардал гардаг байсан. Би «СА» ХХК-д 500 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байсан. Шинжээч нарын дүгнэлт дээр шамшигдуулсан гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Учир нь «СА» ХХК-тай гэрээ байгуулсан, тиймээс энэ компанийн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээд юм гэв.

12. Х.Ха-гээс:- ЭҮ-ийн орлогч нягтлан бодогчоор 35 жил ажиллаж байна. Энэ хугацаанд ЭҮ-ийг нэг ч төгрөгөөр хохироож байгаагүй, үүнийгээ би хаана ч бардам хэлнэ. Өнөөдөр намайг сэжигтэн болгож байгаад би их гайхаж байна. ЭҮ-тэй хийсэн гэрээг би хийдэггүй, манай захирал хийдэг. Мөн тендертэй холбоотой асуудлыг би мэдэхгүй, яаж хийдгийг, мөнгө яаж шилжүүлдгийг би бас мэдэхгүй, надад тийм эрх үүрэг байхгүй, би зөвхөн ЭҮ-ийн тайлан балансыг гаргадаг. Би ийм аймаар ял сонсоно гэж насандаа бодож байгаагүй. Би хэрэгтэн болоод сууж байна, юу болоод байгааг ойлгохгүй байна. Би энэ гэрээг хийлцээгүй, энэ гэрээ манай татварын хэлтсийн асуудалтай холбоотой

байсан болохоор танилцлаа л гэсэн гарын үсэг зурсан байдаг. Би гэрээ батлагдаад ирсний дагуу холбогдох материалыг гаргаж өгсөн. Би гэрээтэй холбоогүй ч гэсэн энэ нь татварын төлөлт, ногдолтой холбоотой зөвлөх үйлчилгээний гэрээ байсан. Д.Га гэж хүнд би энэ тайлантай танилц гээд өгсөн. Д.Га үүнтэй танилцаад үнэ цэнийн бууралтын алдагдлыг сайн ойлгохгүй байна, бусдыг нь ойлгож байна, гадаадын худалдан авсан урьдчилгаа төлбөрт татварт ногдох 12% чөлөөлөгддөг юм болов уу, үүнийг тодруулж өгөөч гэж байсан. Би Ч.Да-д буцааж өгөөд, манайх үүнийг үндсэндээ хүлээн зөвшөөрч байгаа юм байна гэж хэлсэн. Миний оролцоо ердөө л энэ. Хүмүүс зөвлөх үйлчилгээний талаар буруу ойлголттой байсан. Гаднаас хүмүүс ирээд баахан мөнгө аваад явсан мэтээр ойлгосон байсан. Манайх зардлаа буруу нэрлэснээс болоод үнэ цэнийн бууралтын алдагдлыг татварын хуульд заавал алдагдалд тооцдоггүй юм байна лээ. Гэтэл манайх алдагдалд оруулаад тооцсон байдаг. «СА» ХХК-ийн зөвлөмжийн дагуу үүнийг хасагдахгүй зардалд оруулаад 2010 оноос 2011 оны 09 дүгээр сарын байдлаар 2 тайлан авсан байгаа. Ингээд 2.5 миллиард төгрөгийн хэмнэлт гаргаж болох нь гэсэн зөвлөмж өгсөн байдаг. Мөн Монгол Улсад олсон орлогын 20% татварын хуулийн дагуу гэрээ хийсэн байгууллагынхаа үнийн дүн дээр нэмж тогтоож өгдөг. Татвар төлөлтөөс зайлсхийхгүй байлгах, урьдчилан сэргийлэх талаар гадаадын 30 гаран улстай манай улс олон улсын гэрээ хэлэлцээрийг хийсэн байдаг. Мөн манайд үүн дээр нэмүү өртгийн албан татвар дээр зөвлөмж өгснөөр 1 миллиард 364 сая төгрөг алдсан байна гэж зөвлөмж өгсөн байдаг. Нэмэгдсэн өртгийн албан татварын үйлчлэх хүрээ гэдгийг манай нягтлангууд ойлгоогүй байсан. Танайх 2010, 2011 онд нийтдээ 5 миллиард төгрөг хэмнэх боломжоо алдсан байна, манай зөвлөмжөөр засаж залруулбал үр өгөөж улам их гарна гэсэн зөвлөмжийг уг компани өгсөн байсан. Төлбөрийн тооцоо, Үр ашгийг тооцоолсон тооцоолол байгаагүй. Гэрээг дүгнэх ганц тооцоолол бол 5 сая 306 мянган төгрөгийн тооцоо байсан, өөр тооцоо байгаагүй. Сүүлд нь гүйцэтгэх ажлынхаа тайлан дээр бий болох үр өгөөж дараагийн жилээс гарна гэж байсан. 2011 онд 833 сая төгрөгийн татварын үр өгөөж нь гарсан байсан. ЭҮ энэ зөвлөмжөөс ашиг олж байсан. Жил ирэх тусам нэмэгдээд явж байсан. Энэ

зөвлөмж ашигтай зөвлөмж байсан учраас захирлуудынхаа шийдвэрийг үнэн зөв юм гэж үзэж байсан. Бид нар энэ үйлдвэрийг хохироож байгаагүй, хохироох ч үгүй, үнэн зөв зүйл хийж явсан. Би сургалтад суусан. Уг сургалт үнэхээр үр өгөөжтэй ашигтай сургалт болж байсан. Манай нягтлангууд жижиг байгууллагын тайланг ч гаргаж чадахгүй байсан. Эцэст нь хэлэхэд миний хийсэн зүйл үнэн зөв байсан гэв.

13. Б.Жал-аас:-ЭҮ 17 төрлийн татвар төлдөг байгаа. Улсын төсөвт 103 тэрбум төгрөг илүү төлсөн байдаг. Дээрээс нь нэмэгдсэн өртгийн албан татварт 43 тэрбум төгрөг илүү төлсөн байдаг. Үүнийг 2008, 2009, 2010 оны илүү төлсөн мөнгөө ав гэж тогтоолоор үүрэг өгсөн байдаг. Би 2010 оны 04 дүгээр сарын 15-нд ажлаа хүлээж аваад яагаад илүү төлөлт хийдэг юм бэ гэж тодруулсан. Юундаа байна, манай нягтлангуудад байна уу гэж үзээд, «СА» ХХК-д зөвлөх үйлчилгээ авах талаар хандсан. Бид нар зөвлөх үйлчилгээ авахдаа ямар нэгэн тусгай төлбөр байхгүй, тодорхой үр ашгийн 10% өгнө гэсэн үнийн дүнтэй үйлчилгээ авсан. Зөвлөх үйлчилгээ явуулсны дараа 5.5 тэрбум төгрөг ашиг олох байсан байна, энэ боломжийг та нар алдсан байна гэж гарсан. 2004 оны 7 сард Орос Монголын Засгийн Газрын хэлэлцээрээр татвар төлснөөс хойш 2013 он хүртэл 50 тэрбум төгрөг хүртэл илүү төлсөн байдаг. Тэгээд зөвлөх үйлчилгээ байгуулж 5.3 тэрбум гэсэн саналтай орж ирээд, заримыг нь хасаад 4,7 тэрбум төгрөгийг хүлээн зөвшөөрөөд, бид нар тайлангаа 2012 оны 01 дүгээр сарын 03-нд бэлэн болгоод хүлээлгэж өгсөн. Бид нарын хийсэн 4 залруулга 3 тэрбум 366 сая төгрөг болсон. Биет болсон өгөөж нь 883 сая төгрөгийг 30 хоногийн дотор биелүүлсэн байдаг. Үүнийг Авлигатай тэмцэх газраас, Татварын ерөнхий газар ЭҮ-ээс ийм залруулга хийсэн үү гэж асуусан байдаг. Тэгэхэд нь Татварын ерөнхий газрын улсын төсвийн орлого бүрдүүлэлтийн дарга н.А 4 төрлийн залруулга хийсэн гэсэн байдаг. 595 сая төгрөгөөс 12% бодоод 72 сая төгрөг болсон, үлдсэн нь 5 тэрбум төгрөгийг улсыг хохироосон гэж үзээд байгаа, уг нь улс хохирсон зүйл байхгүй 883 сая төгрөгийн ашгаа авсан байдаг. Дээрээс нь шинжээч нар 2012, 2013 оныг үзээгүй байгаа, хэл ус нь болохгүй байсан юм уу яасан юм. 2012 оны 08 сарын 06-ны ерөнхий захирлын тушаал гарсан байдаг, үүнд 2 тэрбум 416 сая

890 мянган төгрөгийн үнэ цэнийн бууралт хийсэн акт үйлдээд 12 хүн гарын үсэг зурсан байдаг. Дараа нь 2013 онд шинэ захирал томилогдоод мөн 12 хүн гарын үсэг зураад 3 тэрбум 51 сая 545 төгрөгийн үнэ цэнийн бууралт хийсэн байдаг. Яагаад Татварын хэлтэст өгсөн 3 залруулгаар явж байгаа юм бэ, бусдыг нь яагаад тооцохгүй байна. ЭҮ-ийн балансыг хэн нэг хүн өөрчлөх боломжгүй. Тиймээс өнөөдөр ЭҮ 2012, 2013 оны эхний 9 сарын байдлаар 8 тэрбум 104 сая 145 мянган 770 төгрөгийн өгөөж үүссэн байдаг. Би ямар ч хэрэг хийгээгүй улсад өгөөжийг нь өгсний төлөө ял сонсож болохгүй биз дээ. Дараагийн асуудал нь нягтлан бодогч нарын мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай гэж үүрэг өгсний дагуу сургалт явуулахаар Монгол Улсын Их сургуулийн эдийн засгийн их сургуультай санамж зурсны үндсэн дээр шалгалт авсан байдаг. Уг шалгалтаар суурь мэдлэг муу нь илэрсэн. Ингээд Монгол Улсын Их сургуультай сургалт явуулах гэрээ байгуулсан. Гэрээ байгуулаад 48 цагийн сургалт явагдсаны дараах шалгалтаар дахин хангалтгүй гэж гарсан байдаг. Тэгээд манай нягтлан бодох бүртгэлийн бодлогыг боловсруулсан “СА” ХХК-д хандаад 2 удаа тестээр мэргэжлийн бүсийн шалгалт авсан байдаг. Үүний үндсэн дээр хөтөлбөр боловсруулаад, нийт ажилчдаараа хэлэлцүүлээд, энэ сургалтыг хийлгэе гэж зөвшөөрсний үндсэн дээр гэрээг байгуулсан. “СА” Ххк-аар хөтөлбөр боловсруулж багшийг сонгуулсан болохоос энэ компанийн боловсон хүчнээр хичээл заалгасан зүйл байхгүй. Ингээд 86 сая төгрөгөөр 96 цагийн сургалтыг авсан. Би 2013 оны 01 сарын 30-ны өдөр ажлаа өгсөн. Тэр үед манай нягтлан бодох бүртгэлийн товчооны дарга О хариуцаж байснаас биш Х.Ха гэж хүн ямар ч хамаагүй, тийм болохоор Х.Ха бид хоёрт бүлэглэх ямар ч үндэс байхгүй. Энэ сургалтыг явуулахаар захирамж гараад ажлын хэсэг гарсан. Олон жилийн алдаатай явагдаж байсан зүйлийг нь би олж харж ЭҮ-т ашиг өгөөж гаргаж өгсөн болохоос ямар нэг хувийн сэдэлттэй, өөртөө ашигласан зүйл байхгүй. Өнөөдөр юм хийж болохгүй юм байна, хийсэн хүн нь хэрэгтэн болдог болохоор зүгээр сууж байх ёстой юм байна гэж үр хүүхдэдээ хэлж байна. Ийм юм хийснийхээ төлөө яллагдаад явж байна гэв.

Шүүх хуралдаан дээр хохирогч, иргэний нэхэмжлэгч Татварын Ерөнхий Газрын төлөөлөгч З.Ми-гаас:-Энэ гэмт хэргүүд үйлдэгдсэн нь нотлогдсон гэж үзэх

юм бол доорх хохирлыг гаргуулж өгнө үү гэсэн саналтай байгаа. Иргэний хариуцагч «ПВР» ХХК-с 1.219.368.700, «КЖЭМ» ХХК-с 13.445.598.900, «АФ» ХХК-с 3.747.357.300 төгрөг, нийт 18.412.324.900 төгрөгийн татварын хохирол гаргуулж өгнө үү гэв.

Хохирогч «ЭҮ» ХХК-ийн төлөөлөгч А.Ба-аас: -»ЭҮ» ХХК, «СА» ХХК хоёрын хооронд байгуулсан гэрээ нь 2013 оноос өмнө буюу ЭҮ-ийн шинэ захирал томилогдохоос өмнө байгуулагдсан гэрээ юм. ЭҮ нь зөвлөх үйлчилгээ авснаар татварын үр ашигтай ажиллаж байгаа нь тодруулгаар тогтоогдсон. Тооцоогоор татварын үр ашгийн 1.8 тэрбум төгрөгийн үр өгөөжтэй ажилласан байна гэж гарсан байгаа. Үр ашгийн гэрээгээр нэхэмжлэх зүйл байхгүй. ЭҮ ямар нэгэн хохиролгүй учир нэхэмжлэх зүйл байхгүй. Нэхэмжлэлээсээ татгалзаж байгаагаа албан тоотоор шүүхэд ирүүлсэн. Сургалтын гэрээгээр анх 48 сая төгрөгийн гэрээ байгуулсан. Үүнээс 38 сая төгрөг авсан, үлдсэн мөнгийг нь дүйцүүлээд хаая гэж үйлдвэрийн удирдлагуудтай ярилцаж тохиролцсон, одоо нэхэмжлэх зүйл байхгүй гэв.

Шүүх хуралдаанд шүүгдэгч, хохирогчийн төлөөлөгч, иргэний хариуцагч, шинжээч, гэрчүүдийн мэдүүлсэн мэдүүлгээс гадна доорх нотлох баримтуудыг шинжлэн судлав. Үүнд:

1. Шүүгдэгч Ч.Га-ийн холбогдсон “БАТТ” ХХК-аас татварын улсын байцаагчийн актаар тавигдах нөхөн татвар, хүү торгуулийг багасгаж, хийх ёстой үйлдлээ хийхгүй байхаар амлан, хясан боогдуулах замаар 250.000 ам долларын буюу 295.500.000 төгрөгийг нэхэж онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан гэх хэрэгт гэрч “ВА” ХХК-ны гүйцэтгэх захирал Г.Ба (20-р хавтас. хх-210-211), Д.Он (20-р хавтас. хх-198), Ж.М (20-р хавтас. хх-219), Ч.Эн (20-р хавтас.хх-221), Н.Бт (20-р хавтас.хх-220), Р.Ар (20-р хавтас.хх-213-214), Ц.Со (20-р хавтас.хх-215), Х.Ат (20-р хавтас.хх-205-206) нарын мэдүүлэг, ТЕГ-ын татварын улсын байцаагчийн 2006.05.31-ний өдрийн 300102 тоот дүгнэлт (21-р хавтас.хх-147-148), ТЕГ-ын татварын улсын байцаагчийн 2006.05.31-ний өдрийн 30064. тоот акт (21-р хавтас.хх-143-146), Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2009.10.20-ны өдрийн 98а тоот шийдвэр (27-р хавтас.хх-8-21), Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хуралдааны 2010.01.19-ний өдрийн

36 тоот магадлал (27-р хавтас.хх-22-30), Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2011.11.15-ны өдрийн 191а тоот шийдвэр (27-р хавтас.хх-59-65), Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2012.03.26-ны өдрийн 48 тоот тогтоол (27-р хавтас.хх-77-81), ШШҮХ-ийн 2006.07.27-ны өдрийн 075/063/ тоот шинжээчийн дүгнэлт (27-р хавтас.хх-82-86), Нийслэлийн прокурорын газрын “БАТТ» ХХК-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тогтоолууд (27-р хавтас.хх-88-90,158) болно.

2. Шүүгдэгч Ч.Га-ийн холбогдсон хууль бусаар хөрөнгөжсөн гэх хэрэгт Ч.Га-ийн Баянзүрх дүүргийн ...дугаар хороо..., ...тоот байранд нэгжлэг хийсэн тухай тэмдэглэл (16-р хавтас хх-25-27), мөн түүний оршин суух Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоотод нэгжлэг хийсэн тухай тэмдэглэл (16-р хавтас. хх-45-53), Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо ...аманд орших зуслангийн хашаанд автомашины гаражид байх автомашинд үзлэг хийсэн тэмдэглэл (16-р хавтас.хх-54-55), Татварын ерөнхий газрын ...тоот Ч.Га-ын ажлын өрөөнд нэгжлэг хийсэн тухай тэмдэглэл (16-р хавтас.хх-125-128), 2012.10.20-ны өдрийн ...дүүргийн ...дүгээр хороо ...тоот 257,8м2 талбай бүхий амины орон сууц худалдах, худалдан авах гэрээ (18-р хавтас.хх-12), 2011.02.23-ны өдрийн Газар эзэмших эрх шилжүүлэх тухай гэрээ, иргэн Ч.Га-аас ...дүүргийн ...дугаар хороо, ...нутаг дэвсгэрт байрлах газрыг эзэмших эрхийг иргэн С.Бс-д шилжүүлсэн тухай лавлагаа (17-р хавтас.хх- 92-93), Голомт банкны дансны мэдээллийн хуулбарууд (19-р хавтас.хх-191-193), У.Чи-ийн нэр дээрх Голомт банкны 120120хххх,110302ХХХХ,110503хххх дансны дэлгэрэнгүй хуулга (19-р хавтас.хх-194-208), У.Чи-ийн Голомт банк дахь данс хамтран эзэмшигчийн талаарх баримтууд (19-р хавтас.хх-212-217), гэрч У.Чи (20-р хавтас. хх-137-140), Г.Га (том хүү) (29-р хавтас. хх-112-113), МУЧ (20-р хавтас.хх-120-121), Д.Аз (20-р хавтас.хх-116), С.Бс (20-р хавтас. хх-122), Д.От (20-р хавтас.хх-52-54), Д.Да (20-р хавтас.хх-55-56) нарын мэдүүлгүүд, Гаалийн Ерөнхий газрын 2013.02.15-ны өдрийн 03-3/510 албан тоот (16-р хавтас. хх-247), ШШҮХ-ийн Криминалистикийн шинжээчийн 2013.11.12-ны өдрийн 3614 тоот дүгнэлт (51-р хавтас.хх-27-31), ШШҮХ-ийн Криминалистикийн шинжээчийн 2013.11.28-ны өдрийн 3930 тоот дүгнэлт (51-р хавтас. хх-43-44), Монголбанкны валютын ханшийн

лавлагаа (21-р хавтас.хх-245-250), “ИЭ” ХХК-ийн тээврийн хэрэгслийн зах зээлийн үнэлгээ (21-р хавтас.хх-195), эд хөрөнгө битүүмжилсэн тогтоол (21-р хавтас.хх-188-229) зэрэг болно.

3.Шүүгдэгч Ч.Га, Б.Бу нарын албан үүрэгтээ хайнга хандсан гэх хэрэгт Татварын ерөнхий газрын 2011.07.28-ны өдрийн «АФ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай татварын улсын байцаагчийн акт 980034, Татварын улсын байцаагч Ё.Эт, Р.Ба (20-р хавтас хх-94-98), ТЕГ-ын дэргэдэх татварын маргаан таслах зөвлөлийн 2011.10.14-ийн өдрийн 45 тоот тогтоол (20-р хавтас хх-91-93), хохирогч ТЕГ-ын төлөөлөгч З.Ми-гийн мэдүүлэг (28-р хавтас хх-147-151), “АФ” ХХК-г эрэн сурвалжлах тухай Чингэлтэй дүүргийн шүүхийн 2012.07.04-ийн өдрийн 1050 тоот шийдвэр, гэрч Ч.Бтр (20-р хавтас хх-40-41), Ё.Эт (20-р хавтас хх-183-184), Н.Чи (20-р хавтас хх-224), Д.Б (20-р хавтас хх-181-182), Д.Баа (20-р хавтас хх-42), Ч.У (20-р хавтас хх-217) нарын мэдүүлгүүд, Б.Бу нь Ч.Ут “АФ” ХХК-ийн акт шийдвэрийг хүлээлгэн өгсөн тэмдэглэл (20-р хавтас хх-218), “АФ” ХХК-ийн 2011 оны санхүүгийн тайлан (29-р хавтас.хх-147-161), ТЕГ-ын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн ажлын байр албан тушаалын тодорхойлолт (19-р хавтас.хх-185-187), ТЕГ-ын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн татварын улсын ахлах байцаагч Б.Бу-ийн ажлын байрны тодорхойлолт (19-р хавтас.хх-188-189), Ч.Га, Б.Бу нарыг ажилд томилсон тушаалын хуулбар зэрэг болно.

4. Шүүгдэгч Ч.Га албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Ч.Да-тэй үгсэн тохирч О.Бя, Б.Жа, Н.Чи, Б.Өс, Н.Ра, П.Га нараар “ХБЭ” ХХК, “ЭрЭ” ХХК, “БАЭ” ХХК, “ХЭ” ХХК, “КЖЭМ” ХХК, “ШЭ” ХХК-иудын татварын ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийлгүүлэн 13.398.688.100 төгрөгийн татварыг ногдуулалгүйгээр татварын байцаагчийн илтгэх хуудас, акт гаргуулан төсөвт төвлөрөх ёстой онц их хэмжээний хохирол учруулсан гэх хэрэгт гэрч Ж.Дэ (50-р хавтас хх-118-119), Р.Ба (50-р хавтас хх-121-123), Д.Бр (15-р хавтас хх-8-41), С.Ба (15-р хавтас хх-3-4), Д.Б (8-р хавтас хх-248-249), Ж.Бая (50-р хавтас хх-117) нарын мэдүүлгүүд,

Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч Б.Жа-ын «ШЭ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай

2010.10.25-ны 06 тоот илтгэх хуудас (2-р хавтас хх-99), Татварын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн Татварын улсын байцаагч Б.Өс-ын «ХБЭ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 2010.10.25-ны 07 тоот илтгэх хуудас (2-р хавтас хх-100), Татварын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн Татварын улсын байцаагч О.Бя-гийн “ЭрЭ ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 2010.10.25-ны 08 тоот илтгэх хуудас (2-р хавтас хх-101-103), Татварын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн Татварын улсын байцаагч Н.Ра-гийн «БАЭ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 2010.10.26-ны 09 тоот илтгэх хуудас (2-р хавтас хх-110-11), Татварын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн Татварын улсын байцаагч П.Га, Б.Жа, Б.Өс нарын «КЖЭМ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 2010.11.08-ны 10 тоот илтгэх хуудас (2-р хавтас хх-100,117), Татварын Ерөнхий газрын татварын улсын байцаагч Н.Чи-ын «ХЭ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан 2010.11.01-ний 980020 дугаартай акт, Эд мөрийн баримтаар хураагдсан Р.Ба-ын нэрээр Татварын Ерөнхий газарт бичсэн гомдол, гомдлын хариу (50-р хавтас хх-82-94), Шинжээч Ч.У, З.Э нарын 2013.11.11-ний 01 тоот дүгнэлт («БАЭ» ХХК 50-р хавтас хх-162-16), Шинжээч Ц.Б, С.Ба нарын 2013.11.05-ны өдрийн 01 тоот дүгнэлт («ЭрЭ» ХХК 50-р хавтас хх-182-191), Шинжээч О.Б, Б.Э нарын 2013.11.08-ны 01 тоот дүгнэлт («ШЭ» (50-р хавтас хх-192-206), Шинжээч Ц.Б, С.Ба нарын 2013.11.11-ний 01 тоот дүгнэлт («ХЭ» ХХК 50-р хавтас хх-208-221), шинжээч Л.А, Д.Б нарын 2013.11.11-ний 01 тоот дүгнэлт («ХБЭ» ХХК (50-р хавтас хх-222-234), Шинжээч Б.Ба, С.О нарын 2013.11.14-ний 01 тоот дүгнэлт («КЖЭМ» ХХК 50-р хавтас хх-225-250, 51-р хавтас хх-1-9), Шинжээч Л.А-ыг байцаасан тэмдэглэл (51-р хавтас хх-20 дугаар тал), Шинжээч Ц.Б-г байцаасан тэмдэглэл (51-р хавтас хх-10-11), Шинжээч Б.Бя-ыг байцаасан тэмдэглэл (51-р хавтас хх-18-19), Шинжээч З.Э-г байцаасан тэмдэглэл (51-р хавтас 16-17), иргэний хариуцагч Г.З-ын мэдүүлэг (50-р хавтас хх-113-116), Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм (51-р хавтас хх-131-143), Б.Жр, Б.Өс, Н.Чи, П.Га нарыг ТЕГ-ын ХШАЗ хэлтсийн татварын улсын байцаагчаар томилсон тушаалын хуулбар (51-р хавтас хх-153, 169, 176), О.Бя-г томилсон тушаалын хуулбар

(4-р хавтас хх-138) зэрэг болно.

5. Мөн шүүгдэгч Ч.Га, Д.Эн, Н.Ра, П.Га нар албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулж “УМ” ХХК, “З.У” ХХК, “НТГ” ХХК-ийн татварын акт, дүгнэлтүүдийг хүчингүй болгож шийдвэрлэсэн гэх хэрэгт Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн “ЗУ”, “УМ”, “НТГ” ХХК-иудын албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд яаралтай шалгалт хийлгүүлэх тухай 2010.01.19-ний өдөр Баянгол дүүргийн татварын хэлтэст хүргүүлсэн 26/123 тоот албан бичиг (32-р хавтас хх-96), Баянгол дүүргийн татварын улсын байцаагчийн 2010.02.25-ны “УМ” ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 260007 тоот дүгнэлт (31-р хавтас хх-193-94), Баянгол дүүргийн татварын улсын байцаагчийн 2010.03.19-ний «ЗУ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 260009 тоот дүгнэлт (31-р хавтас хх-195-196), Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2010.02.25-ны “НТГ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 260006 тоот дүгнэлт (31-р хавтас хх-199-200), Татварын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн 2010.04.23-ны өдөр ТЕГ-ын татварын байцаагч П.Га-ыг «УМ» ХХК-д татварын хяналт шалгалт хийлгэхээр, татварын улсын байцаагч Н.Ра-г «НТГ» ХХК-ийн татварын хяналт шалгалт хийлгэхээр тус тус томилсон томиллолт (32-р хавтас хх-26,35), ТЕГ-ын татварын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч П.Га-ын 2010.04.23-ны «УМ» ХХК-ийн татвар төлөлтийн байдалд шалгалт хийсэн талаарх Илтгэх хуудас №02 (32-р хавтас хх-28), ТЕГ-ын татварын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч Н.Ра 2010.04.23-ны «НТГ» ХХК-ийн татвар төлөлтийн байдалд шалгалт хийсэн талаарх Илтгэх хуудас №01 (32-р хавтас хх-27), Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-ын 2010.05.07-ны «УМ» ХХК, «НТГ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан Татварын улсын байцаагчийн 260007, 260006 тоот дүгнэлтийг тус тус хүчингүй болгох тухай 73 тоот тушаал (31-р хавтас хх-189), Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-ын 2010.06.07-ны «ЗУ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж бичсэн Татварын улсын байцаагчийн 260009 тоот дүгнэлтийг тус тус хүчингүй болгох 33 тоот тушаал (31-р хавтас хх-

190), Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын 2013.04.11-ний 9ж/1814 албан тоот, Үндэсний аудитын газрын ахлах аудитор Ц.С, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.А, Татварын ерөнхий газрын хяналт шалгалтын удирдлага, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч Н.Г нарын 2013.11.29-ний шинжээчийн дүгнэлт (36-р хавтас хх-33-46), гэрч Ш.На (28-р хавтас хх-164-166), А.До (28-р хавтас хх-167-169), Г.Бая (28-р хавтас хх-183-185), Д.Бр (32-р хавтас хх-68), Р.Д (32-р хавтас хх-73-76), Ц.Ц (32-р хавтас хх-77-78), Ж.На (32-р хавтас хх-80-81), Шинжээч Н.Г-ын мэдүүлэг (36-р хавтас хх-47-48), шинжээч Б.А (36-р хавтас хх-49-50), Ц.С (36-р хавтас хх-51-52) нарын мэдүүлгүүд, иргэний хариуцагч Б.Б (40-р хавтас хх-37-38)-ын мэдүүлэг зэрэг болно.

6. Шүүгдэгч Д.Эн-ын хууль бусаар хөрөнгөнгөжсөн, татвар төлөхөөс зайлсхийсэн гэх хэрэгт Д.Эн-ын хөрөнгө орлогын мэдүүлэг (30-р хавтас хх-18-51), Авлигатай тэмцэх газар хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс Д.Эн-ын 2007-2011 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хянасан талаарх албан бичиг, гэрч Б.Хү (31-р хавтас хх-151-153), Д.Бс (31-р хавтас хх-166), Д.Цэ (30-р хавтас хх-169-170), Г.Чн (30-р хавтас хх-175-176) нарын мэдүүлэг, “НК” ХХК-ийн санхүүгийн болон орон сууцны гэрээний баримтад үзлэг хийсэн тэмдэглэл, гэрээ төлбөр төлсөн баримтуудын хамт (30 -р хавтас хх-177-184), Д.Эн-аас “ЖМ” ХХК-д мөнгө зээлдүүлсэн санхүүгийн баримтуудад үзлэг хийж хуулбарлан авсан баримтууд (31-р хавтас хх-9-94), иргэн Д.Эн-ын татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 250041 тоот дүгнэлт, шинжээч Ц.С (36-р хавтас хх-51-52)-гийн мэдүүлэг, Д.Эн-ын Голомт банк дахь данснуудын хуулга зэрэг болно.

7. Шүүгдэгч Б.Жа-ын хууль бусаар хөрөнгөжсөн, шинжээчийн дүгнэлт санаатай худал гаргасан гэх хэрэгт Б.Жа-ын Хөрөнгө орлогын мэдүүлэг (40-р хавтас хх-213-218), ОС Үл хөдлөх хөрөнгө зуучлалын компанийн 2013.09.27-ны 69/1 албан бичиг, гэрч Э.Зо (41-р хавтас хх-97), Б.Са (41-р хавтас хх-98), Ү.Сэ (41-р хавтас хх-96), Э.Бо (41-р хавтас хх-95) нарын мэдүүлгүүд, эд мөрийн баримтаар тооцож хэрэгт хавсаргах тогтоол (35х- 230-236), шинжээч Б.Жа-ын Д.Эн-д холбогдох хэрэгт Д.Эн-ын ХООАТ-ыг тооцоолсон талаарх баримт, 2013.08.21-ний өдрийн 164

тоот дүгнэлт (35 дугаар 231-235) зэрэг болно.

8. Шүүгдэгч Ч.Да, Б.Жал, Х.Ха нар бүлэглэн, “ЭҮ” ХХК-д онц их хэмжээний хохирол учруулан, хөрөнгө завшиж, үрэгдүүлсэн гэх хэрэгт ажилд томилсон тушаалууд, ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь (48-р хавтас хх-68-71), ЭҮ-ийн дүрэм (79-92, 107-110, 117-120), Тендер зарлахгүйгээр худалдан авах бараа материал үнэт зүйлсийн жагсаалт, журам (48-р хавтас хх-130-135), Сургалтын гэрээ, мөнгө шилжүүлсэн баримт (43-р хавтас хх-195-199), Зөвлөх үйлчилгээний гэрээ, мөнгө шилжүүлсэн баримт (43-р хавтас хх-210-214), Зөвлөх үйлчилгээний тайлан (48-р хавтас хх-222-230), хохирогч, иргэний нэхэмжлэгч А.Ба (47-р хавтас хх-138-140), Д.Б (47-р хавтас хх-141-142), гэрч БЭ (47-р хавтас хх-143-144), Д.Га (42-р хавтас хх-80), Ж.Дэ (42-р хавтас хх-72-73), Д.Бз (42-р хавтас хх-70) нарын мэдүүлэг, Шинжээчийн дүгнэлт (47-р хавтас хх-1-60), Шинжээч Д.Ш, Д.С нарын мэдүүлэг (47-р хавтас хх-54-161) зэрэг болно.

Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн үед яллах, цагаатгах болон бичгийн бусад нотлох баримтуудыг шинжлэн судалж

ТОДОРХОЙЛБОЛ:

Нэг.Нийслэлийн прокурорын газраас шүүгдэгч Б.Бу-ийг ТЕГ-ын Татварын хяналт шалгалтын удирдлага, арга зүйн хэлтсийн татварын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа хууль тогтоомж, журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлэлгүйгээр, 2011 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн татварын улсын байцаагчийн 980034 тоот актаар «АФ» ХХК-д 3.747.357.3 мянган төгрөгийн төлбөр ногдуулж, Татварын Ерөнхий газрын маргаан таслах зөвлөлийн 2011 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45 тоот тогтоолоор уг актыг үндэслэлтэй гэж үзэн Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст шилжүүлэхээр шийдвэрлэсэн байхад дарагдуулж, тус компанийн татвар төлөгч нарт татвар төлөхөөс зайлсхийх боломж олгож, Монгол Улсын төсөвт төвлөрөх байсан 3.747.357.3 мянган төгрөгийн онц их хэмжээний татварыг төлүүлээгүй, албан үүрэгтээ хайнга хандсан,

шүүгдэгч Ч.Га-ийг дээрх татварын улсын байцаагчийн акт, дүгнэлтийг холбогдох байгууллагад шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулж хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Монгол Улсын төсөвт төвлөрөх байсан 3.747.357.3 мянган төгрөгийн онц их хэмжээний татварыг

төлүүлээгүй албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэг үйлдсэн хэмээн тэдгээрийг Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн боловч шүүгдэгч Ч.Га, Б.Бу нар нь дээрх гэмт хэргийг үйлдсэн болох нь нотлогдон тогтоогдохгүй байна.

Үндэсний татварын ерөнхий газраас Чингэлтэй дүүргийн татварын хэлтэстэй харьцдаг «АФ» ХХК-ийн 2007-2010 оны татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 2011 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн татварын улсын байцаагчийн 980034 тоот акт (20-р хавтас хх-94-98)-аар тус компанид 3.739.595,2 мянган төгрөгийн нөхөн татвар, 4.645,3 мянган төгрөгийн торгууль, 3.116,8 мянган төгрөгийн алданги, нийт 3.747.357,3 мянган төгрөгийн төлбөр ногдуулсан ба тус компанийн гүйцэтгэх захирлын гомдлоор Татварын Ерөнхий газрын дэргэдэх маргаан таслах зөвлөлөөр хэлэлцүүлж, тус зөвлөлийн 2011 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45 тоот тогтоол (20-р хавтас хх-91-93)-оор уг актыг үндэслэлтэй гэж үзэж, хэвээр баталсан байна. 2011 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн Үндэсний татварын ерөнхий газрын даргын 621 тоот тушаал (20-р хавтас хх-88)-аар дээрх тогтоолыг баталгаажуулж, тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (О.Т)-т үүрэг болгож байжээ. 2009 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн Монгол Улсын Засгийн газрын №22 тоот тогтоолоор баталсан «Татварын маргаан таслах зөвлөлийн ажиллах журам»-ын 5.10-д «Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга зөвлөлийн хүчин төгөлдөр шийдвэрийг, түүнийг баталгаажуулсан тухайн шатны татварын албаны даргын тушаалын хамт маргааны оролцогч талуудад гардуулна. Зөвлөлийн нарийн бичгийн дарга тогтоолыг гардуулсан тухай тэмдэглэл хийж, бүртгэнэ» гэж заасан байх тул шүүгдэгч Б.Бу, Ч.Га нар нь Маргаан таслах зөвлөлийн 2011 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45 тоот тогтоолыг маргааны оролцогч талуудад гардуулах үүрэг хүлээсэн эрх бүхий албан тушаалтан биш байсан байна. Нөгөөтэйгүүр «АФ» ХХК-ийн ерөнхий захирал А.Т.В нь маргаан таслах зөвлөлийн шийдвэр гарахаас өмнө буюу 2011 оны 09 дүгээр сарын 18-ны өдөр Монгол Улсын хилээр гарч явсан нь шүүгдэгч Б.Бу-ийг тус компанийн татвар төлөгч нарт татвар төлөхөөс зайлсхийх боломж олгосон гэж буруутгах үндэслэлгүй юм. Түүнчлэн «АФ»

ХХК хуульд заасан журмын дагуу татан буугдаагүй, тус компанийг дампууруулсан тухай шүүхийн шийдвэр гараагүй байх бөгөөд татварын улсын байцаагчийн дээрх акт нэгэнт хүчин төгөлдөр байгаа тул Татварын ерөнхий газраас нэхэмжилсэн 3,7 тэрбум төгрөгийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй.

Мөн прокурорын газраас шүүгдэгч Х.Ха, Б.Жал нарыг бүлэглэн «СА» ХХК-ийн захирал Ч.Да-д давуу байдал олгон, албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 36,37,38 дугаар зүйлүүдийг зөрчиж, «СА»ХХК-тай 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр «ЭҮ» ХХК-ийн Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээний №5/426-11 дугаартай гэрээг байгуулж, гэрээний заалтын дагуу ажлын хөлсийг тооцон олгохдоо үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн 547.496.659 төгрөгийг илүү олгосон хэмээн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 265 дугаар зүйлийн 265.2-т зааснаар,

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлан бэлтгэлтийн талаар сургалт явуулах боловсон хүчний боломжгүй «СА» Ххк-аар дээрх сургалтыг явуулахаар 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн №5/336-12 дугаартай гэрээг 48.000.000 төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр, ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр шууд байгуулан, гэрээний урьдчилгаанд 38.400.000 төгрөгийг шилжүүлэн 20.400.000 төгрөгийг завших боломжийг олгон, байгууллагын хөрөнгийг онц их хэмжээгээр үрэгдүүлсэн хэмээн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар, шүүгдэгч Ч.Да-г Б.Жал, Х.Ха нартай бүлэглэн, «СА» ХХК-ийн нэрээр ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр «ЭҮ» ХХК-ийн Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээний №5/426-11 дугаартай гэрээг байгуулан, зөвлөх үйлчилгээний тайлан гаргаж уг үйлчилгээний хөлсөнд 547.496.659 төгрөгийг илүү завшсан, Санхүүгийн сургалт явуулах боловсон хүчний боломжгүй хэрнээ 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 5/336-12 дугаартай 48,0 сая төгрөгийн үнэ бүхий, «ЭҮ» ХХК-ийн нягтлан бодогчдод нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлан бэлтгэлийн талаар сургалт явуулах тухай гэрээг байгуулан, 20.400.000

төгрөгийг завшиж онц их хэмжээний хохирол учруулсан хэмээн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар тус тус яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн боловч шүүгдэгч Б.Жал, Х.Ха, Ч.Да нар дээрх гэмт хэргүүдийг бүлэглэж үйлдсэн болох нь нотлогдон тогтоогдохгүй байна.

“ЭҮ” ХХК, “СА” ХХК-ийн хооронд байгуулсан “ЭҮ” ХХК-ийн Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээний №5/426-11 дугаартай гэрээ”-г Монгол Оросын хамтарсан “ЭҮ” ХХК-ийн ерөнхий захирал Ч.Га баталж, уг гэрээг тус үйлдвэрийн санхүү хэлтсийн дарга Г.Г, ерөнхий нягтлан бодогч П.М.В, хуулийн хэлтсийн дарга Б.М нар зөвшөөрсөн байхад дээрх гэрээг байгуулсан “ЭҮ” ХХК-ийн Ерөнхий захирлын эдийн засаг эрхэлсэн орлогч Б.Жал болон ерөнхий нягтлан бодогчийн орлогч Х.Ха нарыг албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаар урвуулан ашиглаж, зохих зөвшөөрөл авалгүйгээр дур мэдэн гэрээ байгуулсан гэж үзэх үндэслэлгүй юм. Тус үйлдвэр нь дээрх гэрээний зөвлөмжийн дагуу бүртгэлийн залруулга хийснээр 2013 оны 09 дүгээр сарын байдлаар нийт 8,1 тэрбум төгрөгийн татварын үр ашиг олсон, ямар нэг хохирол учраагүй болох нь хэрэгт хавсаргасан гэрээ, “ЭҮ” ХХК-ийн 2014.01.09-ний БУ-20-12/25 тоот албан бичиг, шүүх хуралдаан дээр гэрчээр мэдүүлсэн “ЭҮ” ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч М.В.П-ын мэдүүлэг зэрэг баримтаар нотлогдож байна.

Түүнчлэн «ЭҮ» ХХК, «СА» ХХК-ийн хооронд “ЭҮ” ХХК-ийн нягтлан бодогчдод Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлан бэлтгэлтийн талаар сургалт явуулах» тухай гэрээг «ЭҮ» ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогч П.М.В захиалагчийг төлөөлж хийсэн байхад шүүгдэгч Б.Жал, Х.Ха нарыг ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр дээрх гэрээг шууд байгуулан, 20.400.000 төгрөгийг завших боломжийг олгон, байгууллагын хөрөнгийг онц их хэмжээгээр үрэгдүүлсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

Дээрх нөхцөл байдлуудаас дүгнэхэд шүүгдэгч Ч.Да-г «ЭҮ» ХХК-ийн онц их хэмжээний эд хөрөнгийг бусадтай бүлэглэж, завшсан болох нь нотлогдон тогтоогдохгүй байна.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.1.1-д заасныг баримтлан Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргээс Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-

т заасан гэмт хэрэгт холбогдсон шүүгдэгч Ч.Га, Б.Бу нарт холбогдох хэргийг, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 265 дугаар зүйлийн 265.2-т заасан гэмт хэрэгт, мөн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан гэмт хэрэгт тус тус холбогдсон шүүгдэгч Х.Ха, Б.Жал нарт холбогдох хэргийг, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан гэмт хэрэгт холбогдсон шүүгдэгч Ч.Да-д холбогдох хэргийг тус тус хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч Б.Бу, Х.Ха, Б.Жал нарыг цагаатгах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Хоёр.

Шүүгдэгч Ч.Га нь Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа 2006 оны 5 дугаар сард тус газраас “ВАТТ» ХХК-д татварын хяналт шалгалт хийж байх үед албан тушаалынхаа байдлыг ашиглан өөрийн танил Ц.Со-оор дамжуулан “ВАТТ» ХХК-д ногдох татвар, хүү торгуулийг багасгаж, албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байхаар урьдчилан амлаж, тус компанийн гүйцэтгэх захирал Г.Бай-гаас 250.000 ам.долларын буюу 295.500.000 төгрөг нэхэж, онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан болох нь гэрч С.Ба-гийн «Жил гаран шалгаад 2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 3,6 тэрбум төгрөгийн акт, 5,4 тэрбум төгрөгийн дүгнэлт бичсэн. Акт, дүгнэлт бичигдэхээс өмнө манай ажилтан Р.Ар руу таньдаг хүнээр нь Ч.Га яриулсан байсан. Энэ яриандаа 250,0 мянган ам доллар өгвөл 1,0 тэрбум төгрөгийн акт бичлээ. Тэгэхгүй бол актын дүнг 2,0 тэрбум төгрөгөөр нэмнэ гэсэн байсан. Би Ч.Га гэж хүнд 250,0 мянган ам доллар өгөхгүй гэдгээ шууд хэлсэн» гэх мэдүүлэг (20-р хавтас хх-210-211), гэрч Р.Ар-ын «Ц.Со ах надад татварын асуудлыг нь зохицуулаад өгч чадах байх гэж хэлсэн ба их өндөр дүнтэй төлбөр яриад байсан, тэрбум гэл үү нэг сая ам доллар билүү тоо яригдаад байсан санагдаж байна. Ц.Со ахын хэлсэн тоо, хувь хэмжээг нь шууд С.Ба-д дамжуулан хэлсэн» гэх мэдүүлэг (20-р хавтас хх-213-14), Ц.Со-ын “Татварын ерөнхий газарт ажилладаг танил надад Ч.Га-ээс өөр байхгүй. Ч.Га-ээс ямар шийдвэр гарах гэж байгаа талаар асууж өгөөч гэж Р.Ар хэлсэн. Би Ч.Га-ээс “ВА” ХХК-ийн шалгалт ямар шатандаа явааг асуухад, дуусаж байгаа, татварын улсын байцаагчийн дүгнэлт бичигдэж байна,

...Тодорхой хэмжээний мөнгө өгвөл татварын акт, дүгнэлтийн тоог бууруулж болох талаар ярьсан. Ч.Га-ийн ярьсан яриаг шууд Р.Ар-од утсаар хэлсэн. Хээл хахууль өгсөн авсан асуудлыг нь мэдэхгүй» гэх мэдүүлэг (20-р хавтас хх-215), гэрч Х.Ат-ийн “Акт дүгнэлт арай эцэслэн гараагүй байхад Татварын ерөнхий газрын даргад танай байгууллагаас 250,0 мянган ам.доллар хээл хахуульд нэхсэн гомдол гаргасан байсан» гэх мэдүүлэг (20-р хавтас хх-205-206),

Татварын улсын байцаагч Х.Ат, О.Бя нарын “ВАТТ” ХХК нь аж ахуйн нэгж, байгууллагын орлого, нэмэгдсэн өртгийн албан татвар ногдох 5.682.420,7 мянган төгрөгийн орлого нуусан” гэх 2006.05.31-ний өдрийн 300102 тоот дүгнэлт (21-р хавтас хх-147-148), «Шалгалтаар илэрсэн зөрчилд нийт 3.606.828,5 мянган төгрөг, 38.439,45 ам долларын төлбөр ногдуулан төлүүлэх» тухай дээрх байцаагч нарын №300649 тоот акт (21-р хавтас хх-143-146), Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2009.10.20-ны өдрийн 98а тоот шийдвэр, Захиргааны хэргийн танхимын давж заалдах шатны шүүхийн 2010.01.19-ний өдрийн 36 тоот магадлал (27-р хавтас хх-22-30), Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2011.11.15-ны өдрийн 191а тоот шийдвэр (27-р хавтас хх-59-65), Дээд шүүхийн хяналтын шатны захиргааны хэргийн шүүх хуралдааны 2012.03.26-ны өдрийн 48 тоот тогтоол (27-р хавтас хх-77-81), ШШҮХ-ийн 2006.07.27-ны өдрийн 075/063/ тоот шинжээчийн дүгнэлт (27-р хавтас хх-82-86), “ВАТТ» ХХК-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн Нийслэлийн прокурорын газрын тогтоолууд (27-р хавтас хх-88-90,158) зэргээр нотлогдон тогтоогдож байна.

2.2. Шүүгдэгч Ч.Га нь 2002 оны 02 дугаар сарын 15-наас 2013 оны 01 дүгээр сар хүртэлх хугацаанд Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж, тухайн албан тушаалын цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа хууль ёсны орлогоосоо гадна өөрийн эцэг У.Чи-ийн нэр дээр хамтран эзэмших тоот америк долларын данс банканд нээж, 2008 оны 7 дугаар сарын 16-наас 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд 1.362.655.48 америк долларын буюу 1.771.358.017 төгрөгийн орлого олсон, мөн У.Чи-ийн нэрээр 110503xxxx тоот төгрөгийн данс банканд нээж 2010 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2013 оны 01

дүгээр сарын 12-ны өдөр хүртэлх хугацаанд 1.073.951.176,93 төгрөгийн орлого олж, хууль ёсны орлогоосоо гадна 2.845.309.194 төгрөг хууль бусаар олж хөрөнгөжсөн болох нь хэрэгт хавсаргаж ирүүлсэн дээрх дансны орлого, зарлагын баримтууд, энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураасан болон битүүмжилсэн түүний 2007-2012 онуудад худалдаж авсан 635,0 сая төгрөгийн үнэ бүхий 6 автомашин, 825.375.400 төгрөгийн гэрээний үнэ бүхий 257,8 м2 талбайтай амины орон сууц, автомашины гараж, 58 сая төгрөгийн үнэтэй шүрэн толгойтой, манан хөөрөг 2 ширхэг, 2012.10.20-ны өдрийн Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоот 257,8 м2 талбай бүхий амины орон сууц худалдах, худалдан авах гэрээ (18-р хавтас хх-12), 2011.02.23-ны өдрийн иргэн Ч.Га-ээс Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...нутаг дэвсгэрт байрлах газрыг эзэмших эрхийг иргэн С.Бсд шилжүүлсэн Газар эзэмших эрх шилжүүлэх тухай гэрээ (17-р хавтас хх-92-93), Голомт банкны дансны мэдээллийн хуулбарууд (19-р хавтас хх-191-193, 194-208, 212-217), мөрдөн байцаалтад У.Чи-ийн гэрчээр мэдүүлсэн “...Голомт банканд миний нэрээр ам долларын болон төгрөгийн данс нээж хийсэн. Энэ хоёр дансанд газар зарсан мөнгөнөөс өөр орлого би хийгээгүй, Ч.Га хүүд хөөрөг өгөөгүй. Мөнгөний үнийн дүн орлого зарлагын талаар мэдэх зүйл алга байна» гэх мэдүүлэг (20-р хавтас хх-137-139), Г.Газ-ын (том хүү) “Машиныг нь хүлээн аваад Г.Газ-д хүлээлгэн өгдөг» гэх мэдүүлэг (29-р хавтас хх-112-113), гэрч МУЧ ийн “НК» ХХК-аас барилгыг анх (257.8 м кв байр) 541.900 ам доллар төлж байр худалдан авах гэрээ байгуулсан. Орон сууц анх худалдан авсан 1 м.кв талбайн үнэ дээр 100 ам.долларын ашиг нэмж зарсан» гэх мэдүүлэг (20-р хавтас хх-120-121), гэрч С.Бсг-ийн “Манай «МХГ» ХХК «Миний хайпер маркет» гэж хүнсний дэлгүүрийн хойд талын 240 м кв талбай бүхий газрыг 2011.02.23-ны өдөр Ч.Га-ээс 20,000 ам доллараар худалдан авсан» гэх мэдүүлэг (20-р хавтас хх-122), гэрч Д.От-ын «Ч.Га дарга миний хөөрөгүүдээс үзэж байгаад шүрэн толгойтой дунд зэргийн халтар манан хөөргийг 26.0 сая төгрөгөөр худалдан аваад, хөөрөгний үнийг шууд бэлнээр өгч байсан. 2012 оны 12 дугаар сарын эхээр Ч.Га дарга хөөрөгүүдийг үзэж байгаад шүрэн толгойтой халтар манан хөөргийг ...32,0 сая төгрөгөөр авсан гэх мэдүүлэг (20-р хавтас хх-52-54), Гаалийн Ерөнхий газрын 2013.02.15-ны

өдрийн 03-3/510 албан тоот (16-р хавтас хх-247), ШШҮХ-ийн Криминалистикийн шинжээчийн 2013.11.12-ны өдрийн 3614 тоот дүгнэлт (51-р хавтас хх-27-31), ШШҮХ-ийн Криминалистикийн шинжээчийн 2013.11.28-ны өдрийн 3930 тоот дүгнэлт (51-р хавтас хх-43-44), Ч.Га-ийн Хөрөнгө орлогын мэдүүлэг, "ИЭ" ХХК-аас ирүүлсэн тээврийн хэрэгслийн зах зээлийн үнэлгээ (21-р хавтас хх-195) болон бичгийн бусад баримтуудаар нотлогдон тогтоогдож байна.

2.3. Шүүгдэгч Ч.Га нь Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргын албан тушаалын байдлаа урвуулан, өөрийн төрсөн дүү, шүүгдэгч Ч.Да-тэй урьдчилан үгсэн тохирч түүгээр 2010 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр "ХБЭ" ХХК, "ЭрЭ" ХХК, "БАЭ" ХХК, "ХЭ" ХХК, "КЖЭМ" ХХК, "ШЭ" ХХК-иудад татварын шалгалт хийлгэх тухай мэдээллийг Р.Ба гэгчийн нэрээр Татварын ерөнхий газарт хүргүүлж, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсээс дээрх компаниудад зохих хуваарийн дагуу хийгдэж байсан шалгалтыг зориуд тасалдуулж, улмаар өөрийн удирдлагад ажиллаж байсан татварын улсын байцаагч, шүүгдэгч О.Бя, Б.Жа, Н.Чи, Б.Өс, Н.Ра, П, П.Га нараар шалгалт хийлгүүлэн, тус компаниуд нь татвар, хүү, торгуульд нийт 13.445.598.900 төгрөг төлөхөөр байхад дээрх нэр бүхий татварын улсын байцаагч нар нь илтгэх хуудас бичих, актын дүнг багасгах зэргээр албаны эрх мэдлээ урвуулан ашигласан болох нь шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Ч.Да-гийн үйлдсэн хэргээ хүлээсэн мэдүүлэг, гэрч Ж.Дэ-ийн "Манай "СА" ХХК-ийн захирал Ч.Да надад хандаж Татварын Ерөнхий газарт нэг бичиг хүргэж өгөх хэрэгтэй байна гэхээр нь би өөрийн хамаатан Р.Ба руу утасдаж регистрийн дугаарыг нь аваад захирал Ч.Да-д өгсөн. Захирал Ч.Да нэг дугтуйтай бичиг өгөөд Татварын Ерөнхий газарт хүргүүлчих гэхээр нь би тэр бичгийг аваад Р.Ба ахад өгч гарын үсгээ зураад өгдөг юм гэсэн шүү гэж хэлээд өгсөн" гэх мэдүүлэг (50-р хавтас.хх-118-119), гэрч Р.Ба-ын "2010 оны 09 дүгээр сарын үед "НА" ХХК-д ажилтай Ж.Дэ таны регистрийн дугаар хэрэгтэй байна гэж яриад миний регистрийн дугаарыг авсан. Тэгээд Ж.Дэ дугтуйтай бичиг гаргаж ирээд надаар гарын үсэг зуруулсан. Татварын ерөнхий газрын бичиг хэрэгт тэр бичгийг надаар өгүүлсэн" гэх мэдүүлэг (50-р хавтас хх-121-123),

гэрч Д.Бр-ын "Миний 2010 оны 8 дугаар сард шалгах аж ахуйн нэгжийн хуваарьт "БАЭ"

ХХК (2006-2009 оны), «ХБЭ» ХХК (2005-2009 оны) хуваарилагдан шалгагдахаар болсон. Хэрэв бид 8 дугаар сарын 26-ны өдөр томилолтоо авсан бол хяналт шалгалт үргэлжлэх хугацаа сар гаруйгаар хэтрэх байсан тул тухайн аж ахуйн нэгжийн баримт материал бүрдсэн үед тасгийн даргадаа танилцуулсны үндсэн дээр томилолтоо авч, шалгалтын ажлаа эхлүүлсэн. Ч.Га дарга «манайд иргэний мэдээлэл ирсэн тул энэ мэдээллийн дагуу манайх шалгахаар болсон гэсэн» гэх мэдүүлэг (15-р хавтас хх-8-41), гэрч Д.Бад-ын «КЖЭМ» ХХК-ийн захирал Г гэж хүний удирдаж байсан компани, аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийлгэхээр 9 байцаагчийг томилсон. "ШЭ" ХХК, "ХБЭ" ХХК, "ЭрЭ" ХХК, "БАЭ" ХХК, "ХЭ" ХХК нэг захиралтай учир нэгэн зэрэг шалгалт оруулах шаардлагатай байсан. Тэгтэл Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн дарга Ч.Га та нар томилолт байхгүй байж шалгалт хийлээ гээд шалгалтыг зогсоож өөрөө шалгалт хийсэн» гэх мэдүүлэг (8-р хавтас хх-248-249),

"НТГ" ХХК ихээхэн хэмжээний орлого болох 697.495,0 мянган төгрөгийн орлого олсон нь баримтаар нотлогдож байгаа тул албан татвар ногдох ихээхэн хэмжээний орлого нуусан гэх» Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2010.02.25-ны өдрийн 260006 тоот дүгнэлт (31-р хавтас хх-199-200), «Тус ХХК-ийн 2007-2009 албан татварын ногдуулалт төлөлтийн байдалд хэсэгчилсэн хяналт шалгалт хийхэд зөрчил илрээгүй, 2010.02.25-ны өдрийн 260006 тоот дүгнэлт бичсэн нь хууль, эрх зүйн үндэслэлгүй» гэх Н.Ра-гийн 2010.04.23-ны өдрийн №01 тоот Илтгэх хуудас (32-р хавтас хх-27),

шинжээч З.Э-гийн "БАЭ" ХХК нь 2007 онд 140.203.300 төгрөг, 2008 онд 19.258.100 төгрөг, 2009 онд 28.167.600 төгрөгийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээний орлогыг гадаадад шилжүүлэхдээ аж ахуйн нэгжийн орлогын татварыг суутган авч төсөвт төлөөгүй, 2008 онд 36.612.000 төгрөг, 2009 онд 48.816.000 төгрөг, нийтдээ 85.428.000 төгрөгийн газрын төлбөрийг тооцож төсөвт төлөөгүй зэргийг илтгэх хуудсанд тусгаагүй байсан» гэх мэдүүлэг (51-р хавтас хх-16-17),

Б.Жа-ын "ШЭ" ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай» 2010.10.25-ны өдрийн 06 тоот илтгэх хуудас (2-р хавтас хх-99), Б.Өс-ын «ХБЭ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг

шалгасан тухай 2010.10.25-ны өдрийн 07 тоот илтгэх хуудас (2-р хавтас хх-100), О.Бягийн «ЭрЭ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 2010.10.25-ны өдрийн 08 тоот илтгэх хуудас (2-р хавтас хх-101-103), Н.Ра-гийн «БАЭ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 2010.10.26-ны өдрийн 09 тоот илтгэх хуудас (2-р хавтас хх-110-111), П.Га, Б.Жа, Б.Өс нарын «КЖЭМ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 2010.11.08-ны өдрийн 10 тоот илтгэх хуудас (2-р хавтас хх-100, 117), Н.Чи-ын «ХЭ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан 2010.11.01-ний өдрийн 980020 дугаартай акт, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан Р.Ба-ын нэрээр Татварын Ерөнхий газарт бичсэн гомдол, гомдлын хариу (50-р хавтас хх-82-94), «БАЭ» ХХК татвар төлөх тухай шинжээч Ч.У, З.Э нарын 2013.11.11-ний өдрийн дүгнэлт (50-р хавтас хх-162-165), «ЭрЭ» ХХК нь татвар төлөх тухай шинжээч Ц.Б, С.Ба нарын 2013.11.05-ны өдрийн дүгнэлт (50-р хавтас хх-182-191), «ШЭ» ХХК татвар төлөх тухай шинжээч О.Б, Б.Э нарын 2013.11.08-ны өдрийн дүгнэлт (50-р хавтас хх-192-206), «ХЭ» ХХК татвар төлөх тухай шинжээч Ц.Б, С.Б нарын 2013.11.11-ний өдрийн дүгнэлт (50-р хавтас хх-208-221), «ХБЭ» ХХК татвар төлөх тухай шинжээч Л.А, Д.Б нарын 2013.11.11-ний өдрийн дүгнэлт (50-р хавтас хх-222-234), «КЖЭМ» ХХК татвар төлөх тухай шинжээч Б.Ба, С.О нарын 2013.11.14-ний өдрийн дүгнэлт (50-р хавтас хх-225-250, 51-р хавтас хх-1-9), дээрх шинжээч нарыг байцаасан тэмдэглэлүүд, Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм (51-р хавтас хх-131-143) болон бичгийн бусад баримтуудаар нотлогдон тогтоогдлоо.

2.4. Мөн шүүгдэгч Ч.Га нь Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргын албан тушаалын байдлаа урвуулан Баянгол дүүргийн Татварын хэлтсээс 2010.02.25-ы өдөр «НТГ» ХХК-нд 6.974.495.000 төгрөгийн зөрчилд нь 260006 тоот дүгнэлт, «УМ» ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан нар 2.786.273.500 төгрөгийн ногдох орлогыг нуусан үйлдэлд 260007 тоот дүгнэлт, «ЗУ» ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан нар 975.852.500 төгрөгийн татвар ногдох орлогыг нуусан үйлдэлд 2010.03.19-ний өдөр 260009 тоот дүгнэлт бичигдэж, Эрүүгийн цагдаагийн газарт шалгуулахаар хүргүүлсний дараа, дахин

шалгалт хийлгүүлж, Н.Ра, П.Га нараар «НТГ», «УМ» ХХК-ийн татвар төлөлтийн байдлыг урьд шалгасан татварын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзсэн хэмээн илтгэх хуудас бичүүлж, шүүгдэгч Д.Эн нь Баянгол дүүргийн татварын хэлтсийн даргын албан тушаалын байдлаа урвуулан 2010.05.07-ны өдрийн 73 тоот тушаалаар дээрх 260006, 260007 тоот дүгнэлтүүдийг хүчингүй болгосноос «ПВР» ХХК-с татварт төлбөл зохих 1.219.368.700 төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй болох нь Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн 2010.01.19-ний өдөр Баянгол дүүргийн татварын хэлтэст хүргүүлсэн «ЗУ», «УМ», «НТГ» ХХК-иудын албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд яаралтай шалгалт хийлгүүлэх тухай» 26/123 тоот албан бичиг (32-р хавтас жж-96), «Татварын улсын байцаагчийн 260007, 260006 тоот дүгнэлтийг тус тус хүчингүй болгох тухай» Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-ын 2010.05.07-ны өдрийн 73 тоот тушаал (31-р хавтас.хх-189), Баянгол дүүргийн татварын улсын байцаагчийн 2010.02.25-ны өдрийн «УМ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 260007 тоот дүгнэлт (31-р хавтас хх-193-94), Баянгол дүүргийн татварын улсын байцаагчийн 2010.03.19-ний өдрийн «ЗУ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 260009 тоот дүгнэлт (31-р хавтас хх-195-196), Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2010.02.25-ны өдрийн «НТГ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай 260006 тоот дүгнэлт (31-р хавтас хх-199-200), Татварын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн 2010.04.23-ны өдөр ТЕГ-ын татварын улсын байцаагч П.Га-ыг «УМ» ХХК-д, татварын улсын байцаагч Н.Ра-г «НТГ» ХХК-д татварын хяналт шалгалт хийлгэхээр тус тус томилсон томиллолт (32-р хавтас хх-26,35), «УМ» ХХК-ийн татвар төлөлтийн байдалд шалгалт хийсэн тухай 2010.04.23-ны өдрийн №02 тоот Илтгэх хуудас (32-р хавтас хх-28), 2010.04.23-ны өдрийн «НТГ» ХХК-д татвар төлөлтийн байдалд шалгалт хийсэн тухай №01 тоот Илтгэх хуудас (32-р хавтас хх-27), «Татварын улсын байцаагчийн дүгнэлт хүчингүй болгох тухай» Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-ын 2010.05.07-ны өдрийн 73 тоот тушаал, 2010.06.07-ны өдрийн 33 тоот тушаал (31-р хавтас хх-189), Цагдаагийн ерөнхий газрын

Эрүүгийн цагдаагийн газрын 2013.04.11-ний өдрийн 9ж/1814 албан тоот,

гэрч Г.Бая-гийн “Эрүүгийн Цагдаагийн газраас албан бичиг ирж, «УМ» ХХК-нд 2008-2009 оны татвар ногдуулалтыг татварын улсын байцаагч Ж.На бид хоёр татварын хяналт, шалгалтыг шалгасан. Татварын хяналт шалгалтаар ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдаж 2,4 сая.ам долларын орлого олсон нь холбогдох санхүүгийн баримтуудаар тогтоогддог. Бид 2,7 тэрбум төгрөгийн дүгнэлтийг бичиж Цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулсан. Гэтэл гэнэт давхар хяналт гэдэг нэрийн доор Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч П.Га дуудаж, бидний бичсэн дүгнэлтийг илтгэх хуудсаар хүчингүй болгохоор болсон гэсэн асуудал ярьж байсан» гэх мэдүүлэг (28-р хавтас хх-183-185), гэрч Д.Бр-ын «Татварын ерөнхий газрын хяналт, шалгалт арга зүйн хэлтсээс «НТГ», «УМ» ХХК-д холбогдуулан бичсэн татварын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэлгүй бичсэн гэсэн илтгэх хуудас ирсэн. Уг илтгэх хуудсыг үндэслэн уг 2 компанитай холбоотой дүгнэлтийг хүчингүй болгох талаар Д.Эн дарга надад үүрэг өгч 2010.05.07-ны өдрийн 73 тоот тушаалын ард боловсруулсан хүнд нь би гарын үсэг зурсан нь миний шууд удирдах эрх бүхий албан тушаалтан болох Д.Эн нь надад үүрэг өгч байгаа болохоор би тушаасан үүргийг нь биелүүлэхээс өөр арга байхгүй юм. Харин Д.Эн даргын 2010.06.07-ны өдрийн 93 тоот тушаалаар «ЗУ» ХХК-д холбогдуулан гаргасан татварын улсын байцаагчийн дүгнэлтийг хүчингүй болгосон тушаалд хэн боловсруулсан, хэн хянасан талаар ямар нэгэн гарын үсэг байхгүй байгаа учраас би уг тушаалын талаар мэдэхгүй. Харин уг тушаалыг үндэслэл болгохдоо Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн илтгэх хуудсыг үндэслэсэн байдаг боловч хэн хэзээ ямар илтгэх хуудас бичсэнийг мэдэхгүй» гэх мэдүүлэг (32-р хавтас хх-68 дугаар тал),

гэрч Р.До-ийн «Манай дүүргийн татварын хэлтэст Эрүүгийн Цагдаагийн газраас болон Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсээс хэд хэдэн аж ахуйн нэгжийн татварын ногдуулалт, төлөлтөд хяналт шалгалт хийлгэх тухай албан бичиг ирсний дагуу «ЗУ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийсэн. Уг аж ахуйн нэгж нь нилээн

хэдэн ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий лицензтэй байсан бөгөөд уг тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөний мэдээллийн лавлагаа гаргуулан, холбогдох газруудаас тодруулан үзэхэд уг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий лицензийг нийт 975.852,5 мянган төгрөгөөр тусгай зөвшөөрөл шилжүүлэх гэрээг байгуулсан байсан бөгөөд энэ талаараа тухайн аж ахуйн нэгж нь татварын тайландаа огт тусгаагүй байсан. Харин уг аж ахуйн нэгж нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий лицензийг худалдан борлуулсан бол Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 30 хувийг татварт төлөх ёстой учраас нийт худалдан борлуулсан үнэ болох 975,8 сая төгрөгийн орлогыг татвараас нуусан, татвараас зайлсхийсэн гэж үзэж татварын улсын байцаагчийн дүгнэлтээ бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлсэн» гэх мэдүүлэг (32-р хавтас хх-73-76),

гэрч Ц.Цо-ын «2010 оны эхээр Эрүүгийн Цагдаагийн газар болон Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсээс албан бичиг ирсний дагуу «ЗУ» ХХК-нд татвар төлөлт, ногдуулалтын байдалд хяналт шалгалт хийх томилолтыг татварын улсын байцаагч Д бид хоёрт өгсний дагуу татварын хяналт шалгалт хийж, татварын улсын байцаагчийн дүгнэлт бичиж хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн» гэх мэдүүлэг (32-р хавтас хх-77-78), гэрч Ж.На-гийн «Манай дүүргийн татварын хэлтэст «УМ» ХХК-ийн татвар төлөлтийн байдалд хяналт шалгалт хийх тухай Эрүүгийн Цагдаагийн газар болон Татварын ерөнхий газрын хяналт, шалгалт арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн гарын үсэгтэй албан бичиг ирсэн. Шалгалтын явцад уг аж ахуйн нэгж нь «ПС» ХХК-д ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий лицензийн хамтаар хувьцаагаа худалдсан гэсэн халхавчаар гэрээ байгуулан, нэг сая төгрөгийн дүрмийн сантай, нэг ч үйл ажиллагаа явуулж байгаагүй атлаа 2,4 сая ам доллараар худалдсан гэсэн гэрээг хийсэн байсан. Уг компанид холбогдуулж бичсэн дүгнэлтийн талаар Татварын ерөнхий газрын хяналт, шалгалт арга зүйн хэлтэст эрх борлуулсны орлого болох 30 хувийн татвараас аж ахуйн нэгжүүд ингэж зайлсхийж байгаа талаар албан тоот хүртэл явуулж байсан, харин дүгнэлтээ Эрүүгийн Цагдаагийн газарт шилжүүлсэн» гэх мэдүүлэг (32-р хавтас хх-80-81),

“Татварын улсын байцаагчид зөрчлийн дүнг гаргахдаа гэрээний дүн, төлбөр шилжүүлсэн дүнг давхардуулан нэмж буруу тооцоолол хийсэн байна. Татвар төлөх үүрэгтэй субъект нь одоогийн “ПВР” ХХК нь “НТГ” ХХК-аас худалдан авсан 1041.Х хайгуулын тусгай зөвшөөрлийн үнэд суутгаж төлөөгүй 472.648.4 мянган төгрөгийн албан татварыг төлөхөөр байна. «ЗУ» ХХК нь нэр бүхий 5 компанитай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлэн авах гэрээгээр 981.652,5 мянган төгрөгийн гэрээ байгуулж худалдан борлуулсан ба албан татвар ногдуулан суутгаж төсөвт төлөх үүрэгтэй» гэх шинжээч Ц.С, Б.А, Н.Г нарын 2013.11.29-ний өдрийн дүгнэлт (36-р хавтас 33-46), шинжээч Б.А-г асуусан тэмдэглэлд “НТГ», «УМ», «ЗУ» ХХК-ууд Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21.5-д заасны дагуу эрх борлуулсан орлого болох 30 хувийн татварыг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан авсан «ПВР» ХХК нь хариуцаж 1.416.249.500 төгрөгийн татварыг улсад төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн болох нь тогтоогдсон» гэх тайлбар (36-р хавтас хх-49-50) болон бичгийн бусад баримтуудаар нотлогдон тогтоогдлоо.

2.5. Шүүгдэгч Д.Эн нь татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа цалингаас өөр орлогын эх үүсвэрээ тодорхойлолгүйгээр Голомт банкны 170501xxxx тоот төгрөгийн хувийн харилцах дансаар 2012 оны 05 дугаар сарын 01-нээс хойш 2013 оны 01 дүгээр сарын 01 хүртэл хугацаанд 53.900.000 төгрөг, 180129xxxx тоот ам долларын хувийн харилцах дансаар дээрх хугацаанд 32.430 ам доллар буюу 45.113.500 төгрөгийн орлого оруулсан, мөн 493.822.000 төгрөгийн орон сууц худалдан авч, нийтдээ 592.835.500 төгрөгийн орлогыг хууль ёсны орлогоосоо гадна олж хууль бусаар хөрөнгөжсөн болох нь Голомт банк дахь түүний хувийн харилцах дансны хуулга, “НК” ХХК-тай 2012.05.23-ны өдөр хийсэн “Орон сууцны захиалга, хөрөнгө оруулалт”-ын КС127313... тоот гэрээ, төлбөр төлсөн баримтууд (30-р хавтас хх-177-184), Д.Эн-ын хөрөнгө орлогын мэдүүлэг (30-р хавтас хх-18-51), гэрч Б.Хү (31-р хавтас хх-151-153), Д.Бс (31-р хавтас хх-166) нарын мэдүүлэг, шинжээч Ц.С, Б.А, Н.Г нарын 2013.11.29-ний өдрийн дүгнэлт (36-р хавтас хх-33-46), “Шалгалтаар Д.Эн нь 2011 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийн орлого хэсгийн “Хөрөнгө орлого” хэсэгт

мэдүүлсэн 119.694.666 төгрөгийн орлогыг бодитой үнэн зөв тайлбарлаагүй, “Газар” хэсэгт Нийслэлийн Засаг даргын 2003 оны 248-р захирамжаар Баянгол дүүргийн 4-р хороонд 1654 м2 газар эзэмшиж байгаагаа мэдүүлээгүй, эхнэр Б.Он-ийн нэр дээр бүртгэлтэй хх-хх УБЭ дугаарын Тоёота Хайландер маркийн суудлын автомашиныг Авлигын эсрэг хуулийн 10-р зүйлийн 10.4-т заасан хугацаанд буюу 30 хоногийн дотор бүртгүүлээгүй зөрчлийг тус тус гаргасан нь тогтоогдож байна” гэх Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн албан бичиг, бичгийн бусад баримтуудаар нотлогдон тогтоогдож байна.

2.6. Мөн шүүгдэгч Д.Эн нь 2008 онд 19.000.000, 2009 онд 241.750.000, 2010 онд 9.851.000, 2011 онд 139.322.500, 2012 онд 90.489.600 төгрөг буюу нийт 500.413.100 төгрөгийн орлого олсон атлаа хувь хүний орлогын татвар ногдуулах орлогоо татварт бүрэн тайлагнаагүй, татварт тайлагнах тоо хэмжээгээ зориуд бууруулан тайлагнаж, 50.041.300 төгрөгийн буюу онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн болох нь “Иргэн Д.Эн нь 2008-2011 онуудад “ЖМ” ХХК-д сарын 1,6-2 хувийн хүүтэй 1.350.000 ам доллар буюу 1.815.004,0 мянган төгрөгийн зээл олгож, зээлийн хүүд 208.800,4 мянган төгрөг хүлээн авсан. 2011-2012 онуудад АНУ-аас импортоор оруулж ирсэн 6 ширхэг Лексус 570 маркийн суудлын авто машин худалдан борлуулсны орлого 974.744,2 мянган төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдсан орлого 665.918,9 мянган төгрөг, үл хөдлөх хөрөнгө түрээслүүлсний орлого 86.693,6 мянган төгрөг, тогтмол бус үйл ажиллагааны орлого 30.500,0 мянган төгрөг, нийт 3.781.661,0 мянган төгрөгийн Хувь хүний орлогын албан татварын ногдуулалт, төлөлтийн тайланд тусгаагүй нууж, албан татвар ногдуулан төлөөгүй нь Монгол Улсын Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 8, 27 дугаар зүйлд заасныг зөрчсөн” гэх Сүхбаатар дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 250041 тоот дүгнэлт, гэрч Д.Цэ-ын «Манай компани иргэн Д.Эн-аас 2008 оны 12 дугаар сард 250.000 ам.доллар зээлсэн» гэх мэдүүлэг (30-р хавтас хх-169-170), гэрч Г.Чн-ын «Д.Эн-аас зээлсэн мөнгөний гэрээний ам.доллар 2 хувийн хүүтэй, төгрөг нь 1,6 хувийн хүүтэй байсан» гэх мэдүүлэг (30-р хавтас хх-175-176), шинжээч Ц.С-г байцаасан тэмдэглэлд «Иргэн Д.Эн нь 2008-2012 оныг дуустал хугацаанд нийт 50.041.300 төгрөгийн

татвар ногдох орлогоо татварт тайлагнаагүй татварт ногдох орлогоо бууруулан тайлагнаж онц их хэмжээний татвараас зайлсхийсэн» гэх мэдүүлэг (36-р хавтас хх-51-52), бичгийн бусад баримтуудаар нотлогдон тогтоогдож байна.

2.7. Шүүгдэгч Б.Жа нь Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний хэлтсийн даргаар ажиллаж, уг албан тушаалын цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хх-хх УНТ улсын дугаартай Лексус-470 маркийн автомашиныг 47.500.000 төгрөгөөр, 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...байрлалтай зуслангийн зориулалттай байшин, газрын хамт 39.000.000 төгрөгөөр тус тус худалдан авч, нийт 86.500.000 төгрөгийн хөрөнгө олж, хууль бусаар хөрөнгөжсөн болох нь түүний хөрөнгө орлогын мэдүүлэг (40-р хавтас хх-213-218), "ОС" үл хөдлөх хөрөнгө зуучлалын компанийн 2013.09.27-ны өдрийн 69/1 тоот албан бичиг, гэрч Ү.Сэ-гийн "Манай Өмнөговь аймгийн ББ нь 2013 оны 02 дугаар сард манай гэрт ирээд, таны нэр дээр машин авах хэрэгтэй байна гэхээр нь болдог юм бол хамаа байхгүй ээ гэж хэлээд, ББ болон хүргэн хүү БД, Ж нарын хамт вокзалын машин зогсоол дээрээс ...цаасан хайрцагтай мөнгө гаргаж ирээд машин худалдаж авсан. Энэ хх-хх УНТ улсын дугаартай машин бол ББ-гийн машин, миний машин биш, ямар учраас миний нэр дээр авсан, хэдэн төгрөгөөр авсан талаар мэдэхгүй" гэх мэдүүлэг (41-р хавтас хх-96), Э.Бо-ын "Манай хадам ээж Б.Жа 2013 оны 02 дугаар сарын 07-ны өдөр "хамт яваад машин үзээд өг" гэж хэлсэн. Тэгээд би хадам ээж Б.Жа-ыг аваад очиж саарал өнгийн Тоёота Лексус 470 маркийн машин үзсэн. Маргааш нь манай хадам аав А.Ба надтай утсаар яриад нөгөө машиныг очиж унаж үзсэн. Тэгээд Ү.Сэ өвөөгийн нэр дээр машины гэрчилгээг гаргуулсан. Хадам аав А.Ба хайрцагтай мөнгө гаргаж ирээд 47.500.000 төгрөгөөр худалдан авсан" гэх мэдүүлэг (41-р хавтас хх-95), гэрч Э.Зо (41-р хавтас хх-97), Б.Са (41-р хавтас хх-98), нарын мэдүүлэг, эд хөрөнгө битүүмжилсэн тогтоол, бичгийн бусад баримтуудаар нотлогдон тогтоогдлоо.

2. Мөн шүүгдэгч Б.Жа нь Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний хэлтсийн даргаар ажиллаж байхдаа Д.Эн нь татвар

ногдуулах орлого нуусан, татвар төлөхөөс зайлсхийсэн эсэх талаар 2013.08.21-ний өдөр 164 тоот шинжээчийн дүгнэлт гаргахдаа Д.Эн-ын татварт төлбөл зохих дүнгээс 34.638.200 төгрөгийг зориуд санаатайгаар бууруулж, худал дүгнэлт гаргасан болох нь Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч комиссар Д.З-ын 2013.06.17-ны өдрийн шинжээч томилох тогтоол, Д.Эн-ын Хөрөнгө орлогын албан татварыг тооцоолсон баримт (35-р хавтас хх-231-235), шинжээч Ц.С-г байцаасан тэмдэглэлд "Шинжээч Б.Жа нь иргэн Д.Эн-д холбогдуулан бичсэн дүгнэлтийн ажлын баримтыг нь үзэхэд Д.Эн-ын хувь хүний орлогын албан татварын тооцоолол гэх зүйлийг огт хийгээгүй байсан, дүгнэлтээ хэрхэн гаргасан нь тодорхой бус, үндэслэлгүй гаргасан байсан. Шинжилгээнд бид шинжээч Б.Жа-ын шинжилгээ хийхдээ ашиглаж байсан ажлын баримтад болон Д.Эн-ын өмгөөлөгч нараас гаргаж өгсөн тайлбар, баримтуудыг үндэслэн дүгнэлтээ гаргасан. Д.Эн-ын хувь хүний орлогын албан татвараас зайлсхийсэн 50.041.300 төгрөгийг бид шинжээчийн ажлын баримтад байгаа нотлох баримтуудыг үндэслэж гаргасан болно" гэх мэдүүлэг (36-р хавтас хх-51-52), шинжээч Ц.С, Б.А, Н.Г нарын 2013.11.29-ний өдрийн дүгнэлт (36-р хавтас хх-33-46), бичгийн бусад баримтуудаар нотлогдон тогтоогдлоо.

Иймд:

шүүгдэгч Ч.Га-ийг Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа албан тушаалынхаа байдлыг ашиглан, албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байхаар урьдчилан амлаж, бусдаар дамжуулан онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, түүнд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.1, 60 дугаар зүйлийн 60.3-т заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2-т заасан ял оногдуулах,

шүүгдэгч Ч.Га, Д.Эн, Б.Жа нарыг хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр орлого олж, хууль бусаар хөрөнгөжсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, тэдгээрт эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270¹.2-т заасан ял оногдуулах,

шүүгдэгч Ч.Га-ийг төрийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ

урвуулан ашигласны улмаас татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учирсан гэмт хэргийг зохион байгуулсан, шүүгдэгч Ч.Да, Д.Эн нарыг энэ гэмт хэрэгт хамжигчаар хамтран оролцсон, шүүгдэгч П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя нарыг энэ гэмт хэргийг гардан гүйцэтгэж хамжигчаар хамтран оролцсон гэм буруутайд тус тус тооцож, тэдгээрт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлд заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан ял тус тус оногдуулах, шүүгдэгч Д.Эн-ыг татвар ногдох онц их хэмжээний орлого, эд хөрөнгө нууж, татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, түүнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2-т заасан ял оногдуулах,

шүүгдэгч Б.Жа-ыг мөрдөн байцаалтад шинжээч зориуд худал дүгнэлт гаргаснаас хүнд хор уршиг учирсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, түүнд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254 дүгээр зүйлийн 254.2-т заасан ял тус тус оногдуулах хууль зүйн үндэслэлтэй байна.

Шүүх хохирлын хэмжээг тодорхойлохдоо Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-д заасныг баримтлан гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байсан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хоёр зуугаас дээш дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээгээр тооцсон болно.

Шүүгдэгч Ч.Га-д бусдаас онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан гэмт хэрэгт ял оногдуулахдаа Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 60 дугаар зүйлийн 60.3-т заасныг баримтлан мөн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2-т заасан ялын доод хэмжээний гуравны хоёроос хэтрэхгүйгээр тооцов.

Шүүгдэгч Ч.Га, Д.Эн, Б.Жа нар Эрүүгийн хуулийн тусгай ангийн өөр өөр зүйлд заасан хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн тул шүүх Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1-д заасныг баримтлан шүүгдэгч нарын үйлдсэн гэмт хэрэг тус бүрт нь ял оногдуулж, хөнгөн ялыг хүндэд нь багтаах, хүнд ялтай зүйлийн ялын дээд хэмжээний дотор бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэн тэдгээрийн биечлэн эдлэх ялыг тогтоосон ба мөн зүйлийн 57.2-т зааснаар Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан нэг буюу хэд хэдэн нэмэгдэл ялыг үндсэн ялтай нь хамт оногдуулахаар шийдвэрлэсэн болно.

Шүүх шүүгдэгч нарт ял оногдуулахдаа

гэмт хэрэг бүлэглэж үйлдсэн, гэмт хэргийн улмаас хүнд хор уршиг учирсныг хүндрүүлэх нөхцөлд харгалзан үзлээ.

Шүүгдэгч Б.Жа-д ял оногдуулахдаа түүнийг нийгмээс тусгаарлаж хорихгүйгээр торгох ял оногдуулах боломжтой гэж үзсэн ба Эрүүгийн хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т зааснаар торгох ялын хэмжээг гэмт хэрэг үйлдэх үед мөрдөгдөж байсан нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 140.400 төгрөгийг 150-260 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тогтоолоо. Түүнчлэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.3-т заасныг баримтлан шүүгдэгчийн урьдчилан цагдан хоригдсон хоногийг түүний ял эдэлсэн хугацаанд оруулан тооцож, цагдан хоригдсон нэг хоногийг шүүхийн шийтгэх тогтоол гарах үед мөрдөгдөж байгаа нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ буюу 192.000 төгрөгөөр тооцож, торгох ялаас хассан болно.

Шүүх анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн шүүгдэгч П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя нарын хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэргийн улмаас учирсан гэм хорын хохирлыг иргэний хариуцагч нар арилгах үүрэгтэй зэргийг харгалзан тэдгээрт оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэх шаардлагагүй гэж үзлээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар шүүгдэгч Ч.Га, Д.Эн, Б.Жа нарын гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг эд хөрөнгө хураах ялаас гадуур хурааж, төрийн өмчлөлд шилжүүлэхээр шийдвэрлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-с татварт 13.445.598.900 төгрөг, «ППС» ХХК-с татварт 1.219.368.700 төгрөг, шүүгдэгч Д.Эн-аас татварт 50.041.300 төгрөг тус тус гаргуулж, Татварын ерөнхий газарт олгуулахаар шийдвэрлэлээ.

Хэрэгт эд мөрийн баримтаар ирүүлсэн болон битүүмжилсэн хөрөнгө болох шүүгдэгч Ч.Га-ийн 58,0 сая төгрөгөөр худалдан авсан 2 ширхэг хөөрөг, 825.375.400 төгрөгөөр худалдан авсан Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоот 257,8 м.кв талбайтай амины орон сууц, Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууц, Голомт банк дахь ам долларын 110302XXXX, төгрөгийн 110503xxxx, 120120xxxx тоот хадгаламжин дахь мөнгө, нийт 635,0 сая төгрөгөөр үнэлэгдсэн 6 автомашин, шүүгдэгч Д.Эн-

ын Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо ...тоот, улсын бүртгэлийн №Ү-2203011xxxx дугаарт бүртгэлтэй орон сууц, Баянгол дүүргийн ...дугаар хороо ...байрлалтай, улсын бүртгэлийн №220503xxxx дугаартай үйлчилгээний барилга газрын хамт, 493.822.000 төгрөгөөр худалдан авсан Хан-Уул дүүрэгт байрлалтай, ...178,9 м.кв талбай бүхий ...тоот орон сууц, 2008 онд үйлдвэрлэгдсэн хх-хх УБҮ улсын дугаартай Соната-6 маркийн хар өнгийн автомашин, шүүгдэгч Б.Жа-ын 47.500.000 төгрөгөөр худалдан авсан хх-хх УНТ улсын дугаартай Лексус 470 маркийн автомашин, 39.000.000 төгрөгөөр худалдан авсан Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...байрлах зуслангийн хашаа байшинг тус тус зохих журмын дагуу төлбөрт тооцуулахаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248 дугаар зүйлийн 248.1.1, 283, 286, 294, 297, 298, 300 дугаар зүйлийн 300.1-д тус тус заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.1.1-д заасныг баримтлан Нийслэлийн прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргээс Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан гэмт хэрэгт холбогдсон шүүгдэгч Ч.Га, Б.Бу нарт холбогдох хэргийг, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасныг журамлан, мөн хуулийн тусгай ангийн 265 дугаар зүйлийн 265.2-т заасан гэмт хэрэг, мөн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан гэмт хэрэгт тус тус холбогдсон шүүгдэгч Х.Ха, Б.Жал нарт холбогдох хэргийг, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан гэмт хэрэгт холбогдсон шүүгдэгч Ч.Да нарт холбогдох хэргийг тус тус хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч Б.Бу, Х.Ха, Б.Жал нарыг цагаатгасугай.

2. Шүүгдэгч Ө овогт Ч.Га-ийг

-албан тушаалын байдлыг ашиглан, албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байхаар урьдчилан амлаж, бусдаар дамжуулан онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан, -хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн,

-төрийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас татварын байгууллагад онц их

хэмжээний хохирол учирсан гэмт хэргийг зохион байгуулсан гэмт хэргүүд үйлдсэн,

Шүүгдэгч Д овогт Д.Эн-ыг

-хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн,

-төрийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учирсан гэмт хэрэгт хамжигчаар хамтран оролцсон,

-татвар ногдох онц их хэмжээний орлого, эд хөрөнгө нууж, татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэргүүд үйлдсэн,

Шүүгдэгч С овогт Б.Жа-ыг

-хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн,

-мөрдөн байцаалтад шинжээч зориуд худал дүгнэлт гаргаснаас хүнд хор уршиг учирсан гэмт хэргүүд үйлдсэн,

Шүүгдэгч Б овогт П.Га, У овогт Н.Ра, Г овогт Б.Өс, С...овогт Н.Чи, О...овогт Б.Жр, У овогт О.Бя нарыг төрийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учирсан гэмт хэргийг гардан гүйцэтгэж хамжигчаар хамтран оролцсон,

Шүүгдэгч Ө овогт Ч.Да-г албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учирсан гэмт хэрэгт хатгагчаар хамтран оролцсон гэм буруутайд тус тус тооцсугай.

3. Шүүгдэгч Ч.Га-ийг

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.1, 60 дугаар зүйлийн 60.3-т заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2-т зааснаар 100.000.000 (нэг зуун сая) төгрөгийн эд хөрөнгө хурааж, 3 (гурав) жил 4 (дөрөв) сар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270¹.2-т зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 8 (найм) жилийн хугацаагаар хасаж, 7 (долоо) жил 6 (зургаа) сар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 5 (тав) жилийн хугацаагаар хасаж, 5 (тав) жил хорих ялаар,

Шүүгдэгч Д.Эн-ыг

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-т зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 8 (найм) жилийн хугацаагаар хасаж, 7 (долоо) жил 6 (зургаа) сар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 5 (тав) жилийн хугацаагаар хасаж, 5 (тав) жил хорих ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2-т зааснаар 50.000.000 (тавин сая) төгрөгийн эд хөрөнгө хурааж, 7 (долоо) жил 6 (зургаа) сар хорих ялаар,

Шүүгдэгч Б.Жа-ыг

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-т зааснаар эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 (тав) жил 6 (зургаа) сарын хугацаагаар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 260 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 36.504.000 (гучин зургаан сая таван зуун дөрвөн мянга) төгрөгөөр торгох ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254 дүгээр зүйлийн 254.2-т зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 21.060.000 (хорин нэгэн сая жаран мянга) төгрөгөөр торгох ялаар,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар шүүгдэгч П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя нарын татварын улсын байцаагч хийх эрхийг 3 (гурав) жилийн хугацаагаар хасаж, тус бүрийг 3 (гурав) жил хорих ялаар,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.4-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар шүүгдэгч Ч.Да-г аудитор хийх эрхийг 3 (гурав) жилийн хугацаагаар хасаж, 3 (гурав) жил хорих ялаар тус тус шийтгэсүгэй.

4. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1-д зааснаар

Шүүгдэгч Ч.Га-д энэ тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-т зааснаар оногдуулсан татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жилийн хугацаагаар хасаж, 7 жил 6 сар хорих ялд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар

зүйлийн 263.2-т зааснаар оногдуулсан татварын улсын байцаагч хийх эрхийг 5 жилийн хугацаагаар хасаж, 5 жил хорих ялыг багтааж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.1, 60 дугаар зүйлийн 60.3-т заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2-т зааснаар оногдуулсан 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 3 жил 4 сар хорих ялын зарим болох 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 6 сарыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх ялыг 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жилийн хугацаагаар хасаж, 8 (найм) жил хорих ялаар,

Шүүгдэгч Д.Эн-д энэ тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2-т зааснаар оногдуулсан 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 7 жил 6 сар хорих ялд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар оногдуулсан татварын улсын байцаагч хийх эрхийг 5 жилийн хугацаагаар хасаж, 5 жил хорих ялыг багтааж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-т зааснаар оногдуулсан татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жилийн хугацаагаар хасаж, 7 жил 6 сар хорих ялын зарим болох 6 сарыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх ялыг 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жилээр хасаж, 8 (найм) жил хорих ялаар,

Шүүгдэгч Б.Жа-д энэ тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-т зааснаар оногдуулсан эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сарын хугацаагаар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 260 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 36.504.000 төгрөгөөр торгох ялд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254 дүгээр зүйлийн 254.2-т зааснаар оногдуулсан 21.060.000 төгрөгөөр торгох ялыг багтааж, түүний биечлэн эдлэх ялыг эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сарын хугацаагаар хасаж, 36.504.000 (гучин зургаан сая таван зуун дөрвөн мянга) төгрөгөөр торгох ялаар тус тус тогтоосугай.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6-д зааснаар шүүгдэгч Ч.Га, Д.Эн тус бүрт оногдуулсан хорих ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5-д зааснаар шүүгдэгч

Н.Ра, П.Га, Н.Чи, Ч.Да тус бүрт оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид,

Шүүгдэгч Б.Өс, Б.Жр, О.Бя тус бүрт оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлсүгэй.

6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2-т заасныг баримтлан шүүгдэгч Ч.Га-ийн цагдан хоригдсон 391 хоног, шүүгдэгч Д.Эн-ын цагдан хоригдсон 388 хоног, шүүгдэгч О.Бя-гийн цагдан хоригдсон 55 хоног, шүүгдэгч Ч.Да-гийн цагдан хоригдсон 139 хоногийг тус тус тэдгээрийн эдлэх ялд нь оруулан тооцсугай.

7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.3-т заасныг баримтлан шүүгдэгч Б.Жа-ын цагдан хоригдсон 150 хоногийг ял эдэлсэнд оруулан тооцож, торгох ялаас 28.800.000 (150 x 192.000) төгрөгийг хасаж, түүний биечлэн эдлэх ялыг эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сарын хугацаагаар хасаж, 7.704.000 (36.504.000 - 28.800.000) төгрөгөөр торгох ялаар тогтоосугай.

8. Шүүгдэгч Б.Жа нь торгох ялаас ноцтойгоор заилсхийвэл шүүх Эрүүгийн хуулийн тусгай ангийн 47 дугаар зүйлийн 47.3-т зааснаар уг ялыг хорих ялаар сольж болохыг сануулсугай.

9. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар шүүгдэгч Ч.Га-ээс 2.845.309.193 (хоёр тэрбум найман зуун дөчин таван сая гурван зуун есөн мянга нэг зуун ерэн гурав) төгрөг, шүүгдэгч Д.Эн-аас 592.835.500 (таван зуун ерэн хоёр сая найман зуун гучин таван мянга таван зуу) төгрөг, шүүгдэгч Б.Жа-аас 86.500.00 (наян зургаан сая таван зуун мянга) төгрөг тус тус хурааж, төрийн өмчлөлд шилжүүлсүгэй.

10. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4-т зааснаар шүүгдэгч П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя тус бүрт оногдуулсан 3 жил хорих ялыг тэнсэж, тус бүрийг мөн хугацаагаар хянан харгалзахаар тогтоож, шүүгдэгч П.Га, Б.Өс, О.Бя нарт хяналт тавих үүргийг Баянгол дүүргийн цагдаагийн хэлтэст, Н.Ра-д хяналт тавих үүргийг Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэст, Н.Чи-ад хяналт тавих үүргийг Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн хэлтэст, Б.Жр-д хяналт тавих үүргийг Хан-Уул дүүргийн цагдаагийн хэлтэст тус тус даалгасугай.

11. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д зааснаар иргэний хариуцагч “КЖЭМ” ХХК-с 13.445.598.900 (арван гурван тэрбум дөрвөн зуун дөчин таван сая таван зуун ерэн найман мянга есөн зуу) төгрөг, “ППС” ХХК-с 1.219.368.700 (нэг тэрбум хоёр зуун арван есөн сая гурван зуун жаран найман мянга долоон зуу) төгрөг, шүүгдэгч Д.Эн-аас 50.041.300 (тавин сая дөчин нэгэн мянга гурван зуу) төгрөг тус тус гаргуулж, Татварын ерөнхий газарт олгож, тус газрын нэхэмжлэлээс “АФ” ХХК-д холбогдох 3.747.357,3 мянган төгрөгийг хэрэгсэхгүй болгосугай.

12. Энэ хэрэгт эд мөрийн баримтаар ирүүлсэн шүүгдэгч Ч.Га-ийн 2 ширхэг хөөрөг, мөрдөн байцаагчийн тогтоолоор битүүмжилсэн Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоот 257,8 м.кв талбайтай амины орон сууц, Баянзүрх дүүрэг ...дугаар хороо, ...тоот орон сууц, Голомт банк дахь ам долларын 110302XXXX, төгрөгийн 110503xxxx, 120120xxxx тоот хадгаламж дахь мөнгө, Лексус-570 маркийн 3 автомашин, Лексус-470 маркийн 2 автомашин, Ланд круйзер-200 маркийн 1 автомашин, мөрдөн байцаагчийн тогтоолоор битүүмжилсэн шүүгдэгч Д.Эн-ын Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо ...тоот, улсын бүртгэлийн №Ү-2203011xxxx дугаарт бүртгэгдсэн орон сууц, Баянгол дүүргийн ...дугаар хороо ...байрлалтай, улсын бүртгэлийн №220503xxxx дугаартай үйлчилгээний барилга газрын хамт, Хан-Уул дүүрэгт байрлалтай, ...178,9 м.кв талбай бүхий ...тоот орон сууц, 2008 онд үйлдвэрлэгдсэн хх-хх УБҮ Соната-6 хар өнгийн автомашин,

мөрдөн байцаагчийн тогтоолоор битүүмжилсэн шүүгдэгч Б.Жа-ын хх-хх УНТ улсын дугаартай Лексус 470 маркийн автомашин, Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...байрлах зуслангийн хашаа байшинг тус тус төлбөрт тооцуулахаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжүүлсүгэй.

13. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.10-т заасныг баримтлан шүүгдэгч Ч.Да-гийн «СА» ХХК-ийн өмчлөлийн Сүхбаатар дүүргийн ...дугаар хороо... тоот эрхийн улсын бүртгэлийн Ү-220302xxxx дугаартай ажлын байр, эрхийн улсын бүртгэлийн Ү-220302xxxx дугаарт бүртгэлтэй 10 тоот ажлын байр, эрхийн улсын бүртгэлийн Ү-220302xxxx дугаарт бүртгэлтэй 501 тоот ажлын байр, эрхийн улсын

бүртгэлийн Ү-220601xxxx дугаарт бүртгэгдсэн Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот орон сууцыг, зоорийн давхрын 117, 118 тоот зогсоолын хамт, эрхийн улсын бүртгэлийн Ү-220403xxxx дугаарт бүртгэгдсэн Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоот орон сууц, эрхийн улсын бүртгэлийн Ү-220404xxxx дугаарт бүртгэгдсэн Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоот зогсоол, шүүгдэгч Х.Хагийн эрхийн улсын бүртгэлийн Ү-210100xxxx, Г-210100xxxx, Г-210100xxxx дугаарт бүртгэгдсэн Орхон аймгийн ...сумын ...тоот хувийн орон сууц, газар, шүүгдэгч Б.Жалын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Ү-210101XXXX дугаарт бүртгэгдсэн Орхон аймгийн ...сумын ...тоот орон сууцыг тус тус битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолуудыг хүчингүй болгосугай.

14. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар хавсаргасан “КЖЭМ» ХХК-ийн татварын хяналт шалгалт хийсэн ажлын баримт 16 хавтас, Шинжээч нарын ажлын баримт 3 хавтас, дансны хуулга 2 хавтас, нийт 21 хавтас баримтыг энэ хэргийг хадгалах хугацаа дуустал хэрэгт хавсарган үлдээсүгэй.

15. Шүүгдэгч Б.Бу, Х.Ха, Б.Жал нарт урьд авсан бусдын батлан даалтад өгсөн таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хүчингүй болгож, тэдгээрийг шүүх хуралдааны танхимаас сулласугай.

16. Шүүхийн тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд гомдол,

эсэргүүцэл гаргасан тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, шүүгдэгч Ч.Да-д урьд авсан бусдын батлан даалтад өгсөн таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж цагдан хорих,

шүүгдэгч Ч.Га, Д.Эн нарт урьд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хэвээр үргэлжлүүлж, шүүгдэгч Ч.Га, Д.Эн, Ч.Да нарын эдлэх ялыг энэ өдрөөс эхлэн тоолох,

шүүгдэгч Б.Жа-д урьд авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, түүнийг бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авах,

шүүгдэгч П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя нарт урьд авсан бусдын батлан даалтад өгсөн таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хэвээр үргэлжлүүлсүгэй.

17. Шүүхийн тогтоолд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд тогтоолыг гардуулснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

18. Иргэний хариуцагч, тэдний төлөөлөгч шүүхийн тогтоолын зөвхөн иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт давж заалдах гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

19.Цагаатгагдсан этгээд шүүхийн тогтоолын цагаатгасан гомдол гаргах эрхтэйг дурдсугай.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ
ШҮҮГЧ

Г.БУЯННЭМЭХ
З.БОЛДБААТАР
И.ГАНБАТ

МАГАДЛАЛ

2014 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 436

Улаанбаатар хот

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч Л.Ч.Да даргалж, шүүгч Д.Мягмаржав, М.Пүрэвсүрэн нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанд:

ялтан Д.Эн-ын өмгөөлөгч С.Жанцан, Э.Энэбиш, Д.Батбаяр, Х.Баасанжаргал,
ялтан Ч.Да-гийн өмгөөлөгч С.Оюунцэцэг, Ц.Гансүх,
ялтан Б.Жа, түүний өмгөөлөгч Н.Цогт, Ш.Энхмаа,
ялтан П.Га, түүний өмгөөлөгч Ч.Мөнхцэцэг,
ялтан Н.Ра, түүний өмгөөлөгч Ж.Батзоригт,
прокурор О.Гэрэл, Ш.Баярбилэг,
ялтан Ч.Га-ийн өмгөөлөгч Г.Оюунцэцэг, А.Ундрах,
ялтан Б.Өс, түүний өмгөөлөгч Б.Цэнгүүн,
ялтан Н.Чи, түүний өмгөөлөгч Х.Цогтсайхан,
ялтан Б.Жр, түүний өмгөөлөгч К.Бауиржан,
ялтан О.Бя, түүний өмгөөлөгч Г.Мөнхбат,
цагаатгагдсан этгээд Х.Ха-гийн өмгөөлөгч Б.Хишигбаатар,
цагаатгагдсан этгээд Б.Жал-ы өмгөөлөгч Б.Энхтуяа,
иргэний хариуцагч «ПВР» ХХК-ийн төлөөлөгч М.Ня, Д.Бо, өмгөөлөгч С.Цэрэнжээ,
иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-ийн төлөөлөгч Б.Бая, Н.Зо,
нарийн бичгийн дарга Э.Энххэрлэн нарыг оролцуулан,

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч Г.Буяннэмэх даргалж, шүүгч З.Болдбаатар, И.Ганбат нарын бүрэлдэхүүнтэй хийсэн шүүх хуралдааны 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 261 дүгээр шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч ялтан Ч.Га, түүний өмгөөлөгч Г.Оюунцэцэг, А.Ундрах, ялтан Д.Эн, түүний өмгөөлөгч Д.Батбаяр, Э.Энэбиш, С.Жанцан, Х.Баасанжаргал, ялтан Б.Жа, түүний Ш.Энхмаа, Н.Цогт, ялтан П.Га, түүний өмгөөлөгч Ч.Мөнхцэцэг, ялтан Н.Ра, түүний өмгөөлөгч Ж.Батзоригт, ялтан Б.Өс, түүний өмгөөлөгч Б.Цэнгүүн, ялтан Н.Чи, түүний өмгөөлөгч Х.Цогтсайхан, ялтан Б.Жр, түүний өмгөөлөгч К.Бауиржан, ялтан О.Бя, түүний өмгөөлөгч Г.Мөнхбат, ялтан Ч.Да, түүний өмгөөлөгч С.Оюунцэцэг, Ц.Гансүх, иргэний хариуцагч «ПВР» ХХК-ийн төлөөлөгч М.Ня, Д.Бо, өмгөөлөгч С.Цэрэнжээ, иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Ба нарын гаргасан давж заалдах гомдлуудыг үндэслэн Ч.Га, Ч.Да, Д.Эн, Б.Бу, Н.Ра, П.Га, О.Бя, Б.Жр, Н.Чи, Б.Өс, Х.Ха, Б.Жал, Б.Жа нарт холбогдох 20130100003 дугаартай эрүүгийн хэргийг 2014 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр хүлээн авч, шүүгч М.Пүрэвсүрэнгийн илтгэснээр хянан хэлэлцэв.

1. Ө овгийн Ч.Га, ...оны ... дугаар сарын

...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, охин, хүү, зээгийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суудаг, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ЧМ...../,

2. Д овгийн Д.Эн, ...оны ...дугаар сарын ...ны өдөр Ховд аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч, бизнесийн удирдлага мэргэжилтэй, Баянгол дүүргийн татварын хэлтсийн даргаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, «Алтангадас» одонтой, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ШЖ...../,

3. Х овгийн Б.Бу, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Сүхбаатар аймгийн ...хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст татварын улсын ахлах байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ... тоотод оршин суух, «Алтангадас» одонтой, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: УХ...../,

4. С овгийн Б.Жа, ...оны ...дүгээр

сарын ...-ны өдөр Өмнөговь аймгийн ...суманд төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, Шүүхийн шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн эдийн засгийн шинжилгээний хэлтсийн даргаар ажиллаж байсан, ам бүл ..., эцэг, нөхөр, охин, зээгийн хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: КЮ...../,

5. Б овгийн П.Га, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Булган аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Баянгол дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ГЮ...../,

6. У овгийн Н.Ра, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Булган аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, халх, дээд боловсролтой, нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: УС...../,

7. Г овгийн Б.Өс, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр Төв аймгийн ...суманд төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, барилгын инженер, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., хүүхдийн хамт Баянгол дүүргийн ... дүгээр хороо, ... тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: НЭ...../,

8. С овгийн Н.Чи, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ХО...../,

9. О овгийн Б.Жр, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой,

санхүүч, эдийн засагч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., нөхөр, хүүхдүүдийн хамт Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ... тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ШЗ...../,

10. Ү овгийн О.Бя, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Өвөрхангай аймгийн ...суманд төрсөн, 36 настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., хүүхдийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо, ... тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ЙЮ...../,

11. Ө овгийн Ч.Да, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, 40 настай, эрэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, «СА» ХХК-ийн ерөнхий захирал, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ЦГ...../,

12. Т овгийн Х.Ха, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, «ЭҮ"-т ерөнхий нягтлан бодогчийн орлогчоор ажиллаж ажиллаж байгаад 2013 оны 07 дугаар сарын 19-ний өдөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, ам бүл ..., нөхрийн хамт Орхон аймгийн ...сумын ...байранд оршин суух, «Алтан гадас» одонтой, ял шийтгэлгүй, /регистрийн дугаар: ФМ...../,

13. И овгийн Б.Жал, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, 53 настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч, бизнесийн удирдлага мэргэжилтэй, «ЭҮ"-т ерөнхий захирлын эдийн засаг эрхэлсэн орлогчоор ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй. /регистрийн дугаар: УЖ...../

1. Ч.Га нь Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа 2006 оны 5 дугаар сард "ВАТТ" ХХК-д татварын хяналт шалгалт хийгдэж байгааг нь далимдуулан өөрийн танил Ц.Со-оор дамжуулж тус компанид «250.000 ам.доллар өгвөл татварын улсын байцаагчийн актаар тавигдах нөхөн татвар,

хүү, торгуулийг багасгаж болно. Өгөхгүй бол актын дүнг өсгөнө» гэж хэлүүлж, хясан боогдуулах замаар тухайн үеийн ханшаар 295.500.000 төгрөг буюу онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан гэмт хэрэгт,

2002 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс 2013 оны 01 дүгээр сар хүртэл Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллах хугацаандаа цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа хууль ёсны орлогоос гадна эцэг У.Чи-ийн нэр дээр Голомт банкинд 110302XXXX тоот ам.долларын данс нээж /Ч.Га хамтран эзэмшигч/, 2008 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл 1.362.655.48 ам.доллар буюу тухайн үеийн төгрөгтэй харьцах ханшаар 1.771.358.017 төгрөг орлого, 1.207.415,2 ам.доллар буюу 1.581.063.830 төгрөгийн зарлагын гүйлгээ, мөн эцэг У.Чи-ийн нэрээр Голомт банкинд 110503xxxx тоот төгрөгийн данс нээж, 2010 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2013 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр хүртэлх хугацаанд 1.073.951.176,93 төгрөгийн орлого, 1.073.850.400 төгрөгийн зарлагын гүйлгээ хийж, уг мөнгөнөөс 2007 оны 12 дугаар сараас 2012 оны 07 дугаар сар хүртэлх хугацаанд 635.000.000 төгрөгөөр “Лексус 570” загварыг 3 ширхэг автомашин, “Лексус 470” загварын 2 ширхэг автомашин, “Ланд круйзер 200” загварын 1 ширхэг автомашин, 2012 оны 10 дугаар сарын 21-ний өдөр 825.375.400 төгрөгөөр Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...хотхоны ...дугаар байрны ...тоот, 257,8 м.кв талбай бүхий амины орон сууц, гражийн хамт, 2011, 2012 онд 58.000.000 төгрөгөөр иргэн Д.От-аас 2 ширхэг шүрэн толгойтой, манан хөөрөг тус тус худалдан авч нийт 1.518.375.400 төгрөгийн эд хөрөнгө олж, хууль бусаар хөрөнгөжсөн гэмт хэрэгт,

Татварын улсын ахлах байцаагч Б.Бу нь Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст шилжүүлэх байсан «АФ» ХХК-д 3.747.357.300 төгрөгийн татвар ногдуулсан татварын улсын байцаагчийн актыг шилжүүлээгүй дарагдуулсан байхад «татварын улсын байцаагчийн акт, дүгнэлтийг холбогдох байгууллагад шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулж, хяналт тавих» үүргээ зохих ёсоор биелүүлэлгүй албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэгт, 2010 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсээс «ХБЭ», «ЭрЭ», «БАЭ», «ХЭ», «ШЭ», «КЖЭМ» ХХК-иудын татвар

ногдуулалт, төлөлтийн байдалд төлөвлөгөөт шалгалт хийж байхад нь өөрийн төрсөн дүү Ч.Да-тэй үгсэн тохирч түүнээр татварын шалгалт хийлгэх тухай мэдээллийг Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст гаргуулж, улмаар албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж дээрх шалгалтыг зогсоон өөрийн удирдлагад ажилладаг татварын улсын байцаагч О.Бя, Б.Жр, Н.Чи, Б.Өс, Н.Ра, П.Га нараар дээрх компаниудад татварын шалгалт хийлгэж 13.398.688.100 төгрөгийн татварыг ногдуулалгүй, татварын байцаагчийн илтгэх хуудас, акт гаргуулж дээрх татварыг төсөвт төвлөрүүлэлгүй, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

Баянгол дүүргийн Татварын хэлтэст «НТГ», «УМ», «ЗУ» ХХК-иудын албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд яаралтай хяналт шалгалт хийлгэх тухай 2010 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 26/123 дугаар албан бичиг явуулж, холбогдох шалгалтыг хийлгэсэн. Уг шалгалтаар «ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдсан буюу эрх борлуулсан орлогоо нуусан» гэж үзэж «НТГ» ХХК-ийн 6.974.495.000 төгрөгийн татвараа нуусан үйлдэлд 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 260006 тоот дүгнэлт, «УМ» ХХК-ийн 2.786.273.500 төгрөгийн татвараа нуусан үйлдэлд 260007 тоот дүгнэлт, «ЗУ» ХХК-ийн 975.852.500 төгрөгийн татвараа нуусан үйлдэлд 2010 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 260009 тоот дүгнэлт тус тус бичиж Эрүүгийн цагдаагийн газраар шалгуулахаар хүргүүлсний дараа Ч.Га нь албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Үндэсний татварын албаны хяналт шалгалтын ажлын дүрмийн 2.3, 2.2.6-д заасныг зөрчин татварын хяналт шалгалтын ажилд томилох, томилолт бичих эрхгүй атлаа татварын улсын байцаагч Н.Ра, П.Га нарыг нэг нэгээр нь томилон «НТГ», «УМ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдлыг шалгуулж, татварын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэлгүй гэсэн илтгэх хуудас бичүүлж, уг илтгэх хуудсыг үндэслэн Баянгол дүүргийн Татварын хэлтсийн дарга Д.Эн 2010 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 73 тоот тушаалаар 260006, 260007 тоот дүгнэлтүүдийг хүчингүй болгож 1.021.587.900 төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй, мөн 2010 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 93 тоот тушаалаар 260009 тоот дүгнэлтийг хүчингүй болгож 197.780.800 төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй, улсад онц

их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

2. Б.Бу нь Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа Татварын ерөнхий газраас “АФ” ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж 2011 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн татварын улсын байцаагчийн 9802034 тоот актаар нийт 3.747.357.300 төгрөгийн татвар ногдуулж, Татварын ерөнхий газрын маргаан таслах зөвлөлийн 2011 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45 тоот тогтоолоор уг актыг үндэслэлтэй гэж үзэн Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст шилжүүлэхээр шийдвэрлэсэн байхад дарагдуулж, хууль тогтоомж, журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлэлгүй, тус компанийн эрх бүхий албан тушаалтнуудад татвар төлөхөөс зайлсхийх боломж олгож, улсын төсөвт төвлөрөх байсан дээрх онц их хэмжээний татварыг төлүүлээгүй, албан үүрэгтээ хайнга хандсан гэмт хэрэгт,

2. Д.Эн нь Баянгол дүүргийн татварын хэлтсийн даргаар ажиллаж байхдаа албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж, Татварын ерөнхий хуулийн 36 дугаар зүйлийг зөрчиж, татварын улсын байцаагч Н.Ра, П.Га нарын илтгэх хуудсыг үндэслэн 2010 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 73 тоот тушаалаар тус хэлтсийн татварын байцаагчдын Эрүүгийн цагдаагийн газраар шалгуулахаар бичсэн «НТГ», «УМ» ХХК-иудад холбогдох 260006, 260007 тоот дүгнэлтүүдийг хүчингүй болгож, 1.021.587.900 төгрөгийг төсөвт төвлөрүүлэлгүй, давтан үйлдлээр 2010 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 93 тоот тушаалаар «ЗУ» ХХК-д холбогдох 260009 тоот дүгнэлтүүдийг хүчингүй болгож, 197.780.800 төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлэлгүй, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

Голомт банкны 170501xxxx тоот төгрөгийн дансаар 2012 оны 05 дугаар сарын 01-нийн өдрөөс хойш он дуустал хугацаанд 53.900.000 төгрөг, Голомт банкны 180129xxxx тоот ам.долларын дансаар 2012 оны 05 дугаар сарын 1-ний өдрөөс хойш он дуустал хугацаанд 32.430 ам.долларын орлого олж, «НК» ХХК-тай 2012 оны 05 дугаар сарын 23-ны өдөр «Орон сууцны захиалга, хөрөнгө оруулалт»-ын КС127313... тоот гэрээ байгуулж, 493.822.000 төгрөгийн орон сууц худалдан авч, нийт эх үүсвэр нь тодорхойгүй 592.835.500 төгрөгийн орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн гэмт хэрэгт,

2008 онд 19.000.000 төгрөг, 2009 онд 241.750.000 төгрөг, 2010 онд 9.851.000 төгрөг, 2011 онд 139.322.500 төгрөг, 2012 онд 90.489.600 төгрөг, нийт 500.413.100 төгрөгийн орлого олсон атлаа хувь хүний орлогын албан татварт бүрэн тайлагнаагүй, татвар ногдох орлогоо бууруулан тайлагнаж 50.041.300 төгрөгийн буюу онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэрэгт,

Б.Жа нь Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний албаны даргын албан тушаалын цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хх-хх УНТ улсын дугаартай «Лексус 470» загварын автомашиныг 47.500.000 төгрөгөөр, 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...байрлалтай зуслангийн зориулалттай байшинг газрын хамт 39.000.000 төгрөгөөр тус тус худалдан авч, хууль ёсны орлогоосоо гадна нийт 86.500.000 төгрөгийн орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн гэмт хэрэгт,

Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагчийн 2013 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн «Шинжээч томилох тогтоол»-ын дагуу шинжээчээр томилогдож, Д.Эн-ыг татвар ногдох орлогоо нуусан, татвар төлөхөөс зайлсхийсэн эсэх талаар шинжилгээ явуулахдаа санаатайгаар орлогыг нь 34.638.200 төгрөгөөр бууруулан, 15.403.100 төгрөг төлөх талаар 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 164 тоот худал дүгнэлт гаргасан гэмт хэрэгт,

5. П.Га нь Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж, Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрмийн 2.2.6-д “...хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын /ахлах/ байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх ...” гэсэн заалтыг зөрчиж, Ч.Га-ээс өгсөн томилолтын дагуу ганцаараа “УМ” ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, Баянгол дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагчдын тус компанид холбогдуулан бичсэн 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 260007 тоот дүгнэлтийг хууль, эрх зүйн үндэслэлгүй мэтээр илтгэх хуудас бичсэнээс дээрх дүгнэлт хүчингүй болж, “ПС” буюу одоогийн нэрээр “ПВР” ХХК-ийн татварт төлөх ёстой 472.648.400 төгрөг төлөгдөлгүй,

улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

“КЖЭМ” ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд татварын улсын байцаагч Б.Жа, Б.Өс нарын хамт хяналт шалгалт хийхдээ 11.431.656.900 төгрөгийн татвараас зайлсхийсэн байхад 2010 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр 10 тоот илтгэх хуудас бичсэн нь Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д «...татварын хууль, тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих...» гэж заасныг зөрчсөн, дүгнэлт бичээгүйн улмаас татварт төлөх ёстой 11.431.656.900 төгрөг төлөгдөлгүй улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

6. Н.Ра нь Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж, Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрмийн 2.2.6-д “...хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын /ахлах/ байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх...” гэсэн заалтыг зөрчиж, Ч.Га-ээс өгсөн томилолтын дагуу ганцаараа “НТГ” ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, Баянгол дүүргийн татварын улсын байцаагчдын бичсэн 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдөр 260006 тоот дүгнэлтийг хууль, эрх зүйн үндэслэлгүй мэтээр илтгэх хуудас бичсэнээс дээрх дүгнэлт хүчингүй болж,

“ПС” буюу одоогийн нэрээр “ПВР” ХХК-ийн татварт төлөх ёстой 548.939.500 төгрөг төлөгдөлгүй, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

“БАЭ” ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийхдээ 217.700.600 төгрөгийн татвараас зайлсхийсэн байхад 2010 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 09 тоот илтгэх хуудас бичсэн нь Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д “... татварын хууль, тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих...” гэж заасныг зөрчсөн, дүгнэлт бичээгүйн улмаас татварт төлөх ёстой 217.700.600 төгрөг төлөгдөлгүй, улсад онц их хэмжээний хохирол учруулсан

гэмт хэрэгт,

7. Б.Өс нь Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж, Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрмийн 2.2.6-д “... хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын /ахлах/ байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх ...” гэсэн заалтыг зөрчин, Ч.Га-ээс өгсөн томилолтын дагуу ганцаараа “ХБЭ” ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, 489.998.900 төгрөгийн татвараас зайлсхийсэн байхад 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 07 тоот илтгэх хуудас бичсэн нь Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д “...татварын хууль, тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих...” гэж заасныг зөрчсөн, дүгнэлт бичээгүйн улмаас татварт төлөх ёстой 489.998.900 төгрөг төлөгдөлгүй, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

“КЖЭМ” ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд татварын улсын байцаагч П.Га, Б.Жр нарын хамт хяналт шалгалт хийхдээ 11.431.656.900 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад 2010 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 10 тоот илтгэх хуудас бичсэн нь Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д “...татварын хууль, тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих...” гэж заасныг зөрчсөн, дүгнэлт бичээгүйн улмаас татварт төлөх ёстой 11.431.656.900 төгрөг төлөгдөлгүй, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

8. Н.Чи нь Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрмийн 2.2.6-д “... хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын /ахлах/ байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх ...” гэсэн заалтыг зөрчин, Ч.Га-ээс өгсөн томилолтын дагуу ганцаараа “ХЭ” ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, 896.964.100

төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад 2010 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 980020 тоот акт бичсэн нь Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д "... татварын хууль, тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих..." гэж заасныг зөрчсөн, дүгнэлт бичээгүйн улмаас татварт төлөх ёстой 896.964.100 төгрөг төлөгдөлгүй, улсад онц их хэмжээний учруулсан гэмт хэрэгт,

9. Б.Жр нь Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрмийн 2.2.6-д "...хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын /ахлах/ байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх ..." гэсэн заалтыг зөрчин, Ч.Га-ээс өгсөн томилолтын дагуу ганцаараа "ШЭ" ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 46.900.800 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад 2010 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 06 тоот илтгэх хуудас бичсэн нь Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д "... татварын хууль, тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих..." гэж заасныг зөрчсөн, дүгнэлт бичээгүйн улмаас татварт төлөх ёстой 46.900.800 төгрөг төлөгдөлгүй, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

"КЖЭМ" ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд татварын улсын байцаагч П.Га, Б.Өс нарын хамт хяналт шалгалт хийхдээ 11.431.656.900 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад 2010 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр 10 тоот илтгэх хуудас бичсэн нь Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д "...татварын хууль, тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих..." гэж заасныг зөрчсөн, дүгнэлт бичээгүйн улмаас татварт төлөх ёстой 11.431.656.900 төгрөг төлөгдөлгүй, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

10. О.Бя нь Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрмийн 2.2.6-д "... хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын /ахлах/ байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх ..." гэсэн заалтыг зөрчин, Ч.Га-ээс өгсөн томилолтын дагуу ганцаараа "ЭрЭ" ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж, 315.476.800 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 08 тоот илтгэх хуудас бичсэн нь Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д "... татварын хууль, тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих..." гэж заасныг зөрчсөн, дүгнэлт бичээгүйн улмаас татварт төлөх ёстой 315.476.800 төгрөг төлөгдөлгүй, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

11. Ч.Да нь "ЭҮ"-ийн ерөнхий захирлын эдийн засаг эрхэлсэн орлогч Б.Жал, ерөнхий нягтлан бодогчийн орлогч Х.Ха нартай бүлэглэн, "СА" ХХК-ийн нэрээр ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн №5/426-11 тоот "Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээ"-ний гэрээ байгуулан, үйлчилгээний хөлсөнд 78.623.341 төгрөгийг авахаар байхад 626.120.000 төгрөгийг шилжүүлэн авч, 547.496.659 төгрөгийг илүү завшсан,

Санхүүгийн сургалт явуулах боловсон хүчний боломжгүй атлаа 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 5/336-12 дугаартай 48.000.000 төгрөгийн өртөг бүхий «нягтлан бодогчдод сургалт явуулах» гэрээг байгуулж, 38.400.000 төгрөгийг шилжүүлэн авсан боловч гэрээний үүргийг өөр аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж, гэрээний үнийн дүнгээс 20.400.000 төгрөгийг завшиж онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

Өөрийн төрсөн ах Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-тэй үгсэн тохирч, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсээс «КЖЭМ» ХХК болон хамаарал бүхий «ХБЭ», «ЭрЭ», «БАЭ», «ХЭ», «ШЭ» ХХК-иудад төлөвлөгөөт татварын хяналт шалгалт хийгдэж байхад буюу 2010 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр

иргэн Р.Ба-ын нэрээр Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст дээрх компаниудын татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийлгэх талаар хуурамч мэдээлэл гаргаж, улмаар төрсөн ах Ч.Га нь албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн байцаагчдын хийж байсан шалгалтыг ажлыг зогсоож, өөрийн удирдлагад ажилладаг татварын улсын байцаагч нараар хяналт шалгалт хийлгэж, 13.398.688.100 төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүйн улмаас төсөвт онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт,

“ЭҮ”-ийн ерөнхий захирлын эдийн засаг эрхэлсэн орлогч Б.Жал, ерөнхий нягтлан бодогчийн орлогч Х.Ха нар бүлэглэн албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 36,37,38 дугаар зүйлийг зөрчиж, “СА” ХХК-ийн захирал Ч.Да-д давуу байдал олгон сонгон шалгаруулалтгүйгээр 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр “Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээ”-ний №5\426-11 тоот гэрээг байгуулж, гэрээний заалтын дагуу ажлын хөлсийг тооцон олгохдоо үндэслэлгүйгээр нэмэгдүүлэн 547.496.659 төгрөгийг илүү олгосон гэмт хэрэгт,

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлан бүртгэлтийн талаар сургалт явуулах боловсон хүчний боломжгүй «СА» ХХК-аар сургалт явуулахаар 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн №5/336-12 тоот гэрээг 48.000.000 төгрөгийн төсөвт өртөгтэйгээр шууд байгуулан, гэрээний урьдчилгаанд 38.400.000 төгрөгийг шилжүүлэн 20.400.000 төгрөгийг завших боломж олгон, байгууллагын хөрөнгийг онц их хэмжээгээр үрэгдүүлсэн гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Нийслэлийн прокурорын газраас Ч.Га-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийг 32.1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэг, 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэг, 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэг, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар, Б.Бу-эд Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар, Д.Эн-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар

зүйлийн 35.1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэг, 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэг, 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар, Б.Жа-д Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 254.2, 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэгт зааснаар, П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя нарт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар, Ч.Да-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийг журамлан мөн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэг, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар, Х.Ха, Б.Жал нарт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасныг журамлан 265 дугаар зүйлийн 265.2, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар тус тус яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүх:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.1.1 дэх заалтыг баримтлан шүүгдэгч Ч.Га, Б.Бу нарт холбогдох Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэг, шүүгдэгч Ч.Да-д холбогдох Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг, шүүгдэгч Б.Жал, Х.Ха нарт холбогдох Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсгийг журамлан 265 дугаар зүйлийн 265.2, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэргийг тус тус хэрэгсэхгүй болгон, шүүгдэгч Б.Бу, Х.Ха, Б.Жал нарыг цагаатгаж,

Шүүгдэгч Ч.Га-ийг албан тушаалын байдлаа ашиглан, албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байхаар урьдчилан амлаж, бусдаар дамжуулан онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан, хууль ёсны орлогоосоо гадна онц их хэмжээгээр орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулахыг зохион байгуулсан гэмт хэргүүдийг үйлдсэн гэм буруутайд,

Д.Эн-ыг хууль ёсны орлогоосоо гадна онц их хэмжээгээр орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт хамжигчаар хамтран оролцсон, татвар

ногдох онц их хэмжээний орлого, эд хөрөнгө нууж, татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэргүүдийг үйлдсэн гэм буруутайд,

Б.Жа-ыг хууль ёсны орлогоосоо гадна онц их хэмжээгээр орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн, зориуд худал дүгнэлт гаргаснаас хүнд хор уршиг учирсан гэмт хэргүүдийг үйлдсэн гэм буруутайд,

П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя нарыг албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг гардан гүйцэтгэж хамжигчаар хамтран оролцсон,

Ч.Да-г албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт хатгагчаар хамтран оролцсон гэм буруутайд тус тус тооцож,

Ч.Га-ийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.1, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсгийг журамлан 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 3 жил 4 сар хорих ял, Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэгт зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жилийн хугацаагаар хасаж, 7 жил 6 сар хорих ял, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг журамлан 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар татварын улсын байцаагч Д.Эн-ыг Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэгт зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жилийн хугацаагаар хасаж, 7 жил 6 сар хорих ялаар, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 5 жилийн хугацаагаар хасаж, 5 жил хорих ялаар, Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 7 жил 6 сар хорих ялаар,

Б.Жа-ыг Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэгт зааснаар эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сарын хугацаагаар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 260 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 36.504.000 төгрөгөөр торгох ялаар, Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 254.2 дахь хэсэгт зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 21.060.000 төгрөгөөр торгох ялаар,

П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя нар

тус бүрийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 3 жилийн хугацаагаар хасаж, 3 жил хорих ялаар,

Ч.Да-г Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар аудитор хийх эрхийг 3 жилийн хугацаагаар хасаж, 3 жил хорих ялаар тус тус шийтгэж,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар Ч.Га-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэгт зааснаар оногдуулсан татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жилийн хугацаагаар хасаж, 7 жил 6 сар хорих ялд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасныг журамлан мөн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан ялыг багтаан, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.1, 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан ялын зарим болох 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 6 сар хорих ялыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх ялыг 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хураан, татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жилийн хугацаагаар хасаж, 8 жил хорих ялаар,

Д.Эн-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 7 жил 6 сар хорих ялд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг журамлан мөн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан ялыг багтаан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэгт зааснаар оногдуулсан ялын зарим болох 6 сарын хорих ялыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх ялыг 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жилийн хугацаагаар хасаж, 8 жил хорих ялаар,

Б.Жа-д Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэгт зааснаар оногдуулсан эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сарын хугацаагаар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 260

дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний бууу 36.504.000 төгрөгөөр торгох ялд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254 дүгээр зүйлийн 254.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан ялыг багтааж, түүний биечлэн эдлэх ялыг эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сарын хугацаагаар хасаж, 36.504.000 төгрөгөөр торгох ялаар тус тус тогтоож,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар Ч.Га, Д.Эн нарт оногдуулсан хорих ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид, мөн зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар Н.Ра, П.Га, Н.Чи, Ч.Да нарт оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид, Б.Өс, Б.Жр, О.Бя нарт оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлж,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2 дахь хэсэгт заасныг баримтлан Ч.Га-ийн цагдан хоригдсон 391 хоног, Д.Эн-ын цагдан хоригдсон 388 хоног, О.Бя-гийн цагдан хоригдсон 55 хоног, Ч.Да-гийн цагдан хоригдсон 139 хоногийг тус тусын эдлэх ялд нь оруулан тооцож,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.3 дахь хэсэгт заасныг баримтлан Б.Жа-ын цагдан хоригдсон 150 хоногийг ял эдэлсэнд тооцож, торгох ялаас 28.800.000 төгрөгийг хасаж, түүний биечлэн эдлэх ялыг эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сарын хугацаагаар хасаж, 7.704.000 төгрөгөөр торгох ялаар тогтоож, тэрээр торгох ялаас ноцтойгоор зайлсхийвэл шүүх хорих ялаар сольж болохыг сануулж,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар Ч.Га-ээс 2.845.309.193 төгрөг, Д.Эн-аас 592.835.500 төгрөг, Б.Жа-аас 86.500.00 төгрөг тус тус хураан, төрийн өмчлөлд шилжүүлж

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4 дэх хэсэгт зааснаар П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя нар тус бүрт оногдуулсан 3 жил хорих ялыг тэнсэж, мөн хугацаагаар хянан харгалзахаар тогтоож, тэдэнд хяналт тавих үүргийг Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүргийн цагдаагийн хэлтсүүдэд даалгаж,

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт зааснаар иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-аас 13.445.598.900 төгрөг, иргэний хариуцагч «ППС» ХХК-аас 1.219.368.700 төгрөг, Д.Эн-

аас 50.041.300 төгрөг тус тус гаргуулж, Татварын ерөнхий газарт олгож, тус газрын нэхэмжлэлээс «АФ» ХХК-д холбогдох 3.747.357,3 мянган төгрөгийг хэрэгсэхгүй болгож,

Энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан Ч.Га-ийн 2 ширхэг хөөрөг, битүүмжлэгдсэн Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 257,8 м.кв талбайтай амины орон сууц, Баянзүрх дүүрэг ...дугаар хороо, ...тоот орон сууц, Голомт банк дахь 110302XXXX тоот ам.долларын, 110503xxxx, 120120xxxx тоот төгрөгийн дансан дахь мөнгө, «Лексус 570» загварын 3 ширхэг автомашин, «Лексус-470» загварын 2 ширхэг автомашин, «Ланд круйзер 200» загварын 1 ширхэг автомашин, Д.Эн-ын Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Олимпийн гудамжны 20 дугаар байрны 30 тоот, улсын бүртгэлийн №У-2203011xxxx дугаарт бүртгэгдсэн орон сууц, Баянгол дүүргийн ...дугаар хороо ...байрлалтай, улсын бүртгэлийн №220503xxxx дугаартай үйлчилгээний барилга, газрын хамт, Хан-Уул дүүрэгт байрлалтай, «... тоот, 178,9 м.кв талбай бүхий орон сууц, 2008 онд үйлдвэрлэгдсэн хх-хх УБҮ «Соната 6» загварын автомашин, Б.Жа-ын хх-хх УНТ улсын дугаартай «Лексус 470» загварын автомашин, Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...байрлалтай зуслангийн хашаа байшинг тэдгээр хүмүүсийн төлөх төлбөрт тооцуулахаар Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжүүлж,

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.10 дахь хэсэгт заасныг баримтлан Ч.Да-гийн «СА» ХХК-ийн өмчлөлийн Сүхбаатар дүүргийн ...дугаар хороо, ...тоот, улсын бүртгэлийн У-220302xxxx дугаартай ажлын байр, эрхийн улсын бүртгэлийн У-220302xxxx дугаарт бүртгэлтэй ...тоот ажлын байр, эрхийн улсын бүртгэлийн У-220302xxxx дугаарт бүртгэлтэй ...тоот ажлын байр, эрхийн улсын бүртгэлийн У-220601xxxx дугаарт бүртгэгдсэн Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууцыг, ...тоот зогсоолын хамт, эрхийн улсын бүртгэлийн У-220403xxxx дугаарт бүртгэгдсэн Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо, ...тоот орон сууц, эрхийн улсын бүртгэлийн У-220404xxxx дугаарт бүртгэгдсэн Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо, ...тоот зогсоол, Х.Ха-гийн эрхийн улсын бүртгэлийн У-210100xxxx, Г-210100xxxx, Г-210100xxxx дугаарт бүртгэгдсэн Орхон аймгийн ...сумын

...баг, ...тоот хувийн орон сууц, газар, Б.Жалын өмчлөлийн эрхийн улсын бүртгэлийн Y-210101XXXX дугаарт бүртгэгдсэн Орхон аймгийн ...сумын ...тоот орон сууцыг тус тус битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолуудыг хүчингүй болгож,

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7 дахь хэсэгт «КЖЭМ» ХХК-д татварын хяналт шалгалт хийсэн ажлын баримт 16 хавтас, Шинжээч нарын ажлын баримт 3 хавтас, дансны хуулга 2 хавтас, нийт 21 хавтас баримтыг энэ хэргийг хадгалах хугацаа дуустал хэрэгт хавсарган үлдээж,

Б.Бу, Х.Ха, Б.Жал нарт урьд авсан бусдын батлан даалтад өгсөн таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Ялтан Ч.Га давж заалдах гомдолдоо: "...Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хууль ёсны бус, үндэслэлгүй гарсан тул эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргаж байна.

1. Хээл хахууль авахыг завдсан гэх үйлдлийн талаар:

Би Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа албан тушаалын байдлаа ашиглаж, танил Ц.Со-оор дамжуулан "ВАТТ" ХХК-аас татварын улсын байцаагчийн актаар тавигдах нөхөн татвар, хүү, торгуулийг багасгаж, хийх ёстой үйлдлээ хийхгүй байхаар амлаж, хясан боогдуулах замаар онц их хэмжээний хээл хахууль нэхэж авахыг завдсан гэх 7-8 жилийн өмнөх хэргийг тогтоогоогүй, тогтоосон нотлох баримт ч хэрэгт байхгүй. Би албан үүргийн хувь гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр хэнд ч, юу ч амлаагүй, хэн нэгэн хүнд тохиолдсон шаардлага, хэрэгцээг ашиглах замаар хээл хахууль зайлшгүй өгөх нөхцөл байдлыг бий болгоогүй, өгөхийг тулган шаардаагүй, энэ үйлдлийг хийхэд чиглэсэн үйлдлийг санаатай бүү хэл, огт хийгээгүй, хийх талаар сэтгэл зүрх, ой тойндоо сэтгэн бодоогүй юм.

Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргын үүрэгт ажлаас 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдөр хууль бусаар өөрчлөгдөн, Улсын Дээд шүүхийн шийдвэрээр 2006 оны 5 дугаар сарын 15-ны өдөр буцаж томилогдоход хэлтсийн даргаар ажиллаж байсан Ч.Эн-ын олгосон томилолтын дагуу 2 татварын улсын байцаагч "ВАТТ" ХХК-д хяналт шалгалт хийж, 2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр

3.7 тэрбум төгрөгт акт, 5.4 тэрбум төгрөгт дүгнэлт бичиж гардуулан өгсөн. Үүний дараа тус компанийн санхүү эрхэлсэн дэд захирал Г.Б зөрчил төлбөрийг эс зөвшөөрч, үндэслэлгүйгээр акт, дүгнэлт гаргасан мэтээр гомдол гаргаж байснаа хээл хахууль нэхсэн, төлбөрийг багасгахыг амласан мэтээр 2 татварын улсын байцаагчийг, дараа нь намайг, Татварын ерөнхий газрын дэд дарга Б.А, Н.Б-ыг гүтгэсэн. Энэ нөхцөл байдлыг мөрдөн байцаагч, улсын яллагч, анхан шатны шүүхийн шүүгчид анхааран үзсэнгүй. Мөн хээл хахууль авахыг завдсан гэх хэргийг 8 гэрчийн мэдүүлгээс Ц.Со, Г.Бай нарын мэдүүлэг нотолсон гэх боловч бусад 6 хүний мэдүүлэг, Татварын улсын байцаагчийн акт, дүгнэлт зэргээр тогтоогдоогүй учир эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзаж байсан материал хавтаст хэрэгт авагдсан болно.

Олон жилийн өмнөөс хувийн харьцаа муудсан Ц.Со, өөрийнх нь эрхэлсэн ажлын алдаа, зөрчил дутагдал, хууль бус үйл ажиллагааг нь илрүүлэн, хяналт шалгалтын ажлыг хууль тогтоомжийн дагуу шударга, үнэнээр хийсэн болон хийлгэсний төлөө татварын улсын байцаагч нарт, надад өс хонзон санасан Г.Б хоёрын нотлох баримтгүй, ам дамжсан, яриа, гүтгэлгээр намайг хээл хахууль авахыг завдсан гэмт хэрэгт гэм буруутайд тооцсонд туйлын гомдолтой байна. Гэрч Ц.Со, Р.Ар, Г.Бай нарын 7-8 жилийн өмнөх мэдүүлгүүд нь хоорондоо уялдаа холбоогүй, цаг хугацаа, утга агуулгын хувьд маш их зөрүүтэй байгааг анхааран үзнэ үү.

2. Хууль бусаар хөрөнгөжсөн гэх үйлдлийн талаар:

Гэрчийн мэдүүлгүүд, миний гэр, амьдран сууж буй байр, ажлын өрөө, аавын гражид нэгжлэг хийсэн тухай тэмдэглэл, орон сууц худалдах, худалдан авах гэрээ, газар эзэмших эрхээ бусдад шилжүүлсэн гэрээ, аавын эзэмшиж буй дансны хуулгууд, Гаалийн ерөнхий газрын албан тоот, Криминалистикийн шинжээчийн 2 дүгнэлт зэрэг нотлох баримтууд нь намайг Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж, албан тушаалын цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа хууль ёсны орлогоос гадна хөрөнгийн эх үүсвэрээ тодорхойлж чадахгүйгээр 1.518.375.400 төгрөгийн эд хөрөнгийг олж, хууль бусаар хөрөнгөжсөн гэх эрүүгийн гэмт хэрэг үйлдсэнийг нотлоогүй. Гэтэл Монгол Улсын татварын зарим хууль, Нийгмийн

даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуулийг анх удаа хэрэгжүүлсний дүнд аав У.Чи «байгаа мөнгөө ил болгон тайлагнахад» Ч.Да аавыг төлөөлж татварын хэлтэст мэдүүлсэн. Уг гаргасан тайланд төрсөн хүү нь «У.Чи» гэж гарын үсэг зурсан нь чухал биш байхад дээрх «Шинэчилсэн тайлан» болох «Нууц»-ын зэрэглэлтэй баримтыг задруулан, нотлох баримт болгон ашиглаж байгаад гомдолтой байна. ...байрыг худалдан авах гэрээг аав өөрөө байгуулан, өөрийн эзэмшдэг хадгаламжийн данснаас төлбөрийг төлүүлэх зөвшөөрлийг дүү Ч.Ган-т өгч, нэр дээрээ авсан болно.

“Лексус570” маркийн 3 автомашины нэгийг хүү Г.Га-д дүү Ч.Гб захиж авахуулсан. “Лексус 470” маркийн 2 автомашины нэгийг хүү Г.Га АНУ-д ажил хийж олсон мөнгөөрөө авсан. Монгол Улсад явж байсан “Ланд круйзер 200” маркийн автомашиныг би урьд нь эзэмшиж байсан “Ланд круйзер 105” маркийн автомашинаа зарсан мөнгөөрөө авсан. Харин “Лексус 570” маркийн 2, “Лексус 470” маркийн 1 автомашиныг аавын ам.долларын данснаас шилжүүлж авсан.

Япон Улсад амьдарч байгаа эхнэр, охин хоёр сардаа дунджаар 4000-5000 ам.долларын орлого олдог. Мөн би Сангийн яам, Үндэсний татварын албанаас 2 удаа 20.000.000 төгрөгөөр шагнагдаж байсан. Гэр бүлээрээ БНХАУ, БНСУ, ОХУ, ХБНГУ, АНУ, Япон улс явж наймаа хийж байснаас хуримтлагдсан орлогоор дээрх эд хөрөнгийг авсан болохыг мөрдөн байцаалтад мэдүүлсээр байхад огт хүлээн авсангүй. Д.От-аас 2 хөөрөг авсан нь үнэн. 30 гаруй жил ажиллаж хөдөлмөрлөсөн хүн хоёр хөөрөг худалдан авах чадвартайг хэн ч үгүйсгэхгүй гэж бодож байна.

3.Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан гэх үйлдлийн талаар:

Төрсөн дүү Ч.Да-тэй үгсэн тохирч 13.398.688.100 төгрөгийн татварыг буюу төсөвт төвлөрүүлээгүй буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг үйлдсэнийг 6 гэрч, 4 шинжээчийн мэдүүлэг, татварын улсын байцаагчийн 5 илтгэх хуудас, 1 акт, иргэн Р.Ба-ын нэрээр бичсэн гэх гомдол, гомдлын хариу, 10 шинжээчийн гаргасан 6 дүгнэлт нь нотолж чадаагүй. Энэ хэрэгт яллаж байгаа нь гэмт хэрэгтэн болгох сонирхол бүхий этгээдүүдийн хүсэл зоригт нийцүүлэн зохион байгуулалттайгаар хийж буй гүтгэлэг, хилс хэрэг гэж үзэж байна.

Татварын улсын байцаагч нараар нэр бүхий 6 компанийн татварын ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийлгүүлэн 13 тэрбум гаруй төгрөгийг татварт ногдуулалгүйгээр татварын улсын байцаагчийн илтгэх хуудас, акт гаргуулан төсөвт төвлөрөх ёстой байсан мөнгийг оруулаагүй талаар нэг ч мэдүүлэг, нотлох баримт хэрэгт авагдаагүй.

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд миний мэдүүлэг, тайлбарыг буруу зөрүү, дутуу бичсэн, зарим хэсгийг огт тусгаагүй. Энэ гэмт хэрэгт намайг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт заасныг журамлаж ял ногдуулсан ба энэ зүйлд заасан «захиалагч, зохион байгуулагч, хамжигч, гүйцэтгэгч, хатгагч»-ийн алинд нь хамаарч байгааг тодорхой зааж өгөөгүй. Би Ч.Да-д Татварын ерөнхий газарт мэдээлэл өгөх талаар үйлдэл хийгээгүй, татварын улсын байцаагч нарт илтгэх хуудас бичих талаар чиглэл өгөөгүй. Ч.Да үгсэн тохиролцоогүй, өргөдөл гаргасныг Ч.Га мэдээгүй талаар мэдүүлгээ өгсөн байгаа.

Шинжээчийн дүгнэлтээр гарсан 13.398.688.100 төгрөгийн татвар гэдэг бол Татварын болон бусад хууль тогтоомжийн талаар мэдлэггүй, ашиг сонирхлын зөрчилтэй этгээдүүдийн хийсвэр, бодит бус дүн гэдэг нь тогтоогдсон. Шинжилгээ хууль зөрчиж явагдсан, шинжээчээр хэн нь тодорхойгүй 19 хүн гарын үсэг зурсан. 2013 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн нэмэлт шинжилгээ хийх тогтоол хууль зөрчсөн, 12 хүний нэрийг гараар нөхөж бичсэн. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2 дахь хэсгийг зөрчиж ашиг сонирхлын зөрчилтэй Чингэлтэй дүүргийн татварын улсын байцаагчдыг шинжээчээр томилсон. Тэд татгалзах үүрэгтэй байтал татгалзаагүй, шинжилгээ явуулахдаа мөн хуулийн 14 дүгээр зүйлийг ноцтой зөрчсөн. Шинжээч нар хуулиар олгогдоогүй бүрэн эрхийг хэрэгжүүлж, мөрдөгдөж буй хууль тогтоомж, журмыг санаатай буцаан хэрэглэх, татварын хяналт шалгалтад хамрагдаагүй хугацааг дүгнэлтдээ оруулах, томилогдоогүй байхдаа шинжилгээ хийх, аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулсан гэрээг өөрсдийн үзэмжээр дүгнэх, нөхөн татвар, хүү, торгууль, алдангийг хууль бусаар ногдуулах зэргээр татвар төлөгчдийн болон бидний эрх зүйн байдлыг дордуулсан илт хууль бус дүгнэлт гаргасан.

Тухайлбал, Аж ахуйн нэгжийн орлогын

албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9-ийн д/ дэх заалт нь 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн нэмэлт өөрчлөлтөөр орж 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заасан байхад хуулийн энэ заалтыг буцаан хэрэглэж татвар ногдуулсан. «ЭрЭ», «ХЭ» ХХК-иудад Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчид 2005-2009 оны байдалд хяналт шалгалт хийсэн байхад шинжээч нар 2010 оны 10 дугаар сарын 25, 11 дүгээр сарын 1-ний байдлаар дүгнэлт гаргаж татвар, хүү, торгууль, алданги тооцсон. «ПС» ХХК хувьцаа худалдан авсан байхад ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан авсан мэтээр дүгнэлт гаргасан. Б.А "Цэвэр агаар сан"-ийн хэргээр Авлигатай тэмцэх газарт шалгагдаж, яллагдагчаар татагдсан байхад энэ хэрэгт шинжээчээр томилж дүгнэлт гаргуулсан. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1, 10.4, 10.4.1, 10.4.2 дахь заалтыг зөрчиж шинжилгээ явагдсан. Иймд шийтгэх тогтоолыг хүчингүй болгож хэргийг мөрдөн байцаалтад буцааж өгнө үү...» гэжээ.

Ялтан Д.Эн давж заалдах гомдолдоо: "...Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч дараах үндэслэлээр давж заалдах гомдол гаргаж байна. 2013 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн бүрэлдэхүүнтэй шинжээчийн дүгнэлт Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуулийг ноцтой зөрчсөн, нотлох баримтын шаардлага хангаагүй байхад шүүх үнэлж хэргийг шийдвэрлэсэн. Надад ял оногдуулахад үндэслэл болсон цорын ганц нотлох баримт нь шинжээчийн дүгнэлт бөгөөд мөрдөн байцаагч миний эрх зүйн байдлыг дордуулах зорилгоор шинжээчдийг хангалттай баримттай танилцуулаагүй. Шинжээчээр ашиг сонирхлын зөрчилтэй, хохирогч Татварын ерөнхий газрын улсын байцаагчдийг томилсон. Шинжээч нар дүгнэлт гаргахдаа Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6 дахь хэсэгт зааснаар байгууллагын тэмдэг, шинжээчийн хувийн тамга дараагүй нь нотлох баримтын шаардлага хангаагүй. Миний хувь хүний орлогын болон татварын тооцоог хийхдээ мэргэжлийн алдаа гаргаж, зориуд худал дүгнэлт гаргасан. Жишээлбэл: Шинжээчид хууль сануулах, татгалзан гарах үндэслэл байхад асуугаагүй. Шинжээчдээс тавьсан 7 асуултын 6 нь хууль зүйн үндэслэлийн талаар асуусан нь Эрүүгийн

байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн. Мөн яллах талын баримтаас зарим нь цагаатгах талын нотлох баримт байгаа. Үүнд «ЖМ» ХХК-д олгосон зээлийн баримтууд нь миний үндэслэлгүй хөрөнгөжсөнийг үгүйсгэх, эх үүсвэр нь аль 2012 оноос өмнө бий болсон гэдгийг нотлох баримт юм. "ПР" ХХК-тай намайг ямар нэгэн харилцаа холбоогүйг нотолсон баримтыг хэрэгт авах ажиллагаа хийгээгүй. Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны орлогоос татвар ногдуулахад холбоотойгоор үүсдэг. Гэтэл миний хууль бусаар хөрөнгөжсөн орлогоос татвар ногдуулж байгаа огт ойлгохгүй байна. Иймд надад холбогдох хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж, дахин шинжээч томилж өгнө үү...» гэжээ.

Ялтан Ч.Да давж заалдах гомдолдоо: «...Шийтгэх тогтоолыг дараах үндэслэлээр эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргаж байна.

Би төрийн албан хаагч биш. Гэтэл төрийн албан хаагчийн албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэж ял хүлээлгэж байгаа нь үндэслэлгүй. Хэнийг ч ятгах, заналхийлэх, зоригжуулах, өдөөн турхираагүй. Энэ талаар хэн ч мэдүүлээгүй, тогтоогоогүй байхад ийм зүйл ангиар журамласныг ойлгохгүй байна. Үндэсний Татварын ерөнхий газарт гомдол өгүүлснийг ах Ч.Га мэдээгүй гэдгийг мөрдөн байцаалт болон шүүхийн хэлэлцүүлгийн шатанд удаа дараа мэдүүлсэн боловч хүлээж авсангүй. Би Р.Ба гомдол гаргах бичгийг бэлтгэж өгснөө хүлээн зөвшөөрсөн. Мэдээлэл өгсөн Р.Ба, гэрч Ж.Дэ нар Ч.Га-ийг танихгүй гэж мэдүүлсэн байхад намайг Ч.Га-тэй үгсэн тохирсон гэж байгааг ойлгохгүй байна. «НА» ХХК-ийн захирал, талийгаач Ц.Т намайг өрөөндөө дуудаад Татварын ерөнхий газар гомдол бичээд өг гэж хэлсний дагуу би гомдол гаргах бичгийг зохиож өгсөн. Нэр бүхий 6 компанид татварын хяналт шалгалт хийсэн Н.Чи, Б.Өс, Н.Ра, Т.П.Га, О.Бя, Б.Жа нарыг танихгүй, уулзаж ч байгаагүй. Тэд хуулийн дагуу татварын хяналт шалгалт хийсэн гэдгээ өөрсдөө тайлбарлаж байгаа. Би шүүхийн хэлэлцүүлгийн шатанд «Татварын албанд гомдол хүнээр өгүүлсэн нь ёс зүйгүй болсон» гэж хэлснийг Ч.Га-тэй «үгсэн тохирсон» гэх хэргээ хүлээсэн гэж шийтгэх тогтоолд дурсныг хүлээн зөвшөөрөхгүй. Миний аудитор хийх эрхийг 3 жилийн хугацаагаар хассанд гомдолтой байна. «СА» ХХК нь 7 хүнийг ажлын байраар

хангаж, Монгол Улсын хууль тогтоомж зөрчиж байгаагүй, хуулийн дагуу татвараа төлж, шилдэг татвар төлөгчөөр удаа дараа шалгарч байсан. Иймд хэргийг нааштайгаар шийдвэрлэж өгнө үү ...» гэжээ.

Ялтан Б.Жа давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Надад холбогдох хоёр хэргийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 254.2 дахь хэсэгт зааснаар санаатай дүгнэлт гаргасан зүйл байхгүй. 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 164 тоот дүгнэлтийн объект нь 3 шинжээчийн бүрэлдэхүүнтэй гаргасан дүгнэлтийн объектоос өөр байгаа тул хооронд нь харьцуулах ямар боломжгүй. Би татварын улсын байцаагчийн 2013 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 250041 тоот дүгнэлт үндэслэлтэй эсэх талаар шинжилгээ явуулсан. Ц.С, Б.А, Н.Г нар бол шинжээчийн дүгнэлт гаргаагүй бөгөөд анхан шатны баримтад шалгалт хийсэн. Анхан шатны шүүх хуралдааны хэлэлцүүлгийн үед Н.Г «Шинжилгээний тухай хууль уншсан уу» гэхэд «уншаагүй» гэж хариулж байсан. Гэхдээ миний гаргасан дүгнэлтийн зөрчил дутагдлыг шалгаагүй. Би 10 жил шинжээч хийж байна. Миний баримталдаг зарчим бол гаргаж байгаа тооны баримтыг ард нь бичдэг. Үүнийгээ ч удирдлага доор байдаг хүмүүстээ хэлж захидаг. Энэ бол сүүлд нь ямар нэгэн асуудал гарахад хамгаалах баримт болдог юм. Хэрэгт авагдсан баримтуудаар дурын тоог асуухад би одоо хэлээд өгөх боломжтой. Ийм учраас миний гаргасан дүгнэлт буруу болоогүй. Б.Жа тооцоотой дүн хийгээгүй, үндэслэлгүй дүгнэлт гаргасан гэсэн болохоос энэ нь буруу байна гэсэн ямар ч зүйлийг шинжээч нар дүгнэлтдээ тодорхой дурдаж өгөөгүй. 164 тоот дүгнэлтийг төслөөсөө зөрүүтэй гэж ялласан. 2013 оны 08 дугаар сарын 07-ны өдөр дүгнэлтийн төслийг комиссын хурлаар оруулахад хойшлуулсан бөгөөд дүгнэлт төслөөс 36.000.000 төгрөгөөр зөрсөн нь «ЖМ» ХХК-д олгосон зээл юм.

Зуслангийн байшинг авахдаа би хуучин байраа зарж мөнгийг нь хүүхдүүдээ өгөөд үлдсэн 19.000.000 төгрөгийг, мөн хадгаламжаасаа 10.000.000 төгрөгийг, цалингийн зээл авч 8.000.000 төгрөгийг, хүнд зээлсэн 2.000.000 төгрөгөө авч нийт 39.000.000 төгрөгийг бүрдүүлсэн. Энэ талаар хэрэгт тодорхой мэдүүлсэн. Миний нөхөр А.Ба Өмнөговь аймагт хүнд даацын автомашинаар тээвэр хийдэг бөгөөд өвөлдөө

Дулааны цахилгаан станцад гэрээгээр нүүрс зөөдөг, хилээр ачаа ачиж гардаг. Энэ орлогын эх үүсвэрээр «Лексус 470» загварын автомашин авсан нь нотлох баримтуудаар нотлогдсон. Манай анхны ч автомашин биш. 1991 онд анхны машинаа авсан ба үүнээс хойш 8 дахь автомашин болж байгаа юм. Нөхөр А.Ба-гийн авсан автомашиныг нь намайг үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж тооцсон хэрнээ, 3 жилийн хугацаанд нөхрийн дансаар нийт гүйлгээ хийгдсэн 200.000.000 төгрөг харгалзаж үзээгүй. Энэ нь харилцах дансаар тээврийн хөлсний зардал орж байсан. Иймд дээрх нөхцөл байдлуудыг харгалзан үзэж надад холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү» гэв.

Ялтан П.Га давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан юм. Учир нь «УМ» ХХК-д татварын улсын байцаагчид дүгнэлт бичсэн. Би Ч.Га даргын томилолтын дагуу Баянгол дүүргийн татварын байцаагчдын 260007 тоот дүгнэлтийг үндэслэлтэй эсэхийг нь шалгахад илт хууль бус байсан нь тогтоогдсон. Ашигт малтмалын хайгуулын лицензийг худалдан борлуулах тухай асуудлыг хуулиар хориглосон байдаг. «УМ» ХХК-ийн эзэмшлээс ашигт малтмалын хайгуулын лиценз шилжиж өөр ямар нэгэн байгууллагад очоогүй. Гэтэл Татварын улсын байцаагч Г.Бая, Ж.На нар «УМ» ХХК-ийн үүсгэн байгуулагч Т.У нь «ПС» ХХК-д хувьцаагаа зарсныг ашигт малтмалын тусгай зөвшөөрөл борлуулсан гэж хууль бус дүгнэлт гаргасан. Эрх борлуулсны орлогод ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлсэн асуудал орохгүй байхад шинжээч нар хууль буруу тайлбарлан хэрэглэж, 30 хувийн татвар ногдуулсан. Мөн надад хамаагүй «ПВР» ХХК-ийн баримтад үндэслэн дүгнэлт гаргасан. Нөгөө талаар энэ компани хэдэн ч төгрөгийн дүрмийн сантай байсан хувьцаа нь зах зээлийн ханшаар борлуулагдана. Би Баянгол дүүргийн татварын байцаагчдийн дүгнэлтийг хүчингүй болгоогүй гэдгийг дахин хэлмээр байна. Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд татварын улсын байцаагчийн бүрэн эрхийг хуульчилсан байдаг. Өөрөөр хэлбэл, татварын байцаагч ганцаарчилсан болон 2 ба түүнээс дээш бүрэлдэхүүнтэйгээр шалгана гэсэн заалт байхгүй. Хуулиар хориглоогүй байхад хуулиас давсан дүрэм журам байх ёсгүй. Дүрэмдээ 2 ба түүнээс дээш бүрэлдэхүүнтэй хяналт шалгалтыг

хийвэл илүү үр дүнтэй байдаг гэсэн агуулгыг хэлж байгаа болохоос заавал 2 ба түүнээс дээш шалгалтыг хийнэ гэсэн санаа биш. Өнөөдөр хөдөө орон нутагт нэг байцаагч хяналт шалгалтыг хийж, торгууль ногдуулж арга хэмжээ авдаг гэдгийг хэлмээр байна.

“КЖЭМ” ХХК 14.2 тэрбум төгрөгийн орлого олоод 2.1 тэрбум төгрөгийн орлого ногдуулаагүй гэдэг. Тэгэхлээр Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд ямар байдлаар гэрчилгээ авч, татвар ногдуулж төлөх талаар тодорхой зааж өгсөн. Гэтэл шинжээч нар НӨАТ төлөх болзол журмыг хангаагүй байхад 14.2 тэрбум төгрөгийг хаанаас гаргаж ирснийг одоог хүртэл би мэдэхгүй байна. Энэ талаар анхан шатны шүүх хуралдааны хэлэлцүүлэгт шинжээчээс өмгөөлөгч асуухад «2006 онд тийм байх боловч 2005 онд 12.000.000 төгрөгийн орлоготой байсан» гэсэн нь үндэслэлгүй. Учир нь 2005 оноос өмнө Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс тус компанийн гэрчилгээг хүчингүй болгосон бөгөөд энэ хүчингүй болгосон гэрчилгээг хараагүй байдаг. Шинжээч нь хүчингүй болгосон гэрчилгээг хараагүй байхад өнөөдөр миний бие ялтан болоод явж байгаа нь ойлгомжгүй байна. Мэргэжлийн үүднээс хэлэхэд татвар төлөгч нарын толгой ажлаад эхэлбэл компани нь үндсэн үйл ажиллагаанаас орлого олоогүй, хайгуулын төсөл хэрэгжүүлж, их хэмжээний түлш, эрэл хайгуулын зардал гаргалаа гэхэд НӨАТ төлөгч байгууллагуудаас бараа татварыг авдаг гэж үзэхэд Улсын төсвөөс авлагатай гарна шүү. Үүнийг хариуцлагатай хэлмээр байна. “КЖЭМ» ХХК-ийн эзэмшлээс ямар ч ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл өөр хүний, компанийн, эсхүл Их Британийн Виржиний арлууд гэх мэт байгууллагуудын нэр дээр шилжиж очоогүй. “КЖЭМ» ХХК-д 45, 46, 47 тоот актуудыг тогтоож нэгдсэн дүнгээр илтгэх хуудас бичсэн. Ингэхэд 1.088.000.000 төгрөгөөс цэвэр дүн 980.000.000 төгрөгийг гаргахад үүнийг шинжээч нар бодож 963.000.000 төгрөгийн дүнтэй гэдэг тоог буруу бодож улсад 17.000.000 төгрөгийн хохирол учруулсан гэж дүгнэсэн. Ингэж буруу бодлого хийсний төлөө өнөөдөр миний бие ялтан болж байна. Иймд шинжээч нарын үндэслэлгүй дүгнэлт гаргасан байдалд шүүх дүгнэлт хийж надад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон, цагаатгаж өгнө үү» гэв.

Ялтан Н.Ра давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

«Анхан шатны шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 261 дугаартай шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч дараах гомдлыг гаргаж байна. Үүнд:

Шүүх намайг гэм буруутайд тооцсон үндэслэлээ зааж өгөөгүй. Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд заасан албан тушаалын байдлаа хувийн ашиг сонирхлоо гүйцэтгүүлэх зорилгоор ашигласан гэдгээ ойлгохгүй байна. Өөрөөр хэлбэл: гэмт хэргийн субъектив талын шинжийг тогтоогоогүй.

Би ажлын байрны тодорхойлолтод заасан үүргийн дагуу «НТГ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийг шалгаж, Татварын улсын байцаагчдын 2010 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 260006 тоот дүгнэлтийн хууль зүйн үндэслэлийг тогтоох зорилгоор хэлтсийн даргаас өгсөн томиллоор ажилласан. 260006 тоот дүгнэлтэд 6.9 тэрбум төгрөгийн зөрчил нь энгийн хувьцаа худалдсан орлого 2.7 тэр бум, бусад нь хувьцааны үнийн урьдчилгааг давхардуулсан байсан. Ийнхүү зөрчлийн дүнг хийсвэрээр ихэсгэсэн гэдгээ татварын байцаагч нар ч хүлээн зөвшөөрсөн. Татварын шалгалт хийхдээ 584.000.000 төгрөгийн хохирол учруулсан гэж дүгнэсэн. Ингэж дүгнэхдээ шинжээчээр томилогдсон Н.Г, Ц.С, Б.А нарын 2013 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн шинжээчийн дүгнэлтийг үндэслэсэн. Энэхүү шинжээчийн дүгнэлт нь миний хяналт шалгалт хийх явцдаа үндэслэлгүй гэж үзсэн Баянгол дүүргийн Татварын улсын байцаагч нараас шалгаад 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдөр “НТГ» ХХК-ийн 6.974.495.000 төгрөгийн зөрчилд 260006 дугаартай дүгнэлтийг хүлээн зөвшөөрч, зөв үйлдэл болохыг нотолсон байхад намайг буруутгах үндэслэл болгоод байгааг ойлгохгүй байна. Тэгэхлээр “НТГ» ХХК-ийг үүсгэн байгуулагч Б.Д гэгч хүн “ПС» ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ байгуулж компанийнхаа эрхийг шилжүүлсэн байдаг. Би “ПС» ХХК-д шалгалт хийх томилолт аваагүй. Тэгэхэд шинжээч нар “ПС» ХХК-ийг шалгаад гэрээгээр халхавчлан ашигт малтмалын зөвшөөрөл худалдсан дүгнэсэн. Шинжээч Н.Г нь халхавчилсан гэрээ гэдгийг тогтоох субъект биш. Компанийн хувьцааг худалдаж авах эрх нь ямар ч аж ахуйн нэгжид байдаг. Тэрний дагуу хувьцаа худалдаж авах гэрээгээр авсан нөхцөлд Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлд зааснаар шилжих ёстой. Мөн 150.000.000 төгрөгийн мэдээлэл худалдаж авсан гэрээний дагуу

татвараа төлж тушаасан байдаг. Би томилолт авахдаа татварын байцаагчийн дүгнэлтийг судлах хэсэгчилсэн томилолт авч, хянан шалгалт хийж илтгэх хуудас бичсэн болохоос татварын байцаагчийн дүгнэлтийг хүчингүй болгоогүй.

“БАЭ” ХХК-ийн 2005-2009 оны татвар төлөлтийн байдлыг шалгасан. Шинжээч нар Монгол Улсад явуулаагүй үйл ажиллагаанд татвар ногдуулсан нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалтыг зөрчсөн. Энэ компани ашигт малтмалын хайгуулын лицензтэй хэрнээ Монгол Улсад үйл ажиллагаа явуулаагүй. Учир нь Монгол Улсад хайгуул хийж, чулуулгийн дээж гэж хэлээд Австрали Улсад ачуулсан. Австрали Улсад шинжлээд цахим хэлбэрээр агууламжийг нь тайлбарласан үйлчилгээ үзүүлсэн. Харин аж ахуйн нэгжийн албан татварын тухай хуульд Монгол Улсад үйл ажиллагаа явуулсан аж ахуйн нэгжид татвар ногдуулна гэж заасан байдаг. НӨАТ ногдуулахдаа Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үзүүлсэн үйл ажиллагаанд татвар ногдуулах ёстой болохоос гадаадад улсад явуулсан үйлчилгээнд татвар ногдуулах үндэслэлгүй. Мөн Завхан аймгийн Дөрвөлжин суманд 6102 га газарт хайгуул хийсэн. Гэтэл 85.000.000 төгрөг төлөөгүй байна гээд торгууль алданги гаргаад ирсэн. Завхан аймгийн Дөрвөлжин сумын Засаг даргын 2014 оны 01 дүгээр сарын 14-ний албан бичгээр «БАЭ» ХХК 2010 оноос өмнө газар эзэмшиж байгаагүй гэсэн тодорхойлолт ирүүлсэн. Харин шинжээч нар энэ тоотыг ойлгоогүй, мөрдөн байцаагч дүгнэлт гарга гэсэн байдлаар хандсан гэж хэлж байсан. Мөн 2005-2009 оны татвар ногдуулалтад 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9 дэх заалтад орсон нэмэлт өөрчлөлтийг буцаан хэрэглэсэн. Иймд эдгээр үндэслэлээр надад оногдуулсан ял шийтгэлийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү” гэв.

Ялтан Б.Өс давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: “Намайг албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан гэж байгааг ойлгохгүй байна. Миний гэм бурууг шүүх нотолж чадаагүй. Энэ гэмт хэрэгт гүйцэтгэгч, хамжигчаар оролцсон байдлыг нотлоогүй. Ганцаараа шалгалт хийснийг буруу гэж байгаа бол өмнөх бүх шалгалт буруу болно. Бид өөрсдөө томилолт бичиж хяналт шалгалт

хийдэггүй. Дээрээс өгсөн үүрэг даалгавар, хэлтсийн даргын томилолтын дагуу хяналт шалгалт хийдэг. Уг журмын дагуу хяналт шалгалт хийсний төлөө буруутгаж байгаа нь үндэслэлгүй юм. Надтай холбоотой “ХБЭ”, “КЖЭМ» ХХК-иудын асуудал яригддаг. Эдгээр компаниудад шалгалт эхлэх үед би ээлжийн амралттай байсан ба 10 дугаар сарын 5-ны өдөр ажилдаа орж, 18-ны өдөр томилолт өгснөөр “ХБЭ» ХХК-ийн санхүүд шалгалт хийсэн. “ХБЭ» ХХК нь «КЖЭМ» ХХК-аас 2007 онд 1.086.000.000 төгрөгөөр 12 ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн мэдээлэл худалдаж авсан. Үүнийг “КЖЭМ» ХХК 2007 онд татварын тайландаа орлого гэж тусгасан байсан. Энэ нь Б.Ба, С.О нарын шинжээчийн дүгнэлтээр батлагддаг. Харин НӨАТ-ын тайландаа тусгаагүй байсан. “КЖЭМ» ХХК нь тайландаа тусгасан байхад худалдан авалт хийсэн “ХБЭ» ХХК-д 30% татвар ногдуулсан. “КЖЭМ» ХХК-аас «ХБЭ» ХХК нь мэдээлэл худалдан авах нэг гэрээ, лиценз шилжүүлэх нэг гэрээ гээд 2 өөр гэрээг хийсэн. Эрх борлуулсан үнийн дүнгээс суутгал аваагүй байна гэдэг үндэслэлээр уг гэрээний үнийн дүнгийн 30%-д татвар ногдуулсан. «ХБЭ» ХХК нь мэдээлэл худалдан авч 10 хувийн татвараа төлсөн болохоос лиценз худалдаж аваагүй. Шинжээч нар 30 хувийн татвар нэмж ногдуулан 50 хувиар торгууль ногдуулсан. Үүнийг хүлээн зөвшөөрөх боломжгүй. Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад хайгуулын зардлыг биет бус хөрөнгөд бүртгэнэ гэж заасан. Биет бус хөрөнгө борлуулсан гэж тусгасан байхад яагаад эрх борлуулсан гэж үзэв. Эрх шилжүүлсэн гэх гэрээний хууль зүйн үндэслэл зөв бурууг яагаад тодорхойлоогүй вэ гэдэг асуудал яригдаж байна. 12 лицензийн хуримтлагдсан зардлын тооцоо тус тусдаа гарсан. Үүн дотор эрх борлуулсан гэсэн нэг ч үг үсэг байдаггүй. «ХБЭ» ХХК-тай холбоотой дүгнэлт нь хууль бус юм. Би «КЖЭМ» ХХК-ийн татвар төлөлтийн байдалд шалгалт хийсэн. 2005 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд татвар, санхүүгийн тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох хөндлөнгийн мэдээллийг үндэслэн татварын хяналт шалгалт хийхэд татвар ногдуулалт, төлөлттэй холбоотой зөрчил илрээгүй. Иймээс «КЖЭМ» ХХК-ийн 11 тэрбум төгрөгийн асуудал надад хамааралгүй гэж ойлгож болно. Бүхэл бүтэн 5 жилийн хугацааны баримтыг 7 хоногийн дотор нэг хүн үзэж дуусгах боломжгүй. «2005 оны баримтыг

Б.Өс байцаагч шалгасан, 2006 оны баримтыг Б.Жа шалгасан, 2007-2009 оны баримтыг П.Га байцаагч шалгасан» гэж Б.Жа, П.Га нар анхан шатны шүүх хуралдаанд мэдүүлсэн. Би «ХБЭ» ХХК-д шалгалт хийж байх явцдаа уг 2 гэрээтэй холбоотой асуудлаар хуулийн хэлтсийн дарга Тэнгистэй уулзаж арга зүйн зөвлөгөө авахад «Наадах чинь биет бус хөрөнгөөр бүртгэгдэх юм байна. Иймд акт тавигдах ёсгүй» гэсэн. Үүний дараа Ч.Га дарга дээр орж уг асуудлыг танилцуулахад «зөрчил биш учраас «КЖЭМ» ХХК-д уг борлуулалтаас суутгагчийн эрх, үүрэг үүсэхгүй» гэсэн. Надад үндэслэлгүйгээр ял оноосонд гомдолтой байна. Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэрэгсэхгүй болгож, намайг цагаатгаж өгнө үү» гэв.

Ялтан Н.Чи давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгийн явцад хэт нэг талыг барьсан, шүүхийн дүгнэлт, шийтгэх тогтоол нь хэргийн жинхэнэ бодит байдалтай нийцээгүй.

Шүүхийн хэлэлцүүлэгт шинжээчийн дүгнэлт нь хэрэгт авагдсан бусад нотлох баримтаар нотлогдоогүй, үгүйсгэгдэж, хууль, тогтоомжийг илт зөрчсөн нь тогтоогдсон. Үндэслэл болгосон шинжээчийн дүгнэлтийг шүүх хэрхэн дүгнэсэн талаар шийдвэртээ тусгаагүй, эрх зүйн дүгнэлт хийгээгүй, хэрэгт онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад алийг нь авч бусдыг үгүйсгэсэн тухай үндэслэлийг заагаагүй орхигдуулсан. Шүүх хуралдааны хэлэлцүүлэгт шинжээч нар нь гаргасан дүгнэлтийнхээ хууль зүйн үндэслэлийг тайлбарлаж чадаагүй, өмгөөлөгч нарын зарим асуултанд хариулаагүй, хуулийг буруу хэрэглэсэн гэдэг нь тогтоогдсон. Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ц.Б нь шүүх хуралдаанд ирж мэдүүлэг өгснийг шүүх хуралдааны тэмдэглэлд тусгаагүй. Миний хувьд «ХЭ» ХХК-ын татвар ногдуулалтын байдалд 2010 онд томилолтоор шалгалт хийж 332.000.000 төгрөгийн зөрчил илрүүлэн төлбөр ногдуулан төлүүлэхээр акт тогтоосон. Хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт болон шүүхийн хэлэлцүүлгийн явцад хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгоор албаны эрх мэдлээ ашигласан үйлдэл тогтоогдоогүй. «ХЭ» ХХК 2009 онд газар ашиглуулаагүй, газар ашиглуулахаар гэрээ байгуулаагүй байхад шинжээч нар «2009 онд газрын төлбөр төлөөгүй» гэж дүгнэсэн нь хууль зүйн

үндэслэлгүй. Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ц.Б, С.Ба нар гэрчээр оролцож гэрчийн мэдүүлэг өгсөн хирнээ шинжээчээр дүгнэлт гаргасан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 57 дугаар зүйлийн 57.1, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1, мөн хуулийн 16.1.1 дэх заалтыг тус тус зөрчсөн. Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаггүй гадаадын аж ахуйн нэгжид татвар ногдуулсан, хууль буцаан хэрэглэсэн зэрэг зөрчил гаргасан. Монгол Улсад байрладаггүй аж ахуйн нэгжүүдэд албан татвар ногдуулахдаа Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9.г, 17.2.9.д заасныг дурдсан байдаг. Гэтэл мөн хуулийн 17.2.9-ийн д/ дэх заалт нь 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр нэмэлт өөрчлөлтөөр орсон байхад 2007-2009 оны үйл ажиллагаанд хамааруулсан хууль буцаан хэрэглэсэн. Гадаадаас шилжүүлсэн орлогод нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулсан. Гэтэл нэмэгдсэн өртгийн албан татвар нь дотоодын бараа, ажил үйлчилгээний, Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлчилдэг татвар юм. Ингэж хууль бусаар татвар ногдуулсныг хүчингүй болгосон. Мөн 2009 онд «ХЭ» ХХК-д газрын төлбөр ногдуулсан нь үндэслэлгүй. Төлбөр авах гол нөхцөл нь тухайн компани газар ашигласан байх ёстой, газрыг ашиглахын тулд гэрээ хийсэн байх ёстой. Гэрээний дагуу тухайн газрыг ямар зориулалтаар ашиглаж байгааг гэрээгээр зохицуулдаг. Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Засаг даргаас газар ашиглаагүй талаар тодорхойлолт ирүүлсэн. Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт гэж заасны дагуу, «ХЭ» ХХК нь «КЖЭМ» ХХК-тай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хайгуулын талаарх мэдээлэл буюу хайгуул үнэлгээний хөрөнгийг 32.965.1 төгрөгөөр худалдсан нь Аж нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлд зааснаар «биет бус хөрөнгө борлуулсны орлого нь эрх борлуулсан орлогод хамаарахгүй» тул «ХЭ» ХХК-аас албан татварыг суутган тооцох нь хууль зүйн үндэслэлгүй байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.5, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт-6, Сангийн сайдын 2011 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 12 дугаар тушаалаар батлагдсан «Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын зардлыг нягтлан бодох

бүртгэлд бүртгэх журам»-д зааснаар хайгуулын мэдээллийг биет бус хөрөнгөд бүртгэхээр заасан. Шинжээч нар хохирлын хэмжээг тооцоходоо захиргааны хариуцлага хүлээлгэн торгууль, хүү, алданги ногдуулж, эрүү, захиргааны хариуцлагыг давхардуулан ногдуулж, хууль буруу хэрэглэн дүгнэлт гаргасныг шүүх үнэлж байгаа нь үндэслэлгүй юм. Мөрдөн байцаагч, прокурор, шүүх хэргийг тал бүрээс нь бодитой авч үзэхийн тулд хуульд заасан арга ажиллагааг хийгээгүй. Татварын улсын байцаагч нар гэмт хэрэг хамтран үйлдсэн, зохион байгуулсан гэдгийг нотлох баримт хэрэгт авагдаагүй. Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 261 дүгээр шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж өгнө үү» гэв.

Ялтан Б.Жр давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Шийтгэх тогтоолд хэрэгт шинээр авагдсан нотлох баримтыг үнэлээгүй. Прокурорын яллах дүгнэлт болон мөрдөн байцаалтад баримтуудаас ямар нь үгүйсгэгдэж байгаа болон аль нь үнэлэгдэж байгааг дүгнээгүй. Шүүхийн хэлэлцүүлгийн явцад шүүгдэгч нар гэм буруутай буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэж гол нотлох баримтыг шинжээч нар дүгнэлтүүдээ тайлбарлаж чадаагүй. Зарим асуултуудад хариулт өгөөгүй. Хуулийг буцаан хэрэглэсэн болох нь тогтоогдсон. Шинжээч нар нь ижил төстэй дүгнэлт гаргаж, төлбөр ногдуулсан хохирлын хэмжээ тогтоосон байхад анхан шатны шүүх аль нь үндэслэлтэй, ямар нь үндэслэлгүй гэдгийг харьцуулан судлаагүй. 2006 онд «КЖЭМ» ХХК-д шалгалт хийхдээ ээлжийн амралттай, ажилдаа ороход нэмэлт томиллолтоор 25 хоногийн дараа шалгалт хийсэн юм. Шинжээчээс яагаад нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч биш компанид НӨАТ ногдуулсан юм гэдэг асуудал дээр мэдүүлэхдээ «Чингэлтэй дүүргийн татварын хэлтсээс 2003 онд шалгалт хийж хууль бусаар НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн байна. Ингээд 238.000.000 төгрөгийн НӨАТ-ыг улсаас буцаан авахаар үйлдэл хийсэн байна» гэж Чингэлтэй дүүргийн татварын хэлтсээс акт тогтоосон. Энэ нөхцөл байдлыг хараагүй гэдэг байдлаар мэдүүлсэн. «КЖЭМ» ХХК-д 2006 онд татвар ногдуулалт төлөлтийн байдалд шалгалт хийсэн учраас зөвхөн 2006 онд хамаарах 2 тэрбум төгрөгийн төлбөр ингэж үүссэн. Харин НӨАТ

ногдуулахгүй үндэслэл болох Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн 2006 оны актыг хараагүй гэж шинжээч нар мэдүүлсэн байхад энэ байдлыг анхан шатны шүүх үнэлээгүй.

Миний бие «ШЭ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийсэн бөгөөд хэлтсийн дарга Ч.Га-ийн өгсөн томиллолт хэрэгт авагдсан. Тус байгууллага энэ шалгалтын явцад 1 лиценз эзэмшиж байсан. Харин шинжээч нар ашигт малтмалын лиценз эзэмшиж байсан учраас газар ашигласан гэж үзэж газрын төлбөр ногдуулсан байсан. Гэтэл «ШЭ» ХХК газар эзэмшиж ашиглаагүй гэдгийг Өмнөговь аймгийн газрын албаны тодорхойлолтыг нотлох баримтаар шүүх хуралдаанд гаргаж өгсөн. Харин энэ баримтад анхан шатны шүүх үнэлэлт дүгнэлт хийхгүй шийдвэр гаргаж, шинжээчийн дүгнэлтийг үндэслэж намайг гэм буруутайд тооцсон.

Мөн Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзэж байна. Намайг тус хэрэгт хамжигчаар оролцсон гэж ял оногдуулсан. Гардан гүйцэтгэсэн, хамжигчаар оролцсон гэдэг хуулийн тодорхойлолтыг үзэхэд надад ямар ч хамааралгүй байна. Даргынхаа өгсөн үүргийн дагуу хуулийн хүрээнд хянан шалгалт хийж, илтгэх хуудас үйлдэж, зохих актыг гаргасан юм. Гэтэл хамжигчаар оролцсон гэдэг нь хэрэгт цугларсан баримтуудаар нотлогдоогүй. Иймд шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийн хэрэгсэхгүй болгож өгнө үү» гэв.

Ялтан О.Бя давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Шинжээчээр орсон татварын улсын байцаагч нарт Монгол Улсын хуульд байхгүй лиценз талбайн мэдээллийг нэг компани нөгөөдөө худалдсанд 40 хувийн татвар ногдуулсан. Шинжээчээр оролцсон татварын улсын байцаагч нар тухайн шалгалт хийсэн байгууллагын хайгуулын лицензээс газрын төлбөр авсан. Хайгуулын лицензээс газрын төлбөр авах зохицуулалт байхгүй. Харин газар ашиглах гэрээтэй бол төлбөр авдаг. Газар эзэмших гэрээ байгуулаагүй тохиолдолд газрын төлбөр төлөх үүрэг үүсэхгүй. Татварыг өөрчлөх, шинээр авах асуудлыг зөвхөн хуулиар зохицуулдаг атал шинжээч нар хууль зөрчиж «ЭрЭ» ХХК нь 2007 онд 317.000.000 төгрөгөөр мэдээлэл худалдаж авсныг эрх худалдаж авсан байна гэж үзэж татвар ногдуулсан нь хууль бус юм. «ЭрЭ» ХХК нь уг мэдээллийг 2007 онд худалдан авч татвар ногдуулах хөөн хэлэлцэх

хугацаа дууссан байхад намайг буруутгаж ялласанд гомдолтой байна. «КЖЭМ» ХХК нь мэдээлэл борлуулсны орлогоос 10%-ийн татвар төлсөн байдаг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгт биет бус хөрөнгийг тодорхойлсон байдаг. Уг хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.7 дахь заалтад биет бус хөрөнгөөс 10 хувийн татвар авна гэж заасны дагуу татвараа төлсөн компаниас хуульд зааснаас илүү татвар авах эрх надад байхгүй. Хууль бусаар илүү татвар аваагүйн төлөө намайг ялласанд гомдолтой байна. «ЭрЭ» ХХК нь ашиглалтын лицензтэй байсан боловч тухайн газраа ашиглаагүй байсан тул татвар аваагүй. Шинжээч нар нь Монгол Улсад мөрдөгдөж байгаа 10 гаран хууль, дүрмийг ноцтойгоор зөрчсөн. Чингэлтэй дүүргийн татварын байцаагч С.Б-г гэрчээр асуусан /15 хх 3-4/ атлаа шинжээчээр томилж дүгнэлт гаргуулсан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 45 дугаар зүйл, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийг зөрчсөн. С.Б, Ц.Б нарт шинжилгээ явуулахад анхан шатны баримтуудыг хүлээлгэж өгөөгүй нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалтыг зөрчсөн. Хэргийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий 488 хуудас баримт гаргаж өгснийг нотлох баримтаар үнэлсэнгүй. «ЭрЭ» ХХК лицензийн мэдээллээ 700.783.296,44 төгрөгөөр худалдсан байхад эрх борлуулсан гэж илт буруу дүгнэлт гаргасан. Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт лицензийн мэдээллийг худалдаж болно гэж заасан ба үүнийг эрх борлуулсан гэж үзэхгүй. Би томилолтын үндсэн дээр хяналт шалгалт явуулж, хууль эрх зүйн хүрээнд илтгэх хуудас бичсэн байхад шүүх эрх мэдлээ урвуулан ашигласан гэж илт яллах талыг барьсан. Мөн Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлд заасан гүйцэтгэгч, хамжигчаар хамтран оролцсон болохыг тогтоогоогүй. Иймд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, намайг цагаатгаж өгнө үү» гэв.

Ялтан Ч.Га-ийн өмгөөлөгч Г.Оюунцэцэг, А.Ундрах нар хамтран гаргасан давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбарууддаа: «... Ч.Га-ийг Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргын үүрэгт ажлаас өөрчилсний улмаас 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс 2006 оны 5 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл уг албан тушаалыг

эрхэлж байгаагүй бөгөөд ажилдаа буцаж орохоос өмнө буюу 5 дугаар сарын 12-ны өдөр урьдчилсан байдлаар шалгалтын дүн танилцуулагдсан байсан. «ВАТТ» ХХК-д хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргын үүргийг гүйцэтгэж байсан Ч.Эн-ы томилсон татварын 2 байцаагч 85 хоног хяналт шалгалт хийж 3.7 тэрбум төгрөгт акт, 5.4 тэрбум төгрөгт дүгнэлт бичиж гардуулан өгсний дараа «ВАТТ» ХХК-ийн дэд захирал Г.Бай зөрчил төлбөрийг эс зөвшөөрч, үндэслэлгүйгээр акт, дүгнэлт гаргасан гэж 2 татварын улсын байцаагч, дараа нь Ч.Га, Татварын ерөнхий газрын дэд дарга Б.А, Ш.Б нарыг хээл хахууль нэхсэн, төлбөрийг багасгахыг амласан мэтээр гомдол. Тухайн үед Татварын ерөнхий газрын дотоод хяналтын тасгаас гадна Улсын мөрдөн байцаах газар Г.Бай-гаас хээл хахууль нэхсэн асуудлаар зохих шалгалт хийгээд эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байдаг.

Шийтгэх тогтоолд Ч.Га-ийг 250.000 ам.долларын хээл хахууль авахыг завдсан гэж тэмдэглэсэн. Гэтэл хэн гэгч нь энэ их хэмжээний мөнгийг Ч.Га-д өгөх гээд байсан юм бэ? Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.1, 80.1.2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг гарсан байдал, гэмт хэргийг хэдийд, хаана яаж үйлдсэн, уг гэмт хэргийг хэн үйлдсэн зэргийг нотлоогүй нөхцөлд бусдыг хүнд гэмт хэрэгт буруутгах хууль зүйн үндэслэлгүй юм. Гэрч Р.Ар, Ц.Со нарын мэдүүлгээс үзэхэд хүн нэр дээр, дүн хэлээгүйн дээр тэдний мэдүүлгүүд зөрүүтэй байна. Ч.Га хэн нэгний ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн буюу гэмт хэргийн объектив талын шинжийг тогтоогоогүй. Мөн Ц.С-ыг хээл хахуульд зуулчилсан үндэслэлээр шалгаж байсан ч хөөн хэлэлцэх хугацаа дууссан учраас хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлгүй. Прокурор хөөн хэлэлцэх хугацаа дуусан, дуусаагүй ч энэ маргаантай хэргийг шүүхээр оруулж эцэслэн шийдвэрлэх байсан гэж үзэж байна. Ц.С-ын хэрэг хөөн хэлэлцэх хугацаагаар хэрэгсэхгүй болж, эрх зүйн ямар нэгэн статусгүй болсон учраас шүүх хуралдаанд оролцуулах боломжгүй болсон. Энэ нь Ч.Га-ийг яллах талыг баримтлан хэргийг шалгасан болохыг харуулж байна.

Хууль бусаар хөрөнгөжсөн гэх хэргийн талаар:

Ч.Га нь Татварын ерөнхий газрын

Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байх хугацаандаа өөрийн хөрөнгө орлогын мэдүүлгийг үнэн зөвөөр тодорхойлж ирсэн. Түүнийг буруутгахдаа «... цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа хууль ёсны орлогоосоо гадна хөрөнгийн эх үүсвэрээ тодорхойлж чадахгүйгээр 1.518.375.400 төгрөгийн эд хөрөнгийг олж, хууль бусаар хөрөнгөжсөн...» гэж үзсэн. Гэтэл Ч.Га нь цалингаас өөр орлогын эх үүсвэртэй байсан. Энэ талаар хөрөнгө орлогын мэдүүлэгтээ байнга мэдүүлж ирсэн. Түүний эхнэр, охин гадаад улсад удаан хугацаагаар амьдарч, хөдөлмөрлөж, наймаа хийж байсан нь баримтаар нотлогдсон. Шүүх хуралдааны үед ч гэсэн Ч.Га-ийн зүгээс нотлох баримт болгон гаалийн мэдүүлэг, декларацийг гарган өгсөн байдаг. Ч.Га нь Сангийн яам, Үндэсний татварын албанаас 2 удаа 20.000.000 төгрөгөөр шагнуулж байсан.

Монгол Улсын Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хууль батлагдсантай холбогдуулан Ч.Га, дүү Ч.Да-гийн хамт эцэг У.Чи-ийг ятгаж олон жилийн турш хуримтлуулсан хөрөнгөө ил болгон тайлагнахыг зөвлөж ойлгуулсны үр дүнд өндөр настай, нүд муутай эцэг нь зөвшөөрсөн. Эцэг У.Чи нь хувь хүний орлогын албан татвар тодорхойлох тайлан, нэмэгдсэн өртгийн албан татварын тайланг хүү Ч.Да-гийн тусламжтайгаар хийж гүйцэтгэсэн болно. Эцгийнхээ нэрээр мэдүүлсэн өргөдөл, тайланд төрсөн хүү гарын үсгийг орлуулан зурсанд хэн ч гомдол гаргаагүй, буруутгаагүй, эцгийнхээ хөрөнгийг ил болгох нь чухал гэж үзсэнээс өөр ямар нэгэн хууль бус санаа зорилго агуулаагүйг анхаарч үзнэ үү.

Шийтгэх тогтоолд хураан авахаар дурдсан «Лексус 570» маркийн 3 автомашины нэг нь Г.Газ-д Ч.Гб захиж авахуулсан. Энэ нь уг хоёр хүний мэдүүлгээр давхар батлагддаг. «Лексус 470» маркийн 1 автомашиныг Г.Газ АНУ-д 8 жил сурч, амьдрахдаа ажил хийж авсан. Ч.Га нь «Ланд круйзер 200» маркийн автомашинаа өөрийн урьд унаж байсан унаагаа зарж авсан гэдгээ тодорхой мэдүүлсэн. Иймээс шийтгэх тогтоолд дурдсан бүх автомашиныг Ч.Га-ийн мэдлийнх гэж үзэх нь учир дутагдалтай ба юуг үндэслэн хурааж байгаа нь ойлгомжгүй байна. ...орон сууц эцэг У.Чи-ийн төгрөгийн данснаас мөнгө гаргаж, дүү Ч.Гб нь авсан ба байрны гэрчилгээ нь У.Чи гуайн нэрээр байдаг. Өөрөө төрийн албанд удаан

хугацаагаар ажилласны дүнд бий болгосон хуримтлалаараа 2 хөөрөг худалдан авсан. Хэрэг мөрдөн байцаалтад буцсаны дараа Ч.Га-ийн «хууль бусаар хөрөнгөжсөн» гэх үйлдлийн талаар яллах талын нэг ч нотлох баримт шинээр хэрэгт нэмж авагдаагүйг анхаарч үзнэ үү. Мөн анхан шатны шүүх үндэслэлгүй хөрөнгөжсөн гэх нийт үнийн дүнг яаж тооцоолж байгааг нь ойлгохгүй байна. Шүүх хуралдааны тэмдэглэлээс үзэхэд давхардуулсан тоо харагддаг. Улсын яллагч О.Г нь 1.3 тэрбум төгрөгийн зөрүүтэй байгааг тогтоож чадаагүй, тогтоох боломжгүй гэж хэлсэн юм. Ингээд боломжгүй гэсэн зүйлийг яагаад нэмээд 2.8 тэрбум төгрөгөөр тооцож байгаа нь ойлгохгүй, үүнд гомдолтой байна. Хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийг 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн шинээр гэмт хэрэгт тооцож эхэлсэн. Гэтэл энэ хугацаанаас хойш ам.долларын дансаар зөвхөн 1 удаа гүйлгээ хийснийг хамруулан Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэх зарчмуудыг алдагдуулж байна.

Ч.Га-ийг Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт буруутгахын тулд мөн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг журамласан. Тус зүйл, хэсэгт гэмт хэрэгт хамтран оролцогчдыг «захиалагч, зохион байгуулагч, хамжигч, гүйцэтгэгч, хатгагч» гэж дурдсан байдаг. Гэтэл гэмт хэрэгт хамтран оролцсон хэлбэрийг тодорхой зааж өгөх ёстой байсан. Мөрдөн байцаалтын явцад «бусадтай бүлэглэж, үгсэн тохирч, өөрийн удирдлага дор ажиллаж байсан татварын улсын байцаагч нараар нэр бүхий компаниудын татварын ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийлгүүлэн 13 тэрбум гаруй төгрөгийг татварт ногдуулалгүйгээр татварын улсын байцаагчийн илтгэх хуудас, акт гаргуулан төсөвт төвлөрөх ёстой байсан мөнгийг оруулаагүй» талаар нэг ч мэдүүлэг, нотлох баримт хэрэгт авагдаагүй. Ийм учраас Ч.Га-ийг захиалагч уу, гүйцэтгэгч үү, зохион байгуулагч уу, хамжигч уу, хатгагч уу гэдгийг тодорхойлж чадаагүй гэж үзэж байна. Дүү Ч.Да-г Татварын ерөнхий газарт мэдээлэл өгснийг мэдээгүй, татварын улсын байцаагч нарт илтгэх хуудас бичих чиглэл өгөөгүй. Үүгээр гэмт хэргийн бүрэлдэхүүний объектив талын шинж үгүйсгэгдэж байна.

Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч нар Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Шүүхийн шинжилгээний тухай хуулийг зөрчиж, шинжээч нарыг томилсон

бөгөөд анхан шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтуудад бодитой дүгнэлт хийгээгүй. Мэргэжлийн хувьд чадвартай, хараат бус байх мэдлэгтэй хүмүүсийг шинжээчээр томилоогүй нь анхан шатны шүүх хуралдааны явцад шинжээч нар өмгөөлөгчийн асуултад хариулах чадваргүй, буруу, зөрүү зүйлийг их ярьж байсан учраас эдгээр шинжээч нарын чадварт эргэлзээ гарсан юм. Шинжээчдээс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасны дагуу биеийн байцаалтыг нь авч, хохирогч, сэжигтэн, яллагдагчтай ямар холбоотойг нь тодруулж, татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг нь шалгаагүй, мөн зүйлийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу шинжээчээр томилоход харшлах шалтгаангүй бол тогтоолыг гардуулж, эрх, үүргийг нь танилцуулж, хүлээх хариуцлагыг урьдчилан сануулж гарын үсэг зуруулах шаардлагыг биелүүлээгүй. Мөн хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан шинжилгээ хийх объектыг шинжээчид хүргүүлэх, 10.4 дэх хэсэгт шинжилгээний объект шаардлага хангасан байх, 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасан хугацаанд нь дүгнэлт гаргах, 12 дугаар зүйлд заасан хүлээн авсан шинжилгээний объектыг бэхжүүлж шинжилгээ хийх гэснийг тус тус зөрчсөн.

Шинжээч Ч.У, З.Э нар “БАЭ” ХХК-д шинжилгээ хийхдээ 2007-2009 оны мэргэжлийн зөвлөхийн үйлчилгээний орлогыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9-ийн д/ дэх хэсэгт заасан татвар ногдох орлогод хамааруулж, 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг буцаан хэрэглэсэн. Шинжээч нар «ЭрЭ» ХХК-д шинжилгээ хийхдээ 2005-2009 оны байдалд хяналт шалгалт явагдсан байхад 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар, «ХЭ» ХХК-д 2010 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар дүгнэлт гаргаж, татвар, хүү, торгууль, алданги тооцсон. Мөн лицензийн талбайн мэдээлэл худалдан авсан үйл ажиллагаа болон компанийн хувьцаа худалдсан асуудлыг эрх борлуулсан мэтээр ойлгож татвар ногдуулсан нь үндэслэлгүй юм. Татварын ерөнхий хуульд татварын хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байна гэж заасан байхад 2005-2007 оны хамруулан татвар тооцсон. НӨАТ төлөгч биш хуулийн этгээдэд НӨАТ ногдуулсан. Б.А нь “Цэвэр агаар сан”-ийн хэрэгт яллагдагчаар татагдан шалгагдаж

байхад нь, Н.Г Ч.Га-тэй ашиг сонирхлын зөрчилтэй хүн байхад шинжээчээр томилж дүгнэлт гаргуулж хууль зөрчсөн. Иймд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж өгнө үү. Мөрдөн байцаалтад буцааж шийтгэх тогтоолоор хураахаар шийдвэрлээд байгаа автомашин, хөөрөг, орон сууцны эздийг, мөн 2008 оны Татварын өршөөлийн тухай хуулийн дагуу У.Чи гуайн ил болгосон 1.1 тэрбум төгрөгийн эх сурвалжийг тогтоох, шинжээчийн дүгнэлтийг дахин гаргуулах ажиллагааг хийлгэх шаардлагатай. Яагаад татварын байцаагч нарын хэрэгт “ПВР» ХХК 13 тэрбум төгрөгийн өрөнд орж, хохирох ёстой юм. Үүнд Ч.Да болон татварын 6 байцаагч нарын эрх ашиг, эд хөрөнгө хохирч байна...» гэв.

Ялтан Д.Эн-ын өмгөөлөгч Э.Энэбиш, С.Жанцан нар хамтран гаргасан давж заалдах гомдолдоо: “Д.Эн нь 73, 93 тоот тушаалаар 260006, 260007, 260009 тоот дүгнэлтүүдийг хүчингүй болгож “ПВР» ХХК-ийг 1.416.249.500 төгрөгийн татвар улсад төлөхөөс санаатайгаар зайлсхийх боломж олгосон гэдэг нь нотлогдож, тогтоогдоогүй. Шинжээч Ц.С, Б.А, Н.Г нарын гаргасан шинжээчийн дүгнэлт, тэднийг байцаасан тэмдэглэлээр «ЗУ», «УМ», «НТГ» ХХК-иуд нь татвар төлөх үүрэггүй болох нь тодорхой байна. Ийм байхад Баянгол дүүргийн татварын улсын байцаагч Ш.На, А.До, Г.Бая, Ж.На, Р.Д, Ц.Ц нар нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт заасныг зөрчин хууль бусаар үндэслэлгүй дүгнэлт бичсэн. Иймд Д.Эн нэр бүхий 3 компанид холбогдуулан бичсэн дүгнэлтийг хүчингүй болгосноор “ПВР» ХХК-ийг татвар төлөхөөс зайлсхийх боломж олгосон гэж үзэх үндэслэлгүй.

Учир нь хууль зөрчиж бичсэн дүгнэлтийг хүчингүй болгосон нь өөрөө хууль зөрчсөн үйлдэл биш юм. 260006, 260007, 260009 тоот дүгнэлтүүд хүчин төгөлдөр байгаад ч “ПВР» ХХК-аас нөхөн татвар төлүүлэх эрх үүсэхгүй, ач холбогдолгүй.

Түүнчлэн Баянгол дүүргийн татварын улсын байцаагч Ш.На, А.До, Г.Бая, Ж.На, Р.Д, Ц.Ц нарын 260006, 260007, 260009 тоот дүгнэлтүүдийг үндэслэн Баянгол дүүргийн татварын хэлтсээс “ПВР» ХХК-аас 1.416.249.500 төгрөг, “ЗУ”, “УМ”, “НТГ” ХХК-иудаас 1.416.249.500 төгрөгийг гаргуулж төсөвт төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл

гаргавал, шүүх “уг нэхэмжлэлийг гаргах эрхгүй”, “нэхэмжлэлийн хариуцагч биш”, “нэхэмжлэлийн үндэслэл тогтоогдохгүй” үндэслэлээр хэрэгсэхгүй болгоно. Өөрөөр хэлбэл, зөвхөн “ПВР” ХХК-д өөрт нь холбогдуулж бичсэн татварын акт, дүгнэлтээр л татвар төлүүлэх нь ойлгомжтой.

Д.Эн нь Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга, албаны бүрэн эрхийн дагуу Татварын ерөнхий хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1 заасан үндэслэлээр 260006, 260007, 260009 тоот дүгнэлтүүдийг хүчингүй болгоходоо хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлсэн, эсхүл хохирол учруулсан байдал мөрдөн шалгах ажиллагааны явцад тогтоогдож, нотлогдоогүй. 260006, 260007, 260009 тоот дүгнэлт гарсны дараа тус компаниуд дүгнэлтүүдийг эс зөвшөөрч Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга, Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтэст гомдол гаргасан байдаг. Гомдлын дагуу нягтлах хяналт шалгалт явагдаж 01, 02 тоот илтгэх хуудас бичигдсэн. Хэрэгт авагдсан нотлох баримтаар дүүргийн татварын улсын байцаагчдын гаргасан дүгнэлтэд «УМУК», «НТГ» ХХК-иуд гомдол гаргаж, үндэслэлгүйгээр татвар ногдуулж бичсэн актуудыг захиргааны болон эрүүгийн журмаар хүчингүй болгуулсан, тийнхүү татвар төлөгчийн гомдлыг дээд шатны байгууллага, албан тушаалтан, мөн прокурорын байгууллага хүлээн авч шийдвэрлэснийг Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга хэлбэржүүлэн зохих тушаал гаргасныг «албан тушаалын байдал, эрх мэдлээ урвуулан ашигласан» гэж дүгнэж, буруутгаж байгаа нь илтэд үндэслэлгүй байна. Д.Эн-ыг үйлдэл холбогдол тогтоогдоогүй байхад шүүхээс гэм буруутай гэж үзсэн дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй, Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн байгаа тул анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгон өөрчилж, Д.Эн-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү» гэв.

Ялтан Д.Эн-ын өмгөөлөгч Д.Батбаяр давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүлээн зөвшөөрөхгүй. Д.Эн-д холбогдох хэргийн зүйлчлэлд объектив болон субъектив талын шинж байхгүй гэж үзэж байна. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн тухайд бол

мөрдөн байцаалтын ажиллагаа, шинжээчийн дүгнэлтээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.5 дахь хэсэгт заасан хохирлын хэмжээг бүрэн тодорхойлж чадаагүй. Учир нь шинжээч нарын дүгнэлтүүд эргэлзээтэй гарсан. Эргэлзээтэй гарсан гэдгийг миний өмнө гарч ирж давж заалдах гомдлоо тайлбарласан өмгөөлөгч нар хэлсэн учраас давхардуулж хэлэхгүй.

2009 оны 6 дугаар сараас “НТГ”, “УМ”, “ЗУ” ХХК-иуд нь татварын албанд татан буугдах хүсэлтээ өгөхдөө “ПС” ХХК-д хувьцаагаа худалдан борлуулсан байсан. Д.Эн нь “ПС” ХХК-ийн эрх борлуулсны орлого болох 30 хувийн татварыг хуульд заасны дагуу суутгаж төлөх үүрэгтэй тул татвар төлөхөөс зайлсхийж байна гэж үзээд татварын хяналт шалгалт хийлгүүлэхээр Татварын ерөнхий газрын дарга, Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргад албан бичиг хүргүүлж, ТЕГ-ын Хууль эрх зүйн хэлтсээс дээрх компанид холбогдох материалыг Улсын мөрдөн байцаах газарт хүргүүлэх чиглэл өгсний дагуу нэр бүхий 5 компанийн борлуулалтын талаарх мэдээ, материалыг Улсын Мөрдөн байцаах газрын Эдийн засгийн гэмт хэрэг мөрдөх хэлтэст хүргүүлсэн. Гэтэл Улсын мөрдөн байцаах газраас 10/5-7590 албан тоотоор дээрх материалыг Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-д хүргүүлсэн байдаг. Ингээд Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсээс “ПС” ХХК-д шалгалт хийлгүй, харин уг компанид эрх борлуулсан нэр бүхий 5 компанид татварын хяналт шалгалт хийж дүнг Эрүүгийн цагдаагийн газарт хүргүүлэх тухай албан бичиг ирүүлсэн. Ингээд шалгалт хийж 260006, 260007 тоот дүгнэлтийг тус тус үндэслэлгүй бичигдсэн болох талаар 01, 02 тоот илтгэх хуудас гарсан. Үүний дагуу Д.Эн 73 тоот тушаалаар хэрэгсэхгүй болгосон. Мөн 260009 тоот дүгнэлтийг 93 тоот тушаалаар болгосон. Д.Эн-ын дээрх 73, 93 тоот тушаал, “УМ”, “НТГ”, “ЗУ” ХХК-иуд нь төлөх хариуцагч биш болох талаарх үндэслэл зөв болохыг Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн шинжээч О.Т-ын 123 тоот дүгнэлт, бүрэлдэхүүнтэй шинжээч нарын дүгнэлт зөвтгөсөн болно. Өөрөөр хэлбэл, төлбөр хариуцагч нь “ПС” ХХК болох талаар дүгнэлт гарсан. Д.Эн нь төлбөр хариуцагч биш гурван компанид холбогдох дүгнэлтийг хэрэгсэхгүй болгосонг анхаарч үзнэ үү.

Орлогын эх үүсвэр нь тодорхойгүй

592.835.500 төгрөгийг хууль ёсны орлогоосоо гадна олж хууль бусаар хөрөнгөжсөн гэх тухайд:

Миний үйлчлүүлэгч Д.Эн-ын орлогын эх үүсвэр 1990 оноос Эрээн-Москвагийн хооронд хонины ноос, ямааны ноолуур зарах, Дэнжийн 1000-ын хар зах дээр борлуулж наймаа хийхдээ бэлэн мөнгө хуримтлуулж 1996 онд 1дүгээр хороолол, 32 дугаар байранд 3 өрөө орон сууц, 2002 онд «А...-3» нэртэй ХЭАА хувьцааг 50.000.000 төгрөгөөр худалдан авч, улмаар «АБ» ХХК болгон үйл ажиллагааг нь өргөтгөн эргэлтийн хөрөнгө 150.000.0000 төгрөгт хүргэсэн. Мөн хувиараа Драмын театрын өмнөх талбай, Соёолж худалдааны төвийн авто зогсоол дээр Герман, Япон, АНУ-аас оруулж ирсэн авто машинууд худалдаалдаг байсан. «АБ» ХХК нэр дээр «Барс» худалдааны төвд «А», «Х» нэртэй сендвичин павилонд хүнсний бөөний худалдаа, 6 буудалд «БД» нэртэй супер маркет ажиллуулж байв. Бизнесийн орлогоороо 2003 онд одоогийн амьдарч байгаа Сүхбаатар дүүргийн 1 дүгээр хороо, Жигүүр грандын 20 дугаар байрны 30 тоот орон сууцаа худалдан авсан. Мөн 2003 онд Баянгол дүүргийн 4 дүгээр хороо «П» зочид буудлын зүүн талд 216 м.кв тайлбай бүхий оффис, агуулах, граж, 1960 м.кв газрын хамт худалдан авсан. 2004 онд Чингэлтэй дүүргийн Яргайтын богинод 2 давхар тоосгон зуны сууц худалдан авсан, 2006 онд Баянголд дүүргийн ...дугаар хороонд ...цогцолборт 132 м.кв тайлбай бүхий үйлчилгээний талбайг захиалга өгч худалдан авсан, 2007 онд Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...-д 125 м.кв талбай бүхий өвөл, зуны байшинг «ИХ» ХХК-аар бариулж авсан. Дээрх хөрөнгөөс гадна 300.000.000 орчим төгрөгийг өндөр хүүтэй хадгаламжид хийж, эргүүлээд бусдад зээл хэлбэрээр зээлдүүлж байсан. Д.Эн нь Нийслэлийн татварын газарт хуулийн зөвлөх, Шуурхай хяналтын тасгийн даргаар томилогдохдоо дээрх хөрөнгүүдийг худалдан авсан, тодорхой хэмжээний бэлэн мөнгөтэй гэдгээ 2007 оны 2 сард хөрөнгө орлогын мэдүүлэгтээ мэдүүлсэн. 2008 онд «ЖМ» ХХК-д санхүүгийн эх үүсвэрт зориулан 2012 он хүртэлх хугацаанд 400.000 ам.доллар 2 хувийн хүүтэй зээлсэн. Гэрээний хугацаанд зээлийн хэмжээ, хүүд өөрчлөлт орж зээлийн хүүд нийт 303.600.000 төгрөг авсан. Баримт нь байгаа. Ингээд «ЖМ» ХХК-аас зээл, хүүгийн хамт 2012 оны 02 дугаар сарын 1-нд авч Голомт банк дахь дансандаа тушаасан

ба мөнгөө эргэлтэд оруулахаар АНУ-аас 2011 оны модель 4 ширхэг шинэ «Лексус 570» автомашиныг Б, Г нарт тус бүр 1000 ам.долларын шагнал өгч захиалж авсан.

Иймд дээрх хоёр гэмт хэргийг бүрэлдэхүүнгүй гэж үзэж байгаа тул хэрэгсэхгүй болгож, хорих ангийн дэглэмийг өөрчилж өгнө үү» гэв.

Ялтан Д.Эн-ын өмгөөлөгч Х.Баасанжаргал давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: “Д.Эн-д анхан шатны шүүх ял шийтгэл оногдуулахдаа хэрэгт авагдсан нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитой үнэлээгүй, мөрдөн байцаалтын явцад Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчиж цуглуулсан нотлох баримт, шинжээчийн дүгнэлтийг үндэслэл болгосон тул давж заалдах гомдол гаргаж байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэгт заасан гэмт хэргийн талаар: “НК” ХХК-д байр захиалсан хөрөнгө нь “ЖМ” ХХК-д зээлүүлсэн мөнгөнөөс эх үүсвэртэй гэдгийг Д.Эн тайлбарласан. Үүнийг шийтгэх тогтоолд яллах талын нотлох баримт гэж үнэлсэн юм. Гэтэл “ЖМ” ХХК-тай зээлийн гэрээг 2008 онд байгуулж, энэ хугацаанд үндсэн зээлээс гадна 303.000.000 төгрөг, нийт 812.000.000 төгрөгийг хүлээн авсан гэдэг нь шинжээчийн дүгнэлтээр тогтоосон. Улмаар зээлийн гэрээгээ цуцалж энэ хөрөнгөөр орон сууц худалдан авах захиалга хийсэн. 2012 оны 05 дугаар сарын 01-нээс хойш “НК” ХХК-тай байгуулсан учраас үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж тооцсон нь үндэслэлгүй. Эрүүгийн хуульд “Хууль ёсны орлогоос гадна” гэсэн нь хуулиар зөвшөөрөгдсөн орлогоосоо бусад хэлбэрээр орлого, хээл хахууль зэрэг хууль бус орлого олсон бол гэм буруутай гэж тооцохоор хуульчилсан. Гэтэл Д.Эн-ын хууль ёсны орлого гээд нотлох баримтаар тогтоогоод байхад яагаад ингэж дүгнэснийг шийтгэх тогтоолдоо тодорхой заагаагүй.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийн талаар: Мөрдөн байцаалт 2013 оны 01 дүгээр сараас хойш 5 сарын дараа Д.Эн-д хууль ёсны орлого, эх үүсвэрээс бий болсон эд хөрөнгийн зөрчлийн талаар Сүхбаатар дүүргийн татварын газраар шалгуулж 3.1 тэрбум төгрөгийн орлого илрүүлсэн гэсэн дүгнэлт гарсан. Энэ нь хүний эрх зүйн байдлыг эрс дордуулсан юм. Учир нь татварын байцаагч нарын дүгнэлт

үндэслэлгүй болох нь Б.Жа болон сүүлд томилогдсон шинжээч нарын дүгнэлтээр тогтоогдож байгаа. Анхан шатны шүүх энэ шинжээчийн дүгнэлтийг яллах талын нотлох баримтаар үнэлж байгаа нь хууль зөрчсөн асуудал болсон гэж үзэж байна. Шинжээч нараас гаргасан дүгнэлтүүдийн аль нь хууль зүйн үндэслэлтэй байгаа талаар байнга асууж байсан. Э.Т шинжээчээс энэ асуултыг асуухад хувьцаа худалдсан орлого, эсхүл ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлсэн улсын орлого гэдгийг эдийн засгийн шинжилгээгээр тогтоох боломжгүй гэж мэдүүлсэн юм. Энэ шинжээчийн дүгнэлтийг анхан шатны шүүх үндэслэл болгосон.

Нотлох баримт, шинжээчийн дүгнэлт хууль зөрчсөн талаар: Шинжээч нар тооцооллын болон мэргэжлийн ур чадварын ноцтой алдаанууд гаргасан. Шүүх хуралдааны явцад шинжээч Н.Г уг дүгнэлтийг өөрөө гаргаагүй гэж мэдүүлсэн нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 22.3 дахь хэсгийг зөрчиж шинжилгээний объектыг хуваан авч, тус тусдаа дүгнэлт гаргасан болохыг хангалттай нотолж байна. Мөн шинжээчдийн бүрэлдэхүүнд орсон шинжээч нар ашиг сонирхлын зөрчилтэй буюу Н.Г нь хохирогчийн шууд удирдлагад ажилладаг байсан төдийгүй, шинжээч Б.А нь Авлигатай тэмцэх газарт сэжигтнээр шалгагдаж байх явцдаа тус газрын томилолтоор дүгнэлт гаргасан. Иймээс шинжээчийн дүгнэлтүүд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4, 155 дугаар зүйлд заасны дагуу нотлох чадвараа алдах бөгөөд шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй.

Цагаатгах талын нотлох баримтыг үнэлээгүй талаар: 2009 онд Д.Эн Баянгол дүүргийн татварын хэлтэст ажиллаж байхдаа «ПС» ХХК-ийн татвар ногдуулалт, татвар төлөлтийн байдалд хяналт шалгалт хийх мэргэжил, арга зүйгээр хангах талаар Татварын ерөнхий газрын дарга Ц.О-т 1327 тоот, Хянан шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-д 1326 тоот албан бичгүүд хүргүүлсэн байдаг. Тэгэхээр мэргэжил арга зүйгээр хангах асуудлыг Д.Эн гаргаж тавьсан. Ингэж цагаатгах талын баримтуудыг гаргаж өгсөөр байтал шүүх үнэлээгүй. Д.Эн-ын орлогын эх үүсвэрийг нотлох 2005 оноос 2007 онд банк болон хадгаламж зээлийн хоршоонд хадгалуулж байсан хадгаламжийн талаарх лавлагаа нийт 580.000.000 төгрөгийн нотлох

баримтуудыг гаргасан өгсөн боловч шүүх үнэлсэнгүй. Иймд шийтгэх тогтоолын Д.Эн-д холбогдох хэсгийг хүчингүй болгож өгнө үү” гэв.

Ялтан Б.Жа-ын өмгөөлөгч Ш.Энхмаа давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Б.Жа-ын 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 164 тоот дүгнэлтийг зориуд худал гаргасан эсэхийг тогтоохын тулд бүрэлдэхүүнтэй шинжээч томилохдоо тухайн үед Авлигатай тэмцэх газар шалгагдаж байсан Мэргэжлийн хяналтын байцаагчид, мөн хохирогчоор тогтоогдсон Татварын ерөнхий газрын байцаагчийг оролцуулж зөвхөн яллах талыг баримталсан. Мөн хууль ёсны орлогоос гадна их хэмжээний орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн гэж 36.504.000 төгрөгөөр торгож, эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сарын хугацаагаар хасаж, “Лексус 470” загварын автомашин, Зуслангийн хашаа, байшинг нь төлбөрт тооцуулахаар шийдсэн нь Иргэний хуульд заасан гэр бүлийн гишүүдийн хамтран өмчлөх дундын өмчийн талаарх заалтыг харгалзан үзээгүй, зөвхөн дан хэт нэг талыг барьсны нотолгоо юм. Б.Жа нь хөрөнгө орлогын мэдүүлэгтээ өөрийн гэр бүлийн бүх хөрөнгө, орлогоо түүний дотор өрхийн орлогын гол эх үүсвэрийг бүрдүүлдэг “Норд бенз” загварын хүнд даацын автомашинаар нөхөр А.Баб хэр их хэмжээний орлого олдог байсныг нотлох баримтууд хавтаст хэрэгт байгаа. Зуслангийн байрыг худалдан авахдаа Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хорооны ...тоот нэг өрөө байраа 64.500.000 төгрөгөөр зарж, хүүхдүүддээ байрны урьдчилгаанд 45.000.000 төгрөг өгч үлдэгдэл дээр нь цалингийн зээл авч, мөн хадгаламж дахь мөнгөө нэмж авсан болох нь гэрч А.Баб, хүргэн Э.Бо, цалингийн зээлийн гэрээ, “ОС” зуучлалын гэрээнүүдээр нотлогдоно. Б.Жа-ын хэрэгт гэрчээр байцаагдсан гэрчүүд мэдүүлгийнхээ эх сурвалжуудыг тодорхой заасан байдгийг давж заалдах шатны шүүх анхааран үзэж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4 дэхь хэсэгт заасан “хууль зөрчиж цуглуулсан нотлох баримт, нотлох чадвараа алдаж шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй, нотлогдохгүй бол гэм буруугүй” гэсэн зарчмыг баримтлан Б.Жа-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү” гэв.

Ялтан Б.Жа-ын өмгөөлөгч Н.Цогт давж заалдах гомдол болон тус шүүх

хуралдаанд гаргасан тайлбартаа: «хх-хх УНТ улсын дугаартай «Лексус 470» загварын автомашиныг Б.Жа-ын нөхөр А.Баб нь хүнд даацын «Норт бенз» загварын автомашинаараа Өмнөговь аймгийн Дулааны цахилгаан станц болон уул уурхайн компаниудтай гэрээ хийн 3 жилийн турш нүүрсний тээвэр хийж олсон орлогоороо худалдан авсан болох нь түүний өгсөн гэрчийн мэдүүлэг, «Хас», «ХААН» банкны дансны хуулга зэрэг нотлох баримтаар нотлогдож байгааг шүүх бүрэлдэхүүн огт харгалзаж үзэлгүй, зөвхөн нэг талыг барьж хэргийг шийдвэрлэлээ. Анх Б.Жа, А.Баб нар нь Өмнөговь аймагт ажиллаж, амьдарч байхдаа 3 өрөө байртай, том охиндоо 2 өрөө байр, цөөн тооны бод, бог малтай, 2 граж зэрэг хөрөнгөө зарж, сольж, арвижуулсаар 2002 онд Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоот 2 өрөө байрыг Б.Жа-ын нэр дээр авсан. Энэхүү байраа 2007 онд 35.000.000 төгрөгөөр зарж Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...дүгээр хороолол, ...тоот 4 өрөө байрыг авсан. 2013 онд Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоот 1 өрөө байраа 64.500.000 төгрөгөөр зарж энэ мөнгөнөөс 45.000.000 төгрөгийг нь охин Б.Нямбаяр, хүргэн Э.Бо нартаа байрны урьдчилгаа болгон өгч, үлдсэн 19.500.000 төгрөг дээр 8.000.000 төгрөгийн цалингийн зээл авч нэмээд 2013 оны 05 дугаар сард Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...зуслангийн зориулалттай байшинг, газрын хамт 39.000.000 төгрөгөөр худалдан авсан нь Б.Жа, А.Баб нарын мэдүүлэг, хугацаагүй хадгаламжаасаа зарлага гаргасан гүйлгээ, банкны дансны хуулга, цалингийн зээл олгосон баримт зэргээр нотлогдсон бөгөөд хууль ёсны орлого гэж үзэхээр байтал «хууль бусаар хөрөнгөжсөн байх» гэсэн хий хоосон таамгаар хүнийг буруутгаж байгаа нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.3 дахь хэсгийг ноцтойгоор зөрчсөн байна.

Б.Жа-ыг гэмт хэрэгт буруутгах гол үндэслэл болсон 164 тоот шинжээчийн дүгнэлтийг зориуд худлаа гаргасан гэж үзэх шууд санаатай үйлдэл, эс үйлдэхүй байсан эсэхийг ямар ч баримтаар тогтоогоогүй атал гэмт хэрэгт буруутгаж байгаа нь огт үндэслэлгүй, нотлох чадвараа алдсан шинжээчийн дүгнэлтийг үндэслэн анхан шатны шүүх шийдвэр гаргасан. Сүхбаатар дүүргийн татварын улсын байцаагчдын 2013 оны 06 дугаар сарын 3-ны өдрийн 250041

тоот дүгнэлт, Б.Жа-ын 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 164 тоот шинжээчийн дүгнэлт, Ц.С, Б.А, Н.Г нарын 2013 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн шинжээчийн дүгнэлтүүд нь ашигласан баримт, шалгасан байдал зэрэг нь өөр өөр учир нэг нь нөгөөгөөс зөрүүтэй гэж үзэхээс биш зориуд худал дүгнэлт гаргасныг нотолсон баримт болж чадахгүй юм. Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг зөрчиж хохирогчоор тогтоогдсон Татварын ерөнхий газрыг шинжээчээр томилсон. Шинжээч Н.Г мөн хуульд заасан шинжилгээний объект шаардлага хангахгүй бол, тусгай мэдлэгээс хальсан бол дүгнэлт гаргахаас татгалзана гэснийг зөрчсөн.

Иймд шийтгэх тогтоолын Б.Жа-д холбогдох хэсгийг хүчингүй болгож, түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү. Мөн төрийн өмчлөлд хураан авсан хх-хх УНТ улсын дугаартай «Лексус 470» маркийн автомашин, Баянголын аманд байрлалтай зуслангийн зориулалттай байшин, газар зэрэг эд хөрөнгийг буцаан олгож өгнө үү» гэв.

Ялтан П.Га-ын өмгөөлөгч Ч.Мөнхцэцэг давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хууль ёсны үндэслэлгүй. П.Га-д холбогдох хэрэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй учраас түүнд холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү гэсэн байдлаар давж заалдах гомдол гаргасан.

Нэг. Шийтгэх тогтоол үндэслэл бүхий гараагүй, тогтоолын дүгнэлт хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй талаар: П.Га-ыг давтан үйлдлээр албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан талаар хууль зүйн шаардлага хангасан нотлох баримт байхгүй. Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэмд “татварын хэсэгчилсэн, иж бүрэн, нягтлах шалгалт» гэсэн төрлүүдтэй байх бөгөөд татварын хяналт шалгалтыг 2-оос доошгүй татварын байцаагч хийх талаар зохицуулсан заалтыг нягтлах шалгалт хийх зохицуулалттай хольж хутгаж, ганцаараа хийсэн гэж буруутгаж байна. П.Га хуулиар олгогдсон томилолтын дагуу 260007 дүгнэлтийн хүрээнд “УМ» ХХК-д нягтлан шалгалт хийж илтгэх хуудас бичсэн. Энэхүү 260007 тоот дүгнэлт нь зөрчилгүй болохыг Авлигатай тэмцэх газраас томилогдсон 2 ч

удаагийн шинжээчийн дүгнэлтээр тогтоосоор байхад миний үйлчлүүлэгчийн шалгаагүй, шалгах эрх үүсээгүй “ПС” ХХК-ийн татварын зөрчлийг албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэж дүгнэж, буруутгаж байгаа нь хэргийн жинхэнэ байдалтай тохирохгүй байна.

Шинжээчийн бүрэлдэхүүнд орсон Б.А нь Авлигатай тэмцэх газарт хэрэгт шалгагдаж байхдаа тус газрын мөрдөн байцаагчийн тогтоолоор шинжээчээр ажилласан. Түүнчлэн Б.А-г буруутгаж байгаа хэргийн шинжээчийн дүгнэлтийг Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний хэлтсийн дарга, энэ хэрэгт ял шийтгэл хүлээсэн Б.Жа гаргасан байдаг. Шинжээчийн дүгнэлт нь тухайн байгууллагын болон шинжээчээр ажилласан мэргэжилтний хувийн тэмдгээр баталгааждаг байтал Ц.С гэх шинжээч тамга, тэмдэг дарж баталгаажуулаагүй, хүчин төгөлдөр болоогүй шинжээчийн дүгнэлтээр гэм буруутайд тооцож, ял оногдууллаа.

“УМ” ХХК нь 2008 оны 3 дугаар сард үүсгэн байгуулагдаж, 2008 оны 6 дугаар сард ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшсэн болох нь компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн хуулбараар тогтоогдсон ба байгуулагдаагүй байсан компанийн нэр дээр нь гараагүй байсан лицензийг “ПС” ХХК-д зараад, худалдаж авсан аж ахуйн нэгж нь нягтлан бодох бүртгэлдээ бүртгээд бүр элэгдэл тооцоод эхэлсэн байгааг шүүх нотлох баримт үнэлэхдээ анхаарч үзсэнгүй.

П.Га-ыг татварын улсын байцаагч Б.Өс, Б.Жа нарын хамт «КЖЭМ» ХХК-д 2010 онд татварын хяналт шалгалтыг яагаад хийх болсон шалтгаан нь тэдэнд огт хамаагүй. Хэлтсийн даргаас хяналт шалгалт хийх томилолт өгөхөд эдгээр татварын байцаагч нар үүрэгт ажлаа гүйцэтгэсэн. Шүүхээс гэм буруутайд тооцох үндэслэл болсон нотлох баримт нь «КЖЭМ» ХХК-ийн татвар төлөлтийн байдалд шинжилгээ хийсэн 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 01 тоот шинжээчийн дүгнэлт юм. Энэхүү шинжээчийн дүгнэлт нь «КЖЭМ», «ХБЭ», «ХЭ», «ШЭ», «ЭрЭ», «БАЭ» ХХК-иудын хувьцаа эзэмшигч Их Британийн Виржини арлуудын «Q» компани нь бүх хувьцаагаа «КЖЭ МЛ» компанид шилжүүлж, «КЖЭ МЛ» компани «КЖЭЭАЭ» компанид бүрэн шилжүүлсэн. Гэтэл дүгнэлт гаргасан С.О,

Б.Ба хувьцаа зарсан харилцаанд татвар төлсөн эсэхийг шалгалгүй, «КЖЭМ» ХХК нь ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг 2 удаа зарсанд НӨАТ-т 10 хувь, эрх борлуулсны орлого 30 хувийн татварыг нэг жилд 2 удаа ногдуулж, татварын асар том зөрчил гаргасан.

Үүнээс гадна С.О, Б.Ба нар «КЖЭМ» ХХК нь «ХБЭ» ХХК-д 2007 онд эрх борлуулсны орлогыг 980.004.800 төгрөг, НӨАТ тооцсон байхад Л.А, Д.Б нар нь «ХБЭ» ХХК нь эрх борлуулсны орлогод албан татварыг 1.088.894,263 төгрөг, П.Га мөн 1.088.894,263 төгрөгөөс НӨАТ тооцсон. С.О, Б.Ба нар нь энэ дүнг хэрхэн гаргасан талаараа НӨАТ-ыг хасаж цэвэр дүнгээс тооцсон гэсэн тайлбарыг шүүх хурал дээр өгдөг бол «ХБЭ» ХХК-д шинжээчийн дүгнэлт гаргасан Л.А нь тухайн үед «ХБЭ» ХХК нь НӨАТ төлөгч болоогүй байсан учраас НӨАТ-ыг хасаж тооцохгүй нийт дүнгээс татвар тооцох нь зүйтэй гэж зөрүүтэй тайлбарласан нь шинжээчийн дүгнэлтийг үнэлэхэд нөлөөлж, шүүхээс татварын тооцоололд өөрчлөлт хийх боломжгүй болгосон. Гэсэн хэдий ч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь заалтыг баримталж шийдвэрлэх боломжтой байсан.

Чингэлтэй дүүргийн Татварын байцаагчдын 2005 оны актаар «КЖЭМ» ХХК-ийг НӨАТ төлөгчөөс хасаж, энэ хугацаанд хийгдсэн татварын буцаалтыг нь хүчингүй болгож шийдвэрлэсэн байхад үүнийг үзэж танилцалгүй, 2006 онд олсон орлогоороо НӨАТ төлөгчийн шаардлага хангасан байхад уг орлогоос шууд НӨАТ 15 хувь тооцсон нь хуулиа зөрчсөн дүгнэлт болсон.

Улсын яллагч хохирол хүлээсэн газрыг улсын төсвийн орлого гэж тодорхойлсон мөртлөө, улсын төсвийн орлогыг захиран зарцуулах эрх бүхий байгууллагыг хохирогчоор тогтоогоогүй, татвар цуглуулах, төвлөрүүлэх ажлыг нь хийдэг Татварын ерөнхий газрыг хохирогчоор тогтоосон. Харин шүүхээс энэхүү татварын орлого нь Татварын ерөнхий газрын орлого учраас хохирогчоор тогтоогдох нь зөв гэж дүгнэсэн нь туйлын харамсалтай.

Шинжээчээр ажилласан Ч.У, С.Ба гэх хүмүүс өмнө нь энэ хэрэгт гэрчээр мэдүүлэг өгч байгаад дараа нь шинжээчээр томилогдсон нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар зүйлийн 46.1 дэх заалтыг зөрчсөн. Иймд шийтгэх тогтоол хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгон, П.Га-ыг

цагаатгаж өгнө үү» гэв.

Ялтан Н.Ра-гийн өмгөөлөгч Ж.Батзоригт давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2... тоот шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргасан. Н.Ра нь уг гэмт хэргийг үйлдээгүй, гэм буруугүй гэж үзэж байна. Татварын улсын байцаагч Ш.На, А.До нарын «НТГ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж тогтоосон 260006 тоот дүгнэлтийг уг компанийн зүгээс хүлээн зөвшөөрөхгүй Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст гомдол гаргасны дагуу дарга Ч.Га-ийн 0003 тоот томиллоор Н.Ра хэсэгчилсэн шалгалт хийж илтгэх хуудас бичсэн. Мөн «БАЭ» ХХК-ийн 2005-2009 оны албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд 2010 онд хийсэн хяналт шалгалтаар 2006 онд 3.288.900, 2007 онд 38.118.000, 2008 онд 5.241.500, 2009 онд 8.422.500, нийт 55.070.900 төгрөгийн зөрчил илрүүлж илтгэх хуудас тус тус бичсэн нь Ч.Га-тэй бүлэглэн албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй юм. Шинжээчийн дүгнэлтүүд хэт нэг талын барьсан. Дахин бүрэлдэхүүнтэй шинжээч томилсон тогтоолоо танилцуулаагүй, хохирогч Татварын ерөнхий газрын татварын улсын байцаагчдыг томилон дүгнэлт гаргасан нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуулийг ноцтой зөрчсөн. Ч.У нь энэ хэрэгт хамааралтай асуудлаар гэрчийн мэдүүлэг байхад түүнээр шинжээчийн дүгнэлт гаргуулсан нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг зөрчсөн. 2005-2009 оны байдлаар татварын хяналт шалгалт хийсэн байхад 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдрөөр тооцож дүгнэлт гаргасан нь миний үйлчлүүлэгчийн эрх зүйн байдлыг дордуулсан. Шинжээч нарын зүгээс өөрсдийн гаргасан дүгнэлтийг хамгаалж чадаагүй бөгөөд Н.Ра-гийн 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 01 тоот илтгэх хуудас, хуулийн хүрээнд бичигдсэн болохыг хүлээн зөвшөөрч шүүхийн шинэчилсэн байцаалтад тодорхой мэдүүлэг өгсөн билээ. Гэтэл Н.Ра «НТГ» ХХК-ийг шалгасан улсын байцаагчийн хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт бичсэн байхад шалгаагүй «ПС» ХХК-ийн нягтлан бодох бүртгэлийн баримтыг үндэслэн гэм буруутай

мэтээр дүгнэж ял шийтгэл оногдуулсан нь үндэслэлгүй.

“БАЭ” ХХК-ийн 2005-2009 оны татварын тайланг дүгнэлт гаргасан шинжээч нар нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9-т заасан заалтыг үндэслэн татвар ногдуулах ёстой гэж үзсэн. Гэтэл хуулийн энэ заалт 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон байтал 2005-2006 оны асуудалд буцаан хэрэглэсэн. Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 3 дугаар зүйлийг зөрчсөн дүгнэлт гаргасан. Газрын төлбөрийг төсөвт төвлөрүүлэн төлөөгүй гэж төлбөр ногдуулсан байдаг. Гэтэл уг компани газар эзэмших, ашиглах гэрээ байгуулаагүй байхад газрын төлбөр нөхөн төлбөрийн татвар тогтоосон нь үндэслэлгүй. Мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 215 зүйлийн 215.3 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэх хугацаа 10 хоног байна гэж заасан байхад мөрдөн байцаалтаас яллах дүгнэлт үйлдүүлэхээр шилжүүлэхэд хяналт тавьж байсан прокурор 1 ч хонуулахгүй шүүхэд шилжүүлж дээрх хуулийн заалтыг зөрчсөн болно.

Н.Ра Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг үйлдээгүй, гэмт хэргийн объектив, субъектив талын шинж тогтоогдоогүй. Улсын яллагч нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлд зааснаар хэргийн талаар нотолбол зохих асуудлыг нотолж чадаагүй. Мөн хуулийн 83 дугаар зүйлийн 83.2 дахь хэсэгт зааснаар хохирогч Татварын ерөнхий газар мэдүүлгийнхээ эх сурвалжийг нотолж чадаагүй учир нотлох баримт болохгүй. Шүүх хэрэгт авагдсан нотлох баримтад хууль зүйн үндэслэлтэй дүгнэлт хийлгүй, хэт нэг талын эрх ашигт нийцүүлсэн тул шийтгэх тогтоолын Н.Ра-д холбогдох хэсгийг хэрэгсэхгүй болгон, түүнийг цагаатгаж өгнө үү» гэв.

Ялтан Б.Өс-ын өмгөөлөгч Б.Цэнгүүн давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд заасан гэмт хэргийн субъектив талын заавал байх шинж нь албан тушаалтан албаны эрх мэдлээ хувийн ашиг сонирхлын үүднээс урвуулан ашигласан шууд санаатай үйлдэл хийсэн байхыг шаарддаг. Б.Өс-ын хувьд энэ гэмт хэргийн субъектив талын шинж хангагдаагүй. Шийтгэх тогтоолд заасан Б.Өс нь Ч.Га-тэй бүлэглэн санаатайгаар албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж, «ХБЭ», «КЖЭМ» ХХК-иуд

нь татвар, хүү, торгуульд нийт 11.921.655,800 төгрөг төлөх ёстой байсныг төлүүлэлгүй санаатайгаар, өөрийн хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгоор илтгэх хуудас бичсэн гэдгийг нотолсон ямар ч баримт байхгүй. Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсээс татварын хяналт шалгалт хийхээр байцаагч нар томилогдсон үед Б.Өс нь ажил үүргээ гүйцэтгээгүй байсан бөгөөд ээлжийн амралтаа авсан байсан. Ажилдаа орсны дараа «ХБЭ» ХХК-ийн татвар төлөлтөд ганцаараа шалгалт хийх 0035 тоот томилолтыг дарга Ч.Га-ээс зохих журмын дагуу авч хуульд заасан үүргийнхээ хүрээнд илтгэх хуудас бичсэн байдаг.

Үндэсний татварын албаны хяналт шалгалтын ажлын дүрмийн 2.2-т УТОХН, Нийслэл, аймаг, дүүргүүдийн Татварын газар, хэлтэс болон ХШАЭН-ын дарга нь Татварын улсын /ахлах/ байцаагчидийг томилохдоо дараах бодлого чиглэлийг баримтална гэж заасан. Бодлого чиглэл баримтална гэдэг нь шууд үүрэг болгосон зохицуулалт биш учраас улсын яллагчийн зүгээс түүнийг уг дүрмийн 2.2.6 заасан «... Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх...» гэснийг зөрчиж ганцаараа хяналт шалгалт хийсэн гэж буруутгаж байгаа нь үндэслэлгүй.

Татварын улсын байцаагч хууль хэрэглэн шийдвэр гаргадаг эрх бүхий субъект бөгөөд түүний гаргасан шийдвэр ямар нэгэн байдлаар татварын хууль тогтоомжийг буруу хэрэглэсэн, хууль зөрчсөн гэж үзэж байгаа бол зөвхөн дээд шатны байгууллага албан тушаалтны зүгээс дахин шалгаж, зөрчлийг нь арилгуулах эрх хэмжээтэй байдаг. Б.Өс-ын гаргасан илтгэх хуудсыг Татварын маргаан таслах зөвлөл болон бусад холбогдох албан тушаалтны зүгээс хүчингүй болгосон зүйл огт байхгүй. Б.Өс-ын ямар хууль бус үйлдлээс болж, хэнд хэдий хэмжээний хор хохирол учирсан болохыг тогтоож байж энэ хэргийн объектив талын шинж хангагдана. Түүний учруулсан гэх хохирол нь нэр бүхий аж ахуйн нэгжүүдийн төлөх ёстой байсан татвар юм. Татварын байгууллага нь улсын төсвийг захиран зарцуулах эрх бүхий этгээд биш, илтгэх хуудас бичигдсэн аж ахуйн нэгжийн төлөх ёстой гэх татвар нь татварын байгууллагын төсөвт хамаарахгүй тул Б.Өс-ыг татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан гэж буруутгах боломжгүй. Гэмт хэргийн улмаас учирсан гэм хорыг шууд хохирлын хэмжээгээр тогтоодог. Ямар

нэгэн байдлаар олох ёстой байсан орлого, хүү, алдангийг хохиролд оруулан тооцох үндэслэлгүй.

Шүүх Б.Өс-ыг «ХБЭ», «КЖЭМ» ХХК-уудыг 11.921.655.800 төгрөгийн татвар төлөх байсныг санаатайгаар илтгэх хуудас бичиж төлүүлээгүй гэж үзэхдээ зөвхөн шинжээчийн дүгнэлтэд үндэслэсэн нь учир дутагдалтай. Шинжээчийн дүгнэлт гаргасан Чингэлтэй дүүргийн татварын байцаагч нар хохирогчоор тогтоогдсон Татварын ерөнхий газрын нэгжид хамаардаг, мөн арга зүйн зөвлөгөө авсан, нэр бүхий аж ахуйн нэгжүүдэд нөхөн татвар тооцохдоо хүү, торгуул, алданги тооцоогүй байхад нь Авлигатай тэмцэх газраас хүү, торгууль тооцож гарга гэсэн шаардлага тавьсны дагуу дахин хүү, торгууль тооцож дүгнэлтээ гаргасан зэрэг нь хараат байдлаар шинжилгээ хийгдсэн гэж үзэхээр байна. Мөн шинжээчийн дүгнэлт нь хууль зөрчиж гарсан төдийгүй татварын тооцооллын хувьд илт үндэслэлгүй болсон нь «КЖЭ» ХХК болон «ХБЭ» ХХК-ийн хооронд 2007 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан "...Лицензит талбайн мэдээлэл худалдан авах болон лиценз шилжүүлэх гэрээ ..." гэрээнүүдийг тус тусад нь салгаж ойлгон, санхүүгийн бүртгэлдээ хэрхэн тусгасан, уг үйлдэл нь Ашигт малтмалын тухай хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуульд зөвшөөрөгдсөн байгааг анхаарч, лицензүүдийг төлбөртэй шилжүүлсэн эсэхийг нь харгалзан үзэлгүйгээр зөвхөн нэг гэрээний дагуу ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан борлуулсан мэтээр бодит байдлыг мушгин гуйвуулж үндэслэлгүй дүгнэлт гаргасан.

Иймд дээрх нөхцөл байдлыг харгалзан үзэж шийтгэх тогтоолын Б.Өс-т холбогдох хэсгийг хүчингүй болгож, түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж өгнө үү» гэв.

Ялтан Н.Чи-ын өмгөөлөгч Х.Цогтсайхан давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Н.Чи нь «ХЭ» ХХК-ийн 2005-2009 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд 2010 онд хяналт шалгалт хийж, 980020 дугаартай татварын улсын байцаагчийн акт тогтоосон. Хяналт шалгалтын ажлыг Монгол Улсын татварын болон бусад хууль, тогтоомж, Үндэсний татварын албаны хяналт шалгалтын ажлын дүрмийн дагуу хийж гүйцэтгэсэн нь Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн гэмт хэргийн объектив,

субъективталын шинжийг агуулахгүй байна.

Түүнчлэн Н.Чи-ыг гэмт хэргийг гардан гүйцэтгэгчээр оролцсон гэм буруутайд тооцохдоо Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэгт зааснаар ямар үүрэг даалгавар өгсөн, түүнийг хэрхэн биелүүлсэн зэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд хөдөлшгүй нотлох баримтаар тогтоогдвол зохих зүйлүүд огт тогтоогдоогүй. Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч Ц.Б, С.Б нар Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон холбогдох бусад хуулийг илт зөрчсөн, үндэслэлгүй дүгнэлт гаргасан. Үүнд: Энэ хэрэгт өмнө гэрчээр оролцож байцаалт мэдүүлэг өгсөн татварын улсын байцаагч С.Б-гаар шинжээчийн дүгнэлт гаргуулсан. Шинжээч өөрчлөлт орсон Аж нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг буцаан хэрэглэн, Монгол Улсад байрладаггүй гадаадын аж ахуйн нэгжийн Монгол Улсын нутаг дэвсгэрт явуулаагүй үйл ажиллагаанд татвар ногдуулсныг өмгөөлөгчийн хувьд үнэхээр ойлгохгүй байна. Мөн «ХЭ» ХХК 2010 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Засаг даргатай гэрээ байгуулан, 2010 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Өмнөговь аймгийн татварын хэлтэст газрын төлбөр төлөгчөөр бүртгүүлж, газрын төлбөрийн тооцоог хийсэн. Гэтэл 2009 онд газар ашиглуулаагүй, газар ашиглуулахаар гэрээ байгуулаагүй байхад «2009 онд газрын төлбөр төлөөгүй» гэж дүгнэсэн нь хууль зүйн үндэслэлгүй юм. Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар «ХЭ» ХХК нь «КЖЭМ» ХХК-тай 2007 оны 05 дугаар сарын 31-ний өдөр «Лицензэт талбайн мэдээлэл худалдан авах болон лиценз шилжүүлэх гэрээ» байгуулж ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хайгуулын талаарх мэдээлэл буюу хайгуул үнэлгээний хөрөнгийг 32.965.100 төгрөгөөр худалдан авсан. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-д заасны дагуу 10 хувиар албан татвар ногдуулахаар заасан тул хайгуул үнэлгээний хөрөнгө, биет бус хөрөнгө борлуулсны орлого нь эрх борлуулсан орлогод хамаарахгүй тул «ХЭ» ХХК албан татварыг суутган тооцох нь хууль зүйн үндэслэлгүй байна. Шинжээч эрүүгийн хэргийн хохирлыг хэмжээг тооцохдоо захиргааны хариуцлага хүлээлгэн торгууль, хүү, алданги ногдуулж, эрүү, захиргааны

хариуцлагыг давхардуулан ногдуулж, хууль буруу хэрэглэсэн.

Шүүх шинжээчийн дүгнэлтийг хэрхэн дүгнэсэн талаар шийдвэртээ тусгаагүй, эрх зүйн дүгнэлт хийгээгүй, хэрэгт авагдсан бусад нотлох баримтыг үгүйсгэсэн тухай үндэслэлийг заагаагүй, хэрэгт онцгой ач холбогдол бүхий нотлох баримт харилцан зөрүүтэй байхад аль нэгийг нь авч бусдыг үгүйсгэсэн тухай үндэслэлийг заагаагүй орхигдуулж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлд заасан 13.2 дахь хэсэгт заасан зарчмыг баримтлаагүй.

Н.Чи нь томилолтын дагуу хяналт шалгалтыг явуулж, үүрэгт ажилдаа хайнга хандсан ямар нэг үйлдэл гаргаагүй, харин ч төсвийн их хэмжээний хөрөнгийг үрэгдэхээс сэргийлсэн тул хэн нэгэнд хор уршиг учруулаагүй учир дүүргийн шүүхийн ял оногдуулсан шийдвэрийг ямар ч үндэслэлгүй, хууль бус гэж үзэж байна.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасныг баримтлан шийтгэх тогтоолын Н.Чи-ад холбогдох заалтыг хүчингүй болгож өгнө үү» гэв.

Ялтан Б.Жр-ын өмгөөлөгч К.Бауиржан давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаад гаргасан тайлбартаа: «Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2... тоот шийтгэх тогтоолыг эс зөвшөөрөн дараах үндэслэлээр давж заалдах гомдол гаргаж байна. Шүүх Б.Жа-ыг гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон ял шийтгэл оногдуулахдаа хэрэгт авагдсан нотлох баримтуудад үндэслэл бүхий дүгнэлтийг хийгээгүй, хуулийг буруу хэрэглэсэн. Тухайлбал: Б.Жа болон татварын улсын байцаагч нарыг төрийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулах гэмт хэрэгт гардан гүйцэтгэсэн, хамжигчаар оролцсон гэж буруутгасан. Гэвч «гэмт хэргийг гардан гүйцэтгэсэн, хамжигчаар оролцсон» хэмээн гэмт хэрэг үйлдэхэд 2 өөр байдлаар хамтран оролцсон гэж дүгнэсэн атлаа зөвхөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийг журамласан.

Улсын Дээд шүүхийн 2003 оны 10 дугаар тогтоолд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсэг буюу «гүйцэтгэгч» гэдэгт тухайн гэмт хэргийг санаатайгаар өөрөө гардан үйлдсэн

этгээдийн явдал бөгөөд гэмт үйлдлийн арга, зэвсэг, хэрэгслийг сонгосон байна» гэж тайлбарласан нь Б.Жа албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан гэмт хэргийг үйлдэхдээ шууд санаатайгаар өөрөө гардан үйлдэх байдлаар гүйцэтгэсэн нөхцөлд хуулийн дээрх заалтыг журамлан ял шийтгэх боломжтой байхад шүүх энэ нөхцөл байдлыг тогтоогоогүй. Өөрөөр хэлбэл: анхан шатны шүүх Ч.Га болон тус хэлтсийн татварын улсын байцаагч нарыг гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон гэдгийг тодорхойлохдоо Ч.Га-ийг өөрийн удирдлагад ажилладаг татварын улсын байцаагч нараар шалгалт хийлгэж гүйцэтгүүлсэн гэдгээр буруутгасан. Ч.Га болоод түүний удирдлагад ажиллаж байсан нэр бүхий татварын улсын байцаагч нар нь гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон гэдгийг нотолсон ямар нэг баримт хэрэгт авагдаагүй, мөрдөн байцаалтын явцад тогтоогдоогүй болно.

Харин ажил үүргийн хувьд даргаас өгсөн үүрэг даалгавар, томилолтын дагуу татвар төлөгчийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хуульд заасан журмын дагуу хяналт шалгалт явуулсан талаар мэдүүлэг өгсөн. Үүнээс гадна эрүүгийн хэргийн материалд энэ нөхцөл байдлыг нотлох баримт болох Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтийн даргаас «ШЭ» ХХК, «КЖЭМ» ХХК-д шалгалт хийх тухай Б.Жа, Б.Өс, П.Га нарын нэр дээр олгогдсон томилолтын хуулбарыг шүүх хүлээн авсан атлаа энэ талаар үндэслэл бүхий дүгнэлтийг хийгээгүй болно. Ч.Га-ээс томилолт олгож, уг томилолтыг үндэслэн хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн байхад шүүхээс гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон гэж буруутгах нь учир дутагдалтай, үндэслэлгүй дүгнэлт хийсэн.

Шинжээч О.Б, Б.Э нарын 2013 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн дүгнэлт, шинжээч Б.Ба, С.О нарын 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн дүгнэлт, тэдгээрийг байцаасан тэмдэглэл, Үндэсний татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм зэрэг баримтаар нотлогдож тогтоогдсон гэж дүгнэсэн. Гэтэл шинжээч О.Б, Б.Э, Б.Ба, С.О нарын дүгнэлтүүд нь хууль зүйн хувьд үндэслэлгүй, тусгай мэдлэгийн хүрээнд гараагүй, шинжилгээний явц, үр дүн тусгагдаагүй, холбогдох нотлох баримт, санхүүгийн баримтад үндэслэлгүй болох нь шүүх хуралдааны явцад шинжээч нарын өгсөн мэдүүлэг, шүүгдэгч тэдгээрийн

өмгөөлөгчдөөс гаргаж өгсөн нотлох баримтаар тогтоогдсон болно.

Анхан шатны шүүх шинжээч нарын гаргасан дүгнэлтийг үндэслэн эрүүгийн хэргийн улмаас учирсан гэх хохирлын хэмжээг тогтоож шийтгэх тогтоол гаргасан боловч уг дүгнэлтийг гаргахдаа шинжээч нь бодит тооцоо судалгаанд үндэслэлгүй, холбогдох баримт материалыг сайтар судлан шалгаагүй, эрх бүхий этгээдээс лавлагаа тодорхойлолтыг гаргуулан аваагүй, хуулийн зүйл заалтыг буруу хэрэглэх замаар гаргасан, энэ талаар шүүх хуралдаанд оролцсон шинжээч нар өөрсдөө мэдүүлсэн нь шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлэхэд эргэлзээтэй байгаа тохиолдолд шинжээчийн дүгнэлтийг баримталж уг хэргийг хянан шийдвэрлэх бүрэн боломжтой гэж өмгөөлөгчийн хувьд үзэж байна.

Иймд дээр дурдсан нөхцөл байдал, хэрэгт авагдсан нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн бодитой шинжлэн судлах замаар Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 2... тоот шийтгэх тогтоолын Б.Жа-ыг гэм буруутайд тооцож ял шийтгэл оногдуулсан хэсгийг хүчингүй болгож, түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү.

2008 оны Татварын өршөөлийн тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар миний үйлчлүүлэгчийн шалгасан гээд байгаа 2006 оны үйлдлүүдийг зөрчил гэж үзвэл өршөөлд хамрагдах зөрчил байгаа. Үүнийг шүүх бүрэлдэхүүн хэргийг шийдвэрлэхдээ анхаарч үзэхийг хүсэж байна. Мөн хохирогч байгууллагыг Авлигатай тэмцэх газраас болон анхан шатны шүүх үндэслэлтэй тогтоож чадаагүй. Хэрэв газрын төлбөртэй холбоотой асуудлаар Татварын ерөнхий газар хохирогч гэж үзвэл хууль зөрчсөн зүйл болно” гэв.

Ялтан О.Бя-гийн өмгөөлөгч Г.Мөнхбат давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

“Шийтгэх тогтоол хууль ёсны бөгөөд үндэслэлтэй байх шаардлагад нийцээгүй талаар:

“ЭрЭ” ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 08 дугаартай илтгэх хуудас бичихэд О.Бя хэн гэдэг хүн, ямар шалтгаанаар шалгуулж байгааг мэдээгүй, мэдэх шаардлага, үүрэг

байхгүй юм. Үндэсний татварын албаны хяналт шалгалтын ажлын дүрмийн 2.2.6 дахь заалтыг зөрчиж хяналт шалгалтыг ганцаараа хийсэн гэж буруутгаж байгаа. Татварын хяналт шалгалтын дүрмийн 2.2 дахь хэсэгт “Улсын төсвийн орлого, хяналтын нэгж, Нийслэл, аймаг, дүүргийн татварын газар, хэлтэс болон хяналт шалгалт эрхлэх нэгжийн дарга нь дараах дүрмийг баримтлана” гэж заасан. О.Бя нь Татварын ерөнхий газрын Татварын хяналт, арга зүйн хэлтсийн байцаагч тул уг дүрмийн заалт түүнд хамаарахгүй. Уг дүрмийг буруугаар тайлбарлаж, хэрэглэсэн.

О.Бя-г «ЭрЭ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийхдээ хяналт шалгалтад хамруулахаар хүлээлгэн өгсөн баримт, материалуудыг нягталж, шалгаж үзсэний үндсэн дээр Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу татварын хяналт шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Шинжээчийн дүгнэлтийн талаар:

Чингэлтэй дүүргийн татварын улсын байцаагч Ц.Б, С.Ба нар «ЭрЭ» ХХК-ийг хоёр төрлийн зөрчил гаргасан гэж 315,476.800 төгрөгийн татвар, хүү, торгууль, алданги төлүүлэхээр шинжээчийн дүгнэлт гаргасан нь Монгол Улсын олон хууль тогтоомжийг ноцтой зөрчиж үндэслэлгүй гарсан. Учир нь «ЭрЭ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийлгэхдээ тус компанийн санхүүгийн тайлан тэнцэл, татварын тайлан, нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт болох 2005-2009 оны хоорондох санхүүгийн баримтаа гаргаж өгөөгүй байна.

Энэ хэрэгт хохирогчоор Татварын ерөнхий газар, шинжээчээр нь мөн татварын газрын байцаагч нар оролцсон нь Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Шүүхийн шинжилгээний хуулиудыг ноцтой зөрчсөн.

2013 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн 01 дугаартай шинжээчийн дүгнэлт хууль хэрэглээний хувьд алдаатай гарсан. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг худалдан борлуулах гэсэн ойлголт байхгүй юм. Харин Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлээр зүйлийн 49.2 дахь хэсэгт хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрэл, хайгуулын талаарх анхдагч материал, тайлан зэрэг мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж зохих албан татвар төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд түүний эзэмшилд байсан тусгай зөвшөөрлийг худалдан авагчид шилжүүлж

болно гэж хуульчилсан. Мөн эрх борлуулсныг орлого, мэдээлэл борлуулсныг орлогыг юуг ойлгох талаар Татварын ерөнхий газрын Хууль эрх зүйн хэлтсийн 2011 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 8/2343 албан тоотоор давхар нотлогддог.

Газрын төлбөрийн тухайд «ЭрЭ» 2008, 2009 онд 245 гектар газрыг ашиглаагүй, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Засаг даргын захирамж гараагүй, тус компанид газар ашиглуулах гэрээ байгуулж, гэрчилгээ аваагүй, газрын төлбөр төлөгч биш, газрын төлбөр төлөх үүрэггүй байхад газрын төлбөр төлөөгүй гэж хууль зүйн үндэслэлгүй буруутгасан. Энэ бүхнээс үзэхэд Шинжээчийн дүгнэлт нь хуульд заасан хараат бус хөндлөнгийн байна гэсэн зарчмаа алдаж гарсан нь хэн бүхэнд ойлгомжтой болсон.

Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шийтгэх тогтоолыг О.Бя-д холбогдох Ялтан Ч.Да-гийн өмгөөлөгч С.Оюунцэцэг давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Шийтгэх тогтоолын Ч.Да-д холбогдох зарим хэсгийг эс зөвшөөрч давж заалдах гомдол гаргаж байна. Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан 2 үйлдлийг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж хэрэгсэхгүй болгосныг үндэслэлтэй гэж үзэж байна. Харин Ч.Да-г Т.Б-ын нэрээр татварын шалгалт хийлгүүлэх мэдээлэл гаргасан гэдгийг ах Ч.Га нь мэдээгүй. Гомдлын дагуу хийгдсэн шалгалтууд нь Ч.Га-ийн томилолтоор хийгдсэн боловч тэднийг бүлэглэсэн, үгсэн тохиролцсон талаарх баримт мөрдөн байцаалтаар болон шүүхийн хэлэлцүүлгээр тогтоогдоогүй. Мөн татварын 6 улсын байцаагч татварын хяналт шалгалт хийх талаар Ч.Га зааварчлаагүй, тохиролцоогүй гэж тууштай мэдүүлдэг нь хэргийн үйлдэл үр дагаврын шалтгаант холбоо тогтоогдоогүй гэж үзэж байна.

Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18 дугаар зүйлд «Гомдол үнэн зөв байна» гэж заасан. Үүнд Ч.Да-гийн бусдын нэрээр гомдол гаргаж байгаа үйлдэл хамаарна. Харин гомдолд дурдсан мэдээлэл үнэн зөв эсэхийг төрийн байгууллага, албан тушаалтан тогтооно гэж ойлгож байна. Ч.Да нь бусдын нэрээр гомдол мэдээлэл гаргасан байсан ч мэдээллийн дагуу шалгалт хийсэн төрийн байгууллага, улсын байцаагч нар өөрсдийн гаргасан эрхийн актын хариуцлагыг хүлээх

ёстой. Гэтэл мэдээлэл гомдол бичсэн иргэн, шалгах томилолт өгсөн албан тушаалтан, татварын улсын байцаагчдыг бүлэглэсэн, үгсэн тохиролцсон гэж нотлох баримтгүйгээр хавтгайруулан буруутгах нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 290 дүгээр зүйлийн 290.2-д шийтгэх тогтоол таамаглалд үндэслэж болохгүй гэж заасантай зөрчилдөж байна.

Ч.Га-ийг 17 тэрбум төгрөгийн мөнгө угаасан гэж эрүүгийн хэрэг үүсгээд Авлигатай тэмцэх газраас хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр мэдээлж асар том хэмжээний хэрэг илрүүлсэн мэтээр ард түмэнд ойлгоц өгснөөс улбаалан Ч.Га-ийн эргэн тойрны болон ойр дотны хүмүүсийг өргөнөөр хамруулан шалгаж эцэст нь хүмүүсийг удаан хугацаагаар хорьж, сэтгэл санааны дарамтад оруулах, эцэг, эх, эхнэр, хүүхэд, ах хамтран үйлдсэн мэтээр зааж олон үйлдэлд эрүүгийн хэрэг үүсгэн хэрэгсэхгүй болгосон нь хэрэгт авагдсан. Ч.Га нарт холбогдох хавтаст хэрэгт олон тооны эх хувиараа биш канондсон, давхардсан нотлох баримтууд авагдан шүүгч, хэргийн оролцогчдод хүндрэл учруулсан.

Ч.Да Татварын ерөнхий газарт бусдын нэрээр мэдээлэл өгөхөд аудиторын эрхээ байхад шүүх энэ эрхийг нь 3 жилээр хассан нь буруу болсон. Ч.Га-ийн төрсөн дүү учир түүний мэдээллээр улсын байцаагч нартай урьдчилан тохиролцсон гэсэн таамаглалаар шалгаж, хийсвэр дүгнэлт хийж үндэслэлгүйгээр ял шийтгэж байгааг анхаарч үзэж

Ялтан Ч.Да-гийн өмгөөлөгч Ц.Гансүх давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Шүүх хэт нэг талыг барьж дүгнэлтэд ноцтойгоор нөлөөлж болох байдлыг орхигдуулсан. Учир нь 15 дугаар хавтаст хэргийн 8-41 дүгээр хуудсанд гэрч Чингэлтэй дүүргийн татварын байцаагч Д.Бр, С.Ба нарын мэдүүлгээр Татварын ерөнхий газрын хяналт шалгалт дээрх компаниудын гомдлоор хийгдэж байсныг нотолж байгаа учраас Ч.Да-г хамжигч гэж үзэхэд эргэлзээ төрж байна. Татварын ерөнхий газрын байцаагчдын гаргасан акт, илтгэх хуудаст шинжилгээ хийсэн шинжээчдийн илтэд хууль зөрчсөн, үндэслэлгүй, буруу дүгнэлтийг үндэслэн улсад 13.398.688.100 төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй гэм буруутай гэж ялласан нь үндэслэлгүй байна. Шинжээч газар эзэмших эрх үүсээгүй аж ахуйн нэгж дээр газрын төлбөр төлөөгүй гэж татвар ногдуулсан.

Татварын ерөнхий газрын Хууль эрх зүйн хэлтсээс эрх /30%/ болон мэдээлэл /10%/ борлуулсан орлогоос татвар суутгах талаарх лавлагааг авсан, дээрх лавлагааг мэдсээр байж 30% татвар ногдуулсан, хууль буцаан хэрэглэсэн зэргээр шинжээчид илтэд хууль зөрчиж дүгнэлт гаргасан. Иймд хэргийг дахин бүхэлд нь хянаж шинжээчдийн дүгнэлтийг хууль бус, үндэслэлгүй байгааг тогтоож, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасныг үндэслэн миний үйлчлүүлэгчид ашигтайгаар шийдвэрлэж өгнө үү» гэв.

Иргэний хариуцагч «ПВР» ХХК-ийн төлөөлөгч М.Ня, Д.Бо, өмгөөлөгч Ц.Цэрэнжээ нар хамтран гаргасан давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд өмгөөлөгч Ц.Цэрэнжээ гаргасан тайлбартаа: «Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 261 дугаартай шийтгэх тогтоолоор «ПВР» ХХК-аас 1.219.368.700 төгрөг гаргуулж Татварын ерөнхий газарт олгохоор шийдвэрлэсэн нь нэг талыг барьсан, бодит байдалтай нийцээгүй хууль ёсны бус, үндэслэлгүй болсон. «ПВР» ХХК-ийг уг хэрэгт ямар үндэслэлээр иргэний хариуцагчаар татсан нь тодорхойгүй байхад торгууль оногдуулах үндэслэл байхгүй. Тус компанийн ямар нэг албан тушаалтан, ажилтан энэ хэрэгт яллагдагч, шүүгдэгчээр татагдаагүй, татагдах ч хуулийн үндэслэл байхгүй. Гэтэл сонирхлын зөрчилтэй татварын улсын байцаагч Н.Г, эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан Б.А, аудитор Ц.С гэсэн бүрэлдэхүүнтэй хүмүүсийг оролцуулж гаргасан шинжээчийн дүгнэлтийг нотлох баримт болгон тус компаниас дээрх мөнгийг гаргуулахаар шийдвэрлэсэн. Ингэхдээ татварын ямар хуулийн дагуу төлбөр гаргуулсан тухайгаа бичээгүй нь хуулийн үндэслэлгүй тогтоол гэдгийг нотолж байна.

260006, 260007, 260009 тоот дүгнэлтүүдэд “ЗУ”, “НТГ”, “УМ” ХХК-иуд татвар ногдох орлогоо нуусан гэж бичигдсэн нь “ПВР” ХХК-тай холбоогүй тул тэдгээрийг хүчингүй болгосноор “ПВР” ХХК-ийг татвар төлөөгүй гэж буруутгах, түүнд татвар ногдуулах үүрэг үүсэхгүй. “НТГ” ХХК-ийн хувьцааг эзэмшигч иргэн Б.Д, “УМ” ХХК-ийн хувьцааг эзэмшигч иргэн Т.У нар хувьцаа худалдах, худалдан авах гэрээгээр хувьцаагаа худалдсан болох нь гэрээнүүд, төлбөрийн дансны хуулга, бусад санхүүгийн баримтуудаар хангалттай нотлогдсон юм.

“ПВР” ХХК-д хамааралтай нэг ч нотлох баримт байхгүй бөгөөд эрүүгийн хэргийн буруутгах биш цагаатгах талын нотлох баримтууд байна. Компанийн хувьцааг худалдсан байхад мөрдөн байцаагч, прокурор, шүүх ямар ч үндэслэлгүйгээр нэр бүхий иргэдийн олсон орлогыг аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7-д заасан эрх борлуулсны орлогод хамааруулсан. Иргэн Б.Д, Т.У нарын олсон орлогын төлөө “ПВР” ХХК татвар төлөх үүргийг хуулиар хүлээгээгүй.

Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нь эрх биш захиргааны акт бөгөөд түүнийг худалдан борлуулах нь өөрөө хууль бус үйлдэл. Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг үнэлэх боломжгүй ба зөвхөн хайгуулын үйл ажиллагаа явуулсан зардал болон хайгуулын ажлын мэдээллийг санхүү, нягтлан бодох бүртгэлийн тайландаа аж ахуйн нэгжүүд тусгадаг. Шүүх ямар нотлох баримтыг үндэслэн хайгуулын тусгай зөвшөөрлийг худалдсан гэж дүгнэсэн нь тодорхойгүй байна. Өөрөөр хэлбэл, «ПВР» ХХК нь иргэний хариуцагч болох нь нотлогдоогүй байхад анхан шатны шүүх тодорхой үндэслэл заалгүй тогтоолоор төлбөр гаргуулахаар шийдвэрлэсэн нь үндэслэлгүй. «ПВР» ХХК-ийг 1.2 тэрбум төгрөгийн татварт төлөхөөс зайлсхийсэн гэж үзсэн хирнээ Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйл буюу татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэрэг үйлдсэн гэж эрүүгийн хэрэг үүсгэн шалгаагүй. Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 2... тоот шийтгэх тогтоолын иргэний хариуцагч «ПВР» ХХК-тай холбогдох хэсгийг хүчингүй болгоно уу» гэв.

“ВР” ХХК-ийн төлөөлөгч М.Ня тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: “Тус компани 2009 онд “ПС” ХХК-ийн хувьцааны 50 хувийг худалдаж авч байсан. Одоо яригдаж байгаа асуудал нь 2007 оны үед болсон үйл явдал юм. Тухайн үед “ПС” ХХК нь “УМ”, “НТГ” ХХК-иудыг иргэн Б.Д, Т.У нараас худалдан авч байсан. Үүнээс иргэн Т.У, Б.Д нар ашиг олсон. Иймд “ПВР” ХХК нь иргэний хариуцагчаар татагдах хууль зүйн үндэслэл байхгүй. Шинжээч Н.Г “ПР” ХХК нь 2007 оны 10 дугаар сард тухайн компаниудыг худалдан аваад шууд биет бус хөрөнгөөр бүртгэсэн байсан” гэж Авлигатай тэмцэх газарт мэдүүлсэн байдаг. Энэ бол

манай компанийг буруутгах шалтгаан болсон юм. Шүүх хуралдааны хэлэлцүүлгийн шатанд “2007 оны 11 сар гэдэг гэрээ хаанаас олж үзэв. Бид 2008 онд 4 сард анх уг 2 компанийг худалдаж, аваад хувьцаагаараа хөрөнгө оруулалт хийж бүртгээд улмаар 2009 оны сүүлээр тус 2 компани татан буугдахад биет бус хөрөнгөөр бүртгэсэн гэж шинжээч Н.Г-аас асуухад тэрээр би энэ асуудлыг андуурсан байна” гэж мэдүүлсэн. Хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа хийгээд түүнийхээ төлөө буруудаж байгаа нь харамсалтай байна. Шинжээч Н.Г “ПВР” ХХК-ийг “халхавч гэрээ хийсэн” гэж дүгнэсэн. “ПВР” ХХК нь 2008 оноос 2010 онд хайгуул хийж ашиглагдахуйц хэмжээний нөөц тодроогүй тул лицензээ улсад эгүүлэн өгсөн. Анх 6 тэрбум төгрөгөөр худалдан авснаас хойш 7.5 тэрбум төгрөгийн хөрөнгийг хайгуул хийхэд зарцуулсан. Уг лицензийг худалдан авснаар ямар нэг ашиг олох боломжгүй байсан. Зөвхөн үүрэг хүлээж, зардал гаргаж, хайгуулын ажлын үр дүн нь ердөө л цаасан дээр бичигдсэн мэдээ мэдээллүүд байдаг. Бидэнд байгаа зүйл бол 13 тэрбум төгрөгийн үнэ бүхий мэдээлэл агуулсан цаас юм. Манай компани 2007 онд анх байгуулагдсан цагаас эхлэн олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартыг үйл ажиллагаандаа мөрдүүлж эхэлсэн. Бүртгэлтэй холбоотойгоор уг хэрэгт хүчээр хамаатуулах асуудал үүсээд байна. “Танайд уг хэргээс үүдэн хэдий хэмжээний хохирол учирсан вэ” гэж Үндэсний татварын ерөнхий газрын төлөөлөгчөөс шүүх хуралдааны хэлэлцүүлэгт асуухад “бидэнд одоогоор бодитой учирсан хохирол байхгүй ч шүүхээс та нарыг гэм буруутай гэж тооцвол бид хохирлоо нэхэмжлэх болно” гэж хариулсан болно. Иймд “ПВР” ХХК-д оногдуулсан 1.2 тэрбум торгуулийн арга хэмжээг хүчингүй болгож өгнө үү” гэв.

Иргэний хариуцагч «ПВР» ХХК-ийн төлөөлөгч Д.Бо тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Баянгол дүүргийн татварын байцаагчийн дүгнэлт хууль бус байсан учраас хэзээ нэг цагт хүчингүй болох нь цаг хугацааны асуудал юм. «НТГ» ХХК-ийг худалдан авсан гэрээний дүнг 2 дахин нэмэгдүүлж, түүнд татвар ногдуулсан нь буруу байна гэдгийг шат шатны шинжээч нар хүлээн зөвшөөрсөн. Шинжээч Н.Г хийсэн шалгалтдаа хайнга хандаж буруу дүгнэлтүүд гаргасан. 2009 оныг хүртэл «УМ» ХХК болон «НТГ» ХХК-ийн тайланг тусад нь гаргаж байсан ч худалдаж авангуут нь биет бус

хөрөнгөөр бүртгэсэн байна гэж үзэж төлбөр тавьсан нь үндэслэлгүй. Н.Г нь өөрийн гаргасан дүгнэлтээ буруу байсан гэдгээ хүлээн зөвшөөрсөн. Хайгуулын лицензийг эзэмшсэнээр шууд орлого олдоггүй ба ашиг олох эсэх нь эргэлзээтэй байдаг. Т.У, Б.Д зэрэг хүмүүс ашиг олсон байхад «УМ» ХХК болон «НТ» ХХК-ууд нь ашиг олоод татвар төлөөгүй байна гэж дүгнэж байгаа хууль зүйн үндэслэлгүй. Харин ч 10% татварыг эдгээр иргэдээс суутган авч үлдсэн нь сайшаалтай гэж үзэж байна. Худалдан авсан лицензүүдээс ямар ч ашиг олоогүй тул ашигт малтмалын зөвшөөрлүүдээ ашигт малтмалын газарт хүлээлгэн өгсөн. 800.000.000 төгрөгийн татвар улсад төлөөд байхад 1.2 тэрбум төгрөгийн татвар улсад нэмж төлөх ёстой гэж байгааг хүлээн зөвшөөрөхгүй» гэв.

Иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-ийн төлөөлөгч Б.Ба давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1-р шүүхийн 261 дүгээр шийтгэх тогтоолоор “КЖЭМ” ХХК-д 13.445.598.900 төгрөгийн төлбөр ногдуулахдаа тус компанийг иргэний хариуцагчаар татан оролцуулж байгаа талаар хуульд нийцсэн эсэхийг тогтоож дүгнэлт өгөөгүй, төлбөр ногдуулсан хууль зүйн үндэслэлээ тодорхойлолгүйгээр төлбөр ногдуулсан тул давж заалдах гомдлыг дараах үндэслэлээр гаргаж байна.

Нэг. Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагч, комиссар Г.У-ын «КЖЭМ» ХХК-ийг иргэний хариуцагчаар татах тухай тогтоолд «КЖЭМ» ХХК, «ХБЭ» ХХК, «ЭрЭ» ХХК, «БАЭ» ХХК, «ХЭ» ХХК, «ШЭ» ХХК-иуд нь 2005-2009 оны хооронд 13,398,688,000 төгрөгийн татвар санаатай төлөхөөс зайлсхийсэн ...» гэх үндэслэл заажээ. Гэхдээ зөвхөн «КЖЭМ» ХХК-ийг иргэний хариуцагчаар татан хохирлыг хариуцах этгээд гэж үзсэн нь хууль бус, үндэслэлгүй байна. «КЖЭМ» ХХК болон бусад хамааралтай байсан 5 компанийг тус хэрэгт иргэний хариуцагчаар татах тогтоол үйлдэхдээ татвараас зайлсхийсэн гэсэн гэмт хэрэгт холбогдуулж иргэний хариуцагчаар татсан атлаа яллах дүгнэлт болон шүүхийн шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэг буюу албан тушаалтны гэсэн өөр гэмт хэргийн иргэний хариуцагчаар үндэслэлгүйгээр татсан. «КЖЭМ» ХХК болон бусад нэр бүхий 5 компанийг иргэний хариуцагчаар татах

шалтгаант холбоо байхгүй бөгөөд дурын хөндлөнгийн этгээдийн хууль бус үйлдлийн үр дагаврыг хариуцах үндэслэлгүй.

Хоёр: Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагчдын хамтран гаргасан шинжээч нар дээрх 6 компани тус бүрээр дүгнэлтээ гаргасан байхад ямар үндэслэлээр 13.445.598.900 төгрөгийн татварын төлбөрийг ганцхан «КЖЭМ» ХХК-д ногдуулж төлүүлэхээр шийдвэрлэсэн үндэслэлээ шүүх тогтоолдоо заагаагүй. Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсээс «ШЭ» ХХК-д шалгалт хийж татварын өр төлбөргүй тул 2012 оны 05 дугаар сард татан буулгаж татвар төлөгчөөс хассан байхад мөрдөн шалгах ажиллагаа явуулсан, шинжээчийн дүгнэлт гаргуулсан зэрэг нь үр дагавар үүсгэх ач холбогдолгүй болно. Түүнчлэн «ХЭ», «ЭрЭ» ХХК-иудын хувьцаа эзэмшигч нь өөрчлөгдөж «КЖЭМ» ХХК-д ямар нэгэн хамааралгүй болсон тухай албан бичгээр мэдэгдсэн боловч анхан шатны шүүх дээрх байдлыг анхаараагүй юм.

Гурав. «КЖЭМ» ХХК болон бусад нэр бүхий 5 компанийг иргэний хариуцагчаар татахдаа Улсан Дээд шүүхийн 2009 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 15 дугаар тогтоолд «Эд хөрөнгийн хохирлыг хариуцвал зохих этгээд гэж гэмт хэрэг үйлдээгүй, уг хэргийн сэжигтэн яллагдагч, шүүгдэгч биш боловч хуульд заасан үндэслэлээр тэдгээрийн үйлдлийн улмаас учирсан хохирлыг арилгах үүрэг бүхий, иргэний нэхэмжлэлийн дагуу хариуцагчаар татагдсан этгээдийг хэлнэ» гэж тайлбарласнаас үзэхэд Ч.Га нарын татварын улсын байцаагчид «татварын зөрчлийг илрүүлээгүй» гэх үйлдлийн улмаас учирсан хохирлыг яагаад «КЖЭМ» ХХК хуульд заасан үндэслэлээр хариуцах үүргийг тогтоогоогүй, харин шинжээчийн дүгнэлтээр хийсвэр хохирлыг гаргасан.

Улсын Дээд шүүхийн «Гэмт хэргээс улбаатай боловч тухайн гэмт үйлдэл, эс үйлдэхүйтэй шууд шалтгаант холбоогүй бусад хохирлын асуудлыг эрүүгийн хэргийн хамт шийдвэрлэхгүй» гэсэн тогтоолд заасны дагуу уг компаниудын төлөх байсан гэх татварын өр төлбөрийн хэмжээ нь үндэслэлгүй, татварын улсын байцаагч нарын үйлдэлтэй шууд шалтгаант холбоотой болохыг тогтоогоогүй, ямар хуульд үндэслэн хохирлыг хариуцах болохыг иргэний хариуцагчаар татсан тогтоолд дурдаагүй, дүгнэлт хийгээгүй байх тул уг компаниудын

татварын өр төлбөртэй эсэх асуудал нь татварын эрх зүйн харилцааны объект буюу харьяалалын дагуу захиргааны журмаар шийдвэрлэх асуудал юм.

Дөрөв. «КЖЭМ» ХХК-ийг иргэний хариуцагчаар үндэслэлгүйгээр тогтоож, нотлох баримтыг хууль бусаар бүрдүүлэх зорилгоор шинжээчдийг томилж, дүгнэлт гаргуулахдаа холбогдох хууль тогтоомжийг дараах байдлаар ноцтой зөрчжээ. Үүнд:

Хохирогчоор тогтоогдсон Татварын ерөнхий газар нь өөрөө шинжээчдийг томилсон. Ашиг сонирхлын зөрчилтэй шинжээч нарыг томилж дүгнэлт гаргуулсан.

Нэр бүхий 6 компанид шинжилгээ хийх тогтоолд дурдсан шинжээч нар бүрэлдэхүүнтэй шинжилгээ хийх ёстой байтал шинжээчид өөрсдийн дураар эсхүл мөрдөн байцаагч нь албан ёсны шийдвэр, тогтоолгүйгээр шинжээчдийг хуваарилан компани тус бүрт томилж шинжилгээ хийлгэсэн.

2013 оны 03 дугаар сарын 25-ны өдөр нэр бүхий шинжээчдийг томилон дүгнэлтийг 4 дүгээр сард багтаан ирүүлэх үүрэг бүхий шинжээч томилох тогтоол үйлдсэн. Гэвч энэ хугацаанд шинжээчдийн дүгнэлт гаралгүй 10 сарын хугацаа өнгөрсний дараа нэмэлт шинжилгээ хийлгэх тогтоолыг үйлдэж Чингэлтэй дүүргийн татварын улсын байцаагч нарыг нэр заалгүй томилсон.

Мөн нэмэлт шинжээчийн дүгнэлтэд томилогдоогүй шинжээч нар нэгдүгээр шинжилгээний асуултад хариулт өгсөн.

Шинжээч нар дээрх хоёр тогтоолын дагуу шинжилгээ хийхдээ «тавьсан асуултын дагуу дүгнэлт гаргаагүй» байна.

Ижил мэргэжлийн шинжээчид бүрэлдэхүүнтэйгээр шинжилгээ хийж байгаа тохиолдолд шинжээч тус бүр шинжилгээг эхнээс нь дуустал бие дааж хийж, шинжилгээний үр дүнгээ нэгтгэн нэг дүгнэлт гаргах ба санал зөрсөн шинжээч тусгай санал хүргүүлнэ гэснийг зөрчиж шинжээчид шинжилгээний объектыг хуваан авч, тусдаа дүгнэлт гаргасан болох нь шүүх хуралдааны явцад тогтоогдсон.

Тав. Шинжээчид нь дүгнэлт гаргахдаа мөн л мэргэжлийн ноцтой алдаа гаргаж, татварын хууль тогтоомжийг буруу хэрэглэж дүгнэлт гаргасан байна. Үүнд:

Ашигт малтмалын лицензийг биет бус хөрөнгөн дээр бүртгэж зардлыг нь хуримтлуулах стандартын дагуу бүртгэх болсон. Аливаа тусгай зөвшөөрлийг

ашиглахтай холбоотой гарсан зардал нь Олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандарт, Сангийн сайдын 2011 оны тушаалын дагуу хуримтлагдсан зардал хэлбэрээр биет бус хөрөнгөд бүртгэгддэг тул энэ нь «эрх» биш «биет бус хөрөнгө» юм.

Шинжээчид нь Ашигт малтмалын лицензийг компаниуд хоорондоо шилжүүлж байгаа нь Тусгай зөвшөөрлийг худалдаж байгаа гэж үзээд тус тусгай зөвшөөрөлтэй холбоотой гарсан хайгуулын ажлын зардлын дүн зэрэг хуримтлуулан бүртгэсэн зардлын дүнг уг тусгай зөвшөөрлийг худалдан борлуулсан орлогын дүн гэж тооцон дүгнэлт гаргахдаа уг лицензийг худалдан борлуулсан үнэ гэж яагаад үзэж байгаа тухай хууль зүйн ямар ч үндэслэл тавиагүй.

“КЖЭМ” ХХК хувьцаагаа Монгол улсад бүртгэлгүй хуулийн этгээдэд Монгол Улсын хилийн гадна үнэ төлбөргүй шилжүүлсэн байхад НӨАТ ногдуулсан нь НӨАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтыг зөрчиж Монгол Улсын нутаг дэвсгэрт хийгдээгүй гүйлгээнээс гадна компанийн хувьцаа нь бараа биш, мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн төрөлд бүртгэдэг зүйлд НӨАТ тооцсон байна.

“БАЭ” ХХК, “ХЭ” ХХК-иудыг 2007-2009 онд гадагш шилжүүлсэн үйлчилгээний төлбөрт татвар суутган авч тайлагнаагүй, НӨАТ төлөөгүй гэж шинжээчид дүгнэхдээ ААНОАТХ-д “Монгол улсаас эх үүсвэртэй” гэсэн нэмэлт, өөрчлөлт орсон хуулийг буцаан хэрэглэсэн нь хууль хэрэглээний ноцтой алдаа гаргасан.

“ХЭ” ХХК, “ШЭ” ХХК, “БАЭ” ХХК, “ЭрЭ” компаниуд ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан боловч уг газрыг ашиглаж байгаагүй, газар эзэмших, ашиглах гэрээ байгуулж байгаагүй тул газрыг зохих ёсоор эзэмшиж байсан гэж үзэх боломжгүй, газрын төлбөр төлөх үүрэг хүлээхгүй байхад газар ашигласны төлбөрийг төлөөгүй гэж шинжээчид дүгнэлт гаргасан үндэслэлгүй. Учир нь Газрын тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.6.6, 35.3.3-д зааснаар гэрээ байгуулснаар газрын төлбөр төлөх үүрэг үүснэ.

Иймд «КЖЭМ» ХХК болон бусад 5 компанид татварын өр төлбөр ногдуулж байгаа асуудал нь Ч.Га нарт холбогдох эрүүгийн хэрэгт хамааралгүй тул Татварын хууль тогтоомжийн хүрээнд, захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар шийдвэрлүүлэх боломжтой болохыг

харгалзан үзнэ үү» гэв.

Иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-ийн төлөөлөгч Н.Зо тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Тус компанийн төлөөлөгч Б.Бая-ын саналыг дэмжиж байна. Нэмж хэлэх зүйл байхгүй гэв».

Цагаатгагдсан этгээд Б.Жал-ны өмгөөлөгч Б.Энхтуяа тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Анхан шатны шүүхээс миний үйлчлүүлэгч Б.Жал-ыг цагаатгасан нь хууль зүйн үндэслэлтэй тул шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 1 дэх заалтыг хэвээр үлдээж өгнө үү» гэв.

Цагаатгагдсан этгээд Х.Ха-гийн өмгөөлөгч Б.Хишигбаатар тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: «Давж заалдах гомдол гаргаагүй учир тайлбар хэлэхгүй» гэв.

Прокурор Ш.Баярбилэг шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтээ: «Эрүүгийн хэргийн анхан шатны нэгдүгээр шүүхийн 2014 оны 02 сарын 21-ний өдрийн 2... тоот шийтгэх тогтоол нь хууль ёсны бөгөөд үндэслэлтэй гарсан тул хэвээр үлдээх саналтай байна. Ч.Га-ийн хууль бусаар хөрөнгөжсөн асуудалд өмгөөлөгч нар 1.1 тэрбум төгрөгийг 2008 онд Өршөөлийн хууль батлагдахад ил болгож гаргаж ирсэн гэж байна. 2008 оны 6 дугаар сарын 26-нд 1.1 тэрбум төгрөгийг татварын өршөөлд хамрагдахаар мэдүүлсэн. Энэ мэдүүлэгт шинжээч томилоход шинжээчийн дүгнэлтээр мэдүүлэг дээрх гарын үсэг Ч.Га-ийн эцэг У.Ч-ийнх биш болох нь тогтоогдсон. Иймд уг 1.1 тэрбум төгрөгийг татварын өршөөлд хамрагдахаар мэдүүлсэн нь тогтоогддоггүй. Уг мөнгийг татварын өршөөлд хамрагдахаар мэдүүлсэн гэж байгаа боловч үүний эх үүсвэрийн талаар өмгөөлөгч нар ярихгүй байна. Гаалиар бэлэн мөнгө оруулж ирсэн декларацийн талаар өмгөөлөгч нар хэлж байгаа ч анхан шатны шүүхэд гаалийн деклараци гэх зүйл гаргаж өгөөгүй. Мөрдөн байцаалтын шатанд гаальд бэлэн мөнгө мэдүүлж байсан эсэхийг лавлахад мэдүүлж байгаагүй гэдэг нь тогтоогдсон. Ч.Га-ийн 2 дансанд хадгалж байсан мөнгөний эх үүсвэр тогтоогдоогүй. Шинжээч нар ашиг сонирхлын зөрчилтэй, мэргэжлийн бус гэжээ. 3 компанид Мэргэжлийн хяналтын газар, Аудит, Татварын ерөнхий газрын хамтарсан бүрэлдэхүүнтэй шинжээчдийн баг шинжилгээ явуулсан. Шинжээч Б.А нь ашиг сонирхлын зөрчилтэй, өөр хэрэгт шалгагдаж байсан гэдэг асуудал яригдаж байгаа ч Б.А нь шинжээчийн дүгнэлтийг ганцаараа гаргаагүй,

Н.Г, Ц.С гэдэг хүмүүстэй хамтран дүгнэлт гаргасан. Нэр бүхий 6 компанид шалгалт хийж татвар ногдуулсан, эрх борлуулсан уу эсвэл мэдээлэл борлуулсан уу гэдэг асуудлаар шинжээчийн дүгнэлт хууль ёсны үндэслэлтэй гарсан гэж үзэж байна» гэв.

Прокурор О.Гэрэл шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтээ: «Өмгөөлөгч нарын зүгээс татварын байцаагч нар шинжээчээр дүгнэлт гаргаад нөгөө талд татварын байцаагч нар ялтнаар орж ирээд байна. Татварын ерөнхий газар нь хохирогчоор тогтоогдож орж ирсэн байна гэж хэлсэнд нь тайлбар хийе. Шинжээч нар нь дүгнэлтийг гаргахдаа хууль сануулсан баримттай танилцан, гарын үсэг зурж, өөрсдийн мэдлэгийн хүрээнд дүгнэлтийг гаргасан гэж үзэж байна. Татварын байцаагч нар санхүүгийн чиглэлээр мэргэшсэн байдаг учраас шинжээчээр оролцуулсан. Татварын байгууллагыг хохирогчоор тогтоосон нь хууль зөрчөөгүй. «КЖЭМ» ХХК нь Чингэлтэй дүүргийн татварын албанд тайлангаа гаргадаг байсан учир Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн татварын байцаагч нарыг шинжээчээр томилсон. 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр батлагдсан Үндэсний татварын албаны хяналт шалгалтын дүрмийг 2008 оны 10 дугаар сарын 8-ны өдөр Хууль зүй дотоод хэргийн яам бүртгэж авсан. Хууль зүйн яам бүртгэж авсан хүчин төгөлдөр дүрмээс давж тайлбар ирсэн байна гэдэг асуудлыг шүүх хуралдааны явцад хохирогч байгууллагаас хэлсэн. Үндэсний татварын албаны энэ дүрэм нь татварын улсын байцаагч нарт бүгдэд нь хамаарах дүрэм юм. Энэ дүрэм нь Татварын ерөнхий газрын байцаагч нарт хамаарахгүй гэж тайлбарлаж байгаа нь буруу. Хяналт шалгалт хийж байгаа бүх татварын байцаагч нарт хамаардаг. Иймд хяналт шалгалт хийсэн татварын байцаагч нар уг дүрмийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдож байна. Шалгалт хийсэн компаниудад «КЖЭМ» Ххк-аар дамжиж хөрөнгө оруулалт орсон болох нь тогтоогдсон учраас иргэний хариуцагчаар татсан. Мэдээлэл зарсан байхад тусгай зөвшөөрөл зарсан талаар тайлбар хийе. Энэ компанийн тайлан мэдээлэл зарсан гэж бага үнийн дүнгээр гэрээ хийгдэж байгаа хирнээ нөгөө компаниудад очихдоо шууд биет бус хөрөнгөд бүртгэгдэж байгаа. Үүнээс компанитайгаа хамт тусгай зөвшөөрөл нь зарагдаж байна гэж дүгнэхэд хүргэж байна. Давж заалдах гомдлуудыг хэрэгсэхгүй болгож, анхан шатны шүүхийн шийтгэх

тогтоолыг хэвээр саналтай байна» гэв.

ХЯНАВАЛ:

Давж заалдах шатны шүүх хэргийг хэлэлцэхдээ зөвхөн гомдолд дурдсан үндэслэлээр хязгаарлахгүйгээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 308 дугаар зүйлийн 308.1 дэх хэсэгт заасны дагуу хэргийг бүхэлд нь хянан үзлээ.

Ч.Га нь Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа 2006 оны 5 дугаар сард «ВАТТ» ХХК-д татварын хяналт шалгалт хийгдэж байгааг нь далимдуулан өөрийн танил Ц.Со-оор дамжуулж тус компанид «250.000 ам.доллар өгвөл 1.000.000.000 төгрөгийн акт тавьна. Өгөхгүй бол актын дүнг 2.000.000.000 төгрөгөөр нэмнэ» гэж хэлүүлж, хясан боогдуулах замаар тухайн үеийн ханшаар 295.500.000 төгрөг буюу онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан болох нь:

Гэрч, «ВАТТ» ХХК-ийн гүйцэтгэх захирал Ё.Б-гийн «... 2005 онд “Н» нэртэй аудитын компани манай санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийнэ гэж ирсэн. Бид гэрээт аудитын компанитай, хийлгэх боломжгүй гэсэн хариу өгсөн. Удаагүй Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн томилолтоор О.Бя, С.А нар жил гаран шалгалт хийгээд 2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 3,6 тэрбум төгрөгийн акт, 5,4 тэрбум төгрөгийн дүгнэлт бичсэн. Акт, дүгнэлт бичигдэхээс өмнө манай ажилтан Р.Ар руу таньдаг хүнээр нь Ч.Га яриулсан байсан. Энэ яриандаа 250.000 ам.доллар өгвөл 1 тэрбум төгрөгийн акт бичлээ. Тэгэхгүй бол актын дүнг 2 тэрбум төгрөгөөр нэмнэ гэсэн. Би Ч.Га гэж хүнд 250.000 ам.доллар өгөхгүй гэдгээ хэлсэн...» /20-р хх 210-211/, гэрч, «ВАТТ» ХХК-д худалдааны төлөөлөгчөөр ажиллаж байсан Р.Ар-ын «...2006 оны хавар Ц.Со ах худалдан авсан автомашиныхаа засвар үйлчилгээний талаар утсаар ярьсан. Энэ үедээ танай компанийг татварын газраас шалгаад байгаа юм уу, та нар их хэмжээний өр төлбөрт орсон юм биш үү, миний найз татварт ажилладаг туслалцаа хэрэгтэй бол ахдаа хэлж болно шүү гэсэн. Ерөнхий нягтлан бодогч Г.Б-д энэ талаар хэлэхэд татварын шалгалтын дүнг асуугаад өгөөч гэсэн. Ц.Со ах надад татварын асуудлыг нь зохицуулаад өгч чадах байх гэж хэлсэн ба их өндөр дүнтэй төлбөр яриад байсан. Тэрбум гэл үү, нэг

сая ам.доллар билүү тоо яригдсан санагдаж байна. Ц.Со ахын хэлсэн тоо, хувь хэмжээг нь шууд Г.Б-д дамжуулан хэлсэн. Түүнээс татварын өр төлбөрийг аргалаад хувь хэмжээ олж өгөхөөр хөөцөлдөж байгаагүй ...» /20-р хх 213-214/, гэрч Ц.Со-ын «... “ВА” компаниас ажилдаа 2 жийп автомашин худалдан авсан. Үүнийг Ч.Га мэдсэн байсан ба надаас асуусан санагдаж байна. Би “ВА” компаниас автомашин авч байгаа гэж хэлсэн чинь «наад компанийг чинь шалгаж байгаа» гэсэн. Автомашинтай холбоотой асуудлаар “ВА” компанийн менежер Р.Ар-той утсаар ярилцаж байхдаа татварын шалгалтын талаар ярьсан. Надаас ямар шийдвэр гарах гэж байгааг асууж өгөөч гэсэн. Би Ч.Га-ээс асуухад татварын шалгалт дуусаж байгаа, торгууль, төлбөрийн хэмжээний хувьд тоо хэлж, тодорхой хэмжээний мөнгө өгвөл татварын акт, дүгнэлтийн тоог бууруулж болох талаар ярьсан. Ч.Га-ийн ярьсан яриаг шууд Р.Ар-д утсаар хэлсэн. Хээл хахууль өгсөн, авсан асуудлыг нь мэдэхгүй. Надад Татварын ерөнхий газарт ажилладаг танил Ч.Га-ээс өөр хүн байхгүй шүү дээ...» /20-р хх 215-216/, гэрч, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байсан Х.Ат-ийн «... 2006 оны 05 дугаар сарын 31-ний өдөр татварын улсын байцаагчийн акт, дүгнэлт бичигдсэн. «ВАТТ» ХХК-аас акт, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй талаараа гомдол гаргасан. Мөн акт, дүгнэлт арай эцэслэн гараагүй байхад Татварын ерөнхий газрын даргад 250.000 ам.долларын хээл хахууль нэхсэн гомдол ирсэн...» /20-р хх 205-206/, гэрч, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байсан Ч.Эн-ын «...Баримт харахад би «ВАТТ» ХХК-ийг шалгах томилолт олгосон байна. Гэтэл иргэний мэдээлэл нь 2005 оны 3 дугаар сарын мэдээлэл байна. Шалгалтыг 14 хоногт хийж, үр дүнг танилцуулдаг. Энэ хугацаанд амжихгүй бол сунгалт хийдэг. Тэгэхээр Ч.Га-ийн удирдлагаар хийгдсэн шалгалт гэсэн үг. Ер нь Ч.Га-ийг өөрөө иргэдээс мэдээлэл авч, өөрийн хэлтсийн байцаагч нараар шалгуулж татвар төлөгч нарыг «дэлбэлдэг» гэж ярьдаг байсан...» /20-р хх 221/ гэх мэдүүлгүүд, «ВАТТ» ХХК нь 5.682.420.700 төгрөгийн татвараа нуусан үйлдлийг цагдаагийн байгууллагаар шалгуулах тухай татварын улсын байцаагч Х.Ат, О.Бя нарын 2006 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 300102 тоот дүгнэлт /21-р хх

147-148/, шалгалтаар илэрсэн 13.145.351.500 төгрөг, 85.421,00 ам.долларын зөрчилд 2.404.552.300 төгрөг, 25.626,30 ам.долларын нөхөн татвар, 1.202.276.200 төгрөг, 12.813,15 ам.долларын хүү, нийт 3.606.828.500 төгрөг, 38.439,45 ам.долларын төлбөр ногдуулсан татварын улсын байцаагчийн 2006 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 3000649 тоот акт /21-р хх 143-146/, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2009 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 98а дугаар шийдвэр /27-р хх 8-21/, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2010 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 36 дугаар магадлал /27-р хх 22-30/, Нийслэлийн Захиргааны хэргийн шүүхийн 2011 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 191а дугаар шийдвэр /27-р хх 59-65/, Улсын Дээд шүүхийн 2012 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 48 дугаар тогтоол /27-р хх 77-81/, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн 2006 оны 07 дугаар сарын 27-ны өдрийн 075/063/ дугаар шинжээчийн дүгнэлт /27-р хх 82-86/, Нийслэлийн прокурорын газрын «ВАТТ» ХХК-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон тогтоол /27-р хх 88-90/ зэрэг нотлох баримтуудаар,

2002 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс 2013 оны 01 дүгээр сар хүртэл Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллах хугацаандаа цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа хууль ёсны орлогоос гадна эцэг У.Чи-ийн нэр дээр Голомт банкинд 110302XXXX тоот ам.долларын данс нээж /Ч.Га хамтран эзэмшигч/, 2008 оны 7 дугаар сарын 16-ны өдрөөс 2012 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэлх хугацаанд 1.362.655.48 ам.доллар буюу тухайн үеийн төгрөгтэй харьцах ханшаар 1.771.358.017 төгрөгийн орлого, 1.207.415,2 ам.доллар буюу 1.581.063.830 төгрөгийн зарлагын гүйлгээ, мөн эцэг У.Чи-ийн нэрээр Голомт банкинд 110503xxxx тоот төгрөгийн данс нээж, 2010 оны 11 дүгээр сарын 12-ны өдрөөс 2013 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр хүртэлх хугацаанд 1.073.951.176,93 төгрөгийн орлого, 1.073.850.400,00 төгрөгийн зарлагын гүйлгээ хийж, уг мөнгөнөөс 2007 оны 12 дугаар сараас 2012 оны 07 дугаар сар хүртэлх хугацаанд “Лексус 570” загварыг 3 ширхэг автомашин, “Лексус 470” загварын 2 ширхэг автомашин, “Ланд круйзер 200” загварын 1 ширхэг автомашин, 2012 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...хотхоны ...дугаар байрны

...тоот, 257,8 м.кв талбай бүхий амины орон сууц, гражийн хамт, иргэн Д.От-аас 2011, 2012 онд 2 ширхэг шүрэн толгойтой, халтар манан хөөрөг тус тус худалдан авч нийт 1.493.307.200 төгрөгийн эд хөрөнгө олж, хууль бусаар хөрөнгөжсөн болох нь:

Гэрч У.Чи-ийн «...Голомт банкинд ам.долларын болон төгрөгийн 3 дансыг өөрийн биеэр очиж нээлгэсэн. Нэг дансанд нь 50.000.000 төгрөгийн үлдэгдэлтэй байгаа. Уг данс дахь мөнгөний эх үүсвэр нь өвөг дээдсээс өвлөн авсан хөрөнгө, малтай байх үедээ сүү, ашиг шимээс олсон орлого, бяруу, шүдлэн үхэр зарсан мөнгө байгаа юм. Ам.долларын дансанд байгаа мөнгөний эх үүсвэр нь Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...дахь газраа зарсан мөнгөө хийсэн. Уг газар дээрх хашаа, байшин, жижиг агуулахыг 1990 онд 6.000.000 төгрөгөөр худалдан авч 650.000 ам.доллараар зарсан. Ч.Га хүүд хөөрөг өгөөгүй. Мөнгөний үнийн дүн, орлого, зарлагын талаар мэдэх зүйл алга байна ...» /20-р хх 137-140/, гэрч Г.Газ-ын /том/ «... Г.Газ /жижиг/ АНУ-д сурч байхдаа миний нэрээр 3-4 ширхэг «Лексус 470», «Лексус 570» маркийн автомашин оруулж ирж зарсан. Би автомашиныг нь хүлээн аваад Г.Газ /жижиг/-д хүлээлгэн өгсөн...» /29-р хх 112-113/, гэрч Бүгд Найрамдах Ливан улсын иргэн МУЧ-ийн «АНК» ХХК-аас 257.8 м.кв талбайтай байрыг 541.900 ам.доллараар худалдан авах гэрээ байгуулсан. Мөнгөний хэрэгцээ гарахаар нь зарахаар болсон. Барилга ашиглалтад орох хугацаа дөхөөд ирэхээр үнэ нь өсөж байсан. 1 м.кв талбайн үнэ дээр 100 ам.долларын ашиг нэмж зарсан. Сонинд зар тавьсны дагуу Ганаа гэх залуу ирж үзсэн. Дараагийн удаа аавтайгаа ирсэн. Аав нь өөрийгөө Засгийн газарт ажилладаг гэж танилцуулсан. Ганаа надтай анх утсаар ярихдаа 4 ширхэг «Лексус 570» загварын автомашин байрны үнэнд оруулах санал тавьсан. Би зөвшөөрөөгүй. Байр худалдах гэрээ байгуулаад, нэг удаагийн гүйлгээгээр төлбөрөө төлсөн. Худалдах, худалдан авах гэрээ байгуулах үедээ гэнэт өөр, өвөөгийнхөө нэрээр байгуулахаар болсон. Би гэрээ хийх хүн өөрөө байх ёстой гэтэл энэ бидний хэрэг гэсэн. Би бодохдоо аав нь Засгийн газарт ажилладаг учраас өвөөгийнхөө нэрээр гэрээ хийж байна гэж бодсон ...» /20-р хх 120-121/, гэрч С.Бсг-ийн «... Манай «МХГ» ХХК 2008 онд Баянзүрх дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт газар худалдан авч «МХК» гэж нэртэй хүнсний дэлгүүр барьсан. Дэлгүүрийн

зүүн хойд талд 204 м.кв талбай бүхий газрыг 2011 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Ч.Га-ээс 20.000 ам.доллараар худалдаж авсан ...» /20-р хх 122/, гэрч Д.От-ын «... Далай гэж найзаар дамжуулан Татварын ерөнхий газар дээр Ч.Га-тэй уулзахад, миний хөөрөгнүүдээс үзэж байгаад шүрэн толгойтой дунд зэргийн халтар манан хөөргийг 26.000.000 төгрөгөөр худалдан аваад, мөнгийг нь шууд бэлнээр өгч байсан. 2012 оны 12 дугаар сарын эхээр Ч.Га дарга хөөргүүдийг үзэж байгаад шүрэн толгойтой халтар манан хөөргийг 32.000.000 төгрөгөөр худалдан авсан ...» /20-р хх 53/, гэрч Д.Дан «... Ч.Га хөөрөг сонирхоод байхаар нь Д.От-тай уулзуулсан. Д.От түүнд олон хөөрөг үзүүлж байсан. 2012 оны сүүлээр Ч.Га дарга утсаар яриад нөгөө хөөрөг зардаг Д.От-ыг надтай уулзуулаач гэхээр нь уулзуулсан ...» /20-р хх 55-56/ гэх мэдүүлгүүд, Ч.Га-ийн Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ..., ...тоот байранд нэгжлэг хийсэн тухай тэмдэглэл /16-р хх 25-27/, Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр, ... тоот орон сууцанд нэгжлэг хийсэн тэмдэглэл /16-р хх 45-53/, Чингэлтэй дүүргийн 19 дүгээр хороо, «Гоодойн» аманд орших хашааны гражид байрлуулсан автомашинд үзлэг хийсэн тэмдэглэл /16-р хх 54-55/, 2012 оны 10 дугаар сарын 20-ны өдөр Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 257,8 м.кв талбай бүхий амины орон сууц худалдах, худалдан авах гэрээ /18-р хх 12/, У.Чи-ийн Голомт банк дахь 120120xxxx,11030 2XXXX,110503xxxx тоот дансны дэлгэрэнгүй хуулга /18-р хх 37-45, 19-р хх 194-211/, У.Чи-ийн Голомт банк дахь данс хамтран эзэмшигчийн талаарх баримтууд /19-р хх 212-217/, Гаалийн ерөнхий газрын 2013 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 03-3/510 дугаар албан бичиг /16-р хх 247/, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжээчийн 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 3614 тоот дүгнэлт /51-р хх 27-31/, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжээчийн 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн 3930 тоот дүгнэлт /51-р хх 43-44/, Монгол банкны валютын ханшийн лавлагаа /21-р хх 245-250/, «ИЭ» ХХК-ийн тээврийн хэрэгслийн зах зээлийн үнэлгээ /21-р хх 195/, эд хөрөнгө битүүмжилсэн тогтоол /21-р хх 188-229/ зэрэг нотлох баримтуудаар,

2010 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр “ХБЭ”, “ЭрЭ”, “БАЭ”, “ХЭ”, “ШЭ”, “КЖЭМ” ХХК-иудын татвар ногдуулалт, төлөлтийн байдалд Чингэлтэй дүүргийн Татварын хэлтсээс

төлөвлөгөөт шалгалт хийж байхад нь Ч.Га өөрийн төрсөн дүү “СА” ХХК-ийн захирал Ч.Да-тэй үгсэн тохирч түүнээр татварын шалгалт хийлгэх тухай мэдээллийг Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст буюу өөрийн нэр дээр гаргуулж, улмаар албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж дүүргийн татварын хэлтсийн хяналт шалгалтын ажлыг зогсоон, өөрийн удирдлагад ажилладаг татварын улсын байцаагч О.Бя, Б.Жр, Н.Чи, Б.Өс, Н.Ра, П.Га нарыг томилон татварын шалгалт хийлгэж 13.398.688.100 төгрөгийн татварыг ногдуулалгүй, татварын байцаагчийн илтгэх хуудас, акт гаргуулж дээрх татварыг төсөвт төвлөрүүлэлгүй, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн. Энэ гэмт хэрэгт Ч.Га зохион байгуулагчаар, Ч.Да хатгагчаар, Н.Ра, П.Га, О.Бя, Б.Жр, Н.Чи, Б.Өс нар гүйцэтгэгчээр хамтран оролцсон болох нь:

Гэрч, «СА» ХХК-ийн ерөнхий нягтлан бодогч ажилтай Ж.Дэ-ийн «... захирал Ч.Да надад хандаж «Татварын ерөнхий газарт нэг бичиг хүргэж өгөх хэрэгтэй байна» гэхээр нь өөрийн хамаатан Р.Ба-тай утсаар ярьж, регистрийн дугаарыг нь аваад захирал Ч. Да-д өгсөн. Захирал Ч.Да нэг дугтуйтай бичиг өгөөд Татварын ерөнхий газарт хүргүүлчих гэхээр нь Р.Ба ахад «гарын үсгээ зураад өгдөг юм гэсэн шүү» гэж хэлээд өгсөн. Ч.Да-гийн надад өгсөн бичиг нь ямар агуулгатай талаар мэдэхгүй ...» /50-р хх 118-119/, гэрч Р.Ба-ын «... 2010 оны 09 дүгээр сард ээжийн төрсөн дүү Лхамсүрэнгийн охин Ж.Дэ утсаар яриад «надад нэг итгэлтэй хүн хэрэгтэй» гээд регистрийн дугаар авсан юм. Тэгээд гутлын 22 дугаар дэлгүүрийн хажууд Ж.Дэ-тэй уулзахад цүнхнээсээ дугтуйтай бичиг гаргаж ирээд гарын үсэг зуруулсан. Тэр бичгийг Татварын ерөнхий газрын бичиг хэрэгт надаар өгүүлсэн юм. Тэрнээс миний хувьд бичгийн агуулгын талаар юу ч мэдэхгүй. Ж.Дэ миний барьж байсан утасны 8896xxxx дугаарын сим картыг аваад, надад 9552xxxx гэсэн дугаарын сим картыг өгсөн ...» /50-р хх 121-123/, гэрч, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан Д.Бр-ын «...Миний 2010 оны 8 дугаар сард шалгах аж ахуйн нэгжийн хуваарьт «БАЭ» ХХК-ийн 2006-2009 он, «ХБЭ» ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдлыг шалгах асуудал хуваарилагдсан. Ингээд 9 дүгээр сарын 27-ны өдөр дээрх компанийн ажлын

байранд ирж баримтыг хүлээн авсан. Маргааш нь буюу 9 дүгээр сарын 28-ны өдрийн 09 цагт ажлын байранд ирэхэд Санхүүгийн албаны захирал Ос гүйцэтгэх захирал Бб-тай уулзуулсан. Тэр захирал нь «танай Татварын ерөнхий газарт асуудал тавьсан хяналт шалгалтын ажлыг цааш үргэлжлүүлэх боломжгүй» гэсэн. Энэ тухай тасгийн дарга Д.Б-тай утсаар холбогдоход Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч. Га дуудаж байна гэж хэлсэн. Ингээд бид тасгийн дарга Д.Б-ын хамт Ч.Га даргын өрөөнд очиж уулзахад «та нар яагаад томилолтгүй очиж аж ахуйн нэгж шалгахаар, дарамт үзүүлээд байгаа юм бэ?» гэсэн. Бид 9 дүгээр сарын 27-нд тасгийн даргаас өгсөн томилолтыг Санхүүгийн албаны дарга Ос-д үзүүлсний үндсэн дээр санхүүгийн анхан шатны баримтыг хүлээн авч шалгалтын ажлаа эхлүүлсэн гэдгээ хэлсэн. Ч.Га дарга «манайд иргэний мэдээлэл ирсэн тул энэ мэдээллийн дагуу манайх шалгах болно» гэсэн. Д.Б дарга «манай графикт шалгалт учраас бид дуусгана. Дараа нь та нар дахин шалгаж болно» гээд бид гарсан. 9 дүгээр сарын 30-ны өдөр ажлын байран дээр нь баримтаа үзээд сууж байтал П.Га байцаагч утсаар ярьж «Яагаад та нар шалгалтаа үргэлжлүүлээд байгаа юм. Бид шалгах болсон, баримтуудаа хүлээлгэж өгөөд, наанаасаа гар. Босоо удирдлагадаа захирагдахгүй хаашаа байцаагч нар вэ, татварт хэдэн жил ажиллаж байгаа юм» гэх мэтчилэн загнасан. Маргааш нь биднийг оруулаагүй учир шалгалтаа үргэлжлүүлэх боломжгүй болсон...» /15-р хх 8-41/, гэрч, Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан С.Ба-гийн «... 2010 оны 09 дүгээр сард «БАЭ», «ХБЭ» ХХК-иудыг шалгахаар болсон. Маргааш нь ажлын байран дээр нь ирэхэд Татварын ерөнхий газраас манайхыг шалгахаар болсон тул танайхаар шалгуулахгүй гэж хэлсэн. Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га биднийг «томилолтгүй аж ахуйн нэгж дээр очиж дарамталлаа» гэж загнасан. Бид томилолт авч очсон болохоо тайлбарлахад «манайд энэ компаниудтай холбоотой иргэний мэдээлэл ирсэн тул бид шалгах болсон» гэж хэлсэн. Тасгийн дарга Д.Б «эдгээр компаниудтай холбоотой мэдээлэл манайд ирж, шалгалтын графикт орсон, шалгалт эхэлсэн учир бид дуусгана» гээд гарцаасан. 09 дүгээр сарын 30-ны өдөр

баримт үзээд сууж байтал Хяналт, шалгалт арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч П.Га утсаар яриад «Намайг шалга гэж томилсон. Наад баримтуудаа буцааж өг, босоо удирдлагадаа захирагдахгүй» гэж биднийг загнасан. 2010 оны 10 дугаар сарын 1-ний өглөө Татварын ерөнхий газраас шалгахаар болсон тул та нарыг оруулахгүй гээд оруулаагүй...» /15-р хх 3-4/, гэрч, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн даргаар ажиллаж байсан Д.Б-ын «...» КЖЭМ» ХХК-ийн захирал Г гэж хүний удирдаж байсан компани, аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийлгэхээр 9 байцаагчийг томилсон. «ШЭ», «ХБЭ», «ЭрЭ», «БАЭ», «ХЭ» ХХК-иуд нэг захиралтай учир нэгэн зэрэг шалгалт оруулах шаардлагатай байсан. Тэгтэл Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га «та нар томилолт байхгүй байж шалгалт хийлээ» гээд шалгалтыг зогсоож, өөрсдийн байцаагч нараа томилон шалгуулж, «КЖЭМ» ХХК-д татварын улсын байцаагчийн акт бичүүлсэн бусад аж ахуйн нэгжүүдийн хувьд дандаа илтгэх хуудас бичигдсэн байдаг ...» /8-р хх 248-249/, гэрч, Татварын ерөнхий газрын даргаар ажиллаж байсан Ж.Бая-ын «... Татварын ерөнхий газарт иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн гомдлыг нууцын ажилтан хүлээн авч, Татварын ерөнхий газрын дарга гомдлын төрлөөс хамаарч аль хэлтэс, албадаар шалгуулахыг шийдвэрлэдэг байсан юм. Эдгээр компаниудтай холбоотой гомдол ирсэн талаар сонсож байсан. Гэхдээ миний нэрээр болон над дээр орж ирсэн талаар мэдэхгүй байна. Хэрэв миний нэр дээр гомдол ирсэн бол би цохолт хийсэн байх ёстой...» /50-р хх 117/, шинжээч З. Энхтуяагийн «БАЭ» ХХК нь 2007 онд 140.203.300 төгрөг, 2008 онд 19.258.100 төгрөг, 2009 онд 28.167.600 төгрөгийн мэргэжлийн зөвлөх үйлчилгээний орлогыг гадаадад шилжүүлэхдээ аж ахуйн нэгжийн орлогын татварыг суутган авч төсөвт төлөөгүй. 2008 онд 36.612.000 төгрөг, 2009 онд 48.816.000 төгрөг, нийтдээ 85.428.000 төгрөгийн газрын төлбөрийг тооцож төсөвт төлөөгүй байна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 20 хувь, нэмэгдсэн өртгийн албан татвар 20 хувь, газрын төлбөрийн ашиглалтын лицензийн га тутамд 8000 төгрөгөөр тооцож газрын төлбөр төлөөгүй байхад үүнийг илтгэх хуудаст тусгаагүй байсан ...» /51-хх 16-17/ гэх мэдүүлгүүд, «ШЭ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийг

шалгасан татварын улсын байцаагч Б.Жр-ын 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 06 тоот илтгэх хуудас /2-р хх 99/, «ХБЭ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийг шалгасан татварын улсын байцаагч Б.Өс-ын 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 07 тоот илтгэх хуудас /2-р хх 100/, «ЭрЭ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан татварын улсын байцаагч О.Бя-гийн 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 08 тоот илтгэх хуудас /2-р хх 101-103/, «БАЭ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан татварын улсын байцаагч Н.Ра-гийн 2010 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 09 тоот илтгэх хуудас /2-р хх 110-111/, «КЖЭМ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан татварын улсын байцаагч П.Га, Б.Жа, Б.Өс нарын 2010 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 10 тоот илтгэх хуудас /2-р хх 117/, «ХЭ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан татварын улсын байцаагч Н.Чи-ын 2010 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн 980020 дугаар акт, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан Ч.Да-гийн «Р.Ба» нэрээр Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн нэр дээр бичсэн гомдол, мэдээлэл, түүний хариу /50-р хх 82-94/, «БАЭ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шинжилгээ хийж, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлсний шилжүүлсэн орлогоос аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөөгүй, газрын төлбөр төлөөгүй нийт 460.686.000 төгрөгийн зөрчилд, 217.700.600 төгрөгийн нөхөн татвар, хүү, торгууль, алданги төлөх үндэслэлтэй болохыг тогтоосон шинжээч Ч.У, З.Э нарын 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн дүгнэлт /50-р хх 162-181/, «ЭрЭ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шинжилгээ хийж, хайгуулын тусгай зөвшөөрөл худалдсан авсан буюу эрх борлуулсны орлогод аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган төлөөгүй, газрын төлбөр төлөөгүй нийт 700.783.300 төгрөгийн зөрчилд, 315.476.800 төгрөгийн нөхөн татвар, хүү, торгууль, алданги төлөх үндэслэлтэй болохыг тогтоосон шинжээч Ц.Б, С.Ба нарын 2013 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн дүгнэлт /50-р хх 182-191/, «ШЭ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шинжилгээ хийж, газрын төлбөрт нийт 46.900.800 төгрөг төлөх үндэслэлтэй болохыг тогтоосон шинжээч О.Б, Б.Э нарын 2013 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн

дүгнэлт /50-р хх 192-207/, «ХЭ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шинжилгээ хийж, гадаадад шилжүүлсэн орлогоос аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, хайгуулын тусгай зөвшөөрөл худалдсан авсан буюу эрх борлуулсны орлогод аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган төлөөгүй, газрын төлбөр төлөөгүй нийт 3.633.481.000 төгрөгийн зөрчилд, 896.964.100 төгрөгийн нөхөн татвар, хүү, торгууль, алданги төлөх үндэслэлтэй болохыг тогтоосон шинжээч Ц.Б, С.Ба нарын 2013 оны 11 дүгээр сарын 5-ны өдрийн дүгнэлт /50-р хх 208-221/, «ХБЭ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шинжилгээ хийж, хайгуулын тусгай зөвшөөрөл худалдсан авсан буюу эрх борлуулсны орлогод аж ахуйн нэгжийн орлогын албан татвар суутган төлөөгүй нийт 1.088.864.300 төгрөгийн зөрчилд, 489.988.900 төгрөгийн нөхөн татвар, хүү төлөх үндэслэлтэй болохыг тогтоосон шинжээч Л.А, Д.Б нарын 2013 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн дүгнэлт /50-р хх 222-234/, «КЖЭМ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шинжилгээ хийж, «ХЭ» ХХК-д хайгуулын тусгай зөвшөөрөл шилжүүлэхдээ нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулаагүй, 2007 онд 4682Х, 9007Х, 9015Х, 9022Х тусгай зөвшөөрлүүдийн үнийн зөрүү болох борлуулалтын орлогыг дутуу тусгасан, хайгуулын үнэлгээний хөрөнгө дансанд бүртгэгдсэн тусгай зөвшөөрлүүдийн үнийг нэмэгдсэн өртгийн албан татварт тайлагнаагүй, гадаадын хуулийн этгээд болох «КЖЭМЛ» компанид хувьцаа худалдаж, хайгуулын болон үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн өрийг шилжүүлэхдээ шилжүүлсэн орлогод эрх борлуулсны аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөөгүй нийт 37.565.129.600 төгрөгийн зөрчилд, 18.169.627.100 төгрөгийн нөхөн татвар, хүү, торгууль, алданги төлөх үндэслэлтэй болохыг тогтоосон шинжээч Б.Ба, С.О нарын 2013 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн дүгнэлт /50-р хх 225-250, 51-р хх 1-9/, шинжээч Ц.Б, Б.Э, Ч.У, З.Э, Б.Ба, Л.А нарыг байцаасан тэмдэглэлүүд /51-р хх 10-20/ зэрэг нотлох баримтуудаар, 4. Баянгол дүүргийн татварын хэлтсээс «НТГ», «УМ», «ЗУ» ХХК-иудын албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд татварын хяналт шалгалт хийж, «ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

худалдсан буюу эрх борлуулсан орлогоо нуусан» үйлдлийг нь илрүүлэн «НТГ» ХХК-ийн 6.974.495.000 төгрөгийн зөрчилд 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 260006 тоот дүгнэлт, «УМ» ХХК-ийн 2.786.273.500 төгрөгийн зөрчилд 260007 тоот дүгнэлт, «ЗУ» ХХК-ийн 975.852.500 төгрөгийн зөрчилд 2010 оны 3 дугаар сарын 19-ний өдрийн 260009 тоот дүгнэлт тус тус бичиж, Эрүүгийн цагдаагийн газраар шалгуулахаар хүргүүлсний дараа Ч.Га нь албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Н.Ра, П.Га нарыг томилон «НТГ», «УМ» ХХК-иудад дахин татварын шалгалт хийлгэн, «татварын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэлгүй» гэсэн илтгэх хуудас бичүүлж, уг илтгэх хуудсыг үндэслэн Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн нь албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж 2010 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 73 тоот тушаалаар 260006, 260007 тоот дүгнэлтүүдийг, 2010 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн 93 тоот тушаалаар 260009 тоот дүгнэлтийг тус тус хүчингүй болгосноор «ПС» ХХК буюу одоогийн нэрээ «ПВР» ХХК-ийн татварт төлбөл зохих 1.219.368.700 төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн.

Энэ гэмт хэрэгт Ч.Га, Д.Эн нар зохион байгуулагчаар, Н.Ра, П.Га нар гүйцэтгэгчээр хамтран оролцсон болох нь:

Гэрч, Баянгол дүүргийн татварын хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан Ж.На-гийн «... Манай дүүргийн татварын хэлтэст «УМ» ХХК-ийн татвар төлөлтийн байдалд хяналт шалгалт хийлгэх тухай Эрүүгийн цагдаагийн газар болон Татварын ерөнхий газрын Хяналт, шалгалт арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн гарын үсэгтэй албан бичгүүд ирсэн. Шалгалтын явцад уг аж ахуйн нэгжийн ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий лицензийг хувьцааны хамт «ПС» ХХК-д худалдсан мэтээр халхавч гэрээ байгуулан, 1.000.000 төгрөгийн дүрмийн сантай, ямар ч үйл ажиллагаа явуулаагүй хуулийн этгээдийн хувьцааг 2.400.000 ам.доллараар худалдсан байсан. Өөрөөр хэлбэл, «УМ» ХХК нь хувьцаа худалдах, худалдан авах гэрээгээр халхавчлан «ПС» ХХК-д 2.550.000 ам.доллар буюу 2.960.861.500 төгрөгийн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг аж ахуйн нэгжийн хамт шилжүүлсэн. «ПС» ХХК нь эрх борлуулсны орлогод 30 хувийн татвар

суутган авалгүйгээр, 10 хувийг суутган авч Сүхбаатар дүүргийн татварын хэлтэст хувь хүний орлогын албан татвар гэж төлсөн байсан. Мөн их хэмжээний орлогыг компанийн дансаар шилжүүлэн авахгүйгээр зуучлагч иргэний дансаар шилжүүлэн авсан байдаг. Ингээд «УМ» ХХК эрх борлуулсны орлогоо тайлагнаагүй байсан учир дүгнэлт бичиж Эрүүгийн цагдаагийн газарт шилжүүлсэн юм...» /32-р хх 80-82/, гэрч, Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байсан Ш.На-гийн «... «НТГ» ХХК-д татварын хяналт шалгалт хийх явцад уг аж ахуйн нэгж нь нилээн их ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөлтэй байсан. Тэгээд уг лицензээ иргэний нэрээр компанийн хувьцаа худалдсан мэтээр худалдах, худалдан авах гэрээг байгуулж шилжүүлсэн нь шалгалтаар тогтоогдсон. Гэхдээ ингэж худалдан борлуулахдаа иргэний нэрээр гэрээгээ байгуулан мөнгөө нөгөө хүнийхээ дансаар шилжүүлж, нийтдээ 6,9 тэрбум төгрөгийн лиценз борлуулсан байдаг. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7 дахь заалтын дагуу эрх борлуулсны орлогод 30 хувийн татвар төлөхгүйн тулд иргэнээр гэрээ байгуулан хувь хүний орлогын албан татварт 10 хувийг төлсөн байсан. Өөрөөр хэлбэл, 20 хувийн татвар төлөхөөс зайлсхийсэн нь шалгалтаар тогтоогдсон тул 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдөр 260006 тоот дүгнэлтийг бичиж цагдаагийн байгууллагаар шалгуулахаар шийдсэн. Хэсэг хугацааны дараа Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч Н.Ра биднийг дуудаж «та нарын бичсэн дүгнэлт үндэслэлгүй байна» гэсэн ба энэ талаар илтгэх хуудас ирсэн. Татварын ерөнхий хуульд адил эрх хэмжээтэй татварын улсын байцаагч дүгнэлтийг илтгэх хуудсаар хүчингүй болгох заалт байхгүй тул бид тухайн үедээ яагаад илтгэх хуудсаар дүгнэлтийг хүчингүй болгож, нэгнийгээ дарамталдаг байна аа гэж яриад л өнгөрсөн юм ...» /28-хх 164-165/, гэрч, Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байсан А.До-ын «... «НТГ» ХХК-д татварын хяналт шалгалт хийхэд «ПС» ХХК эрх худалдан авсныгаа иргэнээр зуучлуулан хувьцаа худалдан авсан мэтээр халхавч гэрээ байгуулан, хувь хүний орлогын албан татварт 10 хувийг суутган төлсөн байсан. Уг нь Аж ахуйн нэгжийн орлогын албан

татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.7 дахь заалтад зааснаар «ПС» ХХК нь «НТГ» ХХК-аас эрх борлуулсны орлогод 30 хувийн татварын суутган авч тайландаа тусган төсөвт төлөх ёстой. Энэ асуудлыг шалгуулахын тулд «НТГ» ХХК-д 260006 тоот дүгнэлт бичсэн. «ПС» ХХК нь 2.904.641.000 төгрөгөөс 30 хувийн татварт 871.392.300 төгрөг төлөх ёстойгоос 322.602.770 төгрөгийн төлсөн нь хасагдаад 548.789.530 төгрөгийн татварыг улсад төлөх ёстой...» /32-р хх 85/, гэрч, Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчаар ажиллаж байсан Г.Бая-гийн «... Эрүүгийн цагдаагийн газраас албан бичиг ирж, «УМ» ХХК-д 2008-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд Ж.На бид хоёр хяналт шалгалт хийсэн. Тус компани ашигт малтмалын тусгай зөвшөөрлөө 2.400.000 ам.доллараар худалдаж, уг мөнгийг иргэн Г.Н-гийн дансаар шилжүүлж орлого олсон нь холбогдох санхүүгийн баримтуудаар тогтоогддог. Бид 2.7 тэрбум төгрөгийн дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлэн шалгуулсан. Гэтэл гэнэт давхар хяналт гэдэг нэрийн дор Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч П.Га дуудаж, бидний бичсэн дүгнэлтийн талаар тайлбар авсан. Тэгээд дараа нь дүгнэлтийг буруу байна гэж хүчингүй болгох илтгэх хуудас бичсэн гэж манайд мэдээлсэн байсан ...» /28-р хх 183-184/, гэрч, Баянгол дүүргийн татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн даргаар ажиллаж байсан Д.Бр-ын «... Татварын ерөнхий газрын Хяналт, шалгалт арга зүйн хэлтсээс «НТГ», «УМ» ХХК-иудад холбогдуулан бичсэн дүгнэлтийг үндэслэлгүй гэсэн илтгэх хуудас ирсэн. Уг илтгэх хуудсыг үндэслэн 2 компанид холбоотой дүгнэлтийг хүчингүй болгох талаар Д.Эн дарга надад үүрэг өгсөн. 2010 оны 05 дугаар сарын 7-ны өдрийн 73 тоот тушаалын ард боловсруулсан хүнээр би гарын үсэг зурсан нь миний шууд удирдах эрх бүхий албан тушаалтан болох Д.Эн-аас өгсөн үүргийг биелүүлсэн юм. Харин Д.Эн даргын 2010 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 93 тоот тушаалаар «ЗУ» ХХК-д холбогдуулан гаргасан татварын улсын байцаагчийн дүгнэлтийг хүчингүй болгосон тушаалд хэн боловсруулсан, хэн хянасан талаар ямар нэгэн гарын үсэг байхгүй байгаа учраас би уг тушаалын талаар мэдэхгүй. Уг тушаал Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн

хэлтсийн илтгэх хуудсыг үндэслэсэн...» /32-р хх 68/, гэрч, Баянгол дүүргийн татварын хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан Р.До-ийн «... Эрүүгийн цагдаагийн газраас болон Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсээс хяналт шалгалт хийлгэх тухай албан бичиг ирсний дагуу «ЗУ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдлыг шалгасан. Уг аж ахуйн нэгжийн хэд хэдэн тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөний мэдээллийн лавлагаа гаргуулан, холбогдох газруудаас тодруулан үзэхэд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий лицензийг нийт 975.852.500 төгрөгөөр шилжүүлэх гэрээг байгуулсан байсан. Энэ талаараа татварын тайландаа огт тусгаагүй байсан. Харин уг аж ахуйн нэгж нь ашигт малтмалын тусгай зөвшөөрөл бүхий лицензийг худалдан борлуулсан бол Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн дагуу 30 хувийн татварт төлөх ёстой учраас эрх борлуулсан 975.852.500 төгрөгийн орлогоо татвараас нуусан гэж үзэж дүгнэлт бичин цагдаагийн байгууллагад шилжүүлсэн...» /32-р хх 73-74/, гэрч, Баянгол дүүргийн татварын хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан Ц.Цо-ны «... 2010 оны эхээр Эрүүгийн цагдаагийн газар болон Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсээс албан бичиг ирсний дагуу «ЗУ» ХХК-д татварын хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар 13 хайгуулын тусгай зөвшөөрлөө 975.000.000 төгрөгөөр худалдан борлуулсан зөрчил илэрч татварын улсын байцаагчийн дүгнэлт бичиж хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн ...» /32-р хх 77-78/, шинжээч Б.А-гийн «...Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт зааснаар «НТГ», «УМ» «ЗУ» ХХК-иудаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан авсан «ПВР» ХХК нь эрх борлуулсан орлогод 30 хувийн татвар 1.416.249.500 төгрөгийг улсад төлөх ёстой ...» /36-р хх 49-50/ гэх мэдүүлгүүд, Эрүүгийн цагдаагийн газраас Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч. Га-д хандаж «ЗУ», «УМ», «НТГ» ХХК-иудад татварын хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргуулах тухай 2010 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 9ж/311 тоот албан бичиг /32-р хх 43/, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн Баянгол дүүргийн татварын хэлтэст хандаж

«ЗУ», «УМ», «НТГ» ХХК-иудын албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд яаралтай шалгалт хийлгүүлэх тухай 2010 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр 26/123 тоот албан бичиг /32-р хх 96/, «НТГ» ХХК-д холбогдуулан бичсэн Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2010 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 260006 тоот дүгнэлт /31-р хх 199-201/, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч Н.Ра-гийн 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 01 тоот «260006 тоот дүгнэлт бичсэнийг хууль, эрх зүйн үндэслэлгүй, албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хэсэгчилсэн хяналт шалгалт хийхэд зөрчил илрээгүй» гэх илтгэх хуудас /32-р хх 27/, «УМ» ХХК-д холбогдуулан бичсэн Баянгол дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2010 оны 02 дугаар сарын 25-ны 260007 тоот дүгнэлт /31-р хх 193-194/, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч П.Га-ын 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 02 тоот «260007 тоот дүгнэлт бичсэнийг хууль эрх зүйн үндэслэлгүй, албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хэсэгчилсэн хяналт шалгалт хийхэд зөрчил илрээгүй» гэх илтгэх хуудас /32-р хх 28/, «ЗУ» ХХК-д холбогдуулан бичсэн Баянгол дүүргийн татварын улсын байцаагчийн 2010 оны 03 дугаар сарын 19-ний 260009 тоот дүгнэлт /31-р хх 195-197/, татварын улсын байцаагч П.Га-ыг «УМ» ХХК-д татварын хяналт шалгалт хийлгэхээр, татварын улсын байцаагч Н.Ра-г «НТГ» ХХК-д татварын хяналт шалгалт хийлгэхээр тус тус томилсон Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн дарга Ч. Га-ийн 2010 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн томилот /32-р хх 26,35/, «УМ», «НТГ» ХХК-иудын татвар ногдуулалт, төлөлтийг шалгасан татварын улсын байцаагчийн 260007, 260006 тоот дүгнэлтийг тус тус хүчингүй болгосон Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-ын 2010 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 73 дугаар тушаал /31-р хх 189/, «ЗУ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийг шалгасан татварын улсын байцаагчийн 260009 тоот дүгнэлтийг хүчингүй болгосон 2010 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 93 дугаар тушаал /31-р хх 190/, Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн газрын 2013 оны 04 дүгээр сарын 11-ний 9ж/1814 тоот албан бичиг /26-р хх 105/, 2013 оны 11 дүгээр сарын 29-ний

өдрийн бүрэлдэхүүнтэй шинжээчийн дүгнэлт /36-р хх 33-46/ зэрэг нотлох баримтуудаар,

5. Д.Эн нь Баянгол дүүргийн татварын хэлтсийн даргаар ажиллаж байхдаа дээрх байдлаар албан тушаалаа ашиглаж, улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргээс гадна Голомт банкны 170501xxxx тоот төгрөгийн дансаар 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хойш он дуустал хугацаанд 53.900.000 төгрөг, Голомт банкны 180129xxxx тоот ам.долларын дансаар 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс хойш он дуустал хугацаанд 32.430 ам.долларын орлого олж, «НК» ХХК-аас 493.822.000 төгрөгийн орон сууц худалдан авч, нийт эх үүсвэр нь тодорхойгүй 592.835.500 төгрөгийн орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн гэмт хэрэг,

2008 онд 19.000.000 төгрөг, 2009 онд 241.750.000 төгрөг, 2010 онд 9.851.000 төгрөг, 2011 онд 139.322.500 төгрөг, 2012 онд 90.489.600 төгрөг, нийт 500.413.100 төгрөгийн орлого олсон атлаа хувь хүний орлогын албан татварт бүрэн тайлагнаагүй, татвар ногдох орлогоо бууруулан тайлагнаж 50.041.300 төгрөгийн буюу онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэргийг тус тус үйлдсэн болох нь:

Гэрч Б.Хү-гийн «... Манай «НК» ХХК-ийн ...хотхонд Д.Эн байр авах гэрээ байгуулсан юм. Уг орон сууцны үнээс 203.000.000 төгрөгт нь 145.000 ам.долларын үнэтэй «Лексус 570» загварын автомашин тооцсон. Үлдсэн 296.301.600 төгрөгийг 6 удаа хувааж төлсөн ...» /30-р хх 151-153/, гэрч Д.Бс-ын «... 2005 онд ээжийн дүү Д бид хоёр нийлээд 30 орчим сая төгрөгөөр «АБ» нэртэй компанийг худалдан авсан. Тус компани архи үйлдвэрлэдэг аж ахуйн нэгж байсан ба Б.Он гэж хүний нөхрөөс сонингийн зараар холбогдож авсан. Татварын байгууллагад өртэй гээд архины акц энэ тэрийг нь өгөхгүй байсан учир компанийн үйл ажиллагааг зогсоосон. Ямар нэгэн худалдааны төв, дэлгүүр «АБ» ХХК-ийн нэрээр байгаагүй, бидэнд шилжүүлэн өгөөгүй ...» /31-р хх 166/, гэрч, «ЖМ» ХХК-ийн санхүү, бүртгэлийн газрын захирлаар ажиллаж байсан Д.Ц-ийн «...Манай компани нь Р.Г, Ц.Ц нарын хөрөнгө оруулалтаар үүсгэн байгуулагдсан. Тухайн үед банкнаас мөнгө зээлэх боломжгүй байсан учир хөрөнгө оруулагч нараар дамжуулан иргэн Д.Эн-аас 250.000 ам.доллар зээлсэн ...» /30-р хх 169-170/, гэрч Г.Чн-ын «... Д.Эн-аас 2008 оны 12 дугаар

сарын 11-ний өдөр 250.000 ам.доллар, 2009 оны 7 дугаар сарын 9-ний өдөр 300.000 ам.доллар зээлж, 2010 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр 500.000.000 төгрөгийн гэрээ байгуулсан юм. Гэрээг тухайн үеийн төгрөг, ам. долларын ханшаас шалтгаалаад төгрөг, ам.доллар болгон өөрчилж байсан. Ам.доллар 2 хувийн хүүтэй, төгрөг 1.6 хувийн хүүтэй ...» /30-хх 175-176/ шинжээч Ц.С-гийн «... Д.Эн 2008 оноос 2012 оныг дуустал хугацаанд нийт 50.041.300 төгрөгийн татвар ногдох орлогоо тайлагнаагүй, татвар ногдох орлогоо бууруулан тайлагнаж байсан тогтоогдсон. Үүнийг он тус бүрээр нь авч үзвэл 2008 онд 19.000.0, 2009 онд 241.750.0, 2010 онд 9.851.0, 2011 онд 139.322.5, 2012 онд 90.489.6, нийт 500.413.100 төгрөг болж байгаа ба 50.041.300 төгрөгийн татвар төлөхөөр байна ...» /36-хх 51-52/, шинжээч Б.А-гийн «... Шинжилгээгээр иргэн Д.Эн нь хувь хүний орлогын татварт 50.041.300 төгрөгийн татварыг төлөхөөс санаатайгаар зайлсхийж өөрийнхөө татварын тайланд буруу тайлагнасан байсан нь тогтоогдсон ...» /36-р хх 49-50/, шинжээч Н.Г-ын «... Д.Эн-ын арилжааны банк дахь дансны хуулга, хөрөнгө орлогын мэдүүлэг, татварын албанд гаргаж өгсөн тайлан, түүний өмгөөлөгчөөс ирүүлсэн тайлбар, баримтуудыг шинжилж үзэхэд иргэн Д.Эн нь хувь хүний орлогын албан татварт 50.041.300 төгрөгийг улсад төлөхөөс зайлсхийсэн нь тогтоогдсон ...» /36-хх 47-48/ гэх мэдүүлгүүд, Д.Эн-ын Авлигатай тэмцэх газарт гаргаж өгсөн хөрөнгө орлогын мэдүүлэг /30-р хх 18-51/, Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс Д.Эн-ын 2007 оноос 2011 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хянасан талаарх албан бичиг, «хөрөнгийн орлогоо бодитой тайлбарлаж чадаагүй, газар эзэмших эрхээ мэдүүлээгүй» гэсэн танилцуулга /1-р хх 167-170/, «НК» ХХК-ийн санхүүгийн болон орон сууцны гэрээний баримтад үзлэг хийсэн тэмдэглэл, гэрээ төлбөр төлсөн баримтууд /30-р хх 177-184/, Д.Эн-аас «ЖМ» ХХК-д мөнгө зээлсэн баримтууд /31-р хх 9-94/, Д.Эн-ын татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан тухай татварын улсын байцаагчийн 250041 тоот дүгнэлт /36р хх 173/, 2013 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн шинжээчийн дүгнэлт /36-р хх 33-46/ зэрэг болон хэрэгт цугларч шүүх хуралдаанаар шинжлэн судлагдсан бусад нотлох баримтуудаар нотлогдон тогтоогджээ.

Мөрдөн байцаалтын ажиллагаагаар

тогтоол гаргахад ач холбогдолтой нөхцөл байдлыг бүрэн шалгасан, хэргийн зүйлчлэл тохирсон, шүүх хуульд заасан журмын дагуу цугларч, шүүх хуралдаанаар хэлэлцэгдсэн нотлох баримтуудыг харьцуулан үнэлсний үндсэн дээр Ч.Га, Д.Эн, П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, О.Бя, Ч.Да, Б.Жр нарын гэм буруугийн талаар үндэслэл бүхий дүгнэлт хийж, тэдний хувийн байдал, хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан хуульд заасан төрөл, хэмжээний дотор ял шийтгэсэн байна.

Татварын улсын байцаагчийн 2011 оны 7 дугаар сарын 28-ны өдрийн 980034 тоот актаар «АФ» ХХК-д 3.747.357.300 төгрөгийн татвар ногдуулсныг тус компанийн гүйцэтгэх захирал Влох.Н.Н эс зөвшөөрч гомдол гаргажээ. Уг гомдлыг Татварын ерөнхий газрын дэргэдэх Татварын маргаан таслах зөвлөл хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө «АФ» ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Монгол Улсын хилээр гарч явсан болох нь тогтоогдсон. Өөрөөр хэлбэл, татвар төлөгчийн гомдлыг хуульд заасан журмын дагуу эцэслэн шийдвэрлээгүй буюу акт хүчин төгөлдөр болоогүй байхад татвар төлөгч улсын хилээр гарч явсан байх тул Ч.Га, Б.Бу нарыг албан үүрэгтээ хайнга хандсан гэж үзэх боломжгүй.

Түүнчлэн «СА» ХХК-ийн захирал Ч.Да-гийн «ЭҮ» ХХК-тай байгуулсан «Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээний гэрээ»-г үйлдвэрийн ерөнхий захирал Ч.Га баталж, санхүүгийн хэлтсийн дарга Г.Г, ерөнхий нягтлан бодогч П.М.В, хуулийн хэлтсийн дарга Б.М нар хянаж, зөвшөөрөн гарын үсгээ зурсан. Мөн үйлдвэрийн нягтлан бодогч нарт сургалт явуулах гэрээг ерөнхий нягтлан бодогч П.М.В захиалагчийг төлөөлөн байгуулсан байхад Б.Жал, Х.Ха нарыг албан тушаалаа урвуулан ашиглаж сонгон шалгаруулалтгүй гэрээ байгуулан бусдад давуу байдал олгосон гэж үзэх үндэслэлгүй. Энэ гэрээний дагуу татварын зөвлөгөө авснаар «ЭҮ» ашигтай ажилласан бөгөөд ямар нэгэн хохирол учраагүй, сургалтын тодорхой хэсэг нь явагдсан, үйлдвэрийн ажлын зохион байгуулалтаас болж үлдсэн сургалт хойшлогдсон зэрэг нөхцөл байдал нь хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон тул анхан шатны шүүх дээрх гэмт хэргүүдийг бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Б.Жал, Х.Ха, Б.Бу нарыг цагаатгасан нь хууль зүйн үндэслэлтэй гэж үзэв.

Б.Жа нь Шүүхийн шинжилгээний

үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний албаны даргаар ажиллаж байхдаа 2013 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хх-хх УНТ улсын дугаартай, «Лексус 470» загварын автомашиныг 47.500.000 төгрөгөөр, 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...байрлалтай зуслангийн зориулалттай байшинг газрын хамт 39.000.000 төгрөгөөр тус тус худалдан авсан боловч хууль бус хөрөнгө гэдгийг нотолсон баримтгүй. Прокурорын яллаж байгаа нотлох баримтаар тогтоогдсон «ОС» хөрөнгө зуулчлалын төвөөр дамжуулан зуслангийн байшинг 39.000.000 төгрөгөөр худалдаж авсан, Ү.Сэ-гийн нэр дээр 47.500.000 төгрөгөөр автомашин худалдаж авсан нөхцөл байдал нь хууль бус хөрөнгө болохыг шууд нотолж чадахгүй байна.

Харин Б.Жа дээрх хөрөнгийн эс үүсвэрийн талаар «Орон сууц худалдсан мөнгөнөөс үлдсэн мөнгө дээр цалингийн зээл авч, хадгаламжийн мөнгөнөөс нэмж зуслангийн байшин худалдаж авсан. Нөхөр А.Баб том оврын ачааны автомашинаар Өмнөговь аймагт тээвэр хийж олсон орлогоороо Лексус-470 загварын автомашиныг худалдан авсан» гэж тайлбарласныг үгүйсгэх боломжгүй. Учир нь гэрч А.Баб-гийн «... би 2010 оноос Өмнөговь аймгийн Дулааны цахилгаан станцад гэрээгээр нүүрс зөөдөг байсан. Хажуугаар нь хятадуудын бэлэн мөнгөний нүүрсэнд явж хилээс буцаж ирэхдээ ачаа ачаад ирдэг юм. Сарын дундаж орлого 3.000.000 төгрөг байдаг. Үүнээс хуримтлуулсан мөнгөөрөө Лексус-470 маркийн автомашиныг худалдаж авсан...» /41-р хх 93/ гэх мэдүүлэг, түүний «ХААН», «ХАС» банк дахь хувийн дансаар «нүүрсний тээврийн хөлс» утгатай нийт 78.107.286 төгрөгийн орлого орсон баримт /40-р хх 135, 41-р хх 134-135/, тээврийн хөлсийг бэлнээр хүлээж авсан баримтууд, гэрч Э.Бо-ын «... анх Б.Н бид хоёр хадам аав А.Баб-гийн нэр дээр байдаг Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоот нэг өрөө орон сууцыг 2013 оны 04 дүгээр сард 64.500.000 төгрөгөөр зарж, 45.000.000 төгрөгийг нь байрныхаа урьдчилгаанд өгсөн...» /41-р хх 95/ гэх мэдүүлэг, Б.Жа-ын шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн «... 1 дүгээр хорооллын байраа 64.000.000 төгрөгөөр зарж, 45.000.000 төгрөгийг хүргэний байрны урьдчилгаанд өгсөн. Үүнээс үлдсэн мөнгө дээр хадгаламжид байсан 10.000.000

төгрөгөө нэмж, 8.000.000 төгрөгийн цалингийн зээл авч 39.000.000 төгрөгөөр энэ зуслангийн байрыг худалдаж авсан юм...» /60-р хх 24/ гэх мэдүүлэг, А.Баб-гийн нэр дээр улсын бүртгэлийн Ү-220100хххх дугаарт бүртгэгдсэн, Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоот, 18 м.кв талбай бүхий орон сууцыг 2013 оны 04 дүгээр сарын 6-ны өдөр Д.Д-д 64.500.000 төгрөгөөр худалдсан гэрээ /40-р хх 226/, Б.У-гийн Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоот, 40 м.кв талбай бүхий орон сууцыг Э.Бо, Э.Ня нар 2013 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр 90.000.000 төгрөгөөр худалдан авахаар тохиролцож, урьдчилгаа 44.000.000 төгрөгийг төлж, үлдсэн мөнгийг «Голомт» банкны зээлээр төлж барагдуулах нөхцөлтэй худалдан авсан гэрээ /40-р хх 225/, Б.Жа 2013 оны 05 дугаар сарын 14-ний өдөр «Хас» банкнаас 8.000.000 төгрөгийн цалингийн зээл авсан гэрээ зэрэг нотлох баримтуудаар хөрөнгийн эх үүсвэрээ тайлбарласан үндэслэл нь нотлогдсон. Өөрөөр хэлбэл, жийп ангиллын автомашин болон зуслангийн хашаа, байшингаа хууль ёсны орлогоороо худалдаж авсан гэж үзэх үндэслэл тогтоогдсон байна.

Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлд заасан «Шинжээч зориуд худал дүгнэлт гаргах» гэмт хэргийн заавал байх шинж нь тусгай мэдлэгийн хүрээнд шинжлэн судалдсан асуудлынхаа талаар дүгнэлт гаргахдаа шунахайн болон хувийн бусад сэдэлт, санаа зорилгын үүднээс шууд санаатай буюу зориуд худал дүгнэлт гаргасан үйлдэл байдаг. Гэтэл Б.Жа-ыг «Д.Эн-ын татвар ногдох орлогыг тодорхойлох» зорилгоор шинжилгээ хийхдээ орлогыг нь 34.638.200 төгрөгөөр бууруулж, 15.403.100 төгрөг төлөхөөр 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 164 тоот санаатай, худал дүгнэлт гаргасан хэмээн буруутгахдаа гэмт хэрэг үйлдэх болсон сэдэлт, санаа зорилго нь юу байсныг, ямар учир шалтгааны улмаас Д.Эн-ын эрх ашигт нийцүүлэн санаатай худал дүгнэлт гаргах болсныг мөрдөн байцаалтаар шалгаж, хөдөлбөргүй тогтоогоогүй байна. Түүний гаргасан 164 тоот шинжээчийн дүгнэлт /36-р хх 241-244/ нь бүрэлдэхүүний шинжээчийн 2013 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн дүгнэлт /36-р хх 40/-ээс 34.638.200 төгрөгөөр бага, зөрүүтэй гарчээ. Гэвч ийнхүү зөрүүтэй гаргасан байдлыг бодитойгоор авч үзвэл санаатай худал дүгнэлт гаргасан гэхээс илүү алдаатай, буруу дүгнэлт гэж үзэхээр байна. Учир нь

бүрэлдэхүүнтэй шинжээчдийн дүгнэлтээс үзэхэд Б.Жа-ын гаргасан өмнөх 164 тоот дүгнэлт ямар тооцоолол, аргачлалыг илт зөрчсөний улмаас зөрүүтэй гарсан талаар заагаагүй ба зөвхөн Д.Эн-ын татвар ногдох орлогыг тодорхойлж, дүгнэсэн болно. Өөрөөр хэлбэл, эдгээр дүгнэлтүүд зөрүүтэй гарсан байдал нь зориудаар худал дүгнэлт гаргасан байх сэжиг, таамаг болж, мөрдөн байцаалтын бусад ажиллагаагаар батлагдан нотлогдсон байх учиртай.

Иймд хууль бусаар хөрөнгөжсөн гэх дээрх үйлдэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, санаатай худал шинжээчийн дүгнэлт гаргах гэмт хэргийн заавал байх шинж болох гэм буруугийн хэлбэр, сэдэлт, санаа зорилгыг мөрдөн байцаалтаар бүрэн нотолж чадаагүй байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт «Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд... эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ» гэсэн зарчмыг үндэслэн холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, Б.Жа-ыг цагаатгах нь зүйтэй гэж үзэв.

Давж заалдах гомдлуудад дурдсан үндэслэлээр хэрэгт цугларсан нотлох баримтуудыг судалж үзвэл:

Ч.Га нь Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа «ВАТТ» ХХК-д татварын хяналт шалгалт хийгдэж байгааг далимдуулан онц их хэмжээний авлига нэхэж, үүнийг өгөөгүй нөхцөлд актаар тавигдах төлбөрийн хэмжээг нэмэгдүүлнэ хэмээн хясан боогдуулах замаар хээл хахууль авахыг завдсан болох нь гэрч Ё.Бай, Р.Ар, Ц.Со нарын өгсөн мэдүүлгээр хангалттай нотлогдсон. Түүний үйлдэл хээл хахууль авах гэмт хэргийн шинжийг бүрэн агуулсан боловч «ВАТТ» ХХК авлига өгөхөөс татгалзсанаар төгс үйлдэгдээгүй, завдалтаар дуусажээ. Дээрх гэрчүүдээс хуульд заасан журмын дагуу байцаалт авсан, өгсөн мэдүүлгүүд нь агуулгын хувьд зөрүүгүйн гадна хэрэгт хувийн сонирхлоор хандаж, хүний гэмт хэрэгт гүтгэсэн гэж үзэх үндэслэл гаргасан давж заалдах гомдол үндэслэлгүй байна.

Хэрэв гэрчүүд хувийн ашиг сонирхлын үүднээс худал мэдүүлэг өгч, Ч.Га-ийг хүнд гэмт хэрэгт гүтгэсэн гэх хангалттай нотлох баримт байгаа бол энэ талаар

прокурорт гомдол гарган шалгуулсны эцэст, үндэслэлтэй болох нь тогтоогдвол шүүх шинэ нөхцөл байдал илэрснээр хэргийг сэргээн шалгуулах шийдвэр гаргах боломжтойг дурдах нь зүйтэй.

Ч.Га албан тушаалын цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа эцэг У.Чи-ийн нэр дээрх Голомт банкны ам.долларын болон төгрөгийн дансаар нийт 2.845.309.194 төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийж, уг мөнгөнөөс 6 ширхэг жийп ангиллын автомашин, хувийн орон сууц, гражийн хамт, 2 ширхэг шүрэн толгойтой манан хөөрөг худалдан авч хууль бусаар хөрөнгөжсөн болох нь нотлох баримтаар хангалттай нотлогджээ. Хууль бусаар хөрөнгөжих гэмт хэрэг нь дансанд орсон мөнгөөр эд хөрөнгө авах, дансаар гүйлгээ хийх байдлаар үргэлжилж хамгийн сүүлийн үйлдэл нь Голомт банкны 110302XXXX тоот ам.долларын дансаар 2012 оны 03 дугаар сарын 17-ны өдрөөс он дуустал хугацаанд 6 удаагийн гүйлгээгээр 30.493 ам.долларын орлого, төгрөгийн 110503xxxx тоот дансаар 2012 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс он дуустал 318.951.176 төгрөгийн орлого орсон байх тул Эрүүгийн хуулийн 270¹ зүйлийг буцаан хэрэглэсэн гэж үзэх үндэслэлгүй байна.

Ч.Га нь дансаар орсон мөнгөө тайлбарлахдаа эцэг У.Чи нуугдмал хөрөнгөө ил болгож, борлуулснаас эх үүсвэртэй бөгөөд нэр дурдсан хөрөнгүүдийг эцгийн мөнгөөр авсан талаар давж заалдах гомдолдоо дурджээ. Түүний эцэг У.Чи /15-р хх 110, 20-р хх 137-139/, эх Ц.Н /20-р хх 146/, дүү Ч.Г /20-р хх 129/, дүү Ч.Да /15-р хх 92/, эхнэр Б.Б /20-р хх 124/ нарын мэдүүлэг зэргээс үзэхэд У.Чи-эд их хэмжээний нуугдмал хөрөнгө байсан, уг хөрөнгөө ил болгож борлуулсан, түүнчлэн Ч.Га цалингаас өөр орлогын эх үүсвэртэй, наймаа арилжаа хийдэг байсан гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Баянзүрх дүүрэгт байрлалтай хашааны газраа 650.000 ам.доллараар зарсан гэх боловч үнэн хэрэгтээ 20.000 ам.доллараар буюу тухайн үеийн төгрөгтэй харьцах ханшаар 25.060.000 /21-р хх 249/ төгрөгөөр С.Бс-д зарсан. Харин уг газар 1999 онд иргэн Ж.Баярсүрэнгээс худалдан авсан, хууль ёсны хөрөнгө болох нь тогтоогдсон болно. /20-р хх 122/

У.Чи-ийн нэр дээрх Голомт банкны ам.долларын 110302XXXX тоот данс, төгрөгийн 110503xxxx тоот дансаар нийт

2.845.309.194 төгрөгийн орлого орсон уу, эсхүл тодорхой хэмжээний мөнгийг дансны эргэлтэд оруулж, олон удаагийн давтамж нь онц их хэмжээний орлого олсон мэтээр ойлгогдож байна уу гэдэг нь тодорхойгүй. Өөрөөр хэлбэл, 2.845.309.194 төгрөгийн орлого бодитой тоо мөн эсэх нь эргэлзээтэйн гадна прокурор үүнийг нотлох боломжгүй гэж үзжээ. Харин энэ мөнгөнөөс өндөр үнэтэй үл хөдлөх хөрөнгө, автомашин, хөөрөг зэргийг бодитой худалдан авсан байх тул хөрөнгийн үнийн дүн болох 1.518.375.400 төгрөгөөр хохирлын хэмжээг тооцох нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт «Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд ...эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ» гэсэн зарчимд нийцнэ гэж үзэв. Мөн анхан шатны шүүх Ч.Га-ийн газраа зарсан асуудлыг хууль бусаар хөрөнгөжсөн гэж

Дээр дурдсан дансан дахь мөнгө, түүгээр худалдаж авсан эд хөрөнгүүд нь У.Чи-ийн нуугдмал эд хөрөнгө бус Ч.Га-ийн хууль бус хөрөнгө болох нь тогтоогдсон тул үүнд Татварын зарим хууль болон нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд заасан нууц баримтыг нотлох баримтаар ашиглах, эрүүгийн хэрэг үүсгэх, гүйцэтгэх ажиллагаа явуулахыг хориглосон зохицуулалт хамаарахгүй болно.

Д.Эн нь 592.835.500 төгрөгийн орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн, 50.041.300 төгрөгийн буюу онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн гэмт хэргийн талаар «1990 оноос эхлэн наймаа худалдаа хийсэн. 2002 онд «АБ» ХХК-ийн 150.000.000 төгрөгийн хөрөнгө оруулалттай байгуулсан, автомашины худалдаа эрхэлдэг, 2003 онд байр, оффис, 2004 онд зуслангийн сууц, 2006 онд үйлчилгээний талбай, 2007 онд өвөл зуны сууц худалдаж авсан, гар дээрээ 300.000.000 төгрөг, 100.000.000 төгрөгийн хадгаламж бүхий орлогын эх үүсвэртэй байсан. Олсон орлого, зарлага, тайлагнасан байдал, татвараас чөлөөлөгдөх орлого зэргийг шинжээч буруу шинжилсэн» гэсэн агуулга бүхий давж заалдах гомдол гаргажээ.

Авлигатай тэмцэх газрын хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсээс Д.Эн-ын 2007 оноос 2011 оны хөрөнгө орлогын мэдүүлгийг хянасан танилцуулга, хөрөнгө орлогын мэдүүлэг, татварын улсын

байцаагчийн дүгнэлт, шинжээчийн дүгнэлт болон 2011 оны 09, 2012 оны 09 дүгээр сард Д.Эн-ын 2 ширхэг «Лексус-570» загварын автомашиныг зарж өгсөн талаар гэрч Д.Га-ын мэдүүлэг /31-р хх 1/, 2012 онд Д.Эн АНУ-аас «Лексус-570» загварын автомашин захиж авчруулж байсан талаар гэрч С.Б-ийн мэдүүлэг /31-р хх 3/, 2012 онд Д.Эн-аас «Лексус-570» загварын автомашин худалдаж авсан талаар гэрч Б.Баб-ын мэдүүлэг /31-р хх 7/ зэргээр дээрх давж заалдах гомдол нь үгүйсгэгдэж байна.

Шүүх Ч.Га, Д.Эн нарын хууль бусаар олсон эд хөрөнгө, орлогыг Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн тайлбарт заасны дагуу гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлд тооцож улсын орлогод хурааж шийдвэрлэсэн. Үүний зэрэгцээ тэдний нэр дээр битүүмжилсэн хөрөнгийг төлөх төлбөрт тооцуулахаар Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлсэн нь гэр бүлийн гишүүдийн өмчлөх эрхийг хөндөөгүй бөгөөд шийдвэр гүйцэтгэлийн шатанд хамтран өмчлөх эрхийн асуудлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 94 дүгээр зүйлийн 94.4, 53 дугаар зүйлийн 53.7, Иргэний хуулийн 129 дүгээр зүйлд заасан зохицуулалтын хүрээнд өөрт ногдох хэсгийг гаргуулах замаар шийдвэрлэх боломжтой юм.

Шинжээчийн дүгнэлтэд Д.Эн-ын хувь хүний орлогын албан татварыг тооцоходоо банкны хүү, хадгаламжийн хүү, «ЖМ» ХХК-д олгосон зээлийн хүү, «Ю» Хадгаламж зээлийн хоршооны хүүгийн орлогыг оруулаагүй гэсэн байгааг дурдах нь зүйтэй. /36-р хх 40/

Ч.Га нь өөрийн төрсөн дүү Ч.Да-тэй үгсэн тохирч зохиомол мэдээллийг Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргын нэрээр буюу өөртөө гаргуулж, улмаар үүнийг үндэслэн албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Чингэлтэй дүүргийн татварын хэлтсээс «ХБЭ», «ЭрЭ», «БАЭ», «ХЭ», «ШЭ», «КЖЭМ» ХХК-иудад хийгдэж байсан төлөвлөгөөт татварын хяналт шалгалтын ажлыг зогсоон, өөрийн хэлтсийн байцаагчдаар шалгуулж, илтгэх хуудас, акт бичүүлсэн. Мөн Баянгол дүүргийн татварын хэлтсээс «НТГ», «УМ», «ЗУ» ХХК-иудын татвараа нуусан үйлдэлд нь дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлсэн байхад уг аж ахуйн нэгжүүдэд дахин шалгалт хийлгэж, «татварын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэлгүй» гэсэн илтгэх хуудас бичүүлсэн зэрэг үйлдлүүд нь Эрүүгийн

хуулийн 263 дугаар зүйлд заасан «Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах» гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй гэж үзэв.

Татварын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт «...татварын улсын байцаагчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно», мөн зүйлийн 30.1.14 дэх заалтад «татварын хууль тогтоомж зөрчсөн, эсхүл татвар нуусан буюу төлөхөөс зайлсхийсэн тухай өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авсан бол өөрөө шалгах, эсхүл шалгах ажлыг удирдан зохион байгуулах» гэж заасныг Ч.Га зөрчиж, дээрх хоёр тохиолдолд мэдээллийг өөрөө хүлээн авч, татварын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан нь албаны эрх мэдлээ урвуулан ашигласан болохыг харуулж байна.

Д.Эн нь Баянгол дүүргийн татварын хэлтсийн даргын албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж, татвараа нуусан аж ахуйн нэгжийг цагдаагийн байгууллагаар шалгаж, эцэслэн шийдвэрлээгүй байхад илт үндэслэл муутай татварын улсын байцаагчийн илтгэх хуудсыг үндэслэн татварын улсын байцаагчийн дүгнэлтийг хүчингүй болгосон үйлдлээрээ дээрх гэмт хэрэгт зохион байгуулагчаар хамтран оролцсон гэж үзэв. Татварын улсын байцаагчийн дүгнэлтийг хүчингүй болгох эсэх асуудлыг шийдвэрлэхэд Татварын ерөнхий хуулийн 36 дугаар зүйлийн 36.2 дахь хэсэгт заасны дагуу ажлын хэсэг томилон ажиллуулах боломж нээлттэй байхад зөвхөн илтгэх хуудсыг үндэслэн дүгнэлтийг хүчингүй болгосон нь албаны эрх мэдлээ урвуулан ашигласан гэм буруутай гэсэн дүгнэлт хийхэд хүргэж байна.

Ч.Да хуурамч мэдээлэл гарган дүүргийн татварын хэлтсийн хяналт шалгалтын ажлыг зогсоосон үйлдлээр энэ гэмт хэрэгт хатгагчаар хамтран оролцжээ. Түүний гаргасан мэдээллийн он, сар, өдөр, агуулга нь Чингэлтэй дүүргийн татварын хэлтсээс дээрх нэр бүхий компаниудад татварын хяналт шалгалт хийсэн хугацаа, үйл явц, томилолтгүй үндэслэлээр шалгалтыг зогсоосон шалтгаантай тохирч байгаа нь Ч.Да, Ч.Га нарыг үгсэн тохирсон болохыг харуулж байна. Төрийн албан хаагчийн албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэрэгт хамтран оролцсон этгээдийн хувьд заавал төрийн албан хаагч байхыг шаардахгүй болно.

Татварын ерөнхий газрын Хяналт

шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч П.Га, О.Бя, Н.Чи, Б.Өс, Б.Жр, Н.Ра нар Ч.Га-ийн олгосон томилолтын дагуу татварын хяналт шалгалт хийхдээ онц их хэмжээний татвараас зайлсхийсэн байхад Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6 дахь заалтад «... татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих ...» гэж заасны дагуу дүгнэлт бичиж, цагдаагийн байгууллагаар шалгуулахын оронд, илтгэх хуудас, акт бичсэн үйлдлээрээ «албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласан» гэмт хэрэгт гүйцэтгэгчээр хамтран оролцсон гэж үзэх үндэслэлтэй байна.

4. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт “Гэмт хэргийн улмаас нэр төр, алдар хүнд, санаа сэтгэл, бие эрхтэн, эд хөрөнгийн талаар хохирол хүлээсэн этгээдийг хохирогч гэнэ.” гэж заасан. Татварын улсын /ахлах/ байцаагчид албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэмт хэрэг үйлдсэний улмаас онц их хэмжээний татвар төлөгдөлгүй, улсын төсөвт хохирол учирсан байна. Үндэсний татварын алба нь Татварын ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалтад заасан “улс, орон нутгийн төсвийн орлогыг бүрдүүлэх” үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг учраас дээрх хэрэгт Татварын ерөнхий газрыг хохирогч байгууллагаар тогтоосон нь зөв болжээ. Татварын улсын байцаагчдын үйлдсэн гэмт хэргийн улмаас “ПВР”, “КЖЭМ” ХХК-иудад татвараас зайлсхийх боломж олгосон байх тул эдгээр компаниудад хуулийн дагуу нөхөн татвар, хүү, торгууль, алданги тооцож бүхэлд нь эрүүгийн хэргийн улмаас учирсан хохирол гэж үзсэн буруу биш байна.

Энэ хэрэгт шинжээчээр Чингэлтэй дүүргийн татварын улсын байцаагч нар болох О.Б, Ч.У, Ц.Б, С.О, Б.Б, С.Ба, Д.Бр, Д.Б, З.Э, Л.А, Б.Э болон Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.С, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч Н.Г, Мэргэжлийн хяналтын газрын Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.А нарыг томилж, тэдгээрт эрх, үүргийг нь тайлбарлаж, зориуд худал дүгнэлт гаргах, дүгнэлт гаргахаас хууль

бусаар татгалзах, зайлсхийх зэрэгт хүлээх хариуцлагыг урьдчилан сануулж гарын үсэг зуруулсан. /50-р хх 157/, Шинжээч томилсон тогтоол, дүгнэлттэй холбогдох хүмүүсийг танилцуулсан. /36-р хх 31-32, 50-р хх 158-161/, Шинжилгээ хийхэд шаардлагатай баримтуудыг гардуулан өгсөн /50-р хх 176-180, 187-190, 193-202, 214-220, 229-233, 236-242/ байх тул шинжилгээ явуулахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Шүүхийн шинжилгээний тухай хуулийг ноцтой зөрчсөн гэж үзэхээргүй байна. Шинжээчээр томилогдсон хүмүүс эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, энэ мэргэжлээр олон жил ажилласан дадлага туршлагатай, санхүү, нягтлан бодох бүртгэлийн болон татварын чиглэлээр мэргэшсэн, хохирогч, сэжигтэн, яллагдагчтай хувийн харилцаа холбоогүй болох нь шинжээчийн дүгнэлтийн удирдтгал хэсэг, болон шинжээчээр байцаасан тэмдэглэлээс тодорхой байна. Тэд өөрийн эзэмшсэн тусгай мэдлэгт тулгуурлан шинжилгээ явуулж дүгнэлт гаргасан бөгөөд хэн нэгнээс хараат байдлаар шинжилгээ хийсэн, эсхүл хэрэгт хувийн сонирхлоор хандсан гэх үндэслэл тогтоогдоогүй болно. Мөн татварын улсын байцаагчаар ажиллаж байгаа байдал нь хохирогч Татварын ерөнхий газартай ашиг сонирхол нэгтэй гэж шууд дүгнэх боломжгүй юм.

“ПС” ХХК буюу одоогийн нэрээр “ПВР” ХХК нь “НТГ”, “УМ”, “ЗУ” ХХК-иудаас хайгуулын тусгай зөвшөөрөл худалдан авсан болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогджээ. Өөрөөр хэлбэл, шинжээчийн дүгнэлтээс үзэхэд “ПС” ХХК нь дээрх тусгай зөвшөөрлүүдийг нягтлан бодох бүртгэлдээ биет бус хөрөнгөд, худалдан авсан анхны үнээр бүртгэсэн байгаа нь эрх борлуулсан болохыг нотолж байна. /36-р хх 35-36/ Мөн “ПС” ХХК-ийн зуучлагч гэх Г.Н-гийн “Би нилээн их хэмжээний ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг зуучлан “ПС” ХХК-д ...”ЗУ” ХХК-иудын тусгай зөвшөөрөл бүхий ашигт малтмалын лицензүүдийг худалдан борлуулж байсан... Миний хувьд уг аж ахуйн нэгжүүдийн лицензийг худалдан борлуулахдаа захирлуудтай нь үнэ ханшаа тохиролцоод мөнгийг нь янз янзаар авдаг. Ихэнхдээ бэлэн мөнгөний чекээр, мөн миний хувийн харилцах дансанд шилжүүлж өгдөг. Би лиценз худалдан авч буй аж ахуйн нэгжээс зуучлалын хөлс 10 хувь авдаг. Ингэж олон лиценз худалдан борлуулсан...” гэж

мэдүүлгээр дээрх компаниудын хооронд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан, борлуулах үйл ажиллагаа явагдсан болох нь тогтоогдсон болно. Иргэн Т.У 2008 оны 5 дугаар сарын 12-ны өдөр 1.000.000 төгрөгийн дүрмийн сантай, нэгж хувьцааны үнэ 1.000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1.000 ширхэг хувьцаатай “УМ”-ийг үүсгэн байгуулаад “ПС” ХХК-д худалдах гэрээ байгуулжээ. /3-р хх 10/ Гэтэл тус компани бодит байдал дээр байгуулагдсанаас хойш ямар нэгэн үйл ажиллагаа явуулаагүй, 1.000.000 төгрөгийн мөнгөн хөрөнгөөс өөр хөрөнгөгүй, хувьцааг нь «ПС» ХХК «1.000.000 төгрөгөөр худалдан авсан» /26-р хх 46/, эсхүл «2.300.000 ам.доллараар худалдан авсан» гэсэн хоёр өөр үнийн дүнтэй гэрээ байгуулсан зэрэг нөхцөл байдлыг «хувьцаа худалдах-худалдан авах» гэрээгээр халхавчилсан гэж үзэхээр байна.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэгт «Албан татвар төлөгчийн дараахь орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулна», мөн зүйлийн 17.2.7 дахь хэсэгт «эрх борлуулсны орлогод 30 хувиар» гэж, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсэгт «... 17.2.7 ...-д заасан орлогод ногдох албан татварын мөн хуулийн 4.1.6-д заасан суутгагч ногдуулан суутган авч, ажлын 7 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ» гэж тус тус заажээ. Хуулийн энэ зохицуулалтаас үзэхэд эрх борлуулсны орлогын албан татварыг тухайн ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг худалдан авсан тал буюу одоогийн нэрээр «ПВР» ХХК суутган төлөх үүрэг хүлээсэн гэж үзнэ.

Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад зааснаар «шилжүүлсэн орлого» гэж гэрээ, хэлцлийн үндсэн дээр хувь хүн, хуулийн этгээдээр гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийг тухайн этгээдэд өөрт нь буюу түүний хүсэлтээр бусад этгээдэд бэлэн бусаар шилжүүлснийг ойлгоно гэж заажээ. «БАЭ», «ХЭ» ХХК-иуд 2007-2009 онд зөвлөх үйлчилгээний төлбөрт гадаадад шилжүүлсэн орлогод албан татвар ногдуулан суутгаж төлөөгүй болох нь шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон болно.

Зөвлөх үйлчилгээ хилийн гадна явагдсан ч уг үйлчилгээ Монгол Улсаас эх үүсвэртэй, үр дүнг нь тус улсад хүртэх, үйлчилгээний хөлс Монгол Улсаас шилжүүлэгдсэн байгаа тул Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай

хуулийн 7 дугаар зүйлийн 7.4.9, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9-ийн г/ дэх заалтад заасан «Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үзүүлсэн үйлчилгээ»-нд хамаарч, татвар ногдохоор байна.

Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2. дахь хэсэгт «Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь эрэл, хайгуулын талаарх анхдагч материал, тайлан зэрэг мэдээллийг холбогдох хууль тогтоомжийн дагуу худалдаж зохих албан татвар төлсөн нь баримтаар нотлогдсон тохиолдолд түүний эзэмшилд байсан тусгай зөвшөөрлийг худалдан авагчид нь шилжүүлж болно» гэж заасан. Хуулийн энэ зохицуулалтаас үзэхэд мэдээлэл худалдан авснаар тусгай зөвшөөрөл нь дагаж шилжих бөгөөд тус тусдаа хэрэгжих боломжгүй, салгаж үл болох зүйлүүд байна. Иймээс агуулгаар нь эрх борлуулсан ойлголтод хамааруулж үзнэ.

Дээрх нэр бүхий аж ахуйн нэгжүүдэд хуулиар нөхөн татвар, хүү, торгууль, алданги төлөх үүрэг үүссэн бөгөөд энэ хохирлыг татвар ногдуулан, суутган төлөх үүрэг хүлээсэн «ПВР» ХХК, «КЖЖЭМ» ХХК хариуцах нь шинжээчийн дүгнэлт, мэдүүлгээр

тогтоогдсон тул тус компаниудыг иргэний хариуцагчаар татаж, төлбөр гаргуулан шийдвэрлэсэн нь хууль зөрчөөгүй байна.

Шүүх энэ хэргийг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчөөгүй, шүүгдэгчийн биечлэн эдлэх ялыг хөнгөн ялыг хүндэд багтаах, заримыг нэмж нэгтэх замаар тогтоосон, зарим шүүгдэгчийг анх удаа гэмт хэрэг үйлдсэн, хувийн байдлыг харгалзан оногдуулсан хорих ялыг тэнссэн, гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйлийг хурааж улсын орлого болгосон зэрэг нь үндэслэлтэй, зөв гэж үзэв.

Иймд Б.Жа-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон, түүнийг цагаатгаж, Ч.Га-ийн хууль бусаар хөрөнгөжсөн хэмжээг 1.493.315.400 төгрөгөөр тогтоон, энэ талаар шийтгэх тогтоолд зохих өөрчлөлт оруулж, «хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгах, нэмэлт мөрдөн байцаалтад буцаах, иргэний хариуцагчаар төлбөр төлүүлэхээр шийдвэрлэсэн хэсгийг хүчингүй болгох» талаар ялтан, тэдгээрийн өмгөөлөгч, иргэний хариуцагчдын гаргасан давж заалдах гомдлуудыг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 10 сарын 31 өдөр

Дугаар 385

Улаанбаатар хот

Ч.Га, Ч.Да, Д.Эн, Б.Бу, Н.Ра, П.Га, О.Бя, Б.Жр, Н.Чи, Б.Өс, Х.Ха, Б.Жал,
Б.Жа нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн Танхимын тэргүүн С.Нямжав даргалж, шүүгч Б.Батцэрэн, Т.Уранцэцэг, Б.Цогт, Д.Эрдэнэбалсүрэн нарын бүрэлдэхүүнтэй,

Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор Д.Нарангэрэл, ялтан Ч.Га-ийн өмгөөлөгч Г.Оюунцэцэг, А.Ундрах, ялтан Д.Эн-ын өмгөөлөгч Х.Баасанжаргал, ялтан Ч.Да-гийн өмгөөлөгч С.Оюунцэцэг, Ц.Гансүх, ялтан О.Бя, түүний өмгөөлөгч Г.Мөнхбат, ялтан Н.Ра, түүний өмгөөлөгч Ж.Батзориг, ялтан Б.Өс, түүний өмгөөлөгч Б.Цэнгүүн, ялтан Н.Чи, түүний өмгөөлөгч Х.Цогтсайхан, ялтан Б.Жр, түүний өмгөөлөгч К.Бауржан, Б.Ганбаатар, ялтан Б.Жа, түүний өмгөөлөгч Ш.Энхмаа, ялтан П.Га, түүний өмгөөлөгч Д.Батбаяр, иргэний хариуцагч «ПВР» ХХК-ийн төлөөлөгч М.Ня, өмгөөлөгч Ц.Цэрэнжээ, иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-ийн төлөөлөгч Г.З, Б.Б, Б.Жалы өмгөөлөгч Б.Энхтуяа, нарийн бичгийн дарга Б.Дүүрэнжаргал нарыг оролцуулж хийсэн хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 261 дүгээр шийтгэх тогтоол, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 436 дугаар магадлалтай, Ч.Га нарт холбогдох эрүүгийн 21130065 дугаартай хэргийг Улсын ерөнхий прокурорын эсэргүүцэл, ялтан Ч.Га, түүний өмгөөлөгч Г.Оюунцэцэг, А.Ундрах, ялтан Д.Эн, түүний өмгөөлөгч Х.Баасанжаргал, ялтан П.Га, Н.Ра, тэдний өмгөөлөгч Ж.Батзоригт, ялтан Б.Өс, түүний өмгөөлөгч Б.Цэнгүүн, ялтан Н.Чи, түүний өмгөөлөгч Х.Цогтсайхан, ялтан Б.Жр, түүний өмгөөлөгч К.Бауиржан, ялтан О.Бя, түүний өмгөөлөгч Г.Мөнхбат, ялтан Ч.Да-гийн өмгөөлөгч С.Оюунцэцэг, Ц.Гансүх, иргэний хариуцагч «ПВР» ХХК-ийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээ, иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Б нарын гаргасан гомдлыг үндэслэн, 2014 оны 08 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авч, шүүгч

Б.Цогтын илтгэснээр хянан хэлэлцэв.

1. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, охин, хүү, зээ нарын хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суудаг, Баянзүрх дүүргийн ... дугаар хороо, ...тоотод оршин суух бүртгэлтэй, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, Ө овогт Ч.Га.

2. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, Баянгол дүүргийн татварын хэлтсийн даргаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр ...хүүхдийн хамт Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, Д овогт Д.Эн.

3. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтэст татварын улсын ахлах байцаагч ажилтай, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, Х овогт Б.Бу.

4. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, Шүүх шинжилгээний Үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний хэлтсийн даргаар ажиллаж байсан, ам бүл ..., эцэг, нөхөр, охин, зээ нарын хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, С овогт Б.Жа.

5. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Баянгол дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, хэрэг

хариуцах чадвартай, Б овогт П.Га.

6. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч, эдийн засагч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр хүүхдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, У овогт Н.Ра

7. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, барилгын инженер-эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., хүүхдийн хамт Баянгол дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, Г овогт Б.Өс.

8. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, С... овогт Н.Чи.

9. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., нөхөр, хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, О... овогт Б.Жр.

10. Монгол улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч-эдийн засагч мэргэжилтэй, Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтэст татварын улсын байцаагчаар ажиллаж байсан, ам бүл ..., хүүхдийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, ...овогт О.Бя.

11. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, «СА» ХХК-ийн ерөнхий захирал ажилтай, ам бүл ..., эхнэр, ...хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, гавьяа шагнал,

ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, Ө овогт Ч.Да.

12. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч-эдийн засагч мэргэжилтэй, «ЭҮ» ХХК-нд ерөнхий нягтлан бодогчийн орлогчоор ажиллаж байсан, 2013 оны 07 дугаар сарын 19-нөөс өндөр насны тэтгэвэрт гарсан, ам бүл ..., нөхрийн хамт Орхон аймгийн ...сумын ...дүгээр байранд оршин суух, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, Т овогт Х.Ха.

13. Монгол Улсын иргэн, ...онд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч мэргэжилтэй, «ЭҮ» ХХК-ийн Ерөнхий захирлын эдийн засаг эрхэлсэн орлогчоор ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, гавьяа шагнал, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, И... овогт Б.Жал.

Холбогдсон хэргийн талаар:

Ч.Га нь Татварын ерөнхий газарт ирсэн мэдээллийн дагуу 2006 оны 5 дугаар сард «ВАТТ» ХХК-д татварын хяналт шалгалт хийлгэхдээ албан тушаалын байдлаа ашиглан өөрийн танил Ц.Со-оор дамжуулж «ВАТТ» ХХК-аас татварын улсын байцаагчийн актаар тавигдах нөхөн татвар, хүү торгуулийн хэмжээг багасгаж, хийх ёстой үйлдлээ хийхгүй байхаар амлаж, хясан боогдуулах замаар 250.000 доллар буюу 295.500.000 төгрөг нэхэж онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан,

2002 оны 2 дугаар сарын 15-наас 2013 оны 01 дүгээр сарыг хүртэлх хугацаанд Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа тухайн албан тушаалын цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа эцэг У.Ч-ийн нэрээр өөрөө хамтран эзэмшдэг 110302XXXX тоот америк долларын данс нээлгэж 2008 оны 7 дугаар сарын 16-наас 2012 оны 12 дугаар сарын 31-нийг хүртэлх хугацаанд 1.362.655 америк доллар буюу 1.771.358.017 төгрөгийн орлого, 1.207.415 америк доллар буюу 1.581.063.830 төгрөгийн зарлагын гүйлгээ,

Эцэг У.Ч-ийн нэрээр 110503xxxx тоот төгрөгийн данс нээлгэж 2010 оны 11 дүгээр сарын 12-ноос 2013 оны 01 дүгээр сарын 12-ныг хүртэлх хугацаанд 1.073.951.176 төгрөгийн орлого, 1.073.850.400 төгрөгийн зарлагын гүйлгээ хийж,

Уг мөнгөнөөс АНУ-д амьдрах хүү Г.Газ-д

их хэмжээний мөнгө шилжүүлж 2007 оны 12 дугаар сараас 2012 оны 07 сар хүртэлх хугацаанд 3 ширхэг «Лексус 570» маркийн машин, 2 ширхэг «Лексус 470» маркийн автомашин Монголд оруулж ирсэн, Монгол Улсад явж байсан «Ланд круйзер 200» маркийн 1 машин, нийт 635 сая төгрөгийн үнэ бүхий 6 автомашиныг эзэмших болсон, 2012 оны 10 дугаар сарын 21-нд Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 257,8 м2 талбай бүхий амины орон сууцыг автомашины гражийн хамт 825.375.400 төгрөгөөр худалдаж авсан,

2011, 2012 онд иргэн Д.От-аас 2 ширхэг шүрэн толгойтой манан хөөрөг нийт 58 сая төгрөгөөр худалдан авах зэргээр нийт 1.518.375.400 төгрөгийн эд хөрөнгийг олж хууль бусаар хөрөнгөжсөн,

ТЕГ-ын Татварын хяналт шалгалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын ахлах байцаагч Б.Бу Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст шилжүүлэх байсан «АФ» ХХК-нд 3.747.357.3 мянган төгрөгийн төлбөр ногдуулсан актыг шилжүүлээгүй дарагдуулсан байхад татварын улсын байцаагчийн акт, дүгнэлтийг холбогдох байгууллагад шилжүүлэх арга хэмжээг зохион байгуулж хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас Монгол Улсын төсөвт төвлөрөх байсан 3.747.357.3 мянган төгрөгийн онц их хэмжээний татварыг төлүүлээгүй албан үүрэгтээ хайнга хандсан,

Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргын албан тушаалын байдлаа урвуулж өөрийн төрсөн дүү Ч.Да-гээр 2010 оны 09 дүгээр сарын 27-нд татварын шалгалт хийлгэх тухай мэдээллийг Татварын Ерөнхий газарт гаргуулж улмаар өөрийн удирдлагад ажиллаж байсан татварын улсын байцаагч О.Бя, Б.Жа, Н.Чи, Б.Өс, Н.Ра, П.Га нараар «ХБЭ» ХХК, «ЭЭ» ХХК, «БАЭ» ХХК, «ХЭ» ХХК, «КЖЭМ» ХХК, «ШЭ» ХХК-иудын татварын ногдуулалт, төлөлтийн байдлыг шалгуулан илтгэх хуудас, акт гаргуулж 13.398.688.100 төгрөгийн татварыг ногдуулалгүй улсын төсөвт онц их хэмжээний хохирол учруулсан.

Баянгол дүүргийн Татварын хэлтсийн дарга Д.Эн-д 2010 оны 01 дүгээр сарын 19-нд 26/123 тоот албан бичгээр «НТГ», «УМ» ХХК, «ЗУ» ХХК-иудын албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд яаралтай шалгалт хийлгэх албан бичгийг хүргүүлж, татварын улсын байцаагч томилуулан шалгалт хийлгэж, дээрх нэр бүхий аж ахуйн нэгжүүд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл

худалдсан буюу эрх шилжүүлсэн орлогыг нуусан тул «НТГ» ХХК-ийн 6.974.495.000 төгрөгийн зөрчилд 2010 оны 02 дугаар сарын 25-нд 260006 тоот дүгнэлт,

“УМ” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан нар 2.786.273.500 төгрөгийн татвар ногдох орлогыг нуусан үйлдэлд 260007 тоот дүгнэлт,

“ЗУ” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан нар 975.852.500 төгрөгийн татвар ногдох орлогыг нуусан үйлдэлд 2010 оны 3 дугаар сарын 19-ний өдөр 260009 тоот дүгнэлтийг тус тус бичиж Эрүүгийн цагдаагийн газарт эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар хүргүүлсний дараа Ч.Га нь Үндэсний татварын албаны хяналт шалгалтын ажлын дүрмийн 2.3, 2.2.6-д заасан заалтуудын зөрчиж, татварын хяналт шалгалтын ажилд томилох томилолт бичих эрхгүй атлаа татварын улсын байцаагч Н.Ра, П.Га нарыг нэг нэгээр нь томилж “НТГ”, “УМ” ХХК-ийн татвар төлөлтийн байдлыг шалгуулж, дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагчийн бичсэн дүгнэлтийг үндэслэлгүй гэсэн илтгэх хуудас бичүүлж, Баянгол дүүргийн Татварын хэлтсийн дарга Д.Эн-д хүргүүлж, Д.Эн нь 2010 оны 5 дугаар сарын 7-нд 73 тоот тушаалаар 260006, 260007 тоот дүгнэлтүүдийг хүчингүй болгож “ПС” ХХК буюу одоогийн “ПВР” ХХК-ийн татварт төлөх ёстой 1.021.587.453 төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлэлгүй онц их хэмжээний хохирол учруулсан,

Б.Бу нь ТЕГ-ын Татварын хяналт шалгалтын удирдлага, арга зүйн газрын татварын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа «АФ» ХХК-ийн татварын ногдуулалт, төлөлтийг шалгасан татварын улсын байцаагч 2011 оны 7 дугаар сарын 8-ны өдрийн 9802034 тоот актаар 3.747.357.3 мянган төгрөгийн төлбөр ногдуулж, Татварын Ерөнхий газрын маргаан таслах зөвлөл 2011 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 45 тоот тогтоолоор уг актыг үндэслэлтэй шийдвэрлэж Чингэлтэй дүүргийн татварын хэлтэст шилжүүлсэн шийдвэрийг дарагдуулж, хууль тогтоомж, журмаар тодорхойлогдсон албан үүргээ биелүүлэлгүй татвар төлөгч нарт татвар төлөхөөс зайлсхийх боломж олгож, Монгол Улсын төсөвт төвлөрөх байсан 3.747.357.3 мянган төгрөгийн онц их хэмжээний татварыг төлүүлэлгүй албан үүрэгтээ хайнга хандсан,

Д.Эн нь Баянгол дүүргийн Татварын хэлтсийн даргаар ажиллаж мэдэл, албан

тушаалын байдлаа урвуулж Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн «НТГ» ХХК, «УМ» ХХК, «ЗУ» ХХК-иудын албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд яаралтай шалгалт хийх тухай 2010 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 26/123 дугаартай албан бичгийг үндэслэн татварын улсын байцаагч нараар дээрх компаниудад татварын хяналт шалгалт хийлгэж, шалгалтаар нэр бүхий аж ахуйн нэгжүүд ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдсан, эрх шилжүүлсэн орлогыг нуусан гэж үзэж 2010 оны 2 дугаар сарын 25-нд «НТГ» ХХК-нд 6.974.495.000 төгрөгийн зөрчилд 260006 тоот дүгнэлт,

“УМ” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан нар 2.786.273.500 төгрөгийн ногдох орлогыг нуусан үйлдэлд 260007 тоот дүгнэлт,

“ЗУ” ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан нар 975.852.500 төгрөгийн татвар ногдох орлогыг нуусан үйлдэлд 2010 оны 3 дугаар сарын 19-ний өдөр 260009 тоот дүгнэлт бичиж Эрүүгийн цагдаагийн газарт хүргүүлсэн байхад Ч.Га өөрийн удирдлагад ажилладаг

Рагчаахүү, П.Га нарыг нэг нэгээр нь томилж «НТГ», «УМ» ХХК-ийн татвар төлөлтийн байдлыг шалгуулж, татварын улсын байцаагчийн дүгнэлтийг үндэслэлгүй гэсэн илтгэх хуудас бичүүлж хүргүүлснийг үндэслэж Татварын Ерөнхий хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1-д заасны дагуу шийдвэрлэлгүй 2010 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 73 тоот тушаалаар татварын улсын байцаагчийн 260006, 260007 тоот дүгнэлтүүдийг хүчингүй болгож, 1.021.587.900 төгрөгийн,

“ЗУ” ХХК-д холбогдох 260009 тоот дүгнэлтийг 2010 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн 93 тоот тушаалаар хүчингүй болгож 197.780.800 төгрөгийн, давтан үйлдлээр нийт 219.368.700 төгрөгийг төсөвт төвлөрүүлэлгүй онц их хэмжээний хохирол учруулсан, Голомт банкны 170501xxxx тоот төгрөгийн хувийн харилцах дансаар 2012 оны 05 дугаар сарын 01-нээс он дуустал хугацаанд 53.900.000 төгрөгийн эх үүсвэр нь тодорхойгүй орлого олсон.

/2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 2.500.000 төгрөг, 2012 оны 05 дугаар сарын 21-ний өдөр төгрөг, 2012 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 5.000.000 төгрөг, 2012 оны 06 дугаар сарын 20-ны өдөр 7.000.000 төгрөг, 2012 оны 07 дугаар сарын 09-ний

өдөр 12.000.000 төгрөг, 2012 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр 22.000.000 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 04-ний өдөр 4.000.000 төгрөг/,

Голомт банкны 180129xxxx тоот ам.долларын хувийн харилцах дансаар 2012 оны 05 дугаар сарын 01-нээс он дуусах хүртэл хугацаанд 32.430 ам.долларын эх үүсвэр нь тодорхойгүй орлого /2012 оны 05 дугаар сарын 24-ний өдөр 330 ам доллар, 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 17.100 ам доллар, 2012 оны 11 дүгээр сарын 09-ний өдөр 8.000 ам доллар, 2012 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр 7.000 ам доллар буюу 45.113.500 төгрөг

“НК” ХХК-тай 2012 оны 05 дугаар сарын 23-ны өдөр “Орон сууцны захиалга, хөрөнгө оруулалт”-ын КС127313... тоот гэрээ хийж 493.822.000 төгрөгийн орон сууц худалдан авсан ба орлогын эх үүсвэр нь тодорхойгүй 592.835.500 төгрөгийн орлогыг хууль бусаар олж хөрөнгөжсөн,

2008 онд 19.000.000 төгрөг, 2009 онд 241.750.000 төгрөг, 2010 онд 9.851.000 төгрөг, 2011 онд 139.322.500 төгрөг, 2012 онд 90.489.600 төгрөг буюу нийт 500.413.100 төгрөгийн орлого олсон атлаа орлогоо татварт бүрэн тайлагнаагүй, татварт тайлагнах тоо хэмжээгээ зориуд бууруулж тайлагнан 50.041.300 төгрөгийн буюу онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн,

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн эдийн засгийн шинжилгээний хэлтсийн дарга Б.Жа нь цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа 2013 оны 02 дугаар сарын 08-нд хх-хх УНТ дугаартай «Лексус-470» маркийн автомашиныг 47.500.000 төгрөгөөр,

2013 оны 05 дугаар сарын 15-нд Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...зуслангийн зориулалттай байшинг газрын хамт 39.000.000 төгрөгөөр тус тус худалдан авч, хууль ёсны орлогоосоо гадна 86.500.000 төгрөгийн орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн,

Авлигатай тэмцэх газрын мөрдөн шалгах хэлтсийн мөрдөн байцаагчийн 2013 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн тогтоолын дагуу Д.Эн нь татвар ногдуулах орлого нуусан, татвар төлөхөөс зайлсхийсэн эсэх талаар 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн 164 дүгээр шинжээчийн дүгнэлтийг гаргахдаа санаатайгаар 34.638.200 төгрөгийг бууруулж, хүн амын орлогын албан татварт 15.403.100 төгрөг төлнө гэж санаатай худал дүгнэлт

гаргасан,

Татварын Ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн улсын байцаагч П.Га нь албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Ч.Га-ээс өгсөн томилолтын дагуу Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан «Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм»-ийн 2.2.6-д заасан «... хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш Татварын улсын /ахлах/ байцаагчийн бүрэлдэхүүнтэй багаар хийх» гэсэн заалтыг зөрчиж ганцаараа «УМ» ХХК-ийн татвар ногдуулалт төлөлтийн байдлыг хянан шалгахдаа уг компанийн эрх борлуулсан орлого 2.786.273.500 төгрөгийн зөрчилд Баянгол дүүргийн Татварын хэлтсийн улсын байцаагч Г.Бая, Ж.На нарын 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 260007 тоот дүгнэлтийг үндэслэлгүй гэж үзэж илтгэх хуудас бичиж, уг илтгэх хуудсыг хэлтсийн дарга Ч.Га нь баталгаажуулан Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-д хүргүүлж, Д.Эн нь 2010 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 73 тоот тушаалаар Татварын улсын байцаагчийн 260007 тоот дүгнэлтийг хүчингүй болгож «ПС» ХХК буюу «ПВР» ХХК-ийн төлөх ёстой 472.648.400 төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлэлгүй онц их хэмжээний хохирол учруулсан,

“КЖЭМ” ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд татварын улсын байцаагч Б.Жа, Б.Өс нарын хамт шалгалт хийхдээ уг компани нь 11.431.656.900 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад 2010 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр 10 дугаартай “Илтгэх хуудас” бичин Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу “...татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих” гэсэн заалтыг зөрчиж цагдаагийн байгууллагад шилжүүлэлгүй давтан үйлдлээр нийт 11.904.305.300 төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан,

Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт, Арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч Н.Ра нь албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Ч.Га-ийн бичсэн томилолтын дагуу

«Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм»-ийн 2.2.6-д заасан «...хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын /ахлах/ байцаагчийн бүрэлдэхүүнтэй багаар хийх» гэсэн заалтыг зөрчиж ганцаараа «НТГ» ХХК-нд татварын хяналт шалгалт хийхдээ тус компанид Баянгол дүүргийн татварын улсын байцаагч нар шалгалт хийгээд 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдөр 6.974.495.000 төгрөгийн зөрчилд 260006 дугаартай дүгнэлт бичсэн нь үндэслэлгүй гэж илтгэх хуудас бичиж, илтгэх хуудсыг Ч.Га баталгаажуулж Баянгол дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-д хүргүүлж, Д.Эн нь 2010 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 73 тоот тушаалаар Татварын улсын байцаагчийн 260006 тоот дүгнэлтийг хүчингүй болгож «ПС» ХХК буюу «ПВР» ХХК-ийн төлөх ёстой 548.939.500 төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлэлгүй онц их хэмжээний хохирол, «БАЭ» ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж тус компани нь 217.700.600 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу «... татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч Б.Өс нь албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан «Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм»-ийн 2.2.6 «...Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш Татварын улсын (ахлах) байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх» гэсэн заалтыг зөрчиж ганцаараа «ХБЭ» ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 489.998.900 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 7 дугаартай «илтгэх хуудас» бичсэн,

Татварын улсын байцаагч П.Га, Б.Жа нарын хамт «КЖЭМ» ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 11.431.656.900 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар

зүйлийн 33.2.6-д заасныг зөрчиж 2010 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр 10 дугаартай илтгэх хуудас бичиж, давтан үйлдлээр төсөвт 11.921.655.800 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан,

Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч Н.Чи нь албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Үндэсний Татварын Ерөнхий газрын даргын 2008 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 192 дугаартай тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан «Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм»-ийн 2.2.6-д заасан «...Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш татварын улсын (ахлах) байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх» гэсэн заалтыг зөрчиж ганцаараа «ХЭ» ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 896.964.100 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийснийг илрүүлсэн атлаа 2010 оны 11 дүгээр сарын 1-ийн өдөр 980020 дугаартай «Татварын улсын байцаагчийн акт» бичиж Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасны дагуу «...татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих» гэсэн заалтыг зөрчиж, дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлээгүйн улмаас төсөвт 896.964.100 төгрөг онц их хэмжээний хохирол учруулсан,

Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч Б.Жр нь албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж «Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм»-ийн 2.2.6-д заасан «...Хяналт шалгалтыг 2 ба түүнээс дээш Татварын улсын /ахлах/ байцаагчдын бүрэлдэхүүнтэй багаар хийх» гэсэн заалтыг зөрчиж ганцаараа «ШЭ» ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 46.900.800 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад 2010 оны 10 дугаар сарын 26-ны өдөр 6 дугаартай илтгэх хуудас бичсэн,

Татварын улсын байцаагч П.Га, Б.Өс нарын хамтаар «КЖЭМ» ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж 11.431.656.900 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн

байхад 2010 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр 10 дугаартай илтгэх хуудас бичиж Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасан «... татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих» гэсэн заалтыг зөрчиж давтан үйлдлээр төсөвт нийт 11.478.557.700 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан,

Татварын Ерөнхий газрын Хяналт шалгалт Арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч О.Бя нь албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж «Үндэсний Татварын албаны татварын хяналт шалгалтын ажлын дүрэм»-ийн 2.2.6-д заасныг зөрчиж ганцаараа «ЭЭ» ХХК-ийн 2005-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийн байдалд шалгалт хийж, 315.476.800 төгрөгийн татвар төлөхөөс зайлсхийсэн байхад 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдөр 8 дугаартай илтгэх хуудас бичиж Татварын Ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д заасан «...татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих» тухай заалтыг зөрчиж, дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлээгүйн улмаас төсөвт 315.476.800 төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан,

Ч.Да нь «ЭҮ» ХХК-ийн Ерөнхий захирлын эдийн засаг эрхэлсэн орлогчоор ажиллаж байсан Б.Жал, Ерөнхий нягтлан бодогчийн орлогч Х.Ха нартай бүлэглэн «СА» ХХК-ийн нэрээр ямар нэгэн сонгон шалгаруулалтгүйгээр 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр «ЭҮ» ХХК-ийн Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээний 5/426-11 дугаартай гэрээ байгуулж, тайлан гаргахдаа үйлчилгээний хөлсөнд 78.623.341 төгрөг авахаар байхад 626.120.000 төгрөгийг шилжүүлэн авч, 547.496.659 төгрөгийг илүү завшсан,

мөн Санхүүгийн сургалт явуулах боловсон хүчний боломжгүй хэрнээ 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдөр 5/336-12 дугаартай 48 сая төгрөгийн үнэ бүхий «ЭҮ» ХХК-ийн нягтлан бодогчдод нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлан бэлтгэлийн талаар

сургалт явуулах гэрээ байгуулж 38.400.000 төгрөгийг шилжүүлэн авсан боловч гэрээний үүргийг өөр аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлж, «ЭҮ» ХХК-тай байгуулсан гэрээний үнийн дүнгээс 20.400.000 төгрөгийг завшиж онц их хэмжээний хохирол учруулсан,

Төрсөн ах Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-тэй үгсэн тохиролцож, Чингэлтэй дүүргийн татварын хэлтсээс төлөвлөгөөнд тусгагдсан дагуу «КЖЭМ» ХХК болон хамаарал бүхий «ХБЭ» ХХК, «ЭЭ» ХХК, «БАЭ» ХХК, «ХЭ» ХХК, «ШЭ» ХХК-нд татварын шалгалт хийгдэж эхлэх үед буюу 2010 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Татварын ерөнхий газарт иргэн Р.Ба-ын нэрээр дээрх компаниудын татвар ногдуулалт төлөлтийн байдалд хяналт шалгалт хийлгүүлэх талаар хуурамч гомдол хүргүүлж, улмаар ах Ч.Га нь албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн байцаагч нарын хийж байсан шалгалтыг зогсоож, өөрийн удирдлагад ажилладаг татварын улсын байцаагч нараар дээрх нэр бүхий аж ахуйн нэгжүүдийн татвар ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийлгэж, 13.398.688.100 төгрөгийн татварыг төсөвт төвлөрүүлээгүй улмаас төсөвт онц их хэмжээний хохирол учруулсан,

Х.Ха нь «ЭҮ» ХХК-ийн Ерөнхий захирлын эдийн засаг эрхэлсэн орлогчоор ажиллаж байсан Б.Жал-тай бүлэглэн «СА» ХХК-ийн захирал Ч.Да-д давуу байдал олгон, албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 36, 37, 38 дугаар зүйлүүдийг зөрчиж, «СА» ХХК-тай 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр «ЭҮ» ХХК-ийн Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээний №5/426-11 дугаартай гэрээ байгуулж, гэрээний дагуу ажлын хөлсийг тооцон олгохдоо үндэслэлгүйгээр нэмэгдүүлж 547.496.659 төгрөг илүү олгосон,

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлан бэлтгэлтийн талаар сургалт явуулах боловсон хүчний боломжгүй «СА» Ххк-аар дээрх сургалтыг явуулахаар 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдөр №5/336-12 дугаартай 48.000.000 төгрөгийн төсөвт өртөгтэй гэрээг ямар нэгэн сонгон шалгаруулалтгүй шууд байгуулж, гэрээний урьдчилгаанд 38.400.000 төгрөгийг шилжүүлж 20.400.000 төгрөгийг завших

боломжийг олгож байгууллагын хөрөнгийг онц их хэмжээгээр үрэгдүүлсэн,

Б.Жал нь «ЭҮ» ХХК-ийн Ерөнхий нягтлан бодогчийн орлогч Х.Ха-тэй бүлэглэн «СА» ХХК-ийн захирал Ч.Да-д давуу байдал олгон, албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 36,37,38 дугаар зүйлүүдийг зөрчиж, «СА» ХХК-тай 2011 оны 12 дугаар сарын 15-ны өдөр «ЭҮ» ХХК-ийн Татварын үр ашигт байдлын зөвлөх үйлчилгээний 5/426-11 дугаартай гэрээг байгуулж, гэрээний дагуу ажлын хөлс олгохдоо үндэслэлгүйгээр 547.496.659 төгрөгийг илүү олгосон,

Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлан бэлтгэлийн талаар сургалт явуулах боловсон хүчний боломжгүй «СА» Ххк-аар дээрх сургалтыг явуулахаар 2012 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 5/336-12 дугаартай 48.000.000 төгрөгийн төсөвт өртөгтэй гэрээг ямар нэг сонгон шалгаруулалтгүй шууд байгуулж, гэрээний урьдчилгаанд 38.400.000 төгрөг шилжүүлж 20.400.000 төгрөг завших боломжийг олгож байгууллагын хөрөнгийг онц их хэмжээгээр үрэгдүүлсэн гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 261 дүгээр шийтгэх тогтоолоор «...Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар Ч.Га, Б.Бу нарт холбогдох Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан хэргийг,

Х.Ха, Б.Жал нарт холбогдох Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.2-т заасныг журамлан мөн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, 265 дугаар зүйлийн 265.2-д заасан хэргийг,

Ч.Да-д холбогдох Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан хэргийг хэрэгсэхгүй болгож, Б.Бу, Х.Ха, Б.Жал нарыг цагаатгаж,

Ч.Га-ийг албан тушаалын байдлаа ашиглан, албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байхаар урьдчилан амлаж, бусдаар дамжуулан онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан,

Хууль ёсны орлогоосоо гадна их их хэмжээгээр орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн,

Төрийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны

улмаас татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учирсан гэмт хэргийг зохион байгуулсан,

Д.Эн-ыг хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн,

Төрийн албан тушаалтан албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учирсан гэмт хэрэгт хамжигчаар хамтран оролцсон,

Татвар ногдох онц их хэмжээний орлого, эд хөрөнгө нууж татвар төлөхөөс зайлсхийсэн,

Б.Жа-ыг хууль ёсны орлогоосоо гадна их хэмжээгээр орлого олж хууль бусаар хөрөнгөжсөн,

Мөрдөн байцаалтад шинжээчийн дүгнэлтийг зориуд худал гаргасны улмаас хүнд хор уршиг учирсан,

П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жа, О.Бя нарыг албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учирсан гэмт хэрэгт гүйцэтгэгчээр хамтран оролцсон,

Ч.Да-г албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласны улмаас татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учирсан гэмт хэрэгт хатгагчаар хамтран оролцсон гэм буруутайд тус тус тооцож,

Ч.Га-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.1, 60 дугаар зүйлийн 60.3-т заасныг журамлан 268 дугаар зүйлийн 268.2-т зааснаар 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 3 жил 4 сар хорих ял,

Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-т зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жил хасаж, 7 жил 6 сар хорих ял,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 5 жил хасаж, 5 жил хорих ял,

Д.Эн-д Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-т зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жил хасаж 7 жил 6 сар хорих ял,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 5 жил хасаж 5 жил хорих ял,

Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2-д зааснаар 50.000.000 төгрөгийн эд

хөрөнгө хурааж, 7 жил 6 сар хорих ял,

Б.Жа-ыг Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-т зааснаар эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 260 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 36.504.000 төгрөгөөр торгох ял,

Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 254.2-т зааснаар хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин нэмэгдүүлсэн хэмжээний буюу 21.060.000 төгрөгөөр торгох ял,

П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя нарт Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар татварын улсын байцаагч хийх эрхийг 3 жил хасаж, 3 жил хорих ял,

Ч.Да-д Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.4-д заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар аудитор хийх эрхийг 3 жил хасаж, 3 жил хорих ял тус тус шийтгэж,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1-д зааснаар Ч.Га-д Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-т зааснаар оногдуулсан татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жил хасаж, 7 жил 6 сар хорих ялд Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар оногдуулсан татварын улсын байцаагч хийх эрхийг 5 жил хасаж, 5 жил хорих ялыг багтааж, Эрүүгийн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 60 дугаар зүйлийн 60.3-т заасныг журамлан 268 дугаар зүйлийн 268.2-т зааснаар оногдуулсан 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 3 жил 4 сар хорих ялын зарим болох 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 6 сар хорих ялыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх ялыг 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жил хасаж, 8 жил хорих ял,

Д.Эн-д Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2-т зааснаар ногдуулсан 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, 7 жил 6 сар хорих ялд Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.5-д заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар оногдуулсан татварын улсын байцаагч хийх эрхийг 5 жил хасаж, 5 жил хорих ялыг багтааж, Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-т зааснаар оногдуулсан татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жил хасаж, 7 жил 6 сар хорих ялын зарим болох 6 сарыг нэмж нэгтгэн, түүний биечлэн эдлэх ялыг 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж,

татварын улсын байцаагч хийх эрхийг 8 жил хасаж, 8 жил хорих ял,

Б.Жа-д Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-т зааснаар оногдуулсан эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сар хасаж, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 260 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний буюу 36.504.000 төгрөгөөр торгох ялд Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 254.2-т зааснаар оногдуулсан 21.060.000 төгрөгөөр торгох ялыг багтааж, түүний биечлэн эдлэх ялыг эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сар хасаж, 36.504.000 төгрөгөөр торгох ялаар тус тус тогтоож,

Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.6-д зааснаар Ч.Га, Д.Эн нарт оногдуулсан хорих ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид,

Эрүүгийн хуулийн 52 дугаар зүйлийн 52.5-д зааснаар Н.Ра, П.Га, Н.Чи, Ч.Да нарт оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид,

Б.Өс, Б.Жр, О.Бя нарт оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлэх,

Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.3-т зааснаар Ч.Га-ийн цагдан хоригдсон 391 хоног, Д.Эн-ын цагдан хоригдсон 388 хоног, О.Бя-гийн цагдан хоригдсон 55 хоног, Ч.Да-гийн цагдан хоригдсон 139 хоногийг тэдний хорих ял эдэлсэн хугацаанд оруулан тооцож,

Б.Жа-ын цагдан хоригдсон 150 хоногийг ял эдэлсэнд оруулан тооцож, торгох ялаас 28.800.000 төгрөгийг хасаж, 7.704.000 төгрөгөөр торгох ялаар тогтоож, торгох ялаас ноцтой зайлсхийвэл шүүх уг ялыг хорих ялаар солихыг сануулж,

Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар Ч.Га-ээс 2.845.309.193 төгрөг, Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4-т зааснаар П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя нарт оногдуулсан 3 жил хорих ялыг тэнсэж, тус бүрийг мөн хугацаагаар хянан харгалзаж,

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д зааснаар иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-аас 13.445.598.900 төгрөг, "ППС" ХХК-аас 1.219.368.700 төгрөг, Д.Эн-аас 50.041.300 төгрөг тус тус гаргуулж Татварын ерөнхий газарт олгож, тус газрын нэхэмжлэлээс "АФ" ХХК-нд холбогдох 3.747.357.300 төгрөгийг хэрэгсэхгүй болгож,

Хэрэгт эд мөрийн баримтаар ирүүлсэн Ч.Га-ийн 2 ширхэг хөөрөг, мөрдөн

байцаагчийн тогтоолоор битүүмжилсэн Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоот 257,8 м.кв талбайтай амины орон сууц, Баянзүрх дүүрэг ...дугаар хороо, ..., ...тоот орон сууц, Голомт банк дахь ам долларын 110302XXXX, төгрөгийн 110503xxxx, 120120xxxx тоот хадгаламж дахь мөнгө, Лексус-570 маркийн 3 автомашин, Лексус-470 маркийн 2 автомашин, Ланд круйзер-200 маркийн 1 автомашин,

Д.Эн-ын Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо ...тоот орон сууц, Баянгол дүүргийн ...дугаар хороо ...байрлалтай, үйлчилгээний барилга газрын хамт, Хан-Уул дүүрэгт байрлалтай, ...178,9 м.кв талбай бүхий ...тоот орон сууц, 2008 онд үйлдвэрлэгдсэн хх-хх УБҮ дугаартай Соната-6 маркийн хар өнгийн автомашин,

Б.Жа-ын хх-хх УНТ дугаартай Лексус 470 маркийн автомашин, Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...байрлах зуслангийн хашаа байшинг тус тус төлбөрт тооцуулахаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжүүлж,

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.10-т зааснаар Ч.Да-гийн «СА» ХХК-ийн өмчлөлийн Сүхбаатар дүүргийн ...дугаар хороо ..., ..., ...тоот ажлын байр,

Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ... тоот орон сууц, зоорийн давхрын 117, 118 тоот зогсоол,

Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоот орон сууц,

Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо ...тоот зогсоол,

Б.Жал-ын Орхон аймгийн ...сум, ...тоот орон сууцыг битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгож,

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар хавсаргасан «КЖЭМ» ХХК-нд татварын хяналт шалгалт хийсэн ажлын баримт 16 хавтас, шинжээч нарын ажлын баримт 3 хавтас, дансны хуулга 2 хавтас, нийт 21 хавтас баримтыг хэргийг хадгалах хугацаа дуустал хэрэгт үлдээж,

Б.Бу, Х.Ха, Б.Жал нарын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож, шүүх хуралдааны танхимаас суллаж,

Ч.Да-гийн батлан даалтад өгсөн таслан сэргийлэх арга хэмжээг өөрчлөн цагдан хорьж, Ч.Га, Д.Эн нарын цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлж, П.Га, Н.Ра, Б.Өс, Н.Чи, Б.Жр, О.Бя нарын

батлан даалтад өгсөн таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүх 2014 оны 05 дугаар сарын 19-ний өдөр хэлэлцээд 436 дугаар магадлалаар «... шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт «Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1, 208 дугаар зүйлийн 208.1.2-д зааснаар Б.Жа-д холбогдох Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 254.2, 270¹ дүгээр зүйлийн 270¹.2-д заасан гэмт хэргийг тус тус хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгасугай” гэсэн нэмэлт оруулж, тогтоох хэсгийн 7 дахь заалтын “Эрүүгийн хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.3-т заасныг баримтлан Б.Жа-ын цагдан хоригдсон 150 хоногийг ял эдэлсэнд оруулан тооцож, торгох ялаас 28.800.000 төгрөгийг хасаж, түүний биечлэн эдлэх ялыг эдийн засгийн шинжээч хийх эрхийг 5 жил 6 сар хасаж, 7.704.000 төгрөгөөр торгох ялаар тогтоосугай” гэснийг “Б.Жа 150 хоног цагдан хоригдсон болохыг дурдсугай” гэж өөрчилж, “Б.Жа-д холбогдох бусад заалтыг хүчингүй болгож” шийдвэрлэжээ.

Хяналтын шатны шүүхэд ялтан Ч.Га 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдөр гаргасан гомдолд «... миний бие хоёр шатны шүүхийн тогтоол магадлал нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.2.3-т заасны дагуу хуулийн бүх шаардлагад нийцэн хуульд үндэслэж гараагүй учир хууль ёсны болж чадаагүйгээс гадна мөн хуулийн 284 дүгээр зүйлийн 284.3-т заасны дагуу шүүхэд гаргасан нотлох баримтыг шүүх хуралдаанд тал бүрээс нь бүрэн бодитой шинжилсний үндсэн дээр гараагүй учир үндэслэл бүхий болж чадаагүй гэж үзэж байна. Мөрдөн байцаалтын явцад шинжээч нарыг томилон дүгнэлт гаргуулахдаа Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч, комиссар, шинжээч нар Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шинжилгээний тухай хууль зэргийг зөрчсөн бөгөөд шинжээч нар бусдаас хараат байдлаар ажиллах, өөрсдөөр нь хуулиар олгогдоогүй бүрэн эрхийг хэрэгжүүлэх, мөрдөгдөж буй хууль тогтоомж, журмыг санаатайгаар зөрчин буцаан хэрэглэх, хууль, дүрмийн зүйл, хэсгийг худал тайлбарлах, хяналт шалгалтанд хамрагдаагүй хугацааг дүгнэлтдээ оруулах, томилогдоогүй байхдаа шинжээчээр ажиллах, аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулсан гэрээг

өөрсдийн санаан зоргоор ургуулан бодож дүгнэх, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч бус татвар төлөгчид татвар, хүү, торгууль, алданги тооцох, аж ахуйн нэгжийн орлогын болон нэмэгдсэн өртгийн албан татварыг бусдаас авсан зээлийн өглөгт ногдуулах зэргээр татвар төлөгчид болон миний, Татварын улсын байцаагчдын эрх зүйн байдлыг дордуулан илт гүтгэсэн хууль бус дүгнэлтүүдийг гаргасан. Татварын ерөнхий газрын харьяа улсын төсөв орлого хяналтын газарт Эрдэс баялгийн хэлтэс 2011 онд байгуулагдан, Монгол Улсын Сангийн сайд, Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын 2011 оны 12 дугаар сарын 20-ны 254/286 дугаар хамтарсан тушаалаар «Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын газрын хооронд мэдээлэл солилцох журам» батлагдан 2012 оны 01 дүгээр сарын 01-нээс мөрдөгдөн, мөн өдрөөс ашигт малтмалын тусгай зөвшөөрөл шилжүүлэхэд 30 хувийн татварыг суутган авдаг болсон. Үүнээс өмнө Мэдээлэл солилцох гэрээнд заасан үнээс 10 хувийн татвар авдаг байсан. Энэ талаар «ЭрЭ» ХХК-д шинжилгээ хийсэн шинжээч нар дүгнэлтдээ бичиж, мөрдөн байцаалтад мэдүүлсэн. Гэтэл үүнийг буцаан хэрэглэсэн. Анхан болон давж заалдах шатны шүүх дээр дурдсан тайлбар, үндэслэлүүдийг харгалзан үзэлгүй хэрэгт авагдсан нотлох баримтуудад бодитой дүгнэлт хийлгүй надад үндэслэлгүйгээр ял шийтгэл оногдуулсан, хууль ёсны болон үндэслэл бүхий болж чадаагүй гэж үзэж, туйлын гомдолтой байгаа тул хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж өгнө үү» гэжээ.

Мөн шүүхэд ялтан Д.Эн-ын 2014 оны 07 дугаар сарын 08-ны өдөр гаргасан гомдолд “... шинжээчийн дүгнэлтүүд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 79 дүгээр зүйлийн 79.4, 155 дугаар зүйлд заасны дагуу нотлох чадвараа алдсан бөгөөд шүүх шийдвэрийн үндэслэл болсон нь хууль зүйн үндэслэлгүй. Нотлох баримтыг тал бүрээс нь бүрэн бодитой үнэлээгүй. Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270¹.2-т заасан гэмт хэргийн тухайд эх үүсвэр нь тодорхойгүй орлогоо “НК” ХХК-аас 493 сая төгрөгийн орон сууц, хадгаламждаа 53.9 сая төгрөг, 32.430 ам.доллларын орлого тушаасан нь миний 2012 оны 05 дугаар сарын 01-нээс өмнөх орлого, эд хөрөнгийг баримтаар нотлогдож байхад үнэлээгүй. Дээрх эх үүсвэр нь тодорхойгүй орлого нь бүгд баримтаар нотлогдож байгаа болно. Эрүүгийн хуулийн

263 дугаар зүйлийн 263.2-д заасан хэргийн хувьд миний бие нэр бүхий 3 компанид холбогдох татварын улсын байцаагчийн дүгнэлтүүдийг хэрэгсэхгүй болгоходоо өөрт олгогдсон эрх хэмжээнийхээ хүрээнд Улсын мөрдөн байцаах газрын мөрдөн байцаагч дэслэгч Б-ын эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах санал, Нийслэлийн прокурор С.Х-ын 2010 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тогтоол, Улсын татварын ерөнхий газрын Хяналт шалгалт арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагчийн 1, 2 дугаар дүгнэлтүүдийг тушаалын тэмдэглэх хэсэгт дурдаж, дээрх эрх бүхий албан тушаалтнуудын нэгэн адил шийдвэр гаргасан байхад зөвхөн намайг гэм буруутайд тооцсон нь хууль зүйн үндэслэлгүй. Иймд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгож, надад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, төрийн өмчлөлд хураан авсан 592.8 сая төгрөгийн эд хөрөнгийг буцаан олгож өгнө үү” гэжээ.

Мөн шүүхэд Улсын ерөнхий прокурор Д.Дорлигжавын 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 1 дугаартай эсэргүүцэлд “... Б. Жа нь Сонгинохайрхан дүүргийн ... дугаар хороо ...зусланд байрлалтай зуслангийн зориулалттай 8х9 хэмжээтэй 38-н тоосгон ханатай байшинг «ОС» Үл хөдлөх хөрөнгө зуучлалын компаниас 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдөр нийт 39.000.000 төгрөгөөр худалдаж авсан атлаа «хөрөнгө орлогын мэдүүлэг»-тээ мэдүүлээгүй болох нь түүний хөрөнгө орлогын мэдүүлгээр тогтоогдсон ба дээрх үл хөдлөх хөрөнгийг өөрийн нэр дээр шилжүүлж улсын бүртгэлд бүртгүүлээгүй байна. Хэрэв Б.Жа нь өөрийн болон гэр бүлийн орлогоосоо дээрх зуслангийн байшинг авсан бол хөрөнгө орлогын мэдүүлэгтээ мэдүүлж, өмчлөгчөөр бүртгүүлэх боломжтой байсан. А.Баб нь дээрх автомашиныг өөрийн орлогоосоо авсан гэж мэдүүлж байгаа боловч автомашин авах хэмжээний мөнгөн хуримтлал байсан гэдгээ баримтаар нотолж чадаагүй юм. А.Баб хүргэн н.Бо-тайгаа явж худалдан авсан атлаа гэр бүлийн гишүүдийн нэр дээр бус хамаатны хөгшин Ү.Сэ-гийн нэр дээр авсан зэрэг нь Б. Жа-ыг дээрх автомашиныг хууль бус орлогоосоо авсан түүнийг халхавчлахын тулд тээврийн хэрэгслийн гэрчилгээг бусдын нэр дээр гаргуулсан гэх үндэслэл болж байна. Шүүхийн шинжилгээний Үндэсний

хүрээлэнгийн эдийн засгийн шинжилгээний хэлтсийн шинжээч нарын албан тасалгаанд хийсэн нэгжлэгээр Б.Жа 2013 оны 08 дугаар сарын 7-ны өдөр Д.Эн-ын татвар ногдох орлогыг тооцоходоо 190.544.100 төгрөг тайлагнаагүй гэж дүгнэж байсан баримт илэрч, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан. Гэтэл Б.Жа 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдөр Д.Эн нь татвар ногдуулах 154.031.100 төгрөг тайлагнаагүй гэсэн шинжээчийн 164 тоот дүгнэлтийг гаргаж Авлигатай тэмцэх газарт хүргүүлсэн байдаг. Б.Жа нь дүгнэлт гаргахдаа татварын тооцоолол гэх зүйлийг огт хийгээгүй, дүгнэлтээ хэрхэн гаргасан нь тодорхой бус, Д.Эн-ын орлогыг 34.638.200 төгрөгөөр бууруулсан нь хэргийн зүйлчлэлд шууд нөлөөлж, Д.Эн-ын нуусан татвар ногдох орлого их хэмжээнд хүрэхгүй учир татвараас зайлсхийсэн хэргийн хариуцлагаас чөлөөлөгдөхөд хүргэж байна. Дээрх үр дагавар нь Б.Жа-ыг санаатай худал дүгнэлт гаргасан гэж үзэх хангалттай үндэслэл болно. Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүх Д.Эн-ын нуун дарагдуулсан татвар ногдох орлого нь Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2-т заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй гээд ял шийтгэл оногдуулсан атлаа дээрх дүгнэлтийг гаргасан Б.Жа-ыг цагаатгасан нь үндэслэлгүй юм. Иймд давж заалдах шатны шүүхийн магадлалыг хүчингүй болгуулахаар Мөн шүүхэд ялтан Ч.Га-ийн өмгөөлөгч Г. Оюунцэцэг 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа «... Анхан шатны шүүх Ч.Га нарт холбогдох эрүүгийн хэргээс Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйл 272.2-д заасан хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгосон нь хууль зүйн үндэслэлтэй. Бусад зүйл ангийг эс зөвшөөрч гомдол гаргасан. Шүүх шүүхэд гаргасан нотлох баримтуудыг үнэлж хууль ёсны дүгнэлт хийгээгүйд гомдолтой байна. Иймд шүүхийн шийтгэх тогтоолыг хууль зүйн үндэслэлгүй гэж үзэж байна. Ч.Га-ийг Татварын ерөнхий газарт ирсэн мэдээллийн дагуу 2006 оны 5 дугаар сард «ВАТТ» ХХК-д татварын хяналт шалгалт хийлгэж байх хугацаандаа албан тушаал эрх мэдлээ ашиглан Ц.Со-оор дамжуулан тус компаниас татварын улсын байцаагчийн актаар тавигдах нөхөн татвар, хүү, торгуулийг багасган онц их хэмжээний хээл хахууль авах

гэж завдсан гэж үздэг. Ч.Га-ийг Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргын үүрэгт ажлаас үндэслэлгүй чөлөөлсний улмаас 2005 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс 2006 оны 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл уг албан тушаалыг эрхлээгүй. Монгол Улсын Дээд Шүүхийн тогтоолоор Ч.Га үүрэгт ажилдаа буцаан томилогдсон байдаг. Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргын үүрэг гүйцэтгэж байсан Ч.Эн 2006 оны 2 дугаар сарын 6-ны өдрөөс «ВАТТ» ХХК-д 85 хоногийн хяналт шалгалт хийлгэхээр «Татварын хяналт шалгалт хийх томилолт»-ын дагуу 2 татварын улсын байцаагчийг томилсон байдаг. Ч.Эн зөрчлийн жагсаалт, төлбөрийн тооцоог урьдчилсан байдлаар гарган Татварын ерөнхий газрын дэд дарга Ж.Бая-ад танилцуулж байсан нь нотлогддог. Байцаагч нарт хяналт шалгалтаа үргэлжлүүлэх чиглэлийг Ч.Га-ийг ажилд орохоос өмнө өгсөн байсныг анхаарч үзнэ үү. Ч.Га-ийг ажилдаа орсны дараа «ВАТТ» ХХК-ийн татварын зөрчлийн хэмжээ 10.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн. Улсын мөрдөн байцаах газраас 2006-2007 онуудад Г.Байг -гаас Ч.Га хээл хахууль нэхсэн гэж Авлигатай тэмцэх газар, мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлгүүд хоорондоо зөрдөг. Анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т зааснаар “Эрүүгийн хэрэгт хамааралтай нотлох баримтыг шалгасан боловч хэргийн холбогдогчийг гэм буруутай эсэхэд эргэлзээ төрвөл түүнд ашигтайгаар шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчсөн. Хууль бусаар хөрөнгөжсөн үйлдлийг 2012 оны 05 дугаар сарын 01-нээс шинээр гэмт хэрэгт тооцсон. Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүх нь Эрүүгийн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 12 дугаар зүйлийн 12.1, 12.2-т заасныг зөрчин ялтны эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэсэн. Ч.Га цалингаас өөр орлогын эх үүсвэртэй байсан. Хөрөнгө орлогын мэдүүлэгтээ байнга мэдүүлж байсан. Түүний эхнэр охин хоёр гадаад улсад урт хугацаагаар амьдарч, хөдөлмөрлөж байсан нь нотлогддог. Монгол улсын татварын зарим хууль болон, нийгмийн даатгалын хуулийг хэрэгжүүлэх хууль батлагдсантай холбогдуулан Ч.Га, Ч.Да-гийн хамт хөрөнгөө ил болгосон. Энэ хуульд зааснаар эрүүгийн хэрэг үүсгэх, гүйцэтгэх ажил явуулахыг хориглоно, тайланд тусгагдсан албан татвар ногдох орлого,

орлогоос бусад албан татвар ногдох эд зүйлийн эх үүсвэр, хэмжээ, үнэ өртгийг нууцлах бөгөөд нотлох баримт болгон ашиглахыг хориглоно гэж заасныг зөрчиж эрүүгийн хэрэгт хавсарган нотлох баримт болгон ашиглаж байгаад гомдолтой байна. Ч.Га-ийн эцэг У.Чи 80 гаран настай хөрөнгийн талаар хуулийн хүрээнд тайлбар өгөхөөс татгалзсан. Ч.Га нь эцэг У.Чи-ийн нэр дээр байдаг төгрөгийн болог ам долларын дансыг л зөвхөн хамтран эзэмшдэг. Ч.Га улсад 30 гаран жил ажиллахдаа Сангийн яам, Үндэсний татварын газраас 2 удаа 20 сая төгрөгөөр шагнуулсан байдаг. Г-ын өмчлөлийн эд хөрөнгө, том хүү Г.Газ-ын авто машин зэргийг Ч.Га-ийн эд хөрөнгөнөөс ялгаж салгалгүй хурааж байгаа нь хуульд нийцэхгүй байна. Ч.Га-ийг Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл 263.2-т зааснаар эрх мэдэл, албан тушаалаа урвуулсан гэх үндэслэлээр ял оногдуулсанд гомдолтой байна. Мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйл 35.1 дэх хэсгийг журамлан энэ хэрэгт хамтран оролцсон хэлбэрийг тодорхой зааж өгөөгүй. Прокурорын яллах дүгнэлт, анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлал нэг талыг барьж Ч.Га-д ял ногдуулсан. Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч нар Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Шүүхийн шинжилгээний тухай хуулийг зөрчиж, шинжээч нарыг томилсон. Ч.Га татварын ажилтны ёс зүйн дүрэм мөрдөн хэрэгжүүлээгүй, эрхэлсэн ажлаа зохих ёсоор гүйцэтгээгүй, ёс зүйн зөрчил гаргасан үйлдлийг нь анхааруулан сануулж, ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг нь өөрчлөх талаар удирдлагад нь санал хүргүүлж байсан татварын улсын байцаагчийг шинжээчээр томилсон байдаг. Шинжээчийн багт томилогдсон Н.Г, Ц.С, Б.А нараас Б.А “Цэвэр агаар сан”-гийн төслийн асуудлаар Авлигатай тэмцэх газар байцаагдаж байсан. Анхан шатны шүүхэд шүүх хуралдаанд оролцуулах хүсэлт тавьсан гэтэл шүүх хуралдаанд ирээгүй өөрийнхөө хууль зөрчсөн үйлдлийг мэдээд ирээгүй гэж ойлгож байна. “КЖЭ” ХХК гэх 5 нэр бүхий компанид хамтарсан 10 шинжээч томилсон байдаг. Шинжээчид дүн шинжилгээ хийх объектоосоо халин ашиг сонирхлын зөрчил гаргасан. У, Э нар шинжээчээр томилогдоогүй байхдаа ажиллагаанд орсон байсан. Шүүх хуралдааны явцад процессын зөрчил гарсан шүүх хуралдааны тэмдэглэл танилцуулах хүсэлт тавьсан, мөн тэмдэглэл бүрэн

хөтлөгдөөгүй байсан. Шүүх хуралдааныг 10 цаг хүртэл хийх ёстой зөвлөлдөх нэрээр удаж 10 цагаас хойш шүүх хуралдааныг үргэлжлүүлсэн. Ч.Га-ийн эд хөрөнгийг Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйл 49.2-р зүйлчлэн хурааж авах болсон. Мөн 1970, 1980 оноос Ч.Га-ийн өмчлөлд байсан 2 байрыг хурааж байгаа нь хуульд нийцэхгүй гэр бүлийн гишүүдийн эрх ашгийг зөрчиж байна. Ч.Га-ийн биеийн байдал хүнд сахарын шижинтэй бусдын хяналтад байх шаардлагатай. Иймд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол магадлалыг хүчингүй болгож Ч.Га-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан Ч.Га-ийн өмгөөлөгч А.Ундрах 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа: «... Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 2... тоот шийтгэх тогтоол хуульд нийцээгүй. Үндсэн хуулиар олгогдсон хууль шүүхийн өмнө хүн бүр эрх тэгш байх зарчим алдагдсан гэж үзэж байна. Ч.Га-ийг Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйл ангиар ял оногдуулсан нь үнэнд нийцээгүй. Ч.Га-ийг гэмт хэрэг үйлдсэн гэх нотлох баримт хэрэгт авагдаагүй байдаг. С.Ба, Ц.Со мөн гэрчүүдийн мэдүүлэг зөрдөг. Ц.Со гэдэг хүнтэй 1 минут утсаар ярьсныхаа төлөө Ч.Га 100 сая төгрөгийн эд хөрөнгө хураалгах нэмэгдэл ялтай 3 жил 4 сар чанга дэглэмтэй хорих ангид хоригдох ял оногдуулсан. Хураагдсан эд хөрөнгийн хувьд хүү Г-ынх нь Америк улсад амьдарч ажиллаж авсан Лексус 570 автомашин, дүү Г-ынх нь Лексус 570 автомашин, эцэг У.Ч-ийн хотхонд байдаг байр Ч.Га-ийх биш юм. Гэр бүлээрээ машин оруулж ирж зардаг. Миний үйлчлүүлэгчийг анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд хэрэгт зохион байгуулагчаар оролцсон гэдэг бөгөөд нотлох баримтаар нотолж чаддаггүй. Иймд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож Ч.Га-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан Д.Эн-ын өмгөөлөгч Х.Баасанжаргал 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа «... Д.Эн-ыг Эрүүгийн хуулийн 270 дугаар зүйлд заасан хууль бусаар хөрөнгөжсөн гэж зүйлчилсэн 592.835.500 төгрөгийн орлого хууль бус биш

хууль ёсны эх үүсвэртэй орлого. Автомашин худалдан борлуулдаг. Хэрэгт авагдсан нотлох баримтаар хангалттай нотлогддог. «ЖМ» ХХК-д 512.000.000 төгрөгийг зээлүүлэн хүүгийн хамт 815.000.000 төгрөгийг авсан байдаг. Дээрх мөнгөөр «НК» ХХК-тай 2012 оны 05 дугаар сарын 23-ны өдөр «Орон сууц захиалга, хөрөнгө оруулалт»-ын гэрээ байгуулан худалдан авахаар тохирсон орон сууцны үнэ 493.822.000 төгрөгийг тус тус хууль бусаар хөрөнгөжсөн гэж дүгнэдэг. Д.Эн-ыг Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2-д зааснаар хууль бусаар олсон 500.000.000 төгрөгийг нуун дарагдуулсан гэж үздэг гэтэл 592.835.500 төгрөгтэй давхардаад байдаг. Татвар ногдох орлого гэдэг нь хууль ёсны орлогоос татвар төлөөгүй ойлголт харин хууль бусаар хөрөнгөжсөн гэдэг нь хууль бус эх сурвалжтай тул түүнд татвар төлөх тухай гэсэн ойлголт огтхон ч байхгүй. Шинжээч нар томилогдон 500.000.000 төгрөгт дүгнэлт хийсэн. Бусдаас авсан авлага, хүний хөгжил сангийн орлого, мөн «МТ»-д байр захиалсан гэрээгээ цуцлаад мөнгөө дансаар авсан байсан зэргийг шинжээч нар хууль бусаар олсон орлого гэж дүгнэсэн нь хуульд нийцээгүй. Шинжээчид дүгнэлт гаргахдаа Д.Эн-ын хөрөнгө орлогын мэдүүлгийн хөрөнгө орлого гэсэн хэсгийн мөнгөн дүнгээс хууль бус олсон орлогоо нуун дарагдуулсан гэж үзсэн. Хөрөнгө орлогын мэдүүлэгт тухайн өрхийн бүх гишүүний орлого бүртгэгдсэнийг ялгаж салгаагүй нь хуульд нийцээгүй. Мөн Д.Эн-ыг Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар 8 жил хорих ял ногдуулсан. Тухайн үед Д.Эн нь Баянгол дүүргийн татварын хэлтсийн даргаар ажиллаж байсан. Баянгол дүүргийн татварын улсын байцаагч нар «УМ», «ЗУ», «НТГ» ХХК-уудад хууль бус үндэслэлгүй дүгнэлт гаргасан байсныг 2010 оны 5 дугаар сарын 7-ны өдрийн 73 тоот тушаалаар «Татвар ногдуулах объект биш харьяаллын бус» гэдэг үндэслэлээр хүчингүй болгосон байдаг. Энэ тухайгаа дээд удирдлагууддаа бичгээр хүргүүлсэн байдаг. Нийслэлийн мөрдөн байцаах газар, Нийслэлийн прокурорын газар татварын улсын байцаагч нарын дүгнэлтийг шалгасан байдаг Нийслэлийн прокурорын газраас «УМ» ХХК-д эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан байдаг. Авлигатай тэмцэх газар 2013 оны 07 дугаар сард Нийслэлийн прокурор С.Х-ын эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзсан тогтоолыг хүчингүй болгосон. Д.Эн-ыг Ч.Га-

тэй үгсэн хувилдсан гэж хэрэгт авагдсан нотлох баримтаар нотлогддоггүй шалтгаант холбоо байхгүй. Д.Эн-ыг гэм буруутайд тооцсон шинжээчийн дүгнэлтийг гаргасан шинжээчийн бүрэлдэхүүнд томилогдсон Н.Г нь хохирогчийн шууд удирдлагад ажилладаг албан тушаалтан байсан төдийгүй шинжээч Б.А нь Авлигатай тэмцэх газарт шалгагдаж байх явцдаа тус газрын томилолтоор дүгнэлт гаргасан байдаг. Шинжээч нар гаргасан дүгнэлтээ нэгтгээгүй нь процессын алдаа гэж үзэж байна. Н.Г шинжээч шүүх хуралдааны тайлбартаа хүлээдэг. Б.Жа-ыг Д.Эн-ыг 15.000.000 төгрөг нуун дарагдуулсан гэдэг дүгнэлт гаргасан. Б.Жа-ыг Д.Эн-аас хээл хахууль авсан гэдэг үндэслэлээр энэ хэрэгт сэжигтнээр татсан байдаг. Б.Жа-ын гаргасан дүгнэлтийг анхан болон давж заалдан шатны шүүх нотлох баримтаар татаагүй байдаг. Д.Эн-ын биеийн байдал давж заалдах шатны шүүх хурлаас хойш нийт 6 удаа хагалгаанд орсон эрүүл мэндийн хувьд хүнд байгаа. Мөн улс орондоо олон жил ажилласан хичээл зүтгэлийг нь үнэлэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас «Нийслэлийн хүндэт иргэн» цол тэмдгээр шагнасан. Д.Эн-ын эрх зүйн байдлыг нь дээрдүүлж анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлалын Д.Эн-д холбогдох хэсгийг хүчингүй болгож хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү» гэв.

Ялтан Д.Эн-ын өмгөөлөгч Д.Батбаяр шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа «... өмгөөлөгч Х.Баасанжаргалын хяналтын шатанд гаргасан гомдлыг дэмжиж байна. Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар 8 жил хорих ял оногдуулсныг хангалттай тайлбарласан. Ч.Га-тэй үгсэн хувилдсан гэдэг. Нийслэлийн прокурорын газраас 2010 оны 5 дугаар сарын 6-ны өдөр уг хэрэгт эрүү үүсгэхээс татгалзсан байдаг. Энэ гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй юм. Эрүүгийн хуулийн 270 дугаар зүйлд зааснаар гэмт хэрэг үйлдээд олсон орлого байх ёстой гэтэл хууль ёсны орлого байсан нь хэрэгт авагдсан нотлох баримтаар нотлогддог. Б.Жа-ыг энэ хэрэгт авлига авсан гэж үзэн сэжигтнээр татсан нь хэрэгт авагдсан нотлох баримтаар нотлогдоогүй болохоор үгсэн тохирч худал дүгнэлт гаргасан гэж ялладаг. Д.Эн-ыг цагаатгаж өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан Ч.Да-гийн өмгөөлөгч Ц.Гансүх 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа «... Ч.Да-г

дараах 2 үндэслэлээр ялладаг ах Ч.Га-тэй үгсэн хувилдсан, татвараас зайлс хийсэн гэж эдгээр үндэслэлийг няцааж байна. Хэрэгт авагдсан «Чингэлтэй дүүргийн татварын байцаагч нарын шинжээчээр ажилласан мэдүүлэгт Б /эрх бүхийн 6 компанийн гүйцэтгэх захирал/ Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс тус компани дээр хийгдэж байгаа хяналт шалгалт удаж байна. Иймд дээд шатны байгууллагаар шалгуулах хүсэлтэй байна гэсэн байдаг. Энэ нь

Ч.Да-гийн гомдлоор хяналт шалгалт явуулаагүйг нотолж байна. Ч.Да-г Ч.Га-тэй үгсэн хувилдан хатгагчаар хамтран оролцсон гэж үзэх нь эргэлзээтэй байхад шүүх дүгнэлт өгөөгүй. Татварын Ерөнхий газрын байцаагч нарын шалгасан ажлыг дүүргийн татварын хэлтсийн ашиг сонирхлын зөрчилтэй байцаагч нараар шинжлүүлсэн нь хуульд нийцээгүй. Газар эзэмших эрх үүсээгүй аж ахуйн нэгж дээр газрын төлбөр төлөөгүй гэж татвар ногдуулсан. Шинжээч Татварын Ерөнхий газрын хууль эрх зүйн хэлтсээс татвар суутгах лавлагаа авсан мөртөө 30 хувь татвар ногдуулсан. 2010 онд батлагдаагүй байсан хуулийг 2013 онд хэрэглэж татвар ногдуулаагүй гэж дүгнэлт гаргасан зэргээр шинжээчийн дүгнэлт хуульд нийцээгүй. Ч.Да өнөөдрийн байдлаар 392 хоног хоригдож байна. Эхнэр 3 бага насны хүүхэдтэй анх удаа гэмт хэрэг үйлдсэн зэргийг харгалзан үзэж оногдуулсан ялыг тэнсэж өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан Ч.Да-гийн өмгөөлөгч С.Оюунцэцэг 2014 оны 07 дугаар сарын 04-ний өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа «...Ц.Гансүхийн өмгөөлөгчтэй санал нэг байна. Ч.Га-д холбогдох хэрэгт хийсвэр дүгнэлт хийсэн гэж үздэг. 2012 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Ч.Га-ыг мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэн хэргийг шалгаж байна гэсэн мэдээллийг Авлигатай тэмцэх газар бүх нийтэд зарлаад эрүүгийн хэрэг үүсгэж, анхан болон давж заалдах шатны шүүх Ч.Да-г хэрэг үйлдсэн гэж тогтоосон. Иймд Ч.Да-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох, эсвэл хувийн байдлыг харгалзан тэнсэж өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан Б.Жр-ын өмгөөлөгч К.Бауиржан 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа «... Б.Жа-ыг албан тушаалаа урвуулан ашигласны улмаас татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг

гардан үйлдэж хамжигчаар оролцсон гэж буруутган 3 жилийн хорих ялаар шийтгэсэн нь хууль зүйн үндэслэлгүй. Татварын ерөнхий газар хяналт шалгалт арга зүйн хэлтсийн даргаас өгсөн үүрэг томилолтын дагуу 3 нэр бүхий компанид шалгалт хийсэн байдаг. Ч.Га-ийг өөрийн удирдлагад ажилладаг татварын улсын байцаагч нараар шалгалт хийлгэж гүйцэтгэсэн гэдгээр буруутгасан боловч энэ нь хэрэгт авагдсан нотлох баримт, мөрдөн байцаалтын явцад нотлогдоогүй юм. Шинжээч нарын дүгнэлт үндэслэлгүй, холбогдох баримт бичгийг үндэслээгүй болох нь шинжээч нарын өгсөн мэдүүлэг, хэрэгт авагдсан нотлох баримтаар нотлогддог. Б.Жа-ыг «ШЭ» ХХК-д газар ашиглах газрын төлбөр ногдуулаагүй гэдэг. Өмнөговь аймгийн Манлай сумын газрын мэргэжилтэн Т.М-аас 2014 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 383 тоот албан бичгээр «ШЭ» ХХК-д Манлай сумын Засаг даргаас газар ашиглах, эзэмших эрх үүсэж газрын гэрчилгээ олгогдоогүй. Газрын харилцааны эрх үүсээгүй байгаа тул газрын төлбөр төлөөгүй болно гэснийг анхан болон давж заалдах шатны шүүх нотлох баримтаар үнэлээгүй. Холбогдох баримт бичигт дүгнэлт хийгээгүйгээс 2006 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 4226Х тоот лицензийг үнэ төлбөргүй шилжүүлсэн, лиценз биет бус хөрөнгө гэж бүртгэгдээгүй, мөн лицензийн зардалд 14.2 тэрбум төгрөгийн зардал гараагүй болохыг олж мэдэх байсан. Шинжээч Б.Э «ШЭ» ХХК-д газар эзэмших лицензтэй гэдэг утгаар акт тавьсан гэж мэдүүлсэн байдаг. Шүүх хуралдаан дээр Чингэлтэй дүүргийн татварын улсын байцаагчийн 2005 оны 6 дугаар сарын 2-ны өдрийн акт зэрэг нотлох баримтыг гаргаж өгсөн ба эдгээр нотлох баримтаар «КЖЭ» ХХК-аас 2006 онд 4326Х тоот лицензийг “ХЭ” ХХК-д шилжүүлэх үед нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч биш, нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгчийн бүртгэлээс хасагдсан байсан нь нотлогддог. Шинжээч нар шүүх хуралдаан дээр өөрсдийн гаргасан дүгнэлтээ хамгаалж чадаагүй, Авлигатай тэмцэх газрын байцаагч нарын өгсөн даалгавраар ажилласан нь харагддаг. Иймд Б.Жа-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү” гэв.

Ялтан Б.Жр-ын өмгөөлөгч Б.Ганбаатар шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа «... өмгөөлөгч К.Бауиржаны гомдлыг дэмжиж байна. Б.Жа-ыг «КЖЭ» ХХК-ийн нэмэгдсэн өртгийн албан татвар, «ШЭ» ХХК-д газар

ашиглах газрын төлбөр ногдуулаагүй гэсэн 2 үндэслэлээр буруутгагдаж байгаа. Газрын харилцааны нэг онцлог нь гэрээ байгуулж байж газар ашиглах, эзэмших эрх үүсдгээрээ онцлогтой. Гэтэл Өмнөговь аймгийн Манлай сумын газрын мэргэжилтэн Т.М-гийн 2014 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 383 тоот албан бичгээр «ШЭ» ХХК-д Манлай сумын Засаг даргаас газар ашиглах, эзэмших эрх үүсэж газрын гэрээ, гэрчилгээ олгогдоогүй гэдэг. Орон нутгийн газар зохион байгуулагч гэдэг албан тушаалтан газрын төлбөр хурааж, тайлан гаргадаг, татварын улсын байцаагч энэ үйлдэлд хяналт тавих үүрэгтэй гэтэл татварын улсын байцаагч төлбөр ногдуулах үүрэг өгч байгаа нь хуульд нийцээгүй байна. 2005-2007 оны үйлдэл дээр 2013 эрх зүйн талаас нь дүгнэлт өгөхөд 2008 оны «Өршөөлийн хууль» батлагдсан байхад энэ хэрэг илэрсэн тул өршөөлийн тухай хуулиар зохицуулах эрх зүйн боломж байсан байна. «КЖЭ» ХХК-ийн 14.2 тэрбум төгрөгийн хохирогчоор «Татварын ерөнхий газар» тогтоогдсон байдаг. «Сангийн яам» хохирогчоор оролцох байсан. Шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй байхад улсын яллагч яллах дүгнэлт үйлдсэн нь хуульд нийцээгүй. Шинжээчид 2006 оны санхүүгийн тайланд 14.2 тэрбум төгрөгийн зардалд гарсан байхад татвар ногдуулсан нь хуульд нийцээгүй. Шүүх хуралдааны тэмдэглэл 75, 76, 77 дугаар хуудсан дээр шинжээч нараас 2006 оны тайланг шинжээчийн дүгнэлт хийхдээ харсан уу? гэхэд хараагүй гэдэг. Нотлох баримтыг бүрэн дүүрэн судлаагүй эргэлзээтэй дүгнэлт гаргасан нь нотлогдож байна. 2005 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн Чингэлтэй дүүргийн татварын улсын байцаагчийн хүчин төгөлдөр акт байдаг «КЖЭ» ХХК нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч биш гэдэг шинжээч тухайн актын хараагүй гэдгээ тайлбартаа хэлдэг. 5 аж ахуйн нэгж хувьцаагаа худалдсан байдаг гэтэл «КЖЭ» ХХК-д татвар ногдуулаад байгаа нь хуульд нийцэхгүй байна. Хувьцаа, лиценз худалдах, худалдан авах хоёр өөр харилцаа ялгаж салгаж ойлгоогүй. Шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй гарсан тул Б.Жа-ын гэм буруу тогтоогдохгүй гэж үзэж байна. Иймд Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан энэ хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болохыг тогтоож Б.Жр-ыг цагаатгаж өгнө үү” гэв.

Ялтан Б.Жр шүүх хуралдаанд хэлсэн тайлбарт «... би хяналт шалгалтыг ажлын

байрны тодорхойлолтод заасан үүргийнхээ дагуу хийсэн. Удирдах албан тушаалтнаас ямар нэгэн хууль бус үүрэг даалгавар өгөөгүй. 2010 онд Ч.Га даргын удирдлагад ажиллаж байсан бид бүрэлдэхүүнээрээ шүүхэд дуудагдаж ялтан болсонд гомдолтой байна. «КЖЭМ» ХХК-нд холбогдох дүгнэлт хуульд нийцээгүй, үндэслэлгүй дүгнэлт. «ШЭ» ХХК-нд газар эзэмших гэрчилгээ олгогдоогүй бөгөөд Чингэлтэй дүүргийн татварын хэлтэс «ШЭ» ХХК-нд шалгалт хийгээд зөрчил илрээгүй учир татан буулгасан болохыг анхаарна уу» гэв.

Мөн шүүхэд ялтан Б.Өс-ын өмгөөлөгч Б.Цэнгүүн 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбарт «... анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол, давж заалдах шатны шүүхийн магадлал Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.1-д зааснаар хуульд нийцээгүй гэж үзэн гомдол гаргасан. Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолд Б.Өс-ыг Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар гэмт хэргийг гардан гүйцэтгэж хамжигчаар хамтран оролцсон гэж үзсэн. Гэтэл давж заалдах шатны шүүх магадлалдаа Б.Өс-ыг гүйцэтгэгчээр, Ч.Га-ийг зохион байгуулагчаар оролцсон гэж үзэхдээ зарим нөхцөл байдлыг харгалзан үзээгүй. Б.Өс нь «ХБЭ» ХХК, «КЖЭ» ХХК-ууд татварын хүү, торгуульд нийт 11.921.655.800 төгрөг төлөх ёстой байсныг төлүүлэлгүй санаатайгаар, өөрийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгоор илтгэх хуудас бичсэн гэх нотлох баримт байхгүй. 2010 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн байцаагч нар нэр бүхий аж ахуйн нэгжид шалгалт хийх томилолт авсан байдаг. Б.Өс 2010 оны 09 дүгээр сарын 01-ний өдрөөс 2010 оны 10 дугаар сарын 05-ны өдөр хүртэл хуулиар олгогдсон ээлжийн амралтаа авсан байсныг хэрэгт нотлох баримтаар хавсаргасан байгаа. 2010 оны 10 дугаар сарын 18-ны өдөр Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-ийн «ХБЭ» ХХК-д шалгалт хийх 35 тоот томилолтыг аван шалгалтыг хийж дууссан байдаг. 2010 оны 10 дугаар сарын 25-ны өдөр «КЖЭ» ХХК-ийн 2005 оны татварын ногдуултал, төлөлтөд шалгалт хийх нэмэлт 5 хоногийн томилолтыг авч тус аж ахуйн нэгжийн 2005 оны санхүүгийн баримтыг шалгаж, нэгдсэн илтгэл хуудсанд гарын үсэг зурж баталгаажуулсан байдаг. Эрүүгийн

хуулийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан энэ хэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй юм. Б.Өс-ыг буруутгаж байгаа гол үндэслэл болох шинжээчийн дүгнэлт. Б.Өс нь шинжээчийн дүгнэлтийг гаргасан Л.А, С.Б, Г.Б, С.О нарт үр дүнгийн гэрээний биелэлтийн талаарх судалгааг гаргаж, хэрхэн татвар тооцож байх талаар арга зүйн зөвлөгөө өгч байсан тул хэрэгт хувийн сонирхолгүйгээр шинжээчийн дүгнэлт гаргасан гэдэгт эргэлзээтэй байна. Шинжээчид шинжээчийн дүгнэлт гаргахдаа мэдлэг ур чадвар хүрэхгүй болохоор Татварын ерөнхий газраас арга зүйн зөвлөгөө авсан байдаг. Хохирогчоос арга зүйн зөвлөгөө авсан нь хуульд нийцэхгүй байна. Авлигатай тэмцэх газраас хүү, торгууль тооцож гарга гэсэн шаардлага тавьж дахин хүү, торгууль тооцож шинжээчийн дүгнэлт гаргасан гэдгээ шүүх хуралдаан дээр мэдүүлсэн. «КЖЭ» ХХК, «ХБЭ» ХХК-ийн хооронд лиценз талбайн мэдээлэл худалдан авах болон лиценз шилжүүлэх гэсэн хоёр өөр гэрээ хийгдсэн. Шинжээчээс 2 өөр гэрээг яагаад нэг гэрээ гэж үзээд байна гэхэд мэдрэмжээрээ нэг гэрээ гэж үзсэн гэсэн. Шинжээч талуудын хооронд хийсэн гэрээнд дүгнэлт өгөх эрхгүй. Биет бус хөрөнгө худалдах, худалдан авах гэрээ хийсний дараа лиценз шилжүүлэх гэрээгээр ашигт малтмал хайх 12 лицензийг «ХБЭ» ХХК-нд үнэ төлбөргүй шилжүүлсэн нь хууль ёсны юм. Иймд Б.Өс холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан Б.Өс 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбарт «... 2010 оны Чигэлтэй дүүргийн татварын улсын байцаагч нарын ажлыг дүгнэхэд Г.Б, Л.А нар зөрчилтэй гарсан. Зөрчил гаргасан байцаагч нараар шинжээчийн дүгнэлт хийлгэсэн нь хууль зүйн үндэслэлгүй. С.Б, С.О нар шинжээчийн дүгнэлтдээ «КЖЭ» ХХК-ийн лиценз борлуулсан орлогоо тайландаа тусгасан гэсэн байдаг. Мөн Л.А, Г.Б нар дүгнэлтдээ 12 лицензийг кадастрын албанд буцаагаад өгсөн гэсэн байдаг. Компани хоорондоо лиценз шилжүүлсэн байхад 2008 оны 08 дугаар сарын 01-нээс мөрдсөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийг мөрдөн торгууль ногдуулж байгаа нь хуульд нийцэхгүй. Би зөвхөн 2005 оны баримтыг шалгасан. Шинжээчийн дүгнэлтийг хууль бус байна гэж Авлигатай тэмцэх газарт 2013 оны 12 дугаар сарын 10-ны өдөр, нийслэлийн прокурорт 2013 оны 12 дугаар сарын 25-ны өдөр хүсэлт гаргасан боловч

өнөөдрийг хүртэл хариу өгөөгүй. Татварын ерөнхий газрын даргын үүрэг гүйцэтгэгч Б-ын татварын улсын байцаагч нар энэ хэрэгт хамааралгүй гэсэн албан тоотыг нотлох баримт болгон хэрэгт хавсаргаагүй. Иймд надад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан Н.Чи-ын өмгөөлөгч Х.Цогтсайханы 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа «...

Н.Чи нь ажлын байрны тодорхойлолтод заагдсан үүргийнхээ дагуу томилолт аваад «ХЭ» ХХК-ийн 2005-2009 оны албан татварын ногдуулалт, төлөлтийн байдалд 2010 онд хяналт шалгалт хийж, нийт 332.769.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлэн 50.193.6 мянган төгрөгийн төлбөр ногдуулснаас 163.602.1 мянган төгрөгийн зөрчилд ногдох төлбөр 16.360.2 мянган төгрөгийн дүнгээс компанийн нэмэгдсэн өртгийн албан татварын илүү төлөлт буюу төсвөөс буцаан авах татварын дүнг бууруулан 2010 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийн баталгаажуулалтын акт үйлдэж 169.167.0 мянган төгрөгийн зөрчилд 33.833.4 мянган төгрөг төлбөр ногдуулан 980020 дугаартай татварын улсын байцаагчийн акт тогтоон хяналт шалгалтын ажлыг “Монгол Улсын Татварын тухай хууль” болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн. Н.Чи-ын энэ үйлдлийг байгууллагын эрх ашгийн эсрэг үйлдэл гэж үзэж байгаа нь хуульд нийцээгүй хэрэгт авагдсан нотлох баримтаар нотлогддоггүй. Шинжээчээр ажилласан шинжээч С.Ба нь энэ хэрэгт гэрчээр оролцсон байдаг. Мөрдөн байцаагчийн заавраар ажилласан. Мөн дээд газраасаа заавар зөвлөгөө авсан байдаг. “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль”-ийг шинжээч нар буцаан хэрэглэж “ХЭ” ХХК-ийн 2007, 2008, 2009 оны үйл ажиллагаанд албан татвар ногдуулсан нь хууль зүйн үндэслэлгүй юм. Гадаад улсад олсон орлого дээр нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулан 141.000.000 төгрөгийн зөрчил илрүүлээгүй гэж буруутгадаг. Газрын харилцааны нэг онцлог нь гэрээ байгуулж байж газар ашиглах, эзэмших эрх үүсдэгээрээ онцлогтой гэтэл “ХЭ” ХХК-д газар эзэмших эрх олгогдоогүй байхад газрын төлбөрийг Н.Чи-ыг ногдуулаагүй гэдэг үндэслэлээр буруутгадаг. Мөн “Хайгуулын үнэлгээний хөрөнгө”-д хайгуулын тусгай зөвшөөрлийг

биет бус хөрөнгөнд бүртгүүлэхээр заасан тул биет бус орлого борлуулсныг эрх борлуулсан орлогод хамааруулахгүй. Иймд “ХЭ” ХХК-ийн албан татварыг суутган тооцох нь хууль зүйн үндэслэлгүй. Монгол Улсын хууль тогтоомжийг илт зөрчсөн дүгнэлтийг үндэслэн Н.Чи-ыг 896.964.1 мянган төгрөгийн хохирол учруулсан гэж шүүх дүгнэсэн нь хууль зүйн үндэслэлгүй. Иймд Н.Чи-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү” гэв.

Мөн шүүхэд ялтан Н.Чи-ын 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбарт «... өмгөөлөгчийн гаргасан гомдлыг дэмжиж байна. Миний бие энэ хэрэгт шинжээчийн дүгнэлтээр гэм буруутайд тооцогдож байгаа. Гадаад улсад шилжүүлсэн төлбөрт төлбөр ногдуулаагүй гэж “ХЭ” ХХК нь Австрали улсын шинжилгээний байгууллагаар нүүрснийхээ дээжийг шинжлүүлдэг. Шинжилгээнийхээ төлбөрт 20% татвар ногдуулах шинжээчийн дүгнэлт гарсан нь хууль зүйн үндэслэлгүй юм. 2011 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр нэмэлт өөрчлөлт орсон гэтэл “ХЭ” ХХК-ийн 2007, 2008, 2009 оны үйл ажиллагаан дээр хууль буцаан хэрэглэн татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар зэргийг ногдуулсан нь хуульд нийцээгүй. Газар ашигласан төлбөрийг газрын албаар дамжуулан төлдөг үүнийг шинжээч нар тооцоогүй. Иймд хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан О.Бя-гийн өмгөөлөгч Г.Мөнхбат 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбарт «... татварын байцаагч нар хууль зөрчөөгүй. Шинжээч нар 2005-2009 оны санхүүгийн тайланг огт үзээгүй байж дүгнэлт гаргаснаа хүлээдэг. Анхан болон давж заалдах шатны шүүх хууль бус дүгнэлтийг үнэлж байгаа нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 92 дугаар зүйлийн 92.2-д заасныг зөрчиж байна. Лиценз худалдсан тохиолдолд эрх шилждэг мэдээлэл борлуулсан орлогын 10 хувьд татвар ногдуулна гэдэг. Шинжээчийн дүгнэлт бодит байдал болон хуульд нийцээгүй. Иймд хэргийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан О.Бя-гийн 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбарт «... энэ хэрэгт намайг шинжээчийн дүгнэлтийг үндэслэн улсад гэм хор учруулсан гэм буруутайд тооцож байгаа. Шинжээчийн

дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Шинжээч 315 сая төгрөгийг гаргахдаа 2 асуудлыг хөндсөн. Хайгуулын лицензийг шилжүүлэх нь эрх юм уу, мэдээлэл юм уу гэдгийг тогтоогоогүй. Ашигт малтмалын тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т мэдээллээ худалдаж болно гэж заасан.

Мөн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т «мэдээллийг биет бус гэж үзнэ» гээд заасан байдаг. Сангийн яам нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу хөтөлсөн байна гэж тодорхойлсон. Гэтэл шинжээчийн үндэслэлгүй дүгнэлтээр хүнд ял оногдуулж байгаа нь хуульд нийцэхгүй. «КЖЭ» компани татвараа хууль ёсоор цаг тухайд нь төлсөн. Газар ашигласны төлбөрийг газрын алба хариуцаж төлүүлэх үүрэгтэй. Ашигт малтмалын газраас хайгуулын лиценз авсан болгон газрын татвар төлөгч биш юм. Шинжээч Авлигатай тэмцэх газрын заавраар хөөн хэлэлцэх хугацаа дууссан «ЭрЭ» ХХК-ийг шалгаж байгаа нь хууль зүйн үндэслэлгүй. 2010 онд Ч.Га гэдэг хүний удирдлагад ажиллаж байсан гэдгээрээ энэ хэрэгт холбогдоод байна. Намайг мөнгө угаасан, авлига авсан, зуучилсан гэж 3 зүйлээр буруутгасан. Гэтэл төрүүлсэн хүүгээс минь өөр юу ч байхгүйг мэдээд гэртээ байж бай, дараа нотлох баримт олоод дуудна гэсэн. Иймд надад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, сэтгэлийн зовлонг дуусгаж өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан Н.Ра-гийн өмгөөлөгч Ж.Батзоригтын 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбарт «... анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн. Н.Ра-г албан тушаал эрх мэдлээ урвуулан ашигласан гэж Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйл 363.2-т зааснаар татварын улсын байцаагчийн эрхийг 3 жил хасаж, 3 жил хорих ял шийтгэж, 3 жил тэнсэнг хүлээн зөвшөөрөхгүй. Баянзүрх дүүргийн татварын улсын байцаагч Ш.На, А.До нарын «НТГ» ХХК-ийн 2007-2009 оны татвар ногдуулалт, төлөлтийг шалгаж 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдөр бичсэн 260006 тоот дүгнэлтийг уг компанийн зүгээс хүлээн зөвшөөрөхгүй Татварын ерөнхий газарт гомдол гаргаж, хэлтсийн дарга Ч.Га-ийн 2010 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн 0003 тоот албан томилолтын дагуу «НТГ» ХХК, «УМ» ХХК-нд татварын хэсэгчилсэн

шалгалт хийсэн. Хяналт шалгалтыг 2 буюу түүнээс дээш байцаагч хийнэ гэсэн зүйл заалт огт байхгүй, ганцаараа хийсэн гэж буруутгасан нь хууль бус юм. «УМ» ХХК-ийн тусгай зөвшөөрлийг «ПС» ХХК худалдан авахдаа хувьцаа худалдах, худалдан авах гэрээгээр халхавчилсан гэдэг боловч хэргийг тал бүрээс нь бодитойгоор нотлоогүй, хуульд заасан арга хэмжээ аваагүй. Иймд шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож, миний үйлчлүүлэгчийг цагаатгаж өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан Н.Ра-гийн 2014 оны 07 дугаар сарын 03-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбарт «... Баянзүрх дүүргийн татварын улсын байцаагч Ш.На, А.До нарын «НТГ» ХХК-ийн 2007-2009 оны албан татварын ногдуулалт, төлөлтийг шалгаж тогтоосон 2010 оны 2 дугаар сарын 25-ны өдрийн 260006 тоот дүгнэлтийг хэсэгчлэн шалгахад давхардуулан татвар ногдуулсан байдаг. Шинжээч нар «НТГ» ХХК нь зөрчилгүй байна гэсэн. Тухайн төлбөрийг «ПВР» ХХК төлөх ёстой. Гэтэл би «ПВР» ХХК-нд шалгалт хийгээгүй. Иймд надад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож цагаатгаж өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан П.Га-ын 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбарт «... би «УМ» ХХК-нд хэсэгчилсэн шалгалт хийсэн. Шинжээч Т-ын дүгнэлт миний шалгалтаар тогтоосон «УМ» ХХК нь татвар ногдуулах үүрэггүй гэсэн дүгнэлттэй таарсан. Гэтэл миний шалгаагүй «ПВР» ХХК-ийн 7 жилийн баримтад шалгалт хийж намайг албан тушаалаа урвуулан ашигласан гэж яллаж байгаад гомдолтой байна. Хувьцаа зарсан үйлдлээ хувьцаа худалдах, худалдан авах гэрээгээр халхавчилсан гэж үзсэн нь хуульд нийцэхгүй. Мөн хавтаст хэрэгтэй танилцахдаа хэргийг хэрэгсэхгүй болгосон прокурорын тогтоолтой танилцсан. Шинжээч нарын дүгнэлт хуульд нийцээгүй. «КЖЭ» ХХК-ийн 2.4 тэрбумын нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулсан байдаг. Нэмэгдсэн өртгийн албан татвар ногдуулахдаа орлогод ногдох нэмэгдсэн өртгийн албан татвараас худалдан авалт хийсэн нэмэгдсэн өртгийн албан татварыг хасаад зөрүүгээр нь төлөхөөр тогтоодог. Иймд шийтгэх тогтоол, магадлалын надтай холбоотой хэсгийг хэрэгсэхгүй болгож, цагаатгаж өгнө үү» гэв.

Мөн шүүхэд иргэний хариуцагч «ПВР» ХХК-ийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн 2014 оны 07 дугаар сарын 01-ний өдөр гаргасан

гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбарт «... шинжээчийн дүгнэлтийг нотлох баримтын хэмжээнд үнэлэн тогтоол, магадлал гаргаж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 321 дүгээр зүйлд зааснаар хууль буруу хэрэглэсэн гэсэн үндэслэлүүдээр гомдол гаргасан. Баянгол дүүргийн татварын хэлтсээс «НТГ», «УМ», «ЗУ» ХХК-иуд татвараа нуун дарагдуулсан гэж дүгнэлт бичиж цагдаагийн байгууллагад шилжүүлсэн. Цагдаагийн байгууллага эцэслэн шийдвэрлээгүй байхад тухайн акт дүгнэлтүүдийг хүчингүй болгосон. Бодит байдалтай илт харшилсан дүгнэлтийг татварын улсын байцаагч нар гаргасан. Гэтэл шинжээчийн дүгнэлтээр «НТГ», «УМ», «ЗУ» ХХК-иуд орлого олоогүй нь тогтоогдсон. Дээрх нэр бүхий компаниудын хооронд ямар нэгэн хэлцэл байхгүй. Хууль хэрэглээний хувьд биет бус хөрөнгө, хувьцаа зэргийг хольж ойлгоод байна. Шинжээч нарын дүгнэлт хуульд нийцээгүй, хэрэгт ашигтай нотлох баримтыг үнэлээгүй. Санхүү, татварын тайланг үзээгүй байж шинжээчийн дүгнэлт гаргасан нь хуульд нийцэхгүй байна. Иймд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлалыг хүчингүй болгож өгнө үү» гэв.

Мөн шүүхэд иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Баян 2014 оны 07 дугаар сарын 08-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбарт «... «КЖЭ» ХХК нь толгой компани бөгөөд 2012 оны 03 дугаар сард өөр нэг компани болох охин компанидаа лицензээ шилжүүлсэн, тэр компани цаашаа бас нэг охин компанид бүтцийн өөрчлөлт хийж лицензээ шилжүүлсэн. Гэтэл «КЖЭ» ХХК-д нэг онд дээрх хоёр үйлдэлд нь эрх борлуулсны 30, 30 хувь, татварын 10, 10 гээд нийт 80 хувийн татвар ногдуулсан. Энэ нь зохиомол 9.6 тэрбум төгрөгийн татвар ногуулах болсон. Тэгээд дээрх татварыг нуун далдалсан гэдэг үндэслэлээр иргэний хариуцагчаар татсан. Анх бол татвараас санаатай зайлхийсэн гэсэн үндэслэлээр иргэний хариуцагчаар татсан бол одоо албан тушаал урвуулан ашигласан гэх гэмт хэрэгт 13 тэрбум төгрөгийн татвар төлөхөөр болсон. Яагаад энэ гэмт хэрэгт холбогдсон шалтгаант холбоог тогтоогоогүй. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулиар 10 хувийн татвар ногдуулах ёстой. Стратегийн хөрөнгө оруулалтын тухай хууль 2013 оны

1 сарын 1-нээс хүчингүй болсон. Энэ хууль хүчингүй болсноор гадаад байгаа толгой компаниуд гадаад хувьцаагаа шилжүүлсэн тохиолдолд Монголд байгаа компани татвар төлөхгүй болсон. Хэрэв татварын маргаан байгаа гэж үзэж байгаа юм бол энэ асуудлаар Захиргааны хэргийн шүүхэд хандаж захиргааны журмаар шийдвэрлэх ёстой гэж үзэж байна. Энэ хэрэгт хохирогчтой шууд хамааралтай буюу татварын байцаагчийг шинжээчээр томилсон. «КЖЭ» ХХК-ийн захирал Б.Татварын ерөнхий газрын хяналт шалгалт арга зүйн хэлтсийн дарга Ч.Га-д манай компанид хяналт шалгалт явуулаад удаж байна удирдамжаа танилцуулахгүй шалгалт хийсэн гээд албан бичиг хүргүүлж Ч.Га «та бүхэн яагаад удирдамжгүй шалгалт хийж байгаа юм бэ» гэхэд тэр өдөр удирдамж гаргаж өгсөн. Тэгээд тэр үед шалгалтыг зогсоож Ч.Га-д загнуулж байсан хүнийг энэ хэрэгт шинжээчээр томилсон. Энэ байдлыг та бүхэн анхаарч үзэхийг хүсэж байна. Захиргааны хэргийн шүүхээр ашигт малтмалын лицензтэй байсан ч газар ашиглах гэрээгээ хийгээгүй бол татвар ногдуулахгүй гэж үзэж шийдвэрлэдэг практик байгаа. Ийм шүүхийн практик байхад анхан болон давж заалдах шатны шүүх хэргийг хэрэгсэхгүй болгох байтал хууль буруу хэрэглэж хэргийг шийдвэрлэсэн. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 122 дугаар зүйлийн 122.3-д заасан «Эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явцад тооцоог бүрэн хийх боломжгүй бөгөөд энэ нь гэм бурууг шийдвэрлэхэд нөлөөлөхгүй бол эрүүгийн хэргийг эцэслэн шийдвэрлэж, нэхэмжлэлээ иргэний журмаар гаргахыг нэхэмжлэгчид мэдэгдэнэ» гэж заасны дагуу хэрэгсэхгүй болгож Татварын ерөнхий газар хууль, журмаараа актаа тавьж актыг зөвшөөрөхгүй бол «Татварын маргаан таслах комисст» гомдол гаргаж, гомдлыг шийдвэрлэж гарсан актыг зөвшөөрөхгүй бол Захиргааны шүүхэд нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх эрхээр хангаж Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр үндэслэлтэй гэж үзвэл татварын байгууллага иргэний журмаар нэхэмжлэл гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй гэж үзэж байна» гэв.

Цагаатгагдсан иргэн Б.Жал-ын өмгөөлөгч Б.Энхтуяа шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа «... анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлалын Ж-д холбогдох хэсгийг хэвээр үлдээж өгнө үү» гэв.

Ялтан Б.Жа-ын өмгөөлөгч Ш.Энхмаа шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа «... давж заалдах шатны шүүхийн магадлал хуульд нийцсэн. Б.Жа-ын байр хөрөнгө орлогын мэдүүлэгт бичигдээгүй бол хууль бус гэж үзэж болохгүй. Заавал эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёсгүй. 2013 оны хөрөнгө орлогын мэдүүлэг дээр бичигдсэн байгааг анзаараач гэж прокуророос хүсэх байна. Лексус 470 машиныг нөхөр авсан. Цалингаас өөр орлоготой гэдэг нь хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтаар нотлогддог. Хөрөнгө орлогод Б.Жа-ын ганцхан цалин биш гэр бүлийн гишүүдийн орлого орно. Б.Жа-ын ерөөнд нэгжлэг хийж ноороглож тэмдэглэж байсан зүйлийг нотлох баримтаар авсан нь хуульд нийцэхгүй. Дүгнэлт нь шинжээч гарын үсэг зурж, тамга дарснаар баталгааждаг. Шинжээч нар түүнийг зориуд худал дүгнэлт гаргасан гэж үзсэн нь үндэслэлгүй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлд заасан үйлдэл, эс үйлдэхүй байхгүй тул давж заалдах шатны шүүхийн магадлалын Б.Жа-д холбогдох хэсгийг хэвээр үлдээж, прокурорын эсэргүүцлийг хэрэгсэхгүй болгож өгнө үү» гэв.

Мөн шүүхэд ялтан Б.Жа 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдөр гаргасан гомдол болон шүүх хуралдаанд хэлсэн тайлбартаа «... Д.Эн-ын орлогын 34 сая төгрөгийг бууруулсан нь хэргийн зүйлчлэлд нөлөөлөхөөр байна. Б.Жа нь худал дүгнэлт гаргасан нь хангалттай нотлогдож байна гэж прокурор эсэргүүцэл бичсэн. Эдийн засгийн шинжээчийн 164 тоот дүгнэлтийг бодитой, хууль, стандарт, журамд нийцүүлж би дүгнэлт гаргасан. Шинжилгээний дүгнэлтийн объект нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасныг хэлнэ. Гэтэл татварын улсын байцаагч нар 250041 тоот дүгнэлтэд «ЖМ» ХХК-д өгсөн зээл, зээлийн хүү, «Лексус» машин зарсан орлого, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны орлого гэсэн зөрчил тавьдаг. Хавтас хэрэгт байгаа анхан шатны нотлох баримтын хүрээнд би дүгнэлт гаргасан. Миний гаргасан дүгнэлтийн тоо болгон баримттай гэдгийг би нотолж чадна. Дүгнэлт гаргасан 3 шинжээч өөрсдийн мэдлэгийн хүрээнд дүгнэлт гаргасан. Шүүхийн шинжилгээний тухай хууль огт хараагүй. Н.Г шинжээч анхан шатны шүүх хурал дээр би худал дүгнэлт гаргасан байна гээд дахиад дүгнэлт гаргуулчих гээд инээж байсан. Шинжээч нар объектоо олоогүй, өөр зүйл дээр зөвхөн баримтыг үндэслэн

шинжилгээ хийж намайг буруутгаж байгаад би гомдолтой байна. Иймд давж заалдах шатны шүүхийн магадлалыг хэвээр үлдээж өгнө үү» гэв.

Мөн шүүх хуралдаанд оролцсон прокурор Д.Нарангэрэл «... Б.Жа нь Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо ...байрлалтай зуслангийн байшинг 2013 оны 05 дугаар сарын 15-ны өдөр 39 сая төгрөгөөр авсан атлаа хөрөнгө орлогын мэдүүлэгтээ мэдүүлээгүй. Дээрх үл хөдлөх хөрөнгийг өөрийн нэр дээр шилжүүлж улсын бүртгэлд бүртгүүлээгүй. Хэрэв өөрийн болон гэр бүлийн гишүүдийн орлогоосоо авсан бол хөрөнгө орлогын мэдүүлэгтээ мэдүүлэх байсан. Мөн 2013 оны 02 дугаар сарын 08-нд «Лексус 470» маркийн автомашиныг 47.500.000 төгрөгөөр худалдан авсан. Гэтэл Б.Жа сэжигтнээр өгсөн мэдүүлэгтээ «энэ машиныг хамаатны ах Ү.Сэгийн машин» гэдэг боловч мөрдөн байцаалтын явцад Ү.Сэ гэдэг хүн нь Б.Жа-ын нөхөр А.Баб-гийн ах болон үүнийг хүргэн н.Бо нь машиныг Б.Жа авсан харин эзэмшигчийн гэрчилгээг Ү.Сэ ахын нэр дээр авсан гэдгийг гэрчилдэг. Б.Жа цалингаас гадуур хууль бус орлого олсон нь мөрдөн байцаалтын шатны мэдүүлэг болон бусад нөхцөл байдлаар тогтоогдсон. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн шинжээч нарын албан тасалгаанд нэгжлэг хийхэд 2013 оны 08 дугаар сарын 7-ны өдөр Д.Эн-ын татвар ногдох орлогыг тооцоолохдоо түүний 190.544.100 төгрөгийг тайлагнаагүй гэж дүгнэж ноороглосон баримт нь илэрч гарч ирсэн. Үүнийг албан ёсоор хэрэгт хавсаргаж, бэхжүүлж авсан байгаа. Ийм нөхцөл байдал байхад Б.Жа 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдөр Д.Эн нь ногдуулах 154.031.100 төгрөг тайлагнаагүй байна гэсэн шинжээчийн дүгнэлт гаргасан.

Үүнийг үндэслэлтэй эсэх талаар бүрэлдэхүүнтэй шинжээчийн дүгнэлт гаргахад Д.Эн нь хувь хүний орлогын албан татварт 50.041.100 төгрөгийн татварт ногдох орлогоо төлөх ёстой болох нь тогтоогдсон. Тэгэхээр Б.Жа-ын гаргасан 164 тоот дүгнэлт үндэслэлгүй. Б.Жа нь шинжээчийн дүгнэлтдээ шинжилгээ хийхэд шаардлагатай дүгнэлт тооцоолол огт хийгээгүй, хувь хүний орлогын албан татварыг тооцоолж дүгнэлт гаргахдаа хэрхэн тооцооллосон нь тодорхой бус Д.Эн-ын орлогын 34.638.200 төгрөгөөр бууруулсан нь хэргийн зүйлчлэлд шууд нөлөөлж Д.Эн-ын нуусан орлогын татварт ногдох орлого их хэмжээнд хүрэхгүй учир

татвараас зайлхийсэн хэргийн хариуцлагаас чөлөөлөхөд хүргэж байна гэх хангалттай үндэслэл болж байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 342 дугаар зүйлийн 342.1-д заасны дагуу Улсын Ерөнхий прокурор 436 дугаар магадлалыг хянаад Ч.Га нарт холбогдох хэргийн Б.Жа-д холбогдох хэргийг анхан шатны шүүх үндэслэл бүхий зөв шийдвэрлэсэн байхад давж заалдах шатны шүүх үндэслэлгүй эрүүгийн хуулийг буруу хэрэглэж хэрэгсэхгүй болгож цагаатгасныг эс зөвшөөрч эсэргүүцэл бичсэн. Иймд бусад оролцогч нарт ногдуулсан ял хуульд нийцсэн. Эрүүгийн хуулийг буруу хэрэглээгүй, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчөөгүй байна. Анхан шатны шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, давж заалдах шатны шүүхийн магадлалын хэрэгсэхгүй болгож өгнө үү» гэв.

ХЯНАВАЛ:

Ялтан Ч.Га-ийг Татварын ерөнхий газрын Хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа хээл хахууль өгөгчийн ашиг сонирхлын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байхаар урьдчилан амлаж, бусдаар дамжуулж онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан,

Төрийн албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг зохион байгуулсан,

Ялтан Д.Эн-ыг Баянгол дүүргийн татварын хэлтсийн даргаар ажиллаж байхдаа төрийн албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас Ч.Га-ийн зохион байгуулсан татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт хамжигчаар хамтран оролцсон,

Татвар ногдох онц их хэмжээний орлого, эд хөрөнгөө нууж татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн,

Ялтан О.Бя, Б.Жа, Н.Чи, Б.Өс, Н.Ра, П.Га нарыг татварын улсын байцаагчаар ажиллаж байхдаа албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашиглаж, Ч.Га-ийн зохион байгуулсан, Д.Эн-ын хамжигчаар хамтран оролцож татварын байгууллагад онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт гүйцэтгэгчээр, Ч.Да-г хатгагчаар хамтран оролцсон,

Ялтан Б.Жа-ыг шинжээчийн дүгнэлтийг зориуд худал гаргаж хүнд хор уршиг

учруулсан гэмт хэрэг гэж дүгнэсэн анхан болон давж заалдах шатны шүүхийн дүгнэлт хэргийн жинхэнэ байдалтай нийцсэн, үндэслэл бүхий болжээ.

Нэг. Ялтан Ч.Га нь Татварын ерөнхий газарт ирсэн мэдээллийн дагуу 2006 оны 5 дугаар сард «ВАТТ» ХХК-ийн татвар төлөлт, ногдуулалтын байдалд хяналт шалгалт хийж байх үед албан тушаалын байдлаа ашиглан өөрийн танил Ц.Со гэгчээр дамжуулж тус компанид ногдох татвар, торгуулийн хэмжээг багасгаж, албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байхаар урьдчилан амлаж, 250.000 доллар буюу 295.500.000 төгрөгийн онц их хэмжээний хээл хахууль авахыг завдсан гэмт хэргийг үйлдсэн болох нь Ч.Га-ийн утсаар ярьсан зүйлийг тэр дор нь «ВАТТ» ХХК-ийн менежерт дамжуулж хэлсэн гэдгээ баталж мэдүүлсэн Ц.С-ын «... надад Татварын ерөнхий газарт ажилладаг танил Ч.Га-ээс өөр байхгүй. Р.Ар ямар шийдвэр гарах гэж байгаа талаар асууж өгөөч гэхээр нь Ч.Га-ээс асуухад «шалгалт дуусаж улсын байцаагчийн дүгнэлт бичигдэж байгаа. Тодорхой хэмжээний мөнгө өгвөл татварын акт, дүгнэлтийн тоог бууруулж болох талаар ярьсан. Ч.Га-ийн яриаг шууд Р.Ар-д утсаар хэлсэн. Хээл хахууль өгсөн авсан асуудлыг мэдэхгүй» гэх,

Тус компанийн дэд захирал С.Ба-гийн «...Жил гаран шалгаад 2006 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 3,6 тэрбум төгрөгийн акт, 5,4 тэрбум төгрөгийн дүгнэлт бичсэн. Акт, дүгнэлт бичигдэхээс өмнө манай ажилтан Р.Ар руу таньдаг хүнээр нь Ч.Га яриулсан байсан. Энэ яриандаа 250.000 ам.доллар өгвөл 1 тэрбум төгрөгийн акт бичлээ. Тэгэхгүй бол актын дүнг 2 тэрбум төгрөгөөр нэмнэ гэсэн байсан. Би Ч.Га гэдэг хүнд 250.000 доллар өгөхгүй гэдгээ шууд хэлсэн» гэх,

Гэрч Б.Р.Ар-ын «... Ц.Со ах надад татварын асуудлыг зохицуулаад өгч чадах байх гээд их өндөр дүнтэй тэрбум билүү, нэг сая долларын тоо яригдаад байсан санагдаж байна. Ц.Со ахын хэлсэн тоо хэмжээг шууд С.Ба-д дамжуулж хэлсэн» гэх,

Гэрч Х.Ат-ийн «... акт дүгнэлт арай эцэслэн гараагүй байхад Татварын ерөнхий газрын даргад танай байгууллага 250.000 ам.доллар хээл хахууль нэхсэн гэсэн гомдол гаргасан байсан. Ер нь Ч.Га иргэдээс мэдээлэл авч өөрийн хэлтсийн байцаагч нараар шалгуулж татвар төлөгч нарыг «дэлбэлдэг» гэж ярьдаг байсан» гэх мэдүүлэг

зэрэг тухайн хэрэгт хамааралтай бичгийн нотлох баримтуудаар нотлогдсон, шүүх Ч.Га-ийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээнд тохирсон хуульд заасан төрөл хэмжээний ялыг оногдуулсан байна.

Хоёр. Ялтан Ч.Га нь Татварын Ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн даргын албан тушаалаа урвуулан ашиглаж «КЖЭМ», «ХБЭ», «ЭЭ», «БАЭ», «ХЭ», «ШЭ» ХХК-ийн татвар төлөлт, ногдуулалтын байдлыг шалгуулахгүйн тул өөрийн төрсөн дүү Ч.Да-тэй урьдчилан үгсэн тохирч, 2010 оны 09 дүгээр сарын 27-нд Ч.Да-гийн компанийн нягтлан бодогчийн хамаатан гэх Р.Ба-аар дээрх 1 захиралтай харилцан хамаарал бүхий 6 компанийг татвар төлөхөөс зайлхийж, татвар нуун дарагдуулсан гэх хуурамч мэдээлэл өөрийнхөө нэр дээр гаргуулж, улмаар мэдээллийг шалгах нэрээр өөрийн удирдлагад ажилладаг татварын улсын байцаагч О.Бя, Б.Жа, Н.Чи, Б.Өс, Н.Ра, П.Га нараар дээрх компанийн татвар төлөлт, ногдуулалтын байдлыг шалгуулж, ямар нэгэн зөрчил, дутагдал илрээгүй гэж «илтгэх хуудас», «акт» бичүүлжээ.

Гэтэл мэдээлэл гаргасан өдөр буюу 2010 оны 09 дүгээр сарын 27-ны өглөө Чингэлтэй дүүргийн татварын хэлтсийн 9 байцаагч дээрх 1 захиралтай, харилцан хамаарал бүхий компаниудын татвар төлөлт, ногдуулалтын байдлыг шалгах шалгалтыг эхлүүлсэн боловч Ч.Га шалгалт хийж байсан хэлтсийн дарга, байцаагч нарыг өрөөндөө дуудаж мэдээллийн дагуу шалгахаар болсон учир шалгалтаа зогсоохыг шаардаж, П.Га нь босоо удирдлагадаа захирагдахгүй шалгалтыг үргэлжлүүлээ, бид шалгах ёстой хэмээн утсаар загнаж, шалгуулж байсан компанийн удирдлага нь «Татварын ерөнхий газраар шалгуулна» гээд татварын байцаагч нарыг байгууллага руугаа нэвтрүүлээгүй учир дээрх компанид татварын хяналт шалгалт хийж чадаагүй болох нь шалгалт хийхээр томилогдсон дүүргийн татварын хэлтсийн дарга болон байцаагч нарын мэдүүлгээр тогтоогдсон байна.

Мөн ялтан Ч.Га нь 2010 оны 01 дүгээр сарын 19-нд Эрүүгийн цагдаагийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу Баянгол дүүргийн татварын хэлтэст харьяалагддаг «НТГ», «УМ», «ЗУ» ХХК-ийн албан татварын ногдуулалт, төлөлтийн байдлыг яаралтай шалгах үүргийг тус дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-д албан бичгээр өгсөн

дагуу Д.Эн нь шалгалт хийлгэхэд «НТГ» ХХК нь 6.974.495.000 төгрөгийн, «УМ» ХХК 2.786.273.500 төгрөгийн, «ЗУ» ХХК нь 975.852.500 төгрөгийн татвар ногдох орлогоо нуусан зөрчил илэрч, татварын улсын байцаагч нар дүгнэлт бичиж Эрүүгийн цагдаагийн газарт шалгуулахаар хүргүүлжээ.

Ч.Га нь мөн л «мэдээлэл ирсэн» хэмээн өөрийн удирдлагад ажилладаг татварын улсын байцаагч Н.Ра, П.Га нарыг нэг нэгээр нь томилон дээрх 3 компанийн татвар төлөлтийн байдалд «давхар шалгалт» хийлгүүлсэн бөгөөд Н.Ра, П.Га нар дүүргийн татварын хэлтсийн байцаагч нар үндэслэлгүй дүгнэлт бичсэн байна гэж шалгалтын дүнгээ танилцуулж илтгэх хуудас бичсэн байна.

Ч.Га нь уг илтгэх хуудсыг Баянгол дүүргийн Татварын хэлтэс рүү хүргүүлж учрыг нь олохыг даалгасан дагуу тус хэлтсийн дарга Д.Эн Татварын ерөнхий хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасныг зөрчиж дээрх илтгэх хуудсыг үндэслэн тушаал гаргаж татварын улсын байцаагч нарын бичсэн 3 дүгнэлтийг хүчингүй болгожээ.

Мөн цагдаагийн байгууллага татварын улсын байцаагч Н.Ра, П.Га нарын бичсэн илтгэх хуудас болон дүүргийн татварын хэлтсийн дарга Д.Эн-ын тушаалыг үндэслэн дээрх 3 компанид холбогдох албан татвар төлөхөөс зайлсхийсэн эсэх асуудлыг мөрдөн шалгахыг зогсоосон нь мөрдөн байцаалтаар тогтоогдсон байна.

Мөрдөн байцаагчийн тогтоолоор татварын улсын байцаагч О.Бя, Б.Жа, Б.Өс, Н.Ра, П.Га, Н.Чи нарын бичсэн илтгэх хуудас, акт үндэслэлтэй эсэхийг магадласан шинжээч нар «ХБЭ» ХХК-нд 489.998.900 төгрөгийн, «ЭЭ» ХХК-нд 315.476.800 төгрөгийн, «БАЭ» ХХК-нд 217.700.600 төгрөгийн, «ХЭ» ХХК-нд 896.964.100 төгрөгийн, «КЖЭМ» ХХК-нд 11.431.656.900 төгрөгийн, «ШЭ» ХХК-нд 46.900.800 төгрөгийн, нийт 13.398.688.100 төгрөгийн татварыг ногдуулах ёстой байсныг ногдуулаагүй болохыг тогтоосон бөгөөд шинжээч нар дүгнэлт гаргахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг зөрчөөгүй байх тул ялтан, түүний өмгөөлөгч нарын «шинжээч хууль зөрчилж дүгнэлт гаргасан» гэх гомдлыг хангах үндэслэлгүй болно.

Иймд Татварын ерөнхий газрын хяналт шалгалт, арга зүйн хэлтсийн татварын улсын байцаагч О.Бя, Б.Жа, Б.Өс, Н.Ра, П.Га, Н.Чи нарыг Татварын ерөнхий хуулийн 33

дугаар зүйлийн 33.2.6-д заасан «...татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих» гэсэн заалтыг зөрчиж, татварын улсын байцаагчийн хуулиар олгогдсон эрх мэдлийг урвуулан ашиглаж, Ч.Га-ийн зохион байгуулсан дээрх гэмт хэрэгт гүйцэтгэгчээр хамтран оролцсон гэж дүгнэсэн хоёр шатны шүүхийн дүгнэлт үндэслэл бүхий болжээ.

Баянгол дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагч С.Ба-гийн «...хэлтсийн даргын томилсон дагуу «БАЭ», «ХБЭ» ХХК-ийг шалгах гэсэн боловч «Татварын ерөнхий газраар шалгуулна» гээд шалгуулаагүй. Бид нарыг Татварын ерөнхий газрын хэлтсийн дарга Ч.Га өрөөндөө дуудаж «томилолтгүй аж ахуйн нэгж дээр очиж дарамталлаа, шалгалтаа зогсоо, манайх шалгана» гэж загнасан үйл баримтыг гэрчилсэн асуудал нь «ЭЭ» ХХК-ийн татвар ногдуулалт, төлөлтийн байдлын талаар шинжээчийн дүгнэлт гаргахаас татгалзах, татгалзагдан гарах үндэслэл болохгүй гэж шүүх хуулийг зөв тайлбарлан дүгнэсэн байна.

Шинжээч С.Ба нь «ЭЭ» ХХК-ийн татварын төлөлт, ногдуулалтын байдлыг өмнө нь шалгаж байгаагүй, түүний шалгасан материалыг үндэслэн Ч.Га нарт холбогдох эрүүгийн хэргийг үүсгээгүй байх тул ялтан, иргэний хариуцагч, тэдний өмгөөлөгч нарын гаргасан «шинжээчийн дүгнэлт илт хууль бус тул нотлох баримтаар үнэлэх ёсгүй» гэх гомдлыг хангах үндэслэлгүй болно.

Ийнхүү шинжээчийн дүгнэлтээр анх шалгалт хийсэн Баянгол дүүргийн татварын хэлтсийн улсын байцаагч нарын бичсэн дүгнэлт үндэслэлтэй болох нь нотлогдсоны дээр Ч.Га, Д.Эн, Н.Ра, П.Га нарын албаны эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашигласан хууль бус үйлдлийн улмаас «НТГ», «УМ», «ЗУ» ХХК-наас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдаж, шилжүүлж авсан гэх «ПС» буюу одоогийн «ПВР» компани нь албан татвар төлөхгүй байх нөхцлийг бий болгож, 1.021.587.453 төгрөгийн онц их хэмжээний татварыг төлүүлээгүй үйл баримт тогтоогдсон бөгөөд уг гэмт хэргийг Ч.Га зохион байгуулж, Д.Эн-ыг хамжигчаар, Ч.Да-г хатгагчаар хамтран оролцсон, ялтан О.Бя, Б.Жа, Н.Чи, Б.Өс, Н.Ра, П.Га нарыг гардан гүйцэтгэсэн гэж дүгнэсэн анхан болон давж заалдах шатны

шүүхийн дүгнэлт хэргийн жинхэнэ байдалтай нийцсэн, үндэслэл бүхий болсон байна гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Шүүх Ч.Га нарт холбогдох дээрх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийг буруу хэрэглээгүй, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчөөгүй байна.

Ялтан Ч.Га нар нь гэмт хэрэг үйлдэх замаар «УМ», «НТГ», «ЗУ» ХХК-нд ногдуулсан албан татварыг төлүүлээгүй, «КЖЭМ» ХХК болон түүнтэй хамаарал бүхий «ХБЭ», «ЭЭ», «БАЭ», «ХЭ» «ШЭ» компанийг албан татвар төлөхгүй байх, төлөхөөс зайлсхийх боломжийг олгосон нь тогтоогдсон тул мөрдөн байцаалтын шатанд «КЖЭМ», «ППС» ХХК-ийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 44 дүгээр зүйлд зааснаар иргэний хариуцагчаар татаж, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг хариуцуулахаар үндэслэлтэй зөв шийдвэрлэжээ.

Шинжээчийн дүгнэлтээр дээрх нэр бүхий аж ахуйн нэгжид ногдуулсан татварыг төлөх ёстой, хариуцвал зохих этгээд нь «КЖЭМ», «ППС» компаниуд болохыг тогтоосон тул иргэний хариуцагчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нарын «нэхэмжлэлийг зөвшөөрөхгүй» гэсэн агуулгатай хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлыг хангах үндэслэлгүй байна.

Харин иргэний хариуцагч нараас төлбөр гаргуулахдаа тухайн асуудлыг зохицуулсан ерөнхий заалтыг баримталж, нарийвчилсан зохицуулалтыг хэрэглээгүй байх тул зөвтгөх нь зүйтэй.

Гурав. Ялтан Д.Эн нь мөрдөн байцаалтын явцад албан тушаалын цалингаас гадна автомашины худалдаа эрхэлж, үл хөдлөх хөрөнгө түрээслэх, мөнгө хүүлэх зэргээр орлого олдог байсан нь тогтоогдсон бөгөөд тэрээр 2008 онд 19.000.000 төгрөгийн, 2009 онд 241.750.000 төгрөгийн, 2010 онд 9.851.000 төгрөгийн, 2011 онд 139.322.500 төгрөг, 2012 онд 90.489.600 төгрөгийн, нийт 500.413.100 төгрөгийн орлого олсон атлаа татварын албанд бүрэн тайлагнаагүй, тоо хэмжээг нь зориуд бууруулан мэдээлж 50.041.300 төгрөгийн онц их хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн болох нь түүнийг 2008-2011 онд «ЖМ» ХХК-нд 1.6-2 хувийн хүүтэй 1.350.000 ам.доллар буюу 1.815.004.000 төгрөгийн зээл олгож, зээлийн хүүнд 208.800.400 төгрөг, 2011-2012 онуудад АНУ-аас импортоор оруулж ирсэн 6 ширхэг «Лексус 570» маркийн автомашин худалдаж 974.744.200 төгрөгийн

орлого, үл хөдлөх хөрөнгө худалдаж 665.918.900 төгрөг, үл хөдлөх хөрөнгө түрээслүүлж 86.693.600 төгрөг, тогтмол бус үйл ажиллагаанаас 30.500.000 төгрөг, нийт 3.781.661.000 төгрөгийн орлогыг татварын тайланд тусгалгүй нууж, албан татвар төлөөгүй» болохыг тогтоосон татварын улсын байцаагчийн 250041 тоот дүгнэлт,

Гэрч Д.Цэ, Г.Чн нарын «ЖМ» компани Д.Эн-аас 2008 оны 12 сард 250.000 доллар, 2009 оны 7 сард 300.000 доллар, 2010 оны 1 сард 400.000 доллар, 2011 оны 500.000 доллар зээлсэн», «Д.Эн-аас долларыг 2 хувийн хүүтэй, төгрөгийг 1.6 хувийн хүүтэй зээлдэг байсан»-ыг баталсан мэдүүлгүүд, шинжээч Ц.С-гийн «...Д.Эн нь 2008-2012 оныг дуустал хугацаанд 50.041.300 төгрөгийн татвар ногдох орлогоо тайлагнаагүй, бууруулан тайлагнаж онц их хэмжээний татвараас зайлсхийсэн» гэх мэдүүлэг болон Д.Эн-аас автомашин худалдаж авсан гэрч Н.Цэр, Д.Бт, Б.Баб нарын мэдүүлэг, Д.Эн-ын 2 машиныг зарж өгсөн гэх гэрч Д.Га-ын мэдүүлэг, Д.Эн-ын «ГП» цогцолборын 132 м/кв талбайг түрээслэгч П.Ур-ийн мэдүүлэг зэрэг тухайн хэрэгт хамааралтай бичгийн нотлох баримтуудаар тогтоогдсон байна.

Дөрөв. Б.Жа нь Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Эдийн засгийн шинжилгээний хэлтсийн даргаар ажиллаж байхдаа иргэн Д.Эн-ыг татвар төлөхөөс зайлсхийсэн эсэх талаар шинжээчээр томилогдож дүгнэлт гаргахдаа «Д.Эн-ын татварт төлбөл зохих 50.041.300 төгрөгийг 34.638.200 төгрөгөөр зориуд санаатай бууруулж «хувь хүний орлогын албан татварт 15.403.100 төгрөг төлөхөөс зайлсхийсэн» гэж 2013 оны 08 дугаар сарын 21-ний өдөр 164 дугаартай дүгнэлтийг зориуд санаатайгаар худал гаргасан нь шинжээч Ц.С-гийн «... Б.Жа-ын иргэн Д.Эн-д холбогдуулан бичсэн дүгнэлтийн ажлын баримтыг үзэхэд хувь хүний орлогын албан татварын тооцоолол гэх зүйлийг огт хийгээгүй, дүгнэлтээ хэрхэн гаргасан нь тодорхой бус байсан. Бид шинжээч Б.Жа-ын ашигласан ажлын баримт болон Д.Эн-ын өмгөөлөгч нарын гаргаж өгсөн баримт, тайлбарыг үндэслэн 50.041.300 төгрөгийн хувь хүний орлогын албан татвар төлөхөөс зайлсхийсэн болохыг тогтоосон» гэх мэдүүлэг, шинжээчийн 2013 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн дүгнэлт болон Д.Эн нь «ЖМ» ХХК-нд 2008-2011 онд нийт 1.450.000 долларыг 2 хувийн хүүтэй зээлж ашиг олсон болохыг гэрчилсэн тус

компанийн санхүү эрхэлсэн захирал, нягтлан бодогч нарын мэдүүлэг зэргээр нотлогдож, «Б.Жа-ын тооцоолол үндэслэлгүй» болох нь тогтоогдсон гэсэн анхан шатны шүүхийн дүгнэлт хэргийн жинхэнэ байдалтай нийцжээ.

“Д.Эн нь татвар ногдох 154.031.100 төгрөгийн орлогоо тайлагналгүй нууж, хувь хүний орлогын албан татварт 15.403.100 төгрөгийн “үлэмж” хэмжээний татвар төлөхөөс зайлсхийсэн” гэх шинжээч Б.Жа-ын дүгнэлт ялтан Д.Эн-ыг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөгдөх үр дагаврыг бий болгосон байна.

Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд заасан «Татвар төлөхөөс зайлсхийх» гэмт хэрэгт татвар ногдох «их» хэмжээний орлогоо нууж, тоо хэмжээг зориуд бууруулж мэдээлсэн үйлдлийг тооцох бөгөөд үлэмж хэмжээний хохирол учруулсан үйлдэл нь гэмт хэрэг биш юм.

Гэтэл давж заалдах шатны шүүх мөрдөн байцаалтаар тогтоогдсон дээрх үйл баримтад «...Б.Жа-ын гэмт хэрэг үйлдэх болсон сэдэлт, санаа зорилго юу байсан, ямар шалтгаанаар Д.Эн-ын эрх ашигт нийцүүлж худал дүгнэлт гаргасан болохыг хөдөлбөргүй тогтоогоогүйн дээр зөрүү гарсан байдал нь санаатай худал дүгнэлт гаргасан гэхээс илүү алдаатай, буруу дүгнэлт гэж үзэхээр байна» гэж хэргийн жинхэнэ байдалд нийцээгүй үндэслэл муутай дүгнэлт хийж түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон нь үндэслэлгүй байна.

Иймд Улсын ерөнхий прокурорын бичсэн эсэргүүцлийн энэ хэсгийг хүлээн авч, Б.Жа-д холбогдох Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 254.2-д заасан хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж хэрэгсэхгүй болгосон давж заалдах шатны шүүхийн магадлалын холбогдох заалтыг хүчингүй болгох нь зүйтэй.

Тав. Анхан болон давж заалдах шатны шүүх ялтан Ч.Га, Д.Эн нарыг албан тушаалын цалингаас өөр орлогын эх үүсвэргүй атлаа бусдын нэрээр төгрөгийн болон гадаад валютын данс нээлгэж орлого, зарлагын гүйлгээ хийж, тансаг зэрэглэлийн автомашин, үнэтэй хувийн орон сууц, зуслангийн байшин, хөөрөг худалдан авах зэргээр хууль ёсны орлогоосоо гадна онц их хэмжээний орлого олж үндэслэлгүй хөрөнгөжих гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийг буруу хэрэглэж ял шийтгэл ногдуулсан байна.

Хууль тогтоогч нийтийн албан тушаалтан нь хууль ёсны орлого буюу

цалин хөлс, түүнтэй холбоотой урамшуулал, хуулиар хориглоогүй үйл ажиллагаа эрхэлж олсон орлогоос гадна их хэмжээний орлого олсон боловч түүнийхээ эх үүсвэрийг тодорхойлж чадаагүй үйлдлийг «хууль бусаар хөрөнгөжих» гэмт хэрэгт тооцохоор 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр шинээр хуульчилсан бөгөөд уг хуулийг 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр заажээ.

Өөрөөр хэлбэл, төрийн албан хаагч 2012 оны 05 дугаар сарын 01-нээс хойш олсон орлогынхоо эх үүсвэрийг зааж чадаагүй үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан болно.

Гэтэл хоёр шатны шүүх Ч.Га-ийг эцгийнхээ нэр дээр «Голомт» банкинд 2008 оны 7 дугаар сарын 16-ны өдөр америк долларын, 2010 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр төгрөгийн хадгаламжийн данс нээлгэн орлого, зарлагын гүйлгээ хийж, нийтдээ 1.362.655 америк доллар, 1.073.951.176 төгрөгийн орлогыг хууль бусаар олж, түүгээрээ 2007-2012 оны хооронд 635 сая төгрөгийн үнэ бүхий 6 ширхэг автомашин, 825.375.400 төгрөгийн үнэ бүхий 257.8 м/кв талбайтай хувийн орон сууц, 58 сая төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг шүрэн толгойтой манан хөөрөг зэргийг худалдан авах зэргээр нийт 1.493.307.200 төгрөгийн орлогыг хууль бусаар олж хөрөнгөжсөн,

Д.Эн-ыг «Голомт» банкны хувийн харилцах дансаар 2012 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс 2013 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 53.900.000 төгрөг, америк долларын харилцах дансаар 32.430 америк долларын орлого оруулсан, 493.822.000 төгрөгийн үнэ бүхий орон сууц худалдаж авч, нийт 592.835.500 төгрөгийн орлогыг хууль бусаар олж хөрөнгөжсөн гэж дүгнэн ялтан нарын эрх зүйн байдлыг эрс дордуулсан Эрүүгийн хуулийг буцаан хэрэглэж, тухайн үед мөрдөгдөж байсан хуулиар гэмт хэрэгт тооцогдоогүй байсан үйлдлийг гэмт хэрэгт тооцсон нь үндэслэлгүй байна.

Ч.Га, Д.Эн нар хууль бусаар хөрөнгөжих гэмт хэргийг хуульчлагдахаас өмнө дээрх эд хөрөнгийг олж авсан нь мөрдөн байцаалтаар тогтоогдсон бөгөөд тэдний үйлдэл гэмт хэрэгт тооцогдох ёсгүй тул шийтгэх тогтоол, магадлалын тэдэнд холбогдох хэсгийг хүчингүй болгох нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Мөрдөн байцаалт болон прокурор,

шүүхийн шатанд Ч.Га, Д.Эн нарын хууль бусаар хөрөнгөжсөн гэх цаг хугацааг буруу тогтоож гэмт хэрэг гарсан байдлыг тодорхойлж чадаагүйн дээр хэрэгт цугларсан Ч.Га, Д.Эн нарын өмч хөрөнгийн талаарх мэдээлэл, лавлагаа, гэрч нарын мэдүүлэг зэрэг бичгийн нотлох баримтад ач холбогдол өгч үнэлж дүгнэж чадаагүй байна.

Тухайлбал, мөрдөн байцаагчийн хууль бусаар олсон орлого гэж тооцож битүүмжилсэн Ч.Га-ийн эцэг У.Ч-ийн «Голомт» банкны долларын болон төгрөгийн хадгаламжийн дансыг 2008 он болон 2010 онд анх нээлгэсэн бөгөөд автомашиныг 2007-2012 онд, шүрэн толгойтой 2 ширхэг халтар манан хөөргийг 2011 он болон 2012 оны эхээр тус тус худалдан авсан нь хэрэгт цугларсан нотлох баримтаар тогтоогдсон болно.

Мөн Ч.Га нь 2008 оны хөрөнгө орлогын мэдүүлэгтээ 91 сая төгрөгтэй гэж мэдүүлсэн бол 2009 онд 94.1 сая төгрөг, 2010 онд 142 сая төгрөг, 2011 онд 200 сая төгрөгтэй хэмээн мэдүүлсэн бөгөөд эхнэр Б.Б нь 2008 оноос өнөөдрийг хүртэл Япон улсын "NPO" олон улсын боловсролыг дэмжих нийгэмлэгийн тэтгэлгээр докторантурт суралцаж, 2008-2013 оныг хүртэлх хугацаанд 13.250.000 иений тэтгэмж авсан зэргээр хууль үйлчлэхээс өмнө тодорхой орлоготой, хуримтлалтай байсан, эцгийнхээ нэрээр 2008 онд нээсэн данснаас дүү Ч.Г-аар мөнгө авахуулж «РГ» хотхон дахь 257.8 м/кв орон сууцыг худалдаж авсан нь мөрдөн байцаалтаар тогтоогджээ.

Д.Эн-ын хувьд 2005 онд «АБ» архины үйлдвэрийг Д.Бс гэгчид 30 орчим сая төгрөгөөр худалдаж, 2008 оноос «ЖМ» ХХК-ийн эргэлтийн хөрөнгөд хэрэглэх мөнгө зээлж, АНУ-аас тансаг зэрэглэлийн автомашин импортолж худалдах, үл хөдлөх хөрөнгө түрээслэх зэргээр тодорхой хэмжээний орлогын эх үүсвэртэй байсан нь мөрдөн байцаалтаар тогтоогдсон бөгөөд тэрээр 2008 оны хөрөнгө орлогын мэдүүлэгтээ 2007 оны орлогоо 127.882.294 төгрөг гэж тайлагнаж, 5 үл хөдлөх хөрөнгө, 2 тээврийн хэрэгсэл, хүүхдийнхээ нэр дээр 5 банк болон хадгаламж зээлийн хоршоонд 215 сая төгрөг, 4.000 долларын хадгаламжтай гэж мэдүүлсэн байна.

Тэрээр 2008-2012 оныг дуусах хүртэлх хугацаанд 500.413.100 төгрөгийн орлого олсон боловч орлогоо нууж албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн гэмт хэрэгт

шийтгүүлж байгааг дурдах нь зүйтэй.

Харин давж заалдах шатны шүүх Б.Жа-ыг өөрийн болон гэр бүлийн гишүүний хууль ёсны орлогоороо буюу цалингийн зээл авч, орон сууцаа худалдсан мөнгөний үлдэгдэл, нөхөр А.Баб-гийн хүнд даацын машинаар нүүрс, ачаа тээвэрлэж олсон орлогоор «Лексус 470» маркийн автомашин, ...-ын аманд зуслангийн сууц худалдаж авсан нь нотлогдсон гэж дүгнээд түүнд холбогдох Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270¹.2-т заасан хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, хуулийг зөв хэрэглэжээ.

Зургаа. Анхан шатны шүүх Б.Бу-ийг татварын улсын ахлах байцаагчаар ажиллаж байхдаа «АФ» ХХК-нд 3.747.357.300 төгрөгийн төлбөр ногдуулсан татварын улсын байцаагчийн дүгнэлтийг Маргаан таслах комиссоор баталгаажиж хүчин төгөлдөр болсон байтал хүргүүлэхгүй дарагдуулж тус компанийг татвар төлөхөөс зайлсхийх боломж олгосон, Ч.Га нь ахлах байцаагч Б.Бу-ийн дээрх үйл ажиллагаанд хяналт тавих үүргээ зохих ёсоор биелүүлэлгүй албан үүрэгтээ тус тус хайнга хандсан гэх үйлдлийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж хэрэгсэхгүй болгож, Татварын ерөнхий газрын нэхэмжилсэн 3.7 тэрбум төгрөгийн нэхэмжлэлийг хангах үндэслэлгүй болохыг нотлох баримтад тулгуурлан үндэслэлтэй шийдвэрлэсэн байна.

Мөн «ЭҮ» ХХК-ийн Ерөнхий захирлын эдийн засгийн асуудал эрхэлсэн орлогч Б.Жал, Ерөнхий нягтлан бодогчийн орлогч Х.Ха нарыг бүлэглэж «ЭҮ»-ийн татварын үр ашигт байдалд зөвлөх үйлчилгээ авсан ажлын хөлсийг үндэслэлгүй нэмэгдүүлж 547.496.659 төгрөг илүү олгож, Ч.Да нь 547.496.659 төгрөгийг завшиж «ЭҮ»-т онц их хэмжээний хохирол учруулсан,

Мөн нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, санхүүгийн тайлан бэлтгэлийн талаар сургалт явуулах боловсон хүчингүй «СА» ХХК-тай сонгон шалгаруулалт явуулалгүй шууд гэрээ байгуулж, урьдчилгаанд 38.400.000 төгрөг шилжүүлж, Ч.Да нь 20.400.000 төгрөг завшиж, байгууллагын хөрөнгийг онц их хэмжээгээр үрэгдүүлсэн гэх хэргийг үйлдсэн болох нь нотлогдож тогтоогдоогүй гэсэн үндэслэлээр тэдэнд холбогдох хэргүүдийг хэрэгсэхгүй болгож, Б.Жал, Х.Ха нарыг цагаатгахдаа хэрэгт цугларсан нотлох баримтыг зөв үнэлж үндэслэлтэй шийдвэрлэжээ.

Иймд ялтан Ч.Га, Д.Эн нарын өмгөөлөгч Г.Оюунцэцэг, Ц.Ундрах, Х.Баасанжаргал нарын «Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270¹.2-д заасан хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү» гэсэн гомдлыг хангаж,

Ялтан Ч.Га, Д.Эн, П.Га, Н.Ра, Н.Чи, О.Бя, Б.Жа, Б.Өс нар болон тэдний өмгөөлөгч Г.Оюунцэцэг, Ц.Ундрах, Х.Баасанжаргал, Ж.Батзоригт, Х.Цогтсайхан, К.Бауаржан нарын «хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож цагаатгаж өгнө үү» гэсэн агуулгатай гомдлуудыг,

“Иргэний хариуцагчаар татсан нь үндэслэлгүй, татварын өр төлбөр нь Ч.Га нарт холбогдох хэрэгт хамааралгүй, шүүх татварын асуудлыг холбогдох хуулиар нь шийдвэрлэх ёстой” гэсэн иргэний хариуцагч “ПВР” ХХК-ийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээ, “КЖЭМ” ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Б нарын гомдлыг тус тус хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Улсын Ерөнхий прокурорын Б.Жа-д холбогдуулж бичсэн эсэргүүцлийн «... давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэж Б.Жа-ын хууль бусаар хөрөнгөжсөн үйлдлийг хэрэгсэхгүй болгосон» гэх хэсгийг мөн хэрэгсэхгүй болгохоор шийдвэрлэлээ.

Харин анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэн ялтан Ч.Да-гийн хувийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал болон оногдуулсан хорих ялаас 391 хоног буюу 1/3 хувийг биечлэн эдэлсэн зэргийг харгалзан оногдуулсан ялыг тэнсэж, ялтны өмгөөлөгч нарын хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлыг хангах нь зүйтэй.

Мөн ялтан Ч.Га, Д.Эн нарт Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлд зааснаар ял оногдуулахдаа тэдний гэмт хэрэгт хамтран оролцсон байдлыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасныг журамлан оновчтой бус тогтоосон тул зөвтгөх шаардлагатай байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.2-д заасныг удирдлага болгон Монгол Улсын Дээд шүүхийн эрүүгийн хэргийн хяналтын шатны шүүх хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 261 дүгээр шийтгэх тогтоолд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулсугай. Үүнд:

1.1. Шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт “Ч.Га, Д.Эн нарт холбогдох Эрүүгийн хуулийн

270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэгт заасан хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгосугай” гэсэн,

Шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 10 дахь заалтад «Ч.Да-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсэгт заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар оногдуулсан аудитор хийх эрхийг 3 жил хасаж 3 жил хорих ялыг тэнсэж, 3 жилийн хугацаагаар хянан харгалзсугай» гэсэн нэмэлт тус тус оруулсугай.

1.2. Шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 2, 3 дахь заалтын Ч.Га, Д.Эн нарт Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2} дахь хэсэгт зааснаар гэм буруутайд тооцож ял шийтгэл оногдуулсан хэсгүүдийг тус тус хүчингүй болгосугай гэж,

1.3. Шийтгэх тогтоолын 3 дахь заалтын «Ч.Га-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасныг журамлан” гэснийг «Ч.Га-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3-д заасныг журамлан” гэж,

Мөн заалтын «Д.Эн-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.1-д заасныг журамлан» гэснийг «Д.Эн-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5-д заасныг журамлан» гэж,

Мөн заалтын «Д.Эн-д Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2-т зааснаар 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж 7 жил 6 сар хорих ял» гэснийг «Д.Эн-д Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2-т зааснаар 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж 5 жил 6 сар хорих ял шийтгэсүгэй» гэж,

1.4. Шийтгэх тогтоолын 4 дэх заалтыг “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар Ч.Га-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3-д заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2-д зааснаар оногдуулсан татварын улсын байцаагч хийх эрхийг 5 жил хасаж 5 жил хорих ял дээр Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 32 дугаар зүйлийн 32.1, 60 дугаар зүйлийн 60.3-д заасныг журамлан 268 дугаар зүйлийн 268.2-д зааснаар оногдуулсан 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж 3 жил 4 сар хорих ялын зарим болох 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж 2 жил хорих ялыг нэмж, Ч.Га-ийн биечлэн эдлэх ялыг 100.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, татварын

улсын байцаагч хийх эрхийг 5 жил хасаж, 7 жил хорих ялаар тогтоосугай” гэж,

“Д.Эн-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5-д заасныг журамлан 263 дугаар зүйлийн 263.2-д зааснаар оногдуулсан татварын улсын байцаагч хийх эрхийг 5 жил хасаж 5 жил хорих ял дээр Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2-т зааснаар оногдуулсан 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж 5 жил 6 сар хорих ялын зарим болох 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж 6 сар хорих ялыг нэмж, Д.Эн-ын биечлэн эдлэх ялыг 50.000.000 төгрөгийн эд хөрөнгө хурааж, татварын улсын байцаагч хийх эрхийг 5 жил хасаж, 6 жил хорих ялаар тогтоосугай” гэж,

1.5. Шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 7 дахь заалтыг “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.3-д зааснаар Б.Жа-ын цагдан хоригдсон 150 хоногийн нэг хоногийг одоо мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192.000 төгрөгөөр тооцож, түүнд Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 254.2-д зааснаар оногдуулсан хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 150 дахин буюу 21.060.000 төгрөгөөр торгосон ялыг эдэлсэнд тооцсугай” гэж,

1.6. Шийтгэх тогтоолын 9 дэх заалтыг бүхэлд нь хүчингүй болгосугай гэж,

1.7. Шийтгэх тогтоолын 11 дэх заалтын “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д зааснаар” гэснийг “Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 122 дугаар зүйлийн 122.1, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.3, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д зааснаар” гэж,

1.8. Шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 12 дахь заалтыг “Ч.Га-ийн Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ..., ...тоот орон сууцыг, Д.Эн-ын Сүхбаатар дүүргийн ...дүгээр хороо, ...гудамжны ...дугаар байрны ...тоот орон сууцыг тэдэнд оногдуулсан эд хөрөнгө хураах нэмэгдэл ял болон төлбөрт тооцуулахаар Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж, тэдний бусад эд хөрөнгийг битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгосугай” гэж тус тус өөрчилсүгэй.

2. Давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 436 дугаар магадлалын тогтоох хэсгийн 1 дэх заалтын Б.Жа-д холбогдох Эрүүгийн хуулийн 254 дүгээр зүйлийн 254.2

дахь хэсэгт заасан хэргийг хэрэгсэхгүй болгосон хэсгийг бүхэлд нь хүчингүй болгосугай.

3. Ялтан Ч.Га, түүний өмгөөлөгч Г.Оюунцэцэг, А.Ундрах, ялтан Д.Эн, түүний өмгөөлөгч Х.Баасанжаргал, ялтан П.Га, Н.Ра, тэдний өмгөөлөгч Ж.Батзоригт, ялтан Б.Өс, түүний өмгөөлөгч Б.Цэнгүүн, ялтан Н.Чи, түүний өмгөөлөгч Х.Цогтсайхан, ялтан Б.Жр, түүний өмгөөлөгч К.Бауиржан, ялтан О.Бя, түүний өмгөөлөгч Г.Мөнхбат, ялтан Ч.Да, түүний өмгөөлөгч С.Оюунцэцэг, Ц.

Гансүх, иргэний хариуцагч «ПВР» ХХК-ийн өмгөөлөгч С.Цэрэнжээ, иргэний хариуцагч «КЖЭМ» ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Бая нарын хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлуудыг,

Улсын Ерөнхий прокурорын 2014 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 1/01 дугаартай эсэргүүцлийн «...Б.Жр-д Эрүүгийн хуулийн 270¹ дүгээр зүйлийн 270^{1.2}-д зааснаар ял оногдуулсан шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, магадлалыг хүчингүй болгуулах” тухай хэсгийг тус тус хэрэгсэхгүй болгосугай.

ДАРГАЛАГЧ,
ТАНХИМЫН ТЭРГҮҮН
ШҮҮГЧ

С.НЯМЖАВ
Б.ЦОГТ

ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 08 сарын 19 өдөр

Дугаар 1025

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Д.Алтанжигүүр даргалж, шүүгч Г.Алтанцэцэг, шүүгч Л.Баатар нарын бүрэлдэхүүнтэй,

Улсын яллагч Н.Амарсанаа, Р.Очирсүрэн,
Иргэдийн төлөөлөгч Ж.Нарантуяа, М.Өлзийхүү, Ж.Шагдарсүрэн,
Нарийн бичгийн дарга Э.Гансугар,
Хохирогч, иргэний нэхэмжлэгч П.А, Н.Мөнхсүрэн,
Гэрч Б.А, П.Б, Т.Бая, Ч.З, Н.Мя, Б.Со,
Шүүгдэгч С.Б, түүний өмгөөлөгч Ж.Батхүү, Б.Эрдэнэбулган,
Шүүгдэгч М.Б, түүний өмгөөлөгч Х.Цогтсайхан,
Шүүгдэгч Г.Н, түүний өмгөөлөгч Х.Базаррагчаа,
Шүүгдэгч Д.Э, түүний өмгөөлөгч Д.Батбаатар, К.Бауиржан, М.Хувцагаан нарыг оролцуулан тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар Дүүргийн 2 дугаар прокурорын газраас шүүгдэгч С.Б, Г.Н, Д.Э нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 166¹ дүгээр зүйлийн 166¹.3, 263 дугаар зүйлийн 263.2, шүүгдэгч М.Б-од Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 166¹ дүгээр зүйлийн 166¹.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн 20130100017. дугаартай хэргийг 2014 оны 07 дугаар сарын 29-ний өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт:

1. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр, Төв аймагт төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, нисгэгч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр хүүхдийн хамт, Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо, ...дүгээр ...тоотод оршин суух, 1972-1975 онд онгоцны нэгдсэн засварын газарт механикч, 1975-1977 онд ОХУ-ын Омск хотын нисэхийн дунд сургуульд суралцаж төгссөн, 1977-1984 онд М нэгтгэлийн ой, хөдөө аж ахуй скайдрилийн АН2 онгоцны нисгэгч, 1984-1988 онд ОХУ-ын Санктпетрбург хотын Иргэний нисэхийн академид суралцаж төгссөн, 1988-1990 онд Баянхонгор аймгийн агаарын тээврийн газрын дарга, 1990-1992 онд М нэгтгэлийн нислэгийн хэлтсийн дарга, нислэг эрхэлсэн орлогч, нислэгийн албаны дарга, 1992-1997 онд М нэгтгэлд АН24, АН26 онгоцны дарга нисгэгч, 1997-2001 онд ИНЕГ-ын Захиргаа, хүний нөөцийн хэлтсийн дарга, 2001-2006 онд ИНЕГ-ын Нисэх буудал хариуцсан ерөнхий менежер, 2006-2012 оны 12 дугаар сар хүртэл ИНЕГ-ын дарга, 2012 оны 12 дугаар сараас 2013 оны 06 дугаар сар хүртэл ИНЕГ-ын сургалт, дадлагын цогцолборын сургалтын менежерээр тус тус ажиллаж байсан, одоо эрхэлсэн тодорхой ажилгүй, улсаас 2002 онд “Алтангадас

одон”, 2011 онд “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон” медалиудаар тус тус шагнагдсан, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай С овогт С.Б /РД: ВЭ...../,

2. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Дархан-Уул аймагт төрсөн, эмэгтэй, ...настай, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл ..., нөхөр хүүхдүүдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, 1996 онд Иргэний агаарын тээврийг удирдах газрын харьяа Нислэг хөдөлгөөн удирдах үндэсний төвд нягтлан бодогч, 1998 онд Иргэний агаарын тээврийн удирдах газарт ерөнхий нягтлан бодогч, 2007 оноос Иргэний нисэхийн ерөнхий газарт санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга, 2009-2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдөр хүртэл ИНЕГ-ын санхүү, эдийн засгийн ерөнхий менежерээр ажиллаж байсан, одоо “Х-Э” ХХК-нд дэд захирал ажилтай, 2004 онд Санхүү банкны тэргүүний ажилтан, 2006 онд Иргэний агаарын тээврийн тэргүүний ажилтан, улсаас 2007 онд Улсын шилдэг нягтлан бодогч, 2010 онд Алдарт эхийн 2-р одон медалиудаар тус тус шагнагдсан, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, Г овогт Г.Н /РД: ЧП...../,

3. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар

сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, агаарын тээврийн менежмент мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, 1999 оны 09 дүгээр сараас Буянт-Ухаа Олон улсын нисэх буудалд шуурхай диспетчер, 2000 оны 02 дугаар сарын 01-нээс Буянт-Ухаа нисэх буудалд үйлдвэрлэлийн шуурхай удирдлагын хэлтсийн дарга, 2002 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс 2010 оны 05 дугаар сар хүртэл Буянт-Ухаа нисэх буудлын үйлчилгээний албаны дарга, 2010 оны 05 дугаар сараас 2013 оны 06 дугаар сарын 03-ны өдөр хүртэл ИНЕГ-ын Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежер, газрын даргаар ажиллаж байсан, одоо эрхэлсэн тодорхой ажилгүй, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, У овогт Д.Э /РД: ШЕ...../.

4. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Говь-Алтай аймагт төрсөн, эрэгтэй, ...настай, дээд боловсролтой, электроникийн инженер мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, 2005 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдөр хүртэл "ЧХ" олон улсын буудалд программ сүлжээний инженерээр ажиллаж байсан, одоо "ЭС" ХХК-ийн гүйцэтгэх захирал ажилтай, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай, С овогт М.Б /РД: ДБ...../.

Холбогдсон гэмт хэргийн талаар:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Б, санхүү, эдийн засгийн ерөнхий менежерээр ажиллаж байсан Г.Н, Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежер, газрын даргаар ажиллаж байсан Д.Э нар нь:

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Б-ийн 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/262 тоот тушаалаар ИНЕГ-ТББ/Б-73/11 тоот «Нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж, суурилуулах» ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог томилж, улмаар Үнэлгээний хорооноос «А» /274xxxx/ ХХК-ийг сонгон шалгаруулж, 2011 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс «Нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж, суурилуулах» ажил гүйцэтгэх 299.314.623 төгрөгийн гэрээг

байгуулан "А" ХХК-аас «ЧХ» олон улсын буудлаас томилогдсон ажлын хэсэгт 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр нийт 108 нэр төрлийн 172 ширхэг тоног төхөөрөмж, 9 нэр төрлийн 1 багц, 56 ширхэг програм, хангамжийн иж бүрдэл, түүнчлэн «COTS software and vMUSE licence» буюу зорчигч бүртгэлийн «vMUSE» системийг 3 жил ямар нэг төлбөргүй ашиглах лиценз, тэдгээр дээр ажиллах боловсон хүчнийг сургаж бэлтгэх ажлын хамт хүлээлгэн өгсөн байна.

Гэтэл ИНЕГ-ын даргаар ажиллаж байсан С.Б-ийн 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны 2012 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот «ЧХ Олон улсын буудалд Зорчигч бүртгэлийн сүлжээний оператор»-ыг сонгон шалгаруулах ИНЕГ-ын Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежер Д.Э-аар ахлуулсан Үнэлгээний хороог томилж, улмаар 2011 онд сонгон шалгаруулсан ИНЕГ-ТББ/Б-73/11 тоот тендерийн ялагч "А" ХХК-ийн урьд хийж гүйцэтгэсэн ажлыг дахин давхардуулсан байдлаар болон ИНЕГ-ын харьяа «ЧХ» олон улсын буудлын инженер, техникийн ажилчдын үндсэн чиг үүрэгт хамаарах, тэдгээрийн ажил үүргийн хуваарьт тусгагдсан, тэдгээрээр хийж гүйцэтгүүлэх боломжтой «Оператор»-ын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр "Эс"/278xxxx/ ХХК-ийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2, 9.2-т заасныг тус тус зөрчин хууль бусаар сонгон шалгаруулсан байна.

Улмаар "Эс" ХХК-тай 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 3 жилийн хугацаанд «vMUSE» системээр бүртгүүлсэн зорчигч тутамд 4.000 төгрөгийн хураамж төлөх нөхцөл бүхий «ЧХ» Олон улсын буудалд зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулж, 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 226.628.000 төгрөг нийт 1.062.959.200 төгрөгийг албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаар урвуулан ашиглаж "Эс" ХХК-ийн дансанд шилжүүлж, улсад хүнд хор уршиг буюу 1.062.959.200 төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан,

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Б, “Эс” ХХК-ийн захирал М.Б, ИНЕГ-ын Санхүүгийн ерөнхий менежерээр ажиллаж байсан Г.Н, Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежерээр ажиллаж байсан Д.Э нар нь бүлэглэн “Эс” ХХК-ийн “Голомт” банкин дахь 110268xxxx тоот дансанд ИНЕГ-аас гэрээт ажлын төлбөр гэх үндэслэлээр 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр шилжүүлсэн 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр шилжүүлсэн 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр шилжүүлсэн 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр шилжүүлсэн 226.628.000 төгрөг нийт 1.062.959.200 /нэг тэрбум жаран хоёр сая есөн зуун тавин есэн мянга хоёр зуун/ төгрөгийг завшиж улсад онц их хэмжээний хохирол учруулсан.

2. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Б, “Эс” ХХК-ийн захирал М.Б, ИНЕГ-ын Санхүүгийн ерөнхий менежерээр ажиллаж байсан Г.Н, Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежерээр ажиллаж байсан Д.Э нар нь “Эс” ХХК-ийн “Голомт” банкин дахь 110268xxxx тоот дансаар шилжүүлэн авч завшсан буюу Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан хүнд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөнийхөө хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор, бүлэглэн ИНЕГ-ын даргаар ажиллаж байсан С.Б-ийн эхнэр Г.Чи, тус газрын санхүүгийн ерөнхий менежерээр ажиллаж байсан Г.Н-ийн ээж Ч.Ө, тус газрын Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежерээр ажиллаж байсан Д.Э, “Эс” ХХК-ийн захирал М.Б нарын хамтарсан хөрөнгө оруулалттайгаар Их Британи Виржиний арлуудад /British Virgin Islands / “МСЛ” гэх нэр бүхий компанийг үүсгэн байгуулж:

“МСЛ” ХХК БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-27041x-xxx тоот харилцах дансанд 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 150.000 ам.доллар шилжүүлж улмаар:

- “Эс” ХХК-ийн Голомт банкин дахь 110272xxxx тоот дансаар 2013 оны 02 сарын 05-ны өдөр 144.960 ам.долларыг буцаан хүлээн авсан.

“АЭБ” ХХК-ийн захирал Б.Б-гийн Их Британи Виржиний арлуудад /British

Virgin Islands/ үүсгэн байгуулсан “ТКЛ” компанийн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-2728x-xxx тоот харилцах дансанд 2012 оны 03 дугаар сарын 29-ний өдөр 155.000 ам.доллар шилжүүлж улмаар:

2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 153.993 ам.доллар,

2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 39.968 ам.долларыг тус тус Ц.Б-гийн Худалдаа хөгжлийн банкин дахь 45313xxxx тоот дансаар дамжуулан М.Б-ын Худалдаа хөгжлийн банкин дахь 45102xxxx тоот дансаар буцаан хүлээн авсан,

“ТКЛ” компанийн HSBC банкин дахь 848-2728x-xxx тоот харилцах дансанд 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 202.500 ам.доллар шилжүүлж, улмаар 2012 оны 10 сарын 10-ны өдөр 199.993 ам.долларыг М.Б-ын Худалдаа хөгжлийн банкин дахь 45102xxxx тоот дансаар тус тус буцаан хүлээн авч мөнгө угаасан гэмт хэргүүдэд тус тус холбогджээ.

/Яллах дүгнэлтэд бичигдсэнээр /:

ТОДОРХОЙЛОХ нь:

Нэг: Шүүхийн хэлэлцүүлэгт хохирогч, иргэний нэхэмжлэгч, гэрч, шүүгдэгч нараас мэдүүлсэн мэдүүлгүүд:

Хохирогч, иргэний нэхэмжлэгч П.А-оос: Манай байгууллагын хувьд 1.000 төгрөгийн гэрээ, 4.000 төгрөгийн гэрээ гарч ирсэн, үүнийг зөрүүгээр хохирсон гэж бодож байгаа, хохирлыг нарийн сайн мэдэхгүй байна, байгууллагын удирдлагуудтай уулзахад ингэж л хэлж байсан, өөр мэдэх зүйл алга байна гэв.

Хохирогч, иргэний нэхэмжлэгч Н.М-гээс: Гэрээ давхардаагүй, гэрээний зөрүү мөнгөөр манай байгууллага хохирсон гэж үзэх байх, “Эс” ХХК нь өмнөх тооцоогоо хийгээгүй яваа, тооцоо нийл гэдэг шаардлагыг тавихад алга болсон, манай байгууллага хэдэн төгрөгөөр, яаж хохирсныг сайн мэдэхгүй байна гэв.

Гэрч Б.А-оос: «Ар» систем ямар ч зардлыг 4 дахин багасгадаг сайн систем, аюулгүй байдал, зорчигчдын мэдээллийг авах талаасаа ач холбогдолтой тул дэлхий даяараа “Ар” болон “С” компанийн системийг ашиглаж байгаа. Би Япон улсад 4 жил ажилласан, миний үзсэн, харсан газруудад бүгдэд нь “Ар” болон “С” компанийн системийг ашигладаг. Энэ систем нь олон давуу талтай, «А» компанийн системийн нэг давуу тал нь олон улсын терроризмтэй

тэмцэх нэгдсэн орнууд ашигладаг. Нислэгийн аюулгүй ажиллагаанд бүртгэлийн систем боловсронгуй болсноор их ач холбогдолтой, ялангуяа терроризмын эсрэг ашигтай байдаг. «М» ХК болон бусад авиа компаниуд одоо «vMUSE» системээр бүртгэлээ хийж байгаа. «Ар» компанийн зорчигч бүртгэлийн «vMUSE» систем нь өөрөө нарийн төвөгтэй, мэргэжлийн ур чадвар, өндөр техник технологи шаардсан ажил үйлчилгээ. «vMUSE» системийг «ЧХ» ОУБ дангаараа гүйцэтгэхээр бол ажиллаж байгаа хүмүүс нь мэргэжлийн хүмүүс, инженер байх ёстой.

“Эс” ХХК-ийн “vMUSE” системийг яг одоо зогсоовол бүх нислэг зогсоно, одоо энэ системийг болиулна гэж байхгүй, бүх ажиллагаа уялдсан. “Ар” компанийн “vMUSE” программыг нэвтрүүлснээр миний мэдэхийн хохирол гарч байгаагүй. Шинэ систем тавигдсан байгаа болохоор жижиг алдаа гардаг. Түүнийгээ засаад ажлаа үргэлжлүүлдэг гэв.

Гэрч П.Б-оос: 2011 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс Нисэх буудлын бүртгэлийн цогц систем нийлүүлж, суурилуулах ажил гүйцэтгэлийн гэрээ «А» компанитай байгуулагдаад үүний дагуу үйл ажиллагаа явуулж байсан. Холбоо мэдээлэл чиглэлийн тоног төхөөрөмж зорчигч бүртгэлийн систем орж ирэх юм байна гэдэг асуудал ажил үүргийн дагуу бид нарт яригдаж байсан. Тийм учраас манай албанд сүлжээний инженерээр ажиллаж байсан М.Б манай буудлыг төлөөлөөд энэ тоног төхөөрөмжийг бэлтгэж, нийлүүлдэг ажилд нь мэргэжлийн зүгээс орж ажилласан. Энэ программ дээр ажиллах инженер техникийн ажилчдыг систем, тоног төхөөрөмж орж ирээд ажиллах юм бол мэргэжлийн чиг үүргийнхээ дагуу албаны ажил үүргийн хуваарьт өөрчлөлт орох байх, ажилчид, инженерүүдээ сургаж тэр техникийг ажиллуулах байх гэж ойлгуулсан. Энэ төхөөрөмж тавигдахтай холбоотой манай албанд шинэ технологи орж ирж байгаатай холбоотой инженер техникийн ажилчдын орон тоог нэмэх шаардлага гарч магадгүй, гэхдээ бид өмнө нь нислэгийн аюулгүй байдлыг хянан зохицуулах албаны шалгалтаар инженерийн ажлыг ээлжийн техникч авч үлддэг юм байна, 24 цагийн үйл ажиллагаа явуулж байхад энэ нислэгийн технологи, үйл ажиллагаа зөрчсөн асуудал байна гэж яригдаж байсан. 2, 3 удаагийн дүгнэлт байдаг. Тэр утгаараа бид ээлжийн инженертэй больё гэдэг шаардлага, хүсэлтийг ИНЕГ-т тавьж байсан. Яг “vMUSE»

системтэй холбогдуулж инженерийн орон тоо нэмэгдээгүй гэж би бодож байгаа. Гэхдээ энэ нь үйл ажиллагаатай давхцаад 4 инженерийн орон тоо батлагдаж ирсэн. Тэр үед бидний өмнө тавьж байсан хүсэлтийг биелүүллээ гэж бодож байсан. М.Б 1999 онд камерийн систем тоног төхөөрөмж тавигдаж байхад камер хянагчаар анх ажилд орж байсан. Тэрнээс хойш камерийн тоног төхөөрөмжийн үйл ажиллагааг хариуцаж манай албанд ажиллаж байсан. Тэр үеэс би М.Б-ыг танина. Сүүлд өөрийн мэргэжлийн дагуу тодорхой хэмжээний сонгон шалгаруулалт гэдэг юм уу, чадварыг нь үнэлээд сүлжээний инженерээр ажлуулж байсан. Энэ хүний ажлаас гарах болсон шалтгааныг М.Б хэлэхдээ сурч боловсромоор байна. Програмчлалын чиглэлийн тоног төхөөрөмж хариуцаж байгаа тоног төхөөрөмж дээр сурч төгсөөд олон жил болчихлоо, сурна гэсэн хүсэлтээр ажлаа өгчихлөө гэж байсан. М.Б «Ар» компанийн тавьсан тоног төхөөрөмжтэй холбоотойгоор өөрийн сүлжээний чиглэлээрээ тоног төхөөрөмж хариуцаж байсан. Манайд шинээр тавигдаж байгаа холбоо, мэдээллийн чиглэлийн систем, тоног төхөөрөмжүүдэд хүмүүсээ сургаад тоног төхөөрөмжийг ажиллуулаад явах боломжтой байсан гэв.

Гэрч Т.Бая-аас: Дээрх сонгон шалгаруулалт зарласан нь агуулгын хувьд хийх ёстой ажил байсан, гэхдээ тендерийн тухай хуулиа зөрчиж сонгон шалгаруулалтыг зарласан, нээлттэй тендер байсан учир хэн ч оролцож болно. Тендерийн аудитын хувьд бид өөрсдийн дүгнэлтийг гаргах эрхтэй, энэ дүгнэлтийг хийхдээ тендерийн материалд хавсаргасан 2 дугаар сарын 8-ны өдрийн бичгийг үндэслэсэн. 1000 болон 4000 төгрөгийн гэрээний эх хувь надад байхгүй, энэ хоёр гэрээг тус тусад нь байгуулсан, 4.000 төгрөгийн гэрээний хуулбар хувийг хөрөнгө оруулалтаас, 1000 төгрөгийн гэрээний хуулбар хувийг «ЧХ» ОУБ-аас олж авсан. Зорчигчийн хураамж нь зорчигчдоос гарч байгаа хураамж, сонгон шалгаруулалт явагдахаас өмнө зорчигчоос хураадаг байсан хураамж 18.000 төгрөг байсан. Дараа нь 22.000 төгрөг болгосон, энэ нь зорчигч бүртгэлийн хураамж бага байна гээд нэмсэн үнэ. Яагаад ИНЕГ-ыг хохирсон гэж үзээд байна вэ гэхээр тэр нэмсэн орлого маань «ЧХ» ОУНБ-д орох ёстой байсан. Би яагаад хоёр янзын дүгнэлт гаргасан гэхээр эхлээд сонгон шалгаруулалтын материал хүлээж аваагүй байхдаа нэг дүгнэлтийг гаргаад уг материалыг хүлээж аваад нэмэлтээр

гаргасан дүгнэлт. Зорчигчийн бүртгэлийн хураамж нь борлуулалтын орлого гэв.

Гэрч Ч.З-гоос: ИНЕГ-т Мэдээлэл технологийн албанд ээлжийн инженер ажилтай, миний өмнө мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэг буруу бичигдсэн байх шиг байна. Манайд сургалт явуулаад манай албанд хариуцуулсан тохиолдолд тэр программыг даагаад ажиллах чадвартай гэж хэлсэн. Намайг ээлжийн инженер болох асуудал олон шалтгаантай, олон чиглэлийн тоног төхөөрөмж хариуцаж ажилладаг. Ийм үүднээс ээлжийн инженер болгосон. Нэмж 4 инженер томилсон тушаалыг би мэдэхгүй байна. М.Б-ыг танина, сүлжээний инженер байсан, “Эс” ХХК зорчигч бүртгэлийн систем хариуцаж ажилладаг гэж л мэднэ. Энэ ажиллагааг сургалтад суувал манайд чадвартай инженерүүд байгаа гэв.

Гэрч Н.Мя-гээс: «ЧХ» ОУНБ нь зорчигч бүртгэлийн операторын үйл ажиллагаа явуулах эрхийг “Ар” болон “С” компаниас авсан зүйл байхгүй. Зорчигч бүртгэлийн системийн үйл ажиллагааг авч явахын тулд эхлээд инженер, техникийн ажилчид тусгай мэргэжлийн сургалтад суух ёстой. Дээрээс нь гэрчилгээтэй байх, наад захын англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх шаардлагатай, нисэх буудлын инженер техникийн ажилчид зорчигч бүртгэлийн үйл ажиллагаа явуулах инженерийн сургалтад хамрагдаагүй. «Ар» компанийн сургалтын төвд суугаад сертификат авах ёстой гэв.

Гэрч Б.Со-оос: Б.Г дарга захиргааны хэлтсийн дарга болсон цагаасаа эхлээд надаас нэг гэрээ нэхээд байсан. Би ямар гэрээ нэхээд байсныг мэдэхгүй байсан. Сүүлд чамаас нэхээд байсан гэрээ энэ байна гээд ширээн дээрээсээ авч үзүүлж байсан. Ямар зорилготой юм бэ? гэхээр энэ гэрээ нь миний ажилд ороогүй байх үеийн гэрээ юм. Миний хардсанаар бол Б.Г дарга энэ гэрээг С.Б-өд өгсөн гэж албаар хуучин дарга нартай холбож дарамтлах ч юм уу, эсвэл хуучин дарга нартай холбож намайг харддаг байсан. Тийм учраас гэрээ энэ хүнд байсан гэж мэдүүлэг өгсөн байх гэж би бодож байна. Ер нь гэрээнүүд надад байдаг, гэхдээ хөрөнгө оруулалтын гэрээ бол тусдаа байдаг. 1000 төгрөг, 4000 төгрөгийн гэрээ нь хөрөнгө оруулалтын гэрээ учраас надад байхгүй ёсгүй гэв.

Шүүгдэгч С.Б-өөс: Ингэний нисэхийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.2-т зааснаар Олон улсын Иргэний нисэхийн буудлын зөвлөмж 9-ийн заалтын дагуу

Агаарын тээврийг хялбаршуулах хөтөлбөрийг гарган 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн Засгийн газрын 269 тоот тогтоолоор баталгаажуулж ажилласан бөгөөд уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд олон ажил арга хэмжээ авагдсаны дотор НАА ба НАБ-ыг найдвартай хангуулах үүднээс төр, хувийн хэвшлийн агаарын тээвэрлэгч байгууллагуудын эрэлт хэрэгцээ, тэдгээрийн ажлын уялдаа холбоог сайжруулах, адил тэгш үйлчилгээг үзүүлж ИНЕГ-ын хуулиар олгогдсон хяналтын чиг үүргийг хангах зорилгоор, «ЧХ» ОУНБ-аас санаачлан оруулсан олон талт арга хэмжээний нэг нь «зорчигч бүртгэлийн иж бүрэн систем»-ийг «ЧХ» ОУНБ-д төвлөрүүлэн нэвтрүүлэх ажил байсан. Энэ хүрээнд хийгдсэн зорчигч бүртгэлийн цогц системийн үйл ажиллагааг нэвтрүүлэх явцад төрийн олон бодлого зорилтууд хамрагдаж хэрэгжихэд шууд болон шууд бусаар эерэг нөлөөллийг авчирсан бөгөөд иргэний нисэхийн талаар болон аялал жуулчлалыг хөгжүүлэх, ИН-д хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх, ажлын байрыг нэмэгдүүлэх, үндэсний үйлдвэрлэлийг хөхүүлэн дэмжих ОУ-ын терроризмын эсрэг нэгдсэн орны бодлого, зорилтыг хэрэгжүүлэх зэрэгт хамааралтай шийдэл болсон. Бүртгэлийн системийн тоног төхөөрөмжийг 2010 оны ИНЕГ-ын оны цэвэр ашгаар санхүүжүүлэгдэх 2011 онд хийгдэх ажлын жагсаалтад оруулан яамны сайдаар батлуулсан, «бүртгэл хяналтын цогц систем» гэдэг нэрийн дор авахаар болж, харин операторын асуудлыг шийдвэрлэгдэхэд холбогдох төсвөөс санхүүжихгүй учир бүх асуудал сайдаас баталсан ХОТ-ний жагсаалтад бүтэн нэрээрээ орсон тул операторыг сонгох асуудал ч хамтдаа зөвшөөрөл олгогдсон гэж үзэж санхүүжилтийн эх үүсвэрийг шийдэж, бэлтгэл хангах зорилгоор улсын үйлдвэрийн газрынх нь хувьд «ЧХ» ОУНБ-ын захиалж, чиглэл өгч ОУ-ын иргэний нисэхийн зөвлөмж 15-ын дагуу үйл ажиллагааг эхлэхээс өмнө 56-аас доошгүй хоногийн өмнө зорчигч олон нийт болон албан байгууллагуудад мэдээлэх боломжийг харгалзан зорчигчийн хураамжийг 22.000 төгрөг болгон нэмэгдүүлэхээр болж, улсын үйлдвэрийн газрын хувьд «ЧХ» ОУНБ-ын захирлын тушаал гарч, «М» ХК ИАТА-д мэдэгдэн холбогдох зөвшөөрлийг авч 2012 оны 1 сараас эхлэж мөрдөхөөр болсон байгаа юм. Зорчигчдын зорчсон тухай мэдээллийн нууцлал, зорчигч бүртгэлийн үйлчилгээний хувийн шуурхай байдлыг хангуулах,

зорчигч олныг зорчход хамтран оролцдог байгууллагуудыг үнэн зөв мэдээллээр хангах, бүх зорчигчдын мэдээллийн санг найдвартай хадгалах, терроризмын эсрэг эвсэлд нэгдсэн орны хувьд нисэх буудлыг үйлчлүүлэгчдийн талаарх мэдээлэлтэй холбогдол бүхий асуудлыг шуурхай шийдэж байх, төр, хувийн хэвшлийн байгууллагуудыг энэ тэнцүү боломжоор хангаж оролцуулах зэргийг хангахаар зорчигч бүртгэлийн системийн тоног төхөөрөмжийг ИНЕГ хариуцан гүйцэтгэх болсон. Харин операторын асуудлын хувьд өөр үйлчилгээ, уг асуудлыг Чикагогийн конвенцийн 15, 22 дугаар зүйл, 4 дүгээр бүлгийн 37 дугаар зүйл, зөвлөмж 9 ба 17, мөн конвенцийн Док-9287, 9734-ийн 2.1.4 дүгээр бүлгийн Б-д зааснаар ОУИНБ-ын зөвлөмж, ОУ-ын нийтлэг жишгийн дагуу зорчигчдод үйлчлэх үйлчилгээ гэдгээр нь зорчигчдын хураамжийг нэмэгдүүлэх замаар төсөв төлөвлөгөөнд тусгах шаардлагагүйгээр нийлүүлэх боломжтой тул хураамжийг нэмэгдүүлэх шийдвэр чиглэлийг «ЧХ» ОУНБ-ын удирдлага өгч ОУИН-ын зөвлөмж 15-ыг баримтлан зарлан мэдээлж, «М» ХК нь АИТА-д хандан зөвшилцөж төлбөр тооцоог иж бүрэн шийдвэрлэсэн.

Н-ын тушаалаар үйлчилгээний хөлсийг 22.000 төгрөг болгосон. Энэ мөнгө нь олон улсын зорчигч нарын дундажаас хамаагүй бага мөнгө юм. Бүртгэлийн программ нь нислэгийн бүх асуудалтай нарийн холбоотой, энэ нь онгоцны даац, нислэгийн аюулгүй ажиллагаатай шууд холбоотой. Бүх зорчигч нарын мэдээллийг нарийн хангадаг, зорчигчтой холбоотой бүх мэдээлэл байдаг. «С»-гийн тоног төхөөрөмж, программыг «М» ХК ашигладаг байсан нь «М» ХК-д их хэмжээний алдагдалд ордог талаар зөвлөмж байдаг.

Энэ зорчигч бүртгэлийн программын ажил хийж байгаа нь гэмт хэрэгт биш, намайг миний эсрэг турхирч байна, энэ хэрэг хохирогчгүй хэрэг, ИНЕГ тендерийн хуулийг баримталж ажилладаг, үүнд яам оролцох шаардлагагүй, зөвшөөрөл өгсөн гэж үзэж байгаа, бүртгэлийн цогц систем гэсэн нь зөвшөөрөл өгсөн гэж үзэж байна. Бидний нэг зорчигчоос 10 гаруй доллар авдаг байсныг 4.000 төгрөг болгосныг гэмт хэрэг болгож байгаад харамсаж байна. Үнэлгээний хороог байгуулж, уг хорооны бүрэлдэхүүнээс оруулж ирсэн саналыг баталсан. Тендерийн тухай хуулийн 8.2, 9.2-ыг зөрчсөн гэжээ, үүнийг хуулийн дагуу явуулсан. Яагаад биднийг, намайг буруутгаад байгааг хүлээн

зөвшөөрөхгүй, «ЧХ» ОУБ-ын үндсэн чиг үүрэгт тусгагдсан гээд байгаагаар биднийг буруутгаад байгаад гайхаж байна. «ЧХ» ОУБ-ын чиг үүрэгт байхгүй, ажилчид нь хийж чадахгүй зүйлийг хийж чадна гээд байгаад гайхаж байна. Б.Да, Т.Бая нарын гаргасан дүгнэлт үндэслэлгүй, мөрдөн байцаалтын шатанд өгсөн гэрч нараас мөрдөн байцаагч энэ программ дээр ажиллаж чадах уу гэсэн асуултанд чадна гэж хариулсан, гэтэл тэд хийж чадахгүй юм. «С» компани нь өндөр үнэтэй программ ашиглаж, хэрэглүүлдэг гэдгийг хэн бүхэн мэднэ, газар авсан гэдгийг хэлмээр байна. Х.Э-г шинжээчээр томилсон нь үндэслэлгүй, түүний биеийн байцаалтад түүнийг 8 жил ажилласан гэдэг, гэтэл 7 жил л ажилласан, хуульч хүн гэдэг, гэтэл эрх зүйч мэргэжилтэй хүн, эрх зүйч, хуульч өөр мэргэжил гэж ойлгодог.

Гэрчээр мэдүүлэг өгсөн Б.Мө гэдэг хүнийг танихгүй, манай гэр бүлийн хүний бичиг баримтыг өгөөгүй, бидний бичиг баримт манай байгууллага дээр байдаг, Компани нийлүүлж байгуулсан гэдгийг хүлээн зөвшөөрөхгүй. Албан томилолтын талаар ярья, М.Б-ыг Хонконг яаж явуулсныг мэдэхгүй, Д.Э ажлын шугамаар явсан, тухайн үедээ явсан ажил нь өнөөдөр ч гэсэн хэрэгжиж байгаа, Хонконгийн нислэг 7 хоногт 3 байсныг 8 болгож, одоо ч ингэж нисэж байгаа. Өөрт холбогдсон хэргийн алийг нь ч хүлээн зөвшөөрөхгүй, шүүх шударгаар шийдвэрлэж өгнө үү гэв.

Шүүгдэгч Г.Н-ээс: Миний хийсэн үйлдэлд буруу зүйл байхгүй гэж үзэж байна, намайг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 3 зүйл ангиар цагдан хорьсонд гомдолтой байна. Гэрээ байгуулагдан гарын үсэг зурахад Б.Бо, З.Ту нарын хамт эрх зүйн талаас оролцсон. Өөрийн албаны эрх мэдлийг урвуулан ашиглаагүй. Гэрээг хэн нэгний санаачилгаар хийгээгүй, давхардсан гэдгийг мэдэхгүй, би огт оролцоогүй, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан хөрөнгө завшсан гэж ял сонсож байгаа, үүнийг хүлээн зөвшөөрөхгүй, ИНЕГ-т хөрөнгө зарцуулах эрх надад байхгүй, байгууллагын ямар ч хөрөнгийг авч завшаагүй, 1.062.959.200 төгрөгийн хохирол учруулсан гэсэн, би тэр мөнгөнөөс нэг ч төгрөг аваагүй, мөнгө угаасан гэдгийг ч мэдэхгүй, ойлгохгүй байгаа, энэ талаар ойлголт байхгүй, С.Б, Д.Э нартай хамт ажилладаг учир танина, М.Б-ыг танихгүй, цагдан хоригдож байхдаа анх харсан, өөрт холбогдсон хэргийн талаар хангалттай шалгуулсан, учир нь олдох байх

гэж их тайван хандаж, өнөөдрийг хүртэл явсан, гэтэл шүүх хүртлээ надад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 3 зүйл ангиар ял сонсож байгаад харамсаж байна. Надад хийсэн хэрэг байхгүй, хавтаст хэрэгт надтай холбоотой ямар ч баримт байхгүй, би хэргийн материалтай танилцаад надтай холбоотой, намайг буруутгасан баримт материал хараагүй, энэ хэрэгтэй холбогдуулан намайг болон манай гэрийнхнийг хангалттай шалгасан. Улсын яллагчийн яллах дүгнэлтийг уншихад бүгд л үнэхээр аймшигтай гэмт хэрэгтэн мэт бичигдсэн, гэтэл тийм зүйл байхгүй, болоогүй. Шүүх хэргийн материалд үндэслэлтэй зөв дүгнэлт өгч, шударгаар шийдвэрлэж өгнө үү гэв.

Шүүгдэгч М.Б-оос: Надад сонсгож байгаа зүйл ангийг хүлээн зөвшөөрөхгүй, энэ хэрэг нь зохион байгуулалттайгаар миний хувийн бизнесийг булааж авах гэсэн атгаг санаа агуулсан хэсэг бүлэг хүмүүсийн мэдүүлгээр үүсгэсэн зохиомол хэрэг. Анх хэрэг үүсгэхэд 1.000 төгрөгийн, 4.000 төгрөгийн 2 үнийн дүн бүхий 2 өөр гэрээ хийж улсыг хохироосон байна гэж үзэж хэрэг үүсгэсэн. Үүнээс хойш яллах дүгнэлт 2-3 удаа өөрчлөгдөөд байхад оноосон зүйл анги нь хэвээрээ байгаа нь анхнаасаа энэ хүмүүст Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т заасан ял тулгаад тэрэнд тааруулж хэрэг бүрдүүл гэсэн даалгавар хаа хаанаа авагдсан гэж харагдаж байна. Миний хувьд Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бүх хуулийг даган мөрдөж аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар бүх татвараа төлж явсан. Ямар нэгэн хууль тогтоомж зөрчөөгүй, би шударгаар бизнес эрхэлж цагаан мөртэй явсан. “Эс” ХХК-ийг 2003 онд дохиолол хамгаалалт, программ хангамжийн чиглэлээр анх үүсгэн байгуулагдаж байсан. 2010 оноос “Ар” корпораттай холбогдож 2011 оны 12 дугаар сараас албан ёсны төлөөлөгч болж “vMUSE” системийг Монгол улсад худалдах, борлуулах, угсарч суурилуулах, засвар үйлчилгээг хийх, уг системээр үйлчилгээ үзүүлэх эрхтэйгээр ажиллаж байна. 2012 оны 02 дугаар сард ИНЕГ-аас зарласан тендерт шалгарч гэрээ байгуулан нэг зорчигчийг 4.000 төгрөгөөр бүртгэл хийх эрхтэйгээр операторын үйлчилгээ үзүүлж байна. “ЧХ” нисэх буудал дээр суурилсан зорчигч бүртгэлийн систем нь олон хэрэглэгчийн дундын систем буюу олон улсад CUPPS гэж нэрлэгддэг. Олон улсын нислэг үйлдэгддэг бараг бүх нисэх буудлууд нь уг системийг

ашигладаг бөгөөд холбогдох программ хангамж болон операторын үйл ажиллагааг өнөөдрийн байдлаар дэлхийн АНУ-ын “Ар” болон Европын холбооны “С” гэсэн хоёр л компани үйлдвэрлэж үйл ажиллагаа явуулж байна. Дэлхийн зах зээл дээр эзлэх хувь нь “Ар” 60, “С” 40 гэсэн харьцаатай байна. Гэрээ байгуулснаас хойш өнөөг хүртэл манай компани гэрээнд заасан үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. 2013 оноос ИНЕГ-аас ямар нэг санхүүжилт аваагүй. Энэ хэрэгт Монгол Улсын төсвийн байгууллага, ИНЕГ, “ЧХ” ОУБ-ын аль нь ч хохирогч биш. “А” ХХК нь тоног төхөөрөмж л суурилуулсан. “Эс” ХХК нь техникийн үйлчилгээ системийн бэлэн байдлыг ханган ажилладаг. 2 өөр үйлчилгээ. ИНЕГ-аас хууль ёсны дагуу авсан 1 тэрбум 62 сая төгрөгийн санхүүжилтээс бид Монгол Улсын Татварын хуулийн дагуу бүх татвар, хураамжуудыг төлж байсан. Нийлж компани байгуулсан гэсэн нь ямар нэг баталгаа, нотлох баримт байхгүй. Зөвхөн Д.Э-тай ярьж байсан төсөл л байгаа. Д.Э-тай Хонконгт компани байгуулвал ашигтай талаар ярилцаж байсан ба ярьж байсан хувь хөрөнгөө өгөхгүй удаад нэг их сонирхохгүй байхаар нь би өөрөө ганцаараа “МСЛ” гэдэг компанийг байгуулсан. Энэ компани зөвхөн миний, ганц хүний эзэмшлийн компани. Надад холбогдох хэрэг, зүйл заалтыг хүлээн зөвшөөрөхгүй, шударгаар шийдвэрлэж өгнө үү гэв.

Шүүгдэгч Д.Э-аас: Намайг яллаж байгаа Эрүүгийн хуулийн зүйл ангийг хүлээн зөвшөөрөхгүй, ИНЕГ-ын даргын тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдаж даргаар нь би ажилласан. Хорооны гишүүд хуралдаж тендерийг хязгаарлагдмал байдлаар зарласан, энэ нь хууль зөрчөөгүй. Шинжээчээр томилж, дүгнэлт гаргасан Э-гийн дүгнэлт үндэслэлгүй гарсан, уг дүгнэлтэд «нарийн төвөгтэй» гэсэн байдаг, тийм нарийн төвөгтэй биш юм. ТБОНӨХБАУХАТухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг зөрсөн гэжээ, «Ар», «С» хоёр компаниас өөр компани энэ үйл ажиллагааг явуулдаггүй, тийм учир өөр ямар компанийн эрх ашгийг би зөрчсөн бэ? Зөрчсөн асуудал байхгүй. Аудитын дүгнэлт гаргасан Т.Б-ын дүгнэлтэд «С» компаниас үнийн санал ирүүлээгүй байхад үнийн саналыг үндэслэн гэсэн байдаг, энэ нь огт үндэслэлгүй юм. Уг шалгалтын тайланг хавсаргасан, хэрхэн, яаж хийсэн шалгалт нь тодорхойгүй. Энд яригдаад байгаа 1.000 төгрөгийн гэрээг Т.Б өөрөө гаргаж ирсэн юм шиг байна лээ, «С»

компани тендерийн урилгаа хоцорч авсан байхыг үгүйсгэхгүй, хэрэв урилгаа хоцорч авсан бол «С» нь Үнэлгээний хороонд хүсэлт тавьж болох байсан, энэ нь хуулиараа нээлттэй байсан. Гэтэл урилгаа авчхаад усанд хаясан чулуу шиг алга болсон. «ЧХ» ОУБ-ын техникийн инженер, ажилтнууд хийх бүрэн боломжтой гээд байгааг зөвшөөрөхгүй, энэ нь “Эс” ХХК-ийн өмчийг булааж авах гээд байгаа юм. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар ямар байдлаар хэдэн төгрөг, яаж завшсан бэ?, энэ талаарх баримт байхгүй, үүнийг хүлээн зөвшөөрөхгүй. Мөн Эрүүгийн хуулийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т зааснаар намайг буруутгагдаг, “Эс” ХХК гадаад руу 3 удаа мөнгө шилжүүлсэн байдаг, би М.Б-ыг хаашаа, яаж, ямар зорилгоор мөнгө шилжүүлсэн, шилжүүлэх талаар зааж зөвлөдөггүй, энэ талаарх компанийн үйл ажиллагаанд огт оролцдоггүй.

М.Б-той гадаадад компани байгуулах талаар ярьж байсан, гэтэл мөнгө, төгрөгтэй холбоотой асуудлаас болоод уг компанийг байгуулаагүй, гэтэл М-ийн компьютер дээрээс гарч ирсэн баримтаар таамаглаж, хүнийг онц хүнд гэмт хэрэгт буруутгаад байгааг гайхаж байна. М.Б-той хамт Хонконг улс руу явсан, ингэж хамт явахдаа компани байгуулсан байдаг гэж буруутгагдаж байгаа, намайг Хонконг улс руу явуулъя гэж яамны хүрээнд яригдсан, тухайн үед Хонконг улс руу явсан, томилолтын үеэр ярилцсан хэлэлцээний үр дүнд хоёр улсын хооронд нислэгийн давтамж 3 байсныг 8 болгож шийдвэрлэх арга замыг тохиролцсон. ИНЕГ-ын хүрээнд хийгдэж байгаа. Мөн томилолтын үеэр зөвхөн очсон өдрийнхөө орой М.Б-той цуг оройн хоол идсэн бөгөөд түүнээс хойш огт тааралдаагүй байж байгаад Монгол Улс руу нисэх үедээ нисэх буудалд тааралдсан. Миний бие уг тендер шалгаруулахтай холбогдуулан ямар нэгэн хууль дүрэм зөрчсөн зүйл байхгүй бөгөөд надад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3, 166¹ дүгээр зүйлийн 166¹.3 гэсэн зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэснийг хүлээн зөвшөөрөхгүй. Мөн уг хэрэгтэй холбогдуулан бүх тайлбар нотолгоог зөвхөн буруутгаж болох баримт болон зарим мэдүүлгийг үндэслэн цагаагтах талын ямар нэгэн ажиллагаа хийгээгүй. Шударгаар шийдвэрлэж өгнө үү гэв.

Хоёр: Шүүхийн хэлэлцүүлэгт талуудаас шинжлэн судалсан болон хэрэгт авагдсан бусад нотлох баримтууд:

- Хохирогч, иргэний нэхэмжлэгч П.А /ИНЕГ-ын хуулийн хэлтсийн дарга/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...Урьд зарлагдсан тендерээр хийгдсэн ажлыг давхардуулан тендер зарлаж “Эс” ХХК-ийг шалгаруулж 1.062.959.200 төгрөг шилжүүлсэн...” /22-р хх-ийн 52-55/ гэсэн,

- Хохирогч, иргэний нэхэмжлэгч Н.М /ИНЕГ-ын хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тасгийн дарга/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...Нэхэмжлэл одоогоор тодорхой бус байна, эргэж тодруулаад хариу байцаалт өгнө...” гэсэн мэдүүлгүүд,

- ИНЕГ-ын 2013.10.31-ний өдрийн 01/2705 тоот хохирогч, иргэний нэхэмжлэгч томилж ирүүлсэн албан бичиг /22-р хх-ийн 49/,

- Гэрч Г.На /ИНЕГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын тасагт аудитор/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...ИНЕГ-ын даргын батласан удирдамжийн дагуу 2013 оны 02 дугаар сарын 11-ний өдрөөс 2013 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртлэх хугацаанд ИНЕГ-аас байгуулсан “Зорчигч бүртгэлийн систем”-ийн гэрээнд шалгалт хийсэн.

...Зорчигч бүртгэлийн операторын үйл ажиллагаа явуулах гүйцэтгэчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог ИНЕГ-ын даргын 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар томилсон, тушаалаар томилогдсон Үнэлгээний хороо ИНЕГ/У/ХББ/Б-04/12 дугаартай тендерийг 2012 оны 01 дүгээр сарын 26-наас 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдөр зарлан явуулсан байна. Уг тендерт оролцох урилгыг 2012 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 07/229 тоотой “Э” компанийн албан ёсны төлөөлөгч “Эс” ХХК, Монгол дахь “С” компанийн төлөөлөгчийн газруудад хүргүүлсэн байна.

Уг зарлагдсан ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот дугаартай тендер нь зөвлөхийн бус үйлчилгээний ажлын тендер биш, бараа худалдан авах тендер болж, тендерт оролцогчдод явуулсан урилга нь ч бас зөвлөхийн бус үйлчилгээний ажлын урилга биш харьцуулалтын аргаар бараа материал худалдан авах үнийн санал ирүүлэх урилга болсон байна. SITA-гийн төлөөлөгчийн газарт явуулсан үнийн санал авах урилга нь 2012 оны 02 дугаар сарын 07-ны өдөр очсон бөгөөд уг материалаас тодруулга авах бичгийг 2012 оны 02 дугаар сарын 08-ны өдөр ирүүлж, Үнэлгээний хороо 2012 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хариу тодруулгыг өгсөн байна.

Ингээд үзэхэд сүүлийн 5 хоногийн хугацаа бол SITA компанийг тендерт оролцож үнийн санал ирүүлэх боломжгүй болгосон зориудын хугацаа байсан гэж үзэхээр байна.

Агаарын тээврийг хялбаршуулах хөтөлбөрийн хүрээнд зорчигч бүртгэлийн системийг хялбаршуулах шинэ систем нэвтрүүлэхийн тулд зорчигч бүртгэлийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай техник тоног төхөөрөмжийн тендер шалгаруулалтаар “А” ХХК-ийг шалгаруулж техник, тоног төхөөрөмжийг зорчигч бүртгэлийн программ хангамжийн иж бүрдэл «COTS software & vMUSE» лицензийн хамт 299,3 сая төгрөгөөр 2012 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр нийлүүлсэн байна.

Гэтэл зорчигч бүртгэлийн операторын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэгч сонгон шалгаруулалт явуулахаас өмнө “А” ХХК 2012 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр хүлээлгэн өгсөн ажлаа 2012 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр суурилуулж дуусган 2012 оны 02 дугаар сарын 25-ны өдөр бүрэн ашиглалтад хүлээлгэн өгнө гэж 2012 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр ирүүлсэн бичигтээ дурдсан бөгөөд «ЧХ» ОУБуудлын дарга 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 11/130 тоот албан бичигтээ “А” ХХК-ийн нийлүүлж буй дээр дурдсан ажил дуусаж, туршилтын ажил эхлэхэд бэлэн болсон тул зорчигч бүртгэлийн системийн операторын үйл ажиллагааг дээрх компанитай хамтран явуулах зөвшөөрөл хүссэн байна.

“А” ХХК нь хийгээгүй байгаа ажлаа дуусаж байгаа болон туршилтын ажил эхлэхэд бэлэн болсон мэтээр хуурамч бичиг баримт үйлдэн “ЧХ” ОУБуудлын даргад ирүүлж түүнийг нь “ЧХ” ОУБуудлын дарга хүлээн зөвшөөрч операторын үйл ажиллагааг эхлүүлэх зөвшөөрөл хүсэж байгаа зэрэг нь зүгээр нэг сонгон шалгаруулалтын үйл ажиллагаатай цаг хугацааны хувьд давхацсан тохиолдлын зүйл биш гэж үзэж байна.

“ЧХ” ОУБуудал дээр олон улсын зорчигч бүртгэлийн операторын үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГУ/ХББ/Б-04/12 тоот тендерт оролцогчдын материалыг 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдөр хүлээн авахад ганц “Э” компанийн албан ёсны төлөөлөгч “Эс” ХХК материалаа авчирч өгсөн ба SITA компани материалаа ирүүлээгүй байна. Ингээд ганц оролцогчтой тендерт “Эс” ХХК-ийг шалгаруулж 2012 оны 02 дугаар сарын 16-ны өдөр уг компанитай гэрээ байгуулах эрх

олгох тухай зөвлөмжийг гаргаж, мөн өдөртөө ИНЕГ-ын даргын 2012 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/385 тоот албан бичгээр гэрээ байгуулах эрх олгогдсон байна.

Сонгон шалгаруулалтын материалаас үзэхэд “А” ХХК-аас ирсэн нөхцөл бүрдүүлэх тухай бичиг, “ЧХ» ОУБуудлын дарга Л.Н-ын зөвшөөрөл хүссэн тухай бичгүүд нь болсон үйл явдлаас өмнө үйлдэгдсэн бичгүүд болохын зэрэгцээ захиалагч нь Үнэлгээний хороог томилохдоо ТБОНӨХБАУХА тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.5 «тухайн бараа ажил үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны худалдан авах ажиллагааг эхлүүлэх» заалтыг зөрчсөн, Үнэлгээний хороо нь мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг хэрэглэн хязгаарлагдмал тендер зарлахдаа барааны жишиг тендерийн баримт бичиг ашигласан боловч гэрээ байгуулахдаа үйлчилгээний гэрээг байгуулсан, бараа гэж тендер зарлаад зөвлөхийн бус үйлчилгээний гэрээ байгуулсан, тендерийн урилгад тендерийн баталгааг санал болгож буй үнийн дүнгийн 1% гэж заасан, “Эс” ХХК 10,0 сая төгрөгийн баталгаа гаргасан тул уг зөвлөхийн бус үйлчилгээний үнийн саналыг 1 тэрбум гэж үзэх эсэх, ирүүлсэн тендерийн материалд ТӨӨЗ-ийн 18.2 (а)-д заасан сүүлийн 3 жилийн борлуулалтын хэмжээ санал болгож буй үнийн дүнгийн 30%-иас багагүй байх гэсэн шаардлага дээр гаргасан баталгааны дүнгээс тооцсон 1,0 тэрбум төгрөгийн 6,7-15,2%, гаргасан санхүүгийн мэдээлэлд тодорхойлсон нийт хөрөнгө нь аудитаар баталгаажуулсан балансад туссан нийт хөрөнгийн дүнгээс дариу 10-20 дахин их зөрүүтэй санхүүгийн мэдээлэл нь худлаа, сонгон шалгаруулалтаар ТБОНӨХБАУХА тухай хуулийн 27.1-д заасан тендерийг хянан үзэхэд шалгуур үзүүлэлт, техникийн шаардлагыг хэрхэн хангасныг хянаагүй, 28 дугаар зүйлд тендерийг үнэлээгүй, техникийн шаардлагын Ерөнхий шаардлагын 1.1.б-д Операторын үйл ажиллагаа эрхлэх байгууллага нь иргэний агаарын тээврийн мэдээллийн технологийн чиглэлээр хамгийн багадаа 10 жил ажиллаж олон улсын иргэний агаарын тээврийн салбарт үйл ажиллагаа нь амжилтанд хүрсэн, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн байх гэсэн гол үндсэн шалгуурыг “Эс” ХХК хэрхэн хангаж байгааг хянан үзээгүй, энэ компани нь иргэний агаарын тээврийн мэдээллийн технологийн чиглэлээр 10 байтугай, нэг ч жил ажиллаж үзээгүй, иргэний агаарын тээврийн чиглэлээр

бэлтгэгдсэн нэг боловсон хүчин байхгүй тул энэ шаардлагыг хангахгүй байгууллага нь тодорхой байна. “Эс” ХХК нь Монгол Улсад “Э” компанийг төлөөлөх албан ёсны зөвшөөрөл байхгүй байна.

“ЧХ” ОУБуудалд зорчигч бүртгэлийн системийн техник, тоног төхөөрөмж нийлүүлсэн “А” ХХК нь “Э” ХХК-аас энэ системийн программ хангамж, техник, тоног төхөөрөмжийг нийлүүлсэн гэдэг нь тендерт шалгарсан материалаас харагдаж байгаа тул “Эс” ХХК нь «Э» ХХК-ийн албан ёсны төлөөлөгч байх үндэслэл муутай байна.

Дээрх “А” ХХК-ийн 2012 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр ирүүлсэн худлаа бичиг баримт, «ЧХ» ОУБ-ын даргын 2012 оны 01 дүгээр сарын 19-ний 11/130 тоот албан бичиг, ТБОНӨХБАҮХА тухай хуулийн заалтуудыг зөрчсөн байдал, “Эс” ХХК нь «Э» ХХК-ийн албан ёсны төлөөлөгч болох нь нотлогдохгүй байх, зорчигч бүртгэлийн операторын үйл ажиллагааг эрхлэх компанид тавигдах үндсэн шаардлагыг хангаагүй байдал, мөн тус компанийн тендерийн материалд ирүүлсэн санхүүгийн мэдээллийн зөрүүтэй байдал зэрэг нь “Эс” ХХК-ийг шалгаруулан гэрээ байгуулах эрх олгосон нь хууль бус болжээ гэж үзэж байна.

Дээр дурдсан хууль зөрчсөн сонгон шалгаруулалтаар олгосон зөвлөмжөөр ИНЕГ-ын даргын 2012 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 01/385 тоот албан бичгээр “Эс” ХХК-д гэрээ байгуулах эрх олгогдсон байна. Үүний улмаас ИНЕГ, “Эс” ХХК-ийн хооронд 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдөр ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот гэрээ байгуулагдсан байна. Иймээс хууль бус шалгаруулалтаар шалгарсан “Эс” ХХК-тай ИНЕГ-ын 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот гэрээ нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 42.1.2 «захиалагч энэ хуулийн 27, 28, 29-р зүйлд заасан журмыг зөрчиж байгуулсан»-ны дагуу энэхүү гэрээ нь хүчин төгөлдөр бус гэрээ болжээ гэж үзэж байна.

Энэ үйл ажиллагааг зохион байгуулахдаа эхний ээлжинд зорчигч бүртгэлийн үйл ажиллагааг хялбаршуулах техник, технологи, программ хангамж, үйлчилгээгээр дагнан мэргэшсэн «SITA» ХХК, «Э» ХХК-иудыг өрсөлдүүлэн аль илүү болон хямд үнийн санал ирүүлсэн компанийг сонгон шалгаруулж системийг нь авч суурилуулан ажиллуулах, шалгарсан компанитай гэрээ байгуулахдаа тухайн

систем, техник хэрэгсэл, программ хангамж дээр ажиллах ажилчдаа дагалдуулан сургаж бэлтгэн аваад «ЧХ» ОУБ-аар өөрсдөөр нь операторын үйл ажиллагааг эрхлүүлсэн бол маш оновчтой гарц байсан гэж үзэж байна. Гэтэл энэ үйл ажиллагааг энэ байдлаар зохион байгуулж хийсэнгүй.

“А” ХХК нь тендерт заагдсан ажлыг 2012 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 299,3 сая төгрөгөөр нийлүүлсэн бөгөөд мөн тендер шалгаруулалтаар зорчигч бүртгэлийн дундын системд шаардлагатай тоног төхөөрөмж нийлүүлэх ИНЕГ/У/ХББ/Б-34/12 тоот гэрээг “Эс” ХХК-тай байгуулан 29,6 сая төгрөгийн техник тоног төхөөрөмж нэмж авсан байна. “А” ХХК энэ сонгон шалгаруулалтад оролцохдоо “Э” ХХК компанитай хамтран ажиллагч түнш байсан байна. Уг гэрээгээр “А” ХХК зорчигч бүртгэлийн дундын систем болох “vMUSE” системийг суурилуулж нутагшуулах, боловсон хүчнийг сурган бэлтгэж өгөх тухай үүрэг хүлээсэн бөгөөд энэ үүргээс боловсон хүчнийг сурган бэлтгэж өгөх үүргээ биелүүлээгүй байна.

...ИНЕГ нь 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдөр “Эс” ХХК-тай гэрээ байгуулсан боловч энэ үед “А” ХХК-аас зорчигч бүртгэлийн системийн тоног төхөөрөмжөө хүлээж аваагүй байсан. Өөрөөр хэлбэл, Э компанийн сүлжээг ашиглан зорчигч бүртгэл явуулах боломжгүй байсан. Дээрх 2 хоногийн хугацаанд «ЧХ» нисэх буудалд 134.083 зорчигч бүртгэгдэх ямар ч боломжгүй. Энэ мөнгийг яаж тооцсон гэхээр 2011 онд «ЧХ» ОУБ-аар дамжиж гадаадад зорчсон зорчигчдын статистик мэдээг үндэслэн жилд бүртгэгдэх зорчигчийн тоог харгалзан гэрээнд тусгагдсан 40 хувийн урьдчилгаа гэдгээр шилжүүлсэн байна. Тэгэхээр зорчигч бүртгэгдээгүй байхад мөнгө урьдчилаад шилжсэн гэсэн үг...» /22-р хх-ийн 58-66, 67-68/ гэсэн мэдүүлэг,

- Иргэний нисэхийн Ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Бу-ын баталсан удирдамжийн дагуу санхүүгийн хэсэгчилсэн хяналт шалгалт хийсэн тайлангийн 1.8-ын хавсралт №01 /1-р хх-ийн 24-31/,

- С.Бу /ИНЕГ-ын дарга/ мөрдөн байцаалтын шатанд гэрчээр өгсөн мэдүүлэгтээ: “...Үзүүлж буй төлбөрийн даалгавартай танилцлаа, 1-р гарын үсэг миний гарын үсэг байна, ОУБ-д зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгэх гэрээг 2012 оны 12 дугаар сарын

27-ны өдөр ИНЕГ-ын дарга асан С.Б болон “Эс” ХХК-ийн захирал А.Ба нар байгуулсан байдаг.

Миний бие 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ИНЕГ-ын даргын ажлыг хүлээн авсан бөгөөд манай байгууллагаас гэрээний дагуу харилцах дансаар тогтмол их хэмжээний мөнгөн гүйлгээ гардаг байсан. 2012 оны 12 дугаар сард “Эс” ХХК-ийн гэрээний дагуу 2012 оны 12 сарын сүүлээр 226.628.000 төгрөгийн нэхэмжлэхийг ерөнхий нягтлан бодогч Д.А оруулж ирж танилцуулан, урьд нь байгуулсан гэрээний дагуу шилжүүлэх ёстой гэж танилцуулсан. Ингээд би гэрээг нь авчруулж танилцахад гэрээний ерөнхий нөхцлийн 6-р зүйлд төлбөр хийх хугацаанаас 15 ба түүнээс дээш хоногоор хоцрох юм бол гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу 0.05 хувийн алданги төлөх үндэслэлтэй байсны дагуу нэхэмжилсэн төлбөрийг шилжүүлэх төлбөрийн даалгаварт гарын үсэг зурсан. Намайг ажилд авахаас өмнө энэ гэрээний дагуу нийт 830.000.000 гаруй төгрөг шилжүүлсэн байсан. Ингээд гэрээний дагуу төлбөр шилжүүлсний дараа үнийн дүн нь зөрүүтэй, зорчигч тутамд 1.000 төгрөг, 4.000 төгрөгийн хураамж тооцох нөхцөл бүхий давхар гэрээ гарч ирсэн бөгөөд үүнтэй холбогдуулан ИНЕГ-ын дотоод аудитын ажилчдыг хянуулахаар оруулсан бөгөөд гарч ирсэн дүгнэлтийг үндэслэн танай газарт шалгуулахаар хүргүүлсэн. Үүнээс хойш миний бие уг гэрээний дагуу ямар нэгэн төлбөр шилжүүлээгүй, энэ хугацаанд тус компаниас 2 ч удаа төлбөр нэхэмжилснийг шилжүүлээгүй байгаа...» /22-р хх-ийн 82-84/ гэсэн,

- Гэрч Б.Бо /ИНЕГ-ын Эдийн засгийн хяналт зохицуулалтын хэлтсийн агаарын тээврийн мэргэжилтэн/ “...ИНЕГ-ын даргын 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар “Зорчигч бүртгэлийн сүлжээний оператор”-ыг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог томилсон байна.

Үнэлгээний хорооны даргаар Д.Э, нарийн бичгийн даргаар Ж.Ч, гишүүдэд Ч.Ц, Б.А болон миний бие тус тус томилогдсон. ...Тендер хэрхэн зарласан талаар тодорхой мэдэхгүй байна. Ингээд 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдөр тендерийн нээлтийг хийсэн бөгөөд тендер “Эс” ХХК-аас материалаа ирүүлсэн байсныг нээж материалтай нь танилцахад АНУ-ын «А» ХХК-ийн төлөөлөгчөөр ажилладаг, нэг зорчигчоос 4.000 төгрөгийн бүртгэлийн

хураамж авахаар санал болгосон байсан нь урьд «М» ХК 6 ам.доллараар авч байснаас бага, мөн түүнчлэн бүртгэлийн систем их ачаалалтай байсан бөгөөд тус компанийн санал болгосон техникийн шаардлага нь тавьсан байсан шаардлагад нийцэж байсан тул санал нэгтгэйгээр тус компанийг сонгон шалгаруулсан. Өөр компани тендер ирүүлээгүй байсан. «Эс» ХХК-тай ямар нэгэн харьцаа холбоо, хувь оролцоо байхгүй, уг компанийн талаар сонсож ч байгаагүй, тендерт ороход анх олж мэдсэн, захирал ажилчдыг нь танихгүй, үүсгэн байгуулсан гэх М.Б-ыг танина, түүнтэй ажил үүргийн хуваарийн дагуу харьцдаг байсан. Түүнийг тус компанийн үүсгэн байгуулагч гэдгийг нь мэдэхгүй, сая сонслоо. Тус тендерийг сонгон шалгаруулахад хэн нэгний зүгээс заавар чиглэл өгсөн асуудал байхгүй...» /22-р хх-ийн 89-91/ гэсэн,

- Гэрч З.Ту /ИНЕГ-ын Захиргаа, удирдлагын газрын хуулийн хэлтсийн ахлах мэргэжилтэн/ “...2012 оны сар, өдрийг нь санахгүй байна, ямар ч байсан уг тендер зарлагдахаас өмнө Д.Э дарга намайг дуудаж, “Зорчигч бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагааг хангуулах операторын ажил гүйцэтгэх” тухай гэрээний төсөл үзүүлж, ийм ажил хийгдэх гэж байна, энэ гэрээг хянаж өгөөч гэж байсан бөгөөд миний бие тухайн гэрээний төсөлтэй танилцахад ямар ажил хийж гүйцэтгүүлэх гээд байгаа нь ойлгомжгүй, бүрхэг гэрээ байсан, тухайн үед би уг ажлыг хийж гүйцэтгүүлэх бол зохих журмын дагуу тендер зарлаж, сонгон шалгаруулах нь зүйтэй гэж саналаа хэлж байсан. Мөн гэрээгээ тодорхой болгох талаар зөвлөгөө өгсөн. Ингээд хэсэг хугацааны дараа ИНЕГ-аас Үнэлгээний хороо томилогдож, өмнө Д.Э даргын ярьж байсан ажил, үйлчилгээг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, захиалагчийн гэрээ байгуулах мэдэгдэл болон гэрээний төслийг хянуулахаар надад оруулж ирсэн. Миний хувьд тендер шалгаруулалтын материалтай танилцах шаардлага байхгүй бөгөөд захиалагчийн мэдэгдлийг үндэслэн гэрээний төслийг хянаж, Үнэлгээний хороонд хүргүүлсэн. Гэрээг хянахад зорчигч тутмаас хураах хураамжийг 3 ам.доллараар тогтоосон байсан бөгөөд Монгол Улсад төгрөгөөр аливаа гэрээ хэлцэл, төлбөр тооцоог хийх хууль тогтоомжийн дагуу төгрөгөөр илэрхийл гэсэн саналыг өгсөн байдаг. Ингээд миний хэлсний дагуу уг гэрээ зорчигч тутамд 4.000

төгрөг болж засварлагдаж орж ирсэн бөгөөд миний бие өөрийн гарын үсэг зурах хэсэгт гарын үсгээ зурсан. Ийм л үйл ажиллагаа болсон. Гэрээний төслийг бол тухайн Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нар Сангийн яамнаас батласан жишиг гэрээний дагуу боловсруулдаг. Гэрээтэй танилцахад “ЧХ” ОУНБ-аар үйлчлүүлж байгаа Авиа компаниудын зорчигч нарыг нисэх онгоцонд бүртгэх бүртгэлийн системийн програм, хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах, үйлчилгээ үзүүлэх нөхцөлтэй гэрээ байсан...» /22-р хх-ийн 99-102/ гэсэн,

Гэрч Д.Т /ИНЕГ-ын Агаарын харилцааны хэлтэст мэргэжилтэн/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: «...ИНЕГ-ын дарга тус байгууллагын ирэх оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг батладаг бөгөөд батлагдсан төлөвлөгөөний дагуу гадаад томилолтоор болон гадаадад суралцдаг. Мөн түүнчлэн байгууллагын онцлогоос хамаарч гадаад улсад томилолтоор ажиллах гэнэтийн шаардлага гардаг. Гадаадад томилолтоор ажиллуулах тохиолдолд газрын даргын тушаал гарч, уг тушаалыг үндэслэн холбогдох албан тушаалтанд зардал олгогдож, томилолтоор илгээдэг. Тухайн албан тушаалтан томилолтоос ирээд ажлын 5 хоногийн дотор томилолтын талаар тайлан, илтгэлийг өгдөг. Газрын даргын 2012 оны Б/65 тоот тушаалыг боловсруулсан. 2012 оны 03 дугаар сарын эхээс Д.Э дарга намайг өрөөндөө дуудаж, Хонконгт албан томилолтоор ажиллах батлагдсан удирдамж өгч, тушаалын төсөл боловсруул гэж үүрэг өгсөн. Тухайн удирдамжид дурдсанаар Д.Э, М.Б нар Хонконгт Монголоос үйлдэж буй М ХК-ийн нислэгийн давтамжийг 7 хоногт 5 болгох, Хонконгийн нисэх буудлын зорчигч бүртгэлийн системийн үйл ажиллагаатай танилцах, түүний ашиглалт болон үйлчилгээний талаар сургалт зохион байгуулах тухай ярилцах ажлаар явах тухай агуулгатай байсан. Ийм удирдамжинд заасны дагуу тушаалын төсөл боловсруулж, тушаалын төсөлд санал авах тухай хуудсаар газрын даргын зөвлөлийн гишүүдээр хянуулсны дараа эцсийн байдлаар бичиг хэргийн ажилтнаар гаргуулж, газрын даргаар батлуулсан. Надад Д.Э даргын өгсөн удирдамжинд Д.Э, М.Б нарыг сонгож нэрийг нь тусгасан байсан, эдгээр хүмүүсийг хэн сонгосныг мэдэхгүй. Дээрх чиглэлээр уулзалт зохион байгуулах талаар 2012 онд М ХК-иас нислэгийн давтамж нэмэгдүүлэх

талаар албан бичиг ирсэн байх ёстой. Харин Хонконгийн талаас ямар нэгэн уулзалтын тов, урилга ирсэн эсэхийг мэдэхгүй, томилолтын материалд хавсаргаагүй байсан. Манай хэлтэст албан томилолтоор ажилласан тайлан, илтгэлээ өгөх ёстой байдаг боловч Д.Э, М.Б нар тайлан, илтгэлээ өгөөгүй...” /22-р хх-ийн 106-108/ гэсэн мэдүүлгүүд,

- ИНЕГ-ын 2012 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Б/65 тоот тушаал, тушаалын төсөлд санал авах хуудас, албан томилолтын төсөв, удирдамж /22-р хх-ийн 109-111, 116-119, 120/,

- Гэрч Ц.Га /Олон улсын агаарын тээврийн холбооны мэдээллийн нийгэмлэг, “С” байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгч/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...Манай нийгэмлэг нь 1949 онд Европын авиа компаниудын сайн дурын үндсэн дээр байгуулагдсан авиа компаниудад мэдээлэл технологийн сүлжээгээр хангах туслах зорилготойгоор байгуулагдсан юм. Одоо манай нийгэмлэг дэлхийн 220 гаруй орон төлөөлөгчийн газартай бөгөөд 147 авиа компанитай хамтран ажиллаж байна. Манай нийгэмлэг нь одоо агаарын тээврийн авиа компаниуд болох “М”, “ЭЧ”, “КЭ” компаниудад үйлчилгээ үзүүлж байна.

...2012 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн өглөө 09 цагийн үед утсаар над руу Иргэний нисэхийн ерөнхий газраас яриад тендерт оролцох талаар албан бичиг байгаа, та ирж авна уу гэсний дагуу миний бие тэр өдрөө буюу 2012 оны 02 дугаар сарын 7-ны өдөр 10 цагийн орчимд очиж холбогдох хүнтэй уулзаж албан бичиг болон тендерийн нөхцлийн талаарх баримтуудыг авсан.

Тухайн үедээ надад тендерийн материал өгсөн хүнээс цаг хугацааны хувьд ямар хоцорч ирж байгаа юм бэ, мөн ямар учиртай тендер юм бэ гэхэд та наад материалтайгаа танилцаад албан бичгээр хариу ирүүлээрэй гэж байсан, тэгээд би тендерийн материалтай өдөрт нь танилцахад тендерийн материалд «Оператор үйлчилгээний техникийн шаардлага 1, 2-д зааснаар «Операторын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж нь жилд дунджаар 200,000-250,000 зорчигч бүртгэх хүчин чадалтай техник, төхөөрөмжтэй байна» гэдгийг яг хэдэн үйлчилгээний цэгтэй байх талаар тодруулах шаардлага гарсан тул 2012 оны 02 дугаар сарын 08-ны өдөр албан бичиг төлөвлөж, Иргэний нисэхийн ерөнхий газарт өөрийн биеэр аваачиж өгсөн,

тэгж өгөхдөө уг албан бичигт тендерийн урилга хугацаа алдаж ирсэн талаар тусгасан юм. Тэгээд уг заалтын хариу ирэх байх гэж хүлээсэн боловч ирээгүй бөгөөд тендерийн хугацаа дууссан. Ингээд би эргэж Иргэний нисэхийн газартай холбогдоогүй юм. Манай байгууллагын хувьд 1-рт уг тендер оролцоход цаг хугацааны хувьд амжаагүй учир нь тендерийн урилгыг бид оройтож авсан, 2-рт тодруулах зүйл байсан, 3-рт би албан бичигт дурдсан байгаа төвдөө монгол материалыг орчуулаад явуулах, уг материалыг авсан төв газраас тендер оролцох эсэх талаар хариу ирэх зэргээс харахад ямарч боломжгүй байсан юм. Захиалагч талын хувьд бидэнд тендерийн материалыг өгөхдөө тендер оролцох болон материалыг нягтлан шалгах хугацаа олгоогүй байсан нь бидний хувьд тендер оролцоогүй гол шалтгаан юм...» /22-р хх-ийн 122-123/ гэсэн мэдүүлэг,

- ИНЕГ-ын 2012.01.26-ны өдрийн № 07/229 дугаартай, “С” компанид хүргүүлсэн албан тоот, “С” монгол дахь төлөөлөгчийн газраас 2012.02.08-ны өдөр ИНЕГ-т хүргүүлсэн тендерийн лавлагаа авах тухай албан бичиг, гэрчилгээ /22-р хх-ийн 123-124, 125, 126-127/,

- Гэрч П.Ха /ИНЕГ-ын Санхүү, эдийн засгийн газрын хөрөнгө оруулагч, захиалагчийн албаны мэргэжилтэн/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “... Би 2008 оноос эхлэн ИНЕГ-ын Тендерийн материал бүрдүүлэлтийн тасгийн мэргэжилтэнгээр ажилд орж одоог хүртэл ажиллаж байна. ИНЕГ-ын даргын 2011 оны 07 сарын 06-ны өдрийн 262 тоот тушаалаар Нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж суурилуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай ИНЕГ/ТББ/Б-73/11 тоот тендерийн Үнэлгээний хороо байгуулагдсан. Ингээд Үнэлгээний хорооноос тендерийг нээлттэй зарлахаар шийдвэрлэж урилгыг 2011 оны 09 сарын 20-ны өдөр “Монголын мэдээ” сонин болон Сангийн яамны сайтад тус тус тавьсан. Тендерийг 2011 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаатайгаар зарласан. Тендерийн бичиг баримтын техникийн тодорхойлолтонд зааснаар Нийлүүлэх тоног төхөөрөмж нь нислэг үйлдэж буй агаарын тээвэрлэгчдийн болон ирээдүйд нислэг үйлдэж болох агаарын тээвэрлэгчдийн програм хангамжинд нийцтэй байхын тул ИАТА-ны КР1797 дугаар

зөвлөмжид техникийн шаардлагыг бүрэн хангасан байх, мөн баталгаат хугацаа нь 12 сар хүртэл байх зэрэг үндсэн шаардлагыг хангасан байхаар заасан. Ингээд тендерийн материалыг “ЭСЭ” ХХК, “СТс” ХХК, “Дт” ХХК, “С-гийн Монгол дахь төлөөлөгчийн газар, “А” ХХК, “ӨЭ ӨЭ” ХХК-ниуд тус тус худалдаж авсан. Ингээд 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр тендерийг нээхэд “А” ХХК материалаа ирүүлсэн байсан бөгөөд үнэлгээг хийхэд тус компани нь тендерийн баримт бичгийн техникийн шаардлагыг бүрэн хангасан, “Ап” олон улсын компанийн албан ёсны борлуулагчийн эрхтэйгээр тендер орсон байсан учир Үнэлгээний хороо тус компанийг санал нэгтгэйгээр сонгон шалгаруулсан байдаг. Тендерийн техникийн тодорхойлолтонд зааснаар тоног төхөөрөмжийг нийлүүлж, серверын өрөөний суурилуулалт хийх, үндсэн сүлжээ байгуулах, системийн угсралт суурилуулалт, туршилт, шалгалт, сургалт, бүртгэлийн цэгийн тоног төхөөрөмж холбох, шалгах зүгшрүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна...” /22-р хх-ийн 129-131/ гэсэн мэдүүлэг,

- “А” ХХК-ийн 2012 оны №201204/А-218, №201201/А003, 201203/А032, 201204/А-0219 дугаартай албан бичгүүд, тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн акт /2012 оны 02 сарын 17/ /13-р хх-ийн 152-169/,

- ИНЕГ-ын үндсэн хөрөнгийн 2012 оны баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл болон үзлэгээр бэхжүүлж авсан 2012.04.19-ний өдөр «А» ХХК-аас ИНЕГ нь тоног төхөөрөмж, программ хангамж хүлээн авсан ажлын комиссын акт /26-р хх-ийн 116-138/,

- Гэрч Б.Гб /“Г” ХХК-ийн захирал/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ:

“... “А” ХХК-ийг 2003 онд Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр миний аав Б-н дүү Д-ийн М болон Т нар үүсгэн байгуулсан байдаг. Миний хувьд 2006 оны 10 сараас 2012 оны 04 дүгээр сар хүртэлх хугацаанд гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Тус компани нь олон улсын ярианы карт, тоног төхөөрөмжийн худалдаа, төсөл, хөтөлбөр, программ, хангамж, мэдээлэл, технологи, интернетийн үйлчилгээ үзүүлдэг. 2011 онд ИНЕГ-аас зорчигч бүртгэлийн цогц систем нийлүүлэх тендер зарлаж байгаа талаар сонин, хэвлэлд тавигдсан байсныг олж мэдэн, хүсэлт гарган тендерийн материалыг нь худалдан авч, тендер оролцож шалгарсан. Тухайн тендер нь ИНЕГ-аас “СХ” олон улсын

буудалд зорчигч бүртгэлийн системийн тоног төхөөрөмж, програм хангамж нийлүүлэх ажил байсан бөгөөд гэрээний дагуу зохих, тоног төхөөрөмжийг нийлүүлж, суурилуулан 2012 оны 04 сард хүлээлгэн өгсөн. Гэрээний дүн нь нийт 200,000,000 орчим төгрөг байсан санагдаж байна. Манай компани тендерийн дагуу "ЧХ" ОУБ-д дараах бараа, материалыг нийлүүлсэн байдаг. Түүнчлэн тоног төхөөрөмжүүдийн программ хангамжуудыг нийлүүлж, Нисэх буудлын шаардлагатай газруудад нь суурилуулж өгсөн. Нисэх буудалд серверийн өрөөнд сервертэй холбоотой тоног төхөөрөмжүүдийг, олон улсын бүртгэлийн цэгт зорчигч бүртгэлийн системтэй холбоотой тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан. Тухайн бүртгэлийн систем, тоног төхөөрөмжийн програм хангамж нь хязгаарлагдмал байсан бөгөөд тендерт оролцохын өмнө бүртгэлийн төхөөрөмжийг ажиллуулах програм хангамжийг авах газрыг хайх шаардлагатай болсон. Ингээд судлаж байгаад АНУ-ын «А» болон одоо нэрийг нь санахгүй байгаа, бусад гадаадын компаниуд руу электрон шуудангаар програм, хангамжийн талаарх мэдээлэл, танилцуулгыг нь хүсэж удаа дараа захиа илгээсэн бөгөөд «А» компанийн Ази дахь салбараас хариу ирсэн байдаг. Ингээд тус компанитай харьцаж, зорчигч бүртгэлийн багц систем, програм, хангамжийг худалдан авахаар болсон бөгөөд тоног төхөөрөмжүүдийг суурилуулах үед тус компаниас 3 хүн ирж, сүлжээ програм хангамжийг тавьж өгсөн байдаг. Дээрх гадаад иргэд нь Вьетнам, Малайз улсын иргэд байсан. Манай компаниас О гэж инженер оролцсон. Манай компани нь «ЧХ» олон улсын буудалд тоног төхөөрөмжийг нь программ хангамжтай нь суурилуулж өгснөөр акт үйлдсэн. Тэгэхээр уг тоног төхөөрөмжүүдийг цааш нь ашиглаж, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон гэсэн үг. ИНЕГ-т 2012 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр хүргүүлсэн 201201/A003 дугаартай албан бичиг нь манай компаниас явуулсан тоот байна. Уг бүртгэлийн систем, тоног төхөөрөмжөөр бүртгүүлсэн зорчигчдын мэдээлэл Олон улсад сүлжээгээр холбогдсон байх ёстой байдаг талаар А компаниас манайд хандсаны дагуу уг албан бичгийг явуулсан. Бидний суурилуулж өгсөн бүртгэлийн систем, тоног төхөөрөмж нь зөвхөн дотооддоо бүртгэлээ явуулах боломжтой боловч гадаад улсуудын нэгдсэн бүртгэлийн сүлжээнд холбогдоогүй

байсан юм. Ингээд тэр сүлжээгээ холбуулах шаардлагатай талаар ИНЕГ-т мэдэгдсэн. Хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжүүд дээр ажиллах сургалтыг нисэхийн ажилчдад "А" компаниас ирсэн төлөөлөгч заасан. Миний хувьд М.Б-тай МУИС-ын Электроникийн инженерийн ангид 1995-1999 онуудад хамт суралцаж төгссөн. Гэхдээ ойр дотно харьцаа холбоо байхгүй, нэг ангийн хүүхдүүд юм...» /22-р хх-ийн 134-137/ гэсэн,

- Гэрч Б.Мө /"АЭБ" ХХК-д хуульчаар ажиллаж байсан/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: "...Би "АЭБ" ХХК-нд ажиллах хугацаандаа гадаад, дотоод гэрээ, хэлцлийг хянах, хуулийн зөвлөгөө өгөх асуудал хариуцаж байсан. Би "АЭБ" ХХК-д ажиллаж байх хугацаандаа "Эс" ХХК-д хуулийн зөвлөгөө өгч байсан. И-мэйлд хавсаргасан одоо надад үзүүлж буй бичиг баримтаас үзвэл "Эс" ХХК нь "British Virgin Island" /Бритиш Виржин Айланд/-д хуулийн этгээд үүсгэн байгуулах хүсэлт тавьж, түүндээ туслуулахаар манай хуулийн фирмд хандаж байсан. Миний хувьд "Эс" ХХК-ийн захирал М.Б-ын үүсгэн байгуулах гэж байгаа хуулийн этгээдийг үүсгэн байгуулахад туслалцаа үзүүлж буй гадны этгээдтэй захирал Б.Б-гийн өгсөн мэйл хаягаар харьцаж М.Б-ын надад өгсөн материалуудыг тухайн этгээдэд электрон шуудангаар явуулж байсан. "Эс" ХХК-ийн захирал М.Б нь " British Virgin Island "-д хуулийн этгээд үүсгэн байгуулах туслалцаа хүсэж байсан. Эдгээр хүмүүс буюу Г.Чи, Ч.Ө, М.Б, Д.Э гэх хүмүүс нь М.Б-ын "British Virgin Island"-д тэр үүсгэн байгуулах гэж байсан хуулийн этгээдийн хувьцаа, эзэмшигч эвсэл ТУЗ-ийн гишүүд нь байсан байх. Ийм учраас тухайн бичиг баримтуудыг буюу дээрх хүмүүсийн тодорхойлолт, иргэний бичиг баримтыг компанийн орчуулагчаар орчуулуулж хянаад захирал Б.Б-гийн өгсөн хаяг бүхий гадаад хүн рүү явуулж байсан байна. Явуулсан мэйлээсээ харахад М.Б гадаадад хуулийн этгээд үүсгэн байгуулж, тэр компанийнхаа нэрээр гадаадад харилцах данс нээлгэх шаардлагатай болж түүнийхээ дагуу Хонконг руу явах болж би захирал Б.Б-гийн холбож өгсөн гадаад хүнтэй мэйлээр холбогдож шаардлагатай авч явах бичиг баримтыг М.Б-од хэлж, дамжуулж байсан байна. Яагаад М.Б нь Хонконг явж байна гэхээр бүхий л материалаа хэдийн гадаад руу надаар дамжуулж явуулсан боловч гадаадад өөрөө очиж банкны баталгаа, гарын үсгээ зурах шаардлагатай байсан байх. Би Г.Чи,

Ч.Ө, Д.Э нартай биечлэн уулзаж байгаагүй. Харин М.Б нь энэ хүмүүсийнхээ материалыг надад авчирч өгч байсан. Би гадаад хүнтэй холбогдоод шаардлагатай бичиг баримтыг М.Б-оос авч орчуулагчаар орчуулуулж, нөгөө гадаад хүн рүү явуулж байсан. Харин хувийг нь М.Б-од явуулдаг нь М.Б Хонконг явахад нь хэрэгтэй байсан учраас л явуулсан байх. Би тус компанид ажиллах хугацаандаа анх удаа л гадаадад хуулийн этгээд үүсгэн байгуулах ажлыг хийж байсан, ...Надад үзүүлж буй англи хэл дээр бичигдсэн Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулагдсан, нийт 9 хуудас бүхий хүснэгт, жагсаалт хэлбэрээр оруулсан компаниудын нэрс байна. Би өмнө мэдүүлсэнчлэн “Эс” ХХК-ийн захирал М.Б нь манайд хандаж Их Британи Виржиний арлуудад компани үүсгэн байгуулах хүсэлт тавьж байсны дагуу холбогдох баримтуудыг цуглуулж байсан, өмнөх мэдүүлэгтээ ч энэ талаар дурдсан. Одоо үзүүлж буй 9 хуудас компаниудын нэрсийг “Эс” ХХК-ийн захирал М.Б-д үзүүлж Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулах компанийн нэрийг нь сонгуулсан байна. Хүснэгтээс харахад тус компаниуд нь үүсгэн байгуулагдчихсан компаниуд байх бөгөөд эдгээр дотроос М.Б-оор сонгуулж, сонгогдсон компанийг М.Б нарын нэр дээр болгох талаар бичиг, баримтыг нь цуглуулж өгсөн.

...Надад үзүүлж буй OLN Corporate services гэсэн толгой бүхий Check list on Initial Setting up of a British Virgin Islands Company гэсэн гарчиг бүхий 5 нүүр материалтай танилцлаа. Уг материалыг OLN корпорациас мэйлээр ирүүлж компани үүсгэн байгуулахтай холбоотой мэдээллүүдийг нөхөж бичих талаар дурдсан байсан. Ингээд үүний дагуу М.Б-оос мэдээллийг авч, 1 дэх хэсэг буюу боломжит 9 компанийн нэрс, 5 дугаар хэсэг буюу хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл, хувьцааны тоо, 6 дугаар хэсэг буюу захирлын талаарх мэдээлэл, 11 дэх хэсэг буюу бизнесийн чиглэл, 12 дахь хэсэг буюу харилцах банкны сонголт, үйлчилгээний хэлбэр, данснаас хэн гүйлгээ хийх зэрэг мэдээллийг нөхөж оруулж, М.Б-од өгсөн. Гадаадад үүсгэн байгуулах компанийн захирлаар нь Д.Э, хувьцаа эзэмшигчээр нь Г.Чи, Ч.Ө, М.Б, Д.Э нар болж байсан бөгөөд дээрх компани нь HSBC банкинд данс нээлгэхээр сонгож байсан. Данснаас Д.Э, М.Б нар хамтаар гүйлгээ хийх эрхтэй байхаар сонгож байсан. Миний одоо санаж

байгаагаар Их Британи Виржини арлуудад компани үүсгэн байгуулах талаар Хонконг дахь OLN компанитай харьцаж байсан юм байна.

Надад үзүүлж буй 22 хуудас Г.Чи, Ч.Ө, М.Б, Д.Э нарын оршин суугаа газрын тодорхойлолт, иргэний үнэмлэхний хуулбар, англи дээрх орчуулга, гадаад паспортын хуулбар зэрэг баримт нь Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулах компанийн хувьцаа эзэмшигч нарын мэдээллийг компаниас бүрдүүлж өг гэсний дагуу бүрдүүлсэн баримт байна.

Надад үзүүлж буй 1 хуудас англи хэл дээр бичигдсэн банкны тодорхойлолтын загвар нь тухайн үед миний М.Б-д явуулсан загвар байна. Энэхүү загварын дагуу компанийн хувьцаа эзэмшигчид өөрсдийн нэр дээрх харилцах банкнаас тодорхойлолт авч OLN компанид явуулах учиртай байсан. Энэ нь OLN компанийн Виржиний арлуудад компани үүсгэн байгуулах шаардлагатай баримтуудын 1 хэсэг байсан.

Надад үзүүлж буй 2 хуудас англи хэл дээр OLN компаниас ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэл байна. Энэ нэхэмжлэхийн дагуу бид төлбөрийг шилжүүлсэн байх.

Надад үзүүлж буй 6 хуудас Б.Б захиралд гэсэн баримттай танилцлаа. Уг гэрээ нь OLN компаниас Д.Э, М.Б, Г.Чи, Ч.Ө нарт үйлчилгээ үзүүлэх гэрээ байна.

Надад үзүүлж буй 3 хуудас англи хэл дээрх “Эс” ХХК-ийн танилцуулга, монгол хэл дээрх компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ байна. Уг баримтыг мөн компани үүсгэн байгуулахад OLN компаниас шаардсан байх.

Надад үзүүлж буй буюу Б.Б захиралд хаягласан мэйлээс үзвэл тус мэйлийг OLN компаниас явуулсан бололтой. Энэхүү мэйлээрээ М.Б болон Д.Э нар нь Хонконгт ирэхдээ ямар бичиг баримтуудыг авчрахыг сануулсан байна. Надад үзүүлж буй 4 хуудас компанийн нь “Эс” ХХК-ийн дүрэм байна, үзүүлж буй 1 хуудас Costs/charges гэсэн хаягтай баримтыг санахгүй байна.

Надад үзүүлж буй 6 хуудас материал нь «АЭБ» ХХК-аас “Эс” ХХК-нд илгээсэн албан бичиг бүхий төлбөрийн нэхэмжлэх болон үзүүлсэн үйлчилгээ болон зарцуулсан цагийг тайлбарласан хавсралт зэрэг баримт байна.

...Миний хувьд Их Британи Виржиний арлуудад анх удаа компани үүсгэн байгуулахад тусалсан тохиолдол юм. Тухайн үед OLN гэсэн компанийн нэр, үйл ажиллагааг мэдэхгүй байсан. Миний хувьд

Б.Б захирлын өгсөн үүргийн дагуу хийгдсэн ажлын дэлгэрэнгүй жагсаалтанд дурдагдсан Ан гэж хүний мэйлээр харьцаж байсан. Энэ хүн OLN компанид ажилладаг байсан юм байна. Тухайн үедээ бол би сайн ойлгоогүй байсан. Ан гэж хүний мэйлийг надад Б.Б захирал өгсөн байдаг.

...М.Б, Д.Э нар нь дээрх дурдсан цаг хугацаанд болон өөр хугацаанд Хонконг руу явсан эсэхийг мэдэхгүй байна. Цаанаас нь ирэх шаардлагатай болоод ир гэж байсан байлгүй дээ. Банкны данс нээхэд Хонконгт М.Б, Д.Э нар заавал очих шаардлагатай байсан байх. Миний хувьд нарийн асуудлыг нь сайн мэдэхгүй байна. Захирал Б.Б сайн мэдэх байх.

...Уулзалтын товыг өөрчлөх талаар захирал Б.Б и-мэйл илгээсэн байна. Тэгэхээр Хонконгт уулзах уулзалтын товыг хэзээнээр өөрчилснийг нь мэдэхгүй байна...» /22-р хх-ийн 143-147, 148-151/ гэсэн мэдүүлгүүд,

- Б.Мө-ийн "АЭБ" ХХК-д ажиллаж байсан талаарх холбогдох тушаал /25-р хх-ийн 83-86/,

-М.Б-ын электрон шууданд агуулагдаж буй мэдээлэлд үзлэг хийсэн тэмдэглэл /12-р хх-ийн 100-158/,

-2013.05.14-ний өдөр g@marcolink.mn гэсэн хаягаас ирсэн захиа болон түүнд хавсаргасан фото зургууд нийт 10 хуудас /12-р хх-ийн 103-112/,

-2013.05.08-ны өдөр M@aa.mn гэсэн хаягаас ирсэн захиа 1 хуудас /12-р хх-ийн 113/,

-2012.03.15-ны өдөр M@aa.mn гэсэн хаягаас ирсэн захиа 1 хуудас /12-р хх-ийн 114/,

-2012.03.15-ны өдөр M@aa.mn гэсэн хаягаас ирсэн захиа болон түүнд хавсаргасан материал нийт 2 хуудас /12-р хх-ийн 115-116/,

-2012.01.12-ны өдрийн М.Б-ын оршин суух газрын тодорхойлолт англи орчуулгын хуулбарын хамт 2 хуудас,

-М.Б-ын УБ..... тоот иргэний үнэмлэхний хуулбар орчуулгын хуулбарын хамт 2 хуудас,

2012.01.012-ны өдрийн Д.Э-ын оршин суух газрын тодорхойлолт англи орчуулгын хуулбарын хамт 2 хуудас,

Д.Э-ын УБ..... тоот иргэний үнэмлэхний хуулбар орчуулгын хуулбарын хамт 2 хуудас,

Д.Э-ын Е-0.... тоот, М.Б-ын Е-04.... тоот, Ч.Ө-ны Е-0.... тоот, Г.Чиын Е-0.... тоот гадаад паспортын хуулбарууд /12-р хх-ийн 117-139/,

- Гэрч А.Ба мөрдөн байцаалтын шатанд

өгсөн мэдүүлэгтээ: "...Миний хувьд "Эс" ХХК-ийн талаар тодорхой мэдэхгүй, манай нөхөр М.Б хариуцан ажилладаг, надтай 2008 онд танилцахдаа компаниа үүсгэн байгуулсан байсан бөгөөд ИНЕГ-ын "ЧХ" ОУБ-д сүлжээний инженерээр ажиллаж байсан, гэрээний талаар мэдэхгүй, нөхрийнхөө ажилд оролцдоггүй, асуухаар уурлаад байдаг, уг компанийн санхүүгийн тайлан, гэрээнд гарын үсэг зуруулдаг, 4.000, 1.000 төгрөгийн үнэ бүхий гэрээнүүдэд хэзээ, хаана гарын үсэг зурснаа санахгүй байна, миний гарын үсэг мөн..." /22-р хх-ийн 167-170/ гэсэн,

- Гэрч Л.Эр /"Эс" ХХК-ийн сүлжээний инженер/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: "... "Эс" ХХК-ийн захирал М.Б нь миний ээж Энхтуулын төрсөн дүү юм. Бидний хувьд хамт амьдардаггүй, ах л гэж явдаг. Би 2012 оны 08 сараас тус компанид сүлжээний инженерээр томилогдон ажиллаж байна. Миний хувьд "ЧХ" Олон улсын буудалд байрлах зорчигч бүртгэлийн тоног, төхөөрөмж, системийн тасралтгүй ажиллагааг хангаж ажиллах чиг үүрэгтэйгээр ажилладаг. Манай компани нь "ЧХ" ОУБ-ын 1 давхарт түрээсийн өрөөнд байрлаж үйл ажиллагаа явуулж байна. Ерөнхийдөө нийт 3 инженертэй бөгөөд 24 цаг ажиллаж, 48 цаг амрах хуваарьтай. "ЧХ" ОУБ-аар гадаад улсад зорчиж буй зорчигчдыг бүртгэх тоног төхөөрөмж, системийн тасралтгүй ажиллагааг 24 цаг хангаж ажиллах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Бүртгэлийн систем, тоног төхөөрөмж нь Олон улсын нислэг бүртгэлийн цэг дээр 9 ширхэг, нислэг бүртгэлийн цэг дээр 1 ширхэг, Онгоц руу гарах 3 хоолойн дээр тус бүр 1 ширхэг байрладаг. Мөн түүнчлэн тус нисэх буудалд байрлах манай компанийн ажлын өрөөнд болон нисэх буудлын серверийн өрөөнд мөн бүртгэлийн системийн төв серверүүд байрлаж байгаа. Бидний хувьд эдгээр тоног төхөөрөмжийг хэвийн ажиллуулах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл, ямар нэг гацалт, доголдол үүсвэл очиж засварлаж хэвийн ажиллагаанд нь оруулах үүрэгтэй. Бүртгэлийн систем дээр "М" компаниас ажилчид сууж бүртгэлийг явуулдаг. Бидний хувьд бүртгэлийн ажиллагааг явуулдаггүй..." /22-р хх-ийн 174-175/ гэсэн,

- Гэрч Г.Дө /"Эс" ХХК-ийн сүлжээний инженер/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: "...Би "Эс" ХХК-д 2012 оны 02 сараас эхлэн сүлжээний инженерээр ажилласан. Миний ажил үүргийн хуваарь нь

“ЧХ” ОУНБ дээр байрлах зорчигч бүртгэлийн системийн бэлэн байдлыг хангах, эвдрэл гэмтлийг засаж янзлах чиг үүрэгтэй. Тус компани нь “ЧХ” ОУНБ-ын зорчигч бүртгэлийн системийг хариуцан ажилладаг. Өөрөөр хэлбэл, тус нисэх буудалд байрлах Олон улсын нислэг бүртгэлийн цэг дээр байрлах 9 ширхэг, VIP цэг дээр байрлах 1 ширхэг, Гарц буюу хоолойн дээр байрлах 3 ширхэг, орон нутгийн нислэг дээр байрлах 2 ширхэг нийт 15 ширхэг бүртгэлийн тоног төхөөрөмжийг бэлэн байдлыг хангаж, ямар нэгэн эвдрэл, гэмтэл, гацалтгүйгээр ажиллуулах чиг үүргийг хүлээдэг. Бүртгэлийн систем дээр манай компаниас ажиллаж, операторын үйл ажиллагаа явуулдаггүй, харин зорчигч бүртгэлийн системийн тоног төхөөрөмж дээр «М» ХК-ний ажилчид сууж, бүртгэлийн үйл ажиллагаа явуулдаг. Бидний хувьд зөвхөн тоног төхөөрөмж болон системийн бэлэн байдлыг хангаж ажилладаг...» /22-р хх-ийн 176-178/ гэсэн,

- Гэрч Ч.А / “Эс” ХХК-ийн системийн инженер/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...Би “Эс” ХХК-д системийн инженер ажилтай. Миний хувьд “ЧХ” ОУБ дээр байрлах бүртгэлийн систем, тоног төхөөрөмжүүдийн бүрэн бүтэн байдал, эвдрэл, гэмтлийн хариуцаж ажилладаг. Манай компани нь “ЧХ” ОУБ-ын гадаад, дотоодын болон VIP нислэгийн цэг, хоолойнууд дээр байрлах бүртгэлийн систем, тоног төхөөрөмжүүдийн бэлэн байдлыг хангаж, эвдрэл гэмтлийг цаг алдалгүй засаж янзлах чиг үүргийг нислэгтэй хугацаануудад хангаж ажиллах үйл ажиллагаа явуулдаг. Бүртгэлийн систем дээр “М” ХК-ийн бүртгэгч нар болон Авиа компаниудын бүртгэгч нар сууж ажилладаг. Бид нар сууж бүртгэл явуулдаггүй. Харин тоног, төхөөрөмж, системийг нь засаж янзалдаг...” /22-р хх-ийн 179-180/ гэсэн,

- Гэрч Ц.Ц /ИНЕГ-ын “ЧХ” ОУБ-ын Санхүү, нягтлан бодох, бүртгэлийн хэлтсийн дарга/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...2012 онд ИНЕГ-аас “ЧХ” ОУБ-д Зорчигч бүртгэлийн тоног төхөөрөмж нийлүүлэх тендерийг зарлан, холбогдох тоног, төхөөрөмжүүд суурилагдсан. Уг тоног төхөөрөмжийг манай үндсэн хөрөнгөд 2012 оны 02 дугаар улиралд бүртгэгдэж, байгууллагын орлогод авсан. Уг тоног төхөөрөмжүүдийг ИНЕГ-ын Санхүү, эдийн засгийн газарт орлогоор авсан бөгөөд бүртгэл, санхүүгийн анхан шатны баримт нь

ИНЕГ-ын үндсэн хөрөнгө хариуцсан нягтлан бодогчид байгаа. Өөрөөр хэлбэл, манай “ЧХ” ОУБ дээр уг тоног төхөөрөмж нь байрладаг боловч үндсэн хөрөнгийн анхан шатны баримт нь ИНЕГ-т байрлаж байгаа болно...” /26-р хх-ийн 182-183/ гэсэн мэдүүлгүүд,

-ИНЕГ-ын үндсэн хөрөнгийн 2012 оны баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл болон үзлэгээр бэхжүүлж авсан 2012.04.19-ний өдөр «А» ХХК-с ИНЕГ тоног төхөөрөмж, программ хангамж хүлээн авсан ажлын комиссын акт /26-р хх-ийн 116-138/,

Гэрч П.Б /ИНЕГ-ын «ЧХ» ОУБ-ын Мэдээлэл, технологийн албаны дарга/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: «...Миний хувьд 1987-1999 онуудад Буянт-Ухаа төв буудалд холбооны хэсгийн дарга, инженер. 1999-2013 онуудад Буянт-Ухаа /ЧХ/ төв буудлын Теле мэдээлэл холбооны албаны дарга, 2014 оноос “ЧХ” ОУБ-ын мэдээлэл, технологийн албаны даргаар тус тус ажиллаж байна. Манай мэдээлэл технологийн алба нь дотроо 5 хэсэгтэй. Үүнд:

Аюулгүй үзлэгийн тоног төхөөрөмжийн хэсэг.

Холбоо шуурхай мэдээллийн хэсэг.

Камерын хяналт, галын дохиоллын хэсэг.

АТС, кабель шугамын хэсэг.

Мэдээлэл, сүлжээний хэсэг гэсэн зохион байгуулалттайгаар ажиллаж байна.

Тус алба нь «ЧХ» ОУБ-ын нислэг, үйлчилгээний технологи үйл ажиллагаа холбоо, мэдээллийн үйлчилгээг хангах үндсэн чиг үүрэгтэй. Тус алба нь нийт 24 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд галын дохиоллын оператор 4 хүн, ээлжийн техникч 4 хүн, ээлжийн инженер 4 хүн, хэсэг хариуцсан инженер, техникч 12 хүн байдаг. Уг бүтцээр 1999 оноос үйл ажиллагаа явуулж байна. 2005 оноос ийм тооны бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. 2012 онд ээлжийн инженерийн орон тоонд 4 хүн нэмэгдсэн. Өөрөөр орон тоонд өөрчлөлт ороогүй. 1990 оноос манай нисэх буудалд Зорчигч бүртгэлийн системийг суурилуулж, «С» компанийн сүлжээг ашиглан зорчигчийн бүртгэл, суудал захиалгын системийг нэвтрүүлж одоог хүртэл ажиллаж байна. 2010, 2011 оноос эхлэн Нисэх буудлын хэмжээнд «С» компанийн үйлчилгээ нь өндөр үнэтэй зардал ихтэй тул өөр хямдхан үйл ажиллагаа явуулах системийг хайх тухай

асуудал яригдаж эхэлсэн. Энэ асуудлыг хамгийн их санаачилж, ярьж эхлэсэн хүн бол «ЧХ» ОУБ-ын Зорчигч үйлчилгээний албаны дарга Д.Э юм. Ингээд Д.Э нь ИНЕГ-т хэлтсийн даргаар явсан бөгөөд үүнээс хойш уг асуудал ИНЕГ-ын хэмжээнд яригдаж эхэлсэн. Ингээд 2012 онд «А» гэж компанийн сүлжээ, тоног төхөөрөмжийг ашиглахаар болж холбогдох тендерийг ИНЕГ-аас зарлаж, “А” ХХК шалгарсан байсан. Энэ талаар бидэнд ямар нэгэн ойлголт бараг байгаагүй. Удирдах газраас шууд шийдвэрлэж байсан. Ингээд 2012 онд “А” ХХК нь манай нисэх буудалд тоног төхөөрөмж, программ хангамжийг нийлүүлж, кабель, шугамыг холбож суурилуулж эхлэсэн бөгөөд энэ асуудлыг тухайн үед манай сүлжээ, мэдээллийн инженер М.Б хариуцан ажиллаж байсан. Өөрөөр хэлбэл, өөрийн хариуцаж байсан ажлын чиг үүргийн дагуу уг ажлыг Нисэх буудал талаас хариуцсан. Энэ үеэр Нисэх буудлын дарга, удирдлагын хэмжээнд тухайн тоног төхөөрөмжийг суурилуулсны дараа уг тоног төхөөрөмжийг манай Телемэдээлэл холбооны албанд хариуцуулж өгөхөөр яригдаж байсан бөгөөд үүнтэй холбоотойгоор 2012 онд манай албанд 4 ээлжийн инженерийн орон тоог ИНЕГ-ын даргаас батлаж өгсөн. Ингээд манай алба нь уг бүртгэлийн тоног төхөөрөмжийн ашиглалтын бэлэн байдлыг хариуцахаар төлөвлөж ээлжийн инженер, техникч нарын ажлын байрны тодорхойлолтонд оруулахаар бэлтгэж байсан боловч уг тоног төхөөрөмжийг манайд хүлээлгэж өгөх ажил хойшлогдоод байсан. Ингээд энэ талаар Нисэх буудлын захиргаагаар дамжуулан ИНЕГ-аас шаардахад уг ажлыг “Эс” ХХК-нд гэрээгээр хариуцуулж өгсөн талаар олж мэдсэн. Ингээд манай алба нь уг тоног төхөөрөмжийг ямар нэгэн байдлаар хариуцахгүй байгаа. Уг нь бол чиг үүргийн дагуу манай алба хариуцах ёстой ажил юм. Гэтэл хувийн компанид өгсөн нь ойлгомжгүй байгаа юм. Манай албанд уг ажлыг хариуцаж явуулах нөөц бололцоо байгаа гэж бодож байна. ИНЕГ-аас 4 хүний орон тоо хүртэл нэмж батлаж өгсөн шүү дээ. Сүлжээний инженер М.Б-ыг 2013 оны 03 сараас эхлэн ажлаас нь өөрийнх нь хүсэлтээр чөлөөлсөн байдаг. Тэр урьд нь манайд ажиллах хугацаандаа буудлаас зарласан тендерт оролцож тодорхой ажил хийж байсан. Тэр үед “Эс” гэж компанитай талаар нь мэдсэн. Тухайлбал нислэгийн мэдээллийн дэлгэцийн системийг хувийн компаниараа

хийж нийлүүлсэн байдаг. 2012 онд «А» компанийн тоног төхөөрөмж суурилагдаж бэлэн байдлыг нь М.Б-ын компани хариуцаж эхлэсэн бөгөөд М.Б-ын улсын ажил, хувийн ажил нь давхцаж эхлэсэн. Өөрөөр хэлбэл, М.Б нь ажил үүргийнхээ хуваарийн дагуу уг тоног төхөөрөмжийг хариуцах ёстой байсан атал хувийн компаниараа хариуцуулж байсан нь тохиромжгүй байсан. Ингээд энэ талаар нь түүнтэй ярилцаж, аль нэгийг нь хий гэдэг санал тавьсан бөгөөд тэрээр удалгүй манайхаас чөлөөлөгдсөн. Манай албанаас Нисэх буудалд 1 инженер, 1 техникч 24 цагаар ээлжийн графикаар Нисэх буудлын тоног төхөөрөмжүүдийг хариуцан ажилладаг. Дээрх зорчигч бүртгэлийн тоног төхөөрөмжийг манайд хариуцуулсан бол манайх уг ажлыг хариуцан, 24 цагаар тасралтгүй хянаж, зохицуулах боломжтой. Өөрөөр хэлбэл, хонож буй инженер, техникийн ажилчдын ажил үүргийн хуваарь нэмэгдлээр оруулж өгөх байдлаар шийдвэрлэж болно...» /26-р хх-ийн 177-179/ гэсэн мэдүүлэг,

- ИНЕГ-ын даргын 2012 оны тушаалуудад үзлэг хийсэн тэмдэглэл болон үзлэгээр бэхжүүлж авсан ИНЕГ-ын даргын 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн №А/377 тоот “Орон тоонд өөрчлөлт оруулах тухай” тушаал болон ИНЕГ-ын даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн хуулбар /26-р хх-ийн 97-114/,

- Гэрч Ч.З /ИНЕГ-ын “ЧХ” ОУБ-ын Мэдээлэл, технологийн албаны ээлжийн инженер/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...Би 1990-1991 онуудад “ЧХ” ОУБ-ын цахилгааны албанд оператор, 1991-2012 онуудад Теле, мэдээллийн албанд шуурхай мэдээллийн техникч, 2012 оны 05 сараас уг албанд ээлжийн инженерээр томилогдсон. Миний хувьд ээлжийн хугацаанд “ЧХ” ОУБ-ын тоног төхөөрөмжийг бэлэн байдлыг хангаж ажиллах чиг үүрэгтэй. “ЧХ” ОУБ-д 2012 онд суурилагдсан зорчигч бүртгэлийн системийг манай алба хариуцдаггүй. “Эс” ХХК хариуцдаг. Манай албанд мэргэжлийн сургуулийг нь төгссөн, туршлагатай залуучууд ажиллаж байгаа бөгөөд уг тоног төхөөрөмжийг манайд хариуцуулж өгвөл бид бэлэн байдлыг нь хангаж, ажиллах бүрэн боломжтой. Анх зорчигч бүртгэлийн системийг манайд суурилуулсантай холбоотойгоор намайг ээлжийн техникчээс ээлжийн инженер болгон дэвшүүлэн томилсон. Миний одоо хариуцаж

байгаа ажил үүргийн хуваарьт уг бүртгэлийн тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах чиг үүрэг нэмэгдэж орох байсан боловч дээд газраас хувийн компанид хариуцуулсан байсан...” /26-р хх-ийн 192-193/ гэсэн,

- Гэрч Д.Да /ИНЕГ-ын “ЧХ” ОУБ-ын Мэдээлэл, технологийн албаны Аюулгүй үзлэгийн төхөөрөмжийн инженер/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...Би 1988-1999 онууд “ЧХ” Олон Улсын буудлын холбооны техникч, 1999 оноос одоог хүртэл холбооны инженерээр тус тус ажиллаж байна. Миний хувьд Аюулгүйн үзлэгийн тоног төхөөрөмж болох Рентген төхөөрөмж, металл илрүүлэгч хаалга, ган метал илрүүлэгчийн ажлын бэлэн байдал, засвар үйлчилгээг хариуцан ажилладаг. Манай албанд ажиллаж байсан М.Б-той хамт ажиллаж байсан. Бусад ямар нэгэн харилцаа холбоо байхгүй. «ЧХ» ОУБ-д 2012 онд Зорчигч бүртгэлийн тоног төхөөрөмж шинээр суурилуулсан. Уг тоног төхөөрөмжийг М.Б уг нь ажил үүргийн хуваарийн дагуу хариуцах ёстой. Гэтэл тэр ажлаасаа гарч өөрийн хувийн “Эс” Ххк-аар уг тоног төхөөрөмжийг хариуцан ажиллаж, манай нисэх буудлын зүгээс хариуцахгүй байгаа. Уг нь бол манай алба «ЧХ» ОУБ-д байрлах холбоо, мэдээллийн технологийн чиглэлийн бүхий л тоног төхөөрөмжийг хариуцан ажиллах ёстой. Бүртгэлийн систем нь манай чиглэлд хамаарах ёстой. Гэхдээ байгууллагын удирдлагын зүгээс уг тоног төхөөрөмжийг хувийн компанид хариуцуулсан байсан. Бид яагаад ингэснийг нь ойлгохгүй байгаа. Манай албаны зүгээс удирдлагаас шийдвэр гаргаад хариуцуулах юм бол уг төхөөрөмжийг хариуцаад явах бүрэн боломжтой гэж бодож байна...” /26-р хх-ийн 188-189/ гэсэн,

- Гэрч С.На /ИНЕГ-ын “ЧХ” ОУБ-ын Мэдээлэл, технологийн албаны мэдээллийн технологийн инженер/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...Би 2010 оны 09 сараас “ЧХ” ОУБ-д Мэдээллийн технологийн албаны инженерээр одоог хүртэл ажиллаж байна. Миний хувьд М.Б-тай “ЧХ” ОУБ-д хамтран ажиллаж байсан. Өөр ямар нэгэн харилцаа холбоо байхгүй. 2012 онд манай нисэх буудалд Зорчигч бүртгэлийн систем шинээр суурилагдсан. Энэ системийг манай байгууллага ямар нэгэн байдлаар хариуцахгүй, “Эс” ХХК хариуцаж байгаа, уг нь бол тухайн системийг суурилуулж байхад нь манай албанд харьяалагдан орж ирэх юм байна гэж ойлгож байсан. Гэтэл хувийн

компанид хариуцуулж өгсөн байсан. Тухайн системийн холбогдох сургалтад хамрагдсан тохиолдолд, ИНЕГ-аас хариуцуулахаар үүрэг, чиглэл өгсөн тохиолдолд манай алба тухайн системийг хариуцан, ажлын бэлэн байдлыг хангах боломжтой. Манай албанд 2012 онд уг системийг суурилуулсантай холбоотойгоор 4 хүний орон тоо хүртэл нэмсэн байгаа...” /26-р хх-ийн 190-191/ гэсэн мэдүүлгүүд,

- “ЧХ” ОУ-ын нисэх буудлын инженер, техникийн ажилчдын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваариуд /6-р хх-ийн 1-45/,

- Гэрч Э.Эн /“Х Э” ХХК-ийн Мэдээлэл, технологийн хэлтсийн ерөнхий менежер ажилтай/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...“МА” ХХК нь 2011 оны 10 сард үүсгэн байгуулагдсанаас хойш тасралтгүй ажиллаж байна. 2011 оны 10-11 сар хүртэл Мэдээлэл, технологийн хэлтсийн ахлах инженер, 2011 оны 11 сараас одоог хүртэл хэлтсийн даргаар ажиллаж байна. Миний ажил үүргийн хуваарь нь манай компанийн явуулж буй нислэгийн үйл ажиллагааны цогц системийн хэвийн үйл ажиллагааг хангах, дэвшилтэд технологи нэвтрүүлэх, ажлын уялдаа холбоог сайжруулах зэрэг үүрэгтэй. Манай компани нь 2012 оны 06 сард нэрээ “Х Э” болгож өөрчилсөн байдаг.

Манай компани нь орон нутаг, олон улсын зорчигч тээвэрлэлтийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Тус компани нь Гадаад улсад Тайланд, Хонконг, Манжур зэрэг газруудад тогтмол нислэг үйлддэг. Орон нутагт 7 чиглэлд нислэгийн үйл ажиллагаа явуулдаг.

Тус компани нь 2012 оны 06 сараас эхлэн Испани улсын Ат компанийн Нислэгийн цогц системийг ашиглаж байна. Уг системээр дамжуулан билет борлуулалт, зорчигч бүртгэл, нислэг зохицуулалт зэргийг удирддаг. Өмнө нь ямар нэгэн бүртгэлийн системгүйгээр гар аргаар бүртгэлээ явуулдаг байсан.

Иргэний нисэхийн ерөнхий газраас «ЧХ» ОУБ-д Зорчигч бүртгэлийн тоног, төхөөрөмж, програм хангамжийг суурилуулсан байсан. Манай компани гадаад нислэгээ ИНЕГ-аас суурилуулсан тоног төхөөрөмж, програм хангамжин дээр өөрсдийн Ат системээр бүртгэлийн үйл ажиллагаа явуулж байна. Энэхүү тоног төхөөрөмж, програм хангамжийг ашигласны төлбөрт одоогоор ямар нэгэн төлбөр төлөөгүй бөгөөд гэрээ хэлцэл байгуулаагүй байна. ИНЕГ нь «ЧХ» ОУБ-д

«Ап» компанийн «vMUSE» гэх системийг оруулж ирж суулгасан бөгөөд vMUSE « програм нь манай программтай саадгүй ажилладаг тул бүртгэлээ тус програмаар дамжуулан явуулж байна.

Аливаа нислэгийн компани нь зорчигч бүртгэлийн талаарх мэдээллийг олон улсын нэгдсэн сүлжээнд нууцлалтайгаар дамжуулах шаардлагатай байдаг. Энэ мэдээллийг дамжуулдаг шугам нь Ар, С компанийн 2 шугам байдаг бөгөөд манай компани Ар компанийн AVINET шугамыг ашиглахаар болж тус компанитай 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн сарын 1.200 ам.долларын төлбөртэй гэрээ байгуулсан. Ингээд тус компанийн шугамыг /сүлжээ/ ашигласны төлбөр сард 1.200 ам.долларыг «А» компанийн дансанд шилжүүлдэг. ИНЕГ-аас «А» компанийн «vMUSE» буюу бүртгэлийн програм хангамжийг оруулж ирсэн байдаг бөгөөд AVINET сүлжээг нь бид өөрсдийн шугамаар «Ар» компаниас гэрээ байгуулан авч ашиглаж байгаа...» /23-р хх-ийн 155-157/ гэсэн мэдүүлэг,

- «Х Э» ХХК Ар ХХК-тай байгуулсан гэрээний хуулбар /23-р хх-ийн 159-169/,

- Гэрч Г.На /"ТЭ" компанийн Монгол дахь төлөөлөгчийн газар борлуулалт, тээврийн төлөөлөгч ажилтай/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: "...Би тус компанид 2012 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс одоог хүртэл борлуулалт, тээврийн төлөөлөгчөөр ажиллаж байна. Нисэх буудал дээр газрын үйлчилгээ болон агаарын үйлчилгээг хариуцан ажилладаг.

Манай төлөөлөгчийн газар нь иргэний агаарын тээврийн чиглэлээр Улаанбаатар-Бишкек-Истанбул чиглэлд нислэг үйлддэг. Манай компани нь М ХК-тай гэрээ байгуулж, М ХК-иар бүртгэлээ хийлгүүлж, "М" ХК-ний тоног төхөөрөмжийг ашигладаг. ИНЕГ-ын тоног төхөөрөмжийг ашигладаггүй. Манай компани нь АНУ-ын «Ар» компанитай хамтарч ажилладаггүй. Манай бүртгэлийг "М" ХК хариуцаж, С ХХК-гийн шугам сүлжээгээр дамжуулдаг. Энэ талаарх гэрээ, хэлцлийг албан бичгийн хамт хүргүүлж байна. Манай компани нь зорчигч бүртгэлийн асуудлаар зөвхөн М ХК-тай ажилладаг. "Эс" ХХК, ИНЕГ-тай энэ чиглэлээр хамтран ажилладаггүй...» /23-р хх-ийн 170-171/ гэсэн мэдүүлэг,

- "ТЭ" ХХК-ийн 2013.10.30-ны өдрийн албан бичиг /23-р хх-ийн 172/,

- Гэрч Б.А /"Аэ" компанийн төлөөлөгчийн газрын ажилтан/ мөрдөн байцаалтын шатанд

өгсөн мэдүүлэгтээ: "...Миний хувьд "Аэ" компанийн Монгол дахь төлөөлөгчийн газарт 2007 оноос эхлэн одоог хүртэл ажиллаж байна. Миний хувьд билет борлуулалт, дотоод ажил, "ЧХ" ОУБ дээрх хяналт, нислэгийн чиглэлийн системийн хэвийн ажиллагааг хангах зэрэг ажил үүргийн хуваарьтай.

Манай компани нь Зорчигч тээврийн чиглэлээр Улаанбаатар-Москвагийн хэвийн үйл ажиллагаа хангах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

Манай төлөөлөгчийн газар нь 1960 оноос хойш 2012 оныг хүртэл «М» ХК-ний бүртгэлийн тоног төхөөрөмж дээр «С»-гийн систем дээр бүртгэлийн үйл ажиллагаа явуулж байсан. Харин 2012 оны 07 сараас эхлэн ИНЕГ-аас суурилуулсан бүртгэлийн тоног төхөөрөмж, програм хангамж дээр «Аппс» компанийн шугам сүлжээг ашиглан өөрийн «Sabre» гэсэн бүртгэлийн програм дээр үйл ажиллагаа явуулж байна.

Иргэний нисэхийн ерөнхий газраас «ЧХ» ОУБ-д суурилуулсан тоног, төхөөрөмж, програм хангамжийг бид ямар нэгэн гэрээ хэлцэлгүйгээр, төлбөр тооцоо төлөхгүйгээр ашиглаж байна.

Манай компани нь "Ар" компанийн шугам, сүлжээг ашиглан өөрийн програм дээр бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Манай төв компани нь нилээн дээр үеэс «Ар» компанитай харьцаж байгаа бөгөөд манай төлөөлөгчийн газар 2012 оноос эхлэн «Ар» компанийн шугам сүлжээг ашиглаж байна. Төлөөлөгчийн газар нь тусдаа ямар нэгэн гэрээ байхгүй, төв компани буюу Москва дахь салбараа «Ар» компанитай гэрээ байгуулан ажилладаг. Энэ талаарх мэдээлэл алга байна.

"Ар" компанийн сүлжээг ашиглахад бид ИНЕГ, "Эс" Ххк-аар дамжуулаагүй. Манай төв компани өөрсдөө холбогдож энэ сүлжээг оруулж ирсэн...» /23-р хх-ийн 190-192/ гэсэн мэдүүлэг,

"М" ХК, "ЭЧ", "АМ", "ХЭ", "ТЭ", "Аэ" ХХК-уудиа сүлжээний системийг хэрхэн ашиглаж байгаа болон ашиглахгүй байгаа талаарх албан бичгүүд /23-ХХ-ийн 148-154, 159-169, 172-189, 193-208/,

Гэрч Я.Д /»М» ХК-ний Газрын үйл ажиллагааны хэлтсийн харьяа Олон улсын зорчигч үйлчилгээний тасгийн бүртгэлийн ээлжийн ахлагч/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: «...Би 1998-2000 онуудад «М» ХК-ний Олон улсын зорчигч, үйлчилгээний хэсгийн бүртгэгч, диспетчер,

2000 оноос одоог хүртэл ээлжийн ахлагчаар ажиллаж байна.

Ээлжийн хугацаанд «ЭЧ», «КЭ», «ТЭ» болон өөрийн компанийн агаарын хөлгөөр зорчих зорчигчдын бүртгэлийн үйл ажиллагааг бүхэлд нь хариуцдаг. 1 ээлжинд 12 бүртгэгч, 10 ачигч үүрэг гүйцэтгэдэг бөгөөд тэднийг мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүрэгтэй.

Миний хувьд манай компани нь ямар гэрээгээр бүртгэлийн системийг ашиглаж байгааг мэдэхгүй байна. Бүртгэлийн үйл ажиллагаа нь онгоц хөөрөх хуваарьт цагаас 02 цаг 40 минутын өмнө эхлэдэг. Миний хувьд ээлжинд гарч буй диспетчерүүдийг холбогдох бүртгэлийн цэгүүдэд хуваарилж, хийх ажлыг нь зохицуулж өгдөг. Бүртгэгч нар нь ИНЕГ-аас шинээр тавьсан бүртгэлийн систем, тоног, төхөөрөмжүүдийг ашиглан зорчигчдыг бүртгэж, тэдэнд суугчийн талон, тээшний зүүлтийг хэвлэж өгөх үүрэгтэй. Бүртгэлийн ажиллагааг дууссаны дараа бүртгэлийн системээ хааж, бүртгэгдсэн зорчигчдын талаарх мэдээллийг агаарын хөлгийн ахлах үйлчлэгчид хүргүүлдэг. Мөн түүнчлэн тухайн агаарын хөлгүүдийн авиа компаниудын холбогдох төлөөлөгчийн газар руу бүртгэлийн системээ ашиглан мэдээллийг цацдаг. Үүгээр бүртгэлийн үйл ажиллагаа дуусдаг.

Өмнө бид бүртгэлийг явуулахдаа авиа компаниудын тус тусын компьютер тоног төхөөрөмжүүд дээр ажилладаг байсан. Өөрөөр хэлбэл, тухайн авиа компанийн зорчигчдыг бүртгэхдээ тухайн компанийх нь бүртгэлийн систем бүхий компьютерээр бүртгэлийг явуулдаг байсан. Харин одоо энэ шинэ систем тавигдсанаар 1 компьютерээр бүх авиа компанийн /хариуцан бүртгэдэг авиа компаниудын/ зорчигчдын бүртгэлийг явуулдаг болсон. Бүртгэлийн компьютерийн дэлгэц дээр авиа компаниудын нэрс бүхий сонголтуудтай болсон юм. Түүгээр нь сонгож ороод бүртгэлийг явуулдаг.

Миний хувьд ээлжийн диспетчерийн дутагдалтай нөхцөлд бүртгэлийг өөрөө гардан явуулдаг. Энэ шинэ систем нь ямар нэгэн гацалт, эвдрэл гэмтэл нэг их байдаггүй. Ямар ч байсан эвдрэл, гэмтэл, гацалтаас болж нислэг саатсан асуудал байхгүй. «vMUSE» системийг хариуцсан гэх инженерүүд нислэгтэй үеэр ажилладаг. Хэрвээ ямар нэгэн эвдрэл, гэмтэл гарах, хэвлэх төхөөрөмж гацсан тохиолдолд эдгээр хүмүүсийг дуудаж янзлуулдаг. Энэ хүмүүс нь

хэнд харьяалагддаг хүмүүс гэдгийг мэдэхгүй ...» /26-р хх-ийн 220-222/ гэсэн,

- Гэрч Б.Эб /"М" ХК-ийн Газрын үйл ажиллагааны хэлтсийн харьяа Олон улсын зорчигч үйлчилгээний тасгийн бүртгэлийн ээлжийн ахлагч/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: "...Би "М" ХК-ний 2007 оноос одоог хүртэл ээлжийн ахлагчаар ажиллаж байна. Миний хувьд ээлжинд ажиллах хугацаанд бүртгэгч нарыг мэргэжлийн удирдлагаар хангах,

Манай компаниас тухайн тоног төхөөрөмжүүдийг ямар гэрээ, хэлцлийн дагуу ашиглаж байгааг мэдэхгүй. Ямар ч байсан жил гаруйн өмнө ИНЕГ-аас «ЧХ» ОУБ-ыг 2 давхарт зэрэгцээ 8 ширхэг, хөндлөн 1 ширхэг, 1 давхарт «ВИП» танхимд 1 ширхэг, нийт 10 ширхэг бүртгэлийн цэгүүдэд Бүртгэлийн системийн тоног, төхөөрөмжүүдийг суурилуулсан байдаг. Эдгээр нь иж бүрэн персонал компьютер болон суугчийн талон хэвлэгч, тээшний зүүлт хэвлэх төхөөрөмж зэргийг суурилуулсан байдаг. Мөн хөндлөн байрлах цэг дээр зорчигчийн нэрс хэвлэх принтер тавьсан байдаг. Эдгээр тоног төхөөрөмжүүд дээр манай бүртгэгч нар нь өөрийн компанийн болон «ЭЧ», «КЭ», «Аэ», «ТЭ» компаниудын агаарын хөлгөөр зорчих, зорчигчдын бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна.

Манай компани нь одоо ч гэсэн «С»-гийн «DCS» системээр зорчигч бүртгэлийн үйл ажиллагаагаа явуулж байна. Урьд нь авиа компаниуд тус тусын систем бүхий компьютерүүдээр бүртгэлээ явуулдаг байсан. Тухайлбал «КЭ» тусдаа компьютертэй байсан. Манай «М» ХК болохоор мөн тусдаа компьютертэй байсан. Харин одоо бол бүх системийг нэгтгэсэн 1 компьютерээр бүртгэлийг явуулж байна.

Өөрөөр хэлбэл, тухайн компьютерийн дэлгэцэнд авиа компаниудын нэрс бүхий сонголтууд байдаг болсон юм. Түүгээр нь ороход тухайн авиа компанийн бүртгэлийн систем рүү нэвтэрч орох боломжтой юм.

Мэдээж техник юм чинь тодорхой гацалт, эвдрэл, гэмтэл үүсдэг. Тэр үед нь «vMUSE» программыг хариуцсан 3 ажилтныг утсаар нь дуудаж арга хэмжээ авахуулдаг...» /26-р хх-ийн 223-224/ гэсэн,

- Гэрч Х.Бу /"М" ТӨХК-ийн Газрын үйл ажиллагааны хэлтсийн харьяа Олон улсын зорчигч үйлчилгээний тасгийн бүртгэгч, диспетчер/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: "...Миний хувьд ээлжийн

хугацаанд “Аэ”, “КЭ”, “ЭЧ” компаниудын болон өөрийн компаниа агаарын хөлгөөр олон улсад зорчиж буй зорчигчдыг бүртгэж, тэдгээрийн ачаа, тээшийг мөн бүртгэж, холбогдох мэдээллийг очих газарт нь явуулдаг.

2012 онд “ЧХ” ОУБ-д нийт 10 орчим бүртгэлийн цэгийг тоног, төхөөрөмжийн хамт суурилуулсан байдаг. Миний хувьд эдгээр цэгүүдээс тухайн өдрийн ээлжийн ахлагчийн хуваарилсан цэгт очиж ажлын бэлтгэлээ хангаж, зорчигчдыг бүртгэх үйл ажиллагааг явуулдаг. Бүртгэгч, диспетчер нь нэг бүртгэлийн цэгийг дангаар тогтмол хариуцан ажилладаггүй. Тухайн нислэг бүрт ээлжийн ахлагчийн хуваарилсан цэгт очиж ажилладаг. Манай нислэгүүд байхгүй үед тухайн цэгүүд дээр өөр авиа компаниудын бүртгэгч нар очиж ажилладаг. Өөрөөр хэлбэл, эдгээр бүртгэлийн цэгүүд нь дундын гэж ойлгож болно.

Бүртгэлийн үйл ажиллагаа нь дараахь байдлаар явагддаг. Нислэгийн хуваарьт хугацаанаас 2 цаг 30 минутын өмнө бүртгэлийг эхлэдэг ба бүртгүүлэхээр ирсэн зорчигчийн гадаад паспортыг нь авч овог нэрийг нь компьютерт оруулахад тухайн зорчигч нь тухайн нислэгт билет захиалсан эсэх мэдээлэл нь гарч ирдэг. Үүний дагуу паспортыг нь зориулалтын машинаар уншуулж, мэдээллийг компьютерт аваад зорчих агаарын хөлгийн суудлын дугаарыг нь тавьж, холбогдох суугчийн талон ба ачааны зүүлтийг гаргаж өгснөөр нэг зорчигчийн бүртгэл дуусдаг. Ийм байдлаар бүртгүүлэхээр ирсэн зорчигчдыг бүртгэж дуусаад мэдээллүүдээ нэгтгэж очих газарт нь системээр дамжуулан явуулдаг. Энэ мэдээллийг тухайн бүртгэлийн систем нь автоматаар дамжуулдаг юм. Энэхүү бүртгэлийн цэг, тоног төхөөрөмжийг ямар журмаар, ямар гэрээ хэлцлээр манай компани ашигладаг талаар бол мэдэхгүй байна.

Урьд нь «ЧХ» ОУБ дээр байрлах бүртгэлийн цэгүүдэд манай компаниас суурилуулсан компьютер, процессор, суугчийн талон болон ачааны зүүлт хэвлэдэг машин зэрэг тоног төхөөрөмжүүд байрладаг байсан. Уг тоног төхөөрөмжүүд нь «С»-гийн системээр явагддаг байсан. Бидний хувьд тухайн зорчигчийг дээрхтэй ижил байдлаар овог нэрийг нь хийж шалгаж үзээд агаарын хөлөгт зорчих зорчигчийн талон, тээшний зүүлтийг нь хэвлэж өгөх байдлаар бүртгэлийг

явуулдаг байсан. Ингээд бүртгэлийг дууссаны дараа тухайн авиа компанийн зохих хаяг руу зорчигчдын мэдээллийг шивж оруулсны дараа мэдээллээ илгээдэг байсан. Харин энэ шинэ тавигдсан «vMUSE» систем нь тухайн авиа компанийн бүртгэлийг дуусаад хаах команд өгснөөр зорчигчдын мэдээлэл автоматаар зохих газартаа явдгаараа давуу талтай байх. Энэ шинэ системийн хүрээнд бүртгэлийн цэг дээр 1 ширхэг монитор, 1 ширхэг паспорт уншигч төхөөрөмж бүхий гар, 1 ширхэг хулгана, 1 ширхэг процессор, ачааны болон суугчийн талон хэвлэх төхөөрөмж тус бүр 1 ширхэг зэрэг тоног төхөөрөмжүүд тавигдсан байдаг. Мөн манай «С»-гийн тоног төхөөрөмжүүд давхар байрладаг.

Одоо энэ шинэ тавигдсан системээр «Аэ»-ын зорчигчдыг бүртгэхэд заримдаа хэвлэх төхөөрөмж нь гацдаг, «ЭЧ»-гийн зорчигчдыг бүртгэхэд хэвлэх төхөөрөмж нь байнга гацдаг. Ингээд «vMUSE» системийг хариуцсан гэх залуучуудыг ээлжийн ахлагчаар дамжуулан дууддаг. Тэд ирж гацааг гаргаж, компьютерийг янзалж өгдөг. Өмнө ашиглаж байсан «С»-гийн систем бол ингэж гацдаггүй байсан.

Уг «vMUSE» системийн тоног төхөөрөмжийн ажлын бэлэн байдлыг Нисэх буудалд байрладаг хэдэн залуучууд хариуцдаг. Тэднийг хаана, хэнд харьяалагддагийг мэдэхгүй. Бид ээлжийн ахлагчаараа дамжуулан дуудуулдаг...» /26-р хх-ийн 225-227/ гэсэн,

- Гэрч Г.Сар /"М" ХК-ний Газрын үйл ажиллагааны хэлтсийн харьяа Олон улсын зорчигч үйлчилгээний тасгийн бүртгэгч, диспетчер/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: "...Би 1996 оноос хойш одоог хүртэл "М" ХК-ний Газрын үйл ажиллагааны хэлтсийн бүртгэгч, диспетчерээр ажиллаж байна.

Миний хувьд «КЭ», «ТЭ», «ЭЧ», «АЭ» болон өөрийн компанийн агаарын хөлгөөр зорчих зорчигчдыг бүртгэж, тэдэнд суугчийн талон, ачааны зүүлт хэвлэж өгөх үйл ажиллагааг явуулдаг.

Манай компаниас зорчигч бүртгэлийн тоног төхөөрөмж, системийг ямар гэрээ, хэлцлээр ашиглаж байгааг мэдэхгүй. 2012 онд байх оныг нь сайн санахгүй байна. «ЧХ» ОУБ-д шинээр зорчигч бүртгэлийн тоног, төхөөрөмж, систем байрлуулсан. Бидний хувьд ээлжийн ахлагчийн хуваарилж өгсөн бүртгэлийн цэг дээр очиж ажлын

бэлэн байдлаа хангаж, хуваарьт нислэгийн зорчигчдыг бүртгэх үйл ажиллагааг явуулдаг. Ингэж бүртгэхдээ тухайн зорчигчийн паспортыг нь авч програм дээр хайлт хийж тухайн нислэгээр нисэх билет авсан эсэхийг шалгасны дараа бүртгэлийг явуулдаг. Зарим тохиолдолд билет борлуулдаг агентуудаас тухайн хүний мэдээллийг нь бүрэн оруулсан байдаг. Энэ тохиолдолд паспортыг нь зориулалтын унших төхөөрөмжинд уншуулдаггүй. Хэрэв мэдээлэл ороогүй байвал паспортыг уншуулж, мэдээллийг системд оруулдаг. Ингээд ачаатай бол ачааных нь зүүлтийг хэвлэж ачаанд нь зүүгээд тухайн зорчигчид ачааны зүүлт, суугчийн талоныг хэвлэж өгснөөр 1 зорчигчийн бүртгэл дуусдаг. Ийм байдлаар ирсэн зорчигчдыг бүртгэж дуусаад системээсээ гардаг юм.

Урьд нь манай компани «С»-гийн системийг ашиглаж байхдаа зөвхөн «М» ТӨХК болон «ЭЧ», «ТЭ», «АЭ»-ын зорчигчдыг «М» ХК-ниас суурилуулсан компьютер, тоног төхөөрөмжүүд дээр бүртгэдэг байсан. Харин «Корейн Эйр» компанийн бүртгэлийг тус компаниас тусад нь байрлуулсан компьютер дээр бүртгэдэг байсан. Өөрөөр хэлбэл, 2 өөр компьютерт бүртгэлийг явуулдаг байсан. Харин энэ «vMUSE» систем тавигдсанаар 1 компьютер дээр өөрийн хариуцдаг авиа компаниудын бүртгэлийг 1 дор явуулах боломжтой болсон. Өөр нэг их давуу тал байхгүй байх.

Энэ системээр бүртгэл явуулахад техникийн болон бусад гэмтэл, гацалт үүсэх нь гайгүй л байдаг. Эвдрэл гэмтэл учирсан тохиолдолд «vMUSE» системийн инженерүүдийг дуудаж засварлуулдаг. Тэднийг нисэх буудлын ажилчид гэж ойлгодог...» /26-р хх-ийн 228-229/ гэсэн мэдүүлэг, - ИНЕГ-с сонгон шалгаруулсан «Нисэх буудлын зорчигчийн бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж суурилуулах», «Зорчигч бүртгэлийн операторын үйл ажиллагаа явуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерүүдэд шинжээч томилсон тогтоол, Сангийн яамны мэргэжилтэн Х.Э-гийн гаргасан дүгнэлт, Х.Э-г шинжээчээр байцаасан тэмдэглэл /6-р хх-ийн 75-83/, - Шинжээч Х.Э /Сангийн яамны Хууль, худалдан авах ажиллагааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: «...АТГ-ын 2013 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн шинжээч

томилох тогтоолыг үндэслэн Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 5/3729 тоотой шинжээчээр томилогдсон. Шинжилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Эрүүгийн хуульд заасан шинжээчийн эрх үүрэгт нийцүүлэн, ирүүлсэн баримт, материалд үндэслэн гаргасан байна.

“Нисэх буудлын зорчигчийн бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж суурилуулах” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/ТББ/Б-73/11 тоот тендерийг шалгаруулахдаа Үнэлгээний хороо нь:

Тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт болох үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээ, баталгаат хугацааны шаардлага хангасан гэрчилгээ, албан ёсны борлуулагчийн гэрчилгээ зэрэг баримт материалыг оролцогч “А” ХХК нь ирүүлээгүй байтал сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3, тендерийн баримт бичгийн 12.1-т заасныг зөрчсөн байна.

Тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт болох ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээллийг «А» компани нь хүснэгтээр ирүүлсэн нь хангалтгүй байсан атал сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3, тендерийн баримт бичгийн 18.1-т заасныг зөрчсөн байна.

Мөн түүнчлэн Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг хуулийн 19.2-т заасан шалгуур, үзүүлэлтийг хангаж боловсруулаагүй байгаа нь мөн заалтыг зөрчсөн байна.

Энэ нь Үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХА тухай хууль болон дээрх тендерийн баримт бичгийн шалгуурыг нэгэн зэрэг хангасан оролцогчийн саналыг шалгаруулсан гэж үзэх үндэслэлгүй байна. Өөрөөр хэлбэл, Үнэлгээний хороо нь «А» компанийн ирүүлсэн тендерээс татгалзаж энэ талаар захиалагчид танилцуулах ёстой байсан.

“Зорчигч бүртгэлийн операторын үйл ажиллагаа явуулах” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот тендерийг шалгаруулахдаа Үнэлгээний хороо нь:

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа түүний худалдан авах журмыг төсөвт өртөгийг

үндэслэл болгохоор заасан. Өөрөөр хэлбэл, төсөвт өртөг нь 50.000.000 төгрөгөөс дээш бол нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулах ёстой. Үүний дагуу дээрх тендер шалгаруулалт нь нээлттэй зарлагдах ёстой байсан. Гэтэл Үнэлгээний хороо нь дээрх ИНЕГУ/ХББ/Б-04/12 тоот тендерийг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн. Хязгаарлагдмал тендер шалгаруулалтыг мөн хуулийн 32 зүйлд заасан Мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи шаардсан нарийн төвөгтэй бараа ажил, үйлчилгээг шалгаруулахад ашиглах талаар заасан. Гэтэл Зорчигч бүртгэлийн операторын ажил нь хуулийн дээрх зохицуулалтанд хамаарахгүй. Өөрөөр хэлбэл, хязгаарлагдмал тендер зохион байгуулсан нь хуулийн 9.2-т заасан гадаад этгээд нээлттэй оролцох, хуульд заасан ил тод нээлттэй тэгш өрсөлдөх боломжийг хязгаарласан байна.

- Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичиг боловсруулахдаа тухайн бараа, үйлчилгээнд зориулсан Сангийн сайдын батласан жишиг баримт бичгийг үндэслэх ёстой байсныг зөрчсөн байна.

- Мөн дээрх бараа ажил үйлчилгээ нь Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны 2012 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй байна.

- Мөн тендер баримт бичгийн боловсруулалт нь шаардлагад нийцээгүй, яг ямар ажил, үйлчилгээ худалдан авах нь тодорхойгүй, барааны тендерийн баримт бичигт нийцүүлж боловсруулсан нь буруу, харин Зөвлөхөөс бусад үйлчилгээний тендерийн баримт бичигт нийцүүлэн боловсруулах ёстой байсан.

ИНЕГ-аас дээрх тендерийг сонгон шалгаруулах зайлшгүй шаардлага байсан бол хуулийн 48.1-т заасны дагуу төлөвлөж сангийн яаманд ирүүлэх, мөн хуулийн 19.1-т заасны дагуу батлагдсан сангийн сайдын жишиг баримт, бичгийг үндэслэн тендерийн баримт бичгийг боловсруулж хуульд нийцүүлэн зохион байгуулах ёстой байсан.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиар Худалдан авах ажиллагааг төлөвлөх зохион байгуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар Төрийн болон орон нутгийн өмчит

хуулийн этгээд болон 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь уг хуулийг дагаж мөрдөх үүрэгтэй. ИНЕГ нь төрийн байгууллага бөгөөд уг хуульд заасан захиалагч тул бүхий л тендер шалгаруулалтыг уг хуульд нийцүүлэн зохион байгуулах ёстой. Өөрөөр хэлбэл, зорчигчоос төвлөрүүлсэн хураамжаас хамааруулж худалдан авах ажиллагааг хууль бусаар зохион байгуулах эрхгүй...» /6-р хх-ийн 84-87/ гэсэн мэдүүлэг,

- 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 226,628,000 төгрөг нийт 1.062.959.200 төгрөгийг “Эс” ХХК-ийн дансанд шилжүүлсэн гүйлгээтэй холбоотой ИНЕГ-ын санхүүгийн баримтад үзлэг хийсэн тэмдэглэл, холбогдох баримтууд, мөнгөн шилжүүлэг /26-р хх-ийн 139-176/,

- Гэрч П.Эц /“ТББЭБ” ББСБ ХХК-ийн нягтлан бодогч ажилтай/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...Тус компанийг 2008 оны 12 сард зээлийн үйл ажиллагаа явуулах чиглэлээр 1 гишүүнтэйгээр, 3.000.000.000 төгрөгийн дүрмийн сантайгаар Н.Г нь үүсгэн байгуулсан байдаг. Тус компани нь 2009 оны 01 сараас эхлэн зээл олгож одоог хүртэл үйл ажиллагаа явуулж байна. Манай компанийн оффис нь Сүхбаатар дүүргийн нь ...дугаар хороо, Нарны зам ...»ЭТ» ХХК-ийн байранд 1 өрөө түрээслэн үйл ажиллагаа явуулдаг.

Манай компанийн жинхэнэ эзэн нь Ч.Хо гэж хүн байдаг бөгөөд түүний шийдвэрээр тодорхой хүмүүст зээл олгох үйл ажиллагаа явуулдаг. Түүнээс биш хүссэн хүмүүст зээл олгодоггүй юм. Ч.Хо захирлын зөвшөөрч, олго гэж ам, бичиг, утсаар өгсөн шийдвэрийн дагуу зээлийг олгодог. Зээлийг олгохдоо барьцаатай, барьцаагүй байдлаар олгодог.

2012 оны 02 дугаар сарын 01-ний өдөр Д.Э гэгчээс 110.000.000 төгрөгийн зээлийг 2 сарын хугацаатайгаар авах хүсэлт тавьсны дагуу 2012 оны 02 сарын 03-ны өдөр гэрээ байгуулж 110.000.000 төгрөгийн зээлийг түүнд олгосон. Зээлийг олгох үед захирлаас тухайн үед яг ямар байдлаар чиглэл, шийдвэр өгснийг тодорхой санахгүй байна. Бодвол Д.Э гэж хүн очно, ийм хэмжээний зээл өг гэж хэлсэн байх. Зээл болох 110.000.000 төгрөгөөс 0.5 хувийн менежментийн шимтгэл

авч 109.450.000 төгрөгийг 2012 оны 02 дугаар сарын 03-ны өдөр Д.Э-ын тушаа гэж хэлсэн “Эс” ХХК-ийн “Голомт” банкны 110268xxxx тоот төгрөгийн дансанд тушаасан байна.

Касс, харилцахын баримтаас харахад Д.Э нь зээлийг бэлнээр авна гэж захиалга өгч, манай кассын зарлагын баримтад гарын үсэг зурчхаад дээрх 110268xxxx тоот дансанд тушаалгасан байна. Ингээд зээлийг 2012 оны 03 дугаар сарын 02-ны өдөр манай Голомт банкны 200100xxxx тоот дансанд “Эс” ХХК-аас 111.760.000 төгрөгийг тушааж, зээл, зээлийн хүүгээ хаасан байна. Зээлийн хүүнд нийт 1.760.000 төгрөгийн тушаасан байна.

Тэдний харьцааг мэдэхгүй, зээлийг авахдаа ямарч эд хөрөнгө барьцаалаагүй. Захирал өөрөө батлан даана гэж хэлсэн байх.

Энэ талаар мэдэхгүй байна. Хувийн хэрэгцээнд гэсэн зориулалт хүсэлтэндээ тусгасан байна. Манай компани нь дүрмийн сангийн 3.000.000.000 төгрөгийн илүүдэл эх үүсвэрийг Голомт банкинд хадгалуулсан бөгөөд зээл олгох үедээ тус банкнаас хадгаламжаа барьцаалсан зээл авч зээлээ олгодог. Уг зээлийг олгохдоо Голомт банкнаас 2012 оны 02 дугаар сарын 03-ны өдөр 109.000.000 төгрөгийн хадгаламж барьцаалсан зээл авч, зээлдэгчид олгосон болно. Д.Э нь манайхаас урьд нь зээл авч байгаагүй. Нэг удаа л авсан нь энэ...» /22-р хх-ийн 181-188/ гэсэн, - Гэрч Ч.Хо мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “... Миний хувьд “ТТББЭБ» ББСБ ХХК-ийг үүсгэн байгуулаагүй, харин үүсгэн байгуулахад нь 2006-2010 онуудад нийтдээ 3.000.000.000 төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн. Тус компани нь зээл олгох, валют арилжаа хийх, хадгаламж авах зэрэг банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг юм. Миний хувьд өдөр тутмын ажилд нь оролцдоггүй бөгөөд зарим нэг таньдаг мэддэг, найдвартай хүндээ зээлийн баталгаа гаргаж өгдөг. Өөр юманд оролцдоггүй. Тусдаа захиралтай, нягтлантай компани юм.

“Эс” ХХК-ийн захирал гэх М.Б гэгчийг таньж мэдэхгүй, урьд өмнө уулзаж байгаагүй. Харин Д.Э-ыг танина. Д.Э нь миний эхнэр О.С-гийн хамаатан гэж яригддаг. Яг ямар хамаатан гэдгийг сайн мэдэхгүй. Би эхнэр О.С-тай 1990 онд гэр бүл болсон бөгөөд Э-ыг 1992 оноос хойш хамаатан гэдгээр нь мэднэ. Гэхдээ тийм ойр дотно харилцаа холбоотой байгаагүй.

2012 онд байх хэзээ гэдгийг нь

санахгүй байна. Д.Э над руу ярьж, яаралтай 100.000.000 орчим төгрөгийн зээл авах хэрэгтэй байна. Та Банк бус санхүүгийн байгууллагын хүмүүсдээ хэлээд өгөөч гэсний дагуу Д.Э-ыг найдвартай гэдэг утгаар нь хэлж өгсөн. Тухайн үед “ТТББЭБ” ХХК-ийн захирал, нягтлан бодогч хоёрын аль нэгэнд нь зээл Д.Э-д өгөх талаар хэлж байсан. Харин зээлээ хэрхэн эргэн төлсөн, ямар зорилгоор авсныг нь мэдэхгүй. Зээл эргэн төлөгдсөн эсэх талаар мэдэхгүй байна. Гэхдээ зээл төлөгдөхгүй тохиолдолд Гт, П.Эц нар надад хэлдэг юм. Д.Э-ын зээлийн талаар юм яриагүй учир төлөгдсөн байх.

Д.Э нь уг мөнгийг ямар зорилгоор авч байгаагаа хэлээгүй, би ч асуугаагүй. Урьд нь манай байгууллагаас болон надаас хөрөнгө тусалцаа, дэмжлэг авч байгаагүй.

Б.Б нь 2005 оноос хойш миний бизнесийн үйл ажиллагаанд хуулийн зөвлөгөө өгөх тусалцаа үзүүлдэг өмгөөлөгч юм. Тухайн үеийн гэрээ хийх нөхцөл байдалд хамтран ажилладаг гэсэн үг. Байнгын ажилтан бол биш.

Б.Б нь «АЭБ» гэдэг нэртэй хуулийн фирм ажиллуулдаг бөгөөд үйл ажиллагаандаа зориулж манай банк бус санхүүгийн байгууллагаас зээл авч төлдөг. Зээл олголтын тухайд банк бус санхүүгийн байгууллагын дүрэм журмаар явагддаг бөгөөд миний бие зээл олголтын асуудалд баталгаа гаргаж өгч байгаагүй. Дээрх зээлүүдийг ийм журмаар авч төлж байсан байх. Ямар зориулалтаар авсныг нь тодорхой мэдэхгүй. Тус компанийн талаар мэдэхгүй, ийм компанитай хамтран ажиллаж байгаагүй...» /22-р хх-ийн 190-192/ гэсэн,

- Гэрч Б.Нц /”М” ТӨХК-д 2 дугаар нисгэгч/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...Би М.Б гэгчтэй ямар нэг харилцаа холбоо байхгүй. 2012 онд өөрийн өмчлөлийн Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоот, 3 өрөө орон сууцыг зогсоолын хамт худалдан борлуулахаар зар тавьсан байсан бөгөөд зарын дагуу “ЧХ” ОУБ-д ажилладаг гэх М.Б гэж залуу утсаар ярьж уулзан, манай байрыг нийт 125.000.000 төгрөгөөр худалдан авсан. Ингэж л М.Б гэж хүнийг мэднэ.

Худалдан хөгжлийн банкин дахь миний Төгрөгийн 49913xxxx тоот хадгаламжийн дансанд М.Б 2012 оны 04 сарын 18-ны өдөр 114.500.000 төгрөг, 10.500.000 төгрөгөөр тус тус 2 хувааж бэлнээр тушаасан байдаг. Уг мөнгөөр би БМ хороололд 120.000.000 төгрөгөөр 80 м.кв талбай бүхий 2 өрөө байр худалдан авсан.

Худалдах, худалдан авах тухай гэрээг Хан-Уул дүүргийн хажууд байдаг нотариатаар хийлгэж байсан. Гэрээний хувь нь надад одоо байхгүй байна. Гэрээг 30.000.000 төгрөгийн үнийн дүнгээр хийсэн байдаг. Учир нь Үл хөдлөх хөрөнгийн татвар бага төлөх зорилготой байсан юм...» /22-р хх-ийн 193/ гэсэн мэдүүлэг,

- “Эс” ХХК-ийн оффисын байр / Чингэлтэй “П” цамхгийн 201 тоот/,

А.Ба-ийн орон байр /Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот/-д тус тус нэгжлэг хийсэн тогтоол, тэмдэглэл зэрэг баримтууд /8-р хх-ийн 1-57/,

- “ТТББЭБ” ББСБ-аас Д.Э 110 сая төгрөг зээлсэн тухай 2012.02.03-ны өдрийн №ЗГ2012/01 дугаартай зээлийн гэрээ, эх хувь /11-р хх-ийн 50-53/,

- “Эс” ХХК-с “ТТББЭБ” ББСБ-д Д.Э-ын авсан зээлийг төлсөн баримт эх хувь, мөн “Худалдаа хөгжлийн банк”-ны баримт эх хувь, “Голомт” банкны гадаад төлбөрийн даалгавар /11-р хх-ийн 54-56/,

- Ц.Б-гийн “Худалдаа хөгжлийн банк”-ны 45313xxxx тоот ам.долларын дансанд 2012.04.04-ний өдөр гадаад мөнгөн шилжүүлэг буюу свифт үйлчилгээгээр 154.001.95 ам доллар, 2012.05 сард 39.968.00 ам.доллар шилжин ирсэн,

- М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-ны 45102xxxx төгрөгийн дансаар гадаад мөнгөн шилжүүлгээр буюу свифт үйлчилгээгээр 2010.10.10-ны өдөр 199.993.00 ам.доллар хүлээн авсан талаарх лавлагаа авах тогтоол /7-р хх-ийн 109/,

“Худалдаа хөгжлийн банк”-аас ирүүлсэн Ц.Б-гийн “Худалдаа хөгжлийн банк”-ны 45313xxxx тоот ам долларын дансанд 2012.04.03-ны өдөр 153.993.00 ам доллар, 2012.05.17-ны өдөр 39.968.00 ам долларын гадаад гүйлгээний баримт, М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-ны 45102xxxx тоот дансанд 2010.10.09-ний өдөр төгрөгийн гадаад гүйлгээний баримтууд /7-р хх-ийн 110-146/

“АЭБ” ХХК-ны байрнаас хураан авсан бичиг баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл / “Эс” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрэм, 2012.01.09-ний өдрийн хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ/ /13-р хх-ийн 232-235, 26-р хх-ийн 80-96/,

Гэрч Д.Т /ИНЕГ-ын Агаарын харилцааны хэлтэст мэргэжилтэн/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...Д.Э манай ерөнхий менежер байсан. Түүний удирдлаган дор Эдийн засгийн зохицуулалтын хэлтэс,

Агаарын харилцааны хэлтсүүд хамаарагддаг байсан юм. М.Б-ыг бол танихгүй. Хонконгт албан томилолтоор явах тушаал гарсан эсэхийг лавлаж 1 удаа ирж уулзаж байсан байх.

Би тус газрын Агаарын харилцааны хэлтэст 2011 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мэргэжилтнээр томилогдон одоог хүртэл ажиллаж байна.

ИНЕГ-ын Агаарын харилцааны хэлтэс нь Гадаад орнуудын Засгийн газар хоорондын хэлэлцээр болон гадаад харилцаа, хамтын ажиллагааны үйл ажиллагааг давхар эрхлэн явуулдаг. Миний хувьд 2011 оны 12 сараас 2012 оны 06 сар хүртэл хугацаанд Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хариуцаж байсан бөгөөд 2012 оны 06 сараас хойш Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хариуцаж байна.

ИНЕГ-ын алба хаагчид нь гадаад улсад албан томилолтоор зорчих асуудлыг агентлагийн тухай хууль, ИНЕГ-ын хөдөлмөрийн дотоод журам, гадаадад томилолтоор ажиллуулах тухай журмаар тус тус зохицуулагдана.

ИНЕГ-ын дарга тус байгууллагын ирэх оны гадаад арга хэмжээний төлөвлөгөөг батладаг бөгөөд батлагдсан төлөвлөгөөний дагуу гадаад томилолтоор болон гадаадад суралцдаг. Мөн түүнчлэн байгууллагын онцлогоос хамаарч гадаад улсад томилолтоор ажиллах гэнэтийн шаардлага гардаг. Гадаадад томилолтоор ажиллуулах тохиолдолд газрын даргын тушаал гарч, уг тушаалыг үндэслэн холбогдох албан тушаалтанд зардал олгогдож, томилолтоор илгээдэг. Тухайн албан тушаалтан томилолтоос ирээд ажлын 5 хоногийн дотор томилолтын талаар тайлан, илтгэлийг өгдөг.

Миний хувьд газрын даргын 2012 оны Б/65 тоот тушаалыг боловсруулсан. 2012 оны 03 сарын эхээр Д.Э дарга намайг ерөөндөө дуудаж, Хонконгт албан томилолтоор ажиллах батлагдсан удирдамж өгч, тушаалын төсөл боловсруул гэж үүрэг өгсөн. Тухайн удирдамжинд дурдсанаар Д.Э, М.Б нар нь Хонконгт Монголоос үйлдэж буй “М” ХК-ний нислэгийн давтамжийг 7 хоногт 5 болгох, Хонконгийн нисэх буудлын зорчигч бүртгэлийн системийн үйл ажиллагаатай танилцах, түүний ашиглалт болон үйлчилгээний талаар сургалт зохион байгуулах тухай ярилцах ажлаар явах тухай агуулгатай байсан. Иймд удирдамжинд заасны дагуу тушаалын төсөл боловсруулж,

тушаалын төсөлд санал авах тухай хуудсаар газрын даргын зөвлөлийн гишүүдээр хянуулсны дараа эцсийн байдлаар бичиг хэргийн ажилтнаар гаргуулж, газрын даргаар батлуулсан. Надад Д.Э даргын өгсөн удирдамжинд Д.Э, М.Б нарыг сонгож нэрийг нь тусгасан байсан. Эдгээр хүмүүсийг хэн сонгосныг мэдэхгүй.

2012 онд “М” ХК-иас нислэгийн давтамж нэмэгдүүлэх талаар албан бичиг ирсэн байх ёстой. Харин Хонконгийн талаас ямар нэгэн уулзалтын тов, урилга, ирсэн эсэхийг мэдэхгүй. Томилолтын материалд ямар ч байсан хавсаргагдаагүй байна.

Уг нь бол манай хэлтэст албан томилолтоор ажилласан тайлан, илтгэлээ өгөх ёстой байдаг боловч Д.Э, М.Б нар тайлан, илтгэлээ өгөөгүй...» /22-р хх-ийн 105/ гэсэн,

- Гэрч С.Бн /“К” ХХК-ийн гүйцэтгэх захирал/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...СУ..... тоот арлын дугаартай, “МЭ” маркийн автомашиныг 2011 оны 12 сарын 26-ны өдөр Япон улсаас оруулж ирэн, 14 хоногийн дараа буюу 2012 оны эхээр ЧС..... регистрийн дугаартай, А.Ба гэдэг эмэгтэйд нийт 13.000.000 төгрөгөөр худалдан борлуулсан. Төлбөрийг бэлнээр авсан. Манай компани нь автомашины худалдан борлуулахдаа худалдах, худалдан авах тухай гэрээ хийдэггүй, тухайн хүмүүс төлбөрөө өгсний дараа Авто тээврийн газар албан бичгээр хүсэлт гарган, тухайн хүний нэр дээр шилжүүлдэг. 13.000.000 төгрөгөөр л худалдсан. Манайх тухайн үед санхүү сайн жигдрээгүй байсан учир өөрийн хар дэвтэр дээр тэмдэглэсэн хэсгийг хуулбарлан өгч байна...” /22-р хх-ийн 195/ гэсэн мэдүүлэг,

- “К” ХХК-ийн санхүүгийн баримтууд /12-р хх-ийн 79-82/,

- Гэрч Ц.Эт /“Ма” ХХК-ийн захирал/ мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: “...Манай компанийн 2012 оны жилийн эцсийн тайлангаар нийт 2 тэрбум орчим төгрөгийн борлуулалттай ажилласан байдаг. Тус компанитай 2012 онд хамтран ажилласан, тус компани нь манай компаниас ойролцоогоор 40 нэр төрлийн, 46.000.000 орчим төгрөгийн сүлжээний тоног төхөөрөмж авч, үүнээс одоогийн байдлаар 31.695.703 төгрөгийг төлж, үлдэгдэл 15.000.000 төгрөгийг төлөөгүй байна. Худалдан авалтын байдлыг задалж хэлвэл: 2011 оны 12 дугаар сарын 12-нд 2 нэр төрлийн барааг 1.000.000 орчим төгрөгөөр, 2011 оны 12 дугаар 09-нд 8 нэр

төрлийн барааг 7.200.000 орчим төгрөгөөр, 2012 оны 01 дүгээр сарын 24-д 7 нэр төрлийн барааг 5.100.000 орчим төгрөгөөр, 2012 оны 02 дугаар сарын 14-нд 1 нэр төрлийн барааг 900.000 орчим төгрөгөөр, 2012 оны 02 дугаар сарын 04-нд 1 нэр төрлийн барааг 800.000 орчим төгрөгөөр, 2012 оны 02 дугаар сарын 04-нд 4 нэр төрлийн барааг орчим төгрөгөөр тус тус авч, нийт 19.500.000 орчим төгрөгийн бараа, материал хүлээлгэн өгсөн баримт байна. Нийт бол 31.000.000 төгрөгийг 2 удаагийн байдлаар буюу 2011 оны 12 дугаар сард 20.000.000 төгрөгийг бэлнээр, үлдэгдэл 11.000.000 төгрөгийг 2012 оны дундуур авсан санагдаж байна. Мөнгийг дандаа бэлнээр авч байсан. Кассын баримт байхгүй. Манай компанид 2011 он, 2012 оны эхээр ажиллаж байсан нягтлан бодогч нар НӨАТ-ийн асуудал үүсгэж, санхүүгийн баримт дутааж, будлиантуулсны улмаас 2013 оны эхээр УМБГ-т шалгагдаж байсан. Манай урьд ажиллаж байсан нягтлангууд хариуцлагагүй хандаж, баримт дутаасан асуудал бий. Зарим баримт тэр дутсан баримтуудтай алга болсон байх. Кассын баримт байхгүй байгаа нь ийм л учиртай. Тухайн үед “Эс” ХХК-тай худалдах, худалдан авах гэрээ хийгээгүй. Бараа, бүтээгдэхүүнийг зарим тохиолдолд М.Б өөрөө авч, заримыг нь бид “ЧХ” ОУБ-д хүргэж өгч байсан. Гэхдээ нийт борлуулалтыг базаж, НӨАТ-ийн падаан сүүлд нь үйлдсэн байдаг. Учир нь М.Б НӨАТ-ийн падаанаа нийлүүлж байгаад авья гэсэн учир нийлүүлж байгаад нэг бичээд өгсөн...” /22-р хх-ийн 197/ гэсэн мэдүүлэг, - “Ма” ХХК-ийн санхүүгийн баримтад үзлэг хийсэн тэмдэглэл /12-р хх-ийн 83-99/,

- Гэрч Н.НА мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгтээ: «...М.Б-ын тухайд дүү А.Ба-ийн нөхөр гэдгээр нь танина, бидний хувьд хоорондоо нэг ч удаа мөнгө, төгрөгийн өглөг авлагатай асуудал байхгүй. М.Б-ыг “Эс” ХХК-тай гэж урьд нь сонсож байгаагүй, 75.400.000 төгрөгийг М.Б-д өгч болон зээлж байгаагүй. 2013 оны 06 дугаар сарын сүүлээр улсын наадмын өмнө нэг танихгүй дугаараас эрэгтэй хүн залгаж, М.Б-ын талаар уулзъя, танд юм хэлүүлсэн гэж хэлсэн. Ингээд би тэр хүнтэй баруун 4 замын орчим уулзахад 30 орчим насны залуу байсан бөгөөд танаас М.Б мөнгө зээлж, буцааж төлсөн гэж байцаалт өгсөн шүү гэж дамжуулж байна гэж байсан. Тэгээд л би биеийн байдлыг нь асуугаад тэр залуугаас салсан. Миний хувьд М.Б-д мөнгө, төгрөг

зээлж, авч байгаагүй...» /22-р хх-ийн 202-204/ гэсэн, - Шүүгдэгч С.Б мөрдөн байцаалтын шатанд сэжигтнээр болон яллагдагчаар өгсөн мэдүүлэгтээ: «...Зорчигч бүртгэлийн систем нь дан ганц «М» ТӨХК дээр олон жил төвлөрч ирсэн байдаг. Энэ системийг С компанийн өндөр үнэтэй техник, технологи, програмчлалаар хийгдсэн системийг авч ашиглаж байсан. Зах зээлийн харилцаанд шилжиж байгаа өнөөгийн үед нэг агаарын тээвэрлэгч компани энэ үйл ажиллагааг дангаар гүйцэтгэж байх нь зохимжгүй байсан. Өөрөөр хэлбэл, төр, хувийн хэвшлийн агаарын тээвэрлэгч компаниуд бий болсон, Монгол руу нисдэг гадны агаарын тээвэрлэгч компаниудын тоо өссөн. Агаарын тээвэрлэгч компаниудаас бүртгэлийн системийг нэг компанид төвлөрүүлж монопольчуулж байгаа нь зохимжгүй байгаа талаар шүүмжлэл ирдэг байсан. Ингээд энэ байдлыг зах зээлийн зөв гольдролд нь оруулахын тулд агаарын тээвэрт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх төрийн бодлого, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих төрийн бодлого, аялал жуулчлалыг хөгжүүлэх төрийн бодлого, Иргэний нисэхийн талаар төрөөс баримтлах бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэх, иргэний агаарын тээвэрт шинэ техник, технологи хэрэгжүүлэх, зорчигч олон түмэнд жигд соёлтой чанартай үйлчилгээг нэвтрүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллагаас тавигддаг, зөвлөмж, шаардлага, Иргэний нисэхийн тухай Монгол Улсын хууль, Агаарын зайн тухай МУ-ын хууль, Улсын нисэхийн тухай хууль, Худалдан авах ажиллагааны хууль, компанийн тухайн хууль, Терроризмтой тэмцэх дэлхийн нийтийг мэдээллээр хангах зорилго, бодлогыг хангах, нисэхийн аюулгүй ажиллагаа, нисэхийн байдлыг хангах, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухайн хууль, Тухайн жилийн төсвийн тухайн хууль зэрэгт нийцүүлж Зорчигч бүртгэлийн системийг «ЧХ» ОУБ-д төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан. Энэ нь «ЧХ» ОУБ-д төвлөрөн үйл ажиллагаа явуулж буй бусад төрийн байгууллагатай харилцан, хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлсэн юм.

...Манай газраас зохион байгуулсан тендерийн хүрээнд “А” компани нь бүртгэлийн системийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн, “Эс” компани нь бүртгэлийн системийн програмчлал, сүлжээний асуудлыг шийдвэрлэж, нийлүүлсэн. Тийм

учраас дээрх 2 ажил нь давхардсан ажил биш. Давхардсан тендер биш. 2 дугаарт 2 дахь тендерийн санхүүжилт нь төсвийн хөрөнгө биш, зорчигчид тухайн бүртгэлийн системийг ашиглан үйлчлүүлсэн төлбөрөө тухайн нислэгийн билетийн таксын үнэлгээнд хамруулж төлж байгаа төлбөрөөс санхүүжсэн. Өөрөөр хэлбэл, зорчигч олон түмнээс үйлчилгээнийхээ төлөө төлж байгаа төлбөр юм. Тийм учраас Худалдан авах төлөвлөгөөнд тусгах шаардлагагүй. Ер нь тэгээд нэмж хэлэхэд өмнө нь энэ таксын мөнгө Гадаад улсын “С” компанид шууд шилждэг байсныг өөрчилж Монгол Улсын иргэний компанийг дэмжсэн /үндэсний үйлдвэрлэгч/ юм. Миний бие тендерт шалгарсан “Эс” ХХК-тай гэрээ байгуулж, энэ хугацаанд нийт 4 удаагийн төлбөр хийгдсэнээс 3 гүйлгээг нь гарын үсэг зурж шилжүүлсэн. Үүнээс цааш тухайн компани мөнгөө хэрхсэн талаар огт мэдэхгүй. Гадаадад компани үүсгэн байгуулахад нь эхнэрийнхээ нэрийг оруулсан асуудал байхгүй...” /25-р хх-ийн 19-49/ гэсэн,

- Шүүгдэгч Г.Н мөрдөн байцаалтын шатанд сэжигтнээр болон яллагдагчаар өгсөн мэдүүлэгтээ: “...ИНЕГ-аас 2011 онд явуулсан Нисэх буудлын бүртгэл хяналтын цогц систем нийлүүлж суурилуулах ажил нь тухайн оны төлөвлөгөөнд тусгагдаж, гүйцэтгэгдсэн ажил юм. Харин 2012 онд ИНЕГ-аас явуулсан “ЧХ” ОУБ-д зорчигч бүртгэлийн сүлжээний операторыг сонгон шалгаруулах ажил өөрөө ИНЕГ-аас гарах зардал биш учраас төлөвлөгөөнд суугаагүй.

...Урьд нь Зорчигч бүртгэлийн системийг “М” ХК болон бусад Авиа компаниуд өөр, өөрийн системээр явуулдаг байсан. Энэ нь нислэг давхсан үед явагчдын зааланд зорчигчид багтахгүй байх хүндрэл үүсгэж байсан. Энэ талаар арга хэмжээ авахыг хариуцсан яамнаас үүрэг болгосны дагуу Бүртгэлийн системийг боловсронгуй болгож бүртгэлийн нэгдсэн системийг ашиглах нь зүйтэй гэсэн саналыг тухайн үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн нэгж хэлтсээс оруулж ирсний дагуу уг ажлыг эхлүүлсэн. Урьд нь авиа компаниуд нэг зорчигчоос авах билетийн төлбөр дээр тухайн нисэх буудалд байрлах бүртгэлийн системийг ашигласны хураамжийг нэмж тооцон систем хариуцаж байгаа байгууллагад төлдөг байсан. М ХК-ний ашигладаг С системээр дамжуулж бүртгэлээ явуулдаг компаниуд 6 ам.долларыг зорчигчийн билетийн төлбөрөөс гаргаж өгдөг байсан. Мөн авиа компаниуд нь ИНЕГ-ын

харьяа “ЧХ” ОУБ-ын үйлчилгээний буудлын хураамжинд зорчигч тутмаас орчим төгрөг тооцож ИНЕГ-т төлдөг. Энэ орлого бол манай үндсэн орлого гэж үзэж болно. Харин А компанийг сонгосноор манайд орж буй нисэх буудлын хураамж 12.000 төгрөгөөр хэвээрээ бөгөөд сүлжээ ашигласны хураамжинд тухайн сүлжээний компанид нэг зорчигчоос 4.000 төгрөг тооцож төлөх болсон. Энэ нь 1 зорчигчийн халааснаас гарах төлбөрийг ойролцоогоор 3.000 төгрөгөөр бууруулсан юм. Тэгэхээр энэ сүлжээний төлбөр болгож авиа компаниудын зорчигчоос билетийн үнийн дүн дээр нэмж авч байсан төлбөр нь угаасаа ИНЕГ-т хамааралгүй, урьд нь ч хамааралгүй байсан. Тэр зарчмаар энэ үйл ажиллагааг шийдсэн.

...С.Б, Д.Э, М.Б нартай хамтран өөрийн ээжийн нэрээр гадаадад компани байгуулсан гэх асуудлыг огт мэдэхгүй...” /24-р хх-ийн 241-250, 25-р хх-ийн 1-9/ гэсэн,

- Шүүгдэгч Д.Э мөрдөн байцаалтын шатанд сэжигтнээр болон яллагдагчаар өгсөн мэдүүлэгтээ: “...ИНЕГ-ын даргын 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар “ЧХ” ОУБ-д Зорчигч бүртгэлийн сүлжээний операторыг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулагдаж, Үнэлгээний хорооны даргаар намайг томилсон байсан. Ингээд Үнэлгээний хороог хуралдуулж, Тендерийг хэрхэн явуулах талаар ярилцсан.

Тэгээд «А» компани нь бүртгэлийн системийн тоног төхөөрөмж суурилуулсан юм байна, одоо бид энэ тоног төхөөрөмж бүхий системийн операторын үйл ажиллагааг явуулах гүйцэтгэгчийн талаар ярилцахад Дэлхийд «С», «Ар» гэж 2 компани энэ үйл ажиллагааг эрхэлдэг юм байна гэдгийг олж мэдсэн. Ингээд Үнэлгээний хорооны гишүүн /одоо нас барсан/ Цэдэндорж гуай угаасаа энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг 2 компани л байдаг юм бол тухайн 2 компанидаа урилга явуулж, хязгаарлагдмал байдлаар тендер зарлах санал тавьсны дагуу ярилцаж хязгаарлагдмал байдлаар зарлахаар болсон. Ингээд Тендерийн материалаа, урилгын хамт «С» компанийн Монгол дахь төлөөлөгчийн газарт болон, «Ар» компанийн төлөөлөгч “Эс” ХХК-д хүргүүлсэн. Ингээд тендерийн урилга дээр заасан тендерийг нээх хугацаа болоход “Эс” ХХК-аас санал ирсэн байсан бөгөөд «С»-гийн төлөөлөгчөөс огт санал ирээгүй байсан. Тэгээд Үнэлгээний хороог хуралдуулж, «Ар»-ийн төлөөлөгч “Эс” ХХК-ийн материалтай танилцахад

«Ар» компанийн үндсэн серверээр бүртгэл дамжиж, энэ үйл ажиллагааг «Ар» компани хариуцаж, “Эс” ХХК-ийн хувьд Монгол дахь үйл ажиллагааг хариуцах юм байна гэж ойлгоод “Эс” ХХК-ийг шалгаруулья гэж шийдсэн. Ингээд гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн. Үүгээр миний ажил үүрэг дууссан гэж ойлгож болно.

...Тендер шалгаруулалтын явцад М.Б-ыг “Эс” ХХК-тай гэж мэддэггүй байсан. Хэрвээ мэдсэн бол түүнтэй хамтран гадаадад компани байгуулах асуудал ярилцахгүй байх байсан. Тэгээд ч Ч.Ө, Г.Чи, М.Б нартай хамтарч ийм компани байгуулаагүй.

...Миний хувьд тендерийн урилга бүхий албан бичигт гарын үсэг зурсан бөгөөд албан бичиг хэзээ хэрхэн хүргэгдсэнийг мэдэхгүй.

... М.Б-той ИНЕГ-ын “ЧХ” ОУБ-д 9 жил гаруй жил хамт ажиллаж байсан, найз нөхдийн харилцаа холбоотой.

...2013 оны 01 сар орчим Тайланд улс руу эхнэр Н.М-гийн хамт болон М.Б, түүний эхнэрийн хамт явж, 7 хоног амарсан.

...М.Б нь БНХАУ-ын Шинженьд электроникийн үйлдвэр байдаг, тэндээс хямдхан хяналтын камер тоног, төхөөрөмж, галын болон хулгайн дохиолол зэргийг оруулж ирээд Монголд худалдаж, суурилуулах ажил хийх боломжтой, тэгвэл мөнгөө 2 дахин өсгөх боломж байна гэсэн. Ингээд намайг хамтран орох эсэхийг асууж, нийт 15.000 ам.доллараар тоног төхөөрөмж оруулж ирье, чи 7.500 ам.долларыг гарга, би талыг нь гаргая гэсэн. Ингээд би мөнгө асууж, сураглаад, мөнгө олдвол хамтарья гэж тохиролцоод салсан. Надад тухайн үед томилолтоос хэмнэсэн 2.000 орчим ам.доллар байсан бөгөөд үлдэгдэл мөнгийг олох зорилгоор С.Б даргаас асуухад тийм мөнгө байхгүй, чи тийм мөнгөөр яах гэж байгаа юм бэ гэхээр нь нэг найзтайгаа хамтраад ийм бизнес хийх гэсэн юм эсвэл та цуг орохгүй юм уу гэж асуухад үгүй гэсэн. Ингээд би ИНЕГ-т цуг ажилладаг Г.Н даргад орж мөн санал тавихад бодож байгаад эргээд хариу хэлье гэсэн. Ингээд хэсэг хугацааны дараа С.Б дарга болон Г.Н дарга нар хамт хөрөнгө оруулья гэсэн бөгөөд хүн тус бүр 2.500 ам.доллар оруулахаар болсон. Ингээд М.Б-той холбогдоход ер нь энэ бизнесээ хийх зорилгоор гадаадад компани үүсгэн байгуулья, учир нь татвар бага төлөгдөх боломжтой юм байна гээд иргэний үнэмлэх, хорооны тодорхойлолт, гадаад паспортуудынхаа хуулбаруудыг өгчих,

би өөрөө үүнийг хөөцөлдөнө гэж байсан. Ингээд би С.Б, Г.Н дарга нартай уулзаж шаардлагатай бичиг баримтуудыг хэлэхэд С.Б дарга эхнэрийнхээ, Г.Н дарга ээжийнхээ холбогдох бичиг баримтыг хуулбарлан өгсөн. Ингээд би өөрийнхөө бичиг баримтуудтай нийлүүлж М.Б-д аваачиж өгсөн...” /24-р хх-ийн 184-210/ гэсэн,

- Шүүгдэгч М.Б мөрдөн байцаалтын шатанд сэжигтнээр болон яллагдагчаар өгсөн мэдүүлэгтээ: “...Миний хувьд 2012 оны эхээр Д.Э-тай хамтарч Хонконгт компани байгуулахаар ярьж байсан. Компанийг байгуулахад 2 талаасаа 15.000 ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр ярьсан бөгөөд Д.Э мөнгө төгрөгийн боломж муу байна, өөр дээрээ нэмж 2 хүн олоод өөрийн гаргах хувиа багасгахаар ярилцаж байсан. ...Ингээд Э нь Г.Чи, Ч.Ө гэж хүмүүсийн бичиг баримтуудыг надад өгч 4 хүний гишүүнтэй компани байгуулахаар тохирсон. ...Хэсэг хугацааны дараа Д.Э-тай холбогдож тохиролцсон хөрөнгөө оруулах эсэх талаар асууж, хүлээж нилээн удсан. Ингээд мөнгөө өгөхгүй болохоор нь би өөрийн нэрээр дангаараа Хонконгт компани байгуулахаар болж 2012 оны 11 сарын сүүлээр Хонконгт очиж Ан-той уулзаж, холбогдох бичиг баримтууд дээр гарын үсэг зурж, “МСЛ” гэх компанийг өөрийн нэрээр үүсгэн байгуулсан юм. Мөн тус компанийн Хонконг дахь данс нээх баримтан дээр гарын үсэг зурсан.

...Миний хувьд өөрийн үүсгэн байгуулсан “Эс” ХХК нь АНУ-ын “Ар” компанийн Монгол улс дахь төлөөлөгчийн газрын эрхийг 2011 онд авсан. Тэгээд “ЧХ” ОУНБ дээр суурилуулсан байсан “vMUSE” зорчигч бүртгэлийн системийн 1 дүгээр түвшний операторын эрх буюу аюулгүй найдвартай ажиллагааг хангах ажлыг гүйцэтгэх ИНЕГ-аас зарласан тендерт оролцож ялсан. Ингээд тендерт ялсны дагуу зорчигч, бүртгэлийн системийн найдвартай, тасалдалгүй аюулгүй ажиллагааг ханган өнөөдрийг хүртэл ажиллаж байна.

...2012 онд 4 удаагийн байдлаар нийт 1.062.959.200 төгрөгийн санхүүжилтийг ИНЕГ-аас өөрийн компанийн “Голомт” банкин дахь дансаар авсан. Энэ мөнгийг компанийн тухайн жилийн НӨАТ, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг хууль ёсны дагуу ногдуулж төлүүлэх, компанийн ажилчдын цалин, хөлс, компанийн үйл ажиллагааны зардал, тоног төхөөрөмжийн шинэчлэл зэрэгт зарцуулсан.

...Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулагдсан “МСЛ” гэх компани нь миний нэг хүний гишүүнчлэлтэйгээр үүсгэн байгуулагдсан, миний хувийн компани байгаа юм. Энэ компанийг С.Б-ийн эхнэр Г.Чи, Г.Н-ийн ээж Ч.Ө, Д.Э нартай хамтран байгуулаагүй. Энэ хүмүүстэй хамтран байгуулахаар ярилцаж байгаад больж, зөвхөн өөрийн нэрээр үүсгэн байгуулсан.

...”ТСЛ” компанийг Б-гийн компани гэдгийг мэдэхгүй. “А” компани менежер К, Н нарын олж өгснөөр холбоо тогтоосон. Тус компани нь “vMUSE” системд ашиглагддаг, тоног төхөөрөмжийг нийлүүлдэг компани юм...” /24-р хх-ийн 149-179/ гэсэн мэдүүлгүүд,

- Гэрч Б.Да /ИНЕГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын тасагт аудитор ажилтай, 22-р хх-ийн 69-72/, М.Д /ИНЕГ-ын Нисэх буудлуудын үйлчилгээний газрын Нисэх буудлуудын зохицуулалтын хэлтсийн дарга, 22-р хх-ийн 73-75/, А.А /ИНЕГ-ын Нисэх буудлуудын газрын харьяа ЧХ ОУБ-ын Үйлдвэрлэл зохицуулалт, хяналтын хэлтсийн дарга, 22-р хх-ийн 76-78/, Л.Б /ИНЕГ-ын харьяа “ЧХ” ОУБ-ын ерөнхий захирал, 22-р хх-ийн 79-81/, Б.Г /ИНЕГ-ын Захиргаа удирдлагын газрын дарга, 22-р хх-ийн 85-86/, Б.Со /ИНЕГ-ын Захиргаа удирдлагын газрын хуулийн хэлтсийн хуулийн мэргэжилтэн, 22-р хх-ийн 87-88/, Б.А /ИНЕГ-ын Нисэх буудлуудын үйлчилгээний газрын Нисэх буудлын зохицуулалтын хэлтэст ахлах мэргэжилтэн, 22-р хх-ийн 92-94/, Ж.Ч / Эрхэлсэн тодорхой ажилгүй, 22-р хх-ийн 95-98/, Б.Ж /ИНЕГ-ын Газрын үйлчилгээний албанд жолооч, 22-р хх-ийн 103-105/, А.Л /”А” ХХК-д менежер, 22-р хх-ийн 138-140/, Б.Д / Хувиараа гоо сайханч, 22-р хх-ийн 154-156/, М.Х /”АЭБ” ХХК-ийн хуульч, 22-р хх-ийн 157-158/, С.Ц /”АЭБ” ХХК-ийн хуулийн зөвлөх 22-р хх-ийн 159-161/, С.Ц /”АЭБ” ХХК-ийн хуулийн ажилтан, 22-р хх-ийн 162-163/, Н.П.Эц /”АЭБ” ХХК-ийн гүйцэтгэх захирал, 22-р хх-ийн 164-166/ нарын мэдүүлгүүд,

- А.Б, М.Б нарын орон байр Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод нэгжлэг хийсэн тогтоол тэмдэглэл зэрэг баримтууд /8-р хх-ийн 1-57/,

- “Эс” ХХК-ийн 2011.12.27-ны өдөр №5/41 дугаартай ИНЕГ-ын дарга С.Б-ийн нэр дээр ирүүлсэн албан бичиг, уг албан бичгийн хавсралт болох ажил үйлчилгээ үзүүлэх тухай гэрээний загвар /11-р хх-ийн 21-33/,

- ЧХ ОУБ-д зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгэх

№ИНЕГ/У/ХББ/Б-04/12 дугаартай гэрээ эх хувь /4000 төгрөгийн/ /11-р хх-ийн 34-49/,

- “Эс” ХХК-ийн үүсгэн байгуулагчдын лавлагаа /3-р хх-ийн 189-191/

- “А” ХХК-ийн үүсгэн байгуулагч нарын лавлагаа /5-р хх-ийн 133-145/,

- 2010-2013 онд “Эс” ХХК-ийн гаалийн мэдүүлгээр бүрдүүлэлт хийсэн барааны жагсаалт /4-р хх-ийн 3/,

- “А” ХХК-ийн 2010 оноос хойш импортлосон барааны жагсаалт /5-р хх-ийн 146-151/,

- С.Б, Д.Э, Г.Н, М.Б нарын ажилд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаал ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарьтай холбоотой баримтууд /5-р хх-ийн 203-218, 6-р хх-ийн 3-45/,

- “Ар” ХХК-ийн Ази Номхон Далайн бүсийн төслийн менежер К, СО /Кепд, Бепд Ооп/-той 2013.10.24-ний өдөр хийсэн уулзалт ярилцлага, харилцан ойлголтын тэмдэглэл /4-р хх-ийн 242-246/,

- ГИХАЭГ-ын 2013.11.01-ний өдрийн 5/2361 дугаартай албан бичиг /М.Б, Б.Гб нарын урилгаар Монгол улсад гадаад иргэд ирж байгаагүй гэх/ /5-р хх-ийн 194-195/,

М.Б-ын Хан-Уул дүүргийн ...-р хороо Чингисийн өргөн чөлөө ...тоот болон “Эс” ХХК-ийн ажлын байранд нэгжлэг хийх тогтоол, нэгжлэг хийсэн тэмдэглэл /11-р хх-ийн 58-127/,

- М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-ны 45102xxxx дугаартай дансны хуулгууд /11-р хх-ийн 61-70/,

- Олон улсын “ЧХ” НБ-д зорчигч бүртгэлийн системийн операторыг сонгон шалгаруулах тендерийн баримт бичиг /11-р хх-ийн 71-127/,

- ИНЕГ-ын Д.Э-ын ажлын 209 тоот албан тасалгаанд нэгжлэг хийх тухай тогтоол, нэгжлэг хийсэн тэмдэглэл /11-р хх-ийн 138-151/,

- “М” ХК-с ИНЕГ-т хандан ирүүлсэн “Зорчигч бүртгэлийн системийн алдаа дутагдлын тухай” 2013.03.01-ний өдрийн 0385. дугаартай албан бичиг хавсралтын хамт /11-р хх-ийн 141-144/,

- ИНЕГ-ын дарга С.Б-ийн Зорчигч бүртгэлийн сүлжээний операторыг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог томилох тухай 2012.01.23-ны өдрийн А/54 дугаартай тушаалын хуулбар /11-р хх-ийн 145/,

- М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-н дахь 45102xxxx дугаартай ам.долларын данс, “Эс” ХХК-ийн 110272xxxx дугаартай

ам.долларын дансуудад үзлэг хийсэн тэмдэглэл, дансны хуулгууд. /11-р хх-ийн 156-182/,

- “ТТББЭБ” ББСБ-ийн 2012 оны харилцах болон кассын баримтууд, мөн 2012 оны зээлийн гэрээнүүдэд үзлэг хийсэн тэмдэглэл /11-р хх-ийн 183-218/,

- М.Б-ын орон байрнаас хураан авсан “Touch smart 300” маркын компьютерт үзлэг хийсэн тэмдэглэл /11-р хх-ийн 219-225/,

“Эс” ХХК нь “А” ХХК-ийн охин компани болохыг тодорхойлсон албан бичгийн төсөл,

-М.Б, Д.Э нарын Тайланд улсад амарсан үеийн гэрэл зургууд /11-р хх-ийн 222-225/,

- ИНЕГ-ын архивын бичиг баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл /13-р хх-ийн 138-169/,

- 2012.01.26-ны өдрийн №07/229 албан бичиг /ОУ-ын ЧХ нисэх буудалд зорчигч бүртгэлийн системийн операторыг сонгон шалгаруулах ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот тендерт үнийн санал ирүүлэх тухай/ /13-р хх-ийн 141/,

- 2012.02.09-ний өдрийн №07/321 дугаартай албан бичиг /ОУ-ын ЧХ нисэх буудалд зорчигч бүртгэлийн системийн операторыг сонгон шалгаруулах ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот тендерт тодруулга хүргүүлсэн тухай/ /13-р хх-ийн 142/,

- 2012.02.16-ны өдрийн №01/385 дугаартай /ОУ-ын ЧХ нисэх буудалд зорчигч бүртгэлийн системийн операторыг сонгон шалгаруулах ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот тендерт гэрээ байгуулах эрх олгох тухай/ албан бичиг /13-р хх-ийн 143/,

-“Эс” ХХК-ийн 2011.12.27-ны өдрийн 5/41 дугаартай ИНЕГ-ын дарга С.Б-д хаягласан гэрээ байгуулах тухай албан бичиг /13-р хх-ийн 144/,

Эс ХХК-ны 2012.01.17-ны өдрийн 5/01 дугаартай ИНЕГ-ын дарга С.Б-д хаягласан гэрээний төсөл хүргүүлэх тухай албан бичиг, гэрээний төсөл /13-р хх-ийн 145-151/,

-“А” ХХК-ийн 2012.04.23-ны өдрийн №201204/005 дугаартай 299.314.623 төгрөгийн нэхэмжлэх /13-р хх-ийн 153/,

- Шүүх сэтгэц гэм судлалын дүгнэлтүүд /25-р хх-ийн 193, 196, 199, 202/,

- Иргэний үнэмлэхний лавлагаанууд /3-р хх-ийн 92, 93, 96, 99, 114, 133, 139/,

- Ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /3-р хх-ийн 147, 148, 149, 150/,

- Эд хөрөнгийн ашиглалтын бүртгэл /26-р хх-ийн 74-78/,

- “ЧХ” Олон улсын буудлын мэдээлэл,

технологийн албаны үйл ажиллагааны заавар /26-р хх-ийн 41-73/,

- Зарим сэжигтэн, яллагдагчид холбогдох зарим хэргийг хэрэгсэхгүй болгосон Прокурорын тогтоолууд /27-р хх-ийн 93-94, 95-96, 97, 98-99, 100-101, 102, 103, 104, 105/,

- ИНЕГ-ын 2013.10.31-ний өдрийн 01/2705 тоот хохирогч, иргэний нэхэмжлэгчийг томилж ирүүлсэн албан бичиг /22-р хх-ийн 48/,

- Тээврийн хэрэгслийн лавлагаанууд /3-р хх-ийн 154, 158, 4-р хх-ийн 183-184, 5-р хх-ийн 34, 51, 55, 171/,

- ИНЕГ-ын 2011, 2012, 2013 оны гадаад томилолтын талаарх баримт /5-р хх-ийн 196-201/ зэрэг болно.

Дээрх нотлох баримтуудыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн байх бөгөөд шүүх түүнийг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой, үнэн зөвд тооцож шийтгэх тогтоолын үндэслэл болголоо.

Шүүхийн хэлэлцүүлгийн үед шинжилсэн нотлох баримтууд нь энэ хэрэгт хамааралтай, хуульд заасан журмын дагуу цугларсан, хэрэг хянан шийдвэрлэхэд хангалттай байна гэж үзэв.

Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас шүүгдэгч С.Б-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасныг журамлан тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан гэмт хэрэгт холбогдуулан,

шүүгдэгч Д.Э-ад Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг шүүх шүүгдэгч С.Б, Д.Э нар нь «төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан гэж дүгнэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 болгон,

шүүгдэгч С.Б, М.Б нарт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасныг журамлан тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан гэмт хэрэгт холбогдуулан, шүүгдэгч Д.Э-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг шүүх шүүгдэгч С.Б, М.Б, Д.Э нар нь бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэж үйлдсэний улмаас онц их

хэмжээний хохирол учруулсан гэж дүгнэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 болгон өөрчлөн зүйлчлэх нь зүйтэй гэж үзэв. Учир нь:

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасан «...зохион байгуулагч...» гэдэгт гэмт хэрэг үйлдэх явдлыг анхнаас нь сэдэж санаачлан түүнийгээ хэрэгжүүлэх бүх боломж, нөхцөлийг бүрдүүлэх талаар идэвхтэй үйл ажиллагаа явуулж, удирдан чиглүүлэх ажлыг гардан хариуцаж, гэмт хэрэг үйлдэх төлөвлөгөө боловсруулах, гэмт хэрэгт оролцогчдын үүргийг хуваарилах замаар гэмт хэргийг хэдийд, хаана, хэрхэн яаж үйлдэх, гэмт хэрэг үйлдсэний дараахь ул мөрийг арилгах зэрэг асуудлыг зохицуулагч этгээдийг гэж,

35.6-д заасан «...хамжигч...» гэдэгт бусдыг гэмт хэрэг үйлдэхэд зааж зөвлөх, зэвсэг хэрэгсэл өгөх, учрах саадыг арилгах, унаа, орон байраар хангах, мэдээлэл өгөх зэргээр гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлж, гэмт хэрэг үйлдсэний дараа гэмт этгээд болон гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг хэрэгсэл, гэмт хэргийн улмаас олсон эд зүйлийг нуун далдлах, зарж борлуулах, гэмт хэргийн ул мөрийн баллахаар урьдчилан амласныг ойлгох бөгөөд шүүгдэгч С.Б, Д.Э нар нь төрийн албан тушаалтан албаны эрх мэдлээ буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглах гэмт хэргийг үйлдэхдээ, шүүгдэгч С.Б, Д.Э, М.Б нарт бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэж үйлдэхдээ хэн, ямар оролцоотой оролцсоныг тогтоогоогүй, дээрх гэмт хэргүүдийг үйлдэхдээ С.Б, М.Б нар нь зохион байгуулагчийн, Д.Э нь хамжигчийн хэлбэрээр бус гүйцэтгэгчийн хэлбэрээр оролцсон байна шүүх дүгнэн дээр дурдсанаар өөрчлөх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн Прокурорын газраас шүүгдэгч С.Б-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасныг журамлан тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166^{1.3}-т заасан гэмт хэрэгт холбогдуулан,

шүүгдэгч Г.Н, Д.Э нарт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166^{1.3}-т заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн нь үндэслэлгүй байна. Учир нь:

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166¹ дүгээр зүйлд /2009 оны хууль/ «Хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун

далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор энэ хуулийн 166 дугаар зүйлд зааснаас бусад хүндэвтэр, хүнд, онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө, мөнгийг санаатайгаар хүлээн авсан, Г.Н, шүүгдэгч С.Б, Д.Э нарыг “Эс” ХХК-ийн «Голомт» банкин дахь 110268xxxx тоот дансаар 1.062.959.200 төгрөгийг шилжүүлэн авч завшсан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөнийхөө хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор “Эс” ХХК-ийн захирал М.Б нь Их Британи Виржиний арлуудад /BRITISH VIRGIN ISLANDS/ “МСЛ” гэх нэр бүхий компанийг үүсгэн байгуулж, улмаар тус компанийн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-27041x-xxx тоот харилцах дансанд 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 150.000 ам.доллар шилжүүлж, улмаар “Эс” ХХК-ийн “Голомт” банкин дахь 110272xxxx тоот дансаар 2013 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 144.960 ам.долларыг буцаан хүлээн авсан,

“АЭБ” ХХК-ийн захирал Б.Б-гийн Их Британи Виржиний арлуудад /BRITISH VIRGIN ISLANDS/ үүсгэн байгуулсан “ТКЛ” компанийн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-2728x-xxx тоот харилцах дансанд 2012 оны 03 дугаар сарын 29-ний өдөр 155.000 ам.доллар шилжүүлж, улмаар 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 153.993 ам.доллар,

2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 39.968 ам.долларыг тус тус Ц.Б-гийн “Худалдаа хөгжлийн банк”-н дахь 45313xxxx тоот дансаар дамжуулан М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-н дахь 45102xxxx тоот дансаар буцаан хүлээн авсан,

“ТКЛ” компанийн HSBC банкин дахь 848-2728x-xxx тоот харилцах дансанд 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 202.500 ам.доллар шилжүүлж, улмаар 2012 оны 10 сарын 10-ны өдөр 199.993 ам.долларыг М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-ин дахь 45102xxxx тоот дансаар тус тус М.Б буцаан хүлээн авч, мөнгө угаасан гэмт хэрэгт тэднийг зохион байгуулагчийн болон хамжигчаар гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон болох нь дараах нотлох баримтуудаар няцаагдаж байна.

Үүнд: мөрдөн байцаалтын шатанд М.Б-

ын: “...2012 оны эхээр Д.Э-тай хамтарч Хонконгт компани байгуулахаар ярьж байсан, компанийг байгуулахад 2 талаасаа 15.000 ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр ярьсан, Д.Э мөнгөний боломж муу байна, өөр дээрээ нэмж 2 хүн олоод өөрийн гаргах хувиа багасгахаар ярилцаж байсан, БНХАУ-аас тоног төхөөрөмж татахад дотооддоо худалдан авалт хийвэл гаалийн татвар болон бусад татваруудаас чөлөөлөгддөг, ингээд Д.Э нь Г.Чи, Ч.Ө гэж хүмүүсийн бичиг баримтуудыг надад өгч, 4 хүний гишүүнтэй компани байгуулахаар тохирсон.

Шаардлагатай бичиг баримтуудыг бүрдүүлж, «АЭБ» ХХК-аар хянуулахын зэрэгцээ тус компаниар дамжуулж Ан-той харьцаж бусад мэдээллийг авахуулахаар болсон.

...Ингээд тухайн үед ИНЕГ-ын Д.Э-ын хамт албаны шугамаар Хонконг явах томилолттой үе таарч үүний хажуугаар компани нээх ажлаа амжуулахаар явсан. Хувь нийлүүлэгчдийн гарын үсэг зурах хэрэгтэй болж би материалуудаа аваад монголд ирсэн, монголд ирээд хэсэг хугацааны дараа Д.Э-тай уулзаж хөрөнгө оруулах эсэх асуудлыг ярилцаж удсан, ингээд мөнгөө өгөхгүй болохоор нь би өөрийн нэрээр дангаараа Хонконгт очиж Ан-той уулзаж холбогдох бичиг баримтуудад гарын үсэг зурсан. Яагаад Б.Б-гийн компьютер дээр уг баримтууд байгааг мэдэхгүй, тухайн үед Ан-д өгсөн баримтууд. ...компани нээсэнтэй холбоотой ямар нэг бичиг баримт, сертификат, тамга, тэмдгийг надад өгөөгүй, тийм зүйлс байхгүй. Г.Чи, Ч.Ө, Д.Э нарын нэрээр хамтран компани байгуулах гэж байгаад эдгээр хүмүүс мөнгөө өгөөгүй учир больж өөрийн нэрээр компани байгуулсан...» /24-р хх-ийн 165-171/ гэсэн,

“...Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулагдсан “МСЛ” гэх компани нь нэг хүний гишүүнчлэлтэйгээр үүсгэн байгуулагдсан, миний хувийн компани байгаа юм. Энэ компанийг С.Б-ийн эхнэр Г.Чи, Г.Н-ийн ээж Ч.Ө, Д.Э нартай хамтран байгуулаагүй. Энэ хүмүүстэй хамтран байгуулахаар ярилцаж байгаад больж, зөвхөн өөрийн нэрээр үүсгэн байгуулсан...” /24-р хх-ийн 175-179/ гэсэн,

Шүүгдэгч Д.Э-ын: «...2012 оны 03 сарын эхээр нисэх буудал дээр явж байгаад М.Б-той тааралдаж хамт хоол идсэн. Хамтарч бизнес хийх талаар ярьсан, ...Ингээд М.Б-той холбогдоход ер нь бизнес хийх зорилгоор

гадаадад компани үүсгэн байгуулья, учир нь татвар бага төлөгдөх боломжтой юм байна гээд иргэний үнэмлэх, хорооны тодорхойлолт, гадаад паспортынхоо хуулбарыг өгчих, би өөрөө хөөцөлдөнө гэж байсан. Ингээд С.Б, Г.Н дарга нарт хэлээд холбогдох бичиг баримтуудыг хэлэхэд С.Б дарга эхнэрийнхээ, Г.Н дарга ээжийнхээ холбогдох бичиг баримтыг хуулбарлан өгсөн. Ингээд би өөрийнхөө бичиг баримтуудыг нийлүүлж М.Б-д өгсөн. Хэсэг хугацааны дараа буюу 7-8 хоногийн дараа М.Б над руу ярьж гадаадад компани байгуулахад бүртгэлийн хураамж гэж 10.000 доллар хэрэгтэй юм байна, дахиад хүн тус бүр 2500 доллар хэрэгтэй гэхэд би надад тийм их мөнгө байхгүй, би болилоо гээд энэ талаар С.Б, Г.Н дарга нарт хэлэхэд чи больж байгаа юм бол бид ч гэсэн болилоо гэсэн, ийм л асуудал болсон. Гадаадад хэрхэн компани үүсгэн байгуулах гэж байсан талаараа яриагүй, мэдэхгүй, “АЭБ” ХХК-ийн Б.Б гэдэг хүнийг танихгүй, би М.Б-той Их Британи Виржиний арлуудад МСЛ гэх компани үүсгэн байгуулаагүй. ...2012 оны 02 дугаар сарын 23, 24-нд Хонконг руу компани байгуулахаар М.Б-ын хамт яваагүй, М.Б-той компани байгуулах ажлаар Хонконг явах талаар огт ярилцаагүй. 2012 оны 03 дугаар сарын 17, 18-ны орчим Хонконг руу М.Б-той хамт ИНЕГ-ын даргын 2012 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн Б/65 тоот тушаалын дагуу явсан.

...М.Б ямар ажил хийснийг мэдэхгүй, энэ үеэр Хонконг явахдаа М.Б-ын хамт компани байгуулах чиглэлээр гарын үсэг зурсан, бичиг баримт хүлээлгэн өгсөн асуудал байхгүй, өөр ямар нэгэн компани байгууллага дээр очоогүй,..." /24-р хх-ийн 196-200/ гэсэн,

Г.Н-ийн: «... “АЭБ» гэж компанийг ерөөсөө мэдэхгүй юм байна, тэгээд тэр гадаадад байгуулсан компанийг ч мэдэхгүй, манай ээж Ч.Ө энэ компанийг үүсгэн байгуулахтай ямар ч холбоогүй, энэ хүмүүстэй манай ээж холбоогүй, танил ч биш, манай ээж тэтгэвэрт байдаг хүн шүү дээ. С.Б, Д.Э нартай хамт ажиллаж байсан, Г.Чи-ыг даргын эхнэр мөн манай салбарын байгууллагад ажилладаг байсан гэдгээр нь мэднэ, тэр А-ыг танихгүй, анх удаа сонсож байна. Аж ахуйн нэгж байгуулаагүй, гадаадад компани байгуулах байтугай, дотооддоо ч ямар нэгэн компани байгуулаагүй. Д.Э-д ээжийнхээ бичиг баримтыг нэг удаа өгч байсан, гэхдээ компани байгуулах зорилгоор биш, хэзээ гэдгээ санахгүй байна, 2009, 2010

оны орчим байх, виз мэдүүлэх шалтгаанаар өгч байсан...» /24-р хх-ийн 247-250/ гэсэн,

“...Нэг өдөр Д.Э-тай үдийн цайны цагаар хоол идэж байхад тэрээр компаниудын сүлжээ, дистрибьютр байгуулвал боломжтой юм шиг байна гэсэн, тэгэхээр нь би чи хэлтэй юм чинь судлаж үзээч, төлөөлөгч болчихвол ашигтай юм биш үү гэж байсан, тэгээд хэсэг хугацааны дараа Д.Э “Зара”, нэрийг нь санахгүй байна, ангийн дэлгүүр, электрон тоног төхөөрөмж, хяналтын камер суурилуулдаг компаниудтай харьцлаа гэж байсан. Тэгээд дараа нь хариу ирэхдээ дандаа барьцаа хөрөнгө шаардлагатай байна, энэ нь 10.000 дээш ам.доллар байсан, тэгэхээр нь би боломжгүй юм байна даа гэж байсан, ингээд л энэ талаар өөр яриа хэлцэл бидний хооронд болж байгаагүй. Түүнээс биш “МС” компанийн талаар ямар ч яриа болж байгаагүй. “Эс” ХХК-тай холбогдож байгаагүй. Д.Э надаас мөнгө зээлэх талаар яриа болоогүй, дээр ярьсан зүйлс болсон.

Миний хувьд ээжийнхээ бичиг баримтыг М.Б, Д.Э нарт компани үүсгэн байгуулахаар өгөөгүй, харин Д.Э-ад БНСУ-ын визэнд ороход туслаач гэж өгсөн байсан. Учир нь визний мэдүүлэг бөглөх асуудлыг мэдэхгүй байсан...» /25-р хх-ийн 1-3/ гэсэн,

Шүүгдэгч С.Б-ийн «...Би юу ч мэдэхгүй, эхнэрийнхээ бичиг баримтыг хэнд ч өгөөгүй, тэр талаар мэдэхгүй, М.Б, Д.Э, Г.Н нараас шан харамж авч байгаагүй, Их Британи Виржиний арлуудад компани үүсгэн байгуулаагүй.

...Д.Э бидний хооронд мөнгө зээлэх, зээлүүлэх, банк нээх талаар юу ч яригдаж байгаагүй, эдгээр хүмүүстэй ийм асуудал ярьж байгаагүй, мэдэхгүй байна...» /25-р хх-ийн 35-40/ гэсэн,

Гэрч Г.Чи-ын: «...Би М.Б гэх хүнийг огт танихгүй, миний иргэний үнэмлэх болон гадаад паспортын хуулбарууд мөн байна, хорооны тодорхойлолт мөн байна. Гэхдээ би өөрөө биечлэн ямар нэгэн хүнд эдгээр бичиг баримтаа өгөөгүй, харин охин Г.Н-т он, сарыг нь санахгүй байна, БНСУ-ын Чезү аралд явахаар виз гаргуулахаар бичиг баримтуудаа өгч байсан удаатай, ер нь миний бичиг баримтууд, хуулбарууд охин Г.Н-т байх магадлалтай, охин Г.Н-ийн бичиг баримтын хуулбарууд мөн надад байдаг. Би Засаг захиргааны тусгай бүс Хонконг болон Их Британи Виржини арлуудад очиж үзээгүй, нэрийг нь ч сонсоогүй, харин Бээжин, Эрээн, Тайланд, БНСУ, ОХУ зэрэг улс орнууд руу

явж байсан. Би Г.Чи, М.Б, Д.Э гэх хүмүүсийг танихгүй, мэдэхгүй, Их Британи Виржини арлуудад “МСЛ” гэж компани үүсгэн байгуулаагүй...» /22-р хх-ийн 214-215/ гэсэн,

Г.Чи мөрдөн байцаалтын шатанд сэжигтнээр өгсөн мэдүүлэгтээ: «...Би өөрийн нэрээр Их Британи Виржиний арлуудад “МСЛ” гэх компанийн талаар огт мэдэхгүй, миний хувьд гадаад улсад компани үүсгэн байгуулсан асуудал байхгүй, би өөрийн бичиг баримтуудаа хүмүүст өгч байгаагүй, харин ИНЕГ-ын гадаад хэлтэст виз авах зорилгоор зарим бичиг баримтуудаа өгч байсан байх.

...Би М.Б-ыг “СХ” ОУБ-д ажиллаж байхыг нь мэднэ, гэхдээ М.Б-той үг ч сольж үзээгүй, яагаад миний бичиг баримт М.Б-ын цахим шууданд байгааг мэдэхгүй. Миний хувьд гадаадад аж ахуйн нэгж үүсгэн байгуулах гэж бичиг баримтаа түүнд болон бусад этгээдэд өгсөн асуудал байхгүй. Би тэр компани гэдгийг нь Монголд ч сонсож байгаагүй, гадаадад битгий хэл, монголд ч үүсгэн байгуулж байгаагүй. Би 32 жил сантехникийн инженер хийсэн хүн, би компани гэх “К” үсэг ч мэдэхгүй...” /25-р хх-ийн 75-77, 78-79/ гэсэн,

Гэрч Б.Мө-ийн: «...И-мэйлд хавсаргасан одоо надад үзүүлж буй бичиг баримтаас үзвэл «ЭС» ХХК нь “BRITISH VIRGIN ISLANDS” /Бритиш Виржин Айланд/-д хуулийн этгээд үүсгэн байгуулах хүсэлт тавьж, түүндээ туслуулахаар манай хуулийн фирмд хандаж байсан. “ЭС” ХХК-ийн захирал М.Б нь “BRITISH VIRGIN ISLANDS”-д хуулийн этгээд үүсгэн байгуулах туслалцаа хүсэж байсан. ...Би Г.Чи, Ч.Ө, Д.Э нартай биечлэн уулзаж байгаагүй. Харин М.Б нь энэ хүмүүсийнхээ материалыг надад авчирч өгч байсан. Би гадаад хүнтэй холбогдоод шаардлагатай бичиг баримтыг М.Б-оос авч орчуулагчаар орчуулуулж, нөгөө гадаад хүн рүү явуулж байсан. Харин хувийг нь М.Б-од явуулдаг нь М.Б Хонконг явахад нь хэрэгтэй байсан учраас л явуулсан байх.

...Надад үзүүлж буй OLN Corporate services гэсэн толгой бүхий Check list on Initial Setting up of a British Virgin Islands Company гэсэн гарчиг бүхий 5 нүүр материалтай танилцлаа. Уг материалыг OLN корпорациас и-мэйлээр ирүүлж компани үүсгэн байгуулахтай холбоотой мэдүүлүүдийг нөхөж бичих талаар дурдсан байсан. Ингээд үүний дагуу М.Б-оос мэдээллийг авч, 1 дэх хэсэг буюу боломжит 9 компанийн нэрс, 5 дугаар хэсэг буюу хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл, хувьцааны тоо, 6 дугаар хэсэг буюу захирлын талаарх мэдээлэл,

11 дэх хэсэг буюу бизнесийн чиглэл, 12 дахь хэсэг буюу харилцах банкны сонголт, үйлчилгээний хэлбэр, данснаас хэн гүйлгээ хийх зэрэг мэдээллийг нөхөж оруулж, М.Б-од өгсөн. Гадаадад үүсгэн байгуулах компанийн захирлаар нь Д.Э, хувьцаа эзэмшигчээр нь Г.Чи, Ч.Ө, М.Б, Д.Э нар болж байсан бөгөөд дээрх компани нь HSBC банкинд данс нээлгэхээр сонгож байсан. Данснаас Д.Э, М.Б нар хамтаар гүйлгээ хийх эрхтэй байхаар сонгож байсан. Миний одоо санаж байгаагаар Их Британи Виржини арлуудад компани үүсгэн байгуулах талаар Хонгконг дахь OLN компанитай харьцаж байсан юм байна.

Надад үзүүлж буй 22 хуудас Г.Чи, Ч.Ө, М.Б, Д.Э нарын оршин суугаа газрын тодорхойлолт, иргэний үнэмлэхийн хуулбар, англи дээрх орчуулга, гадаад паспортын хуулбар зэрэг баримт нь Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулах компанийн хувьцаа эзэмшигч нарын мэдээллийг OLN компаниас бүрдүүлж өг гэсний дагуу бүрдүүлсэн баримт байна.

...М.Б, Д.Э нар нь дээрх дурдсан цаг хугацаанд болон өөр хугацаанд Хонконг руу явсан эсэхийг мэдэхгүй байна. Цаанаас нь ирэх шаардлагатай болоод ир гэж байсан байлгүй дээ. Банкны данс нээхэд Хонконгт М.Б, Д.Э нар заавал очих шаардлагатай байсан байх. Миний хувьд нарийн асуудлыг нь сайн мэдэхгүй байна. Захирал Б.Б сайн мэдэх байх...» /22-р хх-ийн 143-147, 148-151/ гэсэн мэдүүлгүүд,

М.Б-ын электрон шууданд агуулагдаж буй мэдээлэлд үзлэг хийсэн тэмдэглэл /12-р хх-ийн 100-158/, 2012.01.12-ны өдрийн М.Б-ын оршин суух газрын тодорхойлолт англи орчуулгын хуулбарын хамт 2 хуудас, М.Б-ын УБ1027972 тоот иргэний үнэмлэхний хуулбар орчуулгын хуулбарын хамт 2 хуудас, 2012.01.012-ны өдрийн Д.Э-ын оршин суух газрын тодорхойлолт англи орчуулгын хуулбарын хамт 2 хуудас, Д.Э-ын УБ..... тоот иргэний үнэмлэхний хуулбар орчуулгын хуулбарын хамт 2 хуудас, Д.Э-ын Е..... тоот, М.Б-ын Е..... тоот, Ч.Ө-ны Е..... тоот, Г.Чи-ын Е..... тоот гадаад паспортын хуулбарууд /12-р хх-ийн 117-139/ зэрэг баримтууд, шүүхийн хэлэлцүүлэгт Г.Н, шүүгдэгч С.Б, М.Б, Д.Э нарын өгсөн мэдүүлгээр мөнгө угаах гэмт хэрэгт Г.Н, С.Б, Д.Э нар оролцоогүй, тэднийг энэ гэмт хэргийг үйлдсэн гэх хангалттай нотлох баримт хэрэгт авагдаагүй байх тул тэдэнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж

шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Харин шүүгдэгч М.Б нь “Эс” ХХК-ийн «Голомт» банкин дахь 110268xxxx тоот дансаар 1.062.959.200 төгрөгийг шилжүүлэн авч завшсан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөнийхөө хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор Их Британи Виржиний арлуудад /BRITISH VIRGIN ISLANDS/ “МСЛ” гэх нэр бүхий компанийг үүсгэн байгуулж, улмаар тус компанийн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-27041х-xxx тоот харилцах дансанд 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 150.000 ам.доллар шилжүүлж, улмаар “Эс” ХХК-ийн “Голомт” банкин дахь 110272xxxx тоот дансаар 2013 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 144.960 ам.долларыг буцаан хүлээн авсан,

“АЭБ” ХХК-ийн захирал Б.Б-гийн Их Британи Виржиний арлуудад /BRITISH VIRGIN ISLANDS/ үүсгэн байгуулсан “ТКЛ” компанийн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-2728х-xxx тоот харилцах дансанд 2012 оны 03 дугаар сарын 29-ний өдөр 155.000 ам.доллар шилжүүлж, улмаар 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 153.993 ам.доллар,

2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 39.968 ам.долларыг тус тус Ц.Б-гийн “Худалдаа хөгжлийн банк”-н дахь 45313xxxx тоот дансаар дамжуулан М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-н дахь 45102xxxx тоот дансаар буцаан хүлээн авсан,

“ТКЛ” компанийн HSBC банкин дахь 848-2728х-xxx тоот харилцах дансанд 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 202.500 ам.доллар шилжүүлж, улмаар 2012 оны 10 сарын 10-ны өдөр 199.993 ам.долларыг М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-н дахь 45102xxxx тоот дансаар тус тус буцааж, хүлээн авч, мөнгө угаасан гэмт хэргийг үйлдсэн болох нь мөрдөн байцаалтын шатанд өгсөн Ц.Б-гийн: “...Тус хуулийн компанид ажиллаж байхад буюу 2012 оны 04 дүгээр сард захирал Б.Б нь чиний дансанд мөнгө орж ирнэ, М.Б-той ярьж дансыг нь авч тэр мөнгийг шилжүүлээрэй гэсний дагуу 2012 оны 04 дүгээр сарын 04-нд 153.993 ам.доллар орж ирэхэд 2012 оны 04 дүгээр сарын 12-нд, 2012 оны 05 дугаар сарын 17-нд 39.968 ам.доллар орж ирснийг нь 2012 оны 05 дугаар

сарын 18-нд, нийт 193.961 ам.долларыг М.Б-ын «Худалдаа хөгжлийн банк»-ны 45102xxxx тоот дансанд бэлэн бусаар шууд шилжүүлсэн. Энэхүү гүйлгээ хийсэн хуулгыг хавтаст хэрэгт гараж өгсөн. Дээрх мөнгөнөөс би ямар нэгэн шан харамж, хөлс гэж аваагүй, удирдлагын өгсөн даалгаврын дагуу биелүүлсэн. Би уг компанид ажиллаж байсны хувьд авдаг цалингаа л авч байсан. Сүүлд миний дансаар орж ирсэн мөнгийг захирал Б.Б зээлийн мөнгө байсан гээд зээлийн гэрээнд гарын үсэг зуруулсан...» /24-р хх-ийн 218, 219/ гэсэн,

“...М.Б-ыг 2009 оноос хойш зүс мэднэ, тэрээр манай ажлаар захирал Б.Б-тай уулзах гэж ирдэг байсан. Б.Б захирлын найз гэж ойлгодог. Өөрөөр танихгүй, ямар нэгэн хувийн болон найз нөхдийн, хамаатан садангийн харьцаа холбоо байхгүй...» /24-р хх-ийн 221-225/ гэсэн хүсэлт, мэдүүлгүүд, шүүгдэгч М.Б-ын мөрдөн байцаалтын болон шүүхийн хэлэлцүүлэгт хэргээ хүлээн мэдүүлсэн мэдүүлгүүд, хэрэгт авагдсан М.Б-ын «Худалдаа хөгжлийн банк»-н дахь 45102xxxx дугаартай ам.долларын данс, “Эс” ХХК-ийн 110272xxxx дугаартай ам.долларын дансуудад үзлэг хийсэн тэмдэглэл, дансны хуулгууд /11-р хх-ийн 156-182/, 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 226.628.000 төгрөг нийт 1.062.959.200 төгрөгийг “Эс” ХХК-ийн дансанд шилжүүлсэн гүйлгээтэй холбоотой ИНЕГ-ын санхүүгийн баримтад үзлэг хийсэн тэмдэглэл, холбогдох баримтууд, мөнгөн шилжүүлэг /26-р хх-ийн 139-176/,

- “ТТББЭБ” ББСБ-с Д.Э 110 сая төгрөг зээлсэн тухай 2012.02.03-ны өдрийн №3Г2012/01 дугаартай зээлийн гэрээ, эх хувь /11-р хх-ийн 50-53/,

- “Эс” ХХК-с “ТТББЭБ” ББСБ-д Д.Э-ын авсан зээлийг төлсөн баримт эх хувь, мөн “Худалдаа хөгжлийн банк”-ны баримт эх хувь, “Голомт” банкны гадаад төлбөрийн даалгавар /11-р хх-ийн 54-56/,

- Ц.Б-гийн «Худалдаа хөгжлийн банк»-ны 45313xxxx тоот ам.долларын дансанд 2012.04.04-ний өдөр гадаад мөнгөн шилжүүлэг буюу свифт үйлчилгээгээр 154.001.95 ам доллар, 2012.05 сард 39.968.00 ам.доллар шилжин ирсэн,

- М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-ны 45102xxxx төгрөгийн дансаар гадаад мөнгөн шилжүүлгээр буюу свифт үйлчилгээгээр

2010.10.10-ны өдөр 199.993.00 ам.доллар хүлээн авсан талаарх лавлагаа авах тогтоол /7-р хх-ийн 109/,

- “Худалдаа хөгжлийн банк”-аас ирүүлсэн Ц.Б-гийн “Худалдаа хөгжлийн банк”-ны 45313xxxx тоот ам долларын дансанд 2012.04.03-ны өдөр 153.993.00 ам доллар, 2012.05.17-ны өдөр 39.968.00 ам долларын гадаад гүйлгээний баримт,

- М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-ны 45102xxxx тоот дансанд 2010.10.09-ний өдөр төгрөгийн гадаад гүйлгээний баримтууд /7-р хх-ийн 110-146/,

- “АЭБ” ХХК-ны байрнаас хураан авсан бичиг баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл / “Эс” ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрэм, 2012.01.09-ний өдрийн хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ/ /13-р хх-ийн 232-235, 26-р хх-ийн 80-96/ зэрэг бичгийн нотлох баримтуудаар нотлогдож байх тул шүүгдэгч М.Б-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166¹ дүгээр зүйлд зааснаар гэм буруутайд тооцож, эрүүгийн хариуцлага хүлээлгэх үндэслэлтэй гэж шүүх үзэв.

Гэхдээ Прокуророос шүүгдэгч М.Б-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасныг журамлан тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166^{1.3}-т заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг шүүгдэгч М.Б нь мөнгө угаах гэмт хэрэг үйлдсэний улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэж үзэж, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166^{1.2} болгон өөрчлөн зүйлчлэх нь зүйтэй байна. Учир нь: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166^{1.3} /2014 оны/-т “...хуулийн этгээд үйлдсэн...” гэж хуульчилжээ.

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 12 дугаар зүйлийн 12.2-т «Үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт шинээр тооцсон буюу оногдуулах ялыг хүндрүүлсэн, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй.» гэж заасан тул шүүгдэгч М.Б-од дээрх зүйл хэсгээр яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг хөнгөрүүлэн өөрчлөх нь зүйтэй гэж үзэв.

Г.Н-т Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан гэмт хэрэгт холбогдуулан,

Мөн Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах

дүгнэлт үйлдэж ирүүлсэн нь үндэслэлгүй байна. Учир нь: Г.Н нь 2010 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэл ИНЕГ-т санхүү, эдийн засгийн ерөнхий менежерээр ажилладаг байсан болох нь ИНЕГ-ын даргын 2010 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Б/122 тоот тушаал /5-р хх-ийн 216-218/, ажлын байрны тодорхойлолт /5-р хх-ийн 205-207/, ИНЕГ-ын даргын 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн Б/26 тоот ажлаас чөлөөлсөн тушаал, хавсралт /5-р хх-ийн 212-213/ зэргээр тогтоогдож байна.

Г.Н нь 2010 оны 05 дугаар сарын 10-ны өдрөөс 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийг хүртэлх хугацаад ИНЕГ-т санхүү, эдийн засгийн ерөнхий менежерээр ажиллаж байхдаа ИНЕГ нь “Эс” ХХК-тай байгуулсан «ЧХ» Олон улсын буудалд зорчигч бүртгэлийн операторын ажлыг гүйцэтгэх ИНЕГ/У/ ХББ/Б-04/12 тоот гэрээнд өөрийн эрхлэж байсан албан үүргийнхээ хувьд захиалагчийг төлөөлж, уг гэрээг хэлбэржүүлэхээр гуравдугаар гарын үсгийг ИНЕГ-ын Эдийн засгийн бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга Х.Б.Бо, Тамгын хэлтсийн ахлах мэргэжилтэн бөгөөд хуулийн зөвлөх З.Ту нарын хамт зурсан /26-р хх-ийн 145-160/, «гэрээт ажлын санхүүжилт» нэртэй төлбөрийн даалгавраар ИНЕГ-аас “Эс” ХХК-ийн данс руу 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 300.000.000 төгрөг нийт 1.062.959.200 төгрөг шилжүүлсэн баримтуудад огт гарын үсэг зурж байгаагүй, уг баримтуудад ИНЕГ-ын даргаар ажиллаж байсан С.Б, С.Бу, ерөнхий нягтлан бодогч Д.А нар зурж төлбөрийг шилжүүлж байсан /26-р хх-ийн 142, 162, 168, 174/ бөгөөд Г.Н-ийг ИНЕГ-ын түүнд хариуцуулсан эд хөрөнгийг С.Б, Д.Э, М.Б нартай бүлэглэн завшиж, үрэгдүүлэх зорилгоор гэрээнд гарын үсэг зурсан, гэрээт ажлын төлбөр гэх төлбөрийг шилжүүлсэн, мөн шүүгдэгч С.Б, Д.Э нартай бүлэглэн төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас хүнд хор уршиг учруулсан гэж үзэх үндэслэлгүй бөгөөд хэрэгт цугларсан нотлох баримтуудаар тогтоогдоогүй байх тул түүнд холбогдох хэргийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, цагаатгах хууль зүйн үндэслэлтэй гэж дүгнэлээ.

Шүүгдэгч С.Б, Д.Э нар нь албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаар урвуулан ИНЕГ-ын даргын 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/62 тоот тушаалаар ИНЕГ-ТББ/Б-73/11 тоот «Нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж, суурилуулах» ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог томилж /хэрэгт хавсаргах материал 1-р хавтасны 54-55/, улмаар Үнэлгээний хорооноос “А” ХХК-ийг сонгон шалгаруулж /хэрэгт хавсаргах материал 1-р хавтасны 56-57/, 2011 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс «Нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж, суурилуулах» ажил гүйцэтгэх 299.314.623 төгрөгийн гэрээг байгуулан /хэрэгт хавсаргах материал 1-р хавтасны 36-53/ “А” ХХК-аас ИНЕГ-аас томилогдсон ажлын хэсэгт 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр нийт 108 нэр төрлийн 172 ширхэг тоног төхөөрөмж, 9 нэр төрлийн 1 багц, 56 ширхэг програм, хангамжийн иж бүрдэл, зорчигч бүртгэлийн «vMUSE» системийг 3 жил ямар нэг төлбөргүй ашиглах лиценз, тэдгээр дээр ажиллах боловсон хүчнийг сургаж бэлтгэх ажлын хамт хүлээлгэн өгсөн байна /13-р хх-ийн 155, 156, 157-169, 26-р хх-ийн 116-138, хэрэгт хавсаргах материал 1-р хавтасны 16-35/.

Гэтэл ИНЕГ-ын даргын 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот «ЧХ» Олон улсын буудалд Зорчигч бүртгэлийн сүлжээний оператор»-ыг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог томилж /11-р хх-ийн 145, 71-126, хэрэгт хавсаргах материал 2-р хавтасны 17/, улмаар 2011 онд сонгон шалгаруулсан ИНЕГ-ТББ/Б-73/11 тоот тендерийн ялагч “А” ХХК-ийн урьд хийж гүйцэтгэсэн ажлыг дахин давхардуулсан байдлаар /26-р хх-ийн 125, 134, 138/ болон ИНЕГ-ын харьяа «ЧХ» олон улсын буудлын инженер, техникийн ажилчдын үндсэн чиг үүрэгт хамаарах, тэдгээрийн ажил үүргийн хуваарьт тусгагдсан, тэдгээрээр хийж гүйцэтгүүлэх боломжтой операторын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр “Эс” ХХК-ийг хууль бусаар сонгон шалгаруулсан.

Улмаар “Эс” ХХК-тай 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 3 жилийн хугацаанд “vMUSE» системээр бүртгүүлсэн зорчигч тутамд 4.000 төгрөгийн хураамж төлөх нөхцөл бүхий «ЧХ» Олон улсын буудалд зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулж, 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 300.000.000

төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 226.628.000 төгрөг нийт 1.062.959.200 төгрөгийг “Эс” ХХК-ийн дансанд шилжүүлж, ИНЕГ-т хүнд хор уршиг буюу 1.062.959.200 төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн болох нь хохирогч, иргэний нэхэмжлэгч П.А, Н.М, гэрч Б.Гб,

П.Ха, З.Ту, Ц.Га, Л.Эр, Ч.А, Г.Дө, Ц.Ц, П.Б, Ч.З, Д.Да, Я.Д нарын мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлгүүд, шүүгдэгч С.Б, Д.Э нарыг ажлаас чөлөөлсөн, ажилд томилсон ИНЕГ-ын даргын тушаал /5-р хх-ийн 208-215/, ажлын байрны тодорхойлолт, ИНЕГ-ын даргын 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/62 тоот, 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалууд, ИНЕГ, “А” ХХК-ийн хооронд байгуулсан болон ИНЕГ, “Эс” ХХК-ийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнүүд /11-р хх-ийн 34-49/, ИНЕГ-ын үндсэн хөрөнгийн 2012 оны баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл, үзлэгээр бэхжүүлж авсан 2012.04.19-ний өдрийн “А” ХХК-аас ИНЕГ-т тоног төхөөрөмж, программ хангамж хүлээлгэн өгсөн, хүлээн авсан тухай акт /26-р хх-ийн 116-138/, ИНЕГ-ыг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Бу-ын баталсан удирдамжийн дагуу санхүүгийн хэсэгчилсэн хяналт шалгалт хийсэн тайлан /1-р хх-ийн 24-31/, “Эс” ХХК-ийн 2011.12.27-ны өдрийн №5/41 тоот ИНЕГ-ын дарга С.Б-ийн нэр дээр ирүүлсэн албан бичиг, уг албан бичгийн хавсралт болох ажил үйлчилгээ үзүүлэх тухай гэрээний загвар /11-р хх-ийн 21-33/, ИНЕГ-ын 2012.01.26-ны өдрийн №07/229 тоот «С» компанид хүргүүлсэн албан тоот, «С» компаниас 2012.12.08-ны өдөр ИНЕГ-т хүргүүлсэн тендерийн лавлагаа авах тухай албан бичиг /22-р хх-ийн 124, 125/, ИНЕГ-ын даргын 2012 оны тушаалуудад үзлэг хийсэн тэмдэглэл болон үзлэгээр бэхжүүлж авсан ИНЕГ-ын даргын 2012.11.08-ны өдрийн №А/377 тоот «Орон тоонд өөрчлөлт оруулах тухай» тушаал болон ИНЕГ-ын даргаын зөвлөлийн хурлын шийдвэрийн хуулбар /26-р хх-ийн 97-114/, «ЧХ» Олон улсын нисэх буудлын инженер, техникийн ажилчдын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь /6-р хх-ийн 1-45/, Сангийн яамны мэргэжилтэн Х.Э-ийн гаргасан дүгнэлт /6-р хх-ийн 80-83/, шинжээчийг байцаасан тэмдэглэл /6-р хх-ийн 84-87/ зэрэг бичгийн нотлох баримтуудаар,

Шүүгдэгч С.Б, М.Б, Д.Э нар нь “Эс” ХХК-ийн «Голомт» банкин дахь 110268xxxx тоот дансанд ИНЕГ-аас гэрээт ажлын төлбөр гэх үндэслэлээр 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр шилжүүлсэн 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр шилжүүлсэн 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр шилжүүлсэн 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр шилжүүлсэн 226.628.000 төгрөг нийт 1.062.959.200 төгрөгийг завшиж, ИНЕГ-т онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг үйлдсэн болох нь хохирогч, иргэний нэхэмжлэгч П.А, Н.М-гийн болон С.Бу-гийн мөрдөн байцаалтын шатанд сэжигтнээр өгсөн мэдүүлэг /26-р хх-ийн 235-237/, төлбөрийн даалгавар, нэхэмжлэх, гэрээт ажлын төлбөр тооцох хуудас /26-р хх-ийн 142, 143-144, 162, 163, 164, 166, 168, 169, 171, 174, 175/ зэрэг хэрэгт авагдсан бичгийн бусад нотлох баримтуудаар,

Шүүгдэгч М.Б нь “Эс” ХХК-ийн «Голомт» банкин дахь 110268xxxx тоот дансаар шилжүүлэн авч завшсан буюу Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөнийхөө хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор “Эс” ХХК-ийн захирал М.Б нь Их Британи Виржиний арлуудад / BRITISH VIRGIN ISLANDS / “МСЛ” гэх нэр бүхий компанийг үүсгэн байгуулж, улмаар « МСЛ » компанийн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-27041х-xxx тоот харилцах дансанд 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 150.000 ам.доллар шилжүүлж улмаар “Эс” ХХК-ийн «Голомт» банкин дахь 110272xxxx тоот дансаар 2013 оны 02 сарын 05-ны өдөр 144.960 ам.долларыг буцаан хүлээн авсан,

“АЭБ” ХХК-ийн захирал Б.Б-гийн Их Британи Виржиний арлуудад /BRITISH VIRGIN ISLANDS/ үүсгэн байгуулсан “ТКЛ” компанийн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-2728х-xxx тоот харилцах дансанд 2012 оны 03 дугаар сарын 29-ний өдөр 155.000 ам.доллар шилжүүлж улмаар, 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 153.993 ам.доллар,

2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 39.968 ам.долларыг тус тус Ц.Б-гийн “Худалдаа хөгжлийн банк”-н дахь 45313xxxx тоот дансаар дамжуулан М.Б-ын “Худалдаа

хөгжлийн банк”-н дахь 45102xxxx тоот дансаар буцаан хүлээн авсан,

“ТКЛ” компанийн HSBC банкин дахь 848-2728х-xxx тоот харилцах дансанд 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 202.500 ам.доллар шилжүүлж, улмаар 2012 оны 10 сарын 10-ны өдөр 199.993 ам.долларыг М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-ин дахь 45102xxxx тоот дансаар тус тус М.Б буцаан хүлээн авч мөнгө угаасан гэмт хэргийг үйлдсэн болох нь шүүгдэгч М.Б-ын шүүхийн хэлэлцүүлэгт болон мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэг /24-р хх-ийн 165-171, 175-179/, гэрч Б.Мө-ийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэг /22-р хх-ийн 143-147, 148-151/, М.Б-ын электрон шууданд агуулагдаж буй мэдээлэлд үзлэг хийсэн тэмдэглэл /12-р хх-ийн 100-158/, гэрч П.Эц, /22-р хх-ийн 182-184, 189/, Ч.Хо /22-р хх-ийн 189/ нарын мэдүүлэг, мөрдөн байцаалтын шатанд Ц.Б-гийн сэжигтнээр өгсөн мэдүүлэг, хүсэлт /24-р хх-ийн 218, 219/, “ТББЭС” ББСБ-аас Д.Э 110 сая төгрөг зээлсэн тухай зээлийн гэрээ /11-р хх-ийн 50-53/, “Эс” ХХК-аас уг зээлийг буцаан төлсөн баримт /11-р хх-ийн 54-56/, шүүгдэгч М.Б-ын мөрдөн байцаалтын болон шүүхийн хэлэлцүүлэгт хэргээ хүлээн мэдүүлсэн мэдүүлгүүд, хэрэгт авагдсан М.Б-ын «Худалдаа хөгжлийн банк»-н дахь 45102xxxx дугаартай ам.долларын данс, “Эс” ХХК-ийн 110272xxxx дугаартай ам.долларын дансуудад үзлэг хийсэн тэмдэглэл, дансны хуулгууд /11-р хх-ийн 156-182/,

2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 226.628.000 төгрөг нийт 1.062.959.200 төгрөгийг “Эс” ХХК-ийн дансанд шилжүүлсэн гүйлгээтэй холбоотой ИНЕГ-ын санхүүгийн баримтад үзлэг хийсэн тэмдэглэл, холбогдох баримтууд, мөнгөн шилжүүлэг /26-р хх-ийн 139-176/,

“ТББЭБ” ББСБ-с Д.Э 110 сая төгрөг зээлсэн тухай 2012.02.03-ны өдрийн №3Г2012/01 дугаартай зээлийн гэрээ, эх хувь /11-р хх-ийн 50-53/,

“Эс” ХХК-с “Т т Б Б Э Б” ББСБ-д Д.Э-ын авсан зээлийг төлсөн баримт эх хувь, мөн “Худалдаа хөгжлийн банк”-ны баримт эх хувь, “Голомт” банкны гадаад төлбөрийн даалгавар /11-р хх-ийн 54-56/,

Ц.Б-гийн «Худалдаа хөгжлийн банк»-ны 45313xxxx тоот ам.долларын дансанд

2012.04.04-ний өдөр гадаад мөнгөн шилжүүлэг буюу свифт үйлчилгээгээр 154.001.95 ам доллар, 2012.05 сард 39.968.00 ам.доллар шилжин ирсэн,

-М.Б-ын "Худалдаа хөгжлийн банк"-ны 45102xxxx төгрөгийн дансаар гадаад мөнгөн шилжүүлгээр буюу свифт үйлчилгээгээр 2010.10.10-ны өдөр 199.993.00 ам.доллар хүлээн авсан талаарх лавлагаа авах тогтоол /7-р хх-ийн 109/,

-"Худалдаа хөгжлийн банк"-аас ирүүлсэн Ц.Б-гийн "Худалдаа хөгжлийн банк"-ны 45313xxxx тоот ам долларын дансанд 2012.04.03-ны өдөр 153.993.00 ам доллар, 2012.05.17-ны өдөр 39.968.00 ам долларын гадаад гүйлгээний баримт,

-М.Б-ын "Худалдаа хөгжлийн банк"-ны 45102xxxx тоот дансанд 2010.10.09-ний өдөр ... төгрөгийн гадаад гүйлгээний баримтууд /7-р хх-ийн 110-146/,

-"АЭБ" ХХК-ны байрнаас хураан авсан бичиг баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл / "Эс" ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрэм,

-2012.01.09-ний өдрийн хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ /13-р хх-ийн 232-235, 26-р хх-ийн 80-96/ зэрэг хэрэгт авагдсан бичгийн бусад нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдож байна гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэлээ.

Шүүгдэгч нарыг сэжигтэн, яллагдагчаар, хохирогч, гэрч, иргэний нэхэмжлэгч нарыг байцаахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 144, 146, 147 дугаар зүйлд заасан хуулийн шаардлага хангасан, нотлох баримтууд нь тухайн хэрэгт хамааралтай, агуулгын хувьд зөрүүгүй, үйл баримтыг хангалттай тогтоож чадсан, Сангийн яамны хууль худалдан авах ажиллагааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн Х.Э-г шинжээчээр томилсон тогтоол, уг шинжээчийн дүгнэлтийг хэрэгт хувийн сонирхолгүй, зохих мэдлэг, дадлага туршлагатай, гаргасан дүгнэлтийнхээ хариуцлагыг хүлээх чадвар бүхий шинжээч гаргасан байх тул хууль ёсны үнэн зөв баримтууд гэж үнэлэв.

Шүүгдэгч С.Б, М.Б, Д.Э нар урьд ял шийтгүүлж байгаагүй болох нь 3 дугаар хавтасны 147, 148, 149, 150 дугаар талд авагдсан тэдний ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудсуудаар тогтоогдож байна.

ИНЕГ-аас шүүгдэгч С.Б нарт холбогдох 201301000179 тоот эрүүгийн хэрэгт хохирогч, иргэний нэхэмжлэгчээр тус байгууллагын хуулийн хэлтсийн дарга П.А, Хяналт

шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын тасгийн дарга Н.М нарыг томилж ирүүлсэн /22-р хавтас 48/ нь хохирогч байгууллагыг бүрэн Эрүүгийн байцаан шийтгэх хууль зөрчөөгүй байна.

Гэмт хэргийн улмаас ИНЕГ-т нийтдээ 1.062.959.200 төгрөгийн хохирол учирсан болох нь 26 дугаар хавтасны 142, 162, 168, 174 дүгээр талуудад төлбөрийн даалгавруудаар тогтоогдсон бөгөөд 174 дүгээр талд авагдсан төлбөрийн даалгавраар «Эс» ХХК-ийн данс руу 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр С.Бу, Д.А нар гарын үсэг зурж шилжүүлсэн байх тул энэ мөнгийг нийт 1.062.959.200 төгрөгөөс хасаж тооцон, үлдэх 836.331.200 /найман зуун гучин зургаан мянга, гурван зуун гучин нэгэн мянга хоёр зуу/ төгрөгийг С.Б, М.Б, Д.Э нараас хувь тэнцүүлэн хуваан гаргуулж, ИНЕГ /хохирогч, иргэний нэхэмжлэгч П.А, Н.М нарт/-т олгох нь зүйтэй.

Шүүдэгч С.Б, М.Б, Д.Э нарт ял шийтгэл оногдуулахдаа анх удаа гэмт хэрэг үйлдсэнийг ял хөнгөрүүлэх нөхцөл байдалд тооцож, бүлэглэж гэмт хэрэг үйлдсэнийг, гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо төлөөгүй зэргийг ял хүндрүүлэх нөхцөл байдалд тус тус тооцлоо.

Шүүгдэгч С.Б нь 2013 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2013 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийг хүртэл /24-р хх-ийн 85-87, 113-114/ нийт 71 /далан нэг/ хоног цагдан хоригдсон,

Шүүгдэгч М.Б нь 2013 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 2013 оны 10 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл /23-р хх-ийн 215-216, 246-247/ нийт 121 /нэг зуун хорин нэг/ хоног цагдан хоригдсон,

Шүүгдэгч Д.Э нь 2013 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 2013 оны 10 дугаар сарын 04-ний өдрийг хүртэл /24-р хх-ийн 3-4, 40-41/ нийт 121 /нэг зуун хорин нэг/ хоног цагдан хоригдсон бөгөөд тэдний урьдчилан цагдан хоригдсон хоногийг ял эдэлсэн хугацаанд нь оруулан тооцож шийдвэрлэв.

Г.Н нь энэ хэрэгт 2013 оны 09 дүгээр сарын 05-ны өдрөөс 2013 оны 10 дугаар сарын 16-ны өдрийг хүртэл /24-р хх-ийн 62-64, 75-76/ нийт 41 хоног цагдан хоригдсон болохыг дурдах нь зүйтэй.

Шүүгдэгч С.Б, М.Б, Д.Э нарын үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, шүүгдэгч нарын хувийн байдал, эрүүл мэндийн байдал, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдлыг харгалзан ял шийтгэл оногдуулах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Шүүгдэгч С.Б, М.Б, Д.Э нарт эд хөрөнгө хураах нэмэгдэл ял хэрэглэхдээ шүүгдэгч нарын өөрсдийнх нь тээврийн хэрэгслүүдийг хурааж улсын орлого болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Эрүүгийн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан эд зүйлгүй ба шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц хэргийн хамт ирүүлсэн нисэх буудлын бүртгэл хяналтын цогц систем нийлүүлж суурилуулах ИНЕГ-ТББ/Б-73/11 тоот тендерийн баримт бичгийн хуулбар 1-287 хүртэл дугаарласан 1 хавтас материал,

“ЧХ” Олон улсын буудлын зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгэх ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот тендерийн баримт бичгийн хуулбар 1-288 хүртэл дугаарласан 1 хавтас материалыг хэрэгт үлдээж, шүүгдэгч С.Б-ийн Е-00973хх дугаарын гадаад паспорт 1 ширхэг, Д-00067хх дугаарын дипломат паспорт 1 ширхэг, цагаатгагдсан этгээд Г.Н-ийн Е-00271хх дугаарын гадаад паспорт 1 ширхэг, А-00244хх дугаарын албан паспорт 1 ширхэг, шүүгдэгч Д.Э-ын А-00229хх дугаарын албан паспорт 1 ширхэг, шүүгдэгч М.Б-ын Е-04051хх дугаарын гадаад паспорт 1 ширхгийг шүүгдэгч, цагаатгагдсан этгээд нарт буцаан олгох,

“АЭБ” ХХК-ны Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг ...дугаар хороо “Ме” төвийн ...дугаар давхарт байрлах оффисын байранд хийсэн нэгжлэгээр хураагдсан М.Х, С.Ц нарын ашиглаж байсан процессор тус бүр 1 ширхэг буюу нийт 2 «Хас» банкин дахь Нийслэлийн Прокурорын газрын 500071хххх тоот дансанд 9700 ам.доллар, тус банкны 500071хххх тоот дансанд 4500 юань байгааг шүүгдэгч С.Б-өд буцаан олгох /12-р хх-ийн 159-165, 15-р хх-ийн 208-209/,

Эд хөрөнгө битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгож, битүүмжлэгдсэн байгаа эд хөрөнгө болох шүүгдэгч М.Б-ын Хан-Уул дүүргийн .. дугаар хороо, ...тоот орон сууц /3-р хх-ийн 160/,

Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, .. тоот зогсоол /3-р хх-ийн 160/

Шүүгдэгч Д.Э-ын Баянзүрх дүүргийн ...дугаар хороо ...дугаар хороолол, ...тоот орон сууц, /6-р хх-ийн 183/,

Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...дугаар хороолол, ...тоот орон сууц /3-р хх-ийн 186/,

Шүүгдэгч С.Б-ийн Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо, ...орон сууц /3-р хх-ийн 162/,

Нийслэлийн Засаг даргын 2004 оны хорооны нутаг дэвсгэрт амины орон сууцны 250 м.кв газар эзэмших эрх /3-р хх-ийн 167/, “Г” ХК-ийн 54 ширхэг хувьцаа, “Цн” ХК-ийн 24 ширхэг хувьцаа. /3-р хх-ийн 171/,

Цагаатгагдсан этгээд Г.Н-ийн Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууц зэргийг битүүмжлэлээс чөлөөлж, хууль ёсны эзэмшигч нарт буцаан олгож шийдвэрлэх нь зүйтэй.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248 дугаар зүйлийн 248.1.1, 246 дугаар зүйлийн 246.2, 283, 286, 294, 295, 296, 297 дугаар зүйлийн 297.1.1-297.1.4, 297.6, 298, 299 дүгээр зүйлийн 299.3-т тус тус заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас Г.Н-т Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож, Г.Н-ийг цагаатгасгай.

2. Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас С.Б-өд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасныг журамлан тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг,

Мөн Прокурорын газраас Д.Э-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг тус тус Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгосугай.

3. Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас М.Б-од Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасныг журамлан тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.2 болгон хөнгөрүүлэн зүйлчилсүгэй.

4. Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас шүүгдэгч С.Б, Д.Э, М.Б нарт Эрүүгийн хуулийн

ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг шүүгдэгч С.Б, Д.Э, М.Б нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар гэж,

Мөн Прокурорын газраас шүүгдэгч С.Б, Д.Э нарт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг шүүгдэгч С.Б, Д.Э нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар гэж тус тус өөрчилсүгэй.

5. Шүүгдэгч С.Б, Д.Э нар нь бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэж үйлдсэний улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг,

Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд,

Шүүгдэгч М.Б-ыг бүлэглэж бусдын эд хөрөнгийг завшиж, онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг,

Мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэний улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг тус тус үйлдсэн гэм буруутайд тооцсугай.

6. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар шүүгдэгч С.Б-ийн эд хөрөнгө болох хх-хх УНЭ улсын дугаартай, JTBHV05J04094xxxx арлын дугаартай, Toyota Land Cruiser-200 маркийн автомашиныг хурааж, 5 /тав/ жил 6 /зургаа/ сарын хугацаагаар хорих,

Шүүгдэгч Д.Э-ын эд хөрөнгө болох хх-хх УНЗ улсын дугаартай, RZN185904xxxx арлын дугаартай, Toyota Hilux маркийн автомашиныг хурааж, 5 /тав/ жил 6 /зургаа/ сарын хугацаагаар хорих,

Шүүгдэгч М.Б-ын эд хөрөнгө болох хх-хх УБК улсын дугаартай, 5GTDN1365681xxxx арлын дугаартай, Hummer H3 маркийн автомашиныг хурааж, 5 жил 6 сарын хугацаагаар хорих,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар шүүгдэгч С.Б, Д.Э нарыг төрийн албанд ажиллах эрхийг тус бүр 2 /хоёр/ жилийн хугацаагаар хасаж, тус бүр 2 /хоёр/ жилийн хорих ял,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.2-т зааснаар шүүгдэгч М.Б-д 6 /зургаа/ жилийн хугацаагаар хорих ял тус тус шийтгэсүгэй.

7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57

дугаар зүйлийн 57.1-д зааснаар шүүгдэгч С.Б-ийн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар оногдуулсан хх-хх УНЭ улсын дугаартай, JTBHV05J04094xxxx арлын дугаартай, Toyota Land Cruiser-200 маркийн автомашиныг хурааж, 5 жил 6 сарын хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар оногдуулсан төрийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 2 жилийн хорих ялын зарим болох 1 /нэг/ жилийн хорих ялыг нэмж нэгтгэн түүний нийт биечлэн эдлэх ялыг хх-хх УНЭ улсын дугаартай, JTBHV05J04094xxxx арлын дугаартай, Toyota Land Cruiser-200 маркийн автомашиныг хурааж, төрийн албанд ажиллах эрхийг 2 /хоёр/ жилийн хугацаагаар хасаж, 6 /зургаа/ жил 6 /зургаа/ сарын хугацаагаар хорих ялаар,

шүүгдэгч Д.Э-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар оногдуулсан хх-хх УНЗ улсын дугаартай, RZN185904xxxx арлын дугаартай, Toyota Hilux маркийн автомашиныг хурааж, 5 жил 6 сарын хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар оногдуулсан төрийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 2 жилийн хорих ялын зарим болох 1 /нэг/ жилийн хорих ялыг нэмж нэгтгэн түүний нийт биечлэн эдлэх ялыг хх-хх УНЗ улсын дугаартай, RZN185904xxxx арлын дугаартай, Toyota Hilux маркийн автомашиныг хурааж, төрийн албанд ажиллах эрхийг 2 /хоёр/ жилийн хугацаагаар хасаж, 6 /зургаа/ жил 6 /зургаа/ сарын хугацаагаар хорих ялаар,

шүүгдэгч М.Б-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.2-т зааснаар оногдуулсан 6 жилийн хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар оногдуулсан 5 жил 6 сарын хорих ялын зарим болох 1 /нэг/ жилийн хорих ялыг нэмж нэгтгэн нийт биечлэн эдлэх ялыг хх-хх УБК улсын дугаартай, 5GTDN1365681xxxx арлын дугаартай, Hummer H3 маркийн автомашиныг хурааж, 7 /долоо/ жилийн хугацаагаар хорих ялаар тус тус тогтоосугай.

8. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6-д зааснаар шүүгдэгч С.Б, М.Б, Д.Э нарт оногдуулсан хорих ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлсүгэй.

9. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1-д зааснаар шүүгдэгч С.Б-

ийн цагдан хоригдсон 71 /далан нэг/ хоногийг, шүүгдэгч М.Б, Д.Э нарын тус бүр цагдан хоригдсон 121 /нэг зуун хорин нэг/ хоногийг тэдний тус тусын ял эдэлсэн хугацаанд нь оруулан тооцож, Г.Н энэ хэрэгт урьдчилан 41 /дөчин нэг/ хоног цагдан хоригдсон болохыг дурдсугай.

10. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар хэрэгт хураагдаж ирүүлсэн С.Б-ийн Е-..... дугаарын гадаад паспорт 1 ширхэг, Д-..... дугаарын дипломат паспорт 1 ширхэг, Г.Н-ийн Е-..... дугаарын гадаад паспорт 1 ширхэг, А-..... дугаарын албан паспорт 1 ширхэг, Д.Э-ын А-..... дугаарын албан паспорт 1 ширхэг, М.Б-ын Е-..... дугаарын гадаад паспорт 1 ширхэгийг С.Б, Г.Н, Д.Э, М.Б нарт буцаан олгож,

“АЭБ” ХХК-ийн Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг ...дугаар хороо ...давхарт байрлах оффисын байранд хийсэн нэгжлэгээр хураагдсан М.Х, С.Ц нарын ашиглаж байсан процессор тус бүр 1 ширхэг, нийт 2 ширхэг Нисэх буудлын бүртгэл хяналтын цогц систем нийлүүлж суурилуулах ИНЕГ-ТББ/Б-73/11 тоот тендерийн баримт бичгийн хуулбар 1-287 хүртэл дугаарласан 1 хавтас материал, «ЧХ» Олон улсын буудлын зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгэх ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот тендерийн баримт бичгийн хуулбар 1-288 хүртэл дугаарласан 1 хавтас материалыг хэрэгт үлдээсүгэй.

12. Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар шүүгдэгч С.Б, Д.Э, М.Б нараас тус бүр 278.777.066 /хоёр зуун далан найман сая долоон зуун далан долоон мянга, жаран зургаа/ төгрөг гаргуулж Иргэний Нисэхийн Ерөнхий газар /хоширогч, иргэний нэхэмжлэгч П.А, Н.М нар/-т олгосугай.

Эрүүгийн 20130100017. тоот хэрэгт битүүмжилсэн шүүгдэгч С.Б-ийн эд хөрөнгө болох Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо, ...тоот орон сууц 250 м2 газар эзэмших эрх, Г ХК-ийн 54 ширхэг хувьцаа, Ц ХК-ийн 24 ширхэг хувьцаа,

Шүүгдэгч Д.Э-ын эд хөрөнгө болох Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...орон сууц,

Шүүгдэгч М.Б-ын эд хөрөнгө болох Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууц,

Г.Н-ийн эд хөрөнгө болох Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууц зэргийг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц тус тус битүүмжлэлээс чөлөөлж, хууль ёсны эзэмшигч нарт буцаан олгож, «Хас» банкин дахь Нийслэлийн Прокурорын газрын 500071xxxx дугаартай дансанд байгаа 9700 /есөн мянга долоон зуу/ ам.долларыг, 500071xxxx дугаартай дансанд байгаа 4500 /дөрвөн мянга таван зуу/ юанийг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц С.Б-д буцаан олгосугай.

13. Шийтгэх тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд шүүгдэгч С.Б, М.Б, Д.Э нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, цагдан хорьж, тэдний эдлэх ялыг 2014 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн тоолсугай.

14. Г.Н-т урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгосугай.

15. Шийтгэх тогтоолыг цагаатгагдсан этгээд болон ялтан нар, тэдгээрийн өмгөөлөгчид, хохирогч, иргэний нэхэмжлэгч нар эс зөвшөөрвөл тогтоолыг гардуулснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг тайлбарласугай.

16. Шийтгэх тогтоолд эрх бүхий этгээд давж заалдах гомдол гаргасан, эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол хүчин төгөлдөр болох хүртэл шүүгдэгч С.Б, М.Б, Д.Э нарт авсан цагдан хорих таслан сэргийлэх, Г.Н-т авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хэвээр үргэлжлүүлэхийг мэдэгдсүгэй.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ
ШҮҮГЧИД

Д.АЛТАНЖИГҮҮР
Г.АЛТАНЦЭЦЭГ
Л.БААТАР

МАГАДЛАЛ

2014 оны 11 сарын 04 өдөр

Дугаар 958

Улаанбаатар хот

С.Б, М.Б, Д.Э, Г.Н нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч Ш.Бат-Эрдэнэ даргалж, шүүгч С.Соёмбо-Эрдэнэ, Ц.Оч нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанд: прокурор Н.Амарсанаа, Р.Очирсүрэн,

ялтан С.Б-ийн өмгөөлөгч Ж.Батхүү, Ж.Эрдэнэбулган,
ялтан М.Б-ын өмгөөлөгч Х.Цогтсайхан,
ялтан Д.Э-ын өмгөөлөгч Д.Батбаатар, К.Бауиржан, М.Хувцагаан,
хохирогч, иргэний нэхэмжлэгч Иргэний нисэхийн ерөнхий газрын төлөөлөгч П.А, Н.М,
Т.Б, нарийн бичгийн дарга Э.Энххэрлэн нарыг оролцуулж,

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгч Д.Алтанжигүүр даргалж, шүүгч Г.Алтанцэцэг, Л.Баатар нарын бүрэлдэхүүнтэй хийсэн шүүх хуралдааны 2014 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 1025 дугаар шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч ялтан С.Б, түүний өмгөөлөгч Ж.Батхүү, Ж.Эрдэнэбулган, ялтан М.Б, түүний өмгөөлөгч Х.Цогтсайхан, ялтан Д.Э, түүний өмгөөлөгч Д.Батбаатар, К.Бауиржан, М.Хувцагаан нарын гаргасан гомдлуудаар С.Б, М.Б, Д.Э, Г.Н нарт холбогдох 20130100017. дугаартай хэргийг 2014 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр хүлээн авч, шүүгч Ц.Очийн илтгэснээр хянан хэлэлцэв.

1. С овогт С.Б, ...оны ...дүгээр сарын ...-ний өдөр Төв аймагт төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, нисгэгч мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Иргэний Нисэхийн Ерөнхий газарт дарга ажилтай байсан, одоо эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл ..., эхнэр хүүхдийн хамт, Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /РД: ВЭ...../,

2. С овогт М.Б, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Говь-Алтай аймагт төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, электроникийн инженер мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ “Эс” ХХК-д гүйцэтгэх захирал ажилтай, “ЧХ” Олон улсын нисэх буудлын Программ сүлжээний инженерээр ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /РД: ДБ...../,

3. У овогт Д.Э, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, агаарын тээврийн менежментийн мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ Зам

тээврийн яамны агаарын тээврийн бодлого хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга ажилтай, ИНЕГазрын Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежер, газрын даргаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр хүүхдүүдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суудаг, ял шийтгэлгүй /РД: ШЕ...../,

4. Г овогт Г.Н, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Дархан-Уул аймагт төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч, нягтлан бодогч мэргэжилтэй, хэрэгт холбогдох үедээ “Х-Э” ХХК-д дэд захирал ажилтай, ИНЕГазрын Санхүү эдийн засгийн ерөнхий менежерээр ажиллаж байсан, ам бүл 6, нөхөр хүүхдүүдийн хамт Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /РД: ЧП/.

- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Б, санхүү, эдийн засгийн ерөнхий менежерээр ажиллаж байсан Г.Н, Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежер, газрын даргаар ажиллаж байсан Д.Э нар нь:

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Б-ийн 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/262 тоот тушаалаар ИНЕГ-ТББ/Б-73/11 тоот «Нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж, суурилуулах» ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог томилж, улмаар Үнэлгээний хорооноос «А» /274xxxx/ ХХК-ийн сонгон шалгаруулж, 2011 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс «Нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж, суурилуулах» ажил гүйцэтгэх 299.314.623 төгрөгийн гэрээг байгуулан “А” ХХК-аас «ЧХ» Олон улсын буудлаас томилогдсон ажлын хэсэгт 2012

оны 04 дүгээр сарын 19-ний өдөр нийт 108 нэр төрлийн 172 ширхэг тоног төхөөрөмж, 9 нэр төрлийн 1 багц, 56 ширхэг программ хангамжийн иж бүрдэл, түүнчлэн зорчигч бүртгэлийн “vMUSE « системийг 3 жил төлбөргүй ашиглах лиценз, тэдгээр дээр ажиллах боловсон хүчнийг сургаж бэлтгэх ажлын хамт хүлээлгэн өгсөн байна.

Гэтэл ИНЕГ-ын даргаар ажиллаж байсан С.Б-ийн 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны 2012 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот «ЧХ Олон улсын буудалд Зорчигч бүртгэлийн сүлжээний оператор»-ыг сонгон шалгаруулах ИНЕГ-ын Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежер Д.Э-аар ахлуулсан Үнэлгээний хороог томилж, улмаар 2011 онд сонгон шалгаруулсан ИНЕГ-ТББ/Б-73/11 тоот тендерийн ялагч “А” ХХК-ийн урьд хийж гүйцэтгэсэн ажлыг дахин давхардуулсан байдлаар болон ИНЕГ-ын харьяа «ЧХ» Олон улсын буудлын инженер, техникийн ажилчдын үндсэн чиг үүрэгт хамаарах, тэдгээрийн ажил үүргийн хуваарьт тусгагдсан, тэдгээрээр хийж гүйцэтгүүлэх боломжтой «Оператор»-ын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр “Эс”/278xxxx/ ХХК-ийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 9 дүгээр зүйлийн 9.2-т заасныг тус тус зөрчин хууль бусаар сонгон шалгаруулсан байна.

Улмаар “Эс” ХХК-тай 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 3 жилийн хугацаанд “vMUSE» системээр бүртгүүлсэн зорчигч тутамд 4.000 төгрөгийн хураамж төлөх нөхцөл бүхий «ЧХ» Олон улсын буудалд зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулж, 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 9-ний өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 226.628.000 төгрөг, нийт 1.062.959.200 төгрөгийг албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаар урвуулан ашиглаж “Эс” ХХК-ийн дансанд шилжүүлж, улсад хүнд хор уршиг буюу 1.062.959.200 төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан,

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Б, “Эс” ХХК-ийн захирал М.Б, ИНЕГ-ын Санхүүгийн ерөнхий

менежерээр ажиллаж байсан Г.Н, Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежерээр ажиллаж байсан Д.Э нар нь бүлэглэн “Эс” ХХК-ийн «Голомт» банкин дахь 110268xxxx тоот дансанд ИНЕГ-аас гэрээт ажлын төлбөр гэх үндэслэлээр 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр шилжүүлсэн 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр шилжүүлсэн 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр шилжүүлсэн 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр шилжүүлсэн 226.628.000 төгрөг, нийт 1.062.959.200 төгрөгийг завшиж улсад онц их хэмжээний хохирол учруулсан.

- Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Б, “Эс” ХХК-ийн захирал М.Б, ИНЕГ-ын Санхүүгийн ерөнхий менежерээр ажиллаж байсан Г.Н, Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежерээр ажиллаж байсан Д.Э нар нь “Эс” ХХК-ийн “Голомт” банкин дахь 110268xxxx тоот дансаар шилжүүлэн авч завшсан буюу Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан хүнд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөнийхөө хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор, бүлэглэн ИНЕГ-ын даргаар ажиллаж байсан С.Б-ийн эхнэр Г.Чи, тус газрын санхүүгийн ерөнхий менежерээр ажиллаж байсан Г.Н-ийн ээж Ч.Ө, тус газрын Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежерээр ажиллаж байсан Д.Э, “Эс” ХХК-ийн захирал М.Б нарын хамтарсан хөрөнгө оруулалттайгаар Их Британи Виржиний арлуудад / BRITISH VIRGIN ISLANDS / “МСЛ” гэх нэр бүхий компанийг үүсгэн байгуулж,

“МСЛ” ХХК-ийн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-27041x-xxx тоот харилцах дансанд 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр 150.000 ам.доллар шилжүүлж улмаар “Эс” ХХК-ийн Голомт банкин дахь 110272xxxx тоот дансаар 2013 оны 02 дугаар сарын 5-ны өдөр 144.960 ам.долларыг буцаан хүлээн авсан,

“АЭБ” ХХК-ийн захирал Б.Б-гийн Их Британи Виржиний арлуудад /BRITISH VIRGIN ISLANDS / үүсгэн байгуулсан «ТКЛ» компанийн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-2728x-xxx тоот харилцах дансанд 2012

оны 03 дугаар сарын 29-ний өдөр 155.000 ам.доллар шилжүүлж улмаар

-2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 153.993 ам.доллар,

-2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 39.968 ам.долларыг тус тус Ц.Б-гийн Худалдаа хөгжлийн банкин дахь 45313xxxx тоот дансаар дамжуулан М.Б-ын Худалдаа хөгжлийн банкин дахь 45102xxxx тоот дансаар буцаан хүлээн авсан,

“ТКЛ” компанийн HSBC банкин дахь 848-2728x-xxx тоот харилцах дансанд 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 202.500 ам.доллар шилжүүлж, улмаар 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 199.993 ам.долларыг М.Б-ын Худалдаа хөгжлийн банкин дахь 45102xxxx тоот дансаар тус тус буцаан хүлээн авч мөнгө угаасан гэмт хэргүүдэд тус тус холбогджээ.

Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас С.Б-ийн үйлдлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 166¹ дүгээр зүйлийн 166¹.3, 263 дугаар зүйлийн 263.2, Г.Н, П.Э нарын үйлдлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 166¹ дүгээр зүйлийн 166¹.3, 263 дугаар зүйлийн 263.2, М.Б-ын үйлдлийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, 166¹ дүгээр зүйлийн 166¹.3 дахь хэсэгт зааснаар тус тус зүйлчлэн яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүх: Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас Г.Н-т Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож, Г.Н-ийг цагаатгаж, Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас С.Б-өд Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасныг

журамлан тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг, мөн

Прокурорын газраас Д.Э-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг тус тус Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож, Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас М.Б-од Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3-т заасныг журамлан тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг “Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.2” болгон хөнгөрүүлэн зүйлчилж, Дүүргийн 2 дугаар Прокурорын газраас шүүгдэгч С.Б, Д.Э, М.Б нарт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг “шүүгдэгч С.Б, Д.Э, М.Б нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар” гэж, мөн Прокурорын газраас шүүгдэгч С.Б, Д.Э нарт Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3, 35.6-д заасныг журамлан тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлснийг “шүүгдэгч С.Б, Д.Э нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар” гэж тус тус өөрчилж, шүүгдэгч С.Б, Д.Э нар нь бусдын эд хөрөнгийг завших гэмт хэргийг бүлэглэж үйлдсэний улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг, Төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд, шүүгдэгч М.Б-ыг бүлэглэж бусдын эд хөрөнгийг завшиж, онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэг, мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэний улмаас онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг тус тус үйлдсэн гэм буруутайд тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар шүүгдэгч С.Б-ийн эд хөрөнгө болох хх-хх УНЭ улсын дугаартай, JTBHV05J04094xxxx арлын дугаартай, Toyota land Cruiser-200 маркийн автомашиныг хурааж, 5 жил 6 сарын хугацаагаар хорих, шүүгдэгч Д.Э-ын эд хөрөнгө болох хх-хх УНЗ улсын дугаартай, RZN185904xxxx арлын дугаартай, Toyota Hilux маркийн автомашиныг хурааж, 5 жил 6

сарын хугацаагаар хорих, шүүгдэгч М.Б-ын эд хөрөнгө болох хх-хх УБК улсын дугаартай, 5GTDN1365681xxxx арлын дугаартай, Hummer H3 маркийн автомашиныг хурааж, 5 жил, 6 сарын хугацаагаар хорих, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар шүүгдэгч С.Б, Д.Э нарыг төрийн албанд ажиллах эрхийг тус бүр 2 жилийн хугацаагаар хасаж, тус бүр 2 жилийн хорих ял, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.2-т зааснаар шүүгдэгч М.Б-од 6 жилийн хугацаагаар хорих ял тус тус шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1-д зааснаар шүүгдэгч С.Б-ийн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар оногдуулсан хх-хх УНЭ улсын дугаартай, JTBHV05J04094xxxx арлын дугаартай, Toyota land Cruiser-200 маркийн автомашиныг хурааж, 5 жил 6 сарын хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар оногдуулсан төрийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 2 жилийн хорих ялын зарим болох 1 жилийн хорих ялыг нэмж нэгтгэн түүний нийт биечлэн эдлэх ялыг хх-хх УНЭ улсын дугаартай, JTBHV05J04094xxxx арлын дугаартай, Toyota land Cruiser-200 маркийн автомашиныг хурааж, төрийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 6 жил 6 сарын хугацаагаар хорих ялаар, шүүгдэгч Д.Э-ын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар оногдуулсан хх-хх УНЗ улсын дугаартай, RZN185904xxxx арлын дугаартай, Toyota Hilux маркийн автомашиныг хурааж, 5 жил 6 сарын хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар оногдуулсан төрийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 2 жилийн хорих ялын зарим болох 1 жилийн хорих ялыг нэмж нэгтгэн түүний нийт биечлэн эдлэх ялыг хх-хх УНЗ улсын дугаартай, RZN185904xxxx арлын дугаартай, Toyota Hilux маркийн автомашиныг хурааж, төрийн албанд ажиллах эрхийг 2 жилийн хугацаагаар хасаж, 6 жил 6 сарын хугацаагаар хорих ялаар, шүүгдэгч М.Б-од Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.2-т зааснаар оногдуулсан 6 жилийн хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар оногдуулсан 5 жил 6 сарын хорих ялын зарим болох 1 жилийн хорих ялыг нэмж нэгтгэн нийт биечлэн

эдлэх ялыг хх-хх УБК улсын дугаартай, 5GTDN1365681xxxx арлын дугаартай, Hummer H3 маркийн автомашиныг хурааж, 7 жилийн хугацаагаар хорих ялаар тус тус тогтоож, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6-д зааснаар шүүгдэгч С.Б, М.Б, Д.Э нарт оногдуулсан хорих ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1-д зааснаар шүүгдэгч С.Б-ийн цагдан хоригдсон 71 хоногийг, шүүгдэгч М.Б, Д.Э нарын тус бүр цагдан хоригдсон 121 хоногийг тэдний тус тусын ял эдэлсэн хугацаанд нь оруулан тооцож, Г.Н энэ хэрэгт урьдчилан 41 хоног цагдан хоригдсон болохыг дурдаж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар хэрэгт хураагдаж ирүүлсэн С.Б-ийн Е-..... дугаарын гадаад паспорт 1 ширхэг, Д-..... дугаарын дипломат паспорт 1 ширхэг, Г.Н-ийн Е-..... дугаарын гадаад паспорт 1 ширхэг, А-..... дугаарын албан паспорт 1 ширхэг, Д.Э-ын А-..... дугаарын албан паспорт 1 ширхэг, М.Б-ын Е-..... дугаарын гадаад паспорт 1 ширхэгийг С.Б, Г.Н, Д.Э, М.Б нарт буцаан олгож, “АЭБ” ХХК-ийн Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг ...дугаар хороо, ...байрлах оффисын байранд хийсэн нэгжлэгээр хураагдсан М.Х, С.Ц нарын ашиглаж байсан процессор тус бүр 1 ширхэг, нийт 2 ширхэг процессорыг “АЭБ” ХХК-нд буцаан олгож, Нисэх буудлын бүртгэл хяналтын цогц систем нийлүүлж суурилуулах ИНЕГ-ТББ/Б-73/11 тоот тендерийн баримт бичгийн хуулбар 1-287 хүртэл дугаарласан 1 хавтас материал, «ЧХ» Олон улсын буудлын зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгэх ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот тендерийн баримт бичгийн хуулбар 1-288 хүртэл дугаарласан 1 хавтас материалыг хэрэгт үлдээж, Иргэний хуулийн 497 дугаар зүйлийн 497.1, 510 дугаар зүйлийн 510.1-д зааснаар шүүгдэгч С.Б, Д.Э, М.Б нараас тус бүр 278.777.066 төгрөг гаргуулж Иргэний Нисэхийн Ерөнхий газар /хоширогч, иргэний нэхэмжлэгч П.А, Н.М нар/-т олгож, Эрүүгийн 20130100xxxx тоот хэрэгт битүүмжилсэн шүүгдэгч С.Б-ийн эд хөрөнгө болох Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо, ... тоот орон сууц, 250 м2 газар эзэмших эрх, «Г» ХК-ийн 54 ширхэг хувьцаа, «Ц» ХК-ийн 24 ширхэг хувьцаа, шүүгдэгч Д.Э-ын эд хөрөнгө болох Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...дугаар хороолол, ...тоот орон сууц, шүүгдэгч М.Б-ын эд хөрөнгө болох Хан-Уул

дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууц, Г.Н-ийн эд хөрөнгө болох Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууц зэргийг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц тус тус битүүмжлэлээс чөлөөлж, хууль ёсны эзэмшигч нарт буцаан олгож, «Хас» банкин дахь Нийслэлийн Прокурорын газрын 500071xxxx дугаартай дансанд байгаа 9700 ам.долларыг, 500071xxxx дугаартай дансанд байгаа 4500 юанийг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц С.Б-өд буцаан олгож, шийтгэх тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд шүүгдэгч С.Б, М.Б, Д.Э нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж, цагдан хорьж, тэдний эдлэх ялыг 2014 оны 08 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн тоолж, Г.Н-т урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хүчингүй болгож шийдвэрлэжээ.

Ялтан С.Б гаргасан давж заалдах гомдолдоо:

Эрүүгийн гэмт хэрэг үйлдээгүй намайг хэлмэгдүүлж байна гэж үзэж, энэ харгис эрүүдэн шүүлт агуулсан шийдвэрийг хүлээж авахгүй гэдгээ албан ёсоор мэдэгдэж, дээд шатны шүүхэд гомдол гаргаж байна. Зорчигч бүртгэлийн систем нэвтрүүлсэн нь шинэлэг технологи ба үнэ хямд найдвартайгаараа эрэлт хэрэгцээг хангасан «ЧХ» ОУНБ-ын захирал О.Н-ын тодорхойлсноор хохирогчгүй, ямар ч хохиролгүй хэрэг тул миний бие хэлмэгдэж буй нь тодорхой юм.

Миний бие 2006 онд Иргэний Нисэхийн Ерөнхий Газрын даргаар ажиллах болсноос хойш, хийсэн бүтээсэн болгоныг минь буруутгах зорилгоор маш олон тооны мэдээллийг Авлигатай тэмцэх газарт өгч шалгуулан энэ нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй болох нь тогтоогдож байсныг Авлигатай тэмцэх газрын олон байцаагчид мэдэх бөгөөд энэхүү зорчигч бүртгэлийн системтэй хамтатган олон ажлыг шалгуулсан ба тэдгээрийн дотроос энэхүү асуудлыг дэвэргэн ихээхэн хор уршиг дагуулж, зовоон тарчлааж, эрүүдэн шүүж байна. Анх 4000 төгрөгийн хураамжийг буруутган хуурамч гэрээ гэж эхэлсэн нь зохиомол, зохион байгуулалттай болохыг гэрчлэх том баримт юм. Гэвч миний бие хуурамч гэрээ хэзээ ч хийгээгүй тул худал болох нь тогтоогдож хэрэгсэхгүй болсон ч, намайг заавал буруутгах бодлого барьж, өөр элдвийн зүйлээр худал үндэслэл гаргаж яллах шийдвэр гаргасан нь зохион байгуулалттай

хэлмэгдүүлэлт юм. Төсөв, төлөвлөгөөнд тусгагдаагүй ажил үйлчилгээ гэж буруутгаж байгаа ч 2011 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд «Зорчигч бүртгэл хяналтын цогц систем» нэрээр орж, тендер шалгаруулалтаар электрон тоног төхөөрөмжийг “А” ХХК гүйцэтгэж, сүлжээ, программ хангамжийн үйлчилгээний тендер дэлхийд тэргүүлэх байгууллага «А» компанийн “vMUSE» программ хангамж үйлчилгээний гэрээт төлөөлөгч, үндэсний байгууллага “Эс” ХХК ялж 2012 оноос эхлэн өнөөдрийг хүртэл хэвийн үйл ажиллагаа явуулж байна. Зорчигчийн хураамж нь төсвийн хөрөнгө бус ба ИНЕГазар нь улсын үйлдвэрийн газрын гэрчилгээтэй бөгөөд Агентлагийн ба Улсын Үйлдвэрийн газрын хоёрдмол статустай байгууллага тул нислэг үйлдвэрлэлийн орлогоо төсөвт өгөх ёстойг нь тодорхой хуваарийн дагуу төвлөрүүлж, үлдсэнийг нь өөрөө захиран зарцуулдаг, «ЧХ» ОУНБ ч ялгаагүй улсын үйлдвэрийн газар бөгөөд энэ тохиолдолд зорчигч бүртгэлийн шинэ систем нэвтрүүлэхэд шаардагдах бэлтгэл хангах зорилгоор нэмэгдүүлсэн зорчигчийн хураамжийн орлогыг үйлчилгээг нь авч буй байгууллагын хувьд ИНЕГ-т төвлөрүүлэн гэрээнд зааснаар төлбөр тооцоог хийж байсан нь ямар ч хууль дүрэм зөрчөөгүй ба байгууллагад ямар нэг хохирол учруулаагүй юм. “А” ХХК-ийн нийлүүлсэн ажлыг давхардуулан тендер зарлаж “Эс” ХХК-д олгосон гэж буруутгасны тухайд, зорчигч бүртгэлийн системийг нэвтрүүлэх ажил яригдаж эхлэх үед л хоёр өөр ажил хийгдэх нь тодорхой болсон. Нэг нь тоног төхөөрөмж нийлүүлэх ажил, нөгөө нь сүлжээ болон бүртгэлийн программ хангамжийн үйлчилгээний ажил байсан ба бид «М» ХК-д С-гийн явуулж буй туршлага дээр тулгуурлан бэлтгэл хангасан нь зорчигчийн хураамжийг 2012 онд 18.000 төгрөг байсныг 22.000 төгрөг болгон нэмэгдүүлсэн явдал нь энэ 2 ажил хоорондоо ямар нэг давхардал байхгүйг гэрчлэх томоохон баримт юм. Би нэг л ажил хүлээлцэх комисс томилж ажиллуулсан бөгөөд “А” ХХК-ийн нийлүүлсэн тоног төхөөрөмжийг хүлээн авсан акт бичиг баримт нь хавтаст хэрэгт бүрэн авагдсан бөгөөд түүнд «сүлжээ ба бүртгэлийн программ» хангамжийг хүлээн авсан талаар тусгагдаагүй байдаг ба “А” ХХК-ийн захирал Б.Гб хоёр тусдаа ажил болохыг гэрчлээд миний нэр дээр болон «ЧХ» ОУНБ-ын захирал асан

Ч.Н-д хаягласан албан тоотод операторын үйл ажиллагааг эхлүүлж шийдэхийг хүссэн хүсэлтээр нотлогдож байгаагаас гадна «А» ХХК-ийн төлөөлөгчтэй Г.На, Н.М нар уулзахад «vMUSE» системийг төлөөлөх байгууллага бол «Эс» ХХК бөгөөд өөр компани энэ зөвшөөрлийг эзэмших ёсгүй гэдгийг нотолсон байдаг. «ЧХ» ОУНБ-ын эрхлэх ажлын чиг үүрэгт байгаа ажлыг хувийн компанид өгсөн гэсний тухайд тус буудал хэзээ ч зорчигч бүртгэлийн системийг ажиллуулж байгаагүй тул үндсэн чиг үүрэгт нь урьд ч байгаагүй, одоо ч байхгүй, хойшид ч байх ёсгүй тийм тогтолцоог бүрдүүлсэн. «ЧХ» ОУНБ-ын ажилтнууд хариуцах боломжтой ажил гэж томъёолон намайг буруутгах бодлого барьсан нь бодит байдалд үл нийцэхээс гадна энэ томъёоллыг онолын талаас нь авч үзвэл харьцангуй ойлголтын төвшинд авч үзэх нөхцөл бөгөөд Олон Улсын Иргэний нисэхийн зөвлөмжийн 1 ба 5-д заахдаа «Иргэний нисэхэд ашиглах тоног төхөөрөмжүүд стандарт шаардлагыг хангасан байхаас гадна түүнийг ажиллуулагч аливаа ажилтнууд нь бүрэн хэмжээний сургалтад хамрагдан англи хэлний 4 дүгээр төвшнөөс дээш мэдлэгтэй, тухайн ажил үйлчилгээний талаар мэдээлэл авах чадвартай байвал гэрчилгээ зөвшөөрөл авч стандарт хангагдана» гэж заасан байдаг учир «ЧХ» ОУНБ-ын ажилтнууд энэ ажлыг эрхлэх боломжгүйн дээр теле мэдээллийн албаны чиг үүрэг, бүтэц зохион байгуулалтад томоохон өөрчлөлт орж байж хийгдэх ёстой тул буруу томъёоллоор буруутгах санаа агуулсан байна. «ЧХ» ОУНБ-д бүртгэлийн систем ашиглалтад орсонтой холбогдуулж гэсэн томъёоллоор 2012 оны 11 дүгээр сард 4 инженерийн орон тоог нэмэгдүүлэн шийдсэн тушаал нь цаг хугацааны хувьд зорчигч бүртгэлийн систем нэвтрүүлснээс хойш 9 сарын дараа гарч энэ нь «Элекрон системс» ХХК-ийн ажилтай огт хамааралгүй бөгөөд ээлжийн инженерийн хяналт тавих ажлын хүрээг өргөтгөх зорилгоор шийдсэнийг мушгин энэ хэрэгт хамаатуулах зорилгоор ашиглаж байгаа нь буруу юм. Харин миний томилж ажиллуулсан ажил хүлээлцэх комиссын акт тусдаа байгаа бөгөөд хавтаст хэрэгт авагдсан болно. Энэ асуудал хохирогчгүй, хохиролгүй юм. Үүнийг хохирогч П.А, Н.М нар нотлоод байхад надад 278.777.066 төгрөгийн хохирол барагдуулахаар шийдвэрлэсэн нь туйлын буруу бөгөөд би «Эс» ХХК-аас нэг төгрөг ч

ямар нэг байдлаар аваагүй бөгөөд үүнийг хавтаст хэрэгт авагдсан материалууд нотлох бөгөөд М.Б ямар нэг шан харамж өгөөгүй гэдгээ нотолдогоос гадна тэдний санхүүгийн зарцуулалтанд тодорхой байх ёстой гэж үзэж байна. Миний хөрөнгө орлогын мэдүүлэгт хууль бус зүйл байхгүй гэдэг нь тодорхой байгаа. Шинжээч Х.Э-гийн гаргасан дүгнэлттэй эхнээсээ л санал нийлээгүй ба санал нийлэх ч аргагүй байна. Мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан байх, мөн хуульч хүн байх юм. Х.Э-гийн хувьд энэ шаардлагыг хангаагүй ба дээр нь гаргасан дүгнэлт нь илэрхий буруу байгаа нь энэ шинжээчийн чадвар сул, мэдлэг муу тул гаргасан дүгнэлт нь шаардлага хангахгүй байгааг нотолж байна. Г.На, Н.Д нарын гаргасан 2 дүгнэлт нь С.Бу-ын удирдамжаар гэх боловч үнэн хэрэгтээ С.Бу-ын даалгавраар бодит үнэнийг илт гуйвуулж дүгнэлт бичсэн нь олон баримтаар нотлогдож байгаа бөгөөд шүүх хуралд өгсөн мэдүүлэгтээ үнэнд гүйцэгдэх мөчид дүгнэлтээсээ буцсанаар том нотолгоо болсон юм. «С» байгууллагад оролцох боломж олгоогүй гэж ор үндэсгүй зүйл ярьсан атлаа 300 сая төгрөгийн санал оруулсан мэтээр худал дүгнэлт бичсэн. Тэрээр зорчигчийн хураамжийг төсвийн хөрөнгө бус «А» ХХК болон «Эс» ХХК-иудын тендерт ялалт байгуулж хийсэн ажлууд нь хоёр тусдаа ажил болохыг баталж, 4000 төгрөгөөр зорчигчийн хураамжийг нэмэгдүүлснийг тус тус хүлээн зөвшөөрч мэдүүлэг өгсөн ба харин прокурор Р.О, Н.А үе үе хууль бус мэдүүлэг өглөө гэж дарамталж байсныг дурдах нь зүйтэй. Мөн «С» байгууллагыг тендерт оролцох боломжоор хангагдсан нь түүний асуултанд хариулсан байдал, хугацаа сунгуулах хүсэлт тавиагүй зэргээр нотлогдох ба нэгэнт өндөр үнэтэй хоцрогдсон систем тул ялах боломжгүй гэдгээ тэд өөрсдөө мэдсэн байх магадлал өндөр юм. Хохирогч П.А, Н.М нар 4000 төгрөгийн хуурамч гэрээ гэж нэхэмжилж байсан бол одоо байдал өөр болсон байна. Иргэний нисэхийн удирдлагатай зөвшилцсөнөөр «Хэрэв хуурамч гэрээний асуудал нотлогдоогүй тул хэрэгсэхгүй болсон учир нэхэмжлэх хохирол байхгүй» гэж шударга мэдүүлээд, «А» ХХК, «Эс» ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлуудад ямар ч давхцал байхгүй болохыг нотолж өгсөн билээ. Мөрдөн байцаагч мөрдөн шалгалтын үедээ гэрч, хохирогч, шинжээч нараас хүссэн мэдүүлгээ авах мугуйд санаа өвөрлөж ажилласан,

хяналтын прокурор түүнд нь нягт нямбай хандан хяналт тавьж хэрэг явдлын үнэн мөнийг голч шударгаар тодорхойлох ажлыг цалгардуулж муу ажилласан болох нь шүүх хуралдааны үед яллагдагч, гэрч, хохирогч нарын мэдүүлгүүдээс тодорхой харагдаж байхад түүнд шударгаар хандахын оронд эрх мэдлээр Б.Д хуулийг ишлэл болгож, түүнийг нь хурал даргалагч уулгалан дэмжиж байсныг хуралд оролцсон бүх хүн мэднэ. Гэрч, хохирогч, яллагдагч нарын үг хэлэх эрхийг хязгаарлаж, хэлсэн ярьсан зүйлүүдийг нь шүүхийн шийдвэр тогтоолд огт дурдаагүй байгаагийн дээр Улсын яллагч хууль зөрчин хохирогч нарыг хоргоон дарамталж байсан ба энэ үеийн зургийг нь авсан яллагдагч нарын ар гэрийн хүнийг цагдаад хэлж шалгуулан авсан мэдээллийг нь устгуулж байсан нь лав ариун явдал биш байх. Ингэж хуулийг ноцтой зөрчсөн хурал болсон тул шүүх хурлын шийдвэр яаж гарах нь тодорхой юм. Энэ зүйлүүдээс үзэхэд миний үйлдсэн гэмт хэрэг гэх зүйл гэмт хэрэг бус нь тодорхой болж хэрэгсэхгүй болон цагаадах учиртай гэж миний бие хатуу итгэдэг юм гэжээ.

Ялтан М.Б гаргасан давж заалдах гомдолдоо:

Би “Эс” ХХК-ийн үүсгэн байгуулагч нь бөгөөд 2003 онд дохиолол хамгаалалт, программ хангамжийн чиглэлээр байгуулагдсан компани юм. 2010 онд «Ар» корпорацитай холбоо тогтоож, 2011 оны 12 дугаар сараас албан ёсны төлөөлөгчийн эрхийг авч, «ЧХ» ОУНБ дээр суурилуулсан “vMUSE» системийг Монгол Улсад худалдах, борлуулах, угсарч суурилуулах, засвар үйлчилгээг хийх эрхтэйгээр ажиллаж байна. 1000 төгрөгийн гэрээний учрыг би мэдэхгүй, урьд нь хараагүй гэрээ байсан. Энэ гэрээний ард ямар хүн байгаа, ямар зорилгоор бичигдсэн гэрээ болохыг өөрсдийн зүгээс тогтоолгож шалгуулах саналтай байна. Захирлыг хорьж байгаад компанийн үйл ажиллагааг нь өөрийн болгож авах гэсэн хүмүүсийн явуулга байж болох талтай. Энэ талаар би хяналтын прокурор Р.О-д хоёр удаа бичгээр гомдол гаргасан. Манай компани нь 2012 оны 02 дугаар сард ИНЕГ-аас зарласан тендерт шалгарч гэрээ байгуулан нэг зорчигчийн 4000 төгрөгөөр бүртгэл хийх гэрээтэйгээр операторын үйлчилгээ үзүүлж байгаа болно. Уг тендер ИНЕГ-аас ирүүлсэн урилгын дагуу оролцож тендер шалгаруулах хуулийн дагуу бүх бичиг баримтыг бүрдүүлэн оролцсон бөгөөд Монгол Улсын ямар нэг

хуулийг зөрчөөгүй. Гэрээ байгуулснаас хойш өнөөг хүртэл тус компани гэрээнд заасан үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. «ЧХ» ОУНБ дээр “Эс” ХХК-ийн инженерүүд 3 ээлжээр ажиллаж байна. Үйл ажиллагаа хэвийн доголдолгүй явагдаж байна. Би ИНЕГ-тай байгуулсан гэрээний дагуу авч байсан орлогоосоо Монгол Улсын Татварын хуульд заасны дагуу бүх татвараа төлж байсан. Нийт 160 орчим сая төгрөг төлсөн. Яллах дүгнэлтэд «А» компанийн «vMUSE» лицензийг 3 жил үнэ төлбөргүй хэрэглэх эрхийг хамт хүлээлгэн өгсөн гэж гол үндэслэл болгож байна. “А” ХХК-ийн шалгарч гүйцэтгэсэн тендер нь тоног төхөөрөмж нийлүүлсэн тендер юм. “Эс” ХХК шалгарсан тендер нь зорчигч бүртгэлийн операторын үйл ажиллагаа эрхлэх тендер юм. Энэ хоёр тендер хоёр тусдаа зүйл болохыг гэрчээр оролцсон яллах талын гол гэрч Д.Ба гэдэг хүн шүүх хурал дээр хэлсэн “А” ХХК-с захиалагч талыг төлөөлж М.Б миний бие хүлээн авсан «Акт» гэдэг нь 4 дүгээр сарын 29-ний өдөр буюу энэ үед “vMUSE” систем суулган ажиллаж байсан. “А” ХХК нь нийлүүлсэн тоног төхөөрөмж нь vMUSE тэй зохицож ажиллаж байна гэдгийг тодорхойлсон акт юм. ИНЕГ нь тендер хүлээн авах дүрэм журамтай. Даргын тушаалаар гарсан 7 хүнтэй комисс хүлээн авдаг. Энэ 7 хүн гарын үсэг зурсан акт дээр «vMUSE» гэсэн үг үсэг байхгүй. ИНЕГ нь комиссын дүгнэлтэд хүлээн авсан, инженер хүн ИНЕГ-г төлөөлөхгүй бөгөөд төлөөлж гарын үсэг зурсан бол эрх зүйн хувьд хүчинтэй баримт болохгүй. “А” ХХК-ийн хүлээлгэн өгөх баримтад “vMUSE” гэж орсон нь техникийн алдаанд орно. Бүх тендерийг нэг иймэрхүү жижиг алдаа байгаа гэдгийг шүүх хуралд хохирогчоор оролцсон Н.М тодорхой хэлсэн. Гэтэл өөр компанийн хариуцлагагүй үйлдлийг манай компанид тохож ял оноож хэлмэгдүүлэлт явагдаж байна гэж үзэж байна. Хамгийн гол нь “А” ХХК нь “vMUSE” системийн лицензийг эзэмших ямарч эрх байхгүй. “vMUSE” системийн эрхийг “Эс” ХХК нь 2012 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс 2015 оны 1 дүгээр сарын 1-ний өдөр хүртэл хугацаанд үзүүлэх эрхтэй 300 сая төгрөгөөр худалдан авсан. Энэ бүх төлбөр шилжүүлэг нь баримтаар авагдсан байгаа. Энэ шилжүүлэг нь Хонгконгоос тоног төхөөрөмж авах зорилгоор шилжүүлж байсан буудалд тоног төхөөрөмж авсан шилжүүлгүүдийг мөнгө угаасан гэмт хэрэгт тооцон ял өгч

байгаад гомдолтой байна. “Ар” корпорацитай байгуулсан гэрээг мөрдөн байцаалтын явцад албаар нуун дарагдуулсан ба прокурорын шатанд шилжих үед тэр гэрээ байхгүй болох нь илэрсэн. Энэ үед уг гэрээг байхгүй байсан гэж хэлсэн. Үүний дараа миний 5 сард хураан авсан флашнаас гарсан гэж байцаагч нь хэрэгт хавсаргасан. Уг гэрээг үзэх талаар амаар хэлж байсан. Харамсалтай нь уг гэрээг нягталж үзвэл надад ял тулгаж байгаа нь илэрхий болох байсан тул дарагдуулсан. Бид үйл ажиллагаагаа зогсоовол бүх нислэг зогсох болно энэ нь ганц манай биш Монгол Улсын нэр хүндэд халтай зүйл болно. Хоёр дахь үндэслэл нь “ЧХ” ОУНБ-ын ажилчид хийх боломжтой гэсэн. Техник технологийн эрин үед технологийн хөгжил нь жилээр биш сар, өдрөөр өөрчлөгдөж байна. Хүн өнөөдөр хамгийн сүүлийн үеийн гар утас худалдан аваад гэтэл 6 сарын дараа хуучин утас болж хоцрогдож байгаа цаг үед явж байна. Мөн “А” ХХК-ийн захирал Б.Гб нь удаа, дараа албан бичиг явуулсан нь хавтаст хэрэгт байгаа. Уг албан бичигт тоног төхөөрөмж суурилсан. Одоо лицензтэй программыг нь олж суулгасан уу гэсэн байдаг. Ийм байтал нотлох баримтыг үл хэрэгсэж яллаж байгааг эсэргүүцэж байна. Улсын яллагчийн яллан, шүүхийн тогтоол гаргасан үндэслэл нь энэ Т.Ба гэдэг хүний гүтгэж бичсэн аудитын дүгнэлт юм. Энэ хурлын дүгнэлтээр ялын тогтоол гарсан. Дүгнэлт хийсэн хүн нь гүтгэж бичсэн гэдгээ хэлээд байхад яллах тогтоол гаргаж байгааг эсэргүүцэж байна.

Нотлох баримт илт гуйвуулсан “А” ХХК хүлээлгэн өгсөн гэх акт нь 9 дүгээр сарын 29-ний “А” ХХК-ийн нийлүүлсэн тоног төхөөрөмжтэй зохицож ажиллаж байна гэдгийг тодорхойлсон тодорхойлолт, ИНЕГ-т тоног төхөөрөмж хүлээн авах акт нь комисс 7 хүний гарын үсэгтэй байх ёстой бөгөөд тэр актаар хүлээн авдаг. «ЧХ» ОУНБ-ын нэгжийн инженер ИНЕГ-ыг төлөөлөн гарын үсэг зурж тендер хүлээн авахгүй. Тийм актаар авсан бол эрх зүйн алдаатай хүчинтэй акт биш болно. «ЭС» болон «А» ХХК-уудын хооронд байгуулсан лиценз эзэмших гэрээ хамгийн гол юм. К.С.О-ны ярилцлагад «А» гэж мэдэхгүй гэдгээ хэлсэн байдаг. Мөн гэрчээр мэдүүлэг авахдаа илт гуйвуулж мэдүүлэг авсан. Гэрч Ч.З шүүх хурал дээр ийм мэдүүлэг өгөөгүй гэдгээ хэлсэн. 2-3 жил ажилласан эгчийн хүүхдээ ажиллуулдаг гэж буруутгаж байгаа. Эгчийн хүүхдийг ажиллуулах нь ямар хууль зөрчиж байгаа юм бэ. Манай дүү Л.Эр нь

Энэтхэг Улсын Банголорын техникийн их сургуульд бакалавр хамгаалсан англи хэлний өндөр мэдлэгтэй, инженер хүн. 20 жилийн өмнө компьютер гэж үзээгүй цэргийн сургууль төгссөн техникч хүнийг туршлагатай тул нарийн мэргэжилтэй ур чадвар шаардсан тоног төхөөрөмжийг чадна гэж үзсэн нь буруу юм. Би бүх татвараа бүрэн төлж байсан. Ямар үндэслэлээр мөнгө угаасан ял оноож, юунаас нуусан гэж үзэж байгааг ойлгохгүй байна. УЕПГ-т гомдол гаргаж прокурор дүгнэлт гаргаж, даалгавар бичсэн нь хэрэгт байхгүй байна. «А» ХХК нь албан ёсны төлөөлөгч тул ИНЕГ-аас урилга ирүүлсний дагуу тендерт орж шалгарсан. Энэ нь ямар хууль зөрчөөгүй. Хохирогчоор сүүлийн өдөр үг хэлүүлээгүй. Хохиролгүй гэдгээ удаа дараа мэдэгдсэн.

Мөрдөн байцаагч, прокурор, шүүх хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд хуульд заасан арга хэмжээг авч хэрэгжүүлээгүй, мөрдөн байцаалтаар төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан хувийн ашиг сонирхолоо гүйцэлдүүлэх зорилгод ашигласан аливаа үйлдэл, эс үйлдэхүй тогтоогдоогүй байхад зөвхөн шинжээч нарын Монгол Улсын хууль тогтоомжийг илт зөрчсөн дүгнэлтийг үндэслэн шүүх ял оногдуулсан нь хууль эрх зүйн үндэслэлгүй байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлд “Тогтоол хууль ёсны ба үндэслэлтэй байна» гэж заасан байдаг.

Иймд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 317 дугаар зүйлд заасан «хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон шүүхийн хэлэлцүүлэг явуулахад нэг талыг барьсан буюу гүйцэд биш хийсэн», «тогтоолд дурдсан дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй», «Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтойгоор зөрчсөн», «Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн» үндэслэлээр Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 1025 дугаар шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж өгнө үү гэжээ.

Ялтан Д.Э гаргасан давж заалдах гомдолдоо:

2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр ИНЕГ-ын даргын “Үнэлгээний хороо томилох тухай” А/54 тоот тушаал гарч “ЧХ” ОУНБ-д зорчигч бүртгэлийн системийн оператор компанийн сонгон үнэлгээнийг хороог

5 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилсон. Үнэлгээний хороо 2012 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр хуралдаж тендерийг хэрхэн яаж явуулах талаар хэлэлцсэн бөгөөд Үнэлгээний хорооны гишүүн Ц нь зорчигч бүртгэлийн системийн операторын үйлчилгээ нь мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага шаардсан нарийн төвөгтэй бараа, ажил үйлчилгээ мөн бөгөөд дэлхийд ийм төрлийн ажил үйлчилгээг гүйцэтгэдэг компанийн тоо хязгаарлагдмал буюу “Ар”, “С” гэдэг 2 компани байдаг тул Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1-д заасны дагуу хязгаарлагдмал тендер зарлах ёстой гэсэн санал гаргасныг олонхи буюу 100 хувийн саналаар дэмжиж шийдвэрлэсэн. Ингээд 2012 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр тендерийн бичиг баримт болон урилгыг “С” компанийн Монгол Улс дахь төлөөлөгч “Эс” ХХК-д тус тус хүргүүлсэн. Тендерийн нээх өдөр буюу 2012 оны 02 дугаар сарын 15-ны өдөр болоход тендер саналыг зөвхөн “Ар” ХХК-ийн төлөөлөгч болох “Эс” ХХК-тай гэрээ байгуулан эрх олгох шийдвэрийг захиалагчид танилцуулсан ба үүгээр Үнэлгээний хорооны ажил дууссан. Миний бие Үнэлгээний хороо байгуулах тухай ИНЕГ-ын даргын 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалыг төрийн албан хаагчийн хувьд биелүүлж, холбогдох хууль журмын дагуу тендерийг л зөвхөн шалгаруулах үйл ажиллагаанд оролцсон бөгөөд Үнэлгээний хороо нь аливаа асуудлыг ердийн олонхоороо шийддэг, Үнэлгээний хорооны дарга нь бусдын адил зөвхөн 1 саналын эрхтэй байдаг байхад ганцхан намайг тендерийг шалгаруулсан мэтээр буруутгаж байна. Тус хороонд ажиллаж байхдаа “Эс” ХХК-ийг шалгаруулах талаар бусад гишүүдэд ямар нэг заавар, зааварчилгаа өгөөгүй болно. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 44 дүгээр зүйлийн 44.1-д заавал биелүүлэх тушаал, захирамжийг биелүүлэхдээ энэ хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд гэм хор учруулсан бол гэмт хэрэгт тооцохгүй гэж заасан байдаг ба ИНЕГ-ын даргын тушаалыг биелүүлсний төлөө Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т заасан гэмт хэрэгт буруутгаж байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна. Хэрэгт авагдсан материалаас үзэхэд тендерийн давхардуулан зарласан гэдэг нь огт нотлогдохгүй байгаа бөгөөд Монгол Улсад «А» ХХК-ийг төлөөлж

“vMUSE” программын лицензийг эзэмших, операторын үйл ажиллагаа явуулах эрх нь зөвхөн “Эс” ХХК-д байгаа гэдгийг хэрэгт байгаа «Ар» болон “Эс” ХХК нарын хооронд байгуулагдсан «^Мизе» ашиглах тухай гэрээ, «Ар» ХХК-ийн бүсийн менежер Кенг болон ИНЕГ-ын холбогдох албан тушаалтнуудын уулзалтын тэмдэглэл, “А” ХХК болон “Эс” ХХК-иудын хийж гүйцэтгэсэн ажил нь хоорондоо давхцаагүй гэдгийг «ЧХ» ОУНБ-ын ерөнхий инженер Н.Мя, мэдээлэл технологийн албаны дарга П.Б, аудитор Т.Ба, хохирогч, иргэний нэхэмжлэгч Н.М нарын шүүх хурлын үед өгсөн мэдүүлгүүд нотлож байгаа. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 9.2-т «захиалагч нь 10.000.000.001 төгрөгөөс дээш өртөг бүхий ажил, 100.000.001 төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа үйлчилгээний тендер шалгаруулалтад гадаадын этгээд оролцохыг хориглож үл болно» гэж заасан бөгөөд тус ажлыг гүйцэтгэгч компани дэлхийд 2 л байдаг. Мөн хуулийн 28 дугаар зүйлийн 28.5.8-д «гадаадын этгээдийг тендер оролцуулах эсэхийг тендерийн урилгад заана» гэсэн байдаг бөгөөд Үнэлгээний хорооноос оролцогчдод явуулсан урилгад гадаадын этгээдийг оролцохыг хориглосон, хязгаарласан ямар нэгэн заалт, зүйл байхгүй болно.

Миний бие ИНЕГ-аас мөнгө шилжүүлэх ямар нэгэн баримт дээр огт гарын үсэг зурдаггүй, тус байгууллагаас мөнгө, хөрөнгө шилжүүлэхтэй холбоотой болон санхүүгийн ямар ч үйл ажиллагаанд ямар нэг хэлбэрээр оролцдоггүй ба агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежерээр ажиллаж байхдаа ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь хөдөлмөрийн гэрээний дагуу байгууллагын гадаад харилцаа, агаарын тээвэрлэгчийн томилгоо, Засгийн газар хоорондын агаарын харилцааны хэлэлцээрийг хариуцдаг байсан болно. Мөн ИНЕГ-аас “А” ХХК, “Эс” ХХК-тай гэрээ байгуулах, гэрээг хянах ажилд огт оролцоогүй бөгөөд эдгээр гэрээнүүдэд гарын үсэг зураагүй болно. ИНЕГ-аас “Эс” ХХК руу шилжүүлсэн төлбөрийн баримтууд дээр ИНЕГ-ын даргаар ажиллаж байсан С.Б, С.Бу, ерөнхий нягтлан бодогч Д.А нар гарын үсэг зурсан байдаг ба мөнгө нь шууд “Эс” ХХК-ийн данс руу орсон байдаг. “Эс” ХХК-ийн захирал М.Б нь надад ямар нэгэн мөнгө, хөрөнгө өгч, авч байгаагүй байхад намайг Эрүүгийн

хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар гэм буруутайд тооцож, ял оноож байгааг үндэслэлгүй гэж үзэн хүлээн зөвшөөрөхгүй байна. Шүүх хуралдааны үед хохирогч, иргэний нэхэмжлэгч ИНЕГ-ын зүгээс 2 өөр үнийн дүнтэй гэрээ байна гэдэг нь нотлогдвол уг 2 гэрээний үнийн дүнгийн зөрүү болох нэг зорчигчийн 3000 төгрөгийг нэхэмжилнэ, өөр хохирсон зүйл байхгүй гэж мэдүүлээд байхад шүүхээс 836.331.200 төгрөгийг хохирол гэж үзэн С.Б, М.Б, Д.Э нараас хувь тэнцүүлэн гаргуулах шийдвэр гарсныг хүлээн зөвшөөрөхгүй байна. Мөн шийтгэх тогтоолын 10 дугаар хуудсанд шүүгдэгч Д.Э-ын мэдүүлэгт «шинжээчээр томилогдсон Х.Э-гийн дүгнэлт үндэслэлгүй гарсан, уг дүгнэлтэд нарийн төвөгтэй гэсэн, тийм нарийн төвөгтэй биш юм» гэж миний хэлсэн үгийг нь эсрэгээр нь сольж бичсэнийг залруулж өгнө үү. Х.Э нь нарийн төвөгтэй биш гэж дүгнэлт гаргасан бөгөөд миний бие нарийн төвөгтэй мөн гэж мэдүүлсэн болно. Иймд уг хэргийг хуулийн дагуу үнэн зөв шийдвэрлэж өгнө үү гэжээ.

Ялтан С.Б-ийн өмгөөлөгч Ж.Батхүү давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

С.Б-ийг шийтгэсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасны тухайд бусдад буюу ИНЕГ-т 278.777.066 төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан гэж шийтгэсэн боловч дээрх зүйл анги нь өмгөөлөгч миний Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхэд 2014 оны 08 дугаар сарын 18-нд гаргаж өгсөн 94 хуудас нотлох баримтыг гаргаж өгсөн боловч шийтгэх тогтоолд нотлох баримтаас хасаагүй боловч нэгийг нь ч үнэлээгүйд гомдолтой байна.

Мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар тоног төхөөрөмж, зорчигч бүртгэлийн систем 2-ын ялгааг огт ойлгоогүй тул буруу дүгнэлт хийсэн. Мөн ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Бу-ын баталсан удирдамжийн дагуу санхүүгийн шалгалт хийж дүгнэлт гаргасан. Т.Ба, Н.Д нар зорчигчийн хураамж нь төсвийн хөрөнгө бус “А” ХХК болон “Эс” ХХК-иудын тендерт шалгарч хийсэн ажлууд нь 2 тусдаа ажил болохыг баталсан АТГ-аас хохирол болон нэхэмжлэгчээр тогтоосон хохирогч П.А, Н.М нар анх 4000 төгрөгийн хуурамч гэрээ гэж нэхэмжилж байсан боловч хэргийн материалтай танилцах явцад байдал өөрчлөгдсөн. Иргэний

нисэхийн удирдлагуудтай зөвшилцсөнөөр «хуурамч гэрээний асуудал» нотлогдоогүй тул нэхэмжлэх зүйлгүй гээд мөн “А” ХХК болон «Электрон систем» ХХК-уудын хийж гүйцэтгэсэн ажлуудад ямарч давхцал байхгүй болохыг шүүх хуралдаан дээр мэдүүлсэн болно. Мөн шүүхийн тогтоолд С.Б нарын 1.062.959.200 төгрөгийг завшсан гэж дүгнээд түүнээс С.Бу-д холбогдох 226.000.000 төгрөгийн хохирлыг хасаж тооцон хэргийг тусгаарласан прокурорын тогтоолыг зөв гэж шийдвэрлэсэн нь ойлгомжгүй. Хэрвээ С.Б нарыг буруутай гэж шүүх үзвэл С.Бу-гийн үйлдэл зайлшгүй хамт шийдвэрлэгдэх ёстой. С.Б нарт холбогдох зохиомол хэрэгт хэн ч хохироогүй тул хохирол болон хохирогч байхгүй нь ИНЕГ-ын 2012-2013 оны тайлан, АЕГ-ын дүгнэлтүүд, МХЕГ-ын шалгалтаар тогтоогдсон байхад ял шийтгэгдсэн 3 хүнээс тус бүрт нь 278.777.066 төгрөгийг гаргуулахаар заасанд гомдолтой, тоног төхөөрөмжийн үнэ, бүртгэлийн системийн үнийг хасаж тооцоогүй. Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг үндэслэл болгосон шинжээч Х.Э-гийн дүгнэлт нь “А” ХХК-ийн тоног төхөөрөмжийн тендерийг ихэвчлэн дүгнэсэн атлаа “Эс” ХХК-ийн сүлжээ программчлалынх уу гэдэг нь тодорхой бусаас гадна шинжээч нь өөрөө Сангийн сайдын баталсан шинжээчийн шаардлагыг хангаагүй байна. С.Б-ийн төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж явуулсан гээд байгаа тендер нь ИНЕГ-ын 2011 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд «зорчигч бүртгэл хяналтын цогц систем» нэрээр орж тендер шалгаруулалтад электрон тоног төхөөрөмжийг “А” ХХК гүйцэтгэсэн, сүлжээ программ хангамжийн үйлчилгээний тендерт дэлхийд тэргүүлэх байгууллага «Ар» компанийн «vMUSE» программ хангамж үйлчилгээний гэрээт төлөөлөгч, үндэсний “Эс” ХХК ялж 2012 оноос эхлэн өнөөдрийг хүртэл хэвийн үйл ажиллагаа явуулж байсан. «ЧХ» ОУНБ-ын эрхлэх ажлын чиг үүрэгт багтсан ажлыг хувийн компанид өгсөн гэж яллаж байгаа нь үндэслэлгүй. Тус буудал хэзээ ч зорчигч бүртгэлийн системийг ажиллуулж байгаагүй, одоо ч байхгүй, хойшид ч байхгүй болох нь гэрч Н, Н.М, П.Б, З, М нарын мэдүүлгүүд болон «ЧХ» ОУНБ-ын үйл ажиллагааны заавар, теле мэдээлэл, хангамжийн албаны бүтэц зохион байгуулалт болон ажлын чиг үүрэгт тусгагдаагүй, ямар ч ажилтны

хөдөлмөрийн гэрээ болон албан тушаалын заавар, ажлын байрны тодорхойлолтонд тусгагдаагүй нь тогтоогдсон. Хэрвээ «ЧХ» ОУНБ-ын ажилтан албан хаагчид, зорчигч бүртгэлийн системийг ажиллуулах болсон тохиолдолд Англи хэлний дундаас дээш төвшний мэдлэгтэй инженерүүд 3-6 сар бэлтгэгдсэний эцэст ажиллуулах боломжтой болох нь анхан шатны шүүхээр хэлэлцэгдэж тогтоогдсон. С.Б нь өөртөө олгогдсон ажил үүргийнхээ хүрээнд тендерийн хороог томилсон бөгөөд дотор нь орж ажиллаагүй юм. Тендерт шалгарсан компанитай байгуулах гэрээг баталгаажуулсан байдаг. Тендерт “Эс” ХХК шалгарснаар зорчигч бүртгэлийн хураамж өмнөх «С»-гийн үеийн хураамжаас 3-4 дахин багассан байдаг бөгөөд үндэсний үйлдвэрлэлийг дэмжиж ажилласан байдаг. Зорчигчийн хураамж нь төсвийн хөрөнгө бус ИНЕГ нь УҮГ-ын гэрчилгээтэй бөгөөд Агентлагийн ба УҮГ-ын хоёрдмол статустай байгууллага тул нислэг үйлдвэрлэлийн орлогоо төсөвт өгөх ёстойг нь тодорхой хуваарийн дагуу төвлөрүүлж, үлдсэнийг өөрөө захиран зарцуулдаг. «ЧХ» ОУНБ нь ялгаагүй УҮГ бөгөөд зорчигчийн хураамжийн орлогыг ИНЕГ-т төвлөрүүлж гэрээнд зааснаар төлбөр тооцоог хийж байсан нь ямар ч хууль дүрэм зөрчөөгүй ба байгууллагад ямар нэгэн хохирол учруулаагүй нь ИНЕГ-ын санхүү үйл ажиллагаанд хийсэн 2012, 2013 оны Улсын ерөнхий аудитын газрын тайлан, 2012 онд МХЕГ-аас хийсэн шалгалтанд зөрчил дутагдлаар тусгагдаагүйгээр хангалттай нотлогддог. С.Б нь Монгол төрийн бодлого, Чикагогийн конвенцийн заалт, холбогдох баримт бичгүүдийн заалт, Иргэний нисэхийн тухай болон Агентлагийн эрх зүйн байдал, Төсвийн тухай болон Иргэний хууль, Засгийн газрын тогтоол, шийдвэрүүд, ЗТАЖ-ы сайдын баталсан «Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр» зэргийг баримтлан зорчигч бүртгэлийн системийг нэвтрүүлэх ажлыг амжилттай хийж гүйцэтгэсэн бөгөөд энэ систем нь өнөөдөр ч хэвийн ажиллаж, нислэгийн аюулгүй байдлыг найдвартай хангаж байгаа тул С.Б-ийг шийтгэсэн Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 1025 дугаар шийтгэх тогтоолын 4, 5, 7, 8, 11 дэх заалтуудыг тус тус хүчингүй болгож, С.Б-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон түүнийг цагаатгуулахаар

энэхүү давж заалдах гомдлыг гаргаж байна гэв.

Ялтан С.Б-ийн өмгөөлөгч Ж.Эрдэнэбулган давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.1-д заасан хууль ёсны ба үндэслэлтэй байх шаардлагыг хангаагүй гэж үзэж байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д зааснаар хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүх хуралдааны явцад уг гэмт хэргийг хэн үйлдсэн, гэмт хэргийн сэдэлт, гэм буруугийн хэлбэр, гэмт хэргийн улмаас учирсан хохирлын шинж чанар, хэр хэмжээ зэргийг заавал тогтоосон байхыг шаарддаг. Гэтэл энэхүү хэргийн улмаас хэнд ямар хохирол учирсан гэдгийг бүрэн тогтоогоогүй, энэ хэргийн хохирогч болон иргэний нэхэмжлэгч нар нь байгууллагад нь ямар нэг хохирол учраагүй, уг тендер давхардаагүй, одоо болтол ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот «ЧХ» ОУНБ-д зорчигч бүртгэлийн сүлжээний операторыг сонгон шалгаруулах тендерээр шалгарсан “Эс” ХХК-ийн үйлчилгээг авч байгаа гэдгээ албан ёсоор хүлээн зөвшөөрсөн. Мөн энэ хэрэгт гэрчээр оролцсон ИНЕГ-ын хяналт шинжилгээ, дотоод аудитын аудитор Т.Ба нь сонгон шалгаруулалтын талаар материалыг хүлээж аваагүй байхдаа 2 өөр дүгнэлт гаргасан, энэхүү тендер нь хийгдэх ёстой байсан ажил гэдгээ шүүх дээр мэдүүлсэн, мөн бусад гэрчүүд энэхүү зорчигч бүртгэлийн үйл ажиллагаа нь хууль зөрчөөгүй гэдгийг шүүх хурал дээр давхар нотлон мэдүүлсэн байдаг. Энэхүү хэрэг нь анхнаасаа мөрдөн байцаалтыг хэт нэг талыг барьж, явагдаж прокурор ч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн холбогдох заалт болон Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэдгийн нэг илэрхийлэл нь Эрүүгийн хуулийн хүчингүй болсон зүйлээр энэ хэрэгт холбогдсон хүмүүсийг ялласан, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн хэм хэмжээг буруу ойлгож журамласан байдлаас харагдаж байгаа юм.

Мөн шүүх ял ногдуулахдаа «гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо төлөөгүй» гэх Эрүүгийн хуулийн ял хүндрүүлэх нөхцөлд байхгүй зүйлийг дурдаж ял оногдуулсан, С.Б-ийг албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан мөн эд хөрөнгийг завшсан гэдгийг бүрэн тогтоож чадаагүй энэ хэргийн шүүхийн өмнөх үе шатанд авагдсан

яллах баримт болж байгаа нотлох баримт, нотолгоонууд нь шүүхийн хэлэлцүүлгийн үед няцаагдсан, эргэлзээтэй байхад шүүх хэт яллах байр суурьнаас хандаж хэргийн нөхцөл байдлын талаар бүрэн гүйцэд, хөдөлбөргүй тогтоогдсон нотлох баримтад үндэслэж дүгнэлт хийгээгүй гэж өмгөөлөгчийн хувьд үзэж байна.

Иймд С.Б-өд холбогдох хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж эргэлзээтэй, зөрүүтэй байгаа зүйлсийг дахин шалгах, энэхүү сонгон шалгаруулалт нь эрүүгийн хэрэг мөн эсэх, үүний улмаас хэнд ямар хохирол учирсан гэдгийг хууль зүйн дагуу, үнэн зөв, шударгаар тогтоож байж эдгээр хүмүүсийн гэм буруутай эсэхийг шийдвэрлэх нь зүйтэй гэж үзэж байна гэв.

Ялтан М.Б-ын өмгөөлөгч Х.Цогтсайхан давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Шүүгдэгч Т.Б нь болсон үйл явдлын талаар үнэн бодитойгоор дурдаж, талуудын хооронд байгуулсан гэрээний дагуу үйл ажиллагаагаа хуулийн дагуу явуулж ирсэн болохыг өөрт байгаа нотлох баримтуудаар үнэн зөв мэдүүлж ирсэн. Харин хэрэгт мөрдөн байцаалт явуулсан мөрдөн байцаагч болон мөрдөн байцаалтын ажиллагаанд хяналт тавьсан прокурорын зүгээс яллагдагчийн гаргасан баримт нотолгоог магадлан шалгах, хэргийн бодит үнэнийг нотлоход ач холбогдол бүхий бусад нотолгоог олж цуглуулах талаар хуульд заасан арга хэмжээг бүрэн аваагүй байна. Мөрдөн байцаагч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон «Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зорилт... аливаа гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлж, гэмт этгээдийг олж тогтоох, гэмт хэрэг үйлдсэн этгээд нэг бүрт зохих ялыг шударгаар оногдуулах» зорилтыг хангалгүйгээр, мөрдөн байцаалт явуулахдаа хэт яллах талыг баримталж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлд заасан «хэргийг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авна...» гэсэн зарчмын хэрэгжилтийг бүрэн хангалгүй хэргийг Прокурорын газарт шилжүүлсэн байна. М.Б нь “Эс” ХХК-ийн үүсгэн байгуулагч нь бөгөөд 2003 онд дохиолол хамгаалалт, программ хангамжын чиглэлээр байгуулагдсан компани юм. 2010 онд «А» корпорочитай холбоо тогтоож, 2011 оны 12 дугаар сараас албан ёсны төлөөлөгчийн эрхийг авч, «ЧХ» ОУНБ

дээр суурилуулсан “vMUSE” системийг Монгол Улсад худалдах, борлуулах, угсарч суурилуулах, засвар үйлчилгээг хийх эрхтэйгээр ажиллаж байна. Анх АТГ-аас яллагдагчийг гэмт хэрэгт холбогдуулан шалгахдаа нэг зорчигч бүртгэх төлбөрийн 1000 болон 4000 төгрөгийн гэрээ гэх хоёр өөр үнийн дүнтэй гэрээ хийсэн байна гэж шалгасан. 1000 төгрөгийн гэрээний учрыг М.Б мэдэхгүй, урьд нь хараагүй гэрээ байсан. Энэ гэрээний ард ямар хүн байгаа, ямар зорилгоор бичигдсэн гэрээ болохыг өмгөөлөгчийн зүгээс тогтоолгож шалгуулах саналтай байна. Яллагдагчийг хорих 461 дүгээр ангид хоригдож байхад ИНЕГ, «ЧХ» ОУНБ-ын зүгээс компанийн инженерүүдийг «Танай захирал шоронд орсон. Та нар манайд ажилд ор. Танай үйл ажиллагааг манайх авна» гэх мэтээр дарамталж шахаж байсан. Захирлыг хориулж байгаад компанийн үйл ажиллагааг нь өөрийн болгож авах гэсэн хүмүүсийн явуулга байж болох талтай. Тус компани нь 2012 оны 02 дугаар сард ИНЕГ-аас зарласан тендерт шалгарч гэрээ байгуулан нэг зорчигчийн 4000 төгрөгөөр бүртгэл хийх гэрээтэйгээр операторын үйлчилгээ үзүүлж байгаа болно. Уг тендер ИНЕГ-аас ирүүлсэн урилгын дагуу оролцож, тендер шалгаруулах хуулийн дагуу бүх бичиг баримтыг бүрдүүлэн оролцсон бөгөөд Монгол Улсын ямар нэг хуулийг зөрчөөгүй. Гэрээ байгуулснаас хойш өнөөг хүртэл тус компани гэрээнд заасан үүргийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна. 2013 онд энэ хэрэгт холбогдуулан шалгаж байгаагаас болж ИНЕГ-аас ямар нэг төлбөр, санхүүжилт аваагүй. «ЧХ» ОУНБ дээр “Эс” ХХК-ийн инженерүүд 3 ээлжээр ажиллаж нэгдүгээр түвшний үйлчилгээ болох сүлжээний доголдлыг засах, тоног төхөөрөмжийн дутагдалыг засах гэх мэтийн арга хэмжээнүүдийг цаг алдалгүй авч хэрэгжүүлж байна. Үйл ажиллагаа хэвийн доголдолгүй явагдаж байна. Тус компанийн системийг ашигласнаар авиа компани болгон өөрийн билет захиалгын системээ ашиглах боломжтой болж байгаа юм. Ингэснээр «ЭЧ», «Аэ», «КЭ» гэх мэт авиа компанийг сонгон үйлчлүүлж байгаа зорчигч аль нэг дундын буудал ашиглан өөр хотруу дамжин нисэх транзит бүртгэлийг «ЧХ» ОУНБ дээр хийх боломжтой болсон. Нисэх буудлын бүртгэлийн танхимд үүсдэг маш их хэмжээний бөөгнөрөл, дугаарлах явдлыг зогсоох, агаарын тээвэрлэгчдийн хувьд

өөрийн зорчигчдод үзүүлэх үйлчилгээг эрс сайжруулах, нисэх буудлын хувьд хамгийн орчин үеийн техник технологийг нэвтрүүлж, дэлхийн бусад нисэх буудлуудын жишигт хүрэх бололцоотой болсон. “Эс” ХХК нь ИНЕГ-аас авсан санхүүжилтээр өөрсдийн санаачилгаар ачаагүй зорчигч өөрөө өөрийгөө бүртгэх систем нэвтрүүлэхээр тоног төхөөрөмжийн шинэчлэл, иж бүрдлийг шат дараатай хийж байсан. ИНЕГ-аас авсан 1 тэрбум 62 сая төгрөгийн санхүүжилтээс компани нь Монгол Улсын Татварын хуулийн дагуу бүх татвар, хураамжуудыг төлж байсан. Тухайлбал НӨАТ-ын татвар 100 орчим сая төгрөг, ААН албан татварт 70 орчим сая төгрөг тайлагнаж, үүнээс 145 сая төгрөгийг төлсөн. Шүүх М.Б нь С.Б, Д.Э нартай бүлэглэн нийт 1.062.959.200 төгрөгийг завшиж улсад онц их хэмжээний хохирол учруулсан гэх боловч гэм буруутайд тооцогдсон этгээдүүд тухайн гэмт хэргийг үйлдэхдээ үгсэн тохиролцсон байдал, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон оролцоо зэрэг гэмт хэргийн бүрэлдэхүүний хувьд зайлшгүй нотлох, баримтаар тогтоогдвол зохих зүйлүүд огт тогтоогдоогүй, шүүгдэгч нар нь гэмт хэрэг үйлдэхэд хамтран оролцсон гэдгийг нотолсон мэдүүлэг, ямар нэг нотлох баримт хавтаст хэрэгт авагдаагүй, мөрдөн байцаалтын явцад Түүнчлэн шинжээч болон тухайн асуудлаар яллах байр суурин дээр байгаа гэрч нар нь тухайн асуудлаар шинжээчийн болон мэргэжлийн төвшинд үнэлэлт дүгнэлт өгөх чадваргүй болох нь бүхий л байдлаараа харагдаж байсан. Мэдлэг чадвар илт дутсан, шинжилгээ хийж байгаа асуудлаараа бусдаас хараат байх, хууль зүйн тодорхой асуудлыг мушгин гуйвуулж хуулийг хэрэглэх, хуулийг дур зоргоороо тайлбарлах зэргээр хууль ёсыг илт завхруулсан үйлдэл удаа дараа хийж байсан нь шүүхийн хэлэлцүүлгийн явцад тогтоогдсон. Хуулиар тогтоосон бүрэн эрхийн хүрээнд албан үүргээ хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааг албан тушаалын эрх мэдлээ албаны эрх ашгийн эсрэг хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашигласан гэж дүгнэж, буруутгаж байгаа нь илт үндэслэлгүй, гэмт үйлдэл холбогдол тогтоогдоогүй байхад прокуророос гэм буруутай гэж үзсэн дүгнэлт нь хэргийн жинхэнэ байдалтай нийцээгүй, Эрүүгийн хуулийг буруу тайлбарлан хэрэглэсэн байх бөгөөд албаны эрх мэдлээ хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх ашигласан гэм буруу, гэм буруугийн хэлбэр, санаа зорилго,

нотлох баримт мөрдөн байцаалт, шүүхийн хэлэлцүүлгээр тогтоогдоогүй юм. Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүний объект нь бусдын өмчлөх эрх, тухайн зүйлийг өмчлөгч нь төр, олон нийт, компани, хувь хүн байдаг бөгөөд энэ субъектуудын өмчид байсан хөдлөх, үл хөдлөх хөрөнгө нь гэмт халдлагын зүйл байдаг. Бусдын эд хөрөнгийг шунахай сэдэлтээр хууль бусаар үнэ төлбөргүйгээр өөртөө болон бусдын өмчлөлд бүрмөсөн авч хууль ёсны өмчлөгчид хохирол учруулсан шинжтэй байдаг. Яллагдагч этгээдүүдийн үйлдлээр хохирогч нарт олон арван сая төгрөгийн хохирол учирсан гэж Мөрдөн байцаалтын шатанд дүгнэхдээ энэ мөнгө нь бодитойгоор ИНЕГ-ын өмч хөрөнгө гэж тооцогдохгүй, тайлан балансад бүртгэгдээгүй гэдгийг зайлшгүй анхаарах учиртай. Энэ мөнгө нь олох байсан орлого гэж тооцогдоно. Энэхүү орлогыг чөлөөт эдийн засгийн хувьд олж ч болох бөгөөд олохгүй байх ч магадлал бас байдаг гэдгийг харгалзахгүй байж болохгүй. Энэ гэмт хэргээс учирсан хохирлыг шууд ИНЕГ-ын өмч хөрөнгө гэж дүгнэж болохгүй. Энэ өмч хөрөнгө нь ИНЕГ-ын дансанд орж тайлан балансад тусгагдсан мөчөөс эхлэн тухайн газрын өмч хөрөнгө гэж тооцогддог. Эрүүгийн хуулийн 6 дугаар зүйлд заасан шударга ёсны зарчимд ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ нь гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдалд тохирсон байна гэж заасан. Гэтэл гэрээнд заасан санхүүжилтээ авч ажил үйлчилгээ эрхэлж ирсэн нь “Эс” ХХК-ийн захирлыг бусдын өмчийг завшсан гэмт хэрэгт холбогдуулан яллаж байгаа нь ямарч хууль зүйн үндэслэлгүй болно. Яллагдагчийн хувьд бусдад учруулсан хохирол, төлбөр байхгүй. ИНЕГ-аас ямар нэгэн төлбөр аваагүй, зөвхөн гол төлөв буюу 60 хувь нь гадаадын зорчигчдоос нисэх буудлаар үйлчлүүлсний хураамж авч үйлчилгээ үзүүлсэн болно. Тиймээс ИНЕГ болон Улсад учруулсан хохирол байхгүй болно. “Эс” ХХК-ийн явуулж байгаа үйл ажиллагааг «ЧХ» ОУНБ-ын инженерүүдийн ажил үүргийн хуваарьтай давхацсан гэсэн зүйл дурдсан байсан. Хавтас хэрэгт байгаа «ЧХ» ОУБ-ын инженерүүдийн ажил үүргийн хуваарьд тус компанийн үйл ажиллагаатай давхацсан зүйл ерөөсөө байхгүй байна. «ЧХ» ОУНБ-д тухайн үйл ажиллагааг аваад явах боловсон

хүчин байхгүй. Хоёр компанийн үйл ажиллагааг давхацсан гэж АТГ-аас дүгнэж байгаа боловч “А” ХХК-аас нягталж, асууж тодруулаагүй, тэдний зүгээс программ нийлүүлээгүй, зөвхөн тоног төхөөрөмж л нийлүүлсэн. Гэрээний хугацаа нь дууссан “Эс” ХХК-ийн байгуулсан гэрээ бол үйлчилгээ үзүүлэх тухай гэрээ, нөгөө гэрээ бол тоног төхөөмж нийлүүлэх гэрээ, энэ бол хоёр тусдаа гэрээ болно. Энд лиценз хэрэглүүлсний төлбөр гэж байхгүй, зөвхөн үйлчилгээний хөлс авдаг. Гэрээний утга нь тийм бөгөөд “А” ХХК нь Аийн программыг нийлүүлэх ямар ч боломжгүй. Энэ нь нисэх буудлаар үйлчлүүлж байгаа иргэдийн төлж байгаа мөнгө, төрөөс гарч байгаа төлбөр мөнгө байхгүй. Гол төлөв гадаадын иргэдийн төлж байгаа хураамж төлбөр юм. Эсрэг мэдүүлэг өгсөн аудитор Т.Ба бол ашиг сонирхлын зөрчилтэй. «С» компанийн ашиг сонирхлын зөрчилтэй гэж өмнө нь “М” ХХК-аас халагдаж байсан. Иймд Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан гэмт хэргийн заавал байх шинж болох гэм буруугийн хэлбэр, сэдэлт, санаа зорилго нь бүрэн нотлогдоогүй тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т «Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ» гэж заасны дагуу холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж үзэж байна.

Мөн М.Б нь хүнд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөнийхөө хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор бүлэглэн «МСЛ» гэх нэр бүхий компанийг үүсгэн байгуулж мөнгө угаасан гэж үзэн гэм буруутайд тооцсон. Олон улсын валютын сангийн 1996 онд хийсэн судалгаанаас үзвэл дэлхийн хэмжээнд нэг жилд 590 тэрбумаас 1.5 их наяд ам.долларын хэмжээний бохир мөнгө угаагдаж байна. Энэ нь хамгийн багадаа Испанийн ДНБ-тэй тэнцүү хэмжээний мөнгө юм. Мөнгө угаасан бүх тохиолдлыг илрүүлээгүй учир энэ бол угаагдаж буй мөнгөний бодит хэмжээ биш. Бодит байдал үүнээс ч их байж болох юм. Олон улсын төвшинд мөнгө угаах гэсэн ойлголтыг өргөн хүрээнд хэрэглэдэг. Гэмт хэрэг үйлдэж олсон

орлогоо нуусан, халхалсан, шилжүүлсэн үйлдэлд нь тухайн гэмт этгээдэд анх үйлдсэн гэмт хэрэг дээр нь давхардуулж ял, шийтгэл оноох эсхүл гэмт хэрэгт нь биечлэн оролцоогүй ч түүнээс олсон орлогыг хууль бус гэдгийг нь мэдсээр байж хүлээн авч, нууж, шилжүүлсэн бусад этгээдийг яллан шийтгэхэд мөнгө угаах гэсэн томъёоллыг ашигладаг. Мөнгө угаахтай тэмцэхийн гол зорилго нь хэн нэгэн хүнд гэмт үйлдэлд нь давхар ял онооход бус харин бусад этгээдийг гэмт этгээдэд тус дэм үзүүлж болохуйц үйл ажиллагаа явуулахыг хязгаарлахад оршдог. Энэ нь нэг талаас мөнгө угаах гэмт хэргийг үйлдэх түүнд татагдан оролцохоос сэргийлэх ач холбогдолтой. М.Б нь өөрийн компанийн татвар төлсний дараах ашиг болох мөнгийг БНХАУ-ын Хонгконгоос тоног төхөөрөмж авах системийн техник технологийн шинэчлэх үүднээс шилжүүлж байсан. Мөн БНХАУ-ын Хонгконгын компаниуд дотооддоо худалдаа хийх тохиолдолд тус улсын татварын хуулиар 30-70 хувийн худалдан авах боломжтой байдаг. Иймд тоног төхөөрөмж оруулж ирж Монголд борлуулах үүднээс М.Б нь Хонгконгд байрлалтай «МСЛ» компанийг өөрийн нэрээр нэг хүний эзэмшилтэйгээр байгуулсан. Энэ компанийн данс руу тоног төхөөрөмжийн худалдаа хийх үүднээс нэг удаа өөрийн компанийн Голомт банкны данснаас 2.000.000 ам.доллар шилжүүлээд уг данс руу буцаан авсан. Энэ шилжүүлсэн мөнгө нь ИНЕГ-тай байгуулсан хууль ёсны эх үүсвэр нь тодорхой зохих татвар төлсөн мөнгө байсан. Мөн энэ мөнгөнөөс «А» компанид гэрээний дагуу лицензийн төлбөр гэж 160.000 ам.доллар төлсөн. Эцэст нь тэмдэглэж хэлэхэд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 16 дугаар зүйлд «Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хэргийн байдлыг тал бүрээс нь бүрэн бодитойгоор нотлохын тулд хуульд заасан бүх арга хэмжээг авч сэжигтэн, яллагдагчид, шүүгдэгчийг яллах ба цагаатгах, эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх ба хөнгөрүүлэх нөхцөл байдлыг бүрэн тогтоох..», мөн хуулийн 80 дугаар зүйлд заасныг тогтоох ажиллагаануудыг тухайн хэргийг удаан хугацаанд мөрдөн шалгасан боловч мөрдөн байцаагч, прокурор олж тогтоож чадаагүй болно.

Иймд Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлд заасан бусдын өмчийг завших гэмт хэргийн заавал байх шинж болох гэм буруугийн хэлбэр, сэдэлт, санаа зорилго, хор

хохирол нь бүрэн нотлогдоогүй тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасны дагуу холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэлтэй гэж үзэж байгаа тул М.Б-ыг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан «Бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх», Эрүүгийн хуулийн 166¹.2 дахь хэсэгт заасан “мөнгө угаах” гэмт хэргийг үйлдсэн гэж буруутгах ямар ч үндэслэл алга байх тул эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгон, цагаатган шийдвэрлэж өгнө үү гэв.

Ялтан Д.Э-ын өмгөөлөгч Д.Батбаатар, К.Бауиржан нар хамтран гаргасан давж заалдах гомдол болон Д.Батбаатар тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт зааснаар журамлаж ирүүлсэн хэргийг Анхан шатны шүүх хэргийг шийдвэрлэхдээ «бүлэглэн» гэж хэргийг шийдвэрлээд Д.Э-ын эрх зүйн байдлыг дордуулсан. Д.Э нь ямар буруутай үйлдэл хийсэн талаар шүүх дүгнэлт өгсөнгүй. Энэ хэрэгт эхний тендер нь дараагийн тендертэй давхардсан уу гэдэг дээр дүгнэлт өгөх хэрэгтэй. Сүүлийн тендерийн даргаар ажилласан болохоос биш хүнтэй хамтраад Улс орноо хохироосон үйлдэл Д.Э-ын хувьд байхгүй. С.Б даргын тушаал гарснаар Үнэлгээний хорооны даргаар томилогдсон. Ингээд 5 гишүүнтэй ажиллаж, энэ гишүүдийнхээ адил саналаа өгч тендер явагддаг журмаар явж тэмдэглэл, шийдвэрээ өгч Д.Э-ын үйлдэл дууссан. Өнөөдөр гол нь тендертэй холбоотой 2 компани гарч ирээд байдаг. Дэлхийн хэмжээнд «Ар», «С» ХХК гэдэг хоёр байгууллага зорчигч бүртгэлийн үйл ажиллагаа явуулдаг. Өнөөдөр “А” ХХК нь «Ар», «С» ХХК-тай операторын үйл ажиллагаа явуулах сүлжээний ашиглалтай холбоотой эрхийн гэрээ авсан эсэх талаар шалгаж үзэх хэрэгтэй байх. Энэ тал дээр ямар ч ажиллагаа хийгдээгүй, гэрээ байхгүй. Зөвхөн тоног төхөөрөмж нийлүүлсэн болохоос сүлжээ ашиглалт, программ хангамжтай холбоотой “А” ХХК болон «Ар», «С» ХХК хооронд гэрээ байдаггүй. Харин “Эс” ХХК-тай тоног төхөөрөмж нийлүүлсний дараа үйл ажиллагааг явуулж жигдрүүлэх, Олон улсын нэгдсэн бүртгэл орох асуудалд албан ёсоор гэрээ хийж 3 жилийн хугацаатай хийсэн гэрээ хэрэгт авагдсан. Гэтэл улсын яллагч нь давхардуулж оруулж ирсэн гээд байдаг. Шийтгэх тогтоолын дүгнэх хэсэгт Д.Э-ын хоёр байрыг буцаан олгохоор

дүгнэж, тогтоох хэсэгтээ нэг байрыг буцаан олгохоор заасан. Үүнийг хууль ёсны буцаан олгох нь зүйтэй. Энэ нь бичилтийн алдаа байж магадгүй. Өнөөдөр Д.Э-ыг тендертэй холбоотой оролцсон болохоос биш эд хөрөнгө авсан, завшсан хувьдаа авсан зүйл байхгүй. 1.062.000.000 төгрөгөөс тухайн үед Д.Э-ын дансанд орсон зүйл мөрдөн байцаалтын шатанд тогтоогдоогүй. Өнөөдөр ИНЕГ-ын хохирогч, иргэний нэхэмжлэгч нар хохирол учраагүй гээд байхад 1 тэрбум гаруй төгрөгийн хохирол учруулсан гэж үзээд 1.062.000.000 төгрөгийг хувь тэнцүүлэн гаргуулахаар заасан нь буруу байна. Мөн “А” ХХК-ийн захирлын албан тоотууд байдаг бөгөөд Иргэний Нисэхий ерөнхий газар болон Олон улсын нисэх буудал руу «тусгай лицензтэй программ байдаг учраас тоног төхөөрөмж нийлүүлсний дараа уг эрхээ аваарай» гэдэг зүйлийг явуулж байсан. Үүгээр “А” ХХК нь операторын программ хангамжийн эрхийг аваагүй байсан гэдэг нь харагдаж байна. Иймд Д.Э-ад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож, түүнийг цагаатгаж өгнө үү гэж хүсэж байна гэв.

Ялтан Д.Э-ын өмгөөлөгч Д.Батбаатар, К.Бауиржан нар хамтран гаргасан давж заалдах гомдол болон К.Бауиржан тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Анхан шатны шүүх хэргийг шийдвэрлэж шүүгдэгч нарын оролцоог тодорхойлсон. Оролцоог тодорхойлохдоо хуульд нийцээгүй үндэслэлээр дүгнэлт хийсэн байдаг. Улсын яллагчийн зүгээс «Хамжигч» гэдэг байдлаар Д.Э-ыг оруулж яллах дүгнэлт үйлдэж оруулж ирсэн байдаг. Үүнийг шүүх нотлогдоогүй гэж дүгнээд, гүйцэтгэгчийн хэлбэрээр оролцсон байна гэж дүгнэсэн байгаа юм. Шүүхийн аливаа дүгнэлт нь нотлох баримт дээр үндэслэсэн байх ёстой бөгөөд эдгээр 3 хүнийг хэн нь ямар хэлбэрээр оролцсон гэдгийг нотлож Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 37 дугаар зүйлд зааснаар хэргийг оролцсон оролцоог ялгамжтай тодорхойлох ёстой байсан. Энэ үүднээс шүүх үндэслэл бүхий дүгнэлт гаргаагүй гэж үзсэн. Д.Э нь албан тушаалын байдлаа яаж урвуулан ашигласан болон энэ гэмт хэргийн улмаас ямар хохирол учирсан гэдгийг тогтоогоогүй байж ял шийтгэл оногдуулсан гэдэг үндэслэл гаргаж байна. Тухайн тендерүүд хоорондоо давхардсан эсэх тал дээр дүгнэлт хийх ёстой байсан. Анхан шатны шүүх давхардсан гэдэг байдлаар дүгнэж ял шийтгэл оногдуулсан. “Эс” ХХК-ийн суурилуулсан программ

хангамжийг салгахад тухайн “А” ХХК-ийн суурилуулсан тоног төхөөрөмжөөр бүртгэлийн үйл ажиллагааг цааш нь үргэлжлүүлж явуулах боломжтой байсан эсэхийг шалгах боломжтой байсан. Гэхдээ ийм боломж байхгүй. Учир нь “Эс” ХХК-ийн суулгасан «vMUSE» программыг салгаснаар Улсад их хэмжээний хохирол учирна гэдгийг Иргэний Нисэхийн ерөнхий газар болон Нисэх буудлын ажилчид мэдүүлэг өгсөн. Харин анхан шатны шүүх хуралдаанд оролцсон гэрч нар «тухайн 2 компанийн хийж гүйцэтгэсэн ажлууд давхцаагүй» гэдэг мэдүүлгийг өгсөн. Энэ нь 2 тендер давхцаагүйг харуулж байна. Нөгөө талаар “Эс” ХХК-ийн худалдаж авсан “vMUSE” программ 300.000.000 төгрөгийг өртөгтэй бол “А” ХХК-ийн тендерээр хийж гүйцэтгэсэн 299.000.000 төгрөг болж байгаа. Д.Э-ын үйлдэлд албан тушаалын байдлаар урвуулан ашигласан гэдэг асуудалд гэмт хэргийн бүрэлдэхүүн байна уу гэдэг зүйлд шүүх дүгнэлт хийх ёстой байсан. Д.Э нь ямар байдлаар албан тушаалаа урвуулан ашигласан гэдэг нь хэрэгт цугларсан нотлох баримтуудаар нотлогддоггүй. Өөрөөр хэлбэл, Д.Э нь Иргэний Нисэхийн ерөнхий газрын даргын тушаалаар томилогдож зохих журмын дагуу бүх ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Д.Э нь дангаараа “Эс” ХХК-ийг сонгон шалгаруулах талаар идэвхтэй үйлдэл хийгээгүй буюу шийдвэр гаргаагүй. Хамтын шийдвэрээр энэ асуудлыг шийдвэрлэсэн. Энэ нь хэрэгт авагдсан баримтуудаар нотлогдоно. Мөн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн оролцоо нь ямар байсан юм. “Эс” ХХК-тай гэрээ байгуулж, гэрээний дагуу мөнгөн шилжүүлэг хийж, тэр нь М.Б-ын өөртөө аваад ашиглаж байгаа үйлдэлд Д.Э-ын хувьд ямар ч оролцоо байхгүй. Энэ талаар үндэслэл бүхий дүгнэлт хийгээсэй гэж хүсэж байна. Д.Э-ын ойр дотны хүмүүсийн эд хөрөнгийг шалгасан бөгөөд бүх хүмүүсийн орлогыг тодорхойлсон. М.Б-оос мөнгө авч ашиглаж, завшсан зүйл нотлогдоогүй. Иймд эдгээр нөхцөл байдлуудыг харгалзан үзэж түүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэсэн хүсэлттэй байна гэв.

Ялтан Д.Э-ын өмгөөлөгч М.Хувцагаан давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Улсын яллагчаас Д.Э-ад Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг журамлан ял төлөвлөсөн. Гэтэл анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн

4-т Эрүүгийн хуулийн 35 дугаар зүйлийн 35.6-д заасныг өөрчилсөн нь шүүгдэгч Д.Э-ын эрх зүйн байдлыг дордуулж хохироолоо. Учир нь мөрдөн байцаалтын шатанд, улсын яллагч Д.Э-ыг энэ хэрэгт гүйцэтгэгч биш хамжигчаар оролцсон гэж үзэн хөнгөн зүйл ангиар ялласан байхад шүүх өөрийн эрх хэмжээгээ хэтрүүлэн гүйцэтгэгч болгосноор Д.Э-ын хувийн байдлыг дордуулж шүүх хууль буруу хэрэглэсэн нь шийтгэх тогтоол хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх зарчим алдагдсан. Монгол Улсын Дээд шүүхийн 2003 оны 10 дугаар тогтоолоор бүлэглэн гүйцэтгэсэн гэж үзэх бол урьдчилан үгсэн тохирсон аль эсхүл үйлдлээрээ бүлэглэсэн гэсэн 2 өөр хэлбэрээр бүлэглэн үйлдэгддэг байна. Тэгвэл С.Б, Д.Э, М.Б нар дээрх бүлэглэн үйлдсэн гэдгийн аль хэлбэрээр үйлдсэн тухай хавтаст хэрэгт ямар ч нотлох баримт байхгүй байхад шүүх юуг үндэслэн дүгнээд байгаа нь хууль буруу хэрэглэж байгаагийн нэг жишээ гэж үзэж байна. ИНЕГ-ын даргын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн А/62 тоот тушаалаар ИНЕГ-ын ТББ/Б-73/11 тоот «Нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж суурилуулах тендер болон ажил гүйцэтгэх гэрээ» байгуулахад Д.Э ямар хэлбэрээр, ямар үүрэг хүлээж оролцсон болоод, албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлыг урвуулсан үйлдэл хийсэн гэдэг нь нотлогдоогүй. Үндэслэл нь хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтуудаас үзвэл энэ А/62 тоот тушаал нь Д.Э-ад огт хамаагүй, тушаал гаргахад огт оролцоогүй, тендерийн Үнэлгээний хорооны дарга, түүний гишүүн биш, тендерийн 299 сая төгрөгийн гэрээг байгуулахад огт оролцоогүй бөгөөд “А” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлын талаар ямар ч мэдээлэл ойлголт байхгүй тэр үйл ажиллагаанд оролцоогүй болох нь нотлогдож байна. Анхан шатны шүүх Д.Э-ыг ямар баримтыг үндэслэж “А” ХХК-ийн урд хийж гүйцэтгэсэн ажлыг давхардуулсан байдлаар ИНЕГ-ын харьяа «ЧХ» ОУНБ-ын инженер техникийн ажилчдын үндсэн чиг үүрэгт хамаарах, тэдгээрийн ажил үүргийн хуваарьт тусгагдсан операторын ажил гүйцэтгүүлэхээр “Эс” ХХК-ийг хууль бусаар сонгон шалгаруулсан гэж буруутгаж байгаа нь тодорхойгүй байна. ИНЕГ-ын даргын 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар «ЧХ» ОУНБ-д зорчигч бүртгэлийн сүлжээний операторыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг томилоход Д.Э

ямар ч оролцоогүй түүний санаа зорилгоос үл хамааран 5 хүний бүрэлдхүүнтэй хороог ИНЕГ-н дарга С.Б өөрийнхөө эрх хэмжээний хүрээнд тушаал гаргаж томилсон байна. Дээрх тушаалын дагуу Үнэлгээний хорооны гишүүд хуралдаж хязгаарлагдмал тендер зарласан нь нотлогдон, Үнэлгээний хорооны гишүүдийн 100 хувийн саналаар “Эс” ХХК-ийг шалгаруулан захиалагчид саналаа хүргүүлсэн. Хэрэгт цугларсан баримтуудаас үзвэл «Электрон системс» ХХК гэрээнийхээ дагуу «ЧХ» ОУНБ-д «А» компанийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын эрхийг 2011 онд авсан. Тэгээд зорчигч бүртгэлийн «vMUSE» дундын хэрэглээний системийн нэгдүгээр түвшний операторын эрх буюу аюулгүй найдвартай ажиллагааг ханган ажиллаж байгаа. Одоо ч энэ үйлчилгээг тасралтгүй явуулсаар байна. Д.Э-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар байгууллагын өмчийг итгэмжлэгдэн хариуцсан этгээд завшсан гэж буруутгаж байгаа ч уг хэргийн объект болсон 1.062.000.000 төгрөгнөөс авч завшсан ямар ч хөрөнгө байхгүй мөрдөн байцаалтын шатанд түүнийг ямар өмч хөрөнгөтэй талаар нарийвчлан шалгасан. Д.Э нь байгууллагын эд хөрөнгийг итгэмжлэн хариуцсан этгээд биш бөгөөд ИНЕГ-ын данснаас гүйлгээ хийх захиран зарцуулах эрх байхгүй. ИНЕГ-ын данснаас “Эс” ХХК-ийн дансанд зорчигч бүртгэлийн төлбөр гэж мөнгө шилжсэн. Энэ мөнгийг шилжүүлсэн этгээд нь С.Б, С.А нар юм. Хүлээн авагч нь хуулийн этгээд болох “Эс” ХХК бөгөөд уг мөнгийг захиран зарцуулах эрх нь гагцхүү М.Б-од байна. М.Б удаа дараагийн мэдүүлэгтээ «Би үйлчилгээний төлбөрийг ИНЕГ-аас авсан. Тухайн мөнгөнөөс орлогын албан татварт 175 сая төгрөг, «А» компанийн оюуны өмч болох “vMUSE” системийг ашигласны төлбөрт 280 сая төгрөг төлсөн гэх бөгөөд уг төлбөрүүд төлсөн баримтууд хавтаст хэрэгт хангалттай авагдсан байна. Нөгөө талаар М.Б нь Д.Э-ад ямар нэгэн байдлаар мөнгө өгч байгаагүй. Харин орон сууц худалдан авахад мөнгө дутаад ББСБ-аас Д.Э-аар зээл бэлэн бусаар авахуулж эргүүлэн төлөхдөө тухайн ББСБ-ын дансанд шилжүүлсэн байдаг. ИНЕГ-аас “Эс” ХХК-ийн дансанд шилжүүлсэн 3 удаагийн гүйлгээний бүх мөнгийг авч захиран зарцуулсан этгээд нь М.Б болох нь нотлох баримтаар бүрэн нотлогдоод байхад сэжиг, таамгаар Д.Э-ыг мөнгө ашигласан гэж хохирол төлүүлэн

яллаж байгаа нь үндэслэлгүй байна.

Анхан шатны шүүхээс Үнэлгээний хороо нь давхардуулсан байдлаар “Эс” ХХК-ийг хууль бусаар сонгон шалгаруулсан гэж үзсэн. Тэгвэл Үнэлгээний хорооны дарга болон гишүүд нь өмнө ямар тендер зарлагдаж байсныг огт мэдэхгүй байсан. Тендер зарлах тухай тушаалыг хүлээн аваад Үнэлгээний хорооны бүх гишүүд 100 хувийн саналтайгаар “Эс” ХХК-ийг шалгаруулсан. Хурлын тэмдэглэлээс үзэхэд гишүүд тус бүр нэг саналын эрхтэй оролцож 100 хувийн саналаар хамтын шийдвэр гаргасан байхад Д.Э ганцаараа хариуцлага хүлээх нь шударга бус явдал болж байна. ИНЕГ-ын даргын гаргасан тушаалаар зарлагдсан тендер давхардаж байгааг Үнэлгээний хорооны дарга мэдэх боломжгүй юм. Тэгээд ч захирах, захирагдах чиг үүргийн дагуу даргынхаа тушаалыг биелүүлэх үүрэгтэй нь хэнд ч ойлгомжтой байх. Эцэст нь зорчигч бүртгэлийн үйл ажиллагаа явуулсан төлбөр болох 1.062.000.000 төгрөгийг завшсан, албаны эрх мэдэл буюу албан тушаалын давуу байдлыг урвуулсан гэж буруутгаж байгаа боловч уг мөнгийг 3 удаа ИНЕГ-ын дарга С.Б “Эс” ХХК-ийн дансанд шилжүүлсэн үйлдэл нь үргэлжилсэн үйлдэл юм. Операторын үйлчилгээг «ЧХ» ОУНБ-д хариуцуулбал орлого нь орж ирнэ тэр хирээр ажилчдын цалин орлого нэмэгдэнэ гэсэн хэсэг хүмүүсийн сонирхол байхыг үгүйсгэхгүй. Мөн энэ операторын бүртгэлийн “vMUSE” систем нь «А» компанийн оюуны өмч юм. Энэ өмчийг гэрээ хэлцлийн үндсэн дээр “Эс” ХХК нь тодорхой хугацаагаар эзэмшдэг. Нарийн төвөгтэй тоног төхөөрөмж учир өндөр мэдлэг ур чадвар дадлага туршлагатай тусгай сургалтад суралцаж шалгалт өгч гэрчилгээ авсан ажилтан уг үйлчилгээг явуулдаг. Оюуны өмч ашиглуулсны төлөө тодорхой хэмжээний төлбөр авах эрх, үүрэг үүссэн албан ёсны гэрээг “Эс” ХХК болон «А» ХХК нарын хооронд 2012 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр байгуулсан байна. Гэтэл «А» компани нь “vMUSE” программын лицензийг эзэмших эрх аваагүй, ямар ч гэрээ хэлцэл байхгүй мөртлөө суурилуулсан гээд байгаа нь тус компани тоног төхөөрөмжөө ИНЕГ-т хүлээлгэн өгөхдөө “Эс” ХХК-ийн «Ар» корпорациас 160.000 ам.доллороор 2012 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр худалдаж авсан лицензтэй программыг суулгаж, туршилт хийж өгснийг хэлээд байгааг шүүх хурлын үеэр ялгаж, салгаагүй. Улсын яллагч

болон анхан шатны шүүх уг гэрээг яллах цагаатгах ямар ч талаас нь ач холбогдол өгч судалсангүй. «А» компани нь тоног төхөөрөмж, хэрэглээний болон дэмжигч, хөтөч программуудыг суурилуулсан бөгөөд “Эс” ХХК нь зорчигч бүртгэлийн «vMUSE» программын лицензийг эзэмших эрхийн дагуу нийлүүлж суурилуулан ажиллаж байна. Энэ утгаараа анхан шатны шүүх эрх зүйн ухамсрыг удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай бүрэн гүйцэт бодит байдлаар хянаж үзнэ гэсэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 985 дугаар зүйлийн 95.2-т заасныг зөрчсөн.

Анхан шатны шүүх «шинжээч Х.Э-г зохих мэдлэг дадлага туршлагатай гаргасан дүгнэлтийнхээ хариуцлагыг хүлээх эрх бүхий шинжээч дүгнэлт гаргасан байх тул хууль ёсны үнэн зөв баримт» гэж үнэлсэн. Шинжээч Х.Э зорчигч бүртгэлийн операторын үйл ажиллагаа явуулах үйлчлэгчийг сонгон шалгаруулах тендер нь хуулийн 32 дугаар зүйлд заасан «Мэргэжлийн өндөр ур чадвар туршлага, техник, технологи шаардсан нарийн төвөгтэй бараа ажил үйлчилгээ гүйцэтгэх чадвартай этгээдийн тоо хязгаарлагдмал» гэсэн заалтад хамаарахгүй юм гэж дүгнэлт гаргасан. Энэ үйлчилгээг дэлхий дахинд хоёрхон компани явуулахаар оюуны өмчийн эрх авсан бөгөөд нарийн төвөгтэй биш байсан бол бусад компани ашиглалтын лиценз аваад байх ямар шаардлага байгаа юм. Энэ чиглэлийн үйл ажиллагаа болоод техник технологийг үйлдвэрлэж борлуулдаг хоёрхон компани байдаг гэдгийг олон гэрч гэрчилсэн байна. Шинжээч Х.Э-гийн хувьд зорчигч бүртгэлийн техник тоног төхөөрөмж технологи болон бүртгэлийн үйл ажиллагааны талаар огт ойлголтгүй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 85 дугаар зүйлийн 85.1-д зааснаар «Шинжээч тусгай мэдлэгийнхээ хүрээнд өөрийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргаж түүнийгээ өөрөө хариуцна» гэж заасан бөгөөд Х.Э-гийн биеийн байцаалтаас үзвэл мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага техник технологи шаардсан нарийн төвөгтэй бараа ажил үйлчилгээ гэдгийг мэдэх тусгай мэдлэг эзэмшээгүй хүн болох нь ойлгогдоно. Иймд уг дүгнэлт нь нотлох баримтын шаардлага хангахгүй баримт учир яллах үндэслэл болохгүй гэж үзэж байна. Тендерийн урьдчилгаа төлбөрийг 2012 ондоо “Эс” ХХК болон ИНЕГ-ын хоорондын тооцоогоор суутган төлж дуусгасан бөгөөд

ИНЕГ-ын балансад 2012 онд ямар нэгэн өр төлбөр гаргаагүй нь хавтаст хэрэгт буй аудитын тайлангаар батлагдаж байна. Зорчигч бүртгэлийн операторын үйлчилгээг «ЧХ» ОУНБ-ын инженер техникийн ажилчид эрхлэн гүйцэтгээгүй, тийм боломж бүрдээгүй талаар дотоод аудитор Т.Ба-ын мэдүүлэг болон бусад гэрчийн мэдүүлгээр давхар нотлогдсон нь тендер давхардаагүй болохыг нотлож байна.

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 6-д Д.Э-ын эд хөрөнгө болох хх-хх УНЗ улсын дугаартай автомашиныг хураасан нь буруу. Энэ автомашины эзэмших эрх нь Д.Э-ын нэр дээр байдаг боловч уг автомашин нь Д.Э-ын хуваарьт хөрөнгө биш гэр бүлийн гишүүдийн дундын хөрөнгө бөгөөд сургууль, цэцэрлэгийн 2 хүүхдээ зөөдөг өдөр тутмын чухал хэрэгцээт эд хөрөнгө учир бага насны хүүхдийн эрх ашиг хөндөгдөхөд хүрч байгааг анхаарч үзнэ үү. Ер нь Д.Э-ын хувьд бусадтай бүлэглэж бусдын өмчийг завшсан, мөн эрх мэдлээ урвуулсан гэх үйлдэлд оролцоогүй тул үйлдэл холбогдлыг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэв.

Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, иргэний нэхэмжлэгч П.А тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Тус шүүх хуралдаанд манай удирдлагаас Т.Б дарга тайлбар хийхээр ирсэн учраас миний зүгээс хэлэх тайлбар байхгүй гэв.

Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, иргэний нэхэмжлэгч хуралдаанд гаргасан тайлбартаа:

Манай удирдлагаас тайлбар хийх учраас миний зүгээс хэлэх тайлбар байхгүй гэв. Хохирогчийн хууль ёсны төлөөлөгч, иргэний нэхэмжлэгч Н.М тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа:

Зорчигч бүртгэлийн дундын “vMUSE» систем нь олон улсад иргэний нисэхийн чиглэлийн тусгай мэргэжлийн программ хийдэг хоёрхон компанийн нэг болох АНУ-ын «Ар» компанийн бүтээгдэхүүн бөгөөд уг системийг «ЧХ» Олон улсын нисэх буудлаар үйлчлүүлэгч зорчигч бүртгэлийн үйл ажиллагаанд нэвтрүүлсэн нь Монгол Улс нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн шаардлага, Аялал жуулчлалыг хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх, Агаарын тээврийг хялбаршуулах Засгийн газрын хөтөлбөр, иргэний нисэхийн талаар төрөөс баримтлах бодлого, агаарын тээвэрт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх төрийн

бодлогод тус тус нийцсэн байна. Мөн Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2011 оны «Жагсаалт батлах тухай» 189 дүгээр тушаалаар баталсан Иргэний нисэхийн ерөнхий газрын 2010 оны цэвэр ашгаар санхүүжигдэн гүйцэтгэх төсөл арга хэмжээний жагсаалт болон ИНЕГ-ын 2012 оны урсгал зардалд тусгагдсан, Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу хийгдсэн ажил бөгөөд “Эс” ХХК-ийн нийлүүлэн ашиглаж байгаа АНУ-ын «А» компанийн бүтээгдэхүүн болох Зорчигч бүртгэлийн дундын «vMUSE» систем нь “А” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн тоног төхөөрөмж нийлүүлж суурилуулах ажилтай давхардаагүй, «ЧХ» Олон улсын нисэх буудал нь зорчигч бүртгэлийн дундын системийг олон улсын нислэгийн бүртгэлийн үйл ажиллагаанд өнөөдрийг хүртэл ашиглаж байгаа ба энэхүү системийн тусламжтайгаар олон агаарын тээвэрлэгчийн зорчигч бүртгэлийн үйл ажиллагааг нэгдсэн байдлаар, хялбаршуулан явуулах болсон билээ. Зорчигч бүртгэлийн дундын «vMUSE» системийн ашиглалт, засвар үйлчилгээний эрхийг 2015 оны 1 дүгээр улирал дуустал “Эс” ХХК бүрэн эзэмшиж байгааг энэ хоёр компанийн хооронд байгуулсан гэрээ, мөн «А» компанийн төлөөлөгч Монгол Улсад нэг бус удаа ирж ИНЕГ-ын төлөөлөлтэй уулзах үедээ “Эс” ХХК нь “vMUSE” системийг ашиглах албан ёсны компани гэж баталсан нь «ЧХ» Олон улсын нисэх буудал АНУ-ын «Ар» компанитай шууд гэрээ байгуулан ажиллах боломжгүй гэдгийг харуулж байгаа юм. Энэхүү эрүүгийн хэрэгт Сангийн яамнаас томилогдсон гэх шинжээч Х.Э-гийн гаргасан дүгнэлт учир дутагдалтай бөгөөд тендерийн хуулийн дагуу хийгдсэн, зорчигчийн хураамжийг төсвийн орлого гэж буруу ойлгон, дүгнэлт гаргахдаа хууль зөрчсөн гэж оруулсан нь алдаатай болжээ. Учир нь Иргэний нисэхийн ерөнхий газар болон «ЧХ» Олон улсын нисэх буудал нь Төрийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар (ТӨААТҮГ)-ын гэрчилгээтэй, үйл ажиллагааны орлогоороо санхүүждэг байгууллагууд болохыг үгүйсгэн дүгнэсэн байна. Хэдийгээр өөрөө өөрийгөө санхүүжүүлдэг агентлаг байхгүй ч Иргэний нисэхийн ерөнхий газрын хувьд Олон улсын иргэний агаарын тээврийн байгууллага ИКАО-гийн конвенцийн 92.87 ба 97.34 дүгээр баримт бичигт «Иргэний нисэхийн навигацын орлого бол тухайн улсын иргэний нисэхийн салбарын аюулгүй

ажиллагааг хангахад болон түүний хөгжилд захиран зарцуулна» гэж заасны дагуу улсын төсөвт төвлөрүүлэх орлогоос бусад орлогыг өөрийн санхүүжилтэд Улсын үйлдвэрийн газрын статусаар захиран зарцуулдаг. Зорчигчийн хураамж бол төсвийн орлого гэх ямарч үндэсгүй бөгөөд тухайн зорчигчоос нисэх буудлын үйлчилгээ авсныхаа хариуд хийсэн төлбөр гэж үзэх ёстой юм. Гэтэл шинжээч энэ бүхнийг нарийвчлан судлаагүй, мэргэжлийн туршлага дадлага дутмаг, хэт нэг талыг барьсан дүгнэлт гаргахыг хичээсэн байдал анзаарагдаж байгаа тул шинжээч Х.Э-гийн дүгнэлт эргэлзээтэй гарсан гэж үзэж байна. “Эс” ХХК-тай холбоотой Иргэний нисэхийн ерөнхий газрын 2013, 2014 оны санхүүгийн үйл ажиллагаанд өглөгөөр болон авлагаар бүртгэгдсэн ямар нэг гүйлгээ хийгдээгүй, харин 2012 оны санхүүгийн тайлан дээрх «Эс» компанид 242,698,845.50 төгрөгийн өглөг тусгагдсан байдаг. Мөн ИНЕГ-ын 2012, 2013 оны санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн Үндэсний Аудитийн Газрын шалгалтын тайлан, мөн 2012 оны 12 дугаар сар, 2013 оны 01 дүгээр сард Монгол Улсын Засгийн Газрын хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга Д.Д-гийн удирдамжаар ИНЕГ-т хийсэн шалгалтын тайланд ч “Эс” ХХК-ийнн зорчигч бүртгэлийн системтэй холбоотой санхүүгийн зөрчил дутагдал дурдагдаагүй байна. Энэхүү эрүүгийн хэрэг нь Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ганцхан жил ажилласан С.Бу-ын хувийн өс хонзонгийн сэдэлтэйгээр өмнөх удирдлагуудаа хилс хэрэгт гүтгэн, ямар ч аргаар хамаагүй буруутгаж, ял хүлээлгэх гэсэн зохиомол хэрэг гэж ойлгогдож байна. «ЭС» ХХК, «А» компанитай байгуулсан гэрээ байсаар байхад тус компанийг «А» компанийн «vMUSE» системийн албан ёсны төлөөллийн байгууллага гэж үзэх боломжгүй, зөвшөөрөлгүй гэж ташаа дүгнэсэн. Иргэний нисэхийн ерөнхий газар болон “Эс” ХХК-ийнн хооронд байгуулсан хүчин төгөлдөр гэрээний дагуу олгосон урьдчилгаа төлбөрийг буруутгаж дүгнэсэн. 2 дахь дүгнэлтдээ өмнө гаргасан дүгнэлтийнхээ зарим хэсгийг хасаж, зөвхөн дарга С.Бу-д танилцуулсан болгож АТГ-д хүргүүлсэн байдаг. Иргэний нисэхийн ерөнхий газрын зүгээс анх 1000 төгрөг болон 4000 төгрөгийн 2 өөр гэрээ хийгдсэн гэдгийг шалгаж өгөхийг хүссэн бөгөөд хэрэв 1000 төгрөгийн гэрээ байвал зөрүү болох 3000 төгрөгөөр хохирсон хэмээн үзэж байсан боловч мөрдөн байцаалтын шатанд үүнийг

хэрэгсэхгүй болгосон. С.Бу нарын алдаатай, буруу үйлдлүүдийг залруулж, шүүхэд үнэн зөв, бодитой мэдээллийг өгөх үүднээс энэхүү эрүүгийн хэрэгт Иргэний нисэхийн ерөнхий газар болон «ЧХ» Олон Улсын нисэх буудлын удирдлагууд байр, сууриа удаа дараа тайлбартаа илэрхийлэн «ЧХ» Олон улсын нисэх буудлын захирал О.Н-ын 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 15/1214 тоот, 2014 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 15/938 тоот, Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Л-гийн 2014 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн 01/1949 тоот, 2014 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 0/2189 тоот албан бичгээр хүргүүлснийг хавтаст хэрэгт баримтаар авагдсан байна. Эцэст дурдахад энэхүү эрүүгийн хэргийн улмаас Иргэний нисэхийн ерөнхий газар, «ЧХ» Олон улсын нисэх буудалд болоод Улсад хохирол учраагүй, хохирогч байхгүй байгаа тул гэмт хэргийн бүрэлдхүүнгүй гэж үзэж байгаа бидний байр суурийг шүүх үнэлж хэргийг үнэн зөвөөр хянан шударга шийдвэрлэнэ гэдэгт найдаж байна. Иргэний нисэхийн ерөнхий газар, «ЧХ» Олон улсын нисэх буудал нь энэ хэрэгт хохирогч биш, хохирол учраагүй болохыг үүгээр батлан тайлбарлаж байна гэв.

Прокурор Н.Амарсанаа тус шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтэд Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 289 дугаар тогтоолоор Агаарын тээврийг хялбаршуулах үндэсний хөтөлбөр батлагдсаны дагуу зорчигч бүртгэлийн системийг хялбаршуулах шинэ систем нэвтрүүлэхийн тулд зорчигч бүртгэлийн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай техник тоног төхөөрөмж, программ хангамжийн тендер шалгаруулалтаар 2011 онд “А” ХХК-ийг шалгаруулж, “А” ХХК-аас техник, тоног төхөөрөмжийг зорчигч бүртгэлийн программ хангамжийн иж бүрдэл «vMUSE» лицензийн хамт “А” ХХК-аас ИНЕГ-т 2012 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр нийлүүлэн худалдаж өгсөн байдаг. Уг гэрээгээр “А” ХХК зорчигч бүртгэлийн дундын систем болох “vMUSE” системийг суурилуулж нутагшуулах, боловсон хүчнийг сурган бэлтгэж өгөх тухай үүрэг хүлээсэн байдаг. Ингээд тухайн техник, тоног төхөөрөмжийг зорчигч бүртгэлийн программ хангамжийн иж бүрдэл “vMUSE» лицензийн хамт хүлээлгэн өгч ашиглалтад оруулсантай холбогдуулан ИНЕГ-ын «ЧХ»

ОУБ-ын мэдээлэл технологийн албанд уг ажлыг хариуцуулахаар 4 ээлжийн инженерийн орон тоог ИНЕГ-ын даргын 2012 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн №А/377 тоот «Орон тоонд өөрчлөлт оруулах тухай» тушаал болон ИНЕГ-ын даргын зөвлөлийн хурлын шийдвэрээр баталж өгсөн байдаг. Энэ үед М.Б нь мэдээлэл технологийн албанд сүлжээ, мэдээллийн инженерээр ажиллаж байсан ба нисэх буудлын зүгээс хариуцан техник, тоног төхөөрөмжийг зорчигч бүртгэлийн программ хангамжийн иж бүрдэл “vMUSE” лицензийн хамт хүлээн авч байсан байдаг. Энэ нь ИНЕГ-ТББ/Б-73/11 тоот гэрээ, “А” ХХК-с нийлүүлсэн орлогын падаан, 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “А” ХХК-аас ИНЕГ тоног төхөөрөмж программ хангамж хүлээн авсан ажлын комиссын актаар тогтоодог. Гэтэл зорчигч бүртгэлийн операторын үйл ажиллагаа явуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог ИНЕГ-ын даргын 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар томилж томилогдсон Үнэлгээний хороо ИНЕГ/У/ХББ/Б-04/12 дугаартай тендерийг 2012 оны 01 дүгээр сарын 26-наас 2012 оны 02 дугаар сарын 15-ны хооронд зарлан явуулсан байгаа. Уг тендерт оролцох урилгыг 2012 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 07/229 тоот албан бичгээр «Ар» компанийн албан ёсны төлөөлөгч гэх “Эс” ХХК, Монгол дахь «С»-гийн төлөөлөгчийн газруудад хүргүүлсэн боловч «С»-гийн төлөөлөгчийн газарт явуулсан үнийн санал авах урилга нь 2012 оны 02 дугаар сарын 07-ны өдөр очсон бөгөөд уг материалаас тодруулга авах бичгийг 2012 оны 02 дугаар сарын 08-ны өдөр ирүүлж Үнэлгээний хороо 2012 оны 02 дугаар сарын 09-ний өдөр хариу тодруулгыг өгсөн байгаа нь тендерт оролцогчдыг тэгш боломжоор хангаагүй байдаг. Ингээд ИНЕГ, “Эс” ХХК-ийн хооронд 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдөр ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот гэрээ байгуулагдсан ба “А” ХХК-аас техник, тоног төхөөрөмжийг зорчигч бүртгэлийн программ хангамжийн иж бүрдэл “vMUSE” лицензийн хамт нийлүүлээгүй байхад буюу 2012 оны 02 дугаар сарын 28-нд 300.000.000 төгрөг, 02 дугаар сарын 29-нд 236.331.000 төгрөг шилжүүлсэн байдаг. Харин сүүлийн хоёр гүйлгээ нь 2012 оны 10, 12 дугаар сард шилжсэн байдаг. Энэ үед М.Б-ын улсын болон хувийн ажил нь давхцаж эхэлсэн учраас гадаадад сургалтад явах болсон

гэсэн шалтгаанаар 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдөр ажлаасаа чөлөөлөгдсөн байдаг. Энэ нь «ЧХ» нисэх буудлын захирлын 2013 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн №Б/48 дугаартай тушаалаар нотлогддог. ИНЕГ, “Эс” ХХК-ийн хооронд 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдөр байгуулагдсан ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот гэрээ нь 8.2, 9.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн ба Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны 2012 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй байсан гэдэг нь Сангийн яамны Хууль, Худалдан авах ажиллагааны бодлогын газрын ахлах мэргэжилтэн Х.Э-ийн дүгнэлт, байцаалтаар нотлогддог. Мөн “Эс” ХХК-аас 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдөр гэрээ байгуулах тухай, 2012 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр гэрээний төсөл хүргүүлэх тухай албан бичгүүдийг гэрээний төслийн хамт Өөрөөр хэлбэл, тендер зарлагдаагүй байхад ИНЕГ-ын даргын нэр дээр хүргүүлж байсан гэдэг нь нотлогддог. Мөн С.Б-ийн 2012 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн Б/65 тоот тушаалаар Д.Э, М.Б нар нь 2014 оны 03 дугаар сарын 16-ны өдрөөс 2014 оны 03 дугаар сарын 20-ны өдрүүдэд БНХАУ-ын Хонгконг Улсад албан томилолтоор явдаг ба ингэж явахдаа “МСЛ” гэх нэр бүхий компанийг үүсгэн байгуулсан байдаг. Томилолтын материалд Хонгконгийн талаас ирүүлсэн ямар нэгэн уулзалтын тов урилга болон албан томилолтоор ажилласан тайлан, илтгэл авагдаагүй байгаа нь үүнийг нотолж байгаа. “МСЛ” гэх нэр бүхий компанийг үүсгэн байгуулсан талаарх баримтууд мөн хавтаст хэрэгт авагдсан байгаа. “ТББЭБ” ББСБ-тай Д.Э нь 2012 оны 02 дугаар сарын 03-ны өдөр гэрээ байгуулж 110.000.000 төгрөгийн зээл авч 109.450.000 төгрөгийг “Эс” ХХК-ийн Голомт банкны 110268xxxx тоот төгрөгийн дансанд тушаасан ба зээлийг 2012 оны 03 дугаар сарын 2-ны өдөр “Эс” ХХК-аас «ТББЭС» ББСБ-ын Голомт банкны 200100xxxx тоот дансанд 111.760.000 төгрөгийг тушааж, зээл, зээлийн хүүгээ хаасан байдаг. “Эс” ХХК нь операторын үйл ажиллагаа буюу бүртгэлийн программ дээр бүртгэл хийгдээгүй. Бүртгэлийг авиа компаниудын бүртгэгч нар өөрсдөө бүртгэлээ явуулж байгаа. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Б, Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежер, газрын даргаар ажиллаж байсан Д.Э нар нь албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаар урвуулан 2011 онд

сонгон шалгаруулсан “А” ХХК-ийн урьд хийж гүйцэтгэсэн ажлыг буюу “А” ХХК-аас «ЧХ» олон улсын буудлаас томилогдсон ажлын хэсэгт 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр тоног төхөөрөмж, программ хангамжийн иж бүрдэл, түүнчлэн зорчигч бүртгэлийн «vMUSE» системийг 3 жил ямар нэг төлбөргүй ашиглах лиценз, тэдгээр дээр ажиллах боловсон хүчнийг сургаж бэлтгэх ажлын хамт хүлээлгэн өгсөн байхад дахин давхардуулсан байдлаар болон Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яамны 2012 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, ИНЕГ-ын харьяа «ЧХ» олон улсын буудлын инженер, техникийн ажилчдаар хийж гүйцэтгүүлэх боломжтой «Оператор»-ын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр “Эс” ХХК-ийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.2, 9.2-т заасныг тус тус зөрчин хууль бусаар сонгон шалгаруулж “Эс” ХХК-тай 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 3 жилийн хугацаагаар «vMUSE» системээр бүртгүүлсэн зорчигч тутамд 4.000 төгрөгийн хураамж төлөх нөхцөл бүхий «ЧХ» олон улсын буудалд зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулж, нийт 4 удаагийн гүйлгээгээр 1.062.959.000 төгрөгийг “Эс” ХХК-ийн дансанд шилжүүлж, улсад хүнд хор уршиг буюу онц их хэмжээний хохирол учруулсан. Иргэний нисэхийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Б, Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежерээр ажиллаж байсан Д.Э, “Эс” ХХК-ийн захирал М.Б нар нь “Эс” ХХК-ийнн «Голомт» банкны дансанд ИНЕГ-аас гэрээт ажлын төлбөр гэх үндэслэлээр шилжүүлсэн нийт 1.062.959.200 төгрөгийг завшиж улсад онц их хэмжээний хохирол учруулсан. “Эс” ХХК-ийн захирал М.Б нь “Эс” ХХК-ийнн «Голомт» банкин дахь дансаар шилжүүлэн авч завшсан буюу Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөнийхөө хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор Их Британи Виржиний арлуудад « МСЛ « гэх нэр бүхий компанийг үүсгэн байгуулж мөн «АЭБ» ХХК-ийн захирал Б.Б-гийн Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулсан «ТКЛ» компанийн дансуудаар нийт 507.500 ам. долларыг шилжүүлж улмаар “Эс” ХХК-ийн Голомт банкин дахь данс, иргэн Ц.Б-гийн

ХХБанк дахь дансуудаар буцаан хүлээн авч, мөнгө угаасан гэмт хэргийг тус тус үйлдсэн болох нь тогтоогдсон. Хохирогч, иргэний нэхэмжлэгч П.А, Н.М, гэрч Б.Гб, П.Ха, З.Ту, Ц.Га, Л.Эр, Я.Ч.А, Г.Дө, Ц.Ц, П.Б, Я.Д, Б.Мө, П.Эц, Ч.Хо нарын мөрдөн байцаалтад өгсөн мэдүүлгүүд, С.Б, Д.Э нарын ажлаас чөлөөлсөн, ажилд томилогдсон, ИНЕГ-ын даргын тушаал, ажлын байрны тодорхойлолт, ИНЕГ-ын даргын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн А/62 тоот, 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А54 тоот тушаалууд, ИНЕГ “А” ХХК-ийн хооронд байгуулсан болон ИНЕГ “Эс” ХХК-ийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнүүд, ИНЕГ-ын үндсэн хөрөнгийн 2012 оны баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл, үзлэгээр бэхжүүлж авсан 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “А” ХХК-аас ИНЕГ-т тоног төхөөрөмж, программ хангамж хүлээлгэн өгсөн, хүлээн авсан тухай акт, ИНЕГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Бун баталсан удирдамжийн дагуу санхүүгийн хэсэгчилсэн хяналт шалгалт хийсэн тайлан, “Эс” ХХК-ийн 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 5/41 дугаартай ИНЕГ-ын дарга С.Б-ийн нэр дээр ирүүлсэн албан бичиг, хавсралт болох ажил үйлчилгээ үзүүлэх тухай гэрээний загвар, ИНЕГ-ын 2012 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 07/229 тоот «С» компанид хүргүүлсэн албан бичиг, «С» компаниас 2012 оны 02 дугаар сарын 08-ны өдөр ИНЕГ-т хүргүүлсэн тендерийн лавлагаа авах албан бичиг, ИНЕГ-ын даргын 2012 оны тушаалуудад үзлэг хийсэн тэмдэглэл, үзлэгээр бэхжүүлж авсан ИНЕГ-ын даргын 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн А/377 тоот «Орон тоонд өөрчлөлт оруулах тухай» тушаал болон ИНЕГ-ын даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн хуулбар, Сангийн яамны мэргэжилтэн Х.Э-гийн гаргасан дүгнэлт, шинжээчээр байцаасан байцаалтын тэмдэглэл, Төлбөрийн даалгавар, нэхэмжлэх, гэрээт ажлын төлбөр тооцох хуудас М.Б-ын электрон шууданд агуулагдаж буй мэдээлэлд үзлэг хийсэн тэмдэглэл, «ТББЭС» ББСБ-с Д.Э 110 сая төгрөг зээлсэн тухай зээлийн гэрээ, “Эс” ХХК-аас уг зээлийг буцаан төлсөн баримт, М.Б-ын болон “Эс” ХХК-ийн ам.долларын дансуудад үзлэг хийсэн тэмдэглэл, дансны хуулгууд, 1.062.959.200 төгрөгийг “Эс” ХХК-ийн дансанд шилжүүлсэн гүйлгээтэй холбоотой ИНЕГ-ын санхүүгийн баримтад үзлэг хийсэн тэмдэглэл, холбогдох баримтууд зэрэг хэрэгт

авагдсан бусад нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдсон. Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 1025 дугаартай шийтгэх тогтоол хууль ёсны ба үндэслэлтэй гарсан, тогтоолд дурдсан дүгнэлт хэргийн жинхэнэ байдалтай нийцсэн, мөрдөн байцаалтын ажиллагаа, шүүхийн хэлэлцүүлэг бүрэн гүйцэт явагдсан учраас шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх саналтай байна гэв.

Прокурор Р.Очирсүрэн тус шүүх хуралдаанд гаргасан дүгнэлтдээ:

Ялтан С.Б, Д.Э нарын албаны эрх мэдлийн байдлаа урвуулсан нь хэрэгт авагдсан баримтуудаар тогтоогддог. Үүнд 2011 “А” ХХК-аас явуулсан зорчигч бүртгэлийн систем буюу нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц ажлын нийлүүлэн суурилуулах ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулалтаар 300.000.000 төгрөгийн тоног төхөөрөмжийг Иргэний Нисэхийн Ерөнхий газар суурилуулж өгсөн байдаг. Үүнд М.Б нь Иргэний Нисэхийн Ерөнхий газар, «ЧХ» Олон улсын нисэх буудал сүлжээний инженерээр ажиллаж байсан бөгөөд “А” ХХК-аас хүлээлгэж өгсөн программ хангамж буюу «vMUSE» системийг хүлээн авсан баримтад гарын үсэг зурсан баримт нь хэрэгт авагдсан бөгөөд “vMUSE” системийн лиценз нь нийт 110.880.000 төгрөгийн тоног төхөөрөмжийн багц, тоног төхөөрөмжтэй хүлээн авсан болон хүлээлгэж өгсөн баримт авагдсан байгаа. Тэгэхээр С.Б, Д.Э нар нь 2011 онд “А” ХХК-аас суурилуулж өгсөн тоног төхөөрөмж, программ хангамжид 2012 онд «Эс» ХХК-аас явуулсан үйл ажиллагааг давхардуулсан байдлаар олгосон байдгийг тухайн үед М.Б нь сүлжээний инженерээр ажиллаж байсан “А” ХХК ямар тоног төхөөрөмж, программ хангамжийг ямар байдлаар Иргэний Нисэхийн Ерөнхий газар суурилуулж өгч байсан гэдгийг мэдэж байсан. Мөн М.Б нь “А” ХХК-ийн захирал Б.Гб-тай Их сургуульд нэг ангид сурч байсан гэж хэлдэг. Энэ талаар М.Б нь «vMUSE» системийг хүлээж аваагүй бөгөөд энэ талаар анзаараагүй гэж мэдүүлж байсан боловч хэрэгт авагдсан баримтаар хүлээж аваад гарын үсэг байдаг. Д.Э нь “Эс” ХХК-тай байгуулсан гэрээндээ ямар байдлаар хамтран ажилласан, урд нь Д.Э М.Б-ыг таньдаг байсан. “Эс” ХХК Иргэний Нисэхийн Ерөнхий газартай 2012 оны 02 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулагдсан байдаг. Гэрээ байгуулагдахаас өмнө 2012

оны 02 дугаар сарын 3-ны өдөр М.Б нь Д.Э-аар дамжуулан «ТББЭС» ББСБ дамжуулан ямар нэгэн барьцаа хөрөнгөгүй 110.000.000 төгрөгийг дамжуулж авсан байдаг. Ингээд 2012 оны 02 дугаар сарын 03-ны өдөр мөнгө аваад 2012 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Иргэний Нисэхийн Ерөнхий газраас зарлагдсан тендерт “Эс” ХХК ямар нэгэн компанийн өрсөлдөгчгүйгээр ялсан байдаг. Энэ нь 2012 оны 01 дүгээр сарын 27-нд тендер зарлагдсан албан бичгийг “Эс” ХХК-д хүргүүлсэн. Харин 2012 оны 02 дугаар сарын 7-нд «С» ХХК-д утсаар ярьж мэдэгдсэн. Ингээд «С» ХХК хугацаа богино байгаа учраас тендерт оролцох боломжгүй гэдгээ мэдэгдэж, “Эс” ХХК тендерт ялсан байдаг юм. Ингээд “А” ХХК “vMUSE” системийг суулгасантай холбоотой М.Б тухайн үедээ ажиллаж байгаад “Эс” ХХК-тай байгуулсан гэрээтэй холбоотой М.Б Иргэний Нисэхийн Ерөнхий газрын ажлаасаа гарсан байдаг. 2012 оны 02 дугаар сарын 26-ны өдөр гэрээ байгуулагдаж, ямар нэгэн ажил үүрэг эрхлээгүй байтал 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдөр “Эс” ХХК-д Иргэний Нисэхийн Ерөнхий газраас 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 236.000.000 төгрөг урдчилсан байдлаар шилжсэн. Ингээд М.Б нь энэ шилжсэн мөнгийг юунд зарцуулсан болон ямар тоног төхөөрөмжийг тухайн тендерт холбогдолтой худалдаж авсан эсэхийг шалгаж баримтжуулахад 2010-2013 оны хооронд “Эс” ХХК-ийн нэр дээр гадаадын байгууллагуудаас ямар нэгэн тоног төхөөрөмж орж ирээгүй. М.Б нь мөрдөн байцаалтын шатанд Хонгконгоос тоног төхөөрөмж авахаар мөнгө шилжүүлсэн гэдэг боловч энэ нь баримтаар тогтоогдоогүй. Ингээд М.Б нь «А Э Б» ХХК-тай гадаадад компани үүсгэн байгуулах талаар хамтран ажилласан байдаг. «АЭБ» ХХК-д хуулийн зөвлөхөөр ажилладаг Б.М хэзээ, хэний нэрээр компани байгуулж өгсөн талаар болон Д.Э, М.Б нар гүйцэтгэх захирлаар, Ч.Ө, Х.Г нар ТУЗ-ын гишүүний байдалтай ажиллаж байсан талаар гэрчийн мэдүүлэг өгсөн. Энэ компани байгуулагдсантай холбогдуулж Д.Э, М.Б нар Хонгконгод ажилласан. Д.Э, М.Б нарын явах болсон шалтгаан нь Хонгконгод компани байгуулсан учраас банкинд данс нээсэнтэй холбоотой гарын үсэг зайлшгүй зурах шаардлагатай болсон. Ингээд Д.Э, М.Б Иргэний Нисэхийн Ерөнхий газрын томилолтоор гадаад руу ажлаар явсан боловч Иргэний Нисэхийн

Ерөнхий газрын албан тушаалтантай уулзаж ямар ажлаар явсан эсэх талаар болон томилолтын гүйцэтгэл хаана байгаа талаар асуухад энэ талаар авагдсан ямар ч баримт байхгүй. Одоо Иргэний Нисэхийн Ерөнхий газарт “Эс” ХХК-ийн 3 инженер, 3 ээлжээр ажилладаг бөгөөд тухайн тоног төхөөрөмжийн доголдол, эвдрэл гэмтлийг засаж байгаа. Тэрнээс бид нар ямар нэгэн байдлаар операторын үйл ажиллагаа явуулдаггүй гэж мэдүүлсэн байгаа. Ингээд тоног төхөөрөмжийг шалгаад үзэхэд “А” ХХК-аас суурилуулж өгсөн программ хангамж байсан. Гэтэл “Эс” ХХК тухайн гэрээтэй холбоотой ямар тоног төхөөрөмж авч тавьсан гэхээр М.Б-ын нэг ангийн хүн болох Ц.Эт-өөс бодитой тоног төхөөрөмж байхгүй зөвхөн процессор, хулгана гэх мэт үнийн дүнтэй тоног төхөөрөмж авсан байдаг юм. Ингээд М.Б нь Иргэний Нисэхийн Ерөнхий газраас авсан мөнгөө 3 удаагийн гүйлгээгээр Хонгконг руу шилжүүлсэн байдаг. Харин буцаж шилжин ирэхдээ М.Б-ын дансаар «АЭБ» ХХК-ийн хуулийн зөвлөх ажилтны нэрээр шилжин ирсэн. Мөнгөний зарцуулалтыг харахаар тус мөнгөнүүдийг бэлнээр авч эхнэрийн хамаатанд 80.000.000 төгрөгийн өртэй байсан учраас энэ өрийг өгсөн гэж мэдүүлдэг. Тус гэрчээс мэдүүлэг авахад эхлээд авлагатай байсан учраас авлагаа авсан гэдэг хэрнээ 2 дахь мэдүүлэгтээ М.Б-ын шаардлагаар худлаа ярьсан гэж мэдүүлгээсээ буцсан. Иргэний Нисэхийн Ерөнхий газраас авсан мөнгө хаашаа яаж зарцуулагдсан нь тодорхойгүй. Хэрэгт авагдсан шинжээч Х.Э-гийн дүгнэлтээр хоёр гол зүйл дурдагдсан байдаг. Үүнд «тухайн тендер нь нээлттэй явагдах ёстой байтал хязгаарлагдмал явагдаж хууль бус тендер явагдсан байна. Иргэний Нисэхийн Ерөнхий газар нь төрийн байгууллага бөгөөд уг хуульд заасан захиалагч тул бүхий л тендер шалгаруулалтыг уг хуульд нийцүүлэн зохион байгуулах ёстой. Өөрөөр хэлбэл, зорчигчоос төвлөрүүлсэн хураамжаас хамааруулж худалдан авах ажиллагааг хууль бусаар зохион байгуулах эрхгүй Төрийн байгууллага» гэдэг дүгнэлтийг гаргасан бөгөөд энэ дүгнэлттэй холбогдуулж шинжээчийг байцаасан. Мөн мөрдөн байцаалтын шатанд «ЧХ» ОУНБ-ын Мэдээлэл, технологийн албаны дарга П.Б нь тухайн тоног төхөөрөмж дээр өөрсдийн ажилчдаасаа сургалтад хамруулах боломжтой байтал “Эс” ХХК-ийн ажилчдад өгөхөөр нь бид нар гайхаж байсан.

Ингээд сүүлд “Эс” ХХК манайд ажиллаж байсан М.Б гэдэг хүний компани болох нь бид сүүлд мэдсэн гэж мэдүүлсэн. Мөн «ЭЧ», «М», «Аэ», «Х Э» гэх мэт байгууллагуудыг тухайн системийг ашиглаж байгаа эсэхийг шалгахад “Эс” ХХК-ийн суурилуулсан тоног төхөөрөмжийг ашигладдаггүй гэдэг мэдээллийг өгсөн. Мөн өмгөөлөгч нар «А» ХХК-ийн Ази дахь төлөөлөгч К.С.О гэх хүнтэй уулзаж тайлбар авсан гэдэг боловч хэрэгт авагдсан баримт дээр яг уулзаж, баримт авсан юм уу гэж үзэхээр тухайн хүний гарын үсэг байдаггүй. “vMUSE” системийг үнэхээр Иргэний Нисэхийн ерөнхий газрын санхүү хүлээлгэж өгсөн эсэхийг хэрэгт авагдсан баримтаас үзэхэд Иргэний Нисэхийн ерөнхий газрын санхүү нягтлан бодох бүртгэлийн дарга Ц.Ц-ын мэдүүлэгт “А” ХХК-аас суурилуулж өгсөн «vMUSE» систем манай санхүүгийн баримтад тусгагдаж орсон. Энэ баримт нь байгаа гэдэг мэдүүлгийг өгсөн. Мөн тухайн эд хөрөнгөд үзлэг хийж баримтыг бэхжүүлж авсан. Эдгээр баримтуудыг дүгнэж үзэхэд “А” ХХК-аас суурилуулж өгсөн программ хангамжид «ЧХ» Олон Улсын буудлын инженер техникийн ажилчид нь эвдрэл гэмтлийг засаад явах боломжтой байсан.

2012 онд “Эс” ХХК-тай Иргэний Нисэхийн Ерөнхий газартай гэрээ байгуулах хууль зүйн үндэслэлгүй бөгөөд хууль бус тендер шалгаруулсан байна гэдэг нь шинжээчийн дүгнэлт хохирогч гэрч нарын мэдүүлгүүд болон бусад бичгийн нотлох баримтуудаар хангалттай тогтоогдож байна гэж улсын яллагчийн зүгээс үзэж байна. Мөрдөн байцаалтын шатанд Иргэний Нисэхийн Ерөнхий газраас П.А, Н.М гэж 2 хүн хохирогчоор тогтоогдож хэрэгтэй танилцсан. Гэтэл Давж заалдах шатны шүүх хуралдаанд О.Н гэж хүнийг иргэний нэхэмжлэгчээр тогтоосон гээд байх юм. Үүнийг ойлгохгүй байна. Мөн С.Бу-гийн үйлдлийг голлож яриад байна. С.Бу-тай холбоотой үйлдлийг Авлигатай тэмцэх газар шалгаж сүүлийн 230.000.000 төгрөгийн үйлдэлд нь С.Б нарын үйлдлээс тусад нь шалгаад явж байгаа. Энэ хэрэгт Иргэний Нисэхийн Ерөнхий газар хохирогчоор тогтоогдсон. Т.Б-ын уншсан баримтыг хүлээн зөвшөөрөхгүй байна. Иймд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоол хууль ёсны үндэслэлтэй гарсан байх тул шийтгэх тогтоолыг хэвээр үлдээх саналтай байна гэв.

ХЯНАВАЛ:

С.Б, М.Б, Д.Э, Г.Н нарт холбогдох эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.1-д зааснаар “...шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор...” эцэслэн хянан шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлтэй байна.

Прокуророос Эрүүгийн хуулийн 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т зааснаар зүйлчилж мөнгө угаах гэмт хэргийг үйлдсэн гэж яллах дүгнэлт үйлдсэн хэргийн хувьд С.Б, Г.Н, Д.Э нарыг гэмт үйлдэлд оролцоогүй, тэднийг уг гэмт хэргийг үйлдсэн гэх нотлох баримт хангалттай авагдаагүй гэж дүгнэж тэдэнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон нь,

Г.Н-ийг Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж шүүхэд шилжүүлсэн хэргийг нотлох баримтаар тогтоогдоогүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, цагаатгасан нь хууль зүйн үндэслэлтэй болжээ.

Хэргийн үйл баримтын талаар:

ИНЕГ-ын даргын 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/62 тоот тушаалаар «Нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж, суурилуулах» ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хороог томилж, энэхүү Үнэлгээний хороо нь “А” ХХК-ийг сонгон шалгаруулж, 2011 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс «Нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж, суурилуулах» ажил гүйцэтгэх 299.314.623 төгрөгийн үнийн дүнтэй гэрээг байгуулан “А” ХХК нь ажлаа бүрэн дуусгаж 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдөр нийт 108 нэр төрлийн 172 ширхэг тоног төхөөрөмж, 9 нэр төрлийн 1 багц, 56 ширхэг программ, хангамжийн иж бүрдэл, түүн дотор зорчигч бүртгэлийн “vMUSE” системийг 3 жил ямар нэг төлбөргүй ашиглах лиценз, тэдгээр дээр ажиллах боловсон хүчнийг сургаж бэлтгэх ажлын хамт ИНЕГ-т хүлээлгэн өгсөн байна.

Гэтэл Иргэний нисэхийн Ерөнхий газрын дарга С.Б, уг газрын Агаарын тээврийн бодлого зохицуулалтын ерөнхий менежер Д.Э нар нь албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ИНЕГ-ын даргын 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот «ЧХ» Олон улсын буудалд «Зорчигч бүртгэлийн сүлжээний оператор»-ыг сонгон шалгаруулах нэртэйгээр Үнэлгээний хороог томилж, хорооны даргаар шүүгдэгч Д.Э нь ажиллаж, 2011 онд сонгон шалгаруулсан ИНЕГ-ТББ/Б-73/11 тоот

тендерийн ялагч “А” ХХК-ийн урьд хийж гүйцэтгэсэн ажилд «Оператор»-ын үйлчилгээ явуулах нэрийдлээр ИНЕГ-ын харьяа «ЧХ» Олон улсын буудлын инженер, техникийн ажилчдын үндсэн чиг үүрэгт хамааруулж, тэдгээрийн ажил үүргийн хуваарьт тусган хийж гүйцэтгүүлэх боломжтой операторын ажлыг хийж гүйцэтгүүлэхээр «ЧХ» Олон улсын буудлын сүлжээний инженерээр ажиллаж байсан М.Б-ын мэдлийн “Эс” ХХК-ийг хууль бусаар сонгон шалгаруулсан тогтоогдсон байна.

Тухайлбал, ИНЕГ-ын даргын даргын 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар байгуулагдсан «Зорчигч бүртгэлийн сүлжээний оператор»-ыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны шийдвэрээр тендерийг 2012 оны 01 дүгээр сарын 26-наас 02 дугаар сарын 15-ны хооронд 20 хоногийн дотор «хязгаарлагдмал» байдлаар, гадаадын хуулийн этгээдийг оролцуулахгүй байдлаар зарлан явуулсан,

Тендерт оролцвол зохих Олон улсын агаарын тээврийн холбооны мэдээллийн нийгэмлэг «SITA» Монгол дахь суурин төлөөлөгчид 2012 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 07/229 дугаартай тендерийн урилга, албан бичгийг 2012 оны 02 дугаар сарын 07-ны өдөр 10 хоногийн дараа гардуулан өгч, ИНЕГазраас тендертэй холбогдох тодруулга хүссэн зэргээс шалтгаалж хугацаа алдсанаас тухайн байгууллага нь уг тендерт оролцоогүй,

улмаар энэхүү тендерт М.Б-ын мэдлийн “Эс” ХХК нь дангаараа тендерийн баримтаа ирүүлснээр Үнэлгээний хорооны шийдвэр гаргуулж гэрээ байгуулах эрх авсан,

ИНЕГазрын дарга С.Б, “Эс” ХХК-ийн захирал А.Ба /М.Б-ын эхнэр/ нар нь 2012 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс 3 жилийн хугацаанд “vMUSE» системээр бүртгүүлсэн зорчигч тутамд 4.000 төгрөгийн хураамж төлөх нөхцөл бүхий «ЧХ» Олон улсын буудалд зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгэх гэрээг байгуулж, энэхүү гэрээний дагуу урьдчилгаа нэрийдлээр маргааш нь 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 226.628.000 төгрөг, нийт 1.062.959.200 төгрөгийг хууль бусаар “Эс” ХХК-ийн дансанд шилжүүлж, ИНЕГ-т хүнд хор уршиг буюу 1.062.959.200 төгрөгийн онц

их хэмжээний хохирол учруулсан,

“Эс” ХХК-ийг операторын үйл ажиллагаа эрхлүүлэхээр сонгосон энэхүү тендер шалгаруулалт болон баримт бичиг бүрдүүлсэн байдал нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай Монгол Улсын хууль болон Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгийг үндэслэх ёстой байтал энэ бүгдийг зөрчиж, М.Б-ын эзэмшлийн “Эс” ХХК-ийг илтэд дэмжиж, улмаар тухайн хуулийн этгээдийн “Голомт” банкин дахь 110268xxxx тоот дансанд ИНЕГ-аас гэрээт ажлын төлбөр гэх нэрийдлээр 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр шилжүүлсэн 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр шилжүүлсэн 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 09-ний өдөр шилжүүлсэн 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр шилжүүлсэн 226.628.000 төгрөг, нийт 1.062.959.200 төгрөгийг завшиж онц их хэмжээний хохирол учруулсан нь тогтоогдсон байна.

Мөн М.Б нь “Эс” ХХК-ийн «Голомт» банкин дахь 110268xxxx тоот дансаар шилжүүлэн авч завшсан буюу Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан онц хүнд гэмт хэрэг үйлдэж олсон мөнгөнийхөө хууль бус эх үүсвэрийг нь халхавчлах, нуун далдлах, түүнчлэн аливаа этгээдийг хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор Их Британи Виржиний арлуудад /BRITISH VIRGIN ISLANDS/ “МСЛ” гэх нэр бүхий компанийг үүсгэн байгуулж, улмаар “МСЛ” ХХКн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-27041x-xxx тоот харилцах дансанд 2013 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр ...ам.доллар шилжүүлж улмаар “Эс” ХХК-ийн “Голомт” банкин дахь 110272xxxx тоот дансаар 2013 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 144.960 ам.долларыг буцаан хүлээн авсан,

“АЭБ” ХХК-ийн захирал Б.Б-гийн Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулсан “ТКЛ” компанийн БНХАУ-ын Засаг захиргааны тусгай бүс Хонконг дахь HSBC банкин дахь 848-2728x-xxx тоот харилцах дансанд 2012 оны 03 дугаар сарын 29-ний өдөр 155.000 ам.доллар шилжүүлж улмаар, 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 153.993 ам.доллар,

2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 39.968 ам.долларыг тус тус Ц.Б-гийн “Худалдаа хөгжлийн банк”-н дахь 45313xxxx

тоот дансаар дамжуулан М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-н дахь 45102xxxx тоот дансаар буцаан хүлээн авсан,

“ТКЛ” компанийн HSBC банкин дахь 848-2728x-xxx тоот харилцах дансанд 2012 оны 10 дугаар сарын 9-ний өдөр 202.500 ам.доллар шилжүүлж, улмаар 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 199.993 ам.долларыг М.Б-ын “Худалдаа хөгжлийн банк”-н дахь 45102xxxx тоот дансаар тус тус М.Б буцаан хүлээн авч мөнгө угаасан гэмт хэрэг тогтоогджээ.

Шүүгдэгч нарын төрийн албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласан, бусдын эд хөрөнгийг бүлэглэн завшиж онц их хэмжээний хохирол учруулсан, мөн мөнгө угаах гэмт хэргийг үйлдэж онц их хэмжээний хохирол учруулсан дээрх үйлдлийг анхан шатны шүүх зөв зүйлчилж, С.Б-ийг Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар, Д.Э-ыг Эрүүгийн хуулийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар, М.Б-ыг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.3, 166¹ дүгээр зүйлийн 166¹.3-т зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь үндэслэлтэй байна.

Дээрх үйл баримт нь мөрдөн байцаалтын шатанд хэрэгт цугларсан, анхан шатны шүүхийн хэлэлцүүлгээр шинжлэн судалсан дараахь нотлох баримтууд, С.Б, Д.Э нарыг ажлаас чөлөөлсөн, ажилд томилсон ИНЕГ-ын даргын тушаал /5-р хх-208-215/, ажлын байрны тодорхойлолт, ИНЕГ-ын даргын 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн А/62 тоот, 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалууд, ИНЕГ, “А” ХХК-ийн хооронд байгуулсан болон ИНЕГ, “Эс” ХХК-ийн хооронд байгуулсан ажил гүйцэтгэх гэрээнүүд /11-р хх-34-49/, ИНЕГ-ын үндсэн хөрөнгийн 2012 оны баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл, үзлэгээр бэхжүүлж авсан 2012 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн “А” ХХК-аас ИНЕГ-т тоног төхөөрөмж, программ хангамж хүлээлгэн өгсөн, хүлээн авсан тухай акт /26-р хх-116-138/, ИНЕГ-ыг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Бу-ын баталсан удирдамжийн дагуу санхүүгийн хэсэгчилсэн хяналт шалгалт хийсэн тайлан /1-р хх-24-31/, “Эс” ХХК-ийн 2011 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн №5/41 тоот ИНЕГ-ын дарга С.Б-ийн нэр дээр ирүүлсэн албан бичиг, уг албан бичгийн хавсралт болох ажил үйлчилгээ үзүүлэх тухай

гэрээний загвар /11-р хх-21-33/, ИНЕГ-ын 2012 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн №07/229 тоот «С» компанид хүргүүлсэн албан тоот, «С» компаниас 2012 оны 02 дугаар сарын 8-ны өдөр ИНЕГ-т хүргүүлсэн тендерийн лавлагаа авах тухай албан бичиг /22-р хх-124-125/, ИНЕГ-ын даргын 2012 оны тушаалуудад үзлэг хийсэн тэмдэглэл болон үзлэгээр бэхжүүлж авсан ИНЕГ-ын даргын 2012 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн №А/377 тоот «Орон тоонд өөрчлөлт оруулах тухай» тушаал болон ИНЕГ-ын даргын зөвлөлийн хурлын шийдвэрийн хуулбар /26-р хх-97-114/, «ЧХ» Олон улсын нисэх буудлын инженер, техникийн ажилчдын ажлын байрны тодорхойлолт, ажил үүргийн хуваарь /6-р хх-1-45/, Сангийн яамны мэргэжилтэн Х.Э-гийн гаргасан дүгнэлт /6-р хх-80-83/, шинжээчийг байцаасан тэмдэглэл /6-р хх-ийн 84-87/, төлбөрийн даалгавар, нэхэмжлэх, гэрээт ажлын төлбөр тооцох хуудас /26-р хх-142, 143-144, 162, 163, 164, 166, 168, 169, 171, 174, 175/, М.Б-ын электрон шууданд агуулагдаж буй мэдээлэлд үзлэг хийсэн тэмдэглэл /12-р хх-100-158/, «ТББЭС» ББСБ-аас Д.Э 110 сая төгрөг зээлсэн тухай зээлийн гэрээ /11-р хх-50-53/, “Эс” ХХК-аас уг зээлийг буцаан төлсөн баримт /11-р хх-54-56/, хэрэгт авагдсан М.Б-ын «Худалдаа хөгжлийн банк»-н дахь 45102xxxx дугаартай ам.долларын данс, “Эс” ХХК-ийн 110272xxxx дугаартай ам.долларын дансуудад үзлэг хийсэн тэмдэглэл, дансны хуулгууд /11-р хх-156-182/, 2012 оны 02 дугаар сарын 28-ны өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 236.331.200 төгрөг, 2012 оны 10 дугаар сарын 9-ний өдөр 300.000.000 төгрөг, 2012 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 226.628.000 төгрөг, нийт 1.062.959.200 төгрөгийг “Эс” ХХК-ийн дансанд шилжүүлсэн гүйлгээтэй холбоотой ИНЕГ-ын санхүүгийн баримтад үзлэг хийсэн тэмдэглэл, холбогдох баримтууд, мөнгөн шилжүүлэг /26-р хх-139-176/, «ТББЭС» ББСБ-с Д.Э 110 сая төгрөг зээлсэн тухай 2012 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн №3Г2012/01 дугаартай зээлийн гэрээ, эх хувь /11-р хх-50-53/, “Эс” ХХК-аас «ТТББЭБ» ББСБ-д Д.Э-ын авсан зээлийг төлсөн баримт эх хувь, мөн «Худалдаа хөгжлийн банк»-ны баримт эх хувь, «Голомт» банкны гадаад төлбөрийн даалгавар /11-р хх-54-56/, Ц.Б-гийн «Худалдаа хөгжлийн банк»-ны 45313xxxx тоот ам.долларын дансанд 2012 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр гадаад мөнгөн шилжүүлэг буюу

свифт үйлчилгээгээр 154.001.95 ам.доллар, 2012 оны 05 сард 39.968.00 ам.доллар шилжин ирсэн, М.Б-ын «Худалдаа хөгжлийн банк»-ны 45102xxxx төгрөгийн дансаар гадаад мөнгөн шилжүүлгээр буюу свифт үйлчилгээгээр 2010 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 199.993.00 ам.доллар хүлээн авсан талаарх лавлагаа авах тогтоол /7-р хх-109/, «Худалдаа хөгжлийн банк»-аас ирүүлсэн Ц.Б-гийн «Худалдаа хөгжлийн банк»-ны 45313xxxx тоот ам.долларын дансанд 2012 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр 153.993.00 ам.доллар, 2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр 39.968.00 ам.долларын гадаад гүйлгээний баримт, М.Б-ын «Худалдаа хөгжлийн банк»-ны 45102xxxx тоот дансанд 2010 оны 10 дугаар сарын 09-ний өдөр 199.993.00 төгрөгийн гадаад гүйлгээний баримтууд /7-р хх-110-146/, «АЭБ» ХХК-ийн байрнаас хураан авсан бичиг баримтад үзлэг хийсэн тухай тэмдэглэл, “Эс”ХХК-ийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар, дүрэм, 2012 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн Хууль зүйн туслалцаа үзүүлэх гэрээ /13-р хх-232-235, 26-р хх 80-96/

Шүүгдэгч С.Б-ийн мөрдөн байцаалтад өгсөн «...Зорчигч бүртгэлийн систем нь дан ганц «М» ТӨХК дээр олон жил төвлөрч ирсэн байдаг. Энэ системийг «С» компанийн өндөр үнэтэй техник, технологиор хийгдсэн системийг авч ашиглаж байсан. Зах зээлийн харилцаанд шилжиж байгаа өнөөгийн үед нэг агаарын тээвэрлэгч компани энэ үйл ажиллагааг дангаар гүйцэтгэж байх нь зохимжгүй байсан. Өөрөөр хэлбэл, төр, хувийн хэвшлийн агаарын тээвэрлэгч компаниуд бий болсон. Монгол Улс руу нисдэг гадны агаарын тээвэрлэгч компаниудын тоо өссөн. Агаарын тээвэрлэгч компаниудаас бүртгэлийн системийг нэг компанид төвлөрүүлж монопольчуулж байгаа нь зохимжгүй байгаа талаар шүүмжлэл ирдэг байсан. Ингээд энэ байдлыг зах зээлийн зөв гольдролд нь оруулахын тулд агаарын тээвэрт хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэх төрийн бодлого, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих төрийн бодлого, аялал жуулчлалыг хөгжүүлэх төрийн бодлого, Иргэний нисэхийн талаар төрөөс баримтлах бодлогын бичиг баримтыг хэрэгжүүлэх, иргэний агаарын тээвэрт шинэ техник, технологи хэрэгжүүлэх, зорчигч олон түмэнд жигд соёлтой чанартай үйлчилгээг нэвтрүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд Олон улсын иргэний агаарын тээврийн

байгууллагаас тавигддаг, зөвлөмж, шаардлага, Иргэний нисэхийн тухай хууль, Агаарын зайн тухай хууль, Улсын нисэхийн тухай хууль, Худалдан авах ажиллагааны хууль, Компанийн тухай хууль, Терроризмтой тэмцэх дэлхийн нийтийг мэдээллээр хангах зорилго, бодлогыг хангах, нисэхийн аюулгүй ажиллагаа, нисэхийн байдлыг хангах тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухайн хууль, Тухайн жилийн төсвийн тухайн хууль зэрэгт нийцүүлж Зорчигч бүртгэлийн системийг «ЧХ» ОУНБ-д төвлөрүүлэх ажлыг зохион байгуулсан. Энэ нь «ЧХ» ОУНБ-д төвлөрөн үйл ажиллагаа явуулж буй бусад төрийн байгууллагатай харилцан, хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлсэн юм. Манай газраас зохион байгуулсан тендерийн хүрээнд «А» компани нь бүртгэлийн системийн тоног төхөөрөмжийг нийлүүлсэн. «Эс» компани нь бүртгэлийн системийн программ, сүлжээний асуудлыг шийдвэрлэж, нийлүүлсэн. Тийм учраас дээрх 2 ажил нь давхардсан ажил биш. Давхардсан тендер биш. 2 дахь тендерийн санхүүжилт нь төсвийн хөрөнгө биш, зорчигчид тухайн бүртгэлийн системийг ашиглан үйлчлүүлсэн төлбөрөө тухайн нислэгийн билетийн таксын үнэлгээнд хамруулж төлж байгаа төлбөрөөс санхүүжсэн. Өөрөөр хэлбэл, зорчигч олон түмнээс үйлчилгээнийхээ төлөө төлж байгаа төлбөр юм. Тийм учраас Худалдан авах төлөвлөгөөнд тусгах шаардлагагүй. Ер нь тэгээд нэмж хэлэхэд өмнө нь энэ таксын мөнгө Гадаад улсын «С» компанид шууд шилждэг байсныг өөрчилж Монгол Улсын иргэний компанийг дэмжсэн юм. Миний бие тендерт шалгарсан “Эс” ХХК-тай гэрээ байгуулж, энэ хугацаанд нийт 4 удаагийн төлбөр хийгдсэнээс 3 гүйлгээг нь гарын үсэг зурж шилжүүлсэн. Үүнээс цааш тухайн компани мөнгөө хэрхсэн талаар огт мэдэхгүй. Гадаадад компани үүсгэн байгуулахад нь эхнэрийнхээ нэрийг оруулсан асуудал байхгүй...» /25-р хх-19-49/,

Шүүгдэгч Д.Э-ын мөрдөн байцаалтад өгсөн «...ИНЕГ-ын даргын 2012 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/54 тоот тушаалаар «ЧХ» ОУНБ-д Зорчигч бүртгэлийн сүлжээний операторыг сонгон шалгаруулах Үнэлгээний хороо байгуулагдаж, Үнэлгээний хорооны даргаар намайг томилсон байсан. Ингээд Үнэлгээний хороог хуралдуулж, тендерийг хэрхэн явуулах талаар ярилцсан. Тэгээд «А» компани нь бүртгэлийн системийн тоног төхөөрөмж суурилуулсан юм байна,

одоо бид энэ тоног төхөөрөмж бүхий системийн операторын үйл ажиллагааг явуулах гүйцэтгэгчийн талаар ярилцахад дэлхийд «С», «Ар» гэж 2 компани энэ үйл ажиллагааг эрхэлдэг юм байна гэдгийг олж мэдсэн. Ингээд Үнэлгээний хорооны гишүүн н.Ц гуай угаасаа энэ төрлийн үйл ажиллагаа явуулдаг 2 компани л байдаг юм бол тухайн 2 компанидаа урилга явуулж, хязгаарлагдмал байдлаар тендер зарлах санал тавьсны дагуу ярилцаж хязгаарлагдмал байдлаар зарлахаар болсон. Ингээд тендерийн материалаа, урилгын хамт «С» компанийн Монгол дахь төлөөлөгчийн газарт болон, «Ар» компанийн төлөөлөгч “Эс” ХХК-д хүргүүлсэн. Ингээд тендерийн урилга дээр заасан тендерийг нээх хугацаа болоход “Эс” ХХК-аас санал ирсэн байсан бөгөөд «С»-гийн төлөөлөгчөөс огт санал ирээгүй байсан. Тэгээд Үнэлгээний хороог хуралдуулж, «Ар»-ийн төлөөлөгч “Эс” ХХК-ийн материалтай танилцахад «А» компанийн үндсэн серверээр бүртгэл дамжиж, энэ үйл ажиллагааг «Ар» компани хариуцаж, “Эс” ХХК-ийн хувьд Монгол дахь үйл ажиллагааг хариуцах юм байна гэж ойлгоод “Эс” ХХК-ийг шалгаруулья гэж шийдсэн. Ингээд гэрээ байгуулах зөвлөмжийг захиалагчид хүргүүлсэн. Үүгээр миний ажил үүрэг дууссан гэж ойлгож болно. Тендер шалгаруулалтын явцад М.Б-ыг “Эс” ХХК-тай гэж мэддэггүй байсан. Хэрвээ мэдсэн бол түүнтэй хамтран гадаадад компани байгуулах асуудал ярилцахгүй байх байсан. Тэгээд ч Ч.Ө, Г.Чи, М.Б нартай хамтарч ийм компани байгуулаагүй. Миний хувьд тендерийн урилга бүхий албан бичигт гарын үсэг зурсан бөгөөд албан бичиг хэзээ хэрхэн хүргэгдсэнийг мэдэхгүй. М.Б-той ИНЕГ-ын «ЧХ» ОУНБ-д 9 жил гаруй хамт ажиллаж байсан, найз нөхдийн харилцаа холбоотой. 2013 оны 1 сар орчим Тайланд Улс руу эхнэр Н.Мя-гийн хамт болон М.Б, түүний эхнэрийн хамт явж, 7 хоног амарсан. М.Б нь БНХАУ-ын Шинженьд электроникийн үйлдвэр байдаг, тэндээс хямдхан хяналтын камер тоног, төхөөрөмж, галын болон хулгайн дохиолол зэргийг оруулж ирээд Монголд худалдаж, суурилуулах ажил хийх боломжтой, тэгвэл мөнгөө 2 дахин өсгөх боломж байна гэсэн. Ингээд намайг хамтран орох эсэхийг асууж, нийт 15.000 ам.доллараар тоног төхөөрөмж оруулж ирье, чи 7.500 ам.долларыг гарга, би талыг нь гаргая гэсэн. Ингээд би мөнгө асууж, сураглаад, мөнгө олдвол хамтарья

гэж тохиролцоод салсан. Надад тухайн үед томилолтоос хэмнэсэн 2.000 орчим ам.доллар байсан бөгөөд үлдэгдэл мөнгийг олох зорилгоор С.Б даргаас асуухад «тийм мөнгө байхгүй, чи тийм мөнгөөр яах гэж байгаа юм бэ» гэхээр нь нэг найзтайгаа хамтраад ийм бизнес хийх гэсэн юм эсвэл та цуг орохгүй юм уу гэж асуухад, үгүй гэсэн. Ингээд М.Б-той холбогдоход ер нь энэ бизнесээ хийх зорилгоор гадаадад компани үүсгэн байгуулья, учир нь татвар бага төлөгдөх боломжтой юм байна гээд иргэний үнэмлэх, хорооны тодорхойлолт, гадаад паспортуудынхаа хуулбаруудыг өгчих, би өөрөө үүнийг хөөцөлдөнө гэж байсан...» /24-р хх-184-210/, шүүгдэгч М.Б-ын мөрдөн байцаалтад өгсөн «...Миний хувьд 2012 оны эхээр Д.Э-тай хамтарч Хонконгт компани байгуулахаар ярьж байсан. Компанийг байгуулахад 2 талаасаа 15.000 ам.долларын хөрөнгө оруулалт хийхээр ярьсан бөгөөд Д.Э мөнгө төгрөгийн боломж муу байна, өөр дээрээ нэмж 2 хүн олоод өөрийн гаргах хувиа багасгахаар ярилцаж байсан. Ингээд Д.Э нь Г.Чи, Ч.Ө гэж хүмүүсийн бичиг баримтуудыг надад өгч 4 хүний гишүүнтэй компани байгуулахаар тохирсон. Хэсэг хугацааны дараа Д.Э-тай холбогдож тохиролцсон хөрөнгөө оруулах эсэх талаар асууж, хүлээж нилээн удсан. Ингээд мөнгөө өгөхгүй болохоор нь би өөрийн нэрээр дангаараа Хонконгт компани байгуулахаар болж 2012 оны 11 дүгээр сарын сүүлээр Хонконгт очиж Ан-той уулзаж, холбогдох бичиг баримтууд дээр гарын үсэг зурж, «МСЛ» гэх компанийг өөрийн нэрээр үүсгэн байгуулсан юм. Мөн тус компанийн Хонконг дахь данс нээх баримтан дээр гарын үсэг зурсан. Миний хувьд өөрийн үүсгэн байгуулсан “Эс” ХХК нь АНУ-ын «Ар» компанийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газрын эрхийг 2011 онд авсан. Тэгээд «ЧХ» ОУНБ дээр суурилуулсан байсан “vMUSE” зорчигч бүртгэлийн системийн нэгдүгээр түвшний операторын эрх буюу аюулгүй найдвартай ажиллагааг хангах ажлыг гүйцэтгэх ИНЕГ-аас зарласан тендерт оролцож ялсан. Ингээд тендерт ялсны дагуу зорчигч, бүртгэлийн системийн найдвартай, тасалдалгүй аюулгүй ажиллагааг ханган өнөөдрийг хүртэл ажиллаж байна. 2012 онд 4 удаагийн байдлаар нийт 1.062.959.200 төгрөгийн санхүүжилтийг ИНЕГ-аас өөрийн компанийн «Голомт» банкин дахь дансаар авсан. Энэ мөнгийг компанийн тухайн жилийн НӨАТ, Аж ахуйн нэгжийн орлогын

албан татварыг хууль ёсны дагуу ногдуулж төлүүлэх, компанийн ажилчдын цалин, хөлс, компанийн үйл ажиллагааны зардал, тоног төхөөрөмжийн шинэчлэл зэрэгт зарцуулсан. Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулагдсан «МСЛ» гэх компани нь миний нэг хүний гишүүнчлэлтэйгээр үүсгэн байгуулагдсан, миний хувийн компани байгаа юм. «ТСЛ» компанийг Б.Б-гийн компани гэдгийг мэдэхгүй. «А» компанийн менежер н.Кин, Н.НАБ нарын олж өгснөөр холбоо тогтоосон. Тус компани нь “vMUSE” системд ашиглагддаг, тоног төхөөрөмжийг нийлүүлдэг компани юм...» /24-р хх-149-179/,

Гэрч С.Бу-гийн «...Үзүүлж буй төлбөрийн даалгавартай танилцлаа, 1-р гарын үсэг миний гарын үсэг байна, ОУБ-д зорчигч бүртгэлийн системийн операторын ажлыг гүйцэтгэх гэрээг 2012 оны 12 дугаар сарын 27-ны өдөр ИНЕГ-ын дарга асан С.Б болон “Эс” ХХК-ийн захирал А.Ба нар байгуулсан байдаг. Миний бие 2012 оны 12 дугаар сарын 10-ны өдөр ИНЕГ-ын даргын ажлыг хүлээн авсан бөгөөд манай байгууллагаас гэрээний дагуу харилцах дансаар тогтмол их хэмжээний мөнгөн гүйлгээ гардаг байсан. 2012 оны 12 дугаар сард “Эс” ХХК-ийн гэрээний дагуу 2012 оны 12 сарын сүүлээр 226.628.000 төгрөгийн нэхэмжлэхийг ерөнхий нягтлан бодогч Д.А оруулж ирж танилцуулан, урьд нь байгуулсан гэрээний дагуу шилжүүлэх ёстой гэж танилцуулсан.

Ингээд би гэрээг нь авчруулж танилцахад гэрээний ерөнхий нөхцлийн 6-р зүйлд төлбөр хийх хугацаанаас 15 ба түүнээс дээш хоногоор хоцрох юм бол гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу 0.05 хувийн алданги төлөх үндэслэлтэй байсны дагуу нэхэмжилсэн төлбөрийг шилжүүлэх төлбөрийн даалгаварт гарын үсэг зурсан. Намайг ажилд авахаас өмнө энэ гэрээний дагуу нийт 830.000.000 гаруй төгрөг шилжүүлсэн байсан. Ингээд гэрээний дагуу төлбөр шилжүүлсний дараа үнийн дүн нь зөрүүтэй, зорчигч тутамд 1.000 төгрөг, 4.000 төгрөгийн хураамж тооцох нөхцөл бүхий давхар гэрээ гарч ирсэн бөгөөд үүнтэй холбогдуулан ИНЕГ-ын дотоод аудитын ажилчдыг хянуулахаар оруулсан бөгөөд гарч ирсэн дүгнэлтийг үндэслэн танай газарт шалгуулахаар хүргүүлсэн. Үүнээс хойш миний бие уг гэрээний дагуу ямар нэгэн төлбөр шилжүүлээгүй, энэ хугацаанд тус компаниас хоёр ч удаа төлбөр нэхэмжилснийг шилжүүлээгүй байгаа...» /22-

р хх-82-84/,

Гэрч Б.Гб-ын «... “А” ХХК-ийг 2003 онд Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр миний нагац Д.М болон Д.Т нар үүсгэн байгуулсан байдаг. Миний хувьд 2006 оны 10 сараас 2012 оны 04 дүгээр сар хүртэлх хугацаанд гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан. Тус компани нь олон улсын ярианы карт, тоног төхөөрөмжийн худалдаа, төсөл, хөтөлбөр, программ, хангамж, мэдээлэл, технологи, интернетийн үйлчилгээ үзүүлдэг. 2011 онд ИНЕГ-аас зорчигч бүртгэлийн цогц систем нийлүүлэх тендер зарлаж байгаа талаар сонин, хэвлэлд тавигдсан байсныг олж мэдэн, хүсэлт гарган тендерийн материалыг нь худалдан авч, тендерт оролцож шалгарсан. Тухайн тендер нь ИНЕГ-аас «ЧХ» олон улсын буудалд зорчигч бүртгэлийн системийн тоног төхөөрөмж, программ хангамж нийлүүлэх ажил байсан бөгөөд гэрээний дагуу зохих, тоног төхөөрөмжийг нийлүүлж, суурилуулан 2012 оны 04 сард хүлээлгэн өгсөн. Гэрээний дүн нь нийт 200.000.000 орчим төгрөг байсан санагдаж байна. Манай компани тендерийн дагуу «ЧХ» ОУБ-д дараах бараа, материалыг нийлүүлсэн байдаг. Түүнчлэн тоног төхөөрөмжүүдийн программ хангамжуудыг нийлүүлж, Нисэх буудлын шаардлагатай газруудад нь суурилуулж өгсөн. Нисэх буудалд серверийн өрөөнд сервертэй холбоотой тоног төхөөрөмжүүдийг, олон улсын бүртгэлийн цэгт зорчигч бүртгэлийн системтэй холбоотой тоног төхөөрөмжүүдийг суурилуулсан. Тухайн бүртгэлийн систем, тоног төхөөрөмжийн программ хангамж нь хязгаарлагдмал байсан бөгөөд тендерт оролцохын өмнө бүртгэлийн төхөөрөмжийг ажиллуулах программ хангамжийг авах газрыг хайх шаардлагатай болсон. Ингээд судлаж байгаад АНУ-ын «Ар» болон одоо нэрийг нь санахгүй байгаа, бусад гадаадын компаниуд руу электрон шуудангаар программ, хангамжийн талаарх мэдээлэл, танилцуулгыг нь хүсэж удаа дараа захиалгээс бөгөөд «Ар» компанийн Ази дахь салбараас хариу ирсэн байдаг. Ингээд тус компаниаар харьцаж, зорчигч бүртгэлийн багц систем, программ, хангамжийг худалдан авахаар болсон бөгөөд тоног төхөөрөмжүүдийг суурилуулах үед тус компаниас 3 хүн ирж, сүлжээ программ хангамжийг тавьж өгсөн байдаг. Дээрх гадаад иргэд нь Вьетнам, Малайз улсын иргэд байсан. Манай компаниас н.О гэж

инженер оролцсон. Манай компани нь «ЧХ» олон улсын буудалд тоног төхөөрөмжийг нь программ хангамжтай нь суурилуулж өгснөөр акт үйлдсэн. Тэгэхээр уг тоног төхөөрөмжүүдийг цааш нь ашиглаж, үйл ажиллагаа явуулахад бэлэн болсон гэсэн үг. ИНЕГ-т 2012 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр хүргүүлсэн 201201/A003 дугаартай албан бичиг нь манай компаниас явуулсан тоот байна. Уг бүртгэлийн систем, тоног төхөөрөмжөөр бүртгүүлсэн зорчигчдын мэдээлэл Олон улсад сүлжээгээр холбогдсон байх ёстой байдаг талаар «Ар» компаниас манайд хандсаны дагуу уг албан бичгийг явуулсан. Бидний суурилуулж өгсөн бүртгэлийн систем, тоног төхөөрөмж нь зөвхөн дотооддоо бүртгэлээ явуулах боломжтой боловч гадаад улсуудын нэгдсэн бүртгэлийн сүлжээнд холбогдоогүй байсан юм. Ингээд тэр сүлжээгээ холбуулах шаардлагатай талаар ИНЕГ-т мэдэгдсэн. Хүлээлгэн өгсөн тоног төхөөрөмжүүд дээр ажиллах сургалтыг нисэхийн ажилчдад «А» компаниас ирсэн төлөөлөгч заасан. Миний хувьд М.Б-тай МУИС-ын Электроникийн инженерийн ангид 1995-1999 онуудад хамт суралцаж төгссөн. Гэхдээ ойр дотно харьцаа холбоо байхгүй, нэг ангийн хүүхдүүд юм...» /22-р хх-134-137/,

Гэрч П.Ха-ын «...Би 2008 оноос эхлэн ИНЕГ-ын Тендерийн материал бүрдүүлэлтийн тасгийн мэргэжилтнээр ажилд орж одоог хүртэл ажиллаж байна. ИНЕГ-ын даргын 2011 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 262 тоот тушаалаар Нисэх буудлын бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж суурилуулах гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тухай ИНЕГ/ТББ/Б-73/11 тоот тендерийн Үнэлгээний хороо байгуулагдсан. Ингээд Үнэлгээний хорооноос тендерийг нээлттэй зарлахаар шийдвэрлэж урилгыг 2011 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр «Монголын мэдээ» сонин болон Сангийн яамны сайтад тус тус тавьсан. Тендерийг 2011 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл 1 сарын хугацаатайгаар зарласан. Тендерийн бичиг баримтын техникийн тодорхойлолтонд зааснаар Нийлүүлэх тоног төхөөрөмж нь нислэг үйлдэж буй агаарын тээвэрлэгчдийн болон ирээдүйд нислэг үйлдэж болох агаарын тээвэрлэгчдийн программ хангамжинд нийцтэй байхын тул ИАТА-ны КР1797 дугаар зөвлөмжид техникийн шаардлагыг бүрэн хангасан байх, мөн баталгаат хугацаа нь 12

сар хүртэл байх зэрэг үндсэн шаардлагыг хангасан байхаар заасан. Ингээд тендерийн материалыг «ЭСЭ» ХХК, «СТс» ХХК, «Дт» ХХК, «С»-гийн Монгол дахь төлөөлөгчийн газар, «А» ХХК, «ӨЭӨЭ» ХХК-ниуд тус тус худалдаж авсан. Ингээд 2011 оны 10 дугаар сарын 20-ны өдөр тендерийг нээхэд «А» ХХК материалаа ирүүлсэн байсан бөгөөд үнэлгээг хийхэд тус компани нь тендерийн баримт бичгийн техникийн шаардлагыг бүрэн хангасан, «Ар» олон улсын компанийн албан ёсны борлуулагчийн эрхтэйгээр тендерт орсон байсан учир Үнэлгээний хороо тус компанийг санал нэгтгэйгээр сонгон шалгаруулсан байдаг. Тендерийн техникийн тодорхойлолтонд зааснаар тоног төхөөрөмжийг нийлүүлж, серверын өрөөний суурилуулалт хийх, үндсэн сүлжээ байгуулах, системийн угсралт суурилуулалт, туршилт, шалгалт, сургалт, бүртгэлийн цэгийн тоног төхөөрөмж холбох, шалгах зүгшрүүлэх зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн байна...» /22-р хх-129-131/,

Гэрч З.Ту-гийн «...2012 оны сар, өдрийг нь санахгүй байна, ямар ч байсан уг тендер зарлагдахаас өмнө Д.Э дарга намайг дуудаж, «Зорчигч бүртгэлийн системийн хэвийн үйл ажиллагааг хангуулах операторын ажил гүйцэтгэх» тухай гэрээний төсөл үзүүлж, ийм ажил хийгдэх гэж байна, энэ гэрээг хянаж өгөөч гэж байсан бөгөөд миний бие тухайн гэрээний төсөлтэй танилцахад ямар ажил хийж гүйцэтгүүлэх гээд байгаа нь ойлгомжгүй, бүрхэг гэрээ байсан, тухайн үед би уг ажлыг хийж гүйцэтгүүлэх бол зохих журмын дагуу тендер зарлаж, сонгон шалгаруулах нь зүйтэй гэж саналаа хэлж байсан. Мөн гэрээгээ тодорхой болгох талаар зөвлөгөө өгсөн. Ингээд хэсэг хугацааны дараа ИНЕГ-аас Үнэлгээний хороо томилогдож, өмнө Д.Э даргын ярьж байсан ажил, үйлчилгээг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, захиалагчийн гэрээ байгуулах мэдэгдэл болон гэрээний төслийг хянуулахаар надад оруулж ирсэн. Миний хувьд тендер шалгаруулалтын материалтай танилцах шаардлага байхгүй бөгөөд захиалагчийн мэдэгдлийг үндэслэн гэрээний төслийг хянаж, Үнэлгээний хороонд хүргүүлсэн. Гэрээг хянахад зорчигч тутмаас хураах хураамжийг 3 ам.доллараар тогтоосон байсан бөгөөд Монгол Улсад төгрөгөөр аливаа гэрээ хэлцэл, төлбөр тооцоог хийх хууль тогтоомжийн дагуу төгрөгөөр илэрхийл гэсэн саналыг өгсөн байдаг. Ингээд миний хэлсний дагуу уг гэрээ зорчигч тутамд 4.000

төгрөг болж засварлагдаж орж ирсэн бөгөөд миний бие өөрийн гарын үсэг зурах хэсэгт гарын үсгээ зурсан. Ийм л үйл ажиллагаа болсон. Гэрээний төслийг бол тухайн Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга нар Сангийн яамнаас батласан жишиг гэрээний дагуу боловсруулдаг. Гэрээтэй танилцахад «ЧХ» ОУНБ-аар үйлчлүүлж байгаа авиа компаниудын зорчигч нарыг нисэх онгоцонд бүртгэх бүртгэлийн системийн программ, хангамжийн хэвийн үйл ажиллагааг хангах, үйлчилгээ үзүүлэх нөхцөлтэй гэрээ байсан...» /22-р хх-99-102/,

Гэрч «С» байгууллагын Монгол дахь төлөөлөгч Ц.Га-ийн «...Манай нийгэмлэг нь 1949 онд Европын авиа компаниудын сайн дурын үндсэн дээр байгуулагдсан авиа компаниудад мэдээлэл технологийн сүлжээгээр хангах туслах зорилготойгоор байгуулагдсан юм.Одоо манай нийгэмлэг дэлхийн 220 гаруй орон төлөөлөгчийн газартай бөгөөд 147 авиа компанитай хамтран ажиллаж байна. Манай нийгэмлэг нь одоо агаарын тээврийн авиа компани болох М, ЭЧ, КЭ зэрэг компаниудад үйлчилгээ үзүүлж байна. ...2012 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн өглөө 09 цагийн үед утсаар надруу Иргэний нисэхийн ерөнхий газраас яриад тендерт оролцох талаар албан бичиг байгаа, та ирж авна уу гэсний дагуу миний бие тэр өдрөө буюу 2012 оны 02 дугаар сарын 07-ны өдөр 10 цагийн орчимд очиж холбогдох хүнтэй уулзаж албан бичиг болон тендерийн нөхцлийн талаарх баримтуудыг авсан. Тухайн үедээ надад тендерийн материал өгсөн хүнээс цаг хугацааны хувьд ямар хоцорч ирж байгаа юм бэ, мөн ямар учиртай тендер юм бэ гэхэд та наад материалтайгаа танилцаад албан бичгээр хариу ирүүлээрэй гэж байсан, тэгээд би тендерийн материалтай өдөрт нь танилцахад тендерийн материалд «Оператор үйлчилгээний техникийн шаардлага 1, 2-д зааснаар «Операторын үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж нь жилд дунджаар 200.000-250.000 зорчигч бүртгэх хүчин чадалтай техник, төхөөрөмжтэй байна» гэдгийг яг хэдэн үйлчилгээний цэгтэй байх талаар тодруулах шаардлага гарсан тул 2012 оны 02 дугаар сарын 08-ны өдөр албан бичиг төлөвлөж, Иргэний нисэхийн ерөнхий газарт өөрийн биеэр аваачиж өгсөн, тэгж өгөхдөө уг албан бичигт тендерийн урилга хугацаа алдаж ирсэн талаар тусгасан юм. Тэгээд уг заалтын хариу ирэх байх гэж хүлээсэн боловч ирээгүй бөгөөд тендерийн

хугацаа дууссан. Ингээд би эргэж Иргэний нисэхийн газартай холбогдоогүй юм. Манай байгууллагын хувьд 1-рт уг тендерт оролцоход цаг хугацааны хувьд амжаагүй учир нь тендерийн урилгыг бид оройтож авсан, 2-рт тодруулах зүйл байсан, 3-рт би албан бичигт дурдсан байгаа төвдөө монгол материалыг орчуулаад явуулах, уг материалыг авсан төв газраас тендерт оролцох эсэх талаар хариу ирэх зэргээс харахад ямарч боломжгүй байсан юм. Захиалагч талын хувьд бидэнд тендерийн материалыг өгөхдөө тендерт оролцох болон материалыг нягтлан шалгах хугацаа олгоогүй байсан нь бидний хувьд тендерт оролцоогүй гол шалтгаан юм...» /22-р хх-122-123/,

Гэрч Б.Мө-ийн «...Би «АЭБ» ХХК-нд ажиллах хугацаандаа гадаад, дотоод гэрээ, хэлцлийг хянах, хуулийн зөвлөгөө өгөх асуудал хариуцаж байсан. Би «АЭБ» ХХК-д ажиллаж байх хугацаандаа “Эс” ХХК-д хуулийн зөвлөгөө өгч байсан. И-мэйлд хавсаргасан одоо надад үзүүлж буй бичиг баримтаас үзвэл “Эс” ХХК нь Их Британи Виржиний арлуудад хуулийн этгээд үүсгэн байгуулах хүсэлт тавьж, түүндээ туслуулахаар манай хуулийн фирмд хандаж байсан. Миний хувьд “Эс” ХХК-ийн захирал М.Б-ын үүсгэн байгуулах гэж байгаа хуулийн этгээдийг үүсгэн байгуулахад туслалцаа үзүүлж буй гадны этгээдтэй захирал Б.Б-гийн өгсөн мэйл хаягаар харьцаж, М.Б-ын надад өгсөн материалуудыг тухайн этгээдэд электрон шуудангаар явуулж байсан. “Эс” ХХК-ийн захирал М.Б нь «British Virgin Island»-д хуулийн этгээд үүсгэн байгуулах туслалцаа хүсэж байсан. Эдгээр хүмүүс буюу Г.Чи, Ч.Ө, М.Б, Д.Э гэх хүмүүс нь М.Б-ын «British Virgin Island»-д тэр үүсгэн байгуулах гэж байсан хуулийн этгээдийн хувьцаа, эзэмшигч эвсэл ТУЗ-ийн гишүүд нь байсан байх. Ийм учраас тухайн бичиг баримтуудыг буюу дээрх хүмүүсийн тодорхойлолт, иргэний бичиг баримтыг компанийн орчуулагчаар орчуулуулж хянаад захирал Б.Б-гийн өгсөн хаяг бүхий гадаад хүн рүү явуулж байсан байна. Явуулсан мэйлээс харахад М.Б гадаадад хуулийн этгээд үүсгэн байгуулж, тэр компанийнхаа нэрээр гадаадад харилцах данс нээлгэх шаардлагатай болж түүнийхээ дагуу Хонконг Улс руу явах болж би захирал Б.Б-гийн холбож өгсөн гадаад хүнтэй мэйлээр холбогдож, шаардлагатай авч явах бичиг баримтыг М.Б-од хэлж, дамжуулж байсан байна. Яагаад М.Б нь Хонконг явж байна

гэхээр бүхий л материалаа хэдийн гадаад руу надаар дамжуулж явуулсан боловч гадаадад өөрөө очиж банкны баталгаа, гарын үсгээ зурах шаардлагатай байсан байх. Би Г.Чи, Ч.Ө, Д.Э нартай биечлэн уулзаж байгаагүй. Харин М.Б нь энэ хүмүүсийнхээ материалыг надад авчирч өгч байсан. Би гадаад хүнтэй холбогдоод шаардлагатай бичиг баримтыг М.Б-оос авч, орчуулагчаар орчуулуулж, нөгөө гадаад хүн рүү явуулж байсан. Харин хувийг нь М.Б-д явуулдаг нь М.Б Хонконг явахад нь хэрэгтэй байсан учраас л явуулсан байх. Би тус компанид ажиллах хугацаандаа анх удаа л гадаадад хуулийн этгээд үүсгэн байгуулах ажлыг хийж байсан. Надад үзүүлж буй англи хэл дээр бичигдсэн Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулагдсан нийт 9 хуудас бүхий хүснэгт, жагсаалт хэлбэрээр оруулсан компаниудын нэрс байна. Би өмнө мэдүүлсэнчлэн “Эс” ХХК-ийн захирал М.Б нь манайд хандаж Их Британи Виржиний арлуудад компани үүсгэн байгуулах хүсэлт тавьж байсны дагуу холбогдох баримтуудыг цуглуулж байсан, өмнөх мэдүүлэгтээ ч энэ талаар дурдсан. Одоо үзүүлж буй 9 хуудас компаниудын нэрсийг “Эс” ХХК-ийн захирал М.Б-д үзүүлж, Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулах компанийн нэрийг нь сонгуулсан. Хүснэгтээс харахад тус компаниуд нь үүсгэн байгуулагдчихсан компаниуд байх бөгөөд эдгээр дотроос М.Б-оор сонгуулж, сонгогдсон компанийг М.Б нарын нэр дээр болгох талаар бичиг, баримтыг нь цуглуулж өгсөн. Надад үзүүлж буй OLN Corporate services гэсэн толгой бүхий Check list on Initial Setting up of a British Virgin Islands Company гэсэн гарчиг бүхий 5 нүүр материалтай танилцлаа. Уг материалыг «OLN» корпорациас мэйлээр ирүүлж, компани үүсгэн байгуулахтай холбоотой мэдээллүүдийг нөхөж бичих талаар дурдсан байсан. Ингээд үүний дагуу М.Б-оос мэдээллийг авч, 1 дэх хэсэг буюу боломжит 9 компанийн нэрс, 5 дугаар хэсэг буюу хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээлэл, хувьцааны тоо, 6 дугаар хэсэг буюу захирлын талаарх мэдээлэл, 11 дэх хэсэг буюу бизнесийн чиглэл, 12 дахь хэсэг буюу харилцах банкны сонголт, үйлчилгээний хэлбэр, данснаас хэн гүйлгээ хийх зэрэг мэдээллийг нөхөж оруулж, М.Б-од өгсөн. Гадаадад үүсгэн байгуулах компанийн захирлаар нь Д.Э, хувьцаа эзэмшигчээр нь Г.Чи, Ч.Ө, М.Б, Д.Э нар болж байсан бөгөөд дээрх компани нь «HSBC» банкинд данс нээлгэхээр сонгож байсан.

Данснаас Д.Э, М.Б нар хамтаар гүйлгээ хийх эрхтэй байхаар сонгож байсан. Миний одоо санаж байгаагаар Их Британи Виржиний арлуудад компани үүсгэн байгуулах талаар Хонконг дахь «OLN» компанитай харьцаж байсан юм байна. Надад үзүүлж буй 22 хуудас Г.Чи, Ч.Ө, М.Б, Д.Э нарын оршин суугаа газрын тодорхойлолт, иргэний үнэмлэхийн хуулбар, англи дээрх орчуулга, гадаад паспортын хуулбар зэрэг баримт нь Их Британи Виржиний арлуудад үүсгэн байгуулах компанийн хувьцаа эзэмшигч нарын мэдээллийг «OLN» компаниас бүрдүүлж өг гэсний дагуу бүрдүүлсэн баримт байна. Надад үзүүлж буй 1 хуудас англи хэл дээр бичигдсэн банкны тодорхойлолтын загвар нь тухайн үед миний М.Б-д явуулсан загвар байна. Энэхүү загварын дагуу компанийн хувьцаа эзэмшигчид өөрсдийн нэр дээрх харилцах банкнаас тодорхойлолт авч «OLN» компанид явуулах учиртай байсан. Энэ нь «OLN» компанийн Виржиний арлуудад компани үүсгэн байгуулах шаардлагатай баримтуудын 1 хэсэг байсан. Надад үзүүлж буй 2 хуудас англи хэл дээр «OLN» компаниас ирүүлсэн төлбөрийн нэхэмжлэл байна. Энэ нэхэмжлэлийн дагуу бид төлбөрийг шилжүүлсэн байх. Надад үзүүлж буй 6 хуудас Media Summit Limited Service Agreement гэсэн баримттай танилцлаа. Уг гэрээ нь «OLN» компаниас Д.Э, М.Б, Г.Чи, Ч.Ө нарт үйлчилгээ үзүүлэх гэрээ байна. Надад үзүүлж буй 3 хуудас англи хэл дээрх “Эс” ХХК-ийн танилцуулга, монгол хэл дээрх компанийн улсын бүртгэлийн гэрчилгээ байна. Уг баримтыг мөн компани үүсгэн байгуулахад «OLN» компаниас шаардсан байх. Надад үзүүлж буй Б.Б захиралд хаягласан мэйлээс үзвэл тус мэйлийг «OLN» компаниас явуулсан бололтой. Энэхүү мэйлээрээ М.Б болон Д.Э нар нь Хонконгт ирэхдээ ямар бичиг баримтуудыг авчрахыг сануулсан байна. Надад үзүүлж буй 4 хуудас нь “Эс” ХХК-ийн дүрэм байна. Надад үзүүлж буй 6 хуудас материал нь «АЭБ» ХХК-аас “Эс” ХХК-нд илгээсэн албан бичиг бүхий төлбөрийн нэхэмжлэх болон үзүүлсэн үйлчилгээ болон зарцуулсан цагийг тайлбарласан хавсралт зэрэг баримт байна. Тухайн үед «OLN» гэсэн компанийн нэр, үйл ажиллагааг мэдэхгүй байсан. Миний хувьд Б.Б захирлын өгсөн үүргийн дагуу хийгдсэн ажлын дэлгэрэнгүй жагсаалтанд дурдагдсан Ан гэж хүний мэйлээр харьцаж байсан. Энэ хүн «OLN» компанид ажилладаг байсан юм

байна. Тухайн үедээ бол би сайн ойлгоогүй байсан. Ан гэж хүний мэйлийг надад Б.Б захирал өгсөн байдаг. М.Б, Д.Э нар нь дээр дурдсан цаг хугацаанд болон өөр хугацаанд Хонконг руу явсан эсэхийг мэдэхгүй байна. Цаанаас нь ирэх шаардлагатай болоод ир гэж байсан байлгүй дээ. Банкны данс нээхэд Хонконгт М.Б, Д.Э нар заавал очих шаардлагатай байсан байх. Миний хувьд нарийн асуудлыг нь сайн мэдэхгүй байна. Захирал Б.Б сайн мэдэх байх. Уулзалтын товыг өөрчлөх талаар захирал Б.Б мэйл илгээсэн байна. Тэгэхээр Хонконгт уулзах уулзалтын товыг хэзээнээр өөрчилснийг нь мэдэхгүй байна...» /22-р хх-143-147, 148-151/,

Гэрч А.Ба-ийн «...Миний хувьд “Эс” ХХК-ийн талаар тодорхой мэдэхгүй, манай нөхөр М.Б хариуцан ажилладаг, надтай 2008 онд танилцахдаа компаниа үүсгэн байгуулсан байсан бөгөөд ИНЕГ-ын «ЧХ» ОУНБ-д сүлжээний инженерээр ажиллаж байсан, гэрээний талаар мэдэхгүй, нөхрийнхөө ажилд оролцдоггүй, асуухаар уурлаад байдаг. Уг компанийн санхүүгийн тайлан, гэрээнд гарын үсэг зуруулдаг ба 4.000, 1.000 төгрөгийн үнэ бүхий гэрээнүүдэд хэзээ, хаана гарын үсэг зурснаа санахгүй байна. Миний гарын үсэг мөн...» /22-р хх-167-170/,

Гэрч Н.На-ын “...М.Б-ын тухайд дүү А.Ба-ийн нөхөр гэдгээр нь танина. Бидний хувьд хоорондоо нэг ч удаа мөнгө, төгрөгийн өглөг авлагатай асуудал байхгүй. М.Б-ыг “Эс” ХХК-тай гэж урьд нь сонсож байгаагүй. 75.400.000 төгрөгийг М.Б-д өгч болон зээлж байгаагүй. 2013 оны 06 дугаар сарын сүүлээр улсын наадмын өмнө нэг танихгүй дугаараас эрэгтэй хүн залгаж, М.Б-ын талаар уулзъя, танд юм хэлүүлсэн гэж хэлсэн. Ингээд би тэр хүнтэй баруун 4 замын орчим уулзахад 30 орчим насны залуу байсан бөгөөд “танаас М.Б мөнгө зээлж, буцааж төлсөн гэж байцаалт өгсөн шүү” гэж дамжуулж байна гэж байсан. Тэгээд л би биеийн байдлыг нь асуугаад тэр залуугаас салсан. Миний хувьд М.Б-д мөнгө, төгрөг зээлж, авч байгаагүй...” /22-р хх-202-204/,

шинжээч Х.Э-гийн «...АТГ-ын 2013 оны 07 дугаар сарын 22-ны өдрийн шинжээч томилох тогтоолыг үндэслэн Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2013 оны 5/3729 тоотоор шинжээчээр томилогдсон. Шинжилгээг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон Эрүүгийн

хуульд заасан шинжээчийн эрх үүрэгт нийцүүлэн, ирүүлсэн баримт, материалд үндэслэн гаргасан байна.

“Нисэх буудлын зорчигчийн бүртгэл, хяналтын цогц систем нийлүүлж, суурилуулах” гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ7ТББ/Б-73/11 тоот тендерийг шалгаруулахдаа Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт болох үйлдвэрлэгчийн гарал үүслийн гэрчилгээ, баталгаат хугацааны шаардлага хангасан гэрчилгээ, албан ёсны борлуулагчийн гэрчилгээ зэрэг баримт материалыг оролцогч “А” ХХК нь ирүүлээгүй байтал сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3, Тендерийн баримт бичгийн 12.1-д заасныг зөрчсөн байна. Тендерийн баримт бичигт заасан шалгуур үзүүлэлт болох ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээллийг “А” компани нь хүснэгтээр ирүүлсэн нь хангалтгүй байсан атал сонгон шалгаруулсан нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 27 дугаар зүйлийн 27.3, Тендерийн баримт бичгийн 18.1-д заасныг зөрчсөн байна. Мөн түүнчлэн Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичгийг хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-т заасан шалгуур, үзүүлэлтийг хангаж боловсруулаагүй байгаа нь мөн заалтыг зөрчсөн байна. Энэ нь Үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХА тухай хууль болон дээрх тендерийн баримт бичгийн шалгуурыг нэгэн зэрэг хангасан оролцогчийн саналыг шалгаруулсан гэж үзэх үндэслэлгүй байна. Өөрөөр хэлбэл, Үнэлгээний хороо нь «А» компанийн ирүүлсэн тендерээс татгалзаж энэ талаар захиалагчид танилцуулах ёстой байсан. «Зорчигч бүртгэлийн операторын үйл ажиллагаа явуулах» гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот тендерийг шалгаруулахдаа Үнэлгээний хороо нь ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа түүний худалдан авах журмыг төсөвт өртөгийг үндэслэл болгохоор заасан. Өөрөөр хэлбэл, төсөвт өртөг нь 50.000.000 төгрөгөөс дээш бол нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулах ёстой. Үүний дагуу дээрх тендер шалгаруулалт нь нээлттэй зарлагдах ёстой байсан. Гэтэл Үнэлгээний хороо нь дээрх ИНЕГ/У/ХББ/Б-04/12 тоот тендерийг хязгаарлагдмал тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулсан нь

ТБОНӨХБАҮХАТХ-ийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн, Хязгаарлагдмал тендер шалгаруулалтыг мөн хуулийн 32 зүйлд заасан «Мэргэжлийн өндөр ур чадвар, туршлага, техник, технологи шаардсан нарийн төвөгтэй бараа ажил, үйлчилгээг шалгаруулахад ашиглах» талаар заасан. Гэтэл Зорчигч бүртгэлийн операторын ажил нь хуулийн дээрх зохицуулалтанд хамаарахгүй. Өөрөөр хэлбэл, хязгаарлагдмал тендер зохион байгуулсан нь хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2-т заасан гадаад этгээд нээлттэй оролцох, хуульд заасан ил тод нээлттэй тэгш өрсөлдөх боломжийг хязгаарласан байна. Үнэлгээний хороо нь тендерийн баримт бичиг боловсруулахдаа тухайн бараа, үйлчилгээнд зориулсан Сангийн сайдын батласан жишиг баримт бичгийг үндэслэх ёстой байсныг зөрчсөн байна. Мөн дээрх бараа ажил үйлчилгээ нь Зам тээвэр, барилга, хот, байгуулалтын яамны 2012 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй байна. Мөн тендер баримт бичгийн боловсруулалт нь шаардлагад нийцээгүй, яг ямар ажил, үйлчилгээ худалдан авах нь тодорхойгүй, барааны тендерийн баримт бичигт нийцүүлж боловсруулсан нь буруу, харин зөвлөхөөс бусад үйлчилгээний тендерийн баримт бичигт нийцүүлэн боловсруулах ёстой байсан. ИНЕГ-аас дээрх тендерийг сонгон шалгаруулах зайлшгүй шаардлага байсан бол мөн хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-д заасны дагуу төлөвлөж сангийн яаманд ирүүлэх, мөн хуулийн 19 дүгээр 19.1-д заасны дагуу батлагдсан сангийн сайдын жишиг баримт, бичгийг үндэслэн тендерийн баримт бичгийг боловсруулж хуульд нийцүүлэн зохион байгуулах ёстой байсан. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиар худалдан авах ажиллагааг төлөвлөх зохион байгуулах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулдаг бөгөөд хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон 50 буюу түүнээс дээш хувийн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нь уг хуулийг дагаж мөрдөх үүрэгтэй. ИНЕГ нь төрийн байгууллага бөгөөд уг хуульд заасан захиалагч тул бүхий л тендер шалгаруулалтыг уг хуульд нийцүүлэн зохион байгуулах ёстой. Өөрөөр хэлбэл, зорчигчоос төвлөрүүлсэн хураамжаас хамааруулж худалдан авах ажиллагааг хууль бусаар

зохион байгуулах эрхгүй...» /6-р хх-84-87/ гэх мэдүүлгүүд, болон гэрч Л.Эр /22-р хх-174-175/, Ч.А /22-р хх-179-180/, Г.Дө /22-р хх-176-178/, Ц.Ц /26-р хх-182-183/, П.Б /26-р хх-177-179/, Ч.З /26-р хх-192-193/, Д.Да /26-р хх-188-189/, Я.Д /26-р хх-220-222/, П.Эц /22-р хх-182-184, 189/, Ч.Хо /22-р хх-189/ нарын мэдүүлгүүд, мөрдөн байцаалтын шатанд Ц.Б-гийн сэжигтнээр өгсөн мэдүүлэг, хүсэлт /24-р хх-218-219/ зэргээр нотлогдсон байна.

Мөрдөн байцаалтын шатанд шалгавал зохих нөхцөл байдлыг бүрэн шалгасан, шүүх С.Б, Д.Э, М.Б нарын үйлдсэн хэрэгт үндэслэл бүхий дүгнэлт хийж Эрүүгийн хуулийг зөв хэрэглэж шийдвэрлэсэн, хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчөөгүй байна.

Иймд ялтан С.Б, түүний өмгөөлөгч Ж.Батхүү, Ж.Эрдэнэбулган, ялтан М.Б, түүний өмгөөлөгч Х.Цогтсайхан, ялтан Д.Э, түүний өмгөөлөгч Д.Батбаатар, К.Бауиржан, М.Хувцагаан нарын гаргасан давж заалдах гомдолд дурдсан үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох буюу мөрдөн байцаалтад буцааж зарим зүйлсийг шалгуулах, мөн хэргийн зүйлчлэлийг хөнгөрүүлэн өөрчлөх хууль зүйн үндэслэл байхгүй тул шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, тэдгээрийн гаргасан давж заалдах гомдлыг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж давж заалдах шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Харин анхан шатны шүүх шийтгэх тогтоолын тодорхойлох хэсэгт «С.Б, М.Б, Д.Э нарт ял шийтгэх ногдуулахдаа ...гэмт хэргийн улмаас учруулсан хохирлоо төлөөгүй зэргийг ял хүндрүүлэх нөхцөл байдалд тооцлоо» гэж Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлийн 56.3-т заасныг зөрчиж дүгнэлт хийсэн нь буруу байгааг,

Мөн тогтоолын тодорхойлох хэсэгт шүүгдэгч Д.Э-ын өмчлөлийн Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...дугаар хороолол, ...тоот орон сууцыг битүүмжлэлээс чөлөөлж, хууль ёсны эзэмшигчид буцаан олгохоор дүгнэсэн атлаа шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт заахгүйгээр орхигдуулсан байх тул шийтгэх тогтоолын холбогдох заалтыг зөвтгөх нь зүйтэй гэж дүгнэлээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 315 дугаар зүйлийн 315.1.1, 315.1.4 дэх заалтыг удирдлага болгон ТОГТООХ нь:

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 1025 дугаартай шийтгэх тогтоолын 12 дахь заалтад «... Шүүгдэгч

Д.Э-ын эд хөрөнгө болох Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, ...дугаар хороолол, ...тоот орон сууц...» гэсний дараа «...Баянзүрх дүүргийн ...дугаар хороо, .. тоот орон сууц...» гэж нэмэлт өөрчлөлт оруулж, шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн бусад заалтуудыг хэвээр үлдээж, ялтан С.Б, түүний өмгөөлөгч Ж.Батхүү, Ж.Эрдэнэбулган, ялтан М.Б, түүний өмгөөлөгч Х.Цогтсайхан, ялтан Д.Э, түүний өмгөөлөгч Д.Батбаатар, К.Бауиржан,

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ
ШҮҮГЧИД

М.Хувцагаан нарын гаргасан давж заалдах гомдлуудыг тус тус хэрэгсэхгүй болгосугай.

Давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл эрх бүхий этгээд 14 хоногийн дотор хяналтын шатны шүүхэд гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

Ш.БАТ-ЭРДЭНЭ
С.СОЁМБО-ЭРДЭНЭ
Ц.ОЧ

ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 1360

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгч Ц.Дайрийжав даргалж, шүүгч А.Алтанхуяг, шүүгч О.Жанчивнямбуу нарын бүрэлдэхүүнтэй

хуралдааны тэмдэглэлийг нарийн бичгийн дарга Ш.Мөнхжаргал, В.Орхон нар хөтлөн иргэдийн төлөөлөгч Б.Баянбилэг, Г.Баярсайхан, С.Эрдэнэчимэг, улсын яллагч Г.Мижиддорж, Н.Мөнхнаран, хохирогч Б.Дө, шүүгдэгч Я.С, А.Х, тэдгээрийн өмгөөлөгч Б.Эрдэнэбат, шүүгдэгч О.Ф, түүний өмгөөлөгч Т.Отгонсүрэн, шүүгдэгч О.С, түүний өмгөөлөгч З.Шүрэнчулуун, шүүгдэгч А.П, түүний өмгөөлөгч Н.Оюунгэрэл, шүүгдэгч Д.А, түүний өмгөөлөгч Ш.Мягмарцэрэн, гэрч Б.Эр, Я.Б, Л.Би нарыг оролцуулан тус шүүхийн хуралдааны танхимд нээлттэй хийсэн эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаар

Дүүргийн 2 дугаар прокурорын газраас Я.С-д холбогдуулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 19 дүгээр зүйлийн 19.2, 35 дугаар зүйлийн 35.2, 35.5 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 264 дүгээр зүйлийн 264.2, 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар,

О.Ф-д холбогдуулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 19 дүгээр зүйлийн 19.2, 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар,

А.Х-ад холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2, 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар,

О.С-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар,

А.П-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар,

Д.А-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.2-т зааснаар тус тус яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн 20130400039 дугаартай 71 хавтаст эрүүгийн хэргийг 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Баян-Өлгий аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, хуульч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр хүүхдүүдийн хамт Баян-Өлгий

аймгийн ...сумын ...дугаар багийн ...тоотод оршин суух хаягтай, одоо өмгөөлөгчөөр ажиллаж байгаа, Хууль зүйн салбарын тэргүүний ажилтан, Үйлдвэр худалдааны тэргүүний ажилтан, Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдаж байсан, Баян-Өлгийн аймгийн Сум дундын шүүхийн 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 82 тоот шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.1 дэх хэсэгт зааснаар гэм буруутайд тооцож Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.2 дахь хэсэгт зааснаар эрүүгийн хариуцлагаас чөлөөлсөн /РД:ПБ...../ И овогт Я.С.

Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Баян-Өлгий аймгийн ...суманд төрсөн, ...настай эрэгтэй, дээд боловсролтой, инженер мэргэжилтэй, ам бүл..., эхнэр хүүхдүүдийн хамт Баян-Өлгий аймгийн ...сумын ...дугаар багт оршин суух хаягтай, Асрамжийн газрын зохион байгуулагчаар ажиллаж байсан, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй /РД:БВ...../ С овгийн О.Ф.

Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Баян-Өлгий аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, ам бүл..., эхнэр, хүүхдийн хамт, Баян-Өлгий аймгийн ...сумын ...дугаар баг ...тоотод оршин суух хаягтай, Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэст

гэрээт ажилтнаар ажиллаж байсан, улсаас авсан гавъяа шагналгүй, ял шийтгэлгүй /РД:ПЭ...../ М овогт А.Х.

Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Баян-Өлгий аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, багш мэргэжилтэй, ам бүл ...эхнэрийн хамт, Баян-Өлгий аймгийн ...сумын ...дугаар баг ...тоотод оршин суух хаягтай, Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн даргаар ажиллаж байсан, Боловсрол, Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтан гадас одон, Хөдөлмөрийн гавъяаны одонгоор шагнагдаж байсан, Баян-Өлгий аймгийн Прокурорын газрын 2009 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр 5/110 тоот прокурорын тогтоолоор Эрүүгийн хуулийн 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсэгт зааснаар гэм буруутайд тооцож 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Өршөөл үзүүлэх тухай Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар хэрэгсэхгүй болгосон /РД:ЦГ...../ Ж овогт О. С.

Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Баян-Өлгий аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, инженер мэргэжилтэй, ам бүл..., эхнэр, хүүхдүүдийн хамт, Баян-Өлгий аймгийн ...сумын ...дугаар багт оршин хаягтай, Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн захиргааны албаны даргаар ажиллаж байсан, Нийгмийн хамгааллын салбарын тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтангадас одонгоор шагнагдаж байсан, Баян-Өлгий аймгийн Прокурорын газрын 2009 оны 8 дугаар сарын 31-ний өдөр 5/77 тоот прокурорын тогтоолоор Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн 150.2 дахь хэсэгт зааснаар гэм буруутайд тооцож 2009 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн Өршөөл үзүүлэх тухай Монгол улсын хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар хэрэгсэхгүй болгосон /РД:ЕП...../ И овогт А.П.

Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-нд Баян-Өлгий аймгийн ...суманд төрсөн ...настай эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, ам бүл ..., эхнэр хүүхдүүдийн хамт Баян-Өлгий аймгийн ...сумын ...оршин суух хаягтай, Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн Дэлүүн сум хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байсан Нийгмийн

хамгааллын салбарын тэргүүний ажилтан, Хөдөлмөрийн хүндэт медалиар шагнагдаж байсан, Баян-Өлгий аймгийн сум дундын шүүхийн 2003 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 56 дугаартай шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 153 дугаар зүйлийн 153.1-д зааснаар 8 сарын хорих ялаар шийтгэж 1 жилийн хугацаагаар тэнсэн харгалзсан /РД:БЖ...../ Ж овогт Д.А.

Прокурорын яллах дүгнэлтэд бичигдсэнээр :

Яллагдагч Я.С 2008-2012 онд Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний хэлтсийн даргаар ажиллаж байхдаа /хуучин нэрээр/ Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4 дэх хэсэгт заасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопедийн хэрэгслийн үнийг 3 /гурав/, 5 /тав/ жилд нэг удаа нөхөн олгох заалтыг далимдуулан уг хэрэгслийн үнийг нөхөн авахад баримталдаг Засгийн газрын 2008 оны 162 дугаар тогтоолоор баталсан журмыг ноцтой зөрчин хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгоор албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, улсын халамжийн санд 90.570.000 мянган төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан, уг мөнгийг бэлэн болон бэлэн бусаар Асрамжийн газрын нярав О.Ф-ын Хаан банкин дахь хувийн данс болон бэлнээр татан авч хувьдаа 63.370.000 төгрөгийг завшсан гэмт хэргийг,

Мөн тус хэлтсийн даргаар ажиллаж байх хугацаандаа Монгол Улсын Хүний хөгжил сан, Халамжийн тухай, Хүний хөгжил сангийн төсвийн тухай хууль, Засгийн газрын 2010 оны 347 дугаар тогтоол болон түүний дагуу гарсан дүрэм журмаар тодорхойлогдсон албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэн Хүний хөгжил сангаас Монгол Улсын харьяатаас гарсан 299 иргэнд 139.426.000 төгрөгийн, нас барсан 127 иргэнд 17.957.000 төгрөгийн Эх орны хувь хишиг, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг зөрчин Халамжийн сангаас 41 иргэнд Бүгд Найрамдах Казакстан улсад эмчилгээ, оношилгоо хийлгэн ирэхэд унааны нэг талын хөнгөлөлт болгон 8,924,680 төгрөгийн тэтгэмж, Улаанбаатар хотод эмчилгээ, оношилгоо, хийлгэсэн нь хангалттай нотлогдож тогтоогдоогүй 16 иргэнд эмнэлэгт

хэвтэн эмчлүүлээгүй, оношилгоо хийлгээгүй байхад 3,155,650 төгрөгийн тэтгэмжийг олгуулан улсад нийт 260.033.330 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг,

Яллагдагч О.Ф Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний газрын Асрамжийн газрын зохион байгуулагчаар ажиллах хугацаандаа Я.С-ийн дээрх гэмт хэргийг үйлдэхэд учрах саадыг хөнгөвчлөн сумын халамжийн сангаас шилжүүлсэн мөнгийг хувийн дансаараа шилжүүлэн авч Я.С-эд өгөх, түүний даалгаснаар бусдад шилжүүлэх, санхүүгийн баримтуудыг нь бүрдүүлэх зэргээр гэмт хэрэг үйлдэхэд тусалж дэмжлэг үзүүлсэн буюу хамжигчаар оролцож 90.570.000 мянган төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг,

Яллагдагч А.Х 2011 оны 01 дүгээр сараас Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн Хүний хөгжил сангийн гэрээт нягтлан бодогчоор ажиллаж байх хугацаандаа Монгол Улсын Хүний хөгжил сан, Халамжийн тухай, Хүний хөгжил сангийн төсвийн тухай хууль, Засгийн газрын 2010 оны 347 дугаар тогтоол болон түүний дагуу гарсан дүрэм журмаар тодорхойлогдсон албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэн Хүний хөгжил сангаас Монгол Улсын харьяатаас гарсан 310 иргэнд 132.734.000, нас барсан 94 иргэнд 8.220.000 төгрөгийг гаргаснаас улсад онц их хэмжээний буюу 140.954.000 төгрөгийн хохирол учруулсан гэмт хэргийг,

Яллагдагч О.С Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн даргаар ажиллах хугацаандаа Хүний хөгжил сангийн хууль, Халамжийн сангийн тухай хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм журмаар тодорхойлогдсон албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс Хүний хөгжил сангаас олгох ёсгүй 82 иргэнд 37,115,000 төгрөгийг, Халамжийн сангаас 4 иргэнд Бүгд Найрамдах Казакстан улсад эмчилгээ, оношилгоо хийлгэн ирэхэд унааны нэг талын хөнгөлөлт болгон 392 000 төгрөгийг, Улаанбаатар хотод эмчилгээ, оношилгоо хийлгэсэн нь хангалттай нотлогдож тогтоогдоогүй 42 иргэнд эмнэлэгт хэвтэн эмчлүүлээгүй, оношилгоо хийлгээгүй байхад 8.019.608 төгрөгийн тэтгэмжийг олгуулан улсын Халамжийн санд онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг,

Яллагдагч А.П Баян-Өлгий аймгийн

Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн Халамжийн сангийн ахлах мэргэжилтэн, хүний хөгжил сангийн ахлах мэргэжилтнээр 2010-2012 оны 03 дугаар сар хүртэл ажиллах хугацаандаа Хүний хөгжил сан, Хүний хөгжил сангийн төсвийн тухай хууль, Засгийн газрын 2010 оны 347 дугаартай тогтоол болон түүнтэй холбогдуулан гаргасан тушаал, журмаар тодорхойлогдсон албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс Хүний хөгжил сангаас олгох ёсгүй 218 иргэнд 75.267.000 төгрөгийг, нас барсан 127 иргэнд 17.957.000 төгрөгийг олгуулан улсад 93.224.000 онц их хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг,

Яллагдагч Д.А Баян-Өлгий аймгийн ...сумын халамжийн байцаагчаар ажиллаж байхдаа 2013 оны халамжийн сангийн төсвийн үлдэгдэл 15.000.000 төгрөгийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн сангийн дансанд шилжүүлэн гарган авч санхүүгийн тайланд тусгалгүй хувьдаа завшиж, үлэмж хэмжээний хохирол учруулсан гэх гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүгдэгч Я.С шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Надад холбогдуулж байгаа Дүүргийн 2 дугаар прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 264 дүгээр зүйлийн 264.2, 150 дугаар зүйлийн 150.3-д заасан гэмт хэрэг үйлдсэн гэж яллах дүгнэлтэд дурдаж буруутгаж байна. Намайг улсын Нийгмийн халамжийн болон Хүний хөгжил санд их хэмжээний хохирол учруулсан гэж яллах дүгнэлтэд бичсэн байна. Энэ бол огт худлаа, үндэслэлгүй гэж үзэж байна. Би гэмт хэрэг үйлдээгүй, өөрийгөө гэм буруутай гэж үзэхгүй байна. Би Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулдаг "ТЦ" ХХК-тай протоез, ортопедийн тусгай хэрэгслийн бүтээгдэхүүн нийлүүлэх талаар ямар нэгэн гэрээ, хэлцэл хийж байгаагүй, ямар нэгэн албан тоот явуулан захиалга өгч хүсэлт гаргаж байгаагүй, тус компанид ортопедийн хэрэгслийн үнийг шилжүүлсэн ямар нэгэн халамжийн санхүүгийн бичиг баримтад гарын үсэг зурж байгаагүй юм. Түүнчлэн сумын Засаг дарга болон сум хариуцсан хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн нарт уг ортопедийн тусгай хэрэгслийн талаар ямар нэгэн албан бичиг, албан даалгавар явуулаагүй, ямар нэгэн эрх олгох, үүрэг бий болгох тухай тушаал гаргаагүй, тэмдэглэл болон албаны цохилт хийгээгүй. Ямар нэгэн

Төрийн ажил бол бичгээр явагдах журамтай байдаг. Тэр тусмаа мөнгөний асуудал албан бичиг хэргээр явагдах ёстой. Тухайн үед манай аймгийн сумдад протез, ортопедийн тусгай хэрэгсэл шаардлагатай болох талаар Сагсай, Толбо, Ногоонуур, Аптанцөгц, Буянт, Цэнгэл, Булган сумдын Засаг дарга нар болон Цагааннуур тосгоны захирагчийн албанаас албан тоотоор хүсэлт ирж байсан юм. Баян-Өлгий аймагт тухайн үед ахмад настан 6800, хөгжлийн бэрхшээлтэй иргэн 4910, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд 258 буюу нийт 11968 хүний судалгааг мэдээлэлээр программ хангажмийн мэргэжилтэн гаргасан байдаг. 2010 оны 04 дүгээр сарын үед Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын халамжийн хэлтсийн дарга Х.Ч-гээс тэргэнцэр буюу ортопедийн хэрэгсэл шаардлагатай иргэдийн нэрсийн жагсаалтыг ирүүлэх талаар албан бичиг ирж байсан. Тухайн албан тоот нь суманд очиж, Баян-Өлгий аймагт тэргэнцэр нийлүүлэх компани, дэлгүүр, хувь хүн байхгүй, хэрэгцээ шаардлага байсан тул сум хариуцсан хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн нар тухайн ортопедийн хэрэгслийг хүлээж авсан байх гэж бодож байна. Мөн УИХ-ын гишүүдээс хүртэл албан тоотоор ирж байсан. “ТЦ” ХХК-наас нийлүүлсэн гэх ортопедийн хэрэгсэл тэргэнцэр, төрөл бүрийн таяг, харааны шилийг Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д заасан болзол, шаардлага хангасан иргэд болон хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэртэй хөгжлийн бэрхшээлтэй иргэн мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд олгосон. Мөн хуульд заасан болзол, шаардлага хангасан иргэдэд ортопедийн хэрэгсэл олгосон бичиг баримт, материалууд нь сум хариуцсан хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн нарт байдаг. Үүнийг саяхан Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас ажлын хэсэгт орж ажилласан Б.Эр, Я.Б, Мэргэжлийн Хяналтын улсын ахлах байцаагч Х, Б нар нэг бүрчлэн шалгаж Засгийн газрын 2008 оны 162 дугаар тогтоолын хавсралтаар баталсан журамд зааснаар бичиг баримтаа хуулийн дагуу бүрдүүлсэн учраас албан ёсны акт гаргаж төлбөр тавигдаагүй. Үүний үлдэгдэл 20.000.000 төгрөгийн ортопедийн хэрэгсэл нь Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн агуулахад одоо

бэлэн байгаа. Үлдэгдэл гэх 23.000.000 сая төгрөгийн ортопедийн хэрэгслүүдийг сумын мэргэжилтэн нарт өгч ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тараах эсвэл тухайн нийлүүлсэн компанид буцаах зэргээр шийдвэрлүүлэх бүрэн боломжтой гэж үзэж байна. Тухайн үед “ТЦ” ХХК-наас нийлүүлсэн гэх ортопедийн хэрэгсэл нь чанарын шаардлага хангаагүй, хэрэгцээнээс илүү нийлүүлсэн гэх ямар нэгэн мэргэжлийн байгууллагын дүгнэлт гараагүй юм. “ТЦ” ХХК-наас нийлүүлсэн гэх 90.570.000 төгрөгийн ортопедийн хэрэгслийг сум хариуцсан хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн нар тус компанийн гэрээт төлөөлөгчийн бичсэн зарлагын падааныг үндэслэн орлогын падаан бичиж сумын халамжийн санд албан ёсоор хүлээн авсан. Тус компанийн санхүүгийн дансанд болон гэрээт төлөөлөгчийн хувийн дансанд бэлэн болон бэлэн бусаар үнийг шилжүүлсэн. Мөнгө шилжүүлсэн санхүүгийн шилжүүлгийн нэгдүгээр гарын үсгийг сумын Засаг дарга, хоёрдугаар гарын үсгийг сум хариуцсан хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн нар зурдаг. Уг ортопедийн хэрэгсэл нь хориглосон бараа биш, харин хуульд заасан болзол шаардлага хангасан иргэдэд олгогдсон. Тухайн үед программд давхардал гараагүй, Нийгмийн халамжийн санд хохирол учраагүй тухай Баян-Өлгий аймаг дахь Сум дундын шүүхийн 2013 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн эрүүгийн шүүх хуралдаанд гэрчээр оролцсон тус аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний мэргэжилтэн нар А.П, н.Ха, мэдээлэл программын ажилтан А.Он нарын мэдүүлгээр нотлогдож байгаа. “ТЦ” ХХК-наас нийлүүлсэн гэх ортопедийн хэрэгслүүдийг хүлээн авч хуульд заасан болзол шаардлага хангасан иргэдэд олгосон. Үүний мөнгийг сумын нийгмийн халамжийн данснаас шилжүүлсэн. Засгийн газрын 2008 оны 162 тоот тогтоолын хавсралтад заасан бичиг баримтуудын бүрдлийг ханган олгосон талаар гэрч Р.Ры, Ш.Ай, Ш.Шүн, Цс, Х.Та, К. Бау, Б.Көк, Ш.Ер, М.Ма, Х.Хо, Ж.Му, Х.Аг, Апт, Мар, Ерк, На, Фар, Бо, Маде, Авчү, Сау нарын мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлгээр нотлогдож байгаа юм. Хавтаст хэрэгт авагдсан “ТЦ” ХХК-ны захирал А.Нар-д Баян-Өлгий аймаг дахь гэрээт төлөөлөгч О.Ф-оос ортопедийн хэрэгслийн үнийг бэлнээр болон бэлэн бусаар өгсөн мөнгөний бичиг баримтууд, орлого, зарлагын падаанууд, нэхэмжлэх, бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, кассын орлогын, зарлагын тайлан,

хоёр талын тооцоо нийлсэн акт, компаниас гэрээт төлөөлөгчид олгосон итгэмжлэл, сумдад протез ортопедийн хэрэгслийг хуваарилсан жагсаалтыг компанийн захирал гарын үсгээ зурж, тэмдэг дарж баталгаажуулсан зэрэг бичиг баримтуудыг би урьд өмнө харж байгаагүй. Хуурамчаар үйлдэх боломжгүй бичиг баримтууд тул би уг асуудлыг огт мэдэхгүй. Уг олон хуудас бүхий бичиг баримтуудыг намайг хуурамчаар үйлдсэн гэж байгаад гайхаж байна. Тухайн байгууллагын тэмдэг нь захиралд байдаг ба түүний гарын үсгийг тийм олон хуудастай бичиг, баримтуудад хуурамчаар зурах гэсэн боломж амьдралд бараг байхгүй.

Намайг хуурамчаар бичиг баримт бүрдүүлсэн гэж байгаа бол тэмдэг, компанийн захирлын гарын үсэг зэргийг шүүх шинжилгээгээр тогтоох хэрэгтэй. Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагч "ТЦ" ХХК-наас Баян-Өлгий аймгийн сумдад нийлүүлсэн гэх ортопедийн хэрэгслийг 2012 оны 05 дугаар сард шалгаж улсын байцаагчийн 2012 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн албан шаардлага үйлдсэн юм. Тухайн албан шаардлагад дурдсан ганц шаардлагын утга нь нэгэнт ортопедийн хэрэгслүүдийг хуульд заасан болзол, шаардлага хангасан иргэдэд олгосон учраас Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн менежер программд бүрэн тусгах тухай бичсэн байсан. Би аймгийн Мэргэжлийн хяналтын газрын албан шаардлагыг хүлээн авч сумдад хэрэгжүүлэн ажиллах талаар албан тоот хүргүүлсэн. Албан шаардлагын хэрэгжилтийн талаар Мэргэжлийн хяналтын газрын дарга Х.М-д хариуг хүргүүлсэн. Гэвч тус аймгийн аудитын газраас 2012 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 149 дугаартай тус хэлтсийн нийгмийн халамжийн сангийн тайланг шалгасан санхүүгийн тайланд Зөрчилгүй санал дүгнэлт өгч байсан дүгнэлтээр, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын хяналт шинжилгээний хэлтсээс тус хэлтэст 2011 онд хийсэн иж бүрэн хяналт шалгалтын дүнгээр няцаагдаж байсан юм. Ховд аймгийн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхийн 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 14 тоот магадлалын үндэслэх хэсэгт заахдаа Аймгийн аудитын газраас Баян-Өлгий аймгийн Халамжийн сангийн 2011 оны жилийн санхүүгийн тайланд зөрчилгүй гэсэн дүгнэлт өгсөн байхад Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын

Улсын байцаагчийн 2012 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн шалгалтаар Баян-Өлгий аймгийн Халамжийн санд тодорхой зөрчлүүд илэрсэн талаар танилцуулга бичсэн байна. Иймээс Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн халамжийн сангийн 2011, 2012 оны санхүүгийн тайлан хуулийн дагуу үнэн зөв гарсан эсэх, үүнд ямар нэг зөрчил дутагдал байгаа эсэхийг тусгай мэдлэг бүхий хөндлөнгийн шинжээч томилж, дүгнэлт гаргуулах гэсэн заалт тусгагджээ. Мөрдөн байцаагч Ц.Н шүүхийн магадлалд заасны дагуу ажлын хэсэг ажиллуулсан. Тухайн ажлын хэсэгт Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын улсын байцаагч Х, Б болон Нийгмийн халамж, үйлчилгээний газрын дотоод аудит, хяналт шалгалтын газрын мэргэжилтэн Б.Эр, Я.Б нар оролцож, "ТЦ" ХХК-наас нийлүүлсэн гэх ортопедийн хэрэгслийн үнийг хэн нэгэн этгээдээр төлүүлэх талаар албан ёсны дүгнэлт, акт гараагүй байна. Үүнээс үзэхэд улсын Нийгмийн халамжийн санд 90.560.000 төгрөгийн хохирол учирсан эсэхийг ажлын хэсгийнхэн ч нотлоогүй. Өөрөөр хэлбэл, хөндлөнгийн мэргэжлийн байгууллага ортопедийн хэрэгслийг буруутай этгээдээр төлүүлэх талаар албан ёсны дүгнэлт, акт гараагүй. "ТЦ" ХХК-аас тус аймгийн сумдад нийлүүлсэн гэх ортопедийн хэрэгсэл болох тэргэнцэр, төрөл бүрийн таяг, харааны шилний үнэ нь Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын 2009 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 24 дугаартай тушаалаар баталсан жишиг үнээс харьцангуй доогуур үнэтэй нийлүүлсэн байна гэж үзэж байна. Сайдын тушаалд зааснаар энгийн таяг-10.000-15.000 төгрөг, суга таяг 30.000-40.000 төгрөг, тохой таяг хос 30.000-40.000 төгрөг, гар таяг 8.000 төгрөг, насанд хүрсэн иргэн болон хүүхдийн тэргэнцэр 15.000-20.000 төгрөгийн үнэтэй байхад "ТЦ" ХХК-наас энгийн таяг 6000-8000 төгрөг, суга таяг 35000 төгрөг, хос таяг 35000 төгрөг, харааны шил 6.000 төгрөг, тэргэнцэр 150.000 төгрөгийн үнэтэй нийлүүлснийг үзэхэд Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын тушаалыг зөрчиж илүү үнээр борлуулсан нь тогтоогдоогүй байна. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-д зааснаар ахмад настан 5 жилд нэг удаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөгжлийн бэрхшээлтэй

хүүхдэд 5-н жилд нэг удаа дотоод хийлгэсэн болон худалдан авсан ортопедийн хэрэгслийн үнийг нэг удаа нөхөн олгооно гэж заасан болохоос хуульд хориглосон заалт байхгүй, уг хуулийг тухайн жилүүдэд хуульд заасан болзол, шаардлагыг хангасан ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд давхардуулан олгосон талаар зөрчил гараагүй. Энэ нь тус хэлтсийн программ хангамж хариуцсан ажилтан А.Он-ын мэдүүлгээр нотлогдож байгаа юм. Иргэний нэхэмжлэгчээр томилогдсон Мж нь тухайн үед Нийгмийн халамжийн санд ажиллаж байгаагүй харин өөр ажил хийж байсан. Мөрдөн байцаалтын шатанд тараагдсан таяг, тэргэнцэр, нүдний шилийн үнийг нэхэмжлэх шаардлагагүй сумдын мэргэжилтэн нар хуульд заасан шаардлага хангасан хүмүүст тараан өгч баримтаа бүрдүүлсэн байна гэж мэдүүлж байгаа юм. Одоогоор улсад бодитой хохирол учирсан гэдэг нь хөдөлбөргүй нотлох баримтаар тогтоогдохгүй байгаа юм. Учир нь уг ортопедийн хэрэгслээс 70,0 сая төгрөгийн тэргэнцэр, төрөл бүрийн таяг, харааны шилийг Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний нийгмийн хамгааллын тухай хуульд заасан болзол, шаардлага хангасан иргэдэд давхардуулахгүйгээр олгосон байна. Нөгөө талаас эд мөрийн баримтаар хурааж авсан гэх 20,0 орчим төгрөгийн үлдэгдэл ортопедийн хэрэгслийг сум хариуцсан хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн нар орлогод авсан, түүнийг цаашид ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тараах шаардлагатай Өөрөөр хэлбэл, байгууллага дотроо шийдвэрлэх бүрэн боломжтой. Нийгмийн халамжийн санд хохирол учраагүй гэж сум хариуцсан хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн нарын мөрдөн байцаалтын шатанд гэрчээр өгсөн мэдүүлгээр нийгмийн халамжийн санд бодит байдлаар хохирол учраагүй гэж үзэж байна. Би уг ортопедийн хэрэгслийг заавал авах буюу доод шатны мэргэжилтэн нарт үүрэг өгсөн асуудал огт байхгүй, мөн хуульд зааснаар албан тушаалын эрх мэдлээ урвуулан ашигласан, иргэдийн хуулиар хамгаалагдсан ашиг сонирхолд их хэмжээний хохирол учруулсан, дарамт шахалт үзүүлэх шууд нөлөөлөх асуудал байхгүй болно. Би хэлтсийн даргын хувьд Буянт сум хариуцсан хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн М.Цэ, Дэлүүн сум хариуцсан хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн Д.А, Бугат сумын халамжийн

мэргэжилтэн н.Аг, Баяннуур сумын нийгмийн ажилтан Н.Нур, Цэнгэл сумын халамжийн мэргэжилтэн Мт нарт тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан. М.Цэ нь мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэгт “ТЦ” ХХК-ны нийлүүлсэн ортопедийн бүтээгдэхүүнийг борлуулаагүй гэх шалтгаанаар надад Я.С дарга хариуцлага тооцсон гэж тайлбарлах боловч мэргэжилтэн М.Цэ-д сахилгын шийтгэл ногдуулсан хэлтсийн дарга Я.С миний 2011 оны 07 дугаар сарын 05-ны өдөр үйлдсэн гэх 102 тоот тушаал нь Сум хариуцсан хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн нарын нэгдсэн сургалтыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тасалсан, хэлтсийн удирдлагаас албан ёсны шаардлага тавихад байнга эсэргүүцэж, ёс зүйн алдаа гаргасан байдлыг харгалзан Төрийн албаны тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.2.1, тус хэлтсийн хөдөлмөрийн дотоод журмын 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх хэсэгт зааснаар хариуцлага ногдуулсан. Намайг уг ортопедийн хэрэгслийн үнийг нөхөн авах талаар Засгийн газрын 2008 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 162 дугаартай тогтоолоор баталсан журмыг зөрчсөн гэж буруутгаж байгааг огт зөвшөөрөхгүй байна. Учир нь Засгийн газрын 2008 оны 162 тоот тогтоолын хавсралтаар баталсан Ахмад настанд мөнгөн тусламж, үзүүлэх, хөнгөлөлт олгох журам, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд мөнгөн тусламж үзүүлэх, хөнгөлөлт олгох журамд зааснаар ортопедийн хэрэгслийг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох, бичиг баримтын бүрдүүлбэр хийх эрх бүхий субъект хэлтсийн дарга биш, харин энэ нь сум хариуцсан Хөдөлмөр, халамжийн мэргэжилтэн нарын биечлэн хариуцах ёстой ажил болно. Засгийн газрын 2008 оны 162 тоот тогтоол нь Засгийн газрын 2012 оны 185 тоот тогтоолоор 2012 оны 07 дугаар сарын 01-нээс эхлэн хүчингүй болсон байх тул яллагдагч миний эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг хэрэглэвэл Эрүүгийн хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийг ноцтой зөрчсөн үйл ажиллагаа болно. Надад холбогдох зохиомол улс төрийн захиалгатай эрүүгийн хэрэг нь анх Баян-Өлгий аймгийн Ардчилсан намын дарга, одоо Зам тээврийн дэд сайд К.Еж болон “А” намын гишүүн, надад өш хонзонтой М.М нарын захиалга, үндэслэлгүйгээр мэдээллээр үүсгэгдсэн. К. Еж болон М.М нарын Авлигатай тэмцэх газарт өгсөн мэдээлэл зэрэг нь нотлох баримтаар авагдсан байгаа. Өнгөрсөн

хугацаанд Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхээс 1, Баян-Өлгий аймгийн давж заалдах шатны шүүхээс 1, Ховд аймаг дахь Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхээс 1 удаа нэмэлт мөрдөн байцаалтад тус тус буцаагдаж, Баян-Өлгий аймаг дахь Сум дундын шүүхийн 2013 оны 10 дугаар сарын 9-ний өдрийн шүүх хуралдаанаас 69 дугаартай цагаатгах тогтоол гарч байсан юм. Дүүргийн 2 дугаар прокурорын газрын хяналтын прокуророос 2014 оны 10 дугаар сарын 13-ны өдөр үйлдсэн яллах дүгнэлтэд Мэргэжлийн хяналтын газрын хяналт шалгалтын танилцуулга, гэрч Х, Я.Б, Л.Би нарын мэдүүлэг, мөрдөн байцаалтын шатанд яллагдагч нартай холбоогүй, иргэний хариуцагчаар татагдсан 130 иргэний мэдүүлэг, зөрчилтэй гэх 381 иргэнээс иргэний хариуцагчаар татагдсан 48 иргэн хишиг, хувиа өөрсдөө хуулийн дагуу авсан тухай мэдүүлгүүд тус тус авагдсан байна. Учир нь Дүүргийн 2 дугаар прокурорын газрын хяналтын прокурорын 2014 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн “Зарим яллагдагч нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох тухай” 522 дугаар тогтоолоор 462 иргэнд холбогдох 140.000.000 орчим сая төгрөгийн төлбөрийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна. Гэтэл надад холбогдолгүй болж хэрэгсэхгүй болсон гэх 462 иргэний жагсаалт дотор нэрс нь бичигдсэн 130 иргэний иргэний хариуцагчаар татагдаж, мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэг нь яллах дүгнэлтэд бичигдсэн байна. Өөрөөр хэлбэл, 130 иргэний Хүний хөгжил сангаас хишиг, хувиа хууль ёсоор авсан эсэх нь яллагдагчид надад хамааралгүй болсон мөртлөө яллах дүгнэлтэд дахин тэдний нэрс, мэдүүлгийг яллах талын нотлох баримт болгож байгаа нь буруу гэж үзэж байна.

Яллах дүгнэлтэд зөрчилтэй гэх 381 иргэнээс мөрдөн байцаалтын шатанд 48 иргэн хишиг, хувиа өөрсдөө бичиг баримтаа бүрдүүлэн авсан гэж мэдүүлсэн байна. Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Сагсай, Алтанцөгц, Буянт, Өлгий, Цэнгэл, Улаанхус, Ногооннуур, Цагааннуур, Толбо, Баяннуур сумдын улсын бүртгэгч болох нэр бүхий 11 гэрч нарын мэдүүлэг бичигдсэн байна. Эдгээр албан тушаалтнууд миний тухай нэг ч зүйл яриагүй, өөрсдийн ажлыг тухайлбал нас барсан иргэдийг хэрхэн бүртгэх, нас барсны гэрчилгээг тэд ямар журмаар авдаг, яаж олгодог тухай өөрсдийн хийж ирсэн ажлыг

ярьсан байна. Ийм учраас тэдний мэдүүлэг нь намайг буруутгах үндэслэл болохгүй гэж үзэж байна. Мөн яллах дүгнэлтэд Хаан банкны теллер нар болох Т.Ю, Б.Нуб, н.Ма, н.Ас нарын 4 иргэний гэрчийн мэдүүлэг авагдсан байна. Тэд 2013 оны асуудлыг ярьж мэдүүлэг өгсөн байдаг юм. Гэтэл би 2012 оны 08 дугаар сард ажлаас гарсан байсан учраас надад холбогдолгүй асуудал гэж үзэж байна. Мөн Хаан банкны Дотоод аудитын газрын дарга Г.Э-ийн мэдүүлэг авагдсан байна. Г.Э ахлагчтай ажлын хэсэг 2013 оны 10 дугаар сард Баян-Өлгий аймагт очиж Хаан банкны санхүүгийн үйл ажиллагаанд дотооды аудитын шалгалт хийсэн байдаг. Хаан банкны 2013 оны санхүүгийн үйл ажиллагааг шалгасан учраас надад хамааралгүй гэж үзэж байна. Учир нь би 2012 онд ажлаас гарсан. Тухайн үед шалгалт хийхэд шалгалтын дүнгийн материалд зөвхөн Г.Э гарын үсэг зурсан ба З.Ц, Г.Л нарын 2 хянан шалгагч гарын үсэг зураагүй, нөгөө шалгуулсан гэх Баян-Өлгий аймгийн Хаан банкны нэр бүхий 9 хүн бүгд гарын үсэг зураагүй байдаг юм. Иймд Хаан банкны дотоодын аудитын газраас хийсэн хяналт шалгалтын дүн гэгч материал нь эргэлзээтэй нотлох баримт учраас шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй гэж үзэж байна. Яллах дүгнэлтэд Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хяналт шалгалтын дүн, гэрч П.Хо, Я.Б, Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч нарын 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн № 04\77\55, 56, 57 дугаар акт, №04\77\24 дүгээр албан шаардлага дурдагдсан байна. Гэтэл Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч нарын ажлын хэсэгтэй хамтран 2014 оны 01 дүгээр сарын 28-наас 05 дугаар сарын 28-ныг хүртэл хийсэн хяналт шалгалт гэдэг нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу явагдаагүй, уг хуулийн олон зүйл заалтуудыг ноцтой зөрчсөн учраас нотлох баримтаас хасагдах ёстой юм. Учир нь хяналт шалгалт нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д хяналт шалгалтыг давхардуулахгүй бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаас хийсэн шинжилгээний дүн, дүгнэлтийг хяналт шалгалтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага харилцан хүлээн зөвшөөрнө гэснийг ноцтой зөрчиж байна. Хүний хөгжил сангийн тухай хуулийн Зургаадугаар бүлэгт Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналтын тухай зохицуулсан.Мөн

хуулийн 21 дүгээр зүйлийн 22.1. Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланд Үндэсний аудитын газар жил бүр аудит хийж, дүгнэлт гаргана. гэснийг үндэслэн аудитын байгууллага хяналт шалгалт хийж дүгнэлт, акт гаргах ёстой. Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн хүний хөгжил сангийн зарцуулалтад Үндэсний аудитын газраас 2011 оны 11 дүгээр сард, Баян-Өлгий аймгийн Аудитын газраас 2012 оны 02, мөн оны 06 дугаар сард, 2013 оны 06 дугаар сард нийт 4 удаа төрийн аудит хийж Зөрчилгүй гэсэн санал дүгнэлт гаргаж байсан нь хавтаст хэрэгт авагдсан байдаг. Аудитын газар нь “Айдо” программтай байдаг. Программ нь Нийгмийн халамж, үйлчилгээний газрын мэдээлэл технологийн төвтэй холбогдсон байдаг юм. Тийм ч учраас аудитын дүгнэлт ямагт үнэн зөв гардаг юм. Гэтэл урьд аудитын хяналт шалгалтаар баталгаажуулсан асуудлыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газар дахин шалгах ёсгүй гэж үзэж байна. Мэргэжлийн хяналтын шалгалтын дүнг гаргахдаа улсын ахлах байцаагч нар болон ажлын хэсэгт орсон бүх хүмүүс гарын үсэг зурж ажлын хэсгийн ахлагч хяналт шалгалт хийсэн дүнг МХЕГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулах ёстой. Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас үйлдсэн хяналт шалгалтын дүнд 15 хавсралттай байгаа тухай нарийвчлан дурдсан ба уг 15 хавсралт нь бодит байдалд хавтаст хэрэгт авагдаагүй, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга П-ийн 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 63 дугаар тушаалаар ажлын хэсэгт орсон н.Бт, н.Гз нар гарын үсэг зураагүй, ажлын хэсгийн ахлагч томилоогүй, ажлын хэсэгт НХЕГ-аас орж ажилласан Б.Эр, Я.Б нар нь хяналт шалгалтын дүнгийн материалд гарын үсэг зурж мөрдөн байцаалтын шатанд гэрчийн мэдүүлэг өгсөн боловч тэднийг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд оруулсан тухай МХЕГ-ын даргын тушаал, шийдвэр гаргаагүй байна. Баян-Өлгий аймгаас Улсын мөрдөн байцаах газрынхан Баян-Өлгий оршин суух 18000 өрхийн Хүний хөгжил сангийн хувийн хэргийн материалыг авч ирсэн болно. Гэтэл уг материалыг огт шалгаагүй, нэг ч хуудас үзээгүй байгаад 2014 оны 08 дугаар сарын 08-ны өдөр Баян-Өлгий аймагт дахин ачуулсан. Бидэнд хяналт шалгалт хийсэн материалыг Төрийн хяналт шалгалтын тухай хуульд зааснаар улсын ахлах байцаагч нар танилцуулах үүрэгтэй юм. Гэтэл ахлах

мөрдөн байцаагч, цагдаагийн хошууч Ц.Н 2014 оны 06 дугаар сард Баян-Өлгий аймагт очих үед бид уулзаж Мэргэжлийн хяналтын газраас ямар акт гарсан байна гэж хэлэхэд маргааш ир, нөгөөдөр ир гэж байгаад хамгийн сүүлд Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагч нарын 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн № 04\77\55, № 04\77\56, № 04\77\57 дугаар актуудыг танилцуулсан. Бид акттай танилцаж гарын үсэг зурахдаа тайлбараа гаргаж өгнө гэж гарын үсэг зурсан болно. Ингээд уг актуудын хавсралтыг авъя гэхэд өгөөгүй. Уг нь актыг зөвшөөрөхгүй гэвэл танилцаж гарын үсэг зурснаас хойш Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д зааснаар дээд шатны байгууллагад гомдол гаргах эрхтэй. Хэрвээ дээд шатны байгууллагаас өгсөн гомдлыг зөвшөөрөхгүй бол Захиргааны хэргийн шүүхэд хандах эрхтэй гэж бичсэн байсан. Бидний эрх ашгийг хөндөж буй актыг мөрдөн байцаагч үйлдээгүй, уг асуудлыг шалгаагүй байж яагаад бидэнд танилцуулж байгааг эргэлзэж байна. Бидэнд хяналт шалгалтын дүн, актыг хяналт шалгалт хийсэн улсын ахлах байцаагчид Х, Б нар танилцуулах ёстой байтал албан ёсоор танилцуулаагүй нь хууль зөрчсөн ажиллагаа гэж үзэж байна. Аливаа шалгалт тэр тусмаа санхүүгийн бичиг, баримтын шалгалт нь заавал үндсэн материалыг нэг бүрчлэн тулган үзсэний үндсэн дээр дүнгээ гаргах ёстой. Хүний хөгжил сангаас хишиг, хувь авах иргэдийн хишиг, хувь хүссэн өргөдлийг дагалдах бичиг баримтуудын хамт сумын нийгмийн халамжийн мэргэжилтэн нар хүлээн авч хянан үзэх үүрэгтэй. Нэгэнт иргэнээс ирүүлсэн материалын бүрдүүлбэр бүрэн, хууль, журамд заасан шаардлагыг хангаж байгаа гэж үзвэл хамгийн түрүүнд хувийн хэрэг нээдэг. Хувийн хэрэг нь өөрөө улсын хэмжээнд давхардахгүйгээр тусгай өгөгдөл бүхий тоо, хэлбэрээр илэрхийлсэн дугаартай байдаг. Түүнчлэн тухайн иргэнд Хүний хөгжил сангийн дэвтэр нээж өгнө. Хүний хөгжил сангийн дэвтэр ч улсын хэмжээнд давхарддаггүй өгөгдөл бүхий тоо хэлбэрээр илэрхийлсэн дугаартай. Тухайн иргэнд Хүний хөгжил сангаас хишиг, хувь олгох асуудлыг мэдээллийн санд заавал шивж оруулна. Ингэхэд хувийн хэргийн болон Хүний хөгжил сангийн дэвтэрийн дугаар нь мөн мэдээллийн санд бичигдэнэ. Иргэний мэдээлэл, хувийн хэргийн болон дэвтрийн дугаар мэдээллийн

санд орсноор тухайн иргэн Хүний хөгжил сангаас хишиг, хувь авах нөхцөл бүрдэнэ. Өнөөдөр зөрчилтэй гэх 381 иргэний нэг ч хувийн хэргийг түүний дотор авагдсан бичиг, баримтуудыг нягталж шалгаагүй байж төлбөр тавьж байгаа нь бас л хууль бус асуудал болсон. Тийм ч учраас бид Дүүргийн эрүүгийн хэргийн 2 дугаар шүүхэд зөрчилтэй гэх иргэдийн дотроос өөр аймаг, дүүрэгт оршин суух нэр бүхий 143 иргэнийг хасаж, үлдсэн Баян-Өлгий аймагт оршин суух 238 иргэний хувийн хэрэгт үзлэг хийх тухай хүсэлтээ гаргасан учиртай юм. Зөрчилтэй гэх 381 иргэний дотор 92 хүүхэд байна. Харин хувийн хэргийг өрх бүрээр нээдэг журамтай тул тэд хишиг, хувиа хуулийн дагуу авсан уу гэдгийг нягталж шалгахын тулд эцэг, эхийн аль нэгний нэрэнд нээсэн хувийн хэргийг үзэх ёстой юм. Мэргэжлийн хяналтын улсын байцаагчдын акт хууль зүйн үндэслэл муутай учраас бид Захиргааны хэргийн шүүхэд хандаж, Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчдын 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн № 04\77\55, №04\77\56, № 04\77\57 дугаар акгууд, № 04\77\24 дүгээр албан шаардлагуудыг бүхэлд нь хүчингүй болгох тухай нэхэмжлэлийн шаардлага гарган шүүгч захиргааны хэрэг үүсгэн шалгаж байна. Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчдын 2014 оны № 04\756 дугаар акт хууль зүйн хувьд ч үндэслэлгүй гэдэг нь актын хавсралтад заасан 852 иргэнээс Дүүргийн 2 дугаар прокурорын газрын хяналтын прокурорын 2014 оны 08 дугаар сарын 07-ны өдрийн 522 дугаар тогтоолоор 462 иргэнд холбогдох төлбөр нь хэрэгсэхгүй болсон. Үлдсэн 381 иргэнд холбогдох төлбөр нь Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын дарга Д.Баяа-аас 2014 оны 08 дугаар сарын 25-ны өдөр Мэргэжлийн Хяналтын Ерөнхий газрын даргад явуулсан 1\1070 дугаар албан бичиг, түүний хавсралт, Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын Л.Би-ээс Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын даргад болон Дүүргийн эрүүгийн хэргийн 2 дугаар шүүхэд 2014 оны 09 дүгээр сарны 23-ны өдөр явуулсан 10\1156 дугаар албан тоот, хавсралт 16 хуудастай нотлох баримт, хэрэг шүүхэд хянагдаж байгаа үед өмгөөлөгч Б.Э-аас гаргаж өгсөн олон хуудас бүхий Баян-Өлгий сумдын Засаг дарга нарын албан бичиг, сумын халамжийн мэргэжилтэн нарын тодорхойлолт, зөрчилтэй гэх иргэд өөрсдөө арилжааны банкинд очиж банкны депозит дансны хуулгаар тус тус

нотлогдох байна. Мөрдөн байцаагч биднийг яллаж буй 381 иргэнээс 48 иргэнийг асууж, харин үлдсэн 333 иргэнийг огт асуугаагүй учраас шүүхэд нэр бүхий 333 иргэнийг асууж өгөх талаар хүсэлт гаргасан. Мөрдөн байцаагч ингээд 381 иргэнийг яагаад ялгаварлан заримыг асууж, заримыг асуухгүй байгаа вэ. Бид МХЕГ-ын даргад энэхүү хууль бус актыг бүхэлд нь хүчингүй болгох тухай 3 удаа бичгээр гомдол гаргасан юм. Уг гомдлыг шийдвэрлэж өгөх талаар Мэргэжлийн хяналтын газрын эрх бүхий албан тушаалтан Санхүү, нийгмийн хамгааллын хяналтын газрын дарга Д.Ба, улсын ахлах байцаагч Х, Б нартай удаа дараа уулзаж байхад тэд хэлэхдээ бид танай хэлтсийн Хүний хөгжил сангийн санхүүгийн бичиг баримтуудыг огт шалгаагүй, зөвхөн мөрдөн байцаагчийн шахалтаар Нийгмийн халамж, үйлчилгээний газрын Л.Б-ээс цахим хэлбэрээр ирүүлсэн жагсаалтыг актын хавсралтад бичиж төлбөр тавигдсан гэж ярьж байсан. Хяналт шалгалтын дүнгийн материалд удирдамж, хяналтын хуудас, шалгалтын тэмдэглэл, мэдэгдэх хуудас, танилцуулга, акт, албан шаардлага, дүгнэлт, торгууль, шийтгэвэр, зөрчлийн тэмдэглэл орно.

Гэтэл хэрэгт авагдсан хяналт шалгалт хийсэн материалуудтай танилцаж үзэхэд удирдамж, хяналтын хуудас, шалгалтын тэмдэглэл, мэдэгдэх хуудас огт байхгүй бөгөөд шалгалтын танилцуулгын дүнд 15 хавсралт байхаар бичигдсэн боловч уг 15 хавсралт бүхэлдээ байхгүй байна. Надад Казакстан улсад эмчилгээнд явсан 41 иргэнд холбогдох 8,924,000 төгрөг, дотоодын эмчилгээнд явсан гэх 16 иргэнд холбогдох 3,155,000 төгрөгийн төлбөрийн асуудлыг тулгаж байгаа юм. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд оношилгоо хийлгэх, эмчилгээнд явж ирсэн үед олгох унааны зардлыг дараах байдлаар олгоно. Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын санхүүгээс аймгийн Төрийн санд сард бөөнөөр 30-40 сая төгрөг гэж Халамжийн сангийн санхүүжилт гэж орж ирнэ. Энэхүү мөнгийг сумын нийгмийн халамжийн ажилтан нараас ирүүлсэн захиалгын дагуу сумын Нийгмийн халамжийн санд шилжүүлнэ. Тэгээд суманд очсон мөнгөнд нэгдүгээр гарын үсгийг сумын Засаг дарга, хоёрдугаар гарын үсгийг халамжийн мэргэжилтэн нар зурж захиран зарцуулдаг юм. Энэ асуудлыг аймгийн төвд суудаг хэлтсийн даргад шууд тохож байгааг зөвшөөрөхгүй байна. Үнэхээр

хууль зөрчиж олгосон бол Мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар сумын Засаг дарга, нийгмийн халамжийн мэргэжилтэн нарт төлбөрөө тавих ёстой байсан. Хэрэгт О.Ф-ын эргэлзээтэй мэдүүлэг байдаг. Энэ мэдүүлэг нь ЭБШХ-ийн 36 дугаар зүйлд заасан сэжигтэн яллагдагч хэргийн ямар нэг байдлыг нотлох үүрэг хүлээхгүй гэсэн хуулийн заалтаар няцаагдаж байгаа юм. Би өөрийгөө буян хийж яваа хүн гэж боддог. Намайг энэ хэрэгт холбогдуулж 3 жил шалгасан. Миний данснаас ямар нэг эрсдэлтэй зүйл гараагүй. Иймд надад холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэв.

Шүүгдэгч О.Ф шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Намайг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт зааснаар зүйлчилснийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Би гэмт хэрэг үйлдээгүй энэ хэргийн субъект биш. Би том албан тушаал эрхлээгүй, төрийн үйлчилгээний ажилтан. Би ямар нэгэн албан бичиг хуурамчаар үйлдээгүй. Анх надад хууль сануулж байцаалт авсан, мөн нүүрэлдүүлж байцаасан. Мөрдөн байцаалтын шатанд миний өгч байсан мэдүүлэг үнэн зөв. "ТЦ" ХХК-ийн хувьд би итгэмжлэлийн дагуу ажлаа хийж байсан. Надад тооцооны асуудал байхгүй, хэрвээ намайг тооцоотой гэж байгаа бол иргэний шүүхэд хандах байсан. Я.С., А.Нар нар хоорондоо ямар холбоотойг би мэдэхгүй. Манай захирал А.Нар намайг мөнгө шилжүүл гэж хэлсний дагуу би мөнгийг нь шилжүүлдэг байсан. Би ямар ч мөнгө аваагүй, нэг удаа хуурамч материал бүрдүүлээгүй. Намайг цагаатгаж өгнө үү гэв.

Шүүгдэгч А.Х шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, 264 дүгээр зүйлийн 264.2, 150 дугаар зүйлийн 150.3 дахь хэсэгт заасан зүйлчлэлийг хүлээн зөвшөөрөхгүй байна. Би гэрээт мэргэжилтэн байсан.

Би ямар нэгэн гэмт хэрэг хийгээгүй тул намайг цагаатгаж өгнө үү гэв.

Шүүгдэгч О.С шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Би Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн даргыг 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 4 сар үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байгаад, төрийн албаны шалгалтанд орж тэнцээд жинхэлсэн. Би албан үүргийн дагуу ажлаа хийж гүйцэтгэсэн. Би ажилд томилогдоод жил орчим болж

байхад энэ асуудал гарсан. Халамжийн хуулийн 28 дугаар зүйлд анхан шатны баримтыг хэн бүрдүүлэх вэ гэхээр сумын халамж хариуцсан ажилтнууд бүрдүүлнэ гэж заасан байгаа. Мөн хуулийн 35 дугаар зүйлд зааснаар анхан шатны материалыг бүрдүүлэхдээ буруу бүрдүүлсэн бол тухайн ажилтан уг хариуцлагаа хүлээнэ гэж заасан. Хэлтсийн дарга нь хуулийн дагуу шийдвэр гаргах, төрийн сангаар дамжуулж, сумын дансанд байршуулах үүрэгтэй. Баян-Өлгий аймгийн 13 сум нь их алсагдсан. Нэг сум 380 км зайтай байдаг. Хэлтсийн дарга өдөр болгон тэр сум руу явах боломжгүй. Намайг ажил үүрэгтэй хайнга хандсан гэж яллах гэж байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна. Мэргэжлийн хяналтын актыг үндэслэлгүй гэж үзэж байна. Энэ актын талаар бид нар мэдэхгүй. Бид нарт тухайн актын талаар танилцуулж гарын үсэг зуруулаагүй. Тэгэхээр актыг Ц.Н гаргасан гэж санагддаг. Дараа нь мөрдөн байцаалтын ажиллагаанд саад учруулвал хорино гэхээр нь айгаад актанд гарын үсэг зурсан. Актан дээр хавсралт гэсэн байна хавсралт нь хаана байна вэ? гэхэд байцаагч дараа нь өгнө гэсэн одоо хүртэл өгөөгүй байгаа. Жишээ нь: прокурорын яллах дүгнэлт дээр хүний хөгжил сангаас олгох ёсгүй 82 иргэнд 37.115.000 төгрөгийг, халамжийн сангаас 4 иргэнд Казакстан улсад эмчилгээ, оношилгоо хийлгэн ирэхэд унааны нэг талын хөнгөлөлт болгон 392.000 төгрөгийг, Улаанбаатар хотод эмчилгээ оношилгоо хийлгэсэн нь нотлогдоогүй байхад 42 иргэнд 8.0198.608 төгрөгийн тэтгэмж олгуулж улсад нийт 45.526.608 төгрөгийн онц их хэмжээний хохирол учруулсан гэж бичсэн байгаа. Хэн хэн гэдэг нэртэй 82 иргэн гэдгийг тогтоогоогүй, хэрэг хотод шилжиж ирсний дараа надаас нэг ч удаа мэдүүлэг аваагүй байж яллаж байгааг хүлээн зөвшөөрөхгүй. Би багш хүн болохоор худлаа хэлэхгүй, хулгай хийхгүй гэдэг зарчмыг барьдаг. Би гэмт хэрэг хийгээгүй. Намайг цагаатгаж өгнө үү гэв.

Шүүгдэгч А.П шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Би Нийгмийн хамгааллын салбарт нийтдээ 20 жил ажиллаж байгаа. Нийгмийн хамгааллын салбарыг анх байгуулагдсанаас хойш 1997 оноос өнөөдрийг хүртэл нийт 17 дахь жилдээ ажиллаж байгаа. 17 жил ажиллахдаа сүүлийн 10 жил нь нийгмийн халамжийн мэргэжилтэнгээр ажилласан. Яллах дүгнэлтэд ахлах мэргэжилтэнд хяналт тавих ахлах мэргэжилтэн гэж бичсэнийг

хүлээн зөвшөөрөхгүй байна. Би гэмт хэрэг үйлдээгүй. Ажил албан тушаалдаа хайнга хандсаны улмаас улсад болон нийгмийн халамжийн санд ямар нэгэн хохирол учруулаагүй. Яллах дүгнэлтээр халамжийн сангийн ахлах мэргэжилтэн, хүний хөгжлийн сангийн мэргэжилтэн гэж тус тусад нь ялгаж бичсэн байгаа. Хөдөлмөрийн халамжийн дансанд жил болгон Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэс, зохион байгуулалтын орон тоог баталж өгдөг. 2009 оны 14 тоот тушаал, 2011 оны 1 тоот тушаал, 2012 оны 1278 тушаал 55 дугаар хавтаст хэргийн 48 дугаар талд байгаа. Энэ материалууд дотор ахлах мэргэжилтний орон тоо байдаггүй. 2011 оны 27 тоот тушаал хавтаст хэрэгт авагдаагүй байхаар нь судалгааг гаргаад өгсөн байгаа. 2012 оны 02 дугаар сарын 4-ний өдрийн тушаалд би гарын үсэг зурсан. Хүний хөгжлийн мөнгийг 2010 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн олгосон. Иргэн бүрт 20.000 төгрөгийг ямар ч бичиг баримт шалгахгүйгээр зөвхөн иргэний үнэмлэхийг үндэслээд иргэн бүрд олгосон. Үүнтэй холбогдуулж 2012 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 28 тоот тушаалын 2 дахь хавсралтанд хүний хөгжил сангаас хишиг хувь хүртээх ажлыг зохион байгуулахыг аймаг хэлтсийн дарга, мэргэжилтэн нарын ажил үүргийн хуваарьт баталсугай гэж заасан байдаг. 2 дугаар хавсралтанд хэлтсийн дарга ямар үүрэгтэй, сумын мэргэжилтэн ямар үүрэгтэй, сангийн мэргэжилтэй ямар үүрэгтэй, хэвлэл мэдээллийн ажилтан ямар үүрэгтэй, хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн ямар үүрэгтэй зэргийг тус тус заасан. Сум хариуцсан мэргэжилтэн нь хишиг хувь хүртээх иргэдийн мэдээллийг аймгийн халамж үйлчилгээний газарт хүргэх, хишиг хувьд хүртээх мэдээллийн асуудлыг үнэн зөв гаргах ёстой. Хяналт шинжилгээний мэргэжилтэн 2009 оны 14 дүгээр тоот тушаалаар мэргэжилтний орон тоо баталгдаад өргөжөөд хяналт, шинжилгээ аудит болж өргөтгөсөн. Тиймээс би яллах дүгнэлтэд бичсэн ахлах мэргэжилтэн биш. 2009 оны 14 дүгээр тушаалын 2 дугаар хавсралтанд халамжийн мэргэжилтний чиг үүргийг тогтоож өгсөн байгаа. 15 төрлийн ажлыг тусгаж өгсөн бөгөөд уг ажлыг 2009 оноос хойш гүйцэтгэж ирсэн. Яллах дүгнэлтэд надад 218 иргэний, 75.267.000 төгрөг, 117 нас барсан иргэний 17.09.000 төгрөгийн зөрчил дутагдал байна гэж бичсэнийг би хүлээн зөвшөөрөхгүй. Өнөөдрийг хүртэл

надад 218 хүний нэр байхгүй. Улсад ямар учраас 75.267.000 төгрөгийн алдагдал учруулсан бэ, хэн гэх иргэний, ямар хохирол учруулсан гэдэгт одоо хүртэл надад нэр байхгүй. Я.С, А.Ха, О.С бид нарын дунд 381 тоо байна. Энэ тоо нь надад ч хамааралтай, Я.С, А.Ха, О.С нарт ч хамааралтай. Бид 381 хүнийг ярихгүй бол дотроос нь би 218 хүний талаар ярих боломжгүй юм. Тийм нэр бид нарт гаргаж өгөөгүй. Мөрдөн байцаагч актанд дээр 08 дугаар сарын 07-ны өдөр прокурорт шилжсэний орой бид нарт 381 хүний нэрийг өгсөн. Тэгэхээр 381 хүний нэрийг яаж гаргаж ирсэн гэдэг нь тодорхойгүй байна. Улсын Мэргэжлийн хяналтын улсын ахлах байцаагчийн гаргасан 2013 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 4/7656 тоот актан дээр намайг буруутгаагүй. Албан тушаалын хувьд надад хамааралгүй. Миний нэр актанд байдаггүй учраас би өнөөдөр яаж албан тушаалаа урвуулсан бэ гэдгийг ойлгохгүй байна. Хүний хөгжил сангийн ажлыг 2013 оны 01 дүгээр сарын 6-ны өдрийн 01 тушаалаар хөгжлийн сангийн нябо гэрээт, хүний хөгжлийн сангийн гэрээт ажилд 2 хүний томилсон байгаа. Хүний хөгжил сангийн ажлыг орон нутагт хариуцан гүйцэтгэхээр ажил үүргийн хуваарьт тусгаж өгсөн байгаа. Хүний хөгжил сангийн баримт бичиг нь хувийн хэрэгт байгаа. Түүн дотор иргэн ороход ямар мэдээлэл өгөх ёстой гэдгийг бичих ёстой. Энэ хувийн хэргийг сум хариуцсан нийгмийн халамжийн ажилтан иргэдээс материал хүлээж аваад нээгээд өөрийн гарын үсэг тамга тэмдгийг дарах ёстой.

Түүний дараа хэлтсийн сангийн мэргэжилтэн, хэлтсийн дарга нар баталгаажуулсны дараа сумын мэргэжилтэн программд оруулснаар иргэдэд мөнгө олгох нөхцөл бүрдэнэ. Тэгэхээр энэ ажил дээр миний оролцоо огт байхгүй. Би иргэдээс материал авч, хувийн хэрэг нээх эрх надад байхгүй. Үүнийг нээх эрх нь сумын нийгмийн ажилтанд байдаг. Хүний хөгжил сангийн программд нэвтрэх эрх бүхий 14 албан тушаалтан байдаг. сумын мэдээллийн мэргэжилтэн, хяналт шинжилгээ хариуцсан мэргэжилтэн гээд нийт 14 хүн программд нэвтрэх эрхтэй. Би халамжийн мэргэжилтэн тул надад нэвтрэх эрх байхгүй. Нас барсан хүн байна гэдгийг би амаар сануулахаас биш программаас хасалт хийх эрх байхгүй. Би Хүний хөгжил сантай холбоотой санхүүгийн ямар нэгэн бичиг баримтад 1, 2 дугаар гарын

үсэг зурахгүй. Ямар нэгэн шийдвэр гаргаж, Хүний хөгжлийн сангаас мөнгө гаргадаг албан тушаалтан биш. Хүний хөгжил сангийн ажлыг Ерөнхий газрын даргын 2010 оны 24 дүгээр тушаал болон хэлстийн даргадаа өгсөн шийдвэрүүд дотроо 8 мөст дотроос 1 мөстийг хүний хөгжил санг хариуцуулан гүйцэтгүүлнэ гэж тодорхой зааж өгсөн. Түүний дагуу хэлтсийн дарга надад 2011 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2011 оны 03 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл надад хүний хөгжлийн сангийн ажлыг хариуцуулсан. Хариуцаж ажиллахдаа мөнгө олгох талдаа биш, хуулиа сурталчлах, ард иргэдэд зөв ойлголт өгөх чиг үүргийг дагуу ажилласан. Яллах дүгнэлтэд нас барсан 117 хүнд холбоотой 17.09.000 төгрөг гэж гарсан байгаа. Я.С 117 хүн, А.Ха-д 98 хүн, надад 117 хүнийг холбогдуулсан. Нийт 420 хүн болж байна. 117 нас барсан хүнийг Я.С, А.Ха бид нарт давхардуулаад хохирлыг бичсэн нь 362 хүн 42.000.000 төгрөг болоод өссөн. 117 нас барсан бол 117 хүн байх ёстой байтал 362 хүн болсон байна. Анх мэргэжлийн хяналтын ахлах байцаагч 852 хүнд холбогдуулан 297.06.000 төгрөгийн төлбөр нэхэмжилсэн. Улсын прокурорын 552 дугаартай тогтоолоор 462 хүний 140.000.000 төгрөгийг хүчингүй болгосон. Гэтэл мөрдөн байцаагч 381 хүнд 149.000.000 төгрөг гээд дундаас нь 34.000.000 төгрөгийг гаргаж ирснийг мэдэхгүй байна. Гэтэл яллах дүгнэлтэд 909 хүнд 358.136.000 төгрөг гээд бичсэн байна. Үүнд эргэлзэж байна. мөрдөн байцаалтын шатанд өөр тоо, яллах дүгнэлтэд өөр тоо, мэргэжлийн хяналтаас өөр тоонууд байна. Уг нь нэг л тоо баймаар юм. 68 дугаар хавтаст хэргийн 47 дугаар хуудсанд хохирлын тооцоо дээр надад 52.000.000 төгрөг бичсэн байна. Гэтэл яллах дүгнэлтэд надад 75.000.000 төгрөг бичсэн байгаагаас харахад хохирлын тооцоо зөрүүтэй байна. Мэргэжлийн хяналтын албаны 56 дугаар актыг Баян-Өлгий аймаг Монгол Улсын харьяатаас гарсан гэх үндэслэлээр 5 шатлалтай акт бичсэн байна. Иргэний бүртгэлийн ерөнхий газраас 2010 оноос өмнө Монгол Улсын харьяатаас гарсан 246 хүнийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамааруулснаас 197 хүнийг хассан байна. 2010 онд Монгол Улсын харьяатаас гарсан 115 иргэнээс 2 хүнийг хассан байна. 2010 онд 96 хүнийг иргэний шинэчилсэн бүртгэлд хамааруулсан гэсэн заалтаас 31 хүнийг хассан байна. 381 хүний нэрс хавтаст хэрэгт авагдсан байдаг. Эхний

хуудсанд 48, дараагийн хуудсанд 41 хүний нэрс байна. Нийт 90 хүний нэрс гарч байна. 90 хүнийг 1995 оны 3 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын харьяатаас гарсан гэж байгаа боловч 1995 оноос хойш төрсөн хүмүүс байдаг. Хүний хөгжил сангаас 500.000 төгрөг иргэнд олгохоор хуульд заасан байгаа гэтэл мөрдөн байцаагч Наранхүү нэг хүнд 1.500.000 гэж гаргасан байна. Бид нарт холбогдуулж байгаа хэргийг үндэслэлгүй гэж үзэж байна. Миний бие хэрэг хийгээгүй. Албан тушаалаа урвуулан ашиглаагүй тул цагаатгаж өгнө үү гэв.

Шүүгдэгч Д.А шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Би Баян-Өлгий аймгийн Дэлүүн суманд 2007 онд Нийгмийн халамжийн ажилтнаар орж одоог хүртэл ажиллаж байгаа. Намайг 2013 оны Халамжийн сангийн төсвийн үлдэгдэл 15.000.000 төгрөгийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн Халамжийн сангийн дансанд шилжүүлэн гарган авч санхүүгийн тайланд тусгалгүй хувьдаа завшсан гэж байгааг би зөвшөөрөхгүй байна. 2013 оны 12 дугаар сард 15.000.000 төгрөгийг Дэлүүн сумын Засаг даргаар батлуулсны үндсэнд нийтийн хурлаар хэлэлцүүлээд төсөл бичиж ирүүлсэн 5-8 хүнд өгөхийг зөвшөөрсөн. Төслийн мөнгийг олгохдоо 1 дүгээр гарын үсгийг сумын Засаг дарга, 2 гарын үсгийг би зурсан. Олон нийтийн хурлын шийдвэр нь Халамжийн тухай хуулийн үндэслэн төсөл хэлэлцэн шийдвэрлэх тогтоол гаргасан. 2013 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар 6 хүний төслийг танилцуулаад 5.000.000 төгрөгийн оёдлын төслийг шийдвэрлүүлсэн. 2011 оны 3 дугаар сард албаны ажлаар Улаанбаатар хотод ирэхэд намайг Улсын мөрдөн байцаах албанд шалгуулахад 15.000.000 төгрөгийн талаар ямар учиртайг асуухад сумын Засаг даргаас зөвшөөрөл авч сум орон нутагтаа зарцуулсан гэдгээ хэлсэн. Санхүүгийн баримтууд ирээгүй байсан. 2014 оны 05 дугаар сарын 20-ны өдөр аймагт ажлаар явж байгаад зүрхний өвчнөөр ухаан алдаж унасан. Тэгээд би гадаад улсад эмчилгээ хийлгэж байгаад 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Монгол улсад ирсэн. Мөрдөн байцаагч намайг гадаад улс руу оргон зайлсхийсэн, төслийн мөнгөөр явсан гэж байсан. 15 сая төгрөгийн 5 сая төгрөгийг н.Хуа-нд, 10 сая төгрөгийг нь н.Күл-д олгосон. Энэ талаар мэдүүлэхэд эдгээр хүмүүсээс мөрдөн байцаагч асууж тодруулаагүй. Иймд хэргийг хэрэгсэхгүй

болгож өгнө үү гэв.

Хохирогч Б.Дө шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Би Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын хуулийн хэлтэст ажилладаг. Мөрдөн байцаах газар манай байгууллагад хандсанаар Бс дарга намайг энэ хэрэгт хохирогч иргэний нэхэмжлэгчээр байгууллагыг төлөөлж оролцуулахаар томилсон. Энэ хэрэгтэй холбоотой хохирлын тооцооны дүнгүүд өөр өөр байна. Тооцоог дахин гаргуулах саналтай байна. Манай байгууллагын мэдээлэл технологийн төвийн дарга Л.Б-ийн сүүлд гаргасан 8 иргэнд холбогдох 1.998.000 төгрөгийн зөрчил гэсэн нь үндэслэлтэй гэж үзэж байгаа. Шүүгдэгч нараас нэхэмжлэх хохирол төлбөр, гомдол санал байхгүй гэв.

Гэрч Я.Б шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Анх шалгалт хийхдээ анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн тайлан баланс журнал ашиглаж 2010-2011 оны нийгмийн халамжийн баримтад шалгалт хийсэн. Миний хувьд бол иргэд Казакстан улсад эмчлүүлсэн талаарх асуудлыг шалгасан. Би программ дээр ажиллаж чадахгүй тул тулгалт хийгээгүй. Манай хуулинд ортопедийг халамжийн байгууллага шууд тараах ёсгүй бөгөөд иргэн өөрөө тохирох зүйлээ сонгож авсныхаа дараа материалаа харьяа халамж хариуцсан мэргэжилтэнд өгөөд авсан эд зүйлийнхээ мөнгийг улсаас гаргуулж авдаг. Баян-Өлгий аймаг алслагдсан гэдгээрээ тусгай хууль дүрэм үйлчлэх асуудал байхгүй гэв.

Гэрч Б.Эр шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Мөрдөн байцаах газрын хүсэлтээр Бс дарга намайг ажлын хэсэгт оруулах тушаал гаргасан юм. Би хүний хөгжил сангийн файл руу ороогүй, ажлын хэсэг тулгалт хийхэд оролцоогүй. Л.Б-ийн гаргасан тулгалтыг үндэслэж акт гаргасан. 2010-2011 оны халамжийн сангийн баримтад тулгалт хийсэн, хүний хөгжил санд тулгалт хийгээгүй. Энэ талаараа танилцуулга бичиж мөрдөн байцаагчид хавсралтын хамт өгсөн.

Гэрч Л.Би шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлэхдээ: Би Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газарт мэдээлэл технологийн төвийн даргын ажил эрхэлдэг. Би хүний хөгжлийн сангийн праграммд тулгалт хийсэн. Харин Б, Х нар биечлэн тулгалт хийсэн гэдгийг сайн мэдэхгүй байна. Би эхний гаргасан 381 хүний нэрсийг алдаатай гаргасан байсан. Харин сүүлд гаргасан 8 хүний нэрсийг дахин праграммд

тулгалт хийж гаргасан тул үндэслэлтэй гэж үзэж байна. Миний гаргасан нэрсийн зөрүүтэй байдал нь програмд мэдээллээ оруулсныхаа дараа ямар нэгэн байдлаар устгасан байсан. Дахин тулгалт хийхэд устгасан мэдээлэл нь хадгалагдсан байсан. Ингээд илүү олголт үүсгэгдсэн байсан. Харин тухайн мэдээллийг Баян-Өлгий аймгаас А.Ха, А.Он гэдэг хоёр хүн устгасан байсан. Баян-Өлгий аймгийн мэдээллийн сангийн программд нэвтрэх эрхтэй хүн нь А.Он, А.Ха 2 юм. Баян-Өлгий аймгийн мэдээллийн сангийн программд нэвтрэх эрхтэй хүн нь А.Он, А.Ха 2 юм. Тухайн хүн өөрийн эрхээр орж, санаатай болон санаандгүй байдлаар устгасан байж болно. Гэхдээ программын цаана нь хаанаас устгасан байдал нь түүх болоод хадгалагдана. Үүнийг программаас устгах боломжгүй. Мөн хэзээ устгасан он сар өдөр нь харагддаг. Устгах асуудал нь зөв ч байж болно. Буруу ч байж болно. Тухайн ажилтан нь банкинд тухайн хүний мэдээллийг буруу явуулснаас болж тухайн хүнд мөнгө нь олгогдохгүй болж уг буруутай мэдээллийг устгаж, засаж шинээр зөв мэдээлэл оруулах тул устгасан байж болно. Хүний хөгжлийн санд хохирол учруулсан талаар хэлж мэдэхгүй байна. Хуулийн байгууллага нь шалгалт хийж тогтоох ёстой. Би хохирлын талаар дүгнэлт гаргах эрхгүй. Цахим программд би орох эрхтэй эрх бүхий албан тушаалтан юм. Програмаас мэдээлэл устгасан тохиолдолд хариуцлага тооцож, тухайн банк руу илүү олголт хийсэн бол хариуцсан ажилтанд байгууллагын зүгээс хариуцлага тооцдог. Тухайн мэдээлэл устгасан асуудлаас болж тулгалтанд өөрчлөлт асуудал гардаг. Баян-Өлгий аймгаас хүсэлт гаргаж манай байгууллагын дарга Бс надад үүрэг болгосны дагуу мэдээллийн санд би дахин дахин тулгалт хийж мэдээллийг гаргасан. Уг мэдээллийг газрын дарга н.Бая нь байгууллагын нэрээр албан бичгээр явуул гэсний дагуу би Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт болон шүүх рүү өөрийнхөө нэрээр явуулсан. Энэ програмаас нэр хассаны улмаас улсад хохирол учирсан талаар сайн мэдэхгүй байна. 55000 хүний мэдээллийн сантай программд шүүж үзэхэд эхлээд 381 хүний зөрчилтэй нэрс байсан, дараа нь Я.С нарын хүсэлтээр дахин тулгалт хийхэд 8 хүний зөрчил илэрч, өөр өөр аймгаас олголт хийгдсэн байсан гэв.

Шүүгдэгч нарын хувийн байдалтай

холбоотой Я.С-ын иргэний үнэмлэхийн лавлагаа /54-р хавтасны 132-р хуудас/, А.Х-ын иргэний үнэмлэхийн лавлагаа /54-р хавтасны 128-р хуудас/, О.С-н иргэний үнэмлэхийн лавлагаа /54-р хавтасны 139-р хуудас/, А.П-ын иргэний үнэмлэхийн лавлагаа /54-р хавтасны 140-р хуудас/, Д.А-ын иргэний үнэмлэхийн лавлагаа /54-р хавтасны 143-р хуудас/

А.Х, Я.С, О.С, А.П нарын эзэмшлийн тээврийн хэрэгслийн лавлагаанууд / 54-р хавтасны 148, 150, 155, 156-р хуудас/

Я.С, О.Ф нарын ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /64-р хавтасны 230-231-р хуудас/,

А.Х-ын ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /54-р хавтасны 118-р хуудас,

О.С-ын ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /54-р хавтасны 108-р хуудас/,

А.П-ын ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /54-р хавтасны 100-р хуудас,

Д.А-ийн ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /5-р хавтасны 139-142-р хуудас/

Баян-Өлгий аймаг дахь Сум дундын шүүхийн 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 82 дугаартай шийтгэх тогтоолын хуулбар / 64-р хавтасны 211-217-р хуудас/,

Хөрөнгө орлогын мэдүүлгүүд /34-35-р хавтас, 39-р хавтасны 100-115-р хуудас/, Я.С орон сууц худалдах, худалдан авах гэрээ /63-р хавтасны 240-р хуудас/,

Я.С-г Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн даргын ажлаас чөлөөлсөн Баян-Өлгий аймгийн Засаг даргын 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 567 дугаартай захирамж /64-р хавтасны 219-р хуудас/,

О.Ф-г Асрамжийн газрын зохион байгуулагчийн үүрэгт ажлаас түр чөлөөлсөн Баян-Өлгий аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтсийн даргын 2012 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 150 дугаартай тушаал / 64-р хавтасны 229-р хуудас/,

О.С-г Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсон Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2013 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 43 дугаартай тушаал /55-р хавтасны 33-р хуудас/,

Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн даргын ажилд томилсон Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2013 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 67 дугаартай тушаал

/55-р хавтасны 32-р хуудас/,

Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн даргын ажлаас чөлөөлсөн Нийгмийн халамж үйлчилгээний ерөнхий газрын даргын 2014 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн тушаал /55-р хавтасны 30-р хуудас/,

А.Х-ыг Хүний хөгжил сангийн ня-богоор томилсон Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн даргын 2011 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн тушаал /58-р хавтасны 243-р хуудас/,

А.Х-ыг ажлаас чөлөөлсөн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн даргын 2011 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн тушаал /58-р хавтасны 244-р хуудас/ болон бичгийн бусад баримтуудыг шинжлэн судлав.

Дүүргийн 2 дугаар прокурорын газраас шүүгдэгч О.С-г Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн даргаар ажиллаж байх хугацаандаа Хүний хөгжил сангийн хууль, Халамжийн сангийн тухай хууль тогтоомж, түүний дагуу гарсан дүрэм журмаар тодорхойлогдсон албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс Хүний хөгжил сангаас олгох ёсгүй 82 иргэнд 37.115.000 төгрөгийг, Халамжийн сангаас 4 иргэнд Бүгд Найрамдах Казакстан Улсад эмчилгээ, оношилгоо хийлгэн ирэхэд унааны нэг талын хөнгөлөлт болгон 392.000 төгрөгийг, Улаанбаатар хотод эмчилгээ, оношилгоо хийлгэсэн нь хангалттай нотлогдож тогтоогдоогүй 42 иргэнд эмнэлэгт хэвтэн эмчлүүлээгүй, оношилгоо хийлгээгүй байхад 8.019.608 төгрөгийн тэтгэмжийг олгуулан улсад 45.526.608 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэж, түүнд холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар,

шүүгдэгч Д.А-ийг Баян-Өлгий аймгийн Дэлүүн суманд Халамжийн байцаагчаар ажиллаж байхдаа 2013 оны Халамжийн сангийн төсвийн үлдэгдэл 15.000.000 төгрөгийг олон нийтийн оролцоонд түшиглэсэн Халамжийн сангийн дансанд шилжүүлэн гарган авч санхүүгийн тайланд тусгалгүй хувьдаа завшиж, үлэмж хэмжээний хохирол учруулсан гэж, түүнд холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.2-т зааснаар тус тус яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд ирүүлжээ.

Прокуророос шүүгдэгч О.С-г Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандсан гэж буруутгахдаа зөвхөн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2014 оны

06 дугаар сарын 19-ний өдрийн 04/77/56, 04/77/57 тоот актуудаар буруутгаж байгаа нь учир дутагдалтай байна.

Актуудаас үзвэл ...Шалгалтад хамрагдсан 2010-2013 оны Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалтын гарын үсгийн нэгдүгээрийг ...хэлтсийн дарга О.С 2012 оны 10 дугаар сараас 2014 оны 04 дүгээр сар хүртэл ...зурж захиран зарцуулж ирсэн байна гэжээ.

Цаашлаад уг актуудад хэт томъёолон бичигдсэнээс шүүгдэгч О.С-н гэм буруутай үйлдлийг хэрхэн яаж нотлоод байгаа нь ойлгомжгүйн зэрэгцээ, түүний үйлдэл чухам яагаад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар зүйлчлэгдэх болсон нь тодорхой бус байна.

Албан тушаалтан албан үүрэгтээ хайнга хандах гэсэн энэ гэмт хэрэг нь хэдийгээр Албан тушаалын эсрэг гэмт хэргийн бүлэгт хамаарах боловч хохирлын хэмжээ заавал шаарддаг. Гэтэл зөвхөн Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн актаар түүний гэм бурууг нотлоод байгааг хангалттай гэж үзэх үндэслэлгүй.

Нөгөөтэйгүүр прокурор яллах дүгнэлтдээ шүүгдэгч О.С-г ямар хугацаанд тухайн албан тушаалд ажиллаж байсныг тодорхой бичээгүй байтал улсын байцаагчийн актанд түүнийг ...2012 оны 10 дугаар сараас 2014 оны 04 дүгээр сар хүртэл гарын үсэг зурж захиран зарцуулж ирсэн гэсэн нь хэргийн үйл баримтын цаг хугацаатай нийцэхгүй, энэ нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлд заасан Хэргийн талаар нотолбол зохих асуудлыг бүрэн гүйцэт хийсэн гэж үзэхээргүй, прокурор нь шүүгдэгч О.С-д холбогдох гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжийг нарийн зааглаж чадахгүй байгаа болно.

Тухайлбал, шүүгдэгч О.С-г яллаж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2 гэсэн, шүүгдэгч Я.С-ийг яллаж байгаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2 гэсэн гэмт хэргүүдийн талаарх үйл баримтууд яг адилхан байхад чухам яагаад өөр өөр зүйл хэсгүүдээр тэдгээрийг яллаад байгаа нь ойлгомжгүй болжээ.

Монгол Улсад одоо мөрдөж буй Эрүүгийн хуулийн онолоор гэмт хэргийн бүрэлдэхүүний 4 шинж байх ёстой бөгөөд үүний нэг шинж нь л үгүйсгэгдэж байвал уг үйлдлийг гэмт хэрэг гэж үзэх хуулийн үндэслэлгүй юм.

Шүүгдэгч Д.А-ийн хувьд: прокуророос

түүнийг Бусдын эд хөрөнгийг завшиж үлэмж хэмжээний хохирол учруулсан гэж яллаж байгаа боловч завшсан гэх тухайн 15 сая төгрөг нь Дэлүүн сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн 2013 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 2 дугаартай тогтоолоор “Х-О” төслийг дэмжиж төслийн санхүүжилтийг Халамжийн үйлчилгээний сангаас санхүүжүүлж хяналт тавьж ажиллахыг сумын хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Д.А-т үүрэг болгосон, мөн сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 13 дугаартай тогтоолоор тус зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.А-т н.Жө малчдын бүлгээс ирүүлсэн төслийг дэмжиж, Дэлүүн сумын халамжийн олон нийтийн оролцоонд түшиглэсэн Халамжийн үйлчилгээний сангаас 5 сая төгрөгөөр санхүүжүүлэхийг сумын хөдөлмөр халамж үйлчилгээний хэлтсийн мэргэжилтэн Д.А-т үүрэг болгосны дагуу Дэлүүн сумын 4-р багийн иргэн Х.Ху-ны малжуулах төсөлд 5 сая төгрөг “Х-О” төсөл боловсруулсан иргэн Т.Ку-д 10 сая төгрөг олгогдсон болох нь хавтаст хэргийн хамт шүүхэд ирүүлсэн 5-р хайрцагт авагдсан Баян-Өлгий аймгийн Дэлүүн сумын Халамж үйлчилгээний хэлтсийн “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн сан”-гийн баримтад авагдсан төслүүд, мөнгө авч төсөлд хамрагдсан гэх иргэн Т.Ку, Х.Ху нарын тайлбараар /70-р хавтасны 71-72/ нотлогдож байна.

Нөгөөтэйгүүр шүүгдэгч Д.А тус сумын Амьжиргааг дэмжих зөвлөлийн даргаар ажиллаж, “олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн сан”-гаас иргэн Т.Ку, Х.Ху нарт нийт 15 сая төгрөг олгосон нь Нийгмийн халамжийн тухай хуулийн зохих заалтуудыг зөрчсөн гэж үзэхээргүй байна.

Хэдийгээр шүүгдэгч Д.А мөрдөн байцаалтын явцад 10 сая төгрөгийг нь би ойр зуур хэрэглэсэн гэж гэрчээр мэдүүлсэн байх боловч энэ мэдүүлэг түүний гэм бурууг шууд нотолсон нотлох баримт болж чадахгүй, үүнийг давхар нотолсон баримт хэрэгт авагдаагүй, шүүгдэгч өөрийн гэм бурууг нотлох үүрэггүй.

Иймд шүүгдэгч О.С, шүүгдэгч Д.А нарт холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, тэдгээрийг цагаатгаж шийдвэрлэлээ.

Шүүх нэгэнт шүүгдэгч О.С, шүүгдэгч Д.А нарт холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж дүгнэсэн тул

нэхэмжлэлийг хэлэлцэхгүй орхих нь зүйтэй бөгөөд хэрэв маргаантай асуудал байвал Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу шийдвэрлүүлбэл зохино.

Түүнчлэн прокуророос шүүгдэгч А.П-г: Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн халамжийн сангийн ахлах мэргэжилтэн, хүний хөгжил сангийн ахлах мэргэжилтнээр 2010-2012 оны 03 дугаар сар хүртэл ажиллах хугацаандаа Хүний хөгжил сан, Хүний хөгжил сангийн төсөв-ийн тухай хууль, Засгийн газрын 2010 оны 347 дугаартай тогтоол болон түүнтэй холбогдуулан гаргасан тушаал, журмаар тодорхойлогдсон албан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйгээс Хүний хөгжил сангаас олгох ёсгүй 218 иргэнд 75.267.000 төгрөгийг, нас барсан 127 иргэнд 17.957.000 төгрөгийг олгуулан улсад 93.224.000 төгрөгийг буюу онц их хэмжээний хохирол учруулсан гэж,

түүнд холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн боловч энэ хэргийг дээрх шүүгдэгч О.С-д холбогдох Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн актуудыг үндэслэл болгож шүүгдэгч О.С-д холбогдох хэргийн нэгэн адил шүүгдэгч А.П-ийн гэм буруутай үйлдлийг хэрхэн яаж нотлоод байгаа нь ойлгомжгүйн зэрэгцээ, түүний үйлдэл чухам яагаад Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар зүйлчлэгдэх болсон нь тодорхой бус байгаа бөгөөд тухайн гэмт хэргийн зүйлчлэл, гэмт хэргийн бүрэлдэхүүний шинжтэй хэр нийцэж байгаа нь ойлгомжгүй тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий л ажиллагааг хийсэн боловч сэжигтэн, яллагдагч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон болох нь нотлогдоогүй байвал хэргийг хэрэгсэхгүй болгох заалтыг баримтлав.

Шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдэд холбогдох асуудлыг жич хэлэлцэх боломжтой юм.

Шүүгдэгч О.С-д холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т заасан гэмт хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгосонтой холбогдуулан шүүгдэгч Я.С-д холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2-т заасан хэргийг мөн гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болгох нь зүйтэй

гэж шүүх үзэв.

Учир нь шүүгдэгч Я.С-г буруутгаж байгаа нэг үйлдэл болох 2008-2012 онд Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний хэлтсийн даргаар ажиллаж байх хугацаандаа Хүний хөгжил сан, Халамжийн тухай, Хүний хөгжил сангийн төсвийн тухай хууль, Засгийн газрын 2010 оны 347 дугаар тогтоол болон түүний дагуу гарсан дүрэм журмаар тодорхойлогдсон албан үүргийн хувьд хуулиар олгогдсон эрх мэдлээ хэтрүүлэн Хүний хөгжил сангаас Монгол Улсын харьяатаас гарсан 299 иргэнд 139.426.000 төгрөгийн, нас барсан 127 иргэнд 17.957.000 төгрөгийн, Эх орны хувь хишиг, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийг зөрчин Халамжийн сангаас 41 иргэнд Бүгд Найрамдах Казакстан улсад эмчилгээ, оношилгоо хийлгэн ирэхэд унааны нэг талын хөнгөлөлт болгон 8,924,680 төгрөгийн тэтгэмж, Улаанбаатар хотод эмчилгээ, оношилгоо, хийлгэсэн нь хангалттай нотлогдож тогтоогдоогүй 16 иргэнд эмнэлэгт хэвтэн эмчлүүлээгүй, оношилгоо хийлгээгүй байхад 3,155,650 төгрөгийн тэтгэмжийг олгуулан улсад нийт 260.033.330 төгрөгийн буюу онц их хэмжээний хохирол учруулсан” гэх гэмт хэргийг зөвхөн дээр дурдсан Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 04/77/56, 04/77/57 тоот актуудаар буруутгаж байгаа бөгөөд уг актанд Тодруулга хийсэн гэх Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын 2014 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 10/1156 тоот албан бичигтэй зөрчилдөж байгаа нь хэргийг шийдвэрлэх хийгээд, тухайн үйлдэлд гэм буруутайд тооцоход эргэлзээ төрүүлж байна.

Прокуророос шүүгдэгч Я.С, шүүгдэгч О.Ф, шүүгдэгч А.Х нарт холбогдуулан Бусдын эд хөрөнгийг завшиж, үрэгдүүлсэн гэж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэрэг материаллаг хохирол заавал шаардах бөгөөд зөвхөн дээр дурдсан Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 04/77/56, 04/77/57 тоот актуудаар буруутгах нь үндэслэл муутай.

Өөрөөр хэлбэл, хохирол шаардсан тухайн гэмт хэрэгт мөрдөн байцаалт, прокурорын шатанд хохирлыг нарийн сайн тогтоогоогүй, шинжээчийн дүгнэлт гаргаагүй байхад тийм хэмжээний хохирол учруулсан байна хэмээн шүүх дүгнэх боломжгүй юм.

Иймд шүүгдэгч Я.С-эд холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан гэмт хэргийг,

шүүгдэгч О.Ф, А.Х нарт холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т заасан гэмт хэргийг тус тус Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгов.Түүнчлэн шүүхийн хэлэлцүүлгийн явцад улсын яллагч шүүгдэгч А.Х-д холбогдох хэргээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2-т заасан хэргийг яллахаас татгалзсан болно.

Нэр бүхий шүүгдэгч нарыг буруутгаж байгаа Мэргэжлийн хяналтын улсын байцаагчийн 2014 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 04/77/56, 04/77/57 тоот актуудад бичигдсэн хохирлын үнийн дүнгийн талаар Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газраас 2014 оны 09 дүгээр сарын 23-ны өдөр 10/1156 тоот албан бичгээр Тодруулгыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газарт хүргүүлсэн нь энэ хэргийг шийдвэрлэх хийгээд, тэдгээрийг тухайн үйлдлүүдэд гэм буруутайд тооцоход эргэлзээ төрүүлж байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т заасан Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ гэсэн заалтыг шүүх баримтлав.

Мөрдөн байцаалтын явцад хохирогчоор тогтоогдон шүүх хуралдаанд оролцсон Нийгмийн халамж, үйлчилгээний ерөнхий газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Б.Дө нь нэр бүхий шүүгдэгч нарт гомдолгүй, тэдгээрээс нэхэмжлэх зүйлгүй гэсэн тайлбарыг шүүхийн хэлэлцүүлэгт гаргалаа.

Түүнчлэн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.6-д Төрийн эрх ашгийг хамгаалах шаардлагатай гэж үзвэл прокурор эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэл гаргах буюу гаргасан нэхэмжлэлийг дэмжих эрхтэй гэж заасан байтал шүүх хуралдаанд оролцсон улсын яллагч нарын зүгээс хохирлыг чухам хэн хэнээс хэрхэн яаж гаргуулах талаар тодорхой тайлбар гаргаагүй болно.

Гэсэн хэдий ч шүүх энэ хэрэгт иргэний хариуцагчаар татагдсан нэр бүхий этгээдүүдээс төлбөрийг буцаан гаргуулж

улсын орлогод оруулахаар шийдвэрлэлээ.

Үүнд: иргэний хариуцагч Х.Мт-ын: ...Би 2012 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Монгол Улсын харьяатаас гарч 2013 оны 05 дугаар сарын 31-ний өдөр иргэний харьяаллаа сэргээлгэсэн. Ерөнхийлөгчийн зарлигийн дугаар нь мэдэхгүй байна. Шинэчилсэн бүртгэлд болохоор зарлиг гарсны дараа Өлгий сумын улсын бүртгэлийн ажилтан дээр очин бүртгүүлж иргэний үнэмлэхээ авсан. Одоогоор дээр бичүүлсэн хаягтаа оршин сууж байгаа. Намайг ямар улсын бүртгэгч бүртгэсэн талаар мэдэхгүй байна... Хүний хөгжил сангийн мөнгийг Хаан банкнаас авч байсан ба миний эхнэр миний өмнөөс итгэмжлэл хийлгэн очиж авч байсан. Олгох ёсгүй 140.000 төгрөгийг намайг төлүүлэх шаардлага тавьж байгаа юм байна. Төлөх эсэх асуудлыг шүүхийн шийдвэрийг харж байж болно /6-р хавтасны 3-4-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Х.Мк-ийн: ...Би 2012 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын харьяатаас гарч 2013 оны 05 дугаар сарын 31-ний өдөр иргэний харьяаллаа сэргээлгэсэн... Намайг Өлгий сумын улсын бүртгэгч бүртгэсэн Хүний хөгжил сангийн мөнгийг Хадгаламж банкнаас авч байсан. Мөнгийг би өөрөө очиж авсан. Олгох ёсгүй 140.000 төгрөгийг намайг төлүүлэх шаардлага тавьж байгааг ойлголоо. Төлөх эсэх асуудлыг шүүхийн шийдвэрийг харж байж болно. /6-р хавтасны 5-6-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч Х.Ер-ийн: ...мөнгө өгөөд л байсан чухам хэдэн төгрөг авсан гэдгээ санахгүй байна. Ямар ч байсан 50.000, 70.000, 21.000 гээд мөнгө өгөөд л байсан... Хүний хөгжил сангийн мөнгийг Хадгаламж банкнаас авч байсан. Мөнгийг би өөрөө очиж авч байсан. Олгох ёсгүй 140.000 төгрөгийг намайг төлүүлэх шаардлага тавьж байгааг ойлголоо /6-р хавтасны 9-10-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ер.Ай-ийн: ...олгох ёсгүй 140.000 төгрөгийг намайг төлүүлэх шаардлага тавьж байгааг ойлголоо /6-р хавтасны 11-12-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч С.Дар-ны: ...хүний хөгжил сангийн мөнгийг Хадгаламж болон Шуудан банкнаас авч байсан. Олгох ёсгүй 140.000 төгрөгийг намайг төлүүлэх шаардлага тавьж байгааг ойлголоо гэхдээ өнөө маргаашдаа өгөхгүй шүүхийн шийдвэрийг харсан нь дээр байхаа /6-р хавтасны 13-14-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч С.Каб-ийн: ...Олгох

ёсгүй 140.000 төгрөгийг намайг төлүүлэх шаардлага тавьж байгааг ойлголоо /6-р хавтасны 15-16-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч А.Меу-ийн: ...Хүний хөгжил сангийн мөнгийг Хадгаламж банкнаас авч байсан...Олгох ёсгүй 140.000 төгрөгийг намайг төлүүлэх шаардлага тавьж байгааг ойлголоо /6-р хавтасны 17-18-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч М.Мар-ын: ...Хүний хөгжил сангийн мөнгийг Хадгаламж банкнаас авч байсан... Олгох ёсгүй 140.000 төгрөгийг намайг төлүүлэх шаардлага тавьж байгааг ойлголоо. Энэ талаар сайтар хэлж мэдэхгүй /6-р хавтасны 19-20-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Р.Ест-ийн: ...Хүний хөгжил сангийн мөнгийг Хаан банкнаас авч байсан... Олгох ёсгүй 140.000 төгрөгийг намайг төлүүлэх шаардлага тавьж байгаа юм байна. Шүүх хэрхэн шийдвэрлэнэ түүгээр болох байхаа /6-р хавтасны 21-22-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Е.Сер-ийн:...Хүний хөгжил сангийн мөнгийг Хадгаламж банкнаас авч байсан. Мөнгийг аав ээж маань өмнөөс минь очин авдаг байсан. Олгох ёсгүй 140.000 төгрөгийг намайг төлүүлэх шаардлага тавьж байгааг ойлголоо. Тухайн үедээ тэдгээр мөнгө олгох зөвшөөрөл өгсөн хүмүүс нь бичиг баримтаа сайтар шалгасан бол одоо ийм зүйл болохгүй шүү дээ /6-р хавтасны 23-24-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч А.Хуа-ийн: ...Уул нь бол гэрийн зүүн талын хана унь шатсан ш дээ. Тэгээд гэрийг бүрэн ашиглах боломжгүй болсон байсан. Ингээд аймгийн онцгой байдлын хэлтсээс дүгнэлт гарган өгсөн бөгөөд түүнийг нь үндэслэн халамжийн хэлтсээс 500.000 төгрөгийн тусламж гарган өндөр настай ээж минь авсан. Тухайн үедээ өгөх ёсгүй байсан юм бол тэр хариугаа өгөхгүй мөнгөө өгчөөд одоо ажилгүй биднээс мөнгө нэхэмжилж байгаа нь зохисгүй юм биш шүү. Ямартай ч шүүхийн болон бусад холбогдох шийдвэрийг харж байж энэ мөнгийг төлөх эсэхээ шийднэ /6-р хавтасны 27-28-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч С.Ама-ийн: ...Хүний хөгжил сангийн мөнгийг Хадгаламж банкнаас авч байсан... Олгох ёсгүй 140.000 төгрөгийг намайг төлүүлэх шаардлага тавьж байгааг ойлгож байна. Хэрэв эргүүлэн төлөх ёстой бол шүүхийн шийдвэрийг харж байж одоогоор хөдөлмөр эрхэлдэггүй болохоор бага багаар нь төлж болох байхаа /6-р хавтасны 30-31-р

хуудас / гэсэн,

иргэний хариуцагч С.Бах-ийн: ...Энэ талаар би одоо сайтар санахгүй байна. Гэхдээ энэ 177,700 төгрөгийг би авсан нь үнэн. Тухайн үедээ энэ баримтыг хэн гэх халамжийн байцаагчид өгсөн гэдгээ санахгүй байна. Мөн дээрээс нь хэлэхэд материалын бүрдэл дутуу байхад тэр ажилтан нь яагаад энэ мөнгийг надад олгосон юм бэ /6-р хавтасны 34-35-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч Ү.Алм-ийн:... Би Монгол Улсын иргэний харьяатаас гарсан эсэхээ огт мэдээгүй. Тэгээд Өлгий сумын улсын бүртгэгч Р дээр очин бүртгүүлж хурууны хээ өгөхөд ямар нэгэн зүйл хэлээгүй шууд бүртгэн иргэний үнэмлэх өгсөн. Хэрэв харьяатаас гарсан бол надад хэлэх ёстой ш дээ би сайн ойлгохгүй байна. Би амьдралдаа Казакстан улсын иргэн болж үзээгүй бөгөөд өөрийн хүсэлтээр иргэний харьяатаас гарсан зүйл байхгүй. Би одоо санахгүй байна. Ямар ч байсан материалаа халамжийн хэлтэст бүрдүүлэн өгсөн. Энэ мөнгийг би өөрийн биеэр Хаан банкнаас очиж авсан теллерийг санахгүй байна. 430.000 төгрөг төлөх шаардлага тавьж байгааг ойлголоо. Шүүхийн шийдвэрийг харж байж болно. Учир нь эхнээсээ надад олгох ёсгүй мөнгийг олгосон бол тухайн албан тушаалтнуудад энэ хариуцлагыг ногдуулж болохгүй юу /6-р хавтасны 40-41-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Б.Бая-ын:...Би хэзээ Монгол Улсын иргэний харьяатаас гарсан гэдгээ сайтар мэдэхгүй байна. Тэгээд 2013 оны 05 дугаар сарын 31-ний өдөр сэргээлгэсэн ба зарлигын дугаарыг нь мэдэхгүй байна. Өлгий сумын улсын бүртгэгчид бүртгүүлэн цахим үнэмлэхээ авсан. Одоогоор дээр бичүүлсэн хаяг нь дээрээ байгаа. Би хүний хөгжил сангийн мөнгийг өөрийн биеэр банкнаас очин авдаг байсан ба нийт хэдэн төгрөг авсан гэдгээ мэдэхгүй байна. Мөнгөө хадгаламж банкнаас авч байсан. Одоо сайн санахгүй байна нилээд хугацаа өнгөрсөн байна. Ерөнхийдөө надад илүү олгосон 140.000 төгрөгийг төлүүлэх шаардлага тавьж байгааг ойлгосон үүнтэй холбогдуулан ямар нэгэн санал хүсэлт байхгүй /6-р хавтасны 48-49-р хуудас / гэсэн.

иргэний хариуцагч Х.Жам-ын: ...Манай ээж 2012 онд Казакстан улсад очин эмчилгээ хийлгэсэн ба ирээд бичиг баримтаа бүрдүүлэн нэг талын унааны зардлаа авсан. Одоо энэ мөнгийг төлүүлэх шаардлага тавьж

байгааг ойлголоо. Тийм болохоор би ээжийн өмнөөс энэ мөнгийг нь төлүүлэх шийдвэр гарвал төлж барагдуулна /6-р хавтасны 50-51-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч Ж.Кул-ийн:...Энэ 132,500 төгрөгийг Хаан банкнаас өөрийн биеэр очин авсан ба тухайн үед материалаа хэн гэх халамжийн байцаагчид бүрдүүлэн өгсөн талаар сайн санахгүй байна. Унааны нэг талын зардал өгдөг гэж хүмүүс яриад байхаар нь болдог юм байх гэж бодоод материалаа бүрдүүлэн өгсөн чинь надад энэ зардлыг гарган өгсөн. Төл гэвэл төлөх л байхдаа /6-р хавтасны 55-56-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч Х.Мах-ын:...Надад ямар нэгэн зүйлийг дутуу өгсөн зүйл байхгүй. Би тархи нуруу нугасны гэмтлийн улмаас хөгжлийн бэрхшээлтэй болсон ба 2011, 2012 онд дараалан Улаанбаатар хот 3-р эмнэлэгт очин хагалгаанд орсон.Тэгээд ирээд унааны нэг талын зардлаа халамжийн хэлтэст баримтаа бүрдүүлэн өгч авсан. Энд маргаад байх зүйл байхгүй /6-р хавтасны 57-58-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч К.Ама-ын:...Би одоо оныг нь сайтар санахгүй байна Монгол Улсын иргэний харьяатаас гарч 2013 оны 06 дугаар сард иргэний харьяатаа эргүүлэн сэргээсэн. Ингээд Өлгий сумын улсын бүртгэгчид бүртгүүлэн цахим үнэмлэхээ авсан. Одоо оршин сууж байгаа хаягтаа байгаа. Хүний хөгжил сангийн мөнгөө Хадгаламж банкнаас өөрийн биеэр очин авдаг байсан...төлөх ёстой бол төлнө /6-р хавтасны 59-60-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Х.Сах-ын:...Би мэргэжлээс шалтгаалах өвчний учраас 2010 онд групп тогтоолгосон ба 2012 оны орчим Казакстан улсад очин эмчилгээ хийлгэсэн. Ингээд ирээд унааны нэг талын зардлаа халамжийн хэлтсээс материалаа бүрдүүлэн өгч Хадгаламж банкнаас авсан. Надаар энэ зардлыг төлүүлэх шаардлага тавьж байгааг ойлголоо. Хэрэв буруу байсан бол анхнаасаа яах гэж энэ мөнгийг олгосон юм бэ. Тийм учраас тэр буруутай хүмүүс нь төлөх биз гэж би бодож байна. /6-р хавтасны 61-62-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ж.Дар-ийн:...Би одоо он сарыг санахгүй байна манай гэрийхэн гэр бүлээрээ Монгол Улсын иргэний харьяатаас гарч Казакстан улсын иргэншилтэй болсон. Учир нь Казакстан улсын иргэн болоход 1.200.000 төгрөг өгч байсан ба ажил төрөлгүй хүнд мөнгө хэрэгтэй болохоор

тэрийг нь авах санаатай иргэний харьяатаас гарсан юм. Тухайн үед манай эндхийн хүн бүр л Казакстан улсын иргэн болж таван төгрөг авахаар явж байсан. Ингээд 2013 онд шиг санаад иргэний харьяатаа эргэн сэргээлгэсэн. Тэр хооронд Хүний хөгжил сангаас 140.000 төгрөг илүү авсан бололтой түүнийг эргүүлэн төлөхөд татгалзах зүйлгүй гэх мэдүүлэг /6-р хавтасны 64-65-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч С.Сау-ийн:... Манай нөхөр М.Зу нь /БЮ..... /одоо Улаанбаатар хотод эмчилгээ хийлгэж байгаа бөгөөд удахгүй ирэх ёстой. Байхгүй байгаа болохоор эхнэрийн хувьд өмнөөс нь би иргэний хариуцагчаар тооцогдох гэсэн юм. 2011 онд манай нөхөр Улаанбаатар хотод эмнэлэгт хэвтэн ирээд нэг талын унааны зардал авсан бөгөөд түүнээс 163,600 төгрөгийг илүү олгосон талаар би ойлголоо. Хэрвээ энэ мөнгийг төлөх ёстой бол зохих журмынх нь дагуу төлж барагдуулахад бэлэн байна /6-р хавтасны 66-67-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Е.Оза-ын:...Би болсон хэргийн талаар сайтар ойлгож байна. Манай эхнэр Жа.Гү /БМ...../, дүү Ау.Му /БЭ...../, Ар.Б /БК...../ нар нь 2011 онд шиг санаад байхын Монгол Улсын иргэний харьяатаас гарч эргэн 2013 оны 05-р сард сэргээлгэсэн. Харьяатаа сэргээлгэн Ногооннуур сумын улсын бүртгэгчид бүртгүүлэн цахим үнэмлэхээ авсан. Одоо Ногооннуур суманд оршин сууж байгаа 2 дүүгийн хувьд хөдөө малтай зусланд гарсан холбоо барьж чадаагүй болохоор ирсэнгүй. Гэхдээ би эдгээр хүмүүсийн өмнөөс иргэний хариуцагчаар тооцогдож үүрэг хүлээхэд болно гэж бодож байна. Учир нь бид нар ах дүү хүмүүс бөгөөд одоо хамт нэг дор амьдардаг юм. Мөн миний эхнэр ч байна. Одоо хүн тус бүрийн 140,000 төгрөгийг Хүний хөгжил сангаас илүү авсан байна гэдгийг ойлголоо. Төлөх эсэхээ шүүхийн харж байж болно. Энэ хүний хөгжил сангийн мөнгийг бид нар бүгд авч байсан /6-р хавтасны 68-69-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Т.Аву-ын:...Би 2012 оны 11 дүгээр сард болсон орон нутгийн сонгуулийн үед сонгууль өгөх үедээ мэдсэн. Миний бие тухайн үед харьяатаас гарах хүсэлт гаргаж байгаагүй. Гэтэл намайг улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 2012 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын харьяатаас гаргасан байсан. Тэгээд би энэ асуудлыг мэдээд буцаж Монгол Улсын

харьяатад орох тухай хүсэлт гаргасны дагуу Монгол Улсын харьяатаа сэргээлгэсэн. Одоогоор Монгол Улсын иргэншилтэй ...Намайг иргэний хариуцагчаар татаж байгааг ойлгож байна. Надаас нэхэмжилж байгаа 140.000 төгрөг нь миний буруутай үйл ажиллагаа биш, тодорхой албан тушаалтны буруутай ажилтнуудаас болж ийм асуудал үүссэнийг өнөөдөр мэдсэн. Гэхдээ би тэр мөнгийг авсан болохоор тэр мөнгийг буцааж өгөхөд татгалзах зүйлгүй Мөн миний эхнэр Ту.Ад РД:..... нь мөн надтай яг ижилхэн асуудалтай байгаа. Одоогоор хуулийн байгууллагад ирэх боломжгүй өвчтэй байгаа. Тиймээс би эхнэрийнхээ өгөх ёстой 140.000 төгрөгийг мөн өгөхөд татгалзах зүйлгүй /6-р хавтасны 72-73-р хуудас/,

иргэний хариуцагч К.Ерж-ын:...Намайг иргэний хариуцагчаар тооцож байгааг ойлгож мэдлээ. Би өөрийгөө Монгол Улсын харьяатаас хасагдсан байсныг 2012 оны намар Өлгий суманд байгаа гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн хэлтсээс орж мэдсэн. Намайг хэзээ, ямар дугаартай Ерөнхийлөгчийн зарлигаар хассан байсныг мэдэхгүй. Ямарч л байсан Өлгий сумын гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн газарт байгуулагдсан байсан харьяатын асуудал сэргээх коммист Ерөнхийлөгчийн нэр дээр өргөдөл бичээд, багийн даргын оршин суух тодорхойлолт, анкет зэрэг 3 зүйл бүрдүүлж өгч байсан. Тэгээд миний иргэншлийг 2013 оны 05 дугаар сард сэргээж өгч байсан. Би хүний хөгжил сангаас өгч байсан мөнгийг бүгдийг нь авч байсан. Би Өлгий сумын Хадгаламж банкнаас эхлээд 390.000 төгрөг дараа нь 110.000 төгрөг авч байсан. Би Монгол Улсад байгаагүй учраас энэ мөнгөө аваагүй байсан. Тэгээд бөөнд нь авсан юмаа. Яг хэзээ энэ мөнгийг авч байснаа огт санахгүй байна. Ямар ч л байсан 2 хуваагаад 500.000 төгрөг авч байсан /6-р хавтасны 116-117-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч Т.Кул-ын:...Би 2012 оны 08 дугаар сард Өлгий сумынхаа гадаадын харьяатын асуудал эрхэлсэн хэлтсээс гадаад паспортоо сунгуулах гэж байгаад харьяатаас хасагдсанаа мэдсэн. Би өөрөө харьяатаас гарах ямар нэгэн санал хүсэлт бол гаргаагүй. Хүний хөгжил сангийн мөнгөний хувьд бол өгч байсан цаг тухай бүрт нь авч байсан. Намайг хариуцагчаар тооцож байгааг ойголлоо. 140.000 төгрөг буцааж өгч байгаа асуудлыг мөн ойлголоо /6-р хавтасны 120-121-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Н.Жан-ын:...Би 2002 онд өөрийн хүсэлтээр Монгол Улсын иргэншлээс гарсан ба 2012 онд иргэншлээс гарсан юм. Иргэншлээ сэргээгээд эхлээд төгрөг дараа нь 70.000 төгрөг авсан. Нийлээд 490.000 төгрөг авсан /6-р хавтасны 122-123-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ш.Аси-ын:...Намайг иргэний хариуцагчаар тооцож байгааг ойлгож мэдлээ. Би 2011 оны 08 дугаар сард Казакстан улсруу эмчилгээ хийлгэхээр явсан ба ирээд 2011 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр Өлгий сумын Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэст эмчилгээний бичиг, иргэний үнэмлэхний хуулбар, хороон тодорхойлолт зэргийг өгөөд 132.500 төгрөг гаргуулж авч байсан. Тухайн үед халамж үйлчилгээний ажилтан нь болно гэж хэлээд л өгч байсан /6-р хавтасны 126-127-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч А.Бей-ын:...Би хүний хөгжил сангийн дэвтрийг Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Халамжийн байцаагчаас л авч байсан. Хэн гэдгийг нь санахгүй байна. Би мөнгөө Улаанхус сумын Хадгаламж банкнаас Хүний хөгжил сангийн дэвтрээ үзүүлээд мөнгөө цаг тухай бүрт нь авдаг байсан. нийт 500.000 төгрөг авсан. Одоо энэ авсан 500.000 төгрөгөө буцаан өгөхөө ойлголоо /6-р хавтасны 144-145-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ө.Жан-ийн:...Хүний хөгжил сангийн дэвтрээ үзүүлээд мөнгөө цаг тухай бүрт нь авдаг байсан...Одоо энэ авсан 500.000 төгрөгөө буцаан өгөхөө ойлголоо /6-р хавтасны 146-147-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Т.Ерб-ын:....Би өөрийгөө харьяатаас 2012 оны 9 сарын үед орон нутгийн сонгуульд нэрээ дэвшүүлэх гэсэн чинь намайг харьяатаас гарчихсан байна гэж хэлсэн. Тэгээд яагаад юу болвоо гэсэн чинь намайг 1998 онд харьяатаас гарсан байна гэсэн. Би Хүний хөгжил сангаас эхлээд 70 000 төгрөг, дараа нь 50 000 төгрөг авсан. Тэгээд харьяатаа сэргээлгээд 300 гаран мянган төгрөг авсан. Нийтдээ 500 000 орчим төгрөг авсан. Би өөрийнхөө харьяатыг сэргээлгэхийн тулд Баян-Өлгий аймгийн гадаадын иргэн харьяатын асуудал эрхэлсэн хэлтсийн дарга М-т, ерөнхийлөгчийн нэр дээр өргөдөл, бичээд, анкет бөглөөд, хуучин иргэний үнэмлэхээ канондоод өөр шаардлагатай бичиг баримтаа, 60 000 төгрөгтэй хавсаргаад өгч байсан. Тэгээд миний харьяатыг 2013 оны 05 сард сэргээсэн

байсан. Одоо би Монгол Улсын иргэн. Баян-Өлгий аймагтаа байнгын оршин сууж байгаа. Би Хүний хөгжил сангийнхаа мөнгийг Хадгаламж банкны дансаараа авдаг байсан /6-р хавтасны 165-167-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч С.Хум-ын:...Би өөрийн эхнэр Н.Му-тай хамт 2010 оны сүүлээр Казахстан улс руу эмчилгээнд яваад ирсэн юмаа. Тэгээд 2011 оны 2 сарын 1-ний өдөр эхнэр бид хоёр хоёулаа Баян-Өлгий аймгийн Өлгий сумын нийгмийн халамж үйлчилгээний хэлтсээс тус бүртээ 198.100 төгрөг авсан. Эхнэр маань бие муутай болохоор би эхнэрийнхээ буцаан олгох ёстой 198.100 төгрөгийг хариуцаж байна /6-р хавтасны 168-171-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч К.Ажы-ын:...Намайг иргэний нэхэмжлэгчээр тооцож байгааг ойлгож мэдлээ. Би энэ хугацаанд Улаанбаатар хот руу яваад эмчлүүлээд ирсэн нь үнэн. Эмчилсэн эмч маань 136 маягтан дээр өөрийнхөө тэмдгийг дараад өгсөн. Би Баян-Өлгий аймагтаа буцаж ирээд шаардлагатай гэсэн бичиг баримтыг нь халамжийн байцаагчидаа өгөөд замын зардлын нэг талын зардал болох 156 000 төгрөг авсан. Хэрэв намайг энэ мөнгийг буцаагаад төл гэсэн шүүхийн шийдвэр гарах юм бол буцаагаад төлөхөд татгалзах зүйлгүй /6-р хавтасны 172-174-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч А.Бер-ийн:...Миний хүү Казахстан улсад оюутан юмаа. Одоо монголд ирэх боломжгүй байгаа тул намайг миний хүсэлтээр иргэний хариуцагчаар тооцож байгааг ойлгож мэдлээ. Миний хүү 2012 онд харьяатаас гарсан байсан ба өөрийнхөө хүсэлтээр харьяатаас гараагүй. Тэгээд 2013 оны 05 сард харьяатаа сэргээлгэсэн ба энэ хугацаанд хүний хөгжил сангийн мөнгө авч байсан. Одоо миний хүүд 140 000 төгрөг илүү олгосон учрыг ойлгож эргүүлэн тэр илүү олгогдсон мөнгийг төлөхөд татгалзах зүйлгүй /6-р хавтасны 175-178-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ү.Бул-ын:...Би болон манай нөхөр РД:БД..... Ха.А, миний том охин БД..... регистртэй А.Ба, миний дунд охин БД..... регистртэй А.Ан буюу одоо нэрээ солиод А.То, миний бага хүү БД..... регистртэй А.Жа нар нь 2005 онд Казахстан улс руу оршин суух санаатай Монгол Улсын иргэншлээс гарсан боловч Казахстан улс руу нүүж чадалгүй Монгол Улсын иргэншлээс гараад Монголдоо амьдарч байсан юм. Тэгээд 2013 оны 05

сард иргэншлээ гэр бүлээрээ сэргээгээд Баян-Өлгий аймгийн нийгмийн халамжаас хүн тус бүр 500 000 төгрөг авсан ба нийтдээ 2 500 000 төгрөг Хүний хөгжил сангийн нөхөн олговрын мөнгө гэж авсан юмаа. Манай гэр бүлийн гишүүд цагдаа дээр ирэх боломжгүй тул би гэр бүлийн гишүүд болох, нөхөр, 3 хүүхдийнхээ өмнөөс иргэний хариуцагчаар тооцогдон энэ хүн тус бүрийн төлөх ёстой 140 000 төгрөгийг татгалзах зүйлгүй. Манай гэр бүл нийтдээ 700 000 төгрөг улсад эргүүлэн төлөх ёстойг ойлголоо гэх мэдүүлэг /6-р хавтасны 179-182-р тал /

иргэний хариуцагч А.Алт-ын:... Хүний хөгжил сангийн дэвтрээ Бугат сумын халамжийн байцаагч Аү гэдэг халамжийн байцаагчаас ямар нэгэн бичиг баримт бүрдүүлэлгүйгээр дэвтрээ авсан ба тэр дэвтрээрээ Хүний хөгжлийн сангийн мөнгөө авч байсан ба нийтдээ 500 000 төгрөг авсан /6-р хавтасны 183-185-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч С.Алм-ын:...Би өөрийн БА..... регистртэй Ка.Ха-тай хамт 2004 онд Монгол Улсын харьяатаас Касахстан улс руу нүүж амьдрах зорилготой гарсан боловч нүүж чадаагүй Монголдоо амьдарч байгаад 2012 онд харьяатаа сэргээлгэсэн. Тэгсэн хүний хөгжил сангаас нөхөр бид хоёрт тус бүрт нь 500 000 төгрөг бөөнөөр нь өгсөн юмаа. Одоо Монгол Улсын иргэн. Баян-Өлгий аймагтаа байнгын оршин сууж байгаа. Бид нар Хүний хөгжил сангийнхаа мөнгийг авах гэж хөөцөлдөж байгаад Алтай сумын халамжийн байцаагч Р.Ра-д Хүний хөгжил сангийнхаа дэвтрийг өгөөд нөхөр бид хоёр тус бүртээ 500 000 төгрөг, нийт 1 000 000 төгрөг авч байсан /6-р хавтасны 186-188-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Р.Сам-ын:... Ямарч л Халамжаас надад замын нэг талын зардалд 183 600 төгрөг өгсөн /6-р хавтасны 190-192-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ш.Ерк-ын:...Би гэр бүлээрээ 2005 онд Монгол Улсын харьяатаас гараад 2012.6.15-ны өдөр Монгол Улсын харьяатаа Ерөнхийлөгчийн зарлигаар сэргээлгэсэн юмаа. Харьяатаа сэргээлгээд хүний хөгжил сангаас нэг удаа 70 000 төгрөг, дараа нь 429 800 төгрөг нийт 499 800 төгрөг хүний хөгжил сангаас авсан /6-р хавтасны 198-200-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч А.Нур-ын:...Би 1999 онд Монгол Улсын харьяатаас гараад 2012.6.15-ны өдөр Монгол Улсын харьяатаа Ерөнхийлөгчийн зарлигаар сэргээлгэсэн.

Харьяатаа сэргээлгээд хүний хөгжил сангаас нэг удаа 70.000 төгрөг, дараа нь 429.800 төгрөг нийт 499.800 төгрөг хүний хөгжил сангаас авсан /6-р хавтасны 201-203-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Х.Өми-ын:...Би 2005 оны 6 сард Монгол Улсын харьяатаас гарсан юм. Уг нь Казакстан улс руу нүүж амьдарна гэж эхнэр Р.Гү-н хамт харьяатаас гарсан боловч нүүж чадалгүй монголдоо амьдарч байсан юм.Тэгээд 2013 оны 05 дугаар сард харьяатаа сэргээлгээд Хүний хөгжил сангаас олгосон хүн тус бүрийн 500.000 төгрөг авсан юм /6-р хавтасны 208-211-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Х.Уна-ын:...Би энэ мөнгийг авсан. Манай хүүхдүүд Казакстан улсад байдаг болохоор эмчилгээгээ Казакстан улсад хийлгэсэн. Мөн дээрээс нь Улаанбаатар хотод миний таньдаг хүн байхгүй болохоор Казакстан улсад очиж эмчилгээ хийлгэсэн. Уг нь бол 190.000 төгрөгийг аваад Улаанбаатар хотод эмчилгээ хийлгэх байсан боловч Улаанбаатар хотод таньдаг хүн байхгүй байсан болохоор Казакстан улсад очсон /6-р хавтасны 234-235-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Б.Хар-ийн:...Ер нь бол би Улаанбаатар хотод очиж эмчилгээ хийлгэдэг. Миний биеийн байдал ерөнхийдөө муу байдаг. Би жил болгон Улаанбаатар хотод очиж эмчилгээ хийлгэдэг. 2013 оны 04 дүгээр сард Улаанбаатар хотын Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн нэгдэл очиж эмчилгээг гадуур авч байсан. 2013 онд миний бие маш муу байсан бөгөөд ерөөсөө орноосоо босож чадахгүй байсан болохоор Чингэлтэй Эрүүл мэндийн нэгдэлд очиж эмчилгээ хийлгэсэн. Надад эмчилгээ хийлгэсэн баримт байгаа. Би 249,900 төгрөгийг хуулийн дагуу авсан /6-р хавтасны 236-237-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ж.Зах-ийн:...2011 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Казакстан улсад очиж эмчилгээ хийлгэсэн. Миний дотор эрхтэн муу болохоор Казакстан улсад очиж эмчилгээ хийлгээд 2012 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Монгол улсад буцаж ирсэн бөгөөд Казакстан улсад эмчлүүлж байсан бүх баримтаа аваад Халамж үйлчилгээний төвд өгөөд Халамж үйлчилгээний төвөөс 73.500 төгрөгийг Хаан банкинд шилжүүлсэн. Би тэр мөнгийг нь Хадгаламж банкнаас очиж авч байсан /6-р хавтасны 240-241-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч М.Сан-гын:...2011 оны 08 дугаар сарын 07-ны өдрөөс 2011

оны 10 дугаар сарын 07-ны өдөр хүртэл Казакстан улсад очоод хоёр нүдэндээ эмчилгээ хийлгэсэн. Би Казакстан улсад хоёр сар байж байгаад нүднээсээ болоод буцаад Монгол улсад ирсэн. Яагаад гэвэл Казакстан улс их чийгтэй байсан болохоор нүдэнд улам муудаад байсан. Казакстан улсаас буцаж ирээд эмчилгээний зардал гээд 190.000 төгрөгийг авсан. Энэ мөнгөө авахдаа Баян-Өлгийн аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс /хуучнаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс/-ээс авч байсан. Би мөнгөө авахдаа Казакстан улсад эмчилгээ хийлгэж байсан баримтаа өгөөд л мөнгөө авч байсан /6-р хавтасны 247-248-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч И.Ахб:... Би нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс /хуучнаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс/-ээс 140.000 төгрөг өгсөн байсныг мэдээгүй /7-р хавтасны 1-2-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч А.Сал-ын:... Би Монгол Улсын иргэн болох гээд оршин суух тодорхойлолт иргэний үнэмлэх, багийн Засаг даргын тодорхойлолт, Казакстан улсруу яваагүй гэсэн баримт, гэр бүлийн баталгаа гэх баримтуудыг гадаадын харьяатын газрын дарга Мягмаржавд өгсөн. Тухайн үед Монгол Улсын харьяатаас гарсан байсан учир хүний хөгжил сангийн мөнгөө авч чадаагүй байж байгаад 2013 оны 07 сард 400 000 орчим мянган төгрөг өгсөн. Энэ мөнгийг манай нөхөр Д.А гэдэг халамжийн байцаагчтай уулзаж байгаад банкнаас авсан. Би урьд нь хүний хөгжил сангаас 70.000 төгрөг авч байсан бөгөөд харьяатаас гарсан учраас 70.000 төгрөг өгөөгүй байж байгаад сүүлд Монгол Улсын харьяат болоход дээр бичүүлсэн 400.000 төгрөг бөөнд нь өгсөн. Би 70.000 төгрөг, 400.000 төгрөгийг Хадгаламж банкнаас авч байсан ба хэн гэдэг теллерээс авч байсныг санахгүй байна. Би өөрөө 70.000 төгрөгийг өөрөө авч байсан бөгөөд 400.000 төгрөгийг манай нөхөр авч байсан /7-р хавтасны 36-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч С.Мар:...2000 оны зарлигаар Монгол Улсын харьяатаас гарсан. Би өөрийн хүсэлтээр харьяатаас гараагүй. Би иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдах гээд иргэний үнэмлэх авах гээд очиход намайг Монгол Улсын харьяатаас гарсан байна гэж хэлсэн. Би буцаад Монгол Улсын иргэн болох гэж 7 үеийн товч намтар, иргэний үнэмлэхийн хуулбар гэх мэт баримтуудыг Баян-Өлгийн аймгийн цэнгэл сумын иргэний

бүртгэлийн улсын байцаагчид өгөөд 2013 оны 06 дугаар сард Монгол Улсын иргэн болсон. Би хүний хөгжил сангаас 2013 оны 11 дүгээр сарын сүүлээр авсан. Би 50.000 төгрөгийг гуйж аваагүй төр өөрөө өгсөн болохоор буцааж өгөх мөнгө байхгүй /7-р хавтасны 40-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Д.Гар-ийн:...Би охиныхоо өмнөөс бичиг баримт бүрдүүлэн Бухад сумын халамжийн байцаагч Аг гэдэг хүнд өгсөн. Аг миний өгсөн баримтыг үзээд болсон байна гээд банкнаас очиж мөнгөө аваарай гэж хэлсэн. Би хэдэн сарын дараа 80.000 төгрөгийг банкнаас авч байсан. /7-р хавтасны 44-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ж.Сай-ийн:...Манай эгч 2011-2013 он хүртэл Улаанбаатар хотын сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв эмнэлэгт хэвтэж эмчилгээ хийлгэж байсан. Эмнэлэгт хэвтсэн баримт нь байгаа. Манай эгч Улаанбаатар хотод очиж эмчилгээ хийлгэсэн гээд унааны тал зардал гэж мөнгө авч байсан. Энэ мөнгийг авахдаа эгчийн эмнэлэгт хэвтсэн гэх баримтуудыг бүрдүүлээд Баян-Өлгий аймгийн халамжийн байцаагч, На-д өгч байсан. На миний өгсөн баримтыг аваад унааны тал зардалаа Хадгаламж банкнаас очиж аваарай гэсэн. Тэгэхээр нь эгчийгээ дагуулж Хадгаламж банк нь дээр очоод 73 500 төгрөг авч байсан /7-р хавтасны 48-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Х.Мам:...2010 оноос 2011 оны хооронд Казакстан улс руу явж эмчилгээ хийлгэсэн. Казакстан улс руу явчхаад Баян-Өлгий аймгийн халамжийн төвд очоод болсон хэргийн талаар хэлсэн. Би Улаанбаатар болон Казакстан улс руу очоод эмчилгээ хийлгээд ирлээ. Халамжийн төвөөс ямар нэгэн зардал өгөх үү гэж асуухад Казакстан улс руу явсан унааны зардал гэж байхгүй. Харин Улаанбаатар хотод очиж эмчилгээ хийлгэсэн унааны тал зардлыг өгч болно гэсэн. Тэгэхээр нь би Казакстан улсад очиж эмчлүүлсэн баримтаа өгсөн. Би баримтаа халамжийн байцаагчид өгсний дараа халамжийн байцаагч банкнаас мөнгөө аваарай гэж хэлсэн. Би халамжийн байцаагчийнхаа нэрийг одоо санахгүй байна. Халамжийн байцаагч нарт өөрийн гэсэн бүх баримтаа өгөөд унааны нэг талын зардал 196.300 төгрөг авсан /7-р хавтасны 95-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Б.Алт-ны:...2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр би Улаанбаатар хотод очиж эмнэлэгт хэвтэхгүйгээр эмчилгээ,

шинжилгээ хийлгэж байгаад ирсэн. 2012 онд Улаанбаатар хотод очиж Хадагтай эмнэлэгт хэвтэж хагалгаанд орж байсан. Улаанбаатарт очиж эмчилгээ хийлгэхээд баримтаа Баян-Өлгий аймгийн Баяннуур сумын халамжийн байцаагч н.Ну гэдэг хүнд өгсөн. Баян-нуур аймгийн халамжийн байцаагч миний бичиг баримтыг аваад аймгийн халамжийн хэлтэст өгсөн байсан. Би бичиг баримтаа бүрдүүлж өгсөн болохоор унааны тал зардал болох 195.000 төгрөгийг миний дансанд хийсэн байсан /7-р хавтасны 112-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч С.Пун-ийн:...Манай эхнэр У.И нь 2009 онд машины осолд ороод хоёр хөл нь хугарсан юм. Тухайн үед Дархан-уул аймагт явж байсан болохоор Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэж байсан. Одоо манай эхнэр Дархан-Уул аймаг руу хөлний хадаасаа авахуулах гээд явсан. Би энэ хүний өмнөөс иргэний хариуцагчаар тооцогдож хариуцлага хүлээж болно. Миний эхнэр хоёр хөлөөрөө явж чадахгүй болсон. Би эхнэрийнхээ эмнэлэгт хэвтэж байсан бичиг баримтыг аваад Баян-Өлгий аймгийн халамжийн байцаагч Мт гэсэн хүнд өгсөн. Мт нь унааны тал зардал гээд 183.600 төгрөг өгсөн. Энэ мөнгийг банкнаас ав гэхээр нь би банк нь дээр яваад очсон чинь банкны теллер таны мөнгийг хүн тарааж байгаа гэсэн. Би одоо болсон хэргийн талаар сайн санахгүй байна. Яагаад гэвэл энэ үйл явдал 4 жил болж байна. Би тэр мөнгө тарааж байсан хүнийг нэрийг мэдэхгүй байна. Надад халамжийн байцаагч Мт банкнаас ав гэсэн чинь хувь хүн мөнгө тарааж байсан /7-р хавтасны 114-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Г.Цэц-гийн:...2012 оны 09 дүгээр сард үнээ сааж байгаад миний баруун хөл хугарсан. Тэр үед Улаанбаатар хотод очиж шинэ гэмтлийн эмнэлэгт 14 хоног хэвтээд гарсан. Улаанбаатар хотод хэвтэж эмчлүүлсэн баримтаа Баян-Өлгий аймгийн халамжийн төвд өгсөн. Халамжийн төвөөс надад 240.000 төгрөг унааны тал зардал гээд өгсөн. Би хэн гэдэг халамжийн байцаагчид хандсанаа санахгүй байна. Би эмнэлэгт хэвтсэн баримтаа л өгсөн. Би аль банкнаас авч байснаа санахгүй байна. Ямар ч байсан 240.000 төгрөг авч байсан /7-р хавтасны 117-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч А.Тал-ын:...2012 оны 07 дугаар сарын 02-ны өдөр Монгол Улсын харьяатаас гараад 2012 оны 10 дугаар сарын 17-ны өдөр Монгол Улсын иргэн болсон. Бид нарыг Монгол улсад ирэхэд Монгол Улсын

харьяатаас гарсан байна гэж хэлсэн. Би хүний хөгжил сангаас мөнгө авдаг байсан. Гэхдээ манай эхнэр миний өмнөөс мөнгө авч байсан. Миний хүний хөгжил сангаас авсан мөнгө нийт 348.900 төгрөг болж байсан /7-р хавтасны 119-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч А.Кам-ны: ...БК..... регистрийн дугаартай ИА-ын овгийн Ке овогтой Ма гэдэг хүн бол миний төрсөн охин бөгөөд одоо өвчтэй учраас цагдаа дээр ирж байцаалт өгч чадахгүй. Би охиныхоо өмнөөс иргэний хариуцагчаар байцаалт өгөх хүсэлтэй байна. Манай охин 2002 онд Баян-Өлгий аймагт машины осолд орсон. 2011 онд миний охин Казакстан улсад очоод эмнэлэгт хэвтэж байгаад буцаад Монголд ирсэн. Манай охин бараг 2 сар Казакстан улсад байсан. Би охиныгоо ирэхээр нь Казакстан улсаас ирсэн эмчилгээний баримт болон бусад баримтаа Баян-Өлгий аймгийн халамжийн байцаагчид өгсөн. Би энэ талаар сайн санахгүй байна. Халамжийн байцаагч унааны тал зардал гээд 73.500 төгрөг өгсөн. Гэхдээ энэ мөнгийг банкнаас авч байсан. Би охиныхоо өмнөөс 73.500 төгрөгийг нь авсан /7-р хавтасны 129-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Х.Аха-ны:...Би ходоодны хорт хавдрыг Турк улсын Анкария хотод эмчлүүлэхээр 2011 оны 6 дугаар сарын 13-ны өдөр Баян-Өлгий аймгаас онгоцоор Казакстаны Алмат хотруу ниссэн. Тухайн үед Баян-Өлгийгөөс Казакстан руу нислэг хийгддэг байсан юм. Тэгээд Казакстаны Алмат хотоос тэр өдрөө Туркид онгоцоор очиж төв эмнэлэгт нь хагалгаа эмчилгээ хийлгэж эмчлүүлж байгаад эмчилгээ дуусаад Москвагаар дамжиж Улаанбаатар хотод 2011 оны 12 дугаар сарын 24-нд ирсэн. Турк улсад эмчилгээ хийлгээд ирсний дараа тэтгэвэрт суудаг хүн эмчилгээ хийхээр явсан унааны зардлын нэг талыг бүрэн олгоно гэсэн халамж үйлчилгээний хуулийн дагуу би Турк улс руу явсан унааны зардлын нэг талыг олж авахаар аймгийн халамж үйлчилгээний газарт гадаад улсад эмчилгээ хийлгэсэн унааны зардал болох Баян-Өлгийгөөс Турк улсад онгоцоор ниссэн нислэгийн нэг талын зардлыг нөхөн олгож өгнө үү, мөн эмчилгээний зардлаас ямар нэг байдлаар нөхөн олгох хөнгөлт байж болох уу гэсэн өргөдөл бичээд, өргөдлийн хамт эмчилгээ хийлгэсэн баримтаа бүрдүүлээд Баян-Өлгий аймгийн халамж үйлчилгээний газарт өгсөн. Тухайн үед Я.С гэх хүн дарга нь байсан юм. Миний өгсөн материалыг Н.НА гэх эмэгтэй

байцаагч авсан. Тэгээд нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс миний өгсөн өргөдлийг шийдвэрлэхдээ унааны зардлын нөхөн олговор гэж 200 гаран мянган төгрөгийг 2012 оны 12 дугаар сард надад өгсөн. байх /7-р хавтасны 131-132-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ж.Гүл-ын: ...140.000 төгрөг илүү авсан асуудал нь нийгмийн халамж үйлчилгээнд тухайн ажиллаж байсан алба хаагч нартай холбоотой байх /7-р хавтасны 134-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч А.Кен-н:... би Эх орны хишиг 500.000 төгрөг авсан байгаа. Хүний хөгжил сангаас олгосон дэвтэр нь надад байгаа. 500 000 төгрөг өгч байх үед бол би 18 насанд хүрээгүй байсан тухайн мөнгийг манай аав ч юмуу эгч юм хэн нэг авсан байх /7-р хавтасны 141-142-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч А.Бер-ны:...Би мөнгийг Баян-Өлгий аймгийн Хаан банкинд очиж бэлнээр авсан. Би 140.000 төгрөг илүү авсан гэх асуудлыг мэдэхгүй байна /7-р хавтасны 148-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч К.Хур-ын:...Би зүрхний өвчтэй байсан тул эмчилгээ хийлгэх шаардлагатай байсан. Тэгээд 2010 онд Казакстан улсын нэгдсэн эмнэлэгт очиж зүрхэндээ эмчилгээ хийлгэсэн. Тэгээд эмчилгээ хийлгэж ирсний дараа Баян-Өлгий аймгийн нийгмийн халамжийн төвд гадаад улсад эмчилгээ хийлгэсэн унааны нэг зардлыг төлж өгнө үү гэсэн хүсэлтийг өгсөн. Миний хүсэлтийг хүлээн авч шийдвэрлээд надад 198.000 төгрөг өгсөн юм. Би энэ мөнгийг авсан юм. 7-р хавтасны 157-158-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч Х.Жом-ын:...Би төрөөс олгож байсан эх орны хишиг болох мөнгүүдийг бол зохих журмаар авч байсан. Гэхдээ 140.000 төгрөг авсан гэдгийг мэдээгүй байсан /7-р хавтасны 160-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ш.Нур:...Би төрөөс олгож байсан эх орны хишиг болох мөнгүүдийг бол зохих журмаар авч байсан. Гэхдээ 140.000 төгрөг авсан гэдгийг мэдээгүй байсан /7-р хавтасны 162-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч З.Алм-ийн:...Хүний хөгжил сангаас олгож байсан мөнгийг авч байсан. Гэхдээ 140.000 төгрөг илүү авсан гэх асуудлыг сайн ойлгохгүй байна /7-р хавтасны 178-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч С.Гүл-н:...Би 2011 онд Казакстан улсын нэгдсэн эмнэлэгт очиж эмчилгээ хийлгэсэн. Тэгээд яваад ирсний дараа Баян-Өлгий аймгийн нийгмийн

халамжийн төвд эмчилгээ хийлгэсэн баримт материалаа өгсөн. Халамжийн төвөөс миний хүсэлтийг хүлээн аваад надад автобусны нэг талын зардалд 73.500 төгрөг өгсөн юм /7-р хавтасны 183-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Т.Миз-н: ...Би эмчилгээ хийлгэж ирсний дараа Баян-Өлгий аймгийн нийгмийн халамж үйлчилгээний дарга Я.С гэх хүнтэй тааралдаад уулзсан чинь эмчилгээ хийлгэсэн зардлыг чинь улсаас төлж болно ш дээ. Та нар эмчилгээ хийлгэсэн материалаа бүрдүүлээд өгчихгүй юу гэхээр нь эхнэр н.Мар бид хоёр хамт эмчилгээнд явсан болохоор баримтаа хуулбарлан өгсөн. Тэгээд бид хоёрын материалыг хүлээн авснаас хойш 2-3 сарын дараа надад банкаар дамжуулан 200 орчим мянган төгрөг өгсөн юм /7-р хавтасны 189-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч А.Гал: ...Би хүний хөгжил сангаас олгож байсан мөнгө бүрийг зохих ёсоор авч байсан. Гэхдээ 140.000 төгрөг илүү авсан гэх асуудлыг мэдэхгүй байна /7-р хавтасны 193-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч У.Хан-ын:...Би хүний хөгжил сангаас олгож байсан мөнгийг авч байсан. Нийт 500.000 төгрөг авсан. 430.000 төгрөг надад илүү олгосон асуудал нь миний иргэний харьяатын асуудалтай холбоотой юм шиг байна /7-р хавтасны 199-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Т.Кат:...Би 2010 онд Казакстан улсын нэгдсэн эмнэлэгт очиж оношилгоо хийлгэж эмчилгээ хийлгээд онгоцоор буцаж ирсэн юм. Ирээд Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний төвд эмчилгээ хийлгэсний унааны зардал олгоно уу гэсэн өргөдөл бичээд Казакстан улсад эмчлүүлсэн материалаа хуулбарлаад өгсөн. Тэгээд халамжийн төвөөс миний хүсэлтийг шийдвэрлээд унааны нэг талын зардалд 190 гаран мянган төгрөг олгохоор болсоо. Би энэ мөнгийг өөрөө хүлээн авсан /7-р хавтасны 201-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч К.Есе: ...Би эцэг С.К-г нь 2012 онд Казакстан улсад очиж эмчилгээ хийлгээд ирсэн юм. Тэгээд эмчилгээ хийлгэхдээ унааны нэг зардлыг авдгийг сонсоод Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний төвд эмчилгээ хийлгэсний унааны зардал олгоно уу гэсэн өргөдөл би бичээд эцгийн Казакстан улсад эмчлүүлсэн материалыг хуулбарлаад өгсөн. Тэр материалыг нийгмийн халамжийн ямар ажилтанд авсныг одоо санахгүй байна.

Тэгээд аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний төвөөс миний хүсэлтийг нааштайгаар шийдвэрлээд унааны нэг талын зардалд 229.500 мянган төгрөг олгосон байсан. Би энэ мөнгийг нь банкнаас өөрөө хүлээн авсан /7-р хавтасны 203-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч Р.Агз-ны:...Би үе мөчний өвчний улмаас Казакстан улсад эмчлүүлэхээр 2010 онд явсан. Явахдаа тухайн үед Өлгий, Казакстан хотын хооронд явдаг байсан олон улсын автобусаар явсан. Казакстан хотод очоод үе мөчний хувийн эмнэлэгт 20 орчим хоног эмчлүүлсэн. Эмнэлгийн нэрийг нь мартсан байна. Тэгээд Баян-Өлгий аймагт ирснийхээ дараа ахмад настан оршин суугаа газраасаа хол газар эмчилгээ хийлгэсэн тохиолдолд унааны нэг зардлыг төрөөс нийгмийн халамж үйлчилгээний байгууллагаар дамжуулан авч болох тухай бусдаас сонссон болохоор Казакстанд эмчлүүлэхээр явсан унааны нэг зардлыг олж авахаар аймгийнхаа Нийгмийн халамж үйлчилгээний газарт өргөдөл бичээд эмчилгээ хийлгэсэн баримтаа хуулбарлан өгсөн. Тэр материалаа хэн ямар байцаагч ажилтанд өгснөө одоо санахгүй байна. Казакстан луу эмчилгээнд явахдаа А13 гэдэг маягт Өлгийн нэгдсэн эмнэлгээс авч явсан байсан юм. Тэгээд нийгмийн халамжийн газраас нэг талынх зардал гэж 70 гаран мянган төгрөг өгсөн. Тэр мөнгийг нь би авсан юм /7-р хавтасны 205-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч Ж.Сье: ...Би зүрх, баруун гарын ясны гэмтэл авч гэмтсэн тул Казакстан улсад эмчлүүлэхээр 2012 онд явсан. Явахдаа тухайн үед Өлгий, Казакстан хотын хооронд явдаг байсан микро автобусаар явсан. Казакстан хотод очоод хувийн эмнэлэгт 28 хоног хэвтэж эмчлүүлсэн. Эмнэлгийн нэрийг нь мартсан байна. Казакстанд эмчлүүлээд ирснийхээ дараа ахмад настан зайлшгүй тохиолдлоор гадаад улсад эмчилгээ хийлгэсэн бол унааны нэг зардлыг нь төрөөс нийгмийн халамж үйлчилгээний байгууллагаар дамжуулан нөхөн олгодог тухай бусдаас сонссон. Тэгээд Казакстанд эмчлүүлэхээр явсан унааны нэг зардлыг олж авахаар аймгийнхаа Нийгмийн халамж үйлчилгээний газарт Казакстан улсад эмчилгээ хийлгэсэн тул унааны нэг зардлыг олгоно уу гэсэн утгатай өргөдөл бичээд эмчилгээ хийлгэсэн баримтаа хуулбарлан өгсөн. Тэр материалаа ямар ажилтанд өгснөө одоо санахгүй байна.

Тэгээд нийгмийн халамжийн газраас унааны нэг талынх зардал,

иргэний хариуцагч Х.Май: ...Би чих, ходоодны өвтэй тул Казакстан улсад эмчлүүлэхээр 2011 онд онгоцоор явсан. Казакстан улсын Астана хотод очоод хувийн эмнэлэгт 14 хоног хэвтэж эмчлүүлсэн. Эмнэлгийн нэрийг нь мартсан байна. Казакстанд эмчлүүлээд ирснийхээ дараа ахмад настан, тэтгэвэрт суудаг иргэн гадаад болон дотоодод эмчилгээ хийлгэсэн бол унааны нэг зардлыг нь төрөөс нийгмийн халамж үйлчилгээний байгууллагаар дамжуулан нөхөн олгодог тухай бусдаас сонссон. Тэгээд Казакстанд эмчлүүлэхээр явсан унааны нэг зардлыг олж авахаар аймгийнхаа Нийгмийн халамж үйлчилгээний газарт Казакстан улсад эмчилгээ хийлгэсэн тул унааны нэг зардлыг олгоно уу гэсэн утгатай өргөдөл бичээд эмчилгээ хийлгэсэн баримтаа хуулбарлан өгсөн. Тэр материалаа ямар ажилтанд өгснөө одоо санахгүй байна. Тэгээд нийгмийн халамжийн газраас унааны нэг талынх зардал гэж надад 190 орчим мянган төгрөг өгсөн /7-р хавтасны 209-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч А.Ман:...Би харьяатаас яагаад гарсан шалтгааныг мэдэхгүй байгаа. 140.000 төгрөг илүү авсан гэдгээ би мэдэхгүй байна /7-р хавтасны 212-213-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Т.Бот:...Би харьяатаас гарсан зүйл байхгүй. Намайг харьяатаас гаргасан болохыг 2010 оны 10 дугаар сард мэдсэн. Би харьяатаас гарсан гэж бүртгэгдсэн 2010 оны 10 сараас 2012 оны 05 сарын хооронд хүний хөгжил сангаас огт мөнгө аваагүй байж байгаад 2012 оны 05 сард завсардсан хугацааны мөнгө болох 500 000 орчим мөнгийг хүний хөгжил сангаас авсан /7-р хавтасны 215-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Х.Уна:...Би даралт ихэсдэг өвчтэй тул эмчилгээ хийлгэхээр 2012 онд Казакстан улс руу хүү У.А-гийн хамт онгоцоор явсан. Хүү А-тай нь сэтгэл мэдрэлийн өвчтэй юм. Хүү бид 2 Астана хотын нэгдсэн эмнэлэгт очиж 20 орчим хоног эмчилгээ хийлгэсэн. Тэгээд эмчилгээ хийлгэж ирснийхээ дараа өндөр настан болон өвчтэй группэд байдаг хүмүүс гадаад болон дотоод улсад эмчилгээ хийлгэсэн бол унааны нэг талын зардлыг нийгмийн халамжийн байгууллагаас олгодог гэж дуулсан болохоор Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний газарт би өөрөө өндөр настай

хүү А-тай группэд байдаг бөгөөд гадаад улсад эмчилгээ хийлгэсэн тул унааны нэг талын зардлыг олгоно уу гэсэн утгатай өргөдөл бичээд эмчилгээ хийлгэсэн материалаа бүрдүүлээд аймгийнхаа нийгмийн халамж үйлчилгээний газрын дарга С-д гэх хүнд өгсөн. С-д өргөдөл дээр цохолт хийгээд өөр байцаагчид шилжүүлсэн. Тэр байцаагчийг хэн болохыг одоо санахгүй байна. Тэгээд 1-2 сарын дараа байх Нийгмийн халамжийн төв материалыг судалж үзээд мөнгө олгох боломжтой гэж шийдвэрлээд надад 198.000 төгрөг хүү А-тайд 140 орчим мянган төгрөг нийт 140 орчим мянган төгрөг өгснийг банкаар дамжуулан би өөрөө хүлээн авсан юм. Мөн 2012 оны 10-р сард Баян-Өлгий аймгийн нийгмийн халамжийн газарт Ахмад настан үзүүлэх хөнгөлт үйлчилгээний дагуу өргөдөл гаргаад 200.000 төгрөг авсан юм. Энэ мөнгийг Хаан банкны салбараас би өөрөө хүлээн авсан байгаа /7-р хавтасны 237-238 -р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч М.Асх-ын:...Би Баян-Өлгий аймгаас 1993 онд Казакстан луу гэр бүлээрээ нүүж амьдарч байгаад 1999 онд буцаж нүүж ирсэн. 2004 онд сумын иргэний бүртгэлтийн ажилтан намайг Монгол Улсын иргэн харьяалалгүй амьдарч байгааг хэлэхэд Монгол Улсын харьяат биш байна гэдгээ мэдсэн. 2013 онд 6 дугаар сарын зарлигаар Монгол Улсын иргэн болж харьяатаа сэргээлгэсэн боловч иргэний цахим үнэлэмлэхээ 2013 оны 08 дугаар сарын 15-ны өдөр авсан болохоор Ерөнхийлөгчийн сонгууль орж чадаагүй... Надад 140.000 төгрөг хүний хөгжил сангаас илүү олгогдсон талаар ойлгохгүй байна /8-р хавтасны 2-3-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч З.Алм-ын:...Би Баян-Өлгий аймгаас 1993 онд Казакстан луу гэр бүлээрээ нүүж амьдарч байгаад 1999 онд буцаж нүүж ирсэн. 2004 онд сумын иргэний бүртгэлийн ажилтан намайг Монгол улсын иргэн харьяалалгүй амьдарч байгааг хэлэхэд Монгол Улсын харьяат биш байна гэдгээ мэдсэн. 2013 онд 6 дугаар сарын зарлигаар Монгол Улсын иргэн болж харьяатаа сэргээлгэсэн боловч иргэний цахим үнэлэхээ 2013 оны 08 дугаар сарын 15-ны өдөр авсан болохоор Ерөнхийлөгчийн сонгууль орж чадаагүй...Надад 140.000 төгрөг хүний хөгжил сангаас илүү олгогдсон талаар ойлгохгүй байна...нөхөр бид 2-т илүү олголт хийгдсэн 280.000 төгрөгийг надаар төлүүлэх шаардлага тавьж байгааг нь ойлгож байна.

Хүлээн зөвшөөрөхгүй байна /8-р хавтасны 4-5-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч М.Улб-ын:...Би одоо Монгол улсад иргэний харьяат биш. Намайг 1995-03-21 нээс хойш иргэний харьяатаас хассан байсан... одоо 500.000 төгрөгийг буцааж төл гэсэн шаардлага тавьж байгаа асуудлыг ойлгож байна...гэхдээ би энэ мөнгийг төлж чадахгүй... /8-р хавтасны 6-7-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Х.Хад:...Би 2012 онд иргэний харьяатаас гарсан байсан. Энэ асуудлыг би өөрөө мэдээгүй байсан... гэхдээ 140.000 төгрөгийг илүү олгосон гээд нэхэмжилж байгаа нь сайн ойлгохгүй байна. Энэ мөнгийг төлөхгүй /8-р хавтасны 8-9-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч Х.Рах:...надад 140.000 төгрөг илүү олгогдсон асуудлыг сайн ойлгохгүй байна. 140.000 төгрөг нэхэмжилж байгааг хүлээн зөвшөөрөхгүй байна /8-р хавтасны 10-11-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ш.Ари-ын:...Би өөрөө элэг цөс, эхнэр А.Улб үе мөчний өвчтэй тул хамт Казакстанд эмчилгээ хийлгэхээр 2011 оны 2-р сард онгоцоор явсан. Казакстаны Астана хотын эмнэлэгт эхнэр бид хоёр 12 хоног эмчилгээ хийлгэсэн юм. Тэгээд ирсэн хойноо Баян-Өлгийн аймгийн нийгмийн халамжийн төвд эхнэр бид 2 Казакстан явсан унааны баримт, эмчилгээний зардлаа хавсаргаад унааны нэг талын зардал олгоно уу гээд өргөдөл бичээд өгсөн. Нийгмийн халамжаас эхнэр бид 2-т тус бүрт 240.000 төгрөг олгосон /8-р хавтасны 15-17-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч Х.Нау-ын:...Би 2011 онд Казакстан улсын нэгдсэн эмнэлэгт очиж дотор эрхтэнд эмчилгээ хийлгээд буцаж ирсэн юм. Тэгээд эмчилгээ хийлгэж ирсний дараа хотоос хол оршин суудаг иргэд жил нэг удаа эмчилгээ хийлгэхдээ унааны нэг талын зардлыг авч болдог гэдгийг сонссон байсан болохоор Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний төвд эмчилгээ хийлгэсний унааны зардал олгоно уу гэсэн өргөдөл бичээд Казакстан улсад эмчлүүлсэн материалаа хуулбарлаад өгсөн. Тэр материалыг нийгмийн халамжийн ямар ажилтанд материалаа өгч байснаа одоо санахгүй байна. Тэгээд ямар ч байсан аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний төвөөс миний хүсэлтийг шийдвэрлээд унааны нэг талын зардалд 132.500 төгрөг олгохоор болсон байсан. Би энэ мөнгийг

өөрөө хүлээн авсан /8-р хавтасны 18-19-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Н.Лаз-ын:... Манай ээж С.Ш 2011 онд Казакстан улсын нэгдсэн эмнэлэгт очиж дотор эрхтэнд эмчилгээ хийлгэсэн юм. Эмчилгээ хийлгэж ирсний дараа нь би ахмад настай хүн эмчилгээ сувилгаа хийлгэхээр явахдаа унааны нэг талын зардлаа авдаг гэдгийг хүмүүсээс сонссон болохоор Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний төвд ээжийн эмчилгээ хийлгэсний унааны зардлыг олгоно уу гэсэн өргөдөл бичээд Казакстан улсад эмчлүүлсэн материалыг хуулбарлаад өгсөн. Тэр материалыг тухайн үед нийгмийн халамжийн ямар ажилтанд материалаа өгч байснаа одоо санахгүй байна. Тэгээд аймгийн нийгмийн халамжийн үйлчилгээний төвөөс миний хүсэлтийг хүлээн авч манай ээжид унааны нэг талын зардалд 190.000 төгрөг олгосон юм. Гадаад улсад эмчилгээ хийлгэсний улмаас нийгмийн халамжаас мөнгө өгдөггүй болохыг ойлгож мэдлээ. Тухайн үед халамжийн ажилтнууд энэ асуудлаа нэг мөр болгож шийдсэн бол одоо энэ асуудал яригдахгүй байх байсан. Би Халамжийн ажилтнуудын алдаатай үйлдэл гэж бодож байна. Би энэ мөнгийг шүүхээс төл гэж шийдвэл төлөх болно /8-р хавтасны 20-22-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч А.Хам-ын:...Би 2012 оны 08 дугаар сард Казакстанд байдаг 2 дахь хүү Б дээр очихоор болсон тул гадаад паспорт авахаар Баян-Өлгий аймгийн иргэний бүртгэлийн албанд хандсан чинь харьяатаас гарсан байх тул гадаад паспорт олгох боломж байхгүй гэсэн хариу өгсөн. Энэ үед харьяатаас хасагдсан байгаагаа мэдсэн. надад 140.000 төгрөг хүний хөгжил сангаас илүү олгогдсон гэх асуудлыг хүлээн зөвшөөрөхгүй. Би олон хүүхэдтэй өрх толгойлсон эмэгтэй, 140.000 төгрөг төлж чадахгүй. Би төлөх ёсгүй гэж бодож байна. Харин ч намайг зүгээр амьдарч байхад иргэний харьяатаас гаргасан албан тушаалтанд зохих хариуцлага хүлээлгэх хэрэгтэй байх. Нийгмийн халамж, иргэний бүртгэлийн ажилчид хариуцлагагүй байгаагаас энэ асуудал гарч байна гэж бодож байна /8-р хавтасны 23-24-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Б.Ахб-ын:...140.000 төгрөг би илүү авснаа мэдэхгүй. Ямар ч байсан би энэ мөнгийг төлөх ёсгүй /8-р хавтасны 31-32-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Р.Боп-ын:...Нийгмийн

халамжаас эхнэр бид 2-т тус бүрт 240.000 төгрөг олгосон. Ахмад настанд хөнгөлөлт үзүүлэх тухай хуульд гадаад улсад эмчилгээ хийлгэхэд унааны нэг талын зардал олгох талаар заагаагүй болохоор эхнэр бид 2-оос дээрх мөнгийг төлүүлэхээр шаардаж байгааг ойлгож байна. Энэ мөнгийг төл гэсэн эцсийн шийдвэр хуулийн байгууллагаас гарвал эхнэр бид 2 төлнө /8-р хавтасны 38-39-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Р.Есе-ын:...Хүний хөгжил сангаас сар бүр олгож байсан мөнгийг авч байсан...140.000 төгрөг илүү олгогдсон гэх асуудал болж цаанаас олгож байсан байгууллага ажилтан нар л мэдэх асуудал байх. Надаас буцааж 140.000 төгрөг нэхэмжилж байгааг хүлээн зөвшөөрөхгүй. Буцааж төлөхгүй. /8-р хавтасны 45-46-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч С.Хал-ын:...Би 2012 онд Баян-Өлгий аймагт орон нутгийн сонгууль өгөхөөр очиход сонгуулийн бүртгэл хөтөлж байсан ажилтан намайг иргэний харьяатаас гарсан байна гэхэд нь МУ-д иргэний харьяатгүй болсноо мэдсэн. хүний хөгжил сангаас надад 140.000 төгрөг яагаад илүү олгогдсоныг мэдэхгүй байна. Би өгч байсан мөнгийг нь л авч байсан. Нэгэнт шалгалтаар илүү олгогдсон тогтоогдож байгаа бол буцааж төлөх л байх /8-р хавтасны 47-48-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Х.Ерк-ын:...Миний төрсөн дүү Х.Нур нь мөн адил надтай хамт харьяат нь сэргэж хүний хөгжил сангийн мөнгийг нь олгосон. Дүү Нур нь цэрэгт байдаг бөгөөд одоо Африкийн Судан улсад энхийг сахиулах ажиллагаанд оролцохоор явсан байгаа тул өөрөө мэдүүлэг өгөх боломжгүй байгаа. Надад болон ээж аав дүү бид нарт 140.000 төгрөг илүү олгогдсон гэх асуудлыг сайн ойлгохгүй байна. Надаас болон дүүгээс энэ мөнгийг нэхэмжилж байгааг төлөх ёсгүй гэж бодож байна. Гэхдээ 140.000 төгрөгийг хуулийн байгууллагын эцсийн шийдвэрээр төл гэх юм бол өөрт оногдох хэсгийг төлж барагдуулах л байх /8-р хавтасны 49-52-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Е.Хай-ын:...Би 2008 онд байх иргэний үнэмлэхээ авахаар бүртгүүлсэн чинь намайг харьяатаас гарсан байна гэсэн. Хэзээ яагаад харьяатаас гарсан болохоо мэдээгүй. Тэгээд 2013 онд Ерөнхийлөгчийн зарлигаар иргэний харьяат сэргэж 2013-08-14 нд цахим үнэмлэхээ Баян-Өлгий иргэний бүртгэлийн газраас очиж

авсан. Одоо бол иргэний харьяатын ямар нэг зөрчил байхгүй. Дээрх өгсөн хаяг дээрээ амьдарч байгаа. 140.000 төгрөг хүний хөгжил сангаас яагаад илүү олгогдсон болохыг сайн мэдэхгүй байна. Энэ мөнгийг би төлж чадахгүй. Надад өгөх ёстой мөнгийг би авсан гэж бодож байна /8-р хавтасны 53-54-р хуудас / гэсэн,

иргэний хариуцагч Д.Ерт-ын:... Миний төрсөн ах Д.Мур нь зуны улиралд Улаанбаатар хот руу хөлсний хар ажил хийгээд явчихдаг. Тодорхой оршин суух газар Улаанбаатар хотод байхгүй. Ажил хаана гарна тэр газар луу явчихдаг юм. Тийм болохоор өөрөө ирж мэдүүлэг өгөх боломжгүй байгаа юм. Би ахтай утсаар яриад би өмнөөс энэ хэрэг асуудалд оролцохоор болсон юм. Манай ах Д.Мур нь одоо МУ-ын иргэний харьяат байгаа. Мур 2012 онд сонгууль өгөх гээд очиход нь МУ-ын харьяатаас гарсан байна гэж хэлсэн байсан. Тэгээд харьяатгүй байж байгаад 2013 онд Ерөнхийлөгчийн зарлигаар харьяат нь сэргэсэн байгаа. Үндсэн хаяг нь Баян-Өлгий сумын ...р багийн задгайд эхнэр 3 хүүхдийнхээ хамт амьдардаг. Энэ хаяг дээрээ намар ажлаа дуусаад ирдэг юм. Ах Мур иргэний харьяатаас гарахаас өмнө хүний хөгжил сангаас өгч байсан мөнгийг авч байсан. Харин Мур-т 140.000 төгрөг хүний хөгжил сангаас илүү олгогдсон гэх асуудлыг мэдэхгүй байна. Илүү олгогдсон хяналт шалтгаанаар гарцаагүй тогтоогдож хуулийн байгууллагаас буцааж төл гэсэн шийдвэр гарвал төлөх болно /8-р хавтасны 57-58-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Д.Айб-ын:...М.Хуа, М.Бод нар эхнэр нөхөр юм. Хуа нь миний аавын төрсөн дүү юм. Хуа ахын хүүхдүүд нь Казакстанд амьдардаг. Хуа, Бод нар хөл муутай, одоо Баян-Өлгий аймгийн Алтай сумын Хар нуур гэх газар хөдөө байгаа юм. Энэ 2 хөгшин аймгийн төвд ирж энэ асуудлынхаа талаар мэдүүлж чадахгүй байгаа юм. Би энэ 2 хөгшинтэй ярилцаж тохироод өмнөөс энэ асуудалд иргэний хариуцагчаар оролцож зохих шийдвэрийг гаргах болно. Ах эгч хоёр 2011 онд Казакстан улс руу үе мөчний өвчнөө эмчлүүлэхээр явсан. Явахад нь би сумын эмнэлэг бусад газраас холбогдох материалыг бүрдүүлэн өгч байсан юм. Тэгээд энэ 2 эмчилгээ хийлгэж ирсний дараа Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамжийн газарт материалаа өгөөд Алтай сумын Хаан банкнаас 2-лаа нийлээд 150.000 төгрөг авч байсан. Би Хуа ахыг банк руу

дагуулан очиж мөнгийг авч өгч байсан юм. Хуа ах банкны баримт дээрээ өөрөө гарын гарын үсэг зурсан. Хуа, Бод нараас эмчилгээний зардалд нэхэмжилж байгаа мөнгийг нь зайлшгүй төлүүлэх шийдвэр гарвал төлж барагдуулна” /8-р хавтасны 59-67-р хуудас/ гэсэн,

иргэний хариуцагч Ш.Ерх-ын:... Миний ээж Х.Айс нь нуруу нугасны өвчтэй Булган сумын эмнэлэгт байгаа тул ирж мэдүүлэг өгөх боломжгүй байгаа юм. Би ээжтэйгээ ярилцаад ээжийнхээ өмнөөс энэ асуудалд иргэний хариуцагчаар оролцож байна...140.000 төгрөг хүний хөгжил сангаас илүү олгогдсон гэх асуудлыг сайн мэдэхгүй байна. Шалгалтаар тогтоогдож хуулийн байгууллагаас энэ мөнгийг буцааж төл гэж эцсийн шийдвэр гарвал төлж барагдуулах болно /8-р хавтасны 62-65-р хуудас/ гэсэн нэр бүхий иргэний хариуцагч нараас нийт 38.115.192 төгрөгийг гаргуулж улсын орлогод оруулах нь зүйтэй.

Мөн энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж битүүмжлэгдсэн байгаа 23.756.000 төгрөгийн үнэ бүхий 2935 ширхэг 5 төрлийн ортопедийг улсын орлого болгох нь зүйтэй.

Харин шүүгдэгч Я.С нь 2008-2012 онд Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, Халамжийн үйлчилгээний хэлтсийн даргаар ажиллаж байхдаа Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т заасан.хөл, гар, шүд (үнэт металлаар хийхээс бусад)-ний протез, сонсох, харах эрхтний ортопедийн хэрэгсэл худалдан авсан болон дотоодод хийлгэсэн зардлын үнийг 5 жил тутам нэг удаа нөхөн олгох,

Хөгжлийн бэрхшээлтэй иргэний Нийгмийн хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.4-т заасан ...18 хүртэлх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, ...хөгжлийн бэрхшээлтэй иргэний дотоодод хийлгэсэн болон худалдан авсан ортопед, тэргэнцэр зэрэг тусгай хэрэгслийн үнийг 3 жил тутам нэг удаа 100 хувь нөхөн олгох гэсэн заалтуудыг тус тус зөрчиж “ТЦ” ХХК-д ортопедийн хэрэгсэл захиалж мөнгийг нь халамжийн сангаас гаргуулж төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэргийг үйлдсэн,

Шүүгдэгч О.Ф нь тус аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний газрын Асрамжийн газрын зохион байгуулагчаар ажиллаж байхдаа шүүгдэгч Я.С-ийн захиалгаар “ТЦ” ХХК-ийн оруулж ирсэн ортопедийн

хэрэгслүүдийг сумдад тарааж мөнгийг нь бэлнээр буюу бэлэн бусаар хувийн дансаараа шилжүүлэн авч Я.С-д болон “ТЦ” ХХК-д шилжүүлснээр гэмт хэрэгт хамтран оролцож Я.С-тэй бүлэглэж төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэргийг үйлдсэн болох нь

гэмт хэргийн гомдол мэдээлэл гаргагч М.М-ийн: Өөрийн эхнэрийн төрсөн дүү болох н.Алт-ыг ажилд авсан. Н.Алт-ыг 2011 оны 02-р сард БНХАУ-ын Эрээн хот руу явуулж 1 сарын цалинтай чөлөө өгч явуулаад хямдхан тэргэнцэр, нүдний шил худалдан авч ирээд сумдад тараан мөнгийг нь өөрийн хүргэн О.Ф-ын дансаар сумдын халамжийн сангийн данснаас авсан. О.Ф-ын данснаас тэргэнцэр, нүдний шилний мөнгийг шилжүүлэн өгөөд 20,0 сая төгрөг Я.С О.Ф-оос авсан гэсэн яриа байдаг. Халамжийн мэргэжилтэн А.П, О.С нараас 2012 оны 03 дугаар сард энэ талаар асуухад зарим сумын халамжийн байцаагч нар тэргэнцэр, нүдний шил, таяг ирээгүй. Хуурамч баримт бүрдүүлээд мөнгийг О.Ф-ын дансаар авсан гэж ярьдаг. Зарим сумын байцаагч нар нүдний шил, таяг хүлээн аваад О.Ф-ын дансаар мөнгийг шилжүүлсэн гэж хэлдэг. “ТЦ” ХХК-ийн захиралтай хуйвалдан мөнгө данснаас гаргаж авдаг тухай яриа бий. /60-р хавтасны 5-6-р хуудас/ гэсэн,

2012 оны 08-р сарын 17-ны өдөр баримт бичигт үзлэг хийсэн тухай тэмдэглэлээр: Үүнд Иргэн О.Ф-оос “ТЦ” ХХК-аас нийлүүлсэн протез, ортопедийн санхүүгийн тайлан 2011 гэсэн нүүр хийсэн 30 хуудас баримт авч үзлэг хийв. Санхүүгийн баримтууд бүгд хуулбар хувиар байна Кассын тайланд: 75.130.000 төгрөгийн орлого, сумдад хүргэсэн тээврийн зардал 1 467 750 төгрөг, УБ хотоос Баян-Өлгий аймгийн тээвэрлэлт 4.000.000 төгрөг, ажлын хөлс 1.200.000 төгрөг, “ТЦ” ХХК-д 2011 оны 7-р сарын 7-ны өдөр 1.400.000 төгрөг, 2011 оны 08-р сарын 5-ны өдөр 1.400.000 төгрөг, 2011 оны 08-р сарын 24-ний өдөр 32,0 сая төгрөг, 2011 оны 10-р сарын 05-ны өдөр, 11-р сарын 07-ны өдөр тус бүр 1,5 сая төгрөг шилжүүлсэн, 2011 оны 7-р сарын 20-ны өдөр 23.202.250 төгрөг, 11-р сарын 19-ний өдөр 500.000 төгрөг, 11-р сарын 20-ны өдөр 6.960.000 төгрөг бэлнээр тушаасан тайлан хийж баримтуудыг хавсаргасан байна. /60-р хавтасны 59-60-р хуудас/,

Хөрөнгө битүүмжилсэн тэмдэглэл: ...Нийт 23.756.000 төгрөгийн үнэлгээтэй 2935 ширхэг 5 төрлийн ортопедийг битүүмжилсэн

тэмдэглэл, фото зургаар / 60-р хавтасны -ийн 213-221-р хуудас/,

О.Ф-оос гаргаж өгсөн “ТЦ” ХХК-ийн 2012 оны тайланд авагдсан 2012 оны 06-р сарын 30-ны өдрийн Бэлэн мөнгөний гүйлгээний тайланд тусгагдсан 15.440.000 төгрөгийн орлого зарлагын баримтуудаар /61-р хуудасны ийн 57-99-р хуудас/,

О.Ф-оос гаргаж өгсөн “ТЦ” ХХК-ийн 2011 оны тайланд авагдсан ...2011 оны 12-р сард сумдад нийлүүлсэн 74.630.000 төгрөгийн 5 төрлийн ортопедийн бүтээгдэхүүний бэлэн мөнгөний гүйлгээний тайлан, 74 630 000 төгрөгийн орлого зарлагын баримтуудаар /61-р хавтасны 100-182-р хуудас/,

“ТЦ” ХХК-ийн захирал А.Нар-аас гаргаж өгсөн тус компанийн Татварын газарт гаргаж өгсөн гэх 2011, 2012 оны санхүүгийн тайлан, тус компанийн ХААН банкин дахь депозит дансны дэлгэрэнгүй хуулгаар /61-р хавтасны 189-245-р хуудас/,

А.Нар-ын ХААН банкин дахь Депозит дансны дэлгэрэнгүй хуулгууд: 2011 оны 07 дугаар сарын 07-ны өдөр Я.С-ээс 1.400.000 төгрөгийн орлого, 2011 оны 08-р сарын 5-ны өдөр О.Ф-оос 1.400.000 төгрөг, 2011 оны 08 дугаар сарын 24-ний өдөр О.Ф-оос 32.000.000 төгрөгийн орлого хийсэн ба тухайн өдөр 30.000.000, 2 000 000 2 хувааж зарлага хийж буцаан гаргасан, 2011 оны 08 дугаар сарын 31 -нд Я.С-ээс О.Ф гэж 10.000.000 төгрөгийн орлого хийгдсэн, 2011 оны 10-р сарын 5-ны өдөр О.Ф-оос 1.500.000 төгрөг, 2011 оны 11 дүгээр сарын 7-ны өдөр О.Ф-оос 1500 000 төгрөг, 2012 оны 1 дүгээр сарын 26-ны өдөр О.Ф-оос 1000 000 төгрөг, 2012 оны 1-р сарын 31-ний өдөр О.Ф-оос 500 000 төгрөг, ман өдөр О.Ф-оос 1.500.000 төгрөг, 2012 оны 05 дугаар сарын 25-ны өдөр О.Ф-оос 500.000 төгрөг, 2012 оны 05 дугаар арын 29-ний өдөр О.Ф-оос 1.000.000 төгрөг, 2012 оны 07 дугаар сарын 10-ны өдөр О.Ф-оос 100.000 төгрөг, 2012 оны 07-р сарын 18-ны өдөр Я.С-ээс 400.000 төгрөгийн орлого хийсэн /62-р хавтасны 156-159-р хуудас/ баримтууд,

Сумдын ХХҮХ-ийн ажил хариуцсан мэргэжилтэн нараас ортопедийн үнийг шилжүүлсэн банкны депозит дансны дэлгэрэнгүй хуулга /63-р хавтасны 43-188-р хуудас/,

Сумдын ХХҮХ-ийн ажил хариуцсан мэргэжилтэн нараас ортопед үнийг О.Ф-д шилжүүлсэн банкны депозит дансны дэлгэрэнгүй хуулга /62-р хавтасны 216-217-р

хуудас/,

гэрчээр Б.Айн-ийн: аймаг дээр ирээд ачаагаа хаана буулгах талаар ачаа ачуулсан хүнээс утсаар асуухад Асрамжийн газар дээр буулгачих гэж хэлсэн. Асрамжийн газрын гадаа очих үед О.Ф гарч ирээд ачааг хүлээн авсан. Одоо санаж байгаагаар 5000 ширхэг нүдний шил, таяг 5500 ширхэг, бас нэг төрлийн таяг 70 ширхэг, мөн нэг төрлийн таяг нь 60 ширхэг, тэргэнцэр 200 ширхэг байсан санагдаад байна... /64-р хавтасны 27-28-р хуудас/

гэрчээр А.Ав-ийн: ...Багийн нийтийн хурал дээр Халамжийн чиглэлээр таяг, нүдний шил үнэ төлбөргүй өгдөг гэсэн, таяг, нүдний шил олгуулж өгнө үү гэсэн хүсэлт гаргасан. Халамжийн байцаагч үнэгүй олгодог гэхээр нь албан бичиг хийж өгсөн. Үнэ төлбөргүй өгдөг юм байна гэж ойлгосон учир албан бичиг Аймгийн ХХҮХ-т хүргүүлсэн... /64-р хавтасны 78-79-р хуудас/

гэрчээр А.Нар-ын:...Я.С дарга надтай уулзах үедээ манай аймагт тэргэнцэр, таяг, нүдний харааны шилний хэрэгцээ байна. Ийм зүйл нийлүүлдэг хүн байвал холбож өгөөч гэж хэлсэн. Би БНХАУ-ын Эрээн хотоос шүдний эмнэлэгт ариутгалын багаж авахаар явах үедээ тэргэнцэр, таяг, нүдний шилний үнэ судлан үзсэн. БНХАУ-ын Эрээн хотод явж байхад нүдний шил, таяг, тэргэнцэр нийлүүлдэг хүмүүстэй уулзсан. Тэр хүмүүс мөнгийг нь шилжүүлбэл Улаанбаатар хотод хүргэж өгнө гэж ярьж байсан. Улаанбаатар хотод ирээд Я.С даргатай утсаар ярихад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгох тэргэнцэр, таяг, нүдний шилний судалгаа гарсан. Танай эмнэлэг боломжтой бол нийлүүлээч гэж ярьсан. Би Я.С-ээс тэргэнцэр, таяг, нүдний шилний тоог аваад БНХАУ-ын Эрээн хот руу захиалга өгсөн. БНХАУ-ын Эрээн, Дорноговь аймгийн Замын-Үүд суманд амьдардаг н.Га гэж залууд захиалга өгөн 20.0 сая төгрөг хувиасаа шилжүүлсэн. Улаанбаатар хотод 3 сарын дараа бараа материал увж цуван ирсэн. Би барааг худалдан авах 20.0 сая төгрөг, портер хөлслөх, зардал, ачаа ачдаг хүмүүсийн зардлыг хувиасаа төлсөн. 20 орчим сая төгрөг надад дансаар шилжүүлэн өгсөн. О.Ф надаар кассын орлогын баримт, нэхэмжлэх гарын үсэг зуруулан аваад явсан. О.Ф гэж хүнээс нэг ч төгрөг бэлнээр аваагүй... О.Ф, Я.С гэж хүмүүс миний хувийн Хаан банкны дансруу таяг, тэргэнцрийн үнэ гэж шилжүүлдэг байсан. Миний Хаан болон

Голомт банкин дахь дансаар 22.200.000 мянган төгрөг шилжин орж ирсэн. Үүнээс гадна 2011 оны 08 дугаар сарын 24-ний өдөр О.Ф-оос 32 сая төгрөг Хаан банк дахь дансаар шилжин орж ирсэн. Энэ мөнгө юу юм болоо гэж бодож байтал Я.С миний утас руу залгаад Улаанбаатар хотод байр авах гэж байна. Чиний данс руу 32.0 сая төгрөг шилжүүлсэн. Хүүд маань мөнгийг гаргаад өгөөрэй гэж хэлсэн. Би Богд-Ар хороололд байдаг Хаан банкин дээр Я.С-ийн хүү болон бэртэй уулзаж 30.0 сая төгрөгийг данснаас гаргаж өгсөн. Я.С-ийн хүү таны дансаар 32.0 сая төгрөг шилжүүлсэн гэж аав хэлсэн. 2.0 сая төгрөг дутуу байна гэхээр нь 2.0 сая төгрөгийг данснаас дахин авч өгсөн /64-р хавтасны 91-94, 96-97-р хуудас/ гэсэн,

гэрчээр В.Ба-ийн: ...2011 оны 08 дугаар сарын орчим санагдаад байна. А.Нар төв шуудангийн ард байдаг үл хөдлөх хөрөнгийн бүртгэлийн газрын гадаа байж байна хүрээд ир гэж хэлсэн. Би яваад очтол Я.С даргын хүү, охин гэх 2 залуу, байр худалдаж байгаа гээд эрэгтэй эмэгтэй хүний хамтаар тавуулаа байж байсан. Миний машин дотор байрны эзэнд мөнгөө өгөлцөж авалцаж байсан. Мөнгөө өгөлцөж, авалцаад тооцоо дуусахаар нь А.Нар-д би хүний мөнгийг өөрийн дансаар оруулж гаргаад болж байгаа юм уу гэж зэмлээд өнгөрсөн...2011 оны 01 дүгээр сард А.Нар-тай хамт Баян-Өлгий аймагт явж байхад О.Ф гэж хүн шатахуун түгээх станц дээр ирээд кассын орлогын ордер, зарлагын ордер багцаар нь авч ирээд хоосноор нь гарын үсэг зуруулан тамга даруулсан. Би А.Нар-ыг яаж байгаа юм бэ хоосон баримтан дээр гарын үсэг зурж тамга дарж болохгүй, хувийг нь өөртөө авч үлд гэхэд Ногооннуур сум орж ирээд авна гэж хэлсэн. Аймаг дээр буцаж ирээд баримт аваагүй. Энэ баримтыг ашигласан гэж бодож байна. Одоогоос 7 өдрийн өмнө манай гэрт Я.С даргын охин баньд хоёр нь “ТЦ” ХХК-ийн 2011 оны тайлан, 2012 оны тайлан гэсэн 2 баримт гэрт хүргэж ирсэн. Баримтыг нь харахад кассын зарлагын ордер, кассын орлогын ордер дээр С.А.Нар-д мөнгө хүлээлгэн өгснөөр баримт хавсаргасан байсан. Тухайн цаг хугацаанд Баян-Өлгий аймагт байгаагүй учир хуурамч баримт болох нь нотлогдоно /64-р хавтасны 98-99-р хуудас/ гэсэн,

гэрчээр Ж.Му-ын: 2009 онд О.Ф асрамжийн газрын нярваар томилогдож би ХХҮХ-ийн нярваар томилогдсон. Өлгий сумын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй

иргэдэд тараан өг гээд таяг, нүдний харааны шил, тэргэнцрийг О.Ф надад хүлээлгэн өгсөн. Би О.Ф-оос хүлээн авсан таяг, нүдний шил, тэргэнцрийг Өлгий сумын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тараан өгч баримт бүрдүүлсэн. Тэргэнцэр, таяг, нүдний шилний үнийг хэзээ хэнд шилжүүлсэн болохыг мэдэхгүй. Өлгий сумын халамжийн сангийн дансны 1 дүгээр гарын үсгийг Я.С дарга өөрөө зурдаг учир энэ хүн мөнгийг хэнд шилжүүлсэн болохоо мэднэ /64-р хавтасны 147-148-р хуудас/ гэсэн,

гэрчээр А.Он-ын: ...О.Ф би болсон хэргийг үнэнээр хэлнэ. Таны хэлснээр мэдүүлэг өгөөд шоронд явах болоод байна гэхэд Я.С дарга үнэнийг чи хэзээ ч хэлж болохгүй шүү гэж О.Ф-д хэлснээ гараад яваад өгсөн.../64-р хавтасны хх-ийн 155-156-р хуудас/,

гэрчээр О.Сай-ийн: ...ах О.Ф танаас болж би хэрэгтэн болж байна. Я.С таныг “ТЦ” ХХК-д өгөх бүх мөнгийг авсан гэдгийг мөрдөн байцаагчид хэлнэ гэж хэлтэл Я.С тэгж болохгүй, үнэнийг ярьж болохгүй, мэдэхгүй гэж хэлээрэй ...үнэнийг мөрдөн байцаагчид хэлж болохгүй гэж хэлчхээд яваад өгсөн /64-р хавтасны 159-160-р хуудас/ гэсэн,

гэрчээр Н.Нур-ын: ...Халамжийн сангийн дансанд шилжүүлсэн мөнгөнөөс сумын иргэдэд олгох халамжийн мөнгийг олгоод илүү мөнгийг нь данснаас гарган авч Я.С даргаас өгсөн үүргийн дагуу мөнгийг О.Ф-д өгч байсан. 2011 оны 6-р сарын 17-ны өдөр манай сумын халамжийн дансанд Я.С дарга 2,0 сая төгрөг илүү шилжүүлсэн. Таяг, нүдний шил, тэргэнцрийн мөнгө байгаа юм гэж хэлсэн. Би чек бичиж 2 сая төгрөгийг аваад Я.С даргад өгсөн. Банкнаас мөнгө авах үед Я.С дарга надтай хамт явсан. О.Ф-ын гар утас руу залгаад надаас 2,0 сая төгрөг бэлнээр авснаа хэлсэн. Дараа нь О.Ф-оос 5 640 000 төгрөг хүлээлгэн өгснөөр баримт бичүүлэн авсан. 3 640 000 төгрөгийг О.Ф-ын хувийн дансанд шилжүүлсэн юм /64-р хавтасны 161-162-р хуудас/ гэсэн,

яллагдагчаар О.Ф-ын: ...Анх гэрчээр мэдүүлэг өгдөг өдөр Я.С намайг өрөөндөө дуудаад тэргэнцэр, таяг, нүдний шилний мөнгийг өөрөө сумдын байцаагч нараас цуглуулан аваад А.Нар гэж хүнд өгсөн гэж хэлээрэй. ...Өнөөдрийг хүртэл үнэнийг хэлж болохгүй гэж загнаад явж байгаа. Миний хувьд Я.С даргыг хуулийн дагуу тэргэнцэр, таяг, нүдний харааны шил “ТЦ” ХХК-аас авч байна гэж ойлгож байсан. Нярвын хувьд надаар сумдын халамжийн байцаагч

нарт тараалгаж байна гэж бодож явсан. Бүх сумдын байцаагч нарт “ТЦ” ХХК-ийн дансыг бичиж өгөөд байхад таяг, тэргэнцэр, харааны шилний үнийг миний хувийн данс болон надад бэлнээр авч ирж өгөхөд ихээр гайхсан. Я.С даргаас энэ мөнгийг яах юм бэ? гэхэд бэлэн мөнгийг орлогын ордер бичээд хүлээн ав. Дансаар болон бэлэн мөнгөөр хүлээн авсан мөнгөө тэр даруйд нь надад авч ирж өг гэж хэлж байсан. Би орж ирсэн мөнгийг шууд хүлээн аваад өөрийн бүртгэл дээр бүртгэн Я.С даргын өрөөнд мөнгийг хүлээлгэн өгдөг байсан. Мөнгийг Я.С хүлээн аваад энэ мөнгийг А.Нар-д шилжүүл гэж хэлдэг байсан. Өгсөн мөнгийг нь А.Нар-ын дансанд банкаар шилжүүлж байсан. А.Нард бэлнээр нэг ч төгрөг өгч байгаагүй. Я.С дарга Улаанбаатар хот явж ирээд А.Нар-аас авсан гээд А.Нар өөрөө тамга дарсан, гарын үсэг бүхий орлого зарлагын ордер, А4 хэмжээтэй цагаан цаасан дээр өөрөө гарын үсгээ зурсан тамгатай 1 ширхэг цаас зэргийг өгсөн. Я.С дарга бичигдсэн итгэмжлэл өгөөд одоо тайлан тааруулан бич гэж хэлсэн. Эхний 75.0 сая төгрөгийн тайлан бичих үед гарын үсэг тамга бүхий орлого зарлагын ордер ирүүлсэн. Би тайлан бичиж Я.С даргад өгсөн.

Я.С дарга тайланг А.Нар-д онгоцоор хүргүүлсэн. Би буруу бичээд орлого зарлагын ордер ашиглах боломжгүй болсон учир тайлан бичих хэрэгцээтэй орлого зарлагын ордер аваад А.Нар-ыг Ногоонуур сум явах гэж байхад нь гарын үсэг зуруулан тамга даруулан авсан. Ер нь хоосон орлого зарлагын ордер, цагаан цаасан дээр тамга дарж гарын үсгээ зурсан А.Нар-тын буруу байгаа гэж бодож байна. А.Нар-ын гарын үсэгтэй “ТЦ” ХХК-ийн тамгатай А4 хэмжээтэй цаасан дээр тооцоо нийлсэн актыг би бичсэн. Итгэмжлэлийг бол надад бичсэн байдлаар Я.С дарга өгсөн, Мөрдөн байцаалтын ажиллагаа эхэлсэн үед чамд тооцоо нийлсэн акт байхад чамайг хэн ч буруутгахгүй. Чи ажлаа зүгээр хийж бай гэж Я.С дарга хэлсэн. Тухайн үед даргын үгийг зөрөх эрх надад байгаагүй. Тооцоо нийлсэн акт гэж зүйл байдаг гэдгийг би мэдэхгүй шүү дээ Я.С даргын зааж өгснөөр Улаанбаатар хотод очиж мэдүүлэг өгөхөөсөө өмнө тооцоо нийлсэн актыг хувийн компьютер дээрээ бичсэн. Тэр хүртэл А.Нар гарын үсэг зурсан тамгаа дарсан цаас цагаанаар байж байсан. Тооцоо нийлсэн актыг бичсэн болохыг Я.С-ээс өөр хүн мэдэхгүй, компьютер дээрээ хадгалаагүй нь миний буруу боллоо. 2011

оны 08 дугаар сарын 24-ний өдөр Я.С даргын өрөөнд байж байтал 15.0 сая төгрөг хүү Е-д шилжүүл гээд мөнгийг өгсөн. Би мөнгийг авч яваад Хаан банкнаас Ес-нд 15.0 сая төгрөг шилжүүлсэн. Буцаад очтол 32.0 сая төгрөг тоолж өгөөд А.Нар гэж хүний дансанд шилжүүлээд ир гэж хэлсэн. Хэлснээр нь мөнгийг А.Нар гэж эмэгтэйн дансанд шилжүүлсэн. 2012 оны 08 дугаар сарын 31-ний өдөр Я.С даргатай хамт явж байтал Хаан банк дээр очоод 10.0 сая төгрөгийг А.Нар гэж хүнд шилжүүлсэн. Банкны ажилтан дарга бид хоёрыг явж байсан болохоор шууд О.Ф, Я.С-ээс гэсэн нэрээр гүйлгээг бичсэн байгаа. Банкнаас хуулга авч харвал шууд харагдана. Эдгээр хүмүүсийг хууль бус үйлдэл хийж байна гэж би мэдээгүй...Я.С даргын хэлснээр мөнгө бэлнээр болон дансаар орж ирсэн даруйд аваад өөрт нь хүргэж өгдөг. Я.С дарга мөнгийг аваад өрөөндөө байсан төмөр бичгийн шүүгэндээ хийдэг. Уг мөнгөнөөсөө хүүхдүүдэд дансаар шилжүүл гэж хэлдэг байсан / 64-р хавтасны 175-177, 66-р хх-ийн 84-86-р хуудас / гэсэн,

гэрчээр Х.Та-ын:...2009 оноос Хөдөлмөр, халамжийн мэргэжилтнээр ажиллаж байна... Асрамжийн газрын зохион байгуулагч О.Ф “ТЦ” ХХК-ийн нэрээр манай суманд 12 тэргэнцэр, нүдний шил 200 ширхэг, гар таяг 300 ширхэг, суга таяг 8 ширхэг, тохой таяг 4 ширхгийг өгсөн. Эдгээрийг нь хүлээн аваад сумын өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тараан өгсөн. Хөдөлмөр халамжийн хэлтсийн дарга Я.С өөрийн биеэр очиж нээлттэй хаалганы өдөр зохион байгуулсан юм. Дээрх бараа бүтээгдэхүүний үнэ болох 5760.000 төгрөгийг 2 удаагийн санхүүжилтээс гаргаж “ТЦ” ХХК-ийн төлөөлөгч О.Ф-ын дансанд шилжүүлэн өгсөн. 2012 оны 02 дугаар сард О.Ф 70 ширхэг нүдний шил 60 ширхэг гар таяг өгсөн. Эдгээрийг мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан хүмүүст тараан өгсөн. Мөнгийг нь халамжийн сангаас гаргаж О.Ф-ын хувийн дансанд шилжүүлэн өгсөн...Миний хувьд “ТЦ” ХХК-ийн дансанд ямар нэгэн мөнгө шилжүүлээгүй, О.Ф-ын Хаан банкны хувийн дансанд 2011 онд нь 5,760,000 төгрөгийг 2 хуваан шилжүүлсэн. 2012 онд болохоор 1 сая гаран төгрөгийг мөн л О.Ф-ын дансанд шилжүүлсэн...Харин манай сумын хөгжлийн бэрхшээлтэй иргэн ахмад наснаас илүү гарсан ортопед, протез ирснийг нь Ч.Ж байцаагчид хураалгасан /64-р хавтасны 40-41, 3-р хавтасны 162-163-р хуудас/ гэсэн,

гэрчээр Х.Аг-ын: ...2011 оны зун Я.С дарга миний гар утас руу залгаад таяг, тэргэнцэр, нүдний шил Улаанбаатар хотоос ирсэн. Асрамжийн газар дээр ирээд О.Ф гэдэг хүнээс ав гэж хэлсэн. Би нөхрийн хамтаар О.Ф гэж хүнээс 10 ширхэг тэргэнцэр, 200 ширхэг гар таяг, 200 ширхэг нүдний шил, 6 ширхэг суга таяг, 3 ширхэг тохой таяг авсан. 200 ширхэг таяг авах хүн суманд бараг байхгүй шүү дээ. Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй болгон таяг авахгүй шүү дээ. Тэргэнцрийг бол иргэд авсан. Одоо надад 1 ширхэг тэргэнцэр үлдсэн санагдаад байна. Таяг, нүдний шил зөндөө олон үлдсэн. Суга таяг, тохой таяг ч үлдэгдлээр байна. Рш гэж хүн манай суман дээр ирж тоолоод явсан. +3, +4 гэсэн харааны шилийг хэн авах юм бэ, хүн бүр нэмэх хасах +3, +4 шилийг зүүхгүй, ахмад настан болгон таяг тулахгүй нь ойлгомжгой шүү дээ. Өнөөдөр үлдэгдэл байгаа бараагаа тоолж танд тоог хэлнэ. 2012 оны эхээр гар таяг 40 ширхэг, 38 ширхэг нүдний шил авсан. Ортопедийн бараа бүтээгдэхүүнийг хүлээн авсны дараа Я.С дарга миний гар утас руу залгаад авсан барааныхаа үнийг О.Ф-ын данс руу Халамжийн сангаас хий гэж хэлсэн. Нэг сарын халамжийн сангийн санхүүжилт ойролцоогоор 8 сая төгрөг хуваарилагдан ирдэг. Мөнгийг бүгдийг нэг доор гаргахаар тухайн сард, зарцуулах мөнгө үрэгдэх, дутагдах учир 2 сарын санхүүжилтээс ортопедийн мөнгийг гаргаж О.Ф-ын дансанд шилжүүлсэн байгаа.

2014.04.09-ний дахин байцаалтаар: Би одоо Бугат сумыг хариуцсан халамжийн мэргэжилтэн. Энэ сумын 1997 оноос эхлэн хариуцан ажиллаж байна...2011 онд бэлнээр 4 сая төгрөгийг О.Ф-д бэлнээр өгсөн, дараа нь 2012 онд О.Ф-ын Төрийн банкны хувийн дансаар 2 удаа нийтдээ 750,000 төгрөгийг шилжүүлсэн. Энэ мөнгийг өгөхгүй гэж нилээд үзэхэд намайг хэлтсийн дарга Я.С чи ганцаараа үлдчихлээ яах гээд байгаа юм бэ гэхээр нь би та хууль зөрчиж байна шүү дээ гэтэл би мэдэж байна чи мөнгө хурдан шилжүүл чи дарга юм уу би дарга юм уу гэх мэтээр дарамталсан. Уул нь бол хуулиараа иргэд өөрсдөө баримтаа бүрдүүлэн өгч бид түүнийг нь санхүүжилтээс олгох ёстой. Гэтэл шууд жагсаалтаар тараасан нь буруу. Ямар нэгэн албан ёсны судалгаа тоо баримт нэхэмжлэлийг үндэслэн захиалга өгсөн зүйл байхгүй. Шууд жагсаалтаар сумдуудад хуваарилан өгсөн. Я.С дарга надад хэлэхдээ асрамжийн газар ортопед, протез ирсэн

тэрнээс ав гэсэн. Би уул нь авахгүй гэж байтал чи ганцаараа үлдчихлээ гэх мэтээр шахаад болохгүй байсан юм /64-р хавтасны 54-55, 3-р хх-ийн 166-р хуудас /

гэрчээр Ш.Ер-ийн:...2011 оны 6 дугаар сард Я.С дарга яриад бүх сумдад нэгдсэн журмаар тэргэнцэр, таяг, суга таяг, нүдний шил ирсэн. Сум бүрт хуваарилалт хийсэн байгаа. Аймаг дээр ирээд О.Ф-оос аваарай гэж хэлсэн. Би сумаас явж байгаа жолооч нарт захиад авсан. 15 ширхэг тэргэнцэр, 300 ширхэг гар таяг, 300 ширхэг нүдний шил, 4 ширхэг суга таяг, 3 ширхэг тохойтой таяг авсан, 2012 оны 01 дүгээр сард О.Ф дахин 70 ширхэг гар таяг, 60 ширхэг нүдний шил нэмж өгсөн. Одоо гэрт хадгалаад байж байна. Анх өгсөн гар таяг, нүдний шилний үлдэгдэл байгаа. Яг хэдэн ширхэг байгааг хэлж мэдэхгүй байна. Маргааш өдөр гэхэд үлдэгдлийн тооцоо хийнэ. Дээрх ортопедийн бүтээгдэхүүний үнийг сумын халамжийн сангийн данснаас гарган О.Ф болон "ТЦ" ХХК-ийн дансанд шилжүүлсэн. 2011 оны 6 дугаар сард Я.С дарга Улаанбаатар хотод явж байна."ТЦ" ХХК-д мөнгийг нь шилжүүл гэж хэлсэн. Би "ТЦ" ХХК-ийн дансыг мэдэхгүй гэхэд Голомт банкны дансны дугаар хэлсэн. Би даргын хэлсэн дансанд 3.0 сая төгрөг шилжүүлэн өгсөн. Бусад мөнгийг О.Ф-ын хувийн дансаар шилжүүлэн өгсөн /64-р хавтасны 46-47, 50-51-р хуудас/ гэсэн,

гэрчээр Р.Ры: 2011 оны 5 дугаар сард О.Ф, Алт нар миний гар утас руу залгаад танай суманд тэргэнцэр, таяг, нүдний шил хуваарилаад байна. Та ирж аваарай гэж нэлээн олон удаа утсаар ярьсан. 2011 оны 5 дугаар сарын 15-ны өдөр О.Ф зарлагын баримт бичээд тэргэнцэр 10 ширхэг, гар таяг 250 ширхэг, нүдний шил 200 ширхэг, суга таяг 3 ширхэг, тохой таяг 4 ширхэгийг надад хүлээлгэн өгсөн. Тэргэнцэр 150.0 төгрөгийн, гар таяг 8000 төгрөгийн, нүдний шил 6000 төгрөгийн, тохой таяг, суга таяг 30.0 мянган төгрөгийн үнэтэй байсан. Мөнгийг нь сумын халамжийн сангийн данснаас (6, 7 дугаар сарын) санхүүжилтээс өгсөн. 2012 оны эхээр 40 ширхэг нүдний шил, 60 ширхэг гар таяг өгсөн. Мөнгийг нь мөн халамжийн сангаас гаргаад өгсөн О.Ф-д шилжүүлэн өгсөн. Одоо 49 ширхэг таяг, 30 ширхэг нүдний шилний үлдэгдэл байна.

2014 оны 04 дүгээр сарын 8-ны өдрийн дахин байцаалтаар: Би одоо Алтай сумыг хариуцсан халамжийн мэргэжилтэн. Энэ сумын 2009 оноос эхлэн хариуцан ажиллаж

байна. 2011, 2012 онд миний хувьд “ТЦ” ХХК-ийн дансанд ямар нэгэн мөнгө шилжүүлээгүй, О.Ф-ын дансанд 2011 онд 6 сая төгрөгийг 3 хуваан шилжүүлсэн, үлдсэн 2 сая төгрөгийг нь Я.С дарга манай сумын Засаг дарга н.Хан-аар дамжуулан аваад ир гэж хэлэн О.Ф-д Засаг дарга аймгийн төвд ажил дээр нь хүлээлгэн өгч О.Ф-оос баримт авсан байсан. Манай сумын халамжийн байгууллага, амжиргаа дэмжих зөвлөлөөс ямар нэгэн захиалга өгөөгүй байхад шууд жагсаалтаар аймгийн халамжийн хэлтсээс сумуудад тараасан. Ямар нэгэн бодит судалгаа авсан зүйл байхгүй. Улмаар эхлээд иргэдээс захиалга авч дараа нь олгох ёстой. Ингээд мөнгийг нь санхүүжилтээс гарган иргэдэд тараан баримт бүрдүүлэн өгсөн. Харин үлдэгдлийг өөр дээрээ хадгалж байгаад Ч.Ж байцаагчид хураалгасан. Халамжийн хэлтсийн дарга Я.С л тараан өгч мөнгийг нь яаралтай шилжүүл гэсэн үүрэг өгсөн /64-р хавтасны 50-51-р хуудас, 3-р хавтасны 174-175-р хуудас/ гэсэн,

гэрч Ш.Шү:...2011 оны 5 дугаар сард Я.С дарга надтай утсаар ярихдаа таяг, тэргэнцэр, суга таяг, нүдний харааны шил ирсэн О.Ф-оос ирж ав гэж хэлсэн. Баян-Өлгий аймаг дээр ирээд О.Ф-оос 300 ширхэг таяг, 250 ширхэг нүдний шил, 12 ширхэг тэргэнцэр, суга таяг 2 ширхэг, тохой таяг 2 ширхгийг хүлээн аваад өөрөө зардал гарган сумандаа хүргэсэн. Мөн 2012 оны 02 дугаар сард тайлан тушаахаар ирэх үед 80 ширхэг таяг, 80 ширхэг нүдний шил нэмж өгсөн. Энэ бүхнийг анх авах үедээ үнэгүй юм байна гэж ойлгосон. 2011 оны 6 дугаар сарын эхээр Я.С дарга тэргэнцэр, таяг, нүдний шилний мөнгийг сумын Халамжийн сангийн 6, 7 дугаар сарын санхүүжилтээс гаргаад явуул гэж хэлсэн. Төлөвлөгөөт санхүүжилт дутна шүү дээ гэхэд нэмэгдэл санхүүжилт хүргүүлсэн, нэмэгдэл санхүүжилтийг гаргаад явуул гэж хэлсэн. Би Я.С даргын хэлснээр 2011 оны 6 дугаар сарын 19-ний өдөр 3 сая төгрөгийг халамжийн сангаас гаргаж аваад О.Ф-д бэлнээр өгсөн. 7 дугаар сард халамжийн сангийн данснаас О.Ф-ын Хаан банк дахь хувийн дансанд үлдэгдэл мөнгийг шилжүүлсэн. 2012 онд авсан таяг, нүдний шилний мөнгийг О.Ф-ын дансаар шилжүүлэн өгсөн. Энэ албан бичгийг би санаж байна. Я.С дарга танай суманд нийлүүлсэн таяг, тэргэнцэр, нүдний шилний баримт бүрдүүлэх гэж байна. Чи Засаг даргадаа хэлж байгаад ийм утгатай албан бичиг хийгээд явуул гэж

хэлсэн. Би хэлснээр нь албан бичгийг бичиж Засаг даргаар гарын үсэг зуруулсан. Уг албан бичиг нь 2011 оны 12 дугаар сард бичигдсэн албан бичиг байсан.

“ТЦ” ХХК-ийн дансанд мөнгө шилжүүлсэн зүйл байхгүй. Бүх мөнгөө О.Ф-д өгсөн. Эхлээд 3 сая төгрөгийг О.Ф-ын ажлын өрөөнд бэлнээр дараа нь үлдсэн мөнгийг нь О.Ф-ын Хаан банкны нэрийн дансанд 3 хуваан шилжүүлсэн...сумаас хуулийн дагуу захиалга өгсөн зүйл байхгүй. Я.С дарга шууд ав гээд л тарааж өгсөн. Тарааж өгсөн хойноо Засаг даргаасаа ортопед, протез хэрэгтэй байна гэсэн бичиг хийлгэж ир гэхээр нь би Засаг даргаас бичиг авч хүргүүлсэн. Манай сум хол болохоор “ТЦ” ХХК-аас ирж шүд хийгээгүй. /64-р хавтасны 82-83-р хуудас, 3-р хавтасны 173-р хуудас/ гэсэн,

гэрчээр К.Бау-ы: ...Баян-Өлгий аймгийн Сагсай сумын хөдөлмөр, халамжийн мэргэжилтнээр 2008 оны 12 дугаар сараас хойш ажиллаж байна. Суманд халамжийн 6 данс байдаг. Сангийн хөрөнгийг хуульд заасан журмын дагуу зарцуулдаг. Хөрөнгийг зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Сагсай сумын Засаг дарга, 2 дугаар гарын үсгийг халамжийн мэргэжилтэн зурдаг журамтай. Сангийн хөрөнгийг банкаар дамжуулан олгодог. 2011 оны 6 дугаар сард шиг санагдаж байна. Асрамжийн газрын О.Ф утсаар яриад сумдад 3 төрлийн таяг, тэргэнцэр, харааны /нүдний/ шил ирсэн. Халамжийн газраас хуваарилалт хийсэн. Сагсай сумд хуваарилагдсан бараа материалыг ирж ав гэж хэлсэн. Энэ үед н.Алт халамжийн газраас яриад танай суманд таяг, нүдний шил, тэргэнцэр хуваарилаад байна. Асрамжийн газар дээр ирээд О.Ф-оос аваарай гэж утсаар хэлсэн.Тухайн ажлыг Алт би хариуцаж байгаа гэж хэлж байсан. Би Асрамжийн газар дээр ирээд бараа материалыг хүлээн авсан. Надад -4 -1, +4, +1 хүртэл үзүүлэлт бүхий 250 ширхэг нүдний шил, суга таяг 4 ширхэг, тохой таяг 5 ширхэг, гар таяг 250 ширхэг, тэргэнцэр 12 ширхгийг хүлээн авсан. Энэ бараа материалыг хүлээн аваад такси хөлслөн сумандаа хүргэсэн. Таксины мөнгийг өөрөөсөө төлөөд дараа нь үнэ төлбөргүй тэргэнцэр авсан 6 хүнээс таксины мөнгийг гаргуулан авсан. Нэг хүнээс 2500 төгрөг гаргуулан авсан. Тэргэнцрийг бүгдийг тараасан. Манай суманд тэргэнцэр авах шаардлага хангасан иргэд олон байсан. Нүдний шилээс 100 орчим ширхгийг, гар таягнаас 80 ширхгийг, суга таягнаас 3

ширхгийг хуульд заасан шаардлага хангасан иргэдэд олгосон. Эхний гар таяг авсан иргэдээс чанар муутай байна 3 хоноод хугарчихлаа, дахин нэгийг нэмж өг гэж ирсэн. Хуульд 5 жилд нэг удаа үнэ төлбөргүй олгох заалттай болохыг хэлээд явуулсан. Чанаргүй гэдгийг нь мэдсэн иргэд авахаа больсон. Багийн Засаг даргын тодорхойлолт, эмчийн бичиг, өөрийнх нь өргөдөл, өндөр настан болохыг нь иргэний үнэмлэхээр нь тодруулаад олголт хийсэн. Би үнэ төлбөргүй тараах юм байна гэж бодож анх ирсэн. Ирээд нүдний шил, тэргэнцэр таяг хүлээн авсан чинь нэхэмжлэх надад өгсөн. Би дотоод хяналтын байцаагч О.С, Халамжийн мэргэжилтэн А.П нараас тэргэнцэр нүдний шилний мөнгө төлөх юм уу гэж асуусан. Дээрх хүмүүс мөнгийг гарган өгч болохгүй. Хууль зөрчсөн асуудал болно гэж хэлсэн. О.Ф миний гар утас руу залгаад мөнгийг нь хурдан шилжүүл. Миний данс руу эсхүл бэлнээр өг гэж хэлсэн. Би мөнгийг гаргаж өгөлгүй нэлээн удаасан. Тэгтэл Хөдөлмөр, халамжийн хэлтсийн дарга Я.С өөрөө миний гар утасруу залгаад ортопедийн мөнгийг О.Ф-д өгөөрэй, компанийн хүмүүс нь мөнгөө нэхээд байна гэж ярьсан. Би “ТЦ” ХХК-ий дансанд шилжүүлэх үү гэхэд алга болж мэднэ О.Ф-д өг гэж хэлсэн. Би О.Ф-ын хувийн данс руу 1.570.000 мянган төгрөгийг Хаан банк дахь дансанд нь шилжүүлсэн. Я.С даргын хэлснээр 6 дугаар сарын санхүүжилтээс 2,0 сая төгрөг, 7 дугаар сарын санхүүжилтээс 2.0 сая төгрөгийг Халамжийн сангаас гаргаж бэлнээр О.Ф-д хүлээлгэн өгсөн. Мөнгийг халамжийн сангаас гаргаж өгөхгүй гэж бодож байсан. Тэгтэл бусад сумдын халамжийн байцаагч нарт мөнгө гаргаж ирүүлсэнгүй гээд Я.С дарга арга хэмжээ авлаа гэхээр нь айгаад мөнгийг О.Ф-д гаргаж өгсөн.

/2014.04.09 дахин/ Би одоо Сагсай сумыг хариуцсан халамжийн мэргэжилтэн. Энэ сумын 2009 оноос эхлэн хариуцан ажиллаж байна...”ТЦ” ХХК-ий дансанд мөнгө шилжүүлээгүй. О.Ф-д эхлээд 2 сая төгрөгөөр 2 удаа нийт 4 сая төгрөгийг ажлынх нь өрөөнд бэлнээр өгсөн. Үлдсэн мөнгийг 4 удаа таслан О.Ф-ын Төрийн банк, Хаан банкны дансаар нь шилжүүлсэн. 2011, 2012 онд Манай сумаас ямар нэгэн захиалга өгөөгүй. Шууд л хувиарлан тараасан. Ирж ав гэж Алт надад хэлсэн. Миний зүгээс ямар нэгэн захиалга өгсөн Засаг даргаас албан тоот авч өгсөн зүйл байхгүй. “ТЦ” ХХК нь суманд мөн хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настай

иргэдэд шүд хийн өгсөн энэ мөн л Я.С дарга зохион байгуулсан. Над руу Я.С дарга утсаар яриад эмч нар очно тосож аваад эмнэлэгт өрөө гарган өгч ажилд нь тусла. Мөн сумдын иргэдийг ирж үйлчлүүл гэж зар өг гэхээр нь би түүнийх нь дагуу ажилласан. Яг хэдэн иргэн хэдэн төгрөгийн ямар шүд хийлгэсэн талаар нь би мэдэхгүй. Санхүүжилт нь хэлтсээс гарсан. Би зарим хүнийг өөрсдөө ирсэн тохиолдолд хөгжлийн бэрхшээлтэй иргэн мөн гэж тодорхойлж өгч байсан өөр зүйл байхгүй. Манай сум одоогийн байдлаар ойролцоогоор 4813 орчим иргэнтэй үүнээс бүгд эх орны хувь хишиг авсан. Манай сумаас харьяатаас гарч хувь хишиг нэмэгдүүлэн авсан хүн байхгүй. 2013 оны эцсийн байдлаар хэлэхэд нийт 55 төрлийн үйлчилгээнд 457,826,695 төгрөгийг 1383 иргэнд олгосон байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд мөнгө зарцуулаагүй. 2009 онд 1 хүүхдийн 100,000 төгрөг давхар олгосон гэсэн үндэслэлээр Аудитын газраас акт тавиулж байсан /64-р хавтасны 29-32-р хуудас, 3-р хавтасны 172-р хуудас/,

гэрчээр Н.Нур-ы:...2011 оны 6 дугаар сарын орчим Я.С дарга миний гар утасруу залгаад тэргэнцэр, таяг, нүдний шил ирсэн. Чи аймаг дээр ирээд хувиар хийсэн ортопедийн бүтээгдэхүүнийг аваарай гэж хэлсэн. Би аймаг дээр ирээд О.Ф гэдэг хүнээс тэргэнцэр 10 ширхэг, гар таяг 300 ширхэг, нүдний шил 200 ширхэг, суга таяг 4 ширхэг, тохой таяг 4 ширхгийг надад хүлээлгэн өгсөн. Дээрх бараа материалыг сумандаа аваачаад хөгжлийн бэрхшээлтэй ахмад настан хүмүүст олгосон. Одоо ойролцоогоор 265 ширхэг таяг, 145 орчим ширхэг нүдний шил, 2 суга таяг үлдсэн. Нүдний шил нь +3, +4, -3, -4-тэй шилийг авах хүн байхгүй байна. 2012 оны эхээр О.Ф мөн таяг, нүдний шил нэмж өгнө гэж хэлсэн. Би таяг, нүдний шилийг авахаар ирэхэд араас чинь явуулна гэж хэлээд нэхэмжлэх, зарлагын баримт өгөөд явуулсан. Би нэхэмжлэхийн дагуу мөнгийг шилжүүлсэн. 2011 онд О.Ф-оос хүлээн авсан барааны үнийг Я.С дарга хурдан шилжүүл гэж хэлсэн. О.С, А.П нараас асуусан чинь хууль бус мөнгө шилжүүлэн өгч болохгүй гэж хэлсэн. Би Я.С даргад мөнгийг нь шилжүүлэхгүй гэж хэлтэл чамайг ажлаас гаргана гэж дарамтлаад байхаар нь халамжийн сангаас мөнгийг нь О.Ф-д шилжүүлэн өгсөн.

О.Ф нь Я.С даргын хамаатан. Намайг 2012 онд аймаг дээр ирсэн байхад 50 ширхэг гар таяг, 60 ширхэг нүдний шил өгнө. Мөнгийг

нь хурдан шилжүүлээрэй гээд нэхэмжлэх, зарлагын баримт өгч гарын үсэг зуруулсан. Тэгээд бараа материал авах гэтэл араас чинь явуулна гэсэн боловч өнөөдрийг хүртэл өгөөгүй байна. Мөн 2011 онд 250 ширхэг нүдний шилний баримт нь дээр гарын үсэг зуруулсан хэрнээ 200 ширхэг нүдний шил өгсөн. Үлдэгдлийг одоо болтол өгөөгүй байна.

2014.04.09 Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэст 2009 оноос хойш ажиллаж байгаа бөгөөд өдөр тутмын ажил маань Монгол хэл бичиг дээр явагддаг... 2011, 2012 онд Би “ТЦ” ХХК-ий дансанд ямар нэг мөнгө шилжүүлээгүй. Эхлээд 1 сая төгрөгийг бэлнээр Я.С дарга манай суманд ажлаар ирэхэд нь өөрт нь өгсөн. Энэ мөнгийг хүлээн авсан гэх баримтыг О.Ф-оос дараа нь авсан. Үлдсэн мөнгийг бүгдийг нь О.Ф-ын Хаан банкны нэрийн дансаар нь 3-4 удаа хуваан шилжүүлсэн. Манай сумаас ямар нэгэн захиалга өгөөгүй. Шууд л хэлтсээс тараан өгсөн. Уул нь бол иргэн өөрөө баримтаа бүрдүүлэн нэхэмжлэх ёстой гэтэл тэгээгүй. Тэгээд эдгээр ортопед, протезийг тараасны дараа араас нь Я.С дарга Засаг даргаасаа манай суманд ортопед, протез хувиарлан өгнө үү гэсэн албан бичиг авч өг гэхээр нь авч өгсөн. “ТЦ” ХХК нь манай суманд мөн хөгжлийн бэрхшээлтэй болон ахмад настай иргэдэд шүд хийн өгсөн үүнийг бас Я.С дарга л зохион байгуулсан ба надруу утсаар яриад танай суманд шүд хийх 2 эмч очно ажлын байрыг нь хангаад сумын иргэддээ зарлаарай гэхээр нь тэрийг нь хийсэн. Санхүүлт нь сумаас гараагүй хэлтсээс гарсан. Мөн би ямар нэгэн баримт бүрдүүлэн өгөөгүй. Эмч нар л өөрсдөө баримтаа бүрдүүлсэн. Миний зүгээс зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг тодорхойлон өгсөн. Манай сум одоогийн байдлаар ойролцоогоор 4700 орчим иргэнтэй үүнээс бүгд эх орны хувь хишиг авсан. 2013 оны эцсийн байдлаар хэлэхэд нийт 65 төрлийн үйлчилгээнд 560,005,647 төгрөгийг 1081 иргэнд олгосон байна. Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 3 сая төгрөг зарцуулсан /64-р хавтасны 52-53-р хуудас, 3-р хавтасны 171-р хуудас/ гэсэн,

гэрчээр М.Цэ-гийн:...Баян-Өлгий аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн Буянт сум хариуцсан халамжийн мэргэжилтнээр 2010 оны 8 дугаар сарын 18-ны өдөр томилогдсон. 2011 оны 5 дугаар

сард санагдаад байна. Я.С дарга манай суман дээр ирсэн. Я.С дарга машиндаа 1 ширхэг тохой таяг, 8 ширхэг тэргэнцэр, 250 ширхэг гар таяг, 200 ширхэг нүдний шил өгсөн. 2012 оны 03 дугаар сард 40 ширхэг нүдний шил нэмж өгсөн. Ямар учиртай таяг, тэргэнцэр, нүдний шил болох талаар Я.С даргад хэлэхэд Хөгжлийн бэрхшээлтэй, ахмад хүмүүст олгоод хуульд заасан баримтуудыг бүрдүүлэн ав гэж хэлсэн. 2011 оны 6 дугаар сард санхүүжилт суманд олгох үедээ Я.С дарга миний гар утасруу залгаад таяг, нүдний шил, тэргэнцрийн мөнгө бэлнээр халамжийн сангаас гаргаад явуул гэж хэлсэн. Угаасаа сар бүрийн санхүүжилт хүрэхгүй байсан мөнгийг шилжүүлэн өгөөгүй. Даргын ярихаар нь санхүүжилт дууссан гэж хэлсэн. 2011 оны 08 дугаар сард Я.С дарга өрөөндөө дуудаад танай сумын халамжийн санд танай суманд олгосон таяг, нүдний шил, тэргэнцрийн мөнгийг шилжүүлнэ. Энэ мөнгийг шууд О.Ф-ын дансанд шилжүүл гэж хэлсэн. Өрөөндөө О.Ф ахыг бас дуудаад надад Хаан банкны данс өгүүлсэн. Сумын халамжийн сангийн дансанд санхүүжилт орж ирсэн. Би 4.430.000 мянган төгрөг О.Ф-ын Хаан банк дахь дансанд шилжүүлэн өгсөн. 40 шилний үнийг 2011 оны 12 дугаар сард О.Ф-ын дансанд шилжүүлсэн.

Би үнэтэй гэдгийг нь мэдээд тэргэнцэр таягаа ав гэж Я.С-эд хэлсэн. Тэгтэл таяг, тэргэнцрийн мөнгө хийгээгүй гэдэг үндэслэлээр бус удирдах албан тушаалтантай зүй бус харьцсан гээд 3 сарын цалингийн 20 хувь хасах шийтгэл оногдуулсан. А.П, О.С нараас үнэтэй тэргэнцэр, таяг, нүдний шил тарааж болох юм уу гэхэд бид тэргэнцэр, таяг, нүдний шил тараах эрх байхгүй. Харин худалдан авсан иргэдэд хуульд заасны дагуу мөнгийг нь олгох ёстой гэж хэлсэн учир мөнгийг нь өгөхгүй, таяг, тэргэнцэр, харааны нүдний шилийг нь тараахгүй байгаад байсан юм. Одоо надад 131 ширхэг гар таяг, 179 ширхэг нүдний шил, 1 ширхэг тэргэнцэр үлдсэн. Тараасан эд зүйлийн баримтыг хуулийн дагуу бүрдүүлсэн. ...Надад 2011, 2012 онд “ТЦ” ХХК-руу мөнгө шилжүүлсэн нэг ч тохиолдол байхгүй. Би бэлнээр нэг ч мөнгө өгөөгүй О.Ф-ын Хаан банкны дансанд бүх мөнгөө 2 хуваан шилжүүлсэн.

манай сумаас албан ёсоор хуулийн дагуу иргэний баримт нэхэмжлэлийг үндэслэн захиалга өгсөн зүйл байхгүй шууд л хэлтсээс тараан өгсөн. Тэгээд мөнгийг нь

сумын халамжийн сангийн санхүүжилтээс гарган өгсөн /64-р хавтасны 66-67-р хуудас, 3-р хавтасны 170-р хуудас/ гэсэн,

Гэрч Б.Көк-ийн:....2009 оны 01 дүгээр сараас хойш Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Хөдөлмөр, халамж хариуцсан мэргэжилтнээр ажиллаж байна. “ТЦ” ХХК-ийн талаар мэднэ. 2011 оны 6 дугаар сард төлөөлөгч О.Ф гэдэг хүнээр дамжуулан 300 ширхэг таяг, 300 ширхэг нүдний шил, 20 ширхэг тэргэнцэр, суга таяг 8 ширхэг, тохой таяг 6 ширхгийг ирүүлсэн. 2011 оны 6 дугаар сард Халамжийн мэргэжилтэн Алтаншаш миний гар утасруу залгаад Улаанхус суманд 300 ширхэг таяг, 300 ширхэг нүдний шил, 20 ширхэг тэргэнцэр, суга таяг 8 ширхэг, тохой таяг 6 ширхгийг хуваарилаад байна. Та нар ирээд аваарай гэж хэлсэн. Би аймаг дээр ирж авч амжаагүй байтал О.Ф өөрөө УАЗ машинд ачин хүргэж өгсөн. Мөнгийг нь Хадгаламж банк дахь халамжийн данснаас гаргаж өгсөн. Нэг удаагийн санхүүжилт хүрэхгүй учир сар бүрийн санхүүжилтээс мөнгийг гаргаж О.Ф-д дансаар шилжүүлэн өгсөн. Хэдэн сарын хэдний өдөр мөнгийг шилжүүлсэн болохоо санахгүй байна. Өнөөдрийн байдлаар 36 ширхэг нүдний шил, 16 ширхэг таяг үлдэгдлээр байж байна. О.Ф 2012 оны эхээр 60 ширхэг гар таяг, 60 ширхэг нүдний шил нэмж надад өгсөн. Хүлээж аваад тараасан. Мөнгийг нь халамжийн сангаас гаргаж өгсөн.

2014.04.09 Би одоо Улаанхус сумыг хариуцсан халамжийн мэргэжилтэн. Энэ сумын 2009 оноос эхлэн хариуцан ажиллаж байна...”ТЦ” ХХК-ийн дансанд ямар нэгэн мөнгө шилжүүлээгүй. Алийг нь санахгүй байна. Гэхдээ эхлээд 3 сая төгрөг халамжийн сангаас гарган бэлнээр О.Ф-ын ажлын өрөөнд нь би өөрөө О.Ф-д өгсөн. Дараагийн мөнгийг нь О.Ф-ын дансаар нь бүгдийг нь шилжүүлсэн. Я.С дарга байс гээд л мөнгөө хурдан О.Ф-ын дансанд хий гэдэг байсан. Хаан банкны данс байсан. Албан ёсоор судалгаа нэхэмжлэлийг үндэслэн захиалга өгсөн зүйл байхгүй. Шууд тараан өгсөн. Тэгээд араас нь Засаг даргаасаа ортопед, протез хэрэгтэй гэсэн бичиг аваад ирээрэй гэж Я.С дарга хэлэхээр нь би тэр бичгийг Засаг даргаасаа авч өгсөн.../ 3-р хавтасны 169-р хуудас / гэсэн,

гэрчээр Ш.Ай-ийн:....2011 оны 5 дугаар сард О.Ф надад 8 ширхэг тэргэнцэр, 250 ширхэг гар таяг, 200 ширхэг нүдний шил, 2 ширхэг суга таяг, 2 ширхэг тохой таяг өөрөө хүргэж өгсөн. Эдгээрийг О.Ф-оос хүлээн

аваад ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд тараагаад өгсөн. Тарааж өгөөд хуульд заасан шаардлагын дагуу баримт бүрдүүлэн авсан. Дээрх эд хөрөнгийн үнийг сумын халамжийн сангийн данснаас О.Ф-д шилжүүлэн өгсөн. 2012 оны 01 дүгээр сард О.Ф дахин 60 ширхэг гар таяг, 60 ширхэг нүдний шил өгсөн. Таяг, нүдний шилний үнийг О.Ф-д шилжүүлэн өгсөн. Нэг ахмад настанд таяг, нүдний шил өгөхөд бусад нь дуулж ирээд аваад яваад өгсөн. Манай сумын настай иргэд бие биенээсээ сонсож байгаад хөдөөнөөс ороод ирдэг. Ирээд улсаас үнэгүй өгч байгаа юмыг хүргээд өгч чадахгүй байна уу гээд загнаад сууж байдаг хүмүүс шүү дээ

Би одоо Алтанцөгц сумыг хариуцсан халамжийн мэргэжилтэн. Энэ сумыг 2009 оноос эхлэн хариуцан ажиллаж байна. Одоо нарийн сайн он сарыг санахгүй байна. 2011 онд тараасан ортопедын мөнгийг сумын халамжийн сангаас бэлнээр нь гарган нийт 2 сая төгрөгийг О.Ф-д суманд ирэхэд бэлнээр нь өгсөн бусад мөнгийг бүгдийг нь О.Ф-ын хаан банкны дансаар нь шилжүүлсэн. Албан ёсоор тоо баримт гарган захиалга өгсөн зүйл байхгүй / 64-р хавтасны 44-45-р хуудас, 3-р хавтасны 167-р хуудас/ гэсэн,

гэрчээр Ч.Эрб-ы:....Халамжийн байгууллагад 2004 оноос хойш ажиллаж байна.Ахмад настны Нийгмийн хамгааллын тухай хуулиар 55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй хүмүүс таяг, нүдний шил, тэргэнцэр худалдан авах, хиймэл шүд

хийлгэх шаардлагатай болвол өөрөө үйлчилгээ аваад худалдан авалт хийсэн баримтаа өргөдлийн хамтаар халамжийн байгууллагад өгч үнийг нь харгалзан үзэлгүй тэргэнцэр, таяг, нүдний шил тараан өгөөд мөнгийг нь Халамжийн сангаас гаргасан асуудал бол дээрх хуулийг зөрчсөн асуудал /64-р хавтасны 129-130-р хуудас/ гэсэн,

гэрчээр Д.Га-ийн:....Халамжийн байгууллагад 1997 оноос хойш ажиллаж байна...Я.С таяг, нүдний шил, тэргэнцэр сумын халамжийн байцаагч нараар иргэдэд тараалгаж мөнгийг нь сумын ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө тэргэнцэр, таяг нүдний шилээ худалдан авах, дараа нь худалдан авалт хийсэн баримт эсхүл нэхэмжлэхээ үндэслэл болгон халамжийн сангаас мөнгөө гаргуулан авах хуультай. Ер нь иргэд өөртөө таарсан бүтээгдэхүүнийг худалдан авах нөхцөл бололцоог хангасан хууль байгаа юм.

Халамжийн байгууллага өөрөө худалдан авалт хийгээд иргэдэд, таяг, нүдний шил, тэргэнцэр тараан өгөх асуудал байхгүй /64-р хавтасны 131-133-р хуудас/ гэсэн тэдгээрийн мөрдөн байцаалтын шатанд мэдүүлсэн мэдүүлгүүд болон шүүхийн хэлэлцүүлэгт хэлэлцэгдэж шүүх шинжлэн судалсан бичгийн бусад баримтуудаар,

Шүүгдэгч А.Х нь Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэст нягтлан бодогчоор ажиллаж байхдаа төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэргийг үйлдсэн болох нь

гэрчээр Г.Э-н:...Би Хаан банкны дотоод аудитын газрын захирлын баталсан удирдамжийн дагуу Баян-Өлгий аймагт Хаан банкны харьяа салбар нэгжүүдэд аудитын үйл ажиллагааг аудитор Г.Л, З.Ц нарын бүрэлдэхүүнтэй явуулсан. Шалгалтаар Баян-Өлгий аймаг дахь Казак иргэдийн Монгол Улсын харьяатаас гарсны нэг удаагийн хишиг хувийг 3 дахин нэмэгдүүлж олгодог мөнгөн дээр халамжийн хэлтсийн ажилтан хуурамч бичиг баримт бүрдүүлж банкны ажилтнуудтай холбогдож дээрх мөнгийг гарган авсан болох нь тогтоогдсон. 120 орчим сая төгрөгийн асуудал гарч ирсэн ба дээрх мөнгийг халамжийн ажилтан бүгдийг авсан гэж үзэх боломжгүй, Казак иргэд Монгол Улсаас гарсан тул тодруулах боломж байгаагүй, ингээд хуулийн байгууллагад хандах болсон. Энэ бол 2013 оны дүн, одоо энэ оныхыг программаар шалгаж байна. Шалгалтын явцад төрийн сангийн ерөнхий нягтлан бодогч А.Ха гэх хүн дээрх үйлдлүүдтэй холбоотой байсан тул түүний хөтөлж байсан хар дансыг шаардаж авсан. Энэ хүн энэ асуудалд халамжийн ажилчид бүгд холбоотой гэж хэлж байсан...Халамж өөрсдөө баримтаа бүрдүүлээд нэр бүхий иргэд мөнгө авах эрх нь үүсэж банкруу жагсаалтыг гарган мэдүүлдэг. Үүний дагуу нэр бүхий иргэд дээр данс нээлгэж улмаар халамжаас санхүүжилт нь орж ирэхээр мөнгийг нь банк олгох зарчмаар явж байсан юм билээ. Хүн бүрийн нэр дээр данс үүсээд нэг хүний нэр дээр ойролцоогоор 500.000 орчим төгрөг орж ирдэг. Үүний дагуу халамжийн мэргэжилтэн өнөөдөр хэдэн хүний мөнгийг банкруу шилжүүлж оруулах асуудлыг зохицуулж улмаар өөрөө банкин дээрээс очиж мөнгийг аваад мөнгийг гаргаж өгч байгаа банкны ажилтанд шан харамж болгон өгөх байдлаар явж байсан

нь харагддаг. Харин үлдсэн мөнгийг А.Ха авч ашиглаж байсан юм билээ...Шалгалтаар хүний хөгжил сангийн 2013 онд олгосон 197 хүний 1119.871.000 төгрөгийг зохих хууль ёсны баримтгүйгээр гүйлгээ хийж гаргасан байсан... /3-р хавтасны 4-6-р хуудас/ гэсэн,

гэрчээр Т.Ю-ийн:...Би 2013 оны 06 дугаар сарын 16-ны өдөр Баян-Өлгий аймгийн Хаан банкны салбарт ажилд орсон ба 2014 оны 07 дугаар сарын 02-ны өдөр манай ахлах теллер Ар, А.Ха-ыг дагуулж ирээд Ар миний Эх орны хишгийг гаргаад өгчих гэхээр нь гаргаж өгсөн... /3-р хавтасны 15-р хуудас/ гэсэн,

гэрчээр Б.Нуб: ...Ш.Ма бид нар зөвхөн дэвтрийг нь бичиж өгнө, банкинд файл өгч мөнгө шилжүүлдэг хүн нь А.Х байгаа гэхээр нь түүнд танихгүй хүний 6 тодорхойлолтоо өгөхөд А.Х би мөнгө авах ёстой хүмүүсийн төсвийг харж байгаад больё гэж хэлсэн. Би хэд хоногийн дараа А.Х дээр очоод мөнгө гаргаж чадахнуу гэж асуухад Хадгаламж банкаар авах уу?, Хаан банкаар авах уу? гэж асуухаар нь Хаан байвал сайн байна.../3-р хуудасны 74-75-р хуудас/ гэсэн,

гэрчээр Ш.Жа-ийн:...Миний төрсөн дүү Ш.Ай 2009 онд Монголоос гарсан юм. Тэгээд харьяатаас гарсан хүнд хүний хөгжлийн мөнгө өгч байна гэхээр нь дүүгийнхээ иргэний үнэмлэхийг явуулсан байсныг аваад гадаадын иргэн харьяатын албанд Д.М-т өгч хураалгаад тодорхойлолт бичүүлж аваад иргэний үнэмлэхний нэг хувийг канондож аваад нотариат дээр очиход байхгүй байхаар нь Бугат сумын Засаг дарга н.Зн-д очиж дүүгийнхээ явуулсан захиаг үзүүлж гуйж байгаад итгэмжлэл хийлгээд халамж үйлчилгээний ажилтан А.Х-д өгсөн. 2012 оны 07 дугаар сард Хаан банкнаас бэлнээр мөнгө авсан.../3-р хавтасны 85-р хуудас/ гэсэн тэдгээрийн мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлгүүд болон шүүхийн хэлэлцүүлэгт хэлэлцэгдэж шүүх шинжлэн судалсан бичгийн бусад нотлох баримтуудаар тус тус нотлогдон тогтоогдлоо.

Иймд шүүгдэгч Я.С, О.Ф нарыг бүлэглэн төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.3-т заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар,

шүүгдэгч А.Х-ыг төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан

тушаалын байдлаа урвуулах гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар ял ногдуулах үндэслэлтэй.

Шүүгдэгч Я.С-ын үйлдсэн энэ гэмт хэрэгт О.Ф-ын хамтран оролцсон хэлбэрийг прокурор тодорхойлохдоо Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 19 дүгээр зүйлийн 19.2, 35 дугаар зүйлийн 35.6 дахь заалтыг журамлаж оруулж ирсэн нь тухайн заалтуудад нийцээгүйг,

Шүүхээс шүүгдэгч нарт ял оногдуулахдаа О.Ф, А.Х нар анх удаа хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэнийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 55 дугаар зүйлийн 55.1.1-д зааснаар ял хөнгөрүүлэх нөхцөлд, Я.С, О.Ф нар гэмт хэрэг бүлэглэж үйлдсэнийг мөн хуулийн 55 дугаар зүйлийн 55.1.2-т зааснаар ял хүндрүүлэх нөхцөлд тооцож, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ зэргийг харгалзан ногдуулсан ялыг биечлэн эдлүүлэх нь зүйтэй.

Мөрдөн байцаалтын явцад “ТЦ” ХХК-ийн захирал А.Нар-д холбогдох 201204000512 дугаартай эрүүгийн хэргийг тусгаарлажээ.

Хохирогч Б.Дө шүүгдэгч нараас нэхэмжлэх зүйлгүй, гомдол саналгүй гэж байх тул Я.С, О.Ф, А.Х нарыг бусдад төлөх төлбөргүйд тооцсон болно.

Нэгэнт шүүгдэгч нарыг бусдад төлөх төлбөргүйд тооцсонтой холбогдуулан хэрэгт битүүмжлэгдсэн Я.С-ийн өмчлөлийн хх-хх БӨА улсын дугаартай УАЗ-31512 маркийн автомашин, Баян-Өлгий аймгийн ...сумын ...дүгээр багийн ...тоотод байрлах 99 м/кв талбай бүхий өвлийн хашаа байшин, Я.С-ийн хүү А.Е-ны өмчлөлийн Баянгол дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууцыг битүүмжилсэн 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн эд хөрөнгө битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.10-т зааснаар хүчингүй болгож, шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц хууль ёсны эзэмшигч, өмчлөгчид буцаан олгох нь зүйтэй гэж үзэв. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.2, 248 дугаар зүйлийн 248.1.1, 248.1.2, 248.1.3, 283, 286, 290, 294, 297, 298 дугаар зүйлүүдэд заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ НЬ:

1. Дүүргийн 2 дугаар прокурорын газраас О.С-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-т зааснаар, Д.А-т холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.2-

т зааснаар тус тус яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгож, Ж овогт О.С, Ж овогт Д.А нарыг цагаатгасугай.

2. О.С, Д.А нарын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц хүчингүй болгосугай.

3. Дүүргийн 2 дугаар прокурорын газраас И овогт А.П-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 272 дугаар зүйлийн 272.2-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т зааснаар хэрэгсэхгүй болгосугай.

4. Дүүргийн 2 дугаар прокурорын газраас Я.С-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгосугай.

5. Дүүргийн 2 дугаар прокурорын газраас О.Ф, А.Х нарт холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 150 дугаар зүйлийн 150.3-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д зааснаар хэрэгсэхгүй болгосугай.

6. Дүүргийн 2 дугаар прокурорын газраас А.Х-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 264 дүгээр зүйлийн 264.2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг улсын яллагч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 239 дүгээр зүйлийн 239.4.1, 239.5-д зааснаар яллахаас татгалзсан тул хэрэгсэхгүй болгосугай.

7. И овогт Я.С, С овогт О.Ф, М овогт А.П нарыг төрийн албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашигласны улмаас байгууллагад их хэмжээний хохирол учруулсан гэмт хэрэгт гэм буруутайд тус тус тооцсугай.

8. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 36 дугаар зүйлийн 36.3-т заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар Я.С-г тодорхой албан тушаал эрхлэх эрхийг 3 жилийн хугацаагаар хасаж, 5 жил хорих ялаар, О.Ф-ыг тодорхой албан тушаал эрхлэх эрхийг 3 жилийн хасаж, 3 жил 6 сар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2-т зааснаар А.Х-ыг

тодорхой албан тушаал эрхлэх эрхийг 3 жилийн хугацаагаар хасаж, 3 жил хорих ялаар тус тус шийтгэсүгэй.

9. Я.С, О.Ф, А.Х нарын эдлэх ялыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5-д зааснаар жирийн дэглэмтэй, эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлсүгэй.

10. Я.С 148 хоног, А.Х 151 хоног цагдан хоригдсоныг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2-т зааснаар тэдгээрийн хорих ял эдлэх хугацаанд оруулан тооцож, О.Ф цагдан хоригдсон хоноггүй болохыг дурдсугай.

11. Я.С, О.Ф, А.Х нар бусдад төлөх төлбөргүй, иргэний бичиг баримт шүүхэд ирүүлээгүй болохыг тус тус дурдсугай.

12. Иргэний хариуцагч Х.Мт /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Мк /ТЯ...../ 140.000 төгрөг, М.Ерб /БВ...../ 175.600 төгрөг, Х.Ер /БД...../ 140.000 төгрөг, С.Дар /БЭ...../ 140.000 төгрөг, С.Каб /БЭ...../ 140.000 төгрөг, А.Меу /БЖ...../ 140.000 төгрөг, М.Мар /БГ...../ 140.000 төгрөг Р.Ест /БЮ...../ 140.000 төгрөг, Е.Сер /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Май /БЭ...../ 229.500 төгрөг, А.Хуа /БЭ...../ 500.000 төгрөг, С.Ама /БЖ...../ 140.000 төгрөг, Х.Бек /БЭ...../ 198.000 төгрөг, С.Бах /БЕ...../ 177.700 төгрөг, К.Бат /БЭ...../ 156.000 төгрөг, Ү.Алм /БЭ...../ 430.000 төгрөг, М.Нур /ПЮ...../ 250.800 төгрөг, С.Зау /БК...../ 177.700 төгрөг, М.Ары /НУ...../ 154.500 төгрөг, Б.Бая /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Жам /БЛ...../ 100.000 төгрөг, Ж.Мер /БЭ...../ 382.350 төгрөг, Ж.Кул /БЮ...../ 132.500 төгрөг, Х.Мах /БЛ...../ 100.000 төгрөг, К.Ама /БК...../ 140.000 төгрөг, Х.Сах /БЖ...../ 100.000 төгрөг, Ү.Маж /БЮ...../ 100.000 төгрөг, Ж.Дар /ББ...../ 140.000 төгрөг, С.Сау /БЕ...../ 163.600 төгрөг, Е.Оза /БМ...../ 140.000 төгрөг, Б.Мыр /БЮ...../ 500.000 төгрөг, Т.Аву /БЖ...../ 140.000 төгрөг, Х.Хон /БВ...../ 140.000 төгрөг, К.Ерж /БЮ...../ 140.000 төгрөг, Т.Кул /МА...../ 140.000 төгрөг, Н.Жан /БЖ...../ 140.000 төгрөг, Ш.Аси /БЮ...../ 132.500 төгрөг, С.Жан /БЮ...../ 140.000 төгрөг, И.Лай /БА...../ 140.000 төгрөг, А.Бей /БК...../ 500.000 төгрөг, Ө.Жан /БЛ...../ 140.0006 төгрөг, С.Кад /БЮ...../ 140.000 төгрөг, Б.Ай /БЮ...../ 140.000 төгрөг, С.Хум /БЮ...../ 198.180 төгрөг, Х.Ерк /ХЛ...../ 140.000 төгрөг, Е.Бах /БК...../ 229.500 төгрөг, А.Бол /БВ...../ 140.000 төгрөг,

Т.Ерб /БИ...../ 140.000 төгрөг, С.Хум /БМ...../ 198.180 төгрөг, К.Ажы /ОЭ...../ 156.000 төгрөг, А.Бер /БЖ...../ 140.000 төгрөг, Ү.Бул /БЮ...../ 140.000 төгрөг, А.Алт /СТ...../ төгрөг, С.Алм /БА...../ 140.000 төгрөг, Р.Сам /БЖ...../ 183.600 төгрөг, С.Елт /БЮ...../ 140.000, Ш.Ерк /БИ...../ 140.000 төгрөг, А.Нур /БИ...../ 140.000 төгрөг, Т.Хуа /БЭ...../ 229.500 төгрөг, Х.Өми /СШ...../ 140.000 төгрөг, Ж.Сай /БД...../ 140.000 төгрөг, М.Айн /БЮ...../ 140.000 төгрөг, Ж.Шак /БЮ...../ 140.000 төгрөг, Т.Нур /БА...../ 160.000 төгрөг, А.Ере /БЮ...../ 140.000 төгрөг, М.Баг /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Уна /БЭ...../ 190.000 төгрөг, Б.Хар /БЙ...../ 249.900 төгрөг, Ш.Ерк /БЗ...../ 140.000 төгрөг, Ж.Зах /БЮ...../ 73.500 төгрөг, Е.Мур /БЭ...../ 136.300 төгрөг, М.Сан /БЮ...../ 190.000 төгрөг, Х.Алт /БК...../ 140.000 төгрөг, И.Ахб /БИ...../ 140.000 төгрөг, З.Ерж /БЮ...../ 140.000 төгрөг, А.Гул /БЮ...../ 140.000 төгрөг, Ж.Шуа /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Мух /ББ...../ 140.000 төгрөг, Т.Бах /ПЮ...../ 140.000 төгрөг, Х.Сул /ББ...../ төгрөг, Н.Хаж /БЮ36091019/ 140.000 төгрөг, М.Жан /БЮ...../ 140.000 төгрөг, Н.Роз /БЖ...../ 140.000 төгрөг, Т.Жул /БЮ...../ 140.000 төгрөг, М.Ари /БЭ...../ 73.500 төгрөг, К.Хам /БЮ...../ 183.600 төгрөг, Х.Жан /БЮ...../ 140.000 төгрөг, П.Бау /БК...../ 430.000 төгрөг, А.Сур /БЗ...../ 140.000 төгрөг, А.Сал /БЖ...../ 140.000 төгрөг, К.Кеж /БЛ...../ 140.000 төгрөг, С.Мар /БЛ...../ 140.000 төгрөг, Д.Гар /БЮ...../ 80.000 төгрөг, Ж.Сай /БЮ...../ 73.500 төгрөг, С.Сур /БЖ...../ 140.000 төгрөг, Х.Тан /БЖ...../ 209.000 төгрөг, А.Рап /БЮ...../ 140.000 төгрөг, Б.Арл /БЕ...../ 156.000 төгрөг, Х.Сур /ЕП...../ 198.200 төгрөг, Ж.Ерт /БИ...../ 140.000 төгрөг, Х.Хам /БЮ...../ 140.000 төгрөг, Т.Жан /БД...../ 229.500 төгрөг, А.Төм /БД...../ 197.300 төгрөг, Х.Мам /БИ...../ 196.300 төгрөг, К.Дол /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Ама /БВ...../ 198.000 төгрөг, Б.Хуа /БД...../ 181.700 төгрөг, И.Бей /БЗ...../ 156.060 төгрөг, Х.Мух /БЮ...../ 500.000 төгрөг, Б.Алт /БВ...../ 195.000 төгрөг, С.Пун /ТЯ...../ 183.600 төгрөг, Г.Цэц /БА...../ 240.000 төгрөг, А.Тал /БЭ...../ 140.000 төгрөг, Х.Гул /БЭ...../ 140.000 төгрөг, Б.Зор /БЭ...../

140.000 төгрөг, А.Кам /БК...../ 73.500 төгрөг, Х.Аха /БЮ...../ 228.000 төгрөг, Ж.Гүл /БЮ...../ 140.000 7xx 134 төгрөг, Х.Бер /БЮ...../ 140.000 төгрөг, А.Бау /БГ...../ 140.000 төгрөг, А.Кен /БГ...../ 140.000 төгрөг, Д.Мар /БЮ...../ төгрөг, И.Сам /БЮ...../ 70.000 төгрөг, А.Бер /ЧД...../ 140.000 төгрөг, К.Мау /БЮ...../ 198.000 төгрөг, Ш.Зоя /БЮ...../ 140.000 төгрөг, У.Гаф /БЭ...../ 166.600 төгрөг, Р.Вос /БЮ...../ 140.000 төгрөг, К.Хур /БЭ...../ 198.000 төгрөг, Х.Жом /БЮ...../ 140.000 төгрөг, Ш.Нур /БЮ...../ 140.000 төгрөг, А.Тел /БЗ...../ 140.000 төгрөг, Х.Ард /БЭ...../ 500.000 төгрөг, Ж.Гүл /БЭ...../ 500.000 төгрөг, А.Ром /БЭ...../ 140.000 төгрөг, З.Алм /БД...../ 140.000 төгрөг, К.Жан /БЮ...../ 140.000 төгрөг, С.Гүл /БЭ...../ 73.500 төгрөг, М.Гүл /БЭ...../ 140.000 төгрөг, Х.Мар /БЭ...../ 140.000 төгрөг, Т.Миз /БЭ...../ 213.700 төгрөг, Э.Биш /БЮ...../ 140.000 төгрөг, А.Гал /БЭ...../ 140.000 төгрөг, Б.Мар /БЭ...../ 140.000 төгрөг, У.Хан /БК...../ 430.000 төгрөг, Т.Кат /ЕП...../ 198.400 төгрөг, К.Есе /БА...../ 229.500 төгрөг, Р.Агз /БЗ...../ 95.000 төгрөг, Ж.Сье /БЮ...../ 145.000 төгрөг, Х.Мау /БЮ...../ 190.000 төгрөг, М.Хар /БЭ...../ 156.000 төгрөг, А.Ман /БЮ...../ 140.000 төгрөг, Т.Бот /ЦЗ...../ 430.000 төгрөг, А.Нур /БЛ...../ төгрөг, Х.Уна /БЭ...../ 190.000 төгрөг, Б.Арл /БЕ...../ 156.000 төгрөг, М.Асх /БЖ...../ 140.000 төгрөг, З.Алм /БД...../ 140.000 төгрөг, М.Улб /БИ...../ 500.000 төгрөг, Х.Хад /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Рах /БЮ...../ 140.000 төгрөг, М.Амг /БД...../ 212.400 төгрөг, Ш.Ари /БК...../ 390.150 төгрөг, Х.Нау /БЮ...../ 132.500 төгрөг, Н.Лаз /ХО...../ 190.000 төгрөг, А.Хам /БЖ...../ 140.000 төгрөг, Б.Нур /БИ...../ 156.000 төгрөг, Т.Баб /БЖ...../ 160.060 төгрөг, Б.Ахб /БЮ...../ 140.000 төгрөг, С.Дам /БЛ...../ 140.000 төгрөг, Б.Ама /БЖ...../ 268.646 төгрөг, Р.Боп /БЖ...../ 240.000 төгрөг, Б.Жам /БА...../ 500.000 төгрөг, У.Ана /ББ...../ 140.000 төгрөг, Р.Есе /БЭ...../ 140.000 төгрөг, С.Хал /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Ерк /ИТ...../ 140.000 төгрөг, Е.Хай /БЗ...../ 140.000 төгрөг, М.Пар /БЖ...../ 261.366 төгрөг, Д.Ерт /БГ...../ 140.000 төгрөг, Д.Айб /БА...../ 150.000 төгрөг, Ш.Ерх /БД...../ 140.000 төгрөг, Х.Ази /БВ...../ 33.000 төгрөг, Х.Дэн /БД...../ 175.600 төгрөг, О.Айж /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Мар /

ЧС...../ 140.000 төгрөг, С.Хөх /ИТ...../ 140.000 төгрөг, Х.Хус /ИТ...../ 140.000 төгрөг, К.Ерж /СШ...../ 140.000 төгрөг, А.Тан /БД...../ 140.000 төгрөг, Е.Сай /БЭ...../ 500.000 төгрөг, А.Жуп /БЭ...../ 140.000 төгрөг, К.Ерл /БЭ...../ 140.000 төгрөг, Д.Бай /БЮ...../ 140.000 төгрөг, А.Жай /ГЕ...../ 140.000 төгрөг, Т.Тох /БЮ...../ 192.800 төгрөг, Р.Ман /БЮ...../ 140.000 төгрөг, О.Бул /БЭ...../ 67.100 төгрөг, Т.Нур /БВ...../ 140.000 төгрөг, А.Күл /БИ...../ 140.000 төгрөг, Д.Алм /БЮ...../ 140.000 төгрөг, Ж.Б.Айн /ХЛ...../ 140.000 төгрөг, М.Нур /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Ван /БЮ...../ 140.000 төгрөг, Б.Сер /БЭ...../ 140.000 төгрөг, З.Хар /АЮ...../ 140.000 төгрөг, Х.Риз /ХК...../ 140.000 төгрөг, Н.Айг /БА...../ 140.000 төгрөг, С.Тим /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Мар /БЮ...../ 140.000 төгрөг, Р.Кен /БЭ...../ 140.000 төгрөг, Б.Сул /БЮ...../ 140.000 төгрөг, А.Мер /БЖ...../ 140.000 төгрөг, А.Бат /БЮ...../ 140.000 төгрөг, Х.Хаз /БЙ...../ 140.000 төгрөг, М.Өми /БИ...../ 237.700 төгрөг, А.Хур /ББ...../ 430.000 төгрөг, А.Ойл /БЛ...../ 140.000 төгрөг, Х.Хож /БЮ...../ 140.000 төгрөг буюу нийт 38.115.192 төгрөгийг гаргуулж улсын төсөвт оруулсугай.

13. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан 5 ширхэг CD-г хэрэгт хавсаргаж, Баян-Өлгий аймгийн сумдуудын халамжийн сантай холбоотой 29 хайрцаг баримтуудыг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтэст буцаан хүргүүлсүгэй.

14. Баян-Өлгий аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн байранд байгаа 2935 ширхэг 5 төрлийн ортопедийг битүүмжилсэн Эд хөрөнгө битүүмжлэх тухай мөрдөн байцаагчийн 2012 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн тогтоолыг шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц битүүмжлэлээс чөлөөлж, улсын орлого болгохыг Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд даалгасугай.

15. Я.С-д холбогдуулан түүний өмчлөлийн хх-хх БӨА улсын дугаартай УАЗ-31512 маркийн автомашин, Баян-Өлгий аймгийн ...сумын ...дүгээр багийн ...тоотод байрлах 99 м/кв талбай бүхий өвлийн хашаа байшин, А.Е-ны өмчлөлийн Баянгол дүүргийн ...дугаар хороо, ...дугаар ...тоот орон сууцыг битүүмжилсэн 2012 оны 12 дугаар сарын 13-

ны өдрийн эд хөрөнгө битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.10-т зааснаар хүчингүй болгож, шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болмогц хууль ёсны эзэмшигч, өмчлөгчид буцаан олгосугай.

15. Я.С, О.Ф, А.Х нарт бусдын батлан даалтад өгөхөөр авсан таслан сэргийлэх арга хэмжээг өөрчилж цагдан хорьж, А.П-д урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсүгэй.

16. Шүүхийн шийтгэх тогтоолыг эс зөвшөөрвөл тогтоолыг гардаж авснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд

ялтан, хохирогч, өмгөөлөгч нар гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих, иргэний нэхэмжлэгч, иргэний хариуцагч нар тогтоолын иргэний нэхэмжлэлтэй холбогдох хэсэгт тус тус давж заалдах эрхтэйг дурдсугай.

17. Шүүхийн шийтгэх тогтоолд эрх бүхий этгээд давж заалдах гомдол гаргасан, улсын яллагч эсэргүүцэл бичвэл уг тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол биелүүлэх хүртэл Я.С, А.Х О.Ф нарт цагдан хорих О.С, А.П, Д.А нарт батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хэвээр үргэлжлүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ
ШҮҮГЧИД

Ц.ДАЙРИЙЖАВ
А.АЛТАНХУЯГ
О.ЖАНЧИВНЯМБУУ

ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 06 сарын 12 өдөр

Дугаар 751

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүх хуралдааныг шүүгч Б.Батболор даргалж, шүүгч Г.Есөн-Эрдэнэ, С.Батгэрэл нарын бүрэлдэхүүнтэй,

шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Б.Энхжаргал,
иргэдийн төлөөлөгч Д.Баасандорж, Ж.Шагдарсүрэн, Д.Баяртогтох,
улсын яллагч О.Сарангэрэл,
хоширогч, иргэний нэхэмжлэгч Ж.О,
шүүгдэгч Х.А, түүний өмгөөлөгч Ц.Цэрэнжээ /ҮД:0-36./, Б.Баярмаа /ҮД:0-25./,
Ж.Эрдэнэбулган /ҮД:0-64./, Х.Базаррагчаа /ҮД:0-19./,
шүүгдэгч Д.А-ы өмгөөлөгч Р.Пүрэвлхам /ҮД:0-65./,
шүүгдэгч Н.О, түүний өмгөөлөгч О.Сайнгэрэл /ҮД:0-09./,
шүүгдэгч Ц.Ч, түүний өмгөөлөгч Ч.Шаравнямбуу /ҮД:0-76./, М.Баяраа /ҮД:0-71./,
Л.Ононбаяр /ҮД:0-75./,

гэрч Г.Т, О.Э, Т.Ц, шинжээч П.С, Ц.Б нарыг оролцуулан тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн хуралдаанаар, Нийслэлийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2, 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Г овогт Х.А, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар Б овогт Д.А, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Ш овогт Н.О, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар А овогт Ц.Ч нарт тус тус холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн 20140100004. дугаартай, 106/2014/0707/Э индексстэй хэргийг 2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүлээн авч, шүүн хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт:

1. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-нд Төв аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, аялал жуулчлалын менежер, орчуулагч мэргэжилтэй, «Тг» ХХК-ийн ерөнхий захирал ажилтай, ам бүл..., эхнэр ...хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, Г овогт Х.А /РД:ЦБ...../

2. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн

засагч мэргэжилтэй, Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан, одоо эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл ..., эхнэр хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, Б овогт Д.А /РД:ХБ...../

3. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч, компьютер-техникийн инженер мэргэжилтэй, «Тг» ХХК-ийн ерөнхий менежер ажилтай, ам бүл ..., эхнэр ...хүүхдийн хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух хаягтай, одоо Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, Ш овогт Н.О /РД:ХБ...../

4. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-нд Бүгд Найрамдах Унгар улсын Будапешт хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, «Те Х» ХХК-д ерөнхий менежер ажилтай, ам бүл ..., эхнэр ...хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, Үйлдвэр 2ХД ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, А овогт Ц.Ч /РД:ХП...../

Холбогдсон хэргийн талаар: /яллах дүгнэлтэд дурдсанаар /

Шүүгдэгч Х.А нь Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухайн хуулийн 7, 8, 16, 17, 21 дүгээр зүйлүүдэд заасан заалтуудыг зөрчин 2007-2011 онд нийт 12.303.690.000 төгрөгөөр хайгуулын болон ашиглалтын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан авч Аж ахуйн нэгжийн

орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлогын албан татвар болох 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөлгүй онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн,

Мөн 2008 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн Үйлдвэр худалдааны сайд Х.Н-гийн 196 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүн хуваах чиглэлээр Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Олон улсын нээлттэй тендер зарлаж, уг тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө «Тг» ХХК-ийн ерөнхий менежер Н.О-д итгэмжлэл хийж өгч, Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлэн хээл хахуульд өгсөн,

Шүүгдэгч Д.А нь Газрын тосны газрын даргаар ажиллаж байхдаа Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан, газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны дарга, Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар тус тус ажиллахдаа тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Х.А-ын 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг төрсөн ах Т.Ц-ийн хүү Ц.Ч-ийн нэр дээр 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр шилжүүлэн авч онц их хэмжээний хээл хахууль авсан,

Шүүгдэгч Н.О нь Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудын сонгон шалгаруулалтад «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д Х.А-ын эзэмшлийн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлж, хээл хахууль өгөх гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлэн хамжигчаар оролцсон,

Шүүгдэгч Ц.Ч нь «Тг» ХХК-ийн захирал Х.А-аас Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д «Тг» ХХК-ийг тендерт шалгаруулсны төлөө өгсөн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг өөрийн нэр дээр шилжүүлэн авч, онц их хэмжээний

хээл хахууль авсан гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг нуун далдалж гэмт хэрэгт хамжигчаар оролцсон гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ТОДОРХОЙЛОХ нь:

Талуудын хүсэлтээр хэрэгт цугларсан нотлох баримтуудыг тал бүрээс нь бүрэн, бодитойгоор шинжлэн судалж, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцэхэд:

1. Шүүгдэгч Х.А нь 2008 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн Үйлдвэр худалдааны сайд Х.На-ийн 196 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүн хуваах чиглэлээр Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Олон улсын нээлттэй тендер зарлаж, уг тендерт “Тг” ХХК-ийг шалгаруулсны төлөө “Тг” ХХК-ийн ерөнхий менежер Н.О-д итгэмжлэл хийж өгч, Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлэн хээл хахуульд өгсөн,

Шүүгдэгч Д.А нь Газрын тосны газрын даргаар ажиллаж байхдаа Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан, газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны дарга, Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар тус тус ажиллахдаа тендерт “Тг” ХХК-ийг шалгаруулсны төлөө Х.А-ын 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг төрсөн ах Д.Ц-ийн хүү Ц.Ч-ийн нэр дээр 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр шилжүүлэн онц их хэмжээний хээл хахууль авсан болох нь:

Шүүгдэгч Х.А-ын шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар мэдүүлсэн:

1. “Би мэдүүлгээ бичгээр гаргасан байгаа, гэхдээ мэдүүлгээ өгч хэлэх зүйлээ хэлээд хавтаст хэрэгт хавсаргах үүднээс өгч байна. Эрхэм хүндэт шүүгчид ээ, өнөөдөр би энэ шүүхийн танхимд та бүхний өмнө үнэн мөнийг 338 хоногийн дараа хоригдсоныхоо эцэст олох байх гэсэн итгэл өвөрлөн зогсож байна. Учир нь 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Авлигатай тэмцэх газрын ажилтнууд намайг саатуулан, улмаар цагдан хорьсноос хойш миний бие болон миний гэр бүл, найз нөхөд, миний хамт олон, Монголд хөрөнгө оруулалт хийсэн хамтрагч нар маань үнэн

мөнийг үзсэнгүй, эрээд олсонгүй. Авлигатай тэмцэх газрын ажилтнууд намайг анх саатуулан цагдан хорихдоо Эрүүгийн хуулийн 263.2 буюу албан тушаалаа урвуулан ашигласан, мөн хуулийн 166¹.2 буюу мөнгө угаасан гэх хэрэгт сэжигтэн яллагдагчаар татан хорьж мөрдөн байцаах ажиллагаа явуулсан. Миний хувьд Монгол Улсын хууль хяналтын байгууллага шалгана гэж байхад шалгуулах үүрэгтэй. ...Хамгийн харамсалтай, асар эмгэнэлтэй нь надад эрүүгийн хэрэг үүсгэн шалгаснаас хойш 5 сар гаруйгийн дараа анх эрүүгийн хэрэг үүсгэн шалгах болсон зүйл ангиас тэс ондоо асуудал үүсгэн, Авлигатай тэмцэх газар намайг болон манай компанийн хоёр захирал залууг, мөн Газрын тосны газрын дарга асан талийгаач Д.А нарыг эрүүгийн хэрэг үүсгэн, авлига өгсөн, авсан, онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн гэж 269.1, 166.2-т зааснаар хэрэг үүсгэн шалгаж эхэллээ гэсэн. Энэ нь даамжран явсаар, Монголын шилдэг сэхээтнүүдийн нэг урьдчилсан цагдан хорих төвийн өмгөөлөгчтэй уулзахын өмнө хоригдогсод хүлээдэг хүлээлгийн өрөөнд өвчний улмаас зуурдаар нас барсан. ...Өнөөдөр намайг Авлигатай тэмцэх газраас шалгаад, прокурорын байгууллага ялын дүгнэлт үйлдээд яллахаар шүүхэд шилжүүлсэн Эрүүгийн хуулийн хоёр зүйл ангийн хэрэгтэй холбоотой асуудлаар тайлбар өгөхөөсөө өмнө, 2013 оны 07 дугаар сарын 09-нд анх цагдан хорихдоо надад тулгасан, анх цагдан хорих шалтаг болсон Эрүүгийн хуулийн 166¹.2 болон 263.2 гэсэн зүйл ангийн, мөнгө угаасан болон албан тушаалаа урвуулан ашигласан гэсэн хэрэгт сэжиглэн шалгасан талаар товч тайлбар өгөхийг хүсэж байна. Учир нь энэ хоёр зүйл ангитай холбоотой хэргийг хэрэгсэхгүй болгоогүй, харин энэ хэргээс (201301000029. дугаартай хавтаст хэргийг тусгаарлан) Нийслэлийн Прокурорын газрын хяналтын прокурор О.С-ийн зөвшөөрснөөр 2014 оны 03 дугаар сарын 18-нд тусгаарлан 20140100004. дугаартай хавтаст хэрэг үүсгэсэн. Надад ямар ч мөнгө угаасан хэрэг байхгүй, би тийм хэрэг үйлдээгүй. Би 1990 оноос эхлэн гадаадын аялал жуулчлалын “Ж” компанийн нэр дээр сурч эхэлснээсээ хойш аялал жуулчлалын салбарт тасралтгүй ажилласан. 1997 онд нэр дээр нь суралцаад, улмаар ачигч, орчуулагч, менежер хийж байсан “Ж” ХХК-ийнхаа баруун европын зах зээл хариуцсан суурин

төлөөлөгчөөр Холбооны Бүгд Найрамдах Герман улсын Берлин хотноо томилогдон ажилласан. 2000 оноос өөрөө Герман улсад “MP” компани үүсгэн байгуулаад “Ж” ХХК-тайгаа хамтран ажиллах болсон. 2006 оноос Монголдоо эргэн ирж “Тг”, улмаар “Тх” компани үүсгэн байгуулж, хөрөнгө оруулалтын чиглэлээр аялал жуулчлал, барилга орон сууц, зочид буудал, газар тариалан, уул уурхай, ашигт малтмалын эрэл хайгуул хийх зэрэг салбаруудад идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Өөрийн гадаад, дотоодод 15-16 жил ажиллахдаа хуримтлуулсан хөрөнгөөрөө “Т” бүлэг компанийн үндэс суурийг тавьсан. Улмаар гадаадын хөрөнгө оруулагчдыг Монголдоо хөрөнгө оруулалт хийлгэхийг зорин, төсөл бичиж, аялал жуулчлалын салбарт ажиллаж байхдаа олсон мэдлэг чадвар, танилцсан гадаадын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчидтай идэвхтэй ажилласны үр дүнд гадаадаас их хэмжээний хөрөнгө оруулалт, урт хугацаатай зээл олж Монголдоо хөрөнгө оруулалт хийсэн. 2006-аас 2013 онуудын хооронд Холбооны Бүгд Найрамдах Герман улсын шууд хөрөнгө оруулалт, Швейцарын банк бус санхүүгийн байгууллага “MOFI”-гоос урт хугацааны зээл, Америкийн Нэгдсэн Улсын нэр хүнд бүхий олон улсын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалт, Австралийн уул уурхайн туршлагатай менежментийн компани, Австралийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компани зэргүүдтэй хамтран ажиллаж, Монголдоо нийтдээ 70 гаруй сая ам долларын буюу 100 гаруй тэрбум төгрөгийн гадаадын шууд хөрөнгө оруулалт татан ажилласан юм. Үүнээс гадна олон төслийн суурийг тавиад байсан бөгөөд цаашдаа олон зуун сая долларын хөрөнгө оруулалт, олон мянган шинэ ажлын байр бий болгох ажил урьдчилсан байдлаар эхлүүлэн гэрээ хэлцлийг нь хийгээд ажлаа эхлүүлсэн байсан билээ. Энэ бүх ажилд нууж хаах зүйл огт байхгүй. Бүгд ил тод, хийсэн гэрээ хэлцлүүд, банкаар орж гарсан мөнгө бүгд ил байгаа. Мөрдөн байцаагчид үүнтэй холбоотой бүх баримт материалыг намайг баривчлахдаа хурааж авсан. Би аливаа далд үйл ажиллагаа явуулж байгаагүй, бүх ажиллагаа, компаниуд маань ил тод байгаа. Надад хөрөнгө мөнгөө нууж хаасан зүйл байхгүй. Монголд ганц харьцдаг хувийн банкны данстай, орж гарсан мөнгө, гаднаас орж ирсэн хөрөнгө мөнгө нь ямар гарал үүсэлтэй нь бүгд тодорхой.

Үүнийг намайг анх хорьж, өнгөрсөн наадмын дараа байцаахад л мөрдөн байцаагчид хэлсэн. Гадаадын хөрөнгө оруулагчид аливаа хөрөнгө оруулалт хийхдээ хэнтэй, ямар хүнтэй хамтрах гэж байна вэ тухайн орны хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин ямар вэ гээд маш нарийн шалгаж байж хөрөнгө оруулалтын шийдээ гаргадаг. Миний хувьд эхний хөрөнгө оруулалтын зээлийн гэрээгээ олон жил найз нөхдийн харилцаа холбоотой байсан Герман хүний дэмжлэгээр хийж байсан бол Америкийн Нэгдсэн Улсын хөрөнгө оруулалтын «First Reserve Corporation»-ны гэрээг хийхийн өмнө намайг асар нарийн шалгаж судалж байж хөрөнгө оруулалтын гэрээг хийсэн гэдгээ хамтрагч нар сүүлд нь надаас нуугаагүй. Энэ нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын сан Монголд анх удаа хөрөнгө оруулалт хийсэн, цаашдаа ч их ажил хийх байсан. Харамсалтай нь намайг Авлигатай тэмцэх газраас шалгаж эхлээд цагдан хорьсон тул манай хамтрагч нар Монгол дахь үйл ажиллагаагаа царцаасан, хэрэг сунжрах тусам одоо бүр зогсоох хандлагатай болоод байна. Энэ бүх хийж байсан ажлууд маань хоосон хардалт сэжиглэлтийн гайгаар нуран унаж байгааг харах асар харамсалтай байна. Ганцхан Австралийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компани үйл ажиллагаагаа энэ хүнд хэцүү үед авч явах гэж чадах ядахаараа мэрийн ажиллаж байна. Мэдээж Монгол хамтрагчийг нь Авлигатай тэмцэх газраас удаан хугацаагаар цагдан хорьж, шалгаж байгаа нь энэ компанийн бусад хөрөнгө оруулагчдыг үргээж, үйл ажиллагааг нь доголдуулж байгаа нь хэнд ч ойлгомжтой. Намайг анх барьж хорихдоо Ашигт малтмалын газрын албан тушаалтнуудтай бүлэглэн ашигт малтмалын хайгуулын лиценз цуцлагдах байтал тэдэнтэй хуйвалдан хууль бусаар сунгуулан эзэмшиж байна гэж буруутгасан. Хэдий тийм ч хэн гэдэг албан тушаалтантай хуйвалдан, албан тушаалаа урвуулан ашигласныг мөрдөн байцаагчид одоо болтол надад хэлээгүй. Би төрд ажиллаж үзээгүй. Надад Ашигт малтмалын газрын дарга нартай хуйвалдсан буруу үйлдэл байхгүй. Үүнийгээ ч би мөрдөн байцаагчид анхнаасаа хэлж байсан. Намайг анх цагдан хорьсноосоо хойш албан ёсоор 7 удаа байцаасан тэгэхдээ ганц л удаа «Т» бүлэг компанийн үйл ажиллагаа, ашигт малтмалын лицензүүдтэй холбоотой байцаалт авсан. Харин 2 дахь байцаалтаас эхлээд нэр бүхий 2 улс

төрчидтэй болон тэдний гэр бүлийхэнтэй холбож байцаалт авч эхэлсэн. «Т» бүлэг компанийг би үүсгэн байгуулсан, энд ямар ч улс төрч, тэдгээрийн гэр бүлийнхний хувь оролцоо огтхон ч байхгүй гэдгийг би үргэлж хэлж ирсэн. Энэ бүгд юуг харуулж байна гэхээр, Х.А гэж хэн ч биш, юу ч чадахгүй, хэн нэгний нөмөр нөөлгөөр «Т» гэдэг компани оршин тогтнож байгаа гэсэн хаа нэгтэйгээс эхэлсэн явуулга намайг болон манай хамт олон, найз нөхдийг минь дайрлаа гэж ойлгож байна. Энэ гүтгэлэг, хардлага, энэ хэлмэгдүүлэлт өнөөдөр зогсох байх гэж найдаж байна. Мөнгө угаасан хэрэг байхгүй, учир нь гадаадын хөрөнгө оруулалт Монголдоо авч ирсэн гэж буруутгахгүй биз, албан тушаалаа урвуулан ашигласан хэрэг байхгүй, би улсад ажиллаж байгаагүй, мөн бусадтай хуйвалдаагүй. Ийм учраас надад үүсгэсэн Эрүүгийн хуулийн 166^{1.2} болон 263.2 гэсэн зүйл ангиар үүсгэсэн хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэж хичээнгүйлэн хүсэж байна. ...Одоо би прокурорын газрын тосны бүтээгдэхүүн хуваах, газрын тосны хайгуулын ажил явуулах, Нэмэгт-6, Шарга-3 талбайнуудад 2008 оны 8 дугаар сард зарласан олон улсын нээлтэй тендерт ялахын тулд 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Зайсан дахь 160 м² бүхий, 2 зогсоолтой орон сууц Ц.Ч-ий нэр дээр шилжүүлэн, Газрын тосны газрын дарга асан, 2014 оны 05 дугаар сарын 13-нд харамсалтайгаар 461 дүгээр хорих ангид нас барсан талийгаач Д.А асанд хээл хахууль өгсөн гэх талаар тайлбар хийе. “Тг” ХХК чухам яагаад энэ тендерт орох болсон талаар товч хэлмээр байна. Монгол Улсад газрын тосны эрэл хайгуулын ажил 1940-өөд оноос явагдаж байсан байдаг. 1960-аад оны үед Зүүнбаянгийн орчмын газар газрын тосны олборлолт хийж, Зүүнбаян хотод нефть боловсруулах үйлдвэр ажиллаж байсан бөгөөд 1968 онд галын осол тус үйлдвэрт гарснаас хойш тус үйлдвэрийг сэргээгээгүй. Ер нь Монгол Улс дахь газрын тосны эрэл хайгуулын ажлыг зогсоосон байдаг. 1990-ээд оны дундаас Монгол улсад газрын тосны хайгуулын ажил эрчимжсэн боловч энэ нь гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай компаниудын хийдэг ажил байв. Барууны компаниуд Засгийн газраас хайгуулын талбай гэрээлж аваад, бага зэрэг ажил хийсний дараа Бүгд Найрамдах Хятад Ард улсын төрийн өмчит компаниудад худалддаг жишиг тогтсон байв. Жишээ нь

Дорнод аймагт Америкийн Нэгдсэн улсын “Soko international” компани бага зэргийн хайгуул хийж байгаад Бүгд Найрамдах Хятад Ард улсын төрийн өмчит “Petrochina” /CNPC/-ийн охин компанид талбайнуудаа зарсан. Мөн Австралийн нэгэн компани Дорноговь дахь талбайгаа Бүгд Найрамдах Хятад Ард улсын төрийн өмчит “Sino Pec”-ийн охин компани “Донг”-д зарсан байдаг. Энэ мэтээр Бүгд Найрамдах Хятад Ард улсын төрийн өмчит компаниуд тэргүүлэн, Монголын газрын тосны нийт 30 орчим талбайгаас 70 гаруй хувийг өөрсдийн мэдэлдээ авсан байдаг. Монголын үндэсний компаниудаас “Пет”, “Шун”, “МТ”, “ЭСЭ”, “МК” компаниуд газрын тосны хайгуулын талбай авснаас ганц “Пет” Лондонгийн хөрөнгийн биржид хувьцаагаа борлуулж хөрөнгө мөнгө босгон газрын тосны хайгуулын ажлыг эрчимтэй явуулах оролдлого хийж ирсэн. “Пет”-ын охин компани “Петро” одоо 3 талбайд хайгуул хийж байгаа. “Тх” тэр үед энэ үүсээд байсан орон зайд ноёрхсон байсан орон зайд Монголын бие даасан газрын тосны хайгуулын үндэсний компани шинээр үүсгэн байгуулж, идэвхтэй үйл ажиллагаа явуулахыг эрмэлзэн, энэ салбарын судалгаа хийж эхэлсэн. Улмаар гадаадын хөрөнгө оруулагчидтай урьдчилсан байдлаар тохиролцож, хөрөнгө мөнгө босгож ажиллах бэлтгэлээ хангасан. Дараа нь дотоодын туслан гүйцэтгэгч компаниудтай хэлэлцээр хийж тендерт бэлдсэн. Уг ажлыг бид 2007 оноос эрчимтэй явуулсан бөгөөд Газрын тосны газраас зарласан сонгон шалгаруулалтад орж Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудын тендерт шалгарсан. Энэ нь манай анхны оролцоод шалгарсан тендер биш, бид өмнө нь Эргэл-12, Төхөм-10 талбайнуудын тендерт оролцоод шалгараагүй. Бид 2009 оны 04 дүгээр сард Шарга-3, Нэмэгт-6 талбайн тендерт шалгарч, Газрын тосны газартай газрын тосны эрэл хайгуул хийх эрх олгох Бүтээгдэхүүн хуваах гэрээг гарын үсэг зурахаар бэлдсэн боловч уг гэрээг тухайн үеийн салбарын сайд Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулаагүй, улмаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр ороогүй. Огт батлагдаагүй хэрэгжээгүй гэрээ. Одоогоос 6 жилийн өмнө зарлагдаад манай компани шалгарсан хэдий ч батлагдаагүй, манай компанид ямар ч эрх олгогдоогүй тендерийг сөхөн, авлига хээл хахуулийн хэрэг үүсгэн шалгаж, шүүхэд шилжүүлснийг огт ойлгохгүй байна. Үүнийг

би мөрдөн байцаагчид удаа дараа хэлсэн ч огт Х.Арч, хүлээж аваагүй. Энд авлига хээл хахуулийн ямар ч асуудал байхгүй. Би тийм ёс зүйгүй хүн биш. Ухамсартай хөдөлмөр эрхэлсэн цагаасаа бүх хууль тогтоомжийг ягштал биелүүлж ирсэн нэгэн. Прокурор танайх энэ тендерт шалгарахгүй байх байсан, тийм ч учраас тендерт ялахын тулд Ц.Ч-аар халхавчилж, үнэтэй орон сууцаар хээл хахууль өгч байж ялсан гэж ойлгуулах гэж байх шиг байна. Энд ялсан, өөрт ашигтай байр суурь үүсгэсэн юм огт байхгүй. Яагаад гэдгийг би маш энгийнээр, гэхдээ хавтаст хэрэгт байгаа нотлох баримтад тулгуурлан тайлбарлая. Би манай компани яагаад уг тендерт ялсны хариуг энэ хавтаст хэрэгтэй танилцаж байхдаа баримттайгаар ойлгосон. Өмнө нь манайх сайн санал өгсөн болоод шалгарсан гэж бодож явсан бол хавтаст хэрэг дотор яагаад гэдгийн хариу бэлээхэн ил байсан. Т-гээс Газрын тосны газарт өгсөн санал Монгол улсад хамгийн ашигтай санал өгсөн тул өндөр оноо авч, уг тендерт шалгарсан байна гэдгийн баталгаа энэ хавтаст хэрэг дотор байгаа. 7 дугаар хавтаст хэргийн 177 хуудсанд 2008 оны 02 дугаар сарын 14-ний Үйлдвэр худалдааны сайдын 33 дугаар тушаал байгаа. Энэ нь бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмыг хавсралтын ёсоор баталсугай гэсэн Х.Н сайдын тушаал. Уг журамд газрын тосны хайгуулын талбайн тендерт оролцож буй захиалагчдын саналыг Газрын тосны газрын Үнэлгээний хороо хэрхэн үнэлэх, Сонгон шалгаруулах зөвлөл хэрхэн үнэлж дүгнэх бүгд нэгд нэгэнгүй заасан байна. Уг журмын 8.3-т сонгон шалгаруулалтад хамруулсан захиалгыг үнэлгээний үзүүлэлтийн ач холбогдлоор нь үндсэн үзүүлэлт 1, туслах үзүүлэлт 2, дэд үзүүлэлт 3 гэсэн 3 үзүүлэлтээр үнэлнэ. Уг журмын 8.4-т Үнэлгээний хороо нь захиалагчийн ирүүлсэн захиалга, холбогдох баримт, бичгийг хянан үзэж үнэлэх, харьцуулах ажлыг гүйцэтгэсэн санал дүгнэлтээ илтгэх хуудсаар сонгон шалгаруулах зөвлөлд ирүүлнэ. Сонгон шалгаруулах үнэлгээний үндсэн үзүүлэлт нь Монгол Улсын байгалийн нөхөн сэргээгдэшгүй баялгийг ашигласан төлбөр Рояалти, бүтээгдэхүүний хуваалт, нөхөх зардлын хувь хэмжээ, энэ нь хасах үзүүлэлт байна. Мөн журмын 8.6-д шаардлагад нийцсэн захиалгыг 8.3-т заасан үзүүлэлтийг харгалзан Үнэлгээний хорооны гишүүн бүр

үзүүлэлт тус бүрээр оноо өгөх ба гишүүдийн өгсөн онооны дундаж дүнгээр байр эзлүүлнэ. Үнэлгээ өгөхдөө үндсэн үзүүлэлтийг 3, туслах үзүүлэлтийг 2, дэд үзүүлэлтийг 1 гэсэн коэффициентээр үржүүлнэ гэж заажээ. Мөн журмын 8.7-д Үнэлгээний хороо санал дүгнэлтээ илтгэх хуудас үйлдэн Сонгон шалгаруулах зөвлөлд өгнө. Сонгон шалгаруулах зөвлөл хуралдаад зөвлөмжөө Эрдэс баялаг, эрчим хүчний яаманд явуулна. Яамны сайд бүтээгдэхүүн хуваах гэрээг Монгол Улсын Засгийн газрын хурлаар батлуулна. Баталсан гэрээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл ахин хэлэлцэж, батлаад Засгийн газарт буцааж өгнө. Засгийн газар яаманд өгнө. Энэ бүх процессийн эцэст яамнаас Газрын тосны хайгуулын талбайд эрэл хайгуулын ажил явуулахыг баталгаажуулсан лиценз олгоно. Энэ олон шат дамжлагын дараа сонгон шалгаруулалтад оролцсон аж ахуйн нэгж хайгуулын ажлаа эхэлнэ. Одоо эргээд Газрын тосны газрын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад зарласан сонгон шалгаруулалтад ямар компаниуд оролцов, ямар санал Монгол Улсын Засгийн газарт өгснөөр ямар оноо авав гэдгийг товч дурдая. Үнэлгээний хорооны үнэлгээгээр Нэмэгт-6 талбай дээр “Тг” үндсэн үзүүлэлт 690, туслах үзүүлэлт 476.90, дэд үзүүлэлт 285, нийт 1451.90 оноогоор 1 дүгээр байр, «ЛЧ» ХХК болон «Н се» ХХК хамтарсан концерциум үндсэн үзүүлэлт 240, туслах үзүүлэлт 361.80, дэд үзүүлэлт 280.40, нийт 882.20 оноогоор 2 дугаар байр, Үнэлгээний хорооны үнэлгээгээр Шарга-3 талбай дээр Тг үндсэн үзүүлэлт 690, туслах үзүүлэлт 476.90, дэд үзүүлэлт 285, нийт 1451.90 оноогоор 1 дүгээр байр, «ЛЧ» ХХК болон «Н се» ХХК хамтарсан концерциум үндсэн үзүүлэлт 240, туслах үзүүлэлт 362.20, дэд үзүүлэлт 280.40, нийт 883.20 оноогоор 2 дугаар байр, Бүгд Найрамдах Польш улсын «РСМС» үндсэн үзүүлэлт 333, туслах үзүүлэлт 160, дэд үзүүлэлт 323.70, нийт 816.70 оноогоор 3 дугаар байр тус тус эзэлсэн байна. Одоо ямар санал Т-гээс Газрын тосны газарт өгснөөр сая хэлсэн оноог авч, сонгон шалгаруулалтад Үнэлгээний хороо болон Сонгон шалгаруулах зөвлөлөөс уг сонгон шалгаруулалтад түрүүлж 1 дүгээр байр эзэлсэн бэ гэдгийг хэлье. Газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Тг бүтээгдэхүүн хуваах гэрээний битүүмжилсэн саналдаа таван жилд нэг талбайд 46.930.000 ам

долларын хайгуулын ажилд хөрөнгө оруулахаар тусгасан. Энэ нь хүндийн хүчний хайгуул 1000 км² хийх, 2 хэмжээт чичирхийлэл 1500 тууш км, 3 хэмжээт чичирхийлэл 800 км², хайгуулын өрмийн цооног 20 ширхэг өрөмдөх гэж тусгасан байна. Тг бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцлүүдэд доорхи санал өгсөн байна. Нэгдүгээрт, бүтээгдэхүүн хуваах өдрийн дундаж гарц өдөрт 0-ээс 5000 баррельд Засгийн газар 45%, гэрээлэгч 55%, 5001-ээс 10000 баррельд Засгийн газар 50%, гэрээлэгч 50%, 10001-ээс 15000 баррельд Засгийн газар 55%, гэрээлэгч 45%, 15001-ээс 20000 баррельд Засгийн газар 60%, гэрээлэгч 40%, 20001-ээс дээш баррельд Засгийн газар 65%, гэрээлэгч 35%, хоёрдугаарт, рояалти 12,5%, гуравдугаарт өртөг нөхөлт 35%. Эдгээр нь 1 дүгээр хавтаст хэргийн 217 дугаар хуудсанд байгаа ажлын хэсгийн тэмдэглэлд, 1 дүгээр хавтаст хэргийн 236 дугаар хуудсанд “Тг-ын Газрын тосны газрын ажлын хэсэгтэй хэлэлцээр хийхдээ рояалти 9% байсныг 12,5% болгосон, өртөг нөхөлт 40% байсныг 35% болгосон, мөн хөрөнгө оруулалтын хэмжээг анхны санал 46.750.000 ам доллар байсныг 46.930.000 ам доллар болгосон гэж өгчээ. Гэтэл өрсөлдөгч сонгон шалгаруулалтад Нэмэгт-6 талбайд 2 дугаар байранд орсон, Шарга-3 талбайд мөн 2 дугаар байранд орсон «Н се», «П ЛЧ» компанийн үндсэн нөхцлүүд нь 8 дугаар хавтаст хэргийн 234 дүгээр хуудсанд байгаа. Нэмэгт-6 талбайд рояалти 6,1%, өртөг нөхөлт 30%, бүтээгдэхүүн хуваалт 0-ээс 5000 баррельд Засгийн газар 35%, гэрээлэгч 65% гэж эхлээд 20001-ээс 25.000 баррельд Засгийн газар 50%, гэрээлэгч 50%. Энэ нь “Тг-ын өгсөн саналтай хол зөрүүтэй байгаа. Засгийн газрыг дэмжих сан, орон нутгийг дэмжих санд санал өгөөгүй. Ажлын 5-н жилийн хөрөнгө оруулалтын санал нь 8 дугаар хавтаст хэргийн 242 дугаар хуудсанд байгаа. Нийт 5-н жилд 24.880.000 ам доллар зарцуулах, анхны санал нь 21.120.000 ам доллар байсан байна. Энэ нь манай өгсөн хөрөнгө оруулалтын сангаас даруй 20 гаруй сая ам доллараар бага байгаа. Мөн энэ компани “Н се петролиум” Шарга-3 талбайд, энэ нь 9 дүгээр хавтаст хэргийн 005 дугаар хуудсанд байгаа, рояалти 8%, өртөг нөхөлт 30%, өдрийн бүтээгдэхүүн хуваалт 5000 баррель байвал Засгийн газар 40%, гэрээлэгч 60% байхаар эхлээд 30000 баррель байвал Засгийн газар 50%, гэрээлэгч 50% гэж санал

өгсөн байна. Ажлын хөтөлбөр нийт 5 жилд 25.000.000 ам доллар санал болгосон байна. Харин Бүгд Найрмадах Польш улсын "PCMC" компани бүтээгдэхүүн хуваах Шарга-3 талбайд санал өгөхдөө 8 дугаар хавтаст хэргийн 218-аас 223 дугаар хуудсанд байгаа. Роялти 3%, өртөг нөхөлт 40%, бүтээгдэхүүн хуваалт 0-ээс 5000 баррельд Засгийн газар 20%, гэрээлэгч 80%, Польшийн компани 80% авах нь байна. Ингэж явсаар байгаад 50000-аас дээш байвал Засгийн газар 50%, гэрээлэгч 50%, байгалийн хий олборлох тохиолдолд Засгийн газар 10% гэрээлэгч 90%, ажлын хөтөлбөр нийт 5-н жилд 4.984.000 ам доллар гэж санал өгчээ. Энэ нь манайхаас даруй 10 дахин бага санал. Газрын тосны газрын ажлын хэсэгт "PCMC" компанид хэлэлцээрийн явцад ажлын хөтөлбөр доод тал нь 20.000.000 ам доллар байхаар төлөвлөх шаардлагатай гэж санал болгосон ч "PCMC" компани саналаа өөрчлөөгүй юм байна. Эндээс юу маш тодоор харагдаж байна вэ гэхээр газрын тосны газрын газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудын бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах сонгон шалгаруулалтад манай «Т» компани үнэн шударгаар шалгарсан нь ямар ч эргэлзээгүй. Үүнийг нотлох баримт харуулж байна. Өрсөлдөгчөөсөө хамаагүй илүү санал Монгол Улсын Засгийн газарт санал болгосноороо сонгон шалгаруулалтад шалгарчээ. Бүтээгдэхүүн хуваах гэрээг Эрдэс баялаг эрчим хүчний сайдын хуучнаар Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 33 дугаар тушаалаар бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам, журмын аргачлалд зааснаар ямар ч хүн сонгон шалгаруулалтын оноог бодоход Тг ялагчаар тодрох нь ойлгомжтой байна. Тг аль аль талбайд өрсөлдөгчөөсөө илт давуу санал өгчээ. Ийм бодит нотлох баримт, материал хавтаст хэрэгт илхэн байхад яагаад Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч, Нийслэлийн хяналтын прокурор нар ойшоохгүй, шалгахгүй шүүхэд шилжүүлэв. Сангийн яамнаас томилогдсон төсвийн бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн, мэргэжлээрээ 2 дахь жилдээ ажиллаж байгаа гэж гэрчийн байцаалт өгсөн, С.Т, Авлигатай тэмцэх газрын тоотын дагуу Газрын тосны газрын бүтээгдэхүүн хуваах гэрээнд гэрээлэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд шинжээчээр томилогдон, шинжээчийн 2 хуудас дүгнэлт гаргахдаа энэ

бүгдийг анхаараагүйд асар их гомдолтой байна. Д.Г-ийн Г.Т Авлигатай тэмцэх газарт 2014 оны 03 дугаар сарын 26-нд гэрчээр байцаалт өгөхдөө ажлын хэсгийнхний дунд "Тг" ХХК-ийг Д.Т сайдтай холбоотой компани гэж ярьж байсан гэсэн байх жишээтэй. Ийм цуу яриагаар хүн яллахгүй байх гэж би гүнээ найдаж байна. Бас нэг Газрын тосны газрын ажилтан байцаалт өгөхдөө "Тг" ХХК-ийг Ерөнхийлөгч асан Н.Э-ийн эхнэр н.Ц-гийн компани гэж нэг нь ярьж байсан гэсэн байсан. Ийм цуу яриа яллах дүгнэлтийн суурь болохгүй байх гэж найдаж байна. Иймэрхүү цуу яриа Монголоор нэг байдаг. Ийм цуу яриа л энэ хавтаст хэрэгт манай эсрэг мэдүүлэг болон орсныг хавтаст хэрэгтэй танилцаад ойлголоо. Авлигатай тэмцэх газраас дуудагдаад гэрчийн байцаалт өгөхдөө хүмүүс айж сандардаг юм байна. Мэдэхгүй, санахгүй байна, "Тг" сонгон шалгаруулалтад ялахгүй байсан байх гэсэн гэрчүүдийн мэдүүлэг байсан. Ганцхан Газрын тосны газрын ажилтны мэдүүлэгт миний хариуцсан чиглэлийн хувьд боломжтой гэж үзсэн гэж хавтаст хэрэгт байсан. Гэтэл яагаад салбарын сайдынхаа баталсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмыг аваад, сонгон шалгаруулалтад оролцсон компаниудын эцсийн битүүмжилсэн саналыг аваад оноог хэн нэгэн ахин бодож үзсэнгүй вэ. Энэ бүгд асар харамсалтай бөгөөд эмгэнэлтэй байна. Энд би бас нэг зүйл нэмж хэлэхийг хүсэж байна. Уг бүтээгдэхүүн хуваах гэрээгээр улсаас ганц ч төгрөг гардаггүй, захиалагч компани 100 хувь эрсдэлээ дааж хайгуул хийгээд, газрын тос олдвол бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу олборлолт явуулна. Миний өмгөөлөгчид энэ бүтээгдэхүүн хуваах гэрээний сонгон шалгаруулалтын талаар хэрэгжээгүй, батлагдаагүй тендер тул их юм яриад хэрэггүй гэж зөвлөсөн. Гэвч энэ илт зохиомол гүтгэлэг, хардлагын хор уршигаар өнөөдөр Монголын шилдэг сэхээтнүүдийн нэг, халуун эх оронч, Газрын тосны салбарын хөгжилд маш их хувь нэмэр оруулсан, Газрын тосны газрын дарга асан Д.А-ны алтан амь эрсдээд, түүний ар гэр, үр хүүхэд, найз нөхөд нь, салбарынхан нь тайлагдашгүй уй гашууд автаад байна. Би энэ бүгдийг нэг бүрчлэн ярьж та бүхний цагийг авахдаа энэ эрхэм хүний сайн нэрийг энэ шүүхийн танхимд сэргээх байх, энэ хардлага гүтгэлэг шүүхийн шийдвэрээр зогсох байх гэж гүнээ найдаж энэ бүхнийг ярьж байгаа билээ. Одоо Ц.Ч-д

хөнгөлттэй нөхцөлөөр зарсан орон сууцны талаар тайлбар өгье. Энд хээл хахууль далдалсан ямар ч асуудал байхгүй. Манай Монгол улс хүн ам багатай. Хүн ам багатайгаас үүдээд бизнес эрхэлж байгаа хэнд ч чадалтай, боловсролтой боловсон хүчний асуудал байнга тулгардаг. Өндөр боловсролтой чадварлаг боловсон хүчинтэй боллоо гэхэд тэднийгээ ажлын дадлага туршлагатай болгох асуудал үүсдэг. Цаашлаад чадалтай, туршлагатай боловсон хүчнээ яаж тогтвор суурьшилтай ажиллуулах вэ гэсэн дараагийн толгойны өвчин бизнес эрхэлж байгаа ямар ч хүнд тулгардаг. Энэ бол зөвхөн бизнесийн салбарынхны асуудал биш гэдгийг бүгд мэднэ. Би бизнес эрхэлж байх өнгөрсөн хугацаанд боловсон хүчний асуудал маш чухал гэдгийг эрт ойлгосон. Аливаа залуу ажилтан жаахан туршлага суугаад, чадваржаад эхлэх дээр нь гадны компаниуд өндөр цалин хангамжаар татаад аваад явчихдаг, ард нь үлдэж байгаа компани хүний нөөцийн хямралд ордог. Энэ бол зөвхөн уул уурхай, ашигт малтмалын эрэл хайгуулын салбарынхны толгойны өвчин биш. Аль ч салбарт энэ асуудал байдаг. Иймээс би өөрийн компанидаа чадварлаг боловсон хүчин яаж татах вэ, тэдгээр ирсэн залуусаа яаж тогтвор суурьшилтай ажиллуулах вэ хэмээн удаан бодсоны эцэст цалингаар бусадтай уралдаж дийлэхгүй юм байна. Хүмүүстээ хөрөнгө оруулалт хийе. Иймээс эхлээд боловсон хүчний цөмөө байртай болгоё. Тэд маань энэ компанийн анхдагч цөм болно. Цаашлаад боломж гармагц шат дараалан бүх ажилчидаа байр сууцтай болгоё гэсэн зорилт тавьсан. Үүнийгээ ч өөрийн менежментийн багийхантайгаа нээлттэй ярилцаж, бодол саналаа солилцдог байсан. Хэдэн залуу байртай болоод тохь тухтай амьдраад эхлэхээр бусад нь мөн урамшиж, удахгүй бид байр сууцтай болох юм байна гэсэн итгэл төрж байсан. Би “Тх” компаниа байгуулсан цагаасаа энэ бодлоо тээж явсан. Бололцооны хирээр эхний 7 ажилтандаа байр олгосон байсан. 2013 онд дахиад 5-аас 6 хүн байртай болгоно гэж зорьж байсан. Байр одоогоор өгч чадахгүй бол унаатай болгох гэж санаа тавьж байсан. Тиймдээ ч манай компанид залуучууд тогтвор суурьшилтай ажилладаг. Манай боловсон хүчний урсгал харьцангуй бага. Би бүх ажилчдынхаа нийгмийн асуудалд анхаарал тавихыг эрмэлзэж ирсэн. Ажилчдаа үргэлж сурч боловсрохыг нь

дэмждэг, хэрэв дээд сургууль төгсөөгүй бол суралц, боловсролтой бол, дээд сургууль төгссөн нэгнийг давхар мэргэжил эзэмш, хэрэв хүсвэл сургалтын төлбөрийг чинь компаниасаа гаргана гэж бүгдэд нь хэлдэг байсан. Энэ боломжуудыг ч манай хамт олон сайн ашигладаг байсан. Тэдний нэг нь Ц.Ч юм. Ц.Ч-тай би Германд сурч байх үеэс нь танилцсан. Би цаг үргэлж чадалтай боловсролтой Монгол залуусыг олж компанидаа ажиллуулах юмсан гэж бодож явсан. Хөрөнгө оруулагчид аливаа төслийг шинжихдээ менежментийн баг нь ямар вэ гэсэн үндсэн шалгуур тавьдаг. Чадалтай, туршлагатай менежментийн баг бүрдүүлэхийн тулд би гадаадын туршлагатай мэргэжилтнүүдийг гэрээгээр компанидаа ажиллуулж үзсэн. Тэд маш өндөр цалин хангамж шаарддаг. Тэдний нэгнийх нь жилийн цалин хангамжаар би 3-аас 4 Монгол залууг байр сууцтай болгочих юм байна шүү дээ гэж ойлгосон. Ийм л бодолд хөтлөгдөн би компанийнхаа цөм болох багийг байр сууцтай болгоё гэж хичээсэн. Мэдээж хүн хүнээсээ шалтгаалаад арай өөр өөр нөхцөлөөр тохироод явж байсан. Жишээ нь энд суугаа Н.О «Т» компанийг байгуулсан цагаас хамт ажилласан. Энэ залуу маань сайхан байртай болсон, машинтай болсон. Манайд менежер хийдэг н.Б, геологичоор ажилладаг н.Х, н.Г, н.Э, компьютерийн сүлжээний менежер н.Ц нар бүгд байртай болсон. Би Ц.Ч-ийг Хас банкинд салбарын захирал хийж байхад нь тухайн үед гадаад захирал байрлуулахаар авсан байсан орон сууцаа хөнгөлөлттэй нөхцөлөөр зарахаар тохироод, улмаар байрыг Ц.Ч-д шилжүүлсэн. Н.О, Ц.Ч хоёрт байр өгөхдөө би гэрээ хийгээгүй. Салбар хариуцаад явж байгаа залуучуудтай би орон сууцтай болголоо гээд гэрээ хийе гэж бодоогүй. Энэ нь миний хувьд хувь хүмүүсийн хоорондын харьцаа, итгэлцэл. Энэ итгэлцэл дээр тулгуурлаж бидний ажил явдаг. Цаашдаа ч явна гэж найдаж байгаа. Энэ асуудал үүсгээд байгаа орон сууцнаас гадна Ц.Ч сайн машин компаниасаа авсан. Тэр машин мөн л Ц.Ч-ий нэр дээр байгаа. Энэ хээл хахууль гээд байгаа орон сууц бас Ц.Ч-ий нэр дээр байгаа. Энэ бүгдийг нотлох баримт хавтаст хэрэгт байгаа. Энд будлих, хардах сэрдэх, хэрэг үүсгэх шаардлага юунд байв гэсэн бодол өнгөрсөн хугацаанд миний толгойд эргэлдэж байсан. Харамсалтай нь бусад залуучуудад өгсөн байрыг энэ хэрэгтэй холбоотой гээд

битүүмжилсэн байгаа. Хэрэв энэ хэрэг буруугаар эргэвэл миний хамт ажилладаг залуусын хувьд тэр залуучууд ч гэсэн байргүй болно гэсэн айдас надад үүссэн байна. Хийгээгүй хэргийн төлөө ял тулгаж, хэлмэгдүүлдэг цаг аль дээр өнгөрсөн гэдэгт итгэлтэй байна. Монгол Улс ардчилал, хүний эрхийг дээдлэх замд эргэлт буцалтгүй ороод 25 жил болох гэж байна. Би 2014 оны 05 дугаар сарын 13-ны өдөр 461 дүгээр хорих ангийн шалган нэвтрүүлэх байрны нэг давхарт өмгөөлөгчтэй уулзахын өмнө хоригдогсод хүлээдэг төмөр торон чулуун шалтай хүлээлгийн өрөөнд ухаан алдаад унасан нөхрийнхөө толгойг түшээд Ц.Ч-ий хамт эмч ирэхийг хүлээгээд шалан дээр өвдөглөн сууж байхдаа үгээр илэрхийлж барахгүй бухимдал, гомдолд автсан. Үгээр илэрхийлэхэд бэрх уй гашуу, гарз учирлаа. Тэр өдөр унаад босож ирээгүй андыг минь хэн ч босгож чадахгүй. Гэхдээ шударга хараат бус шүүх өнөөдөр үнэн мөнийг олж өгнө гэдэгт итгэлтэй байна. Талийгаачийн нэрийг цаашид сэвтүүлэхгүй гэдэгт итгэлтэй байна. Учир нь энд хийсэн хэрэг, буруу үйлдэл гэж байхгүй. Бүх нотлох баримт энэ 16 хавтаст хэрэг дотор байгаа. Энэ 16 хавтаст хэрэгтэй 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлээд 4 дүгээр сарын 14-ний 15.00 цаг хүртэл хагас бүтэн сайн алгасалгүй танилцсан. Би хуульч, эрх зүйч мэргэжилгүй. Гэхдээ би боловсролтой иргэн хүний хувьд биднийг буруутгаад байгаа хэргийг цагаатгах нотлох баримт чинь энэ 16 хавтастай баримт юм байна гэсэн итгэл үнэмшилтэй болсон. Үүнийгээ би та бүхэнтэй хуваалцаж байна. Талийгаач Д.А-ны шударга нэр төр өнөөдөр энэ шүүхийн танхимд сэргээгдэнэ гэдэгт итгэлтэй байна. Би анх 2013 оны 07 дугаар сарын 9-нд хоригдсоноос хойш 338 хоног энэ өдрийг хүлээсэн. Учир нь мөрдөн байцаагч дээрээс чигтэй тул би хоригдсоор, прокурор дээрээс чигтэй тул би хоригдол хэвээр. Дээрээс чигтэй, дээрээс чигтэй тул гэсээр өнөөдрийг хүрлээ. Уршгаар нь Монгол хүмүүс хохироод байна. Монгол нутгийн маань хөгжил хойшлоод байна. Монгол хүний амь нас эрсдээд байна. Миний хувьд, миний гэр бүл үр хүүхдүүдийн хувьд, миний найз нөхөд, тэдний гэр бүл, үр хүүхдүүдийн хувьд, манай хамт олны хувьд надад итгээд Монголд хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчдын хувьд дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу болоод 338 хоног болж байна. Өнөөдөр намайг болон надтай

хамтран зүтгэж ирсэн залуучуудыг яллаваас өнөөгийн Монголд хэн ч айдас хүйдэсгүй бизнес эрхэлж болохгүй юм байна гэж Монголчууд ойлгоно, дэлхий даяараа ойлгоно гэдгээс эмзэглэж байна, эмээж байна. Олоогүй орлогоос намайг яллахгүй байх, хэрэгжээгүй сонгон шалгаруулалтаас үүдэн хээл хахуулийн хэрэг тулгаж яллахгүй байх. Өнөөдөр хэрэг хийгээгүй учир надад айдас алга. Харин ардчилсан Монгол Улсын шударга, хараат бус, гагцхүү хуульд захирагдах шүүх үнэн мөнийг олж өгнө гэсэн итгэл байна. Энэ бүхнийг харгалзаад анхнаасаа ямар ч хэрэг байхгүй юм байна гэдгийг харгалзаад шүүхэд энэ хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэж гүнээ хүсэж байна. Хэрэгжээгүй тендер гэж би ярьж байгаа. Энд Газрын тосны газраас 2013 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Дүүргийн Эрүүгийн хэргийн 2 дугаар шүүхэд хандан Газрын тосны албаны дарга н.Ө-гийн явуулсан албан тоот байна. “Тг” ХХК-аас 2014 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/303 албан тоотоор манай газарт хүсэлт гаргасан байна. “Тг” ХХК 2008 онд газрын тосны хайгуулын Нэмэгт-6, Шарга-3 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах гэрээлэгчийн сонгон шалгаруулалтад оролцож шалгарсан болно. Улмаар газрын тосны газраас бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг 200908261/747 тоотоор Эрдэс баялаг, эрчим хүчний яаманд хүргүүлсэн. Одоогоор энэ 2 талбайд байгуулах бүтээгдэхүүн хуваах гэрээний төсөл Монгол Улсын Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцэгдээгүй, гэрээ байгуулагдаагүй болно гэсэн албан тоот байна. Та бүхэнд хүрсэн байх гэж найдаж байна” гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Гэрч Г.Т-гийн шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар мэдүүлсэн: «...Би Х.А захирлыг ажил хэргийн шугамаар танина. Би Газрын тосны газарт гэрээлэлтийн хэлтэст мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, улмаар хэлтсийн даргаар ажиллаж байсан. 2009 оны 01 дүгээр сар хүртэл ажилласан. Тг намайг байх 2009 оны 01 дүгээр сар хүртэлх хугацаанд Эргэл-12, Төхөм-10 гэсэн 2 талбайд захиалгын материал ирүүлж байсан. Энэ 2 талбай дээр миний бие ажлын хэсгийн гишүүнээр мөн ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байсан. Тухайн ажлын хэсгийн үүрэг бол тухайн компанид тодорхой хэмжээгээр дэмжлэг үзүүлэх, эргээд нөгөө

тухайн материал захиалга өгсөн заагдсан хугацаанд зохих төвшинд материалыг нь бүрдүүлэх зохих арга зүйн туслалцаа үзүүлэх үндсэн үүрэгтэй. Энэ шугамаар миний бие ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байхдаа удаа дараа уулзаж байсан...Би 2 удаа мөрдөн байцаагчтай уулзсан. 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдөр, сүүлд 2014 оны 03 дугаар сарын сүүлээр өдрийг нь сайн мэдэхгүй байна, уулзсан. Эхний удаа дэлгэрэнгүй мэдүүлэг авсан. Сүүлийн удаа зөвхөн 2 асуудлын хүрээнд тойрч их олон асуудлаар мэдүүлэг авсан. Шууд утгаараа ямар нэг дарамт үзүүлсэн зүйл байхгүй... Ажлын хэсэгт тодорхой заасан хугацаа байдаг тэр заасан хугацаанд захиалга өгсөн компанитай хэлэлцээр хийж ажиллах үүрэгтэй. Эргэл-12 талбайн хувьд 6 жилийн өмнөх асуудал байгаа. Миний хувьд эргээд санахын тулд өөрийн тухайн үед хийж байсан ажлын хэсэг хуралдаж байсан илтгэх хуудастай танилцаж байж сэргээсэн. 6 жилийн өмнөх материалаа үзэхэд тухайн компанийн хувьд Газрын тосны хуулийн дагуу гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу 3 шалгуур үзүүлэлтээр шалгаруулдаг. Үүнд нэгдүгээрт үндсэн шалгуур, хоёрдугаарт туслах зүйл, гуравдугаарт дэд бүлэг гэсэн энэ 3 үндсэн үзүүлэлтүүд нь бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой, 2 дахь туслах үзүүлэлт нь тухайн компанийн хөрөнгө санхүүгийн чадавхийг, техник тоног төхөөрөмжийн хувьд бололцоотой, чадалтай, хүний нөөцийн хувьд чадалтай, туршлагатай эсэхийг нь тогтоох үзүүлэлтүүд байдаг. Эргэл-12 талбайд “Тг” компани шалгарч чадаагүй, бусад хамт оролцсон компаниудыг бодвол шалгаруулалтад доогуур үзүүлэлттэй байсан болохоор шалгараагүй. Монголын нийтлэг компаниудын хувьд газрын тосны салбар шинэ салбар. Дөнгөж анхдагч компаниуд орж ирсэн. Эдгээрийн нэг нь “Тг” компани байгаа. «ЭСЭ», «МАК», МТ, «Пет» зэрэг компаниуд анх газрын тосны хайгуулын захиалга өгч байсан. Эдгээр компаниудын сул тал гарааны нөхцөл нь гадны компаниудыг бодоход сул байдаг. Боловсон хүчний хувьд сул талтай. Туслах үзүүлэлтээс туслан гүйцэтгэгч компанитай хийсэн гэрээ дутуу хангалтгүй төвшинд байна, тухайн хийх ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргах шаардлагатай байна гэсэн хүсэлтийг ажлын хэсгийн зүгээс тавьсан. Нэмэлт материал бүрдүүлэлт хийгээд түүнийгээ үнэлүүлэх асуудал нь Үнэлгээний хороонд хамааралтай

байдаг. Энэ талаар арга зүйн зөвлөгөө өгч байсан. ...Би өмнөх материалаа үзэж байхад туслан гүйцэтгэгч компани ирэх 5 жилийн хугацаанд бид туслан гүйцэтгүүлэхээр ийм гадны компанитай гэрээ хийнэ гэсэн нөхцөл нь хангалттай бус, гэрээ эх хувиараа байгаагүй, эсвэл тамга тэмдэг нь дутуу байсан гэсэн иймэрхүү зөрчлүүд байсан. Түүнээс биш бүрдүүлэлт бол байсан... Өөрт байгаа архив материалаа үзэхэд Эргэлт-12 талбайтай холбоотой материал байсан. Нэмэгт-6, Шарга-3 талбайн хувьд 2009 оны 01 дүгээр сард би ажлаа өгсөн. Өөр ажилд томилогдсон. Тухайн үед дөнгөж ажлын хэсэг байгуулагдаад дөнгөж материал өгсөн байсан...Цаг хугацааны хувьд 10 дугаар сараас 01 дүгээр сар хүртэл материалтай танилцсан. Гэхдээ ажлын хэсэг ажиллах хугацаа дуусаагүй байсан. Ажлын хэсгийн ахлагчийн ажлыг би өөр ажилд томилогдох болсонтой холбоотойгоор өөр хүнд шилжүүлж өгсөн...Өнөөдрийн хувьд Нэмэгт-6, Шарга-3 материалыг хайгаад дахиж үзэх гээд чадсангүй. Тийм учраас 12 дугаар сард тийм мэдүүлэг өгсөн бол тухайн үед үзсэн материал байх...Мэдүүлгийг би хувилж авч үлдээгүй. Үг, үсэггүй санахгүй байна. Тухайн үед мэдүүлгээ өгөөд гарын үсгээ зурсан...Улсын яллагчийн асуулт: Таны мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэг үнэн үү? гэхэд Гэрчийн хариулт: Үнэн... Улсын яллагчийн асуулт: Нэмэгт-6, Шарга-3 талбай дээр сонгон шалгаруулалт зарлаад та ажлын хэсэгт ажиллаж байхад, таныг ажлаа өгөхөөс өмнө танай ажлын хэсэг хуралдсан уу? гэхэд Гэрчийн хариулт: Ажлын хэсэг хуралдсан...Улсын яллагчийн асуулт: Таныг ажлын хэсэгт ажиллаж байхад “Тг-ын хувьд ямар нэг байдлаар гуйж асууж байсан зүйл байна уу? гэхэд Гэрчийн хариулт: Тийм зүйл байхгүй... Мөрдөн байцаалтын шатанд эхний удаа бүх дэлгэрэнгүй мэдээлэл авсан. Сүүлд 2 зүйлд асуусан бараг 2 цагийн хугацаанд байцаалт авсан. “Тг-ын зүгээс танд дарамт шахалт үзүүлж байсан уу, танай удирдлагуудын зүгээс дарамт шахалт үзүүлж байсан уу гэж асууж байсан. Дарамт шахалт байгаагүй...Тухайн үед намайг ажиллаж байхад ажлын хэсэг яг агентлагийн даргын тушаалаар байгуулагддаг. Ажлын хэсэг болон Үнэлгээний хороо байдаг. Хамгийн эхлээд тухайн компани материалаа агентлагт өгнө. Түүний дагуу эхний байдлаар үнэлэлт дүгнэлт хийгээд ажлын хэсэг гаргая гэсэн тушаал гаргадаг, ажлын хэсэг

тухайн материал дээр ажиллаад хичнээн компани материал ирүүлсэн байна тухайн компани бүр дээр хүмүүсээ томилоод эргээд компани тус бүртэй хэлэлцээр хийгээд зохих төвшинд хуулийн хүрээнд материал бүрдүүлэхэд нь арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж ажилладаг..Ажлын хэсэг 2008 онд байгуулагдсан. Хуулийн хүрээнд агентлагийн даргын тушаалаар ажлын хэсгийн ахлагчаар томилогдож ажилласан. 01 дүгээр сард миний бие ажлаа өгсөн. Ажлын хэсэг надаас хойш 14 хоног ажилласан байх ёстой... Шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуулт: Шарга-3, Нэмэгт-6 талбай дээр ажлын хэсгийн ахлагч байж байгаад явцын дунд өөр ажилд орсон гэж байна. Тэгэхээр өнөөдөр таны дараа шалгарсан Шарга-3, Нэмэгт-6 талбайд эцсийн шалгаруулалт болсон, болоогүй гэж яригдаж байгаа энэ асуудалд эцсийн үр дүнд Тг компани шалгарах боломжтой байсан, боломжгүй байсан гэдэгт үнэлэлт, дүгнэлт өгөх эрх, боломж танд бий юу? гэхэд Гэрчийн хариулт: Үнэлэлт өгөх эрхгүй. Дэмжлэг үзүүлэх эрхтэй...Шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуулт: Таныг ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байхад Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А "Тг" ХХК-ийг дэмжих боломж бий юу гэж асууж байсан гээд таны мэдүүлэгт тусгагдсан байна. Таны хувьд журмын дагуу явна гэж хэлсэн гэсэн өгүүлбэр байна. Ийм асуудал болж байсан уу? гэхэд Гэрчийн хариулт: Ажил эрхэлсэн даргын үүднээс тухайн ажил байдалтай танилцах эрх байгаа, энэ үүднээс талийгаач даргад танилцуулж байсан. 2008 оноос өмнөх онуудад дандаа гадны хөрөнгө оруулалттай компаниуд шалгарч байсан. Манай агентлаг дотоодын компанийг оруулж ирэх боломж байна уу, гадны компанитай ижил төвшинд ажиллах боломжоор хангахад асуудал юу байна вэ гэдэг асуудал байсан. Тэр ч үүднээс тухайн үед санхүүгийн болон техникийн чадвартай компаниуд материалаа ирүүлж байсан...Шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуулт: Үндэсний компанийг дэмжих боломж байна уу? үндэсний компаниуд орж ирж байна уу гэж асууж байсан гэж ойлгож болох уу? гэхэд Гэрчийн хариулт: Тийм...Шүүгдэгч Х.А-ын асуулт: Бүтээгдэхүүн хуваах гэрээний битүүмжилсэн саналдаа Шарга-3, Нэмэгт-6 талбайд Тг ямар санал өгсөн гэдгийг та мэдэх үү? гэхэд Гэрчийн хариулт: Мэдэхгүй байна, санал нь Үнэлгээний хороонд очиж байгаа...» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Гэрч О.Э-ын шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар мэдүүлсэн: «...2009 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Төхөм-10, Шарга-3, Нэмэгт-6 талбайн сонгон шалгаруулалтын гишүүнээр орсон...Сонгон шалгаруулах зөвлөлд Уул уурхайн яам, тухайн үеийн Газрын тосны асуудал хариуцсан яам, Сангийн яамны төлөөлөл оролцдог Н.А орсон...Шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуулт: Н.А Монголын "Тг" компани санхүүгийн тайланд аудит хийлгээгүй, санхүүгийн тайлангаа зөрүүтэй гаргасан байна. Ажлын хэсэг муу ажилласан байна. Санхүүгийн болон бусад баримтуудыг компаниас гаргуулж аваагүй байсан гэсэн зүйл хэлжээ. Энэ хүнд энэ компанийг сонгон шалгаруулахаас татгалзах эрх байсан уу? гэхэд...Гэрчийн хариулт: Байхгүй. Сонгон шалгаруулах үйл ажиллагаа тухайн үеийн Үйлдвэр худалдааны сайдын баталсан журмын дагуу явагддаг. Журмын 7.7-д зааснаар олонхийн саналаар хамтын шийдвэр гаргана. Н. А тухайн үед санал хэлбэрээр хэлж байсан байх, олонхийн саналаар шийдэх ёстой...Би түрүүн хэлсэн журмын 7.7-д сонгон шалгаруулах зөвлөл олонхийн саналаар шийдвэр гаргадаг. Үнэлгээний хорооноос хамгийн өндөр оноо авсан компанийг шалгаруулж бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг үзэглэх шийдвэр гаргах талаар зөвлөмж гаргахад 100 хувь гараа өргөж дэмжсэн гэсэн үг. Гарын үсэг зурж баталгаажуулдаг...Байхгүй. Тг тухайн үед Төхөм-10 /урд/ талбай дээр сонгон шалгаруулалтад оролцож байсан. Тэр ажлын хэсгийг би ахлаж ажиллаж байсан. Энэ 2 хүнийг ажлын шугамаар танина. Шарга-3, Нэмэгт-6 талбай дээр яг журмын дагуу ажил нь явагдсан. Шан харамж авсан зүйл байхгүй...Энэ хэрэгтэй холбогдуулаад Авлигатай тэмцэх газраас шалгаж байх явцад бид нарыг маш олон удаа дуудаж байцааж байсан. Үнэлгээний хороонд би орж ажиллаагүй. Гэхдээ Үнэлгээний хороотой холбогдсон материалын эх хувь олдохгүй байсан. Яагаад би үүнийг сайн мэдэж байна вэ гэхээр тухайн үед би гэрээлэлт хайгуул судалгааны хэлтсийн даргаар ажиллаж байсан. Миний хариуцаж байсан ажил учраас тэр материалтай холбогдуулж маш олон удаа очиж байцаалт өгч байсан. Үнэлгээний хорооны материалыг бид хайж байх явцдаа Үнэлгээний хороонд ажиллаж байсан хүмүүстэй уулзаж, яг Үнэлгээний хорооны даргаар хэн ажиллаж байсан бэ,

тухайн үед 2 агентлаг салж байсан үе нь байна. Төсөл дээр талийгаач Д.А-ны нэр явж байдаг. Тэгэхэд манай Үнэлгээний хороонд ажиллаж байсан н.Аг гээд геологич байгаа. Санхүүч Ш.Ц 2 бол Үнэлгээний хорооны даргаар талийгаач даргыг ажиллаагүй Л.Сүх ажилласан гэж надад хэлсэн. Үүнийг гэрчлэх хүн нь манай Газрын тосны газар ажиллаж байсан н.Д, А.Тү гэж 2 хүн байгаа. А.Тү нь манайд ажиллаж байгаа. Н.Д одоо Уул уурхайн яаманд ажиллаж байгаа. ...Ажлын хэсэгт төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс ордог. Санхүүч, геологич, хуульч, Үнэлгээний хороонд бас ийм мэргэжлийн хүмүүс ордог. Тухайн үед ажлын хэсэг үнэлгээ хийх боломжтой гэж дүгнэлт гаргасан бол Үнэлгээний хороо тэрийг зайлшгүй үнэлэх үүрэгтэй, журмын дагуу татгалзах боломж байхгүй. Хэрэв зөрчил гэж тогтоогоогүй тохиолдолд зайлшгүй үнэлэх шаардлагатай. Энэ тал дээр би санал нийлэхгүй байна. Яагаад ийм дүгнэлт гаргах болсныг сайн ойлгохгүй байна...Шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуулт: "Т" бүлэг компани шалгарсан нь зөв гэж та хэлэх гэж байна уу? гэхэд Гэрчийн хариулт: Тийм...Сонгон шалгаруулах зөвлөл анх захиалгын материалын бүрдэл бүрэн эсэхийг ажлын хэсэг хянадаг. Энэ сонгон шалгаруулалт маань өөрөө 3 үе шаттай явагдаж байгаа. Ажлын хэсэг доод тал нь сарын хугацаанд компанийн материалыг судалж, үнэлгээнд оруулах боломжтой эсэх талаар шийдвэр гаргадаг. Үнэлгээний хороо битүүмжилж ирүүлсэн бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцөл гэж байгаа, тэр нь хэрэв тос олохын бол улсад юу юу өгөх вэ олсон тосныхоо хэдэн хувийг улсад өгөх вэ гэдгээ битүүмжилсэн саналаар ирүүлдэг. Тэр битүүмжилсэн саналыг Үнэлгээний хороо, бүх компани ижил төвшинд, ажлын хэсэг ч мэдэхгүй, битүүмжилсэн саналыг аваад ажлын хэсгээс үнэлгээнд оруулах боломжгүй гэсэн дүгнэлт гараагүй тохиолдолд яг тэр тоогоор нь үнэлнэ. Тоогоор нь үнэлэхдээ энэ журмын хавсралтын аргачлалд туслах үзүүлэлтээс бусад нь томъёогоор гарна. Журмын 9.1-д Монголын талд ашигтай санал өгсөн Үнэлгээний хорооны дүгнэлтээр хамгийн дээд оноо авсан захиалгыг шаардлагад нийцсэн захиалга гэж хэлнэ гэж заасан байгаа. Үүний дагуу хамгийн өндөр оноо авсан компанийг шалгаруулаад, гэрээний төслийг үзэглэхээр эрх олгогдоод явдаг...Ажлын хэсэг тухайн үед Ашигт малтмал, Газрын тосны газар

хоёр хамтдаа нэг агентлаг байхад ажлын хэсгийн тушаалууд гарсан байгаа. Хавтаст хэрэгт авагдсан байгаа. Үнэлгээний хорооны тушаал олдоогүй. Гэхдээ Үнэлгээний хороонд ажилласан хүмүүс ажилласан гэдгээ хэлж байсан. Энэ тухай Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчид хэлж байсан... Журмын дагуу сонгон шалгаруулахтай холбогдсон материал маань журмын 6.4-т байна. Захиалга хүлээн авах, хянан үзэх, үнэлэх, харьцуулах, сонгон шалгаруулалтын талаар эцсийн шийдвэр гарч гэрээ байгуулах зөвлөмж, гэрээ байгуулах тухай мэдээлэл захиалагчид өгөх хүртэл сонгон шалгаруулалттай холбогдсон мэдээллийн материалыг задруулахыг хориглоно гэсэн байдаг. Энэ журмын дагуу нарийн бичгээс нарийн бичгийн гарт дамжаад явдаг. Жишээ нь, ажлын хэсгийн нарийн бичиг битүүмжилсэн материалаа Үнэлгээний хорооны нарийн бичигт өгөөд, тэр нарийн бичиг сонгон шалгаруулах зөвлөлийн нарийн бичигт өгөөд, тэр нарийн бичиг нь сайдад танилцуулж шийдвэр гардаг. 2 агентлаг салж байх үед материал нь үнэндээ хайгаад олдоогүй...Олдоогүй, бүх архивт, яамны архивт хүртэл хайсан...Би 2009 оны 3 дугаар сард гэрээлэлт хайгуул судалгааны хэлтсийн даргаар ажиллаж байсан. Энэ үед 2 агентлаг салж байсан үе. Энэ процесс маань өмнө нь болоод өнгөрсөн асуудал. Мөрдөн байцаагч нэхсэний дагуу архивтаа хайгаад олохгүй, компьютерийн файлуудаа үзээд, С.Са гэж залуугийн файл миний компьютерт байсан файл адилхан байсан тул тэр файлаас хэвлэж аваачиж өгсөн...Оноо гаргахад туслах, үндсэн, дэд үзүүлэлтүүдийг бүгдийг нь үнэлээд, үнэлсэн үнэлгээгээр хамгийн өндөр оноо авч байгаа...Улсын яллагчийн асуулт: Та сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан уу? гэхэд Гэрчийн хариулт: Ажилласан...Улсын яллагчийн асуулт: Та яг ямар асуудлыг хариуцсан бэ? гэхэд Гэрчийн хариулт: Би нефтийн геофизикч мэргэжилтэй. Дараа нь Хууль зүйн дээд сургуулийг төгссөн. Тухайн үед би 3 дугаар сард гэрээлэлт хайгуул судалгааны хэлтсийн даргаар томилогдсон...Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн нь тусгайлан энэ хүн энэ талаар дүгнэлт гаргана гэж байхгүй. Ажлын хэсгийн гишүүд хуульч бол эрх зүйн баримт бичигт нь, санхүүч санхүүгийн бичиг баримтад нь гаргадаг. Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн нь ажлын хэсэг Үнэлгээний хорооны санал дүгнэлтийг

үндэслээд өөрийн дотоод итгэлээр санал өгнө. Тусгай асуудал хариуцсан зүйл байхгүй...Тийм зүйл байхгүй, би яагаад гэвэл санхүүч биш учраас санхүүгийн чиглэлээр дүгнэлт гаргуулсан хүмүүсийн дүгнэлтийг үндэслэнэ гэхээс би санхүүгийн мэргэжилгүй учир үзэж чадахгүй...Сонгон шалгаруулах зөвлөл зөвлөмж гаргаж байгаа. Зөвлөмжийг тухайн үеийн сайд тушаалаар батална. Тэр нь гэрээ байгуулах биш гэрээний төслийг үзэглэх тухай байдаг...Энэ бол журам нь өөрөө зөрчил гэж тогтоосон тохиолдолд үнэлэхгүй. Тэгэхээр ажлын хэсэг нь өөрөө санхүүгийн боломжтой гээд дүгнэлт гаргасан, Үнэлгээний хорооны гишүүдийн нэг нь санал гаргасан. Тэгээд санал хураагаад 100 хувийн саналаар дэмжсэн. Зөрчил гэж тогтоогдсон зүйл байхгүй учраас журмаараа үнэлэхгүй байх боломжгүй...Би өмнө хэлсэн сонгон шалгаруулалтад төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс оролцдог. Үүнийг санхүүгийн чиглэлийн хүн нь хянаад саналаа хэлсэн...» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

4. Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолын хамт битүүмжилсэн тогтоол, тэмдэглэл /1хх-ийн 41-43/

5. Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолын үнэлгээ /1хх-ийн 86-87/

6. Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод нэгжлэг хийх тогтоол, тэмдэглэлийн хамт /1хх-ийн 108-112/

7. Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ... тоотод нэгжлэгээр хураан авсан эд зүйл, бичиг баримтад үзлэг хийсэн тэмдэглэл /1хх-ийн 113-128/

8. Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо, Залуучууд гудамж-..., Сөүл бизнес центр ...дугаар давхар, "Тг" ХХК-ийн захирал Х.А-ын ажлын өрөө, захирал Ё.О-ны өрөө, Х.А-ын Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр нэгжлэгээр хураан авсан эд зүйл, бичиг баримтад үзлэг хийсэн тэмдэглэл /1хх-ийн 130-167/

9. Газрын тосны газрын архивын баримт бичигт үзлэг хийсэн тэмдэглэл /1хх-ийн 177-179/

10. Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан «Шарга-3», «Нэмэгт-6» талбайнуудад «Тг» ХХК-ийг шалгаруулсан сонгон шалгаруулах зөвлөл болон түүнтэй холбоотой материалд үзлэг

хийсэн тэмдэглэл /1хх-ийн 180-241/

11. Хан-Уул дүүргийн бүртгэлийн хэлтсийн 2013 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 377 дугаартай албан бичиг /7хх-ийн 67-116/

12. 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1-123 дугаартай Газрын тосны газрын албан бичиг /7хх-ийн 164-167/

13. 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 4/238 дугаартай Уул уурхайн яамны албан бичиг /7хх-ийн 169-174, 176-211/

14. Гэрч Д.Ө-ын мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «...»Тг» ХХК-ийн захирал Х.А-ыг танина. Манай компаниас байр захиалан авсан. Үйлчилгээний журмаар танина...Би одоо үнэхээр санахгүй байна. Энд миний гарын үсэг зурагдсан байна. Тийм болохоор энэ орон сууц захиалан бариулсан 372.480.000 төгрөг төлсөн гэж үзэж байна...» гэсэн мэдүүлэг /2хх-0/

15. Гэрч О.Э-ын мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн:

"...Үйлдвэр худалдааны сайдын 2008.02.14-ний өдрийн 33 дугаар тушаалаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас гадаад, дотоодын ижил төрлийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдээс газрын тосны талбайн захиалга авч, гэрээ байгуулах үйл ажиллагааг зохих ёсоор шуурхай явуулах шаардлагад нийцүүлэн "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмыг баталсан. Мөн тушаалын 2 дугаар заалтаар уг журмыг Үйлдвэр худалдааны яам болон Ашигт малтмал, газрын тосны газрын дотоод удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаанд мөрдөхөөр болсон байдаг. Журмын 6.4-т заасны дагуу Сонгон шалгаруулалтын эцсийн шийдвэр гарч, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж, гэрээ байгуулах мэдэгдлийг захиалагчид өгөх хүртэл хугацаанд сонгон шалгаруулалттай холбогдсон материал, мэдээлэл задруулахыг хориглоно гэж заасны дагуу ажлын хэсэгт орсон гишүүд нууц хадгалах талаар баталгааг гаргадаг. Журмын 7 дугаар зүйлд заасны дагуу Үнэлгээний хороог тухай бүр Газрын тосны даргын тушаалаар томилох юм. Үнэлгээний хороог Газрын тосны газрын "газрын тосны асуудал хариуцсан" мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулна. Журмын 7.2-т заасны дагуу үнэлгээг Ажлын хэсгээс битүүмжилсэн материалыг актаар хүлээн авсан өдрөөс

хойш ажлын 10 хоногт багтааж хийж дуусгана. Журмын 8 дугаар зүйлд заасны дагуу үндсэн, туслах, дэд үзүүлэлтээр үнэлгээ хийнэ. Үүнд: Үндсэн үзүүлэлт нь байгалийн нөхөн сэргээгдэшгүй баялгийг ашигласны төлбөр, бүтээгдэхүүн хуваалт нөхөх зардлын хувь хэмжээ хамаарна. Үнэлгээний хороонд битүүмжлэн өгсөн “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний үндсэн нөхцлүүдэд өгсөн саналаар уг журмын хавсралтад дурдсан “бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний сонгон шалгаруулалтын аргачлалаар оноо өгч, үнэлгээ хийнэ...Журмын хавсралтын 2-т заасан туслах үзүүлэлтийн 1 дэх хэсгийг үнэлэхдээ гэрээлэгч, туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, мэргэжлийн чадавхийг үнэлэхдээ тухайн захиалагч болон хөрөнгө оруулагч компанийн газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан эсэх, эсхүл мэргэжлийн компанитай гэрээ санамж бичиг байгуулсан эсэх, мэргэжлийн зөвлөх инженерүүдийн багтай эсэх, гэрээ байгуулсан тохиолдолд хайгуул судалгааны ажлыг хэрхэн хийх талаар ирүүлсэн бичиг баримтыг харгалзан үнэлдэг. Санхүүгийн чадавхийг үнэлэхдээ тухайн захиалагч болон хөрөнгө оруулагч компанийн санхүүгийн тайлан аль нэг банк, хөрөнгө оруулалтын сангуудаас хөрөнгө оруулалт хийх баталгаа авсан эсэх, тухайн захиалагч болон хөрөнгө оруулагч компанийн өмнө нь эрхэлж байсан үйл ажиллагаа, хэрхэн амжилттай хэрэгжиж байсан зэргийг харгалзан үнэлдэг. Энэ хэсгийг үнэлэхдээ Үнэлгээний хорооны гишүүд Захиалгын материал, ажлын хэсгийн санал, дүгнэлтийг харгалзан өөрсдийн дотоод итгэлээр 0-15 оноо өгнө. Туслах үзүүлэлтийн 2-т заасан гэрээлэгч, туслан гүйцэтгэгч нарын хооронд гэрээ хийсэн эсэх, харилцан хүлээх үүргийг үнэлэхдээ газрын тосны мэргэжлийн компанитай гэрээ хийсэн эсэхийг харгалзан оноо өгнө. Ямар нэг урьдчилан тохиролцоо байхгүй бол 0 оноо өгдөг. Ямар нэг гэрээ байх юм бол тэрийг Үнэлгээний хорооны гишүүд өөрийн дотоод итгэлээр 10 хүртэл оноо өгнө. Журмын хавсралтын туслах үзүүлэлтийн 3 дахь хэсэгт заасан ашиглахаар санал болгож буй техник, технологи, тоног төхөөрөмжийг үнэлэхдээ захиалгын материалд дурдсан хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэх арга аргачлал, хэрэглэх тоног төхөөрөмжийг харгалзан Үнэлгээний хорооны гишүүд 0-10 хүртэл оноог өөрсдийн дотоод итгэлээр өгнө. Журмын хавсралтын туслах үзүүлэлтийн

4 дэх хэсэгт заасан хайгуулын хугацаанд заавал хийж гүйцэтгэх үндсэн ажлыг үнэлэхдээ захиалгад дурдсан заавал хийж гүйцэтгэх ажлаа мэргэжлийн төвшинд хэрхэн төлөвлөснийг харгалзан Үнэлгээний хорооны гишүүд өөрсдийн дотоод итгэлээр 0-20 хүртэл оноо өгнө...Ингээд үндсэн үзүүлэлт, туслах үзүүлэлт, дэд үзүүлэлт тус бүр авсан оноог нэмж захиалагчид өгөх үнэлгээний оноог гаргана. Журмын 8.7, 8.8-д заасны дагуу Үнэлгээний хороо санал, дүгнэлтээ илтгэх хуудас үйлдэн хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан Сонгон шалгаруулах зөвлөлийн нарийн бичгийн даргад холбогдох баримт бичгийн хамт дугтуйлан битүүмжлэн лацдаж хүргүүлнэ. “Тг” ХХК нь Шарга-3 болон Нэмэгт-6 талбайд захиалга ирүүлсэн ба Ажлын хэсэгт нь хуучнаар Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Б-ны 2009.01.14-ний өдрийн 12 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Ажлын хэсгийн ахлагчаар Гэрээлэлтийн хэлтсийн дарга Г.Т, одоо “Эрдэнэс МГЛ”-т ажиллаж байгаа, гишүүдээр Гэрээлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Н, Гэрээний хэрэгжилтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.А, Олборлолт, тээвэрлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн А.П, Олборлолт тээвэрлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Н.У нар байсан. Үнэлгээний хорооны гишүүдээр томилогдсон хүмүүсийн тушаал нь одоо олдохгүй байгаа. АМГТХЭГ-ын даргын 2009.01.14-ний 12 дугаар тушаалын 3-т заасны дагуу Ажлын хэсэг хэлэлцээг 2009.02.16-ны дотор хийж дуусган холбогдох материалыг бүрдүүлэн битүүмжилж Үнэлгээний хороонд актаар хүлээлгэн өгөхийг даалгасан байдаг. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 7.2-т заасны дагуу үнэлгээг Ажлын хэсгээс битүүмжилсэн материалыг актаар хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногт багтаан хийж дуусгана гэж заасан байдаг. Харин Үнэлгээний хорооны илтгэх хуудсын төслийг Гэрээлэлтийн хэлтсийн дарга Г.Т-гийн ажил хүлээлцэх үед компьютерийн файл дотор байсан. Энэ илтгэх хуудсаар Үнэлгээний хорооны гишүүдэд Үнэлгээний хорооны даргаар газрын тосны газрын дарга Д.А, нарийн бичгийн даргаар Гэрээлэлтийн хэлтсийн мэргэжилтэн С.Са, гишүүдэд Газрын тосны газарт ажиллаж байсан Л.Сүх, Д.А, С.Н, Ш.Ц, Л.А, Э.Т, Н.О нар ажиллаж байсан. Эрдэс баялаг Эрчим хүчний сайдын 2009 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 79

дүгээр тушаалаар Сонгон шалгаруулалтын зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг баталсан. Зөвлөлийн даргаар Газрын тосны газрын дарга Д.А, нарийн бичгийн даргаар А.Тү, гишүүдэд Н.Б, П.Х, Л.Р, Г.Э, М.А, Д.А, О.Э нар ажилласан юм... Үнэлгээний хорооны санал дүгнэлтэд дурдсан асуудалтай танилцаагүй ээ. Хэрвээ Үнэлгээний хорооны илтгэх хуудсанд дурдсан санал дүгнэлтийн талаар Сонгон шалгаруулах зөвлөл дээр яригдсан бол энэ асуудал нь тэмдэглэл дээр тусгагдах ёстой. Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэл дээр энэ талаар дурдаагүй байна...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 68-73, 74-76/

Гэрч Г.Т-гийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «...Д.А-ыг танина. Ажил хэргийн шугамаар танина...»Тг» ХХК-ийн захирал Х.А-ыг танина. Ажил хэргийн шугамаар танина. Намайг Газрын тосны газарт ажиллаж байхад газрын тосны олон улсын нээлттэй тендерт материалаа ирүүлж байсан. Энэ компанийн материалыг би үзэж байсан юм. Тэр шугамаар танина. Энэ материалыг үзэх Ажлын хэсгийн даргаар би ажиллаж байсан юм. Хуучнаар ашигт малтмал, газрын тосны газраас зарлагдсан Олон улсын нээлттэй тендерийн захиалгын материал хүлээн авах Эргэл-12 хайгуулын талбайд «Тг» ХХК нь захиалгын материал ирүүлсэн байсан. Ажлын хэсэг 2008.06.23-наас 2008.07.21-ний дотор хэлэлцээрээ хийж дуусгах ёстой байсан. Хэлэлцээрийн явцад тухайн компаниас бүрдүүлж ирүүлсэн материал нь шаардлага хангахгүй байсныг Ажлын хэсгээс мэдэгдэж, ирүүлсэн материалыг буцааж байсан. Тухайн үед «Т» ХХК-ийн хувьд Эргэл-12 талбайд хайгуулын ажлын туслан гүйцэтгэгчээр ажиллах гадны компаниудтай санамж бичиг, гэрээ байгуулаагүй, ирүүлсэн санамж бичиг нь баталгаажаагүй, хуулбар хувь ирүүлсэн байсан. Мөн санхүүгийн чадварыг нотлох баримт бичгүүд нь тухайн компанийн санхүүгийн чадварыг тодорхойлох боломжгүй, хангалтгүй байсан. Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байсан тул Ажлын хэсгээс материалыг буцааж байсан. Энэ талбайтай холбоотой захиалгын материалыг хэлэлцэхдээ Ажлын хэсэг 2 удаа уулзалт хийгээд дутуу материалаа бүрдүүлэхийг шаардаж байсан. «Т» ХХК-ийн зүгээс дутуу материалаа бүрдүүлж өгөөгүй, захиалгын материалыг буцаан өгч цаашид

оролцох боломжгүй талаар 2008.07.04-ний өдрийн хэлэлцээрээр манай Геологи, хайгуулын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.А, нарийн бичгийн даргаар Гэрээлэлтийн хэлтсийн мэргэжилтэн З.Б бид гурав «Тг» ХХК-ийн зүгээс ерөнхий захирал Х.А, ерөнхий менежер Н.О нараас шаардаж байсан. Дараа нь манай байгууллагаас Нэмэгт-6, Шарга-3 талбай дээр захиалга авах сүүлийн хугацаа нь 2008.12.05-ны өдөр дуусгавар болох байсан. Уг хоёр талбай нь байгалийн цогцолбор газарт хамрагдаж байсан тул уг асуудлыг шийдвэрлэх хүртэл буюу 2009.01.05-ны өдөр сунгах арга хэмжээг байгууллагаас авах байсан. Харин 2008.10.20-ны өдөр «Тг» ХХК нь Шарга-3, Нэмэгт-3 талбайнуудад Олон улсын нээлттэй тендерт дахин захиалгын санал ирүүлсэн байсан. Тус компаниас ирүүлсэн захиалгын саналд Ажлын хэсэг 2009.01.05-ны өдрөөс эхлэн ажилласан байх ёстой. 2009.01.14-ний өдөр Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын даргын 12 дугаар тушаалаар Ажлын хэсэг 2009.02.16-ны өдөр хүртэл ажиллах талаар тусган «Тг» ХХК-ийн захиалгын материал дээр Ажлын хэсгийн даргаар би, гишүүдэд ахлах мэргэжилтэн Ч.Н захиалгын материалын бүрдэл хэсэг, дүрэм журмын дагуу ирүүлсэн эсэхийг нягтлан, ахлах мэргэжилтэн Л.А геологийн талаар үнэлэлт дүгнэлт өгөх, ахлах мэргэжилтэн А.П, мэргэжилтэн Н.У нар нь тухайн компанийн санхүүгийн чадварыг нотлох талаар тус тус ажилласан. Миний хувьд 2009.01.27-ны өдрөөс эхлэн өөр газарт томилогдон ажиллахаар болоод уг ажлыг Геологи, хайгуулын хэлтсийн даргаар ажиллаж байсан Ж-д Ажлын хэсгийн ажлыг өгсөн юм. Намайг Ажлын хэсэгт ажиллах хугацаанд «Тг» ХХК-ийн захиалгын материал нь Эргэл-12 хайгуулын талбайд өгсөн материалтай адилхан байсан ...Миний санаж байгаагаар манай Ашигт малтмал, газрын тосны газрын дэд даргаар ажиллаж байсан Д.А нь «Тг» ХХК-ийг «дэмжих боломжтой юу» гэж асууж байсан. Тухайн үед нь би Ажлын хэсгийн даргаар ажиллаж байсны хувьд журмын дагуу явна гэж хэлж байсан. «Тг» ХХК-ийн захиалгын материалыг судлах Ажлын хэсэг намайг ажиллаж байх үед хуралдаагүй байх...»Тг» ХХК-ийн Эргэл-12 хайгуулын талбайд ирүүлсэн материал, түүнийг судалсан дүгнэлт нь надад байна. Мөн Нэмэгт-6, Шарга-3 талбайд ирүүлсэн захиалгын материалыг судлаж үзсэн хоёр

дүгнэлт нь бүгд надад байна. Эндээс харахад ялгагдах зүйл байхгүй. Өмнөх Эргэл-12 өгсөн захиалгын материалтай адилхан байна. Энэ компанийн хувьд ирүүлсэн захиалгын материалуудыг үзэхэд тухайн компанийн санхүүгийн чадавхийг нотлох баримт бичгийн бүрдэл болон туслан гүйцэтгэгчээр ажиллах чадавхийг нотлох баримт бичгүүд хангалтгүй байсан...»Тг» ХХК-ийн газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайд ирүүлсэн захиалгын материалыг танилцаж судлах Ажлын хэсгийн даргаар ажиллаж байхад Д.А нь «Тг» ХХК-ийн талаар асууж байсан. «Энэ компанийн хувьд материал нь хэр байгаа бэ, явц байдал нь ямар байгаа юм, энэ компанийн ирүүлсэн материалын хувьд дэмжих боломжтой юм уу» гэж асууж байсан. Би уг компанийн ирүүлсэн материалын хүрээнд дүрэм журмын дагуу явна гэж хэлсэн. Өөр хүмүүс тухайн үед “Т” компанийн талаар асуусан зүйл байхгүй. Ажлын хэсгийн дунд хэн хэлсэн нь мэдэгдэхгүй дам яриа байдаг байсан. «Тг» ХХК-ийг Д.Тэрбишдагва сайдтай холбоотой компани гэж ярьж байсан...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 77-79, 102-103/

Гэрч С.С-ын мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн:

“...Д.А-ыг бол танина. Газрын тосны газарт хамт ажиллаж байсан. Ажил хэргийн холбоотой. Харин “Тг” ХХК-ийн захирал Х.А-ыг танихгүй. Харин энэ компанийн газрын тосны хайгуулын талбайн тендерт ирүүлсэн материалд нь үнэлгээ хийхэд материалыг нь танилцаж байсан. Компанийн хүмүүстэй нь уулзаж байгаагүй. Би Үнэлгээний хорооны нарийн бичгээр ажилласны хувьд үнэлгээний явцыг тэмдэглэж, тэмдэглэл хөтөлсөн. Мөн хүснэгт гаргаж Үнэлгээний хорооны гишүүдэд танилцуулж гарын үсэг зуруулаад Үнэлгээний хорооны дүгнэлт гарган төлөвлөж, Үнэлгээний хорооны гишүүдэд бүгдэд нь танилцуулж, Сонгон шалгаруулах зөвлөлийн нарийн бичгийн даргад бүх бичиг баримтыг хүлээлгэж өгсөн. Анх тендерт оролцох компаниудын Ажлын хэсэг гэж гарч ажилласан. Харин “Тг” ХХК-ийн Ажлын хэсэгт би байгаагүй болохоор сайн мэдэхгүй байна. Тендерийн Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажилласны хувьд тус компанийн өгсөн үндсэн үзүүлэлт орох саналаар нилээн дээгүүр санал өгсөн байсан. Тэгээд Үнэлгээний хороо өгсөн оноог нь бүрдүүлээд Сонгон шалгаруулалтын зөвлөлд өгсөн юм. Үнэлгээний хороо 1 удаа

хуралдсан. Үнэлгээний хорооны гишүүдэд хэн хэн орсон талаар одоо санахгүй байна. Үнэлгээний хороог ажиллах зохион байгуулалтын ажлыг хийх талаар хуучнаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Газрын тос хариуцсан дарга Л.Сүх томилсон. “Тг” ХХК-ийн Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах захиалгын материалд Ажлын хэсэг ажилласан хурлын тэмдэглэл болон бусад бичиг баримттай танилцсан. Харин дуу хураагуур дээр бичигдсэн гэх зүйлтэй танилцаагүй. Бусад протокол тэмдэглэлтэй танилцсан. Ажлын хэсэг ажилласан баримт бичгүүд нь одоо архивт байгаа гэж бодож байна. Сайн мэдэхгүй байна. Үнэлгээний хорооны ажилласан ажлын тэмдэглэл болон зүйлүүдийг би эх хувиар нь гарын үсэг зурж баталгаажуулсан. Бичиг баримтуудыг би Сонгон шалгаруулах зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилогдсон А.Тү-д хүлээлгэн өгсөн. Харин хүлээлгэн өгсөн баримт байхгүй...”Тг” ХХК-ийн хувьд газрын тосны чиглэлээр хайгуулын үйл ажиллагаа явуулах өөрсдийн хүчин чадал болон техник тоног төхөөрөмж байхгүй, туршлага байхгүй байсан. Харин гадны компанитай урьдчилсан гэрээ юм уу, эсвэл санамж бичиг байгуулсан бол тухайн гадны компанийг судлах шаардлагатай юм. Энэ компани Норвегийн дэлхийд газрын тосны чиглэлээр тэргүүлэгч компанитай санамж бичиг байгуулсан байсан. Өөр туршлага бол байгаагүй. Энэ компанийн захиалгын материалд Ажлын хэсгийн гишүүд одоо нэрийг нь санахгүй байна “Тг” ХХК-ийг “компанийн хөрөнгө чинь дутуу байна, та нар энэ ажлыг хийж чадахгүй байна” гэхээр доороо баахан охин компанитай эд нараас хөрөнгө татах боломжтой гэж баахан компанийн танилцуулга авчирдаг байсан юм. Мөн хэн хэлснийг санахгүй байна Ажлын хэсэг болон Үнэлгээний хорооны гишүүдийн дунд нэг явган яриа байдаг нь “Тг” ХХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Н.Э-ын эхнэр н.Ц-гийн компани гэсэн яриа яригдаж байсан. Хэн хэлснийг нь мэдэхгүй. Гэхдээ гишүүдийн дунд тийм яриа бол яригдаж байсан. Бид нар хоорондоо “Тг” ХХК нь ийм олон компанитай, их хэмжээний хөрөнгөтэй юм бол яагаад “Н” компани шиг олонд танигдсан нэртэй болоогүй юм бэ гэж хүртэл ярьдаг байсан юм. «Тг» ХХК-ийн захиалгын материалд ирүүлсэн Норвегийн «Лг групп»-тэй хамтран ажиллах санамж

бичгийн эх хувиар нь үзээгүй. Хуулбар хувь байсан ба яг үнэлгээ хийгээд эхэлсэн учир үзэх боломж бол байгаагүй...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 104-107/

Гэрч А.П-ийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн:

«...Би Ажлын хэсгийн тушаалыг үзээгүй. Ажлын хэсэгт орж ажиллаагүй. Тухайн үед би өвчтэй байсан болохоор энэ талаар мэдэх зүйл байхгүй. Учир нь тэр үед өвчтэй хагалгаанд орсон байсан юм. Энэ Ажлын хэсэгт орсон гэдгээ сая өнөөдөр мэдэж байна. Би энэ ажлын хэсэгт огт оролцоогүй...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 108-109/

Гэрч Ш.Ц-ийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «... Үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан. Үнэлгээний хороо ажиллахдаа Ажлын хэсгээс ирүүлсэн материалуудыг компани тус бүрээр нь үзээд холбогдох санал дүгнэлтээ өгдөг юм. Миний хувьд бол тухайн компаниудын эдийн засгийн чадавхи, санхүүгийн тайлангийн үзүүлэлт, хийгдэх ажлын хөтөлбөр төсвийг нь бусад компаниудтай зэрэгцүүлж үздэг. Тэгж байж дүгнэлтээ гаргадаг. «Тг» ХХК-ийн хувьд ямар байсныг одоо сайн санахгүй байна. Олон компанийн материалыг үзэж байсан болохоор санахгүй байна. Уг компанид ямар үнэлгээ өгсөн нь гарын үсэг зурагдсан үнэлгээн дээр байгаа гэж бодож байна. 2009.02.23-ны өдөр Үнэлгээний хорооны илтгэх хуудсанд «Тг» ХХК нь захиалгын материалдаа олон тооны компаниудтай газрын тосны үйл ажиллагаанд хамтран оролцож санхүүжилт хийхээр дурдсан. Гэвч эдгээр компаниудад нь газрын тостой холбогдолтой үйл ажиллагаанд, улмаар «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-гээр аливаа хариуцлага хүлээх нь Монгол Улсын иргэний хууль тогтоомжийн дагуу эрх зүйн үндэслэлгүй байх тул зөвхөн «Тг» ХХК-ийн санхүүгийн тайлан, холбогдох бичиг баримтад үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой юм. «Тг» ХХК-ийн 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс харахад орлого, үр дүнгийн тайланд борлуулалтын орлого тусгагдаагүй, 40 сая төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай, тайлангаа аудитаар баталгаажуулаагүй зэрэг үндэслэлээр санхүүгийн чадавхийг үнэлэхэд хүндрэлтэй байна. «Зоос» банкны 2008.08.20-ны өдрийн 1020 тоот албан бичиг, «Голомт» банкны 2008.10.16-ны өдрийн 08/109 тоот албан бичиг нь цаг хугацааны хувьд шаардлага хангахгүй байна. Учир

нь өнөөгийн байдлаар үүсээд байгаа банк санхүүгийн хямрал, бэлэн мөнгөний хомсдол зэрэг бодит байдал нь дээрх албан бичиг ирүүлсэн хугацааны дараа болж байна. Мөн тус компанийн 2008.10.03-ны өдөр орж ирсэн 2.000.000 ам доллар нь ямар байгууллагаас юунд зориулагдан ирсэн нь тодорхой биш байгаа тул үйл ажиллагаа явуулах санхүүгийн боломжгүй, зөвхөн аль нэг талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах боломжтой байж болох талтай байна» гэсэн үнэлэлт дүгнэлт өгсөн байна. «Тг» ХХК-ийн хувьд яг ийм бодит байдал болж байсан болоод ийм дүгнэлт өгсөн байна. Одоо миний санаж байгаагаар энэ асуудал болж байсан. Эдийн засгийн чадавхгүй гэдэг нь энэ материалаас харагдаж байгаа болохоор энэ компани ийм өндөр оноо авч байгаа нь эргэлзээтэй болж байна. Бодит байдал дээр энэ компани ийм л байсан. Яг үнэнийг хэлэхэд би өөрийнхөө өгсөн үнэлгээг хэлж мэдэхгүй байна. Гэхдээ дээрх байдлаар компанийн санхүүгийн байдлыг харахад ийм өндөр оноо өгөх боломжгүй оноо өгсөн. Хүснэгтийг үзлээ. Энэ өгсөн оноонд итгэхгүй байна. Учир нь гарын үсэг байхгүй байна...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 120-122/

Гэрч П.Х-гийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «...Газрын тосны газрын хурлын зааланд 2009.04.16-ны өдөр хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах, «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах Зөвлөлийн хурал болсон. Энэ зөвлөлийн бүтээгдэхүүнд хуучнаар Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Түлшний бодлогын газрын орлогч дарга Б, мэргэжилтэн Р, миний бие яамнаас уг бүрэлдэхүүнд оролцсон. Уг Сонгон шалгаруулах зөвлөлийн хуралдаанд Газрын тосны хайгуулын Төхөм-10 /урд/, Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад захиалга ирүүлсэн компаниудын үнэлгээнд сонгон шалгаруулалт явуулах зорилготой байсан...2 дугаарт Газрын тосны хайгуулын Нэмэгт-6 талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар захиалга ирүүлсэн компаниудын асуудлыг хэлэлцсэн. Дээрх талбайд 2 компани захилга ирүүлснээс Үнэлгээний хороо үнэлж «Т» компани оноогоор тэргүүлж 1 дүгээр байр эзэлсэн байсан. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу 1 дүгээр байр эзэлсэн компанийг дэмжсэн Ажлын хэсгийн хүмүүс бүгд 100 хувь дэмжиж оролцсон...3

дугаарт Газрын тосны хайгуулын Шарга-3 талбайд захиалга ирүүлсэн компаниудын өгсөн үнэлгээнд сонгон шалгаруулалт хийх байсан. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу Үнэлгээний хороо үнэлгээ хийлгэж, мөн эхний байрт «Тг» ХХК нь шалгарсан байсан. Уг шалгаруулалтад миний хувьд БНПУ-ын «РСМС» компанитай «Бүтээгдэхүүн хуваах гэрээ» байгуулахаар хэлэлцээр хийх Ажлын хэсэгт Газрын тосны газарт ажиллаж байхдаа орж ажиллаж байсан. БНПУ-ын «РСШС» компани нь газрын тосыг хайгуулын үе шатнаас газрын тосны эцсийн бүтээгдэхүүн гарах хүртэл бүхий л үе шатны ажлыг дангаараа гүйцэтгэдэг Польш улсдаа төдийгүй Европт нэр хүндтэй компани байсан. Үнэлгээгээр тус компани нь хамгийн сүүлийн байранд орсон байсан. Хэрвээ эхний байранд шалгарсан компанитай ойролцоо оноо авсан байсан бол Польшийн энэ компанийг Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдээс дэмжиж ажиллах байсан. Нэгэнт оноо доогуур байсан учраас «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу үнэлгээнд хамгийн өндөр оноо авсан «Тг» ХХК-ийг дэмжсэн болно. Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд нь Үнэлгээний хорооны үнэлгээг бодитой байна уу, үгүй юу гэдгийг дүгнэлт гаргах, Үнэлгээний хорооны үнэлгээг хүчингүйд тооцох, сонгон шалгаруулахаас татгалзах санал гаргах эрхтэй байдаг. Үнэлгээний хорооны дүгнэлтийг Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд танилцана. Шаардлагатай гэсэн тохиолдолд үнэлгээ өгсөн материалтай танилцана. Хэрвээ Үнэлгээний хорооны өгсөн үнэлгээ нь бодит байдалд нийцэхгүй бол «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг Сонгон шалгаруулах журмын 11 дүгээр зүйлийн 11.2-т зааснаар Сонгон шалгаруулалтын материалыг хянан үзэх, сонгон шалгаруулалт хийх, гэрээ байгуулах, эрх олгох, зөвлөмж гаргах, Сонгон шалгаруулах зөвлөл нь зарлал мэдээллийг зохих журмын дагуу явуулсан, оролцогчдоос захиалгаа ирүүлэхэд нь ижил хугацаа олгосон, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж шаардлагад нийцсэн захиалга ирүүлсэн эсэхийг хянах, Сонгон шалгаруулах зөвлөл нь энэ журмын дагуу хянаж зөрчил илрүүлсэн тохиолдолд гэрээлэгч сонгох ажиллагааг зогсоож, энэ журмын дагуу тухайн ажиллагаа, эсхүл үнэлгээг, тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дахин хийлгэх

эрх үүрэгтэй ажиллах юм. «Тг» ХХК-ийн талаар сайн мэдэхгүй байна. Ажлын хэсэг, Үнэлгээний хорооны материалтай сайн танилцаагүй. Ажлын хэсгээс боломжтой гэж үзэн тус компанийн захиалгын материалыг Үнэлгээний хороонд өгсөн байх гэж бодож байна. Ер нь Ажлын хэсэг бол «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-г байгуулахаар захиалга ирүүлсэн компани, аж ахуйн нэгжээс эхлээд тухайн компанийн хайгуулын ажил гүйцэтгэх чадвартай гэсэн санхүүгийн баталгааг гаргуулж авдаг. Үүний дараа мөн мэргэжлийн баг, боловсон хүчин ажиллах чадвартай эсэхийг үзнэ. Хэрвээ тухайн компани мэргэжлийн баг, боловсон хүчин байхгүй тохиолдолд мэргэжлийн туслан гүйцэтгэгч компани, аж ахуйн нэгж авч ажиллуулах боломжтой. Сонгон шалгаруулах зөвлөл дээр үнэлгээ хийгдсэн компаниудын талаарх аль аль компани ямар оноо авсан, хэддүгээр байр эзэлсэн талаар ямар компани оролцсон талаар танилцуулсан. Одоо миний санаж байгаагаар Үнэлгээний хорооны илтгэх хуудас танилцуулагдаагүй гэж үзэж байна. Асуусан асуултын хүрээнд «Тг» ХХК-ийн талаар танилцуулаагүй. Хэрвээ ийм асуудал танилцуулагдсан бол Зөвлөлийн гишүүд Үнэлгээний хороонд дахин асуудлыг буцааж, дахиж материалын бүрдлийг бүрдүүлэх ёстой байсан. Эсхүл Үнэлгээний хорооны гишүүд тухайн компанийн материалыг иж бүрдэл дутуу гэж үзээд үнэлэхээс татгалзах ёстой байсан. Үнэлгээний хорооны илтгэл дээр тавигдсан БНПУ-ын «РСМС» компанийн холбоотой асуудлыг Сонгон шалгаруулах зөвлөлийн хурал дээр энэ асуудал танилцуулагдаагүй. Хэрвээ танилцуулагдсан бол Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэл дээр миний хэлсэн үг байгаа. БНПУ-ын «РСМС» компани нь газрын тосны хайгуулаас газрын тосны эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэл үйлдвэрлэх чадвартай санхүүгийн хувьд компани, өөрөө дангаараа шийдэх боломжтой талаар хурлын тэмдэглэлд дурдсан байгаа. Хэрвээ дээрх асуудал танилцуулагдсан бол Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд анхаарлаа хандуулах байсан болов уу гэж бодож байна...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 135-139/

Гэрч Л.О-ийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «...2009 оноос Газрын тосны газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчээр ажиллаж байсан. Газрын тосны газрын даргын тушаал, шийдвэрээр ажиллаж байгаа бүх бичиг

баримт нь архивт хадгалагдах ёстой байдаг. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийн болон Үнэлгээний хороо, Сонгон шалгаруулах зөвлөлийн баримт бичгүүдийг тухайн ажил хариуцсан Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга бүрдүүлээд архивт өгөх үүрэгтэй. Тэр өгсөн материалыг би хадгалах үүрэгтэй юм. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах захиалгын материалд ажиллах Ажлын хэсгийн материал, Үнэлгээний хорооны материал, Сонгон шалгаруулах зөвлөлийн материалуудыг ажил хариуцсан хүмүүс нь эцсийн шийдвэр гараагүй тул «нууц» гээд өөр дээрээ байлгадаг. «Тг» ХХК-ийн газрын хайгуулын талбайд өгсөн захиалгын үдэгдсэн материалууд бол байгаа. Харин танай 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 06/352 дугаар албан бичигт дурдсан зүйлүүд бол манай архивт байхгүй...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 144-145/

Гэрч М.А-гийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «... Сонгон шалгаруулах зөвлөл нь Ажлын хэсэг, Үнэлгээний хороо зохих ажлаа хийсний дараа Сонгон шалгаруулах зөвлөлийн нарийн бичиг хурлын товыг Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдэд хэлдэг. Тэрний дагуу «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах хуралд оролцдог. Газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6, Төхөм-10 талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүнээр уг хуралд оролцсон. Сонгон шалгаруулах зөвлөлийн хурал хэзээ, хэдэн удаа болсныг одоо би санахгүй байна. Сонгон шалгаруулах зөвлөл нь нэг удаа хуралдсан шиг санагдаж байна. Угаасаа эцсийн байдлаар материалууд нь орж ирдэг болохоор 1 л удаа хуралдсан. Ажлын хэсэг, Үнэлгээний хорооны гаргасан шийдвэртэй танилцаад санал хураах журмаар санал хураагаад олонхийн зөвлөлийн гишүүд шийдвэрээ гаргадаг. Үнэлгээний хорооны дүгнэлтээр хамгийн өндөр оноо авсан нь «Тг» 2009.04.17-ны өдөр «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэлд «Тг» ХХК-ийн талаар «...Монголын «Тг» ХХК нь санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй, санхүүгийн тайланг зөрүүтэй гаргасан байна. Ер нь Ажлын хэсэг муу ажиллажээ. Санхүүгийн баримт бусад материалыг

бүрэн хэмжээнд компаниас гаргуулж аваагүй байна...» гэж тэмдэглэсэн байсан. Тухайн үед би энэ асуудлыг хэлж байсан нь үнэн. «Тг» ХХК-ийн санхүүгийн тайлан нь 1 дүгээрт, гараар бичигдсэн, 2 дугаарт санхүүгийн тайлан аудитаар баталгаажуулаагүй, мөнгөн дүн зөрүүтэй байсан тул Ажлын хэсэг муу ажилласан, нэмэлт материал шаардахгүй яасан юм гэсэн үүднээс хандаж хэлсэн. Үнэлгээний хорооны албажаагүй илтгэх хуудсанд: «...»Тг» ХХК нь захиалгын материалдаа олон тооны компаниудтай газрын тосны үйл ажиллагаанд хамтран оролцож санхүүжилт хийхээр дурдсан байна. Гэвч эдгээр компаниудад нь газрын тостой холбогдолтой үйл ажиллагаанд, улмаар «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний аливаа хариуцлага хүлээх нь Монгол Улсын иргэний хууль тогтоомжийн дагуу эрх зүйн үндэслэлгүй байх тул зөвхөн «Тг» ХХК-ийн санхүүгийн тайлан, холбогдох бичиг баримтад үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой юм. «Тг» ХХК-ийн 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс харахад орлого үр дүнгийн тайланд борлуулалтын орлого тусгагдаагүй, 40 сая төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай, тайлангаа аудитаар баталгаажуулаагүй зэрэг үндэслэлээр санхүүгийн чадавхийг үнэлэхэд хүндрэлтэй байна. «Зоос» банкны 2008 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 1020 тоот албан бичиг нь цаг хугацааны хувьд шаардлага хангахгүй байна. Учир нь өнөөгийн байдлаар үүсээд байгаа банк санхүүгийн хямрал, бэлэн мөнгөний хомсдол зэрэг бодит байдал нь дээрх албан бичиг ирүүлсэн хугацааны дараа болж байна. Мөн компанийн 2008 оны 10 дугаар сарын 03-ны өдөр орж ирсэн 2.000.000 ам доллар нь ямар байгууллагаас, юунд зориулагдан ирсэн нь тодорхой биш байгаа тул газрын тосны хайгуулын 2 талбайд нэгэн зэрэг «Бүтээгдэхүүн хуваах гэрээ» байгуулж үйл ажиллагаа явуулах санхүүгийн боломжгүй, зөвхөн аль нэг талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах боломжтой байж болох талтай байна» гэсэн байна. Энэ талаар мэдэхгүй байна. Таны асуусан асуултын хүрээнд энэ байдлыг сая мэдэж байна. Үнэлгээний хороо ийм илтгэх хуудас бичиж байгаа нь сонин байна. Учир нь ийм өндөр оноо авсан компанийн ард нь сонин тайлбар хийж байгаа нь ойлгомжгүй байна...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 146-149/

Гэрч А.Тү-ын мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэд үүлсэн: «...»Тг»

ХХК-ийн захиалгын материалыг судалсан Ажлын хэсгийн материалууд бол над дээр ирээгүй. Харин Үнэлгээний хорооны санал дүгнэлт нь битүүмжлэгдэн ирсэн. Энэ дотор бол Ажлын хэсгийн материал байхгүй байсан. Үнэлгээний хорооны хуралдсан хурлын тэмдэглэл, санал дүгнэлт, илтгэх хуудас зэрэг материалуудыг ирүүлсэн байсан. Ажлын хэсэг ажилласан материал нь яасан талаар би мэдэхгүй байна. Надад энэ материал нь ирээгүй. Үнэлгээний хорооны материалын 1 хувийг нь тухайн үеийн Эрдэс баялаг эрчим хүчний сайд Д.З сайдад өгүүлэхээр манай газрыг хариуцаж байсан П.Х-д өгсөн. Үлдсэн хувийг нь миний ажлын өрөөнд байрлах онгорхой, цоожгүй битүүмжлэлгүй шкафанд хадгалаж байсан бөгөөд 2011 оны 05 дугаар сард би Австрали улс руу суралцахаар яваад хэн нэгэнд хүлээлгэн өгснөө сайн мэдэхгүй байна. Учир нь олон компанийн материалууд байсан ба одоо зөвхөн «Тг» ХХК-ийн Үнэлгээний хорооны санал дүгнэлт, илтгэх хуудас, хурлын тэмдэглэл болон түүнтэй холбоотой материалууд олдохгүй байна. Одоо би «тэр авсан», «энэ авсан» гэж хэлж чадахгүй байна. 1 дүгээрт журмын дагуу бол Ажлын хэсгийн материал надад ирүүлэх ёсгүй. 2 дугаарт Сонгон шалгаруулах зөвлөл дээр Үнэлгээний хэсгээс хүлээлгэн өгсөн материалын лацыг шалган задалж үзэхэд Үнэлгээний хэсгийн илтгэх хуудас, хурлын тэмдэглэл, захиалга өгсөн компаниудын үндсэн нөхцөлд өгсөн санал зэрэг гарч ирсэн талаар Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэл дээр тусгагдсан байгаа юм. Ажлын хэсгийн материал олдохгүй байгаа асуудлыг би мэдэхгүй байна...Үнэлгээний гишүүдийг томилсон тушаалыг олоогүй. Уг тушаал нь байгууллагын архивт байгаагүй. Үнэлгээний хорооны ажилласан гарын үсэгтэй илтгэх хуудас нь олдоогүй. Иймд Газрын тосны газрын Хайгуул, судалгааны хэлтсийн компьютер дотор хадгалж байсан файлаас Үнэлгээний хорооны хүмүүсийн нэрсийг олж авч, тухайн хүмүүс Үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан үгүйг тодорхойлох зорилгоор тэдгээр хүмүүстэй уулзсан. Ихэнх хүмүүс нь ажлаас гарсан хүмүүс байсан. Өөр буруу санаа, зорилго агуулаагүй. Яагаад ингэх болсон бас нэг шалтгаан нь журмын 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаас бусад гишүүнийг Үнэлгээний хорооны гишүүнээр томилж болно гэхээр Д.А дарга Үнэлгээний

хорооны даргаар орсон бол Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар томилж болохгүй болж таарсан. Ингээд Үнэлгээний хорооны гишүүдтэй уулзсан юм. Үнэлгээний хорооны албажаагүй илтгэх хуудсанд» ...»Тг» ХХК нь захиалгын материалдаа олон тооны компаниудтай газрын тосны үйл ажиллагаанд хамтран оролцож санхүүжилт хийхээр дурдсан байна. Гэвч эдгээр компаниудад нь газрын тостой холбогдолтой үйл ажиллагаанд, улмаар «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний аливаа хариуцлага хүлээх нь Монгол Улсын иргэний хууль тогтоомжийн дагуу эрх зүйн үндэслэлгүй байх тул зөвхөн «Тг» ХХК-ийн санхүүгийн тайлан, холбогдох бичиг баримтад үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой юм. «Тг» ХХК-ийн 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс харахад орлого үр дүнгийн тайланд борлуулалтын орлого тусгагдаагүй, 40 сая төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай, тайлангаа аудитаар баталгаажуулаагүй зэрэг үндэслэлээр санхүүгийн чадавхийг үнэлэхэд хүндрэлтэй байна. «Зоос» банкны 2008 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 1020 тоот албан бичиг нь цаг хугацааны хувьд шаардлага хангахгүй байна. Учир нь өнөөгийн байдлаар үүсээд байгаа банк санхүүгийн хямрал, бэлэн мөнгөний хомсдол зэрэг бодит байдал нь дээрх албан бичиг ирүүлсэн хугацааны дараа болж байна. Мөн компанийн 2008 оны 10 дугаар сарын 03-ны өдөр орж ирсэн 2.000.000 ам доллар нь ямар байгууллагаас, юунд зориулагдан ирсэн нь тодорхой биш байгаа тул газрын тосны хайгуулын 2 талбайд нэгэн зэрэг «Бүтээгдэхүүн хуваах гэрээ» байгуулж үйл ажиллагаа явуулах санхүүгийн боломжгүй, зөвхөн аль нэг талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах боломжтой байж болох талтай байна гэсэн энэ асуудлыг ярилцаагүй. Сангийн яамнаас Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүнээр оролцсон М.А хэлсэн учраас энэ тэмдэглэл дээр тусгагдсан. М.А-г үг хэлж байх үед би хэлсэн үгийг нь тэмдэглэж авсан. «Тг» ХХК-ийн шалгаруулсан Үнэлгээний хорооны илтгэх хуудсанд Үнэлгээний хорооны дүгнэлт гэсэнд «...Нэмэгт-6 талбайд «Тг» ХХК-ийг шалгаруулсан байна. Харин Шарга-3 талбайд БНПУ-ын «РСШС» компани бага оноо авсан боловч газрын тосны мэргэжлийн бөгөөд санхүүгийн чадвартай тул тус компанитай «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-г байгуулах талаар хэлэлцээг хийх нь зүйтэй, стратегийн

түншлэлийн харилцааг бий болгох санал гаргаж байсан байна. Хэрэв энэ асуудал яригдсан бол Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэл дээр тусгагдсан байх ёстой. Хэрэв энэ талаар хэн нэгэн хүн үг хэлсэн бол тэмдэглэл дээр тусгагдаад нөгөө хүний нэртэйгээ тэмдэглэлд орох ёстой. Тэгэхээр энэ асуудал яригдаагүй болохоор гишүүд хурлын тэмдэглэлд гарын үсэг зурсан гэсэн үг...Тийм асуудал байж болохгүй. Үнэлгээний хорооны илтгэх хуудас нь тодорхой хувиуд байсан. Гишүүд өөрсдөө танилцах үүрэгтэй. Уншиж танилцсан байх ёстой. Уншиж танилцах нь тэдний үүрэг юм...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 154-158/

Гэрч Л.Сүх-ийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «...2013 оны сүүлээр байх 11 дүгээр сарын сүүлээр Газрын тосны газарт ажилладаг А.Тү нь Үнэлгээний хорооны илтгэх хуудас гээд нэг зүйл барьчихсан энэ тэмдэглэл дээр нөхөж гарын үсэг зуруулж байгаа юм гэхээр нь би илтгэх хуудсыг хараад Д.А даргын үед ийм асуудал хариуцаж байгаагүй, би эх материал байхгүй байгаа учир гарын үсэг зурахаас татгалзсан...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 123-124/

2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн шинжээчийн дүгнэлтэд: "...1-ээс 6 дугаар асуулттай холбоотой материал, нотлох баримт зэрэг нь Уул уурхайн яамны болон Газрын тосны газрын архивт архивлагдаагүй байна гэсэн Газрын тосны газрын 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1-123 албан тоот болон Уул уурхайн яамны 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 4/238 албан тоотыг ирүүлсэн тул дүгнэлт гаргах боломжгүй байна. Эрдэс баялаг, Эрчим хүчний сайдын 2009 оны 79 тоот тушаалаар Газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6, Төхөм-10 талбайнуудын "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан байна. Дээрх Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд 2009.04.17-ны өдөр сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Тус баталгаажуулсан хурлын тэмдэглэлтэй танилцахад Зөвлөлийн зарим гишүүд БНПУ-ын "РСШС" компанийг дэмжих хүсэлтэй байсан боловч үнэлгээний оноо хэтэрхий доогуур байсан байна. Мөн Зөвлөлийн гишүүн М.А нь "Тг" ХХК нь санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй, санхүүгийн тайланг зөрүүтэй гаргасан,

санхүүгийн баримт, бусад материалыг бүрэн хэмжээнд компаниас гаргуулж аваагүй, Ажлын хэсэг муу ажилласан гэсэн санал хэлсэн байна. Түүнчлэн Зөвлөлийн гишүүн Н.Б нь "Тг" ХХК-ийг газрын тосны хайгуулын 2 талбайд зэрэг хөрөнгө оруулж чадах эсэхэд эргэлзэж байна гэсэн байна. "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 11 дүгээр зүйлийн 11.2-т "СШЗ нь энэ журмын дагуу хянаж зөрчил ирүүлсэн тохиолдолд гэрээлэгч сонгох ажиллагааг зогсоож, энэ журмын дагуу тухайн үйл ажиллагаа, эсхүл үнэлгээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дахин хийлгэх" гэж заасан байтал Зөвлөлийн гишүүдийн дээр дурдсан саналыг үндэслэн зохих арга хэмжээ авалгүйгээр "Тг" ХХК-ийн захиалгыг дэмжсэн байна. Иймд тус Сонгон шалгаруулах зөвлөл нь журмын дагуу ажилласан эсэх нь эргэлзээтэй байна. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад "Тг" ХХК-ийн ирүүлсэн захиалгын материалуудтай танилцахад тус компанийн санхүүгийн чадавхийг нотлох материалууд нь баталгаажаагүй байна. Түүнчлэн тус компанийн гадны туслан гүйцэтгэгч компаниудтай хамтарч ажиллах гэрээ байгуулаагүй, санамж бичиг байгуулсан бөгөөд тус санамж бичгээ эх хувиар нь ирүүлээгүй байна. Санамж бичиг нь эрх зүйн харилцаа үүсгэхгүй бөгөөд талууд аливаа эрх зүйн хариуцлага үүрэхгүй тул тус компаниас туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг шаардах нь зүйтэй байсан гэж үзэж байна. Иймд "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 8.4.2-т заасан "Сонгон шалгаруулалтын үнэлгээний туслах үзүүлэлт"-ийг тус компани нь хангахгүй байгаа тул газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад шалгарах боломжгүй байсан байна..." гэжээ. /2хх-ийн 206-212/

Шинжээч С.Т-ын мөрдөн байцаалтын шатанд мэдүүлсэн: «...Авлигатай тэмцэх газраас надад шинжээчийн дүгнэлт гаргуулахаар шинжилгээ хийлгэх тухай тогтоол ирүүлсэн уг тогтоолд Газрын тосны газрын Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулсан 7 асуулга ирүүлсэн үүний дагуу шинжээчээр ажилласан шинжээчээр ажиллахад 1-6 асуултын хүрээнд хариулах боломжгүй байсан учир нь түүнтэй холбоотой албан ёсны баримт бичиг байгаагүй, харин «Тг» ХХК-ийн Газрын тосны

хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах зөвлөлийг журмын дагуу ажилласан эсэхэд шинжээчийн дүгнэлтээр тодруулж өгсөн болно. Сонгон шалгаруулах бүтээгдэхүүнийг журмын дагуу баталсан гэхдээ сонгон шалгаруулах зөвлөлийн протоколыг уншихад зөвлөлийн зарим гишүүд горимын зөрчилтэй санал хэлсэн байна. Жишээлбэл зөвлөлийн гишүүн М.А «Тг» ХХК-ийг санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй санхүүгийн тайлан зөрүүтэй гаргасан, санхүүгийн баримт бусад холбогдох материалыг тус компаниас бүрэн гаргуулж аваагүй ажлын хэсэг муу ажилласан гэсэн санал хэлсэн байна түүнчлэн сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн Н.Б «Тг» ХХК-ийг Газрын тосны хайгуулын 2 талбайд зэрэг хөрөнгө оруулж чадах эсэхэд эргэлзэж байна гэсэн байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 11 дүгээр зүйлийн 11.2-т сонгон шалгаруулах зөвлөл нь энэ журмын дагуу хянаж зөрчил илэрүүлсэн тохиолдолд гэрээлэгч сонгох ажиллагааг зогсоож энэ журмын дагуу тухайн үйл ажиллагааг эсхүл үнэлгээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дахиж хийлгэх гэж заасан байхад зөвлөлийн гишүүний дээр дурдсан саналыг үндэслэн зохих арга хэмжээг авалгүйгээр «Тг» ХХК-ийг сонгон шалгаруулсан байна. Иймд уг сонгон шалгаруулах зөвлөл нь журмын дагуу ажилласан эсэх нь эргэлзээтэй байна. Түүнчлэн тус компанийн Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад ирүүлсэн захиалгын материалуудтай танилцахад / шинжилгээнд ирүүлсэн/ тус компанийн санхүүгийн чадавхийг нотлох материалууд нь баталгаажаагүй байсан. Мөн «Тг» ХХК-ийн гадны туслан гүйцэтгэгч компаниудтай хамтарч ажиллах гэрээ байгуулаагүй санамж бичиг байгуулсан бөгөөд тус санамж бичгийг нь эх хувиар нь ирүүлээгүй байна санамж бичиг нь Эрх зүйн харилцаа үүсгэхгүй бөгөөд талууд аливаа эрх зүйн хариуцлага үүрэхгүй тул «Тг» ХХК-наас туслан гүйцэтгэгчэй байгуулсан гэрээг нь шаардах нь зүйтэй байсан гэж үзэж байна. Иймд Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 8.4.2-т заасан сонгон шалгаруулалтын үнэлгээний туслах үзүүлэлтийг тус компани хангахгүй байгаа тул Газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад шалгарах боломжгүй байсан гэж үзэж байна...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн

213-214/ гэх зэрэг нотлох баримтуудаар хөдөлбөргүй нотлогдон тогтоогдож байна.

Шүүгдэгч Х.А, Д.А нь урьд ял шийтгэл хүлээж байгаагүй болох нь ял шалгах хуудас /бхх-ийн 234, 235/-аар тус тус тогтоогдлоо.

Шүүгдэгчийг сэжигтэн, яллагдагчаар, хохирогч, гэрч нарыг байцаахдаа Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 144, 146, 147 дугаар зүйлд заасан хуулийн шаардлага хангасан, нотлох баримтууд нь тухайн хэрэгт хамааралтай, агуулгын хувьд зөрүүгүй, үйл баримтыг хангалттай тогтоож чадсан, албан ёсоор томилогдсон /2хх-ийн 205, 206, 207/ 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн С.Т шинжээчийн дүгнэлтийг хэрэгт хувийн сонирхолгүй, зохих мэдлэг, дадлага, туршлагатай, гаргасан дүгнэлтийнхээ хариуцлагыг хүлээх чадвар бүхий шинжээч гаргасан байх тул хууль ёсны үнэн зөв баримтууд гэж үнэлэв.

Прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар Х.А, мөн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар Д.А нарт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн нь шүүгдэгч Х.А, Д.А нарын үйлдэлд тохирсон байна.

Учир нь:

Ц.Ч-ийн мөрдөн байцаалтад сэжигтнээр болон яллагдагчаар "...Анхны 50.000 ам долларыг Хадам ээжийн дүү О-аас зээлсэн... Х.А-т өгсөн..." гэсэн мэдүүлэг /бхх-ийн 223, 231/ өгсний дагуу мөрдөн байцаагч, гэрч Ч.О-аас Ц.Ч-ийн мэдүүлэгтэй холбогдуулан мэдүүлэг авах гэсэн боловч Гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээ эдлэн мэдүүлэг /2хх-ийн 163-164/ өгөхөөс татгалзсан, Д.А, Ц.Ч нараас мөрдөн байцаалтад сэжигтнээр болон яллагдагчаар «... Энэ байрыг түрээсэлж байгаа, энэ талаар /Д.А-ны эхнэр/ Д.Н мэдэж байгаа ...» гэсэн мэдүүлэг /бхх-ийн 148-149, 152, 223, 232/ өгсний дагуу Д.А-ны эхнэр Д.Н-гаас мэдүүлэг авахад мөн л Гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээ эдлэн татгалзсан байгаа нь шүүгдэгч нарын тайлбарлаж байгаа тухайн орон сууцны үнэнд төлсөн төлбөр, мөн байрыг түрээслэн сууж байсныг үгүйсгэх нөхцөл байдал болсон гэж үзэхээр байна.

Мөн Х.А-ын мөрдөн байцаалтад өгсөн: «...Д.А-тай 2008 оны хавар танилцаж байсан, хуучнаар Үйлдвэр худалдааны сайд Х.Н-тэй уулзахад Газрын дэд дарга /Газрын тосны

газрын дэд дарга/ явж байгаа энэ хүнтэй уулз гээд танилцуулж байсан түүнээс хойш таних болсон бидний хувьд найз нөхдийн холбоо байгаа, гэр бүлийн найзууд...» гэсэн мэдүүлэг /6хх-ийн 190/,

Д.А-ны оршин сууж байсан орон сууц: Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод / Уг байранд 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр нэгжлэг хийхэд Д.А гэр бүлийн хамтаар амьдарч байсан тухай энэ хэрэгт эд мөрийн баримтаар видео бичлэг авагдсан/,

Х.А-ын оршин сууж байсан орон сууц: Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод амьдардаг /Х.А нь Д.А-ыг өмнө нь таньдаг найз нөхдийн дотно холбоотой, хөрш зэргэлдээ амьдардаг байсан/,

2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 54 дугаартай Д.А-ыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газрын тосны газрын даргаар томилсон Засгийн газрын тогтоол /6хх-ийн 240/,

2012 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 12 дугаартай Д.А-ыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газрын тосны газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн Засгийн газрын тогтоол /6хх-ийн 241/,

Гэрч Л.Сүх-ийн мөрдөн байцаалтад өгсөн: «...2013 оны сүүлээр байх 11 дүгээр сарын сүүлээр Газрын тосны газарт ажилладаг А.Тү нь Үнэлгээний хорооны илтгэх хуудас гээд нэг зүйл барьчихсан энэ тэмдэглэл дээр нөхөж гарын үсэг зуруулж байгаа юм гэхээр нь би илтгэх хуудсыг хараад Д.А даргын үед ийм асуудал хариуцаж байгаагүй, би эх материал байхгүй байгаа учир гарын үсэг зурахаас татгалзсан...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 123-124/

Гэрч Г.Т-гийн мөрдөн байцаалтад өгсөн: «...Хэлэлцээрийн явцад тухайн компаниас бүрдүүлж ирүүлсэн материал нь шаардлага хангахгүй байсныг Ажлын хэсгээс мэдэгдэж, ирүүлсэн материалыг буцааж байсан...»Тг» ХХК нь Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Олон улсын нээлттэй тендерт дахин захиалгын санал ирүүлсэн байсан...Өмнөх Эргэл-12 өгсөн захиалгын материалтай адилхан байна. Энэ компанийн хувьд ирүүлсэн захиалгын материалуудыг үзэхэд тухайн компанийн санхүүгийн чадавхийг нотлох баримт бичгийн бүрдэл болон туслан гүйцэтгэгчээр ажиллах чадавхийг нотлох баримт бичгүүд хангалтгүй байсан... «Тг» ХХК-ийн газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайд ирүүлсэн захиалгын материалыг танилцаж судлах Ажлын хэсгийн

даргаар ажиллаж байхад Д.А нь «Тг» ХХК-ийн талаар асууж байсан. «Энэ компанийн хувьд материал нь хэр байгаа бэ, явц байдал нь ямар байгаа юм, энэ компанийн ирүүлсэн материалын хувьд дэмжих боломжтой юм уу» гэж асууж байсан. Би уг компанийн ирүүлсэн материалын хүрээнд дүрэм журмын дагуу явна гэж хэлсэн. Өөр хүмүүс тухайн үед Т компанийн талаар асуусан зүйл байхгүй... гэсэн мэдүүлэг /2хх-ийн 77-79, 102-103/,

Шинжээчийн дүгнэлтэд дурдагдсанаар Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын протоколд М.А, Н.Б нарын хэлсэн санал: «Тг» ХХК-ийг санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй санхүүгийн тайлан зөрүүтэй гаргасан, санхүүгийн баримт бусад холбогдох материалыг тус компаниас бүрэн гаргуулж аваагүй ажлын хэсэг муу ажилласан, ...»Тг» ХХК-ийг Газрын тосны хайгуулын 2 талбайд зэрэг хөрөнгө оруулж чадах эсэхэд эргэлзэж байна... гэжээ. /Тендерт шаардлага хангаагүй материал ирүүлсэн/,

Шинжээч С.Т-гын 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн шинжээчийн «... Зөвлөлийн зарим гишүүд БНПУ-ын «РСМС» компанийг дэмжих хүсэлтэй байсан боловч үнэлгээний оноо хэтэрхий доогуур байсан байна. Мөн Зөвлөлийн гишүүн М.А нь «Тг» ХХК нь санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй, санхүүгийн тайланг зөрүүтэй гаргасан, санхүүгийн баримт, бусад материалыг бүрэн хэмжээнд компаниас гаргуулж аваагүй, Ажлын хэсэг муу ажилласан гэсэн санал хэлсэн байна. Түүнчлэн Зөвлөлийн гишүүн Н.Б нь «Тг» ХХК-ийг газрын тосны хайгуулын 2 талбайд зэрэг хөрөнгө оруулж чадах эсэхэд эргэлзэж байна гэсэн байна. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 11 дүгээр зүйлийн 11.2-т «СШЗ нь энэ журмын дагуу хянаж зөрчил ирүүлсэн тохиолдолд гэрээлэгч сонгох ажиллагааг зогсоож, энэ журмын дагуу тухайн үйл ажиллагаа, эсхүл үнэлгээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дахин хийлгэх» гэж заасан байтал Зөвлөлийн гишүүдийн дээр дурдсан саналыг үндэслэн зохих арга хэмжээ авалгүйгээр «Тг» ХХК-ийн захиалгыг дэмжсэн байна. Иймд тус Сонгон шалгаруулах зөвлөл нь журмын дагуу ажилласан эсэх нь эргэлзээтэй байна...» /2хх-ийн 206-212/ гэсэн дүгнэлт / Сонгон шалгаруулах зөвлөл журмын дагуу ажиллаагүй/,

Х.А-аас Н.О-д өөрийн өмчлөлийн орон

сууцыг захиран зарцуулах ...арилжих бүрэн эрхийг олгосон 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн итгэмжлэл /7хх-ийн 88/, бэлэглэгч Х.А-аас бэлэг хүлээн авагч Ц.Ч-ийн өмчлөлд шилжүүлсэн 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн бэлэглэлийн гэрээ /7хх-ийн 87/ зэргээс үзвэл шүүгдэгч Х.А нь 2008 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн Үйлдвэр худалдааны сайд Х.Н-гийн 196 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүн хуваах чиглэлээр Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Олон улсын нээлттэй тендер зарлаж, уг тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө «Тг» ХХК-ийн ерөнхий менежер Н.О-д итгэмжлэл хийж өгч, Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлэн хээл хахуульд өгсөн,

Шүүгдэгч Д.А нь Газрын тосны газрын даргаар ажиллаж байхдаа Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан, газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны дарга, Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар тус тус ажиллахдаа тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Х.А-ын 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг төрсөн ах Д.Ц-ийн хүү Ц.Ч-ийн нэр дээр 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр шилжүүлэн онц их хэмжээний хээл хахууль авсан болох нь дээрх нотлох баримтуудаар хангалттай нотлогдон тогтоогдож байх тул шүүгдэгч Х.А-ыг албан тушаалтанд бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн,

Шүүгдэгч Д.А-ыг онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Х.А-т ял шийтгэл оногдуулах хууль зүйн үндэслэлтэй гэж шүүхээс дүгнэв.

Шүүх Х.А нарт холбогдох хэргийг 2014 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүлээж аваад 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдөр хэргийг шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх хамтын зарчмын хүрээнд яллагдагчийг шүүхэд шилжүүлж хуралдааныг товлон зарласан.

Гэтэл энэ хэргийн шүүгдэгч Д.А нь 2014 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нас барсан

байх тул мөн л хэргийг шүүх хуралдаанаар, шүүх бүрэлдэхүүнээр шийдвэрлэх зарчмын хүрээнд хэргийг хэлэлцэж, шүүгдэгчийн өмгөөлөгч Р.Пүрэвлхам нь Д.А-ны гэм буруутай эсэхийг шийдвэрлүүлэхээр байр сууриа илэрхийлэн шүүх хуралдаанд оролцож байгаагаа хэлсэн тул шүүх Д.А-д холбогдох хэргийг тусгаарлахгүйгээр түүний гэм буруутайг тогтоож, хэргийг шийдвэрлэсэн болно.

Харин Д.А нь 2014 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нас барсан болох нь нас барсны гэрчилгээний хуулбар /16хх-ийн 178/, нас барсны бүртгэлийн лавлагаа /16хх-ийн 215/ зэргээр тогтоогдож байх тул түүнд холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй.

Прокуророос, шүүгдэгч Х.А нь Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухайн хуулийн 7, 8, 16, 17, 21 дүгээр зүйлүүдэд заасан заалтуудыг зөрчин 2007-2011 онд нийт 12.303.690.000 төгрөгөөр хайгуулын болон ашиглалтын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан авч, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлогын албан татвар болох 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөлгүй онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн болох нь:

Шүүгдэгч Х.А-ын шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар мэдүүлсэн:

"...Одоо би прокурорын надад үүсгэн, энэ шүүх хурал болж байгаа татвараас санаатай зайлсхийсэн, ...гэх хэргийн талаар тайлбар өгье. Прокурор намайг яллах дүгнэлтдээ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлого 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөлгүй онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн гэж буруутгаад, Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2-т зааснаар татвар төлөхөөс зайлсхийсэн гэсэн зүйл ангиар яллах үндэстэй гэжээ. Эрүүгийн хууль энд байна, би үүнийг олон удаа уншиж үзсэн. Орлого олсон хүн татвараа төлөх ёстой. Гэтэл надад олсон орлого байхгүй. Тэгээд энд суутгагч гэдэг үг байхгүй. Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйл. Татвар төлөхөөс зайлсхийх.

“166.1.Татвар ногдох их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нуух, тэдгээрийн тоо хэмжээг зориуд бууруулан мэдээлэх, байнга оршин суугаа газар, хаягаа өөрчлөх зэргээр албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг...” гэх мэтчилэн цаашаа явж байгаа. “166.2.Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл татвар ногдох онц их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нуусан бол эд хөрөнгийг хурааж...” гээд шийтгэлүүд явж байгаа. Энд надад олсон орлого байхгүй, суутгагч гэдэг үг энд байхгүй. Би татвар ногдох ямар ч эд хөрөнгө, их хэмжээний орлого, ажил үйлчилгээг хэнээс ч нуугаагүй. Миний үйл ажиллагаа бүгд ил тод явагдсан. Буруу зөрүү мэдээлсэн зүйл огт байхгүй. Оршин суугаа хаягаа өөрчлөөгүй. Иймд прокурорын чухам ямар орлого нуусан гэж буруутгаад байгааг би асууж тайлбарлуулмаар байна. Би орлого олоогүй. Өөрийн олсон боловсрол, туршлага, мэдлэгийн хүрээнд эх орныхоо хөгжилд хөг нэмэх гэсэн олон мянган Монголчуудын адил чадах ядахаараа төсөл бичиж, гадаадынхан хийж болдог ажлыг яагаад Монгол хүн хийж болдоггүй юм бэ гэсэн бодолд хөтлөгдөн гадаадын хөрөнгө оруулагчид, банк санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын сангуудтай олон жил тууштай уулзаж, хэлэлцээр хийж, тэдний итгэлийг олон Монгол орондоо өнөөг хүртэл 70 гаруй сая ам долларын буюу 100 гаруй тэрбум төгрөгийн гадаадын хөрөнгө оруулалтыг татаж ажилласан. Үүнийг би өчигдөр эхлээд өнөөдөр ийм болгосон юм биш. Үүнийг би 1990 онд «Ж» ХХК-д ачигчаар ажиллаж эхлээд, 25 жил хөдөлмөрлөж байж өөрийн хамт олны нөр их хөдөлмөрийн дэмтэйгээр босгосон юм. Үүний зах зухаас санхүүгийн шинжээч нар дүгнэлтдээ тусгахдаа ашигт малтмалын хайгуул, шинжилгээ судалгааны ажилд 38 тэрбум төгрөг зарцуулсан байна гэж дүгнэх жишээтэй. Эдгээр нь дандаа өндөр эрсдэлтэй хөрөнгө оруулалт. Үйл ажиллагаа явуулаад орлого олчихсон, түүнийгээ нуун далдалсан зүйл огт байхгүй. Би ямар нэгэн буруу мэдээ гаргасан зүйл огт байхгүй. «Т» бүлэг компаниудын эзэмшилд байгаа ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын зөвшөөрлүүдийг олон аж ахуйн нэгжүүд, компаниудын хувьцааг худалдаж авснаар нэг дор цуглуулсан. Компанийн

хувьцааг худалдах, худалдан авах гэрээ хийж, тухайн үед Ашигт малтмалын газраас шаардаж байсан материалуудыг бүрдүүлээд, жишээ нь мэдээлэл худалдаж, худалдан авах гэрээг Ашигт малтмалын газрын гаргасан маягыг бөглөөд, тухайн үед үйлчилж байгаа хуулийн дагуу гэрээ хийж авч байсан. Мэдээлэл худалдан авах гэрээ бол аж ахуйн нэгжийн хооронд хийгддэг гэрээ. Прокурор намайг тусгай зөвшөөрөл авсан гэж буруутгах юм. Энэ боломжгүй зүйл шүү дээ. Тусгай зөвшөөрлийг зөвхөн хуулийн этгээд эзэмшдэг. Би компаниудын хувьцааг худалдаж авч байсан. Авсан компаниудыг «Т» бүлэг хөрөнгө оруулалт болгон нэгтгэж байсан. Худалдаж авсан компаниуд тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан. Ганц нэг тохиолдолд тусгай зөвшөөрөл шилжсэн. Ашигт малтмалын эрэл хайгуулын салбар асар өндөр эрсдэлтэй, асар их зардал өртөгтэй ажил тул гадны хөрөнгө татахаас өөр аргагүй байсан. Гадаадаас чадварлаг, туршлагатай, мэргэжлийн багтай хамтрах ёстой. Гадныхан асар өндөр шалгуураар хөрөнгө оруулалт хийхийн өмнө нягталдгийг ойлгосон байсан тул компаниуд худалдаж авахдаа, гэрээ хэлцэл хийхдээ нэр хүндтэй, туршлагатай хуулийн товчоо, компаниар дүгнэлт гаргуулдаг байсан. «ЛШ», «Ц» гэх мэтийн хуулийн фирмээр эрх зүйн талаас нь хянуулж, дүгнэлт гаргуулаад авч байсан. Хувьцаагаа хүмүүс үнэлээд худалдана, би үнийг нь төлнө. Тэдгээр хүмүүс энэ эрэл хайгуулын ажил асар их зардалтай, эрсдэлтэй ажил байна, компанийг аваач эсвэл хамтраад цааш нь гадны хөрөнгө оруулалт татаад аваад яваач, бид ачаагаа дийлэхгүй байна гэдэг байсан. Ихэнх хэлэлцээрүүдийг эдийн засгийн хямралын үед хийж, компаниудыг авсан. Өөрөө ч тэр үед эрсдэлээ буруу тооцоолоод хямралын дайрлагад өртөөд 2009-2010 онуудад ачаандаа дийлдэх шахаад, өөрийн орон сууцаа барьцаалж зээл аваад, ажилчдынхаа цалинг тавиад явж байсан. Хэдэн монгол хүнээс компанийг нь тохирсон үнээр аваад тэднийг мөнгөтэй төгрөгтэй болгосноороо буруутгагдана гэж юу байхав дээ. Хэрэв тухайн үед би тэдгээр гэрээнүүдийг хийгээгүй бол нөгөө л Л овогт эсвэл В овогт нь тэр компаниудыг нь авчихсан, тэдгээр нь өнөөдөр 100 хувь гадныхны мэдэлд явж байх байсан болов уу. Би өөрөө тусгай зөвшөөрөлтэй компани зарж байсангүй. Би өөрийн үүсгэн байгуулсан компанид хөрөнгө

оруулалт татаж байсан. Өөрийн компанийн хувьцааг арилжихдаа өөрөө мөнгө авч байсангүй, үүссэн өр зээлээ төлсөн, мөн бодит хөрөнгө оруулалт татсан. Мэдээлэл худалдах худалдан авах гэрээг шинжээч нар хуурамч гэрээ гэж дүгнэснийг ойлгохгүй байна. Ашигт малтмалын газар тусгай зөвшөөрлийг шилжүүлэхдээ Мэдээлэл худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг шаарддаг. Энэ гэрээг хийхгүйгээр тусгай зөвшөөрөл шилжихгүй. Хүмүүст яагаад их хэмжээний мөнгө өгдөг вэ гэж та бүхэн асууж магадгүй. Тусгай зөвшөөрөлтэй компанитай хүмүүс энэ компанийг дээр хэлсэнчлэн цаашид аваад явах боломжгүй боллоо, та гадны хөрөнгө оруулалттай бол үүнийг, эхлүүлсэн ажлыг аваад яваач гэдэг. Өөрсдийн оруулсан хөрөнгө оруулалтаа үнэлдэг. Компани өөрийн гаргасан мөнгөнөөс алдагдалгүй зарчихмаар байна гэдэг байсан. Би тэр компанийн хувьцааг аваад, мөнгийг нь төлчөөд, хүний мөнгийг яаж суутгаад дансанд хадгалах юм бэ, Монголд үйлчилж байгаа хуулиар ийм боломж, эрх надад байхгүй шүү дээ. Хувь хүний орлогын албан татварын хуульд ийм заалт байхгүй. Хүнд мөнгө өглөө гэж прокурор намайг буруутгахгүй биз дээ. Хүнд мөнгө төллөө гэж хүнийг буруутгадаг хууль манай улсад байхгүй биз дээ. Би орлого олоогүй. Бусдын олсон орлогын төлөө би эрүүгийн харуцлага хүлээх тогтолцоо дэлхийн аль ч оронд байхгүй гэдэгт би итгэлтэй байна. Тэр тусмаа хүнлэг ардчилсан нийгмийн замд эргэлт буцалтгүй орсон Монгол улсад байхгүй гэдэгт итгэлтэй байна. Энэ олон ажил эхэлсэн, энэ олон тусгай зөвшөөрөлтэй компаниуд цуглуулсан нэгэн гэж яллах гэж байгаа бол би нэгэн тайлбар хийх нь зөв гэж бодож байна. Би дээр хэлсэн ашигт малтмалын эрэл хайгуулын ажил асар их эрсдэлтэй ажил. Энэ хөрөнгө оруулалтыг хийдэг, энэ эрсдлийг үүрдэг хөрөнгө оруулагчид гэж маш цөөн тооны мэргэшсэн хөрөнгө оруулагчид байдаг. Тэдгээр нь өөрийн эрсдэлийг маш нарийн тооцоод хөрөнгө оруулалт хийх эсэх шийдээ гаргадаг. Тэд ганц нэг лицензтэй компанитай харьцахгүй, тэдэнд хөрөнгө оруулалт хийхгүй. Үүнийг ойлгож мэдрээд Монгол хүн, Монголын нэг ч гэсэн компани гадныхны хийгээд байгаа ажлыг Монгол нутагтаа, өөрсдөө хэнээс ч дутахгүй хийж чадна гэсэн итгэлтэйгээр эдгээр ажлуудыг эхлүүлсэн. Энэ шийд ч зөв байсныг өнгөрсөн цаг хугацаа харуулсан. Би Холбооны Бүгд

Найрамдах Герман улсад олон жил ажиллаж амьдарсан хүн. Олон жил гадаадад амьдрахдаа Монголынхоо сайхныг, Монголынхоо нөөц бололцоог сайтар олж харсан, мэдэрсэн. Эх орондоо нэг ч гэсэн сайн сайхан зүйл бүтээчих юмсан гэсэн эрмэлзлэлээр дүүрэн яваа нэгэн. Энэ ч хүсэл эрмэлзлийнхээ хүчинд би Холбооны Бүгд Найрамдах Герман улсаас хөрөнгө оруулагч, Америкийн Нэгдсэн Улсын хөрөнгө оруулалтын сан, Швейцарын банк бус санхүүгийн байгууллага, Австралийн уул уурхайн компаниудын мэргэжлийн багуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, хөрөнгө санхүү босгож, 100 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийлгэсэн байсан. Цаашид хэдэн зуун сая ам долларын хөрөнгө оруулалт татахад бэлэн болоод байсан. Цаашид олон мянган ажлын шинэ байр бий болгож, олон олон бүтээн байгуулалт эх нутагтаа босгоно гэж итгэлтэй явсан. Энэ бүх ажил, эдгээр хөрөнгө оруулалтууд, айсуу асан их бүтээн байгуулалтууд миний 25 жилийн хөдөлмөрийн үр шим, манай хамтрагч нар, хамт олны нөр их хөдөлмөрийн үр өгөөж юм. Эдгээр ажлууд эх орны маань хөгжил дэвшилд хөг нэмэх учиртай байсан. Ингэж ажиллахдаа би өөрөө болон миний гэр бүл, «Т» бүлэг компаниас нэг ч төгрөгийн ашиг орлого, цалин хөлс аваагүй. Энэ эхлүүлсэн ажлуудаас би өнөөдрийг болтол орлого олсон зүйл одоогоор алга. Ирээдүйд үр ашгаа өгөөд, ногдол ашиг гэх мэт үр шим нь ирэх байх гэж явсан. Харамсалтай нь намайг хорьсноос хойш эхлүүлсэн ажлууд зогсоод, ахин сэхэл авах эсэх нь тодорхойгүй болоод байна...» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Хохирогч, иргэний нэхэмжлэгч Ж.О-ын шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар мэдүүлсэн: «Миний хувьд Авлигатай тэмцэх газраас Х.А нарт холбогдох эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэгчээр томилж ирүүлнэ үү гэсэн хүсэлтийн дагуу Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын итгэмжлэгдсэн төөлөлөгчөөр томилогдон ирсэн. Гол асуудал нь лиценз шилжүүлсэн асуудал, эрх шилжүүлсэн асуудалтай холбоотойгоор татвар төлөөгүй байна гэдэг асуудалд шүүх хуралдаанд оролцож байна. Шинжээчийн дүгнэлттэй танилцсан. Татварт ногдох ёстой орлого буюу 3,6 тэрбум төгрөгийн татварын авлага. Үүнийг барагдуулаагүй байна гэдэгтэй холбоотой хэрэгт оролцож энэ мөнгийг нэхэмжлэх үүрэгтэй ирсэн,

үүнийг нэхэмжилж байна. Гэхдээ хамгийн гол асуудлуудыг шинжээч нар хэлэх байх гэж бодож байна. Нарийн асуудлыг би өөрөө сайн мэдэхгүй байна» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Гэрч Т.Ц-ын шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар мэдүүлсэн:

“Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: “Т” энерги компанийн захирлаар хэзээнээс эхэлж ажилласан бэ? гэхэд Гэрчийн хариулт: 2011 оны 04 дүгээр сарын 7-ны өдрөөс эхлэн ажилласан... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Нягтлан бодох бүртгэлийн 1 дүгээр гарын үсэг зурна гэж ойлгож болох уу? гэхэд Гэрчийн хариулт: Болно...Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: 1.2 тэрбум төгрөгийн гүйлгээ байна. 2011 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр шилжүүлсэн байна, У “ТЭ” 2.2 тэрбум төгрөг, “АТ” 3.7 тэрбум төгрөгийн гүйлгээнүүд хийгдсэн байна. Энэ гүйлгээг та хийсэн үү, өөр хүн хийсэн үү? гэхэд Гэрчийн хариулт: Мөнгө гүйлгээний эхний 2 гүйлгээг Х.А захирал хийсэн. Тухайн үед захирлаар томилогдоод байсан болохоор санхүүгийн гарын үсэг авч чадаагүй байсан. “АТ” гүйлгээг би хийсэн... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Суутгал хийгдсэн үү? гэхэд Гэрчийн хариулт: “АТ” суутгал нь хийгдээд явсан, 2011 оны гүйлгээний балансуудыг тухай үед нь тушаагаад явж байсан. Ямар нэг татварын асуудал манай компани дээр ирээгүй байгаа. Татварын шалгалт “АТ” дээр эхэлж байгаа... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: “АТ” мэдээлэл худалдах худалдан авах гэрээ хийсэн үү, хувьцаа худалдан авах гэрээ хийсэн үү? гэхэд Гэрчийн хариулт: Компанийн хувьцаа худалдаж авах гэрээ хийсэн...” гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Шинжээч П.С-гийн шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар мэдүүлсэн:

“Шинжээчийн дүгнэлтэд бид тодорхой жагсаалтаар шинжээчийнхээ дүгнэлтийг гаргаад ийм ийм компаниудын эдийн засгийн үнэлгээнд нь шинжилгээ судалгаа хийсэн гээд гаргасан байгаа. Х.А энд 100 хувь эзэмшилтэй ч байгаа, тодорхой хувь эзэмшдэг ч компани байгаа, доод тал нь 30 хувь эзэмшдэг компани байгаа. Ихэнх нь 100 хувь Х.А-ын эзэмшлийн компаниуд байгаа. Би саяын таны асуусан асуултад хариулъя. Ер нь нягтлан бодох бүртгэлийн стандартаар биет бус хөрөнгөд юу бүртгэх

вэ гэхээр лицензийг худалдаж авсан үнэ, тухайн жилийн лицензийн төлбөрүүдийг оруулаад биет бус хөрөнгөд бүртгэнэ. Харин хайгуулын үнэлгээний хөрөнгөд юу бүртгэх вэ гэхээр тухайн онуудад гарч байгаа зардлуудыг бүртгэдэг. Гэтэл ...”СН”, “ГМ” гээд бүх компаниуд яаж бүртгэсэн бэ гэхээр лицензийн төлбөрийг худалдаж авсан үнэ дээр нь лицензнийхээ төлбөрийг биет бус хөрөнгө дээрээ бүртгээд, хайгуул үнэлгээний хөрөнгөн дээр гарч байгаа зардлуудаа бүгдийг бүртгэсэн. Бид эдийн засгийн үзүүлэлтүүд гаргаж өгсөн. Миний бичсэнээр олон компани хайгуул үнэлгээ дээр бүртгэсэн байгаа. Энэ дээр маргаад байх юм ерөөсөө байхгүй...Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Та нар биет бус хөрөнгө, тусгай зөвшөөрлийн мэдээлэл худалдаж байгаа гэрээ эрх, хувьцаа худалдаж байгаа гэрээ бас эрх гэж та нарын дүгнэлтэд байна. Энэ хуульд эрх борлуулсны орлого тусдаа, хувьцаа үнэт цаас борлуулсны орлого тусдаа, биет бус хөрөнгө борлуулсны орлого тусдаа байна. Та нар энэ 3 заалтыг бүгдийг нь бөөгнүүлж байгаад эрх борлуулсны орлого гэж гаргаж ирээд байгаа. Жишээ нь н.Д-гээс хувьцаа худалдан авах гэрээ хийсэн байгаа. Эрх гээд дүгнэсэн. Компаниуд дотроо мэдээлэл худалдах, худалдан авах гэрээ хийсэн. Бас эрх гээд дүгнэсэн. Яагаад хуулинд тус тусдаа бичсэн зүйлийг бөөгнүүлж ганцхан болгож эрх борлуулсан орлого гэж үзэж байна вэ? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Энэ компани худалдаж байгаа тохиолдолд яг энэ хайгуулын тусгай зөвшөөрөл давхар худалдагдсан байдаг. Тухайн компанийн үнэ цэнэ юу вэ? Хайгуулын тусгай зөвшөөрлөөр явж байгаа. Х.А шүүх хуралд мэдүүлэхдээ тухайн компани санхүүгийн боломжгүйгээс болоод цаашид үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байгаа учраас та үүнийг худалдаад авчих гэсэн санал тавьсан гэж байсан. Гэтэл Х.А-ын худалдаж авсан компаниуд нь зөвхөн лицензийг нь аваад өөр компаниудад төвлөрүүлсэн. Хэрэв тухайн хүн үйл ажиллагаа явуулах байсан бол одоо болтол үйл ажиллагаагаа явуулаад явж байх ёстой байсан. Гэтэл лицензийг худалдаж аваад одоо болтол үйл ажиллагаа явуулаагүй «Х» тайлантай явж байгаа. ...Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Лиценз худалдсан гэдгийг та нар юугаар нотолж байгаа вэ? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Эрх гэдгийг Ашигт малтмалын хуулинд

4.1.15-д хайгуулын тусгай зөвшөөрөл гэдэг нь энэ хуулийн дагуу ашигт малтмалыг эрэх, хайх, эрх олгосон баримт бичиг байна гээд заагаад өгсөн. Бид өөрсдөө нэгэнт хууль хэрэгжүүлж байгаагийн хувьд хүнийг хэлмэгдүүлэхгүй гэдэг талаас нь дандаа баримттай зүйлд тулгуурлан дүгнэлтээ гаргасан...Гэрээнүүдийг үзэхэд 2 давхар гэрээ хийгдсэн. Хувьцаа худалдах худалдан авах гэрээ, эрх шилжүүлэх гэрээ хийгдсэн байгаа, зарим нь хэргийн материалд байгаа... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Хувь хүн лиценз тусгай зөвшөөрөл худалдах эрх байгаа юу? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Хувь хүн гэж бичээгүй. Урд нь захирлууд ард нь компаниуд нь байгаа...Санаатай хийсэн үйлдэл байхгүй хуулийн дагуу ажлаа хийсэн...Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: ...Д.С мэдүүлэхдээ Х.А-тай уулзсан, хайгуулын тусгай зөвшөөрлыг 2,9 тэрбум төгрөгөөр худалдаж авсан гэж мэдүүлсэн байна. Х.А тусгай зөвшөөрөл худалдаж авсан гэсэн баримт хаана байна вэ? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Энэ компаниудын захирал нь Х.А байсан. Тийм учраас Х.А худалдаж авсан гэж хэлсэн байх. Гэхдээ бид нар ард нь тайлбар бичихдээ хорих 461 дүгээр ангид очиж Х.А-аас ярилцлага авахдаа өөрийнх нь хэлснээр тайлбар гараар нь бичүүлж авсан... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: ...ойролцоо гээд 800.000 ам доллар гэсэн байна. Ойролцоо гэдэг нь баримтгүй гэсэн үг үү? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Х.А өөрийн гараар бичсэн тайлбар байгаа. Тийм учраас бид 3 ярьж байгаад ойролцоо гэх үү гэж байгаад бичсэн гэсэн байна. Ард нь Х.А-тай хийсэн ярилцлагын үед хэлсэн үнээр нь тооцов гэж бичсэн байгаа... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Таамаглаж, ойролцоо гэж дүгнэлт гаргаж болохгүй шүү дээ гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Бид таамаглаагүй, ойролцоо гэдгийг амаар нь, гэхдээ ард нь бид нар тайлбарыг нь хийсэн байгаа...Шүүгдэгчийн өмгөөлөгч Х.Базаррагчаагийн асуулт: Лиценз шилжүүлсэн мөртлөө наана нь хувьцаа гэсэн гэрээ хийсэн учраас бид нар лиценз шилжүүлсэн гэдгээр нь дүгнэлт гаргасан гэж хэлэх гэж байна уу? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Би өмнө нь хэлж байсан эрх шилжүүлэх гэрээ, худалдах, худалдан авах гэрээ гэж давхар хийдэг...Шүүгдэгчийн өмгөөлөгч Х.Базаррагчаагийн асуулт: Х.А 12 тэрбум төгрөгөөс хэдийг нь гаргасан

бэ, ойролцоо гэдэг нь хэд байгаа вэ? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Ойролцоо 2.440.942.000 төгрөг нь Х.А-ын амаар байгаа, үүний 30 хувь нь 732.282.600 төгрөг... Шүүгдэгчийн өмгөөлөгч Х.Базаррагчаагийн асуулт: Х.А-аас авсан тайлбар дангаараа шинжилгээний объект болж чадах уу? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Амаар ярилцлага авсан бол болохгүй байх гэж бодоод, хэргийн материалыг мөрдөн байцаагчаас бүрэн авч асуугаагүй. Байгаа өгсөн материалд нь үндэслээд дүгнэлт гаргасан...Шүүгдэгчийн өмгөөлөгч М.Баяраагийн асуулт: Би та нараас энэ захиргааны зөрчил байх боломжтой юу гэж л асууж байна гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Хэрэв буцаад дүгнэлт акт болох хэмжээнд бол болно...» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Шинжээч Ц.Б-гийн шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар мэдүүлсэн: «Бид энэ хэрэгт шинжилгээ хийхдээ 3-лаа ажилласан. Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч н.Б-ын томилгоогоор Нийслэлийн татварын байцаагч Ц.Ү-гийн хамт бид 2 ажилласан. Тухайн үед дүгнэлт гаргахад Авлигатай тэмцэх газраас 12 асуулт тавьсан. Үүнээс өнөөдөр хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор 5 дугаар асуудалд «Т» бүлэг компаниудын үүсгэн байгуулагдсан үеэс хойш ашгийн, нэмэгдсэн өртгийн, гаалийн татвар болон бусад төлбөр хураамжийг бүрэн төлсөн эсэх, үүнтэй холбогдох татварын алба, гаалийн газрын баримттай нь тулган шалгах гэсэн асуултын дагуу бид ашигт малтмалын лицензтэй холбоотой эрх борлуулсны орлогын албан татвар төлөөгүй байна гэсэн дүгнэлт гаргасан. Энэ дүгнэлтийг гаргахдаа Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль, татварын албанд мөрдөж байгаа дүрэм, журам, Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимаас гарсан шүүхийн тогтоолыг баримтлан дүгнэлт гаргасан. Ашигт малтмалын лицензтэй холбоотой 12 тэрбум төгрөгийн татвар ногдох зүйлээс улсын төсөвт төлөх ёстой 3,6 тэрбум төгрөгийг төлөөгүй байна гэсэн дүгнэлт гаргасан. Үүнийг гаргахдаа бүгдийг нь Х.А-ын өөрийнх нь ярьсан хэлснээр гаргаагүй. Тухайн үед шинжилгээ хийх үед ирүүлсэн баримтууд, энэ компаниудын хооронд хийсэн гэрээ, шилжүүлсэн мөнгөний баримт болон бусад баримтуудыг үндэслэн гаргасан. Мөн хавтаст хэрэгт энэ талаарх тайлбарыг

тодорхой бичиж өгсөн. Зарим компанийн лиценз шилжсэнтэй холбоотой эсэхийг тогтоох гэхэд бид нарт баримт байгаагүй. Х.А-тай шинжилгээ хийх явцдаа өөртэй нь уулзаж асууж ярилцсаны үндсэн дээр хийсэн дүгнэлт байгаа. Эдгээр нь хавтаст хэрэгт байгаа...Татвар зөвхөн орлого дээр тавьдаг зүйл биш. Татварыг нуусан гэж үзвэл зөвхөн орлого нуусан тохиолдолд татвар нуусан байна гэж үзэхгүй. Татвар ногдох зүйл гэж байгаа. Татвар ногдох зүйлд Татварын ерөнхий хуулийн 6.1-д заасан орлого, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлийн байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна гэж заасан...Тухайн үед "Тг" компанийн бүх санхүүгийн бичиг баримт, гэрээ, хэлцэл Авлигатай тэмцэх газарт ирсэн байсан. Тэр ирсэн баримтуудын дагуу үзсэн. Дээр нь санхүүгийн баримтуудын дагуу гэрээнүүд байсан. Тухайн компанийн захирал Х.А-тай өөртэй нь биечлэн уулзсан...Компанийн бүх бичиг баримт нь Авлигатай тэмцэх газарт байсан...Компанийн лицензтэй холбоотой асуудал зөвхөн Татварын албаны хууль гэж үзэхгүй нэг удаагийн хэлэлцэгдсэн асуудал биш. Манай татварын газрын маргаан таслах зөвлөлөөр болон Захиргааны хэргийн шүүхээр хэлэлцэгдсэн асуудлууд байдаг. Лицензтэй компани лицензээ шилжүүлэхдээ өмнөх гарсан шийдвэрүүдээс харахад халхавч маягийн гэрээ хийж байсан байна. Хувьцаа шилжүүлэх, компани шилжүүлэх гэх мэтээр. Эцсийн эцэст энэ компаниудын зарагдаж байгаа үнэ цэнэ юу байна гэхээр энд лиценз байна. Тийм учраас лиценз борлууллагдсан байна гэж үзэж, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр байгаа. Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 09 дүгээр сарын 16-ны №134 дүгээр тогтоол, 2011 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн №230 дугаар тогтоолууд бүгд асуудлыг хэлэлцсэн...Татвар 2-оос 40 хувь хүртэл тус тусдаа заалттай. Орлого дээр үү, татвар ногдох зүйл дээр үү, тодорхой эд хөрөнгө дээр үү гэдгээс хамаарна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулинд эрх борлуулсны орлогод 30 хувийн татвар ногдуулна гэж заасны дагуу эрх борлуулсан гэж үзэж 30 хувийн татвар гэж үзсэн...Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.10-т хайгуулын тусгай зөвшөөрлийг энэ хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх эрх олгосон байна, мөн 4.1.16-д ашиглалтын тусгай

зөвшөөрөл гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал ашиглах эрх олгосон гээд тус тус заасан байгаа...Орлогуудыг хэн, яаж төлөх талаар Татварын тухай хуульд тодорхой зааж өгсөн байгаа. Тухайлбал, эрх борлуулсны орлогыг тухайн этгээд худалдаж аваад мөнгийг нь олгохдоо тэр мөнгөнөөс төлөх ёстой. Мөнгө олж байгаа буюу худалдаж авч байгаа этгээд 30 хувийн татварыг суутгаад, улсын төсөвт шилжүүлэх ёстой гэж заасан байгаа. Тийм учраас энэ хүнийг суутгагч гэж заасан...Бид нарын гаргасан дүгнэлт биш. Татварын албаны хувьд гаргасан дүгнэлт... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Хуульд ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг биет бус хөрөнгө болгоод бичсэн байхад та нар яагаад эрх гэж үзээд байгаа юм бэ? гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Лиценз биет бус хөрөнгө мөн, гэхдээ хуульдаа эрх борлуулсны орлогоос татварыг суутгах хувь хэмжээ... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ж.Эрдэнэбулганы асуулт: Та нар дүгнэлт гаргахдаа ямар эх сурвалж ашигласан гэж хэлсэн бэ? гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ж.Эрдэнэбулганы асуулт: Та нар ямар эрх зүйн харилцаанд дүгнэлт гаргаж байгаагаа мэдэж байгаа юу? эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой, эсвэл захиргааны журмаар маргаантай, эсвэл иргэний журмаар гэдгээ ялгаж ойлгож байна уу? Өөрөө хэлбэл та нар Захиргааны хэргийн хяналтын шатны шүүхийн тогтоолыг ярих гээд байх шиг байна. Эрүүгийн эрх зүй гэдэгт хууль хэрэглэдэг, хуулийг төсөөтэй хэрэглэдэггүй. Тийм болохоор Захиргааны хэргийн шүүхийн тогтоол ерөөсөө хамаа байхгүй. Манай улсад жишиг гэдэг зүйлийг хэрэглэдэггүй. Энэ бол Америкийн Нэгдсэн улсын эрх зүйн тогтоолцоотой улс оронд байдаг. Манай орон хууль хэрэглэдэг улс. Яагаад ийм зүйлийг жишиг болгосон юм бэ? гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Тэрийг бид өөрсдийн ажлын практикт тулгуурлаж дүгнэлт хийсэн... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ж.Эрдэнэбулганы асуулт: Дээд шүүхийн тогтоол гэж бас хэлэх гэж байх шиг байна. Үндсэн хуулиас бусад хуулийг тайлбарлаж гаргасан Дээд шүүхийн тогтоолыг шүүгч хэрэглэдэггүй. Энэ бол тодорхой зүйлүүдийг тайлбарлахад үндэслэл болгодог болохоос дүгнэлт болгодоггүй. Та нарын ярьж байгаа Захиргааны хэргийн

хяналтын шатны шүүхийн тогтоолыг жишиг болгосон юм шиг байна гэж ойлгож байна, зөв үү? гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Болно...Шүүгдэгчийн өмгөөлөгч Р.Пүрэвлхамын асуулт: Х.А гэдэг хүн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль зөрчсөн юм уу? Хувь хүний орлогын албан татварын хууль зөрчсөн үү? гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Бид нар Х.А гэдэг хүн хууль зөрчсөн гэж дүгнэлт гаргаагүй... Шүүгдэгчийн өмгөөлөгч Р.Пүрэвлхамын асуулт: Компани нь ямар холбогдох хуулийг зөрчсөн бэ? гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль зөрчсөн...Шүүгдэгчийн өмгөөлөгч Р.Пүрэвлхамын асуулт: Ойролцоо гэсэн үнийн дүн чинь анхан шатны баримт байхгүй гэсэн үг үү? гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Ойролцоо гэдэг нь лиценз нь шилжсэн, компанийн баримтууд бид нарт байгаа, гэхдээ хэдэн төгрөгөөр шилжүүлсэн гэсэн баримт байхгүй. Анхан шатны баримт байхгүй...Шүүгдэгч Х.А-ын асуулт: Энд би орлого олсон уу? гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Орлого олоогүй. Татвар ногдох зүйл...» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

“Т” ХХК болон түүнтэй хамааралтай компаниудын нэр дээр бүртгэлтэй ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай 25 зөвшөөрлийн файлд үзлэг хийсэн тэмдэглэл /2хх-ийн 22-50/

Хохирогч, иргэний нэхэмжлэгч Ж.О-ын мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «...Монгол Улсад үйл ажиллагаа явуулж ашиг орлого олж байгаа дотоодын болон гадаадын ямар ч аж ахуйн нэгж, байгууллага татвар төлөх үүрэгтэй. Шинжээчийн дүгнэлттэй танилцлаа. Дүгнэлтээр тогтоогдсон төлөх татварын хувь хэмжээгээр хохирлыг барагдуулж нэр бүхий аж ахуйн нэгж болон этгээдээс нэхэмжилж байна...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 53/

Гэрч Л.Д-ийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн:

“... “ГМ” ХХК-ийг 2006 онд би өөрөө үүсгэн байгуулсан. Компанийн үйл ажиллагааны чиглэл нь худалдаа үйлчилгээний чиглэлээр үүсгэн байгуулсан, нэг гишүүнтэй компани юм. Компанийн нэр дээр Архангай аймгийн Тариат суманд байрлалтай 11936Х хайгуулын тусгай зөвшөөрөл байсан. Архангай аймгийн Тариат суманд байрлалтай 11936Х хайгуулын тусгай зөвшөөрлийг 2007 онд байх Х.А гэх хүн над руу утсаар яриад “уулзмаар байна”

гэж уулзаад “уг тусгай зөвшөөрөл дээр хөрөнгө оруулалт хиймээр байна” гэж ярьж байсан. Тэгээд тухайн үед надад мөнгөний хэрэг болоод бага багаар мөнгө авч байсан ба сүүлдээ уг тусгай зөвшөөрлийг компанийн хамт 500.000 ам доллараар худалдан борлуулсан. Одоо миний санаж байгаагаар эрх шилжүүлэх гэрээгээр шилжүүлсэн шиг санагдаж байна. 2007 онд 500.000 ам долларыг увуулж цувуулж байгаад тэр 2007 ондоо багтааж авсан. Одоогоор надад ямар нэг баримт байхгүй...” гэсэн мэдүүлэг /2хх-ийн 165-166/

Гэрч Г.У-ийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «...»ТМТ» ХХК-ийг 2003 онд би өөрөө үүсгэн байгуулсан бөгөөд 1 гишүүнтэй байсан. Уг компанийн нэр дээр үл хөдлөх хөрөнгө байхгүй. Харин ашигт малтмалын 3 тусгай зөвшөөрөл байсныг Х.А-ын «Рф» ХХК-нд шилжүүлсэн. Уг 3 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нь кварцын илрэлтэй, 1 тусгай зөвшөөрөл Дорноговь аймгийн Даланжарганд 11667Х, 11339Х байгаа. 1 тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон байгаа, 9 дэх жил нь болоод мөнгө хөрөнгөгүй болоод тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан гээд хүчингүй болсон юм. Манай аав н.Го гэх хүн байдаг, геологичоор ажилладаг байсан. Тэгээд өөрийн компанийн нэр дээр байсан 1 тусгай зөвшөөрлийг «ТМТ» ХХК руу шилжүүлсэн юм. Эдгээр 3 тусгай зөвшөөрлийг Х.А-т зараагүй, ирээдүйд олох орлогоос ашиг хуваахаар тохирон Х.А-ын компани руу шилжүүлсэн юм. Гэрээ байгуулна гэсэн. Тэгээд амжихгүй явж байна. Өнөөдрийн байдлаар ашиг хуваах талаар ямар нэг гэрээ болон бичиг баримт байхгүй байна...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 169-170/

Гэрч Д.Г-ийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн:

“...Манай аав Б.Д гэж байдаг бөгөөд “Сн” ХХК-ийг үүсгэн байгуулсан. Энэ компани уул уурхайн геологи хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани бөгөөд энэ компанийн нэр дээр Говь-Алтай аймгийн Цээл сум, мөн Цээл Алтай сумдыг дамнасан ашигт малтмалын 1454.Х, 1454.Х, 1454.Х тоот тусгай зөвшөөрлүүдийн геологи хайгуулын судалгааны үйл ажиллагаа явуулж байсан. Говь-Алтай аймгийн Цээл сум, мөн Цээл Алтай сумдыг дамнасан ашигт малтмалын 1454.Х, 1454.Х, 1454.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын газарт 2008 онд өргөдөл өгөөд авч байсан юм. Говь-Алтай аймгийн Цээл сум, мөн Цээл Алтай

сумдыг дамнасан ашигт малтмалын 1454.Х, 1454.Х, 1454.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг Х.А-т зарсан асуудал байхгүй. Харин “ТГ” ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.О-д өмнө би 20.000 ам долларын өртэй байсан ба тэр өрөө суутгуулаад Гранд марк-2 машин аваад увуулж цувуулаад 30-40 мянган ам доллар авсан. Нэг жил дамнаад увуулж цувуулаад нийт 100 сая төгрөгөөр зарсан. 2009 онд дээрх тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлсэн. Мөнгө хүлээн авсан өгсөн баримт байхгүй. Зүгээр Н.О-той ярьж байгаад мөнгөө өгч авдаг байсан. Мөнгийг дандаа бэлнээр авдаг байсан...Говь-Алтай аймгийн Цээл сум, мөн Цээл Алтай сумдыг дамнасан ашигт малтмалын 1454.Х, 1454.Х, 1454.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг 250.000 ам доллараар зарсан асуудал байхгүй. Харин цааш нь Н.О хэдэн төгрөгөөр зарсан эсэхийг мэдэхгүй. Ямар ч байсан миний тооцоогоор 100 сая төгрөгөөр зарсан...” гэсэн мэдүүлэг /2хх-ийн 175-176/

Гэрч С.А-ийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «... “ЖГ” ХХК-ийг 2006 онд байгуулсан. Манай эхнэр Д.О уг компанийн 85 хувийн хувьцааг эзэмшиж байсан, үлдсэн 15 хувийг нь М.Б гэдэг хүн эзэмшиж байсан. Энэ компани уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутагт байрлах жоншны хайгуулын 2 тусгай зөвшөөрлийг өмнө нь миний нэр дээр байсныг шилжүүлж өгсөн. Миний нэр дээр байсан ашигт малтмалын 2 тусгай зөвшөөрлийг би 2001 онд авсан... Х.А-тай 2010 оны 12 дугаар сарын эхээр өмнө нь Улсын мөрдөн байцаах газарт ажиллаж байсан Н.О-оор дамжуулан уулзан танилцсан бөгөөд «ЖГ» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутагт байрлах 1073.А, 1073.А тоот тусгай зөвшөөрлийг «ЖГ» компанийн хувьцааг бэлэглэлийн гэрээгээр өгсөн байх. Тэгээд Х.А-т уг хоёр тусгай зөвшөөрлийг 400.000 ам доллараар зарсан. Уг мөнгийг тухайн үедээ би уурхай ажиллуулах гээд техник тоног төхөөрөмж зэрэг ахуйн хэрэглээний зүйлд өр тавьсан байсан учир тэрэнд зарцуулсан юм...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 177-178/

Гэрч Д.Цгэ-ийн мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «... “УТ” ХХК, “ЧХ” ХХК-ийн нэр дээр байсан ашигт малтмалын хайгуулын 3 тусгай зөвшөөрлийг 2006 онд 600.000 ам доллараар тохирч шилжүүлсэн. Ингэхдээ 550.000 ам долларыг

бэлнээр авсан. Харин үлдсэн 50.000 ам долларыг Н.О зуучилж өгсний хөлс гэж авсан. 2008.10.20-доор байх би эмнэлэгт хэвтэж байсан, мөн надад мөнгөний хэрэг гараад Дорнод аймагт барилга барьж байсан бөгөөд мөнгөний хэрэг болоод Х.А-тай уулзъя гээд өмнө нь Х.А сонирхож байсан миний «Рф» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй байсан 9 ширхэг хайгуулын тусгай зөвшөөрлийг компанитай нь цуг зарахаар ярилцсан. Өмнө нь Х.А энэ компанийн тусгай зөвшөөрлийг сонирхож байсан бөгөөд гэхдээ хөрөнгө оруулалтыг нь олно, харин компанийн 30 хувийн эзэмшилтэйгээр ярилцаж байсан юм. Би тэр үед мөнгө хэрэгтэй байсан учир «Рф» ХХК-ийг бүтнээр нь 300.000 ам доллараар авчих гэж ярьсан. Х.А «тэгье» гэж зөвшөөрөөд компаниа 300.000 ам доллараар зарсан юм. Өөр ямар нэг наймаа байхгүй. Гэрээ хийсэн асуудал байхгүй. Мөнгө хүлээн авсан, өгсөн баримт байгаа эсэхийг санахгүй байна. Х.А нь “УТ” ХХК, “ЧХ” ХХК-ийн нэр дээр байсан ашигт малтмалын хайгуулын 3 тусгай зөвшөөрлийг 800.000 ам доллараар, “Рф” ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй байсан 9 ширхэг хайгуулын тусгай зөвшөөрлийг 800.000 ам доллараар, нийт 1.600.000 ам доллараар худалдан авсан асуудал байхгүй. Худлаа ярьж байна. Миний хувьд Х.А-аас нийт 850.000 ам доллар авсан. Өөр мөнгө аваагүй...” гэсэн мэдүүлэг /2хх-ийн 180-181/

Гэрч Б.Уу-ын мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «... “ТД» компанийн нэр дээр Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Ханан хонгил толгой гэх нэртэй 1513.Х, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Ханан хонгил толгой-1 нэртэй 1513.Х, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Оюут нуруу нэртэй 1442.Х тусгай зөвшөөрлүүдийг Х.А-ын «МХ» ХХК-ийн нэр дээр байдаг Чингэлтэй дүүргийн ...дугаар хороо... байрлах 5 давхар 620 м2 бүхий байраар сольсон. Мөнх «ЦӨ» ХХК-ийн Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг Өвөлжөө уул нэртэй 5264Х, Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг Баруун ноён уул-1 нэртэй 1378.Х, Өмнөговь аймгийн Ноён, Гурвантэс сумын нутаг Цагаа уул нэртэй 14522Х хайгуулын тусгай зөвшөөрлүүд, «Ас» ХХК-ийн нэр дээр Дорноговь аймгийн Мандах сумын нутаг 1552.Х, 1553.Х тусгай зөвшөөрлүүдийг Х овогтой Х.А-тай Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд байрлах «АП» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй 12 давхар байшингаар сольсон. Бусад тусгай

зөвшөөрлүүдийг мөнгөөр нь зарсан. Одоо яг хэдээр зарсныг санахгүй байна. Баримт материалаа харж байгаад хэлье. Эдгээр наймаа нэг доор хийгдээгүй. Тэр нь энийх энэ гээд нилээн удаан үргэлжилсэн юм. Мөнгө бэлнээр авч байсан. Яг хэдэн төгрөг авч байснаа санахгүй байна. Увуулж цувуулаад мөнгө авдаг байсан. Х.А-аас 2010.08.27-нд Б.Уут хоорондын тооцоо гэж Голомт банкны 913100xxxx дугаар данснаас 200.000 ам доллар «ХСү» ХХК-ийн 110210xxxx дансанд, мөн өдрөө миний 420734458888xxxx дансанд 115.000 ам долларыг тус тус шилжүүлсэн нь үнэн...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 182-184/

Гэрч Б.С-ын мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «...2005 оноос «СГ» ХХК-ийг байгуулсан. Үйл ажиллагаа явуулж байна. Манай компани ашигт малтмалын хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани юм. «Тг» ХХК-нд ажилладаг Н.О-ыг өмнө нь таньдаг байсан юм. Тэгээд Н.О-оор дамжуулан 2010 оны сүүлээр Х.А-тай танилцсан ба тухайн үед «нүүрсний сонирхолтой талбай байна уу» гэж асууж байсан. 2011.02.05-ны өдөр Х.А-т Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт байрлалтай хайгуулын 1292.Х, 1546.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг 1 сая ам доллараар зарсан. Мөнгийг 900.000 ам долларыг бэлнээр, 100.000 ам долларт Бенз ЖЛ-450, Ауди КУ-7 маркийн машинуудыг бодож авсан. Мөнгө хүлээн авсан баримт байгаа эсэхийг мэдэхгүй байна. Харин тусгай зөвшөөрлийг зарах «Баталгааны гэрээ» хийгдсэн. Энэ гэрээнд бүх зүйлийг тусгасан байгаа...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 185-186/

Гэрч Г.Э-ын мөрдөн байцаалтын шатанд хэргийн талаар мэдүүлсэн: «...»ЭЭЭ» ХХК-нд 2006-2007 онд геологичоор ажиллаж байсан. Харин «ИЭЖА» ХХК-ийг би өөрөө үүсгэн байгуулсан бөгөөд энэ компани нь уул уурхайн геологи судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан. Манай компанийн нэр дээр ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүд байсан юм. «ЭЭЭ» ХХК-ийн нэр дээр ашигт малтмалын хайгуулын 1331.Х, 1331.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг болохоор тус компанийн захирал Б нь «жилийн төлбөр төлж чадахгүй байна», мөн «сунгалтыг нь хийж чадахгүй байна» гэхээр нь «ИЭЖА» ХХК-ийн нэр дээр ашигт малтмалын 1439.Х, 1439.Х дугаар тусгай зөвшөөрлүүдийг нийлүүлж байгаад Н.О-той ярьж тохиролцоод, одоо миний санаж байгаагаар «НБА» ХХК-нд шилжүүлсэн шиг

санагдаж байна. Дээрх ашигт малтмалын хайгуулын 4 тусгай зөвшөөрлийг 50.000.000 төгрөгөөр зарсан. Гэхдээ «ЭЭЭ» ХХК-ийн захирал Б-д 10.000.000 төгрөг өгсөн. Би өөрөө 20.000.000 төгрөгийг нь авсан. Үлдсэн 20.000.000 төгрөгийг тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөр, тусгай зөвшөөрлийн сунгалтын төлбөр мөн шилжүүлгийн төлбөрт тус тус зарцуулсан. Н.О-ос 50.000.000 төгрөг авсан, өөр мөнгө аваагүй...» гэсэн мэдүүлэг /2хх-ийн 187-188/

2013 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн №01 дүгээр шинжээчийн дү гнэлтэд: «... Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд: “Албан татвар ногдох орлого 1.Энэ хуулийн 5.3-д заасан албан татвар төлөгчийн тухайн жилд Монгол Улсын нутаг дэвсгэрт болоод гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно..., 3.Албан татвар төлөгчийн дараах орлогод албан татвар ногдоно.

Үйл ажиллагааны орлого...», 8 дугаар зүйлд: «Үйл ажиллагааны орлого...1.2.Эрх борлуулсны орлого... 8.2.Эрх борлуулсны орлогод эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад төлбөртэй шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна», 16 дугаар зүйлд: «Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох. 16.3.Дараахь орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо тухайн орлого тус бүрийн нийт дүнгээр тооцно..., 3.5.Эрх борлуулсны орлого..., 17 дугаар зүйлд: «Албан татварын хувь хэмжээ. 2.Албан татвар төлөгчийн дараарь орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулна. 2.7.эрх борлуулсны орлогод 30 хувиар...», 21 дүгээр зүйлд : «21.5 Энэ хуулийн...17.2.7...д заасан орлогод ногдох албан татварыг мөн хуулийн 4.1.6-д / Суутгагч гэж албан татвар төлөгчид олгосон орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх эрх бүхий этгээдийг;.../ заасан суутгагч ногдуулан суутган авч ажлын 7 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ» гэж заасан байна. Энэ хуулийн дагуу лицензийг худалдан авагч тал худалдагч талд олгох орлогоос 30 хувийн татвар /эрх борлуулсны орлогын албан татвар/ суутган төсөвт шилжүүлэх үүрэгтэй байна. «Т» бүлэг компаниуд нь худалдан авсан лицензүүдийн орлогыг олгохдоо 526.Х лиценз бүхий «АТ» ХХК-ийг худалдан авахдаа олгосон орлогоос

375.8 сая төгрөгийг суутган төсөвт төлсөн ба бусад иргэн, аж ахуйн нэгжээс авсан лицензийн төлбөрийг шилжүүлэхдээ эрх борлуулсны орлогын албан татварыг суутган төсөвт төлөөгүй байна. Т бүлэг компаниуд нь байгуулагдсан үеэсээ хойш ихэнх нь татварын шалгалтад хамрагдаагүй ба дээрх лиценз шилжүүлэгч компани, иргэдийг татварын албаны шалгалтанд хамруулан уг компани иргэд өөрсдөө эрх борлуулсны орлогын албан татварыг төлсөн эсэхийг тогтоох нь зүйтэй гэж үзэж байна. Харин «TRC» ХХК-нд «АА» ХХК-аас шилжүүлсэн лицензүүдийн төлбөр 550.0 мянган америк доллар буюу 687.160.0 мянган төгрөгийн орлогоос эрх борлуулсны орлогын албан татвар 206.137.8 мянган төгрөгийг төсөвт төлөх нь зүйтэй байна...» гэжээ. /2хх-ийн 221, 3хх-ийн 25/

Шинжээч П.С-гийн мөрдөн байцаалтын шатанд мэдүүлсэн: «...Энэ хэрэгт шинжээчийн дүгнэлт гаргахад миний хувьд Т компани болон түүний охин компаниуд болох 39 аж ахуйн нэгжийн татварын албанд гаргадаг санхүүгийн татварын тайланг үзэж шалгасан юм. Үүнд одоогоор үйл ажиллагаа явуулдаг компаниуд байхгүй байсан. Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 10 орчим аж ахуйн нэгж байсан эдгээр 10 аж ахуйн нэгжийн нэр дээр 50 орчим ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байсан. Х.А-ын хувьд эзэмшилтэй дээрх тусгай зөвшөөрөлтэй компаниуд нь ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг бусдаас 1-3 сая төгрөг, дээд тал нь 10 сая хүртэл төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээгээр худалдаж авсан байдаг эдгээрийг компанийн санхүүгийн болон бусад баримт гэрээ, мөн Х.А-тай хийсэн ярилцлагын явцад дээрх гэрээнүүд худлаа 1-10 хүртлэх сая төгрөгөөр ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг худалдах худалдан авах гэрээг хуурамчаар хийдэг байсан нь харагдаж байсан. Нийтдээ 14 компаниас 30 орчим хайгуулын тусгай зөвшөөрөл худалдаж авсан байна. Шинжээчийн дүгнэлтэд тусгасан байгаа. Ингэж тусгай зөвшөөрөл худалдаж авахдаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар 30 хувийг суутган авч татварт төлсөн аж ахуйн нэгж байхгүй байсан. Үүнд баримтаар буюу хийгдсэн гэрээний дагуу 6 аж ахуйн нэгж байгууллагын 12 ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг 8.674.814.000 худалдан авсан. Үүнээс аж ахуйн нэгжийн орлогын

албан татварын хуулиар 30 хувийн татварт 2.602.444.000 төгрөгийг суутган авч төлсөн байх ёстой. Х.А-тай шинжээчийн дүгнэлт гаргах явцад ярилцсан. Ярилцлагаар 8 аж ахуйн нэгжээс худалдан авсан 18 ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг 2.941.750.000 төгрөгөөр худалдан авсан, эрх борлуулсны албан татварт 882.525.000 төгрөгийг суутган авч төсөвт төлсөн байх ёстой. Мөн “АТ” ХХК-аас «ТЭ” ХХК руу 1 тусгай зөвшөөрлийг 3.758.700.000 төгрөгийг худалдан авсан мөнгийг шинжлүүлэхдээ 10 хувийг татварт 375.800.000 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байсан. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар эрх борлуулсны орлогын албан татварт 10 хувиар биш 30 хувиар суутгаж авах ёстой. “АА” ХХК-ийн 3 тусгай зөвшөөрлийг “TRC” ХХК нь 687.126.000 төгрөгөөр худалдан авсан. Үүний 30 хувийн татвар нь 206.137.800 төгрөг болж байсныг бас төлөөгүй. Ингээд нийт 12.303.690.000 төгрөгөөр тусгай зөвшөөрөл худалдсаны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлогын албан татвар болох 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөх ёстой байсан...” гэсэн мэдүүлэг /3хх-ийн 29-31/ зэрэг баримтуудаар тогтоогдож байна гэж үзэж яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд ирүүлсэн боловч хавтаст хэрэгт авагдсан болон шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судлагдсан нотлох баримтуудын хүрээнд түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх хангалттай үндэслэл тогтоогдохгүй байна.

Учир нь: Улсын яллагчаас шүүгдэгч Х.А-ыг шинжээчийн дүгнэлтээр гол баримт болгон яллаж байгаа бөгөөд 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01 дугаартай шинжээчийн дүгнэлт /2хх-ийн 221-225/ нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаж гараагүй байна гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Б-гийн албан бичгээр Нийслэлийн татварын газрын Хяналт шалгалтын хэлтсийн Татварын улсын байцаагч Б.Х, Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн Татварын улсын байцаагч Б.Ба, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн Татварын улсын байцаагч О.Ц нарыг албан ёсоор томилжээ.

Гэтэл Шүүх шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т «Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас

гадуур хийлгэх бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлт гаргаж, шинжилгээ хийхээр томилогдож байгаа / тухайн байгууллагаас томилсон гэж ойлгоно/ шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийг дуудан ирүүлж, түүний биеийн байцаалт, мэргэжил, чадвартай танилцан, сэжигтэн, яллагдагч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тогтоохоос гадна шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана» гэж заасныг зөрчиж Авлигатай тэмцэх газраас хууль зүйн үндэслэлгүйгээр томилогдсон шинжээч нарыг хүлээн авах боломжгүй гэж үзэн Шүүх шинжилгээний тухай хуулийг зөрчин Чингэлтэй дүүргийн Татварын улсын байцаагч П.С, Ц.Б, Нийслэлийн Татварын улсын байцаагч Ц.Ү нарыг нэр заан томилуулах талаар хүсэлт гаргасан бөгөөд дээрх нэр бүхий шинжээч нарыг холбогдох албан тушаалтан томилоогүй байхад тэдгээр шинжээч нар дүгнэлт гаргасан нь хууль бус байна гэж шүүх дүгнэлээ.

Шүүхийн хэлэлцүүлэгт шинжээч П.С, Ц.Б нар нь шинжээчийн дүгнэлтийг «УДШ-ийн Захиргааны хэргийн шүүхийн тогтоолд үндэслэж гаргасан, шүүгдэгч Х.А-тай ярилцлага хийх замаар хохирлыг ойролцоогоор тооцож гаргасан, хэрвээ бидний гаргасан дүгнэлт буцаад акт болох юм бол захиргааны зөрчил гэж тооцож болно...» гэж мэдүүлсэн нь хөдөлбөргүй үнэн зөв нотлох баримтад тулгуурлан дүгнэлтээ гаргаж чадаагүй, мөн ойлгомжгүй, эргэлзээтэй байгаагаас гадна шинжээч нар өөрсдийн дүгнэлтийг хууль зүйн хувьд тайлбарлаж чадахгүй байсныг тэмдэглэе.

Мөн шүүх хуралдаанд шүүгдэгч Х.А-ын «би эрх борлуулаагүй, худалдсан улсууд нь компани, тусгай зөвшөөрөл, хувьцаагаа зарж өөрсдөө ашиг орлого олсон байхад зөвхөн надаас нэхээд байгаа нь хачирхалтай, би үйл ажиллагаа явуулж ашиг олоогүй байхад орлого эд хөрөнгийг нуусан, оршин суугаа газар хаягаа өөрчлөн татвар төлөхөөс зайлсхийсэн гэж байгаа нь үндэслэлгүй юм...» гэсэн мэдүүлэг,

Шүүгдэгч Х.А-ын өмгөөлөгч нарын «Улсын яллагчаас ашиг сонирхлын зөрчилтэй шинжээчийн дүгнэлтийг гол баримт болгон яллаж байгаа нь үндэслэлгүй юм. Татварын улсын байцаагчийн акт тавигдаагүй байхад шууд мэргэжлийн бус хүмүүсээр шинжээчийн дүгнэлт гаргуулсан нь буруу. Шинжээчийн

дүгнэлтэд хэдэн төгрөгийн татвараас зайлсхийсэн болохыг шүүгдэгч Х.А-аас шинжээч нар хорих ангид нь очиж ярилцлага хийн ойролцоогоор хохирлын дүнг гаргасан нь эмгэнэлтэй» гэж тайлбарласныг шүүх үндэслэлтэй гэж үзэв.

Түүнчлэн шинжээч нарт дээрх мөрдөн шалгах эрх олгоогүй бөгөөд хууль бус ажиллагаа явуулсан нь шүүхийн хэлэлцүүлгээр нотлогдон тогтоогдлоо.

Нөгөө талаар Татварын ерөнхий хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн холбогдох зүйлд зааснаар албан татвар төлөгчийн үйл

ажиллагааны дараах орлогод буюу хувьцаа үнэт цаас борлуулсан орлого, биет бус хөрөнгө борлуулсан орлого нь тус тус албан татвар ногдох орлогод хамаарах тул нэр бүхий шүүгдэгчид /Х.А-т/ компанийнхаа эрх, хувьцааг төлбөртэйгөөр шилжүүлсэн этгээд нь өөрийн хөрөнгө борлуулсны орлогоос хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр ногдох албан татварыг төлөх ёстой.

Тухайн нөхцөлд Х.А нь нэр бүхий аж ахуйн нэгжүүдийн эрх, хувьцааг гэрээний дагуу төлбөртэйгээр шилжүүлэн авсны үнэд тухайн хөрөнгө борлуулсан орлогоос тооцогдох татвар шингэсэн эсэх, худалдан авсан үнэд тооцогдох татварын хувь хэмжээг тооцон шингээсэн бол татварыг эд хөрөнгөө худалдан борлуулж орлого олсон этгээд төлөх бөгөөд энэ талаар зохих ажиллагаа хийж, шалган тогтоосон үндэслэл бүхий баримт нотолгоо хэрэгт үгүй байна.

Иймд шүүгдэгч Х.А-т холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2-т зааснаар татвар төлөхөөс зайлсхийсэн гэж прокуророос яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т «эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд ...эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ» гэж заасныг баримтлан мөн хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэлээ.

Прокуророос Шүүгдэгч Н.О нь Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудын сонгон шалгаруулалтад "Тг" ХХК-ийг шалгаруулсны төл өө Газрын тосны газрын даргаар

ажиллаж байсан Д.А-д Х.А-ын эзэмшлийн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий “Р.Г.В”, Зайсангийн тойруу ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлж, хээл хахууль өгөх гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлэн хамжигчаар оролцсон гэж үзэж яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд ирүүлсэн боловч:

Шүүгдэгч Н.О-ын шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар мэдүүлсэн:

“...би энэ эрүүгийн хэрэгт Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1 гэсэн зүйл ангиар яллагдагчаар татагдаж шалгагдаж байгаа. Миний бие Х.А захиралтай 2007 оноос хойш хамтран ажиллаж байна. Би өөрөө эрх зүйч мэргэжилтэй, энэ чиглэлээр цагдаагийн байгууллагад ажиллаж байсан. ...Эхлээд би 2 жил орчим менежерээр ажиллаж байгаад 2009 оноос ерөнхий менежер болон дэвшин ажилласан. Тухайн 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр захирал надад энэ байрыг Ц.Ч гэж хүнд шилжүүлж өгөх хэрэгтэй байна чи энэ ажлыг хариуцаж аваад үлд. Би бол ажил ихтэй төрийн байгууллагаар нааш цааш яваад, байрны асуудал гээд явах зав надад байхгүй гэж хэлсэн. Тэгэхэд нь би таны өмчилж байгаа захиран зарцуулах эрхтэй энэ байрыг хуулийн дагуу би шилжүүлэх боломжгүй юм. Тийм учраас хэрвээ би энэ ажлыг хариуцаж аваад шийдээд хийх ёстой бол та надад итгэмжлэл олгох ёстой гэдгийг захиралд тайлбарласан. Захирал үүнийг зөвшөөрч надад итгэмжлэл олгосон. Хавтаст хэрэгт итгэмжлэл авагдсан байгаа. Анх удаа итгэмжлэл аваад Ц.Ч гэж хүний утсыг надад захирал надад өгсөн. Энэ итгэмжлэлийн дагуу Ц.Ч гэдэг хүнд энэ байрыг тухайн үед нь шилжүүлж өгсөн. Тухайн үед энэ Ц.Ч гэдэг хүн энэ итгэмжлэлийг авсан, итгэмжлэл авсныхаа дараа би захирлаас асууж байсан. Захирлаа худалдах, худалдан авах гэрээгээр юм уу бэлэглэлийн гэрээгээр байр шилжүүлэх боломжтой. Аль хувилбараар нь шилжүүлэх вэ гэхэд захирал мөнгө бага зарлагдахаар нь хийж болно гэсэн зөвшөөрөл надад олгож байсан. Тэгэхэд нь би тухайн үед байрыг нь 100 сая төгрөгөөр үнэлээд бэлэглэлийн гэрээгээр тэр орон сууцыг Ц.Ч-д шилжүүлээд би шилжүүлсэнтэй холбоотой баримтыг үл хөдлөх хөрөнгийн Хан-Уул дүүрэг хариуцсан цонхонд өгөөд тэгээд би өөр зүйл мэдэхгүй. Гэрчилгээ гарсны дараа Ц.Ч өөрөө гэрчилгээ гарсан байна лээ, би гэрчилгээгээ

авсан шүү гэж надад хэлж байсан. Би “Т” компанид хөдөлмөрийн гэрээтэй ажилладаг. Гэрээний дагуу ажиллаж байгаа, цалин хөлс авч ажиллаж байгаа учраас хөдөлмөрөө үнэлүүлж ажиллаж байгаа хүн учраас би захирлаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх үүрэгтэй. Тэгээд ч захирлын надад өгч байгаа энэ итгэмжлэл бол хуулиар хориглогдоогүй зүйл. Иргэний хуулийн 62.3 дахь хэсгийн заалтыг үндэслэж итгэмжлэл авсны дагуу захирлын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн хүн. Би бас хоригдсон. Энэ асуудалд би жил гаран шалгагдлаа, миний ар гэр, миний үр хүүхдүүд, намайг их л гэмт хэрэг хийсэн, янз бүрийн юм хийсэн юм шиг бодоод хэвлэл мэдээллээр бичээд, би Монгол улсад ажиллаж хөдөлмөрлөх эрхтэй, үр хүүхдээ өгсөн хүмүүжүүлж, сурч боловсрох боломжоор нь хангах эрхтэй. ...Мөн Эрүүгийн хуулийн 269.1-д өөртөө ямар нэг байдлаар ашигтай нөхцөл байдал үүсгэхийн тулд авлига өгсөн гэж. Энэ байрыг шилжүүлээд надад наалдсан зүйл юу ч байхгүй. Миний цалин нэмэгдээгүй, би ямар нэгэн байдлаар тендерт, тэр шарга 3, нэмэгт 6 гэсэн тендер л яриад байна. Тэр тендер өнөөдрийг хүртэл 6 жилийн хугацаанд эцэслэн шийдэгдээгүй л байгаа. Батлагдаагүй байгаа тендер. Тийм учраас эрхэм шүүгчид минь үнэн зөвийг тунгааж, хар цагааныг ялгаж, энэ хэргийг минь хэрэгсэхгүй болгож, бид нарын энэхүү гомдлыг хүлээж авна гэж найдаж байна” гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Н.О-ын «Тг» ХХК-нд ерөнхий менежерээр ажилладаг болохыг тодорхойлж «Тг» ХХК-ийн захирал Ё.О-аас гаргасан ажил байдлын тодорхойлолт /7хх-ийн 6/

“Тг”-ын захирал Х.А-ын захирлын тушаал /7хх-ийн 8/, Х.А-аас Н.О-д өөрийн өмчлөлийн орон сууцыг захиран зарцуулах ...арилжих бүрэн эрхийг олгосон 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн итгэмжлэл /7хх-ийн 88/, бэлэглэгч Х.А-аас бэлэг хүлээн авагч Ц.Ч-ийн өмчлөлд шилжүүлсэн 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн бэлэглэлийн гэрээ /7хх-ийн 87/ зэргээр баримтуудаар няцаан үгүйсгэгдэж байна.

Учир нь: Н.О-ыг энэ компанид ажилладаг болохыг нотолж «Тг» ХХК, «Тг» ХХК-ийн захирлуудаас тодорхойлсон баримтууд, шүүх хуралдаанд шүүгдэгч Н.О-ос гаргасан «...Би энэ компанид хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг учраас захирлаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх үүрэгтэй...» гэсэн

мэдүүлэг зэргээс үзвэл түүнийг тухайн үед Х.А захирлаас үүрэг өгсний дагуу итгэмжлэлийн үндсэн дээр уг байрыг Ц.Ч-д шилжүүлсэн нь хангалттай нотлогддог тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар хээл хахууль өгөх гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлэн хамжигчаар оролцсон болох нь тогтоогдохгүй байна гэж үзлээ.

Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн бүрэлдэхүүний сэдэлт, санаа зорилго / субъектив тал/ нь бүрэн үгүйсгэгдэж байх тул Эрүүгийн хуулийн тусгай ангийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр Н.О-д холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх нь зүйтэй.

Прокуророос, шүүгдэгч Ц.Ч нь “Тг” ХХК-ийн захирал Х.А-аас Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д “Тг” ХХК-ийг тендерт шалгаруулсны төлөө өгсөн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг өөрийн нэр дээр шилжүүлэн авч, онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг нуун далдалж гэмт хэрэгт хамжигчаар оролцсон гэж үзэн яллах дүгнэлт үйлдэж хэргийг шүүхэд ирүүлсэн боловч:

Шүүгдэгч Ц.Ч-ийн шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар мэдүүлсэн:

“...Ц.Ч миний бие 1980 онд Унгар улсад Монгол Улсаас төлөөлөн сууж байсан элчин сайдын анхны зээ хүү болж төрсөн. Миний эцэг эх, миний өвөө эмээ нар энэ төрд үнэлэгдсэн сэхээтэн эрдэм номтой хүмүүс байсан учраас намайг хар багаас минь эрдэм ном, боловсрол, хөдөлмөрийн үнэ цэнийг мэдрүүлж өсгөсөн. ...Тэгээд байр авах гэсэн хүнд аль болох боломжийн байрыг нь авч өгөх, байр зарах гэж байгаа хүнд нь зарж өгөөд, зуучлалын хөлс авах зэргээр хувиараа байрны ченж гэж ярьдаг даа хүмүүс, тийм зүйл ажлынхаа хажуугаар хийж эхэлсэн. Үүний хажуугаар өөрийнхөө ганц сонирхол болсон машин бизнесээ хийж л явсан. Х.А ахын хувьд би 1999 он 2000 оны үеэс Германд жуулчны төлөөлөгч байхаас нь танина. Ганцхан надаар тогтохгүй Германд байсан оюутнууд бүгд мэднэ. Гадаад оронд, хүний нутагт өөрийнхөө хувийн бизнесийг амжилттай явуулна гэдэг хүнд асуудал.

Үүнийг хийж чадсан цөөхөн залуучуудын нэг учраас бүгдээрээ таньдаг, энэ хүнийг үнэлдэг, хүндэлдэг байсан. Тэгээд намайг 2007 онд Хас банкны салбарын захирал болсон хойно Х.А ах Монголд ирсэн, өөрөө нэг компани байгуулсан, манайд орооч ээ гээд янз бүрийн санал тавьдаг, янз бүрийн зүйл ч амалдаг л байсан. Гэтэл би өөрөө боломжийн ажилтай байсан болохоор тэрийг нь ойшоодоггүй байсан. Гэхдээ яах вэ ажлын хажуугаар өөрөө гадаад орноос зээл авна, санхүүжилт хийнэ гэхэд банк санхүүгийн хувьд материалтай нь танилцаж, зөвлөгөө өгч, тусламж үзүүлж байсан. Би өөрөө ч гэсэн шаардлагатай тохиолдолд Х.А ахаас юм гуйж үзсэн. Ингээд би өөрийн бизнесийн дагуу 2009 оноос Х.А ахаа хямдхан байр байна уу, надад нэг байр өгөөч ээ гэж гуйсан. Тэгэхэд Х.А ах, ах нь жаахан санхүүгийн асуудалтай байгаа, чи миний байрыг 200.000 ам доллараар хямдхан авбал авахгүй юу гэсэн. Үүн дээр та бүхэнд тайлбар хэлэхэд мөрдөн байцаагчийн хэлээд байгаа шиг огт танихгүй нэг хүн гарч ирээд нэг хүн явуулаад миний нэр дээр байр шилжүүлсэн асуудал байхгүй. Би 11 сард тэр байрыг зөндөө очиж үзсэн. Үнэ ханшийг нь судалсан, гэр бүлтэйгээ зөвлөлдсөн. Алс ирээдүйдээ үнэд хүрэх юм байна, ашигтай байх юм байна гэдэг үүднээс би энэ байрыг авсан. Авах авахдаа надад 200.000 ам доллар бэлнээр байгаагүй. Би Х.А ахаас эргээд гуйсан, мөнгийг хуваагаад төлөх боломж байна уу гэж асуухад, Х.А ах бодож байгаад чи эхлээд 50.000 ам долларыг өгчих, үлдсэнийг нь удаахгүй төлчихөөрэй гэсэн. Энд дахиад давтаад хэлэхэд би бол сэтгэлийн хөөрлөөр юм уу, хүний ятгалгад орж шийдвэр гаргадаггүй хүн, аль болох урьдчилж бүх юмыг тооцоолж байгаад, тал талаас нь харж байж, төлөвлөж байж шийдвэр гаргадаг хүн. Та нар үүнийг нэг бодлын Герман зан гэдгийг сайн мэдэж байгаа байх. Ингээд 2012 оны эхээр Х.А ах над руу яриад, ах нь гадаад явах боллоо манай итгэмжлэгдсэн хүн очоод чамд байрыг чинь шилжүүлж өгөөд, чи мөнгөө тэр хүнд өгөөрэй гэсэн. Тэгээд манай ажил дээр Н.О гэдэг залуу ирээд анх танилцаж байсан. Бид 2 хуучин үл хөдлөх байсан Ард кино театрын хажууд байх нотариат ороод гэрээ байгуулаад, би материалаа өгсөн. Тэгэхэд би мөнгө өгсөн, гэхдээ би анх удаа энэ хүнтэй танилцаж байгаа учраас би 50.000 ам доллар хүлээж авсан гээд гарын үсэг зуруулж авч байсан. Даанч харамсалтай нь манайх 2011

оны эхээр манай салбарын үйл ажиллагаа өргөжөөд манай салбар том байранд шилжиж орсон. Тэгэхэд нь би энэ гэрээ бөгөөд өөр бусад зарж байсан байрнуудын гэрээг банкны хуучин хэрэгцээгүй баримтуудтайгаа хамт устгалд оруулсан санаад одоо ерөөсөө олдохгүй байгаа. Яг үнэндээ 5 жилийн дараа энэ байрыг авсантай холбоотой нэг хүн ирээд шалгана гэж зүүдлээгүй явсан болохоор энэ баримтыг ямар ч шаардлагагүй гэж бодож устгасан. Хавтаст хэрэгт авагдсан байгаа, та нар сайн мэдэж байгаа байх, би энэ байрны 50 хувийг өөрөө төлсөн байгаа. Үүнийг төлөхдөө, та нар бас төсөөлөөд үзээрэй. Би өөрийн олсон ихэнх мөнгөө энэ байрны төлбөрт өгч байсан. Хүн хүнээс зээлээд өгөх тохиолдол бас байсан. Өөрийнхөө нэр дээр, ээжийн нэр дээр, эхнэрийн нэр дээр байсан илүү дутуу машинуудаа хүртэл зараад борлуулаад мөнгийг нь гаргаж өгч байсан тохиолдол байгаа. Үүнийг авто тээврийн газраас шалгаж үзэхийн бол машин зарж байсан баримтууд нь байгаа. Би мөрдөн байцаагчид үүнийг хэлсэн л дээ. Яагаад үүнийг шалгаж баталгаажуулахгүй байгаа юм бэ гэж. Тэгэхэд шүүх дээрээ, тэр шүүгчдээ хэл гэсэн. Тийм учраас энэ талаар ярьж байгаа юм шүү. 2011 оны хавар Х.А ах надтай уулзаад манайх шинээр Австралиудтай нийлээд шинээр төсөл эхэлж байгаа. Цаад компани нь Австралийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, том компани, чамд цаашдаа өсөх боломж байгаа шүү гэж надад санал тавьсан. Гэхдээ эхэн үедээ би чамд банкны чинь адил цалин өгч чадахгүй. Өөрийн компанийн жишгийн дагуу чамд байр машин өгье, машин бол Ланд 200 машин өгсөн байгаа, байрны хувьд үлдэгдэл 100.000 ам доллар дээрээ зохицье гэж ярьж байсан. Би энэ байранд урхидуулаад энэ компанид ажилд орсон ч юм биш. Та нар бодоод үз, би банкиндаа өөрийн гэсэн захиран зарцуулах төсөвтэй, жолоочтой, машинтай, утас, бензин бүх зардал цаанаасаа даадаг гээд бүрэн дүүрэн сэтгэл хангалуун байсан. Мөрдөн байцаагч намайг, чи энэ компанид орохдоо Ланд аваад орсон байх гэж тулгаад байгаа. Би тэр үед Лексүс 470 гээд машинтай байсан. Банкны машин унадаг учраас энийгээ хэзээ ч унадаггүй гаражид байж байдаг л байсан. Хүн болгон нотолно. Тэгээд ч бодоод үзэхэд би өөрийгөө ганцхан машинаар үнэлээд ажлаа солих хүн мөн үү. Өнөөдөр би банкиндаа ажиллаж байсан бол миний цалин

3-аас 4 сая хүрчихсэн, би өөрөө ч гэсэн хувийнхаа журмаар дахиад нэг байрны мөнгө хийх л байсан. Тийм боломжтой байсан. Ер нь би энэ компанид орохдоо, манай захирлууд, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд мэдэхгүй байх, би шууд энэ компанид ажилд ороогүй юмыг яаж мэдэх вэ харзная гэж бодоод Хас банкнаасаа чөлөө аваад, давхар ажиллаж байгаад 2012 онд за боломжийн юм байна гээд Хас банкнаасаа гүйцэд гарсан. Миний энэ байр, хувийн өмчид цаг хугацаа, орон зай, харилцан хамааралгүй тендер, татвар гэсэн огт ойлгомжгүй зүйлд холбож намайг 2 сар гаруй цагдан хорьж байгаад үнэндээ гайхаж байна. Өмнө хэлсэнчлэн би 2 хүүхэдтэй хүн. Би хүүхдүүдээ өсөж том болоход нь энэ байрандаа орно. Цаашдаа дахиж хүүхэдтэй болно, бүр цаашлаад энэ байраа худалдан борлуулж хүүхдүүддээ байр авч өгнө гэж алсыг бодолтой, ирээдүйн хөрөнгө оруулалт болгож авсан шүү. Өнөөдөр эрдэм боловсрол чадвартай нэг нь биш сэргэлэн зальтай нэг нь сайн сайхан амьдардаг нийгэм болсныг та бүхэн мэдэж байгаа. Надад үнэндээ аавынхаа талийгаач болсон дүүг ашиглаад мөрдөн байцаагчийн тулгаад яриад байгаа шиг ямар нэгэн тендерт ороод, түүнийг нь ялаад, зарж баяжаад, үгүй дээ гэхэд аль нэг яамны юм уу агентлагийн хурган дарга болох боломж байсан уу гэвэл байсан. Гэхдээ би хэзээний хүмүүсийн нам болж хуваагдаад, улс төр, төрийн алба, авлига, хээл хахууль, ар өвөрийн асуудлаас хол байж зөвхөн урд ажлаа сайн хийж байснаараа сайхан амьдарч байсныг та бүхэн хавтаст хэрэгт авагдсан миний тодорхойлолт болон намтар түүхээс харж ойлгож байгаа байх. Гэтэл өнөөдөр намайг хээл хахууль авсан яллах гэж байгаад би улс эх орон, төр засаг, хууль хүчний байгууллагад үнэндээ гомдож цөхрөөд байна. Би ямар албан тушаалтан болоод, ямар ашиг хонжоо олсон болоод, хэн яаж хохироод гомдол гаргасан болоод өнөөдөр өөрийн өмч, байр, машинаа хураалгах гээд зогсож байгаагаа ойлгохгүй байна. Түүгээр ч зогсохгүй надаас мөнгө аваад захиралдаа шилжүүлж байсан, надад байрыг нэр дээр минь шилжүүлж байсан, 4 хүүхэдтэй, зүгээр л ажлаа хийж байсан залууг буцаад эсрэгээрээ надад авлига өгсөн болоод цуг яллах гээд сууж байгаа нь ямар ч логикгүй утга учиргүй зүйл болоод байна. Та бүхэн сонссон байх, прокурорын уншсан яллах дүгнэлтэд тендер, татвар гээд зөндөө

зүйл яригдаж байгаа боловч миний байртай холбоотой, үүнийг миний байртай яаж холбож байгаа, би хэнийг хохироогоод, хэн гомдол гаргасан талаар нотлох баримт юу ч байхгүй. Яллах дүгнэлтэд тэр талаар огт дурдагдаагүй байгаа. Шүүгч нар болон прокурор мэдэхгүй зүйлийг энд хэлье гэж бодож байна. Холбоогүй зүйлийг холбоотой болгох гэж, хийгээгүй зүйлийг хийсэн болгох гэж, нотлогдоогүй зүйлийг нотлох гэж мөрдөн байцаагч зөндөө оролдсон. Тэр болгонд нь би хэлж байсан. Тэр тендер зэрэг асуудлыг би огт мэдэхгүй. Энэ байр миний байр, 100 хувь миний байр. Та надад чин сэтгэлээсээ итгэж болно. Шалгах зүйл байвал шалгах журмаараа шалгаач ээ, энэ байр энд ямар ч хамаагүй, та буруу замаар яваад байгаа юм уу гэдгийг би зөндөө хэлж байсан. Би Х.А ахаас ганцхан байр биш машин бас авсан байгаа. Гэтэл машиныг огт ярьдаггүй. Зөвхөн байрыг л тойроод авч үзээд байдаг. Өмгөөлөгч маань энэ Х.А гэдэг хүнээс ганцхан Ц.Ч биш, 2-3 хүн байр, машин авсан байна, яагаад ганц Ц.Ч-ийг шалгаад байдаг юм бэ гэж асууж байсан. Мөрдөн байцаагчийн өгч байсан хариулт нь ердөө Ц.Ч Д.А гэдэг хүний төрсөн ахын хүүхэд учир шалгаж байгаа юм гэсэн хариу өгч байсан. Түүнийг нь М.Баяраа өмгөөлөгч сонссон байгаа. Миний Грийн вилла дахь байрыг маань битүүмжилнэ гээд түүнээс гадна хөрөнгө хураах ялтай гээд манай амьдарч байгаа нөгөө байрыг маань битүүмжилнэ гээд эхнэр хүүхдийг минь хөөж гаргаад, зургийг нь аваад хавтаст хэрэгт авагдсан байгаа. Үүн дээр манай өмгөөлөгч маш ихээр дургүйцсэн. Яагаад заавал та нар энэ хүний байрыг нь хураах гээд эхнэр хүүхдийг нь гудамжинд гаргах гээд улайраад заавал байраар нь оролдоод байдаг юм бэ? Хөрөнгө хураах гээд байвал наад хүн чинь дансандаа мөнгөтэй, өөр машин тэрэг гээд олон хөрөнгө байхад байрыг нь хураана гэж дарамтлаад байх ямар шаардлага байна гэж эсэргүүцэж, нилээн асуудал үүсгэж байж одоо амьдарч байгаа байрыг минь битүүмжлэхээ больсон байгаа. Бүүр сүүлдээ мөрдөн байцаагч надад юу гэж хэлсэн бэ гэвэл та одоо 2 хүүхэдтэй, гэр бүлээ бод оо, өөр зүйл ярь, одоо удахгүй энэ хэрэг чинь прокурорт шилжлээ шүү, прокурор дээрээс шүүхэд очно, шүүхээс бол та заавал ял авна шүү. Тийм учраас та эртхэн дээр юм аа яриад сал гэж хэлсэн. Би тэр даруйдаа өмгөөлөгчдөө утасдаж хэлсэн. Одоо та нар тэр гүйцэтгэх ажиллагаагаар янз

бүрийн утасны бичлэг гээд байгаа, тэр утасны бичлэгээс сонсох юм бол би өмгөөлөгчдөө тэр дор нь хэлсэн байгаа. Дараа нь сүүлийн байцаалт авахдаа мөрдөн байцаагч миний хэлснийг чи сайн бодсон уу одоо ярих зүйл байвал яриарай гэж хэлж байсныг тэр байцаалтад биеэрээ оролцсон улсын яллагч чихээрээ сонссон байгаа шүү. Гэхдээ би хэлсэн, би байгаа зүйлийг байгаагаар нь ярина, би өөрөө аврагдаж ялгүй салахын тулд байхгүй зүйлийг бий болгож зохиогоод 2 хүнийг гүжирдэх боломж байхгүй гэж би өөрт нь хэлээд хавтаст хэрэгт авагдсан мэдүүлгээ өгсөн байгаа. Ердөө үүнээс 2 хоногийн дараа намайг дуудаад чи оргон зайлах гэж байсан гэсэн үндэслэлээр цагдан хорино гэсэн. Тэгээд манай өмгөөлөгч эсэргүүцсэн байгаа. Яагаад урьдчилаад танилцуулдаггүй юм бэ оргон зайлах гэсэн нөхцөл чинь юу байгаа юм бэ Үнэндээ ажлын 5 өдрийн 4 өдөр нь Н.О бид хоёр Авлигатай тэмцэх газрын үүдэнд уяатай нохой шиг л сууж байдаг байсан. Тэгээд яаж оргон зайлах гэсэн гэдгээ батлаад өгөөч гэхэд батлах шаардлагагүй, манайх хил хорио тавих боломжгүй болсон, оргон зайлсан тохиолдолд интерполоор хайхад бөөн зардал гарна гээд шууд хорьсон. Хориод 2 сар гаруй хугацаанд юу хийсэн бэ гэхээр юу ч хийгээгүй. Мөрдөн байцаагч, прокурорын хэн нь ч над дээр очоогүй, би зүгээр хий хоосон тэнд хэвтээд, миний архаг хууч өвчин хөдлөөд дээрээс нь чийгтэй газар удаан байснаас болоод бөөрний үрэвсэлтэй болоод ядарч сульдаад өөрөө хохироод сууж байна шүү дээ. Тэгэхээр шүүгч та бүхнээс өнөөдөр хэн нэг албан тушаалтан, ямар нэгэн дарамт шахалт байхгүйгээр нөхцөл байдлыг үзээд яаж миний байрыг хаа хамаагүй зүйлд холбоод байгааг ялгаж салгаад үнэн зөв шийдвэр гаргаж өгөөч гэж хүсэж байна» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/.

Бэлэглэгч Х.А-аас бэлэг хүлээн авагч Ц.Ч-ийн өмчлөлд шилжүүлсэн 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн бэлэглэлийн гэрээ /7хх-ийн 87/ зэрэг баримтуудаас үзвэл Ц.Ч нь хээл хахууль авсан гэмт хэрэгт шүүгдэгч өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх /авга ах Д.А-ы эсрэг мэдүүлэг өгөхгүй байх/-ийнхээ хүрээнд байцаан шийтгэх ажиллагаанд оролцсон бөгөөд энэ нь түүнийг буруутгах хангалттай үндэслэл болохгүй, мөн Д.А өөрийн нэр дээр тухайн эд хөрөнгийг шилжүүлэн авч болохгүй, хөрөнгө орлогын мэдүүлэгтээ тусгах боломжгүй байх

тул Ц.Ч-ийг ашиглагдсан байна гэж шүүх бүрэлдэхүүн үзсэн болно.

Иймд шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т «Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд ...эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ» гэж заасныг баримтлан Ц.Ч-д холбогдуулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг нуун далдалж гэмт хэрэгт хамжигчаар оролцсон гэж прокуророос яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэлээ.

Шүүх шүүгдэгч Х.А-т ял оногдуулахдаа гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хир хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэм буруугаа хүлээн зөвшөөрөхгүй байгаа зэргийг харгалзан тухайн зүйл хэсэгт заасан 3 /гурав/ жилийн хорих ял оногдуулах нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзэв.

Харин гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл болох Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот, /Улсын бүртгэлийн Y-220601xxxx дугаартай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй/ 160м² талбай бүхий орон сууц, зорийн давхарын ...тоот, ...байрны ...тоот 2 ширхэг авто зогсоол зэргийг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт «Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл... эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана» гэж заасны дагуу хурааж улсын орлого болгохоор шийдвэрлэх нь зүйтэй.

Шүүгдэгч Д.А-ны өмгөөлөгч Р.Пүрэвлхам хавтаст хэрэгт яллагдагчаар татах тогтоол хэрэгт байхгүй байгаа нь түүнийг яллагдагчаар татаагүй гэж үзнэ гэж маргасан бөгөөд хэргийг шүүх хүлээн авахад Д.А-ны яллагдагчаар татах тогтоол хэрэгт авагдаагүй алдаа зөрчил байсан хэдий ч түүнийг яллагдагчаар татсаны дагуу яллагдагчаар байцаахад ял сонссон талаараа мэдэж байсан нь нотлогддог, Д.А-ыг яллагдагчаар татаж тогтоол үйлдэж байсан талаарх өмгөөлөгч Б.Баясгалан, Г.Оюунцэцэг нараас шүүхэд гаргасан тодорхойлолт, мөн Д.А-д ял өөрчлөн сонсгож өмгөөлөгч Р.Пүрэвлхамын

хамтаар гарын үсгийг нь зуруулан авсан баримт хэрэгт авагдсан байх тул хэргийг шүүхээр шийдвэрлэх боломжтой гэж үзсэн болно.

Мөрдөн байцаагч, прокурорын хайнга, хайхрамжгүй үйл ажиллагааны улмаас талийгаач Д.А-ы яллагдагчаар татах тогтоол хэрэгт авагдаагүй байх боловч үүнийг шүүх хуралдаан болон мөрдөн байцаалтаар дахин нөхөн гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал бий болжээ.

Өмгөөлөгч Р.Пүрэвлхам шүүх хуралдаанд шүүгдэгч Д.А-ны гэм буруугийн асуудлыг шийдвэрлүүлэх хүсэлтээ бичгээр гаргаж өгөөгүй ч шүүх хуралдаанд түүний амаар гаргасан хүсэлтийг шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах замаар хүсэлтийг нь хүлээж авлаа.

Түүнчлэн шүүхээс яллагдагчийг шүүхэд шилжүүлэх захирамж гарснаас хойш товлогдсон шүүх хуралдаанаас өмнө шүүгдэгч Д.А нас барсан асуудал гарсан бөгөөд уг асуудлаар шүүх бүрэлдэхүүн товлогдсон өдрөөс өмнө хуралдах хуулийн зохицуулалт байхгүй болно.

Шүүх хөндлөнгийн байгууллага болохын хувьд шүүх хуралдаанд өөрийн санаачилгаар асуудалд хандах хуулийн зохицуулалт байхгүй, хэргийн оролцогч нарын хүсэлтийг шийдвэрлэх замаар шүүх хуралдааныг явуулдаг ба хэргийн оролцогч нараас Д.А-д холбогдох хэргийг тусгаарлах тухай хүсэлт гаргаагүй болохыг тэмдэглэв.

Өмгөөлөгч нараас Авлигатай тэмцэх газарт шүүгдэгч Х.А-ын хэргээс өөр хэрэг тусгаарласан. Уг тусгаарласан хэргийг энэ хэргээс тусад нь шийдвэрлүүлэх нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордох тул хэргийг мөрдөн байцаалтад буцааж өгнө үү гэх хүсэлтийг хүлээн авах боломжгүй гэж үзлээ. Учир нь:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.1-д «шүүхэд хэрэг хянан хэлэлцэх ажиллагаа нь зөвхөн шүүгдэгчийн хувьд, гагцхүү түүнийг шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор явагдана» гэж заасны дагуу уг тусгаарласан гэх хэрэгт Х.А хамааралтай эсэх, хэзээ, хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй хэрэгт шүүгдэгч Х.А-т холбогдох хэргийг нэгтгүүлж шийдвэрлүүлэхээр буцаах нь шүүгдэгчийн эрх зүйн байдал дордох тул хэргийг хянан шийдвэрлэх нь зүйтэй гэж шүүх үзлээ.

Энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн 9 хавтас материал, «Хас

банк» гэсэн тэмдэглэлийн дэвтэр 1 ширхэг, №001567. дугаартай үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх дэвтэр 1 ширхэг, «Татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр» 1 ширхэг зэргийг хууль ёсны эзэмшигч нарт нь буцаан олгож, нэгжлэг хийсэн видео бичлэгтэй диск 3 ширхэг, №001567. дугаартай үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх дэвтрийн хуулбар, «Татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр»-ийн хуулбар зэргийг уг хэргийг хадгалах хугацаа дуустал хэрэгт үлдээхээр шийдвэрлэв.

Эд хөрөнгө битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгож, Д.А-аас хураан авсан 1.000.000 /нэг сая/ төгрөгийг түүний ар гэрт, хх-хх УНЦ улсын дугаартай «Тоёота Ланд Круйзер» маркийн автомашиныг эзэмшигч Ц.Ч-д, Х.А-ын үүсгэн байгуулсан «ДЕ» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 57,68м² талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо Ралид харш /17011/ ...тоот 57,99м² талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 57,99м² талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 57,99м² талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 31,61м² талбайтай хоёр өрөө Y-220601xxxx бүртгэлийн дугаартай орон сууц зэргийг Х.А-т тус тус буцаан олгож шийдвэрлэсэн болохыг дурдав.

Шүүгдэгч нарын иргэний бичиг баримт шүүхэд шилжиж ирээгүй, бусдад төлөх төлбөргүй, шүүгдэгч Д.А нь энэ хэрэгтээ 52 /тавин хоёр/ хоног, шүүгдэгч Ц.Ч нь энэ хэрэгтээ 82 /наян хоёр/ хоног, шүүгдэгч Н.О нь энэ хэрэгтээ 11 /арван нэг/ хоног цагдан хоригдсон болохыг дурдаж, шүүгдэгч Х.А-ын энэ хэрэгт урьдчилан цагдан хоригдсон 338

/гурван зуун гучин найм/ хоногийг түүний ял эдлэх хугацаанд нь оруулан тооцвол зохино.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 248 дугаар зүйлийн 248.1.1, 248.1.2, 283, 290 дүгээр зүйлийн 290.3, 294-298 дугаар зүйлүүдэд заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Нийслэлийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Ш овогт Н.О-д холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар А овогт Ц.Ч-д холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгож, Н.О, Ц.Ч нарыг цагаатгасугай.

2. Н.О, Ц.Ч нарт урьд авсан бусдын батлан сэргийлэх арга хэмжээг тус тус хүчингүй болгосугай.

3. Нийслэлийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар Г овогт Х.А-т холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосугай.

4. Шүүгдэгч Г овогт Х.А-ыг албан тушаалтанд бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн,

Шүүгдэгч Б овогт Д.А-ыг онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.

5. Шүүгдэгч Б овогт Д.А-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосугай.

6. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Г овогт Х.А-ыг 3 /гурав/ жилийн хугацаагаар хорих ял шийтгэсүгэй.

7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар

Х.А-ын эдлэх 3 /гурав/ жилийн хорих ялыг жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлсүгэй.

8. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2 дахь хэсэгт зааснаар шүүгдэгч Д.А нь энэ хэрэгтээ 52 /тавин хоёр/ хоног, шүүгдэгч Ц.Ч нь энэ хэрэгтээ 82 /наян хоёр/ хоног, шүүгдэгч Н.О нь энэ хэрэгтээ 11 /арван нэг/ хоног тус тус хоригдсон болохыг дурдаж, шүүгдэгч Х.А-ын энэ хэрэгтээ цагдан хоригдсон 338 /гурван зуун гучин найм/ хоногийг түүний хорих ял эдэлсэн хугацаанд оруулан тооцсугай.

9. Х.А, Д.А, Н.О, Ц.Ч нарт холбогдох шүүхэд шилжиж ирээгүй, бусдад төлөх төлбөргүй болохыг дурдсугай.

10. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэг зааснаар гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл болох Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо, ...тоот, /Улсын бүртгэлийн Y-220601xxxx дугаартай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй/ 160м2 талбай бүхий орон сууц, зоорийн давхарын ...тоот, ...байрны ...тоот 2 ширхэг авто зогсоол зэргийг хурааж, улсын орлого болгохоор Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд Улсын бүртгэлийн Y-220601xxxx дугаартай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг эх хувиар нь шилжүүлсүгэй.

11. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.10 дахь хэсэгт зааснаар тогтоол хүчин төгөлдөр болмогц эд хөрөнгө битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгож, Д.А-аас хураан авсан 1.000.000 /нэг сая/ төгрөгийг түүний ар гэрт, хх-хх УНЦ улсын дугаартай "Тоёота Ланд Круйзер" маркийн автомашиныг эзэмшигч Ц.Ч-д,

Х.А-ын үүсгэн байгуулсан «ДЕ» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 57,68м2 талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай,

Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо Рарид харш /1701./ ...тоот 57,99м2 талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx,

Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 57,99м2 талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 31,61м2 талбайтай хоёр өрөө Y-220601xxxx бүртгэлийн дугаартай орон сууц зэргийг Х.А-т тус тус буцаан олгосугай.

12. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар тогтоол хүчин төгөлдөр болмогц энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн Бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд "Газрын тосны газар Б-193" гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, "Тг" ХХК-ийн талбайн захиалга, доод хэсэгт "2008 он" гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, 1-181 хүртэл дугаарлагдсан, "Эргэл-12" талбайд захиалга ирүүлсэн "Тг" ХХК-ийн тухай танилцуулга гэсэн 1 боть материал, "Тг" ХХК-ийн талбайн захиалга" гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд "АМГТХЭГ Т-63" гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, "2008 он" гэсэн, 1-210 хүртэл дугаар хуудастай 1 боть материал, "Тг" ХХК-ийн Шарга-3 талбайн захиалга" гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтасатай, нүүрэн хэсгийн дээд талд "АМГТХЭГ Т-36" гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, "2008 он" гэсэн, 1-208 хүртэл дугаар хуудастай 1 боть материал, "Тг" ХХК гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд "Б-191" гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, "2008 он" гэсэн, 1-209 хүртэл дугаар хуудастай, 1 боть материал, "Тг" ХХК-ийн Төхөм-10 талбайд өгсөн захиалгын материал гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд "Газрын тосны газар Б-227" гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, "2008 он" гэсэн 1-205 хүртэл дугаар хуудастай, 1 боть материал, "Тг" ХХК-ийн Нэмэгт-6 талбайд өгсөн захиалгын материал" гэсэн гарчигтай, бор өнгийн цагаан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд "Газрын тосны газар Б-226" гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, "2008 он" гэсэн, 1-208 хүртэл дугаар хуудастай, 1 боть материал, Газрын тосны газрын Гэрээлэлтийн хэлтсийн дарга О.Э, мэргэжилтэн А.Тү нар нь 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэн "Тг" ХХК-ийн Газрын тосны газарт Шарга-3 талбайд өгсөн захиалгын хуулбар хувь» боть 1, «Тг» ХХК-ийн Газрын тосны газарт Нэмэгт-3 талбайд өгсөн захиалгын хуулбар хувь» 1 боть, «Тг» ХХК-ийн санхүүгийн чадамжийн талаарх танилцуулга нийт 3 боть, 2013 оны

12 дугаар сарын 16-ны өдөр яллагдагч Ц.Ч-ийн Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот орон сууцанд нэгжлэг хийх үед хураан авсан хар өнгийн Хас банк 10, 2008 гэсэн тэмдэглэлийн дэвтэр 1 ширхэг, №001567. дугаартай үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх дэвтэр 1 ширхэг, Т.Ц-ийн эхнэр /ХА..... регистрийн дугаартай/ Ч овогт Б.Т-н «татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр» 1 ширхэг зэргийг хууль ёсны эзэмшигч нарт нь буцаан олгож, 2013 оны 12 дугаар сарын 17-ны өдөр яллагдагч Ц.Ч-ийн Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууцанд нэгжлэг хийсэн видео бичлэгтэй диск 1 ширхэг, 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоот Д.А-ны амьдарч буй орон сууцанд нэгжлэг хийсэн видео бичлэгтэй диск 2 ширхэг, №001567. дугаартай үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх дэвтрийн хуулбар, Ц.Ч-ийн эхнэр /ХА..... регистрийн дугаартай/ Ч овогт Б.Т-н «татвар төлөгч иргэний орлого,

татварын бүртгэлийн дэвтэр»-ийн хуулбар зэргийг уг хэргийг хадгалах хугацаа дуустал хэрэгт үлдээсүгэй.

13. Энэ тогтоол нь танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд Х.А-т авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлж, түүний эдлэх ялыг 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрөөс эхлэн тоолсугай.

14. Гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээдүүд шийтгэх тогтоолыг эс зөвшөөрвөл тогтоолыг гардуулснаас хойш Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд 14 хоногийн дотор давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

15. Давж заалдах шатны шүүхэд гомдол гаргасан, эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол хүчин төгөлдөр болтол Х.А-т авсан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлж, Н.О, Ц.Ч нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ
ШҮҮГЧИД

Б.БАТБОЛОР
Г.ЕСӨН-ЭРДЭНЭ
С.БАТГЭРЭЛ

МАГАДЛАЛ

2014 оны 09 сарын 11 өдөр

Дугаар 787

Улаанбаатар хот

Х.А, Д.А, Н.О, Ц.Ч нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн шүүгч Ш.Бат-Эрдэнэ даргалж, шүүгч Ч.Хосбаяр, Н.Батсайхан нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанд:

Прокурор О.Сарангэрэл,
Талийгаач Д.А-ны өмгөөлөгч Р.Пүрэвлхам,
Цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч М.Баяраа, Л.Ононбаяр,
Ялтан Х.А-ын өмгөөлөгч Ц.Цэрэнжээ, Б.Баярмаа, Ж.Эрдэнэбулган, Х.Базаррагчаа,
Нарийн бичгийн дарга Б.Хулангоо нарыг оролцуулан,

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн шүүгч Б.Батболор даргалж, шүүгч Г.Есөн-Эрдэнэ, С.Батгэрэл нарын бүрэлдэхүүнтэй хийсэн шүүх хуралдааны 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 дүгээр шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч ялтан Х.А, түүний өмгөөлөгч Ж.Эрдэнэбулган, Ц.Цэрэнжээ, Б.Баярмаа нарын хамтран гаргасан, хохирогч, иргэний нэхэмжлэгч Монгол Улсын Сангийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Г, цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч Л.Ононбаяр, Д.А-ны өмгөөлөгч Р.Пүрэвлхам нарын гаргасан давж заалдах гомдол болон Улсын яллагч О.Сарангэрэлийн бичсэн эсэргүүцлээр С.Д.А, Ц.Ч, Х.А, Н.О нарт холбогдох 20140100004 дугаартай хэргийг 2014 оны 08 дугаар сарын 4-ний өдөр хүлээн авч, шүүгч Н.Батсайханы илтгэснээр хянан хэлэлцэв.

1. Г овогт Х.А, ...оны ...дүгээр сарын ...-нд Төв аймгийн ...суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, аялал жуулчлалын менежер, орчуулагч мэргэжилтэй, «Тг» ХХК-ийн ерөнхий захирал ажилтай, ам бүл..., эхнэр, хүүхдүүдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /РД:ЦБ...../,

2. Б овогт Д.А, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан, одоо эрхэлсэн тодорхой ажилгүй, ам бүл..., эхнэр, хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /РД:ХБ...../,

3. Ш овогт Н.О, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч, компьютер-техникийн инженер мэргэжилтэй,

«Тг» ХХК-ийн ерөнхий менежер ажилтай, ам бүл... , эхнэр, хүүхдүүдийн хамт Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух хаягтай, одоо Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /РД:ХБ...../,

4. А овогт Ц.Ч, ...оны ...дугаар сарын ...-нд Бүгд Найрамдах Унгар Улсын Будапешт хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, «Те Х» ХХК-д ерөнхий менежер ажилтай, ам бүл..., эхнэр, хүүхдүүдийн хамт Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, /РД:ХП...../,

Х.А нь Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухайн хуулийн 7, 8, 16, 17, 21 дүгээр зүйлүүдэд заасан заалтуудыг зөрчин 2007-2011 онд нийт 12.303.690.000 төгрөгөөр хайгуулын болон ашиглалтын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан авч Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлогын албан татвар болох 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөлгүй онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн,

Мөн 2008 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн Үйлдвэр худалдааны сайд Х.Н-гийн 196 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүн хуваах чиглэлээр Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Олон улсын нээлттэй тендер зарлаж, уг тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө «Тг» ХХК-ийн ерөнхий менежер Н.О-д итгэмжлэл хийж өгч, Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины

зогсоолыг Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлэн хээл хахууль өгсөн,

Д.А нь Газрын тосны газрын даргаар ажиллаж байхдаа Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан, газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны дарга, Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар тус тус ажиллахдаа тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Х.А-ын 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг төрсөн ах Д.Ц-ийн хүү Ц.Ч-ийн нэр дээр 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр шилжүүлэн авч онц их хэмжээний хээл хахууль авсан,

Шүүгдэгч Н.О нь Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудын сонгон шалгаруулалтад «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д Х.А-ын эзэмшлийн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлж, хээл хахууль өгөх гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлэн хамжигчаар оролцсон,

Ц.Ч нь «Тг» ХХК-ийн захирал Х.А-аас Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д «Тг» ХХК-ийг тендерт шалгаруулсны төлөө өгсөн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг өөрийн нэр дээр шилжүүлэн авч, онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг нуун далдалж гэмт хэрэгт хамжигчаар оролцсон гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Нийслэлийн Прокурорын газраас: Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2, 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Х.А, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар Д.А, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Н.О, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан, Эрүүгийн хуулийн тусгай 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт

зааснаар Ц.Ч нарт тус тус холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж, хэргийг шүүхэд шилжүүлжээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүх: Нийслэлийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Н.О-д холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар Ц.Ч-д холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгож, Н.О, Ц.Ч нарыг цагаатгаж, Н.О, Ц.Ч нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хүчингүй болгож, Нийслэлийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар Х.А-т холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Х.А-ыг албан тушаалтанд бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн,

Д.А-ыг онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Д.А-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Х.А-ыг 3 жилийн хугацаагаар хорих ял шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар Х.А-ын эдлэх 3 жилийн хорих ялыг жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.1, 59.2 дахь хэсэгт зааснаар Д.А нь энэ хэрэгтээ 52 хоног, Ц.Ч нь энэ хэрэгтээ 82 хоног, Н.О нь энэ хэрэгтээ 11 хоног тус тус хоригдсон болохыг дурдаж, Х.А-ын энэ хэрэгтээ цагдан хоригдсон 338 хоногийг түүний хорих ял эдэлсэн хугацаанд оруулан тооцож. Х.А, Д.А, Н.О, Ц.Ч нарт

холбогдох иргэний бичиг баримт шүүхэд шилжиж ирээгүй, бусдад төлөх төлбөргүй болохыг дурдаж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл болох Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот, /Улсын бүртгэлийн Y-220601xxxx дугаартай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй/ 160 м2 талбай бүхий орон сууц, зоорийн давхарын ...тоот, ...байрны ...тоот 2 ширхэг авто зогсоол зэргийг хурааж, улсын орлого болгохоор Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд Улсын бүртгэлийн Y-220601xxxx дугаартай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг эх хувиар нь шилжүүлж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.10 дахь хэсэгт зааснаар тогтоол хүчин төгөлдөр болмогц эд хөрөнгө битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгож, Д.А-аас хураан авсан 1.000.000 төгрөгийг түүний ар гэрт, хх-хх УНЦ улсын дугаартай «Тоёота Ланд Круйзер» маркийн автомашиныг эзэмшигч Ц.Ч-д,

Х.А-ын үүсгэн байгуулсан «ДЕ» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 57,68 м2 талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай,

Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо Репид харш /17011/ ...тоот 57,99 м2 талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай,

Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 57,99 м2 талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай,

Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 57,99 м2 талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай,

Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 31,61 м2 талбайтай хоёр өрөө Y-220601xxxx бүртгэлийн дугаартай орон сууц зэргийг Х.А-т тус тус буцаан олгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар тогтоол хүчин төгөлдөр болмогц энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн Бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «Газрын тосны газар Б-193»

гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «Тг» ХХК-ийн талбайн захиалга, доод хэсэгт «2008 он» гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, 1-181 хүртэл дугаарлагдсан, «Эргэл-12» талбайд захиалга ирүүлсэн «Тг» ХХК-ийн тухай танилцуулга гэсэн 1 боть материал, «Тг» ХХК-ийн талбайн захиалга» гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «АМГТХЭГ Т-63» гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «2008 он» гэсэн, 1-210 хүртэл дугаар хуудастай 1 боть материал, «Тг» ХХК-ийн Шарга-3 талбайн захиалга» гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «АМГТХЭГ Т-36» гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «2008 он» гэсэн, 1-208 хүртэл дугаар хуудастай 1 боть материал, «Тг» ХХК гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «Б-191» гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «2008 он» гэсэн, 1-209 хүртэл дугаар хуудастай, 1 боть материал, «Тг» ХХК-ийн Төхөм-10 талбайд өгсөн захиалгын материал гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «Газрын тосны газар Б-227 гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «2008 он» гэсэн 1-205 хүртэл дугаар хуудастай, 1 боть материал, «Тг» ХХК-ийн Нэмэгт-6 талбайд өгсөн захиалгын материал» гэсэн гарчигтай, бор өнгийн цагаан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «Газрын тосны газар Б-226» гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «2008 он» гэсэн, 1-208 хүртэл дугаар хуудастай, 1 боть материал, Газрын тосны газрын гэрээлэлтийн хэлтсийн дарга О.Э, мэргэжилтэн А.Тү нар нь 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэн «Тг» ХХК-ийн Газрын тосны газарт Шарга-3 талбайд өгсөн захиалгын хуулбар хувь» боть 1, «Тг» ХХК-ийн Газрын тосны газарт Нэмэгт-3 талбайд өгсөн захиалгын хуулбар хувь» 1 боть, «Тг» ХХК-ийн санхүүгийн чадамжийн талаарх танилцуулга нийт 3 боть, 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдөр яллагдагч Ц.Ч-ийн Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууцанд нэгжлэг хийх үед хураан авсан хар өнгийн Хас банк 10, 2008 гэсэн тэмдэглэлийн дэвтэр 1 ширхэг, №001567. дугаартай үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх дэвтэр 1 ширхэг, Ц.Ч-ийн эхнэр /РД:ХА...../ Б.Т-ын «татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр» 1 ширхэг зэргийг хууль ёсны эзэмшигч нарт нь буцаан олгож,

2013 оны 12 дугаар сарын 17-ны өдөр яллагдагч Ц.Ч-ийн Хан-Уул дүүргийн

...дугаар хороо, ...тоот орон сууцанд нэгжлэг хийсэн видео бичлэгтэй диск 1 ширхэг, 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоот Д.А-ны амьдарч буй орон сууцанд нэгжлэг хийсэн видео бичлэгтэй диск 2 ширхэг, №001567. дугаартай үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх дэвтрийн хуулбар, Ц.Ч-ийн эхнэр /ХА.....регистрийн дугаартай/ Б.Т-ын "татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр"-ийн хуулбар зэргийг уг хэргийг хадгалах хугацаа дуустал хэрэгт үлдээхээр шийдвэрлэжээ.

Ялтан Х.А давж заалдах гомдолдоо: Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 751 тоот шийтгэх тогтоолын зарим хэсгийг миний өмгөөлөгч нар эс зөвшөөрч гомдол гаргаж байгаа ба би эрүүл мэндийн байдлынхаа талаар доорхи хүсэлт гаргаж байгааг хүлээн авна уу. 2013 оны 07 дугаар сарын 09-нд Авлигатай тэмцэх газраас намайг саатуулан цагдан хорьсноос хойш өнөөдрийг хүртэл миний эрүүл мэндийн байдал муудсаар байна. Миний бие 2011 оноос ходоодны үрэвсэл, шархтай болоод 2 жил тасралтгүй гадаадад эмчлүүлж, эмчийн байнгын хяналтад байсан. Цагдан хоригдсоноос хойш эмчилгээ тасарч, ходоодны үрэвсэл ахин сэдэрсэн, мөн арьсны үрэвсэл ахин гарч эмчилгээ хийлгэх шаардлагатай болсон. Мөн удаан хугацаагаар чийгтэй орчинд хоригдсоноос үүдэн 2 бөөр үрэвсэлтэй болсон билээ. Энэ бүгдийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хорих 461 дүгээр ангийн эмчийн тодорхойлолт баталж байгаа. 2013 оны намраас миний нуруун дээр шинээр хавдар үүсэж, 2014 оны 01 дүгээр сард эд эсийн шинжилгээ аваад, Хавдар Судлалын Үндэсний Төвд хагалгаа хийлгэх шаардлагатай гэсэн эмч нарын дүгнэлт гарсан бөгөөд 2014 оны 07 дугаар сарын 07-нд мэс засалд орж, нуруунаасаа 2 ширхэг хавдар авахуулсан. Одоогоор биеийн байдал муу, анх хоригдсоноосоо хойш 22 кг турсан байгаа бөгөөд цаашид үргэлжлүүлэн эмчийн хяналтад байж эмчилгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай байна.

Миний холбогдсон хэргийг ахин хянаж, хэрэгсэхгүй болгон, анхан шатны шүүхээс өгсөн хорих ялыг хөнгөрүүлж, надад эрүүл мэндээ анхаарах, цаашид эрүүл мэндээрээ үргэлжлүүлэн хохирохгүй байх боломж олгоно уу гэж хичээнгүйлэн хүсэн энэхүү хүсэлтийг

гаргаж байна гэжээ.

Ялтан Х.А-ын өмгөөлөгч Ж.Эрдэнэбулган давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн №751 тоот шийтгэх тогтоолыг эс зөвшөөрч Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 303, 304 дүгээр зүйлд заасан дагуу энэхүү гомдлыг гаргаж байна.

Х.А-ыг анх 2013 оны 07 сарын 9-ний өдөр Авлигатай тэмцэх газраас Ашигт малтмалын газрын дарга нартай хуйвалдан албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, мөнгө угаах гэмт хэрэгт хамтран оролцсон байж болзошгүй гэдэг үндэслэлээр Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсгийг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 мөн хуулийн 166¹ дүгээр зүйлийн 166^{1.3} дахь хэсэгт зааснаар яллагдагчаар татан эрүүгийн 20130100004. тоот хэрэг үүсгэн 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн цагдан хорьсон. Эдгээр гэмт хэргүүдтэй холбогдуулан Х.А-ыг хорьж шалгаж байгаад 2014 оны 03 дугаар сарын 18-ны өдөр өмнө шалгаж байсан хэргээс тусгаарлан дахин /20140100004./ тоот эрүүгийн хэрэг үүсгэн шинээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2, 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллагдагчаар татсан болно.

Х.А-ыг дээрх гэмт хэргүүдэд холбогдуулан шалгах явцад мөрдөн байцаалт болон прокурорын шатанд эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн үйлдлүүдийг мөрдөн байцаагч болон прокурор удаа дараа гаргаж Х.А-ыг ямар ч хамаагүй аргаар шүүхээр шийтгүүлэх гэсэн хандлагатай байсан ба анхан шатны шүүх хэргийг шийдвэрлэх явцдаа мөрдөн байцаагч, прокурорын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчсөн, хариуцлага алдсан алдаа, зөрчил байсан гэдгийг хүлээн зөвшөөрсөн атлаа /энэ хэрэгт холбогдсон Д.А-ыг яллагдагчаар татсан тогтоолгүйгээр мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж түүнийг гэм буруутай гэж үзэж шийтгэсэн/ алдаануудыг үл хайхран түүнийг шийтгэсэн мөн Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 80 дугаар зүйлд заасан хэргийн талаар нотолбол зохих асуудлуудыг бүрэн нотолж чадалгүйгээр Х.А-ыг гэм буруутайд тооцон ял шийтгэсэн юм.

Х.А-ыг анх Эрүүгийн хуулийн тусгай

ангийн 263 дугаар зүйлийн 263.2 мөн хуулийн 166¹ дүгээр зүйлийн 166^{1.3} дахь хэсэгт холбогдуулан шалгаж байсан ба энэ хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 125 дугаар зүйлд заасны дагуу тусгаарлажээ. Эрүүгийн хэргийг тусгаарлах үндэслэл нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.4-д заасан “Хоёр буюу хэд хэдэн сэжигтэн, яллагдагч хэрэгт татагдсан бөгөөд, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэл нь бүх сэжигтэн, яллагдагчид хамаарахгүй байвал зарим сэжигтэн яллагдагчид холбогдох хэргийг тусгаарлан түдгэлзүүлдэг.

Мөн энэ хуулийн 208 дугаар зүйлийн 208.2-д заасан «Хэд хэдэн яллагдагч хэрэгт татагдсан бөгөөд, хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл нь нийт яллагдагчид хамаарахгүй байвал тухайн яллагдагчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгоно» гэсэн тохиолдолд тусгаарлагддаг. Нэг хүнд холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн дөрвөн өөр зүйлд заасан гэмт хэрэгт яллагдагчаар татсан хэргүүдийг ингэж хоёр хоёроор нь өөр өөр дугаар бүхий хавтаст хэргүүд болгон салган шийдвэрлэж байгаа нь Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчсөн явдал болж байна.

Шүүхийн шийтгэх тогтоолын тодорхойлох хэсгийн 4-д «...өмгөөлөгч нараас Авлигатай тэмцэх газарт Х.А-ын хэргээс өөр хэргийг тусгаарласан. Уг тусгаарласан хэргийг энэ хэргээс тусад нь шийдвэрлүүлэх нь шүүгдэгчийн эрх зүйн байдал дордох тул мөрдөн байцаалтад хэргийг буцааж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авах боломжгүй. Учир нь, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн 246.1-д Шүүхэд хэрэг хэлэлцэх ажиллагаа нь зөвхөн шүүгдэгчийн хувьд, гагцхүү түүний шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор явагдана гэж заасны дагуу уг тусгаарласан гэх хэрэгт Х.А нь хамааралтай эсэх хэзээ, хэрхэн шийдвэрлэх тодорхойгүй хэрэгт шүүгдэгч Х.А-т холбогдох хэргийг нэгтгүүлж шийдвэрлүүлэхээр буцаах нь шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулах тул хэргийг хянан шийдвэрлэх нь зүйтэй гэжээ. Гэтэл өмнө нь бүтэн 8 сар хорьж мөрдөж шалгасан хэргийг хэрхэн шийдвэрлэсэн нь тодорхойгүйгээр хэргийг буруу тусгаарласнаас болж Х.А-ыг өмнө шалгаж байсан дээрх хэргүүдэд дахин шийтгүүлэх нөхцлийг бүрдүүлж байгаа бөгөөд энэ нь түүний эрх зүйн байдлыг шууд

дордуулах үндэслэлийг бий болгож байна. Шүүхийн тогтоолд заасан энэхүү дүгнэлт нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйл болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230 дугаар зүйлийн 230.1.1-д заасан заалтыг зөрчсөн буруу жишиг тогтоосон шийдвэр болсон гэх үндэслэлтэй.

Шүүхийн шийтгэх тогтоолоор Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо “Р.Г.В” хотхон ...тоот, 160 м2 кв талбай бүхий орон сууц, зоорийн давхарын ...тоот, Г... байрны ...тоот 2 ширхэг авто зогсоолыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт заасны дагуу хурааж улсын орлого болгохоор шийджээ. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлд «Эд хөрөнгө хураах ялыг хуульчилсан бөгөөд энэ зүйлийн 49.2-т «Гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана гээд» гэж заасан бөгөөд энэ нь хэдийгээр нэмэгдэл ялын шинжийг агуулахгүй боловч эдгээр зүйл нь гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг үнэ төлбөргүй хурааж улсын орлого болгох ёстой. Гэтэл энэ байр зогсоол нь Ц.Ч-ийн өмчлөлд байдаг бөгөөд энэ байр болон зогсоолын өмчлөх эрхийг ямар нэг байдлаар хүчингүй болгоогүй байхад шууд улсын орлого болгож шийдвэрлэсэн нь ойлгомжгүй бөгөөд хүний өмчлөх эрхэнд шууд халдсан шинжтэй шийдвэр болжээ. Иймд Х.А-ыг гэм буруутай гэж үзсэн энэхүү хэрэгт Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230 дугаар зүйлд заасан хэргийг буруу нэгтгэсэн, тусгаарласан, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн энэ хуулийг ноцтой зөрчсөн байдлууд байгаа тул анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж өгнө үү гэв.

Ялтан Х.А-ын өмгөөлөгч Ц.Цэрэнжээ, Б.Баярмаа нар хамтран гаргасан давж заалдах гомдолдоо: Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 тоот шийтгэх тогтоолын зарим хэсгийг эс зөвшөөрч гомдол гаргаж байна. Анхан шатны шүүх Х.А-т холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2-д заасан гэмт хэргийг, Ц.Ч-д холбогдох мөн

хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2-д заасан гэмт хэргүүдийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-д заасан үндэслэлээр, Н.О-д холбогдох мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан гэмт хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгон цагаатгасан нь хуулийн үндэслэлтэй юм.

Харин Х.А-ыг албан тушаалтанд бусдаар дамжуулан хээл хахууль өгсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар 3 жилийн хорих ял оноосон, шүүх хуралдаанаар холбогдуулсан хэрэг нь хэлэлцэгдээгүй, нас барсан Д.А-ыг онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон зэрэг хуулийн болон нотолгооны үндэслэлгүй байгаа тул эс зөвшөөрч гомдол гаргаж байгааг хүлээн авна уу.

-Х.А албан тушаалтанд бусдаар дамжуулж хээл хахууль өгөөгүй юм. Хавтас хэрэгт авагдсан, анхан шатны шүүх хуралдаан дээр шинжлэн судлагдсан нотлох баримтуудаар Х.А тухайн үедээ /2009 онд/ Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д орон сууцыг бусдаар дамжуулан өгсөн гэдэг нь тогтоогдоогүй болно. Х.А Хан-уул дүүргийн 1 дүгээр хороо, "Р.Г.В" хотхон, ...тоот, 160 м2 орон сууц, 2 машины зогсоолыг Хас банкинд хэлтсийн даргаар ажиллаж байсан Ц.Ч-ийг компанидаа менежерээр ажиллуулахдаа хөнгөлөлттэй үнээр худалдсан нь хавтас хэрэгт авагдсан Орон сууц бэлэглэлийн гэрээ, мөнгө төлсөн баримт, шүүгдэгч Х.А, Ц.Ч, Н.О нарын мэдүүлэг, Ц.Ч-ийн «ТХ» ХХКомпанид менежерээр ажиллаж байсан зэрэг нөхцөл байдлуудаар тогтоогдсон. Мөн Х.А тухайн үед ажилд орсон өндөр мэргэжлийн Х, Г, Б нарын 7 залууд орон сууц олгосон бөгөөд тэдгээрийн нэг нь Ц.Ч юм. Мөн Н.О, Ц.Ч нарт орон сууцнаас гадна Ланд- 200 автомашиныг өгсөн байна. Анхан шатны шүүх энэ байдлуудад бодитой дүгнэлт хийж хээл хахуулийг дамжуулсан гэх Н.О, Ц.Ч нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

-Х Х.А Д.А-д хээл хахууль өгөх шаардлага байхгүй, өгөөгүй нь дараах байдлуудаас харагдана. 2008 оны 8 сард олон улсад газрын тосны хайгуулын Шарга-3. Нэмэгт-6 талбайд нээлттэй зарлагдсан

сонгон шалгаруулалт 2008 оны сүүлчээр явагдсан байна. "Тг" ХХК энэ шалгаруулалтад зохих журмын дагуу оролцож, хамгийн өндөр оноог авсан. Өөрөөр хэлбэл, бусад оролцогч нартай харьцуулахад Монгол Улсын Засгийн газарт хамгийн ашигтай саналыг ирүүлсэн нь хавтас хэрэгт авагдсан сонгон шалгаруулалтын баримтуудаар нотлогддог. Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг, Үнэлгээний хороо, Сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрүүдийг сонгон шалгаруулалтад оролцсон бусад оролцогч нар хүлээн зөвшөөрсөн нь шалгаруулалттай холбоотой ямар маргаан хийгээгүйгээс харагддаг юм. Харин 2009 оны эхээр тухайн үед Эрдэс баялаг эрчим хүчний сайдаар ажиллаж байсан сайд Д.З асуудлыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын хуралд оруулан хэлэлцүүлээгүй 6 жилийн хугацаа өнгөрч хуулийн дагуу сонгон шалгаруулалт цуцлагдсан байна. Энэ нь сонгон шалгаруулалт бүрэн явагдаагүй, төрийн эрх бүхий албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагааны хохирогч нь "Тг" ХХК болсныг нотолж байна. Энэ байдал нь сонгон шалгаруулалтын зөвлөлийн гишүүдийн болон шүүх хуралдаанд гэрч О.Э, Г.Т нарын өгсөн мэдүүлгээр нотлогдсон.

-Д.А ажлын хэсэг, Үнэлгээний хорооны ажиллагаанд оролцоогүй нь хавтас хэрэгт авагдсан болон анхан шатны шүүх хурал дээр шинжлэн судалсан нотлох баримтуудаар тогтоогдсон. Харин Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар ажиллахдаа "Тг" ХХК-ийг шалгаруулах талаар бусад гишүүддээ нөлөө үзүүлсэн гэх байдал тогтоогдоогүй юм. Мөн тухайн асуудлыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын хуралд хэлэлцүүлэх эрх бүхий албан тушаалтан биш юм.

-"Тг" ХХК нь гэнэт Газрын тосны хайгуулын сонгон шалгаруулалтад оролцоогүй. Өмнө нь Эргэл-12, Төхөм-10 тайлбайнуудын сонгон шалгаруулалтад оролцсон боловч шалгарч чадаагүй. Мөн тус компани Шарга-3, Нэмэгт-6 талбайд газрын тосны хайгуул хийх сонгон шалгаруулалтад оролцон хамгийн өндөр оноо авсан боловч, захиргааны байгууллагын зарим ажилтнуудын буруутай үйл ажиллагааны улмаас шалгаруулаагүй, гэрээ байгуулж чадалгүй, ажилчин, ажилтнууд, хөрөнгө оруулагч нарынхаа өмнө маш хүнд байдалд орсон, захирал Х.А нь хилсээр шийтгүүлэн давхар давхар эрүүл мэнд, эд хөрөнгө, ажил хэргийнхээ нэр хүндээр хохирч байна.

Энэ бүхнээс үзэхэд Х.А нь Д.А-д орон сууц хээл хахууль болгон өгөх бодит шалтгаан, шаардлага байхгүй юм.

-Анхан шатны шүүхийн Х.А-ыг яллах үндэслэл болгосон гэрчүүдийн мэдүүлгээс үзэхэд ихэнх нь хов шинжтэй, шинжээч С.Т нь мэргэжил, туршлагын хувьд дутмаг, Х.А-ыг ямар нэг юм олж буруутгах зорилготой байсан нь сонгон шалгаруулалтын оролцогч компаниудын Засгийн газарт өгсөн саналуудыг харьцуулан үзэлгүйгээр. зөвхөн сонгон шалгаруулах зөвлөлийн хуралд эсрэг саналтай оролцсон зарим гишүүдийн хэлсэн үгэн дээр тулгуурлан, нэг ч тоо баримтыг нэмж хасаж үзэлгүй дүгнэлт гаргасан байдлаас харагдана. Ийм учраас шинжээч гэх С.Т-ын дүгнэлт нь нотолгооны чанаргүй юм.

- Анхан шатны шүүх Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдлуудыг тогтоожээ. Гэтэл анхан шатны шүүх шүүх хуралдаанд оролцох, шүүхийн өмнө өөрийн гэм буруугүйг нотлох ажиллагаа явуулах боломжгүй болсон нас барсан иргэнийг гэм буруутайд тооцсон нь хүний эрх зөрчиж байгаа маш бүдүүлэг алдаа юм. Шүүх зөвхөн гэм буруугийн асуудал нь шүүх хурал дээр хэлэлцэгдсэн, шүүх хуралд оролцсон хүний гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх эрхтэй. Гэтэл хуулийн тодорхой үндэслэлгүйгээр, байцаан шийтгэх ажиллагаа явуулахыг хориглосон, яллагдагчаар татсан тогтоол байхгүй байхад Д.А-ыг хээл хахууль авсан гэх гэмт хэрэгт гэм буруутайд тооцсон тогтоол гаргалаа. Яллагдагчаар татсан тогтоолгүй хүнийг яллагдагчаар байцаасан, мөн шүүгдэгч болгосон, гэм буруутайд тооцсон нь илэрхий бүдүүлэг алдаа, хуулийн зөрчил юм.

-Авлигатай тэмцэх газар, Нийслэлийн прокурор Х.А-ыг анх 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр гэнэт баривчлан цагдан хорьж, түүнийг гэмт хэрэгт буруутгах янз бүрийн арга хэрэглэсэн боловч “Үнэнээр явбал, үхэр тэргээр туулай гүйцэнэ” гэсэн зүйр үгийн нотолгоо болж Х Х.А ямар нэг гэмт хэрэг үйлдээгүй нь тогтоогдсоор байна. Түүнийг 1 жилийн хугацаанд 3 шорон дамжуулан цагдан хорьж, эрүүл мэнд, эд хөрөнгө, ажил хэргийн нэр хүнд, бизнесээр нь хохироолоо. Тэрээр хавдартай болж, мэс засал хийлгэлээ. 27 килограммаар турсан байна. Гадаадын хөрөнгө оруулагч хамтран ажиллагч нар нь эргэлзэн хөрөнгөө

татан, Монгол Улсаас гарч байна. Анх сэжиглэн яллагдагчаар татсан гэмт хэрэг нь тогтоогдохгүй болохоор өөр гэмт хэрэгт үндэслэлгүйгээр сэжигтэн яллагдагчаар татан заавал ял оноож хохироох, өөрсдөө хариуцлагаас зайлсхийх гэсэн улайрсан байдал Х.А-ыг мөрдсөн, хянасан, цагдан хорьсон, шүүн тасалсан мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нарын ажиллагаанд илт ажиглагдаж байна. Д.А-ыг яллагдагчаар татсан тогтоол хавтас хэрэгт байхгүй, прокурор нь тогтоолгүй гэдгээ хүлээн зөвшөөрсөөр байхад шүүх тэрхүү хууль бус ажиллагааг хаацалсан дүгнэлт хийж байгаа нь зөвхөн нэг жишээ юм. Яллагдагчаар татсан тогтоолыг хүмүүсийн тодорхойлолт, тайлбар, шүүхийн дүгнэлт оролж чадахгүй.

Иймд Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 сарын 12-ны 751 тоот шийтгэх тогтоолын Х.А-т холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дугаар зүйлийн 269.1-д заасан гэмт хэрэгт гэм буруутайд тооцон 3 жилийн хорих ял оноосон 4, 6,10 дахь заалтуудыг хүчингүй болгож түүнийг цагаатгаж өгнө үү гэв.

Ялтан Х.А-ын өмгөөлөгч Б.Баярмаа тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 тоот шийтгэх тогтоолын зарим хэсгийг эс зөвшөөрч гомдол гаргаж байна. Анхан шатны шүүх Х.А-т холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2-д заасан гэмт хэргийг, Ц.Ч-д холбогдох мөн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2-д заасан гэмт хэргүүдийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-д заасан үндэслэлээр, Н.О-д холбогдох мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан гэмт хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгон цагаатгасан нь хуулийн үндэслэлтэй юм. Харин Х.А-ыг албан тушаалтанд бусдаар дамжуулан хээл хахууль өгсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар 3 жилийн хорих ял оноосон, шүүх хуралдаанаар холбогдуулсан хэрэг нь хэлэлцэгдээгүй, нас барсан Д.А-ыг онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон зэрэг хуулийн болон нотолгооны үндэслэлгүй байна. Х.А-ыг газрын тосны хайгуулын 2 талбайд

тендерт орохдоо сонгон шалгаруулалтын даргаар ажиллаж байсан Д.А-д орон сууц өгч хахуулдсан гэж ял оноосон боловч тухайн тендерт “Тг” ХХК хамгийн ашигтай санал өгсөн, тухайн хахуульд өгсөн гэж байгаа байр нь өөр хүний нэр дээр байгаа, Тг ХХК тендерт шалгарч тусгай зөвшөөрөл аваагүй зэргээс харахад энэ нь логик холбоогүй байна. Х.А-ын эрүүл мэндийн байдлын тодорхойлолтыг шүүх хуралдааны өмнө шүүхэд өгсөн. Х.А нь цагдан хоригдохоосоо өмнө ходоодны өрөвсөлтөй, байнга гадаад улсад очиж эмчилгээ хийлгэдэг байсан боловч цагдан хоригдсоноор эмчилгээ нь тасалдан биеийн байдал нь муудан, хавдартай болж хагалгаанд орсон боловч бүрэн эдгэрээгүй дахин хавдар ургаж байгаа, бөөрний өрөвсөлтөй болсон зэрэг биеийн бадлыг харгалзан үзэж Х.А-т оноосон ялын хамгийн дээд хэмжээг багасгаж, ялыг хөнгөрүүлж өгнө үү гэв.

Ялтан Х.А-ын өмгөөлөгч Ц.Цэрэнжээ тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Анх Х.А-ыг 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр мөнгө угаах гэмт хэрэгт холбогдуулж баривчилсан. Гэтэл хэний мөнгийг хэзээ аваад ямар үйлдэл хийсэн нь одоог хүртэл тодорхойгүй байхад прокурор яллах дүгнэлт үйлдэж ялласан.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 тоот шийтгэх тогтоолын зарим хэсгийг эс зөвшөөрч гомдол гаргаж байна. Анхан шатны шүүх Х.А-т холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2-д заасан гэмт хэргийг, Ц.Ч-д холбогдох мөн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2-д заасан гэмт хэргүүдийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-д заасан үндэслэлээр, Н.О-д холбогдох мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан гэмт хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгон цагаатгасан нь хуулийн үндэслэлтэй юм. Харин Х.А-ыг албан тушаалтанд бусдаар дамжуулан хээл хахууль өгсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцон, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар 3 жилийн хорих ял оноосон, шүүх хуралдаанаар холбогдуулсан хэрэг нь хэлэлцэгдээгүй, нас барсан Д.А-ыг онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцсон зэрэг хуулийн

болон нотолгооны үндэслэлгүй байна. Х.А нь Д.А-д авлига өгөх шаардлага байсан эсэх, тендер зохих ёсоор шалгараад дүгнэгдсэн эсэхийг тогтоох хэрэгтэй. Хавтас хэрэгт авагдсан, анхан шатны шүүх хуралдаан дээр шинжлэн судлагдсан нотлох баримтуудаар Х.А тухайн үедээ /2009 онд/ Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д орон сууцыг бусдаар дамжуулан өгсөн гэдэг нь тогтоогдоогүй болно. Х.А Хан-уул дүүргийн ...дүгээр хороо, “РГВ” хотхон, ...тоот, 160 м2 орон сууц, 2 машины зогсоолыг Хас банкинд хэлтсийн даргаар ажиллаж байсан Ц.Ч-ийг компанидаа менежерээр ажиллуулахдаа хөнгөлөлттэй үнээр худалдсан нь хавтас хэрэгт авагдсан Орон сууц бэлэглэлийн гэрээ, мөнгө төлсөн баримт, шүүгдэгч Х.А, Ц.Ч, Н.О нарын мэдүүлэг, Ц.Ч-ийн “ТХ” ХХК-д менежерээр ажиллаж байсан зэрэг нөхцөл байдлуудаар тогтоогдсон. Мөн Х.А тухайн үед ажилд орсон өндөр мэргэжлийн Х, Г, Б нарын 7 залууд орон сууц олгосон бөгөөд тэдгээрийн нэг нь Ц.Ч юм. Мөн Н.О, Ц.Ч нарт орон сууцнаас гадна Ланд- 200 автомашиныг өгсөн байна. Анхан шатны шүүх энэ байдлуудад бодитой дүгнэлт хийж хээл хахуулийг дамжуулсан гэх Н.О, Ц.Ч нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Хавтаст хэрэгт байгаа нотлох баримтуудаас үзэхэд Х.А-ын авлига өгсөн гэдгийг нотлох 1 ч үг байхгүй. Газрын тосны хайгуулын талбайд нээлттэй зарлагдсан сонгон шалгаруулалт явагдсан. «Тг» ХХК энэ шалгаруулалтад зохих журмын дагуу оролцож, хамгийн өндөр оноог авсан. Өөрөөр хэлбэл, бусад оролцогч нартай харьцуулахад Монгол Улсын Засгийн газарт хамгийн ашигтай саналыг ирүүлсэн нь хавтас хэрэгт авагдсан сонгон шалгаруулалтын баримтуудаар нотлогддог. Гэрч Г.Т «Д.А надаас “Тг” ХХК-ийн материал ямар байна гэж асууж байсан. Би ном журмаар нь шалгаруулна гэж хариулсан» гэж мэдүүлсэн байгааг мушгиж яллах талын нотлох баримт болгосон байна. Үүнийг анхан шатны шүүх хуралдааны хэлэлцүүлэгт Г.Т залруулахдаа «Би 2009 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр ажлаа өгч өөр ажил хийсэн тул тухайн сонгон шалгаруулалтын ажлын хэсэгт орж чадаагүй» гэж хэсэн. Гэрч О.Э-ын мэдүүлгийг мөн л яллах нотлох баримт гэж үзсэн. Гэтэл О.Э нь сонгон шалгаруулалт хэрхэн явагддаг талаарх журмыг тайлбарлан яриад «сонгон шалгаруулах хурал дээр 100 хувийн саналтайгаар “Тг” ХХК-ын төслийг дэмжсэн.

Харин тухайн үед Үнэлгээний хороог Д.А даргалаагүй зөвхөн сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар ажиллаж байсан» гэдэг. Тухайн үед Үнэлгээний хороог Л.Сүх гэх хүн даргалаж байсан. Гэрч Л.Сүх «2013 оны 11 дүгээр сарын сүүлээр газрын тосны газарт ажилладаг А.Тү нь илтгэх хуудасд нөхөж гарын үсэг зуруулах гэхэд би татгалзсан гэж хэлсэн» гэснийг мөн яллах талын нотлох баримт болгосон байна. Шинжээч С.Т нь мэргэжил, туршлагын хувьд дутмаг, Х.А-ыг ямар нэг юм олж буруутгах зорилготой байсан нь сонгон шалгаруулалтын оролцогч компаниудын Засгийн газарт өгсөн саналуудыг харьцуулан үзэлгүйгээр зөвхөн сонгон шалгаруулах зөвлөлийн хуралд эсрэг саналтай оролцсон М.А, Б нарын хэлсэн үгэнд тулгуурлан, нэг ч тоо баримтыг нэмж хасаж үзэлгүй дүгнэлт гаргасан байдлаас харагдана. Ийм учраас шинжээч гэх С.Т-ын дүгнэлт нь нотолгооны чанаргүй юм. Х.А-ыг газрын тосны хайгуулын тусгай зөвшөөрлийн тендерт шалгарахын тулд Д.А-д байр өгсөн гэж байгаа боловч Х.А-ын "Тг" ХХК-д ямар ч газрын тосны хайгуулын тендерт шалгарч тусгай зөвшөөрөл огт аваагүй. Зөвхөн «... гэрээнд үзэглэхийг Д.А-д даалгасугай» гэсэн тушаал байгаа. Энэ сонгон шалгаруулалтын хариу Засгийн газрын хурлаар ороод, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр асуудал хэлэцэгдэж байж зөвшөөрлийг авах байсан. Гэтэл эдгээр ажиллагаанууд огт хийгдээгүй. Зоригт гэх хүн «танайд энэ талбайг өгөхгүй» гэж хэлээд л болсон гэж Х.А хэлдэг. Иймд Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 сарын 12-ны 751 тоот шийтгэх тогтоолын Х.А-т холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дугаар зүйлийн 269.1-д заасан гэмт хэрэгт гэм буруутайд тооцон 3 жилийн хорих ял оноосон 4, 6, 10 дахь заалтуудыг хүчингүй болгож түүнийг цагаатгаж өгнө үү гэв.

Ялтан Х.А-ын өмгөөлөгч Х.Базаррагчаа тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Шинжээчийн дүгнэлт үндэслэл бүхий болоогүй. Шинжилгээний объект байхгүй бол шинжээч шинжилгээ хийхээс татгалзах ёстой байтал шинжээч С.Т дүгнэлт гаргасан. Тухайн дүгнэлтэд 3 тэрбум төгрөг гэдэг нь баттай тоо биш ойролцоогоор гаргасан дүн гэдгийг хүлээн зөвшөөрсөн. Прокурорын эсэргүүцэлд дурдагдсан гэрч нар нь татвар төлөгч нар байхад татвар төлөгч нараар нь гэрчлүүлж татвар суутгагчийг яллаж байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт «нуусан» гэх идэвхтэй үйлдэлийг шаарддаг. Шүүх Х.А-ыг өөрийн гэм бурууг хүлээгээгүй байгааг түүний хувийн байдалтай холбож Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлд заасан ялын дээд хэмжээг өгсөн. Гэтэл хувийн байдал гэдэг нь түүний эрүүл мэнд, ар гэрийн байдал юм. Тиймээс Х.А-ын эрүүл мэндийн байдлыг харгалзан үзэж эмчилгээ хийлгэх боломжоор хангаж өгнө үү. Х.А-тай энэ хэрэгт холбогдсоноос болж 50 орчим залуус ажилгүй болсон тул үнэхээр гэм буруутайд тооцох бол түүнд оногдуулсан ялыг хуульд заасны дагуу хөнгөрүүлж өгнө үү гэв.

Цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч Л.Ононбаяр давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 дугаартай шийтгэх тогтоолын зарим зүйл заалтыг эс зөвшөөрч, дараах үндэслэлээр давж заалдах гомдол гаргаж байна. Үүнд:

Анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолын 10 дахь заалтыг «нотлох баримтыг дутуу үнэлэн, бусдын өмчлөх эрхэд ноцтойгоор халдсан» гэж үзэж байна.

Учир нь, Ц.Ч шийтгэх тогтоолын 10-т заасан орон сууцыг худалдан авахад зориулж 100.000 ам доллар зарцуулсан болох нь түүний болон хэргийн бусад оролцогчдын мэдүүлэг, хавтаст хэрэгт авагдсан төлбөр төлсөн баримтаар нотлогдож байхад анхан шатны шүүх энэ асуудалд ямар ч хууль зүйн дүгнэлт өгөлгүй, орон сууцыг хурааж улсын орлого болгохоор шийдвэрлэсэн нь хууль бус болжээ.

Ц.Ч нь уг орон сууцыг худалдан авахад зориулж 100.000 ам.доллар зарцуулсан нь нотлогдож байгаа тул уг мөнгийг буцаан олгох, эсхүл орон сууцыг буцаан олгох замаар миний үйлчлүүлэгч Ц.Ч-ийг хохиролгүй болгож өгнө үү гэв.

Цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч М.Баяраа тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Сонгон шалгаруулах үйл ажиллагаанд "Тг" ХХК холбогддог. Гэтэл Ц.Ч нь тухайн сонгон шалгаруулалтад огт хамааралгүй "Те Х" ХХК-д ажиллаж байсан тул тухайн тендерийн үйл ажиллагаанд огт хамааралгүй хүн юм. Д.А-тай хамаатан тул худалдан авсан байрандаа түр амьдруулсныг хээл хахуульд өгсөн байрыг өөрийн нэр дээр шилжүүлж гэмт хэрэгт оролцсон гэж

үзэж байгаа нь огт үндэслэлгүй юм. Сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа, шийдвэрийг хэн буруу явагдсан тухай асуудал нь захиргааны журмаар шийдэгдэх маргаан гэж үзэж байна гэв.

Талийгаач Д.А-ны өмгөөлөгч Р.Пүрэвлхам давж заалдах гомдол болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 6-р сарын 12-ны өдрийн 751 тоот шийтгэх тогтоол нь хууль ёсны ба үндэслэлтэй байх шаардлагыг хангаагүй бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн болно.

Нэг. Д.А-ны өмгөөлөгч Р.Пүрэвлхам хавтаст хэрэгт яллагдагчаар татах тогтоол хэрэгт байхгүй байгаа нь түүнийг яллагдагчаар татаагүй гэж үзнэ гэж маргасан бөгөөд хэргийг шүүх хүлээн авахад Д.А-ны яллагдагчаар татах тогтоол хэрэгт авагдаагүй алдаа зөрчил байсан хэдий ч түүнийг яллагдагчаар татсаны дагуу яллагдагчаар байцаахад ял сонссон талаараа мэдэж байсан нь нотлогддог, Д.А-ыг яллагдагчаар татаж тогтоол үйлдэж байсан талаарх өмгөөлөгч Б.Баясгалан, Г.Оюунцэцэг нараас шүүхэд гаргасан тодорхойлолт, мөн Д.А-д ял өөрчлөн сонсгож, өмгөөлөгч Р.Пүрэвлхамын хамтаар гарын үсгийг нь зуруулан авсан баримт хэрэгт авагдсан байх тул хэргийг шүүхээр шийдвэрлэх боломжтой гэж үзсэн болно.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 8 дугаар зүйлд «Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа хууль ёсны байх зарчмыг хуульчилсан байх бөгөөд 8.1-д «хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч прокурор, шүүх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина 8.2-т «эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа хэрэгжүүлж байгаа этгээд энэ хуулийн 8.1-ийг зөрчвөл түүний гаргасан шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүйд тооцож, түүнд хариуцлага хүлээлгэнэ» хэмээн заажээ.

Анхан шатны шүүх хэргийг хүлээн авахад Д.А-ны яллагдагчаар татах тогтоол хэрэгт авагдаагүй алдаа зөрчил байсан гэдгийг хүлээн зөвшөөрч дүгнэсэн бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 225 дугаар зүйлийн 225.1-д шүүхэд ирсэн хэргийн талаар шүүгч дараах шийдвэрийн аль нэгийг гаргана. 225.1.1-д яллагдагчийг шүүхэд шилжүүлнэ хэмээн заасаар байхад Эрүүгийн

байцаан шийтгэх хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д заасан энэ хуулиар тогтоосон журмын дагуу хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тогтоол үйлдэж, ял сонгосон этгээдийг яллагдагч гэнэ гэж заасныг ноцтойгоор зөрчин яллагдагчаар татаагүй этгээдийг шүүхэд шилжүүлж, хуулийн заалтыг чанд сахих зарчмыг санаатайгаар зөрчсөн.

Түүгээр ч зогсохгүй анхан шатны шүүх энэхүү хууль бус үйлдлээ мөрдөн байцаагч, прокурорын хайнга, хайхрамжгүй үйл ажиллагааны улмаас талийгаач Д.А-ны яллагдагчаар татах тогтоол хэрэгт авагдаагүй байх боловч үүнийг шүүх хуралдаан болон мөрдөн байцаалтаар дахин нөхөн гүйцэтгэх боломжгүй нөхцөл байдал бий болжээ хэмээн тайлбарласан боловч анхан шатны шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 196 дугаар зүйлийн 196.1-д заасан ...Яллагдагчаар татах тухай тогтоол үйлдэнэ, 196.2-т заасан яллагдагчаар татах тухай тогтоолд ...тогтоогдсоныг бичнэ гэсэн хуулийн заалтыг бүхэлд нь зөрчсөн нөхцөл байдлыг зөвтгүүлэх, хуулийн шаардлага хангуулахаар захирамжаар буцаах бүрэн эрх нь байсан бөгөөд шүүх хэргийг шүүхэд шилжүүлэх тухайн үед талийгаач амьд байсан нь нөхөн гүйцэтгэх боломж байсныг нотолж байна. Гэвч анхан шатны шүүх байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчиж түүнийг яллагдагчаар татсаны дагуу яллагдагчаар байцаахад ял сонссон талаараа мэдэж байсан нь нотлогддог гэж дүгнэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 27 дугаар бүлэгт яллагдагчаар татах, яллагдагчийг байцаах үндэслэлийг хуульчилан заасан, мөн 196 дугаар зүйлд яллагдагчаар татах, 199 дүгээр зүйлд яллагдагчаар татах тухай тогтоолыг сонсгох тухай тус бүрд нь зүйлчлэн заасны дагуу яллагдагчаар татсан тогтоол зайлшгүй үйлдэгдсэн байхыг хуульчилсан байна. Д.А-ыг яллагдагчаар татаж тогтоол үйлдэж байсан Хэргийн 6 дугаар хавтасны 155 дугаар талд яллагдагчид сонгосон ялыг өөрчлөх тогтоол авагдсан бөгөөд уг тогтоолыг миний үйлчлүүлэгч агсан Д.А-д танилцуулж тайлбарласан гэдэгт эргэлзээтэй баримт авагдсан нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 36 дугаар зүйлд заасан эрхийг Х.А-т танилцуулснаас харагддаг болон тогтоох хэсэгт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2-т заасныг хэвээр үлдээж, нэмж Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн

35.3-т заасныг журамлан ял сонсгосугай гэсэн хэдий ч Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлээр ял сонсгосон тогтоол хэрэгт огт авагдаагүй болох нь нотлогдсон байхад анхан шатны шүүх мөн Д.А-д ял өөрчлөн сонсож өмгөөлөгч Р.Пүрэвлхамын хамтаар гарын үсгийг нь зуруулан авсан баримт хэрэгт авагдсан байх тул хэргийг шүүхээр шийдвэрлэх боломжтой гэж үзсэн болно хэмээн илт хууль зөрчсөн дүгнэлтийг гаргаснаас гадна ял өөрчлөн сонсгосон тогтоолд өмгөөлөгч миний бие огт гарын үсэг зураагүй, харин хэргийн материалтай танилцаагүй байсан. 2014 оны 03 дугаар сарын 24-ний өдөр яллагдагчаар байцаасан тэмдэглэлд гарын үсэг зурсан нь яллагдагчаар татсан тогтоолтой гэж үзэж шийдвэр гаргах шалтаг, шалтгаан болохгүй бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 284 дүгээр зүйлийн 284.2-т заасан «хуулийн бүх шаардлагад нийцүүлэн, хуульд үндэслэн гаргасан тогтоолыг хууль ёсны гэж үзнэ» гэснийг ноцтой зөрчсөн хууль ёсны шаардлагыг хангаагүй тогтоол гэж үзэж маш их гомдолтой байна.

Хоёр. Д.А нь Газрын тосны газрын даргаар ажиллаж байхдаа Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан, газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны дарга, Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар тус тус ажиллахдаа тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Х.А-ын 494.000.000 төгрөгийн үнэ бүхий ХУД-ийн ...-р хороо, "Р.Г.В", Зайсан тойруу ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг төрсөн ах Д.Ц-ы хүү Ц.Ч-ийн нэр дээр 2009 оны 12-р сарын 2-ны өдөр шилжүүлэн онц их хэмжээний хээл хахууль авсан болох нь дээрх нотлох баримтуудаар хангалттай нотлогдон тогтоогдож байх тул Х.А-ыг албан тушаалтанд бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн, Д.А-ыг онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Х.А-т ял шийтгэл оногдуулах хууль зүйн үндэслэлтэй гэж шүүхээс дүгнэв.

Анхан шатны шүүх Д.А агсныг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны даргаар ажилласан хэмээн хэрэгт авагдсан баримтаар нотлогдоогүй үндэслэл гаргаж Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2-т заасан гэмт хэрэгт

гэм буруутайд тооцсон нь илт хууль бус, цагаатгах нотлох баримтыг санаатайгаар үнэлээгүй, нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд бодит байдлаар нь хянаж үзэлгүй таамаглалд үндэслэн шийдвэр гаргасанд маш их гомдолтой байна. 1 дүгээр хавтасны 185-р талд Сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайд Д.З-ын 2009 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 79 дүгээр тушаалд авагдсан байгаагаасаа гадна шүүхийн хэлэлцүүлэгт гэрч О.Э Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар ажилласан талийгаач Д.А Үнэлгээний хорооны даргаар ажиллаагүй, харин Үнэлгээний хорооны даргаар Л.Сүх гэх газрын тосны асуудал эрхэлсэн албан тушаалтан ажилласан болохыг гэрчлэн мэдүүлсэн байна. 2 дугаар хавтасны 115-117 дугаар талд гэрч Ч.Н «... ажлын хэсэгт орж ажиллахдаа «Тг» ХХК-ийн ирүүлсэн захиалгын бүрдэл хэсгийг хариуцан нэмж ирүүлсэн материалыг хавсаргаж дараагийн Үнэлгээний хороонд хүлээлгэн өгөхөд бэлэн болгон хүлээлгэн өгөх ажлыг хариуцан ажиллаж байсан...» «...материалууд нь хангалттай, бүх баримт бичгүүдийг хууль дүрэм, журмын дагуу бүрдүүлэн өгсөн...» гэж мэдүүлсэн, 118 дугаар талд гэрч Л.А «...миний хариуцсан чиглэлийн хүрээнд боломжтой гэж үзсэн...» гэсэн мэдүүлгээс харахад ажлын хэсэг дүрэм, журмын дагуу ажилласан болох нь нотлогддог. Үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан гэрч Ш.Ц, Л.Сүх, Д.А Э.Т, С.Н нараас хууль сануулан мэдүүлэг авсан ч эдгээр гэрчүүдийн нэгнээс нь ч Үнэлгээний хорооны даргаар хэн ажиллаж байсныг огт асуугаагүй, харин бүгдээс нь «Тг» ХХК-ийг шалгаруулах, уг компанийн асуудлыг нааштай шийдүүлэх талаар хэн нэг нь хүсэлт гаргах, гуйх, шаардах, айлган сүрдүүлэх зэрэг асуудал гарч байсан уу хэмээн асууж тийм асуудал байгаагүй гэх хариултыг авч байжээ.

Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 33 дугаар тушаалын хавсралт 1-ээр батлагдсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 7.1-д Үнэлгээний хороог тухай бүр Ашигт малтмалын газрын тосны газрын даргын тушаалаар томилно. 7.2-т Үнэлгээний хороог Ашигт малтмалын газрын тосны газрын асуудал эрхэлсэн албан тушаалтан, мэргэжилтнүүдийн бүрэлдхүүнтэйгээр байгуулна. 2 дугаар хавтасны 104-107-р

талд гэрч С.Са мэдүүлэхдээ «...Үнэлгээний хорооны ажиллах зохион байгуулалтыг хийх талаар хуучнаар Ашигт малтмалын газрын тосны газрын Газрын тос хариуцсан дарга Л.Сүх томилсон...» гэснээс харахад Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажиллаж байсан түүний хувьд Үнэлгээний хорооны даргаар талийгаач Д.А-ыг ажиллаагүй болохыг хангалттай нотолсон гэж өмгөөлөгчийн зүгээс үзэж байна.

Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 33 дугаар тушаалын хавсралт 1-ээр батлагдсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын Эрдэс баялаг, эрчим хүчний яамны сайд Д.З нь бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 7 дугаар зүйлийн 3 дахь «үйлдвэр худалдааны сайдын тушаалаар Ашигт малтмалын газрын тосны газрын саналыг харгалзан тухай бүр томилно» сонгон шалгаруулах зөвлөл нь орон тооны бус байх бөгөөд Ашигт малтмалын газрын тосны газар, Үйлдвэр худалдааны яам болон Сангийн яамны газрын тосны асуудал хариуцсан албан хаагчдаас бүрдүүлж болно» гэсэн заалтыг үндэслэн 2009 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 79 дүгээр тушаал гаргасан байх бөгөөд 74-т ...сонгон шалгаруулах журмыг Ашигт малтмалын газрын тосны газрын дарга, эсхүл Ашигт малтмалын газрын тосны газрын тосны асуудал хариуцсан орлогч дарга тэргүүлнэ. 7.5-д Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаас бусад гишүүнийг Үнэлгээний хорооны гишүүнээр томилж болох... гэснээс харахад сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг томилж байгаа сайд Үнэлгээний хорооны бүрэлдэхүүн, дарга хэн байсныг хянаж, Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 33 дугаар тушаалын хавсралт 1-ээр батлагдсан журмаа хэрэгжүүлэх эрхийнхээ дагуу сонгон шалгаруулах зөвлөлийг сонгосон гэж үзэж байна. Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 33 дугаар тушаалын хавсралт 1-ээр батлагдсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 7.7-д зааснаар сонгон шалгаруулах зөвлөл нь Үнэлгээний хорооны ирүүлсэн санал дүгнэлтийг зөвлөлийн хуралдаанаараа хэлэлцэж илээр санал хурааж, гишүүдийн олонхийн саналаар гэрээ байгуулах эрх бүхий этгээдийг сонгож зөвлөмж гаргана, мөн 11.4-т хурлын шийдвэр, түүний үндэслэлийн талаар тэмдэглэл хөтөлж, протокол

үйлдэх ба сонгон шалгаруулах зөвлөлийн зөвлөмжид хуралдаанд оролцсон бүх гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна гэжээ. Хавтаст хэргийн 1 дүгээр хавтасны 191-р талд 2009 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 1 тоот Сонгон шалгаруулах зөвлөлийн зөвлөмж, 193-198-р талд бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэл №1 гэсэн сонгон шалгаруулалтын зөвлөлийн гишүүд болох Н.Б, Д.А, О.Э, П.Х, Л.Р, Г.Э, М.А, нарийн бичгийн дарга А.Тү нар оролцон нийт гишүүдийн 100 хувийн саналаар дэмжсэн баримт авагдсан байна. Тодруулбал сонгон шалгаруулалтын зөвлөлийн даргаар ажилласан талийгаач Д.А-ны хувьд дан ганцаар шийдвэр гаргах эрх бүхий этгээд бус бөгөөд сонгон шалгаруулалтын зөвлөлийн бусад гишүүд нь таслах эрхтэй оролцдог тул илээр хураасан саналаа дэмжсэн гишүүдийн санал хүчин төгөлдөр бус эсэх асуудлаар эрх бүхий байгууллагын дүгнэлт гараагүй байхад хамтын саналаар гаргадаг шийдвэрийг талийгаач Д.А-ыг дангаар гаргасан мэтээр хэт өрөөсгөл дүгнэлтийг гаргаж, гэм буруутайд тооцсоныг эс зөвшөөрч байна.

Анхан шатны шүүх хавтаст хэрэгт авагдсан албажаагүй баримт гэх мөрдөн байцаагч, прокурорын зүгээс нотлох баримтын шаардлага хангахгүй болохыг үнэлэн дүгнэсэн баримтад тулгуурлан талийгаач Д.А, Х.А нарыг найз байсан, Ц.Ч дүү нь байсан юм чинь авлига л байж таараа гэсэн хийсвэр дүгнэлтийг хийж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 290 дүгээр зүйлийн 290.2 дахь заалтыг зөрчин таамаглалд үндэслэн шийдвэр гаргасан. Харин хавтаст хэрэгт авагдсан Ц.Ч, Х.А, Н.О нарын мэдүүлэг нь Н.О-ын 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр 50.000 ам долларыг Ц.Ч-иас хүлээн аваад захирал Х.А-аас бэлнээр авсан 30.000 ам долларын хамт «Тг» ХХК-ийн дансанд тушаасан болох нь 2 дугаар хавтасны 189 дүгээр талд авагдсан гэрч Н.Ц-гийн мэдүүлэг, 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Х.А-аас Н.О-д олгосон Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо "Г.В" хотхонд байрлах 160 м2 орон сууцыг захиран зарцуулах эрх олгосон итгэмжлэл зэргээс нотлогдож байгаа нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 82 дугаар зүйлийн 82.2-т заасан үндэслэл болж байгааг шүүх үнэлсэнгүй.

Шийтгэх тогтоолд шинжээч С.Т-гын 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн шинжээчийн «...Зөвлөлийн зарим

гишүүд Бүгд найрамдах польш улсын «РСМС» компанийг дэмжих хүсэлтэй байсан боловч үнэлгээний оноо хэтэрхий доогуур байсан байна. Мөн зөвлөлийн гишүүн М.А нь «Тг» ХХК нь санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй, санхүүгийн тайланг зөрүүтэй гаргасан, санхүүгийн баримт бусад материалыг бүрэн хэмжээнд компаниас гаргуулж аваагүй, ажлын хэсэг муу ажилласан гэсэн санал хэлсэн байна. Түүнчлэн Зөвлөлийн гишүүн Н.Б нь «Тг» ХХК-ийг газрын тосны хайгуулын 2 талбайд зэрэг хөрөнгө оруулж чадах эсэхэд эргэлзэж байна. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 11 дүгээр зүйлийн 11.2-т «сонгон шалгаруулах журам нь энэ журмын дагуу хянаж зөрчил илрүүлсэн тохиолдолд гэрээлэгч сонгох ажиллагааг зогсоож, энэ журмын дагуу тухайн үйл ажиллагаа, эсхүл үнэлгээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дахин хийлгэх» гэж заасан байтал Зөвлөлийн гишүүдийн дээр дурдсан саналыг үндэслэн зохих арга хэмжээ авалгүйгээр «Тг» ХХК-ийн захиалгыг дэмжсэн байна. Иймд тус сонгон шалгаруулах зөвлөл нь журмын дагуу ажилласан эсэх нь эргэлзээтэй байна...» гэх дүгнэлтийг үндэслэн миний үйлчлүүлэгч агсныг гэм буруутайд тооцсон. Гэтэл 1 дүгээр хавтасны 238-р талд авагдсан «Тг» ХХК-ийн санхүүгийн талаар танилцуулгад ...»УСА» ХХК-ийн санхүүгийн тайлан шалгасан аудитийн дүгнэлт 2008 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар гаргаж санхүүгийн тайлангын олон улсын стандартын дагуу санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээ үнэн зөв илэрхийлэгдсэн байна хэмээн дүгнэжээ. Энэ нь сонгон шалгаруулах зөвлөлийн хуралдааны үед санхүүгийн баримт бүрэн хэмжээнд байсан болон аудит хийлгэсэн хугацаа хүчинтэй байсныг харуулж байна. Тиймээс энэхүү баримтыг байсныг харж дүгнэсний улмаас гишүүн М.А саналаа «Тг»-д өгснөөр батлагдаж байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журамын 8.3-т заасан сонгон шалгаруулалтад хамруулсан захиалгыг үнэлгээний үзүүлэлтийн ач холбогдлоор нь үндсэн үзүүлэлт /1/, туслах үзүүлэлт /2/, дэд үзүүлэлт /3/ гэсэн 3 үзүүлэлтээр үнэлнэ. Шинжээч С.Т болон сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн М. М.А, Н.Б нарын хэлж буй саналууд бүгд «Сонгон шалгаруулах үнэлгээний туслах үзүүлэлтэд» орно. Тус

журмын 9.1-т шаардлагад нийцсэн захиалга гэж Газрын тосны тухай хуулийг хэрэгжүүлэх журмын 8 дугаар зүйлийн 3-т заасны дагуу бүрдүүлсэн, хэлэлцээний явцад Ашигт малтмалын газрын тосны хэрэг эрхлэх газраас санал болгосон Бүтээгдэхүүн хуваах гэрээний гол нөхцөлийг хүлээж авч болохуйц хэмжээнд захиалагч тал хүлээн зөвшөөрч Монгол Улсын талд ашигтай санал өгсөн, Үнэлгээний хорооны дүгнэлтээр хамгийн дээд оноо авсан захиалгыг хэлнэ гэжээ. Сонгон шалгаруулах зөвлөлийн дээрх гишүүдийн тавьсан санал нь үндсэн үзүүлэлтийг хөндөөгүй, Ашигт малтмалын газрын тосны хэрэг эрхлэх газраас санал болгосон Бүтээгдэхүүн хуваах гэрээний гол нөхцөлийг хүлээж авч болохуйц хэмжээнд захиалагч тал хүлээн зөвшөөрч Монгол Улсын талд ашигтай саналд нөлөөлөхгүй тул өөрсдөө ч үүнийгээ хүлээн зөвшөөрч, эцсийн ил санал хураалтаар «Тг» ХХК-т саналаа өгсөн байдаг.

Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журамд ямар зүйлийг зөрчил гэж үзэх талаар тодорхойлоогүй байна. Тус журмын 12.1-т сонгон шалгаруулалтыг зохион байгуулагч болон оролцогч журмыг зөрчсөн гэж үзвэл Ашигт малтмалын газрын тосны хэрэг эрхлэх газарт бичгээр гомдол гаргаж болох ба энэхүү зөрчлийн талаар нотлох баримтыг хавсаргана гэжээ. Гэтэл сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд болон оролцогч талуудаас зөрчил гаргасан талаар ямар нэгэн гомдол мэдүүлээгүй, нотлох баримтыг протокол болон зөвлөмжинд хавсаргаагүй байгаа нь сонгон шалгаруулах зөвлөл журмын дагуу ажилласныг харуулж байна. Өөрөөр хэлбэл, шинжээч С.Т-гын журмын дагуу ажиллаагүй гэх дүгнэлт нь өөрөө яг ямар зөрчил байсан болон гишүүдээс ямар зөрчлийг арилгаагүй талаар огт дүгнээгүй. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 46 дугаар зүйлийн 46.1-д «...тусгай мэдлэг бүхий, тухайн хэрэгт хувийн сонирхолгүй этгээдийг томилно.» гэж заасан байх бөгөөд шинжээч С.Т тусгай мэдлэг бүхий этгээд гэхэд эргэлзээтэй байхад шүүх дүгнэлтийг үнэлсэн. Мөн түүнчлэн сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдээс хууль сануулан мэдүүлэг авахад тэдгээр гэрчүүд бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу «Тг» ХХК-ийг сонгосон болохоо мэдүүлсэн байгаа бөгөөд сонгон шалгаруулах журамд ажилласан гэрчээр тогтоогдсон Н.Б, Д.А,

О.Э, П.Х, Л.Р, Г.Э, М.А нарт хариуцлага тооцон шалгаагүй нь хамтаар гаргасан шийдвэр хууль бус гэх үндэслэлгүй байна. Хавтаст хэрэгт ажлын хэсэг, Үнэлгээний хороонд ажилласан гэрчүүдэд холбогдуулан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан хэмээн эрүүгийн хэрэг үүсгэн шалгаагүй, сэжигтнээр тооцон мэдүүлэг аваагүй, сэжигтнээр тооцсон тогтоол ч үйлдээгүй атлаа «Зарим сэжигтэн, яллагдагчид холбогдох үйлдлийг хэрэгсэхгүй болгох тухай санал хүргүүлэх тогтоол»-ийг мөрдөн байцаагчийн зүгээс гаргаж Нийслэлийн Прокурорын газар «Прокурорын Тогтоол» гаргасан нь 15 дугаар хавтасны 163, 164, 222 дугаар талд авагдсан байгаа нь илт хууль зөрчсөн үйлдэл гэж үзэхээр байна.

Гурав. Ц.Ч-ийн мөрдөн байцаалтад сэжигтнээр болон яллагдагчаар «...Анхны 50.000 ам долларыг хадам ээжийн дүү Ч.О-аас зээлсэн. Х.А-т өгсөн...» гэсэн мэдүүлэг /6-р хх-ийн 223, 231/ өгсний дагуу мөрдөн байцаагч, гэрч Ч.О-аас Ц.Ч-ийн мэдүүлэгтэй холбогдуулан мэдүүлэг авах гэсэн боловч гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээ эдлэн мэдүүлэг /2-р хх-ийн 163-164/ өгөхөөс татгалзсан, Д.А, Ц.Ч нараас мөрдөн байцаалтад сэжигтнээр болон яллагдагчаар «... Энэ байрыг түрээсэлж байгаа, энэ талаар /Д.А-ы эхнэр/ Д.Н мэдэж байгаа...» гэсэн мэдүүлэг /6-р хх-ийн 148-149, 152, 223, 232/ өгсний дагуу Д.А-ны эхнэр Д.Н-гаас мэдүүлэг авахад мөн л гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээ эдлэн татгалзсан байгаа нь шүүгдэгч нарын тайлбарлаж байгаа тухайн орон сууцны үнэнд төлсөн төлбөр, мөн байрыг түрээслэн сууж байсныг үгүйсгэх нөхцөл байдал болсон гэж үзэхээр байна. «Гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрх» нь аливаа хэрэг, зүйлийг үгүйсгэх нөхцөл байдал болох үндэслэлгүй бөгөөд уг байрыг Ц.Ч худалдан авсан болох нь түүний бэлэглэлийн гэрээний дагуу орон сууцыг өөрийн өмчлөлд бүртгүүлэхдээ 50.000 ам долларыг бэлнээр төлсөн болох нь хэрэгт авагдсан баримтаар хангалттай нотлогдож байна.

Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 6-р сарын 12-ны өдрийн 751 тоот шийтгэх тогтоолыг хүчингүй болгож «Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т хуульчилсан «...шударга шүүхээр шүүлгэх, шүүх ажиллагаанд биеэр оролцох...» гэм буруутай нь хуулийн дагуу

шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно...» гэсэн үндсэн эрхийг нь ноцтойгоор зөрчиж байгааг харгалзан миний үйлчлүүлэгчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж өгнө үү гэв.

Хохирогч, иргэний нэхэмжлэгч Монгол Улсын Сангийн Яамны төрийн нарийн бичгийн дарга Х.Г гаргасан давж заалдах гомдолдоо: Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхээс шинжээчийн 2014 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 1 дугаартай дүгнэлтээр шүүгдэгч Х.А-ын эзэмшлийн «Тг» бүлэг компани нь нийт төгрөгийн албан татварыг нуун дарагдуулсан бөгөөд шинжээчийн дүгнэлтээр жагсаасан тодорхой лиценз, тусгай зөвшөөрлийг бусдад шилжүүлэхдээ халхавч гэрээ байгуулсан нь тогтоогдоод байна. Гэвч анхан шатны шүүхээс мэргэжлийн шинжээчийн дүгнэлтийг бүхэлд нь нотолгооны баримт гэж үнэлээгүй, түүнд огт үндэслээгүй, шинжээчийн дүгнэлтээр тогтоогдсон үйлдлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож байгааг хүлээн зөвшөөрөх боломжгүй бөгөөд анхан шатны шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 дүгээр шийтгэх тогтоол хууль зүйн хувьд учир дутагдалтай гэж үзэж байна. Иймд шинжээчийн дүгнэлтийг хууль ёсны гэж үзэж, уг дүгнэлтээр тогтоогдсон татварын 3,691,107,000 төгрөгийг улсад олгож өгнө үү гэжээ.

Улсын яллагч О.Сарангэрэл гаргасан эсэргүүцэл болон тус шүүх хуралдаанд гаргасан тайлбартаа: Х.А нь Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 7, 8, 16, 17, 21 дүгээр зүйлүүдэд заасан заалтуудыг зөрчин 2007-2011 онд нийт 3.691.107.000 төгрөгөөр хайгуулын болон ашиглалтын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан авч Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлогын албан татвар болох 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөлгүй онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн үйлдэлдээ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар,

Мөн 2008 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн Үйлдвэр худалдааны сайд Х.Н-гийн 196 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүн хуваах чиглэлээр Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Олон улсын нээлттэй тендер зарлаж, уг тендерд «Тг»

ХХК-ийг шалгаруулсны төлөө «Тг» ХХК-ийн ерөнхий менежер Н.О-д итгэмжлэл хийж өгч Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлэн хээл хахуульд өгсөн үйлдэлдээ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар,

Д.А нь Сонгинохайрхан дүүргийн нутаг дэвсгэр, Газрын тосны газрын даргаар ажиллаж байхдаа Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан, газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны дарга, сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар тус тус ажиллахдаа тендер «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Х.А-ын 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг төрсөн ах Д.Ц-ийн хүү Ц.Ч-ийн нэр дээр 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр шилжүүлэн авч, бусдаас онц их хэмжээний хээл хахууль авсан үйлдэлдээ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар,

Н.О нь Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудын сонгон шалгаруулалтад «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д Х.А-ын эзэмшлийн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлж, хээл хахууль өгөх гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлэн хамжигчаар оролцсон үйлдэлдээ Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр ангийн 269.1 дэх хэсэгт зааснаар,

Ц.Ч нь «Тг» ХХК-ийн захирал Х.А-аас Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д «Тг» ХХК-ийг тендер шалгаруулсны төлөө өгсөн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай

орон сууц, 2 автомашины зогсоолыг өөрийн нэр дээр шилжүүлэн авч, онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг нуун далдалж гэмт хэрэгт хамжигчаар оролцсон гэмт үйлдэлдээ Монгол Улсын Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан мөн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллагдах үндэслэлтэй гэж дүгнэн, хэргийг шүүхэд шилжүүлсэн.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүх 2014 оны 06 дугаар сарын 11, 12-ны өдрүүдэд Х.А, Д.А, Н.О, Ц.Ч нарт холбогдох хэргийг шүүх Шийтгэх тогтоолын 1 дэх заалтад:

“Нийслэлийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Н.О-д холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр,

Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар Ц.Ч-д холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгож, Н.О, Ц.Ч нарыг цагаатгасугай» гэжээ.

Шүүх «Н.О-ыг тухайн үед Х.А захирлаас үүрэг өгсний дагуу итгэмжлэлийн үндсэн дээр байрыг Ц.Ч-д шилжүүлсэн нь хангалттай нотлогддог тул Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-т зааснаар хээл хахууль өгөх гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлэн хамжигчаар оролцсон болох нь тогтоогдохгүй Өөрөөр хэлбэл, гэмт хэргийн бүрэлдэхүүний сэдэлт, санаа зорилго / субъектив тал/ нь бүрэн үгүйсгэгдэж байна»... гэж дүгнэсэн нь дараах нотлох баримтуудаар үгүйсгэгдэж байна. Үүнд:

Н.О гэрчээр өгсөн мэдүүлэгтээ «... Газрын тосны газраас 2009 онд газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 гэсэн 2 талбай дээр нээлттэй тендер зарласан. Энэ

тендерт техникийн материал бүрдүүлж өгч оролцоод ялсан. Гол шалгуур үзүүлэлт нь «танай компани мэргэжлийн боловсон хүчин, мөн энэ геологи судалгааны ажлын зардлыг гаргах хөрөнгийн эх үүсвэртэй юу, хэрвээ энэ газрын тосны хайгуул хийх хөрөнгө санхүү байхгүй бол танай ажлыг санхүүжүүлээд явах гадны хөрөнгө оруулагч компани байгаа юу» гэсэн шалгуур үзүүлэлтийг тавьж байсан» гэж,

Гэрч Г.Т «...Хуучнаар Ашигт малтмал газрын тосны газраас зарлагдсан Олон улсын нээлттэй тендерийн захиалгын материал хүлээн авах Эргэл-12 хайгуулын талбайд «Т» ХХК захиалгын материал ирүүлсэн байсан. Хэлэлцээрийн явцад тухайн компаниас бүрдүүлж ирүүлсэн материал нь шаардлага хангахгүй байсныг ажлын хэсгээс мэдэгдэж, ирүүлсэн материалыг буцааж байсан. Тухайн үед энэ ажлын хэсэгт ажлын хэсгийн даргаар ажиллаж байхад «Т» ХХК-ийн хувьд Эргэл-12 талбайд хайгуулын ажлын туслан гүйцэтгэгчээр ажиллах гадны компаниудтай санамж бичиг, гэрээ байгуулаагүй, ирүүлсэн санамж бичиг нь баталгаажуулаагүй, хуулбар хувь ирүүлсэн байсан. Мөн санхүүгийн чадварыг нотлох баримт бичгүүд нь тухайн компанийн санхүүгийн чадварыг тодорхойлох боломжгүй, хангалтгүй байсан. Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байсан тул ажлын хэсгээс материалыг буцааж байсан. Энэ талбайтай холбоотой захиалгын материалыг хэлэлцэхдээ ажлын хэсэг 2 удаа уулзалт хийгээд дутуу материалаа бүрдүүлэхийг шаардаж байсан. «Т» ХХК-ийн зүгээс дутуу материалаа бүрдүүлж өгөөгүй, захиалгын материалыг буцаан өгч цаашид оролцох боломжгүй талаар 2008 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хэлэлцээрээр манай геологи, хайгуулын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.А, нарийн бичгийн даргаар Гэрээлэлтийн хэлтсийн мэргэжилтэн З.Б бид гурав «Тг» ХХК-ийн зүгээс ерөнхий захирал Х.А, ерөнхий менежер Н.О нараас шаардаж байсан. Дараа нь манай байгууллагаас Нэмэгт-6, Шарга-3 талбай дээр захиалга авах сүүлийн хугацаа нь 2008 оны 12 дугаар сарын 5-ны өдөр дуусгавар болох байсан. 2008 оны 10 дугаар сарын 20-ны өдөр «Тг» ХХК нь Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Олон улсын нээлттэй тендерт дахин захиалгын санал ирүүлсэн байсан. 2009 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын даргын 12

дугаар тушаалаар ажлын хэсэг 2009 оны 2 дугаар сарын 16-ны өдөр хүртэл ажиллах талаар тусган «Тг» ХХК-ийн захиалгын материал дээр ажлын хэсгийн даргаар би, гишүүдэд ахлах мэргэжилтэн Ч.Н захиалгын материалын бүрдэл хэсэг, дүрэм журмын дагуу ирүүлсэн эсэхийг нягтлах, ахлах мэргэжилтэн Л.А, геологийн талаар үнэлэлт дүгнэлт өгөх, ахлах мэргэжилтэн А.П, мэргэжилтэн Н.У нар нь тухайн компанийн санхүүгийн чадварыг нотлох талаар тус тус ажилласан. Намайг ажлын хэсэгт ажиллах хугацаанд «Тг» ХХК-ийн захиалгын материал нь Эргэл-12 хайгуулын талбайд өгсөн материалтай адилхан байсан...» гэжээ.

Дээрх мэдүүлгүүдээр Н.О нь Ашигт малтмал газрын тосны хэрэг эрхлэх газраас Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах олон улсын нээлттэй тендер зарлахад «Тг» ХХК-ийн захиалгын материалыг бүрдүүлж өгсөн, уг захиалгын материал нь журамд зааснаар шаардлага хангахгүй байгааг мэдэж байсан, улмаар Х.А нь «Тг» ХХК-ийг тендерт шалгаруулсны төлөө Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, "Р.Г.В", ...тоот орон сууц, автомашины зогсоолыг Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлэн өгөх итгэмжлэл хийж өгсөн нь хавтаст хэрэгт авагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон.

Н.О-ын «Х.А захирлын өгсөн үүргийг л биелүүлж байрыг Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлсэн» гэж мэдүүлж байгаа нь Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан яллагдагч, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэй холбоотой гэж үзэхээр байна.

Иймд Н.О-ын дээрх гэмт хэрэгт гэмт хэрэг үйлдэхэд учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлсэн гэж үзэх үндэслэлтэй.

Ц.Ч-ийн хувьд Хан-Уул дүүрэг ...дүгээр хороо, "Р.Г.В" дахь ...тоот байрыг өөрийн мөнгөөр Х.А-аас худалдаж авсан гэх боловч Х.А, Н.О нарт мөнгө хүлээлгэн өгсөн ямарваа нэгэн баримт байхгүй, Н.О-той «Бэлэглэлийн гэрээ» байгуулж байрыг шилжүүлэн авсан, нэгжлэг хийх үед уг байранд Д.А амьдарч байсан, уг байрыг худалдан авсан гэх санхүүгийн эх үүсвэр тодорхойгүй зэрэг нотлох баримтуудаар Д.А дээрх байрыг өөрийн нэр дээр авч чадахгүй байсан учир төрсөн ахын хүү Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлэн авсан нь тогтоогдсон. Дээрх байрыг Ц.Ч өөрийн нэр дээр шилжүүлэн авч

байгаа нь учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг нуун далдалж гэмт хэрэгт хамжигчаар оролцож байна гэж үзэх үндэслэлтэй.

Мөн «Тг» ХХК-ийн захирал Х.А нь өөрийн компанид ажиллаж байгаа залуу боловсон хүчнийг дэмжих, нийгмийн асуудлыг нь шийдэж өгөх зорилгоор байрыг Ц.Ч-д хөнгөлөлттэй нөхцөлтэйгээр өгсөн гэж мэдүүлдэг боловч Ц.Ч 2009 онд «Тг» ХХК-нд ажиллаж байгаагүй ба харин Хас банкинд ажиллаж байсан болох нь Хас банкны албан бичиг болон Ц.Ч-ийн мөрдөн байцаалт болон шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн мэдүүлэг зэргээр нотлогддог.

Шийтгэх тогтоолын 3 дахь заалтад:

“Нийслэлийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар Х.А-т холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгосугай” гэжээ.

Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 8 дугаар зүйлд «Албан татвар төлөгчийн үйл ажиллагааны дараахь орлогод албан татвар ногдоно.

...8.1.2 эрх борлуулсны орлого...,

...8.2. Эрх борлуулсны орлогод эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад төлбөртэй шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна ...

16 дугаар зүйлд Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох ...16.3. Дараахь орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо албан татвар ногдуулах тухайн орлого тус бүрийн нийт дүнгээр тооцно.

...16.3.5. эрх борлуулсны орлого...,

17 дугаар зүйл. Албан татварын хувь, хэмжээ ...17.2.7. эрх борлуулсны орлогод 30 хувиар...,

21 дүгээр зүйл. Албан татвар төлөх, тайлагнах

...21.5. Энэ хуулийн 17.2.1-17.2.3, 17.2.7-17.2.9-д заасан орлогод ногдох албан татварыг мөн хуулийн 4.1.6-д заасан суутгагч ногдуулан суутган авч, ажлын 7 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ...,

...4.1.6. “суутгагч” гэж албан татвар төлөгчид олгосон орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын

болон орон нутгийн төсөвт шилжүүлэх үүрэг бүхий хуулийн этгээдийг хэлнэ... гэж тус тус заасан байна.

“Тг” ХХК-ийн захирал Х.А нь 2007-2011 онд нийт 12.303.690.000 төгрөгөөр хайгуулын болон ашиглалтын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан авч, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлогын албан татвар болох 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөлгүй онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн нь дараах нотлох баримтуудаар тогтоогдож байна. Үүнд:

Гэрч Л.Д ...”ГМ» ХХК-ийг 2006 онд би өөрөө үүсгэн байгуулсан. Компанийн үйл ажиллагааны чиглэл нь худалдаа үйлчилгээний чиглэлээр үүсгэн байгуулсан, нэг гишүүнтэй компани юм. Компанийн нэр дээр Архангай аймгийн Тариат суманд байрлалтай 1193.Х хайгуулын тусгай зөвшөөрөл байсан. Архангай аймгийн Тариат суманд байрлалтай 1193.Х хайгуулын тусгай зөвшөөрлийг 2007 онд байх Х.А гэх хүн над руу утсаар яриад «уулзмаар байна» гэж уулзаад «уг тусгай зөвшөөрөл дээр хөрөнгө оруулалт хиймээр байна» гэж ярьж байсан. Тэгээд тухайн үед надад мөнгөний хэрэг болоод бага багаар мөнгө авч байсан ба сүүлдээ уг тусгай зөвшөөрлийг компанийн хамт 500.000 ам доллараар худалдан борлуулсан. Одоо миний санаж байгаагаар эрх шилжүүлэх гэрээгээр шилжүүлсэн шиг санагдаж байна. 2007 онд 500.000 ам долларыг цувуулж авч байгаад тэр ондоо багтааж авсан. Одоогоор надад ямар нэг баримт байхгүй» /2-р хавтас 165-1655-р хуудас/ гэж,

Гэрч Г.У «... “ТБ” ХХК нь манай аав н.Г-гийн компани юм. Харин «ТМТ» ХХК миний компани юм. Энэ компанийг би үүсгэн байгуулсан бөгөөд ашигт малтмалын геологийн эрэл хайгуулын ажлыг хийж гүйцэтгэдэг компани юм. «ТБ» ХХК-ийн нэр дээр байсан 1166.А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг Х.А манай аав Г-тэй хамтран ажиллах гэрээ байгуулан 100.000 ам доллароор өгсөн бөгөөд ирээдүйд уг ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайгаас олборлолт явуулаад ашиг олох юм бол ашгаа 50:50 хувиар хувааж авахаар гэрээ байгуулсан юм. Одоо уг тусгай зөвшөөрлийг Х.А-ын «Рф» ХХК-нд шилжүүлсэн байгаа»... /2 хавтас 169-170-р хуудас/ гэж, Гэрч Д.Г «...Манай аав Б.Д «Сн» ХХК-ийг үүсгэн

байгуулсан. Говь-Алтай аймгийн Цээл сум, мөн Цээл, Алтай сумдыг дамнасан ашигт малтмалын 1454.Х, 1454.Х, 1454.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын газарт 2008 онд өргөдөл өгөөд авч байсан юм. «Тг» ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.О-д өмнө би 20.000 ам долларын өртэй байсан ба тэр өрөө суутгуулаад, Гранд марк-2 машин аваад, увуулж цувуулаад 30-40 мянган ам.доллар авсан. Нэг жил дамнаад увуулж цувуулаад нийт 100 сая төгрөгөөр зарсан. 2009 онд дээрх тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлсэн. Мөнгө хүлээн авсан өгсөн баримт байхгүй. Зүгээр Н.О-той ярьж байгаад мөнгөө өгч авдаг байсан. Мөнгийг бэлнээр авдаг байсан...» /2-р хавтас 175-176-р хуудас/ гэж,

Гэрч С.А «... “ЖГ” ХХК-ийг 2006 онд байгуулсан. ...Х.А-тай 2010 оны 12 дугаар сарын эхээр өмнө нь Улсын мөрдөн байцаах газарт ажиллаж байсан Н.О-оор дамжуулан уулзаж танилцсан бөгөөд «ЖГ» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутагт байрлах 1073.А, 1073.А тоот тусгай зөвшөөрлийг «ЖГ» компанийн хувьцааг бэлэглэлийн гэрээгээр өгсөн байх. Тэгээд Х.А-т уг хоёр тусгай зөвшөөрлийг 400.000 ам доллараар зарсан...» /2-р хавтас 177-178-р хуудас/ гэж,

Гэрч Д.Цгэ «... «УТ» ХХК, «ЧХ» ХХК-ийн нэр дээр байсан ашигт малтмалын хайгуулын 3 тусгай зөвшөөрлийг 2006 онд 600.000 ам.доллараар тохирч шилжүүлсэн. Ингэхдээ 550.000 ам долларыг бэлнээр авсан. Харин үлдсэн 50.000 ам.долларыг Н.О зуучилж өгсний хөлс гэж авсан. 2008 оны 10 дугаар сарын 20-ны үед байх, би эмнэлэгт хэвтэж байсан, мөн Дорнод аймагт барилга барьж байсан бөгөөд мөнгөний хэрэг болоод Х.А-тай уулзъя гээд өмнө нь Х.А сонирхож байсан миний «Рф» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй байсан 9 ширхэг хайгуулын тусгай зөвшөөрлийг компанитай нь цуг зарахаар ярилцсан. Өмнө нь Х.А энэ компанийн тусгай зөвшөөрлийг сонирхож байсан бөгөөд гэхдээ хөрөнгө оруулалтыг нь олно, харин компанийн 30 хувийн эзэмшилтэйгээр ярилцаж байсан юм. Би тэр үед мөнгө хэрэгтэй байсан учир «Рф» ХХК-ийг бүтнээр нь 300.000 ам доллараар авчих гэж ярьсан. Х.А “тэгье” гэж зөвшөөрөөд компаниа 300.000 ам.доллараар зарсан юм...” /2-р хавтас 180-181-р хуудас/ гэж,

Гэрч Б.Уу «... “ТД” компанийн нэр дээр Өмнөговь аймгийн Номгон сумын

нутаг Ханан хонгил толгой гэх нэртэй 15130Х, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Ханан хонгил толгой-1 гэх нэртэй 15131Х, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Оюут нуруу нэртэй 1442.Х тусгай зөвшөөрлүүдийг Х.А-ын «МХ» ХХК-ийн нэр дээр байдаг Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо Бөмбөгөр худалдааны төвийн урд байрлах 5 давхар 620 м2 бүхий байраар сольсон. Мөн «ЦӨ» ХХК-ийн Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг Өвөлжөө уул гэх нэртэй 526.Х, Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг Баруун ноён уул-1 нэртэй 1378.Х, Өмнөговь аймгийн Ноён, Гурвантэс сумын нутаг Цагаан уул нэртэй 14522Х хайгуулын тусгай зөвшөөрлүүд, “А» ХХК-ийн нэр дээр Дорноговь аймгийн Мандах сумын нутаг 1552.Х, 1553.Х тусгай зөвшөөрлүүдийг Х.А-тай Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд байрлах «АП» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй 12 давхар байшингаар сольсон. Бусад тусгай зөвшөөрлүүдийг мөнгөөр нь зарсан. Мөнгө бэлнээр авч байсан. Яг хэдэн төгрөг авч байснаа санахгүй байна. Увуулж цувуулаад мөнгө авдаг байсан. Х.А-аас 2010 оны 8 дугаар сарын 27-нд Б.Уут хоорондын тооцоо гэж Голомт банкны 913100xxxx дугаар данснаас 200.000 ам доллар «ХСү» ХХК-ийн 110210xxxx дансанд, мөн өдрөө миний 420734458888xxxx дансанд 115.000 ам долларыг тус тус шилжүүлсэн нь үнэн...» /2-р хавтас 182-184-р хуудас/ гэж,

Гэрч Б.С «...2005 оноос «СГ» ХХК-ийг байгуулсан. «Тг» ХХК-нд ажилладаг Н.О-ыг өмнө нь таньдаг байсан юм. Тэгээд Н.О-оор дамжуулан 2010 оны сүүлээр Х.А-тай танилцсан ба тухайн үед «нүүрсний сонирхолтой талбай байна уу» гэж асууж байсан. 2011 оны 2 дугаар сарын 25-ны өдөр Х.А-т Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт байрлалтай хайгуулын 1292.Х, 1546.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг 1 сая ам доллараар зарсан. Мөнгийг 900.000 ам долларыг бэлнээр, 100.000 ам долларт Бенз ЖЛ-450, Ауди КУ-7 маркийн машинуудыг бодож авсан. Мөнгө хүлээн авсан баримт байгаа эсэхийг мэдэхгүй байна. Харин тусгай зөвшөөрлийг зарах «Баталгааны гэрээ» хийгдсэн. Энэ гэрээнд бүх зүйлийг тусгасан байгаа...» /2-р хавтас 185-186-р хуудас/ гэж,

Гэрч Г.Э «... “ИЭЖА” ХХК-ийг би өөрөө үүсгэн байгуулсан бөгөөд энэ компани нь уул уурхайн геологи судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан. Манай компанийн нэр дээр ашигт малтмалын хайгуулын тусгай

зөвшөөрлүүд байсан юм. «ЭЭЭ» ХХК-ийн нэр дээр ашигт малтмалын хайгуулын 1331.Х, 1331.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг болохоор тус компанийн захирал Б нь «жилийн төлбөр төлж чадахгүй байна», мөн «сунгалтыг нь хийж чадахгүй байна» гэхээр нь «ИЭЖА» ХХК-ийн нэр дээр ашигт малтмалын 1439.Х, 1439.Х дугаар тусгай зөвшөөрлүүдийг нийлүүлж байгаад Н.О-той ярьж тохиролцоод, одоо миний санаж байгаагаар «НБА» ХХК-нд шилжүүлсэн шиг санагдаж байна. Дээрх ашигт малтмалын хайгуулын 4 тусгай зөвшөөрлийг 50.000.000 төгрөгөөр зарсан. Гэхдээ «ЭЭЭ» ХХК-ийн захирал Б-д 10.000.000 төгрөг өгсөн. Би өөрөө 20.000.000 төгрөгийг нь авсан. Үлдсэн 20.000.000 төгрөгийг тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөр, тусгай зөвшөөрлийн сунгалтын төлбөр мөн шилжүүлгийн төлбөрт тус тус зарцуулсан. Н.О-ос 50.000.000 төгрөг авсан, өөр мөнгө аваагүй...» /2-р хавтас 187-188-р хуудас/ гэж тус тус мэдүүлсэн.

Мөрдөн байцаалтын шатанд Х.А-ын оршин суух орон сууц болон албаны тасалгаанд нэгжлэг хийх үед «Худалдах, худалдан авах», «Тусгай зөвшөөрөлтэй холбоотой анхдагч техникийн мэдээ, мэдээллийг худалдах, худалдан авах», «Хувьцаа худалдах, худалдан авах», «Компанийн эрх шилжүүлж, худалдан авах» тухай гэрээнүүд хураагдсан болон дээрх гэрч нарын мэдүүлгүүдээр Х.А компанийг худалдан авах гэрээгээр халхавчилж хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлүүдийг худалдан авсан нь тогтоогдсон.

Дээрх худалдан авалт хийснээр Х.А нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд зааснаар 30 хувийг суутган 7 хоногийн дотор татварыг төлөх ёстой байсан атал төлөөгүй нь шинжээч нарын дүгнэлтээр тогтоогдсон.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлд «татвар ногдох их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил үйлчилгээ, бусад зүйлээ биетээр нь нуун дарагдуулсан бол...» гэж заасан байдаг. Шүүхийн хэлэлцүүлэгт шинжээч нар ашигт малтмалтай холбоотой албан татварыг «бусад зүйл» гэдэгт хамааруулан ойлгодог талаар тайлбарласан. Албан татварыг нуун дарагдуулах үйлдэл нь тухайн зүйлийг биет байдлаар нь татварын албанаас өнгөлөн далдлах буюу данс бүртгэл, хууль бус хэлцлээр халхавчлах... үйлдлээр илрэх тул Х.А-ын хийсэн

гэрээнүүдийг хууль бус, халхавчаар хийсэн гэрээ гэж үзэхээр байна.

Татварын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.6-д «татварын алба нь татварын хууль тогтоомжийг ноцтой зөрчсөн, эсхүл их хэмжээний татвар ногдох орлогыг нуусан буюу бусад хэлбэрээр татвар төлөхөөс зайлсхийсэн этгээдэд эрүүгийн хэрэг бүртгэлт хийлгэхээр дүгнэлт бичих...» гэж заасан байх бөгөөд татварын улсын байцаагчийн акт бичигдэх боломжгүй юм.

Мөн Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлд «Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлт гаргаж, шинжилгээ хийхээр томилогдож байгаа шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийг дуудан ирүүлж, түүний биеийн байцаалт, мэргэжил, чадвартай танилцан, сэжигтэн, яллагдагч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тогтоохоос гадна шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана» гэж заасан байна.

Татварын Ерөнхий газраас Нийслэлийн татварын газрын Хяналт шалгалтын хэлтсийн татварын улсын байцаагч Б.Х, Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч Б.Б, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн татварын улсын байцаагч О.Ц нарыг томилсон боловч дээрх татварын улсын байцаагч нар нь байцаан шийтгэх ажиллагаанд оролцох боломжгүй, татгалзан гарах хүсэлт гаргасны дагуу мөрдөн байцаагч хэрэгт нэр заан шинжээч нарыг томилсон нь Шүүхийн шинжилгээний тухай хуулийг зөрчөөгүй. Шүүхийн шинжилгээний тухай хуульд зөвхөн тухайн байгууллага шинжээчийг томилно гэсэн заасан заалт байхгүй ба мөрдөн байцаагчийн нэр зааж томилсон шинжээч нарын хуульд заасан журмын дагуу гаргасан дүгнэлтийг шүүх хууль бус гэж дүгнэсэн нь үндэслэлгүй гэж үзэж байна.

Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны хоёрдугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 дүгээр шийтгэх тогтоолыг хүчингүй болгуулж, хэргийг анхан шатны шүүхээр дахин хянан хэлэлцүүлэхээр Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 303 дугаар зүйлийн 303.1, 304 дүгээр зүйлийн 304.1 дэх хэсэг, Прокурорын

байгууллагын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт заасныг үндэслэн улсын яллагчийн эсэргүүцэл бичив гэв.

ХЯНАВАЛ:

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 дугаарын шийтгэх тогтоол нь хууль ёсны ба үндэслэл бүхий гарчээ.

Х.А нь 2008 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн Үйлдвэр худалдааны сайд Х.На-ийн 196 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүн хуваах чиглэлээр Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Олон улсын нээлттэй тендер зарлаж, уг тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө «Тг» ХХК-ийн ерөнхий менежер Н.О-д итгэмжлэл хийж өгч, Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д 2009-оны 12 дугаар сарын 2-ны өдөр 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлэн хээл хахуульд өгсөн,

Талийгаач Д.А нь Газрын тосны газрын даргаар ажиллаж байхдаа Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан, газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны дарга, Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар тус тус ажиллахдаа тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Х.А-ын 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг төрсөн ах Д.Ц-ийн хүү Ц.Ч-ийн нэр дээр 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр шилжүүлэн онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн болох нь:

Гэрч О.Э-ын «...Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 33 дугаар тушаалаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас гадаад, дотоодын ижил төрлийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдээс газрын тосны талбайн захиалга авч, гэрээ байгуулах үйл ажиллагааг зохих ёсоор шуурхай явуулах шаардлагад нийцүүлэн «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмыг баталсан. Мөн тушаалын 2 дугаар заалтаар уг журмыг Үйлдвэр худалдааны яам болон Ашигт малтмал, газрын тосны газрын дотоод удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаанд мөрдөхөөр

болсон байдаг. Журмын 6.4-т заасны дагуу Сонгон шалгаруулалтын эцсийн шийдвэр гарч, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж, гэрээ байгуулах мэдэгдлийг захиалагчид өгөх хүртэл хугацаанд сонгон шалгаруулалттай холбогдсон материал, мэдээлэл задруулахыг хориглоно гэж заасны дагуу ажлын хэсэгт орсон гишүүд нууц хадгалах талаар баталгааг гаргадаг. Журмын 7 дугаар зүйлд заасны дагуу Үнэлгээний хороог тухай бүр Газрын тосны даргын тушаалаар томилох юм. Үнэлгээний хороог Газрын тосны газрын «газрын тосны асуудал хариуцсан» мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулна. Журмын 7.2-т заасны дагуу үнэлгээг Ажлын хэсгээс битүүмжилсэн материалыг актаар хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтааж хийж дуусгана. Журмын 8 дугаар зүйлд заасны дагуу үндсэн, туслах, дэд үзүүлэлтээр үнэлгээ хийнэ. Үүнд: Үндсэн үзүүлэлт нь байгалийн нөхөн сэргээгдэшгүй баялгийг ашигласны төлбөр, бүтээгдэхүүн хуваалт нөхөх зардлын хувь хэмжээ хамаарна. Үнэлгээний хороонд битүүмжлэн өгсөн «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний үндсэн нөхцлүүдэд өгсөн саналаар уг журмын хавсралтад дурдсан «бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний сонгон шалгаруулалтын аргачлалаар оноо өгч, үнэлгээ хийнэ... Журмын хавсралтын 2-т заасан туслах үзүүлэлтийн 1 дэх хэсгийг үнэлэхдээ гэрээлэгч, туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, мэргэжлийн чадавхийг үнэлэхдээ тухайн захиалагч болон хөрөнгө оруулагч компанийн газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан эсэх, эсхүл мэргэжлийн компанитай гэрээ санамж бичиг байгуулсан эсэх, мэргэжлийн зөвлөх инженерүүдийн багтай эсэх, гэрээ байгуулсан тохиолдолд хайгуул судалгааны ажлыг хэрхэн хийх талаар ирүүлсэн бичиг баримтыг харгалзан үнэлдэг. Санхүүгийн чадавхийг үнэлэхдээ тухайн захиалагч болон хөрөнгө оруулагч компанийн санхүүгийн тайлан аль нэг банк, хөрөнгө оруулалтын сангуудаас хөрөнгө оруулалт хийх баталгаа авсан эсэх, тухайн захиалагч болон хөрөнгө оруулагч компанийн өмнө нь эрхэлж байсан үйл ажиллагаа, хэрхэн амжилттай хэрэгжиж байсан зэргийг харгалзан үнэлдэг. Энэ хэсгийг үнэлэхдээ Үнэлгээний хорооны гишүүд Захиалгын материал, ажлын хэсгийн санал, дүгнэлтийг харгалзан өөрсдийн дотоод итгэлээр 0-15 оноо өгнө. Туслах үзүүлэлтийн 2-т заасан гэрээлэгч, туслан

гүйцэтгэгч нарын хооронд гэрээ хийсэн эсэх, харилцан хүлээх үүргийг үнэлэхдээ газрын тосны мэргэжлийн компанитай гэрээ хийсэн эсэхийг харгалзан оноо өгнө. Ямар нэг урьдчилан тохиролцоо байхгүй бол 0 оноо өгдөг. Ямар нэг гэрээ байх юм бол тэрийг Үнэлгээний хорооны гишүүд өөрийн дотоод итгэлээр 10 хүртэл оноо өгнө. Журмын хавсралтын туслах үзүүлэлтийн 3 дахь хэсэгт заасан ашиглахаар санал болгож буй техник, технологи, тоног төхөөрөмжийг үнэлэхдээ захиалгын материалд дурдсан хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэх арга аргачлал, хэрэглэх тоног төхөөрөмжийг харгалзан Үнэлгээний хорооны гишүүд 0-10 хүртэл оноог өөрсдийн дотоод итгэлээр өгнө. Журмын хавсралтын туслах үзүүлэлтийн 4 дэх хэсэгт заасан хайгуулын хугацаанд заавал хийж гүйцэтгэх үндсэн ажлыг үнэлэхдээ захиалгад дурдсан заавал хийж гүйцэтгэх ажлаа мэргэжлийн төвшинд хэрхэн төлөвлөснийг харгалзан Үнэлгээний хорооны гишүүд өөрсдийн дотоод итгэлээр 0-20 хүртэл оноо өгнө... Ингээд үндсэн үзүүлэлт, туслах үзүүлэлт, дэд үзүүлэлт тус бүр авсан оноог нэмж захиалагчид өгөх үнэлгээний оноог гаргана. Журмын 8.7, 8.8-д заасны дагуу Үнэлгээний хороо санал, дүгнэлтээ илтгэх хуудас үйлдэн хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан Сонгон шалгаруулах зөвлөлийн нарийн бичгийн даргад холбогдох баримт бичгийн хамт дугуйлан битүүмжлэн лацдаж хүргүүлнэ. «Тг» ХХК нь Шарга-3 болон Нэмэгт-6 талбайд захиалга ирүүлсэн ба Ажлын хэсэгт нь хуучнаар Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Б-ны 2009 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 12 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Ажлын хэсгийн ахлагчаар Гэрээлэлтийн хэлтсийн дарга Г.Т, одоо «ЭМГЛ»-т ажиллаж байгаа, гишүүдээр Гэрээлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Н, Гэрээний хэрэгжилтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.А, Олборлолт, тээвэрлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн А.П, Олборлолт тээвэрлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Н.У нар байсан. Үнэлгээний хорооны гишүүдээр томилогдсон хүмүүсийн тушаал нь одоо олдохгүй байгаа. АМГТХЭГ-ын даргын 2009 1 дүгээр сарын 14-ний 12 дугаар тушаалын 3-т заасны дагуу Ажлын хэсэг хэлэлцээг 2009 2 дугаар сарын 16-ны дотор хийж дуусган холбогдох материалыг бүрдүүлэн битүүмжилж Үнэлгээний хороонд актаар хүлээлгэн өгөхийг даалгасан байдаг.

«Бүтээгдэхүүн хуваах гэрээний»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 7.2-т заасны дагуу үнэлгээг Ажлын хэсгээс битүүмжилсэн материалыг актаар хүлээн авсан өдрөөс хойш 10 хоногт багтаан хийж дуусгана гэж заасан байдаг. Харин Үнэлгээний хорооны илтгэх хуудсын төслийг Гэрээлэлтийн хэлтсийн дарга Г.Т-гийн ажил хүлээлцэх үед компьютерийн файл дотор байсан. Энэ илтгэх хуудсаар Үнэлгээний хорооны гишүүдэд Үнэлгээний хорооны даргаар газрын тосны газрын дарга Д.А, нарийн бичгийн даргаар Гэрээлэлтийн хэлтсийн мэргэжилтэн С.Са, гишүүдэд Газрын тосны газарт ажиллаж байсан Л.Сүх, Д.А, С.Н, Ш.Ц, Л.А, Э.Т, Н.О нар ажиллаж байсан. Эрдэс баялаг Эрчим хүчний сайдын 2009 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 79 дүгээр тушаалаар Сонгон шалгаруулалтын зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг баталсан. Зөвлөлийн даргаар Газрын тосны газрын дарга Д.А, нарийн бичгийн даргаар А.Тү, гишүүдэд Н.Б, П.Х, Л.Р, Г.Э, М.А, Д.А, О.Э нар ажилласан юм... Үнэлгээний хорооны санал дүгнэлтэд дурдсан асуудалтай танилцаагүй ээ. Хэрвээ Үнэлгээний хорооны илтгэх хуудсанд дурдсан санал дүгнэлтийн талаар Сонгон шалгаруулах зөвлөл дээр яригдсан бол энэ асуудал нь тэмдэглэл дээр тусгагдах ёстой. Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэл дээр энэ талаар дурдаагүй байна...» гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 68-73, 74-76/,

Гэрч Г.Т-гийн: «... Д.А-ыг ажил хэргийн шугамаар танина... «Тг» ХХК-ийн захирал Х.А-ыг ажил хэргийн шугамаар танина. Намайг Газрын тосны газарт ажиллаж байхад газрын тосны олон улсын нээлттэй тендерт материалаа ирүүлж байсан. Энэ компанийн материалыг би үзэж байсан юм. Тэр шугамаар танина. Энэ материалыг үзэх ажлын хэсгийн даргаар би ажиллаж байсан юм. Хуучнаар ашигт малтмал, газрын тосны газраас зарлагдсан Олон улсын нээлттэй тендерийн захиалгын материал хүлээн авах Эргэл-12 хайгуулын талбайд «Тг» ХХК нь захиалгын материал ирүүлсэн байсан. Ажлын хэсэг 2008 оны 6 дугаар сарын 23-наас 2008 оны 7 дугаар сарын 21-ний дотор хэлэлцээрээ хийж дуусгах ёстой байсан. Хэлэлцээрийн явцад тухайн компаниас бүрдүүлж ирүүлсэн материал нь шаардлага хангахгүй байсныг Ажлын хэсгээс мэдэгдэж, ирүүлсэн материалыг буцааж байсан. Тухайн үед «Т» ХХК-ийн хувьд

Эргэл-12 талбайд хайгуулын ажлын туслан гүйцэтгэгчээр ажиллах гадны компаниудтай санамж бичиг, гэрээ байгуулаагүй, ирүүлсэн санамж бичиг нь баталгаажаагүй, хуулбар хувь ирүүлсэн байсан. Мөн санхүүгийн чадварыг нотлох баримт бичгүүд нь тухайн компанийн санхүүгийн чадварыг тодорхойлох боломжгүй, хангалтгүй байсан. Шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг хэрхэн шийдвэрлэх нь тодорхойгүй байсан тул Ажлын хэсгээс материалыг буцааж байсан. Энэ талбайтай холбоотой захиалгын материалыг хэлэлцэхдээ Ажлын хэсэг 2 удаа уулзалт хийгээд дутуу материалаа бүрдүүлэхийг шаардаж байсан. «Т» ХХК-ийн зүгээс дутуу материалаа бүрдүүлж өгөөгүй, захиалгын материалыг буцаан өгч цаашид оролцох боломжгүй талаар 2008 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хэлэлцээрээр манай Геологи, хайгуулын хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.А, нарийн бичгийн даргаар Гэрээлэлтийн хэлтсийн мэргэжилтэн З.Б бид гурав «Тг» ХХК-ийн зүгээс ерөнхий захирал Х.А, ерөнхий менежер Н.О нараас шаардаж байсан. Дараа нь манай байгууллагаас Нэмэгт-6, Шарга-3 талбай дээр захиалга авах сүүлийн хугацаа нь 2008 оны 12 дугаар сарын 5-ны өдөр дуусгавар болох байсан. Уг хоёр талбай нь байгалийн цогцолбор газарт хамрагдаж байсан тул уг асуудлыг шийдвэрлэх хүртэл буюу 2009 оны 01 дүгээр сарын 05-ны өдөр сунгах арга хэмжээг байгууллагаас авах байсан. Харин 2008 оны 10 дугаар сарын 20-ны өдөр «Тг» ХХК нь Шарга-3, Нэмэгт-3 талбайнуудад Олон улсын нээлттэй тендерт дахин захиалгын санал ирүүлсэн байсан. Тус компаниас ирүүлсэн захиалгын саналд Ажлын хэсэг 2009 оны сарын 1 дүгээр 5-ны өдрөөс эхлэн ажилласан байх ёстой. 2009 оны 1 сарын 14-ний өдөр Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын даргын 12 дугаар тушаалаар Ажлын хэсэг 2009 оны 2 дугаар сарын 16-ны өдөр хүртэл ажиллах талаар тусган «Тг» ХХК-ийн захиалгын материал дээр Ажлын хэсгийн даргаар би, гишүүдэд ахлах мэргэжилтэн Ч.Н захиалгын материалын бүрдэл хэсэг, дүрэм журмын дагуу ирүүлсэн эсэхийг нягтлан, ахлах мэргэжилтэн Л.А геологийн талаар үнэлэлт дүгнэлт өгөх, ахлах мэргэжилтэн А.П, мэргэжилтэн Н.У нар нь тухайн компанийн санхүүгийн чадварыг нотлох талаар тус тус ажилласан. Миний хувьд 2009 оны 01 дүгээр 27-ны өдрөөс эхлэн өөр газарт томилогдон ажиллахаар болоод уг

ажлыг Геологи, хайгуулын хэлтсийн даргаар ажиллаж байсан. Ж-д Ажлын хэсгийн ажлыг өгсөн юм. Намайг Ажлын хэсэгт ажиллах хугацаанд «Тг» ХХК-ийн захиалгын материал нь Эргэл-12 хайгуулын талбайд өгсөн материалтай адилхан байсан. ...Миний санаж байгаагаар манай Ашигт малтмал, газрын тосны газрын дэд даргаар ажиллаж байсан Д.А нь «Тг» ХХК-ийг «дэмжих боломжтой юу» гэж асууж байсан. Тухайн үед нь би Ажлын хэсгийн даргаар ажиллаж байсны хувьд журмын дагуу явна гэж хэлж байсан. «Тг» ХХК-ийн захиалгын материалыг судлах Ажлын хэсэг намайг ажиллаж байх үед хуралдаагүй байх... «Тг» ХХК-ийн Эргэл-12 хайгуулын талбайд ирүүлсэн материал, түүнийг судалсан дүгнэлт нь надад байна. Мөн Нэмэгт-6, Шарга-3 талбайд ирүүлсэн захиалгын материалыг судлаж үзсэн хоёр дүгнэлт нь бүгд надад байна. Эндээс харахад ялгагдах зүйл байхгүй. Өмнөх Эргэл-12 өгсөн захиалгын материалтай адилхан байна. Энэ компанийн хувьд ирүүлсэн захиалгын материалуудыг үзэхэд тухайн компанийн санхүүгийн чадавхийг нотлох баримт бичгийн бүрдэл болон туслан гүйцэтгэгчээр ажиллах чадавхийг нотлох баримт бичгүүд хангалтгүй байсан...»Тг» ХХК-ийн газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайд ирүүлсэн захиалгын материалыг танилцаж судлах Ажлын хэсгийн даргаар ажиллаж байхад Д.А нь «Тг» ХХК-ийн талаар асууж байсан. «Энэ компанийн хувьд материал нь хэр байгаа вэ, явц байдал нь ямар байгаа юм, энэ компанийн ирүүлсэн материалын хувьд дэмжих боломжтой юмуу» гэж асууж байсан. Би уг компанийн ирүүлсэн материалын хүрээнд дүрэм журмын дагуу явна гэж хэлсэн. Өөр хүмүүс тухайн үед «Тг» ХХК-ийн талаар асуусан зүйл байхгүй. Ажлын хэсгийн дунд хэн хэлсэн нь мэдэгдэхгүй дам яриа байдаг байсан. «Тг» ХХК-ийг Д.Т сайдтай холбоотой компани гэж ярьж байсан...» гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 77-79, 102-103/,

17. Гэрч С.С-ын "...Д.А-ыг бол танина. Газрын тосны газарт хамт ажиллаж байсан. Ажил хэргийн холбоотой. Харин "Тг" ХХК-ийн захирал Х.А-ыг танихгүй. Харин энэ компанийн газрын тосны хайгуулын талбайн тендерт ирүүлсэн материалд нь үнэлгээ хийхэд материалыг нь танилцаж байсан. Компанийн хүмүүстэй нь уулзаж байгаагүй. Би Үнэлгээний хорооны нарийн бичгээр ажилласны хувьд үнэлгээний явцыг тэмдэглэж, тэмдэглэл хөтөлсөн.

Мөн хүснэгт гаргаж Үнэлгээний хорооны гишүүдэд танилцуулж гарын үсэг зуруулаад Үнэлгээний хорооны дүгнэлт гарган төлөвлөж, Үнэлгээний хорооны гишүүдэд бүгдэд нь танилцуулж, Сонгон шалгаруулах зөвлөлийн нарийн бичгийн даргад бүх бичиг баримтыг хүлээлгэж өгсөн. Анх тендер оролцох компаниудын Ажлын хэсэг гэж гарч ажилласан. Харин “Тг” ХХК-ийн Ажлын хэсэгт би байгаагүй болохоор сайн мэдэхгүй байна. Тендерийн Үнэлгээний хорооны нарийн бичгийн даргаар ажилласны хувьд тус компанийн өгсөн үндсэн үзүүлэлт орох саналаар нилээн дээгүүр санал өгсөн байсан. Тэгээд Үнэлгээний хороо өгсөн оноог нь бүрдүүлээд Сонгон шалгаруулалтын зөвлөлд өгсөн юм. Үнэлгээний хороо 1 удаа хуралдсан. Үнэлгээний хорооны гишүүдэд хэн хэн орсон талаар одоо санахгүй байна. Үнэлгээний хороог ажиллах зохион байгуулалтын ажлыг хийх талаар хуучнаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Газрын тос хариуцсан дарга Л.Сүх томилсон. “Тг” ХХК-ийн Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах захиалгын материалд Ажлын хэсэг ажилласан хурлын тэмдэглэл болон бусад бичиг баримттай танилцсан. Харин дуу хураагуур дээр бичигдсэн гэх зүйлтэй танилцаагүй. Бусад протокол тэмдэглэлтэй танилцсан. Ажлын хэсэг ажилласан баримт бичгүүд нь одоо архивт байгаа гэж бодож байна. Сайн мэдэхгүй байна. Үнэлгээний хорооны ажилласан ажлын тэмдэглэл болон зүйлүүдийг би эх хувиар нь гарын үсэг зурж баталгаажуулсан. Бичиг баримтуудыг би Сонгон шалгаруулах зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилогдсон А.Тү-д хүлээлгэн өгсөн. Харин хүлээлгэн өгсөн баримт байхгүй... “Тг” ХХК-ийн хувьд газрын тосны чиглэлээр хайгуулын үйл ажиллагаа явуулах өөрсдийн хүчин чадал болон техник тоног төхөөрөмж байхгүй, туршлага байхгүй байсан. Харин гадны компанитай урьдчилсан гэрээ юмуу, эсвэл санамж бичиг байгуулсан бол тухайн гадны компанийг судлах шаардлагатай юм. Энэ компани Норвегийн дэлхийд газрын тосны чиглэлээр тэргүүлэгч компанитай санамж бичиг байгуулсан байсан. Өөр туршлага бол байгаагүй. Энэ компанийн захиалгын материалд Ажлын хэсгийн гишүүд одоо нэрийг нь санахгүй байна “Тг” ХХК-ийг “компанийн хөрөнгө чинь дутуу байна, та нар энэ ажлыг хийж чадахгүй байна”

гэхээр доороо баахан охин компанитай эд нараас хөрөнгө татах боломжтой гэж баахан компанийн танилцуулга авчирдаг байсан юм. Мөн хэн хэлснийг санахгүй байна. Ажлын хэсэг болон Үнэлгээний хорооны гишүүдийн дунд нэг явган яриа байдаг нь “Тг” ХХК нь Монгол Улсын Ерөнхийлөгчөөр ажиллаж байсан Н.Э-ын эхнэр О.Ц-гийн компани гэсэн яриа яригдаж байсан. Хэн хэлснийг нь мэдэхгүй. Гэхдээ гишүүдийн дунд тийм яриа бол яригдаж байсан. Бид нар хоорондоо “Тг” ХХК нь ийм олон компанитай, их хэмжээний хөрөнгөтэй юм бол яагаад “Н” компани шиг олонд танигдсан нэртэй болоогүй юм бэ гэж хүртэл ярьдаг байсан юм. “Тг” ХХК-ийн захиалгын материалд ирүүлсэн Норвегийн “Л групп”-тэй хамтран ажиллах санамж бичгийн эх хувиар нь үзээгүй. Хуулбар хувь байсан ба яг үнэлгээ хийгээд эхэлсэн учир үзэх боломж бол байгаагүй...” гэх мэдүүлэг /2-р хх-ийн 104-107/,

Гэрч А.П-ийн «...Би Ажлын хэсгийн тушаалыг үзээгүй. Ажлын хэсэгт орж ажиллаагүй. Тухайн үед би өвчтэй байсан болохоор энэ талаар мэдэх зүйл байхгүй. Учир нь тэр үед өвчтэй хагалгаанд орсон байсан юм. Энэ Ажлын хэсэгт орсон гэдгээ сая өнөөдөр мэдэж байна. Би энэ ажлын хэсэгт огт оролцоогүй...» гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 108-109/,

Гэрч Ш.Ц-ийн «...Үнэлгээний хорооны гишүүнээр орж ажилласан. Үнэлгээний хороо ажиллахдаа Ажлын хэсгээс ирүүлсэн материалуудыг компани тус бүрээр нь үзээд холбогдох санал дүгнэлтээ өгдөг юм. Миний хувьд бол тухайн компаниудын эдийн засгийн чадавхи, санхүүгийн тайлангийн үзүүлэлт, хийгдэх ажлын хөтөлбөр төсвийг нь бусад компаниудтай зэрэгцүүлж үздэг. Тэгж байж дүгнэлтээ гаргадаг. «Тг» ХХК-ийн хувьд ямар байсныг одоо сайн санахгүй байна. Олон компанийн материалыг үзэж байсан болохоор санахгүй байна. Уг компанид ямар үнэлгээ өгсөн нь гарын үсэг зурагдсан үнэлгээн дээр байгаа гэж бодож байна. 2009 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Үнэлгээний хорооны илтгэх хуудсанд «Тг» ХХК нь захиалгын материалдаа олон тооны компаниудтай газрын тосны үйл ажиллагаанд хамтран оролцож санхүүжилт хийхээр дурдсан. Гэвч эдгээр компаниудад нь газрын тостой холбогдолтой үйл ажиллагаанд, улмаар «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-гээр аливаа хариуцлага хүлээх нь Монгол Улсын иргэний хууль тогтоомжийн

дагуу эрх зүйн үндэслэлгүй байх тул зөвхөн «Тг» ХХК-ийн санхүүгийн тайлан, холбогдох бичиг баримтад үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой юм. «Тг» ХХК-ийн 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс харахад орлого, үр дүнгийн тайланд борлуулалтын орлого тусгагдаагүй, 40 сая төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай, тайлангаа аудитаар баталгаажуулаагүй зэрэг үндэслэлээр санхүүгийн чадавхийг үнэлэхэд хүндрэлтэй байна. «Зоос» банкны 2008 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 1020 тоот албан бичиг, «Голомт» банкны 2008 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн 08/109 тоот албан бичиг нь цаг хугацааны хувьд шаардлага хангахгүй байна. Учир нь өнөөгийн байдлаар үүсээд байгаа банк санхүүгийн хямрал, бэлэн мөнгөний хомсдол зэрэг бодит байдал нь дээрх албан бичиг ирүүлсэн хугацааны дараа болж байна. Мөн тус компанийн 2008 оны 10 дугаар сарын 3-ны өдөр орж ирсэн 2.000.000 ам доллар нь ямар байгууллагаас юунд зориулагдан ирсэн нь тодорхой биш байгаа тул үйл ажиллагаа явуулах санхүүгийн боломжгүй, зөвхөн аль нэг талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах боломжтой байж болох талтай байна» гэсэн үнэлэлт дүгнэлт өгсөн байна. «Тг» ХХК-ийн хувьд яг ийм бодит байдал болж байсан болоод ийм дүгнэлт өгсөн байна. Одоо миний санаж байгаагаар энэ асуудал болж байсан. Эдийн засгийн чадавхигүй гэдэг нь энэ материалаас харагдаж байгаа болохоор энэ компани ийм өндөр оноо авч байгаа нь эргэлзээтэй болж байна. Бодит байдал дээр энэ компани ийм л байсан. Яг үнэнийг хэлэхэд би өөрийнхөө өгсөн үнэлгээг хэлж мэдэхгүй байна. Гэхдээ дээрх байдлаар компанийн санхүүгийн байдлыг харахад ийм өндөр оноо өгөх боломжгүй оноо өгсөн. Хүснэгтийг үзлээ. Энэ өгсөн оноонд итгэхгүй байна. Учир нь гарын үсэг байхгүй байна...» гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 120-122/,

Гэрч П.Х-гийн «...Газрын тосны газрын хурлын зааланд 2009 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах, «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах Зөвлөлийн хурал болсон. Энэ зөвлөлийн бүтээгдэхүүнд хуучнаар Эрдэс баялаг, эрчим хүчний яамны Түлшний бодлогын газрын орлогч дарга Б, мэргэжилтэн Р, миний бие яамнаас уг бүрэлдэхүүнд оролцсон. Уг Сонгон шалгаруулах зөвлөлийн хуралдаанд

Газрын тосны хайгуулын Төхөм-10 /урд/, Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад захиалга ирүүлсэн компаниудын үнэлгээнд сонгон шалгаруулалт явуулах зорилготой байсан. ...Газрын тосны хайгуулын Нэмэгт-6 талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулахаар захиалга ирүүлсэн компаниудын асуудлыг хэлэлцсэн. Дээрх талбайд 2 компани захилга ирүүлснээс Үнэлгээний хороо үнэлж «Тг» компани оноогоор тэргүүлж 1 дүгээр байр эзэлсэн байсан. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу 1 дүгээр байр эзэлсэн компанийг дэмжсэн Ажлын хэсгийн хүмүүс бүгд 100 хувь дэмжиж оролцсон... Газрын тосны хайгуулын Шарга-3 талбайд захиалга ирүүлсэн компаниудын өгсөн үнэлгээнд сонгон шалгаруулалт хийх байсан. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу Үнэлгээний хороо үнэлгээ хийлгэж, мөн эхний байрт «Тг» ХХК нь шалгарсан байсан. Уг шалгаруулалтад миний хувьд БНПУ-ын «РСМС» компанитай «Бүтээгдэхүүн хуваах гэрээ» байгуулахаар хэлэлцээр хийх Ажлын хэсэгт Газрын тосны газарт ажиллаж байхдаа орж ажиллаж байсан. БНПУ-ын «РСМС» компани нь газрын тосыг хайгуулын үе шатнаас газрын тосны эцсийн бүтээгдэхүүн гарах хүртэл бүхий л үе шатны ажлыг дангаараа гүйцэтгэдэг Польш улсдаа төдийгүй Европт нэр хүндтэй компани байсан. Үнэлгээгээр тус компани нь хамгийн сүүлийн байранд орсон байсан. Хэрвээ эхний байранд шалгарсан компанитай ойролцоо оноо авсан байсан бол Польшийн энэ компанийг Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдээс дэмжиж ажиллах байсан. Нэгэнт оноо доогуур байсан учраас «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу үнэлгээнд хамгийн өндөр оноо авсан «Тг» ХХК-ийг дэмжсэн болно. Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд нь Үнэлгээний хорооны үнэлгээг бодитой байна уу, үгүй юу гэдгийг дүгнэлт гаргах, Үнэлгээний хорооны үнэлгээг хүчингүйд тооцох, сонгон шалгаруулахаас татгалзах санал гаргах эрхтэй байдаг. Үнэлгээний хорооны дүгнэлтийг Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд танилцана. Шаардлагатай гэсэн тохиолдолд үнэлгээ өгсөн материалтай танилцана. Хэрвээ Үнэлгээний хорооны өгсөн үнэлгээ нь бодит байдалд нийцэхгүй бол «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг Сонгон шалгаруулах

журмын 11 дүгээр зүйлийн 11.2-т зааснаар Сонгон шалгаруулалтын материалыг хянан үзэх, сонгон шалгаруулалт хийх, гэрээ байгуулах, эрх олгох, зөвлөмж гаргах, Сонгон шалгаруулах зөвлөл нь зарлал мэдээллийг зохих журмын дагуу явуулсан, оролцогчдоос захиалгаа ирүүлэхэд нь ижил хугацаа олгосон, шударга өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлж шаардлагад нийцсэн захиалга ирүүлсэн эсэхийг хянах, Сонгон шалгаруулах зөвлөл нь энэ журмын дагуу хянаж зөрчил илрүүлсэн тохиолдолд гэрээлэгч сонгох ажиллагааг зогсоож, энэ журмын дагуу тухайн ажиллагаа, эсхүл үнэлгээг, тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дахин хийлгэх эрх үүрэгтэй ажиллах юм. «Тг» ХХК-ийн талаар сайн мэдэхгүй байна. Ажлын хэсэг, Үнэлгээний хорооны материалтай сайн танилцаагүй. Ажлын хэсгээс боломжтой гэж үзэн тус компанийн захиалгын материалыг Үнэлгээний хороонд өгсөн байх гэж бодож байна. Ер нь Ажлын хэсэг бол «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-г байгуулахаар захиалга ирүүлсэн компани, аж ахуйн нэгжээс эхлээд тухайн компанийн хайгуулын ажил гүйцэтгэх чадвартай гэсэн санхүүгийн баталгааг гаргуулж авдаг. Үүний дараа мөн мэргэжлийн баг, боловсон хүчин ажиллах чадвартай эсэхийг үзнэ. Хэрвээ тухайн компани мэргэжлийн баг, боловсон хүчин байхгүй тохиолдолд мэргэжлийн туслан гүйцэтгэгч компани, аж ахуйн нэгж авч ажиллуулах боломжтой. Сонгон шалгаруулах зөвлөл дээр үнэлгээ хийгдсэн компаниудын талаарх аль аль компани ямар оноо авсан, хэддүгээр байр эзэлсэн талаар ямар компани оролцсон талаар танилцуулсан. Одоо миний санаж байгаагаар Үнэлгээний хорооны илтгэх хуудас танилцуулагдаагүй гэж үзэж байна. Асуусан асуултын хүрээнд «Тг» ХХК-ийн талаар танилцуулаагүй. Хэрвээ ийм асуудал танилцуулагдсан бол Зөвлөлийн гишүүд Үнэлгээний хороонд дахин асуудлыг буцааж, дахин материалын бүрдлийг бүрдүүлэх ёстой байсан. Эсхүл Үнэлгээний хорооны гишүүд тухайн компанийн материалыг иж бүрдэл дутуу гэж үзээд үнэлэхээс татгалзах ёстой байсан. Үнэлгээний хорооны илтгэл дээр тавигдсан БНПУ-ын «РСМС» компанийн холбоотой асуудлыг Сонгон шалгаруулах зөвлөлийн хурал дээр энэ асуудал танилцуулагдаагүй. Хэрвээ танилцуулагдсан бол Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэл дээр миний хэлсэн үг байгаа. БНПУ-ын «РСМС» компани нь газрын

тосны хайгуулаас газрын тосны эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүртэл үйлдвэрлэх чадвартай санхүүгийн хувьд компани, өөрөө дангаараа шийдэх боломжтой талаар хурлын тэмдэглэлд дурдсан байгаа. Хэрвээ дээрх асуудал танилцуулагдсан бол Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд анхаарлаа хандуулах байсан болов уу гэж бодож байна...» гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 135-139/,

Гэрч Л.О-ийн «...2009 оноос Газрын тосны газрын Архив, бичиг хэргийн эрхлэгчээр ажиллаж байсан. Газрын тосны газрын даргын тушаал, шийдвэрээр ажиллаж байгаа бүх бичиг баримт нь архивт хадгалагдах ёстой байдаг. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах Ажлын хэсгийн болон Үнэлгээний хороо, Сонгон шалгаруулах зөвлөлийн баримт бичгүүдийг тухайн ажил хариуцсан Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга бүрдүүлээд архивт өгөх үүрэгтэй. Тэр өгсөн материалыг би хадгалах үүрэгтэй юм. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах захиалгын материалд ажиллах Ажлын хэсгийн материал, Үнэлгээний хорооны материал, Сонгон шалгаруулах зөвлөлийн материалуудыг ажил хариуцсан хүмүүс нь эцсийн шийдвэр гараагүй тул «нууц» гээд өөр дээрээ байлгадаг. «Тг» ХХК-ийн газрын хайгуулын талбайд өгсөн захиалгын үдэгдсэн материалууд бол байгаа. Харин танай 2014 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 06/352 дугаар албан бичигт дурдсан зүйлүүд бол манай архивт байхгүй...» гэх мэдүүлэг /2-р хх-ийн 144-145/,

Гэрч М.А-гийн «...Сонгон шалгаруулах зөвлөл нь Ажлын хэсэг, Үнэлгээний хороо зохих ажлаа хийсний дараа Сонгон шалгаруулах зөвлөлийн нарийн бичиг хурлын товыг Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүдэд хэлдэг. Тэрний дагуу «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах хуралд оролцдог. Газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6, Төхөм-10 талбайд газрын тостой холбогдсон үйл ажиллагаа явуулах «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүнээр уг хуралд оролцсон. Сонгон шалгаруулах зөвлөлийн хурал хэзээ, хэдэн удаа болсныг одоо би санахгүй байна. Сонгон шалгаруулах зөвлөл нь нэг удаа хуралдсан шиг санагдаж байна. Угаасаа эцсийн байдлаар материалууд нь орж ирдэг болохоор 1 л удаа хуралдсан. Ажлын хэсэг, Үнэлгээний хорооны гаргасан шийдвэртэй

танилцаад санал хураах журмаар санал хураагаад олонхийн зөвлөлийн гишүүд шийдвэрээ гаргадаг. Үнэлгээний хорооны дүгнэлтээр хамгийн өндөр оноо авсан нь «Тг» 2009 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэлд «Тг» ХХК-ийн талаар «...Монголын «Тг» ХХК нь санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй, санхүүгийн тайланг зөрүүтэй гаргасан байна. Ер нь Ажлын хэсэг муу ажиллажээ. Санхүүгийн баримт бусад материалыг бүрэн хэмжээнд компаниас гаргуулж аваагүй байна...» гэж тэмдэглэсэн байсан. Тухайн үед би энэ асуудлыг хэлж байсан нь үнэн. «Тг» ХХК-ийн санхүүгийн тайлан нь 1 дүгээрт, гараар бичигдсэн, 2 дугаарт санхүүгийн тайлан аудитаар баталгаажуулаагүй, мөнгөн дүн зөрүүтэй байсан тул Ажлын хэсэг муу ажилласан, нэмэлт материал шаардах яасан юм гэсэн үүднээс хандаж хэлсэн. Үнэлгээний хорооны албажаагүй илт хуудсанд: ...»Тг» ХХК нь захиалгын материалдаа олон тооны компаниудт газрын тосны үйл ажиллагаанд хамтран оролцож санхүүжилт хийхээр дурдсан байна. Гэвч эдгээр компаниудад нь газрын тостой холбогдолтой үйл ажиллагаанд, улмаар «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний аливаа хариуцлага хүлээх нь Монгол Улсын иргэн хууль тогтоомжийн дагуу эрх зүйн үндэслэлгүй байх тул зөвхөн «Тг» ХХК-ийн санхүүгийн тайлан, холбогдох бичиг баримтад үнэлэлт дүгнэлт өгөх боломжгүй юм. «Тг» ХХК-ийн 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтээ харахад орлого үр дүнгийн тайланд борлуулалтын орлого тусгагдаагүй, 40 сая төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай, тайлангаа аудитаар баталгаажуулаагүй зэрэг үндэслэлээр санхүүгийн чадавхийг үнэлэхэд хүндрэлтэй байна. «Зоос» банкны 2008 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 1020 тоот албан бичиг нь цаг хугацааны хувьд шаардлага хангахгүй байна. Учир нь өнөөгийн байдлаар үүсээд байгаа банк санхүүгийн хямрал, бэлэн мөнгөний хомсдол зэрэг бодит байдал нь дээрх алба бичиг ирүүлсэн хугацааны дараа болж байна. Мөн компанийн 2008 оны 10 дугаа сарын 3-ны өдөр орж ирсэн 2.000.000 ам доллар нь ямар байгууллагаас, юунд зориулагдан ирсэн нь тодорхой биш байгаа тул газрын тосны хайгуулын 2 талбайд нэгэн зэрэг «Бүтээгдэхүүн хуваах гэрээ» байгуулж үйл ажиллагаа явуулах санхүүгийн

боломжгүй, зөвхөн аль нэг талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах боломжтой байж болох талтай байна» гэсэн байна. Энэ талаар мэдэхгүй байна. Таны асуусан асуултын хүрээнд энэ байдлыг сая мэдэж байна. Үнэлгээний хороо ийм илтгэх хуудас бичиж байгаа нь сонин байна. Учир нь ийм өндөр оноо авсан компанийн ард нь сонин тайлбар хийж байгаа нь ойлгомжгүй байна...» гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 146-149/,

Гэрч А.Тү-ын «...»Тг» ХХК-ийн захиалгын материалыг судалсан Ажлын хэсгийн материалууд бол над дээр ирээгүй. Харин Үнэлгээний хорооны санал дүгнэлт нь битүүмжлэгдэн ирсэн. Энэ дотор бол Ажлын хэсгийн материал байхгүй байсан. Үнэлгээний хорооны хуралдсан хурлын тэмдэглэл, санал дүгнэлт, илтгэх хуудас зэрэг материалуудыг ирүүлсэн байсан. Ажлын хэсэг ажилласан материал нь яасан талаар би мэдэхгүй байна. Надад энэ материал нь ирээгүй. Үнэлгээний хорооны материалын 1 хувийг нь тухайн үеийн Эрдэс баялаг эрчим хүчний сайд Д.З сайдад өгүүлэхээр манай газрыг хариуцаж байсан П.Х-д өгсөн. Үлдсэн хувийг нь миний ажлын өрөөнд байрлах онгорхой, цоожгүй битүүмжлэлгүй шкафанд хадгалаж байсан бөгөөд 2011 оны 5 дугаар сард би Австрали улс руу суралцахаар яваад хэн нэгэнд хүлээлгэн өгснөө сайн мэдэхгүй байна. Учир нь олон компанийн материалууд байсан ба одоо зөвхөн «Тг» ХХК-ийн Үнэлгээний хорооны санал дүгнэлт, илтгэх хуудас, хурлын тэмдэглэл болон түүнтэй холбоотой материалууд олдохгүй байна. Одоо би «тэр авсан», «энэ авсан» гэж хэлж чадахгүй байна. 1 дүгээрт журмын дагуу бол Ажлын хэсгийн материал надад ирүүлэх ёсгүй. 2 дугаарт Сонгон шалгаруулах зөвлөл дээр Үнэлгээний хэсгээс хүлээлгэн өгсөн материалын лацыг шалган задалж үзэхэд Үнэлгээний хэсгийн илтгэх хуудас, хурлын тэмдэглэл, захиалга өгсөн компаниудын үндсэн нөхцөлд өгсөн санал зэрэг гарч ирсэн талаар Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэл дээр тусгагдсан байгаа юм. Ажлын хэсгийн материал олдохгүй байгаа асуудлыг би мэдэхгүй байна... Үнэлгээний гишүүдийг томилсон тушаалыг олоогүй. Уг тушаал нь байгууллагын архивт байгаагүй. Үнэлгээний хорооны ажилласан гарын үсэгтэй илтгэх хуудас нь олдоогүй. Иймд Газрын тосны газрын Хайгуул, судалгааны хэлтсийн компьютер дотор хадгалж байсан файлаас

Үнэлгээний хорооны хүмүүсийн нэрсийг олж авч, тухайн хүмүүс Үнэлгээний хорооны гишүүнээр ажилласан үгийг тодорхойлох зорилгоор тэдгээр хүмүүстэй уулзсан. Ихэнх хүмүүс нь ажлаас гарсан хүмүүс байсан. Өөр буруу санаа, зорилго агуулаагүй. Яагаад ингэх болсон бас нэг шалтгаан нь, журмын 7 дугаар зүйлийн 7.5-д заасны дагуу Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаас бусад гишүүнийг Үнэлгээний хорооны гишүүнээр томилж болно гэхээр Д.А дарга Үнэлгээний хорооны даргаар орсон бол Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар томилж болохгүй болж таарсан. Ингээд Үнэлгээний хорооны гишүүдтэй уулзсан юм. Үнэлгээний хорооны албажаагүй илтгэх хуудсанд» ...»Тг» ХХК нь захиалгын материалдаа олон тооны компаниудтай газрын тосны үйл ажиллагаанд хамтран оролцож санхүүжилт хийхээр дурдсан байна. Гэвч эдгээр компаниудад нь газрын тостой холбогдолтой үйл ажиллагаанд, улмаар «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний аливаа хариуцлага хүлээх нь Монгол Улсын иргэний хууль тогтоомжийн дагуу эрх зүйн үндэслэлгүй байх тул зөвхөн «Тг» ХХК-ийн санхүүгийн тайлан, холбогдох бичиг баримтад үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой юм. «Тг» ХХК-ийн 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн үзүүлэлтээс харахад орлого үр дүнгийн тайланд борлуулалтын орлого тусгагдаагүй, 40 сая төгрөгийн үйл ажиллагааны алдагдалтай, тайлангаа аудитаар баталгаажуулаагүй зэрэг үндэслэлээр санхүүгийн чадавхийг үнэлэхэд хүндрэлтэй байна. «Зоос» банкны 2008 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 1020 тоот албан бичиг нь цаг хугацааны хувьд шаардлага хангахгүй байна. Учир нь өнөөгийн байдлаар үүсээд байгаа банк санхүүгийн хямрал, бэлэн мөнгөний хомсдол зэрэг бодит байдал нь дээрх албан бичиг ирүүлсэн хугацааны дараа болж байна. Мөн компанийн 2008 оны 10 дугаар сарын 3-ны өдөр орж ирсэн 2.000.000 ам доллар нь ямар байгууллагаас, юунд зориулагдан ирсэн нь тодорхой биш байгаа тул газрын тосны хайгуулын 2 талбайд нэгэн зэрэг «Бүтээгдэхүүн хуваах гэрээ» байгуулж үйл ажиллагаа явуулах санхүүгийн боломжгүй, зөвхөн аль нэг талбайд газрын тосны хайгуулын үйл ажиллагаа явуулах боломжтой байж болох талтай байна гэсэн энэ асуудлыг ярилцаагүй. Сангийн яамнаас Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүнээр оролцсон М.А хэлсэн учраас энэ тэмдэглэл дээр тусгагдсан. М.А-г үг хэлж байх үед би

хэлсэн үгийг нь тэмдэглэж авсан. «Тг» ХХК-ийн шалгаруулсан Үнэлгээний хорооны илтгэх хуудсанд Үнэлгээний хорооны дүгнэлт гэсэнд «...Нэмэгт-6 талбайд «Тг» ХХК-ийг шалгаруулсан байна. Харин Шарга-3 талбайд БНПУ-ын «РСШС» компани бага оноо авсан боловч газрын тосны мэргэжлийн бөгөөд санхүүгийн чадвартай тул тус компанитай «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-г байгуулах талаар хэлэлцээг хийх нь зүйтэй, стратегийн түншлэлийн харилцааг бий болгох санал гаргаж байсан байна. Хэрэв энэ асуудал яригдсан бол Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэл дээр тусгагдсан байх ёстой. Хэрэв энэ талаар хэн нэгэн хүн үг хэлсэн бол тэмдэглэл дээр тусгагдаад нөгөө хүний нэртэйгээ тэмдэглэлд орох ёстой. Тэгэхээр энэ асуудал яригдаагүй болохоор гишүүд хурлын тэмдэглэлд гарын үсэг зурсан гэсэн үг...Тийм асуудал байж болохгүй. Үнэлгээний хорооны илтгэх хуудас нь тодорхой хувиуд байсан. Гишүүд өөрсдөө танилцах үүрэгтэй. Уншиж танилцсан байх ёстой. Уншиж танилцах нь тэдний үүрэг юм...» гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 154-158/

Гэрч Л.Сүх-ийн «...2013 оны сүүлээр байх 11 дүгээр сарын сүүлээр Газрын тосны газарт ажилладаг А.Тү нь Үнэлгээний хорооны илтгэх хуудас гээд нэг зүйл барьчихсан энэ тэмдэглэл дээр нөхөж гарын үсэг зуруулж байгаа юм гэхээр нь би илтгэх хуудсыг хараад Д.А даргын үед ийм асуудал хариуцаж байгаагүй, би эх материал байхгүй байгаа учир гарын үсэг зурахаас татгалзсан...» гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 123-124/,

2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн шинжээчийн дүгнэлтэд: "...1-6 дугаар асуулттай холбоотой материал, нотлох баримт зэрэг нь Уул уурхайн яамны болон Газрын тосны газрын архивт архивлагдаагүй байна гэсэн Газрын тосны газрын 2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1-123 албан тоот болон Уул уурхайн яамны 2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 4/238 албан тоотыг ирүүлсэн тул дүгнэлт гаргах боломжгүй байна. Эрдэс баялаг, Эрчим хүчний сайдын 2009 оны 79 тоот тушаалаар Газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6, Төхөм-10 талбайнуудын "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан байна. Дээрх Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүд 2009 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр сонгон шалгаруулах

зөвлөлийн хурлын тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Тус баталгаажуулсан хурлын тэмдэглэлтэй танилцахад Зөвлөлийн зарим гишүүд БНПУ-ын «РСМС» компанийг дэмжих хүсэлтэй байсан боловч үнэлгээний оноо хэтэрхий доогуур байсан байна. Мөн Зөвлөлийн гишүүн М.А нь «Тг» ХХК нь санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй, санхүүгийн тайланг зөрүүтэй гаргасан, санхүүгийн баримт, бусад материалыг бүрэн хэмжээнд компаниас гаргуулж аваагүй, Ажлын хэсэг муу ажилласан гэсэн санал хэлсэн байна. Түүнчлэн Зөвлөлийн гишүүн Н.Б нь «Тг» ХХК-ийг газрын тосны хайгуулын 2 талбайд зэрэг хөрөнгө оруулж чадах эсэхэд эргэлзэж байна гэсэн байна. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 11 дүгээр зүйлийн 11.2-т «Сонгон шалгаруулах зөвлөл нь энэ журмын дагуу хянаж зөрчил ирүүлсэн тохиолдолд гэрээлэгч сонгох ажиллагааг зогсоож, энэ журмын дагуу тухайн үйл ажиллагаа, эсхүл үнэлгээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дахин хийлгэх» гэж заасан байтал Зөвлөлийн гишүүдийн дээр дурдсан саналыг үндэслэн зохих арга хэмжээ авалгүйгээр «Тг» ХХК-ийн захиалгыг дэмжсэн байна. Иймд тус Сонгон шалгаруулах зөвлөл нь журмын дагуу ажилласан эсэх нь эргэлзээтэй байна. Авлигатай тэмцэх газраас ирүүлсэн Газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад «Тг» ХХК-ийн ирүүлсэн захиалгын материалуудтай танилцахад тус компанийн санхүүгийн чадавхийг нотлох материалууд нь баталгаажаагүй байна. Түүнчлэн тус компанийн гадны туслан гүйцэтгэгч компаниудтай хамтарч ажиллах гэрээ байгуулаагүй, санамж бичиг байгуулсан бөгөөд тус санамж бичгээ эх хувиар нь ирүүлээгүй байна. Санамж бичиг нь эрх зүйн харилцаа үүсгэхгүй бөгөөд талууд аливаа эрх зүйн хариуцлага хүлээхгүй тул тус компаниас туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээг шаардах нь зүйтэй байсан гэж үзэж байна. Иймд «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 8.4.2-т заасан «Сонгон шалгаруулалтын үнэлгээний туслах үзүүлэлт»-ийг тус компани нь хангахгүй байгаа тул газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад шалгарах боломжгүй байсан байна...» гэжээ. /2-р хх-ийн 206-212/,

Шинжээч С.Т-гын «...Авлигатай тэмцэх газраас надад шинжээчийн дүгнэлт

гаргуулахаар шинжилгээ хийлгэх тухай тогтоол ирүүлсэн уг тогтоолд Газрын тосны газрын Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулсан 7 асуулга ирүүлсэн үүний дагуу шинжээчээр ажилласан шинжээчээр ажиллахад 1-6 асуултын хүрээнд хариулах боломжгүй байсан учир нь түүнтэй холбоотой албан ёсны баримт бичиг байгаагүй, харин «Тг» ХХК-ийн Газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах зөвлөлийг журмын дагуу ажилласан эсэхэд шинжээчийн дүгнэлтээр тодруулж өгсөн болно. Сонгон шалгаруулах бүтээгдэхүүнийг журмын дагуу баталсан гэхдээ сонгон шалгаруулах зөвлөлийн протоколыг уншихад зөвлөлийн зарим гишүүд горимын зөрчилтэй санал хэлсэн байна. Жишээлбэл зөвлөлийн гишүүн М.А «Тг» ХХК-ийг санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй санхүүгийн тайлан зөрүүтэй гаргасан, санхүүгийн баримт бусад холбогдох материалыг тус компаниас бүрэн гаргуулж аваагүй ажлын хэсэг муу ажилласан гэсэн санал хэлсэн байна, түүнчлэн сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн Н.Б «Тг» ХХК-ийг Газрын тосны хайгуулын 2 талбайд зэрэг хөрөнгө оруулж чадах эсэхэд эргэлзэж байна гэсэн байна. Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 11 дүгээр зүйлийн 11.2-т сонгон шалгаруулах зөвлөл нь энэ журмын дагуу хянаж зөрчил илрүүлсэн тохиолдолд гэрээлэгч сонгох ажиллагааг зогсоож энэ журмын дагуу тухайн үйл ажиллагааг эсхүл үнэлгээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дахин хийлгэх гэж заасан байхад зөвлөлийн гишүүний дээр дурдсан саналыг үндэслэн зохих арга хэмжээг авалгүйгээр «Тг» ХХК-ийг сонгон шалгаруулсан байна. Иймд уг сонгон шалгаруулах зөвлөл нь журмын дагуу ажилласан эсэх нь эргэлзээтэй байна. Түүнчлэн тус компанийн Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад ирүүлсэн захиалгын материалуудтай танилцахад / шинжилгээнд ирүүлсэн/ тус компанийн санхүүгийн чадавхийг нотлох материалууд нь баталгаажаагүй байсан. Мөн «Тг» ХХК-ийн гадны туслан гүйцэтгэгч компаниудтай хамтарч ажиллах гэрээ байгуулаагүй санамж бичиг байгуулсан бөгөөд тус санамж бичгийг нь эх хувиар нь ирүүлээгүй байна санамж бичиг нь Эрх зүйн харилцаа үүсгэхгүй бөгөөд талууд аливаа эрх зүйн хариуцлага хүлээхгүй тул «Тг» ХХК-наас туслан

гүйцэтгэгчэй байгуулсан гэрээг нь шаардах нь зүйтэй байсан гэж үзэж байна. Иймд Бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 8.4.2-т заасан сонгон шалгаруулалтын үнэлгээний туслах үзүүлэлтийг тус компани хангахгүй байгаа тул Газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад шалгарах боломжгүй байсан гэж үзэж байна...» гэх мэдүүлэг /2-р хх-ийн 213-214/

Х.А шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар өгсөн мэдүүлэгтээ: «Би мэдүүлгээ бичгээр гаргасан байгаа, гэхдээ мэдүүлгээ өгч хэлэх зүйлээ хэлээд хавтаст хэрэгт хавсаргах үүднээс өгч байна. Эрхэм хүндэт шүүгчид ээ, өнөөдөр би энэ шүүхийн танхимд та бүхний өмнө үнэн мөнийг 338 хоногийн дараа хоригдсоныхоо эцэст олох байх гэсэн итгэл өвөрлөн зогсож байна. Учир нь 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Авлигатай тэмцэх газрын ажилтнууд намайг саатуулан, улмаар цагдан хорьсноос хойш миний бие болон миний гэр бүл, найз нөхөд, миний хамт олон, Монголд хөрөнгө оруулалт хийсэн хамтрагч нар маань үнэн мөнийг үзсэнгүй. Авлигатай тэмцэх газрын ажилтнууд намайг анх саатуулан цагдан хорихдоо Эрүүгийн хуулийн 263.2 буюу албан тушаалаа урвуулан ашигласан, мөн хуулийн 166¹.2 буюу мөнгө угаасан гэх хэрэгт сэжигтэн яллагдагчаар татан хорьж мөрдөн байцаах ажиллагаа явуулсан. Миний хувьд Монгол Улсын хууль хяналтын байгууллага шалгана гэж байхад шалгуулах үүрэгтэй. ...Хамгийн харамсалтай, асар эмгэнэлтэй нь надад эрүүгийн хэрэг үүсгэн шалгаснаас хойш 5 сар гаруйн дараа анх эрүүгийн хэрэг үүсгэн шалгах болсон зүйл ангиас тэс ондоо асуудал үүсгэн, Авлигатай тэмцэх газар намайг болон манай компанийн хоёр захирал залууг, мөн Газрын тосны газрын дарга асан талийгаач Д.А нарыг эрүүгийн хэрэг үүсгэн, авлига өгсөн, авсан, онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн гэж 269.1, 166.2-т зааснаар хэрэг үүсгэн шалгаж эхэллээ гэсэн. Энэ нь даамжран явсаар, Монголын шилдэг сэхээтнүүдийн нэг урьдчилсан цагдан хорих төвийн өмгөөлөгчтэй уулзахын өмнө хоригдогсод хүлээдэг хүлээлгийн өрөөнд өвчний улмаас зуурдаар нас барсан. ...Өнөөдөр намайг Авлигатай тэмцэх газраас шалгаад, прокурорын байгууллага ялын дүгнэлт үйлдээд яллахаар шүүхэд шилжүүлсэн Эрүүгийн хуулийн хоёр зүйл ангийн хэрэгтэй

холбоотой асуудлаар тайлбар өгөхөөсөө өмнө, 2013 оны 07 дугаар сарын 09-нд анх цагдан хорихдоо надад тулгасан, анх цагдан хорих шалтаг болсон Эрүүгийн хуулийн 166¹.2 болон 263.2 гэсэн зүйл ангийн, мөнгө угаасан болон албан тушаалаа урвуулан ашигласан гэсэн хэрэгт сэжиглэн шалгасан талаар товч тайлбар өгөхийг хүсэж байна. Учир нь энэ хоёр зүйл ангитай холбоотой хэргийг хэрэгсэхгүй болгоогүй, харин энэ хэргээс (201301000029. дугаартай хавтаст хэргийг тусгаарлан) Нийслэлийн Прокурорын газрын хяналтын прокурор О.С-ийн зөвшөөрснөөр 2014 оны 03 дугаар сарын 18-нд тусгаарлан 20140100004. дугаартай хавтаст хэрэг үүсгэсэн. Надад ямар ч мөнгө угаасан хэрэг байхгүй, би тийм хэрэг үйлдээгүй. Би 1990 оноос эхлэн гадаадын аялал жуулчлалын “Ж” компанийн нэр дээр сурч эхэлснээсээ хойш аялал жуулчлалын салбарт тасралтгүй ажилласан. 1997 онд нэр дээр нь суралцаад, улмаар ачигч, орчуулагч, менежер хийж байсан “Ж” ХХК-ийнхаа баруун европын зах зээл хариуцсан суурин төлөөлөгчөөр Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Берлин хотноо томилогдон ажилласан. 2000 оноос өөрөө Герман улсад “MP” компани үүсгэн байгуулаад “Ж” ХХК-тайгаа хамтран ажиллах болсон. 2006 оноос Монголдоо эргэн ирж “Тг, улмаар “Тх” компани үүсгэн байгуулж, хөрөнгө оруулалтын чиглэлээр аялал жуулчлал, барилга орон сууц, зочид буудал, газар тариалан, уул уурхай, ашигт малтмалын эрэл хайгуул хийх зэрэг салбаруудад идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Өөрийн гадаад, дотоодод 15-16 жил ажиллахдаа хуримтлуулсан хөрөнгөөрөө “Т” бүлэг компанийн үндэс суурийг тавьсан. Улмаар гадаадын хөрөнгө оруулагчдыг Монголдоо хөрөнгө оруулалт хийлгэхийг зорин, төсөл бичиж, аялал жуулчлалын салбарт ажиллаж байхдаа олсон мэдлэг чадвар, танилцсан гадаадын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчидтай идэвхтэй ажилласны үр дүнд гадаадаас их хэмжээний хөрөнгө оруулалт, урт хугацаатай зээл олж Монголдоо хөрөнгө оруулалт хийсэн. 2006-2013 онуудын хооронд Холбооны Бүгд Найрамдах Герман улсын шууд хөрөнгө оруулалт, Швейцарын банк бус санхүүгийн байгууллага MOFI-гоос урт хугацааны зээл, Америкийн Нэгдсэн Улсын нэр хүнд бүхий олон улсын хөрөнгө оруулалтын сангийн хөрөнгө оруулалт, Австралийн уул уурхайн

туршлагатай менежментийн компани, Австралийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компани зэргүүдтэй хамтран ажиллаж, Монголдоо нийтдээ 70 гаруй сая ам долларын буюу 100 гаруй тэрбум гадаадын шууд хөрөнгө оруулалт татан ажилласан юм. Үүнээс гадна олон төслийн суурийг тавиад байсан бөгөөд цаашдаа олон зуун сая долларын хөрөнгө оруулалт, олон мянган шинэ ажлын байр бий болгох ажил урьдчилсан байдлаар эхлүүлэн гэрээ хэлцлийг нь хийгээд ажлаа эхлүүлсэн байсан билээ. Энэ бүх ажилд нууж хаах зүйл огт байхгүй. Бүгд ил тод, хийсэн гэрээ хэлцлүүд, банкаар орж гарсан мөнгө бүгд ил байгаа. Мөрдөн байцаагчид үүнтэй холбоотой бүх баримт материалыг намайг баривчлахдаа хурааж авсан. Би аливаа далд үйл ажиллагаа явуулж байгаагүй, бүх ажиллагаа, компаниуд маань ил тод байгаа. Надад хөрөнгө мөнгөө нууж хаасан зүйл байхгүй. Монголд ганц харьцдаг хувийн банкны данстай, орж гарсан мөнгө, гаднаас орж ирсэн хөрөнгө мөнгө нь ямар гарал үүсэлтэй нь бүгд тодорхой. Үүнийг намайг анх хорьж, өнгөрсөн наадмын дараа байцаахад л мөрдөн байцаагчид хэлсэн. Гадаадын хөрөнгө оруулагчид аливаа хөрөнгө оруулалт хийхдээ хэнтэй, ямар хүнтэй хамтрах гэж байна вэ тухайн орны хөрөнгө оруулалтын эрх зүйн орчин ямар вэ гээд маш нарийн шалгаж байж хөрөнгө оруулалтын шийдээ гаргадаг. Миний хувьд эхний хөрөнгө оруулалтын зээлийн гэрээгээ олон жил найз нөхдийн харилцаа холбоотой байсан. Герман хүний дэмжлэгээр хийж байсан бол Америкийн Нэгдсэн Улсын хөрөнгө оруулалтын «First Reserve Corporation»-ны гэрээг хийхийн өмнө намайг асар нарийн шалгаж судалж байж хөрөнгө оруулалтын гэрээг хийсэн гэдгээ хамтрагч нар сүүлд нь надаас нуугаагүй. Энэ нэр хүнд бүхий хөрөнгө оруулалтын сан Монголд анх удаа хөрөнгө оруулалт хийсэн, цаашдаа ч их ажил хийх байсан. Харамсалтай нь намайг Авлигатай тэмцэх газраас шалгаж эхлээд цагдан хорьсон тул манай хамтрагч нар Монгол дахь үйл ажиллагаагаа царцаасан, хэрэг сунжрах тусам одоо бүр зогсоох хандлагатай болоод байна. Энэ бүх хийж байсан ажлууд маань хоосон хардалт сэжиглэлтийн гайгаар нуран унаж байгааг харах асар харамсалтай байна. Ганцхан Австралийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компани үйл ажиллагаагаа энэ хүнд хэцүү үед авч явах гэж чадах ядахаараа мэрийн

ажиллаж байна. Мэдээж Монгол хамтрагчийг нь Авлигатай тэмцэх газраас удаан хугацаагаар цагдан хорьж, шалгаж байгаа нь энэ компанийн бусад хөрөнгө оруулагчдыг үргээж, үйл ажиллагааг нь доголдуулж байгаа нь хэнд ч ойлгомжтой. Намайг анх цагдан хорихдоо Ашигт малтмалын газрын албан тушаалтнуудтай бүлэглэн ашигт малтмалын хайгуулын лиценз цуцлагдах байтал тэдэнтэй хуйвалдан хууль бусаар сунгуулан эзэмшиж байна гэж буруутгасан. Хэдий тийм ч хэн гэдэг албан тушаалтантай хуйвалдан, албан тушаалаа урвуулан ашигласныг мөрдөн байцаагчид одоо болтол надад хэлээгүй. Би төрд ажиллаж үзээгүй. Надад Ашигт малтмалын газрын дарга нартай хуйвалдсан буруу үйлдэл байхгүй. Үүнийгээ ч би мөрдөн байцаагчид анхнаасаа хэлж байсан. Намайг анх цагдан хорьсноос хойш албан ёсоор 7 удаа байцаасан тэгэхдээ ганц л удаа «Т» бүлэг компанийн үйл ажиллагаа, ашигт малтмалын лицензүүдтэй холбоотой байцаалт авсан. Харин 2 дахь байцаалтаас эхлээд нэр бүхий 2 улс төрчидтэй болон тэдний гэр бүлийхэнтэй холбож байцаалт авч эхэлсэн. «Т» бүлэг компанийг би үүсгэн байгуулсан, энд ямар ч улс төрч, тэдгээрийн гэр бүлийнхний хувь оролцоо огтхон ч байхгүй гэдгийг би үргэлж хэлж ирсэн. Энэ бүгд юуг харуулж байна гэхээр, Х.А гэж хэн ч биш, юу ч чадахгүй, хэн нэгний нөмөр нөөлгөөр «Т» гэдэг компани оршин тогтнож байгаа гэсэн хаа нэгтэйгээс эхэлсэн явуулга намайг болон манай хамт олон, найз нөхдийг минь дайрлаа гэж ойлгож байна. Энэ гүтгэлэг, хардлага, энэ хэлмэгдүүлэлт өнөөдөр зогсох байх гэж найдаж байна. Мөнгө угаасан хэрэг байхгүй, учир нь гадаадын хөрөнгө оруулалт Монголдоо авч ирсэн гэж буруутгахгүй биз, албан тушаалаа урвуулан ашигласан хэрэг байхгүй, би улсад ажиллаж байгаагүй, мөн бусадтай хуйвалдаагүй. Ийм учраас надад үүсгэсэн Эрүүгийн хуулийн 166¹.2 болон 263.2 гэсэн зүйл ангиар үүсгэсэн хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэж хичээнгүйлэн хүсэж байна. ...Одоо би прокурорын газрын тосны бүтээгдэхүүн хуваах, газрын тосны хайгуулын ажил явуулах, Нэмэгт-6, Шарга-3 талбайнуудад 2008 оны 8 дугаар сард зарласан олон улсын нээлтэй тендерт ялахын тулд 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр Зайсан дахь 160 м² бүхий, 2 зогсоолтой орон сууц Ц.Ч-ий нэр дээр шилжүүлэн, Газрын тосны газрын дарга асан, 2014 оны

05 дугаар сарын 13-нд харамсалтайгаар 461 дүгээр хорих ангид нас барсан талийгаач Д.А асанд хээл хахууль өгсөн гэх талаар тайлбар хийе. “Тг” ХХК чухам яагаад энэ тендерт орох болсон талаар товч хэлмээр байна. Монгол улсад газрын тосны эрэл хайгуулын ажил 1940-өөд оноос явагдаж байсан байдаг. 1960-аад оны үед Зүүнбаянгийн орчмын газар газрын тосны олборлолт хийж, Зүүнбаян хотод нефть боловсруулах үйлдвэр ажиллаж байсан бөгөөд 1968 онд галын осол тус үйлдвэрт гарснаас хойш тус үйлдвэрийг сэргээгээгүй. Ер нь Монгол улс дахь газрын тосны эрэл хайгуулын ажлыг зогсоосон байдаг. 1990-ээд оны дундаас Монгол улсад газрын тосны хайгуулын ажил эрчимжсэн боловч энэ нь гадаадын 100 хувь хөрөнгө оруулалттай компаниудын хийдэг ажил байв. Барууны компаниуд Засгийн газраас хайгуулын талбай гэрээлж аваад, бага зэрэг ажил хийсний дараа Бүгд Найрамдах Хятад Ард улсын төрийн өмчит компаниудад худалддаг жишиг тогтсон байв. Жишээ нь Дорнод аймагт Америкийн Нэгдсэн улсын Soko international компани бага зэргийн хайгуул хийж байгаад Бүгд Найрамдах Хятад Ард улсын төрийн өмчит «Petrochina» (СМРС)-ийн охин компанид талбайнуудаа зарсан. Мөн Австралийн нэгэн компани Дорноговь дахь талбайгаа Бүгд Найрамдах Хятад Ард улсын төрийн өмчит «Sino Pec»-ийн охин компани «Донг»-д зарсан байдаг. Энэ мэтээр Бүгд Найрамдах Хятад Ард улсын төрийн өмчит компаниуд тэргүүлэн, Монголын газрын тосны нийт 30 орчим талбайгаас 70 гаруй хувийг өөрсдийн мэдэлдээ авсан байдаг. Монголын үндэсний компаниудаас «Пет», «Шун», «МТ», «ЭСЭ», «МАК» компаниуд газрын тосны хайгуулын талбай авснаас ганц «Пет» Лондонгийн хөрөнгийн биржид хувьцаагаа борлуулж хөрөнгө мөнгө босгон газрын тосны хайгуулын ажлыг эрчимтэй явуулах оролдлого хийж ирсэн. «Пет» ХХК-ийн охин компани «Петро»-д одоо 3 талбайд хайгуул хийж байгаа. Тх тэр үед энэ үүсээд байсан орон зайд Монголын бие даасан газрын тосны хайгуулын үндэсний компани шинээр үүсгэн байгуулж, идэвхтэй үйл ажиллагаа явуулахыг эрмэлзэн, энэ салбарын судалгаа хийж эхэлсэн. Улмаар гадаадын хөрөнгө оруулагчидтай урьдчилсан байдлаар тохиролцож, хөрөнгө мөнгө босгож ажиллах бэлтгэлээ хангасан. Дараа нь дотоодын туслан гүйцэтгэгч компаниудтай хэлэлцээр

хийж тендерт бэлдсэн. Уг ажлыг бид 2007 оноос эрчимтэй явуулсан бөгөөд Газрын тосны газраас зарласан сонгон шалгаруулалтад орж Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудын тендерт шалгарсан. Энэ нь манай анхны оролцоод шалгарсан тендер биш, бид өмнө нь Эргэл-12, Төхөм-10 талбайнуудын тендерт оролцоод шалгараагүй. Бид 2009 оны 04 дүгээр сард Шарга-3, Нэмэгт-6 талбайн тендерт шалгарч, Газрын тосны газартай газрын тосны эрэл хайгуул хийх эрх олгох Бүтээгдэхүүн хуваах гэрээг гарын үсэг зурахаар бэлдсэн боловч уг гэрээг тухайн үеийн салбарын сайд Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулаагүй, улмаар Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр ороогүй. Огт батлагдаагүй хэрэгжээгүй гэрээ. Одоогоос 6 жилийн өмнө зарлагдаад манай компани шалгарсан хэдий ч батлагдаагүй, манай компанид ямар ч эрх олгогдоогүй тендерийг сөхөн, авлига хээл хахуулийн хэрэг үүсгэн шалгаж, шүүхэд шилжүүлснийг огт ойлгохгүй байна. Үүнийг би мөрдөн байцаагчид удаа дараа хэлсэн ч огт Х.Арч, хүлээж аваагүй. Энд авлига хээл хахуулийн ямар ч асуудал байхгүй. Би тийм ёс зүйгүй хүн биш. Ухамсартай хөдөлмөр эрхэлсэн цагаасаа бүх хууль тогтоомжийг ягштал биелүүлж ирсэн нэгэн. Прокурор танайх энэ тендерт шалгарахгүй байх байсан, тийм ч учраас тендерт ялахын тулд Ц.Ч-аар халхавчилж, үнэтэй орон сууцаар хээл хахууль өгч байж ялсан гэж ойлгуулах гэж байх шиг байна. Энд ялсан, өөрт ашигтай байр суурь үүсгэсэн юм огт байхгүй. Яагаад гэдгийг би маш энгийнээр, гэхдээ хавтаст хэрэгт байгаа нотлох баримтад тулгуурлан тайлбарлая. Би манай компани яагаад уг тендерт ялсны хариуг энэ хавтаст хэрэгтэй танилцаж байхдаа баримттайгаар ойлгосон. Өмнө нь манайх сайн санал өгсөн болоод шалгарсан гэж бодож явсан бол хавтаст хэрэг дотор яагаад гэдгийн хариу бэлээхэн ил байсан. Т-гээс Газрын тосны газарт өгсөн санал Монгол улсад хамгийн ашигтай санал өгсөн тул өндөр оноо авч, уг тендерт шалгарсан байна гэдгийн баталгаа энэ хавтаст хэрэг дотор байгаа. 7 дугаар хавтаст хэргийн 177 хуудсанд 2008 оны 2 дугаар сарын 14-ний Үйлдвэр худалдааны сайдын 33 дугаар тушаал байгаа. Энэ нь бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмыг хавсралтын ёсоор баталсугай гэсэн Х.Н сайдын тушаал. Уг журамд газрын тосны хайгуулын талбайн

тендерт оролцож буй захиалагчдын саналыг Газрын тосны газрын Үнэлгээний хороо хэрхэн үнэлэх, Сонгон шалгаруулах зөвлөл хэрхэн үнэлж дүгнэх бүгд нэгд нэгэнгүй заасан байна. Уг журмын 8.3-т сонгон шалгаруулалтад хамруулсан захиалгыг үнэлгээний үзүүлэлтийн ач холбогдлоор нь үндсэн үзүүлэлт 1, туслах үзүүлэлт 2, дэд үзүүлэлт 3 гэсэн 3 үзүүлэлтээр үнэлнэ. Уг журмын 8.4-т Үнэлгээний хороо нь захиалагчийн ирүүлсэн захиалга, холбогдох баримт, бичгийг хянан үзэж үнэлэх, харьцуулах ажлыг гүйцэтгэсэн санал дүгнэлтээ илтгэх хуудсаар сонгон шалгаруулах зөвлөлд ирүүлнэ. Сонгон шалгаруулах үнэлгээний үндсэн үзүүлэлт нь Монгол Улсын байгалийн нөхөн сэргээгдэшгүй баялгийг ашигласан төлбөр Рояалти, бүтээгдэхүүний хуваалт, нөхөх зардлын хувь хэмжээ, энэ нь хасах үзүүлэлт байна. Мөн журмын 8.6-д шаардлагад нийцсэн захиалгыг 8.3-т заасан үзүүлэлтийг харгалзан Үнэлгээний хорооны гишүүн бүр үзүүлэлт тус бүрээр оноо өгөх ба гишүүдийн өгсөн онооны дундаж дүнгээр байр эзлүүлнэ. Үнэлгээ өгөхдөө үндсэн үзүүлэлтийг 3, туслах үзүүлэлтийг 2, дэд үзүүлэлтийг 1 гэсэн коэффициентээр үржүүлнэ гэж заажээ. Мөн журмын 8.7-д Үнэлгээний хороо санал дүгнэлтээ илтгэх хуудас үйлдэн Сонгон шалгаруулах зөвлөлд өгнө. Сонгон шалгаруулах зөвлөл хуралдаад зөвлөмжөө Эрдэс баялаг, эрчим хүчний яаманд явуулна. Яамны сайд бүтээгдэхүүн хуваах гэрээг Монгол Улсын Засгийн газрын хурлаар батлуулна. Баталсан гэрээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөл ахин хэлэлцэж, батлаад Засгийн газарт буцааж өгнө. Засгийн газар яаманд өгнө. Энэ бүх процессийн эцэст яамнаас Газрын тосны хайгуулын талбайд эрэл хайгуулын ажил явуулахыг баталгаажуулсан лиценз олгоно. Энэ олон шат дамжлагын дараа сонгон шалгаруулалтад оролцсон аж ахуйн нэгж хайгуулын ажлаа эхэлнэ. Одоо эргээд Газрын тосны газрын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад зарласан сонгон шалгаруулалтад ямар компаниуд оролцов, ямар санал Монгол Улсын Засгийн газарт өгснөөр ямар оноо авав гэдгийг товч дурдая. Үнэлгээний хорооны үнэлгээгээр Нэмэгт-6 талбай дээр Тг үндсэн үзүүлэлт 690, туслах үзүүлэлт 476.90, дэд үзүүлэлт 285, нийт 1451.90 оноогоор 1 дүгээр байр, «ЛЧ» ХХК болон «Н се» ХХК хамтарсан концерциум

үндсэн үзүүлэлт 240, туслах үзүүлэлт 361.80, дэд үзүүлэлт 280.40, нийт 882.20 оноогоор 2 дугаар байр, Үнэлгээний хорооны үнэлгээгээр Шарга-3 талбай дээр Тг үндсэн үзүүлэлт 690, туслах үзүүлэлт 476.90, дэд үзүүлэлт 285, нийт 1451.90 оноогоор 1 дүгээр байр, «ЛЧ» ХХК болон «Н се» ХХК хамтарсан концерциум үндсэн үзүүлэлт 240, туслах үзүүлэлт 362.20, дэд үзүүлэлт 280.40, нийт 883.20 оноогоор 2 дугаар байр, Бүгд Найрамдах Польш улсын «РСМС» үндсэн үзүүлэлт 333, туслах үзүүлэлт 160, дэд үзүүлэлт 323.70, нийт 816.70 оноогоор 3 дугаар байр тус тус эзэлсэн байна. Одоо ямар санал Т-гээс Газрын тосны газарт өгснөөр сая хэлсэн оноог авч, сонгон шалгаруулалтад Үнэлгээний хороо болон Сонгон шалгаруулах зөвлөлөөс уг сонгон шалгаруулалтад түрүүлж 1 дүгээр байр эзэлсэн бэ гэдгийг хэлье. Газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Тг бүтээгдэхүүн хуваах гэрээний битүүмжилсэн саналдаа таван жилд нэг талбайд 46.930.000 ам долларын хайгуулын ажилд хөрөнгө оруулахаар тусгасан. Энэ нь хүндийн хүчний хайгуул 1000 м2 хийх, 2 хэмжээт чичирхийлэл 1500 тууш км, 3 хэмжээст чичирхийлэл 800 км2, хайгуулын өрмийн цооног 20 ширхэг өрөмдөх гэж тусгасан байна. Тг бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцлүүдэд доорхи санал өгсөн байна. Нэгдүгээрт, бүтээгдэхүүн хуваах өдрийн дундаж гарц өдөрт 0-5000 баррельд Засгийн газар 45%, гэрээлэгч 55%, 5001-10000 баррельд Засгийн газар 50%, гэрээлэгч 50%, 10001-15000 баррельд Засгийн газар 55%, гэрээлэгч 45%, 15001-20000 баррельд Засгийн газар 60%, гэрээлэгч 40%, 20001-ээс дээш баррельд Засгийн газар 65%, гэрээлэгч 35%, хоёрдугаарт, рояалти 12,5%, гуравдугаарт өртөг нөхөлт 35%. Эдгээр нь 1 дүгээр хавтаст хэргийн 217 дугаар хуудсанд байгаа ажлын хэсгийн тэмдэглэлд, 1 дүгээр хавтаст хэргийн 236 дугаар хуудсанд "Тг-ын Газрын тосны газрын ажлын хэсэгтэй хэлэлцээр хийхдээ рояалти 9% байсныг 12,5% болгосон, өртөг нөхөлт 40% байсныг 35% болгосон, мөн хөрөнгө оруулалтын хэмжээг анхны санал 46.750.000 ам доллар байсныг 46.930.000 ам доллар болгосон гэж өгчээ. Гэтэл өрсөлдөгч сонгон шалгаруулалтад Нэмэгт-6 талбайд 2 дугаар байранд орсон, Шарга-3 талбайд мөн 2 дугаар байранд орсон «Нсе», «П ЛЧ» компанийн үндсэн нөхцлүүд нь 8 дугаар хавтаст хэргийн 234 дүгээр хуудсанд байгаа.

Нэмэгт-6 талбайд роялти 6,1%, өртөг нөхөлт 30%, бүтээгдэхүүн хуваалт 0-5000 баррельд Засгийн газар 35%, гэрээлэгч 65% гэж эхлээд 20001-25.000 баррельд Засгийн газар 50%, гэрээлэгч 50%. Энэ нь “Тг-ын өгсөн саналтай хол зөрүүтэй байгаа. Засгийн газрыг дэмжих сан, орон нутгийг дэмжих санд санал өгөөгүй. Ажлын 5-н жилийн хөрөнгө оруулалтын санал нь 8 дугаар хавтаст хэргийн 242 дугаар хуудсанд байгаа. Нийт 5-н жилд 24.880.000 ам доллар зарцуулах, анхны санал нь 21.120.000 ам доллар байсан байна. Энэ нь манай өгсөн хөрөнгө оруулалтын сангаас даруй 20 гаруй сая ам доллараар бага байгаа. Мөн энэ компани Шарга-3 талбайд, энэ нь 9 дүгээр хавтаст хэргийн 005 дугаар хуудсанд байгаа, роялти 8%, өртөг нөхөлт 30%, өдрийн бүтээгдэхүүн хуваалт 5000 баррель байвал Засгийн газар 40%, гэрээлэгч 60% байхаар эхлээд 30000 баррель байвал Засгийн газар 50%, гэрээлэгч 50% гэж санал өгсөн байна. Ажлын хөтөлбөр нийт 5 жилд 25.000.000 ам доллар санал болгосон байна. Харин Бүгд Найрмадах Польш улсын РСМС компани бүтээгдэхүүн хуваах Шарга-3 талбайд санал өгөхдөө 8 дугаар хавтаст хэргийн 218-аас 223 дугаар хуудсанд байгаа. Роялти 3%, өртөг нөхөлт 40%, бүтээгдэхүүн хуваалт 0-5000 баррельд Засгийн газар 20%, гэрээлэгч 80%, Польшийн компани 80% авах нь байна. Ингэж явсаар байгаад 50000-аас дээш байвал Засгийн газар 50%, гэрээлэгч 50%, байгалийн хий олборлох тохиолдолд Засгийн газар 10% гэрээлэгч 90%, ажлын хөтөлбөр нийт 5-н жилд 4.984.000 ам доллар гэж санал өгчээ. Энэ нь манайхаас даруй 10 дахин бага санал. Газрын тосны газрын ажлын хэсэгт РСШС компанид хэлэлцээрийн явцад ажлын хөтөлбөр доод тал нь 20.000.000 ам доллар байхаар төлөвлөх шаардлагатай гэж санал болгосон ч РСШС компани саналаа өөрчлөөгүй юм байна. Эндээс юу маш тодоор харагдаж байна вэ гэхээр газрын газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудын бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах сонгон шалгаруулалтад манай «Т» компани үнэн шударгаар шалгарсан нь ямар ч эргэлзээгүй. Үүнийг нотлох баримт харуулж байна. Өрсөлдөгчөөсөө хамаагүй илүү санал Монгол Улсын Засгийн газарт санал болгосноороо сонгон шалгаруулалтад шалгарчээ. Бүтээгдэхүүн хуваах гэрээг Эрдэс баялаг эрчим хүчний сайдын хуучнаар

Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 33 дугаар тушаалаар бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журам, журмын аргачлалд зааснаар ямар ч хүн сонгон шалгаруулалтын оноог бодоход Тг ялагчаар тодрох нь ойлгомжтой байна. Тг аль аль талбайд өрсөлдөгчөөсөө илт давуу санал өгчээ. Ийм бодит нотлох баримт, материал хавтаст хэрэгт илхэн байхад яагаад Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч, Нийслэлийн хяналтын прокурор нар ойшоохгүй, шалгахгүй шүүхэд шилжүүлэв. Сангийн яамнаас томилогдсон төсвийн бодлого төлөвлөлтийн газрын мэргэжилтэн, мэргэжлээрээ 2 дахь жилдээ ажиллаж байгаа гэж гэрчийн байцаалт өгсөн С.Т, Авлигатай тэмцэх газрын тоотын дагуу Газрын тосны газрын бүтээгдэхүүн хуваах гэрээнд гэрээлэгчийг сонгон шалгаруулах ажиллагаанд шинжээчээр томилогдон, шинжээчийн 2 хуудас дүгнэлт гаргахдаа энэ бүгдийг анхаараагүйд асар их гомдолтой байна. Д.Г-ийн Г.Т Авлигатай тэмцэх газарт 2014 оны 03 дугаар сарын 26-нд гэрчээр байцаалт өгөхдөө ажлын хэсгийнхний дунд “Тг” ХХК-ийг Д.Т сайдтай холбоотой компани гэж ярьж байсан гэсэн байх жишээтэй. Ийм цуу яриагаар хүн яллахгүй байх гэж би гүнээ найдаж байна. Бас нэг Газрын тосны газрын ажилтан байцаалт өгөхдөө “Тг” ХХК-ийг Ерөнхийлөгч асан .Н.Э-ын эхнэр О.Ц-ийн компани гэж нэг нь ярьж байсан гэсэн байсан. Ийм цуу яриа яллах дүгнэлтийн суурь болохгүй байх гэж найдаж байна. Иймэрхүү цуу яриа Монголоор нэг байдаг. Ийм цуу яриа л энэ хавтаст хэрэгт манай эсрэг мэдүүлэг болон орсныг хавтаст хэрэгтэй танилцаад ойлголоо. Авлигатай тэмцэх газраас дуудагдаад гэрчийн байцаалт өгөхдөө хүмүүс айж сандардаг юм байна.

Мэдэхгүй, санахгүй байна, “Тг” сонгон шалгаруулалтад ялахгүй байсан байх гэсэн гэрчүүдийн мэдүүлэг байсан. Ганцхан Газрын тосны газрын ажилтны мэдүүлэгт миний хариуцсан чиглэлийн хувьд боломжтой гэж үзсэн гэж хавтаст хэрэгт байсан. Гэтэл яагаад салбарын сайдынхаа баталсан бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмыг аваад, сонгон шалгаруулалтад оролцсон компаниудын эцсийн битүүмжилсэн саналыг аваад оноог хэн нэгэн ахин бодож үзсэнгүй вэ. Энэ бүгд асар харамсалтай бөгөөд эмгэнэлтэй байна. Энд би бас нэг зүйл нэмж хэлэхийг хүсэж байна. Уг бүтээгдэхүүн хуваах гэрээгээр

улсаас ганц ч төгрөг гардаггүй, захиалагч компани 100 хувь эрсдэлээ дааж хайгуул хийгээд, газрын тос олдвол бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу олборлолт явуулна. Миний өмгөөлөгчид энэ бүтээгдэхүүн хуваах гэрээний сонгон шалгаруулалтын талаар хэрэгжээгүй, батлагдаагүй тендер тул их юм яриад хэрэггүй гэж зөвлөсөн. Гэвч энэ илт зохиомол гүтгэлэг, хардлагын хор уршигаар өнөөдөр Монголын шилдэг сэхээтнүүдийн нэг, халуун эх оронч, Газрын тосны салбарын хөгжилд маш их хувь нэмэр оруулсан, Газрын тосны газрын дарга асан Д.А-ны алтан амь эрсдээд, түүний ар гэр, үр хүүхэд, найз нөхөд нь, салбарынхан нь тайлагдашгүй уй гашууд автаад байна. Би энэ бүгдийг нэг бүрчлэн ярьж та бүхний цагийг авахдаа энэ эрхэм хүний сайн нэрийг энэ шүүхийн танхимд сэргээх байх, энэ хардлага гүтгэлэг шүүхийн шийдвэрээр зогсох байх гэж гүнээ найдаж энэ бүхнийг ярьж байгаа билээ. Одоо Ц.Ч-д хөнгөлттэй нөхцөлөөр зарсан орон сууцны талаар тайлбар өгье. Энд хээл хахууль далдалсан ямар ч асуудал байхгүй. Манай Монгол Улс хүн ам багатай. Хүн ам багатайгаас үүдээд бизнес эрхэлж байгаа хэнд ч чадалтай, боловсролтой боловсон хүчний асуудал байнга тулгардаг. Өндөр боловсролтой чадварлаг боловсон хүчинтэй боллоо гэхэд тэднийгээ ажлын дадлага туршлагатай болгох асуудал үүсдэг. Цаашлаад чадалтай, туршлагатай боловсон хүчнээ яаж тогтвор суурьшилтай ажиллуулах вэ гэсэн дараагийн толгойны өвчин бизнес эрхэлж байгаа ямар ч хүнд тулгардаг. Энэ бол зөвхөн бизнесийн салбарынхны асуудал биш гэдгийг бүгд мэднэ. Би бизнес эрхэлж байх өнгөрсөн хугацаанд боловсон хүчний асуудал маш чухал гэдгийг эрт ойлгосон. Аливаа залуу ажилтан жаахан туршлага суугаад, чадваржаад эхлэх дээр нь компаниуд өндөр цалин хангамжаар татаад аваад явчихдаг, ард нь үлдэж байгаа компани хүний нөөцийн хямралд ордог. Энэ бол зөвхөн уул уурхай, ашигт малтмалын эрэл хайгуулын салбарынхны толгойны өвчин биш. Аль ч салбарт энэ асуудал байдаг. Иймээс би өөрийн компанидаа чадварлаг боловсон хүчин яаж татах вэ, тэдгээр ирсэн залуусаа яаж тогтвор суурьшилтай ажиллуулах вэ хэмээн удаан бодсоны эцэст цалингаар бусадтай уралдаж дийлэхгүй юм байна. Хүмүүстээ хөрөнгө оруулалт хийе. Иймээс эхлээд боловсон хүчний цөмөө байртай болгоё. Тэд маань энэ компанийн

анхдагч цөм болно. Цаашлаад боломж гармагц шат дараалан бүх ажилчидаа байр сууцтай болгоё гэсэн зорилт тавьсан. Үүнийгээ ч өөрийн менежментийн багийхантайгаа нээлттэй ярилцаж, бодол саналаа солилцдог байсан. Хэдэн залуу байртай болоод тохь тухтай амьдраад эхлэхээр бусад нь мөн урамшиж, удахгүй бид байр сууцтай болох юм байна гэсэн итгэл төрж байсан. Би Тх компаниа байгуулсан цагаасаа энэ бодлоо тээж явсан. Боллоцооны хирээр эхний 7 ажилтандаа байр олгосон байсан. 2013 онд дахиад 5-6 хүн байртай болгоно гэж зорьж байсан. Байр одоогоор өгч чадахгүй бол унаатай болгох гэж санаа тавьж байсан. Тиймдээ ч манай компанид залуучууд тогтвор суурьшилтай ажилладаг. Манай боловсон хүчний урсгал харьцангуй бага. Би бүх ажилчдынхаа нийгмийн асуудалд анхаарал тавихыг эрмэлзэж ирсэн. Ажилчдаа үргэлж сурч боловсрохыг нь дэмждэг, хэрэв дээд сургууль төгсөөгүй бол суралц, боловсролтой бол, дээд сургууль төгссөн нэгнийг давхар мэргэжил эзэмш, хэрэв хүсвэл сургалтын төлбөрийг чинь компаниасаа гаргана гэж бүгдэд нь хэлдэг байсан. Энэ боломжуудыг ч манай хамт олон сайн ашигладаг байсан. Тэдний нэг нь Ц.Ч юм. Ц.Ч-тай би Германд сурч байх үеэс нь танилцсан. Би цаг үргэлж чадалтай боловсролтой Монгол залуусыг олж компанидаа ажиллуулах юмсан гэж бодож явсан. Хөрөнгө оруулагчид аливаа төслийг шинжихдээ менежментийн баг нь ямар вэ гэсэн үндсэн шалгуур тавьдаг. Чадалтай, туршлагатай менежментийн баг бүрдүүлэхийн тулд би гадаадын туршлагатай мэргэжилтнүүдийг гэрээгээр компанидаа ажиллуулж үзсэн. Тэд маш өндөр цалин хангамж шаарддаг. Тэдний нэгнийх нь жилийн цалин хангамжаар би 3-4 Монгол залууг байр сууцтай болгочих юм байна шүү дээ гэж ойлгосон. Ийм л бодолд хөтлөгдөн би компанийнхаа цөм болох багийг байр сууцтай болгоё гэж хичээсэн. Мэдээж хүн хүнээсээ шалтгаалаад арай өөр өөр нөхцөлөөр тохироод явж байсан. Жишээ нь энд суугаа Н.О «Т» компанийг байгуулсан цагаас хамт ажилласан. Энэ залуу маань сайхан байртай болсон, машинтай болсон. Манайд менежер хийдэг н.Б, геологичоор ажилладаг н.Х, н.Г, н.Э, компьютерийн сүлжээний менежер н.Ц нар бүгд байртай болсон. Би Ц.Ч-ийг Хас банкинд салбарын захирал хийж байхад нь тухайн үед гадаад

захирал байрлуулахаар авсан байсан орон сууцаа хөнгөлөлттэй нөхцөлөөр зарахаар тохироод, улмаар байрыг Ц.Ч-д шилжүүлсэн. Н.О, Ц.Ч хоёрт байр өгөхдөө би гэрээ хийгээгүй. Салбар хариуцаад явж байгаа залуучуудтай би орон сууцтай болголоо гээд гэрээ хийе гэж бодоогүй. Энэ нь миний хувьд хувь хүмүүсийн хоорондын харьцаа, итгэлцэл. Энэ итгэлцэл дээр тулгуурлаж бидний ажил явдаг. Цаашдаа ч явна гэж найдаж байгаа. Энэ асуудал үүсгээд байгаа орон сууцнаас гадна Ц.Ч сайн машин компаниасаа авсан. Тэр машин мөн л Ц.Ч-ий нэр дээр байгаа. Энэ хээл хахууль гээд байгаа орон сууц бас Ц.Ч-ий нэр дээр байгаа. Энэ бүгдийг нотлох баримт хавтаст хэрэгт байгаа. Энд будлих, хардах сэрдэх, хэрэг үүсгэх шаардлага юунд байв гэсэн бодол өнгөрсөн хугацаанд миний толгойд эргэлдэж байсан. Харамсалтай нь бусад залуучуудад өгсөн байрыг энэ хэрэгтэй холбоотой гээд битүүмжилсэн байгаа. Хэрэв энэ хэрэг буруугаар эргэвэл миний хамт ажилладаг залуусын хувьд тэр залуучууд ч гэсэн байргүй болно гэсэн айдас надад үүссэн байна. Хийгээгүй хэргийн төлөө ял тулгаж, хэлмэгдүүлдэг цаг аль дээр өнгөрсөн гэдэгт итгэлтэй байна. Монгол Улс ардчилал, хүний эрхийг дээдлэх замд эргэлт буцалтгүй ороод 25 жил болох гэж байна. Би 2014 оны 05 дугаар сарын 13-ны өдөр 461 дүгээр хорих ангийн шалган нэвтрүүлэх байрны нэг давхарт өмгөөлөгчтэй уулзахын өмнө хоригдогсод хүлээдэг төмөр торон чулуун шалтай хүлээлгийн өрөөнд ухаан алдаад унасан нөхрийнхөө толгойг түшээд Ц.Ч-ий хамт эмч ирэхийг хүлээгээд шалан дээр өвдөглөн сууж байхдаа үгээр илэрхийлж барахгүй бухимдал, гомдолд автсан. Үгээр илэрхийлэхэд бэрх уй гашуу, гарз учирлаа. Тэр өдөр унаад босож ирээгүй андыг минь хэн ч босгож чадахгүй. Гэхдээ шударга хараат бус шүүх өнөөдөр үнэн мөнийг олж өгнө гэдэгт итгэлтэй байна. Талийгаачийн нэрийг цаашид сэвтүүлэхгүй гэдэгт итгэлтэй байна. Учир нь энд хийсэн хэрэг, буруу үйлдэл гэж байхгүй. Бүх нотлох баримт энэ 16 хавтаст хэрэг дотор байгаа. Энэ 16 хавтаст хэрэгтэй 2014 оны 04 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлээд 04 дүгээр сарын 14-ний 15.00 цаг хүртэл хагас бүтэн сайн алгасалгүй танилцсан. Би хуульч, эрх зүйч мэргэжилгүй. Гэхдээ би боловсролтой иргэн хүний хувьд биднийг буруутгаад байгаа хэргийг цагаатгах нотлох баримт чинь энэ 16

хавтастай баримт юм байна гэсэн итгэл үнэмшилтэй болсон. Үүнийгээ би та бүхэнтэй хуваалцаж байна. Талийгаач Д.А-ны шударга нэр төр өнөөдөр энэ шүүхийн танхимд сэргээгдэнэ гэдэгт итгэлтэй байна. Би анх 2013 оны 07 дугаар сарын 09-нд хоригдсоноос хойш 338 хоног энэ өдрийг хүлээсэн. Учир нь мөрдөн байцаагч дээрээс чигтэй тул би хоригдсоор, прокурор дээрээс чигтэй тул би хоригдол хэвээр. Дээрээс чигтэй, дэрээс чигтэй тул гэсээр өнөөдрийг хүрлээ. Уршгаар нь Монгол хүмүүс хохироод байна. Монгол нутгийн маань хөгжил хойшлоод байна. Монгол хүний амь нас эрсдээд байна. Миний хувьд, миний гэр бүл, үр хүүхдүүдийн хувьд, миний найз нөхөд, тэдний гэр бүл, үр хүүхдүүдийн хувьд, манай хамт олны хувьд надад итгээд Монголд хөрөнгө оруулалт хийсэн хөрөнгө оруулагчдын хувьд дээшээ тэнгэр хол, доошоо газар хатуу болоод 338 хоног болж байна. Өнөөдөр намайг болон надтай хамтран зүтгэж ирсэн залуучуудыг яллаваас өнөөгийн Монголд хэн ч айдас хүйдэсгүй бизнес эрхэлж болохгүй юм байна гэж Монголчууд ойлгоно, дэлхий даяараа ойлгоно гэдгээс эмзэглэж байна, эмээж байна. Олоогүй орлогоос намайг яллахгүй байх, хэрэгжээгүй сонгон шалгаруулалтаас үүдэн хээл хахуулийн хэрэг тулгаж яллахгүй байх. Өнөөдөр хэрэг хийгээгүй учир надад айдас алга. Харин ардчилсан Монгол Улсын шударга, хараат бус, гагцхүү хуульд захирагдах шүүх үнэн мөнийг олж өгнө гэсэн итгэл байна. Энэ бүхнийг харгалзаад анхнаасаа ямар ч хэрэг байхгүй юм байна гэдгийг харгалзаад шүүхэд энэ хэргийг хэрэгсэхгүй болгож өгнө үү гэж гүнээ хүсэж байна. Хэрэгжээгүй тендер гэж би ярьж байгаа. Энд Газрын тосны газраас 2013 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Дүүргийн Эрүүгийн хэргийн 2 дугаар шүүхэд хандан Газрын тосны албаны дарга н.Ө-гийн явуулсан албан тоот байна. “Тг” ХХК-аас 2014 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/303 албан тоотоор манай газарт хүсэлт гаргасан байна. Тг ХХК 2008 онд газрын тосны хайгуулын Нэмэгт-6, Шарга-3 талбайд бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах гэрээлэгчийн сонгон шалгаруулалтад оролцож шалгарсан болно. Улмаар газрын тосны газраас бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг 20090826./747 тоотоор Эрдэс баялаг, эрчим хүчний яаманд хүргүүлсэн. Одоогоор энэ 2 талбайд байгуулах бүтээгдэхүүн хуваах

гэрээний төсөл Монгол Улсын Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцэгдээгүй, гэрээ байгуулагдаагүй болно гэсэн албан тоот байна. Та бүхэнд хүрсэн байх гэж найдаж байна” гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Гэрч Г.Т-гийн шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар өгсөн мэдүүлэгтээ «...Би Х.А захирлыг ажил хэргийн шугамаар танина. Би Газрын тосны газарт гэрээлэлтийн хэлтэст мэргэжилтэн, ахлах мэргэжилтэн, улмаар хэлтсийн даргаар ажиллаж байсан. 2009 оны 01 дүгээр сар хүртэл ажилласан. Тг намайг байх 2009 оны 01 дүгээр сар хүртэлх хугацаанд Эргэл-12, Төхөм-10 гэсэн 2 талбайд захиалгын материал ирүүлж байсан. Энэ 2 талбай дээр миний бие ажлын хэсгийн гишүүнээр мөн ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байсан. Тухайн ажлын хэсгийн үүрэг бол тухайн компанид тодорхой хэмжээгээр дэмжлэг үзүүлэх, эргээд нөгөө тухайн материал захиалга өгсөн заагдсан хугацаанд зохих төвшинд материалыг нь бүрдүүлэх зохих арга зүйн туслалцаа үзүүлэх үндсэн үүрэгтэй. Энэ шугамаар миний бие ажлын хэсгийн гишүүнээр ажиллаж байхдаа удаа дараа уулзаж байсан. Би 2 удаа мөрдөн байцаагчтай уулзсан. 2013 оны 12 дугаар сарын 27-ны өдөр, сүүлд 2014 оны 03 дугаар сарын сүүлээр өдрийг нь сайн мэдэхгүй байна, уулзсан. Эхний удаа дэлгэрэнгүй мэдүүлэг авсан. Сүүлийн удаа зөвхөн 2 асуудлын хүрээнд тойрч их олон асуудлаар мэдүүлэг авсан. Шууд утгаараа ямар нэг дарамт үзүүлсэн зүйл байхгүй. ...Ажлын хэсэгт тодорхой заасан хугацаа байдаг тэр заасан хугацаанд захиалга өгсөн компанитай хэлэлцээр хийж ажиллах үүрэгтэй. Эргэл-12 талбайн хувьд 6 жилийн өмнөх асуудал байгаа. Миний хувьд эргээд санахын тулд өөрийн тухайн үед хийж байсан ажлын хэсэг хуралдаж байсан илтгэх хуудастай танилцаж байж сэргээсэн. 6 жилийн өмнөх материалаа үзэхэд тухайн компанийн хувьд Газрын тосны хуулийн дагуу гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын дагуу 3 шалгуур үзүүлэлтээр шалгаруулдаг. Үүнд нэгдүгээрт үндсэн шалгуур, хоёрдугаарт туслах зүйл, гуравдугаарт дэд бүлэг гэсэн энэ 3 үндсэн үзүүлэлтүүд нь бүтээгдэхүүн хуваах гэрээтэй холбоотой, 2 дахь туслах үзүүлэлт нь тухайн компанийн хөрөнгө санхүүгийн чадавхийг, техник тоног төхөөрөмжийн хувьд бололцоотой, чадалтай, хүний нөөцийн хувьд чадалтай, туршлагатай эсэхийг

нь тогтоох үзүүлэлтүүд байдаг. Эргэл-12 талбайд Тг компани шалгарч чадаагүй, бусад хамт оролцсон компаниудыг бодвол шалгаруулалтад доогуур үзүүлэлттэй байсан болохоор шалгараагүй. Монголын нийтлэг компаниудын хувьд газрын тосны салбар шинэ салбар. Дөнгөж анхдагч компаниуд орж ирсэн. Эдгээрийн нэг нь “Тг” компани байгаа. «ЭСЭ», «МАК», «МТ», «Пет» зэрэг компаниуд анх газрын тосны хайгуулын захиалга өгч байсан. Эдгээр компаниудын сул тал гарааны нөхцөл нь гадны компаниудыг бодоход сул байдаг. Боловсон хүчний хувьд сул талтай. Туслах үзүүлэлтээс туслан гүйцэтгэгч компанитай хийсэн гэрээ дутуу хангалтгүй төвшинд байна, тухайн хийх ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргах шаардлагатай байна гэсэн хүсэлтийг ажлын хэсгийн зүгээс тавьсан. Нэмэлт материал бүрдүүлэлт хийгээд түүнийгээ үнэлүүлэх асуудал нь Үнэлгээний хороонд хамааралтай байдаг. Энэ талаар арга зүйн зөвлөгөө өгч байсан. ...Би өмнөх материалаа үзэж байхад туслан гүйцэтгэгч компани ирэх 5 жилийн хугацаанд бид туслан гүйцэтгүүлэхээр ийм гадны компанитай гэрээ хийнэ гэсэн нөхцөл нь хангалттай бус, гэрээ эх хувиараа байгаагүй, эсвэл тамга тэмдэг нь дутуу байсан гэсэн иймэрхүү зөрчлүүд байсан. Түүнээс биш бүрдүүлэлт бол байсан. ...Өөрт байгаа архив материалаа үзэхэд Эргэлт-12 талбайтай холбоотой материал байсан. Нэмэгт-6, Шарга-3 талбайн хувьд 2009 оны 01 дүгээр сард би ажлаа өгсөн. Өөр ажилд томилогдсон. Тухайн үед дөнгөж ажлын хэсэг байгуулагдаад материал өгсөн байсан. ...Цаг хугацааны хувьд 10 дугаар сараас 1 дүгээр сар хүртэл материалтай танилцсан. Гэхдээ ажлын хэсэг ажиллах хугацаа дуусаагүй байсан. Ажлын хэсгийн ахлагчийн ажлыг би өөр ажилд томилогдох болсонтой холбоотойгоор өөр хүнд шилжүүлж өгсөн. ...Өнөөдрийн хувьд Нэмэгт-6, Шарга-3 материалыг хайгаад дахиж үзэх гээд чадсангүй. Тийм учраас 12 дугаар сард тийм мэдүүлэг өгсөн бол тухайн үед үзсэн материал байх...Мэдүүлгийг би хувилж авч үлдээгүй. Үг, үсэггүй санахгүй байна. Тухайн үед мэдүүлгээ өгөөд гарын үсгээ зурсан. ...Улсын яллагчийн асуулт: Таны мөрдөн байцаалтын шатанд өгсөн мэдүүлэг үнэн үү? гэхэд Гэрчийн хариулт: Үнэн. ...Улсын яллагчийн асуулт: Нэмэгт-6, Шарга-3 талбай дээр сонгон шалгаруулалт зарлаад та ажлын хэсэгт ажиллаж байхад, таныг ажлаа

өгөхөөс өмнө танай ажлын хэсэг хуралдсан уу? гэхэд Гэрчийн хариулт: Ажлын хэсэг хуралдсан. ...Улсын яллагчийн асуулт: Таныг ажлын хэсэгт ажиллаж байхад “Тг-ын хувьд ямар нэг байдлаар гуйж асууж байсан зүйл байна уу? гэхэд Гэрчийн хариулт: Тийм зүйл байхгүй. ...Мөрдөн байцаалтын шатанд эхний удаа бүх дэлгэрэнгүй мэдээлэл авсан. Сүүлд 2 зүйлд асуусан бараг 2 цагийн хугацаанд байцаалт авсан. “Тг-ын зүгээс танд дарамт шахалт үзүүлж байсан уу, танай удирдлагуудын зүгээс дарамт шахалт үзүүлж байсан уу гэж асууж байсан. Дарамт шахалт байгаагүй. ...Тухайн үед намайг ажиллаж байхад ажлын хэсэг яг агентлагийн даргын тушаалаар байгуулагддаг. Ажлын хэсэг болон Үнэлгээний хороо байдаг. Хамгийн эхлээд тухайн компани материалаа агентлагт өгнө. Түүний дагуу эхний байдлаар үнэлэлт дүгнэлт хийгээд ажлын хэсэг гаргая гэсэн тушаал гаргадаг, ажлын хэсэг тухайн материал дээр ажиллаад хичнээн компани материал ирүүлсэн байна тухайн компани бүр дээр хүмүүсээ томилоод эргээд компани тус бүртэй хэлэлцээр хийгээд зохих төвшинд хуулийн хүрээнд материал бүрдүүлэхэд нь арга зүйн дэмжлэг туслалцаа үзүүлж ажилладаг. ...Ажлын хэсэг 2008 онд байгуулагдсан. Хуулийн хүрээнд агентлагийн даргын тушаалаар ажлын хэсгийн ахлагчаар томилогдож ажилласан. 1 дүгээр сард миний бие ажлаа өгсөн. Ажлын хэсэг надаас хойш 14 хоног ажилласан байх ёстой. ...Шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуулт: Шарга-3, Нэмэгт-6 талбай дээр ажлын хэсгийн ахлагч байж байгаад явцын дунд өөр ажилд орсон гэж байна. Тэгэхээр өнөөдөр таны дараа шалгарсан Шарга-3, Нэмэгт-6 талбайд эцсийн шалгаруулалт болсон, болоогүй гэж яригдаж байгаа энэ асуудалд эцсийн үр дүнд Тг компани шалгарах боломжтой байсан, боломжгүй байсан гэдэгт үнэлэлт, дүгнэлт өгөх эрх, боломж танд бий юу? гэхэд Гэрчийн хариулт: Үнэлэлт өгөх эрхгүй. Дэмжлэг үзүүлэх эрхтэй. ...Шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуулт: Таныг ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байхад Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А “Тг”-ыг дэмжих боломж бий юу гэж асууж байсан гээд таны мэдүүлэгт тусгагдсан байна. Таны хувьд журмын дагуу явна гэж хэлсэн гэсэн өгүүлбэр байна. Ийм асуудал болж байсан уу? гэхэд Гэрчийн хариулт: Ажил эрхэлсэн даргын үүднээс тухайн ажил байдалтай танилцах эрх байгаа, энэ үүднээс

талийгаач даргад танилцуулж байсан. 2008 оноос өмнөх онуудад дандаа гадны хөрөнгө оруулалттай компаниуд шалгарч байсан. Манай агентлаг дотоодын компанийг оруулж ирэх боломж байна уу, гадны компанитай ижил төвшинд ажиллах боломжоор хангахад асуудал юу байна вэ гэдэг асуудал байсан. Тэр ч үүднээс тухайн үед санхүүгийн болон техникийн чадвартай компаниуд материалаа ирүүлж байсан. ...Шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуулт: Үндэсний компанийг дэмжих боломж байна уу? үндэсний компаниуд орж ирж байна уу гэж асууж байсан гэж ойлгож болох уу? гэхэд

Гэрчийн хариулт: Тийм. ...Шүүгдэгч Х.А-ын асуулт: Бүтээгдэхүүн хуваах гэрээний битүүмжилсэн саналдаа Шарга-3, Нэмэгт-6 талбайд Тг ямар санал өгсөн гэдгийг та мэдэх үү? гэхэд Гэрчийн хариулт: Мэдэхгүй байна, санал нь Үнэлгээний хороонд очиж байгаа...» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Гэрч О.Э-ын шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар өгсөн мэдүүлэгтээ: «...2009 оны 04 дүгээр сарын 16-ны өдөр Төхөм-10, Шарга-3, Нэмэгт-6 талбайн сонгон шалгаруулалтын гишүүнээр орсон... Сонгон шалгаруулах зөвлөлд Уул уурхайн яам, тухайн үеийн Газрын тосны асуудал хариуцсан яам, Сангийн яамны төлөөлөл оролцдог Н.А орсон... Шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуулт: Н.А Монголын “Тг” компани санхүүгийн тайланд аудит хийлгээгүй, санхүүгийн тайлангаа зөрүүтэй гаргасан байна. Ажлын хэсэг муу ажилласан байна. Санхүүгийн болон бусад баримтуудыг компаниас гаргуулж аваагүй байсан гэсэн зүйл хэлжээ. Энэ хүнд энэ компанийг сонгон шалгаруулахаас татгалзах эрх байсан уу? гэхэд...Гэрчийн хариулт: Байхгүй. Сонгон шалгаруулах үйл ажиллагаа тухайн үеийн Үйлдвэр худалдааны сайдын баталсан журмын дагуу явагддаг. Журмын 7.7-д зааснаар олонхийн саналаар хамтын шийдвэр гаргана. Н.А тухайн үед санал хэлбэрээр хэлж байсан байх, олонхийн саналаар шийдэх ёстой...Би түрүүн хэлсэн журмын 7.7-д сонгон шалгаруулах зөвлөл олонхийн саналаар шийдвэр гаргадаг. Үнэлгээний хорооноос хамгийн өндөр оноо авсан компанийг шалгаруулж бүтээгдэхүүн хуваах гэрээний төслийг үзэглэх шийдвэр гаргах талаар зөвлөмж гаргахад 100 хувь гараа өргөж дэмжсэн гэсэн үг. Гарын үсэг зурж баталгаажуулдаг...Байхгүй. “Тг” тухайн

үед Төхөм-10 /урд/ талбай дээр сонгон шалгаруулалтад оролцож байсан. Тэр ажлын хэсгийг би ахлаж ажиллаж байсан. Энэ 2 хүнийг ажлын шугамаар танина. Шарга-3, Нэмэгт-6 талбай дээр яг журмын дагуу ажил нь явагдсан. Шан харамж авсан зүйл байхгүй...Энэ хэрэгтэй холбогдуулаад Авлигатай тэмцэх газраас шалгаж байх явцад бид нарыг маш олон удаа дуудаж байцааж байсан. Үнэлгээний хороонд би орж ажиллаагүй. Гэхдээ Үнэлгээний хороотой холбогдсон материалын эх хувь олдохгүй байсан. Яагаад би үүнийг сайн мэдэж байна вэ гэхээр тухайн үед би гэрээлэлт хайгуул судалгааны хэлтсийн даргаар ажиллаж байсан. Миний хариуцаж байсан ажил учраас тэр материалтай холбогдуулж маш олон удаа очиж байцаалт өгч байсан. Үнэлгээний хорооны материалыг бид хайж байх явцдаа Үнэлгээний хороонд ажиллаж байсан хүмүүстэй уулзаж, яг Үнэлгээний хорооны даргаар хэн ажиллаж байсан бэ, тухайн үед 2 агентлаг салж байсан үе нь байна. Төсөл дээр талийгаач Д.А-ны нэр явж байдаг. Тэгэхэд манай Үнэлгээний хороонд ажиллаж байсан н.А гээд геологич байгаа. Санхүүч Ш.Ц 2 бол Үнэлгээний хорооны даргаар талийгаач даргыг ажиллаагүй Л.Сүх ажилласан гэж надад хэлсэн. Үүнийг гэрчлэх хүн нь манай Газрын тосны газар ажиллаж байсан н.Д, А.Тү гэж 2 хүн байгаа. А.Тү нь манайд ажиллаж байгаа. Н.Д одоо Уул уурхайн яаманд ажиллаж байгаа... Ажлын хэсэгт төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс ордог. Санхүүч, геологич, хуульч, Үнэлгээний хороонд бас ийм мэргэжлийн хүмүүс ордог. Тухайн үед ажлын хэсэг үнэлгээ хийх боломжтой гэж дүгнэлт гаргасан бол Үнэлгээний хороо тэрийг зайлшгүй үнэлэх үүрэгтэй, журмын дагуу татгалзах боломж байхгүй. Хэрэв зөрчил гэж тогтоогоогүй тохиолдолд зайлшгүй үнэлэх шаардлагатай. Энэ тал дээр би санал нийлэхгүй байна. Яагаад ийм дүгнэлт гаргах болсныг сайн ойлгохгүй байна. ...Шүүгдэгчийн өмгөөлөгчийн асуулт: «Т» бүлэг компани шалгарсан нь зөв гэж та хэлэх гэж байна уу гэхэд Гэрчийн хариулт: Тийм... Сонгон шалгаруулах зөвлөл анх захиалгын материалын бүрдэл бүрэн эсэхийг ажлын хэсэг хянадаг. Энэ сонгон шалгаруулалт маань өөрөө 3 үе шаттай явагдаж байгаа. Ажлын хэсэг доод тал нь сарын хугацаанд компанийн материалыг судалж, үнэлгээнд оруулах боломжтой эсэх талаар шийдвэр

гаргадаг. Үнэлгээний хороо битүүмжилж ирүүлсэн бүтээгдэхүүн хуваах гэрээний үндсэн нөхцөл гэж байгаа, тэр нь хэрэв тос олохын бол улсад юу юу өгөх вэ олсон тосныхоо хэдэн хувийг улсад өгөх вэ гэдгээ битүүмжилсэн саналаар ирүүлдэг. Тэр битүүмжилсэн саналыг Үнэлгээний хороо, бүх компани ижил төвшинд, ажлын хэсэг ч мэдэхгүй, битүүмжилсэн саналыг аваад ажлын хэсгээс үнэлгээнд оруулах боломжгүй гэсэн дүгнэлт гараагүй тохиолдолд яг тэр тоогоор нь үнэлнэ. Тоогоор нь үнэлэхдээ энэ журмын хавсралтын аргачлалд туслах үзүүлэлтээс бусад нь томъёогоор гарна. Журмын 9.1-д Монголын талд ашигтай санал өгсөн Үнэлгээний хорооны дүгнэлтээр хамгийн дээд оноо авсан захиалгыг шаардлагад нийцсэн захиалга гэж хэлнэ гэж заасан байгаа. Үүний дагуу хамгийн өндөр оноо авсан компанийг шалгаруулаад гэрээний төслийг үзэглэхээр эрх олгогдоод явдаг. ...Ажлын хэсэг тухайн үед Ашигт малтмал, Газрын тосны газар хоёр хамтдаа нэг агентлаг байхад ажлын хэсгийн тушаалууд гарсан байгаа. Хавтаст хэрэгт авагдсан байгаа. Үнэлгээний хорооны тушаал олдоогүй. Гэхдээ Үнэлгээний хороонд ажилласан хүмүүс ажилласан гэдгээ хэлж байсан. Энэ тухай Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагчид хэлж байсан. ...Журмын дагуу сонгон шалгаруулахтай холбогдсон материал маань журмын 6.4-т байна. Захиалга хүлээн авах, хянан үзэх, үнэлэх, харьцуулах, сонгон шалгаруулалтын талаар эцсийн шийдвэр гарч гэрээ байгуулах зөвлөмж, гэрээ байгуулах тухай мэдээлэл захиалагчид өгөх хүртэл сонгон шалгаруулалттай холбогдсон мэдээллийн материалыг задурлахыг хориглоно гэсэн байдаг. Энэ журмын дагуу нарийн бичгээс нарийн бичгийн гарт дамжаад явдаг. Жишээ нь, ажлын хэсгийн нарийн бичиг битүүмжилсэн материалаа Үнэлгээний хорооны нарийн бичигт өгөөд, тэр нарийн бичиг сонгон шалгаруулах зөвлөлийн нарийн бичигт өгөөд, тэр нарийн бичиг нь сайдад танилцуулж шийдвэр гардаг. 2 агентлаг салж байх үед материал нь үнэндээ хайгаад олдоогүй. ...Олдоогүй, бүх архивт, яамны архивт хүртэл хайсан. ...Би 2009 оны 3 дугаар сард гэрээлэлт хайгуул судалгааны хэлтсийн даргаар ажиллаж байсан. Энэ үед 2 агентлаг салж байсан үе. Энэ процесс маань өмнө нь болоод өнгөрсөн асуудал. Мөрдөн байцаагч нэхсэний дагуу архивтаа хайгаад олохгүй,

компьютерийн файлуудаа үзээд, С.Са гэж залуугийн файл миний компьютерт байсан файл адилхан байсан тул тэр файлаас хэвлэж аваачиж өгсөн. ...Оноо гаргахад туслах, үндсэн, дэд үзүүлэлтүүдийг бүгдийг нь үнэлээд, үнэлсэн үнэлгээгээр хамгийн өндөр оноо авч байгаа. ...Улсын яллагчийн асуулт: Та сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүнээр ажиллаж байсан уу гэхэд Гэрчийн хариулт: Ажилласан. ...Улсын яллагчийн асуулт: Та яг ямар асуудлыг хариуцсан бэ? гэхэд Гэрчийн хариулт: Би нефтийн геофизикч мэргэжилтэй. Дараа нь Хууль зүйн дээд сургуулийг төгссөн. Тухайн үед би 3 дугаар сард гэрээлэлт хайгуул судалгааны хэлтсийн даргаар томилогдсон. Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн нь тусгайлан энэ хүн энэ талаар дүгнэлт гаргана гэж байхгүй. Ажлын хэсгийн гишүүд хуульч бол эрх зүйн баримт бичигт нь, санхүүч санхүүгийн бичиг баримтад нь гаргадаг. Сонгон шалгаруулах зөвлөлийн гишүүн нь ажлын хэсэг Үнэлгээний хорооны санал дүгнэлтийг үндэслээд өөрийн дотоод итгэлээр санал өгнө. Тусгай асуудал хариуцсан зүйл байхгүй. ...Тийм зүйл байхгүй, би яагаад гэвэл санхүүч биш учраас санхүүгийн чиглэлээр дүгнэлт гаргуулсан хүмүүсийн дүгнэлтийг үндэслэнэ гэхээс би санхүүгийн мэргэжилгүй учир үзэж чадахгүй. ...Сонгон шалгаруулах зөвлөл зөвлөмж гаргаж байгаа. Зөвлөмжийг тухайн үеийн сайд тушаалаар батална. Тэр нь гэрээ байгуулах биш гэрээний төслийг үзэглэх тухай байдаг. ...Энэ бол журам нь өөрөө зөрчил гэж тогтоосон тохиолдолд үнэлэхгүй. Тэгэхээр ажлын хэсэг нь өөрөө санхүүгийн боломжтой гээд дүгнэлт гаргасан, Үнэлгээний хорооны гишүүдийн нэг нь Тэгээд санал хураагаад 100 хувийн саналаар дэмжсэн. Зөрчил гэж тогтоосон зүйл байхгүй учраас журмаараа үнэлэхгүй байх боломжгүй. ...Би өмнө нь хэлсэн сонгон шалгаруулалтад төрөл бүрийн мэргэжлийн хүмүүс оролцдог. Үүнийг санхүүгийн чиглэлийн хүн нь хянаад саналаа хэлсэн...» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/.

-Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолын хамт битүүмжилсэн тогтоол, тэмдэглэл /1-р хх-ийн 41-43/.

-Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолын үнэлгээ /1-р хх-ийн 86-87/.

-Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод нэгжлэг хийх тогтоол, тэмдэглэлийн

хамт /1-р хх-ийн 108-112/.

-Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод нэгжлэгээр хураан авсан эд зүйл, бичиг баримтад үзлэг хийсэн тэмдэглэл /1-р хх-ийн 113-128/.

-Баянзүрх дүүргийн ...дүгээр хороо, Залуучууд гудамж-28, ...дугаар давхар, "Тг" ХХК-ийн захирал Х.А-ын ажлын өрөө, захирал Ё.О өрөө, Х.А-ын Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр нэгжлэгээр хураан авсан эд зүйл, бичиг баримтад үзлэг хийсэн тэмдэглэл /1-р хх-ийн 130-167/.

-Газрын тосны газрын архивын баримт бичигт үзлэг хийсэн тэмдэглэл /1-р хх-ийн 177-179/.

-Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан "Шарга-3", "Нэмэгт-6" талбайнуудад "Тг" ХХК-ийг шалгаруулсан сонгон шалгаруулах зөвлөл болон түүнтэй холбоотой материалд үзлэг хийсэн тэмдэглэл /1-р хх-ийн 180-241/.

-2014 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 1-123 дугаартай Газрын тосны газрын албан бичиг /7-р хх-ийн 164-167/.

-2014 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн 4/238 дугаартай Уул уурхайн яамны албан бичиг /7-р хх-ийн 169-174, 176-211/.

-Гэрч Д.Ө-ын "...Тг" ХХК-ийн захирал Х.А-ыг танина. Манай компаниас байр захиалан авсан. Үйлчилгээний журмаар танина. ...Би одоо үнэхээр санахгүй байна. Энд миний гарын үсэг зурагдсан байна. Тийм болохоор энэ орон сууц захиалан бариулсан 372.480.000 төгрөг төлсөн гэж үзэж байна..." гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 159-160/.

-Гэрч О.Э-ын "...Үйлдвэр худалдааны сайдын 2008 оны 2 дугаар сарын 14-ний өдрийн 33 дугаар тушаалаар Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газраас гадаад, дотоодын ижил төрлийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдээс газрын тосны талбайн захиалга авч, гэрээ байгуулах үйл ажиллагааг зохих ёсоор шуурхай явуулах шаардлагад нийцүүлэн "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмыг баталсан. Мөн тушаалын 2 дугаар заалтаар уг журмыг Үйлдвэр худалдааны яам болон Ашигт малтмал, газрын тосны газрын дотоод удирдлага зохион байгуулалтын үйл ажиллагаанд мөрдөхөөр болсон байдаг. Журмын 6.4-т заасны дагуу Сонгон шалгаруулалтын эцсийн шийдвэр гарч, гэрээ байгуулах эрх олгох зөвлөмж, гэрээ байгуулах мэдэгдлийг захиалагчид өгөх

хүртэл хугацаанд сонгон шалгаруулалттай холбогдсон материал, мэдээлэл задруулахыг хориглоно гэж заасны дагуу ажлын хэсэгт орсон гишүүд нууц хадгалах талаар баталгааг гаргадаг. Журмын 7 дугаар зүйлд заасны дагуу Үнэлгээний хороог тухай бүр Газрын тосны даргын тушаалаар томилох юм. Үнэлгээний хороог Газрын тосны газрын “газрын тосны асуудал хариуцсан” мэргэжилтнүүдийн бүрэлдэхүүнтэй байгуулна. Журмын 7.2-т заасны дагуу үнэлгээг Ажлын хэсгээс битүүмжилсэн материалыг актаар хүлээн авсан өдрөөс хойш ажлын 10 хоногт багтааж хийж дуусгана. Журмын 8 дугаар зүйлд заасны дагуу үндсэн, туслах, дэд үзүүлэлтээр үнэлгээ хийнэ. Үүнд: Үндсэн үзүүлэлт нь байгалийн нөхөн сэргээгдэшгүй баялгийг ашигласны төлбөр, бүтээгдэхүүн хуваалт нөхөх зардлын хувь хэмжээ хамаарна. Үнэлгээний хороонд битүүмжлэн өгсөн “Бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний үндсэн нөхцлүүдэд өгсөн саналаар уг журмын хавсралтад дурдсан “бүтээгдэхүүн хуваах гэрээ”-ний сонгон шалгаруулалтын аргачлалаар оноо өгч, үнэлгээ хийнэ. ...Журмын хавсралтын 2-т заасан туслах үзүүлэлтийн 1 дэх хэсгийг үнэлэхдээ гэрээлэгч, туслан гүйцэтгэгчийн ажлын туршлага, мэргэжлийн чадавхийг үнэлэхдээ тухайн захиалагч болон хөрөнгө оруулагч компанийн газрын тосны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан эсэх, эсхүл мэргэжлийн компанитай гэрээ санамж бичиг байгуулсан эсэх, мэргэжлийн зөвлөх инженерүүдийн багтай эсэх, гэрээ байгуулсан тохиолдолд хайгуул судалгааны ажлыг хэрхэн хийх талаар ирүүлсэн бичиг баримтыг харгалзан үнэлдэг. Санхүүгийн чадавхийг үнэлэхдээ тухайн захиалагч болон хөрөнгө оруулагч компанийн санхүүгийн тайлан аль нэг банк, хөрөнгө оруулалтын сангуудаас хөрөнгө оруулалт хийх баталгаа авсан эсэх, тухайн захиалагч болон хөрөнгө оруулагч компанийн өмнө нь эрхэлж байсан үйл ажиллагаа, хэрхэн амжилттай хэрэгжиж байсан зэргийг харгалзан үнэлдэг. Энэ хэсгийг үнэлэхдээ Үнэлгээний хорооны гишүүд Захиалгын материал, ажлын хэсгийн санал, дүгнэлтийг харгалзан өөрсдийн дотоод итгэлээр 0-15 оноо өгнө. Туслах үзүүлэлтийн 2-т заасан гэрээлэгч, туслан гүйцэтгэгч нарын хооронд гэрээ хийсэн эсэх, харилцан хүлээх үүргийг үнэлэхдээ газрын тосны мэргэжлийн компанитай гэрээ хийсэн эсэхийг харгалзан оноо өгнө. Ямар нэг

урьдчилан тохиролцоо байхгүй бол 0 оноо өгдөг. Ямар нэг гэрээ байх юм бол тэрийг Үнэлгээний хорооны гишүүд өөрийн дотоод итгэлээр 10 хүртэл оноо өгнө. Журмын хавсралтын туслах үзүүлэлтийн 3 дахь хэсэгт заасан ашиглахаар санал болгож буй техник, технологи, тоног төхөөрөмжийг үнэлэхдээ захиалгын материалд дурдсан хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэх арга аргачлал, хэрэглэх тоног төхөөрөмжийг харгалзан Үнэлгээний хорооны гишүүд 0-10 хүртэл оноог өөрсдийн дотоод итгэлээр өгнө. Журмын хавсралтын туслах үзүүлэлтийн 4 дэх хэсэгт заасан хайгуулын хугацаанд заавал хийж гүйцэтгэх үндсэн ажлыг үнэлэхдээ захиалгад дурдсан заавал хийж гүйцэтгэх ажлаа мэргэжлийн төвшинд хэрхэн төлөвлөснийг харгалзан Үнэлгээний хорооны гишүүд өөрсдийн дотоод итгэлээр 0-20 хүртэл оноо өгнө. ...Ингээд үндсэн үзүүлэлт, туслах үзүүлэлт, дэд үзүүлэлт тус бүр авсан оноог нэмж захиалагчид өгөх үнэлгээний оноог гаргана. Журмын 8.7, 8.8-д заасны дагуу Үнэлгээний хороо санал, дүгнэлтээ илтгэх хуудас үйлдэн хорооны гишүүд гарын үсэг зурж баталгаажуулан Сонгон шалгаруулах зөвлөлийн нарийн бичгийн даргад холбогдох баримт бичгийн хамт дугтуйлан битүүмжлэн лацдаж хүргүүлнэ. “Тг” ХХК нь Шарга-3 болон Нэмэгт-6 талбайд захиалга ирүүлсэн ба Ажлын хэсэгт нь хуучнаар Ашигт малтмал, газрын тосны Хэрэг эрхлэх газрын дарга Ж.Б-ны 2209 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 12 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар Ажлын хэсгийн ахлагчаар Гэрээлэлтийн хэлтсийн дарга Г.Т, одоо “ЭМГЛ”-т ажиллаж байгаа, гишүүдээр Гэрээлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Ч.Н, Гэрээний хэрэгжилтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн Л.А, Олборлолт, тээвэрлэлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн А.П, Олборлолт тээвэрлэлтийн хэлтсийн мэргэжилтэн Н.У нар байсан. Үнэлгээний хорооны гишүүдээр томилогдсон хүмүүсийн тушаал нь одоо олдохгүй байгаа. АМГТХЭГ-ын даргын 2009 оны 01 дүгээр сарын 14-ний 12 дугаар тушаалын 3-т заасны дагуу Ажлын хэсэг хэлэлцээг 2009 оны 2 дугаар сарын 16-ны дотор хийж дуусган холбогдох материалыг бүрдүүлэн битүүмжилж Үнэлгээний хороонд актаар хүлээлгэн өгөхийг даалгасан байдаг. “Бүтээгдэхүүн хуваах гэрээний”-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 7.2-т заасны дагуу үнэлгээг Ажлын хэсгээс битүүмжилсэн материалыг актаар хүлээн

авсан өдрөөс хойш 10 хоногт багтаан хийж дуусгана гэж заасан байдаг. Харин Үнэлгээний хорооны илтгэх хуудсын төслийг Гэрээлэлтийн хэлстийн дарга Г.Т-гийн ажил хүлээлцэх үед компьютерийн файл дотор байсан. Энэ илтгэх хуудсаар Үнэлгээний хорооны гишүүдэд Үнэлгээний хорооны даргаар газрын тосны газрын дарга Д.А, нарийн бичгийн даргаар Гэрээлэлтийн хэлтсийн мэргэжилтэн С.Са, гишүүдэд, Газрын тосны газарт ажиллаж байсан Л.Сүх, Д.А, С.Н, Ш.Ц, Л.А, Э.Т, Н.О нар ажиллаж байсан. Эрдэс баялаг Эрчим хүчний сайдын 2009 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 79 дүгээр тушаалаар Сонгон шалгаруулалтын зөвлөлийн гишүүдийн бүрэлдэхүүнийг баталсан. Зөвлөлийн даргаар Газрын тосны газрын дарга Д.А, нарийн бичгийн даргаар А.Тү, гишүүдэд Н.Б, П.Х, Л.Р, Г., М.А, Д.А, О.Э нар ажилласан юм. ...Үнэлгээний хорооны санал дүгнэлтэд дурдсан асуудалтай танилцаагүй ээ. Хэрвээ Үнэлгээний хорооны илтгэх хуудсанд дурдсан санал дүгнэлтийн талаар Сонгон шалгаруулах зөвлөл дээр яригдсан бол энэ асуудал нь тэмдэглэл дээр тусгагдах ёстой. Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэл дээр энэ талаар дурдаагүй байна..." гэх мэдүүлэг /2-р хх-ийн 68-73, 74-76/ зэрэг нотлох баримтуудаар хөтөлбөргүй нотлогдон тогтоогдож байна.

Прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн Х.А, мөн. Хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар Д.А нарт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн нь Х.А, Д.А нарын үйлдэлд тохирсон байна. Учир нь,

Ц.Ч-ийн мөрдөн байцаалтад сэжигтнээр болон яллагдагчаар «...Анхны 50.000 ам долларыг Хадам ээжийн дүү О-аас зээлсэн... Х.А-т өгсөн...» гэсэн мэдүүлэг /6-р хх-ийн 223, 231/ өгсний дагуу мөрдөн байцаагч, гэрч Ч.О-аас Ц.Ч-ийн мэдүүлэгтэй холбогдуулан мэдүүлэг авах гэсэн боловч Гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээ эдлэн мэдүүлэг /2-р хх-ийн 163-164/ өгөхөөс татгалзсан, Д.А, Ц.Ч нараас мөрдөн байцаалтад сэжигтнээр болон яллагдагчаар « ...Энэ байрыг түрээслэж байгаа, энэ талаар /Д.А-ы эхнэр/ Д.Н мэдэж байгаа ...» гэсэн мэдүүлэг /6-р хх-ийн 148-149, 152, 223, 232/ өгсний дагуу Д.А-ны эхнэр Д.Н-аас мэдүүлэг авахад мөн л Гэр бүлийн гишүүн, төрөл садангийн хүний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхээ эдлэн татгалзсан байгаа нь шүүгдэгч нарын

тайлбарлаж байгаа тухайн орон сууцны үнэнд төлсөн төлбөр, мөн байрыг түрээслэн сууж байсныг үгүйсгэх нөхцөл байдал болсон гэж үзэхээр байна.

Мөн Х.А-ын мөрдөн байцаалтад өгсөн: «...Д.А-тай 2008 оны хавар танилцаж байсан, хуучнаар Үйлдвэр худалдааны сайд Х.Н-тэй уулзахад Газрын дэд дарга /Газрын тосны газрын дэд дарга/ явж байгаа энэ хүнтэй уулз гээд танилцуулж байсан түүнээс хойш таних болсон бидний хувьд найз нөхдийн холбоо байгаа, гэр бүлийн найзууд...» гэсэн мэдүүлэг/бхх-ийн 190/,

Д.А-ны оршин сууж байсан орон сууц: Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод / Уг байранд 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр нэгжлэг хийхэд Д.А гэр бүлийн хамтаар амьдарч байсан тухай энэ хэрэгт эд мөрийн баримтаар видео бичлэг авагдсан/,

Х.А-ын оршин сууж байсан орон сууц: Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод амьдардаг /Х.А нь Д.А-ыг өмнө нь таньдаг найз нөхдийн дотно холбоотой, хөрш зэргэлдээ амьдардаг байсан/,

2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 54 дугаартай Д.А-ыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын тосны газрын даргаар томилсон Засгийн газрын тогтоол /6-р хх-ийн 240/,

2012 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 12 дугаартай Д.А-ыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын тосны газрын даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн Засгийн газрын тогтоол /6-р хх-ийн 241/,

Гэрч Л.Сүх-ийн мөрдөн байцаалтад өгсөн: «...2013 оны сүүлээр байх 11 дүгээр сарын сүүлээр Газрын тосны газарт ажилладаг А.Тү нь Үнэлгээний хорооны илтгэх хуудас гээд нэг зүйл барьчихсан энэ тэмдэглэл дээр нөхөж гарын үсэг зуруулж байгаа юм гэхээр нь би илтгэх хуудсыг хараад Д.А даргын үед ийм асуудал хариуцаж байгаагүй, би эх материал байхгүй байгаа учир гарын үсэг зурахаас татгалзсан...» гэсэн мэдүүлэг /2-р хх-ийн 123-124/,

Гэрч Г.Т-гийн мөрдөн байцаалтад өгсөн: «...Хэлэлцээрийн явцад тухайн компаниас бүрдүүлж ирүүлсэн материал нь шаардлага хангахгүй байсныг Ажлын хэсгээс мэдэгдэж, ирүүлсэн материалыг буцааж байсан...»Тг» ХХК нь Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Олон улсын нээлттэй тендерт дахин захиалгын санал ирүүлсэн байсан...Өмнөх Эргэл-12 өгсөн захиалгын материалтай адилхан байна. Энэ компанийн хувьд

ирүүлсэн захиалгын материалуудыг үзэхэд тухайн компанийн санхүүгийн чадавхийг нотлох баримт бичгийн бүрдэл болон туслан гүйцэтгэгчээр ажиллах чадавхийг нотлох баримт бичгүүд хангалтгүй байсан... «Тг» ХХК-ийн газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайд ирүүлсэн захиалгын материалыг танилцаж судлах Ажлын хэсгийн даргаар ажиллаж байхад Д.А нь «Тг» ХХК-ийн талаар асууж байсан. «Энэ компанийн хувьд материал нь хэр байгаа бэ, явц байдал нь ямар байгаа юм, энэ компанийн ирүүлсэн материалын хувьд дэмжих боломжтой юм уу» гэж асууж байсан. Би уг компанийн ирүүлсэн материалын хүрээнд дүрэм журмын дагуу явна гэж хэлсэн. Өөр хүмүүс тухайн үед Т компанийн талаар асуусан зүйл байхгүй... гэсэн мэдүүлэг /2хх-ийн 77-79, 102-103/,

Шинжээчийн дүгнэлтэд дурдагдсанаар Сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын протоколд М.А, Н.Б нарын хэлсэн санал: «Тг» ХХК-ийг санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй санхүүгийн тайлан зөрүүтэй гаргасан, санхүүгийн баримт бусад холбогдох материалыг тус компаниас бүрэн гаргуулж аваагүй ажлын хэсэг муу ажилласан, ...»Тг» ХХК-ийг Газрын тосны хайгуулын 2 талбайд зэрэг хөрөнгө оруулж чадах эсэхэд эргэлзэж байна... гэжээ /Тендерт шаардлага хангаагүй материал ирүүлсэн/,

Шинжээч С.Т-ын 2014 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн шинжээчийн «... Зөвлөлийн зарим гишүүд БНПУ-ын «РСШО» компанийг дэмжих хүсэлтэй байсан боловч үнэлгээний оноо хэтэрхий доогуур байсан байна. Мөн Зөвлөлийн гишүүн М.А нь «Тг» ХХК нь санхүүгийн тайландаа аудит хийлгээгүй, санхүүгийн тайланг зөрүүтэй гаргасан, санхүүгийн баримт, бусад материалыг бүрэн хэмжээнд компаниас гаргуулж аваагүй, Ажлын хэсэг муу ажилласан гэсэн санал хэлсэн байна. Түүнчлэн Зөвлөлийн гишүүн Н.Б нь «Тг» ХХК-ийг газрын тосны хайгуулын 2 талбайд зэрэг хөрөнгө оруулж чадах эсэхэд эргэлзэж байна гэсэн байна. «Бүтээгдэхүүн хуваах гэрээ»-ний гэрээлэгчийг сонгон шалгаруулах журмын 11 дүгээр зүйлийн 11.2-т «СШЗ нь энэ журмын дагуу хянаж зөрчил ирүүлсэн тохиолдолд гэрээлэгч сонгох ажиллагааг зогсоож, энэ журмын дагуу тухайн үйл ажиллагаа, эсхүл үнэлгээг тухайн нөхцөл байдлаас шалтгаалан дахин хийлгэх» гэж заасан байтал Зөвлөлийн гишүүдийн дээр

дурдсан саналыг үндэслэн зохих арга хэмжээ авалгүйгээр «Тг» ХХК-ийн захиалгыг дэмжсэн байна. Иймд тус Сонгон шалгаруулах зөвлөл нь журмын дагуу ажилласан эсэх нь эргэлзээтэй байна...» /2-р хх-ийн 206-212/ гэсэн дүгнэлт /Сонгон шалгаруулах зөвлөл журмын дагуу ажиллаагүй/,

Х.А-аас Н.О-д өөрийн өмчлөлийн орон сууцыг захиран зарцуулах ...арилжих бүрэн эрхийг олгосон 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн итгэмжлэл /7-р хх-ийн 88/, бэлэглэгч Х.А-аас бэлэг хүлээн авагч Ц.Ч-ийн өмчлөлд шилжүүлсэн 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн бэлэглэлийн гэрээ /7-р хх-ийн 87/ зэргээс үзвэл ялтан Х.А нь 2008 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн Үйлдвэр худалдааны сайд Х.На-ийн 196 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүн хуваах чиглэлээр Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Олон улсын нээлттэй тендер зарлаж, уг тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө «Тг» ХХК-ийн ерөнхий менежер Н.О-д итгэмжлэл хийж өгч, Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлэн хээл хахуульд өгсөн,

Талийгаач Д.А нь Газрын тосны газрын даргаар ажиллаж байхдаа Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан, газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны дарга, Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар тус тус ажиллахдаа тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Х.А-ын 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг төрсөн ах Д.Ц-ийн хүү Ц.Ч-ийн нэр дээр 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр шилжүүлэн онц их хэмжээний хээл хахууль авсан болох нь дээрх нотлох баримтуудаар хангалттай нотлогдон тогтоогдож байх тул ялтан Х.А-ыг албан тушаалтанд бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн, талийгаач Д.А-ыг онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Х.А-т ял шийтгэл оногдуулах, талийгаач Д.А нь 2014 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нас барсан болох нь нас барсны гэрчилгээний хуулбар /16-р хх-ийн 178/, нас

барсны бүртгэлийн лавлагаа /16-р хх-ийн 215/ зэрэг нотлох баритуудаар тогтоогдож байх тул түүнд холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2-т зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь хууль зүйн үндэслэлтэй байна.

Х.А нь Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 7, 8, 16, 17, 21 дүгээр зүйлүүдэд заасан заалтуудыг зөрчин 2007-2011 онд нийт 12.303.690.000 төгрөгөөр хайгуулын болон ашиглалтын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан авч, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлогын албан татвар болох 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөлгүй онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн гэмт хэрэг үйлдсэн болох нь

Хохирогч, иргэний нэхэмжлэгч Ж.О-ын «...Монгол Улсад үйл ажиллагаа явуулж ашиг орлого олж байгаа дотоодын болон гадаадын ямар ч аж ахуйн нэгж, байгууллага татвар төлөх үүрэгтэй. Шинжээчийн дүгнэлттэй танилцлаа. Дүгнэлтээр тогтоогдсон төлөх татварын хувь хэмжээгээр хохирлыг барагдуулж нэр бүхий аж ахуйн нэгж болон этгээдээс нэхэмжилж байна...» гэх мэдүүлэг /2-р хх-53/,

Гэрч Л.Д-ийн «...Г М» ХХК-ийг 2006 онд би өөрөө үүсгэн байгуулсан. Компанийн үйл ажиллагааны чиглэл нь худалдаа үйлчилгээний чиглэлээр үүсгэн байгуулсан, нэг гишүүнтэй компани юм. Компанийн нэр дээр Архангай аймгийн ...суманд байрлалтай 1193.Х хайгуулын тусгай зөвшөөрөл байсан. Архангай аймгийн Тариат суманд байрлалтай 1193.Х хайгуулын тусгай зөвшөөрлийг 2007 онд байх Х.А гэх хүн над руу утсаар яриад «уулзмаар байна» гэж уулзаад «уг тусгай зөвшөөрөл дээр хөрөнгө оруулалт хиймээр байна» гэж ярьж байсан. Тэгээд тухайн үед надад мөнгөний хэрэг болоод бага багаар мөнгө авч байсан ба сүүлдээ уг тусгай зөвшөөрлийг компанийн хамт 500.000 ам доллараар худалдан борлуулсан. Одоо миний санаж байгаагаар эрх шилжүүлэх гэрээгээр шилжүүлсэн шиг санагдаж байна. 2007 онд 500.000 ам долларыг увуулж цувуулж байгаад тэр 2007 ондоо багтааж авсан. Одоогоор надад ямар нэг баримт

байхгүй...» гэх мэдүүлэг /2-р хх-ийн 165-166/,

Гэрч Г.У-ий «...»ТМТ» ХХК-ийг 2003 онд би өөрөө үүсгэн байгуулсан бөгөөд 1 гишүүнтэй байсан. Уг компанийн нэр дээр үл хөдлөх хөрөнгө байхгүй. Харин ашигт малтмалын 3 тусгай зөвшөөрөл байсныг Х.А-ын «Рф» ХХК-нд шилжүүлсэн. Уг 3 ашигт малтмалын тусгай зөвшөөрөл нь кварцын илрэлтэй, 1 тусгай зөвшөөрөл Дорноговь аймгийн Даланжаргаланд 1166.Х, 1133.Х байгаа. 1 тусгай зөвшөөрөл нь хүчингүй болсон байгаа, 9 дэх жил нь болоод мөнгө хөрөнгөгүй болоод тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан гээд хүчингүй болсон юм. Манай аав н.Го гэх хүн байдаг, геологичоор ажилладаг байсан. Тэгээд өөрийн компанийн нэр дээр байсан 1 тусгай зөвшөөрлийг «ТМТ» ХХК руу шилжүүлсэн юм. Эдгээр 3 тусгай зөвшөөрлийг Х.А-т зараагүй, ирээдүйд олох орлогоос ашиг хуваахаар тохирон Х.А-ын компани руу шилжүүлсэн юм. Гэрээ байгуулна гэсэн. Тэгээд амжихгүй явж байна. Өнөөдрийн байдлаар ашиг хуваах талаар ямар нэг гэрээ болон бичиг баримт байхгүй байна...» гэх мэдүүлэг /2-р хх-ийн 169-170/,

Гэрч Д.Г-ийн «...Манай аав Б.Д гэж байдаг бөгөөд «Сн» ХХК-ийг үүсгэн байгуулсан. Энэ компани уул уурхайн геологи хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компани бөгөөд энэ компанийн нэр дээр Говь-Алтай аймгийн Цээл сум, мөн Цээл Алтай сумдыг дамнасан ашигт малтмалын 1454.Х, 1454.Х, 1454.Х тоот тусгай зөвшөөрлүүдийн геологи хайгуулын судалгааны үйл ажиллагаа явуулж байсан. Говь-Алтай аймгийн Цээл сум, мөн Цээл Алтай сумдыг дамнасан ашигт малтмалын 1454.Х, 1454.Х, 1454.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг Ашигт малтмалын газарт 2008 онд өргөдөл өгөөд авч байсан юм. Говь-Алтай аймгийн Цээл сум, мөн Цээл Алтай сумдыг дамнасан ашигт малтмалын 1454.Х, 1454.Х, 1454.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг Х.А-т зарсан асуудал байхгүй. Харин "Тг" ХХК-ийн гүйцэтгэх захирал Н.О-д өмнө би 20.000 ам долларын өртэй байсан ба тэр өрөө суутгуулаад Гранд марк-2 машин аваад увуулж цувуулаад 30-40 мянган ам доллар авсан. Нэг жил дамнаад увуулж цувуулаад нийт 100 сая төгрөгөөр зарсан. 2009 онд дээрх тусгай зөвшөөрлүүдийг шилжүүлсэн. Мөнгө хүлээн авсан өгсөн баримт байхгүй. Зүгээр Н.О-той ярьж байгаад мөнгөө өгч авдаг байсан. Мөнгийг дандаа бэлнээр авдаг байсан...Говь-Алтай аймгийн Цээл

сум, мөн Цээл Алтай сумдыг дамнасан ашигт малтмалын 1454.Х, 1454.Х, 1454.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг 250.000 ам доллараар зарсан асуудал байхгүй. Харин цааш нь Н.О хэдэн төгрөгөөр зарсан эсэхийг мэдэхгүй. Ямар ч байсан миний тооцоогоор 100 сая төгрөгөөр зарсан...» гэх мэдүүлэг /2-р хх-ийн 175-176/,

Гэрч С.А-ийн «...»ЖГ» ХХК-ийг 2006 онд байгуулсан. Манай эхнэр Д.О уг компанийн 85 хувийн хувьцааг эзэмшиж байсан, үлдсэн 15 хувийг нь М.Б гэдэг хүн эзэмшиж байсан. Энэ компани уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутагт байрлах жоншны хайгуулын 2 тусгай зөвшөөрлийг өмнө нь миний нэр дээр байсныг шилжүүлж өгсөн. Миний нэр дээр байсан ашигт малтмалын 2 тусгай зөвшөөрлийг би 2001 онд авсан... Х.А-тай 2010 оны 12 дугаар сарын эхээр өмнө нь Улсын мөрдөн байцаах газарт ажиллаж байсан Н.О-оор дамжуулан уулзан танилцсан бөгөөд «ЖГ» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй Дундговь аймгийн Говь-Угтаал сумын нутагт байрлах 10735А, 1073.А тоот тусгай зөвшөөрлийг «ЖГ» компанийн хувьцааг бэлэглэлийн гэрээгээр өгсөн байх. Тэгээд Х.А-т уг хоёр тусгай зөвшөөрлийг 400.000 ам доллараар зарсан. Уг мөнгийг тухайн үедээ би уурхай ажиллуулах гээд техник тоног төхөөрөмж зэрэг ахуйн хэрэглээний зүйлд өр тавьсан байсан учир тэрэнд зарцуулсан юм...» гэх мэдүүлэг /2-р хх-ийн 177-178/,

Гэрч Д.Цгэ-ийн «...»УТ» ХХК, «ЧХ» ХХК-ийн нэр дээр байсан ашигт малтмалын хайгуулын 3 тусгай зөвшөөрлийг 2006 онд 600.000 ам доллараар тохирч шилжүүлсэн. Ингэхдээ 550.000 ам долларыг бэлнээр авсан. Харин үлдсэн 50.000 ам долларыг Н.О зуучилж өгсний хөлс гэж авсан. 2008 оны 10 дугаар сарын 20-р байх би эмнэлэгт хэвтэж байсан, мөн надад мөнгөний хэрэг гараад Дорнод аймагт барилга барьж байсан бөгөөд мөнгөний хэрэг болоод Х.А-тай уулзъя гээд өмнө нь Х.А сонирхож байсан миний «Рф» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй байсан 9 ширхэг хайгуулын тусгай зөвшөөрлийг компанитай нь цуг зарахаар ярилцсан. Өмнө нь Х.А энэ компанийн тусгай зөвшөөрлийг сонирхож байсан бөгөөд гэхдээ хөрөнгө оруулалтыг нь олно, харин компанийн 30 хувийн эзэмшилтэйгээр ярилцаж байсан юм. Би тэр үед мөнгө хэрэгтэй байсан учир «Рф» ХХК-ийг бүтнээр нь 300.000 ам доллараар авчих гэж ярьсан. Х.А «тэгье» гэж

зөвшөөрөөд компаниа 300.000 ам доллараар зарсан юм. Өөр ямар нэг наймаа байхгүй. Гэрээ хийсэн асуудал байхгүй. Мөнгө хүлээн авсан, өгсөн баримт байгаа эсэхийг санахгүй байна. Х.А нь «УТ» ХХК, «ЧХ» ХХК-ийн нэр дээр байсан ашигт малтмалын хайгуулын 3 тусгай зөвшөөрлийг 800.000 ам доллараар, «Рф» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй байсан 9 ширхэг хайгуулын тусгай зөвшөөрлийг 800.000 ам доллараар, нийт 1.600.000 ам доллараар худалдан авсан асуудал байхгүй. Худлаа ярьж байна. Миний хувьд Х.А-аас нийт 850.000 ам доллар авсан. Өөр мөнгө аваагүй...» гэх мэдүүлэг /2-р хх-ийн 180-181/,

Гэрч Б.Уу-ын «...»ТД» компанийн нэр дээр Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Ханан хонгил толгой гэх нэртэй 15130Х, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Ханан хонгил толгой-1 нэртэй 15131Х, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Оюут нуруу нэртэй 1442.Х тусгай зөвшөөрлүүдийг Х.А-ын «МХ» ХХК-ийн нэр дээр байдаг Чингэлтэй дүүргийн 2 дугаар хороо Бөмбөгөр худалдааны төвийн урд байрлах 5 давхар 620 м2 бүхий байраар сольсон. Мөнх «ЦӨ» ХХК-ийн Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг Өвөлжөө уул нэртэй 5264Х, Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг Баруун ноён уул-1 нэртэй 1378.Х, Өмнөговь аймгийн Ноён, Гурвантэс сумын нутаг Цагаа уул нэртэй 1452.Х хайгуулын тусгай зөвшөөрлүүд, «А» ХХК-ийн нэр дээр Дорноговь аймгийн Мандах сумын нутаг 1552.Х, 1553.Х тусгай зөвшөөрлүүдийг Х.А-тай Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороонд байрлах «АП» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй 12 давхар байшингаар сольсон. Бусад тусгай зөвшөөрлүүдийг мөнгөөр нь зарсан. Одоо яг хэдээр зарсныг санахгүй байна. Баримт материалаа харж байгаад хэлье. Эдгээр наймаа нэг доор хийгдээгүй. Тэр нь энийх энэ гээд нилээн удаан үргэлжилсэн юм. Мөнгө бэлнээр авч байсан. Яг хэдэн төгрөг авч байснаа санахгүй байна. Увуулж цувуулаад мөнгө авдаг байсан. Х.А-аас 2010 оны 8 дугаар сарын 27-нд Б.Уу-т хоорондын тооцоо гэж Голомт банкны 913100xxxx дугаар данснаас 200.000 ам доллар «ХСү» ХХК-ийн 110210xxxx дансанд, мөн өдрөө миний 420734458888xxxx дансанд 115.000 ам долларыг тус тус шилжүүлсэн нь үнэн...» гэх мэдүүлэг /2-р хх-ийн 182-184/,

Гэрч Б.С-ын «...»2005 оноос «СГ» ХХК-ийг байгуулсан. Үйл ажиллагаа явуулж байна. Манай компани ашигт малтмалын хайгуулын чиглэлээр үйл ажиллагаа

явуулдаг компани юм. Тг ХХК-нд ажилладаг Н.О-ыг өмнө нь таньдаг байсан юм. Тэгээд Н.О-оор дамжуулан 2010 оны сүүлээр Х.А-тай танилцсан ба тухайн үед “нүүрсний сонирхолтой талбай байна уу” гэж асууж байсан. 2011 оны 2 дугаар сарын 5-ны өдөр Х.А-т Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын нутагт байрлалтай хайгуулын 1292.Х, 1546.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг 1 сая ам доллараар зарсан. Мөнгийг 900.000 ам долларыг бэлнээр, 100.000 ам долларт Бенз ЖЛ-450, Ауди КУ-7 маркийн машинуудыг бодож авсан. Мөнгө хүлээн авсан баримт байгаа эсэхийг мэдэхгүй байна. Харин тусгай зөвшөөрлийг зарах “Баталгааны гэрээ” хийгдсэн. Энэ гэрээнд бүх зүйлийг тусгасан байгаа...” гэх мэдүүлэг /2-р хх-ийн 185-186/,

Гэрч Г.Э-ын «...»ЭЭЭ» ХХК-нд 2006-2007 онд геологичоор ажиллаж байсан. Харин «ИЭЖА» ХХК-ийг би өөрөө үүсгэн байгуулсан бөгөөд энэ компани нь уул уурхайн геологи судалгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байсан. Манай компанийн нэр дээр ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлүүд байсан юм. «ЭЭЭ» ХХК-ийн нэр дээр ашигт малтмалын хайгуулын 1331.Х, 1331.Х тоот тусгай зөвшөөрлүүдийг болохоор тус компанийн захирал Б нь «жилийн төлбөр төлж чадахгүй байна», мөн «сунгалтыг нь хийж чадахгүй байна» гэхээр нь «ИЭЖА» ХХК-ийн нэр дээр ашигт малтмалын 1439.Х, 1439.Х дугаар тусгай зөвшөөрлүүдийг нийлүүлж байгаад Н.О-той ярьж тохиролцоод, одоо миний санаж байгаагаар «НБА» ХХК-нд шилжүүлсэн шиг санагдаж байна. Дээрх ашигт малтмалын хайгуулын 4 тусгай зөвшөөрлийг 50.000.000 төгрөгөөр зарсан. Гэхдээ «ЭЭЭ» ХХК-ийн захирал Б-д 10.000.000 төгрөг өгсөн. Би өөрөө 20.000.000 төгрөгийг нь авсан. Үлдсэн 20.000.000 төгрөгийг тусгай зөвшөөрлийн ээлжит жилийн төлбөр, тусгай зөвшөөрлийн сунгалтын төлбөр мөн шилжүүлгийн төлбөрт тус тус зарцуулсан. Н.О-ос 50.000.000 төгрөг авсан, өөр мөнгө аваагүй...» гэх мэдүүлэг /2-р хх-ийн 187-188/,

2013 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн №01 дүгээр шинжээчийн дүгнэлтэд “... Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлд: “Албан татвар ногдох орлого 1. Энэ хуулийн 5.3-д заасан албан татвар төлөгчийн тухайн жилд Монгол Улсын нутаг дэвсгэрт болоод гадаад улсад олсон орлогод албан татвар ногдоно..., 3. Албан татвар төлөгчийн

дараах орлогод албан татвар ногдоно. 3.1. Үйл ажиллагааны орлого...», 8 дугаар зүйлд: «Үйл ажиллагааны орлого...1.2. Эрх борлуулсны орлого... 8.2. Эрх борлуулсны орлогод эрх бүхий байгууллагаас олгосон тодорхой төрлийн үйл ажиллагаа эрхлэх эрх, эсхүл эд хөрөнгө эзэмших, ашиглах эрхийг хуульд заасан хэлбэрээр бусдад төлбөртэй шилжүүлснээс олсон орлогыг хамааруулна», 16 дугаар зүйлд: «Албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох. 16.3. Дараах орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо тухайн орлого тус бүрийн нийт дүнгээр тооцно..., 3.б. Эрх борлуулсны орлого..., 17 дугаар зүйлд: «Албан татварын хувь хэмжээ. 2. Албан татвар төлөгчийн дараарь орлогод дор дурдсан хувиар албан татвар ногдуулна. 2.7. эрх борлуулсны орлогод 30 хувиар...», 21 дүгээр зүйлд: «21.5 Энэ хуулийн...17.2.7...д заасан орлогод ногдох албан татварыг мөн хуулийн 4.1.6-д / Суутгагч гэж албан татвар төлөгчид олгосон орлогод энэ хуулийн дагуу албан татвар ногдуулан суутгаж, улсын болон орон нутгийн төсөвт шилжүүлэх эрх бүхий этгээдийг;.../ заасан суутгагч ногдуулан суутган авч ажлын 7 хоногийн дотор төсөвт шилжүүлнэ» гэж заасан байна. Энэ хуулийн дагуу лицензийг худалдан авагч тал худалдагч талд олгох орлогоос 30 хувийн татвар /эрх борлуулсны орлогын албан татвар/ суутган төсөвт шилжүүлэх үүрэгтэй байна. «Т» бүлэг компаниуд нь худалдан авсан лицензүүдийн орлогыг олгохдоо 5262Х лиценз бүхий «АТ» ХХК-ийг худалдан авахдаа олгосон орлогоос 375.8 сая төгрөгийг суутган төсөвт төлсөн ба бусад иргэн, аж ахуйн нэгжээс авсан лицензийн төлбөрийг шилжүүлэхдээ эрх борлуулсны орлогын албан татварыг суутган төсөвт төлөөгүй байна. «Т» бүлэг компаниуд нь байгуулагдсан үеэсээ хойш ихэнх нь татварын шалгалтад хамрагдаагүй ба дээрх лиценз шилжүүлэгч компани, иргэдийг татварын албаны шалгалтанд хамруулан уг компани иргэд өөрсдөө эрх борлуулсны орлогын албан татварыг төлсөн эсэхийг тогтоох нь зүйтэй гэж үзэж байна. Харин «ТРС» ХХК-нд «АА» ХХК-аас шилжүүлсэн лицензүүдийн төлбөр 550.000 америк доллар буюу 687.160.0 мянган төгрөгийн орлогоос эрх борлуулсны орлогын албан татвар 206.137.8 мянган төгрөгийг төсөвт төлөх нь зүйтэй байна...» гэжээ. /2-р хх-ийн 221, 3-р хх-ийн 25/,

Шинжээч П.С-гийн «...Энэ хэрэгт

шинжээчийн дүгнэлт гаргахад миний хувьд «Т» компани болон түүний охин компаниуд болох 39 аж ахуйн нэгжийн татварын албанд гаргадаг санхүүгийн татварын тайланг үзэж шалгасан юм. Үүнд одоогоор үйл ажиллагаа явуулдаг компаниуд байхгүй байсан. Уул уурхайн үйл ажиллагаа явуулдаг 10 орчим аж ахуйн нэгж байсан эдгээр 10 аж ахуйн нэгжийн нэр дээр 50 орчим ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй байсан. Х.А-ын хувьд эзэмшилтэй дээрх тусгай зөвшөөрөлтэй компаниуд нь ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлүүдийг бусдаас 1-3 сая төгрөг, дээд тал нь 10 сая хүртэл төгрөгөөр худалдах, худалдан авах гэрээгээр худалдаж авсан байдаг эдгээрийг компанийн санхүүгийн болон бусад баримт гэрээ, мөн Х.А-тай хийсэн ярилцлагын явцад дээрх гэрээнүүд худлаа 1-10 хүртэлх сая төгрөгөөр ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг худалдах худалдан авах гэрээг хуурамчаар хийдэг байсан нь харагдаж байсан. Нийтдээ 14 компаниас 30 орчим хайгуулын тусгай зөвшөөрөл худалдаж авсан байна. Шинжээчийн дүгнэлтэд тусгасан байгаа. Ингэж тусгай зөвшөөрөл худалдаж авахдаа аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар 30 хувийг суутган авч татварт төлсөн аж ахуйн нэгж байхгүй байсан. Үүнд баримтаар буюу хийгдсэн гэрээний дагуу 6 аж ахуйн нэгж байгууллагын 12 ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг 8.674.814.000 худалдан авсан. Үүнээс аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар 30 хувийн татварт 2.602.444.000 төгрөгийг суутган авч төлсөн байх ёстой. Х.А-тай шинжээчийн дүгнэлт гаргах явцад ярилцсан. Ярилцлагаар 8 аж ахуйн нэгжээс худалдан авсан 18 ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг 2.941.750.000 төгрөгөөр худалдан авсан, эрх борлуулсны албан татварт 882.525.000 төгрөгийг суутган авч төсөвт төлсөн байх ёстой. Мөн «АТ» ХХК-аас «ТЭ» ХХК руу 1 тусгай зөвшөөрлийг 3.758.700.000 төгрөгийг худалдан авсан мөнгийг шижлүүлэхдээ 10 хувийг татварт 375.800.000 төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байсан. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулиар эрх борлуулсны орлогын албан татварт 10 хувиар биш 30 хувиар суутгаж авах ёстой. «АА» ХХК-ийн 3 тусгай зөвшөөрлийг «ТРС» ХХК нь төгрөгөөр худалдан авсан. Үүний 30 хувийн татвар нь 206.137.800

төгрөг болж байсныг бас төлөөгүй. Ингээд нийт 12.303.690.000 төгрөгөөр тусгай зөвшөөрөл худалдсаны аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлогын албан татвар болох 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөх ёстой байсан...» гэх мэдүүлэг /3-р хх-ийн 29-31/ зэрэг баримтуудаар тогтоогдож байна гэж үзэж яллах дүгнэлт үйлдэн хэргийг шүүхэд ирүүлсэн боловч хавтаст хэрэгт авагдсан болон шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судлагдсан нотлох баримтуудын хүрээнд түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэж үзэх хангалттай үндэслэл тогтоогдохгүй байна.

Учир нь, улсын яллагчаас шүүгдэгч Х.А-ыг шинжээчийн дүгнэлтээр гол баримт болгон яллаж байгаа бөгөөд 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01 дугаартай шинжээчийн дүгнэлт /2хх-ийн 221-225/ нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаж гараагүй байна гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Б-гийн албан бичгээр Нийслэлийн татварын газрын Хяналт шалгалтын хэлтсийн Татварын улсын байцаагч Б.Х, Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн Татварын улсын байцаагч Б.Ба, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн Татварын улсын байцаагч О.Ц нарыг албан ёсоор томилсон атал Шүүх шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т «Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлт гаргаж, шинжилгээ хийхээр томилогдож байгаа / тухайн байгууллагаас томилсон гэж ойлгоно/ шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийг дуудан ирүүлж, түүний биеийн байцаалт, мэргэжил, чадвартай танилцан, сэжигтэн, яллагдагч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тогтоохоос гадна шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана» гэж заасныг зөрчиж Авлигатай тэмцэх газраас хууль зүйн үндэслэлгүйгээр томилогдсон шинжээч нарыг хүлээн авах боломжгүй гэж үзэн Шүүх шинжилгээний тухай хуулийг зөрчин Чингэлтэй дүүргийн Татварын улсын байцаагч П.С, Ц.Б, Нийслэлийн Татварын улсын байцаагч Ц.Ү нарыг нэр заан томилуулах талаар хүсэлт гаргасан бөгөөд дээрх нэр бүхий шинжээч нарыг холбогдох

албан тушаалтан томилоогүй байхад тэдгээр шинжээч нар дүгнэлт гаргасан нь хууль бус байна. Шүүхийн хэлэлцүүлэгт шинжээч П.С, Ц.Б нар нь шинжээчийн дүгнэлтийг «Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн шүүхийн тогтоолд үндэслэж гаргасан, ялтан Х.А-тай ярилцлага хийх замаар хохирлыг ойролцоогоор тооцож гаргасан, хэрвээ бидний гаргасан дүгнэлт буцаад акт болох юм бол захиргааны зөрчил гэж тооцож болно...» гэж мэдүүлсэн нь хөтөлбөргүй үнэн зөв нотлох баримтад тулгуурлан дүгнэлтээ гаргаж чадаагүй, мөн ойлгомжгүй, эргэлзээтэй байгаагаас гадна шинжээч нар өөрсдийн дүгнэлтийг хууль зүйн хувьд тайлбарлаж чадахгүй байсан байна. Мөн шүүх хуралдаанд ялтан Х.А-ын «би эрх борлуулаагүй, худалдсан улсууд нь компани, тусгай зөвшөөрөл, хувьцаагаа зарж өөрсдөө ашиг орлого олсон байхад зөвхөн надаас нэхээд байгаа нь хачирхалтай, би үйл ажиллагаа явуулж ашиг олоогүй байхад орлого эд хөрөнгийг нуусан, оршин суугаа газар хаягаа өөрчлөн татвар төлөхөөс зайлсхийсэн гэж байгаа нь үндэслэлгүй юм...» гэсэн мэдүүлэг,

Ялтан Х.А шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар өгсөн мэдүүлэгтээ «...Одоо би прокурорын надад үүсгэн, энэ шүүх хурал болж байгаа татвараас санаатай зайлсхийсэн, ...гэх хэргийн талаар тайлбар өгье. Прокурор намайг яллах дүгнэлтдээ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлого 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөлгүй онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн гэж буруутгаад, Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2-т зааснаар татвар төлөхөөс зайлсхийсэн гэсэн зүйл ангиар яллах үндэстэй гэжээ. Эрүүгийн хууль энд байна, би үүнийг олон удаа уншиж үзсэн. Орлого олсон хүн татвараа төлөх ёстой. Гэтэл надад олсон орлого байхгүй. Тэгээд энд суутгагч гэдэг үг байхгүй. Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйл. Татвар төлөхөөс зайлсхийх. «166.1.Татвар ногдох их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нуух, тэдгээрийн тоо хэмжээг зориуд бууруулан мэдээлэх, байнга оршин суугаа газар, хаягаа өөрчлөх зэргээр албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн бол эд хөрөнгийг хураах буюу хураахгүйгээр, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг...» гэх мэтчилэн цаашаа явж байгаа.

«166.2.Энэ хэргийг давтан үйлдсэн, эсхүл татвар ногдох онц их хэмжээний орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, бусад зүйлийг нуусан бол эд хөрөнгийг хурааж ...» гээд шийтгэлүүд явж байгаа. Энд надад олсон орлого байхгүй, суутгагч гэдэг үг энд байхгүй. Би татвар ногдох ямар ч эд хөрөнгө, их хэмжээний орлого, ажил үйлчилгээг хэнээс ч нуугаагүй. Миний үйл ажиллагаа бүгд ил тод явагдсан. Буруу зөрүү мэдээлсэн зүйл огт байхгүй. Оршин суугаа хаягаа өөрчлөөгүй. Иймд прокурорын чухам ямар орлого нуусан гэж буруутгаад байгааг би асууж тайлбарлуулмаар байна. Би орлого олоогүй. Өөрийн олсон боловсрол, туршлага, мэдлэгийн хүрээнд эх орныхоо хөгжилд хөг нэмэх гэсэн олон мянган Монголчуудын адил чадах ядахаараа төсөл бичиж, гадаадынхан хийж болдог ажлыг яагаад Монгол хүн хийж болдоггүй юм бэ гэсэн бодолд хөтөлгдөн гадаадын хөрөнгө оруулагчид, банк санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулалтын сангуудтай олон жил тууштай уулзаж, хэлэлцээр хийж, тэдний итгэлийг олон Монгол орондоо өнөөг хүртэл 70 гаруй сая ам долларын буюу 100 гаруй тэрбум төгрөгийн гадаадын хөрөнгө оруулалтыг татаж ажилласан. Үүнийг би өчигдөр эхлээд өнөөдөр ийм болгосон юм биш. Үүнийг би 1990 онд «Ж» ХХК-д ачигчаар ажиллаж эхлээд, 25 жил хөдөлмөрлөж байж өөрийн хамт олны нөр их хөдөлмөрийн дэмтэйгээр босгосон юм. Үүний зах зухаас санхүүгийн шинжээч нар дүгнэлтдээ тусгахдаа ашигт малтмалын хайгуул, шинжилгээ судалгааны ажилд 38 тэрбум төгрөг зарцуулсан байна гэж дүгнэх жишээтэй. Эдгээр нь дандаа өндөр эрсдэлтэй хөрөнгө оруулалт. Үйл ажиллагаа явуулаад орлого олчихсон, түүнийгээ нуун далдалсан зүйл огт байхгүй. Би ямар нэгэн буруу мэдээ гаргасан зүйл огт байхгүй. «Т» бүлэг компаниудын эзэмшилд байгаа ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын зөвшөөрлүүдийг олон аж ахуйн нэгжүүд, компаниудын хувьцааг худалдаж авснаар нэг дор цуглуулсан. Компанийн хувьцааг худалдах, худалдан авах гэрээ хийж, тухайн үед Ашигт малтмалын газраас шаардаж байсан материалуудыг бүрдүүлээд, жишээ нь мэдээлэл худалдаж, худалдан авах гэрээг Ашигт малтмалын газрын гаргасан маягтыг бөглөөд, тухайн үед үйлчилж байгаа хуулийн дагуу гэрээ хийж авч байсан.

Мэдээлэл худалдан авах гэрээ бол аж ахуйн нэгжийн хооронд хийгддэг гэрээ.

Прокурор намайг тусгай зөвшөөрөл авсан гэж буруутгах юм. Энэ боломжгүй зүйл шүү дээ. Тусгай зөвшөөрлийг зөвхөн хуулийн этгээд эзэмшдэг. Би компаниудын хувьцааг худалдаж авч байсан. Авсан компаниудыг «Т» бүлэг хөрөнгө оруулалт болгон нэгтгэж байсан. Худалдаж авсан компаниуд тусгай зөвшөөрөл эзэмшиж байсан. Ганц нэг тохиолдолд тусгай зөвшөөрөл шилжсэн. Ашигт малтмалын эрэл хайгуулын салбар асар өндөр эрсдэлтэй, асар их зардал өртөгтэй ажил тул гадны хөрөнгө татахаас өөр аргагүй байсан. Гадаадаас чадварлаг, туршлагатай, мэргэжлийн багтай хамтрах ёстой. Гадныхан асар өндөр шалгуураар хөрөнгө оруулалт хийхийн өмнө нягталдгийг ойлгосон байсан тул компаниуд худалдаж авахдаа, гэрээ хэлцэл хийхдээ нэр хүндтэй, туршлагатай хуулийн товчоо, компаниар дүгнэлт гаргуулдаг байсан. «ЛШ», «Ц» гэх мэтийн хуулийн фирмээр эрх зүйн талаас нь хянуулж, дүгнэлт гаргуулаад авч байсан. Хувьцаагаа хүмүүс үнэлээд худалдана, би үнийг нь төлнө. Тэдгээр хүмүүс энэ эрэл хайгуулын ажил асар их зардалтай, эрсдэлтэй ажил байна, компанийг аваач эсвэл хамтраад цааш нь гадны хөрөнгө оруулалт татаад аваад яваач, бид ачаагаа дийлэхгүй байна гэдэг байсан. Ихэнх хэлэлцээрүүдийг эдийн засгийн хямралын үед хийж, компаниудыг авсан. Өөрөө ч тэр үед эрсдэлээ буруу тооцоолоод хямралын дайрлагад өртөөд 2009-2010 онуудад ачаандаа дийлдэх шахаад, өөрийн орон сууцаа барьцаалж зээл аваад, ажилчдынхаа цалинг тавиад явж байсан. Хэдэн монгол хүнээс компанийг нь тохирсон үнээр аваад тэднийг мөнгөтэй төгрөгтэй болгосноороо буруутгагдана гэж юу байхав дээ. Хэрэв тухайн үед би тэдгээр гэрээнүүдийг хийгээгүй бол нөгөө л Л овогт эсвэл В овогт нь тэр компаниудыг нь авчихсан, тэдгээр нь өнөөдөр 100 хувь гадныхны мэдэлд явж байх байсан болов уу. Би өөрөө тусгай зөвшөөрөлтэй компани зарж байсангүй. Би өөрийн үүсгэн байгуулсан компанид хөрөнгө оруулалт татаж байсан. Өөрийн компанийн хувьцааг арилжихдаа өөрөө мөнгө авч байсангүй, үүссэн өр зээлээ төлсөн, мөн бодит хөрөнгө оруулалт татсан. Мэдээлэл худалдах худалдан авах гэрээг шинжээч нар хуурамч гэрээ гэж дүгнэснийг ойлгохгүй байна. Ашигт малтмалын газар тусгай зөвшөөрлийг шилжүүлэхдээ Мэдээлэл худалдах, худалдан авах гэрээ байгуулахыг шаарддаг. Энэ гэрээг хийхгүйгээр тусгай

зөвшөөрөл шилжихгүй. Хүмүүст яагаад их хэмжээний мөнгө өгдөг вэ гэж та бүхэн асууж магадгүй. Тусгай зөвшөөрөлтэй компанитай хүмүүс энэ компанийг дээр хэлсэнчлэн цаашид аваад явах боломжгүй боллоо, та гадны хөрөнгө оруулалттай бол үүнийг, эхлүүлсэн ажлыг аваад яваач гэдэг. Өөрсдийн оруулсан хөрөнгө оруулалтаа үнэлдэг. Компани өөрийн гаргасан мөнгөнөөс алдагдалгүй зарчихмаар байна гэдэг байсан. Би тэр компанийн хувьцааг аваад, мөнгийг нь төлчөөд, хүний мөнгийг яаж суутгаад дансанд хадгалах юм бэ Монголд үйлчилж байгаа хуулиар ийм боломж, эрх надад байхгүй шүү дээ. Хувь хүний орлогын албан татварын хуульд ийм заалт байхгүй. Хүнд мөнгө өглөө гэж прокурор намайг буруутгахгүй биз дээ. Хүнд мөнгө төллөө гэж хүнийг буруутгадаг хууль манай улсад байхгүй биз дээ. Би орлого олоогүй. Бусдын олсон орлогын төлөө би эрүүгийн харуцлага хүлээх тогтолцоо дэлхийн аль ч оронд байхгүй гэдэгт би итгэлтэй байна. Тэр тусмаа хүнлэг ардчилсан нийгмийн замд эргэлт буцалтгүй орсон Монгол улсад байхгүй гэдэгт итгэлтэй байна. Энэ олон ажил эхэлсэн, энэ олон тусгай зөвшөөрөлтэй компаниуд цуглуулсан нэгэн гэж яллах гэж байгаа бол би нэгэн тайлбар хийх нь зөв гэж бодож байна. Би дээр хэлсэн ашигт малтмалын эрэл хайгуулын ажил асар их эрсдэлтэй ажил. Энэ хөрөнгө оруулалтыг хийдэг, энэ эрсдлийг үүрдэг хөрөнгө оруулагчид гэж маш цөөн тооны мэргэшсэн хөрөнгө оруулагчид байдаг. Тэдгээр нь өөрийн эрсдэлийг маш нарийн тооцоод хөрөнгө оруулалт хийх эсэх шийдээ гаргадаг. Тэд ганц нэг лицензтэй компанитай харьцахгүй, тэдэнд хөрөнгө оруулалт хийхгүй. Үүнийг ойлгож мэдрээд Монгол хүн, Монголын нэг ч гэсэн компани гадныхны хийгээд байгаа ажлыг Монгол нутагтаа, өөрсдөө хэнээс ч дутахгүй хийж чадна гэсэн итгэлтэйгээр эдгээр ажлуудыг эхлүүлсэн. Энэ шийд ч зөв байсныг өнгөрсөн цаг хугацаа харуулсан. Би Холбооны Бүгд Найрамдах Герман улсад олон жил ажиллаж амьдарсан хүн. Олон жил гадаадад амьдрахдаа Монголынхоо сайхныг, Монголынхоо нөөц бололцоог сайтар олж харсан, мэдэрсэн. Эх орондоо нэг ч гэсэн сайн сайхан зүйл бүтээчих юмсан гэсэн эрмэлзлэл ээр дүүрэн яваа нэгэн. Энэ ч хүсэл эрмэлзлийнхээ хүчинд би Холбооны Бүгд Найрамдах Герман улсаас хөрөнгө оруулагч, Америкийн Нэгдсэн Улсын

хөрөнгө оруулалтын сан, Швейцарын банк бус санхүүгийн байгууллага, Австралийн уул уурхайн компаниудын мэргэжлийн багуудтай хамтран ажиллах гэрээ байгуулж, хөрөнгө санхүү босгож, 100 гаруй тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийлгэсэн байсан. Цаашид хэдэн зуун сая ам долларын хөрөнгө оруулалт татахад бэлэн болоод байсан. Цаашид олон мянган ажлын шинэ байр бий болгож, олон олон бүтээн байгуулалт эх нутагтаа босгоно гэж итгэлтэй явсан. Энэ бүх ажил, эдгээр хөрөнгө оруулалтууд, айсуу асан их бүтээн байгуулалтууд миний 25 жилийн хөдөлмөрийн үр шим, манай хамтрагч нар, хамт олны нөр их хөдөлмөрийн үр өгөөж юм. Эдгээр ажлууд эх орны маань хөгжил дэвшилд хөг нэмэх учиртай байсан. Ингэж ажиллахдаа би өөрөө болон миний гэр бүл, «Т» бүлэг компаниас нэг ч төгрөгийн ашиг орлого, цалин хөлс аваагүй. Энэ эхлүүлсэн ажлуудаас би өнөөдрийг болтол орлого олсон зүйл одоогоор алга. Ирээдүйд үр ашгаа өгөөд, ногдол ашиг гэх мэт үр шим нь ирэх байх гэж явсан. Харамсалтай нь намайг хорьсноос хойш эхлүүлсэн ажлууд зогсоод, ахин сэхэл авах эсэх нь тодорхойгүй болоод байна...» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Хохирогч, иргэний нэхэмжлэгч Ж.О шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар өгсөн мэдүүлтээ «...Миний хувьд Авлигатай тэмцэх газраас Х.А нарт холбогдох эрүүгийн хэрэгт иргэний нэхэмжлэгчээр томилж ирүүлнэ үү гэсэн хүсэлтийн дагуу Сангийн яамны Төрийн нарийн бичгийн даргын итгэмжлэгдсэн төөлөлөгчөөр томилогдон ирсэн. Гол асуудал нь лиценз шилжүүлсэн асуудал, эрх шилжүүлсэн асуудалтай холбоотойгоор татвар төлөөгүй байна гэдэг асуудалд шүүх хуралдаанд оролцож байна. Шинжээчийн дүгнэлттэй танилцсан. Татварт ногдох ёстой орлого буюу 3,6 тэрбум төгрөгийн татварын авлага. Үүнийг барагдуулаагүй байна гэдэгтэй холбоотой хэрэгт оролцож энэ мөнгийг нэхэмжлэх үүрэгтэй ирсэн үүнийг нэхэмжилж байна. Гэхдээ хамгийн гол асуудлуудыг шинжээч нар хэлэх байх гэж бодож байна. Нарийн асуудлыг би өөрөө сайн мэдэхгүй байна» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Гэрч Т.Ц шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар өгсөн мэдүүлэгтээ:

«...Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: “Т” энерги компанийн захирлаар хэзээнээс эхэлж

ажилласан бэ? гэхэд Гэрчийн хариулт: 2011 оны 04 дүгээр сарын 7-ны өдрөөс эхлэн ажилласан...Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Нягтлан бодох бүртгэлийн 1 дүгээр гарын үсэг зурна гэж ойлгож болох уу? гэхэд Гэрчийн хариулт: Болно...Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: 1.2 тэрбум төгрөгийн гүйлгээ байна. 2011 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр шилжүүлсэн байна, У “ТЭ” 2.2 тэрбум төгрөг, “АТ” 3.7 тэрбум төгрөгийн гүйлгээнүүд хийгдсэн байна. Энэ гүйлгээг та хийсэн үү, өөр хүн хийсэн үү? гэхэд Гэрчийн хариулт: Мөнгө гүйлгээний эхний 2 гүйлгээг Х.А захирал хийсэн. Тухайн үед захирлаар томилогдоод байсан болохоор санхүүгийн гарын үсэг авч чадаагүй байсан. “АТ” гүйлгээг би хийсэн... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Суутгал хийгдсэн үү? гэхэд Гэрчийн хариулт: “АТ” суутгал нь хийгдээд явсан, 2011 оны гүйлгээний баланссуудыг тухай үед нь тушаагаад явж байсан. Ямар нэг татварын асуудал манай компани дээр ирээгүй байгаа. Татварын шалгалт “АТ” дээр эхэлж байгаа... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: “АТ” мэдээлэл худалдах худалдан авах гэрээ хийсэн үү, хувьцаа худалдан авах гэрээ хийсэн үү? гэхэд Гэрчийн хариулт: Компанийн хувьцаа худалдаж авах гэрээ хийсэн...» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Шинжээч П.С шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар өгсөн мэдүүлэгтээ «... Шинжээчийн дүгнэлтэд бид тодорхой жагсаалтаар шинжээчийнхээ дүгнэлтийг гаргаад ийм ийм компаниудын эдийн засгийн үнэлгээнд нь шинжилгээ судалгаа хийсэн гээд гаргасан байгаа. Х.А энд 100 хувь эзэмшилтэй ч байгаа, тодорхой хувь эзэмшдэг ч компани байгаа, доод тал нь 30 хувь эзэмшдэг компани байгаа. Ихэнх нь 100 хувь Х.А-ын эзэмшлийн компаниуд байгаа. Би саяын таны асуусан асуултад хариулъя. Ер нь нягтлан бодох бүртгэлийн стандартаар биет бус хөрөнгөд юу бүртгэх вэ гэхээр лицензийг худалдаж авсан үнэ, тухайн жилийн лицензийн төлбөрүүдийг оруулаад биет бус хөрөнгөд бүртгэнэ. Харин хайгуулын үнэлгээний хөрөнгөд юу бүртгэх вэ гэхээр тухайн онуудад гарч байгаа зардлуудыг бүртгэдэг. Гэтэл... СН, Г М гээд бүх компаниуд яаж бүртгэсэн бэ гэхээр лицензийн төлбөрийг худалдаж авсан үнэ дээр нь лицензнийхээ төлбөрийг биет бус хөрөнгө дээрээ бүртгээд, хайгуул

үнэлгээний хөрөнгөн дээр гарч байгаа зардлуудаа бүгдийг бүртгэсэн. Бид эдийн засгийн үзүүлэлтүүд гаргаж өгсөн. Миний бичсэнээр олон компани хайгуул үнэлгээ дээр бүртгэсэн байгаа. Энэ дээр маргаад байх юм ерөөсөө байхгүй... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Та нар биет бус хөрөнгө, тусгай зөвшөөрлийн мэдээлэл худалдаж байгаа гэрээ эрх, хувьцаа худалдаж байгаа гэрээ бас эрх гэж та нарын дүгнэлтэд байна. Энэ хуулинд эрх борлуулсны орлого тусдаа, хувьцаа үнэт цаас борлуулсны орлого тусдаа, биет бус хөрөнгө борлуулсны орлого тусдаа байна. Та нар энэ 3 заалтыг бүгдийг нь бөөгнүүлж байгаад эрх борлуулсны орлого гэж гаргаж ирээд байгаа. Жишээ нь Л.Д-ээс хувьцаа худалдан авах гэрээ хийсэн байгаа. Эрх гээд дүгнэсэн. Компаниуд дотроо мэдээлэл худалдах, худалдан авах гэрээ хийсэн. Бас эрх гээд дүгнэсэн. Яагаад хуулинд тус тусдаа бичсэн зүйлийг бөөгнүүлж ганцхан болгож эрх борлуулсан орлого гэж үзэж байна вэ? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Энэ компани худалдаж байгаа тохиолдолд яг энэ хайгуулын тусгай зөвшөөрөл давхар худалдагдсан байдаг. Тухайн компанийн үнэ цэнэ юу вэ? Хайгуулын тусгай зөвшөөрлөөр явж байгаа. Х.А шүүх хуралд мэдүүлэхдээ тухайн компани санхүүгийн боломжгүйгээс болоод цаашид үйл ажиллагаагаа явуулах боломжгүй байгаа учраас та үүнийг худалдаад авчих гэсэн санал тавьсан гэж байсан. Гэтэл Х.А-ын худалдаж авсан компаниуд нь зөвхөн лицензийг нь аваад өөр компаниудад төвлөрүүлсэн. Хэрэв тухайн хүн үйл ажиллагаа явуулах байсан бол одоо болтол үйл ажиллагаагаа явуулаад явж байх ёстой байсан. Гэтэл лицензийг худалдаж аваад одоо болтол үйл ажиллагаа явуулаагүй «Х» тайлантай явж байгаа. ...Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Лиценз худалдсан гэдгийг та нар юугаар нотолж байгаа вэ? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Эрх гэдгийг Ашигт малтмалын хуульд 4.1.15-д хайгуулын тусгай зөвшөөрөл гэдэг нь энэ хуулийн дагуу ашигт малтмалыг эрэх, хайх, эрх олгосон баримт бичиг байна гээд заагаад өгсөн. Бид өөрсдөө нэгэнт хууль хэрэгжүүлж байгаагийн хувьд хүнийг хэлмэгдүүлэхгүй гэдэг талаас нь дандаа баримттай зүйлд тулгуурлан дүгнэлтээ гаргасан... Гэрээнүүдийг үзэхэд 2 давхар гэрээ хийгдсэн. Хувьцаа худалдах худалдан авах гэрээ, эрх шилжүүлэх гэрээ хийгдсэн байгаа, зарим нь

хэргийн материалд байгаа...Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Хувь хүн лиценз тусгай зөвшөөрөл худалдах эрх байгаа юу? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Хувь хүн гэж бичээгүй. Урд нь захирлууд ард нь компаниуд нь байгаа...Санаатай хийсэн үйлдэл байхгүй хуулийн дагуу ажлаа хийсэн... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: ...Д.С мэдүүлэхдээ Х.А-тай уулзсан, хайгуулын тусгай зөвшөөрлыг 2,9 тэрбум төгрөгөөр худалдаж авсан гэж мэдүүлсэн байна. Х.А тусгай зөвшөөрөл худалдаж авсан гэсэн баримт хаана байна вэ? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Энэ компаниудын захирал нь Х.А байсан. Тийм учраас Х.А худалдаж авсан гэж хэлсэн байх. Гэхдээ бид нар ард нь тайлбар бичихдээ хорих 461 дүгээр ангид очиж Х.А-аас ярилцлага авахдаа өөрийнх нь хэлснээр тайлбар гараар нь бичүүлж авсан... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: ...ойролцоо гээд 800.000 ам доллар гэсэн байна. Ойролцоо гэдэг нь баримтгүй гэсэн үг үү? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Х.А өөрийн гараар бичсэн тайлбар байгаа. Тийм учраас бид 3 ярьж байгаад ойролцоо гэх үү гэж байгаад бичсэн гэсэн байна. Ард нь Х.А-тай хийсэн ярилцлагын үед хэлсэн үнээр нь тооцов гэж бичсэн байгаа... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Таамаглаж, ойролцоо гэж дүгнэлт гаргаж болохгүй шүү дээ гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Бид таамаглаагүй, ойролцоо гэдгийг амаар нь, гэхдээ ард нь бид нар тайлбарыг нь хийсэн байгаа...Шүүгдэгчийн өмгөөлөгч Х.Базаррагчаагийн асуулт: Лиценз шилжүүлсэн мөртлөө наана нь хувьцаа гэсэн гэрээ хийсэн учраас бид нар лиценз шилжүүлсэн гэдгээр нь дүгнэлт гаргасан гэж хэлэх гэж байна уу? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Би өмнө нь хэлж байсан эрх шилжүүлэх гэрээ, худалдах, худалдан авах гэрээ гэж давхар хийдэг...Шүүгдэгчийн өмгөөлөгч Х.Базаррагчаагийн асуулт: Х.А 12 тэрбум төгрөгөөс хэдийг нь гаргасан бэ, ойролцоо гэдэг нь хэд байгаа вэ? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Ойролцоо 2.440.942.000 төгрөг нь Х.А-ын амаар байгаа, үүний 30 хувь нь 732.282.600 төгрөг... Шүүгдэгчийн өмгөөлөгч Х.Базаррагчаагийн асуулт: Х.А-аас авсан тайлбар дангаараа шинжилгээний объект болж чадах уу? гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Амаар ярилцлага авсан бол болохгүй байх гэж бодоод, хэргийн материалыг мөрдөн байцаагчаас бүрэн авч асуугаагүй. Байгаа өгсөн материалд нь

үндэслээд дүгнэлт гаргасан...Шүүгдэгчийн өмгөөлөгч М.Баяраагийн асуулт: Би та нараас энэ захиргааны зөрчил байх боломжтой юу гэж л асууж байна гэхэд Шинжээч Д.С-гийн хариулт: Хэрэв буцаад дүгнэлт акт болох хэмжээнд бол болно...» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

Шинжээч Ц.Б шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар өгсөн мэдүүлэгтээ «...Бид энэ хэрэгт шинжилгээ хийхдээ 3-лаа ажилласан. Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч н.Б-ын томилгоогоор Нийслэлийн татварын байцаагч Ц.Ү-гийн хамт бид 2 ажилласан. Тухайн үед дүгнэлт гаргахад Авлигатай тэмцэх газраас 12 асуулт тавьсан. Үүнээс өнөөдөр хэлэлцэж байгаа асуудалтай холбоотойгоор 5 дугаар асуудалд «Т» бүлэг компаниудын үүсгэн байгуулагдсан үеэс хойш ашгийн, нэмэгдсэн өртгийн, гаалийн татвар болон бусад төлбөр хураамжийг бүрэн төлсөн эсэх, үүнтэй холбогдох татварын алба, гаалийн газрын баримттай нь тулган шалгах гэсэн асуултын дагуу бид ашигт малтмалын лицензтэй холбоотой эрх борлуулсны орлогын албан татвар төлөөгүй байна гэсэн дүгнэлт гаргасан. Энэ дүгнэлтийг гаргахдаа Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль, татварын албанд мөрдөж байгаа дүрэм, журам, Улсын Дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимаас гарсан шүүхийн тогтоолыг баримтлан дүгнэлт гаргасан. Ашигт малтмалын лицензтэй холбоотой 12 тэрбум төгрөгийн татвар ногдох зүйлээс улсын төсөвт төлөх ёстой 3,6 тэрбум төгрөгийг төлөөгүй байна гэсэн дүгнэлт гаргасан. Үүнийг гаргахдаа бүгдийг нь Х.А-ын өөрийнх нь ярьсан хэлснээр гаргаагүй. Тухайн үед шинжилгээ хийх үед ирүүлсэн баримтууд, энэ компаниудын хооронд хийсэн гэрээ, шилжүүлсэн мөнгөний баримт болон бусад баримтуудыг үндэслэн гаргасан. Мөн хавтаст хэрэгт энэ талаарх тайлбарыг тодорхой бичиж өгсөн. Зарим компанийн лиценз шилжсэнтэй холбоотой эсэхийг тогтоох гэхэд бид нарт баримт байгаагүй. Х.А-тай шинжилгээ хийх явцдаа өөртэй нь уулзаж асууж ярилцсаны үндсэн дээр хийсэн дүгнэлт байгаа. Эдгээр нь хавтаст хэрэгт байгаа...Татвар зөвхөн орлого дээр тавьдаг зүйл биш. Татварыг нуусан гэж үзвэл зөвхөн орлого нуусан тохиолдолд татвар нуусан байна гэж үзэхгүй. Татвар ногдох зүйл гэж байгаа. Татвар ногдох

зүйлд Татварын ерөнхий хуулийн 6.1-д заасан орлого, эд хөрөнгө, бараа, ажил үйлчилгээ, тодорхой эрх, газар, түүний хэвлийн байгалийн баялаг, ашигт малтмалын нөөц, агаар, хөрс, усны бохирдол хамаарна гэж заасан...Тухайн үед Тг компанийн бүх санхүүгийн бичиг баримт, гэрээ, хэлцэл Авлигатай тэмцэх газарт ирсэн байсан. Тэр ирсэн баримтуудын дагуу үзсэн. Дээр нь санхүүгийн баримтуудын дагуу гэрээнүүд байсан. Тухайн компанийн захирал Х.А-тай өөртэй нь биечлэн уулзсан. Компанийн бүх бичиг баримт нь Авлигатай тэмцэх газарт байсан...Компанийн лицензтэй холбоотой асуудал зөвхөн Татварын албаны хууль гэж үзэхгүй нэг удаагийн хэлэлцэгдсэн асуудал биш. Манай татварын газрын маргаан таслах зөвлөлөөр болон Захиргааны хэргийн шүүхээр хэлэлцэгдсэн асуудлууд байдаг. Лицензтэй компани лицензээ шилжүүлэхдээ өмнөх гарсан шийдвэрүүдээс харахад халхавч маягийн гэрээ хийж байсан байна. Хувьцаа шилжүүлэх, компани шилжүүлэх гэх мэтээр. Эцсийн эцэст энэ компаниудын зарагдаж байгаа үнэ цэнэ юу байна гэхээр энд лиценз байна. Тийм учраас лиценз борлууллагдсан байна гэж үзэж, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр байгаа. Дээд шүүхийн хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2013 оны 09 дүгээр сарын 16-ны №134 дүгээр тогтоол, 2011 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн №230 дугаар тогтоолууд бүгд асуудлыг хэлэлцсэн... Татвар 2-40 хувь хүртэл тус тусдаа заалттай. Орлого дээр үү, татвар ногдох зүйл дээр үү, тодорхой эд хөрөнгө дээр үү гэдгээс хамаарна. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулинд эрх борлуулсны орлогод 30 хувийн татвар ногдуулна гэж заасны дагуу эрх борлуулсан гэж үзэж 30 хувийн татвар гэж үзсэн... Мөн Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.10-т хайгуулын тусгай зөвшөөрлийг энэ хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх эрх олгосон байна, мөн 4.1.16-д ашиглалтын тусгай зөвшөөрөл гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал ашиглах эрх олгосон гээд тус тус заасан байгаа... Орлогуудыг хэн, яаж төлөх талаар Татварын тухай хуулинд тодорхой зааж өгсөн байгаа. Тухайлбал, эрх борлуулсны орлогыг тухайн этгээд худалдаж аваад мөнгийг нь олгохдоо тэр мөнгөнөөс төлөх ёстой. Мөнгө олж байгаа буюу худалдаж авч байгаа этгээд 30 хувийн татварыг суутгаад, улсын төсөвт шилжүүлэх ёстой гэж заасан

байгаа. Тийм учраас энэ хүнийг суутгагч гэж заасан... Бид нарын гаргасан дүгнэлт биш. Татварын албаны хувьд гаргасан дүгнэлт... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ц.Цэрэнжээгийн асуулт: Хуульд ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийг биет бус хөрөнгө болгоод бичсэн байхад та нар яагаад эрх гэж үзээд байгаа юм бэ гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Лиценз биет бус хөрөнгө мөн, гэхдээ хуулиндаа эрх борлуулсны орлогоос татварыг суутгах хувь хэмжээ... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ж.Эрдэнэбулганы асуулт: Та нар дүгнэлт гаргахдаа ямар эх сурвалж ашигласан гэж хэлсэн бэ гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын хууль, Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ж.Эрдэнэбулганы асуулт: Та нар ямар эрх зүйн харилцаанд дүгнэлт гаргаж байгаагаа мэдэж байгаа юу, эрүүгийн гэмт хэрэгтэй холбоотой, эсвэл захиргааны журмаар маргаантай, эсвэл иргэний журмаар гэдгээ ялгаж ойлгож байна уу. Өөрөөр хэлбэл, та нар Захиргааны хэргийн хяналтын шатны шүүхийн тогтоолыг ярих гээд байх шиг байна. Эрүүгийн эрх зүй гэдэгт хууль хэрэглэдэг, хуулийг төсөөтэй хэрэглэдэггүй. Тийм болохоор Захиргааны хэргийн шүүхийн тогтоол ерөөсөө хамаа байхгүй. Манай улсад жишиг гэдэг зүйлийг хэрэглэдэггүй. Энэ бол Америкын Нэгдсэн улсын эрх зүйн тогтолцоотой улс оронд байдаг. Манай орон хууль хэрэглэдэг улс. Яагаад ийм зүйлийг жишиг болгосон юм бэ гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Тэрийг бид өөрсдийн ажлын практикт тулгуурлаж дүгнэлт хийсэн... Шүүгдэгчийн өмгөөлөгч Ж.Эрдэнэбулганы асуулт: Дээд шүүхийн тогтоол гэж бас хэлэх гэж байх шиг байна. Үндсэн хуулиас бусад хуулийг тайлбарлаж гаргасан Дээд шүүхийн тогтоолыг шүүгч хэрэглэдэггүй. Энэ бол тодорхой зүйлүүдийг тайлбарлахад үндэслэл болгодог болохоос дүгнэлт болгодоггүй. Та нарын ярьж байгаа Захиргааны хэргийн хяналтын шатны шүүхийн тогтоолыг жишиг болгосон юм шиг байна гэж ойлгож байна, зөв үү гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Болно... Шүүгдэгчийн өмгөөлөгч Р.Пүрэвлхамын асуулт: Х.А гэдэг хүн Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хууль зөрчсөн юм уу, Хувь хүний орлогын албан татварын хууль зөрчсөн үү гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Бид нар Х.А гэдэг хүн хууль зөрчсөн гэж

дүгнэлт гаргаагүй... Шүүгдэгчийн өмгөөлөгч Р.Пүрэвлхамын асуулт: Компани нь ямар холбогдох хуулийг зөрчсөн бэ гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль зөрчсөн... Шүүгдэгчийн өмгөөлөгч Р.Пүрэвлхамын асуулт: Ойролцоо гэсэн үнийн дүн чинь анхан шатны баримт байхгүй гэсэн үг үү гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Ойролцоо гэдэг нь лиценз нь шилжсэн, компанийн баримтууд бид нарт байгаа, гэхдээ хэдэн төгрөгөөр шилжүүлсэн гэсэн баримт байхгүй. Анхан шатны баримт байхгүй... Шүүгдэгч Х.А-ын асуулт: Энд би орлого олсон уу гэхэд Шинжээч Ц.Б-гийн хариулт: Орлого олоогүй. Татвар ногдох зүйл...» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/

“Тг” ХХК болон түүнтэй хамааралтай компаниудын нэр дээр бүртгэлтэй ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай 25 зөвшөөрлийн файлд үзлэг хийсэн тэмдэглэл /2-р хх-ийн 22-50/ зэрэг хавтаст хэрэгт авагдсан шүүхийн хэлэлцүүлэгт шинжлэн судлагдсан нотлох баримтуудын хүрээнд түүнийг гэмт хэрэг үйлдсэн гэх хангалттай үндэслэл тогтоогтохгүй байна.

Учир нь, улсын яллагчаас ялтан Х.А-ыг шинжээчийн дүгнэлтээр гол баримт болгон яллаж байгаа бөгөөд 2013 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01 дугаартай шинжээчийн дүгнэлт /2-р хх-ийн 221-225/ нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий байх хуулийн шаардлагыг хангаж гараагүй байна гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, Татварын ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Б-гийн албан бичгээр Нийслэлийн татварын газрын Хяналт шалгалтын хэлтсийн Татварын улсын байцаагч Б.Х, Сонгинохайрхан дүүргийн Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн Татварын улсын байцаагч Б.Ба, Сүхбаатар дүүргийн Татварын хэлтсийн Хяналт шалгалтын тасгийн Татварын улсын байцаагч О.Ц нарыг албан ёсоор томилжээ.

Гэтэл Шүүх шинжилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-т «Шинжилгээг шүүхийн шинжилгээний байгууллагаас гадуур хийлгэх бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамж, хүсэлт гаргаж, шинжилгээ хийхээр томилогдож байгаа /тухайн байгууллагаас томилсон гэж ойлгоно/ шүүхийн шинжилгээний байгууллагад ажилладаггүй шинжээчийг дуудан ирүүлж, түүний биеийн байцаалт, мэргэжил,

чадвартай танилцан, сэжигтэн, яллагдагч, хохирогчтой ямар харилцаатай болохыг тогтоохоос гадна шинжээчээс татгалзан гарах үндэслэл байгаа эсэхийг шалгана» гэж заасныг зөрчиж Авлигатай тэмцэх газраас хууль зүйн үндэслэлгүйгээр томилогдсон шинжээч нарыг хүлээн авах боломжгүй гэж үзэн Шүүх шинжилгээний тухай хуулийг зөрчин Чингэлтэй дүүргийн Татварын улсын байцаагч П.С, Ц.Б, Нийслэлийн Татварын улсын байцаагч Ц.Ү нарыг нэр заан томилуулах талаар хүсэлт гаргасан бөгөөд дээрх нэр бүхий шинжээч нарыг холбогдох албан тушаалтан томилоогүй байхад тэдгээр шинжээч нар дүгнэлт гаргасан нь хууль бус байна.

Шүүхийн хэлэлцүүлэгт шинжээч П.С, Ц.Б нар нь «Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн шүүхийн тогтоолд үндэслэж гаргасан, Х.А-тай ярилцлага хийх замаар хохирлыг ойролцоогоор тооцож гаргасан, хэрвээ бидний гаргасан дүгнэлт буцаад акт болох юм бол захиргааны зөрчил гэж тооцож болно...» гэж мэдүүлсэн нь хөтөлбөргүй үнэн зөв нотлох баримтад тулгуурлан дүгнэлтээ гаргаж чадаагүй, мөн ойлгомжгүй, эргэлзээтэй байгаагаас гадна шинжээч нар өөрсдийн дүгнэлтийг хууль зүйн хувьд тайлбарлаж чадахгүй байсан, мөн шүүх хуралдаанд Х.А-ын «би эрх борлуулаагүй, худалдсан улсууд нь компани, тусгай зөвшөөрөл, хувьцаагаа зарж өөрсдөө ашиг орлого олсон байхад зөвхөн надаас нэхээд байгаа нь хачирхалтай, би үйл ажиллагаа явуулж ашиг олоогүй байхад орлого эд хөрөнгийг нуусан, оршин суугаа газар хаягаа өөрчлөн татвар төлөхөөс зайлсхийсэн гэж байгаа нь үндэслэлгүй юм...» гэх мэдүүлэг, Х.А-ын өмгөөлөгч нарын «Улсын яллагчаас ашиг сонирхлын зөрчилтэй шинжээчийн дүгнэлтийг гол баримт болгон яллаж байгаа нь үндэслэлгүй юм. Татварын улсын байцаагчийн акт тавигдаагүй байхад шууд мэргэжлийн бус хүмүүсээр шинжээчийн дүгнэлт гаргуулсан нь буруу... Шинжээчийн дүгнэлтэд хэдэн төгрөгийн татвараас зайлсхийсэн болохыг Х.А-аас шинжээч нар хорих ангид нь очиж ярилцлага хийн ойролцоогоор хохирлын дүнг гаргасан нь эмгэнэлтэй» гэж тайлбарласныг шүүх үндэслэлтэй гэж үзэв.

Шинжээч нарт дээрх мөрдөн шалгах эрх олгоогүй бөгөөд хууль бус ажиллагаа явуулсан нь шүүхийн хэлэлцүүлгээр нотлогдон тогтоогдсон, Татварын ерөнхий

хууль болон Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн холбогдох зүйлд зааснаар албан татвар төлөгчийн үйл ажиллагааны дараах орлогод буюу хувьцаа үнэт цаас борлуулсан орлого, биет бус хөрөнгө борлуулсан орлого нь тус тус албан татвар ногдох орлогод хамаарах тул нэр Х.А-т компанийнхаа эрх, хувьцааг төлбөртэйгөөр шилжүүлсэн этгээд нь өөрийн хөрөнгө борлуулсны орлогоос хууль тогтоомжид заасан хувь хэмжээгээр ногдох албан татварыг төлөх ёстой.

Ялтан Х.А нь нэр бүхий аж ахуйн нэгжүүдийн эрх, хувьцааг гэрээний дагуу төлбөртэйгээр шилжүүлэн авсны үнэд тухайн хөрөнгө борлуулсан орлогоос тооцогдох татвар шингэсэн эсэх, худалдан авсан үнэд тооцогдох татварын хувь хэмжээг тооцон шингээсэн бол татварыг эд хөрөнгөө худалдан борлуулж орлого олсон этгээд төлөх бөгөөд энэ талаар зохих ажиллагаа хийж, шалган тогтоосон үндэслэл бүхий нотлох баримт хэрэгт авагдаагүй байна.

Иймд ялтан Х.А-т холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2-т зааснаар татвар төлөхөөс зайлсхийсэн гэж прокуророос яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т «эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд ...эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ» гэж заасныг баримтлан мөн хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэлтэй

Цагаатгагдсан этгээд Н.О нь Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудын сонгон шалгаруулалтад «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д Х.А-ын эзэмшлийн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий “Р.Г.В”, Зайсангийн тойруу ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлж, хээл хахууль өгөх гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлэн хамжигчаар оролцсон гэмт хэрэг үйлдсэн гэх боловч,

Цагаатгагдсан этгээд Н.О-ын шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар мэдүүлсэн: «...»

би энэ эрүүгийн хэрэгт Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1 гэсэн зүйл ангиар яллагдагчаар татагдаж шалгагдаж байгаа. Миний бие Х.А захиралтай 2007 оноос хойш хамтран ажиллаж байна. Би өөрөө эрх зүйч мэргэжилтэй, энэ чиглэлээр цагдаагийн байгууллагад ажиллаж байсан. ...Эхлээд би 2 жил орчим менежерээр ажиллаж байгаад 2009 оноос ерөнхий менежер болон дэвшин ажилласан. Тухайн 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдөр захирал надад энэ байрыг Ц.Ч гэж хүнд шилжүүлж өгөх хэрэгтэй байна чи энэ ажлыг хариуцаж аваад үлд. Би бол ажил ихтэй төрийн байгууллагаар нааш цааш яваад, байрны асуудал гээд явах зав надад байхгүй гэж хэлсэн. Тэгэхэд нь би таны өмчилж байгаа захиран зарцуулах эрхтэй энэ байрыг хуулийн дагуу би шилжүүлэх боломжгүй юм. Тийм учраас хэрвээ би энэ ажлыг хариуцаж аваад шийдээд хийх ёстой бол та надад итгэмжлэл олгох ёстой гэдгийг захиралд тайлбарласан. Захирал үүнийг зөвшөөрч надад итгэмжлэл олгосон. Хавтаст хэрэгт итгэмжлэл авагдсан байгаа. Анх удаа итгэмжлэл аваад Ц.Ч гэж хүний утсыг надад захирал надад өгсөн. Энэ итгэмжлэлийн дагуу Ц.Ч гэдэг хүнд энэ байрыг тухайн үед нь шилжүүлж өгсөн. Тухайн үед энэ Ц.Ч гэдэг хүн энэ итгэмжлэлийг авсан, итгэмжлэл авсныхаа дараа би захирлаас асууж байсан. Захирлаа худалдах, худалдан авах гэрээгээр юм уу бэлэглэлийн гэрээгээр байр шилжүүлэх боломжтой.

Аль хувилбараар нь шилжүүлэх вэ гэхэд захирал мөнгө бага зарлагдахаар нь хийж болно гэсэн зөвшөөрөл надад олгож байсан. Тэгэхэд нь би тухайн үед байрыг нь 100 сая төгрөгөөр үнэлээд бэлэглэлийн гэрээгээр тэр орон сууцыг Ц.Ч-д шилжүүлээд би шилжүүлсэнтэй холбоотой баримтыг үл хөдлөх хөрөнгийн Хан-Уул дүүрэг хариуцсан цонхонд өгөөд тэгээд би өөр зүйл мэдэхгүй. Гэрчилгээ гарсны дараа Ц.Ч өөрөө гэрчилгээ гарсан байна лээ, би гэрчилгээгээ авсан шүү гэж надад хэлж байсан. Би «Т» компанид хөдөлмөрийн гэрээтэй ажилладаг. Гэрээний дагуу ажиллаж байгаа, цалин хөлс авч, хөдөлмөрөө үнэлүүлж ажиллаж байгаа хүн учраас би захирлаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх үүрэгтэй. Тэгээд ч захирлын надад өгч байгаа энэ итгэмжлэл бол хуулиар хориглогдоогүй зүйл. Иргэний хуулийн 62.3 дахь хэсгийн заалтыг үндэслэж итгэмжлэл авсны дагуу захирлын өгсөн үүрэг даалгаврыг биелүүлсэн хүн. Би бас хоригдсон. Энэ

асуудалд би жил гаран шалгагдлаа, миний ар гэр, миний үр хүүхдүүд, намайг гэмт хэрэг хийсэн, янз бүрийн юм хийсэн юм шиг бодоод хэвлэл мэдээллээр бичээд, би Монгол улсад ажиллаж хөдөлмөрлөх эрхтэй, үр хүүхдээ өгсөн хүмүүжүүлж, сурч боловсрох боломжоор нь хангах эрхтэй. ...Мөн Эрүүгийн хуулийн 269.1-д өөртөө ямар нэг байдлаар ашигтай нөхцөл байдал үүсгэхийн тулд авлига өгсөн гэж. Энэ байрыг шилжүүлээд надад наалдсан зүйл юу ч байхгүй. Миний цалин нэмэгдээгүй, би ямар нэгэн байдлаар тендерт, тэр шарга 3, нэмэгт 6 гэсэн тендер л яриад байна. Тэр тендер өнөөдрийг хүртэл 6 жилийн хугацаанд эцэслэн шийдэгдээгүй л байгаа. Батлагдаагүй байгаа тендер. Тийм учраас эрхэм шүүгчид минь үнэн зөвийг тунгааж, хар цагааныг ялгаж, энэ хэргийг минь хэрэгсэхгүй болгож, бид нарын энэхүү гомдлыг хүлээж авна гэж найдаж байна» гэсэн мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/ Н.О-ын «Тг» ХХК-нд ерөнхий менежерээр ажилладаг болохыг тодорхойлж «Тг» ХХК-ийн захирал Ё.Оюунаас гаргасан ажил байдлын тодорхойлолт /7-р хх-ийн 6/, «Тг»-ын захирал Х.А-ын захирлын тушаал /7-р хх-ийн 8/, Х.А-аас Н.О-д өөрийн өмчлөлийн орон сууцыг захиран зарцуулах, арилжих бүрэн эрхийг олгосон 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн итгэмжлэл /7-р хх-ийн 88/, бэлэглэгч Х.А-аас бэлэг хүлээн авагч Ц.Ч-ийн өмчлөлд шилжүүлсэн 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн бэлэглэлийн гэрээ /7-р хх-ийн 87/ зэргээр баримтуудаар нотлогдон тогтоогдохгүй байна.

Цагаатгагдсан этгээд Ц.Ч нь «Тг» ХХК-ийн захирал Х.А-аас Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д «Тг» ХХК-ийг тендерт шалгаруулсны төлөө өгсөн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий ...тоот 160м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг өөрийн нэр дээр шилжүүлэн авч, онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг нуун далдалж гэмт хэрэгт хамжигчаар оролцсон гэх гэмт хэрэг үйлдсэн гэх боловч,

Цагаатгагдсан этгээд Ц.Ч шүүхийн хэлэлцүүлэгт хэргийн талаар өгсөн мэдүүлэгтээ «...Ц.Ч миний бие 1980 онд Унгар улсад Монгол Улсаас төлөөлөн сууж байсан элчин сайдын анхны зээ хүү болж төрсөн. Миний эцэг эх, миний өвөө эмээ нар энэ төрд үнэлэгдсэн сэхээтэн эрдэм номтой хүмүүс байсан учраас намайг хар багаас

минь эрдэм ном, боловсрол, хөдөлмөрийн үнэ цэнийг мэдрүүлж өсгөсөн. ...Тэгээд байр авах гэсэн хүнд аль болох боломжийн байрыг нь авч өгөх, байр зарах гэж байгаа хүнд нь зарж өгөөд зуучлалын хөлс авах зэргээр хувиараа байрны ченж гэж ярьдаг даа хүмүүс, тийм зүйл ажлынхаа хажуугаар хийж эхэлсэн. Үүний хажуугаар өөрийнхөө ганц сонирхол болсон машин бизнесээ хийж л явсан. Х.А ахын хувьд би 1999 он 2000 оны үеэс Германд жуулчны төлөөлөгч байхаас нь танина. Ганцхан надаар тогтохгүй Германд байсан оюутнууд бүгд мэднэ. Гадаад оронд, хүний нутагт өөрийнхөө хувийн бизнесийг амжилттай явуулна гэдэг хүнд асуудал. Үүнийг хийж чадсан цөөхөн залуучуудын нэг учраас бүгдээрээ таньдаг, энэ хүнийг үнэлдэг, хүндэлдэг байсан. Тэгээд намайг 2007 онд Хас банкны салбарын захирал болсон хойно Х.А ах Монголд ирсэн, өөрөө нэг компани байгуулсан, манайд орооч ээ гээд янз бүрийн санал тавьдаг, янз бүрийн зүйл ч амалдаг л байсан. Гэтэл би өөрөө боломжийн ажилтай байсан болохоор тэрийг нь ойшоодоггүй байсан. Гэхдээ яах вэ ажлын хажуугаар өөрөө гадаад орноос зээл авна, санхүүжилт хийнэ гэхэд банк санхүүгийн хувьд материалтай нь танилцаж, зөвлөгөө өгч, тусламж үзүүлж байсан. Би өөрөө ч гэсэн шаардлагатай тохиолдолд Х.А ахаас юм гуйж үзсэн. Ингээд би өөрийн бизнесийн дагуу 2009 оноос Х.А ахаа хямдхан байр байна уу, надад нэг байр өгөөч ээ гэж гуйсан. Тэгэхэд Х.А ах, ах нь жаахан санхүүгийн асуудалтай байгаа, чи миний байрыг 200.000 ам доллараар хямдхан авбал авахгүй юу гэсэн. Үүн дээр та бүхэнд тайлбар хэлэхэд мөрдөн байцаагчийн хэлээд байгаа шиг огт танихгүй нэг хүн гарч ирээд нэг хүн явуулаад миний нэр дээр байр шилжүүлсэн асуудал байхгүй. Би 11 сард тэр байрыг зөндөө очиж үзсэн. Үнэ ханшийг нь судалсан, гэр бүлтэйгээ зөвлөлдсөн. Алс ирээдүйдээ үнэд хүрэх юм байна, ашигтай байх юм байна гэдэг үүднээс би энэ байрыг авсан. Авах авахдаа надад 200.000 ам доллар бэлнээр байгаагүй. Би Х.А ахаас эргээд гуйсан, мөнгийг хуваагаад төлөх боломж байна уу гэж асуухад, Х.А ах бодож байгаад чи эхлээд 50.000 ам долларыг өгчих, үлдсэнийг нь удаахгүй төлчихөөрэй гэсэн. Энд дахиад давтаад хэлэхэд би бол сэтгэлийн хөөрлөөр юм уу, хүний ятгалгад орж шийдвэр гаргадаггүй хүн, аль болох урьдчилж бүх юмыг тооцоолж байгаад, тал талаас нь харж байж, төлөвлөж байж

шийдвэр гаргадаг хүн. Та нар үүнийг нэг бодлын Герман зан гэдгийг сайн мэдэж байгаа байх. Ингээд 2012 оны эхээр Х.А ах над руу яриад, ах нь гадаад явах боллоо манай итгэмжлэгдсэн хүн очоод чамд байрыг чинь шилжүүлж өгөөд, чи мөнгөө тэр хүнд өгөөрэй гэсэн. Тэгээд манай ажил дээр Н.О гэдэг залуу ирээд анх танилцаж байсан. Бид 2 хуучин үл хөдлөх байсан Ард кино театрын хажууд байх нотариат ороод гэрээ байгуулаад, би материалаа өгсөн. Тэгэхэд би мөнгө өгсөн, гэхдээ би анх удаа энэ хүнтэй танилцаж байгаа учраас би 50.000 ам доллар хүлээж авсан гээд гарын үсэг зуруулж авч байсан. Даанч харамсалтай нь манайх 2011 оны эхээр манай салбарын үйл ажиллагаа өргөжөөд манай салбар том байранд шилжиж орсон. Тэгэхэд нь би энэ гэрээ бөгөөд өөр бусад зарж байсан байрнуудын гэрээг банкны хуучин хэрэгцээгүй баримтуудтайгаа хамт устгалд оруулснаа санаад одоо ерөөсөө олдохгүй байгаа. Яг үнэндээ 5 жилийн дараа энэ байрыг авсантай холбоотой нэг хүн ирээд шалгана гэж зүүдлээгүй явсан болохоор энэ баримтыг ямар ч шаардлагагүй гэж бодож устгасан. Хавтаст хэрэгт авагдсан байгаа, та нар сайн мэдэж байгаа байх, би энэ байрны 50 хувийг өөрөө төлсөн байгаа. Үүнийг төлөхдөө, та нар бас төсөөлөөд үзээрэй. Би өөрийн олсон ихэнх мөнгөө энэ байрны төлбөрт өгч байсан. Хүн хүнээс зээлээд өгөх тохиолдол бас байсан. Өөрийнхөө нэр дээр, ээжийн нэр дээр, эхнэрийн нэр дээр байсан илүү дутуу машинуудаа хүртэл зараад борлуулаад мөнгийг нь гаргаж өгч байсан тохиолдол байгаа. Үүнийг авто тээврийн газраас шалгаж үзэхийн бол машин зарж байсан баримтууд нь байгаа. Би мөрдөн байцаагчид үүнийг хэлсэн л дээ. Яагаад үүнийг шалгаж баталгаажуулахгүй байгаа юм бэ гэж. Тэгэхэд шүүх дээрээ, тэр шүүгчдээ хэл гэсэн. Тийм учраас энэ талаар ярьж байгаа юм шүү. 2011 оны хавар Х.А ах надтай уулзаад манайх шинээр Австралиудтай нийлээд шинээр төсөл эхэлж байгаа. Цаад компани нь Австралийн хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй, том компани, чамд цаашдаа өсөх боломж байгаа шүү гэж надад санал тавьсан. Гэхдээ эхэн үедээ би чамд банкны чинь адил цалин өгч чадахгүй. Өөрийн компанийн жишгийн дагуу чамд байр, машин өгье, машин бол Ланд 200 машин өгсөн байгаа, байрны хувьд үлдэгдэл 100.000 ам доллар дээрээ зохицье гэж ярьж байсан. Би энэ байранд

урхидуулаад энэ компанид ажилд орсон ч юм биш. Та нар бодоод үз, би банкиндаа өөрийн гэсэн захиран зарцуулах төсөвтэй, жолоочтой, машинтай, утас, бензин бүх зардал цаанаасаа даадаг гээд бүрэн дүүрэн сэтгэл хангалуун байсан. Мөрдөн байцаагч намайг, чи энэ компанид орохдоо Ланд аваад орсон байх гэж тулгаад байгаа. Би тэр үед Лексүс 470 гээд машинтай байсан. Банкны машин унадаг учраас энийгээ хэзээ ч унадаггүй гаражид байж байдаг л байсан. Хүн болгон нотлоно. Тэгээд ч бодоод үзэхэд би өөрийгөө ганцхан машинаар үнэлээд ажлаа солих хүн мөн үү. Өнөөдөр би банкиндаа ажиллаж байсан бол миний цалин 3-4 сая хүрчихсэн, би өөрөө ч гэсэн хувийнхаа журмаар дахиад нэг байрны мөнгө хийх л байсан. Тийм боломжтой байсан. Ер нь би энэ компанид орохдоо, манай захирлууд, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд мэдэхгүй байх, би шууд энэ компанид ажилд ороогүй юмыг яаж мэдэх вэ харзная гэж бодоод Хас банкнаасаас чөлөө аваад, давхар ажиллаж байгаад 2012 онд за боломжийн юм байна гээд Хас банкнаасаа гүйцэд гарсан. Миний энэ байр, хувийн өмчид цаг хугацаа, орон зай, харилцан хамааралгүй тендер, татвар гэсэн огт ойлгомжгүй зүйлд холбож намайг 2 сар гаруй цагдан хорьж байгаад үнэндээ гайхаж байна. Өмнө хэлсэнчлэн би 2 хүүхэдтэй хүн. Би хүүхдүүдээ өсөж том болоход нь энэ байрандаа орно. Цаашдаа дахиж хүүхэдтэй болно, бүр цаашлаад энэ байраа худалдан борлуулж хүүхдүүддээ байр авч өгнө гэж алсыг бодолтой, ирээдүйн хөрөнгө оруулалт болгож авсан шүү. Өнөөдөр эрдэм боловсрол чадвартай нэг нь биш сэргэлэн зальтай нэг нь сайн сайхан амьдардаг нийгэм болсныг та бүхэн мэдэж байгаа. Надад үнэндээ аавынхаа талийгаач болсон дүүг ашиглаад мөрдөн байцаагчийн тулгаад яриад байгаа шиг ямар нэгэн тендерт ороод, түүнийг нь ялаад, зарж баяжаад, үгүй дээ гэхэд аль нэг яамны юм уу агентлагийн хурган дарга болох боломж байсан уу гэвэл байсан. Гэхдээ би хэзээний хүмүүсийн нам болж хуваагдаад, улс төр, төрийн алба, авлига, хээл хахууль, ар өвөрийн асуудлаас хол байж зөвхөн урд ажлаа сайн хийж байснаараа сайхан амьдарч байсныг та бүхэн хавтаст хэрэгт авагдсан миний тодорхойлолт болон намтар түүхээс харж ойлгож байгаа байх. Гэтэл өнөөдөр намайг хээл хахууль авсан яллах гэж байгаад би улс эх орон, төр засаг, хууль

хүчний байгууллагад үнэндээ гомдож цөхрөөд байна. Би ямар албан тушаалтан болоод, ямар ашиг хонжоо олсон болоод, хэн яаж хохироод гомдол гаргасан болоод өнөөдөр өөрийн өмч, байр, машинаа хураалгах гээд зогсож байгаагаа ойлгохгүй байна. Түүгээр ч зогсохгүй надаас мөнгө аваад захиралдаа шилжүүлж байсан, надад байрыг нэр дээр минь шилжүүлж байсан, 4 хүүхэдтэй, зүгээр л ажлаа хийж байсан залууг буцаад эсрэгээрээ надад авлига өгсөн болоод цуг яллах гээд сууж байгаа нь ямар ч логикгүй утга учиргүй зүйл болоод байна. Та бүхэн сонссон байх, прокурорын уншсан яллах дүгнэлтэд тендер, татвар гээд зөндөө зүйл яригдаж байгаа боловч миний байртай холбоотой, үүнийг миний байртай яаж холбож байгаа, би хэнийг хохироогоод, хэн гомдол гаргасан талаар нотлох баримт юу ч байхгүй. Яллах дүгнэлтэд тэр талаар огт дурдагдаагүй байгаа. Шүүгч нар болон прокурор мэдэхгүй зүйлийг энд хэлье гэж бодож байна. Холбоогүй зүйлийг холбоотой болгох гэж, хийгээгүй зүйлийг хийсэн болгох гэж, нотлогдоогүй зүйлийг нотлох гэж мөрдөн байцаагч зөндөө оролдсон. Тэр болгонд нь би хэлж байсан. Тэр тендер зэрэг асуудлыг би огт мэдэхгүй. Энэ байр миний байр, 100 хувь миний байр. Та надад чин сэтгэлээсээ итгэж болно. Шалгах зүйл байвал шалгах журмаараа шалгаач ээ, энэ байр энд ямар ч хамаагүй, та буруу замаар яваад байгаа юм уу гэдгийг би зөндөө хэлж байсан. Би Х.А ахаас ганцхан байр биш машин бас авсан байгаа. Гэтэл машиныг огт ярьдаггүй. Зөвхөн байрыг л тойроод авч үзээд байдаг. Өмгөөлөгч маань энэ Х.А гэдэг хүнээс ганцхан Ц.Ч биш, 2-3 хүн байр, машин авсан байна, яагаад ганц Ц.Ч-ийг шалгаад байдаг юм бэ гэж асууж байсан. Мөрдөн байцаагчийн өгч байсан хариулт нь ердөө Ц.Ч Д.А гэдэг хүний төрсөн ахын хүүхэд учир шалгаж байгаа юм гэсэн хариу өгч байсан. Түүнийг нь М.Баяраа өмгөөлөгч сонссон байгаа. Миний "Г.В" дахь байрыг маань битүүмжилнэ гээд түүнээс гадна хөрөнгө хураах ялтай гээд манай амьдарч байгаа нөгөө байрыг маань битүүжилнэ гээд эхнэр хүүхдийг минь хөөж гаргаад, зургийг нь аваад хавтаст хэрэгт авагдсан байгаа. Үүн дээр манай өмгөөлөгч маш ихээр дургүйцсэн. Яагаад заавал та нар энэ хүний байрыг нь хураах гээд эхнэр хүүхдийг нь гудамжинд гаргах гээд улайраад заавал байраар нь оролдоод байдаг юм бэ. Хөрөнгө хураах гээд байвал наад хүн чинь

дансандаа мөнгөтэй, өөр машин тэрэг гээд олон хөрөнгө байхад байрыг нь хураана гэж дарамтлаад байх ямар шаардлага байна гэж эсэргүүцэж, нилээн асуудал үүсгэж байж одоо амьдарч байгаа байрыг минь битүүмжилэхээ больсон байгаа. Бүүр сүүлдээ мөрдөн байцаагч надад юу гэж хэлсэн бэ гэвэл та одоо 2 хүүхэдтэй гэр бүлээ бод оо, өөр зүйл ярь, одоо удахгүй энэ хэрэг чинь прокурорт шилжлээ шүү, прокурор дээрээс шүүхэд очно, шүүхээс бол та заавал ял авна шүү. Тийм учраас та эртхэн дээр юм аа яриад сал гэж хэлсэн. Би тэр даруйдаа өмгөөлөгчдөө утасдаж хэлсэн. Одоо та нар тэр гүйцэтгэх ажиллагаагаар янз бүрийн утасны бичлэг гээд байгаа, тэр утасны бичлэгээс сонсох юм бол би өмгөөлөгчдөө тэр дор нь хэлсэн байгаа. Дараа нь сүүлийн байцаалт авахдаа мөрдөн байцаагч миний хэлснийг чи сайн бодсон уу одоо ярих зүйл байвал яриарай гэж хэлж байсныг тэр байцаалтад биеэрээ оролцсон улсын яллагч чихээрээ сонссон байгаа шүү. Гэхдээ би хэлсэн, би байгаа зүйлийг байгаагаар нь ярина, би өөрөө аврагдаж ялгүй салахын тулд байхгүй зүйлийг бий болгож зохиогоод 2 хүнийг гүжирдэх боломж байхгүй гэж би өөрт нь хэлээд хавтаст хэрэгт авагдсан мэдүүлгээ өгсөн байгаа. Ердөө үүнээс 2 хоногийн дараа намайг дуудаад чи оргон зайлах гэж байсан гэсэн үндэслэлээр цагдан хорино гэсэн. Тэгээд манай өмгөөлөгч эсэргүүцсэн байгаа. Яагаад урьдчилаад танилцуулдаггүй юм бэ, оргон зайлах гэсэн нөхцөл чинь юу байгаа юм бэ. Үнэндээ ажлын 5 өдрийн 4 өдөр нь Н.О бид хоёр Авлигатай тэмцэх газрын үүдэнд уяатай нохой шиг л сууж байдаг байсан. Тэгээд яаж оргон зайлах гэсэн гэдгээ батлаад өгөөч гэхэд батлах шаардлагагүй, манайх хил хорио тавих боломжгүй болсон, оргон зайлсан тохиолдолд интерполоор хайхад бөөн зардал гарна гээд шууд хорьсон. Хориод 2 сар гаруй хугацаанд юу хийсэн бэ гэхээр юу ч хийгээгүй. Мөрдөн байцаагч, прокурорын хэн нь ч над дээр очоогүй, би зүгээр хий хоосон тэнд хэвтээд, миний архаг хууч өвчин хөдлөөд дээрээс нь чийгтэй газар удаан байснаас болоод бөөрний үрэвсэлтэй болоод ядарч сульдаад өөрөө хохироод сууж байна шүү дээ. Тэгэхээр шүүгч та бүхнээс өнөөдөр хэн нэг албан тушаалтан, ямар нэгэн дарамт шахалт байхгүйгээр нөхцөл байдлыг үзээд яаж миний байрыг хаа хамаагүй зүйлд холбоод байгааг ялгаж салгаад үнэн зөв шийдвэр гаргаж өгөөч гэж

хүсэж байна» гэх мэдүүлэг /шүүх хуралдааны тэмдэглэл/, бэлэглэгч Х.А-аас бэлэг хүлээн авагч Ц.Ч-ийн өмчлөлд шилжүүлсэн 2009 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн бэлэглэлийн гэрээ /7-р хх-87/ зэрэг нотлох баримтуудаар хангалттай нотлогдон тогтоогдохгүй байх тул анхан шатны шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т «Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд ...эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ» гэж заасныг баримтлан Ц.Ч-д холбогдуулан Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг нуун далдалж гэмт хэрэгт хамжигчаар оролцсон гэж прокуророос яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь үндэслэлтэй байна.

Х.А-т хэрэгт цугларсан болон шүүхийн хэлэлцүүлгээр хэлэлцэгдсэн нотлох баримтуудаар хангалттай тогтоогдсон, түүнд холбогдох хэргийн бүрдэл хангагдсан, мөрдөн байцаалтын шатанд шалгавал зохих зүйлийг бүрэн шалгасан, хэргийг зөв зүйлчилсэн байна.

Анхан шатны шүүхээс гэмт хэрэг үйлдэгдсэн байдал, нийгмийн хор аюулыг харгалзан Х.А-т Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар 3 жил хорих ял оногдуулсан нь хууль зөрчөөгүй байна.

Иймд анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, ялтан Х.А-ын «... хэргийг хэрэгсэхгүй болгон, хорих ялыг хөнгөрүүлж, цаашид эрүүл мэндээрээ үргэлжлүүлэн хохирохгүй байх боломж олгоно уу», ялтан Х.А-ын өмгөөлөгч Ж.Эрдэнэбулганы «...анхан шатны шүүхийн шийтгэх тогтоолыг хүчингүй болгож, хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж өгнө үү», ялтан Х.А-ын өмгөөлөгч Ц.Цэрэнжээ, Б.Баярмаа нарын «...шийтгэх тогтоолын 4, 6,10 дахь заалтуудыг хүчингүй болгож, түүнийг цагаатгаж өгнө үү», цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч Л.Ононбаярын «...Ц.Ч нь уг орон сууцыг худалдан авахад

зориулж 100.000 ам.доллар зарцуулсан нь нотлогдож байгаа тул уг мөнгийг буцаан олгох, эсхүл орон сууцыг буцаан олгож түүнийг хохиролгүй болгож өгнө үү», талийгаач Д.А-ын өмгөөлөгч Р.Пүрэвлхамын «...хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгаж өгнө үү», хохирогч, иргэний нэхэмжлэгч Монгол Улсын Сангийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Га-ын «... шинжээчийн дүгнэлтийг хууль ёсны гэж үзэж, уг дүгнэлтээр тогтоогдсон татварын 3.691.107.000 төгрөгийг улсад олгож өгнө үү» гэсэн давж заалдах гомдлууд болон улсын яллагч О.Сарангэрэлийн «...шийтгэх тогтоолыг хүчингүй болгуулж, хэргийг анхан шатны шүүхээр дахин хэлэлцүүлэхээр буцааж өгнө үү» гэсэн эсэргүүцлийг тус тус хэрэгсэхгүй болгох зүйтэй гэж давж заалдах шатны шүүх дүгнэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 315 дугаар зүйлийн 315.1.1-д заасныг удирдлага

болгон ТОГТООХ нь:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 дүгээр шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, ялтан Х.А болон түүний өмгөөлөгч Ж.Эрдэнэбулган, Ц.Цэрэнжээ, Б.Баярмаа, цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч Л.Ононбаяр, талийгаач Д.А-ын өмгөөлөгч Р.Пүрэвлхам, хохирогч, иргэний нэхэмжлэгч Монгол Улсын Сангийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Га нарын гаргасан давж заалдах гомдол болон улсын яллагч О.Сарангэрэлийн бичсэн эсэргүүцлийг тус тус хэрэгсэхгүй болгосугай.

2. Давж заалдах шатны шүүх хэргийг хянан шийдвэрлэхдээ Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, эсхүл Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн гэж үзвэл эрх бүхий этгээд 14 хоногийн дотор хяналтын шатны шүүхэд гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэйг дурдсугай.

ДАРГАЛАГЧ, ШҮҮГЧ
ШҮҮГЧИД

Ш.БАТ-ЭРДЭНЭ
Ч.ХОСБАЯР
Н.БАТСАИХАН

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 11 сарын 28 өдөр

Дугаар 425

Улаанбаатар хот

Х.А, Д.А, Н.О, Ц.Ч нарт холбогдох эрүүгийн хэргийн тухай

Монгол Улсын Дээд шүүхийн хяналтын шатны эрүүгийн шүүх хуралдааныг танхимын тэргүүн С.Нямжав даргалж, шүүгч Б.Бат-Эрдэнэ, Б.Батцэрэн, Д.Ганзориг, Б.Цогт нарын бүрэлдэхүүнтэйгээр, Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор Д.Эрдэнэцэцэг, ялтан Х.А-ын өмгөөлөгч Ц.Цэрэнжээ, Б.Баярмаа, Ж.Эрдэнэбулган, Д.А-ы өмгөөлөгч Р.Пүрэвлхам, цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч М.Баяраа, Л.Ононбаяр, нарийн бичгийн дарга Б.Дүүрэнжаргал нарыг оролцуулан, Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 дүгээр шийтгэх тогтоол, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 787 дугаар магадлалтай, Х.А, Д.А, Н.О, Ц.Ч нарт холбогдох эрүүгийн хэргийг ялтан Х.А-ын өмгөөлөгч Ц.Цэрэнжээ, Б.Баярмаа, Ж.Эрдэнэбулган, Д.А-ы өмгөөлөгч Р.Пүрэвлхам, цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч М.Баяраа, Л.Ононбаяр нарын гаргасан гомдлыг үндэслэн шүүгч Д.Г-ийн илтгэснээр хянан хэлэлцэв.

1. Г овогт Х.А, ...оны ...дүгээр сарын ...-нд Төв аймгийн Зуунмод суманд төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, аялал жуулчлалын менежер, орчуулагч мэргэжилтэй, «Тг» ХХК-ийн ерөнхий захирал ажилтай, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй.

2. Б овогт Д.А, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоотод оршин сууж байсан, 2014 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нас барсан.

3. Ш овогт Н.О, ...оны ...дугаар сарын ...-нд Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эрх зүйч, компьютер-техникийн инженер мэргэжилтэй, «Тг» ХХК-ийн ерөнхий менежер ажилтай, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт

Сонгинохайрхан дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух хаягтай, одоо Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй.

4. А овогт Ц.Ч, ...оны ...дугаар сарын ...-нд Бүгд Найрамдах Унгар Улсын Будапешт хотод төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, эдийн засагч мэргэжилтэй, «Те Х» ХХК-д ерөнхий менежер ажилтай, ам бүл ..., эхнэр, хүүхдүүдийн хамт Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй.

Холбогдсон хэрэг:

Х.А нь Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухайн хуулийн 7, 8, 16, 17, 21 дүгээр зүйлүүдэд заасныг зөрчин, 2007-2011 онд нийт 12.303.690.000 төгрөгөөр хайгуулын болон ашиглалтын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан авч Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлогын албан татвар болох 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөлгүй онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн,

2008 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн Үйлдвэр худалдааны сайд Х.Найин 196 дугаар тушаалаар газрын тосны бүтээгдэхүүн хуваах чиглэлээр Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад Олон улсын нээлттэй тендер зарлаж, уг тендерт "Тг" ХХК-ийг шалгаруулсны төлөө "Тг" ХХК-ийн ерөнхий менежер Н.О-д итгэмжлэл хийж өгч, Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлэн хээл хахуульд өгсөн,

Д.А нь Газрын тосны газрын даргаар ажиллаж байхдаа Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан, газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудыг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны дарга, Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар тус тус ажиллахдаа тендерт «Тг» ХХК-ийг

шалгаруулсны төлөө Х.А-ын 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг төрсөн ах Д.Ц-ийн хүү Ц.Ч-ийн нэр дээр 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр шилжүүлэн авч онц их хэмжээний хээл хахууль авсан,

Н.О нь Газрын тосны газраас Олон улсын нээлттэй тендер зарлагдсан газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудын сонгон шалгаруулалтад «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д Х.А-ын эзэмшлийн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Ц.Ч-ийн нэр дээр шилжүүлж, хээл хахууль өгөх гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэхэд дэмжлэг үзүүлэн хамжигчаар оролцсон,

Ц.Ч нь «Тг» ХХК-ийн захирал Х.А-аас Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д «Тг» ХХК-ийг тендерт шалгаруулсны төлөө өгсөн 494.000.000 төгрөгийн үнэ бүхий ...тоот 160 м2 талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг өөрийн нэр дээр шилжүүлэн авч, онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэгт учрах саадыг арилгаж, гэмт хэрэг үйлдэж олсон эд хөрөнгийг нуун далдалж, гэмт хэрэгт хамжигчаар оролцсон гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 дүгээр шийтгэх тогтоолоор Нийслэлийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Н.О-д холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1-д заасан үндэслэлээр, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсэгт заасныг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар Ц.Ч-д холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгож, Н.О, Ц.Ч нарыг цагаатгаж, Н.О, Ц.Ч нарт урьд авсан бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хүчингүй болгож, Нийслэлийн

Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт зааснаар Х.А-т холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Х.А-ыг албан тушаалтанд бусдаар дамжуулж хээл хахууль өгсөн, Д.А-ыг онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцож, Д.А-д холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар Х.А-ыг 3 жилийн хугацаагаар хорих ял шийтгэж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар Х.А-ын эдлэх 3 жилийн хорих ялыг жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид эдлүүлж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 59 дүгээр зүйлийн 59.2 дахь хэсэгт зааснаар Д.А нь энэ хэрэгтээ 52 хоног, Ц.Ч нь энэ хэрэгтээ 82 хоног, Н.О нь энэ хэрэгтээ 11 хоног тус тус хоригдсон болохыг дурдаж, Х.А-ын энэ хэрэгтээ цагдан хоригдсон 338 хоногийг түүний хорих ял эдэлсэн хугацаанд оруулан тооцож, Х.А, Д.А, Н.О, Ц.Ч нарт холбогдох иргэний бичиг баримт шүүхэд шилжиж ирээгүй, бусдад төлөх төлбөргүй болохыг дурдаж, Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл болох Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот, /Улсын бүртгэлийн Y-220601xxxx дугаартай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй/ 160 м2 талбай бүхий орон сууц, зоорийн давхарын ...тоот, ...байрны ...тоот 2 ширхэг авто зогсоол зэргийг хурааж, улсын орлого болгохоор Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албанд Улсын бүртгэлийн Y-220601xxxx дугаартай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээг эх хувиар нь шилжүүлж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 134 дүгээр зүйлийн 134.10 дахь хэсэгт зааснаар тогтоол хүчин төгөлдөр болмогц эд хөрөнгө битүүмжилсэн мөрдөн байцаагчийн тогтоолыг хүчингүй болгож, Д.А-аас хураан авсан 1.000.000 төгрөгийг түүний ар гэрт, хх-хх УНЦ улсын дугаартай «Тоёота Ланд Круйзер» маркийн автомашиныг эзэмшигч Ц.Ч-д, Х.А-ын үүсгэн байгуулсан «ДЕ» ХХК-ийн нэр дээр бүртгэлтэй, Улсын

бүртгэлийн дугаар 901111xxxx, регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 57,68 м2 талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx, регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо Рапид харш /1701./ ...тоот 57,99 м2 талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 57,99 м2 талбайтай хоёр өрөө орон сууц Y-220601xxxx бүртгэлийн дугаартай, Улсын бүртгэлийн дугаар 901111xxxx регистрийн дугаар 279xxxx, Хан-Уул дүүргийн ...дугаар хороо ...тоот 31,61 м2 талбайтай хоёр өрөө Y-220601xxxx бүртгэлийн дугаартай орон сууц зэргийг Х.А-г тус тус буцаан олгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.7-д зааснаар тогтоол хүчин төгөлдөр болмогц энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураагдаж ирсэн бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «Газрын тосны газар Б-193» гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «Тг» ХХК-ийн талбайн захиалга, доод хэсэгт «2008 он» гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, 1-181 хүртэл дугаарлагдсан, «Эргэл-12» талбайд захиалга ирүүлсэн «Тг» ХХК-ийн тухай танилцуулга гэсэн 1 боть материал, «Тг» ХХК-ийн талбайн захиалга» гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «АМГТХЭГ Т-63» гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «2008 он» гэсэн, 1-210 хүртэл дугаар хуудастай 1 боть материал, «Тг» ХХК-ийн Шарга-3 талбайн захиалга» гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «АМГТХЭГ Т-36» гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «2008 он» гэсэн, 1-208 хүртэл дугаар хуудастай 1 боть материал, «Тг» ХХК гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «Б-191» гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «2008 он» гэсэн, 1-209 хүртэл дугаар хуудастай, 1 боть материал, «Тг» ХХК-ийн Төхөм-10 талбайд өгсөн захиалгын материал гэсэн гарчигтай, бор өнгийн цаасан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «Газрын тосны газар Б-227 гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «2008 он» гэсэн 1-205 хүртэл дугаар хуудастай, 1 боть материал,

«Тг» ХХК-ийн Нэмэгт-6 талбайд өгсөн захиалгын материал» гэсэн гарчигтай, бор өнгийн цагаан хавтастай, нүүрэн хэсгийн дээд талд «Газрын тосны газар Б-226» гэсэн тэмдэглэгээ хийгдсэн, «2008 он» гэсэн, 1-208 хүртэл дугаар хуудастай, 1 боть материал, Газрын тосны газрын гэрээлэлтийн хэлтсийн дарга О.Э, мэргэжилтэн А.Тү нар нь 2013 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр ирүүлсэн «Тг» ХХК-ийн Газрын тосны газарт Шарга-3 талбайд өгсөн захиалгын хуулбар хувь» боть 1, «Тг» ХХК-ийн Газрын тосны газарт Нэмэгт-3 талбайд өгсөн захиалгын хуулбар хувь» 1 боть, «Тг» ХХК-ийн санхүүгийн чадамжийн талаарх танилцуулга нийт 3 боть, 2013 оны 12 дугаар сарын 16-ны өдөр яллагдагч Ц.Ч-ийн Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууцанд нэгжлэг хийх үед хураан авсан хар өнгийн Хас банк 10, 2008 гэсэн тэмдэглэлийн дэвтэр 1 ширхэг, №001567. дугаартай үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх дэвтэр 1 ширхэг, Ц.Ч-ийн эхнэр /РД:ХА...../ Б.Т-ын «татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр» 1 ширхэг зэргийг хууль ёсны эзэмшигч нарт нь буцаан олгож, 2013 оны 12 дугаар сарын 17-ны өдөр яллагдагч Ц.Ч-ийн Хан-Уул дүүргийн ...дугаар хороо, ...тоот орон сууцанд нэгжлэг хийсэн видео бичлэгтэй диск 1 ширхэг, 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоот Д.А-ын амьдарч буй орон сууцанд нэгжлэг хийсэн видео бичлэгтэй диск 2 ширхэг, №001567. дугаартай үндсэн ажлаас гадуур гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний орлогоос төлсөн шимтгэлийг бүртгэх дэвтрийн хуулбар, Ц.Ч-ийн эхнэр /ХА..... регистрийн дугаартай/ Б.Т-ын «татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр»-ийн хуулбар зэргийг уг хэргийг хадгалах хугацаа дуустал хэрэгт үлдээхээр шийдвэрлэжээ.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 787 дугаар магадлалаар Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 дүгээр шийтгэх тогтоолыг хэвээр үлдээж, Улсын яллагч О.Сарангэрэлийн бичсэн 2014 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн 15 тоот эсэргүүцэл, ялтан Х.А болон түүний өмгөөлөгч Ж.Эрдэнэбулган, Ц.Цэрэнжээ, Б.Баярмаа, цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч

Л.Ононбаяр, талийгаач Д.А-ын өмгөөлөгч Р.Пүрэвлхам, хохирогч, иргэний нэхэмжлэгч Монгол Улсын Сангийн Яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Г нарын гаргасан давж заалдах гомдлыг тус тус хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Ялтан Х.А-ын өмгөөлөгч Ц.Цэрэнжээ хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол болон тайлбартаа: «... Х.А-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан гэмт хэрэгт яллах үндэслэлгүй бөгөөд хавтас хэрэгт авагдсан, анхан шатны шүүх хурал дээр шинжлэн судлагдсан нотлох баримтуудаар Х.А-ыг тухайн үеийн Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д орон сууцыг бусдаар дамжуулан өгсөн гэдэг нь тогтоогдохгүй байхад нотлох баримтгүйгээр түүнд ял оногдууллаа.

Монгол Улсын Дээд шүүхийн 2009 оны 06 дугаар сарын 24-ний өдрийн 23 дугаар тогтоолд «хээл хахууль гэдэг нь хууль бус зорилгоо гүйцэлдүүлэхийн тулд өгсөн эдийн болон эдийн бус баялаг, тэдгээрийг өмчлөх эрх, төлбөргүй буюу хөнгөлөлттэй үзүүлсэн аливаа ажил үйлчилгээ зэргийг хамааруулан үзнэ» гэжээ. Гэтэл Х.А-т ямар нэгэн хууль бус зорилго байгаагүй учраас түүнийг гүйцэлдүүлэх гэж хэн нэгэнд эд хөрөнгө, өмчлөх эрх, зэргийг өгөх ямар ч шалтгаан байхгүй юм. Түүнийг хууль бус зорилго гүйцэлдүүлэхээр хэн нэгэнд эд хөрөнгө, өмчлөх эрх өгсөн гэх нотлох баримт хавтаст хэрэгт байхгүй юм. Улсын Дээд шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1-д заасан «гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийх» гэдгийг албан тушаалтны хувьд өөрт нь олгогдоогүй эрх, үүргийг хэрэгжүүлснийг ойлгоно» гэж тодорхой тайлбарласан байна.

Гэтэл хавтас хэрэгт талийгаач Д.А-ыг албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байсан, гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийсэн гэх нотлох баримт мөн байхгүй.

Х.А Хан-Уул дүүргийн 1 дүгээр хороо ...тоот орон сууцыг «Хас банк»-д хэлтсийн даргаар ажиллаж байсан Ц.Ч-ийг компанийнхаа менежерээр ажиллуулахдаа хөнгөлөлттэй үнээр түүний өмчлөлд шилжүүлсэн нь хавтас хэрэгт авагдсан Орон сууц бэлэглэлийн гэрээ, мөнгө төлсөн баримт, шүүгдэгч Х.А, Ц.Ч, Н.О нарын мэдүүлэг, Ц.Ч-ийн «Те Х» ХХК-д менежерээр ажиллаж байгаа зэрэг нөхцөл байдлуудаар тогтоогдсон. Х.А нь тухайн үед ажилд орсон

өндөр мэргэжлийн Н.Х, Н.Г, Н.Б, Н.О нарын нийт 7 залууд орон сууц олгосон бөгөөд тэдгээрийн нэг нь Ц.Ч юм. Анхан болон давж заалдах шатны шүүх энэ нөхцөл байдлууд, нотлох баримтуудыг үнэлэхгүй, үнэлэхээс санаатайгаар зайлсхийсэн байна. Х.А нь Д.А-д хээл хахууль өгөх шаардлага байгаагүй, өгөөгүй болох нь дараах байдлаас харагдана. 2008 оны 08 дугаар сард олон улсад газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайд нээлттэй зарлагдсан сонгон шалгаруулалт 2008 оны сүүлчээр явагдсан. «Тг» ХХК энэ шалгаруулалтад зохих журмын дагуу оролцож, хамгийн өндөр оноог авсан. Үнэлгээний хорооны дүгнэлтээр үндсэн үзүүлэлт 690, туслах үзүүлэлт 478.90, дэд үзүүлэлт 280.40 нийт 1454.90 оноогоор 1 дүгээр байрт шалгарчээ. Мөн бусад оролцогч нараас 20.0 сая ам.долларын илүү хөрөнгө оруулалт хийх саналыг Засгийн Газарт өгсөн байна /1-р хх-ийн 217-228 тал/. Өөрөөр хэлбэл, «Тг» ХХК нь бусад оролцогч нартай харьцуулахад Монгол Улсын Засгийн газарт хамгийн ашигтай саналыг ирүүлсэн нь хавтаст хэрэгт авагдсан сонгон шалгаруулалтын баримтуудаар нотлогддог. Сонгон шалгаруулах ажлын хэсэг, Үнэлгээний хороо, Сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрүүдийг сонгон шалгаруулалтад оролцсон бусад оролцогч нар хүлээн зөвшөөрсөн нь шалгалттай холбоотой ямар нэгэн албан ёсны маргаан гараагүйгээр нотлогдоно. Сонгон шалгаруулалт нь Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын хурлаар хэлэлцэгдэж эцэслэн шийдвэрлэгдэнэ. Гэтэл Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газарт энэ сонгон шалгаруулалт хэлэлцэгдээгүй өнгөрч, сонгон шалгаруулалт цуцлагдсан нь энэ сонгон шалгаруулалт бүрэн явагдаагүйг нотолж байна. Шарга-3, Нэмэгт-6 талбайд газрын тосны хайгуул хийх сонгон шалгаруулалтад оролцон хамгийн өндөр оноо авсан ч төрийн эрх бүхий албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагааны улмаас шалгарч чадаагүй, хөрөнгө оруулагч нарынхаа өмнө маш хүнд байдалд орсон. Энэ нь тухайн сонгон шалгаруулалтын гишүүдийн болон шүүх хуралд гэрчээр оролцсон О.Э, Г.Т болон бусад гэрчүүдийн мэдүүлэг баримтуудаар нотлогдоно. Ийм учраас анхан болон давж заалдах шатны шүүхийн «Тг» ХХК-ийг шалгаруулсан гэсэн дүгнэлт үндэслэлгүйг харуулж байна.

Х.А нь талийгаач Д.А-д орон сууц хээл хахуульд өгөх бодит шалтгаан, шаардлага

байхгүй бөгөөд гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив тал болох гэмт хэрэг үйлдэх санаа, зорилго, сэдэлт байхгүй юм.

Талийгаач Д.А нь Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг, Үнэлгээний ажиллагаанд оролцоогүй нь хавтас хэрэгт авагдсан, анхан шатны шүүх хурал дээр шинжлэн судлагдсан нотлох баримтуудаар тогтоогдсон. Сонгон шалгаруулах зөвлөл нь 9 гишүүдээс бүрддэг бөгөөд 100 хувийн саналаар Үнэлгээний хорооны дүгнэлтийг баталсан байдаг. Хамтын шийдвэр, гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэгдсэн асуудалд нэг хүнийг буруутгах гэж зүтгэх нь дэндүү шударга бус бөгөөд хуулийн үндэслэлгүй байна.

Х.А-т холбогдох дээрх эрүүгийн хэргийг мөрдөн байцаах ажиллагаа болон түүнд тавигдах прокурорын хяналт нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн, хуулийн бус аргаар явагдсанд анхан болон давж заалдах шатны шүүх дүгнэлт хийсэнгүй.

Авлигатай тэмцэх газрын мөрдөн байцаагч Э.Б, Х.А-т холбогдуулан үүсгэсэн 20140100029. тоот хэргээс Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2, 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан хэргийг 20140100004. гэх эрүүгийн хэрэгт үндэслэлгүйгээр тусгаарлан, улмаар прокурорт шилжүүлж, прокурор нь энэхүү ноцтой алдааг залруулах ажиллагаа хийлгүй шүүхэд шууд шилжүүлсэн бөгөөд шүүхээс дээрх Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн ажиллагааг үл хэрэгсэн хэргийг шийдвэрлэсэн. Х.А-т холбогдох Эрүүгийн хэргийг үндэслэлгүйгээр тусгаарласан, улмаар түүний эрх зүйн байдлыг дордуулсан. Үүгээрээ хэд хэдэн эрүүгийн хэрэгт холбогдсон этгээдийн хэргийг шүүхээс олон удаа ял өгч хохироох гэсэн санаа зорилго илт ажиглагдаж байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.2-т «Хэд хэдэн яллагдагч хэрэгт татагдсан бөгөөд хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл нь нийт яллагдагчид хамаарахгүй байвал тухайн яллагдагчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгоно» гэжээ. Гэтэл нэг хүнд холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн дөрвөн өөр зүйлд заасан гэмт хэрэгт яллагдагчаар татсан өөр дугаар бүхий хэрэгт тусгаарлан Эрүүгийн хууль, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчлөө. Мөрдөн байцаагч нь дээрх хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.11-д «энэ хуулийн заалтыг ягштал баримтлан

яллах болон цагаатгах нотлох баримтыг цуглуулах замаар хэргийг тал бүрээс нь бүрэн бодитойгоор шалгаж гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг олж тогтоох талаар шаардлагатай бүх арга хэмжээ авах» үүрэгтэй.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230 дугаар зүйлд «хэргийг буруу нэгтгэсэн, тусгаарласан бол; хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагааг бүрэн биш хийсэн бөгөөд түүнийг шүүх хуралдаанаар нөхөн гүйцэтгэх боломжгүй бол; хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын ажиллагаа явуулахад Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, энэ хуулийг ноцтой зөрчсөн» бол шүүгч захирамж, шүүх тогтоол гарган хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаахаар хуульчилсан байдаг.

Х.А-ын хэргийн мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нар нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д «Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулахдаа Үндсэн хууль, энэ хууль, бусад хуулийн заалтыг чанд сахина» гэснийг зөрчсөн бөгөөд 8.2-т «Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааг хэрэгжүүлж байгаа этгээд энэ хуулийн 8.1-ийг зөрчвөл түүний гаргасан шийдвэрийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу хүчингүйд тооцож, түүнд хариуцлага хүлээлгэнэ» гэх нөхцөл байдал үүсгэлээ.

Мөн анхан шатны шүүхээр хэрэг хянан шийдвэрлэгдэх явцад талийгаач Д.А-ыг яллагдагчаар татсан тогтоол хавтаст хэрэгт байхгүй, түүнийг яллагдагчаар татсан тогтоолгүйгээр цагдан хорьж амь насаар нь хохироосон нь тогтоогдсон. Гэтэл анхан болон давж заалдах шатны шүүхээс дээрх нөхцөл байдалд хуулийн бодит дүгнэлт хийхийн оронд тэрхүү үйлдлийг зөвтгөх, хамгаалахыг оролдож байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 225 дугаар зүйлийн 225.1.1-д яллагдагчийг шүүхэд шилжүүлэх гэж заасан боловч яллагдагч нь нас барсан байхад хэргийг шүүхэд шилжүүлсэн. Мөн хуулийн 226 дугаар зүйлийн 226.1-д яллагдагчийг шүүхэд шилжүүлэхдээ шүүгч дараахь асуудлыг тодруулсан байна гэсний 226.1.4-т «хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд шүүх хуралдааныг явуулж болохгүй байдалд хүргэх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн явдал байгаа эсэх» гэж заажээ. Гэтэл шүүх Эрүүгийн байцаан

шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн дээрх асуудлуудад хуулийн дүгнэлт хийлгүй хэргийг шийдвэрлэсэн.

Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 787 дугаартай магадлалын хянавал хэсэгтээ Х.А хээл хахууль өгсөн, талийгаач Д.А хээл хахууль авсан болох нь гэрч О.Э, Г.Т, С.Са, Ш.Ц, П.Х, Л.Л.О, М.А, А.Тү, Л.Сүх, шинжээчийн дүгнэлт, шинжээч С.Т-гын мэдүүлэг, гэрч Д.Ө болон шүүгдэгч Х.А-ын нарын мэдүүлгүүд зэрэг нотлох баримтуудаар тогтоогдсон үндэслэлтэй гэсэн нь илэрхий ташаа юм.

Анхан болон давж заалдах шатны шүүхээс Х.А-ыг буруутгасан нотлох баримтуудыг хавтас хэргээс үзэхэд түүнийг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан гэмт хэргийг үйлдсэн гэж нотлох нэг ч үг үсэг байхгүй байна.

Мөн хавтаст хэрэгт авагдсан, зайлшгүй үнэлэгдвэл зохих дараах нотлох баримтуудыг үнэлэхээс зайлсхийж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 319 дүгээр зүйлийн 319.1-д заасныг зөрчлөө.

Талийгаач Д.А-ыг Үнэлгээний хорооны даргаар ажилласан хэмээн хэрэгт авагдсан баримтаар нотлогдоогүй, харин гэрч О.Э шүүх хуралдаанд өгсөн мэдүүлэгт «Үнэлгээний хорооны даргаар Л.Сүх гэх хүн байсан» гэдэг.

2-р хх-ийн 115-117 дугаар талд гэрч Ч.На "...ажлын хэсэг групп" ХХК-ийн ирүүлсэн захиалгын бүрдэл хэсгийг хариуцан нэмж ирүүлсэн материалыг хавсаргаж дараагийн Үнэлгээний хороонд хүлээлгэн өгөх ажлыг хариуцан ажиллаж байсан..., материалууд нь хангалттай, бүх баримт бичгүүдийг хууль дүрэм, журмын дагуу бүрдүүлэн өгсөн..., гэж мэдүүлсэн, 118 дугаар талд гэрч Л.А-г "... миний хариуцсан чиглэлийн хүрээнд боломжтой гэж үзсэн ..." гэж мэдүүлжээ.

Мөн ажлын хэсэгт орж ажилласан хүмүүсээс гэрчийн мэдүүлэг авахдаа Үнэлгээний хорооны даргаар хэн ажиллаж байсныг асуугаагүй бөгөөд С.Са, О.Э нарын мэдүүлгээр Л.Сүх Үнэлгээний хорооны даргаар ажилласан байна.

1-р хх-ийн 191-р талд 2009 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн сонгон шалгаруулах зөвлөмж, 193-198 дугаар талд бүтээгдэхүүн хуваах гэрээний гэрээлэгчийг сонгон шалгаруулах зөвлөлийн хурлын тэмдэглэлд гишүүд болох Н.Б, Д.А, О.Э, П.Х, Л.Р, Г.Э, М.А, нарийн бичгийн дарга А.Тү

нар оролцон нийт гишүүдийн 100 хувийн саналаар дэмжсэн баримт, 2-р хх-ийн 198-р талд авагдсан Н.Ц-гийн мэдүүлэг, 1-р хх-ийн 238-р талд авагдсан "Тг" ХХК-ийн санхүүгийн талаарх танилцуулгад "УСА" ХХК-ийн санхүүгийн тайлан шалгасан Аудитийн дүгнэлт, 7-р хх-ийн 87-р талд Х.А, Ц.Ч нарын бэлэглэлийн гэрээ, мөнгө төлсөн баримт, гэрч Н.О, Ц.Ч, нягтлан бодогч Н.Цэц нарын мэдүүлгүүд зэрэг цагаатгах талын нотлох баримтууд байхад үнэлсэнгүй.

Тухайн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүх хурал дээр шүүгч улсын яллагчаас «хээл хахууль өгсөн гэдгийг шууд нотолж байгаа нотлох баримт байгаа юу?» гэж асуухад улсын яллагч «нотлох баримт байхгүй», мөн шүүгчийн «тендерийн асуудал авлига авсан, өгсөн гэдэг үйлдлийн хооронд шалтгаант холбоо байгаа юу?» гэхэд улсын яллагч «байхгүй» гэж хариулсан нь шүүх хуралдааны тэмдэглэлд бичигдсэн бөгөөд Х.А-ыг уг эрүүгийн хэрэгт буруутгах үндэслэлгүй гэдгийн нотолгоо юм. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 91 дүгээр зүйлийн 91.2-т «Яллагдагч гэм буруутай эсэх, түүнд ял оногдуулах үндэслэл байгаа эсэхийг нотлох үүргийг улсын яллагч хүлээнэ» гэж заасан ба улсын яллагч нотлох баримтгүй гэдгээ шүүхийн өмнө хүлээн зөвшөөрсөн юм.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 95 дугаар зүйлийн 95.1-д «Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь тухайн хэрэгт хамааралтай, хуулийн дагуу цуглуулж, бэхжүүлж авсан бүх нотлох баримтыг хэргийг хянан шийдвэрлэхэд хангалттай эсэхийг бүхэлд нь үнэлнэ» гэсэн заалтыг тухайн хэргийн прокурор, шүүгч нар хэрэгжүүлэлгүй зөвхөн буруутгах гэж оролдон хэрэгт авагдсан цагаатгах нотлох баримтуудыг санаатайгаар үнэлэлгүй орхигдуулж, нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд бодит байдлаар нь хянаж үзэлгүй хийсвэр дүгнэлт хийж шийтгэх тогтоол, магадлал гаргалаа.

Энэ нь Х.А-т холбогдох эрүүгийн хэргийн мөрдөн байцаагч, прокурор, шүүгч нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 95 дугаар зүйлийн 95.2-т «Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх нь хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгож нотлох баримтыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэний үндсэн дээр нотлох баримтыг өөрийн дотоод итгэлээр үнэлнэ» гэснийг зөрчлөө.

Анхан болон давж заалдах шатны шүүхээс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн

290 дүгээр зүйлийн 290.4-т «Гэмт хэрэг гарсан нь тогтоогдоогүй, эсхүл шүүгдэгчийн холбогдсон үйлдэл нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй буюу шүүгдэгч гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь нотлогдоогүй бол шүүх цагаатгах тогтоол гаргана», 13 дугаар зүйлийн 13.2-т «Эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд түүнчлэн Эрүүгийн хууль болон энэ хуулийг тайлбарлах, хэрэглэхэд эргэлзээ гарвал түүнийг сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэнэ» гэж заасныг үндэслэн хэргийг хэрэгсэхгүй болгох бүхий л үндэслэл бүрдсэн байхад шийтгэх тогтоол гаргасанд гомдож байна.

Хэрэв тогтоогдсон гэж үзвэл Х.А-т оногдуулсан хорих ялыг тэнсэж, хянан харгалзах боломж бүрэн байгааг анхаарч өгнө үү гэв.

Ялтан Х.А-ын өмгөөлөгч Б.Баярмаа хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол болон тайлбартаа: Хавтас хэрэгт авагдсан, анхан шатны шүүх хуралдаан дээр шинжлэн судлагдсан нотлох баримтуудаар Х.А нь тухайн үедээ \2009 онд\ Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д орон сууцыг бусдаар дамжуулан өгсөн гэдэг нь тогтоогдоогүй.

Анхан болон давж заалдах шатны шүүх Х.А-ыг бусдад хээл хахууль өгөх буюу Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт гэм буруутайд тооцохдоо «...хэргийн үйл баримт тогтоогдсон» гэж дүгнэсэн нь үндэслэлгүй байна.

2008 оны 08 дугаар сард олон улсад газрын тосны хайгуулын Шарга-3, Нэмэгт-6 талбайд нээлттэй зарлагдсан сонгон шалгаруулалтад оролцогчдын материалд үнэлгээ авахад "Те х" ХХК зохих журмын дагуу оролцож, хамгийн өндөр оноог авсан.

Өөрөөр хэлбэл, бусад оролцогч нартай харьцуулахад Монгол Улсын Засгийн газарт хамгийн ашигтай саналыг ирүүлсэн нь хавтас хэрэгт авагдсан сонгон шалгаруулалтын баримтуудаар нотлогддог. Сонгон шалгаруулалтын Ажлын хэсэг, Үнэлгээний хороо, Сонгон шалгаруулах зөвлөлийн шийдвэрүүдийг сонгон шалгаруулалтад оролцсон бусад оролцогч нар хүлээн зөвшөөрсөн нь шалгаруулалттай холбоотой ямар нэгэн маргаан хийгээгүйгээс харагддаг юм. Харин 2009 оны эхээр тухайн үед Эрдэс баялаг эрчим хүчний сайдаар

ажиллаж байсан сайд Д.Зо асуудлыг Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын хуралд оруулан хэлэлцүүлээгүй 6 жилийн хугацаа өнгөрч хуулийн дагуу сонгон шалгаруулалт цуцлагдсан байна. Энэ нь сонгон шалгаруулалт бүрэн явагдаагүй, төрийн эрх бүхий албан тушаалтнуудын буруутай үйл ажиллагааны хохирогч нь «Тг» ХХК болсныг нотолж байна. Энэ байдал нь сонгон шалгаруулалтын зөвлөлийн гишүүдийн болон шүүх хуралдаанд гэрч О.Э, Г.Т нарын өгсөн мэдүүлэг бусад нотлох баримтуудаар нотлогдоно.

Д.А Сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар ажиллахдаа «Тг» ХХК-ийг шалгаруулах талаар бусад гишүүддээ нөлөө үзүүлсэн гэх байдал тогтоогдоогүй юм.

Шинжээч гэх С.Т-гын дүгнэлт нь нотолгооны чанаргүй байна. Учир нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 155 дугаар зүйлийн 155.1-д «Шинжилгээ хийлгэхэд энэ хууль болон Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасан журмыг баримтална.» гэж заасан, Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2-т «шинжээч» гэж шүүхийн шинжилгээ хийж дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон, тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн этгээдийг» хэлнэ гэж заасан. Гэтэл шинжээч С.Т-гын биеийн байцаалтаас үзэхэд энэ шаардлагыг хангаагүй байх бөгөөд шинжилгээний объект нь тоо баримтад тулгуурласан байхад Тендерт оролцогчдын авсан оноог бодож дүгнэсэн нэмж хассан нэг ч үйлдэл хийлгүйгээр зөвхөн сонгон шалгаруулах зөвлөлийн хуралд оролцсон зарим гишүүдийн хэлсэн үгэн дээр тулгуурласан нь уг дүгнэлт нотолгооны чанаргүй, өрөөсгөл гэдгийг нотолж байна.

Д.А нь урд нь Х.А-ын өмчлөлд байсан Хан-уул дүүргийн 1 дүгээр хороо, ...тоот орон сууцанд гэр бүлийн хамт амьдарч байсан тул энэ орон сууцыг хахууль авсан байх үндэслэлтэй гэж шүүх таамаглаж, уг таамгаа үйл баримтаар нотлогдож байна гэсэн дүгнэлт хийж, талийгаач Д.А, Х.А нарыг Хээл хахууль авах өгөх гэмт хэрэгт буруутгасан. Гэтэл Хан-уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот, 160 м2 орон сууц, 2 машины зогсоолын хууль ёсны өмчлөгч нь Ц.Ч. Х.А нь Ц.Ч-ийг компанидаа менежерээр ажиллуулахын тулд дээрх орон сууцыг хөнгөлөлттэй үнээр худалдсан нь хавтас хэрэгт авагдсан Орон сууц бэлэглэлийн гэрээ, мөнгө төлсөн баримт, шүүгдэгч Х.А,

Ц.Ч, Н.О нарын мэдүүлэг, Ц.Ч-ийн «Те х» ХХК-ийн менежерээр ажиллаж байсан зэрэг нөхцөл байдлуудаар тогтоогдсон.

Х.А нь тухайн үед ажилд орсон өндөр мэргэжлийн Х, Г, Б нарын 7 залууд орон сууц олгосон бөгөөд тэдгээрийн нэг нь Ц.Ч юм. Компанийн менежер Н.О, Ц.Ч нарт орон сууцнаас гадна Ланд-200 автомашиныг өгсөн байна.

Д.А-ы уг сууцанд амьдарч байсан явдал бол шинээр гэр бүл зохиож нялх хүүхэдтэй, өмнөх эхнэр хүүхэддээ орон гэрээ өгсөн гэх зэргээс дүү Ц.Ч-ийн байранд амьдарч байсан.

“Тг” ХХК нь анх удаа Газрын тосны хайгуулын сонгон шалгаруулалтад оролцоогүй. Өмнө нь Эргэл-12, Төхөм-10 талбайнуудын сонгон шалгаруулалтад оролцсон боловч шалгарч чадаагүй. Мөн тус компани Шарга-3, Нэмэгт-6 талбайд газрын тосны хайгуул хийх сонгон шалгаруулалтад оролцож хамгийн өндөр оноо авсан боловч, захиргааны байгууллагын зарим ажилтнууд шалгаруулаагүй, гэрээ байгуулж чадаагүй.

Эдгээр нотлох баримт, үйл баримтыг дүгнэхэд Х.А нь Д.А-д орон сууцыг авлигад өгөх бодит шалтгаан, шаардлага байхгүй юм.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлээр эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй тохиолдлуудыг тогтоожээ. Гэтэл анхан шатны шүүх хуралдаанд оролцох, шүүхийн өмнө өөрийн гэм буруугүйг нотлох ажиллагаа явуулах боломжгүй болсон нас барсан иргэнийг гэм буруутайд тооцсон нь хүний эрх зөрчиж байгаа маш бүдүүлэг алдаа юм. Шүүх зөвхөн гэм буруугийн асуудал шүүх хурал дээр хэлэлцэгдсэн, шүүх хуралд оролцсон хүний гэм буруугийн асуудлыг шийдвэрлэх эрхтэй.

Гэтэл хуулийн тодорхой үндэслэлгүйгээр, байцаан шийтгэх ажиллагаа явуулахыг хориглосон, яллагдагчаар татсан тогтоол байхгүй байхад Д.А-ыг хээл хахууль авсан гэх гэмт хэрэгт гэм буруутайд тооцсон тогтоол гаргасан. Яллагдагчаар татсан тогтоолгүй хүнийг яллагдагчаар байцаасан, шүүгдэгч болгосон, гэм буруутайд тооцсон нь илэрхий бүдүүлэг алдаа, ноцтой зөрчил юм. Энэ алдааг давж заалдах шатны шүүх зөвтгөж засахын оронд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчөөгүй, Д.А-ыг нас барсан байхад түүний өмгөөлөгчийн зүгээс шүүхэд ямар нэг хүсэлт гаргаагүй, шүүх хуралдаанд цагаатгах байр суурьтай оролцсон тул хэрэг

хянан шийдвэрлэх ажиллагааг ердийн журмаар явуулж шийдвэрлэснийг буруутгах үндэслэлгүй гэж дүгнэсэн нь мөрдөн байцаагч, прокурор, анхан шатны шүүхийн хууль зөрчсөн ажиллагааг хаацайлж, зөвтгөх, Х.А-т зөвхөн ял оноох гэсэн зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хийж байгаа үйлдэл гэж ойлгогдож байна.

Хэрэв Х.А гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож байна гэж үзвэл ял шийтгэлийг хөнгөрүүлж өгнө үү гэв.

Ялтан Х.А-ын өмгөөлөгч Ж.Эрдэнэбулган хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол болон тайлбартаа: «...Х.А-ыг 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдөр Авлигатай тэмцэх газрын Мөрдөн шалгах хэлтсээс Ашигт малтмалын газрын дарга нартай хуйвалдан албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулсан, мөнгө угаах гэмт хэрэгт хамтран оролцсон байж болзошгүй гэдэг үндэслэлээр Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.6 дахь хэсгийг журамлан Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, мөн хуулийн 166¹ дүгээр зүйлийн 166^{1.3} дахь хэсэгт зааснаар яллагдагчаар татан эрүүгийн /201301000029./ тоот хэрэг үүсгэн 2013 оны 07 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн цагдан хорьсон. Эдгээр гэмт хэргүүдтэй холбогдуулан Х.А-ыг хорьж шалгаж байгаад 2014 оны 03 дугаар сарын 18-ны өдөр өмнө шалгаж байсан хэргээс тусгаарлан дахин /20140100004./ тоот эрүүгийн хэрэг үүсгэн шинээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2, 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэгт яллагдагчаар татсан болно.

Х.А-ыг Авлигатай тэмцэх газраас эхлээд Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2 мөн хуулийн 166¹ дүгээр зүйлийн 166^{1.3} дахь хэсэгт холбогдуулан шалгаж байсан ба мөрдөн байцаагч 2014 оны 03 дугаар сарын 18-ны өдөр Х.А-т холбогдох эрүүгийн 201301000029. тоот хэргээс түүнд холбогдох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1, 166 дугаар зүйлийн 166.2 дахь хэсэгт заасан гэмт хэргүүдийг тусгаарлах тогтоол гарган прокурор О.Сарангэрэл баталж 20140100004. дугаартай хэрэгт тусгаарлажээ. Ингэхдээ уг тогтоолд Х.А-т холбогдох Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлогын албан татвар болох 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт

төлөөгүй албан татвар төлөхөөс санаатай зайлсхийсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 166 дугаар зүйлийн 166.2, Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д 160 м² орон сууц, авто зогсоолын хамт хээл хахуульд өгсөн үйлдлийг 201301000029. тоот хэргээс тусгаарлаж шийдвэрлэх шаардлагатай, харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 263 дугаар зүйлийн 263.2, мөн хуулийн 166¹ дүгээр зүйлийн 166^{1.3} дахь хэсэгт заасан үйлдлүүдийг 201301000029. тоот хэрэгт үргэлжлүүлэн шалгах шаардлагатай гэж Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 125 дугаар зүйлд заасны дагуу тусгаарлажээ. Эрүүгийн хэргийг тусгаарлах үндэслэл нь дараах тохиолдолд хийгддэг.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 205 дугаар зүйлийн 205.4-т заасан «Хоёр буюу хэд хэдэн сэжигтэн, яллагдагч хэрэгт татагдсан бөгөөд, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтыг түдгэлзүүлэх үндэслэл нь бүх сэжигтэн, яллагдагчид хамаарахгүй байвал зарим сэжигтэн, яллагдагчид холбогдох хэргийг тусгаарлан түдгэлзүүлдэг.

Мөн энэ хуулийн 208 дугаар зүйлийн 208.2-т заасан «Хэд хэдэн яллагдагч хэрэгт татагдсан бөгөөд хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл нь нийт яллагдагчид хамаарахгүй байвал тухайн яллагдагчид холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгоно» гэсэн тохиолдолд тусгаарлагддаг.

Нэг хүнд холбогдуулан Эрүүгийн хуулийн тусгай ангийн дөрвөн өөр зүйд заасан гэмт хэрэгт яллагдагчаар татсан хэргүүдийг ингэж хоёр хоёроор нь өөр өөр дугаар бүхий хавтаст хэргүүд болгон салган шийдвэрлэж байгаа нь Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн болон зөрчсөн явдал болж байна.

Учир нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлд хэд хэдэн гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд ял оногдуулах, мөн хуулийн 12 дугаар зүйлд гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан зохицуулалт хэрэглэхгүй байхаар хуульчилсан. Гэтэл анхан шатны шүүх болон давж заалдах шатны шүүх энэ байдлыг харгалзан үзэлгүйгээр «... өмгөөлөгч нараас Авлигатай тэмцэх газарт шүүгдэгч Х.А-ын хэргээс өөр хэргийг тусгаарласан. Уг тусгаарласан хэргийг энэ хэргээс тусад нь шийдвэрлүүлэх нь шүүгдэгчийн эрх зүйн байдал дордох тул мөрдөн байцаалтад хэргийг буцааж өгнө үү гэсэн хүсэлтийг хүлээн авах боломжгүй. Учир нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар

зүйлийн 246.1-д шүүхэд хэрэг хэлэлцэх ажиллагаа нь зөвхөн шүүгдэгчийн хувьд, гагцхүү түүнийг шүүхэд шилжүүлсэн хэргийн хэмжээний дотор явагдана гэж заасан дагуу уг тусгаарласан гэх хэрэгт Х.А нь ямар хамааралтай, хэрэг нь ямар шатандаа байгаа нь тодорхойгүй байгаа тул энэ хэргийг эцэслэн шийдвэрлэхэд саад болохгүй хэзээ хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүй хэрэгт шүүхэд шилжүүлсэн хэргийг нэгтгэх ач холбогдолгүй гэсэн ойлгомжгүй дүгнэлт хийжээ. Гэтэл өмнө нь бүтэн 8 сар хорьж мөрдөж шалгасан, байцаалтын шатандаа байгаа, эдгээр хэргүүд нь тусдаа дугаартай, мөрдөн байцаагч болон прокурор үргэлжлүүлэн шалгах шаардлагатай гэж тогтоол гаргасан байхад анхан болон давж заалдах шатны шүүх «Х.А-т тэрхүү хэрэг нь ямар хамааралтай, хэрэг нь ямар шатандаа байгаа нь тодорхойгүй» гэж үзэж байгаа нь ойлгомжгүй, хэргийг тусгаарласнаас болж Х.А нь анх шалгагдаж байсан дээрх хэргүүдэд дахин шийтгүүлэх нөхцөл бүрдэж байгаа бөгөөд энэ нь түүний эрх зүйн байдлыг шууд дордуулах үндэслэлийг бий болгож байна. Иймд давж заалдах шатны шүүхийн магадлалд заасан энэхүү дүгнэлт нь Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйл болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 230 дугаар зүйлийн 230.1.1-д заасан заалтыг зөрчсөн буруу жишиг тогтоосон шийдвэр болсон гэх үндэслэлтэй.

Давж заалдах шатны шүүх магадлалдаа анхан шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглээгүй гэж үзжээ. Шүүхийн шийтгэх тогтоолоор Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоот, 160 м² талбай бүхий орон сууц, зоорийн давхрын ...тоот, ...байрны ...тоот 2 ширхэг авто зогсоолыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт заасан дагуу хурааж улсын орлого болгохоор шийджээ. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлд «Эд хөрөнгө хураах» ялыг хуульчилсан бөгөөд энэ зүйлийн 49.2-т «гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд хөрөнгө хураах ялаас гадуур заавал хураана» гэж заасан бөгөөд энэ нь хэдийгээр нэмэгдэл ялын шинжийг агуулахгүй боловч эдгээр зүйл нь гэм буруутай этгээдийн өмчлөлд байсан нь тогтоогдсон тохиолдолд түүнийг үнэ төлбөргүйгээр хурааж улсын орлого болгох ёстой. Гэтэл энэ байр болон зогсоол нь Ц.Ч-

ийн өмчлөлд байдаг бөгөөд энэ байр болон зогсоолын өмчлөх эрхийг ямар нэг байдлаар хүчингүй болгоогүй байхад шууд улсын орлого болгож шийдвэрлэсэн нь ойлгомжгүй бөгөөд хүний өмчлөх эрхэнд шууд халдсан шинжтэй шийдвэр болжээ.

Иймд Х.А-ыг гэм буруутай гэж үзсэн энэхүү хэрэгт Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн байдлууд байгаа тул эдгээрийг зөвтгөж хууль зүйн дагуу шийдвэрлэж, Х.А-ын ялыг хөнгөрүүлж өгөхийг хүсье» гэв.

Талийгаач Д.А-ны өмгөөлөгч Р.Пүрэвлхам хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол болон тайлбартаа: Давж заалдах шатны шүүх «...талийгаач Д.А-ыг яллагдагчаар татсан тогтоол хэрэгт байхгүй байгаа хэдий ч мөрдөн байцаалтын шатанд Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 36 дугаар зүйлд заагдсан яллагдагчаар татах, яллагдагчийг байцаах ажиллагаа бүрэн хийгдсэн болох нь тогтоогджээ ...» гэж үзсэн нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг ноцтой зөрчсөн гэх үндэслэл болж байна.

Давж заалдах шатны шүүх хуралдаанд улсын яллагч яллагдагчаар татах тогтоол байсан боловч байхгүй болчихсон талаар ярьдаг бөгөөд хэдийд, ямар шалтгааны улмаас, яагаад алга болсноо мэддэггүй, энэ талаар шалгасан тодруулсан баримт хэрэгт авагдаагүй байтал байцаан шийтгэх ажиллагаа бүрэн хийгдсэн гэж үзсэн нь үндэслэлгүй юм.

Сонсгосон ялыг өөрчилсөн тогтоолд өмгөөлөгч оролцуулан байцаасан нь сэжигтнийг яллагдагчаар татаагүй гэж дүгнэх хууль зүйн үндэслэлгүй гэснийг хүлээн зөвшөөрөх боломжгүй бөгөөд ял өөрчлөн сонсгох үед хэргийн материалыг танилцуулаагүй байсан тул яллагдагчаар татсан тогтоолтой эсэхийг мэдэх боломжгүй байсан.

Яллагдагчийг шүүхэд шилжүүлсний дараа шүүгдэгч Д.А нь нас барсан байх агаад энэ талаар өмгөөлөгчийн зүгээс шүүхэд ямар нэгэн хүсэлт гаргаагүй төдийгүй шүүх хуралдаанд цагаатгах байр суурьтай оролцсон тул гэсэн нь шүүх хуулийг буруу хэрэглэсэн үндэслэл болж байна. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1-д «... хэрэв үүсгэсэн бол прокурор, шүүгч хэргийг хэрэгсэхгүй болгоно ...» 24.1.3-т хэрэгт холбогдсон этгээд нас барсан гэсэн нь шүүх хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл

бөгөөд Эрүүгийн байцаан шийтгэх хуульд өмгөөлөгч хүсэлт санал гаргаагүй нь хэргийг хянан шийдвэрлэх үндэслэл биш юм. Харин 24 дүгээр зүйлийн 24.3-т ийнхүү хэрэгсэхгүй болгосныг эс зөвшөөрвөл ердийн журмаар хэрэг хянан шийдвэрлэхийг хуульчилсан байтал 2 шатны шүүх хуулийг буруу хэрэглэж шийдвэр гаргасан.

Миний үйлчлүүлэгч агсныг авлигын гэмт хэрэгт гэм буруутайд тооцохдоо Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 290 дүгээр зүйлийн 290.2-т заасан «шүүхийн тогтоол нь таамаглалд үндэслэж болохгүй» гэсэн заалтыг зөрчин таамаглалд үндэслэсэн нь хэрэгт авагдсан баримтуудаар хангалттай нотлогдоно.

Цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч Л.Ононбаяр, М.Баяраа нар хяналтын шатны шүүхэд гаргасан гомдол болон тайлбартаа: «...Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 751 дүгээр тогтоолын 10 дахь заалт болох «Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар гэмт хэрэг үйлдэж олсон эд зүйл болох Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот / Улсын бүртгэлийн Y-220601xxxx дугаартай үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээтэй/ нийт 160 м2 талбай бүхий орон сууц, 2 ширхэг авто зогсоолыг хурааж улсын орлого болгохоор» шийдвэрлэсэн нь шүүхээс бусдын өмчлөх эрхэд халдсан хууль зүйн үндэслэлгүй шийдвэрийг гаргасан.

Учир нь тухайн үл хөдлөх эд хөрөнгө нь Ц.Ч-ийн хууль есны дагуу олж авсан эд хөрөнгө бөгөөд «Тг» ХХК-ийн захирал Х.А-тай харилцан тохиролцон, Ц.Ч-д «Те Х» ХХК-д ажиллуулахаар урьж, ажил санал болгосны дагуу түүнд хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдсан үл хөдлөх эд хөрөнгө байдаг.

Өөрөөр хэлбэл, иргэдийн хооронд хийсэн энэхүү тохиролцооны үндсэн дээр Ц.Ч нь өмнө ажиллаж байсан «Хас банк»-ний салбарын захирлын ажлаасаа гарсан байгааг шүүх анхаарна уу.

Өнгөрсөн хугацаанд тухайн үл хөдлөх эд хөрөнгийн үнэд нийт 100.000 ам долларыг Ц.Ч нь Х.А-т төлсөн бөгөөд түүний тал мөнгө болох 50.000 ам долларыг 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр буюу Ц.Ч нь Х.А нар худалдах, худалдан авах гэрээ байгуулсан өдрөө бэлнээр Х.А-ын туслах Н.О-д өгснийг Н.О бусад мөнгөтэйгөө хамтад нь тухайн үед байгууллагын санхүүдээ аваачиж тушаасан баримт хэрэгт /хх-250 дахь тал/ тодорхой

авагдсан байгаа.

Энэ талаар Х.А, Н.О, Ц.Ч нарын хэрэгт өгсөн мэдүүлгээр тодорхой нотлогддог бөгөөд Х.А нь Ц.Ч-д төдийгүй бусад 6 ажилтандаа орон сууцных нь /зарим хүнд нэмж автомашин өгсөн/ асуудалд хөнгөлөлт дэмжлэг үзүүлсэн байгааг шүүх бодитойгоор анхаарах шаардлагатай юм.

Анхан болон давж заалдах шатны шүүхээс Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 95 дугаар зүйлд зааснаар дээр дурдсан болон хэрэгт авагдсан бусад нотлох баримтуудыг тал бүрээс нь нягт нямбай, бүрэн гүйцэд, бодит байдлаар нь хянаж үзсэнгүй. Мөн Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийн 49.2-т заасныг буруу хэрэглэсэн.

Учир нь уг үүсгэсэн эрүүгийн хэрэгт «тендерийн сонгон шалгаруулалт хууль бус явагдсан эсэх», «авлига өгсөн, авсан эсэх» гэх 2 асуудлыг хооронд нь холбохдоо гэмт хэргийг шууд нотолж буй нотлох баримтгүйгээр анхан шатны шүүхээс хэргийг шийдвэрлэсэн нь буруу.

Ц.Ч-ийн өөрийн боловсрол, мэдлэг, ажлын туршлага, ур чадвараа үнэлүүлсэн, өнгөрсөн 4 жилийн шударга хөдөлмөр нь шингэсэн уг эд хөрөнгийг хураахаар шүүхээс шийдвэрлэсэн нь Эрүүгийн хуулийг буруу хэрэглэн, бусдын өмчид халдсан хууль зүйн үндэслэлгүй шийдвэр гаргасан.

Түүнчлэн хэрэгт авагдсан нотлох баримт болон давж заалдах шатны шүүхийн хуралдаанаар хэргийг хэлэлцэж байхад шүүх бүрэлдэхүүн, тухайлбал шүүгч Ч.Хосбаярын тавьсан асуултад прокурорын хариулснаас үзэхэд «тендерийн сонгон шалгаруулалт хууль бус явагдсан эсэх», «авлига өгсөн, авсан эсэх» хэргийг холбосон шууд болоод хангалттай нотлох баримт байхгүй болох нь тодорхой болсон бөгөөд хяналтын шатны шүүхээс үүнийг анхаарахыг хүсье.

Анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3 болон 24.3-т заасныг буруу хэрэглэн, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 240 дүгээр зүйлд заасныг зөрчин шүүгдэгч Д.А-гүйгээр хэргийг шийдвэрлэсэн нь буруу юм.

Шүүхийн энэхүү хэргийг шийдвэрлэсэн практик нь талийгаач Д.А-ы Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14-т заасан «шүүхэд гомдол гаргах, өөрийг өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн

шийдвэрт давж заалдах гомдол гаргах» зэрэг иргэний үндсэн болоод Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаанд оролцогчийн бусад эрхийг ноцтой зөрчсөн явдал.

Иймд Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 дүгээр шийтгэх тогтоолын 10 дахь заалт, Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 787 тоот магадлалын түүнд холбогдох хэсгийг хүчингүй болгож, Ц.Ч-ийн орон сууц, хөрөнгийг буцаан олгохоор шийдвэрлэхийг хүсье» гэжээ.

Улсын Ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор Д.Эрдэнэцэцэг хяналтын шатны шүүх хуралдаанд гаргасан саналдаа: «...анхан болон давж заалдах шатны шүүх хэрэгт авагдсан нотлох баримтад үндэслэлтэй дүгнэлт хийж хэргийг шийдвэрлэн гэм буруутай этгээдэд ял оногдуулан шийдвэрлэжээ.

Шийтгэх тогтоол, магадлалаар анхан болон давж заалдах шатны шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглээгүй, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчөөгүй байх тул тогтоол, магадлалыг хэвээр үлдээх саналтай байна.

Өмгөөлөгч нарын гомдлыг хүлээн авах боломжгүй гэж үзэж байна. Ц.Ч нь 2009 оны 02 дугаар сарын 02-ны өдөр тухайн байрыг Н.О-оос бэлэглэлийн гэрээгээр байрыг өөртөө шилжүүлэн авсан нь тогтоогдсон, харин байрны төлбөр төлсөн болох нь нотлогдоогүй. Байрыг бусдаар дамжуулан Д.А хээл хахуульд авсан тул Ц.Ч-д байрыг олгох үндэслэлгүй. Гэмт хэргийн журмаар олж авсан эд хөрөнгө тул хураахаар шийдвэрлэсэн шүүхийн тогтоол зөв юм. Сонгон шалгаруулах зөвлөл шийдвэр гаргаж «Тг» ХХК-д Бүтээгдэхүүн хуваах гэрээг эзэмших эрх олгосноор тендерийн асуудал эцэслэн шийдвэрлэгдэж байгаа. Иймд энэ асуудал одоо хүртэл шийдвэрлэгдээгүй байгаа гэсэн өмгөөлөгчдийн гомдлыг хүлээн авах боломжгүй юм.

Д.А тендерийн асуудалд оролцсон болох нь түүний өөрийнх нь Сонгон шалгаруулах зөвлөлийн хурал дээр хэлсэн үгнээс тодорхой харагддаг.

Иймд шүүхийн шийтгэх тогтоол, магадлалыг хэвээр үлдээх саналтай байна» гэв.

ХЯНАВАЛ:

Анхан болон давж заалдах шатны шүүх ялтан Х.А-ыг 2008 өдөр газрын тосны бүтээгдэхүүн хуваах чиглэлээр Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад зарласан Олон улсын нээлттэй тендерт «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө Газрын тосны газрын даргаар ажиллаж байсан Д.А-д 2009 оны 12 дугаар сарын 02-ны өдөр 494.000.000 төгрөгийн үнэ бүхий Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо, ...тоот 160 м² талбайтай орон сууц, 2 автомашины зогсоолыг бусдаар дамжуулж хээл хахуульд өгсөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож, энэ хэрэгт хээл хахууль өгөхөд хамжигчаар оролцсон гэх Н.О-д холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж, хээл хахууль авахад хамжигчаар оролцсон гэх Ц.Ч-д холбогдох хэргийг гэмт хэрэг үйлдэхэд оролцсон нь тогтоогдоогүй гэж тус тус хэрэгсэхгүй болгож,

Х.А-т холбогдох Монгол Улсын Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухайн хуулийн 7, 8, 16, 17, 21 дүгээр зүйлүүдэд заасныг зөрчин, 2007-2011 онд нийт 12.303.690.000 төгрөгөөр хайгуулын болон ашиглалтын ашигт малтмалын тусгай зөвшөөрөл худалдан авч Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн дагуу эрх борлуулсны орлогын албан татвар болох 3.691.107.000 төгрөгийг суутган авч төсөвт төлөлгүй онц их хэмжээний албан татвар төлөхөөс санаатайгаар зайлсхийсэн гэмт хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2-т заасан үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь хууль ёсны бөгөөд үндэслэл бүхий болсон байна.

Анхан болон давж заалдах шатны шүүх шийтгэх тогтоол болон магадлалд дээрх байдлаар дүгнэлт хийхдээ хавтаст хэрэгт цуглуулж, бэхжүүлсэн нотлох баримтуудыг харьцуулан судалж, шалгасны эцэст хууль болон эрх зүйн ухамсрыг удирдлага болгон өөрийн дотоод итгэлээр үнэлж тогтоосон байх бөгөөд шүүх тогтоол гаргахад ач холбогдолтой байж болох бүхий л байдлыг шалгаж тогтоосон, мөрдөн байцаалт болон шүүхээс хэрэг хянан шийдвэрлэх явцад ялтан болон хэргийн бусад оролцогчийн хуулиар хамгаалагдсан эрхийг хассан, хязгаарласан, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасан шаардлагыг зөрчсөн ноцтой зөрчил тогтоогдоогүй, анхан болон давж заалдах шатны шүүх Х.А-т холбогдох хэргийн зүйлчлэлийг зөв хийж, гэмт хэрэг үйлдэгдсэн

нөхцөл байдал, нийгмийн хор аюул, хувийн байдал, гэм буруу, учруулсан хор уршигт тохирсон ял оногдуулж Эрүүгийн хуулийг зөв хэрэглэсэн байна.

Х.А-т холбогдох Эрүүгийн хуулийн 166 дугаар зүйлийн 166.2-т заасан гэмт хэргийг хэрэгсэхгүй болгосон нь цаашид зохих хууль тогтоомжийн хүрээнд татвар төлөх эсэхтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд нөлөөлөхгүй болохыг тэмдэглэвэл зохино.

Х.А бусдад онц их хэмжээний хээл хахууль өгсөн үйл баримт анхан болон давж заалдах шатны шүүхээр тогтоогдсон, шүүх тогтоосон үйл баримтдаа Эрүүгийн хуулийг буруу хэрэглээгүй байх тул энэ талаар гаргасан ялтны өмгөөлөгчийн гомдлыг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй.

Харин ялтан Х.А-ын өмгөөлөгч нараас «Х.А-т холбогдох хэргийг буруу тусгаарлаж, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг зөрчсөн» гэх гомдлын тухайд, анхан болон давж заалдах шатны шүүх «шүүх хуралдааны ажиллагааг явуулах хэмжээ хязгаар»-ыг тогтоосон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 246 дугаар зүйлийн дагуу хэргийг хянан шийдвэрлэсэн байх бөгөөд өмгөөлөгч нарын гомдолд дурдсан үндэслэлд тодорхой хариу өгч шийдвэрлэсэн нь үндэслэлтэй болжээ.

Мөн цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч М.Баяраа, Л.Ононбаяр нарын «Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлийг буруу хэрэглэж, Ц.Ч-ийн өмчлөлийн үл хөдлөх хөрөнгийг улсын орлого болгохоор шийдвэрлэсэн гэх гомдолтой холбогдуулан хэргийн материалыг шинжлэн судалбал: Ц.Ч Х.А-аас уг орон сууц, автомашины зогсоолуудыг хууль ёсоор, өөрсдийн хүсэл зоригоо харилцан илэрхийлж хэлцэл хийсэн, улмаар Ц.Ч уг үл хөдлөх эд хөрөнгийг худалдаж авсан гэх бодит нөхцөл байдал тогтоогдоогүй, харин Х.А нь 2008 оны 08 дугаар сарын 13-ны өдөр газрын тосны бүтээгдэхүүн хуваах чиглэлээр Шарга-3, Нэмэгт-6 талбайнуудад зарласан Олон улсын нээлттэй сонгон шалгаруулалтад «Тг» ХХК-ийг шалгаруулсны төлөө уг сонгон шалгаруулах зөвлөлийн даргаар ажиллаж байсан Д.А-д өөрийн эзэмшлийн байраа хээл хахуульд өгсөн үйл баримт анхан болон давж заалдах шатны шүүхээр тогтоогдсон байх тул уг хээл хахуульд өгсөн эд хөрөнгийг Эрүүгийн хуулийн 49 дүгээр зүйлд заасан үндэслэлээр улсын орлогод оруулахаар шийдвэрлэсэн нь үндэслэлтэй байна гэж үзнэ.

Харин талийгаач Д.А-ны өмгөөлөгч Д.Пүрэвлхамын «... шийтгэх тогтоол магадлалын талийгаач Д.А-ыг гэм буруутайд тооцсоныг хэрэгсэхгүй болгож өгнө үү» гэсэн гомдлын тухайд, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.3-т гэмт хэрэгт холбогдсон этгээд нас барсан бол түүнд үүсгэсэн хэргийг хэрэгсэхгүй болгож, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа явуулж болохгүй талаар шууд зохицуулсан заалтыг анхан болон давж заалдах шатны шүүх зөрчсөн байна.

Өөрөөр хэлбэл, анхан шатны шүүх Д.А-д холбогдох хэргийг нас барсан үндэслэлээр шууд хэрэгсэхгүй болгох ёстой байтал түүний гэм бурууг хэлэлцэж, гэм буруутайг тогтоосон ажиллагаа үндэслэлгүй болжээ. Иймд өмгөөлөгч Д.Пүрэвлхамын хяналтын шатны шүүхэд гаргасан дээрх гомдлыг хангах хууль зүйн үндэслэлтэй байна.

Хяналтын шатны шүүх хуралдаанд оролцсон ялтан Х.А-ын өмгөөлөгч нараас «Х.А-г оногдуулсан хорих ялыг тэнсэж өгөх» талаар хүсэлт гаргасан бөгөөд Х.А-ын үйлдсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан гэмт хэрэг нь хүндэвтэр гэмт хэргийн ангилалд хамаарч байх бөгөөд Х.А дээрх гэмт хэргийг анх удаа үйлдэж хорих ял шийтгүүлсэн, түүний хувийн байдлын талаар хэрэгт цугларсан нотлох баримт зэргийг харгалзан Эрүүгийн хуулийн 61 дүгээр зүйлийг хэрэглэж, түүнд оногдуулсан хорих ялыг биечлэн эдлүүлэхгүйгээр тэнсэж, хянан харгалзах боломжтой гэж үзэв.

Иймд анхан болон давж заалдах шатны шүүхийн шийтгэх тогтоол, магадлалд зохих өөрчлөлт оруулж, талийгаач Д.А-ны өмгөөлөгч Л.Пүрэвлхамын гомдлыг бүхэлд нь хангаж, Х.А-ын өмгөөлөгч нараас хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлын зарим хэсгийг хангаж, бусад хэсгийг хэрэгсэхгүй болгож, цагаатгагдсан этгээд

Ц.Ч-ийн өмгөөлөгч М.Баяраа, Л.Ононбаяр нарын гомдлуудыг хэрэгсэхгүй болгож тус тус шийдвэрлэх үндэслэлтэй гэж хяналтын шатны шүүх бүрэлдэхүүн дүгнэв.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.2-т заасныг тус тус удирдлага болгон Улсын Дээд шүүхийн хяналтын шатны шүүх хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 751 дүгээр шийтгэх тогтоол, түүнийг хэвээр үлдээсэн Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхийн 2014 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн 787 дугаар магадлалд дараах өөрчлөлтийг оруулсугай:

- шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 4 дэх заалтын “Шүүгдэгч Б овогт Д.А-ыг онц их хэмжээний хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд” гэснийг хасаж,

- шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт “Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэгт зааснаар Х.А-т оногдуулсан 3 жилийн хорих ялыг тэнсэж, 3 жилийн хугацаагаар хянан харгалзаж, түүнд хяналт тавихыг Хан-Уул дүүргийн Цагдаагийн хэлтэст даалгасугай” гэсэн,

- шийтгэх тогтоолын тогтоох хэсэгт “Татварын байгууллага татвар төлүүлэх асуудлаа хууль тогтоомжийн дагуу жич шийдвэрлүүлбэл зохихыг дурдсугай.” гэсэн нэмэлт тус тус оруулсугай.

2. Шийтгэх тогтоол, магадлалын бусад заалтыг хэвээр үлдээсүгэй.

3. Ялтан Х.А-ын өмгөөлөгч Ц.Цэрэнжээ, Б.Баярмаа, Ж.Эрдэнэбулган нарын гомдлын Х.А-т оногдуулсан ялыг тэнсэж, хянан харгалзаж өгнө үү гэснээс бусад хэсгийг, цагаатгагдсан этгээд Ц.Ч-ийн өмгөөлөгч М.Баяраа, Л.Ононбаяр нарын хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлыг бүхэлд нь тус тус хэрэгсэхгүй болгосугай.

ДАРГАЛАГЧ,
ТАНХИМЫН ТЭРГҮҮН
ШҮҮГЧ

С.НЯМЖАВ
Д.ГАНЗОРИГ

ЦАГААТГАХ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 04 өдөр

Дугаар 1299

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 1 дүгээр шүүхийн шүүгч Б.Зориг даргалж, шүүгч Б.Сарантуяа, С.Оюунгэрэл нарын бүрэлдэхүүнтэй,

иргэдийн төлөөлөгч Б.Эрдэнэчимэг, Н.Дуламсүрэн, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга Н.Номинчимэг, улсын яллагч Д.Ганчанга, шүүгдэгч Г.Д, түүний өмгөөлөгч О.Сайнгэрэл, Г.Наранбаатар, Г.Оюунцэцэг, шүүгдэгч М.Э, түүний өмгөөлөгч Б.Наранцэцэг, Энхжаргал, шүүгдэгч М.Б, Э.С, тэдгээрийн өмгөөлөгч Н.Энхбаяр, шүүгдэгч Ч.П, түүний өмгөөлөгч Д.Тамир, шүүгдэгч Б.Ц, түүний өмгөөлөгч Б.Мянган, шүүгдэгч Б.Д, түүний өмгөөлөгч Ж.Болдбаатар нарыг оролцуулан тус шүүхийн хуралдааны «Б» танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар,

Дүүргийн 1 дүгээр прокурорын газраас Эрүүгийн хуулийн 245 дугаар зүйлийн 245.2, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийг журамлан 254 дүгээр зүйлийн 254.2, 256 дугаар зүйлийн 256.2, 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдсэн Г.Д, мөн хуулийн 254 дүгээр зүйлийн 254.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдсэн М.Э, М.Б, Э.С, Б.Ц, Б.Д, 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийг журамлан 254 дүгээр зүйлийн 254.2 дахь хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдсэн Ч.П нарт холбогдох эрүүгийн 201301040877 дугаар хэргийг 2014 оны 10 дугаар сарын 3-ны өдөр хүлээн авч, энэ өдөр хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт:

1. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ний өдөр Улаанбаатар хотод төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, хүний их эмч мэргэжилтэй, Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн хэлтсийн дарга ажилтай, ам бүл ..., хүүхдийн хамт Хан-Уул дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, ХЕ..... дугаар регистртэй, С овогт Г.Д;

2. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Хөвсгөл аймагт төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, хүний их эмч мэргэжилтэй, Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн хэлтэст шинжээч эмч ажилтай, ам бүл ..., эхнэр хүүхдүүдийн хамт Баянгол дүүргийн ...дугаар хороо ...оршин суух, ял шийтгэлгүй, ЧП..... дүгээр регистртэй, Б овогт М.Э;

3. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Дундговь аймагт төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, хүний их эмч мэргэжилтэй, Дундговь аймгийн Шүүхийн шинжилгээний албанд шинжээч эмч ажилтай, ам бүл ..., эхнэр, хүүхдийн хамт Дундговь аймгийн ...сумын ...дугаар баг ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, ЗВ..... дүгээр регистртэй, Х овогт М.Б;

4. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Сүхбаатар аймагт төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, хүний их эмч мэргэжилтэй, Сүхбаатар аймгийн Шүүхийн шинжилгээний албанд шинжээч эмч ажилтай, ам бүл ..., эхнэр хүүхдүүдийн хамт Сүхбаатар аймгийн ...сумын ...дугаар багийн ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, ЛЮ..... дугаар регистртэй, Х овогт Э.С;

5. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Увс аймагт төрсөн, ...настай, эрэгтэй, дээд боловсролтой, хүний их эмч мэргэжилтэй, Сэлэнгэ аймгийн Шүүхийн шинжилгээний албанд шинжээч эмч ажилтай, ам бүл ..., эхнэр хүүхдийн хамт Дархан-Уул аймгийн ...сумын ...дугаар баг ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, ОЖ..... дүгээр регистртэй, Х овогт Б.Д;

6. Монгол Улсын иргэн, ...оны ...дүгээр сарын ...-ны өдөр Ховд аймагт төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, хүний их эмч мэргэжилтэй, Ховд аймгийн Шүүхийн шинжилгээний албанд шинжээч эмч ажилтай, ам бүл ..., нөхөр хүүхдийн хамт Ховд аймгийн ...сумын ...багийн ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, ПН..... дугаар регистртэй, С

овогт Б.Ц;

7. Монгол Улсын иргэн, ...оны ...дугаар сарын ...-ны өдөр Архангай аймагт төрсөн, ...настай, эмэгтэй, дээд боловсролтой, нягтлан бодогч мэргэжилтэй, Шүүхийн шинжилгээний хүрээлэнгийн шинжилгээний бүртгэл мэдээллийн ажилтан, ам бүл ..., охины хамт Чингэлтэй дүүргийн ...дүгээр хороо ...тоотод оршин суух, ял шийтгэлгүй, АО..... дугаар регистртэй, Х овогт Ч.П.

Холбогдсон хэргийн талаар /Прокурорын яллах дүгнэлтэд бичигдсэнээр /;

"Яллагдагч Г.Д нь Шүүх шинжилгээний үндэсний төвийн дэд дарга Шүүх эмнэлгийн хэлтсийн даргаар ажиллаж байхдаа албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтсээс мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж байсан эрүүгийн 2083099. дугаартай хэрэгт хохирогч Р.А-гийн биед учирсан гэмтлийн зэргийг шинжээч эмч Ж.Г 2008 оны 10 дугаар сарын 10-ны өдөр гэмтлийн зэрэг тогтоох Шүүх эмнэлгийн магадлан шинжилгээний зааврын 2.2.1-д зааснаар амь биед аюултай хүнд гэмтэлд хамаарна гэж дүгнэлт гаргаад Г.Д-д хянуулахаар өгөхөд Хүндэвтэр зэрэгт хамаарна гэж өөрчлөн шинжээч эмч Ж.Г-ийн гарын үсгийг дуурайлгаж, зурж зориуд худал дүгнэлт гаргаж уг дүгнэлтийг цагдаагийн байгууллагад хүргүүлж албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж мөрдөн байцаалтын, шүүн таслах ажиллагаанд саад учруулсан,

Эрүүгийн 2083099. дугаартай эрүүгийн хэрэгт шинжээч эмч Б.У, Ч.Э, Д.Д, Ц.Б, З.Х нар 2008 оны 12 дугаар сарын 18-ны өдөр 544 тоот шинжээчийн дүгнэлтээр хохирогч Р.А-гийн биед учирсан гэмтэл нь хүнд гэсэн дүгнэлт гаргасныг өөрийн удирдлаганд ажиллаж байсан шинжээч эмч Б.А, Н.Т, Ө.С, Г.Э нараар 2009 оны 2 дугаар сарын 23-ны өдөр 36 тоот дүгнэлтээр хохирогч Р.А-гийн биед учирсан гэмтлийг Хүндэвтэр гэмтэлд хамаарна гэж зориуд худал дүгнэлт гаргуулж албан тушаалтан, албаны эрх мэдлээ урвуулан ашиглаж хүнд хор уршиг учруулсан,

Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн хэлтсээс мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шалгасан Г.С-д холбогдох эрүүгийн 2083877. дугаартай хэрэгт хохирогч М.Ц-ын биед учирсан гэмтлийн зэрэг тогтоох Шүүх эмнэлгийн магадлан шинжилгээний зааврын 2.2.1-д зааснаар гэмтлийн хүнд зэрэгт хамаарна гэж дүгнэлтийг шинжээч эмч

Н.Б гаргаад Г.Д-д хянуулахаар өгөхөд Г.Д нь засварлаж хохирогч М.Ц-ын биед учирсан гэмтлийг хөнгөн зэрэгт хамаарна гэж албан тушаалтан албаны эрх мэдэл буюу албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж зориуд худал дүгнэлт гаргуулсан,

Баянгол дүүргийн цагдаагийн хэлтсээс мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шалгаж байсан эрүүгийн 20120101154. дүгээр Б.Б-д холбогдох хэрэгт хохирогч М.О-ын биед учирсан гэмтлийн зэргийг шинжээч эмч Г.Э, М.О, М.З нар нь 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр гэмтлийн зэрэг тогтоох журмын 3.1.11-д зааснаар Хүнд зэрэгт хамаарна гэж 812 тоотод дүгнэлт гаргасан байхад Г.Д нь цагдаагийн байгууллагад хүргүүлэх ёстой шинжээчийн дүгнэлтийг сольж шинжээч эмч дадлагажигч ажилтнаар ажиллаж байсан Б.До, М.Б, Э.С, нарын нэрээр Б.О-ын биед учирсан гэмтлийн зэргийг Хүндэвтэр гэж хуурамч дүгнэлт үйлдэж М.Б, Э.С нараар гарын үсэг зуруулж шинжээч эмч Б.До-гийн гарын үсгийг статискч бага эмчээр ажиллаж байсан Ч.П-аар, зуруулж уг дүгнэлтээ цагдаагийн байгууллагад хүргүүлэн мөрдөн байцаалт шүүн таслах ажиллагаанд саад учруулсан мөн 201201011548. дугаартай хэрэгт хавтаст хэргийн материалаар шинжээч томилох тогтоолын дагуу 2013 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр шинжээч эмч М.Э, Б.Д, Б.Ц, нараар хохирогч Б.О-ын биед учирсан хүнд зэргийн гэмтлийг хүндэвтэр зэрэгт хамаарна гэж 828 дугаартай шинжээчийн зориуд хуурамч дүгнэлт гаргуулсан,

Яллагдагч М.Б Баянгол дүүргийн цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгаас мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шалгаж байсан хэрэгт Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтсийн ахлах зэргийн шинжээч эмч Г.Э, эмч шинжээч Б.О, М.З нар 2011 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хохирогч Б.О-ын биед гэмтлийн зэрэг тогтоох зорилгоор хавтаст хэргийн материалаас Шүүх эмнэлгийн давтан магадлан шинжилгээ хийж 828 дугаартай шинжээчийн дүгнэлт гаргахдаа хохирогч Б.О-ын биед учирсан хүнд зэргийн гэмтлийг хүндэвтэр зэрэгт хамаарна гэж зориуд худал дүгнэлт гаргаж хүнд хор уршиг учруулсан,

Яллагдагч Э.С нь Баянгол дүүргийн цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгаас мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж шалгаж байсан хэрэгт Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтсийн ахлах зэргийн шинжээч эмч Г.Э, эмч шинжээч М.О, М.З нар

2011 оны 11 дүгээр сарын 19-ний хохирогч Б.О-ын биед гэмтлийн тогтоох зорилгоор хавтаст хэргийн материалаас шүүх эмнэлгийн давтан магадлан шинжилгээг явуулж, Б.О-ын биед учирсан гэмтлийг шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоох журмын 3.1.11 дэх хэсэгт зааснаар амь биед аюултай гэмтлийн хүнд зэрэгт хамаарна гэж гарсан шинжээчийн 812 дугаартай дүгнэлт гаргасан байхад шинжээч эмчээр ажиллаж байсан, Б.До, М.Б, Э.С нар хохирогч Б.О-ын бие учирсан гэмтлийг шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоох журмын 2.3.1-д зааснаар эрүүл мэндийг удаан хугацаагаар сарниулах тул гэмтлийн хүндэвтэр зэрэгт хамаарна гэж зориуд худал дүгнэлт гаргаж хүнд хор уршиг учруулсан,

Яллагдагч Б.Д нь Баянгол дүүргийн цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад С.С-ын 2012 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн шинжээч томилох тогтоолын дагуу шинжээч эмч дадлагажигч ажилтан Б.Ц, Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтсийн дэд дарга М.Э нарын хамт 2013 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Б.О-ын биед гэмтлийн зэрэг тогтоох хавтаст хэргийн материалаар, шүүх эмнэлгийн давтан магадлан шинжилгээ хийж 828 дугаартай шинжээчийн дүгнэлт гаргахдаа хохирогч Б.О-ын биед учирсан хүнд зэргийн гэмтлийг хүндэвтэр зэрэгт хамаарна гэж зориуд худал дүгнэлт гаргаж хүнд хор уршиг учруулсан,

Яллагдагч Б.Ц нь Баянгол дүүргийн цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад С.С-ын 2012 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн шинжээч томилох тогтоолын дагуу шинжээч эмч дадлагажигч ажилтан Б.Ц, Шүүх эмнэлгийн шинжилгээний хэлтсийн дэд дарга М.Э нарын хамт 2013 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Б.О-ын биед гэмтлийн зэрэг тогтоох зорилгоор хавтаст хэргийн материалаар, шүүх эмнэлгийн давтан шинжилгээ хийж 828 дугаартай шинжээчийн дүгнэлт гаргахдаа хохирогч Б.О-ын биед учирсан хүнд зэргийн гэмтлийг хүндэвтэр гэж зориуд худал дүгнэлт гаргаж хүнд хор уршиг учруулсан,

Яллагдагч Ч.П нь Шүүх шинжилгээний хүрээлэнд статистикч бага эмчээр ажиллаж байхдаа Баянгол дүүргийн цагдаагийн хэлтсийн Мөрдөн байцаах тасгийн мөрдөн байцаагч цагдаагийн ахмад С.С-ын шинжээч томилох тогтоолын дагуу Шүүх

эмнэлгийн шинжилгээний хэлтсийн ахлах зэргийн шинжээч эмч Г.Э, эмч шинжээч М.О, М.З нар 2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр хохирогч Б.О-ын биед гэмтлийн зэрэг тогтоох зорилгоор хавтаст хэргийн материалаар шүүх эмнэлгийн давтан магадлан шинжилгээг явуулж Б.О-ын биед учирсан гэмтлийг шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоох журмын 2.3.1-д зааснаар эрүүл мэндийг удаан хугацаагаар сарниулах тул гэмтлийн хүндэвтэр зэрэгт хамаарна гэсэн дүгнэлтийг шинжээч эмч дадлагажигч Б.До-гийн гарын үсэг зурах хэсэгт Ч.П гарын үсэг зурж цагдаагийн байгууллагад хүргүүлж зориуд худал дүгнэлт гаргаж хүнд хор уршиг учруулсан» гэмт хэрэгт тус тус холбогджээ.

ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Г.Д мэдүүлэхдээ: «Р.А-гийн биед гэмтлийн зэрэг тогтоосон актад би өөрийнхөө гарын үсгийг өөрийнхөө нэрээр Ж.Г /ийг/ гээд Г.Д гэж зурсан. Хууль хяналтын байгууллагын ажлыг удаашруулахгүй гэж дүгнэлт нэхэгдээд байхаар нь л би зурсан. Үүнд би ямарч хувийн сэдэлт байхгүй. Би даргын хувьд байгууллагаас гарч байгаа аль ч акт дүгнэлтийг хянах үүрэгтэй. Энэ 1242 тоот актын талаар 2008 оны 11 сард хангалттай шалгуулсан. Энэ актын ноорог нь байгууллагад байгаа, ноорог дээр шинжээч эмч заавал гарын үсэг зурдаг, шинжээч Ж.Г хүнд гээд би хүндэвтэр гэж өөрчлөөгүй. Уг дүгнэлтийг цагдаагийн байгууллагад хүргүүлж албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, мөрдөн байцаалт, шүүн таслах үйл ажиллагаанд саад учруулсан гэж ямар үндэслэлээр прокурор үзэж байгааг ойлгохгүй байна. Би энэ актыг хүргэж өгөх ажил үүргийн хуваарь байхгүй. Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн И даргаас манайд албан тоот ирүүлж, хохирогч А-гийн дүгнэлт удаж байгаа тул яаралтай гаргаж өгөхийг шаардсан байсан. Би компьютертомографикийн зургийг нь хүлээж байсан юм. Мөн прокурор өөрийн удирдлага дор байсан хүмүүс дээр худал дүгнэлт гаргуулсан гэж байна. Улсын хэмжээнд 26 шинжээч эмч байдаг. Шинжээч нар өөрсдийн мэдлэгийн төвшинд дүгнэлтийг өөрсдөө хариуцаж гаргадаг. Эдгээр шинжээч нарын мэдүүлэгт ч тэр Г.Д дарга ингэж тэг гээд дүгнэлт гаргуулсан гэсэн зүйл байхгүй, би ч ингэж тэднээр дүгнэлт гаргуулах ч боломжгүй. М.Ц-ын биед гаргасан гэмтлийн

зэргийн хувьд түүнийг анх хүлээн авахын эмч нь байж магадгүй гэмтсэн байж болох гэмтлээр нь хүндрүүлж бичсэн байдаг. Ер нь анх онош тавихдаа ийм байдлаар таамаг тавьж оношийг шалгах үүднээс хүнд талаас нь бичдэг. Гэтэл яг эмчилгээ хийсэн эмч нь болохоор өвчний түүх дээр нь амьсгалтай, цээжинд шингэн байхгүй, хий байхгүй гэсэн байгаа. Энэ нь түүний цээж рүү нэвтэрсэн зүйл байхгүйг нотолж байгаа юм. Ц гэж хүнийг ч гэсэн миний энэ хэрэг дээр асуусан байсан ба эмнэлэгт 3 хоног хэвтээд л гарчихсан ямарч гомдол саналгүй гэсэн байсан. Мөн Ц-ын биед эхний дүгнэлт гаргасан шинжээч эмч Б мэдүүлэхдээ би эхний магадлах оношид нь хөтлөгдөөд буруу дүгнэлт гаргасан байсан гэдгээ ч хэлсэн. Үүнийг ч гэсэн урьд нь прокурор шалгаж шалгаад хэрэгсэхгүй болгож байсан. Гуравдугаарт М.О-ын биед гарсан дүгнэлтийг хооронд нь сольсон гэж байгаа юм. Би үүнийг солих боломжгүй. Харин 5 удаа дүгнэлт гарсны нэг нь дугаар давхардсан байсан. Гол нь дүгнэлт олдохгүй байна гэж л байгаад, яагаад ч олдоогүй юм мэдэхгүй. Гэтэл энэ үйлдэлд Эрүүгийн хуулийн 35.3-ыг журамлаад гэмт хэргийг зохион байгуулсан гээд байгааг ойлгохгүй байна. Энэ М.О хохирогчтой эрүүгийн хэргийг ч гэсэн шүүх нэмэлт мөрдөн байцаалтад буцааж шинжээчийн дүгнэлтийг дахин гаргуул гэсэн байдаг. Тэгээд ч түүний биед хүнд гэмтэл учирсан гэж хүнд гэмтлээр нь тухайн шүүгдэгчид нь ял өгсөн байхад намайг буруутгаж байгааг хүлээн зөвшөөрөхгүй. Дараа нь энэ хэрэг дээр би статистикч бага эмчээр гарын үсэг зуруулсан гэж буруутгаж байгаа юм. Өмнөх шүүх хурал дээрч П тодорхой мэдүүлсэн. Би үүнд оролцох ямарч боломжгүй. Харин ч эхнээсээ томилогдсон шинжээч эмч Б.До өөрөө яагаад энэ хүнд дүгнэлт гаргаагүй юм бэ гэдэг нь ойлгомжгүй байна шүү дээ. Ер нь эрүүгийн хэргүүдийг ганц нэг удаагийн дүгнэлтээр шийдвэрлэдэг тохиолдол бага байдаг шүү дээ. Энэ бүхэн нь биднээс ямарч шалтгаангүй, тухайн хэргийн хохирогч шүүгдэгч өмгөөлөгч нар гомдол гаргаад дахин дахин дүгнэлт гаргадаг. Дүгнэлт өөрчлөгдөх болгонд шинжээч эмч нарыг ингэж ялласан тохиолдол байхгүй. Энэ бол анагаах ухааны шинжлэн ухаан. Одоо ч анагаахын шинжлэн ухаан тодроогүй зүйл байгаа шүү дээ. Иймд би прокурорын яллах дүгнэлтийг зөвшөөрөхгүй байна» гэв.

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч М.Э мэдүүлэхдээ: «А-гийн биед учирсан гэмтэл

бол хүнд биш хүндэвтэр гэмтэл юмаа. Би үүнд зориуд худал дүгнэлт гаргаад яах юм. Хохирогч А-гийн гавал тархины критер учирсан. Ухаангүй согтуу анх гэмтлийн эмнэлэг дээр хүргэгдэж ирсэн. Энэ нь гэмтлээс болоогүй. Дараа нь архи нь гараад ухаан орсон байдаг. Үхэж болох гэмтэлд хамаарахгүй. Амьдралын амин чухал эд эрхтэн гэмтсэн, орчиндоо харьцахгүй болсон зэрэг хүнд гэмтлийн шинж огт байхгүй байсан. Мэс засалд 30-40 мг цус авсан боловч энэ нь 8 хоногийн дараа хийгдсэн мэс засал. Амь насанд аюултай гэмтэл аль хэдийн өнгөрсөн ба тухайн үеийн тархины цусыг эмчийн эмчилгээгээр өөрөө нь шимэгдүүлээд эмчлэх ёстой байхад хагалгаа хийсэн нь буруу байсан. Хагалгаа хийснээр хүнд гэмтэл болно гэж гэмтлийн зэрэг тогтоох журамд заагаагүй. Энэ хэрэг дээр аль ч талаас нь гомдол гаргаагүй, шүүх ч түүгээр нь шийдвэрлэсэн. Би өөрийн итгэл үнэмшил, мэдлэг туршлагаараа шинжлэх ухааны үндэстэй дүгнэлт гаргасан байтал яагаад зориуд худал дүгнэлт гаргасан гэж байгааг ойлгохгүй байна. Дараа нь Б.О-ын биед учирсан гэмтлийг хүнд гэж л гаргасан. Харин Б.О-ын биед дүгнэлт гаргасан 3 шинжээч хүндэвтэр гэмтлийг үндэслэлтэй гэсэн. Үүнийг би бас л хүлээн зөвшөөрөхгүй байгаа. Тэр өвчтөнд оношилгооны зорилгоор мэс засал хийсэн, энэ мэс заслыг хийх шаардлагагүй байсан. Хүнд гэмтлээрээ ч тэр хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байгаа. Иймд эрхэм шүүгч нар миний ажил үүргийнхээ дагуу үндэслэл дүгнэлт гаргасан байдлыг зөвөөр шийдвэрлэнэ үү» гэв.

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч М.Б мэдүүлэхдээ: «Хохирогч Б.О-ын биед учирсан гэмтлийг хуурамчаар үйлдсэн гэж намайг буруутгаж байгаа. Надад тийм юм огт байхгүй. Би тухайн үед дадлагажигч ажилтнаар ажиллаж байсан ба Э.С ирээд чи бид хоёрын гарын үсэг зурах ёстой юм байна гэхээр нь зурсан. Намайг цагаатгаж өгнө үү» гэв.

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Э.С мэдүүлэхдээ: «Би тухайн үед захирлын тушаал гараагүй дадлагажигч эмч байсан. Би худал дүгнэлт гаргаагүй, гарын үсгээ л зурсан» гэв.

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Б.Д мэдүүлэхдээ: «Хохирогч Б.О-ын биед учирсан гэмтлийн хувьд тухайн өвчтөнд мэс засал хийснийг нь гэмтлийн хүндэвтэрт хамаарна гэж үзсэн. Дотор эрхтэн гэмтээгүй,

харин цээж хэвлийд ямар гэмтэл үүссэнийг тогтоох зорилгоор мэс засал хийгдсэн байсан. Хутганы шарх, хэвлийн хөндийг нээх шарх хоёр өөр» гэв.

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Б.Ц мэдүүлэхдээ: «Би энэ зүйл ангийг хүлээн зөвшөөрөхгүй. Тухайн үед би Говь-Алтай аймагт Анагаахын сургууль төгсөөд Ховд аймагт томилогдоод хотод дадлагажигчаар ажиллаж байсан. Би гарын үсэг зурснаа санахгүй байгаа юм. Гарын үсэг зурсан байлаа гэхэд миний эмчийн тамга задлагдаагүй ууттайгаа л байсан. Шинжилгээнд тамга тэнцэхгүй гэсэн. Гарын үсэг бол мөн гэсэн» гэв.

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Ч.П мэдүүлэхдээ: «Хохирогч Б.О-ын биед учирсан гэмтлийг сольсон, Д-гийн гарын үсгийг зурсан гэж намайг буруутгаж байгаа. Би байгууллагын тэмдгийг хариуцдаг бөгөөд хамгийн сүүлд байгууллагын тэмдгийг дарж баталгаажуулахдаа л Д эмчийн гарын үсгийг дууриалгаж биш, зүгээр нэрээр нь бичээд байгууллагын тамгаа дарсан. Үүнд би ямар ч хувийн санаа бодолгүй зурсан болохоос зориудаар худал дүгнэлт гаргаагүй. Би ноорог хувийг нь ч тулгаж магадласан. Үнэн зөвийг нь тогтоож өгнө үү» гэв.

Мөн шүүх хуралдаанаар яллах болон цагаатгах талуудын саналаар дараахь мөрдөн байцаалтын шатанд цугларсан бичгийн нотлох баримтуудыг уншиж сонсгох замаар шинжлэн судлав.

Гэрч С.Со мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: «2012 оны 08 дугаар сарын 29-нд шилжих шөнө Баянгол дүүргийн ...дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах «Тод өнгө» дэлгүүрийн орчим Б.О нь үл таних залууд хутгалуулж, биедээ хүнд гэмтэл авсан гэх ропартын 5439 дугаартай өргөдлийг хүлээн авч шалгаад 2012 оны 08 дугаар сарын 29-ний өдөр Монгол Улсын Эрүүгийн хуулийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэгт зааснаар 20120101154. дугаар хэрэг үүсгэн шалгаж, хохирогч Б.О-ын биед учирсан гэмтлийн зэргийг тогтоох зорилгоор 2012 оны 09 дүгээр сарын 03-ны өдөр шинжээч томилсон. 2012 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр шинжээчийн 10625 дугаартай дүгнэлтээр хохирогч Б.О-ын биед цээж хэвлийн хөндийд нэвтэрсэн шарх, цус хуралт бүхий гэмтлийн хүнд зэрэг тогтоогдсон. 2012 оны 08 дугаар сарын 29-ний өдөр хэргийн холбогдогч Б.Бж-ыг Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэгт зааснаар сэжигтнээр

тооцож, 2012 оны 10 дугаар сарын 9-ний өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96 дугаар зүйлийн 96.1 дэх хэсэгт зааснаар ял сонсгосон. Мөрдөн байцаалтын шатанд Б.Бж-ын өмгөөлөгч Одгариг 2012 оны 10 дугаар сарын 10-ны өдөр шинжээчийн дүгнэлт эргэлзээтэй тул бүрэлдэхүүнтэй шинжээч томилуулах хүсэлт гаргасан. Хүсэлтийг тухайн үед прокурор н.Дд-той зөвлөлдөөд нэгэнт хэрэг шүүхээр эцэслэн шийдвэрлэгдэх учир хүсэлтийг хангах үндэслэлтэй гэж үзээд 2012 оны 10 дугаар сарын 19-ний өдөр комиссын бүрэлдэхүүнтэй дахин шинжээч томилсон. Гэтэл шинжээч эмч Б.До, М.Б, Э.С нарын комисстой 812 дугаар дүгнэлтээр хохирогч Б.О-ын биед цээж хэвлийн хөндийн шарх, оношилгооны зорилгоор мэс засал хийсэн байдал бүхий гэмтэл тогтоогдлоо. Энэ нь гэмтлийн хүндэвтэр зэрэгт хамаарна гээд урьдах шинжээчийн дүгнэлтээс илт зөрүүтэй гарсан байсан учраас 2012 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр дахин комисстой шинжээч томилсон байна. Яагаад дахин шинжээч томилох болсон гэхээр өмнө гарсан 2 шинжээчийн дүгнэлт хоорондоо илт зөрүүтэй эргэлзээтэй байсан учраас мөрдөн байцаагчийн зүгээс 3 дахь удаагаа шинжээч томилсон. Шинжээч томилох тогтоолдоо урьд өмнө гарсан шинжээчийн дүгнэлтийн аль үндэслэлтэй эсэхийг тодруулах зорилгоор асуулт тавьж өгсөн. Хамгийн сүүлийн шинжээчийн дүгнэлт нь мөн хүндэвтэр гэж гарч ирсэн учраас хяналт тавьж байгаа прокурортойгоо ярилцаад Б.Бж-д урьд сонгосон Эрүүгийн хуулийн тусгай ангийн 96 дугаар зүйлийн 96.1-д заасан ялыг 2013 оны 02 дугаар сарын ний өдөр ял өөрчлөн сонсгох тогтоолын дагуу 181 дүгээр зүйлийн 181.3-д зааснаар ял өөрчлөн сонсгосон. Тэгээд хэргийг яллах дүгнэлт үйлдлүүлэх прокурорт шилжүүлсэн юм. Би шинжээчийн дүгнэлт солигдсон талаар мэдээгүй бөгөөд одоо таниас сонсож байна. Сүүлд н.Дд прокуророос дүгнэлт гаргахад ахалсан шинжээч эмч нь гарын үсэг зураагүй гэж байна гэсэн юм. Б.Бж-д холбогдох эрүүгийн хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа удаашрах болсон шалтгаан нь шинжээчийн дүгнэлтээс шалтгаалсан юм. Гурав дахь удаа бүрэлдэхүүнтэй шинжээч томилсон чинь удаад байхаар нь би өөрөө Шүүх эмнэлгийн дүн бүртгэл дээр очоод энэ дүгнэлт өчнөөн сар боллоо, яагаад гарахгүй удаад байгаа юм бэ? гэж асуусан юм. Тэгтэл дүн бүртгэл та энийг хэзээ өгсөн юм бэ? бүртгэлээс хайгаад

олдохгүй байна гэсэн. Тэгээд даргын нарийн бичгийг дуудаад асуухад нарийн бичиг эмэгтэй манайд ороод ирсэн байгаа одоо дүгнэлт нь энэ 7 хоногт гарна. Та албан бичиг өгөөд хэрэггүй гэхээр нь би нарийн бичгийн утасны дугаарыг нь тэмдэглэж аваад явж байсан юм. Тухайн үед шинжээчийн дүгнэлт гаргахгүй, мөрдөн байцалтын ажиллагаа удааширч байсан бөгөөд шинжээчийн дүгнэлт хуурамч эсэхийг мэдэхгүй учраас санаатай учруулсан гэж дүгнэж чадахгүй байна...» гэжээ /5 дугаар хавтаст хэргийн 99-101 дүгээр тал/.

Гэрч Б.До мөрдөн байцаалтын шатанд мэдүүлэхдээ: «2012 оны 11 дүгээр сард өдрийг нь сайн санахгүй байна манай хэлтсийн дарга Г.Д намайг өрөөндөө дуудсан. Надад Б.О-ын хавтаст хэргийн дүгнэлтийг үзүүлээд энэ хүний цээжний хөндийд шархтай, оношилгооны зорилгоор мэс засал хийгдсэн байгаа хүндэвтэр зэрэг гарна чи гарын үсгээ зурчих гэхээр нь би зурахгүй эмнэлгийн бичиг баримттай нь танилцаж байж зурна гэж хэлээд өрөөнөөс гарсан. Үүнээс хойш Г.Д дарга надтай энэ талаар огт яриагүй, би дүгнэлт гарсан эсэхийг ч мэдээгүй. Тэгтэл Баянгол дүүргийн цагдаагийн хэлтсээс дуудаж энэ дүгнэлтийг харуулсан. Өөр зүйл мэдэхгүй» гэжээ /5 дугаар хавтаст хэргийн 104 дүгээр тал/.

Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжээчийн 2013 оны 08 дугаар сарын 13-ны өдрийн 2008 тоот дүгнэлтэд: «2012 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 812 тоот шинжээчийн дүгнэлт дээрх Б.До-гийн гарын үсэг болон тэмдэгний дардас тохирохгүй байна» гэжээ /5 дугаар хавтаст хэргийн 188-189 дүгээр тал/.

Криминалистикийн шинжилгээний хэлтсийн 2013 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 3830 тоот дүгнэлт: «Баянгол дүүрэг дэх цагдаагийн 2 дугаар хэлтсийн ахлах мөрдөн байцаагч, цагдаагийн ахмад С.С-ын эрүүгийн 201201010154. дугаартай хэрэгт холбоотойгоор 2012 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр томилсон «Шинжилгээ хийлгэх тогтоол» болон Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Шүүх эмнэлгийн шинжилгээний ахлах зэргийг шинжээч эмч М.Э, эмч шинжээч Б.Д, Б.Ц нарын 2013 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 828 дугаартай шинжээчийн дүгнэлтийн нүүр болон төгсгөл хэсэгт зурагдсан шинжээч М.Э-ын гарын үсэг нь харьцуулсан шинжилгээнд хүргүүлж буй

М.Э-ын гарын үсгийн загвартай тохирч байна.

Шинжээч томилсон тогтоол болон дүгнэлт дээр зурагдсан шинжээч Б.Д-гийн гарын үсэг нь харьцуулах шинжилгээнд хүргүүлж буй Б.Д-гийн гарын үсгийн загвартай тохирч байна.

Шинжээч томилох тогтоол болон дүгнэлтийн нүүр болон төгсгөл хэсэгт зурагдсан шинжээч Б.Ц-гийн гарын үсэг нь харьцуулах шинжилгээнд хүргүүлж буй Б.Ц-гийн гарын үсгийн загвартай тохирч байна.

Шинжээчийн 828 дугаартай дүгнэлтийн сүүлийн хуудас дээр «Шинжээч эмч М.Э», «шинжээч эмч Б.Д» нарын тэмдэгний дардсууд нь харьцуулах загвараар ирүүлсэн М.Э, Б.Д нарын тэмдэгний дардастай тохирч байна. Шинжээч эмч Б.Ц гэсэн хэсэгт дарагдсан шинжээчийн тэмдэгний дардас нь шинжилгээнд тэнцэхгүй байна...» гэжээ /5 дугаар хавтаст хэргийн 214-216 дугаар тал/.

Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэнгийн Криминалистикийн шинжээчийн 2014 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 663 тоот дүгнэлтэд: «2008 оны 9 сарын 30-ны өдөр гэсэн огноотой Шинжилгээ хийх шинжээч томилох тогтоол, 2008.10.29 гэсэн огноотой 1242 дугаартай шинжээчийн дүгнэлт зэрэг баримтуудад зурсан шинжилж буй гарын үсгүүдийг Г.Д зурсан байна.

ШШҮХ-ийн архив дахь 1404 дугаартай шинжээчийн дүгнэлтэд зурсан шинжилж буй гарын үсгүүдийг Н.Б зурсан байна.

2009-01-08 гэсэн огноотой, 37 гэсэн дугаартай шинжээчийн дүгнэлтийн /шинжээч эмч Ж.Г/ гэсний зүүн дээр зурагдсан шинжилж буй гарын үсгийг Ж.Г зурсан байна.

Уг дүгнэлтийн /Шинжээч эмч Ч.Э/ гэсэн дээр зурсан шинжилж буй гарын үсгийг Ч.Э зурсан байна.

2009-02-23 гэсэн огноотой 36 дугаартай шинжээчийн дүгнэлтийн /Шинжээч эмч Б.А/ гэсний дээрх шинжилж буй гарын үсгүүдийг Б.А зурсан байна.

2009-01-08 гэсэн огноотой, 37 гэсэн шинжээчийн дүгнэлт болон 2009-06-08 гэсэн огноотой, 260 гэсэн шинжээчийн дүгнэлтийг /Шинжээч эмч М.Э/ гэсний дээрх шинжилж буй гарын үсгүүдийг М.Э зурсан байна.

2009-01-08 гэсэн огноотой, 37 гэсэн шинжээчийн дүгнэлт болон 2009-06-08 гэсэн огноотой, 260 гэсэн шинжээчийн дүгнэлтийг /Шинжээч эмч Н.Т/ гэсний дээрх шинжилж буй гарын үсгүүдийг Н.Т зурсан байна.

2009-01-08 гэсэн огноотой 37 дугаартай дүгнэлтийн шинжээчийн дүгнэлтийн /

Шинжээч эмч Ө.С/ гэсэн хэсэгт болон 2009 оны 02 дугаар сарын 02-ны өдөр гэсэн огноотой 1146 дугаартай шинжээчийн дүгнэлтэд зурсан шинжилж буй гарын үсгүүдийг Ө.С зурсан байна.

2009-01-08 гэсэн огноотой, 37 гэсэн дугаартай шинжээчийн дүгнэлт болон

2009-01-08 гэсэн огноотой, 441 гэсэн дугаартай шинжээчийн дүгнэлтийн /Шинжээч эмч Г.Э/ гэсний дээрх шинжилж буй гарын үсгүүдийг Г.Э зурсан байна.

2009-01-20 гэсэн огноотой, 441 дугаартай шинжээчийн дүгнэлтийн /Шинжээч эмч Б.У/ гэсний дээрх шинжилж буй гарын үсгүүдийг Б.У зурсан байна.

Шинжилгээнд ирүүлсэн 2008 оны 11 дүгээр сарын 10 өдөр гэсэн огноотой 1404 дугаартай Шүүх эмнэлгийн магадлан шинжилгээний акт гэх баримтын арын нүүрний доороосоо 8 дахь мөр, 6 дахь мөрний мөрний «үйлчлэлээр үүсгэгдэнэ» гэх баримтын арын хөх өнгийн будагчтай бичигч хэрэгслээр бичсэн бичвэрүүдийг Г.Д бичсэн байна.

Уг баримт дахь бусад гарын бичвэрүүдийг Н.Б бичсэн байна гэжээ. /6 дугаар хавтаст хэргийн 1-6-р хуудас/

Хавтаст хэргийн материалаар бүрэлдэхүүнтэй шинжилгээ хийсэн дүгнэлтэд:

“Шинжээч эмч Н.Б-гийн гаргасан 1404 тоот актын дүгнэлтий хувьд гэмтлийн зэргийг тогтоох шүүх эмнэлгийн магадлан шинжилгээний зааврын 2.2.1/и/-д зааснаар дотор эрхтнийг гэмтээсэн эсэхийг харгалзахгүйгээр цээжний хөндий рүү нэвтэрсэн шарх учирсан нь эмнэлзүй болон шинжилгээгээр нотлогдсон бол гэжээ. Дээрх шарх цээжний хөндий рүү нэвтэрсэн нь рентген шинжилгээгээр батлагдаж байх тул гэмтлийн хүнд зэрэгт хамаарна. Иймд үндэслэлгүй байна.

Хохирогчийн биед учирсан цээжний зүүн талын 4, 5-р хавирганы хутганы шарх нь цээжний хөндий рүү нэвтэрсэн нь нотлогдож байх тул гэмтлийн зэргийг тогтоох шүүх эмнэлгийн магадлан шинжилгээний зааврын 2.2.1-д заасан амь биед аюултай гэмтэл гэдэгт гэмтэх үедээ амь насанд аюултай байдалд хүргэсэн гэмтэл хамаарах бөгөөд эмнэлгийн тусламжийн үр дүнд амь нас аврагдсан нь дээрх шинжийг өөрчлөхгүй гэсний дагуу гэмтлийн хүнд зэрэгт хамаарна.

Шинжээч эмч Ж.Г-ийн гаргасан 1242 тоот актын дүгнэлтийн хувьд баруун

чамархай, дух хэсгийн хатуу бүрхүүл доорхи цусан хураа /40гр/, цусан хурааг мэс заслын аргаар авсан байдал нь эрүүл мэндийг удаан хугацаагаар сарниулах хүндэвтэр зэргийг гэмтэлд хамаарна гэсэн нь үндэслэлгүй байна. Учир нь хэдийгээр хугарал нь үгүйсгэгдсэн боловч баруун зулайн зөөлөн бүрхүүл доорхи цус харвалтыг орхигдуулсан байна. Дээрх гэмтлүүд нь Гэмтлийн зэргийг тогтоох шүүх эмнэлгийн магадлан шинжилгээний зааврын 2.2.1/д/-д зааснаар тархины хальснуудыг дээр, доор цус харваж, амь насанд ноцтой байдал илэрсэн учир гэмтлийн хүнд зэрэгт хамаарна.

Шинжээч эмч Б.У, Ч.Э, Д.Д, Ц.Б, З.Х нарын гаргасан 544 тоот актын хувьд Гэмтлийн зэрэг тогтоох шүүх эмнэлгийн магадлан шинжилгээний зааврын 2.2.1/д/-д зааснаар гэмтлийн хүнд зэрэгт хамаарна гэсэн нь үндэслэлтэй байна.

Шинжээч эмч Б.А, М.Э, Н.Т, Ө.С, Г.Э нарын гаргасан 36 тоот актын дүгнэлтийн хувьд Тархины баруун талын бөмбөлгийн зулай, чамархай хэсгийн хатуу хальсан доорх цусан хураа, тархины зөөлөн бүрхүүл доорх цус харвалт нь эрүүл мэндийг удаан хугацаагаар сарниулах гэмтлийн хүндэвтэр гэмтэлд хамаарна, мөн 1242 тоот актыг үндэслэлтэй, 544 тоот актын дүгнэлт үндэслэлгүй гэсэн нь үндэслэл муутай байна.

Р.А-гийн биед учирсан баруун дух, чамархай, зулайн хэсгийн хатуу хальсан доорхи цус хуралт /40гр/ торлог бүрхэвчийн доорх цус харвалт нь Гэмтлийн зэргийг тогтоох шүүх эмнэлгийн магадлан шинжилгээний зааврын 2.2.1/д/-д зааснаар гэмтлийн хүнд зэрэгт хамаарна» гэжээ /3 дугаар хавтас хэргийн 227-233 дугаар тал/.

Мөн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдан ирсэн 3 ширхэг Шүүх эмнэлгийн бүртгэлийн дэвтэр, шүүгдэгч нарын иргэний үнэмлэхийн лавлагаа, ял шалгах хуудас, тэдний ажил үүргийн хуваарь, ажил орсон тушаал шийдвэр, ажлын байрны тодорхойлолт зэрэг бусад нотлох баримтуудыг шинжлэн судлав.

Ийнхүү шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч нарын өгч байгаа мэдүүлэг, хавтаст хэргийн материалаас шинжлэн судласан бусад нотлох баримтуудаар хэргийг анхан шатны шүүхээс эцэслэн шийдвэрлэх нь зүйтэй, хэргийг нотлуулахаар нэмэлт мөрдөн байцаалтын ажиллагаа хийлгэхээр шүүхээс дахин буцаах боломжгүй, хэрэгт шалгавал зохих зүйлийг бүрэн шалгасан байна гэж

шүүх дүгнэж, шүүгдэгч нарын гэм буруугийн талаар дараахь дүгнэлтэд хүрэв.

Прокуророос шүүгдэгч Г.Д-г эрүүгийн 2083099., 2083877., 20120101154. дугаар хэргүүдэд хохирогч Р.А, М.Ц, М.О, Б.О нарын, шүүгдэгч М.Э-ыг 2083099., 2012010115. дугаар хэргүүдэд Р.А, Б.О нарын, шүүгдэгч М.Б, Э.С, Б.Д, Б.Ц, Ч.П нарыг 2012010115. дугаар эрүүгийн хэрэгт хохирогч Б.О-ын биед учирсан гэмтлийн зэргийг зориуд худал дүгнэлт гаргасан, ингэж худал дүгнэлт гаргуулахад шүүгдэгч Г.Д нь албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж оролцсон, шүүгдэгч нарын худал дүгнэлт гаргасны улмаас бусдад хүнд хор уршиг учруулсан гэж үзэж, шүүгдэгч Г.Д-д Эрүүгийн хуулийн 245 дугаар зүйлийн 245.2, 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийг журамлан 254 дүгээр зүйлийн 254.2, 256 дугаар зүйлийн 256.2, 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар, шүүгдэгч М.Э, М.Б, Э.С, Б.Д, Б.Ц нарт Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254 дүгээр зүйлийн 254.2, шүүгдэгч Ч.П-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийг журамлан тусгай ангийн 254 дүгээр зүйлийн 254.2 дахь хэсэгт зааснаар прокурорын яллах дүгнэлт үйлджээ.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254 дүгээр зүйлд шинжээч зориуд худал дүгнэлт гаргасан гэж шууд санаатай үйлдэгдэх субъектив талын шинжийг тодорхойлж, хүнд хор уршиг учирсан байх шинжид онц их хэмжээний хохирол учирсан, хүний амь нас хохирсон, хүний биемахбодид хүнд, эсхүл хэд хэдэн хүний биед хүндэвтэр гэмтэл учирсан, байгалийн тэнцэл алдагдсан, халдварт өвчин тархсан, аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагаа алдагдсан, зогссон зэргийг ойлгохоор бас Эрүүгийн 2083099. дугаар хэргийн хохирогч Р.А-гийн биед учирсан гэмтлийг тогтоосон Шүүх эмнэлгийн үзлэг хийсэн 2008 оны 1242 дугаар дүгнэлтийн шинжээч эмч Ж.Г гэсэн хэсэгт «-ийг Г.Д» гэж өөрийнхөө нэрээр гарын үсгээ зурсан /3 дугаар хавтаст хэргийн 102 дугаар тал/, энэ 1242 дугаар дүгнэлтийг таван эмчийн бүрэлдэхүүнтэй хийсэн 2009 оны 36 дугаар дүгнэлтээр үндэслэлтэй гэж дүгнэсэн /3 дугаар хавтаст хэргийн 109 дүгээр тал/-ээр шүүх хэргийг шийдвэрлэж /3 дугаар хавтаст хэргийн 91 дүгээр тал/, шүүхийн энэ шийдвэр хүчин төгөлдөр болсон байна.

Үүнд, шүүгдэгч Г.Д-г гэмт хэрэг үйлдсэн гэж буруутгаж, прокурорын дүгнэснээр «дүгнэлтийг өөрчлөн Ж.Г-ийн гарын үсгийг

дуурайлган зурж зориуд худал дүгнэлт гаргаж уг дүгнэлтийг цагдаагийн байгууллагад хүргүүлж албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж мөрдөн байцаалт, шүүн таслах ажиллагаанд саад учруулсан» гэж үзэх үндэслэлгүй байна.

Тухайн хэргийн хохирогч Р.А-гийн биед учирсан гэмтлийн талаар шинжээч эмч нарын хоорондох анагаахын шинжлэх ухааны маргаантай байсан асуудал буюу тархины цусан хурааг гэмтэл авснаас хойш 8 хоногийн дараа мэс ажилбараар авах байсан, авах шаардлагагүй эмийн эмчилгээгээр өөрөөр нь шимэгдүүлэн эмчлэх ёстой байсан гэсэн асуудлууд болон өвчтөнийг анх үзсэн хүлээн авахын эмчийн анхны нүдээр харж, магадлах замаар бичсэн онош, эмчилгээ хийлгэх үеийн эмчлэгч эмчийн үзлэгийн онош зэрэг зөрүүтэй байдал нь зэргээс үзэхэд шүүгдэгч Г.Д, М.Э нарыг хувийн сонирхлоор хохирогчийн илтэд хүнд гэмтлийг хүндэвтэр болгож гаргасан байна гэж шууд буруутгах хууль зүйн үндэслэл тогтоогдохгүй байна.

Дээрх 1242 дугаар дүгнэлтийг үндэслэлгүй, гэмтэл нь хүнд зэрэгт хамаарна гэж дүгнэсэн 2008 оны 544 дүгээр дүгнэлт, бүрэлдэхүүнтэй хийсэн 2010 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн дүгнэлт зэргээр шүүгдэгч Г.Д, М.Э нарын зориуд худал дүгнэлт гаргасан гэх субъектив санаа зорилгыг тодорхойлж, шүүхээс яллах боломжгүй юм.

Мөн шүүгдэгч Г.Д нь 2083877. дугаар эрүүгийн хэргийн хохирогч М.Ц-ын биед учирсан гэмтлийг хянахдаа засварлаж хүнд гэмтлийг хөнгөн болгож албан тушаалын байдал, эрх мэдлээ урвуулан ашиглаж зориуд худал дүгнэлт гаргасан үйлдэлд холбогдсон боловч анх дүгнэлт гаргахдаа хөнгөн гэмтэл гэж гаргасан шинжээч эмч Н.Б-гийн дүгнэлтийг гурван эмчийн бүрэлдэхүүнтэй хийсэн 2009 оны 37 дугаар дүгнэлтээр үндэслэлтэй гэж дүгнэснээр прокурорын 2009 оны 2 дугаар сарын 05-ны өдрийн 80 дугаар тогтоолоор яллагдагч, хохирогч нар сайн дураараа эвлэрсэн гэж хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн нь /3 дугаар хавтаст хэргийн 142 дугаар тал/ хүчин төгөлдөр байна.

Хохирогч М.Ц-ын цээж рүү хутга нэвтэрсэн эсэх, эсхүл хутгалагдсан шарх байсан уу гэдэг нь түүний өвчний түүхээс тодорхой харагдах бөгөөд Шүүх эмнэлгийн гэмтлийн зэрэг тогтоох зааврын 2.1.1 /з/ дэх хэсгийн онолын тайлбарт цээжний хөндийд нэвтэрсэн шархыг оношлохдоо үнхэлцгийн

болон гялтангийн хөндий, голтод цус хий хурсан, эрхтнүүд гэмтсэн, шахагдсан, арьсан доорх зөөлөн эдэд хий хуралдсан зэрэг шинжүүд дээр тулгуурлана. Цээжний хөндийд нэвтэрснийг баттай нотлоогүй бол нэвтэрсэн гэж үзэхгүй. Цээжний хөндий рүү нэвтэрснийг нарийн ялгаж оношлоогүй боловч болгоомжлохын үүднээс ч юмуу, өвчний түүх, амбулаторын картанд нэвтэрсэн шарх гэсэн онош тавьсан байх нь тохиолддог. Энэ үед хохирогчийн биеийн байдал хүндрээгүй, шарх цэвэр эдгэсэн бол шархыг нэвтрээгүй гэж үзэх нь зүйтэй гэжээ.

Иймд шүүгдэгч Г.Д-г хохирогч М.Ц-ын хүнд зэргийн гэмтлийг хөнгөн болгож засварлаж албан тушаалын байдлаа урвуулан ашигласан гэж эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй байна.

Мөн шүүгдэгч Г.Д нь 2012010115. дүгээр эрүүгийн хэргийн хохирогч Б.О-ын үед учирсан гэмтлийг шинжээч эмч Г.Э, М.О, М.З нар хүнд гэж 2012 оны 812 дугаар дүгнэлт гаргасныг сольж, хүндэвтэр гэмтэл болгон шинжээч эмч Б.До-гийн гарын үсгийг статистикч бага эмч Ч.П-аар, дадлагажигч шинжээч эмч М.Б, Э.С нараар өөрсдөөр нь зуруулж мөрдөн байцаах, шүүн таслах ажиллагаанд саад учруулсан, шүүгдэгч М.Э нь хохирогч Б.О-ын биед учирсан хүнд гэмтлийг хүндэвтэр гэмтэл гэж зориуд худал дүгнэлт гаргасан гэж үзэхэд хохирогчийн биед удаа дараа шинжээчийн дүгнэлтүүд гарч, эдгээр нь бусдыгаа зөвтгөсөн, үгүйсгэсэн шинжтэй байснаас Баянгол дүүргийн шүүхийн 2013 оны 80 дугаар шүүхийн тогтоолоор шинжээчийн дүгнэлт тодорхой бус байна гэж хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцааж, таван шинжээч эмчийн бүрэлдэхүүнтэй хийсэн 2013 оны 362 дугаар хүнд гэмтэл гэсэн дүгнэлтээр нь Баянгол дүүргийн шүүх 2013 оны 290 дүгээр шийтгэх тогтоолоор хэргийг шийдвэрлэж /1 дүгээр хавтаст хэргийн 208-210 дугаар тал/, шүүхийн энэ шийдвэр хүчин төгөлдөр болсон байна.

Өөрөөр хэлбэл, эхэнд нь гаргасан хүнд гэмтэл гэсэн дүгнэлтийг шүүгдэгч Г.Д сольсон, дараагийн хүндэвтэр гэсэн дүгнэлтийг шинжээч бус статистикч Ч.П-аар Б.До гэж зуруулсан, шинжээч М.Б, Э.С нараар зуруулсан, шүүгдэгч М.Э нь хэрхэн ямар гэм буруугийн хэлбэрээр худал дүгнэлт гаргасан, уг дүгнэлтээс хэнд ямар хүнд хор уршиг учирсан зэргийг прокурор нотолж чадаагүй байна.

Иймд шүүгдэгч Г.Д, М.Э нарын үйлдэлд гэмт хэргийн бүрэлдэхүүний субъектив санаа зорилго тогтоогдохгүй байх тул тэдэнд холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэх үндэслэлээр хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх бүрэлдэхүүн үзлээ.

Шинжээч эмч Б.До-гийн гарын үсгийг статистикч бага эмч Ч.П ажлын аргагүй нөхцөл байдлаас шалтгаалан дүгнэлтийг цагдаагийн байгууллагаас шаардаад байсан болохоор гар ноорогтой нь тулгаж, шинжээч Б.До-гийн гарын үсгийг дууриалгахгүйгээр Долгормаа гэж бичсэн гэдгээ хүлээж байгаа ба үүнд дүгнэлтийг зориуд хуурамчаар гаргасан гэж үзэх нотлох баримтгүй байна.

Түүнчлэн шүүгдэгч М.Б, Э.С, Б.Д, Б.Ц, Ч.П нарыг зориуд худал шинжээчийн дүгнэлт гаргаж хүнд хор уршиг учруулсан гэх хэрэгт шалгаж, дахин нэмэлт нотлох баримтыг цуглуулах бүхий л ажиллагаа хийсэн боловч гэмт хэрэгт оролцсон нь болох нь нотлогдохгүй байх тул тэдэнд холбогдох хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 208 дугаар зүйлийн 208.1.2 дахь хэсэгт зааснаар хэрэгсэхгүй болгох нь зүйтэй гэж шүүх дүгнэв.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248 дугаар зүйлийн 248.1.1, 248.1.2, 283, 290 дүгээр зүйлийн 290.4, 294, 298 дугаар зүйлүүдэд заасныг тус тус удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Прокуророос шүүгдэгч Г.Д-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 245 дугаар зүйлийн 245.2, ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.3 дахь хэсгийг журамлан тусгай ангийн 254 дүгээр зүйлийн 254.2, 256 дугаар зүйлийн 256.2, 263 дугаар зүйлийн 263.2 дахь хэсэгт зааснаар, шүүгдэгч М.Э, М.Б, Э.С, Б.Ц, Б.Д нарт тус тус Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254 дүгээр зүйлийн 254.2 дахь хэсэгт зааснаар, шүүгдэгч Ч.П-д Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 35 дугаар зүйлийн 35.5 дахь хэсгийг журамлан тусгай ангийн 254 дүгээр зүйлийн 254.2 дахь хэсэгт зааснаар тус тус яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 248 дугаар зүйлийн 248.1.1, 248.1.2 дахь хэсэгт зааснаар тус тус хэрэгсэхгүй болгож, шүүгдэгч нарыг цагаатгасугай.

2. Шүүгдэгч нарт урьд авсан батлан даалтан өгөх таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хүчингүй болгосугай.

3. Цагаатгагдсан этгээд нар энэ хэргийн учир цагдан хоригдоогүй, хэрэгт

битүүмжилсэн зүйлгүй болохыг тус тус дурдсугай.

4. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.1 дэх хэсэгт зааснаар хэрэгт эд мөрийн баримтаар ирүүлсэн 3 ширхэг дэвтрийг хэргийг хадгалах хугацаа хүртэл хэрэгт хавсаргасугай.

5. Цагаатгах тогтоол нь танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд тогтоолд гомдол гаргах эрх бүхий этгээдүүд эс зөвшөөрвөл гардуулснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны

10 дугаар шүүхэд гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор мөн хугацаанд эсэргүүцэл бичих, цагаатгагдсан этгээд цагаатгасан шалтгаан үндэслэлд гомдол гаргах эрхтэйг тайлбарласугай.

6. Хэрэв давж заалдах гомдол гаргасан, эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол хүчин төгөлдөр болтол шүүгдэгч нарт урьд авсан таслан сэргийлэх арга хэмжээг тус тус хэвээр үргэлжлүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ
ШҮҮГЧИД

Б.ЗОРИГ
Б.САРАНТУЯА
С.ОЮУНГЭРЭЛ

ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 08 өдөр

Дугаар 13/А

Булган сум

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Сум дундын 26 дугаар шүүхийн шүүгч Ц.Энхжаргал даргалж тус шүүхийн эрүүгийн хэргийн шүүх хуралдааны танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанаар:

Нарийн бичгийн дарга Ц.Отгонжаргал,
Улсын яллагчаар ахлах прокурор Б.Хосбаяр,

Өмгөөлөгч Д.Эрдэнэчимэг, Н.Оюунчимэг, шүүгдэгч Б.Э, Д нарыг оролцуулан Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 6 дугаар шүүхээс дахин хэлэлцүүлэхээр ирүүлсэн Б.Э, Д нарт холбогдох эрүүгийн 20132101010. тоот эрүүгийн хэргийг 2014 оны 08 дугаар сарын 04-ний өдөр хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, ...аймгийн ...сумын харьяат, ...аймгийн ... сумын ...багийн ...тоотод оршин суух, ...онд төрсөн, ...настай, дээд боловсролтой, биеийн тамирын багш мэргэжилтэй, Ховд аймгийн Булган сумын Гаалийн газарт гаалийн улсын байцаагч ажилтай, аминдаа Ланд 80 маркийн автомашин, хашаа байшин зэргийн хөрөнгөтэй, улсаас авсан гавьяа шагналгүй, ял шийтгэлгүй, бие эрүүл ухаан бүрэн, хэрэг хариуцах чадвартай ПЮ..... регистртэй, Ц овогт Б.Э

Шүүгдэгч: Монгол Улсын иргэн, ...аймгийн ...суманд ...онд төрсөн, ... настай, эрэгтэй, ам бүл ... эхнэр хүүхдүүдийн хамт амьдрах, бүрэн бус дунд боловсролтой, мэргэжилгүй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, аминдаа суудлын автомашин 1, хашаа зэргийн хөрөнгөтэй ...аймгийн ...сумын ...дугаар багт ... айлын орон сууцны ...тоотод оршин суух, улсаас авсан гавьяа шагнал, ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай ХЕ..... регистртэй С овогт М.Д нар нь хээл хахууль өгөх, хээл хахууль авах гэмт хэрэг үйлдсэнд холбогджээ.

ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүхийн хэлэлцүүлэгт дараах нотлох баримтуудыг шинжлэн судлав. Үүнд:

Гэрч: И.Ал-ийн ... Би 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдөр 14 цаг 30 минутад хх-хх БӨТ улсын дугаартай авто машины ачиж явсан ачаанд мэргэжлийн хяналт шалгалт хийж тэмдэглэл үйлдсэн байна. Уг машинд хөргөгч 1 ширхэг, угаалгын машин 6 ширхэг,

халуун сав 120 ширхэг, буйдан ор 2 ширхэг, диван ор 2 ширхэг, хувцасны шкаф 2 ширхэг, матрас 8 ширхэг, сандал 16 ширхэг тус тус эд зүйлс байсан байна.

Манай мэргэжлийн хяналтын байцаагч нар бүх ачааг нь нэг бүрчлэн тусгаж бичдэггүй. Учир нь маш олон машин, маш олон зорчигч нар байдаг учир түргэн шуурхай шалгаад олон ширхэгтэй том овортой эд зүйлсийг нь бичиж тэмдэглэдэг. Би сайн санахгүй байна.

Татварын асуудлыг манай байгууллага мэдэхгүй ээ. Манайх хорио цээр чанарын шаардлага хангаагүй эд зүйлс бараа байхгүй л байвал шууд гаалийн газар луу шилжүүлдэг гэх мэдүүлэг /хх-ийн 87-88 хуудас/

Гэрч: Т.Б-ийн ...Дээрх ачаанд гаалийн бүрдүүлэлт хийгээгүй. Зорчигчийн барааны бүрдүүлэлтийн хуудас бөглөөд татвар төлөөд гарсан болохоор хэмжээ, хийц, загвар, материал зэргийг нь тодорхойлох боломжгүй ээ гэх мэдүүлэг /хх-ийн 95 хуудас/

Гэрч Б овогт Ж.Ха хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтад өгсөн...Тэр өдөр би Баян-Өлгий аймагт зах дээр гэр ахуйн бараа зардаг М.Д-ийн ачааг БНХАУ-аас ачиж Баян-Өлгий аймагт хүргэж ирсэн.Тэр өдөр 6 тн ачаа ачиж улсын хилээр нэвтэрсэн.М.Д нь гэр ахуйн бараа зардаг учир ор шкаф, угаалгын машин, хөргөгч сандал зэрэг эд зүйлсийг дандаа ачдаг.Тэр өдөр ч гэсэн дээрх ачаануудыг БНХАУ-аас ачиж улсын хилээр нэвтэрсэн гэх мэдүүлэг /хх-ийн 171 дүгээр хуудас/

Гэрч: Н.Лх-ыг дахин байцаасан мэдүүлгийн тэмдэглэлд: 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдөр манай гаалийн газрын жижүүр байцаагчаар 0346 хувийн дугаартай Ж.М байцаагч ажиллаж байсан байна. Ж.М нь 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 12 цаг 41 минутад хх-хх БӨТ улсын дугаартай авто машинд ачаа тээвэрлэн улсын хилээр нэвтэрсэн М.Д гэх хүний ачаанд хяналт шалгалт хийгээд 283008 төгрөгийн татвар ногдуулж төлүүлэн 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 19 цаг 01 минутад хяналтын бүсээс гарсан байна. Уг хяналт шалгалт хийсэн болон СА15 системээр хувиарлагдсан талаарх мэдээллийг программаас хэвлэн гаргаж өгсөн. Манай гаалийн газар тухайн

үед пүүгүй байсан. Тийм болохоор улсын хилээр нэвтэрч байгаа бараа, тээврийн хэрэгслүүдийг жинлэх боломжгүй байсан гэх мэдүүлэг /хх-ийн 235 дугаар хуудас/

Гаалийн бүрдүүлэлтийн хуудас №0087770 /2 дугаар хавтас 12 дугаар хуудас/

Голомт банкны орлогын мэдүүлэг /2 хавтас 13 дугаар хуудас/

2014 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн шинжээчийн дүгнэлт

Ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч М.Д мэдүүлэхдээ: Би гаалийн байцаагч нартай холбоотой гомдол гаргахдаа гаалийн байгууллага нь байцаагч нартаа арга хэмжээ авах байх гэж бодож гомдол гаргасан.

Гэтэл миний өргөдлийг шалгах явцад өөрөө болон Б.Э гэдэг хүн хэрэгт холбогдлоо. Гаалийн татвар өдөр бүр нэмэгдээд байхаар нь би байцаагч нарыг нэмээд байна гэж бодож гомдол гаргасан. Бид хоёрт мөнгө төгрөг өгч авалцсан асуудал байхгүй гэх мэдүүлэг,

Шүүхийн хэлэлцүүлэгт шүүгдэгч Б.Э мэдүүлэхдээ: Тэр өдөр би М.Д-ээс мөнгө төгрөг аваагүй. Харин ачаа барааг нэг бүрчлэн үзэхгүйгээр М.Д-ийн амаар мэдүүлсний дагуу зорчигчийн барааны татвар ногдуулсан нь үнэн. Тухайн өдөр орой болсон хил хаах цаг болоод хүйтэн байсан учир хүмүүсийг чирэгдүүлэхгүй гэж бодсон юм гэх мэдүүлэг зэрэг болно.

Шүүгдэгч М.Д нь албан тушаалтанд өөрөө буюу бусдаар дамжуулж хээл хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн,

Шүүгдэгч Б.Э нь албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхолын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэж Ховд аймгийн Булган дахь сум дундын прокурорын газраас яллах дүгнэлт үйлдэж шүүхэд ирүүлжээ.

Шүүгдэгч М.Д нь Б.Э-д 900.000 төгрөгийн хээл хахууль өгөөгүй, харин гаалийн татвар өдөр бүр нэмэгдээд байхаар нь гаалийн байгууллага нь байцаагч нартаа арга хэмжээ авах байх гэж бодож Ай-ын нэрээр болон өөрийнхөө нэрээр гомдол гаргасан гэж мэдүүлж байгаа мэдүүлэг нь:

Гэрч М.Ай-ыг байцаасан тэмдэглэлийн Би өөрөө ямар ч өргөдөл гаргаагүй. Харин миний танил болох М.Д гэдэг хүн хэд

хоногийн өмнө надад «Би Ярантын боомт дээр Монгол Улс руу хил нэвтэрч байхад чиний нэр дээр гаалийн мэдүүлэг бичсэн, тухайн үед толгойдоо орж ирсэн танил нэр чиний нэр болохоор л бичсэн юм» гэж надад зүгээр хэлж байсан. М.Д нь зах дээр гэр ахуйн бараа зардаг хүн гэх мэдүүлэг нь М.Д-ийн шүүх хуралдаанд мэдүүлсэн мэдүүлэгтэй зөрөхгүй байгаа.

Гэрч Ж.Ха-ийн хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтад өгсөн...М.Д уг бараандаа гаалийн татвар хэдэн төгрөг төлсөн гэдгийг би мэдэхгүй байна. Ачааны эзэд өөрсдөө гаалийн газар луу орж татвараа төлөөд гараад ирдэг гэх мэдүүлэгтэй,

Гэрч:Т.Б-ийн Дээрх ачаанд гаалийн бүрдүүлэлт хийгээгүй, Зорчигчийн барааны бүрдүүлэлтийн хуудас бөглөөд татвар төлөөд гарсан болохоор хэмжээ, хийц, загвар, материал зэргийг нь тодорхойлох боломжгүй гэх мэдүүлэгтэй,

Шүүгдэгч М.Д-ийн 2013 оны 12 дугаар сарын 22-ны өдөр яллагдагчаар байцаасан тэмдэглэлд уг ачаанд гаалийн бүрдүүлэлт хийгээгүй. Харин зорчигчийн бараа гээд халуун сав, хүүхдийн хувцас гэж бичээд 280.000 орчим мянган төгрөгийн татвар төлүүлээд намайг гаргасан гэх мэдүүлэгтэй,

2013 оны 03 дугаар сарын 13-ны өдөр бичигдсэн гаалийн бүрдүүлэлтийн №0087770 тоот хуудас

Голомт банкны орлогын мэдүүлэг /М.Д-ээс зорчигчийн барааны татварт 283008 төгрөг төлсөн/ зэрэг баримтуудтай зөрөөгүй, шүүгдэгч М.Д нь Б.Э-д 900.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэх үйлдэл нь эдгээр нотлох баримтаар нотлогдохгүй байх тул дээрх гэрч нарын мэдүүлгийг хэрэгт хамааралтай, ач холбогдолтой хуульд заасан журмын дагуу авагдсан мэдүүлэг гэж үнэлэв.

Иймд гэрч нарын мэдүүлэг нь М.Д-ийн хээл хахууль өгсөн, шүүгдэгч Б.Э-ын хээл хахууль авсан гэх үйлдлийг гэрчлэх нотлох гэрчийн мэдүүлэгт үнэлэгдэхгүй, гаалийн тухай хуульд заасан гаалийн бүрдүүлэлт, болон гаалийн татварын хэмжээ хязгаар, татвар ногдуулах журам зэргийг гэрчилсэн мэдүүлэг болно.

Харин шүүгдэгч М.Д-ийн шүүхийн хэлэлцүүлэгт мэдүүлсэн «бид хоёрт мөнгө өгч авалцсан асуудал байхгүй» гэх мэдүүлэг нь Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 264 дүгээр зүйлийн 264.1.1-д зааснаар урьд гаргасан мэдүүлэг нь шүүх хуралдаан дээр гаргаж байгаа мэдүүлгээс ноцтой зөрөөтэй

мэдүүлэг боловч талууд нь шүүх хуралдаанд хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын үед шүүгдэгчийн гаргасан мэдүүлгийг уншиж сонсохоор санал гаргаагүй нь шүүгдэгчийн шүүх хуралдаанд мэдүүлсэн мэдүүлгийг үнэлэх үндэслэл болно.

Шүүгдэгч Б.Э-ын Эрүүгийн хуулийн 268 дугаар зүйлийн 268.1-д зааснаар албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхолын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх, эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан нь хавтаст хэрэгт авагдсан 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдөр бичигдсэн гаалийн бүрдүүлэлтийн №0087770 тоот хуудсаар татвар ногдуулсан тухай баримт

Голомт банкны орлогын мэдүүлэг /М.Д-ээс зорчигчийн барааны татварт 283008 төгрөг төлсөн/ зэрэг баримтаар албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх гэсэн үйлдэл тогтоогдохгүй байна.

Мөн М.Д-ийн улсын хилээр оруулж ирсэн ачааг тухайн үед шалгаж хэмжээг тогтоох боломжгүй ачааг пүүлэх пүү ажиллахгүй байсан нь гэрч ...И.Ал-ийн «Тухайн үед манай боомтын пүү ажиллахгүй байсан болохоор хэдэн тонн гэдгийг нь хэмжиж чадахгүй байсан гэх мэдүүлгээр,

мөн шинжээч Б.Н-ийг байцаасан тэмдэглэлд ...Гэр ахуйн зориулалттай нэр төрөл бүрээс 1 ширхгээс илүүгүй бараанд үнийн дүн харгалзахгүй барааны гаалийн бүрдүүлэлтийн хуудас /маягт 2/-оор гаалийн бүрдүүлэлт хийнэ гэж зааж өгсөн байдаг.

М.Д-ийн тээвэрлэж явсан ачаа бараа нь дээрх журамд зааснаас илүү хэмжээтэй байсан тул гаалийн бүрдүүлэлт хийж татвар ногдуулах ёстой байсан байна гэх мэдүүлэг нь 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдөр бичигдсэн гаалийн бүрдүүлэлтийн маягт 2, № 0087770 дугаартай гаалийн бүрдүүлэлтийн хуудас бичигдэж, тухайн өдөр уг бараанд үзлэг хийж хэдэн ширхэг, ямар нэр төрлийн бараа байсан нь хэрэгт авагдсан баримтаар бүрэн нотлогдохгүй байхад Б.Э-ыг албан тушаалтан хээл хахууль өгөгчийн ашиг сонирхолын үүднээс албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүй байх эсхүл гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлах буюу амлахгүйгээр өөрөө, эсхүл бусдаар дамжуулан хээл хахууль авсан гэмт хэрэг үйлдсэн гэж яллах үндэслэлгүй байна.

2014 оны 02 дугаар сарын 27-ны

өдрийн шинжээчийн дүгнэлтэд: М.Д-ийн барааг худалдан авсан үнийг нотлох үнийн нэхэмжлэх төлбөр төлсөн баримт байхгүй, барааны марк, онцлог шинж, тодорхойгүй тул үнийн мэдээллийн санд байгаа нэг төрлийн барааны хэлцлийн үнээр гаалийн үнийг тодорхойлох боломжгүй байна гэж дүгнэсэн нь ...Тэмдэглэлийн дэвтэрт бичигдсэн 2013.3.3 гэх он сар өдөр, авсан барааны үнэ бичигдээгүй, ямар нэр төрлийн бараа хэдэн ширхэг авсан, ямар үнээр авсан тухайн үед юань, долларын аль мөнгөн тэмдэгтээр худалдан авалт хийгдсэн нь тодорхойгүй, гарын үсгийн бичилт зөрөөтэй Өөрөөр хэлбэл, М.Д-ийн өөрийн гарын үсгийн бичилт нь Б.Э 900.000т, гааль 283.000т, 80.000т гэх бичилттэй тохирохгүй байгаа зэрэг нь тухайн 900.000 төгрөгийн хээл хахууль өгсөн гэх 2013 оны 03 дугаар сарын 13-ны өдөр үйлдэгдсэн он сар өдрөөс зөрөөтэй байх тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 85 дугаар зүйлийн 85.4-д зааснаар шинжээчийн дүгнэлт нь үндэслэл муутай, эргэлзээтэй гарсан дүгнэлт гэж шүүхээс үнэлэв.

Иймд шүүгдэгч М.Д-т зүйлчилж ирүүлсэн Эрүүгийн хуулийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар хахууль өгсөн үйлдэл нь нотлогдохгүй байх тул:

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 82 дугаар зүйлийн 82.2-д зааснаар яллагдагч өөрийн гэм бурууг хүлээсэн нь хэрэгт байгаа бусад нотлох баримтаар батлагдвал яллах үндэслэл болно.

Харин Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т зааснаар эрүүгийн хэрэгт хамааралтай бүхий л нотлох баримтыг шалгасан боловч шүүгдэгчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ гарвал шүүгдэгчид ашигтайгаар шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Шүүгдэгч Б.Э, М.Д нарт прокуророос Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268, 269 дүгээр зүйлийн 268.1, 269.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн нь шүүхийн хэлэлцүүлгийн явцад тогтоогдохгүй, субъектив талын шинж байхгүй байх тул шүүгдэгч Б.Э, М.Д нарт холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэх үндэслэлтэй гэж шүүх дүгнэв.

Шүүхэд эд мөрийн баримтаар хураагдсан тэмдэглэлийн дэвтрийг шүүгдэгч М.Д-т буцаан олгох нь зүйтэй байна.

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн зүйлийн 246.1, 248 дугаар зүйлийн 248.1.1, 283, 284, 286, 290.4, 295-

299 дүгээр зүйлд заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 24 зүйлийн 24.1.1 дэх хэсэгт зааснаар С овогт М.Д-т Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1-д зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн хэргийг хэрэгсэхгүй болгож,

Шүүгдэгч Ц овогт Б.Э-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн эрүүгийн 20132101010 дугаартай хэргийг хэрэгсэхгүй болгож шүүгдэгч Б.Э, М.Д нарыг цагаатгасугай.

2. Шүүгдэгч нар нь цагдан хоригдсон хоноггүй, шүүгдэгчээс гаргуулах хохирол төлбөргүй болохыг дурдсугай.

3. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 88 дугаар зүйлийн 88.1.3-д зааснаар шүүхэд эд

мөрийн баримтаар хураагдсан тэмдэглэлийн дэвтрийг М.Д-т буцаан олгосугай.

4. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 249 дүгээр зүйлийн 249.1-д зааснаар М.Д, Б.Э нарт батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээ авсныг тус тус хүчингүй болгосугай.

5. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 299 дүгээр зүйлийн 299.3-д зааснаар цагаатгах тогтоол танилцуулан сонсгосноор хүчинтэй болох бөгөөд мөн хуулийн 303 дугаар зүйлийн 303.3, 304 дүгээр зүйлийн 304.1-д зааснаар тогтоолыг эс зөвшөөрвөл цагаатгагдсан этгээд, түүний өмгөөлөгч тогтоолыг гардуулснаас хойш 14 хоногийн дотор аймгийн шүүхэд давж заалдах гомдол гаргах, улсын яллагч, дээд шатны прокурор эсэргүүцэл бичих эрхтэйг мэдэгдсүгэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

Ц.ЭНХЖАРГАЛ

ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 11 өдөр

Дугаар 132

Хэрлэн сум

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Сум дундын 28 дугаар шүүхийн Эрүүгийн хэргийн шүүх хуралдааныг тус шүүхийн шүүгч Ж.Болдбаатар даргалж, тус шүүхийн «Б» танхимд нээлттэй хийсэн шүүх хуралдаанд:

Нарийн бичгийн дарга: Б.Батбилэг

Улсын яллагч: С.Нарангэрэл

Шүүгдэгч нарын өмгөөлөгч: Г.Баярсайхан, Л.Наранчимэг

Шүүгдэгч: Я.Э, Д.П нар оролцов.

Тус аймгийн Прокурорын газраас Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1, 269 дүгээр зүйлийн 269.1-д заасан гэмт хэрэгт холбогдуулан яллах дүгнэлт үйлдэж ирүүлсэн шүүгдэгч Я.Э, Д.П нарт холбогдох 20142300032. дугаартай эрүүгийн хэргийг 2014 оны 12 дугаар сарын 01-нд хүлээн авч хянан хэлэлцэв.

Шүүгдэгч нарын биеийн байцаалт:

1. Монгол Улсын иргэн: ...оны ...сарын ...-ний өдөр төрсөн, ...настай, эрэгтэй, халх, дээд боловсролтой, хүний нөөцийн менежер мэргэжилтэй, Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга ажилтай, ам бүл-..., эхнэр ...хүүхэд, ачийн хамт, Хэнтий аймгийн ...сумын ...дүгээр баг, ...тоотод оршин суух, 2011 онд Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн медаль, 2014 онд Засгийн газрын Хүндэт жуух бичгээр шагнагдсан, урьд ял шийтгэлгүй, хэрэг хариуцах чадвартай М овогт Я.Э /РД: СО...../

2. Монгол Улсын иргэн: ...оны ...сарын ...-ны өдөр төрсөн, ...настай, эрэгтэй, халх, бүрэн дунд боловсролтой, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан мэргэжилтэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ам бүл-..., эхнэр хүүхдийн хамт, Хэнтий аймгийн ...сумын ...дугаар баг, ...гэх газарт оршин суух, улсаас авсан гавъяа шагналгүй, урьд Хэнтий аймгийн Сум дундын 1 дүгээр шүүхийн 2007 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн №126 дугаартай шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 145 дугаар зүйлийн 145.2 дахь хэсэгт зааснаар 2 жилийн хорих ял жирийн дэглэмд эдлүүлэхээр шийтгэгдэж, уг ялыг мөн хугацаагаар тэнсэж хянан харгалзагдсан 3 овогт Д.П /РД: СО...../

Шүүгдэгч нарын холбогдсон хэргийн талаар / яллах дүгнэлтэд дурдсанаар /

Яллагдагч Я.Э нь Хэнтий аймгийн Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар ажиллаж байхдаа Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 2.1 дэх хэсэгт «Бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлох талаар нөхөрлөлөөс гаргасан хүсэлтийг хүлээн авч Газрын тухай хуулийн 16.1.11 дэх хэсэгт заасан зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах газрыг сонгож, солбицлыг тогтоох», мөн журмын 2.2 дахь хэсэгт «Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож, солбицлыг тогтоосон газрын талаар Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23 дахь хэсэгт заасан дүгнэлт гаргуулахаар геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавихыг зөвшөөрсөн шийдвэр гаргах», 2.3 дахь хэсэгт «Сонгосон газрыг бичил уурхайн зориулалтаар ашиглах боломжгүй болох нь геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гаргасан дүгнэлтээр тогтоогдвол сум, дүүргийн нутагт бичил уурхайгаар ашиглах бололцоогүй болсон тухай шийдвэрийг ажлын 10 хоногт багтаан гаргах» гэсэн заалтуудыг зөрчиж албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүйгээр 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр иргэн Д.П-аас 350000 төгрөгийн үнэ бүхий Samsung Galaxy S маркийн гар утас хээл хахуульд авсан, яллагдагч Д.П нь бичил уурхайн зориулалтаар ашигт малтмал олборлох хүсэлтийг иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлэх зорилгоор Хэнтий аймгийн Мөрөн сумын Иргэдийн хурлын дарга Я.Э-д 2014 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр 350.000 төгрөгийн үнэ бүхий Samsung Galaxy S маркийн гар утас хээл хахуульд өгсөн гэмт хэрэгт тус тус холбогджээ.

Шүүх хуралдаанд эрүүгийн

20142300032. дугаартай хэрэгт мөрдөн байцаалтын шатанд цугларсан болон шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт дурдагдсан нотлох баримтуудыг шинжлэн судлаад ТОДОРХОЙЛОХ нь:

Шүүгдэгч Я.Э нь Хэнтий аймгийн Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын хувьд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын 2.1 дэх хэсэгт заасан «Бичил уурхайн хэлбэрээр ашигт малтмал олборлох талаар нөхөрлөлөөс гаргасан хүсэлтийг хүлээн авч Газрын тухай хуулийн 16.1.11-д заасан зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах газрыг сонгож, солбилцлыг тогтоох», мөн журмын 2.2 дахь хэсэгт заасан «Бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авахаар сонгож, солбилцлыг тогтоосон газрын талаар Ашигт малтмалын тухай хуулийн 11.1.23-т заасан дүгнэлт гаргуулахаар геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавихыг зөвшөөрсөн шийдвэр гаргах», мөн журмын 2.3 дахь хэсэгт заасан «Сонгосон газрыг бичил уурхайн зориулалтаар ашиглах боломжгүй болох нь геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын гаргасан дүгнэлтээр тогтоогдвол сум, дүүргийн нутагт бичил уурхайгаар ашиглах бололцоогүй болсон тухай шийдвэрийг ажлын 10 хоногт багтаан гаргах» гэсэн заалтуудыг зөрчиж албан үүргийн хувьд гүйцэтгэх үүргээ хэрэгжүүлэхгүйгээр, сумынхаа нутаг дэвсгэрт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох зөвшөөрлийг гаргаж өгнө гэж урьдчилан амлаж шүүгдэгч Г.П-аас 2014.01.29-ний өдөр 350.000 /гурван зуун тавин мянга/ төгрөгийн үнэ бүхий Samsung Galaxy /Самсунг галакси/ маркийн гар утсыг хээл хахуульд авсан гэмт хэрэг үйлдсэн, шүүгдэгч Д.П нь бичил уурхайн зориулалтаар Хэнтий аймгийн Мөрөн сумын нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлох зөвшөөрлийг гаргуулахаар Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Я.Э-д 2014.01.29-ний өдөр 350.000 төгрөгийн үнэ бүхий Самсунг галакси маркийн гар утсыг хээл хахуульд өгсөн гэмт хэргийг тус тус үйлдсэн болох нь доорх нотлох баримтуудаар нотлогдон тогтоогдож байна гэж шүүх дүгнэв. Үүнд:

1. Гэрч Ж.Д-ын:... Би 2013 оны 12 дугаар сард сумын захиргааны үүдэнд Д.П-тай тааралдаад мэнд усаа мэдэлцээд хаа хүрч яваа талаар нь асуухад Мөрөн сумын Засаг

дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга нартай уулзах гээд ирж байна гэж хэлсэн. Үдээс хойш нь Д.П-тай тааралдахад миний ажил төрөл амжсан оройдоо буцна. Дүү нь Мөрөн суманд ах дүү нартайгаа нийлж нөхөрлөл бүлэг байгуулаад бичил уурхайгаар ажиллах гээд зориглоод Улаанбаатар хотоос ажлаа орхиод ирсэн гэж хэлэхэд нь нутагтаа ажил хийх гэж байгаа юм байна гэж ойлгосон. Д.П-тай тааралдсан орой нь би игэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Я.Э-гийн өрөөнд ортол тэнд Д.П найзтайгаа хамт гурвуулаа юм яриад сууж байснаа Я.Э дарга шударга ярьчихъя, чи надад бензиний мөнгө өгөөрэй гэж Д.П-д хэлтэл Д.П за за гэж хэлж байсан тэгээд би хурлын даргын өрөөнөөс гарсан. Миний хажууд бол мөнгө төгрөг өгч авалцаагүй...гэсэн мэдүүлэг /хх-ийн 45-46х/

2. Гэрч Ж.Гэ-ын:...Д.П нь 2013 оны 12 дугаар сард Мөрөн сумын 3 дугаар багийн нутаг дэвсгэрт бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хүсэлт гаргаж надад танилцуулахад нь иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар оруулж шийдвэр гарсны дараа би гэрээ байгуулна тийм болохоор иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга Я.Э-тэй уулз гэж хэлээд материал хүсэлтийг нь хүлээн авч байгаль орчны байцаагч Г.Бт судалж үз гээд өгсөн. 2013 оны 12 дугаар сарын сүүлээр Д.П надтай уулзаад миний хүсэлт өгсөн газар орон нутгийн тусгай хамгаалалтанд байдаг юм байна, 05 дугаар сард хугацаа нь дуусахаар иргэдийн хурлаас шийдвэр гаргана гэсэн гэж хэлсэн. 2014 оны 05 дугаар сарын сүүлээр тусгай хамгаалалтанд байгаа хугацаа нь дуусаж байгаа газруудыг дахин хугацааг сунгаж хамгаалалтанд авах талаар хэлэлцэхэд бичил уурхайгаар ашигт малтмал олборлуулахаар саналыг хэн ч гаргаагүй хугацааг дахин 5 жилээр сунгаад Хэнтий аймгийн Байгаль орчны газарт явуулсан. Д.П 2014 оны 07 дугаар сард надтай утсаар яриад бичил уурхайгаар ашигт малтмал олборлох шийдвэр гарсан гэсэн та гэрээгээ хэзээ хийх вэ гэж асуухад нь юу яриад байгаа юм бэ? Хурал дээр бичил уурхайгаар ашигт малтмал олборлох талаар яригдаагүй, чиний авах гэж байгаа газрыг 5 жилийн хугацаагаар сунгасан гэж хэлсэн. Түүний дараа 2014 оны 08 дугаар сарын сүүлээр Д.П надтай утсаар ярихад нь гарсан шийдвэрийг нь үзүүлье, хэн нь ч үнэн худлаа яриад байгаа нь мэдэгдэхгүй, чи өөрөө хүрээд ир гурван нүүрээрээ уулзъя гэж хэлтэл 2014 оны 09 дүгээр сарын 05-ны өдөр Д.П ирэхээр нь би дагуулаад Я.Э даргатай

уулзах гээд өрөөнд нь ортол хүмүүстэй байж байхаар нь Д.П ирсэн байна, гурвуулаа уулзъя гэж хэлсэн чинь за өрөөнд чинь би орлоо гэж хэлчхээд орж ирэхгүй байхаар нь дахин өрөөнд нь ортол гарч яваад Төрийн банкин дотор зогсож байхаар нь Я.Э дарга та өрөөндөө ороод байж бай би орлоо гэхээр нь би Д.П-д хурлын дарга аймаг явна гэж байсан, чи хүлээж байгаад хамт ороод ирээрэй гэж хэлчхээд өрөөндөө сууж байтал машиндаа суугаад явчихлаа гэж хэлэхээр нь утсаар залгасан чинь утсаа авахгүй байж байгаад эхнэр нь утсыг нь аваад аймагт байна гэж хэлсэн. Тэгтэл Д.П намайг юу гэж бодоод байгаа юм. Хуулийн байгууллагад өргөдөл өгнө гээд уурлаад явсан...гэх мэдүүлэг /хх-ийн 47-48х/

3. Гэрч Г.Б-ийн:...2013 оны 12 дугаар сард Мөрөн сумын Засаг дарга Ж.Гэ Мөрөн сумын 3 дугаар баг Улааны энгэрт Д.П бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хүсэлт гаргасан байна, бүрдүүлсэн материалтай нь танилцаадах гээд өгсөн. Д.П-ын бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хүсэлт гаргасан газар 2009 оны 05 сарын 13-ны өдөр 5 жилийн хугацаатайгаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авагдаад 2014 оны 05 сарын 13-ны өдөр дуусахаар байсан. Тусгай хэрэгцээнд авсан хугацаа нь дууссан үед Засгийн газрын 308 дугаар тогтоол, бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журмын дагуу иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар шийдвэрлэх боломжтой. Дээрх газрыг тусгай хэрэгцээнд авах 5 жилийн хугацаа дуусаж дахин 2014 оны 06 сарын 04-ний өдрөөс 5 жилийн хугацаагаар тусгай хэрэгцээнд авахаар Иргэдийн хурлын тогтоол гаргаж Ашигт малтмалын газар хүргүүлсэн» гэх мэдүүлэг /хх-ийн 50 хуудас/

4. Гэрч Г.О-ын:...Орон нутагт Бичил уурхайгаар нөхөрлөлд ашигт малтмал олборлуулахаар газар эзэмшүүлэхэд тухайн орон нутагт бүртгэлтэй 5-аас доошгүй иргэн нөхөрлөл байгуулаад орон нутгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд бичил уурхайгаар талбай эзэмшүүлэх талаар хүсэлт гаргана. Иргэдийн хурал хүсэлтийг хүлээн аваад тухайн газрын солбицлыг тогтоож тухайн газрыг бичил уурхайн зориулалтаар орон нутгийн тусгай хэрэгцээнд авах тухай тогтоол гаргана. Уг тогтоолд орон нутгийн Засаг даргыг ашигт малтмалын газарт хандаж талбайн дүгнэлт гаргуулах заалт оруулж өгсний дагуу Засаг дарга ашигт малтмалын газарт иргэдийн хурлаас гаргасан солбицол

бүхий талбайг бичил уурхайгаар ашиглаж болох талаар дүгнэлт гаргуулахаар ашигт малтмалын газарт хандана. Ашигт малтмалын газар уг хүсэлтийг хүлээн аваад кадастрын зураг зүйн бүртгэлээс шүүлт хийгээд давхцалтай талбай мөн эсэхийг шалгаад давхцалтай байвал бичил уурхайгаар ашиглах боломжгүй гэсэн, давхцалгүй байвал бичил уурхайгаар ашиглаж болно гэсэн аль нэг дүгнэлт гарна. Гарсан дүгнэлтийг орон нутагт явуулаад боломжгүй дүгнэлт байвал Иргэдийн хурал гаргасан тогтоолоо хүчингүй болгоод нөхөрлөлд мэдэгдэнэ. Ашиглаж болно гэсэн тохиолдолд орон нутгийн Засаг дарга тухайн нөхөрлөлтэй гэрээ байгуулна» гэх мэдүүлэг / хх-ийн 51, 52х/

5. Насанд хүрээгүй гэрч Э.Ан-ийн:... «Би гар утастай болмоор байна гэж 2014 оны 01 дүгээр сард цагаан сарын өмнө хэлтэл аав нэг хүнтэй утсаар яриад миний охинд утас олж өгөх боломж байна уу гэж хэлсэн чинь за гэж хэлсэн байсан. Цагаан сарын битүүний өдөр хүн утас авч ирж байна гээд би аавын машинтай Мөрөн сумын замын уулзвар дээр очоод хар өнгийн дэлгэцтэй цагаан өнгийн тагтай Samsung S маркийн утсыг нэг танихгүй эрэгтэй хүнээс аваад барьж байгаад хураалгасан...гэх мэдүүлэг /хх-ийн 109-110х/

6. Шүүгдэгч Д.П-ын:...Би 2013 онд Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хууль тогтоомж журмыг судалж байгаад Хэнтий аймгийн Мөрөн суманд нөхөрлөл байгуулж ашигт малтмал олборлохоор 2013 оны 11 дүгээр сард Хэнтий аймгийн Мөрөн суманд очиж Засаг дарга Ж.Гэтай уулзаж хэлтэл хурлын дарга Я.Э-тэй уулз гэж хэлсний дагуу уулзаж хэлтэл дэмжиж байна болно бүтнэ, нөхөрлөлөө байгуулаад хүрээд ир, бичил уурхайн журмын дагуу Иргэдийн хурлаар оруулж тогтоол гаргаж өгнө гэж хэлэхээр нь Улаанбаатар хот орж ажлаа амжуулчихаад 2013 оны 12 дугаар сарын дунд үеэр буцаж очоод Я.Э даргад танилцуулсан....2014 оны 01 дүгээр сард Я.Э даргатай уулзаад юу болж байгаа талаар асуухад санаа зоволтгүй 2 дугаар сард гарна гэж хэлсэн. Цагаан сарын өмнөхөн Я.Э дарга утсаар яриад миний охин андройд утас нэхээд байна утас аваад явуулчих гэж ярихаар нь цагаан сарын өмнө амжихгүй цалин буухаар явуулъя гэж хэлсэн чинь ойр ойрхон утасдаад байхаар нь миний хүсэлт юу болж байна гэж асуутал утас аваад явуулчих юм бол зөвшөөрөл асуудалгүй бүтнэ гэж хэлэхээр нь утас авч

өгөхгүй бол болохгүй юм байна гэж бодоод цагаан сарын битүүний өдөр цалин буухаар нь Монтелийн гадаа утас зарж байсан танихгүй хүнээс Samsung Galaxy маркийн урд тал нь хар өнгөтэй, зайны таг нь ар хэсэгтээ гялгар хуучин хэрэглэж байсан утсыг 350.000 төгрөгөөр худалдаж аваад Я.Э даргатай утсаар яриад хотоос гарч байна замаас тосоод аваарай гэж хэлээд Мөрөн сум ороод залгасан чинь сумын төвийн гүүрэн дээр мазда маркийн автомашинтай өөрөө унаад охинтойгоо хамт ирээд утсаа аваад баярлалаа сайхан шинэлээрэй гэж хэлээд явсан» гэх мэдүүлэг /хх-ийн 80 х/

7. Шүүгдэгч Я.Э-гийн:...2013 оны 12 дугаар сард Д.П нөхөрлөл байгуулж бичил уурхайгаар ашигт малтмал олборлох хүсэлт гаргасан. Тухайн үед надад мөнгөний хэрэг байсан болохоор 280.000 төгрөгийг зээлж аваад хувийн хэрэгцээндээ зарцуулсан. Мөн 2014 оны 02 дугаар сард цагаан сарын үед охин утас нэхээд байхаар нь Д.П-тай утсаар ярьж гар утас авахуулж охиндоо өгсөн. 2014 оны хавар Улаанбаатар хотод ирэд бензины мөнгөгүй болчихоор нь 70.000 төгрөг авсан...280.000, 70.000 төгрөгийг зээлсэн. Гар утсыг бол ажлыг нь бүтээж өгнө гээд хээл хахуульд авсан нь үнэн. Д.П-ын гаргасан хүсэлтийг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар оруулж шийдвэрлэх эрх байсан боловч цаг хугацаа тохирохгүй, мөн хууль бусаар ашигт малтмал олборлогч нэмэгдчих байх гэсэн үүднээс сэрэмжилж байсан юм. Д.П-д чирэгдэл учруулж хээл хахуульд гар утас авснаа хүлээн зөвшөөрч байна» гэх мэдүүлэг /хх-ийн 62 х/

8. Эд мөрийн баримт хураан авч хадгалах тухай тогтоол /хх-ийн 2х/

/самсунг галакси маркийн гар утас/

9. Хэнтий аймгийн Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит бус хуралдааны тогтоол, хавсралтууд /хх-ийн 18-21х/

10. Мөрөн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын наймдугаар хуралдааны тогтоол, хавсралт /хх-ийн 22-26х/

11. Ашигт малтмалын газрын 2014.04.08-ны өдрийн 6/2704 тоот албан бичиг, хавсралт /хх-ийн 23-25х/

12. Шүүгдэгч Я.Э-гийн урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /хх-ийн 81х/

13. Шүүгдэгч Д.П-ын урьд ял шийтгэгдсэн эсэхийг шалгах хуудас /хх-ийн 99х/

14. Шүүгдэгч нарын мөрдөн байцаалтын шатанд болон шүүхийн шинэчилсэн хэлэлцүүлэгт үйлдсэн гэмт хэргээ хүлээн мэдүүлсэн мэдүүлгүүд зэрэг болно.

Шүүгдэгч Я.Э нь хээл хахууль өгөгч Д.П-ын ашиг өөрийн эрхэлж байгаа ажил, албан тушаалаа ашиглан өөртөө ашиг олох зорилгоор сумынхаа нутаг дэвсгэрт ашигт малтмал олборлох зөвшөөрлийг гаргаж өгнө гэж урьдчилан амлаж, түүнээс хээл хахууль авсан үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн дэх хэсэгт заасан гэмт хэрэг мөн байна.

Шүүгдэгч Д.П нь өөрийн бизнесийн үйл ажиллагаа, ажил хэргээ хурдан, хялбар, баталгаатай бүтээх хувийн явцуу зорилгоор Я.Э-д хээл хахууль өгсөн үйлдэл нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт заасан гэмт хэрэг мөн байна.

Шүүгдэгч нар нь дээрх гэмт хэргүүдийг гэм буруугийн шууд санаатай хэлбэрээр материаллаг ашиг хонжоо олох зорилгоор үйлджээ.

Шүүгдэгч нарын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүндэвтэр гэмт хэрэг анх удаа үйлдсэн байдал, үйлдсэн гэмт хэрэгтээ чин санаанаасаа гэмшиж байгаа байдал, тэдний ар гэр, хувийн байдлуудыг харгалзан энэ удаад нийгмээс тусгаарлаж хорих ял оногдуулах шаардлагагүй гэж шүүх үзлээ.

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 283, 286, 294, 295, 296, 297, 298, 299 дүгээр зүйлүүдэд заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. Шүүгдэгч М овогт Я.Э-г хээл хахууль авах, шүүгдэгч З овогт Д.П-ыг хээл хахууль өгөх гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Я.Э-д тодорхой албан тушаал эрхлэх, үйл ажиллагаа явуулах эрхийг нь 2 / хоёр / жилийн хугацаагаар хасаж, 1 / нэг / жил 6 / зургаа / сарын хугацаагаар хорих ял, шүүгдэгч Д.П-д Эрүүгийн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар 1 / нэг / жил 6 / зургаа / сарын хугацаагаар хорих ял тус тус шийтгэсүгэй.

3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт заасныг журамлан шүүгдэгч Я.Э-д оногдуулсан 1 жил 6 сарын хорих ял, шүүгдэгч Д.П-д оногдуулсан 1 жил 6 сарын хорих ялыг тус тус жирийн дэглэмтэй хорих ангид эдлүүлсүгэй.

4. Шүүгдэгч нар нь энэ хэрэгт урьдчилан

цагдан хоригдоогүй, тэдний иргэний бичиг баримт шүүхэд ирээгүй, шүүгдэгч нар нь бусдад төлөх хохирол төлбөргүй болохыг тус тус дурдсугай.

5. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2-т зааснаар энэ хэрэгт эд мөрийн баримтаар хураагдан ирсэн Samsung Galaxy S /Самсунг галакси/ маркийн гар утас 1 ширхгийг хурааж улсын орлого болгосугай.

6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1 дэх хэсэгт зааснаар шүүгдэгч Я.Э-д оногдуулсан 1 жил 6 сарын хорих ял, шүүгдэгч Д.П-д оногдуулсан 1 жил 6 сарын хорих ялыг тус тус тэнсэж, мөн хугацаагаар хянан харгалзсугай.

7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.4 дэх хэсэгт зааснаар тэнсэгдсэн ялтан Я.Э, Д.П нарт хяналт тавьж

ажиллахыг Хэнтий аймгийн Цагдаагийн газарт даалгасугай.

8. Шийтгэх тогтоол нь танилцуулан сонсгосноор хуулийн хүчинтэй болох бөгөөд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд нь энэ шийтгэх тогтоолыг эс зөвшөөрвөл гардан авснаас хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 1 дүгээр шүүхэд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэй болохыг дурдсугай.

9. Давж заалдах гомдол гаргасан буюу эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол биелэгдэх хүртэл шүүгдэгч Я.Э, Д.П нарт урьд бусдын батлан даалтад өгөхөөр авсан таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үлдээсүгэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ

Ж.БОЛДБААТАР

/Энэхүү шийтгэх тогтоол нь хувь хүний нууцтай холбоотой тул зөвхөн Тогтоох хэсгийг оруулав./

ШИЙТГЭХ ТОГТООЛ

2014 оны 09 сарын 30 өдөр

Дугаар 1214

Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН НЭРИЙН ӨМНӨӨС

Дүүргийн Эрүүгийн анхан шатны хоёрдугаар шүүхэд шүүгч П.Туяат даргалж, П.Туяат, Ц.Дайрийжав, Г.Есөн-эрдэнэ нарын бүрэлдэхүүнтэй тус шүүхийн шүүх хуралдааны танхимд хийсэн шүүх хуралдаанаар

Улсын яллагч: Д.Ганчимэг

Шүүгдэгч: М, С, О, Ц

Монгол Улсын Эрүүгийн Байцаан Шийтгэх хуулийн 283, 286, 290, 294, 296, 297, 298 дугаар зүйлүүдэд заасныг удирдлага болгон ТОГТООХ нь:

1. М-ийг албан үүргийн хувьд гүйцэтгэх ёсгүй үйлдлийг хийхээр урьдчилан амлаж хээл хахууль авсан, эрүүгийн хэргийн нотлох баримтыг хуурамчаар бүрдүүлсэн, албан тушаалын байдлаа ашиглан давтан үйлдлээр бусдын эд хөрөнгийг хуурч мэхлэх итгэл эвдэх аргаар залилан мэхлэн авч бага бус хэмжээний хохирол учруулсан гэмт хэргийг,

С-ийг бүлэглэн хохирогчид хүч хэрэглэж хүчиндсэн, албан тушаалтанд хээл хахууль өгсөн гэмт хэргийг,

О-г бүлэглэн хохирогчид хүч хэрэглэж хүчиндсэн, албан тушаалтанд хээл хахууль өгсөн гэмт хэргийг

Ц-г мөрдөн байцаалтад зориуд худал мэдүүлэг өгсөн гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тус тус тооцсугай.

2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар М-ийг мөрдөн байцаагчийн албан тушаал эрхлэх эрхийг 1 /нэг/ жилийн хугацаагаар хасаж, 2 /хоёр/ жилийн хугацаагаар хорих ялаар, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 253 дугаар зүйлийн 253.2 дахь хэсэгт зааснаар 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.2 дахь хэсэгт зааснаар эд хөрөнгө хураахгүйгээр 6 /зургаа/ сарын хугацаагаар баривчлах ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.2.6 дахь

хэсэгт зааснаар С-г 5 /тав/ жил 1 /нэг/ сарын хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.2.6 дахь хэсэгт зааснаар О-г 5 /тав/ жил 1 /сар/ сарын хугацаагаар хорих ялаар, мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 254 дүгээр зүйлийн 254.1 дэх хэсэгт зааснаар Ц-г 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ялаар тус тус шийтгэсүгэй.

3. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэгт зааснаар Эрүүгийн хуулийн тусгай ангийн 268 дугаар зүйлийн 268.1 дэх хэсэгт зааснаар М-д оногдуулсан мөрдөн байцаагчийн албан тушаал эрхлэх эрхийг 1 /нэг/ жилийн хугацаагаар хасаж, 2 /хоёр/ жилийн хугацаагаар хорих ял дээр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 253 дугаар зүйлийн 253.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ялыг нэмж нэгтгэн, мөн хуулийн тусгай ангийн 148 дугаар зүйлийн 148.2 дахь хэсэгт зааснаар оногдуулсан эд хөрөнгө хураахгүйгээр 6 /зургаа/ сарын хугацаагаар баривчлах ялыг багтааж биечлэн эдлэх нийт ялыг 3 /гурав/ жилийн хугацаагаар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.2.6 дахь хэсэгт зааснаар С-д оногдуулсан 5 /тав/ жил 1 /нэг/ сарын хугацаагаар хорих ял дээр мөн хуулийн тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ялыг нэмж нэгтгэн, биечлэн эдлэх нийт ялыг 6 /зургаа/ жил 1 /нэг/ сарын хугацаагаар хорих ялаар,

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.2.6 дахь хэсэгт зааснаар О-д оногдуулсан 5 /тав/ жил 1 /нэг/ сарын хугацаагаар хорих ял дээр мөн хуулийн

тусгай ангийн 269 дүгээр зүйлийн 269.1 дэх хэсэгт зааснаар оногдуулсан 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ялыг нэмж нэгтгэн, биечлэн эдлэх нийт ялыг 6 /зургаа/ жил 1 /нэг/ сарын хугацаагаар хорих ялаар тус тус тогтоосугай.

4. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.6 дахь хэсэгт зааснаар С, О нарт оногдуулсан хорих ялыг чанга дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид,

Мөн хуулийн ерөнхий ангийн 52 дугаар зүйлийн 52.5 дахь хэсэгт зааснаар Ц-д оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй эмэгтэйчүүдийн хорих ангид, М-д оногдуулсан хорих ялыг жирийн дэглэмтэй эрэгтэйчүүдийн хорих ангид тус тус эдлүүлсүгэй.

5. М, С, О, Ц нар нь цагдан хоригдсон хоноггүй, бусдад төлөх төлбөргүй, хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан зүйлгүй болохыг дурдсугай.

6. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 61 дүгээр зүйлийн 61.1, 61.4 дэх хэсгүүдэд зааснаар Ц-д оногдуулсан 1 /нэг/ жилийн хугацаагаар хорих ялыг тэнсэж, 1 /нэг/ жилийн хугацаагаар хянан харзалзаж, цаашдын засрал хүмүүжилд хяналт тавихыг Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн хэлтэст даалгасугай.

7. Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 49 дүгээр зүйлийн 49.2 дахь хэсэгт зааснаар М-ийн хууль бусаар олсон орлого болох 2.000.000 /хоёр сая/ төгрөгийг улсын орлого болгосугай.

8. М, С, О нарын бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс өөрчлөн цагдан хорьсугай.

9. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 299 дүгээр зүйлийн 299.3, 303 дугаар зүйлийн 303.1, 304 дүгээр зүйлийн 304.1 дэх хэсэгт зааснаар шийтгэх тогтоол танилцуулан сонсгосноор хуулийн хүчинтэй болохыг дурдаж, шийтгэх тогтоолд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрх бүхий этгээд тогтоолыг гардаж авсан өдрөөс хойш 14 хоногийн дотор Эрүүгийн хэргийн давж заалдах шатны 10 дугаар шүүхэд давж заалдах гомдол гаргах, эсэргүүцэл бичих эрхтэй болохыг дурдсугай.

10. Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 306 дугаар зүйлийн 306.1 дэх хэсэгт зааснаар давж заалдах гомдол, эсэргүүцэл бичигдсэн тохиолдолд тогтоолын биелэлтийг түдгэлзүүлж, тогтоол биелүүлэх хүртэл М, С, О нарын цагдан хорих, Ц-н бусдын батлан даалтад өгөх таслан сэргийлэх арга хэмжээг хэвээр үргэлжлүүлсүгэй.

ДАРГАЛАГЧ ШҮҮГЧ
ШҮҮГЧИД
Г.ЕСӨН-ЭРДЭНЭ

П.ТУЯАТ
Ц.ДАЙРИЙЖАВ

*/Энэхүү тогтоол нь хувь хүний
нууцтай холбоотой байх тул зөвхөн
Тогтоох хэсгийг оруулав./*

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ХЯНАЛТЫН ШАТНЫ ЭРҮҮГИЙН ХЭРГИЙН ШҮҮХ ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2014 оны 12 сарын 19 өдөр

Дугаар 472

Улаанбаатар хот

Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 350 дугаар зүйлийн 350.1.2-д заасныг удирдлага болгон хяналтын шатны эрүүгийн хэргийн шүүх хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн 1214 дүгээр шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн 3 дахь заалтын «М-ын биечлэн эдлэх ялыг нийт 3 жилийн хугацаагаар тогтоосугай» гэснийг “М-ын

биечлэн эдлэх ялыг мөрдөн байцаагчийн албан тушаал эрхлэх эрхийг 1 жил хасаж, 3 жилийн хугацаагаар хорих ялаар тогтоосугай” гэж өөрчилсүгэй.

2. Шийтгэх тогтоол, магадлалын бусад заалт, хэсгийг хэвээр үлдээж, ялтан М-ын өмгөөлөгч Л.Цэндоогийн хяналтын шатны шүүхэд гаргасан гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

ДАРГАЛАГЧ,
ШҮҮГЧ
ШҮҮГЧ

Б.БАТ-ЭРДЭНЭ
Б.ЦОГТ

